ВЗГРЕТЬ 1. зандрах, донгодох; 2. тонших, дэлдэх.
ВЗГРОМОЖДА́ТЬ овоолох, овооруулах.
ВЗГРОМОЖДА́ТЬСЯ овоололдох, оворолдох, мацаж авирах.
ВЗГРУСТНУ́||ТЬСЯ гуних, уйдах; **мне ~лось** би уйдаж байна.
ВЗДВА́ИВАТЬ давхар эгнэх, хоёр эгнээ болох.
ВЗДЁРГИВАТЬ 1. өргөх, дээш нь татах; 2. шантайх, агсах;
ВЗДЁРНУТЬ ~ нос хамраа шантайлгах, их зантай болох.
ВЗДОР дэмий балай; **молоть ~** дэмий балай чалчих, шаан паан гэх.
ВЗДО́РИТЬ тар түр хийх, үг хаялцах, муудалцах.
ВЗДО́РНЫЙ 1. дэмий, балай; 2. яншаа, хэрүүлч.
ВЗДОРОЖА́НИЕ үнэ нэмэгдэх, үнэтэй болох.
ВЗДОРОЖА́ТЬ үнэ нэмэгдэх, үнэтэй болох.
ВЗДОХ гүнзгий амьсгалах, сүүрс алдах, санаа алдах; **испустить последний ~** амьсгал тасрах.
ВЗДОХНУ́ТЬ амьсгаа авах, амьсгаалах; **~ свободно** чөлөөтэй амьсгаалах.
ВЗДРА́ГИВАТЬ 1. сочих, чацвалзах, татвалзах; 2. *разг.* архи уух.
ВЗДРЕМНУ́ТЬ үүрэглэх, дуг хийх.
ВЗДУВА́ТЬ 1. үлээх, хийсгэх; 2. хавдах, *сэлхийх*; 3. даврууллах, гаарууллах.
ВЗДУ́МАТЬ санаанд орох, гэнэт санах.
ВЗДУ́МА||ТЬСЯ санаа төрөх, санаанд орох; **что тебе ~лось?** юу санаанд *чинь оров*?
ВЗДУ́ТЫЙ хий дүүрсэн, ёлхойсон.
ВЗДУ||ТЬ 1. үлээх, хийсгэх; **ветер ~л песок** салхи элс хийсгэв; 2. хавдах, сэлхийх; **у меня ~ло щёку** *миний* хацар хавдлаа; 3. даврууллах, гаарууллах, ахдуулах; **~ цены** үнэ даврууллах.
ВЗДУ́ТЬСЯ 1. хавдах, хөөх, булцайх, овойх; **почки на деревьях вздулись** модны найлзуур булцайв; 2. даврах, хэтрэх; *** река вздулась** гол үерлэв.
ВЗДЫБИТЬ цоройлгох, цовхруулах.
ВЗДЫМА́ТЬ өргөх, бургиулах; **~ пыль** тоос бургиулах.
ВЗДЫХА́ТЬ 1. амьсгаа авах; 2. шүүрс алдах, санаа алдах, санаашрах.
ВЗИМА́НИЕ хураах, татах; **~ налогов** татвар хураах.
ВЗИМА́ТЬ хураах, төлүүлэх, татах, авах; **~ штраф** торгууль төлүүлэх.
ВЗИРА||ТЬ харах, үзэх, ширтэх; **критиковать, не ~я на лица** нүүр харгалзахгүй шүүмжлэх; *** не ~я ни на что** яалаа ч гэсэн; **не ~я на это** тэглээ ч гэсэн.
ВЗЛА́МЫВАТЬ эвдэх, хэмхчих.
ВЗЛЕЗА́ТЬ авирах, асах; **~ на дерево** мод өөд авирах.
ВЗЛЕЛЕ́ЯТЬ 1. торниулах, энхрийлэх; 2. - саар явах, - сээр явах; **~ надежду** найдсаар явах.
ВЗЛЁТ нисэх, дэгдэх, хөөрөх.
ВЗЛЕТА́ТЬ нисэх, хийсэх, харайх; *** ~ на воздух** тэс үсрэх.
ВЗЛОМ эвдэх, хамхлах; **кража со ~ом** эвдэж хулгайлах.
ВЗЛОМА́ТЬ эвдэх, хамхлах; **~ дверь** хаалга эвдэх.
ВЗЛО́МЩИК эвдэж хулгайлагч.
ВЗЛОХМА́ТИТЬ өрвийлгөх, сэгсийлгэх.
ВЗЛОХМА́ТИТЬСЯ өрвийх, сэгсийх.
ВЗЛОХМА́ЧЕННЫЙ өрвийсөн, сэгсийсэн.
ВЗМАХ дэвэх, самрах, далайх.
ВЗМА́ХИВАТЬ дэвэх, далайх, даллах.
ВЗМЁТ атар хагалах.
ВЗМЕТА́ТЬ 1. хийсгэх; 2. дэвэх, далайсхийх.
ВЗМЕТНУ́ТЬСЯ дээш үсрэх, зурсхийх.
ВЗМОЛИ́ТЬСЯ гуйж гувших, мөргөн гуйх.
ВЗМО́РЬЕ далайн хаяа, далайн хөвөө.
ВЗМЫВА́ТЬ хөврөн нисэх, дэгдэн нисэх.
ВЗМЫЛЕННЫЙ 1. хөөсөрсөн; 2. хөлсөө гоожуулсан.
ВЗМЫ́ЛИТЬ 1. хөөсрүүлэх; 2. хөлөргөх; **~ коня** морио хөлөргөх.
ВЗМЫТЬ хөврөн нисэх, дэгдэн нисэх.
ВЗНОС татвар, төлбөр; **членский ~** гишүүний татвар; **~ квартирной платы** байрын хөлс төлөх.
ВЗНУЗДА́ТЬ хазаарлах.
ВЗОБРА́ТЬСЯ авирч гарах, мацаж авирах.
ВЗОЙТИ́ 1. гарах, дээр гарах; **~ на трибуну** индэр дээр гарах; 2. гарах, мандах; **солнце взошло** нар мандав; 3. ургах, булталх; **пшеница хорошо взошла** буудай сайн ургалаа.
ВЗОР харц, анхаарал; **задумчивый ~** санааширсан харц; **~ы всей публики** олон нийтийн анхаарал; *** вперить ~** ширтэх, гөлийх.
ВЗОРВА́||ТЬ 1. тэслэх, дэлбэлэх; 2. цухалдуулах, уур их хүргэх; **его слова ~ли меня** түүний үг миний уурыг хүргэв.
ВЗОРВА́ТЬСЯ тэсрэх, дэлбэрэх.
ВЗРАСТИ́ТЬ 1. ургуулах; 2. бойжуулах, торниулах.
ВЗРЕВЕ́ТЬ чарлах, бархирах.
ВЗРЕ́ЗАТЬ хага зүсэх, тас хэрчих.
ВЗРО́СЛ||ЫЙ насанд хүрсэн, том, цээнд хүрсэн, өөлий; **~ человек** насанд хүрсэн хүн; **~ые и дети** томчууд ба багачууд.
ВЗРЫВ дэлбэрэх, тэсэлгээ, тэсрэх; *** ~ смеха** инээд алдах; **~ аплодисментов** нижигнэтэл алга таших; **~ на макаронной фабрике** босоо, замбараагүй үгтэй байх.
ВЗРЫВА́ТЬ 1. дэлбэлэх, тэслэх; 2. ухах, малтах.
ВЗРЫВА́ТЬСЯ дэлбэрэх, тэсрэх.
ВЗРЫВН||О́Й дэлбэрэх, тэслэх, тэсрэлтийн; **~ая волна** тэсрэлтийн долгио; **взрывные работы** тэсэлгээний ажил.
ВЗРЫВЧАТ||ЫЙ тэсрэмтгий, дэлбэрэх, тэсрэх; **~ые вещества** тэсрэх эд.
ВЗРЫТЬ ухах, малтах, онгилох.
ВЗРЫХЛИ́ТЬ хөвсийлгөх, сийчих, зөөлрүүлэх; **~ почву** хөрс сийчих.
ВЗЪЕРЕПЕ́НИТЬСЯ адрах, шазрах.
ВЗЪЕРО́ШИТЬ сэгсийлгэх, өрвийлгөх.
ВЗЪЕРО́ШИТЬСЯ сэгсийх, өрвийх.
ВЗЪЕ́СТЬСЯ занах, зүхэх, зэмлэх.
ВЗЫВА́ТЬ дуудах, гуйж хүсэх.
ВЗЫСКА́НИЕ 1. шийтгэл, зэмлэл, цээрлэл үзүүлэх; **дисциплинарное ~** сахилга батын зэмлэл; 2. албадан төлүүлэх, нэхэлт.
ВЗЫСКА́ТЕЛЬНЫЙ чанга, шаардлагатай.
ВЗЫСКА́ТЬ, 1. хураах, нэхэж авах, төлүүлэх; **~ налоги** татвар хураах; **~ недоимки** дутууг нэхэж авах; 2. гэсгээх, цээрлүүлэх, шийтгэх; *** не взыщите** өршөөж хайрла.
ВЗЯ́ТИ||Е 1. олзлох; **~ в плен** олзлон авах; 2. эзлэн авах; **при ~и крепости** хэрмийг эзлэн авахад; 3. авах; **~ пробы** сорьц авах.
ВЗЯ́ТК||А 1. хээл, хахууль, идэш, авлига; 2. идэх, цохих; **остался без ~ок** нэг ч идэлгүй хоцорлоо *(хөзрөөр тоглоход)*.
ВЗЯ́ТОЧНИК авлигач, хахууль авагч.

ВЗЯ́ТОЧНИЧЕСТВО хээл хахууль авах явдал.

ВЗЯТЬ 1. авах; ~ **взаймы** зээл авах; 2. барих; ~ **за руку** гараас барих; 3. давах, дийлэх, ялах; ~ **препятствие** саадыг давах; ~ **под стражу** хорих; **возьми и скажи** заа, хэлж орхи; ~ **на мушку** буу тулгах; ~ **страх** айдас хүрэх; ~ **в оборот** ажиллуулах, хэрэглэх; ~ **слово** хурал дээр үг хэлэх.

ВЗЯ́ТЬСЯ 1. барих, барилцах; 2. эхлэх, орох; ~ **за работу** ажилдаа орох; 3. бий болох, олох; **откуда у тебя взялась эта книга?** чи энэ номыг хаанаас олов? 4. авах, болох, гэх; ~ **написать статью** үгүүлэл бичих гэх; * **откуда ни возьмись** хаанаас ирснийг бүү мэд.

ВИАДУ́К гүүрэг, дам гүүр.

ВИБРА́ТОР 1. цацаргуур; 2. чичиргүүр; 3. доргилуур.

ВИБРА́ЦИЯ чичрэх, чичигнэх, доргилох, долгион.

ВИБРИ́РОВАТЬ чичрэх, чичигнэх, доргилох.

ВИВА́РИЙ амьтны жүчээ, амьтан агуулах газар.

ВИГВА́М Хойт Америкийн индианчуудын сууц, урц, байшин сав, орох орон.

ВИД I 1. байдал, дүр, хэлбэр, янз; **внешний** ~ гаднах байдал; **потерять** ~ янзаа алдах; 2. харах, харагдах, үзэгдэх, үзэмж; **самолёт скрылся из** ~**у** нисэх онгоц харагдахаа болилоо; 3. шиг, мэт; **камень в** ~**е яйца** өндөг шиг чулуу; 4. анхаарах, хараандаа авах, мартахгүй, бодох, мэдэх;**иметь в** ~**у** анхааралдаа авч байх; 5. санаатай байх, хэлэх; **кого имеете в** ~**у?** хэнийг та хэлж байна? * **под** ~**ом друга** найзын нэрийдлээр; **для** ~**а** үзэмжийн төдий, ёсын төдий; **видавшие** ~**ы** хал үзсэн, догь.

ВИД II 1. зүйл, төрөл; **дерево — ~ растения** мод бол нэг зүйл ургамал; 2. байдал; **совершенный** ~ **глагола** төгс байдалт үйл үг; **несовершенный** ~ **глагола** төгс бус байдалт үйл үг.

ВИДА́||ТЬ I 1. харах, үзэх; 2. харагдах, үзэгдэх; ~**л?** харав уу? **поезда не** ~ галт тэрэгхарагдахгүй байна.

ВИДА́ТЬ II 1. байх бололтой, шиг байх; **он,** ~**, дома** тэр гэртээ байгаа байх.

ВИДЕ́НИЕ 1. үзэгдэл, харагдах, хараа; **ясное** ~ **предметов** юм тодорхой харагдах; 2. хий үзэгдэл, сүүдэгнэх.

ВИ́ДЕО дүрс бичлэгийн.

ВИДЕОЗА́ПИСЬ дүрс бичлэг.

ВИДЕОКА́МЕРА дүрс бичлэгийн камер, видеокамер.

ВИДЕОКАССЕ́ТА хуурцаг.

ВИДЕОМАГНИТОФО́Н видеомагнитофон, приставк.

ВИДЕОТЕЛЕФО́Н дүрс дамжуулагчтай утас.

ВИ́ДЕ||ТЬ 1. харах, үзэх; **слепые не видят** сохор хүн юм хардаггүй; 2. уулзах, учрах, дайралдах; **рад вас** ~ тантай уулзсандаа баярлалаа; 3. мэдэх, ойлгох; **вижу свою ошибку** алдаагаа мэдлээ; **вижу, что он прав** түүний зөвийг ойлголоо; **только и** ~**л** хальт хараад алдсан; **он, видите ли, много читает** тэр ч нээрээ их уншдаг хүн; **видит око, да зуб неймёт** харахад ойрхон ч хазахад хол, санаа байвч сачий хүрэхгүй.

ВИ́ДЕТЬСЯ учрах, уулзах.

ВИ́ДИМО бололтой, биз, байх, бараглахад; **он,** ~**, задержится ещё на час** тэр дахиад нэг цаг саатах нь бололтой.

ВИ́ДИМО-НЕВИ́ДИМО нүд алдам, учир нажиргүй олон.

ВИ́ДИМОСТЬ 1. үзэгдэх, бараа, харагдах; **в ясный день** ~ **лучше** тунгалаг өдөр үзэгдэх нь сайн; 2. үзэгдэхийн төдий, нүд хуурах, хуурмаг; **одна** ~ нүд хуурах төдий.

ВИ́ДИМ||ЫЙ 1. харагдах, үзэгдэх; ~ **мир** үзэгдэх ертөнц; 2. илэрхий, үзэгдэхүйц; **для этого нет никакой** ~**ой причины** ингэнэ гэхэд ямар ч үзэгдэхүйц шалтгаан байхгүй; 3. хуурмаг, өнгөцхөн, үзэгдлийн төдий; **этот успех только** ~ энэ амжилт нь үзэгдлийн төдий юм.

ВИДНЕ́ТЬСЯ харагдах, үзэгдэх, сүүмэлзэх; **вдали виднелись горы** нүдний үзүүрт уул сүүмэлзэж байв.

ВИ́ДНО 1. харагдах, үзэгдэх; **ни зги не** ~ бүр юу ч харагдахгүй байна; **из этого** ~ үүнээс үзэхэд; 2. бололтой, юм шиг; ~**, что ты устал** чи ядарсан бололтой.

ВИ́ДН||ЫЙ 1. ил, үзэгдэх, харагдах; **на** ~**ом месте** ил газарт; 2. чухал, томоохон, нэртэй; **занимать** ~ **пост** чухал тушаалд томилогдох; ~ **учёный** нэртэй эрдэмтэн; 3. биелэг, том; ~ **мужчина** том эр.

ВИДОИЗМЕНЕ́НИЕ хувирах, ондооших, өөрчлөгдөх.

ВИДОИЗМЕНИ́ТЬ хувиргах, ондоо болгох, өөрчлөх.

ВИДОИЗМЕНИ́ТЬСЯ хувирах, ондооших, өөрчлөгдөх.

ВИДОИСКА́ТЕЛЬ хараа, шагайвар.

ВИ́ДЫВАТЬ харсаар байх, үзсээр байх.

ВИ́ЗА виз, цохдол, хил нэвтрэх зөвшөөрөл.

ВИЗГ чарлах, орилох.

ВИЗГЛИ́ВЫЙ чарладаг, орилдог, чарлаа.

ВИЗЖА́ТЬ гангинах, чарлах.

ВИЗИ́РОВАТЬ 1. виз олгох; 2. хараа чиглүүлэх, шагайх.

ВИЗИ́РЬ их сайд, чинсан.

ВИЗИ́Т уулзах, уулзалт хийх, золгох.

ВИЗИ́ТКА нэрийн хуудас.

ВИЗИ́ТН||ЫЙ уулзалтын, золголтын, нэрийн; ~**ая карточка** нэрийн хуудас.

ВИЗУА́ЛЬН||ЫЙ ~**ое наблюдение** нүдээр ажиглах; ~**ое обследование** харж судлах, нүдэн баримжаагаар судлах; ~ **способ** нүдээр баримжаалах арга.

ВИ́КА *бот.* гиш өвс, хүсий.

ВИКТОРИ́НА асуултын наадам.

ВИ́ЛКА сэрээ, ац.

ВИ́ЛЛА сэрүүн лавран, сэрүүн ордон.

ВИЛО́К монцгор байцай.

ВИЛЬНУ́ТЬ шарвах, бултах.

ВИЛЯ́||ТЬ 1. шарвах; ~ **хвостом** сүүлээ шарвах; 2. бултах; **не** ~**й, а прямо говори** бултаглүй шууд хэл.

ВИН||А́ ял, гэм, осол, алдал; **вменять в** ~**у** ял тулгах, буруушаах; **сваливать** ~**у на других** гэмээ бусдад тохох; **не по моей** ~**е** миний буруугаас болоогүй.

ВИНЕГРЕ́Т 1. холимцог, ногоотой хярамцаг; 2. холио бантан.

ВИНИ́Л винил.

ВИНИ́ТЕЛЬНЫЙ ПАДЕ́Ж заахын тийн ялгал.

ВИНИ́ТЬ буруушаах, буруутгах, зэмлэх.

ВИНИ́ТЬСЯ буруугаа хүлээх, гэмших.

ВИ́НН||ЫЙ архины, дарсны; ~ **погреб** дарсны зоорь; * ~ **камень** 1. дарсны чулуу, дарсны тунадас; 2. шүдний хөгц; ~**ая ягода** инжир.

ВИНО́ дарс, сархад; **виноградное** ~ үзмийн дарс; **белое** ~ цагаан дарс.

ВИНОВА́Т||ЫЙ 1. буруу, буруутай; **он не** ~ түүний буруу биш; 2. гэмших, буруугаа мэдэх; ~ **вид** гэмшсэн байдалтай; * ~**!** өршөө!; **без вины** ~ гэмгүй мөртлөө зэмтэй.

ВИНО́ВНИК 1. гэмт этгээд; 2. өдүүлэгч, үүсгэгч; ~ **торжества** хуримын эзэн, баярын шалтгаан бологч.

ВИНО́ВНОС||ТЬ буруу, буруутай, зэмтэй; ~ **его установлена** түүний буруутай нь нотлогдсон юм; **степень** ~**ти** хэр зэрэг буруутай нь.

ВИНО́ВН||ЫЙ буруутай, буруут, гэмт этгээд, зэмт хүн; **чувствовать себя** ~**ым** буруугаа мэдэх.

ВИНОГРА́Д үзэм, усан үзэм.

ВИНОГРА́ДАРЬ үзэмчин.

ВИНОГРА́ДНИК үзмийн тариалан.

ВИНОГРА́ДН||ЫЙ үзмийн; ~**ая лоза** үзмийн залаа.

ВИНОДЕ́Л дарсч, сархад нэрэгч.
ВИНОКУ́Р архи спирт нэрэгч.
ВИНОКУРЕ́НИЕ архи нэрэх, спирт үйлдэх.
ВИНОКУ́РЕННЫЙ архи нэрэх.
ВИНТ 1. шүрэв, шураг, эрэг; 2. сэнс.
ВИ́НТИК жижиг шүрэв, эрэгтэй хадаас; **у него ~а не хватает** ухаанд нь согог оржээ.
ВИНТИ́ТЬ эрэгдэх, шүрэвдэх.
ВИНТО́ВКА винтоов буу.
ВИНТОВ||О́Й 1. шураг,эрэгтэй, эргийн шүрэвтэй, шүрвийн; **~ая шляпка** шүрвийн тав; 2. мушгиа, эргүүлгэн; **~ая лестница** эргүүлгэн шат.
ВИНТО́ВОЧНЫЙ винтоов буюны.
ВИНТООБРА́ЗНЫЙ эрэг шиг мушгиа.
ВИНЬЕ́ТКА бирга, номын чимэг.
ВИОЛОНЧЕ́ЛЬ эхил хуур, хийл хуур, морин хийл.
ВИРА́Ж 1. тодруулга зай; 2. ташуу эргэлт, хэлтийж эргэх.
ВИРТУО́З 1. дадамгай жүжигчин, гарамгай жүжигчин; 2. мэргэжсэн ажилтан.
ВИРТУО́ЗНЫЙ дадамгай мэргэжсэн.
ВИ́РУС, вирус, хоруу *(халдварт өвчний нян)*.
ВИ́СЕЛИЦА цаазын дүүжлүүр.
ВИСЕ́ТЬ 1. өлгөөтэй байх, дүүжлээтэй байх, зүүлттэй байх, унжих; **картина висит** зураг өлгөөтэй байна; **лампа висит над столом** ламп ширээн дээр унжиж байна; 2. элбэгдэх, хэлхийх; **платье висит на ней** тэрлэг нь элбэгдэж байна; 3. өнгийх; **скала висит над дорогой** зам дээгүүр хад өнгийж байна; 4. тусах, учрах, тулгарах; **над ними висит опасность** тэдэнд аюул учрах гэж байна; *** ~ на волоске** дээсэн дөрөөтэй; **~ в воздухе** тэнгэрт хөвөх, яаж ч мэдэхээр; **висит на шее** тээр болох.
ВИСКО́ЗА 1. вискоз, зуурмаг; 2. дууриамал торго, торгонцор.
ВИСЛОУ́ХИЙ дэлдэн чихтэй, дэлдэн.
ВИ́СМУТ висмут, ягаанжин.
ВИ́СНУТЬ унжих, орооцолдох.
ВИСО́К чамархай, санчиг.
ВИСОКО́СНЫЙ ~ год өндөр жил *(хоёрдугаар сар нь хорин есөн хоногтой)*.
ВИСО́ЧН||ЫЙ чамархайн, санчгийн; **~ая доля** чамархайн хэсэг; **~ая кость** чамархайн яс.
ВИСЮ́ЛЬКА молцог, унжлага.
ВИСЯ́ЧИЙ өлгөх, өлгүүр, дүүжин; **~ замок** өлгүүр цоож; **~ мост** дүүжин гүүр.
ВИТАЛИ́ЗМ амьдралын ёс.
ВИТАМИ́Н аминдэм *(амьдралын чухал бодис)*.
ВИТАМИ́НН||ЫЙ аминдэмийн; **~ая недостаточность** витамины дутагдал; **~ые корма** витаминт тэжээл.
ВИТА́ТЬ хөвөлзөх, санаархах; **~ в облаках** санашгүй юманд санаархах, хоосон бодолд автагдах.
ВИТИЕВА́ТО гоёмсоглож, хөвөлдүүлэн, эздрэнгэ.
ВИТИЕВА́ТЫЙ гоёмсоглон, орооцолдсон, хөвөлдсөн; **~ стиль** хөвөлдсөн найруулга.
ВИТ||О́Й мушгимал, томсон, эрчилсэн; **~ая колонна** мушгимал багана.
ВИТО́К эргүүлэг, мушгирал, эргэц.
ВИТРИ́НА үзмэрийн цонх, дэлгэц, дэлгээс.
ВИТЬ 1. томох, гөрөх; **~ верёвку** дээс томох; 2. засах, хийх; **~ гнездо** үүр засах.
ВИ́ТЬСЯ 1. буржийх; **волосы вьются** үс буржийна; 2. хуйлрах, мушгирах, эргэлдэх; **пыль вьётся** тоос хуйларч байна.
ВИ́ТЯЗЬ баатар, хөлөг баатар.
ВИХЛЯ́ТЬ майжигнах, яйжигнах.
ВИХО́Р хөхөл, өрвөлгө, өрвийсэн үс.
ВИ́ХРЕМ хуйлран, мушгиран.
ВИХРЬ *хуй салхи, шуурга*.
ВИ́ЦЕ- ... дэд; **~президент** дэд ерөнхийлөгч.
ВИЧ *(вирус иммунодефицита человека)* дархлал хомсдолын нян.
ВИШНЁВЫЙ интоорын.
ВИ́ШНЯ *интоор*.
ВИШЬ! хараач гэм! ээ! **~ ты какой!** ээ чи ийм бий.
ВКА́ПЫВАНИЕ зоох.
ВКА́ПЫВАТЬ зоох, суулгах.
ВКАТИ́ТЬ өнхрүүлэн оруулах; **~ бочку в погреб** торхыг зооръ өнхрүүлэн оруулах.
ВКАТИ́ТЬСЯ өнхрөн орох, бөмбөрөн орох.
ВКА́ТЫВАТЬ өнхрүүлэн оруулах.
ВКЛАД 1. хадгалуулсан мөнгө; **сделать ~ в сберкассу** хадгаламжийн кассад мөнгө хадгалуулах; 2. нэмэр, нэмэр хандив; **сделать ~ в науку** шинжлэх ухаанд нэмэр оруулах.
ВКЛА́ДКА хавчуулга.
ВКЛА́ДЧИК-ДО́НОР хандивлагч.
ВКЛА́ДЫВАНИЕ хавчуулах, хадгалах, нийлүүлэх.
ВКЛА́ДЫВАТЬ хадгалах, хавчуулах, нийлүүлэх.
ВКЛА́ДЫШ 1. хавчуулга, хавчуулсан хуудас; 2. жан.
ВКЛЕ́ИВАТЬ наах, наалдуулах, хавчуулж наах.
ВКЛЕ́ЙКА наалт хавсаргах, наалт.
ВКЛИ́НИВАТЬ шаантаглан шаах, шааж оруулах.
ВКЛИ́НИТЬСЯ 1. шаантаглан орох, хавчуулагдан орох; 2. *цөмрөн орох*, хушууран орох.
ВКЛЮЧА́ТЬ 1. багтаах, оруулах; 2. асаах, ноцоох, залгах.
ВКЛЮЧА́ТЬСЯ 1. багтах, оролцох, орох; 2. асах, ноцох, залгагдах.
ВКЛЮЧА́Я оролцуулаад, багтаан.
ВКЛЮЧЕ́НИЕ 1. оруулах, багтаах; 2. залгах, ноцоох.
ВКЛЮЧИ́ТЕЛЬНО оролцуулаад, тоололцоод; **по десятое число ~** аравны өдрийг оролцуулаад.
ВКЛЮЧИ́ТЬ 1. багтаах, оруулах; **~ в список** цэсэнд оруулах; 2. асаах, ноцоох, залгах; **~ свет** цахилгаан гэрэл залгах.
ВКЛЮЧИ́ТЬСЯ 1. багтах, оролцох, орох; **~ в соревнование** уралдаанд оролцох; 2. асах, ноцох, залгагдах.
ВКОЛА́ЧИВАНИЕ хадах, шаах.
ВКОЛА́ЧИВАТЬ хадах, шаах, зоох.
ВКОЛОТИ́ТЬ хадах, шаах, зоох; **~ в стену гвоздь** туурганд хадаас шаах.
ВКОЛО́ТЬ хатгах, сүлбэх.
ВКОНЕ́Ц дуустал, бүрмөсөн, бүүр; **~ измучился** бүүр ядарчлаа.
ВКО́ПАННЫЙ зоомол, зоогдсон, хадагдсан; **он стоит как ~** тэр зоомол юм шиг зогсож байна.
ВКОПА́ТЬ зоох, шаах, суулгах.
ВКОРЕНИ́ТЬ шингээх, заншуулах, бэхжүүлэх.
ВКОРЕНИ́ТЬСЯ шингэх, занших.
ВКОСЬ буруу, ташаа, сөөлжүү, муруй; **~ и вкривь** буруу зөрүү, эндүү ташаа.
ВКРА́ДЧИВОСТЬ 1. зулгуй; 2. гэтэх.
ВКРА́ДЧИВЫЙ 1. зулгуй; 2. гэтүүр.
ВКРА́ДЫВАТЬСЯ 1. зулгуйдах; 2. гэтэж орох, сэм орох, мэдэгдэлгүй орох.
ВКРА́СТЬСЯ 1. зулгуйдах; 2. гэтэж орох, сэм орох, мэдэгдэлгүй орох; **вкрался в доверие** зулгуйдан итгэгдэх; 2. гэтэж орох, сэм орох, мэдэгдэлгүй орох; **вкралась ошибка** алдаа мэдэгдэлгүй оржээ.
ВКРА́ТЦЕ товч, товчхон; **~ изложить содержание книги** номын агуулгыг товчлон хэлэх.

ВКРИВЬ ташаа, мушгиу, муруй, сарий; **буквы шли ~ и вкось** үсгүүд нь муруй сарий байлаа.
ВКРУГ эргэн тойрон.
ВКРУТУ́Ю аргатал, аргуухан; **сварить яйцо ~** өндөг аргатал чанах.
ВКУ́ПЕ цугтаа, хамт.
ВКУС амт, амтших; **приятный на ~** аятайхан амттай; **войти во ~** амтших, амтанд орох; **~ воды** усны амт; **вяжущий ~** ахуун амт, хөхүүн амт; **кислый ~** эсгэлэн амт; **сладкий ~** чихэрлэг амт; **солёный ~** шорвог амт; * **одеваться со ~ом** аятайхан хувцаслах; **тонкий ~** юмыг нарийн мэддэг.
ВКУСИ́ТЬ амтлах, амтших.
ВКУ́СНЫЙ амттай, амтлаг.
ВКУСОВ||О́Й ааг амтны, амтлаг, амт; **~ая адаптация** амтанд дасах; **~ое качество пищи** хүнсний амтлаг чанар; **~ое восприятие** амт мэдрэхүй; **~ анализатор** амт задлуур..
ВКУША́ТЬ амтлах, амтших.
ВЛА́ГА чийг, нойт; **~ грунтовая** хөрсний чийг.
ВЛАГА́ЛИЩЕ үтрээ, умсаг.
ВЛАГА́ЛИЩН||ЫЙ үтрээний; **~ая полость** үтрээний хөндий; **~ое зеркало** үтрээний толь; **влагалищное исследование** үтрээний үзлэг.
ВЛАГОМЕ́Р чийг хэмжүүр.
ВЛАГООБМЕ́Н чийг солилцоо.
ВЛАДЕ́ЛЕЦ эзэн, юмны эзэн; **~ счёта** харилцагч.
ВЛАДЕ́НИЕ 1. эзэмшихүүн, эзлүүр, эзэмших газар, харъяат газар; 2. өмч хөрөнгө.
ВЛАДЕ́ТЕЛЬ эзэн, засаг ноён.
ВЛАДЕ́ТЕЛЬНЫЙ засаг, харъяат бүхий.
ВЛАДЕ́ТЬ 1. эзэмших, эрхлэх; 2. эзэмшиж чадах, хэрэглэж сурах; **~ инструментом** багаж хэрэглэж сурах; 3. мэдэх, сайн мэдэх; **~ русским языком** орос хэл сайн мэдэх.
ВЛАДЫ́КА эзэн; **~ солнца** *фольк.* арван хоёрын эзэн.
ВЛАДЫ́ЧЕСТВО эзэрхэх, эрхшээл.
ВЛАДЫ́ЧЕСТВОВАТЬ эзэрхэх, захирах.
ВЛА́ЖНОСТЬ чийг, нойтон, чийгшил; **~ воздуха** агаарын чийг; **~ зерна** үр тарианы чийг; **~ почвы** хөрсний чийгшил.
ВЛА́ЖН||ЫЙ чийгтэй, нойтон; **~ая повязка** чийгтэй боолт.
ВЛА́МЫВАТЬСЯ дайран орох, түрж орох; **~ в амбицию** шаралхах.
ВЛА́СТВОВАТЬ захирах, ноёлох.
ВЛА́СТНЫЙ 1. эзэрхэг, ноёрхог, захирамтгай; 2. эрх мэдэл; **я не властен это сделать** би үүнийг хийх эрх мэдэлгүй билээ.
ВЛАСТЬ 1. засаг, засаг захиргаа; **Советская ~** Зөвлөлт засаг; 2. эрх мэдэл, мэдэл; **превышение власти** эрх мэдлийг хэтрүүлэх; **это вне его власти** энэ түүний мэдлээс хэтэрсэн хэрэг; **употребить ~** эрх хүчийг хэрэглэх.
ВЛАЧИ́ТЬ 1. ядах, зүдэх; 2. чирэх; **~ жалкое существование** амь улжих, ядаж аж төрөх, амь зогоох, өлөн живэр аж төрөх.
ВЛЕ́ВО зүүн тийш, зүүн гар тийш.
ВЛЕЗА́ТЬ 1. авирах, асах, дээр нь гарах; **~ на дерево** модонд авирах; 2. багтаж орох, шургах; **~ в окно** цонхоор шургах.
ВЛЕПИ́ТЬ шигтгэх, тусгах; * **~ пощёчину** алганы амт үзүүлэх.
ВЛЕТА́ТЬ 1. нисэж орох, гүйж орох; 2. өртөгдөх, аашлуулах; **шалуну влетело** дүрсгүй жаал аашлуулав.
ВЛЕЧЕ́НИЕ хүсэл, дур.
ВЛЕЧ||Ь 1. чирэх, чангаах; 2. дуртай болох, татагдах; **его ~ёт к искусству** түүний сэтгэл урлагт татагдана; 3. уршиг гаргах.
ВЛИВА́НИЕ юүлэх, тарих, хийх; **подкожное ~** арьс махны завсраар тарих.
ВЛИВА́ТЬ 1. цутгах, юүлэх, дүүргэх; 2. нэмж оруулах; 3. оруулах, нэмэгдүүлэх.
ВЛИВА́ТЬСЯ 1. цутган урсах, юүлэх, дүүрэх; 2. нэмэгдэх, нэмэх.
ВЛИ́ТЬ 1. цутгах, юүлэх, дүүргэх; 2. нэмж оруулах.
ВЛИ́ТЬСЯ 1. цутган урсах, юүлэх, дүүрэх; **вода влилась в канал** ус сувагт цутган урсав; 2. нэмэгдэх, нэмэх.
ВЛИЯ́НИ||Е нөлөө, эрхшээл; **под ~ем этого** үүний нөлөөгөөр, үүнээс болж.
ВЛИЯ́ТЕЛЬНЫЙ нөлөөтэй.
ВЛИЯ́ТЬ нөлөөлөх.
ВЛКСМ *(Всесоюзный Ленинский Коммунистический Союз Молодёжи)* Бүх Холбоотын Лениний Коммунист Залуучуудын Эвлэл.
ВЛОЖЕ́НИ||Е оруулалт, оруулах, хавсралт; **капитальное ~ в строительство** барилгад хөрөнгө оруулалт; **письмо с ~ем** хавсралттай захиа.
ВЛОЖИ́ТЬ 1. агуулах, хийх; **~ письмо в конверт** захиа дугтуйд хийх; 2. зориулах, оруулах, зарцуулах; 3. хандуулах; **~ всю душу в любимое дело** бүх сэтгэлээ дуртай хэрэгтээ хандуулах.
ВЛОМИ́ТЬСЯ түрж орох, давшлан орох.
ВЛЮБИ́ТЬ дурлуулах, биедээ татах.
ВЛЮБИ́ТЬСЯ дурлах, янаг болох, сэтгэлтэй болох.
ВЛЮБЛЁННОСТЬ дурлал, янаг, амраг.
ВЛЮБЛЁННЫЙ янаг амраг, дурласан, дуртай.
ВЛЮБЛЯ́ТЬ дурлуулах.
ВЛЮБЛЯ́ТЬСЯ дурлах, янаглах, сэтгэлтэй болох.
ВМА́ЗАТЬ шигтгэж шавах, шигтгэж наах.
ВМЕНИ́ТЬ гэж үзэх, тооцох, оноох.
ВМЕНЯ́ЕМОСТЬ эрүүл эсэн, мэдрэл эрүүл, эрүүл ухаантай.
ВМЕНЯ́ЕМЫЙ эрүүл эсэн, мэдрэл бүтэн, хэргийн хариуцлага хүлээх чадвартай.
ВМЕНЯ́ТЬСЯ даалгагдах, тооцогдох; **это вменяется ему в заслугу** түүний гавьяа гэж энэ тооцогдоно.
ВМЕ́РУ тааруу, хирийн дотор.
ВМЕ́СТЕ 1. хамт, цуг; **жить ~** хамт амьдрах; 2. хамт, зэрэгцээгээр; **~ с тем** түүний зэрэгцээгээр.
ВМЕСТИ́ЛИЩЕ сав, багтаах газар.
ВМЕСТИ́МОСТЬ багтац, багтаамж, зай.
ВМЕСТИ́ТЕЛЬНЫЙ багтаамжтай, зайтай; **~ зал** багтаамжтай танхим.
ВМЕСТИ́||ТЬ 1. багтаах, багтах; **зал не ~л всех слушателей** бүх сонсогчид танхимд багтсангүй; 2. хийх, багтаах; **~ все книги в шкаф** шүүгээнд бүх номыг хийх.
ВМЕСТИ́ТЬСЯ багтах.
ВМЕ́СТО оронд, төлөөнөө; **взять одну книгу ~ другой** нэг номын оронд нөгөөг авах.
ВМЕТА́ТЬ шидэх, шидэж оёх; **~ рукав** ханцуй тааруулж шидэх.
ВМЕША́ТЕЛЬСТВО оролцох, оролцогоо; **хирургическое ~** мэс заслын оролцогоо.
ВМЕША́ТЬ 1. холих; 2. оролцуулах, холбогдуулах.
ВМЕША́ТЬСЯ 1. холилдох; 2. оролцох, хамаарах.
ВМЕЩА́ТЬ багтаах.
ВМЕЩА́ТЬСЯ багтах.
ВМИГ нүд ирмэхийн завсар, агшин зуур, хоромхон зуур.
ВМЯ́ТИНА хонхорхой.
ВМЯТЬ хонхойлох.
ВНАЁМ хөлсөөр, хөлсөлж; **сдавать ~** хөлслөх; **взять ~** хөлсөөр авах.
ВНАКИ́ДКУ эгэлдрэх, нөмрөх, хэдрэх; **носить куртку ~** хүрмээ эгэлдрэх.
ВНАКЛА́ДКУ саахартай; **пить чай ~** саахартай цай уух.

ВНАЧА́ЛЕ эхэнд, анханд, түрүүнд.
ВНЕ 1. гадна, гадуур; ~ **города** хотын гадна; ~ **плана** төлөвлөгөөнөөс гадуур; 2. гүй; ~ **очереди** дугааргүй, оочиргүй; ~ **сомнения** эргэлзээгүй; * ~ **закона** хуулинд харш, хуулинд хамаагүй; **быть** ~ **себя** байж ядах, тачаадах.
ВНЕБРА́ЧНЫЙ бутач, хоноцын, гэр бүлээс гадуур олсон; ~ **ребёнок** бутач хүүхэд.
ВНЕДРЕ́НИЕ нэвтрэх, нэвтрүүлэх.
ВНЕДРИ́ТЬ нэвтрүүлэх; ~ **в практику достижения науки** шинжлэх ухааны ололтыг амьдралд нэвтрүүлэх.
ВНЕДРИ́ТЬСЯ нэвтрэх.
ВНЕЗА́ПНО гэнэт, гэнэт, цочмог.
ВНЕЗА́ПНОСТЬ гэнэт, цочмог.
ВНЕЗА́ПНЫЙ гэнэт, цочмог.
ВНЕКЛА́ССНЫЙ хичээлээс гадуур, сургуулиас гадуур.
ВНЕКЛА́ССОВ||ЫЙ ангийн гаднах, ангигүй; **~ая точка зрения** ангиас гаднах үзэл.
ВНЕКЛЕ́ТОЧНЫЙ эсийн гаднах.
ВНЕМА́ТОЧН||ЫЙ умайн гаднах, савны гадуур; **~ая беременность** савны гадуур хүүхэд олох.
ВНЕОЧЕРЕДНО́Й эзлэгүй, эзлэжит бус, онцын.
ВНЕПАРТИ́ЙНЫЙ намын гаднах.
ВНЕПЛА́НОВЫЙ төлөвлөгөөнөөс гадуур.
ВНЕСЕ́НИЕ 1. оруулах, тэмдэглэх; ~ **в протокол** тогтоолд оруулах; ~ **в список** дансанд оруулах; 2. хураалгах; ~ **платы** төлбөрийг хураалгах.
ВНЕСЛУЖЕ́БНЫЙ албан бус, албанаас гадуур.
ВНЕСТИ́ 1. оруулах; ~ **вещи в дом** юм гэртээ оруулах; 2. төлөх, хураалгах, тушаах; ~ **деньги в кассу** мөнгө кассад хураалгах; 3. гаргах, оруулах, илэрхийлэх; ~ **предложение** санал гаргах, санал оруулах; 4. нэмэх, нэмж оруулах; ~ **в список** жагсаалтад нэмж оруулах.
ВНЕУТРО́БНЫЙ хэвлийн гадна.
ВНЕШКО́ЛЬНЫЙ сургуулиас гадуур.
ВНЕ́ШНЕ гаднаа, өнгөндөө.
ВНЕШНЕПОЛИТИ́ЧЕСКИЙ гадаад бодлогын.
ВНЕШНЕТОРГО́ВЫЙ гадаад худалдааны.
ВНЕ́ШН||ИЙ 1. гадаад; **~яя среда** гадаад орчин; **~яя торговля** гадаад худалдаа; **Внешняя Монголия** Гадаад Монгол; 2. гаднах; 3. өнгөндөө, наагуураа; **~ее спокойствие** өнгөндөө амгалан.
ВНЕ́ШНОСТЬ гадаад байдал, царайтай; **красивая** ~ сайхан царайтай.
ВНЕШТА́ТНЫЙ орон тооноос гадуур, орон тооны бус.
ВНИЗ доош, доошоо, уруу, уруудаж; ~ **по течению** гол уруудаж.
ВНИЗУ́ 1. дор; ~ **у подножия горы видны дома** дор, уулын бэлд байшингууд харагдана; 2. доод талд, адагт; ~ **письма стояла дата** захидлын доод талд өдөрлөл байлаа.
ВНИКА́ТЬ нарийвчлан хянах, нягтлах, сайтар мэдэх.
ВНИМА́НИ||Е анхаарах, анхаарал; **обращать** ~ анхаарал тавих; **достойный ~я** анхаарвал зохих; **привлекать** ~ анхаарал татах.
ВНИМА́ТЕЛЬНО анхааралтай.
ВНИМА́ТЕЛЬНОСТЬ анхаарал, болгоомж.
ВНИМА́ТЕЛЬНЫЙ 1. анхааралтай, хичээлтэй; 2. халамжтай, хайхрамжтай.
ВНИМА́||ТЬ анхаарах, сонсох, хайхрах; **слушай и ~й!** аан гээд уун гэж бай!
ВНИЧЬЮ́ хайнцах, тэнцэх, хожилгүй болох.
ВНОВЬ 1. дахиж, дахин; **увидеться** ~ дахин уулзах; 2. шинээр, саяхан; ~ **прибывший** саяхан ирсэн.
ВНОСИ́ТЬ оруулах, хураалгах; ~ **в протокол** тогтоолд оруулах; ~ **свой членский взнос** гишүүнийхээ татварыг хураалгах.
ВНОСИ́ТЬСЯ орох, оруулагдах.
ВНУК ач хүү, зээ хүү; **сын сына** ач хүү; **сын дочери** зээ хүү.
ВНУ́ТРЕНН||ИЙ 1. доторх; **~яя обстановка дома** гэрийн доторхи хогшил; **~ее повреждение** доторх гэмтэл; 2. дотоод; **~яя торговля** дотоод худалдаа; **~яя политика** дотоод бодлого; 3. дотрын, дотор; **~яя болезнь** дотрын өвчин.
ВНУ́ТРЕННОСТИ гэдэс дотор.
ВНУ́ТРЕННОСТЬ доторх байдал, доторх хогшил, дотор байгаа юм.
ВНУТРИ́ дотор, доторх, дотоод, дунд; ~ **города** хотын дотор.
ВНУТРИМА́ТОЧН||ЫЙ савны доторхи, савны; **~ое вливание** саванд юүлэх.
ВНУТРИПАРТИ́ЙНЫЙ намын дотоод.
ВНУТРИСОСУ́ДИСТЫЙ судас доторхи.
ВНУТРИУТРО́БН||ЫЙ эх доторхи, савны доторхи; **~ая асфиксия** эх дотроо бүтэх.
ВНУТРИЧЕРЕПН||О́Й гавлын доторхи; **~ое давление** гавлын даралт.
ВНУТРЬ дотор, дотогш нь, уруу; **войти** ~ **дома** байшингийн дотор орох; * **принять лекарство** ~ эм уух.
ВНУЧА́ТА ач нар, зээ нар.
ВНУ́ЧКА ач охин, зээ охин; **дочь сына** ач охин; **дочь дочери** зээ охин.
ВНУША́ТЬ ятгах, ойлгуулах, итгүүлэх.
ВНУШЕ́НИЕ ятгах, ойлгуулах, итгүүлэх.
ВНУШИ́ТЕЛЬН||ЫЙ бишрэм, сүрлэг, их, бараа сүрээ ихтэй; ~ **вид** сүрлэг байдал; **~ых размеров** их хэмжээний.
ВНУШИ́ТЬ ятгах, ойлгуулах, итгүүлэх.
ВНЯ́ТНОСТЬ тод, ойлгомжтой.
ВНЯ́ТНЫЙ тод, ойлгомжтой.
ВНЯТЬ дуулах, сонсох, хайхрах.
ВО ~ **время** цаг тухайд; ~ **весь рост** бүх хэмжээгээрээ, бүхэл бүтэн биеэрээ; ~ **имя** төлөө,тусын тул; ~ **главе** тэргүүнтэй, толгойлуулан.
ВО́БЛА башинга загас.
ВОБРА́ТЬ сорох, балгах, шингээж авах.
ВОВЕ́К үүрд, ашид, хэзээд.
ВОВЕ́КИ үүрд, ашид, хэзээд; **во веки веков** үүрд мөнх.
ВОВЛЕКА́ТЬ элсүүлэх, хамаарууллах, татан оруулах.
ВОВЛЕЧЕ́НИЕ элсүүлэх, хамаруулах,татан оруулах.
ВО́ВРЕМЯ цаг тухайд, зохих цагт нь, цагаа олж, яг цагтаа.
ВО́ВСЕ ердөө, бүрмөсөн, огт; ~ **нет** огтгүй; ~ **не нужно** ердөө хэрэггүй.
ВОВСЮ́ хамаг чадлаараа; **жатва идёт** ~ хамаг чадлаараа хадаж байна.
ВО-ВТОРЫ́Х хоёрдугаарт.
ВОГНА́ТЬ 1. тууж оруулах, хөөж оруулах; 2. оруулах, шаах, хатгах; ~ **под ноготь занозу** хумсны завсраар өргөс шаачхах; * ~ **в гроб** үхтэл нь зовоох, тарчилгах; ~ **в краску** улайлгах, ичээх.
ВО́ГНУТ||ЫЙ хотойсон, хотгор, хүнхэр, матгар; **~ое зеркало** хотгор толь, хүнхэр толь; **~ая линза** хүнхэр мэшил.
ВОД||А́ ус; **проточная** ~ урсгал ус; **стоячая** ~ тогтмол ус; **питьевая** ~ амны ус, ундны ус; ~ **пресная** цэнгэг ус; ~ **речная** голын ус; ~ **солёная** давслаг ус; ~ **сточная** хаягдал ус; **морская** ~ далайн шорвог ус; **минеральная** ~ рашаан ус; ~ **горячая** халуун ус; ~ **грунтовая** ул хөрсний чөлөөт гадаргатай ус; ~ **неочищенная** цэвэрлэгдээгүй ус; ~ **в порах** сүв дэх ус; ~ **околоплодная** ургийн ус; * **много ~ы утекло** их

удлаа; **толочь ~у в ступе, черпать воду решетом, носить ~у в решете** ёроолгүй хувингаар ус зөөх мэт, ёроолгүй хувингаар ус авах; **концы в ~у** сумаа харваад нумаа нуух; **их ~ой не разольёшь** салшгүй найз, сааршгүй зангилаа; **как в ~у кануть** далайд хаясан чулуу шиг, сураггүй алга болох; **чувствовать себя как рыба в ~е** усанд байгаа загас шиг дураараа байх; **вывести на чистую ~у** хар цагааныг ялгах; **выйти сухим из ~ы** уснаас хуурай гарах мэт, гэмээ хийгээд зэмээ хүлээхгүй; **быть тише ~ы, ниже травы** хониноос номхон, өвснөөс намхан явах; **как две капли ~ы** усны хоёр дусал шиг, ав адил, ив ижил; **пройти сквозь огонь и ~у** хал үзэж халуун чулуу долоох.

ВОДВОРЕ́НИЕ 1. байрлуулах, төвхнүүлэх, тогтоох; 2. тогтох, болгох.

ВОДВОРИ́ТЬ 1. байрлуулах, төвхнүүлэх; 2. тогтоох, болгох.

ВОДВОРИ́ТЬСЯ 1. байрлах, төвхнөх; 2. тогтох.

ВОДЕВИ́ЛЬ 1. алиа дуурь, инээдтэй ший; 2. дууны наадал.

ВОДИ́ЛА жолооч, машины эзэн, таксины жолооч.

ВОДИ́ТЕЛЬ жолооч.

ВОДИ́ТЕЛЬСТВО жолоодлого.

ВОДИ́ТЬ 1. дагуулах, хөтлөх; ~ **детей гулять** хүүхэд дагуулан зугаалах; 2. жолоодох; ~ **трамвай** трамвай жолоодох; 3. удирдах; 4. заах; ~ **карандашом по карте** зураг дээгүүр харандаагаар заах; 5. харьцаа тогтоох; ~ **знакомство** танилын харьцаа тогтоох; * ~ **за нос** толгой эргүүлэх, залилах.

ВОДИ́ТЬСЯ 1. байх, бий; **в лесах водятся медведи** ойд баавгай байдаг; 2. нөхөрлөх, явах, явалцах; **скажи мне, с кем ты водишься** хэнтэй явдгаа хэл; * **как водится** заншлаараа.

ВО́ДКА крепкая ~ хатуу архи; ~ **молочная двойной перегонки** арз; ~ **молочная тройной перегонки** хорз.

ВО́ДН||ЫЙ усан, устай; ~ **транспорт** усан тээвэр; **~ая растительность** усны ургамал; **~ое законодательство** усны хууль тогтоомж; **~ое хозяйство** усны аж ахуй; **~ые ресурсы** усны нөөц; **~о-солевой обмен** ус эрдсийн солилцоо; ~ **режим** усны горим.

ВОДОБОЯ́ЗНЬ уснаас айх өвчин.

ВОДОВО́Д ус дамжуулагч.

ВОДОВО́З усчин, ус зөөгч.

ВОДОВО́ЗН||ЫЙ усчны, ус зөөх; **~ая бочка** ус зөөх ган.

ВОДОВОРО́Т усны эргүүлэг, усны ойл, эргэц.

ВОДОЁМ усны сав газар, усны уурхай, усан сан.

ВОДОИЗМЕРИ́ТЕЛЬНЫЙ ус хэмжих.

ВОДОИЗМЕЩЕ́НИ||Е усан түрц; **пароход ~ем в тысячу тонн** мянган тонн усан түрцтэй галт онгоц.

ВОДОЗАБО́Р ус татаж хураах байгууламж.

ВОДОКА́ЧКА усан бүлүүр, өндөр худаг, бүлүүртэй худаг.

ВОДОЛА́З шумбагч.

ВОДОЛА́ЗНЫЙ шумбах, шумбалтын.

ВОДОЛЕ́Й хумх

ВОДОЛЕЧЕ́НИЕ усан засал, рашаан эмнэлэг.

ВОДОЛЕЧЕ́БНИЦА рашаан эмнэлэг, рашаан эмнэлгийн газар.

ВОДОМЕ́Р усны хэмжүүр, тоолуур.

ВОДОМЕ́РНЫЙ ус хэмжүүрийн; ~ **пост** усны харуул.

ВОДОНАПО́РН||ЫЙ бүлүүрийн, бүлүүрт худгийн, ус түрэх; **~ая башня** ус түрэх цамхаг.

ВОДОНЕПРОНИЦА́ЕМОСТЬ ус үл нэвтрүүлэх чанар.

ВОДОНЕПРОНИЦА́ЕМЫЙ нэвтрэхгүй, ус даах.

ВОДОНО́СНОСТЬ ус агууламж, усжилт.

ВОДОНО́СНЫЙ устай, усархаг, усан судалтай; ~ **слой земли** газрын усан судалтай давхарга.

ВОДООБЕСПЕЧЕ́НИЕ ус хангалт.

ВОДООБЕСПЕ́ЧЕННОСТЬ усаар хангасан байдал.

ВОДООТВО́Д ус зайлуулалт.

ВОДООТВО́ДН||ЫЙ зайлуулал; **~ая линия** ус зайлуулах шугам.

ВОДООХРА́НН||ЫЙ ус хамгаалалт; **~ая зона** ус хамгаалалтын бүс.

ВОДООЧИСТИ́ТЕЛЬНЫЙ ус цэвэрлэх, ус цэвэрлүүрийн.

ВОДООЧИ́СТКА ус цэвэрлэх.

ВОДОПА́Д усан хүрхрээ, хөрхрөө.

ВОДОПЛА́ВАЮЩ||ИЙ усанд самардаг, усны; **~ие птицы** усны шувууд.

ВОДОПОТРЕБЛЕ́НИЕ усны хэрэглээ.

ВОДОПОТРЕ́БНОСТЬ усны хэрэгцээ.

ВОДОПО́Й услуур, мал услах газар.

ВОДОПРОВО́Д ус түгээгүүр, усан хоолой.

ВОДОПРОВО́ДЧИК усан түгээлийн ажилтан.

ВОДОПРОНИЦА́ЕМЫЙ ус нэвтрэх.

ВОДОРАЗДЕ́Л усны хагалбар.

ВОДОРО́Д устөрөгч, гидроген.

ВОДОРО́ДНЫЙ устөрөгчийн; ~ **показатель** устөрөгчийн илтгэгч.

ВО́ДОРОСЛ||Ь замаг, хиг, хигдэр; **зелёные ~и** ногоон замаг; **~и кораллиновые** үрэн замаг.

ВОДОСБО́Р 1. ус цуглуулах сав газар; 2. *бот.* удвал.

ВОДОСБО́РНЫЙ ус цуглуулах; ~ **бассейн** ус хураах сав газар.

ВОДОСНАБЖЕ́НИЕ усаар хангах, усан хангамж.

ВОДОСПУ́СК гоожуур, цорго.

ВОДОСТО́ЙКИЙ усанд тэсвэртэй.

ВОДОСТО́К ус урсгуур.

ВОДОСТО́ЧН||ЫЙ усны, ус урсгуурын; **~ая труба** ус урсгуурын хоолой.

ВОДОСЧЁТЧИК ус хэмжүүр.

ВОДОУПО́Р ус үл нэвтрүүлэгч чулуулаг.

ВОДОУПО́РНЫЙ ус даах, ус нэвтрэхгүй.

ВОДОХРАНИ́ЛИЩЕ хиймэл усан сан, ус хураах газар, цөөрөм, цунхээл.

ВО́ДОЧНЫЙ архины.

ВОДРУЖА́ТЬ мандуулах, хатгах, босгох.

ВОДРУЖЕ́НИЕ босгох, хатгах, зоох, мандуулах.

ВО́ДЫ 1. рашаан ус; 2. тунадас; ~ **атмосферные** хур тунадас; 3. ус; ~ **бытовые сточные** ахуйн хаягдал ус; ~ **грунтовые** ул хөрсний ус.

ВОДЯНИ́СТЫЙ усавхи, услаг, усархаг.

ВОДЯ́НКА усан хаван; ~ **беременных** жирэмсний усан хаван.

ВОДЯ́НИК ямаан арц.

ВОДЯН||О́Й 1. лус; 2. усан, усны; **~ое растение** усны ургамал; * ~ **знак** далд хээ.

ВОЕВА́ТЬ 1. дайтах, байлдах; 2. тулалдах, маргалдах.

ВОЕВО́ДА мужийн цэргийн ноён, мужийн ноён.

ВОЕВО́ДСТВО 1. мужийн ноёны хэргэм; 2. муж.

ВОЕДИ́НО хамт, цуг, нэг дор; **собрать всех** ~ булты нь нэг дор цуглуулах.

ВОЕНАЧА́ЛЬНИК цэргийн тэргүүн, жанжин.

ВОЕНИЗА́ЦИЯ цэрэгжих, цэрэгжүүлэх.

ВОЕНИЗИ́РОВАТЬ цэрэгжүүлэх.

ВОЕНИЗИ́РОВАТЬСЯ цэрэгжих.

ВОЕНКО́М цэргийн комиссар; **военно-политический комиссар** цэргийн улс төрийн комиссар.

ВОЕНКОМА́Т цэргийн комиссариат, цэргийн яам.

ВОЕНКО́Р цэргийн сурвалжлагч.

ВОЕ́ННО-ВОЗДУ́ШН||ЫЙ, агаарын цэргийн; **~ые силы** цэргийн нисэх хүчин.

ВОЕ́ННО-МОРСКО́Й усан цэргийн.
ВОЕННООБЯ́ЗАННЫЙ цэргийн албаны, цэргийн бүртгэлтэй, цэргийн насны.
ВОЕННОПЛЕ́ННЫЙ *олзлогдсон* цэрэг.
ВОЕННО-ПОЛЕВ||О́Й цэргийн, хээрийн; ~ **суд** цэргийн хээрийн шүүх; **~ая хирургия** цэргийн хээрийн мэс засал.
ВОЕ́ННО-РЕВОЛЮЦИО́ННЫЙ хувьсгалт цэргийн.
ВОЕННОСЛУ́ЖАЩИЙ цэргийн албаны хүн.
ВОЕННОУЧЕ́БН||ЫЙ цэргийн сургуулийн; **~ое заведение** цэргийн сургууль.
ВОЕ́НН||ЫЙ 1. цэргийн, дайны; **~ое время** дайны цаг; **~ая служба** цэргийн алба; 2. цэрэг, цэргийн хүн.
ВОЕ́НЩИНА дайнчид.
ВОЖА́К 1. хушуу, удирдагч; 2. хөтлөгч, газарч; ~ **слепого** сохор хүний хөтлөгч; 3. түрүүч, дагуулагч; ~ **стада** сүргийн түрүүч.
ВОЖА́ТЫЙ 1. удирдагч; ~ **пионеров** пионерийн удирдагч; 2. жолоодогч; ~ **слона** зааны жолоодогч; 3. газарч.
ВОЖДЕЛЕ́НИЕ шунахайрал, хурьцал.
ВОЖДЕ́НИЕ жолоодох, жолоодлого.
ВОЖДЬ удирдагч, жолоодогч; ~ **партии** намын удирдагч.
ВО́ЖЖИ жолоо; **отпустить** ~ *жолоо сулруулах*, сахилга сулрах; **натянуть** ~ жолоо татах, сахилга чангалах; * **вожжа под хвост попала** адгаж алдах.
ВОЗ тэрэг, тээвэр, ачаа; ~ **дров** тэрэг түлээ; * **что с ~у упало, то пропало** гэсэн *юм гэдэргээ ирэхгүй*.
ВОЗБРАНИ́ТЬ цээрлэх, хориглох.
ВОЗБРАНЯ́ТЬСЯ цээртэй, хориотой; **не возбраняется** цээргүй, хориогүй.
ВОЗБУДИ́МОСТЬ хөөрөх, сэргэх, өдөгдөх.
ВОЗБУДИ́МЫЙ хөөрүү, өдөгдөх.
ВОЗБУДИ́ТЕЛЬ сэргээгүүр, өдөөгүүр, үүсгүүр; ~ **болезни** өвчин өдөөгүүр.
ВОЗБУДИ́ТЬ сэргээх, өдөөх, төрүүлэх.
ВОЗБУДИ́ТЬСЯ хөөрөх, өдөгдөх.
ВОЗБУЖДА́ТЬ сэргээх, өдөөх, төрүүлэх; ~ **вопрос** асуудал тавих; ~ **внимание** анхаарлыг татах; ~ **иск** зарга мэдүүлэх.
ВОЗБУЖДА́ЮЩ||ИЙ өдөөх, сэргээх; **~ее средство** сэргээх эм.
ВОЗБУЖДЕ́НИЕ 1. хөөрөл, өдөгдөх, сэрэх, сэргээх, сэрэл; ~ **деятельности сердца** зүрхний үйл ажиллагааг сэргээх; 2. цочрох, цочрол,
ВОЗБУЖДЕ́ННОСТЬ хөөрөх, өдөгдөх, сэргэх.
ВОЗБУЖДЕ́ННЫЙ хөөрсөн, өдөгдсөн, хөхүүн.
ВОЗВЕДЕ́НИЕ 1. босгох, барих, байгуулах; ~ **здания** барилга барих; 2. дэвшүүлэх, оруулах; ~ **в степень** зэрэгт дэвшүүлэх; 3. өргөдөх, өргөмжлөгдөх.
ВОЗВЕЛИ́ЧИВАТЬ өргөмжлөх, магтан мандуулах.
ВОЗВЕСТИ́ 1. босгох, байгуулах, барих; ~ **здание** барилга барих; 2. дэвшүүлэх; ~ **в степень** зэрэгт дэвшүүлэх; 3. өргөмжлөх; ~ **в графское достоинство** гүнгийн хэргэм өргөмжлөх; * ~ **в принцип** зарчим болгож өргөмжлөх.
ВОЗВЕСТИ́ТЬ мэдэгдэх, зарлах, тунхаглах.
ВОЗВЕЩА́ТЬСЯ зарлагдах, сонсдох.
ВОЗВОДИ́ТЬ 1. босгох, барих; 2. эхэлж бий болох, үүссэн гэж үзэх, үүсэх; **возникновение валунов возводят к ледниковому периоду** адуун чулууны гарал нь мөсөн галбын үеэс үүссэн ажээ.
ВОЗВОДИ́ТЬСЯ босгогдох, дэвшигдэх, өргөмжлөгдөх.
ВОЗВРА́Т 1. буцах, буцаах, гэдрэг, сөөрөг нь; 2. дахих; ~ **болезни** өвчин дахих.
ВОЗВРАТИ́ТЬ 1. буцаах, эгүүлэх, буцааж өгөх; ~ **книгу** номыг буцааж өгөх; 2. сэргээх, дахих; ~ **здоровье** дахиж эрүүл болох.
ВОЗВРАТИ́ТЬСЯ 1. буцаж ирэх, буцаж очих, харих, гэдрэг буцах; 2. сэргэх дахих, дахин тэнхрэх.
ВОЗВРА́ТН||ЫЙ дахих, дахисан, буцах; ~ **тиф** дахих хижиг; **~ая локтевая артерия** тохойн буцсан артери.
ВОЗВРАЩЕ́НИЕ 1. буцаж ирэх, харьж ирэх; ~ **из командировки** албан томилолтоос буцаж ирэх; 2. буцааж өгөх; ~ **денег** мөнгийг буцааж өгөх; 3. тэнхрэх, дахих.
ВОЗВЫ́СИТЬ 1. өргөмжлөх; 2. чангаруулах; ~ **голос** дуугаа чангаруулах.
ВОЗВЫ́СИТЬСЯ 1. товойх, гөвийх, сүндэрлэх; 2. дэвших, дээшлэх, хүндтэй болох.
ВОЗВЫША́ТЬСЯ 1. товойх, гөвийх, сүндэрлэх; 2. дэвших, дээшлэх, хүндтэй болох.
ВОЗВЫШЕ́НИЕ 1. дэвших, дээшлэх, дэвшилт; 2. өндөрлөг газар.
ВОЗВЫ́ШЕННОСТЬ 1. өндөр газар, өндөрлөг, гүдгэр газар; 2. эрхэм дээд, ариун санаа.
ВОЗВЫ́ШЕНН||ЫЙ 1. өндөр, тэгш өндөрлөг; **~ая местность** өндөрлөг газар; 2. эрхэм дээд, ариун сайхан; **~ая цель** эрхэм дээд зорилго.
ВОЗГЛА́ВИТЬ толгойлох, тэргүүлэх, манлайлах.
ВО́ЗГЛАС чанга авиа, дуун аялгуу, уухай; ~ **радости** баярын уухай.
ВОЗГЛАСИ́ТЬ өндөр дуугаар зарлах.
ВОЗГОРА́ТЬСЯ 1. *ноцох, асах, бадрах*; 2. дүрэлзэх, оргилох.
ВОЗГОРДИ́ТЬСЯ бардамнах.
ВОЗГОРЕ́ТЬСЯ 1. *ноцох, асах, бадрах*; **из искры возгорится пламя** очноос дөл бадарна; 2. дүрэлзэх, *оргилох*; ~ **желанием учиться** сурах хүсэл нь дүрэлзэх.
ВОЗДАВА́ТЬ ачлах, ач хариулах, хариулах, үнэлэх.
ВОЗДА́ТЬ ачлах, ач хариулах, хариулах, үнэлэх; ~ **по заслугам** зүтгэлий нь үнэлэх; ~ **добром за зло** хорыг тусаар хариулах.
ВОЗДВИГА́ТЬ босгох.
ВОЗДВИГА́ТЬСЯ байгуулагдах, босох.
ВОЗДВИ́ГНУТЬ босгох; ~ **памятник** дурсгалын хөшөө босгох.
ВОЗДВИ́ГНУТЬСЯ байгуулагдах, босох.
ВОЗДЕВА́ТЬ наманчлах, зангах.
ВОЗДЕ́ЙСТВИЕ үйлдэл үзүүлэх, нөлөөлөх, үйлчлэл.
ВОЗДЕ́ЙСТВОВАТЬ нөлөөлөх, үйлдэл үзүүлэх.
ВОЗДЕ́ЛАТЬ газар эдлэх, тариалах, тариалан үйлдэх.
ВОЗДЕ́ЛЫВАТЬСЯ эдлэгдэх, тариалагдах.
ВОЗДЕРЖА́ВШ||ИЙСЯ татгалзсан, түдгэлзсэн; **при голосовании ~ихся не было** *санал хураахад* түдгэлзсэн хүнгүй байв.
ВОЗДЕРЖА́НИЕ цээрлэх, тэвчих, түдгэлзэх.
ВОЗДЕ́РЖАННОСТЬ тэвчээр, биеэ барих, хирээ мэдэх.
ВОЗДЕ́РЖАННЫЙ тэвчилтэй, биеэ барьсан, даруу.
ВОЗДЕРЖА́||ТЬСЯ цээрлэх, царгалах, түдгэлзэх, биеэ барих; ~ **от курения** тамхи татахыг цээрлэх; **десять голосовало за, пятеро против, двое ~лось** арван хүн зөвшөөрч, таван хүн татгалзаж, хоёр хүн түдгэлзэв.
ВО́ЗДУХ агаар, агаарын хий; **свежий** ~ цэвэр агаар; * **выйти на** ~ салхинд гарах; **парить в ~е** агаарт халин нисэх.
ВОЗДУХООБМЕ́Н агаар солилцоо.
ВОЗДУХОПЛА́ВАНИЕ агаарт дэгдэх, агаарт хөөрөх.
ВОЗДУХОПЛА́ВАТЕЛЬНЫЙ агааралр дэгдэх.
ВОЗДУ́ШН||ЫЙ 1. агаарын; ~ **шар** агаарын бөмбөрцөг; **~ое сообщение** агаарын харилцаа; 2. сиймхий, сэмбэгэр; **~ое платье** сиймхий даашинз; * **~ые замки** тэнгэрийн харш,гандирсын балгас, хоосон санаа.
ВОЗЗВА́НИЕ уриа, тунхаг.
ВОЗЗРЕ́НИЕ үзэл.
ВОЗИ́ТЬ зөөх, тээх, чирэх.

ВОЗЙ||ТЬСЯ 1. ноололдох; **дети ~лись на полу** хүүхэд шалан дээр ноололдож байв; 2. зууралдах, мунгинах, нооролдох; **~ со сборами** төхөөрөх ажлаар зууралдах.
ВО́ЗКА, зөөх, тээх.
ВОЗЛАГА́ТЬ 1. тавих, өргөх; 2. даалгах, үүрүүлэх; **~ тяжёлую ответственность** хүнд хариуцлагыг даалгах.
ВОЗЛАГА́ТЬСЯ даалгагдах, үүрэх, тохогдох.
ВО́ЗЛЕ дэргэд, хажууд; **стоять ~** дэргэд зогсох.
ВОЗЛИКОВА́ТЬ баясах, бахдах.
ВОЗЛО́ЖИТЬ 1. тавих, өргөх; **~ венок на могилу** шарилд цэцэг тавих; 2. даалгах үүрүүлэх, оногдуулах; **~ вину** гэмийг оногдуулах.
ВОЗЛЮБЛЕННЫЙ янаг хайртай, хайртай хүн.
ВОЗМЕ́ЗДИЕ хариулал, ланчиг, хохь нь болох, өр төлөөс; **справедливое ~** зохих хариулал, хохь нь болж таарах; **~ за грехи** тийн боловсрох гэсгээл.
ВОЗМЕСТИ́ТЬ төлж өгөх, нөхөн төлөх, нөхөн олгох.
ВОЗМЕЩА́ТЬ төлж өгөх, нөхөн төлөх, нөхөн олгох; **~ расходы** зардлыг нөхөн төлөх.
ВОЗМЕЩЕ́НИЕ нөхөж төлөх, төлбөр; **получить ~ за убытки** хохирлын төлбөрийг авах.
ВОЗМО́ЖНО магадгүй, мэдэж; **~ придёт** ирж магадгүй, ирж мэднэ.
ВОЗМО́ЖНОСТ||Ь болмоор, боломж, бололцоо, бололцох, болох арга; **~ такого исхода сомнительна** тэгж болмоор байгаа нь эргэлзээтэй байна; **тут имеются разные ~и** үүнд элдэв бололцоо байна; **производственные ~и** үйлдвэрлэлийн боломж; * **по мере ~и** бололцох хирээр, чадах чинээгээр.
ВОЗМО́ЖН||ЫЙ болмоор, боломжтой; **сделать всё ~ое** болмоор бүгдийг хийх.
ВОЗМУЖА́ЛЫЙ идэрших, бялдар суух, чийрэг эр болох.
ВОЗМУТИ́ТЕЛЬНО жигшүүртэй, зэвүү хүрмээр, эгдүүтэй.
ВОЗМУТИ́ТЕЛЬНЫЙ жигшүүртэй, эгдүү хөдөлмөөр, зэвүү хүрэх.
ВОЗМУТИ́ТЬ эгдүү хөдөлгөх, зэвүү хүргэх.
ВОЗМУТИ́ТЬСЯ эгдүү хөдлөх, зэвүү хүрэх, жигших.
ВОЗМУЩЕ́НИЕ 1. жигшил, эгдүү хөдөлгөх, зэвүү хүргэх; 2. долгисол; **магнитное ~** соронзонгийн долгисол.
ВОЗМУЩЁННО эгдүүцэн, зэвүүцэн.
ВОЗМУЩЁННЫЙ эгдүүцсэн, зэвүүцсэн.
ВОЗНАГРАДИ́ТЬ шагнах, ач хариулах; **~ за доблестный труд** гавъяат хөдөлмөрийн төлөө шагнах.
ВОЗНАГРАЖДЕ́НИЕ шагнах, ач хариулах.
ВОЗНЕГОДОВА́ТЬ хорсох, зэвүүцэх.
ВОЗНЕНАВИ́ДЕТЬ үзэн ядах, жигших.
ВОЗНЕСТИ́ өргөмжлөх, магтах; **~ до небес** тэнгэрт тулгал магтах.
ВОЗНИКА́ТЬ төрөх, үүсэх, бий болох; **возникла мысль** санаа төрлөө.
ВОЗНИКНОВЕ́НИЕ үүсэх, бий болох; **~ жизни на земле** дэлхий дээр амьдрал үүссэн нь.
ВОЗНИ́ЦА улаач.
ВОЗНОСИ́ТЬСЯ 1. өргөмжлөгдөх, магтагдах; 2. дээрэлхэх.
ВОЗН||Я́ 1. шуугилдах, бужигнах; **дети подняли ~ю** хүүхэд шуугилдаж байв; 2. төвөг, чирэгдэл, уршиг, яршиг.
ВОЗОБЛАДА́ТЬ дийлэх, булих.
ВОЗОБНОВИ́ТЬ дахин сэргээх, дахин үргэлжлүүлэх, дахин хийх; **~ занятие** хичээлээдахин хийх.
ВОЗОБНОВИ́ТЬСЯ дахин хийгдэх, сэлбэгдэх, сэргээгдэх, дахин эхлэх.
ВОЗОБНОВЛЕ́НИЕ сэлбэх, сэргээх, дахин хийх, үргэлжлүүлэх.
ВОЗОБНОВЛЯ́ТЬ дахих, сэлбэх, сэргээх, үргэлжлүүлэх.
ВОЗОМНИ́ТЬ биеэ тоох.
ВОЗРАЖА́||ТЬ татгалзах; **вы не ~ете** та татгалзахгүй биз.
ВОЗРАЖЕ́НИЕ татгалзал.
ВО́ЗРАСТ нас; **школьный ~** сургуулийн нас; **я одного ~а с ним** би түүнтэй нас чацуу; **выйти из ~а** нас хэтрэх; **абсолютный геологический ~** геологийн үнэмлэхүй нас.
ВОЗРАСТА́НИЕ өсөх, нэмэгдэх, олшрох.
ВОЗРАСТА́ТЬ өсөх, нэмэгдэх, олшрох.
ВОЗРАСТА́ЮЩИЙ өсөх, нэмэгдэх.
ВОЗРАСТНО́Й насны, насаар нь ялгах.
ВОЗРОДИ́ТЬ, 1. сэргээн мандуулах, сэргээн хөгжүүлэх, сэргээн босгох; **~ промышленность** үйлдвэрийг сэргээн босгох; 2. оруулах; **~ к жизни** амь оруулах.
ВОЗРОДИ́ТЬСЯ 1. сэргэн мандах, дахин хөгжих, сэргэж босох; 2. зориг орох, хүч орох.
ВОЗРОЖДЕ́НИ||Е 1. мандал, хөгжил, сэргэлт; **эпоха ~я** сэргэлтийн үе; 2. төлжиж ургах; **~ органов** эрхтэн төлжиж ургах.
ВО́ЗЧИК жинчин, хөтөч, тэрэг хөтлөгч.
ВОЗЫМЕ́ТЬ хүрэх, орох, төрөх; **~ желание** хүсэл төрөх дур хүрэх; **~ силу** хүч орох.
ВО́ИН цэрэг, дайчин цэрэг, цэргийн хүн.
ВО́ИНСКИЙ цэргийн; **~ поезд** цэргийн галт тэрэг.
ВОЙНСТВЕННЫЙ дайнч, дайчин.
ВОЙНСТВУЮЩИЙ дайчин.
ВОЙСТИНУ үнэхээр, чухамхан, нээрээ.
ВОЙ 1. улих; 2. ухилах, уйлаан, майлаан; 3. сүнгэнэх; **~ ветров** салхи сүнгэнэх.
ВО́ЙЛОК эсгий.
ВО́ЙЛОЧНЫЙ эсгий, эсгийгээр.
ВОЙНА́ дайн, байлдаан; **гражданская ~** иргэний дайн.
ВО́ЙСКО цэрэг, цэргүүд.
ВОЙСКОВО́Й цэргийн.
ВОЙТИ́ 1. орох; **~ в комнату** тасалгаанд орох; 2. багтах; **бельё вошло в чемодан** дотуур хувцас чемоданд багтав; 3. оролцох; **~ в состав комиссии** комиссын бүрэлдэхүүн доролцох; 4. дадах; **актёр вошёл в роль** жүжигчин дүрдээ дадав; 5. оруулах, хийх, олох; **~ с предложением** санал оруулах; **~ в доверие** итгэлийг олох.
ВОКА́ЛЬНЫЙ дуулалт, дууны, дуулаачны; **~ вечер** дуулалт үдэшлэг.
ВОКАЛИ́ЗМ эгшиг авиа.
ВОКЗА́Л төмөр замын буудал, төмөр замын өртөө.
ВОКРУ́Г эргэн тойрон, орчин, ойр хавь; * **~ да около** хальт хавьтуулаад.
ВОЛ шар, эр үхэр.
ВОЛА́Н салбан, хуниас, санжуурга.
ВОЛДЫ́РЬ цэврүү, бэлцрүү.
ВОЛЕВО́Й чин зоригтой, зориг төгөлдөр, туйлбартай.
ВОЛЕИЗЪЯВЛЕ́НИЕ саналаа илэрхийлэх.
ВОЛЕЙБО́Л гар бөмбөг, волейбол.
ВО́ЛЕЙ-НЕВО́ЛЕЙ дуртай дургүй ч гэсэн, аргагүй.
ВОЛК чоно; **~ в овечьей шкуре** хонины арьс нөмөрсөн чоно; **~ гривистый** дэлт чоно; * **~а бояться — в лес не ходить** чононоос айвал ойд битгий яв, айвал бүү хий, хийвэл бүү ай; **и ~и сыты, и овцы целы** чоно ч цатгалан, хонь ч бүтэн; 2. *устар.* арааиға.
ВОЛКОДА́В гарз нохой, хасар нохой.
ВОЛНА́ долгион, давалгаа; **морская ~** далайн долгио; **~ сейсмическая** газар хөдлөлийн долгион.
ВОЛНЕ́НИЕ 1. долгио, долгилоо, долгилох, давалгаа; **морское ~** далайн давалгаа; 2. санаа зовох, сэтгэл түгших, догдлох; 3. үймээн, хөдөлгөөн; **народное ~** ардын хөдөлгөөн.

ВОЛНИ́СТ||ЫЙ долгиотсон, буржгар, гөвөөтэй, атиралдсан, эвхрэлдсэн; **~ые волосы** буржгар үс; **~ая степь** гөвөөтэй тал.

ВОЛНОВА́ТЬ 1. долгилуулах, долгисуулах; 2. санаа зовоох, сэтгэл түгшүүлэх, тэвдүүлэх.

ВОЛНОВА́ТЬСЯ 1. *долгилох*, долгисох; 2. санаа зовох, сэтгэл түгших, тэвдэх.

ВОЛНОВ||О́Й долгионы; **~ое движение** долгионы хөдөлгөөн.

ВОЛНООБРА́ЗН||ЫЙ долгион шиг, долгион хэлбэртэй; **~ая лихорадка** халуурал.

ВОЛНУ́ШКА хагархай сархиаг мөөг.

ВОЛО́ВИЙ үхрийн, шарын.

ВОЛОДУ́ШКА *бот.* бэриш.

ВОЛОКИ́ТА унжруулах, яршиг, нуршуудал, чирэгдэл.

ВОЛОКИ́ТЧИК нуршигч, чирэгдүүлэгч, ярвиг татагч.

ВОЛОКНИ́СТ||ЫЙ ширхэгт, сэмэрхий, цуултархаг; **~ая ткань** ширхэгт эд; **~ межпозвоночный хрящ** нугалмын хоорондох ширхэгт мөгөөрс.

ВОЛОКНО́ ширхэг, сэмэрдэс, цуулт; **шёлковое ~** торгон цуулт.

ВО́ЛОКОМ чирэх; **тащить ~** газар дээгүүр чирэх.

ВОЛОКУ́ША аралт чиргүүл.

ВОЛОНТЁР сайн дураар элсэгч, элссэн цэрэг.

ВО́ЛОС үс, хялгас; **расчесать ~ы** үс самнах; **конские ~ы** хялгас; *** краснеть до корней волос** ичиж час улаан болох; **ни на ~** бүр юу ч байхгүй; **~ы встают дыбом** үс арвайж босох.

ВОЛОСА́ТЫЙ үсэрхэг, үслэг.

ВОЛОСН||О́Й хялгасан, цуултан, маш нарийхан; **~ые сосуды** хялгасан судас.

ВОЛОСО́К 1. жаахан үс, үсхэн, өчүүхэн хялгас; 2. утас; *** быть на ~ от смерти** үхлийн амсар дээр гарах, арай л үхсэнгүй; **держаться на волоске** дээсэн дөрөөтэй дөнгөж явах, хялгасанд торж байх, амь алддагийн даваан дээр.

ВОЛОСТНО́Й хушууны, аймгийн.

ВО́ЛОСТЬ хушуу, отог.

ВОЛОСЯНО́Й хялгасан, үсэн; **~ матрац** хялгасан дэвсгэр.

ВОЛОЧИ́ТЬ чичрэх.

ВОЛОЧИ́ТЬСЯ 1. чирэгдэх, чиргүүлдэх; 2. хүүхэн эргүүлэх.

ВОЛХВ шидтэн, арш.

ВОЛЧА́НКА чонын хөрөвдөс, чоно яр.

ВОЛЧА́РА 1. чоно, боохой; 2. амиа бодсон, өлөн ховдог, идэж ашиглах дуртай хүн.

ВО́ЛЧИЙ чонын, чонон; **волчья доха** чонон дах; *** волчья ягода** чөтгөрийн идээ.

ВОЛЧИ́ХА өлөгчин чоно, гичий чоно.

ВОЛЧКО́М эрчигнүүр шиг.

ВОЛЧНИКО́ВЫЕ *бот.* далан түрүүтэн.

ВОЛЧО́К 1. эрчигнүүр, удган; 2. ээрүүл, газрын сам хорхой.

ВОЛЧО́НОК бэлтрэг, чонын гөлөг.

ВОЛШЕ́БНИК илбэчин.

ВОЛШЕ́БНИЦА илбэч эмэгтэй.

ВОЛШЕ́БН||ЫЙ 1. илбийн, автай, шидэт; **~ая сказка** шидэт үлгэр; 2. *хачин сайхан, жигтэй сайхан*; **~ая музыка** хачин сайхан хөгжим.

ВОЛШЕБСТВО́ илбэ, шид.

ВОЛЫ́НИТЬ, унжруулах, нурших, ужаах.

ВОЛЫ́НКА 1. хөөрөгт цуур; 2. нурших, нуршил.

ВОЛЬГО́ТНО эрх дураараа, талбиун, санаа амар.

ВОЛЬГО́ТН||ЫЙ эрх дураар, талбиун; **~ая жизнь** талбиун амьдрал.

ВО́ЛЬНАЯ чөлөөлөх бичиг, хамжлагаас гаргах баримт.

ВО́ЛЬНИЧАТЬ зоргоор аашлах, дур мэдэх.

ВО́ЛЬНО 1. дураараа, дуртай; **~ или невольно** дуртай ч дургүй ч гэсэн; 2. сул, сул зогс; **~!** сул зогс!

ВОЛЬНОДУ́МЕЦ чөлөөт санаатан.

ВОЛЬНОДУ́МНЫЙ чөлөөт санааны.

ВОЛЬНОДУ́МСТВО *чөлөөт санаа, чөлөөтэй сэтгэх явдал.*

ВОЛЬНОЛЮБИ́ВЫЙ эрх чөлөөнд дуртай.

ВОЛЬНОНАЁМНЫЙ хөлсний, хөлсөлсөн.

ВОЛЬНООТПУ́ЩЕННИК суллагдсан боол, чөлөөлөгдсөн хамжлага.

ВОЛЬНОСЛУ́ШАТЕЛЬ лекци сонсогч, сайн дурын оюутан.

ВО́ЛЬНОСТЬ 1. эрх чөлөө, чөлөөтэй; 2. задгай, сул, зоргондоо орох.

ВО́ЛЬН||ЫЙ сул, эрх чөлөөт, дархан, зоргоороо; **~ город** дархан хот; **~ перевод** чөлөөтэй орчуулга, найруулан орчуулах; **~ые движения** чөлөөт хөдөлгөөн; **~ая птица** зоргоороо хүн.

ВОЛЬТ 1. вольт *(цахилгааны урсгалын хүчдэлийг хэмжих нэгж)*; 2. эргэлт, тойруулга.

ВО́ЛЬТОВА ДУГА́ вольтын нум, вольтын дугуй, цахилгаан гэрэлтүүр.

ВОЛЬФРА́М вольфрам, *гянт (амархан хайлдаггүй төмөрлөг).*

ВОЛЬФРА́МОВЫЙ вольфрамын, вольфрамт.

ВО́Л||Я 1. чөлөө, эрх чөлөө; 2. зориг, дур хүсэл, таалал; **человек железной ~и** хатан зоригтой хүн; **отдаться на ~ю победителей** ялагсдын дур зоргонд автах; **это в вашей ~е** та дураараа бол та л мэднэ; 3. суллах, тавих; **отпустить на ~ю** суллаж гаргах; *** ~ею судеб** заяаны эрхээр; **~ неба** тэнгэрийн бошго.

ВОН I 1. тонил, зайл, талий, гар; **~ отсюда!** эндээс зайл! талий! **пошёл ~!** тонил! **выгнать ~** хөөж гаргах; 2. хэтрүү, гаргуун; **из ряда ~ выходящий** хирээс хэтрүү давсан; *** из рук ~ плохо** авах танагтүй муу.

ВОН II тээ тэр, тээр; **~ он идёт** тээ тэр айсуй; **~ там** тээр тэнд.

ВОНЗА́ТЬ бүлэх, шаах, хатгах, шигтгэх.

ВОНЗА́ТЬСЯ бүлэгдэх, шаагдах, хатгагдах, *шигдэх.*

ВОНЗИ́ТЬ бүлэх, шаах, хатгах, шигтгэх; **~ кинжал** чинжаал хутга шаах.

ВОНЬ өмхий үнэр, үнэр танар.

ВОНЮ́ЧИЙ өмхий, муухай үнэртэй, өмхий самхай.

ВОНЯ́ТЬ өмхийрөх, өмхий үнэр гаргах, унгах.

ВООБРАЖА́ЕМЫЙ сэтгэлдээ бодсон, ухаанд ургасан, санаанд дүрсэлсэн.

ВООБРАЖА́ТЬ 1. сэтгэх, санаандаа дүрслэх; 2. биеэ тоох, сайрхах.

ВООБРАЖЕ́НИЕ 1. дүрслэн бодох, тухайлах; 2. хоосон санаа, санаархал.

ВООБРАЗИ́МЫЙ бодож болом, сэтгэж болом.

ВООБРАЗИ́ТЬ 1. санах, сэтгэх; 2. биеэ тоох, сайрхах.

ВООБЩЕ́ ер, ер нь, ердөө; **~, это верно** ер нь энэ зөв; **я ~ сегодня никуда не пойду** би өнөөдөр ердөө хаашаа ч гарахгүй.

ВООДУШЕВИ́ТЬ урам оруулах, урамшуулах, *зоригжуулах.*

ВООДУШЕВИ́ТЬСЯ урам орох, урамших, зоригжих.

ВООДУШЕВЛЕ́НИЕ урам хөгжих, урамшил, зоригжил.

ВООДУШЕВЛЁННЫЙ урам хөгжсөн, урам орсон, зоригжсон.

ВООДУШЕВЛЯ́ТЬ урам оруулах, зоригжуулах.

ВООДУШЕВЛЯ́ТЬСЯ урам орох, зоригжих.

ВООРУЖА́ТЬ зэвсэглэх, зэвсэгжүүлэх.

ВООРУЖА́ТЬСЯ зэвсэглэх.

ВООРУЖЕ́НИЕ зэр зэвсэг, зэвсэглэх.

ВООРУЖЁННОСТЬ зэвсэглэл, зэвсэглэх.

ВООРУЖЁНН||ЫЙ зэвсэгт, зэвсэглэсэн; **~ые силы** зэвсэгт хүчин; **~ техникой** техникээр зэвсэглэсэн.

ВООРУЖИ́ТЬ зэвсэглэх, зэвсэгжүүлэх; **~ армию** цэргийг зэвсэглэх.

ВООРУЖИ́ТЬСЯ зэвсэглэх, зэвсэглүүлэх; * ~ **терпением** тэсэж үзэх, тэсвэржих
ВОО́ЧИЮ нүдний өмнө, илт, ив илхэн, нүдээрээ харж.
ВО-ПЕ́РВЫХ нэгдүгээрт, нэгд.
ВОПИ́ТЬ орилох, бархирах, чарлах.
ВОПИЮЩ||ИЙ хачин жигтэйхэн, жигшмээр, зэвүү хүрмээр; * **глас ~его в пустыне** хоосон цөлд гуугалах мэт.
ВОПЛОТИ́ТЬ биелүүлэх, хэрэгжүүлэх; ~ **замысел в произведении** санаснаа сайхан зохиол болгон биелүүлэх.
ВОПЛОТИ́ТЬСЯ биелэх, биелэгдэх, гүйцэтгэгдэх.
ВОПЛОЩА́ТЬ биелүүлэх, хэрэгжүүлэх.
ВОПЛОЩА́ТЬСЯ биелэх, биелэгдэх.
ВОПЛОЩЕ́НИЕ 1. биелэх, биелэгдэх; 2. хувилгаан.
ВОПЛОЩЁНН||ЫЙ 1. биелсэн; **проект, ~ в жизнь** амьдралд биелсэн төсөл; 2. эрхэм жишээ, оргил; **человек этот — ~ая справедливость** энэ хүн үнэн шударгын эрхэм жишээ болно.
ВОПЛЬ орилоон, чарлаан.
ВОПРЕКИ́ зөрүү, сөрөх, гадуур; ~ **здравому смыслу** зүйг сөрж; ~ **желанию** дур хүслээсээ гадуур.
ВОПРО́С, 1. асуулт; **задать** ~ асуулт тавих; **осаждать ~ами** асуултаар ноцох, асууж шалах; 2. асуудал; **аграрный** ~ газар тариалангийн асуудал; **оставить** ~ **открытым** асуудлыг шийдэлгүй орхих; 3. хэрэг, учир зүйл; **весь** ~ **в том, что...** бүхучир нь юу вэ гэхэд□; **это** ~ **времени** энэ байзнаж байтал болох зүйл; **по личному ~у** хувийн хэргээр; * ~ **жизни и смерти** амь өрөх асуудал, амь насны хэрэг; **что за ~?** ямар асуулт байх вэ? хэлэлцээн юу байх вэ?; **ставить под** ~ асуудал болгох.
ВОПРОСИ́ТЕЛЬНЫЙ асуух, асуусан; ~ **знак** асуух тэмдэг.
ВОПРО́СНИК асуултын хуудас, асуулга.
ВОПРОША́ТЬ лавлах, сураглах.
ВОР хулгайч; **карманный** ~ өвөр суйлах хулгайч.
ВОРВА́ТЬСЯ 1. нэвтрэх, орох, цөмрөн орох; 2. нэвт үлээх.
ВОРИ́ШКА явган хулгайч, шалихгүй хулгайч.
ВОРКОВА́ТЬ 1. гөвтнөлдөх, шивэр авир хийх; 2. түдэглэх, донгодох.
ВОРКОТНЯ́ 1. гөвтнөх, түдэгнэх; 2. түдэглэх, донгодох.
ВОРОБЬЁ́Й бор шувуу, богширго, гятруу, бялзуухай; * **стреляный** ~ долорсон амьтан, хашир гайхал.
ВОРОБЬИ́НЫЙ бор шувууны.
ВОРО́ВАННЫЙ хулгайлсан, хулгайн.
ВОРОВА́ТЫЙ хулгай, нохойрхог, гөнтэй; ~ **взгляд** хулгай харц.
ВОРОВА́ТЬ хулгайлах, хулгуух, хулгай хийх.
ВОРО́ВКА хулгайч хүүхэн.
ВОРОВСКО́Й хулгайгаар.
ВОРОВСКО́Й хулгайн, хулгайчийн.
ВОРОВСТВО́ хулгай, хулгайлах, хулгуух; ~ **скота** *разг.* толгой салгах.
ВОРОЖБА́ 1. дом, домнох, гүрэм; 2. мэрэглэх, төлөг үзэх.
ВОРОЖЕ́Я домч эхнэр, төлөгч эхнэр, удган.
ВОРОЖИ́ТЬ домнох, мэрэглэх, төлөг үзэх.
ВО́РОН хон хэрээ, хэрээ.
ВОРО́НА турлааг, хар торуу; * **пуганая ~ и куста боится** сүүнд халаад тараг үлээх; **ворон считать** ангайх, ангалзах.
ВОРО́НЕЦ *бот.* ховолгоно; ~ **красноплодный** улаан ховолгоно.
ВОРОНЁНЫЙ хав хар, бараан, хар будагтай.
ВОРО́НИЙ хэрээний, турлаагийн; ~ **глаз** *бот.* чандган чих.
ВОРОНИ́ТЬ өнгөлөх, хараар будах.
ВОРО́НКА 1. гоожуур, юүлүүр, юүлүүр лууз, хүнхий; ~ **ушная** чихний лууз; 2. өрх, шувтан нүх.
ВОРОНО́Й хар, хөө хар.
ВОРО́НЬЁ сэгийн хэрээ, шунахайчууд.
ВО́РОТ 1. зах, заам, энгэр; 2. эргүүлэг өргөх хөшүүр.
ВОРО́ТА хаалга, их хаалга; **триумфальные** ~ ёслолын хаалга.
ВОРОТИ́ЛА мундагчууд, толгойлогчид.
ВОРОТИ́ТЬ буцаах, эргүүлэх.
ВОРОТИ́ТЬСЯ буцах, эргэх.
ВОРОТНИ́К зах заам, зах.
ВОРОТНИЧО́К зах, бяцхан зах; **стоячий** ~ босоо зах; **отложной** ~ эвхээ зах, сөхдөг зах.
ВО́РОХ бөөм, овоо.
ВОРО́ЧАТЬ 1. мухруулах, хөлбөрүүлэх, эргүүлэх, өнхрүүлэх; ~ **брёвна** мод өнхрүүлэх; 2. захирах, даамалдах; ~ **всеми делами** бүх хэргийг даамалдах.
ВОРО́ЧАТЬСЯ эргэлдэх, өнхрөх, хөрвөх, хөлбөрөх.
ВОРОШИ́ТЬ урвуулах, сийчих; ~ **сено** өвс сийчих.
ВОРС илбэргэ, илбэрээс.
ВОРСИ́НКА цэлмэн, илбэрхий.
ВОРСИ́СТЫЙ илбэргэтэй, илбэрхий.
ВОРСЯ́НКОВЫЕ *бот.* бааварын овог.
ВОРЧА́НИЕ 1. архирах; 2. янших, донгосох.
ВОРЧА́ТЬ 1. архирах; 2. янших, донгосох.
ВОРЧЛИ́ВОСТЬ яншаа, уймраа.
ВОРЧЛИ́ВЫЙ яншаа, уймар.
ВОРЧУ́Н яншаа хүн, уймар хүн.
ВОРЧУ́НЬЯ яншаа эхнэр, уймар эхнэр.
ВОСВОЯ́СИ гэр тийшээ гэлдрэх, орон нутгаа тэмцэх.
ВОСЕМНА́ДЦАТ||ЫЙ арван наймдугаар, арван найм; ~ **параграф** арван наймдугаар зүйл; **~ое число** арван наймны өдөр.
ВОСЕМНА́ДЦАТЬ арван найм.
ВО́СЕМЬ найм.
ВО́СЕМЬДЕСЯТ ная.
ВОСЕМЬСО́Т найман зуу.
ВО́СЕМЬЮ найман, найм дахин; ~ **восемь — шестьдесят четыре** найман найм — жаран дөрөв.
ВОСК лав, цагаан лав, балуус, шааг; ~ **зубоврачебный** шүдний хэв авах зориулалтын бэлдмэл.
ВОСКЛИ́КНУТЬ халаглан хэлэх, бахдан хашгирах.
ВОСКЛИЦА́НИЕ дуудал, халаглан хашгирах, бахдан бархирах.
ВОСКЛИЦА́ТЕЛЬНЫЙ дуудах, анхааруулах, халаглах; ~ **знак** дуудах тэмдэг.
ВОСКЛИЦА́ТЬ халаглан хэлэх, бахдан хашгирах.
ВОСКОВ||О́Й лавын; **~ая свеча** лавын лаа; * **~ое лицо** цонхигор царай.
ВОСКРЕСА́ТЬ амь орох, амьдрах, сэхэх.
ВОСКРЕСЕ́НИЕ 1. амь орох, дахин амьдрах; 2. сэргэх, сэхэх, тамир орох.
ВОСКРЕСЕ́НЬЕ ням гариг, адьяа, сайн өдөр, бүтэн сайн өдөр.
ВОСКРЕСИ́ТЬ амь оруулах, амьдруулах, сэхээх.
ВОСКРЕ́СНИК сайн өдрийн хамтын ажил.
ВОСКРЕ́СНУТЬ 1. амь орох, үхээд амилах, дахин амьдрах, сүнс орох; 2. сэргэх, сэхэх.
ВОСКРЕ́СН||ЫЙ сайн өдрийн, ням гаригийн; **~ая прогулка** сайн өдрийн зугаалалт.
ВОСКРЕША́ТЬ 1. амь оруулах, амьдруулах; ~ **из мёртвых** үхсэнийг амилуулах; 2. сэргээх, сэхээх.
ВОСПАЛЕ́НИЕ үрэвсэл, үрэвсэх; ~ **лёгких** уушиг үрэвсэх; ~ **крупозное** сахуулайт үрэвсэл.
ВОСПАЛИ́ТЕЛЬНЫЙ үрэвсэх.
ВОСПАЛИ́ТЬСЯ үрэвсэх, үрэвсчих, улайх.

ВОСПЕВА́ТЬ магтан дуулах, сайшаах, дуурсгах.
ВОСПЕВА́ТЬСЯ магтагдах, алдарших, дуурсган дуулах.
ВОСПЕ́ТЬ магтан дуулах, алдрыг дуурсгах, цолыг дуудах.
ВОСПИТА́НИЕ хүмүүжил, хүмүүжүүлэх, хүмүүжих, бойжуулах.
ВОСПИ́ТАННИК хүмүүжигч, тэжээлгэгч, суралцагч.
ВОСПИ́ТАННИЦА хүмүүжигч охин, суралцагч хүүхэн.
ВОСПИ́ТАННОСТЬ хүмүүжил, боловсон, ургамж, учир мэдэх.
ВОСПИ́ТАННЫЙ хүмүүжүүлсэн, боловсорсон, сургамжтай, томоожсон.
ВОСПИТА́ТЕЛЬ хүмүүжүүлэгч, асрагч багш, сургамжлагч.
ВОСПИТА́ТЕЛЬНИЦА хүмүүжүүлэгч эмэгтэй, асрагч эх, эмэгтэй багш.
ВОСПИТА́ТЕЛЬНЫЙ хүмүүжүүлэх.
ВОСПИТА́ТЬ хүмүүжүүлэх, сургамжлах; ~ **в детях привычку к труду** хүүхдийг хөдөлмөрийн дадлагатай болгон хүмүүжүүлэх.
ВОСПИ́ТЫВАТЬ хүмүүжүүлэх, хүмүүжүүлсээр байх.
ВОСПИ́ТЫВАТЬСЯ хүмүүжих, сургамжлагдах.
ВОСПЛАМЕНЕ́НИЕ ноцох, шатах, асах, гал авалцах.
ВОСПЛАМЕНИ́ТЬ 1. *ноцоох*, шатаах, асах, гал авалцуулах; 2. бадруулах.
ВОСПЛАМЕНИ́ТЬСЯ 1. ноцох, шатах, гал авалцах, асах; 2. бадрах.
ВОСПЛАМЕНЯ́ЕМОСТЬ шатах чанар, шатамгай, гал авалцамтгай.
ВОСПЛАМЕНЯ́ТЬ 1. ноцоох, шатаах, асаах, гал авалцуулах; 2. бадруулах.
ВОСПЛАМЕНЯ́ТЬСЯ 1. ноцох, шатах, гал авалцах; 2. бадрах.
ВОСПО́ЛНИТЬ нөхөж гүйцээх, нөхөх.
ВОСПО́ЛНИТЬСЯ нөхөгдөх, нөхөгдөж гүйцэх.
ВОСПОЛНЯ́ТЬ нөхөж гүйцээх, дутууг нөхөх.
ВОСПОЛНЯ́ТЬСЯ нөхөгдөх, гүйцэлдэх.
ВОСПО́ЛЬЗОВАТЬСЯ ашиглах, самбаачлах, завших; ~ **случаем** завшааныг ашиглах.
ВОСПОМИНА́НИЕ дурсах, дурсан санах, дурсамж.
ВОСПРЕПЯ́ТСТВОВАТЬ саад хийх, түйтгэрлэх.
ВОСПРИИ́МЧИВОСТЬ 1. авхаалж, ухамтгай; 2. халдамтгай, эмзэг, өвчлөмтгий, эмзэг чанар.
ВОСПРИИ́МЧИВЫЙ 1. авхаалжтай, ухамтгай, ойлгомжтой; 2. халдамтгай, өртөмхий эмзэг.
ВОСПРИНИМА́ТЬ ухах, ойлгох.
ВОСПРИНЯ́ТЬ ойлгочих, ухамсарлах, шүүрч авах.
ВОСПРИЯ́ТИЕ ойлгоц, ойлгох, ухах.
ВОСПРОИЗВЕДЕ́НИЕ 1. нөхөн үйлдвэрлэх, ахиж үйлдэх; 2. буулгавар, хуулбар.
ВОСПРОИЗВЕСТИ́ 1. нөхөн үйлдвэрлэх, ахиж үйлдэх; 2. буулгах, хуулбарлах; 3. сэргээж санах.
ВОСПРОИЗВОДИ́ТЬ 1. нөхөн үйлдвэрлэх, ахиж үйлдэх; 2. буулгах, хуулбарлах 3. сэргээж санах.
ВОСПРОИЗВО́ДСТВО 1. нөхөн үйлдвэрлэл, ахиж үйлдэх; **простое** ~ энгийн нөхөх үйлдвэрлэл.
ВОСПРОТИ́ВИТЬСЯ эсэргүүцэх, татгалзах, цааргалах.
ВОСПРЯ́НУТЬ сэргэх, сэхэх, орох; ~ **духом** зориг орох, сэтгэл сэргэх.
ВОСПЫЛА́ТЬ буцлах, оргилох; ~ **гневом** уур буцлах; ~ **любовью** янаг сэтгэл оргилох, хурьцах.
ВОССЕДА́ТЬ морилж суух, ажааран суух, залран суух.
ВОССЕ́СТЬ морилж суух, ажааран суух, суух; ~ **на престол** хаан ширээнд суух.
ВОССОЕДИНЕ́НИЕ сөөргө нь нийлүүлэх.
ВОССОЕДИНИ́ТЬ сөөргө нь нийлүүлэх, ахиж нийлүүлэх.
ВОССОЕДИНИ́ТЬСЯ сөөргөө нийлэх, ахиж нийлэх.
ВОССОЗДАВА́ТЬ сөөргө нь босгох, ахиж үүдэх, дахин сэргээх.
ВОССОЗДАВА́ТЬСЯ *сөөргөө* байгуулагдах, ахиж хийгдэх, дахин сэргэх.
ВОССОЗДА́НИЕ сэргээн байгуулах, ахиж босгох, дахин сэргээх, сэлбэх.
ВОССОЗДА́ТЬ дахин босгох, сөөргө нь байгуулах, ахиж сэргээх.
ВОССОЗДА́ТЬСЯ сөөргөө байгуулагдах, дахин сэргэх, сэлбэгдэх.
ВОССТАВА́ТЬ эсэргүүцэх, эсэргүүцэн босох.
ВОССТАНА́ВЛИВАТЬ 1. сэргээн босгох, сэргээн тогтоох, сэлбэн засах, тэнхрүүлэх; ~ **разрушенный город** эвдэрсэн хотыг сэлбэн засах; 2. сэргээн санах; 3. хэвээр болгох, эгүүлэн олгох; ~ **в правах** эрхийг эгүүлэн олгох.
ВОССТАНА́ВЛИВАТЬСЯ 1. сэргэн босох, сэргэн тогтох, сэлбэгдэх, тэнхрэх; 2. сэргэж санагдах; 3. хэвээр болох, эгж орох.
ВОССТА́НИЕ бослого; **вооружённое** ~ зэвсэгт бослого.
ВОССТАНОВИ́ТЕЛЬНЫЙ 1. сэргээн босгох, сэргээн тогтоох, сэлбэн засах тэнхрүүлэх; 2. сэргээн санах.
ВОССТАНОВИ́ТЬ 1. сэргээн босгох, сэргээн тогтоох, тэнхрүүлэх; ~ **своё здоровьебиеэ** тэнхрүүлэх; 2. сэргээн санах; ~ **в памяти** сэтгэлдээ сэргээн санах; 3. хэвээр болгох, эгүүлэн оруулах; ~ **в должности** *албан тушаалд эргүүлэн оруулах*; 4. хандуулах, болгох; ~ **всех против себя** бүгдийг өөрийн эсрэг хандуулах.
ВОССТАНОВИ́ТЬСЯ 1. сэргэн босох, сэргэх, тэнхрэх; 2. буцаж орох, олж авах ~ **в правах** эрхээ олж авах.
ВОССТАНОВЛЕ́НИЕ 1. сэргээн босгох, сэргээх, сэлбэн засах; ~ **репутации** *сайн нэрээ* сэргээх; 2. тэнхрүүлэх; 3. хэвээр болгох, эгж орох.
ВОССТА́ТЬ босох, эсэргүүцэн босох.
ВОСТО́К дорно, дорно зүг, дорнод, зүүн, зүүн зүг; **идти на** ~ зүүн тийшээ явах **Дальний** ~ Алс Дорнод; **Ближний** ~ Ойрхи Дорнод.
ВОСТОКОВЕ́Д дорно дахиныг судлагч.
ВОСТОКОВЕ́ДЕНИЕ дорно дахины судлал.
ВОСТОКОВЕ́ДЧЕСКИЙ дорно дахины судлалын.
ВОСТО́РГ сэтгэл хөгжих, хөөрөх, бахдах; **приходить в** ~ сэтгэлийг хөгжөөн бахдуулах; **я в восторге от этого** би үүнд бахдана.
ВОСТОРГА́ТЬСЯ бахдах.
ВОСТО́РЖЕННО бахдан, бахархан; ~ **отзываться** бахдан хэлэх.
ВОСТО́РЖЕННОСТЬ бахдах, бахархах.
ВОСТО́РЖЕННЫЙ бахдах; ~ **поклонник** бахдан шүтэгч.
ВОСТОРЖЕСТВОВА́ТЬ ялах, дийлэх.
ВОСТО́ЧН||ЫЙ дорнод, дорно дахины, зүүн, зүүн зүгийн; ~**ая граница** дорнод хил; ~ **ветер** зүүн зүгийн салхи.
ВОСТРЕ́БОВАНИ||Е нэхэх, нэхэж авах, шаардах; **письмо до** ~**я** өөрөө хүлээн авах захиа.
ВОСТРЕ́БОВАТЬ нэхэх, шаардах.
ВОСТРЕ́Ц хиаг, түнх; ~ **пушистоколосый** унгариль түрүүт түнх.
ВОСТРО́ держать ухо ~ чихээ сонор байлгах сэрэмжтэй байх
ВОСХВАЛЕ́НИЕ магтах, магтаал.
ВОСХВАЛИ́ТЬ магтах, их магтах.
ВОСХВАЛЯ́ТЬСЯ магтуулах, их магтагдах.
ВОСХИТИ́ТЕЛЬНО гайхамшигтай, гайхалтай, дур булаам.
ВОСХИТИ́ТЕЛЬНЫЙ дур булаамаар, гайхалтай.
ВОСХИТИ́ТЬ гайхуулах, дур булаах.
ВОСХИТИ́ТЬСЯ дур булаагдах, шагшин гайхах.
ВОСХИЩА́ТЬ гайхуулах, дур булаах.
ВОСХИЩА́ТЬСЯ шагшин гайхах, дур булаагдах.

ВОСХИЩЕ́НИЕ шагшин гайхах, дур булаах.
ВОСХО́Д мандах, ургах; **на ~е солнца** нар мандах үед.
ВОСХОДИ́||ТЬ 1. мандах, ургах, гарах; **солнце ~т** нар ургаж байна; 2. авирах, авиран гарах, мацаж гарах; **~ на вершину горы** уулын оргилд авиран гарах; 3. үүсвэр, үүсвэрлэх, гарал; **многие обычаи ~ят к глубокой древности** олон заншил эрт урьдын гаралтай юм.
ВОСХОДЯ́Щ||ИЙ мандах, ургах, гарах; **~ее солнце** мандаж байгаа нар; **родственник по ~ей линии** дээд үеийн садан; **~ая звезда** алдаршиж яваа хүн, гийж яваа од.
ВОСХОЖДЕ́НИЕ мандах, авиран гарах.
ВОСШЕ́СТВИЕ ~ на престол хаан ширээнд суух, хаан ширээнд залрах.
ВОСЬМЁРКА найм, найман, наймт, найман тоот.
ВОСЬМИДЕСЯТИЛЕ́ТНИЙ наян наст.
ВОСЬМИДЕСЯ́ТЫЙ наядугаар.
ВОСЬМИКЛА́ССНИК наймдугаар ангийн сурагч.
ВОСЬМИКЛА́ССНИЦА наймдугаар ангийн эмэгтэй сурагч.
ВОСЬМИЛЕ́ТНИЙ найман наст, найман жилийн.
ВОСЬМИСО́ТЫЙ найман зуудугаар.
ВОСЬМИЧАСОВО́Й найман цагийн.
ВОСЬМ||О́Й найман, наймдугаар, найм дахь; **~ое ноября** арван нэгдүгээр сарын найман; **~ час** найм дахь цаг, долоо өнгөрч байна.
ВОСЬМУ́ШКА наймны нэг, наймт; * **~ чаю** хоёр шар цай.
ВОТ 1. энэ, уухай; **~ такой** иймэрхүү; **~ наказание-то** ийм лай байх гэж; **~ и зима настала** за өвөл болжээ, тэгээд өвөл боллоо.
ВОТИ́РОВАТЬ санал өгөх, санал хураах.
ВОТКНУ́ТЬ шаах, хатгах, зоох, чичих; **~ кол в землю** гадас газарт шаах.
ВОТКНУ́ТЬСЯ шаагдах, хатгагдах.
ВО́ТУМ санал илэрхийлэх, олонхийн санал; **~ недоверия** үл итгэх саналыг илэрхийлэх.
ВО́ТЧИНА ноёны харьяат газар, эзэмшлийн нутаг, өв газар.
ВОЦАРЕ́НИЕ 1. хаан суух; 2. чив чимээгүй болох, нам гүм болох, намхрах.
ВОЦАРЯ́||ТЬСЯ 1. хаан суух; 2. чив чимээгүй болох; **~лась тишина** чив чимээгүй болов.
ВОШЬ 1. бөөс; 2. ширх; 3. бүүрэг.
ВОЩЁНЫЙ лавдсан, лав шингээсэн.
ВОЩИ́ТЬ лавдах, лав шингээх, цардах.
ВОЮ́ЮЩИЙ байлдагч, байлдаж байгаа.
ВОЯ́КА хэцүү цэрэг, хэцүүдсэн цэрэг, үхээнц баатар.
ВПАДА́||ТЬ 1. урсаж орох, цутгаж орох; **Волга ~ет в Каспийское море** Ижил Мөрөн Каспийн тэнгист цутган ордог; 2. орох; **~ в бедность** ядуу байдалд орох; **~ в противоречие** зөрчилд орох; 3. хонхойх, хотойх; **щёки впали** хацар нь хонхойжээ.
ВПА́ДИНА 1. ухархай; **глазная ~** нүдний ухархай; 2. хонхорхой, хонхор газар, хотгор.
ВПА́ИВАТЬ гагнах, ширээх.
ВПА́ЙКА гагнаас, гагнуур, гагнах.
ВПА́Л||ЫЙ хонхор, хөнхөр; **~ые глаза** хөнхөр нүд.
ВПАСТЬ 1. хонхойх, хотойх; **после болезни глаза и щёки впадают** өвдсөнөөс хойш нүд хацар нь хонхойжээ; 2. орох, доройтох шиг болох; **~ в отчаяние** цөхрөлд орох, цөхрөх; **~ в крайность** хэтрэлд орох, бүр хэтрэх; **~ в детство** хүүхэд шиг болох.
ВПАЯ́ТЬ гагнах, ширээх, гагнаж суулгах.
ВПЕРВЫ́Е анх, анх удаа.
ВПЕРЕВА́ЛКУ гуйвалзан, дайвалзан, майжигнан.
ВПЕРЕГИ́Б тонгойн, бөгтийн, бөхийн.
ВПЕРЕГО́НКИ́ уралдан; **бежать ~** уралдан гүйх.
ВПЕРЕГО́НКУ уралдан, хойно урдаа, оролцон, хөөцөлдөн.
ВПЕРЁД 1. урагшаа, урагш давших, урагш; **сделать два шага ~** хоёр алхам урагш давших; 2. хойшдоо, цаашдаа; **~ будь осторожнее** хойшдоо болгоомжтой бай; 3. урьдаас, урьдчилан; **заплатить ~** урьдчилан төлөх.
ВПЕРЕДИ́ 1. өмнө, урьд, түрүүнд, түрүүлэн; **идти ~** өмнө явах, түрүүлэн явах; 2. өмнө нь, урьд нь, ирээдүйд; **у него вся жизнь ~** түүний бүх насны явдал өмнө нь *(ирээдүйд)* байна; 3. урьд нь, түрүүнд нь; **он ехал ~ всех** тэр бүгдийн түрүүнд нь явж байлаа.
ВПЕРЕМЕ́ЖКУ сольцолдон, сэлгэлдэн.
ВПЕРЕМЕ́ШКУ хольцолдон, хутгалдан.
ВПЕЧАТЛЕ́НИЕ сэтгэгдэл, хошигнол, хадаашрал; **произвести сильное ~** гүн сэтгэгдэл төрүүлэх.
ВПЕЧАТЛИ́ТЕЛЬНОСТЬ сэтгэгдэлтэй, авхаалж, хоногшил, хадаашрал.
ВПЕЧАТЛИ́ТЕЛЬНЫЙ сэтгэгдэлт, авхаалжтай, соргог, мэдрэлтэй.
ВПИВА́ТЬ сорох, уух, уусгах.
ВПИВА́ТЬСЯ шигтгэх, зуух; **~ зубами** шүдээр зуух.
ВПИ́КУ хорлох гэж, зориуд санаатайгаар.
ВПИСА́ТЬ 1. оруулж бичих, оруулга хийх, нэмэх; 2. дотор нь зурах, оруулж зурах, багтааж зурах; **~ треугольник в окружность** тойргийн дотор гурвалжныг багтааж зурах.
ВПИ́СЫВАТЬ оруулах, оруулж бичих, багтааж бичих.
ВПИТА́ТЬ 1. шингээх; 2. ойлгож авах.
ВПИТА́||ТЬСЯ шингэх, нэвтрэх, орох; **вода ~лась в землю** ус газарт шингэв.
ВПИ́ТЫВАНИЕ шингэх, нэвтрэх.
ВПИ́ТЬСЯ зуух, зуурчих, шигдэх; **~ в когтями** хумсаараа зуурчих.
ВПИ́ХИВАТЬ чихэх, чихэж оруулах.
ВПЛАВЬ самран, усчлан.
ВПЛЕСТИ́ залгаж гөрөх, сүлжих; **~ ленту в косу** гэзгэнд бүч залгаж гөрөх.
ВПЛЕТА́ТЬ залгаж гөрөх.
ВПЛОТНУ́Ю тулж, ойртож очих, шахцалдаж.
ВПЛОТЬ хүртэл, болтол; **~ до вечера** үдэш хүртэл, орой болтол.
ВПОВА́ЛКУ хавьдахуйц хэвтээд, ундуй сундуй хэвтэж; **спать ~** ундуй сундуй хэвтэн унтах.
ВПОЛГО́ЛОСА нам дуугаар, авир шивэр.
ВПОЛЗА́ТЬ мөлхөж орох, мөлхөж гарах, гулгах.
ВПОЛНЕ́ бүрэн, бардаагаар; **я ~ удовлетворён** би бүрэн ханав.
ВПОЛОБОРО́ТА хагас эргээд, эргэсгээд..
ВПОЛОВИ́НУ 1. хагас; 2. хоёр дахин; **~ меньше** хоёр дахин бага.
ВПОПЫХА́Х тэвдүү, тэвдээд, яаран, санд мэнд, адгаад; **~ я забыл книгу дома** тэвдээд би номоо гэртээ мартжээ.
ВПО́РУ 1. цаг нь болох; **~ над этим подумать** үүнийг бодох цаг нь болов; 2. таарах, яг тааруу; **эти ботинки мне ~** энэ гутал над яг таарав.
ВПОРХНУ́ТЬ нисэж орох, дүрхийн орох, сэвэлзэн орох.
ВПОСЛЕ́ДСТВИИ эцэсдээ, хойно, хожим, байн байсаар; **~ не повторяй** хожим битгий тэгээрэй.
ВПОТЬМА́Х харанхуйгаар, харанхуйд.
ВПРА́ВДУ үнэхээр, нээрээ; **я и ~ этого не знал** би үүнийг нээрээ мэдээгүй.
ВПРА́ВЕ эрхтэй; **он ~ требовать** тэр шаардах эрхтэй.
ВПРА́ВИТЬ барих, барьж засах; **~ вывихнутую руку** булгарсан гарыг барих.

ВПРА́ВО баруун тийш, баруун гар тийш, баруунш; **повернуть ~** баруун тийш эргүүлэх.

ВПРЕДЬ үүнээс хойш, цаашдаа, хойшдоо; **~ будь внимательней** үүнээс хойш анхааралтай бай.

ВПРИКУ́СКУ саахар үмхэж; **пить чай ~** саахар үмхэж цай уух.

ВПРИПРЫ́ЖКУ харайн гүйх, дэвхцэн гүйх, догонцон гүйх.

ВПРИСЯ́ДКУ суун босон, цовхчин.

ВПРО́ГОЛОДЬ өл залгаж, өлөн зэлмүүр, арайхан амь улжиж; **жить ~** өлөн зэлмүүр амь зуух.

ВПРОК 1. нөөц, үүц; **заготовить ~** нөөц бэлтгэх; 2. тус; **ему ничто ~ не идёт** түүнд юу ч тус болохгүй.

ВПРОСА́К попасть ~ бачлагдах, гэнэдэх.

ВПРО́ЧЕМ гэвч, үгүй, тэгээд.

ВПРЫ́ГИВАТЬ үсрэн орох, харайн орох.

ВПРЫ́СКИВАНИЕ тарих; **подкожное ~** арьс махны завсар тарих.

ВПРЯГА́ТЬ хөллөх.

ВПРЯГА́ТЬСЯ хөллөх, хөллүүлэх.

ВПРЯМЬ нээрээ, үнэхээр.

ВПРЯЧЬ хөллөх; **~ лошадь в повозку** морь тэргэнд хөллөх.

ВПУСКА́||ТЬ оруулах, нэвтрүүлэх; **не ~йте его сюда** түүнийг нааш нь битгий оруулаарай.

ВПУСКА́ТЬСЯ орох, оруулах, тавигдах.

ВПУСТУ́Ю талаар, шал хэрэггүй, мийн.

ВПУ́ТАТЬ ороолдуулах, холбогдуулах, оролцуулах.

ВПУ́ТАТЬСЯ ороолдох, холбогдох, оролцох.

ВПУХ бүрмөсөн, яйртал, ягтаа тултал; *** ~ и впрах** үнсэн товрог болтол.

ВПЯ́ТЕРО тав дахин.

ВПЯТЕРО́М тавуул, тавуулаа.

ВРАГ дайсан, өшөөтөн.

ВРАЖДА́ дайсагнах, өшөө хонзон.

ВРАЖДЕ́БНО дайсагнан, өшөөрхөн.

ВРАЖДЕ́БНОСТЬ дайсагнал, өшөөрхөл.

ВРАЖДЕ́БНЫЙ дайсагнасан, өшөөтэй, хонзонтой.

ВРАЖДОВА́ТЬ дайсагнах, өшөөрхөх, хонзогнох.

ВРА́ЖЕСКИЙ дайсны.

ВРА́Ж||ИЙ 1. дайсны; 2. шумнасын; **~ья сила** шумнасын хүч.

ВРАЗБИ́ВКУ энд тэндээс, салаавчлан, сөөлжүүлэн; **спрашивать ~ таблицу умножения** үржүүлэх хүснэгтийг энд тэндээс асуух.

ВРАЗБРО́Д 1. тархай, саланги; 2. чиг, чигээрээ.

ВРАЗВА́ЛКУ найгалзан, хэлтэлзэн, дайвалзан.

ВРАЗНОБО́Й чиг чигээрээ, тус тусдаа.

ВРАЗРЕ́З тас зөрүү, огт ондоо, бүр сөрүү.

ВРАЗУМИ́ТЕЛЬНО ойлгомжтой, мэдэгдэхүйц.

ВРАЗУМИ́ТЕЛЬНЫЙ ойлгомжтой, мэдэгдэхүйц.

ВРАЗУМИ́ТЬ ойлгуулах, ухамсарлуулах.

ВРА́КИ дэмий балай юм.

ВРАЛЬ худалч.

ВРАНЬЁ худал үг.

ВРАСПЛО́Х гэнэдүүлэх, гэнэдүүлэн, цочмог.

ВРАССЫПНУ́Ю таран, бутран, бут үсрэн.

ВРАСТА́НИЕ шигдэн ургах, дотогш ургах, лавшран суух, тааралдан орох.

ВРАСТА́ТЬ 1. шигдэн ургах, дотогшоо ургах, авалцан ургах; 2. тааралдан орох, зохицон нийлэх.

ВРАСТЯ́ЖКУ сунаж, сунгаж; **лежать ~** сунаж хэвтэх.

ВРАТА́ хаалга.

ВРАТА́РЬ хаалгач, үүдэч.

ВРАТЬ худал хэлэх; *** часы врут** цаг буруу явж байна; **~ как сивый мерин** худал галлах.

ВРАЧ эмч, их эмч.

ВРАЧЕ́БНЫЙ эмнэлгийн.

ВРАЩА́ТЕЛЬН||ЫЙ эргэх, орчих, эргэлдэх; **~ое движение** эргэх хөдөлгөөн.

ВРАЩА́ТЬ эргүүлэх, эргэлдүүлэх, өнхрүүлэх.

ВРАЩА́ТЬСЯ эргэх, эргэлдэх, өнхрөх; *** ~ среди молодёжи** залуучуудын дунд явах, залуучуудтай нийлж авах.

ВРАЩЕ́НИЕ эргэх, эргэлдэх, орчих, өнхрөх.

ВРЕД хор, хөнөөл, хохирол; **причинить ~** хор хүргэх; *юрид.* **возмещение неимущественного вреда** эдийн бус гэм хорыг арилгах.

ВРЕДИ́ТЕЛЬ хорлогч, сүйтгэгч, хорлон сүйтгэгч.

ВРЕДИ́ТЕЛЬСКИЙ хорлох, хорлон сүйтгэх.

ВРЕДИ́ТЕЛЬСТВО хорлон сүйтгэх.

ВРЕДИ́ТЬ хорлох, хорлон сүйтгэх, хор хүргэх, гэмтээх.

ВРЕ́ДНО хортой, хөнөөлтэй, гэмтэй; **курение ~ для здоровья** тамхи татах нь эрүүл мэндэд хортой.

ВРЕ́ДНОСТЬ хор хөнөөл.

ВРЕ́ДНЫЙ хортой, хөнөөлтэй.

ВРЕДОНО́СНЫЙ их хортой, хор хүргэх, хөнөөлтэй.

ВРЕ́ЗАТЬ суулгах, шигтгэх, шааж оруулах, зүсэж оруулах.

ВРЕ́ЗА||ТЬСЯ 1. шааж орох, хатган орох; **лодка ~лась в берег** завь эрэг рүү шааж оров; 2. зүсэж орох, нэвтрэх орох, дайран орох; 3. хадаж орох, хадагдах; **~ в память** санаанд хадагдах.

ВРЕМЕНА́МИ заримдаа, хааяа хааяа.

ВРЕ́МЕННО түр, түр зуур, цаг зуур.

ВРЕМЕНН||О́Й цагийн; **~ая связь между двумя событиями** хоёр явдлын хоорондох цагийн холбогдол.

ВРЕ́МЕНН||ЫЙ түр, түр зуурын, цаг зуурын; **~ое правительство** түр засгийн газар; **~ поверенный в делах** хэргийг түр хамаарагч.

ВРЕМЕНЩИ́К түр ноёрхсон сайд, өргөмжийн ноён.

ВРЕ́М||Я 1. цаг, хугацаа; **вне ~и и пространства движение материи невозможно** цаг зай хоёроос гадна материйн хөдөлгөөн байж болохгүй; **в назначенное ~** болзсон цагт; **в рабочее ~** ажлын цагт; **в нерабочее ~** ажлын бус цагаар; **в свободное ~** чөлөөт цагт; **всему своё ~** аливаа юм өөрийн цаг хугацаатай байдаг; **в прежние ~ена** эрт цагт, урьд цагт; **в зимнее ~** өвлийн цагт; **сколько ~ени?** хэдэн цаг болж байна? **~ истекло** цаг өнгөрлөө, цаг дууслаа; **прошедшее ~** өнгөрсөн цаг, **настоящее ~** одоо цаг; **будущее ~** ирээдүй цаг; 2. үе; **во ~ Петра Первого** нэгдүгээр Петр хааны үед; **в последнее ~** сүүлийн үед; **во ~ революции** хувьсгалын үед; **в то ~** мөн тэр үед; 3. зав, зав чөлөө; **у меня нет ~ени** би завгүй; *** в любое ~** хэзээ ч, хэзээ ч хамаагүй; **в скором ~ени** мөд, удахгүй; **в короткое ~** богино хугацаанд; **~ от ~ени** үе үе, хааяа хааяа; **в своё ~** цаг тухайдаа; **до сего ~ени** одоо хүртэл, одоо болтол; **до поры, до ~ени** одоохондоо байзнаж байгаад; **четыре ~ени года** жилийн дөрвөн улирал, жилийн дөрвөн цаг; **всё ~** цаг үргэлж, дандаа; **на ~** түр зуур; **~ не ждёт** бушуухан, яарах хэрэгтэй; **тем ~енем** тэр сацуугаар, тэгж байтал; **в данное ~** одоо үед.

ВРЕМЯИСЧИСЛЕ́НИЕ цаг тоолох, лэт зохиох.

ВРЕМЯ́НКА ортог, зөөдөг зуух.

ВРЕМЯПРЕПРОВОЖДЕ́НИЕ цаг өнгөрөөх, цаг нөгчөөх.

ВРО́ВЕНЬ чацуу, чацуу тэгш.

ВРО́ДЕ шиг, шүү, мэт; **он, ~ тебя, увлекается футболом** тэр чам шиг хөл бөмбөг сонирхдог.

ВРОЖДЁНН||ЫЙ төрөлхийн; **~ талант** төрөлхийн билэг; **~ая аномалия** төрөлхийн гажиг; **~ инстинкт** төрөлхийн зөн билэг.

ВРО́ЗНИЦУ жижиглэн, ширхгээр; **продажа оптом и ~** бөөнөөр ба жижиглэн худалдах.

ВРОЗЬ саланги, тус тусдаа, хувь хувьдаа.
ВРУБА́ТЬ ухаж суулгах, төнхөж суулгах.
ВРУБА́ТЬСЯ 1. ухаж орох, төнхөж засвар гаргах; 2. цөмрөн орох.
ВРУБИ́ТЬСЯ 1. ухаж орох, төнхөж завсар гаргах; ~ **в каменную породу** хад төнхөж завсар гаргах; 2. цөмрөн орох; ~ **в ряды врага** дайсны эгнээнд цөмрөн орох.
ВРУ́БОВ||ЫЙ өрөмдөх, төнхөх; **~ая машина** өрөмдөх машин.
ВРУКОПА́ШНУЮ гардан, гараараа, улаан гараараа; **драться** ~ гардан ноцолдох.
ВРУН худалч.
ВРУ́НЬЯ худалч эмэгтэй.
ВРУЧА́ТЬ гардуулах, бариулах, шилжүүлэх, олгох.
ВРУЧА́ТЬСЯ олгогдох, өгөгдөх.
ВРУЧЕ́НИЕ гардуулах, гардуулан өгөх, бариулах, шилжүүлэх, олгох; ~ **послом верительных грамот** элчин сайд итгэмжлэх бичгээ гардуулан өгөх.
ВРУЧЁННЫЙ олгогдсон, өгөгдсөн.
ВРУЧИ́ТЕЛЬ гардуулан өгөгч, бариулагч, олгогч.
ВРУЧИ́ТЬ 1. гардуулах, гардуулан өгөх, бариулах, олгох; ~ **письмо** захиа гардуулан өгөх; 2. даатгах, даалгах, мэдэлд өгөх; ~ **свою судьбу** хувь заяагаа даалгах.
ВРУЧНУ́Ю гараар.
ВРЫВА́ТЬ зоох, булах, ухаж суулгах.
ВРЫВА́ТЬСЯ 1. нэвтрэн орох, цөмрөн орох; 2. ухаж орох, малтаж орох.
ВРЫТЬ зоох, малтан суулгах; ~ **столбы в землю** газарт багана зоох.
ВРЫ́ТЬСЯ малтан орох, ухаж орох.
ВРЯД ЛИ юу л бол, ямар бол даа, үгүй байхаа; ~ **он придёт** тэр ирэхгүй байхаа.
ВСАДИ́ТЬ шаах, хадаах, хоноох; ~ **топор в бревно** сүх шургаатт хадаах.
ВСА́ДНИК морьтой хүн.
ВСА́ДНИЦА морьтой эмэгтэй, морь унасан эмэгтэй.
ВСА́ЖИВАТЬ шаах, хадаах, хоноох.
ВСА́СЫВАНИЕ сорох, соролт, хөхөх, шингээх.
ВСА́СЫВАТЬ сорох, хөхөх.
ВСА́СЫВАТЬСЯ 1. сорогдох, хөхөгдөх; 2. шингэх.
ВСЁ 1. ямагт, үргэлж, хэзээд, дандаа; **он ~ в разъездах** тэр үргэлж ийш тийш явсаар байна; 2. одоо болтол, - саар л; **дождь ~ ещё идёт** бороо орсоор л байна; 3. улам бүр; ~ **дальше** улам цаашаа; ~ **более и более** улам улам, улам бүр; 4. ч, гэсэн, гэвч; **как ни старается, ~ не выходит** хичнээн оролдлоо ч гэсэн бүтэхгүй байна; * ~ **же** ямар ч гэсэн; **~таки мужчина** ямар ч гэсэн эр хүн; **и ~ из-за тебя** цөм чамаас боллоо; ~ **равно** ялгаагүй, хамаагүй, яасан ч яах вэ.
ВСЁ бүгд, бүх,цөм, булт, бултаараа.
ВСЕВЕ́ДУЩИЙ 1. хамгийг айлдагч, бүхнийг мэдэгч; 2. мэдэмгий.
ВСЕВОЗМО́ЖНЫЙ янз янзын, элдэв янзын, янз бүрийн.
ВСЕГДА́ үргэлж, байнга, хэзээд, ямагт; ~ **готов** хэзээд бэлхэн.
ВСЕГДА́ШНИЙ үргэлжийн, байнгын.
ВСЕГО́ 1. дүн, бүгд, нийлсэн тоо; **израсходовано ~ сто рублей** бүгд зуун төгрөг зарцуулагдав; 2. - хан, - хэн, - хон, - хөн; **работа началась ~ два месяца назад** ажил хоёрхон сарын өмнө эхэлсэн; * **~навсего** зөвхөн, төдийхөн; **только и ~** ердөө л энэ, энэхэн л байна; ~ **хорошего** за баяртай.
ВСЕЗНА́ЙКА мэдэмгий хүн, их мэдэх.
ВСЕЗНА́ЙСТВО мэдэмгий, мэдэмгийлэх.
ВСЕЛЕ́НИЕ оруулан суулгах, байрлуулах, нүүлгэн оруулах.
ВСЕЛЕ́ННАЯ орчлон ертөнц, ертөнц.
ВСЕЛИ́||ТЬ 1. оруулж суулгах, нүүлгэж оруулах; **в квартиру ~ли нового жильца** байранд шинэ хүнийг оруулж суулгав; 2. оруулах, төрүүлэх; **его слова ~ли в нас уверенность** түүний үг нь бидэнд итгэл найдвар төрүүлэв; ~ **тревогу в сердце** зүрхэндтүгшүүр төрүүлэх.
ВСЕЛИ́ТЬСЯ 1. нүүж орох; 2. орох, төрөх.
ВСЕМЕ́РНО аль болохуйц, аль болохоор, бүх аргаар.
ВСЕМИ́РНО-ИСТОРИ́ЧЕСКИЙ бүх дэлхийн түүхт, даян дэлхийн түүхт, дэлхий дахины түүхт.
ВСЕМИ́РН||ЫЙ бүх дэлхийн, даян дэлхийн, дэлхий дахины, ертөнцийн; **~ое тяготение** ертөнцийн таталцахуй; ~ **банк** дэлхийн банк; **Всемирная торговая организация** Дэлхийн худалдааны байгууллага.
ВСЕМОГУ́ЩЕСТВО төгс хүч, хамгийг чадах.
ВСЕМОГУ́ЩИЙ хамгийг чадагч, төгс хүчит.
ВСЕНАРО́ДНЫЙ бүх ардын, хамаг ардын.
ВСЕО́БЩ||ИЙнийтийн, нийтээр, нийгмийн, хотол олны; **~ее избирательное право** нийтээр сонгох эрх.
ВСЕО́БЩНОСТЬ нийт, нэлэнхий, даяар.
ВСЕОБЪЕ́МЛЮЩИЙ хамарсан, цөмийг багтаасан, бүхнийг мэдэх.
ВСЕОРУ́ЖИ||Е во **~и** бүрэн зэвсэглээд, төгс зэвсмшин; **во ~и знаний** мэдлэгээр бүрэн зэвсэглээд.
ВСЕПОБЕЖДА́ЮЩИЙ бүхнийг ялах, хамгийг дийлэх.
ВСЕПОГЛОЩА́ЮЩИЙ сэтгэлийг бүрэн хамарсан, дур сэтгэлийг цөм булаасан.
ВСЕРДЦА́Х цухалдаж, уурлаад.
ВСЕРОССИ́ЙСКИЙ бүх оросын.
ВСЕРЬЁЗ 1. үнэн гэж, нээрээ гэж, үнэнээсээ; **принимать** ~ үнэн гэж бодох; 2. лавдуун, чармайж; **довольно гулять, пора ~ приняться за учение** зугаалахаа бользноод сурах ажилдаа лавдуун орох цаг боллоо.
ВСЕСИ́ЛИЕ хамгийг чадах, эрх хүч, төгс хүч.
ВСЕСИ́ЛЬНЫЙ хамгийг чадагч, төгс хүчит.
ВСЕСОЮ́ЗНЫЙ Бүх Холбоот Улсын, Бүх Холбоотын.
ВСЕСТОРО́ННИЙ нарийвчлан, аль ч талаар, бүх талаар, тал бүрээс.
ВСЕСТОРО́ННЕ бүх талаар, тал бүрээс нь; ~ **обсудить вопрос** асуудлыг тал бүрээс нь авч хэлэлцэх.
ВСЁ-ТАКИ бас л, тэгсэн ч, хэдий тийм боловч, ийгээс.
ВСЕУСЛЫ́ШАНИЕ во ~ өндөр дуугаар, олонд дуулдахаар; **говорить во** ~ өндөр дуугаар өгүүлэх, олны сонорт хүргэх.
ВСЕЦЕ́ЛО бүрнээр, бүрмөсөн; **это зависит** ~ **от вас** энэ танаас бүрмөсөн шалтгаална.
ВСЕЯ́ДН||ЫЙ холимог тэжээлтэн, юуг ч иддэг; **~ое животное** холимог тэжээлт адгуус.
ВСКА́КИВАНИЕ босон харайх, үсрэн гарах.
ВСКА́КИВАТЬ босон харайх, үсрэн гарах.
ВСКАРА́БКАТЬСЯ авирах, авиран гарах.
ВСКА́РМЛИВАНИЕ тэжээх, бордох; * **искусственное ~ ребёнка** хүүхэд угжих.
ВСКА́РМЛИВАТЬ хөхүүлэх тэжээх.
ВСКА́ЧЬ хар хурдаар харайлган, давхин.
ВСКИ́ДЫВАТЬ, ВСКИ́НУТЬ,1. хаях, шидэх; ~ **мешок на плечи** мөрөн дээрээ шуудай хаях; 2. өлсхийх; ~ **голову** толгойгоо өлсхийх.
ВСКИПА́НИЕ буцлах.
ВСКИПА́ТЬ 1. буцлах; 2. их уурлах.
ВСКИПЯТИ́ТЬ буцалгах.
ВСКЛОКО́ЧЕННЫЙ сагсайсан, өрвийсөн.
ВСКОЛЫХНУ́ТЬ намилзуулах, долгилуулах.
ВСКОЛЫХНУ́ТЬСЯ намилзах, долгилох.

ВСКО́ЛЬЗЬ хальт мөлт, өнгөцхөн, зэрвэсхэн.
ВСКО́ПАННЫЙ онгилсон, сэвсийлгэсэн, хөвсийлгөсөн.
ВСКОПА́ТЬ онгилох, хөвсийлгөх, сэвсийлгэх.
ВСКО́РЕ удалгүй, даруйхан.
ВСКОРМИ́ТЬ тэжээж өсгөх, бойжуулах.
ВСКОЧИ́||ТЬ 1. харайж орох, үсэрч мордох; ~ **на лошадь** моринд үсэрч мордох; 2. харайжбосох; ~ **с постели** хөнжлөөс харайн босох; 3. гэнэт гарах; **прыщ ~л на лбу** батга магнайд гэнэт гарав.
ВСКРИ́КИВАТЬ дуу тавих, бархирах, чарлах.
ВСКРИЧА́ТЬ хашгирах, бархирах.
ВСКРУЖИ́ТЬ, эргүүлэх; ~ **голову** толгой эргүүлэх.
ВСКРЫВА́ТЬ 1. нээх, задлах, уудлах; 2. хагалах; 3. илрүүлэх, олох.
ВСКРЫВА́ТЬСЯ 1. хагарах, задрах; 2. урсах, ханзрах; 3. илрэх.
ВСКРЫ́ТИЕ хагалах, задлах, ханзрах, илрэл, нээх, илрүүлэх.
ВСКРЫ́ТЬ 1. нээх, задлах; ~ **письмо** захидал нээх; 2. хагалах, эвдэх; ~ **труп** хүүр задлах; 3. илрүүлэх, олох; ~ **недостатки** дутагдлыг илрүүлэх.
ВСКРЫ||ТЬСЯ 1. хагарах; **нарыв ~лся** буглаа хагарлаа; 2. ханзрах; **река ~лась** гол ханзрав; 3. илрэх, олдох, тодрох; **недостатки в работе ~лись критикой** ажлын дутагдал шүүмжлэлээр илэрлээ.
ВСЛАСТЬ ханатал, бахаа ханатал, цадтал.
ВСЛЕД хойноос, араас нь; **послать** ~ хойноос нь явуулах.
ВСЛЕ́ДСТВИЕ үчир, учраас, тул; ~ **болезни** өвчний учраас.
ВСЛЕПУ́Ю харалгүй, мухар сохор, нүд балай.
ВСЛУХ дуулдахаар, дуудаж; **читать** ~ дуудаж унших.
ВСЛУ́ШАТЬСЯ чагнах, чих тавих, анхаарч сонсох.
ВСМА́ТРИВАТЬСЯ ажиглах, ширтэн үзэх.
ВСМЯ́ТКУ яйцо ~ шүүрхий болгосон өндөг, нялцгай өндөг.
ВСО́ВЫВАТЬ шургуулах, чихэх, хийх.
ВСОСА́ТЬ хөхөх, сорох, шингээх; * ~ **с молоком матери** хар нялхаасаа сурсан юм.
ВСОСА́||ТЬСЯ 1. шингэх, нэвтрэх; **вода ~лась в землю** ус шороонд шингэв; 2. сорогдох; 3. хөхөж сурах,
ВСПА́ИВАТЬ уулгах, тэжээх.
ВСПА́РЫВАТЬ ханз татах, хага татах.
ВСПА́ХАННЫЙ хагалсан.
ВСПАХА́ТЬ хагалах; ~ **целину** атар газар хагалах.
ВСПА́ШКА хагалах; **зяблевая** ~ намар паар хагалах.
ВСПЕ́НИВАТЬ 1. хөөсрүүлэх, хөөс сагуулах; 2. их хөлөргөх.
ВСПЕ́НИВАТЬСЯ хөөсрөх, хөөс сагах.
ВСПЕНИ́ТЬ 1. хөөсрүүлэх, хөөс сагуулах; 2. их хөлөргөх; ~ **коня** морио их хөлөргөх.
ВСПЕ́НИТЬСЯ хөөсрөх, хөөс сагах.
ВСПЛЕСК цалгиа, цалгих.
ВСПЛЕ́СКИВАТЬ 1. цалгиулах, цалгилуулах; 2. шагшрах, шогшрох.
ВСПЛЕСНУ́ТЬ 1. цалгиулах, цалгилуулах; 2. шагшрах, шогшрох; ~ **руками** зүхэн шагшрах.
ВСПЛОШНУ́Ю туж, үргэлж, нэлэнхүйдээ.
ВСПЛЫВА́ТЬ 1. хөвөх, хөөрөн гарах; 2. илрэх, илрэн гарах.
ВСПЛЫ||ТЬ 1. хөвөх, хөөрөн гарах; 2. илрэх, илрэн гарах; **~ли наружу недочёты** дутагдал илрэн гарав.
ВСПОЙТЬ уулгаж идүүлэх, угжиж өсгөх, торниулах.
ВСПОЛА́СКИВАТЬ зайлах.
ВСПОЛЗА́ТЬ авирч гарах, мөлхөж гарах.
ВСПОЛОШИ́ТЬ сандруулах, сандаргах, бахардуулах.
ВСПОЛОШИ́ТЬСЯ сандрах, бахардах.
ВСПОМИНА́ТЬ дурьдах, дурсах.
ВСПОМИНА́ТЬСЯ санагдах, дурсагдах, дурьдагдах.
ВСПОМОГА́ТЕЛЬН||ЫЙ туслах, дэмжих; ~ **глагол** туслах үйл үг; **~ая дорога** туслах зам.
ВСПОРО́ТЬ ханз татах, хага татах, задчих.
ВСПОРХНУ́||ТЬ дэгдэх, давхийх, дэрхийх; **птичка ~ла и улетела** шувуу дэрхийн нисэв.
ВСПОТЕ́ТЬ хөлрөх.
ВСПРЫ́ГИВАТЬ харайж гарах, үсэрч гарах.
ВСПРЫ́СКИВАТЬ 1. цацах, шүрших, үсэргэх; 2. мялаах; 3. тарих.
ВСПРЫСНУТЬ 1. цацах, шүрших, үсэргэх; ~ **цветы водой** цэцэгт ус шүрших; 2. мялаах; ~ **новую квартиру** шинэ байраа мялаах; 3. тарих.
ВСПУ́ГИВАТЬ үргээх, цочоох, айдас хүргэх, айлгах.
ВСПУХА́ТЬ хавагнах, хөвсийх, хөөх.
ВСПУ́ЧИВАНИЕ хөвсийлт.
ВСПУ́ЧИВАТЬ овойлгох, хөвсийлгөх, цүрдийлгэх.
ВСПЫЛИ́ТЬ унтууцах, цухалдах; ~ **из-за пустяков** яльгүй юманд цухалдах.
ВСПЫ́ЛЬЧИВОСТЬ унтуу цухал, түргэн уур.
ВСПЫ́ЛЬЧИВЫЙ цочмог ууртай, түргэн ууртай, цухалдуу.
ВСПЫ́ХИВАТЬ 1. гялс хийх, гал авалцах, дүрд хийх; 2. дэгдэх, гэнэт гарах, **вспыхнула война** дайн дэгдлээ.
ВСПЫ́ШКА 1. гялс хийх, гал авалцах, дүрд хийх; 2. улайх; ~ **гнева** уурлаж улайх.
ВСПЯТЬ гэдрэгээ, сөөргөө ухарч.
ВСТАВА́НИЕ босох, босоо зогсох.
ВСТАВА́ТЬ босох, өндийх, босоо зогсох.
ВСТА́ВИТЬ 1. суулгах, хийх, углах; ~ **стекло в раму** жаазанд шил суулгах; 2. хавчуулах, оруулах; ~ **слово в разговор** ярианд үг хавчуулах.
ВСТА́ВКА оруулга, нөхөөс.
ВСТАВЛЯ́ТЬ 1. суулгах, хийх, углах; 2. хавчуулах, оруулах.
ВСТАВЛЯ́ТЬСЯ суух, хийгдэх, тавигдах.
ВСТАВН||О́Й *хиймэл, шургуулдаг;* **~ые зубы** *хиймэл шүд;* ~ **шип** хиймэл углуурга.
ВСТАРЬ хуучин цагт, эрт урьд цагт.
ВСТА||ТЬ 1. босох, зогсох, босоо зогсох, өндийх; ~ **с места** суудлаас босох; ~ **на ковёр** хивсэн дээр зогсох; 2. гишгэх, зогсох; ~ **на стул** сандал дээр зогсох; 3. багтах; **стол ~нет между окнами** хоёр цонхны хооронд ширээ багтана; 4. гарах, ургах; **солнце ~ёт** нар гарч байна; 5. тохиолдох, учрах; **~ли препятствия** саад тохиолдов; 6. мордох, жагсах; ~ **на защиту родины** эх орноо хамгаалахаар мордох; 7. тулгарах; **перед ними ~л вопрос** тэдний өмнө асуудал тулгарав.
ВСТРЕВО́ЖИТЬ мэгдүүлэх, үймүүлэх, сэтгэл зовоох.
ВСТРЕВО́ЖИТЬСЯ мэгдэх, цочих, түгших.
ВСТРЁПАННЫЙ бөрзийсөн,үнгэгдсэн, салмарсан.
ВСТРЕПЕНУ́ТЬСЯ зог тусах, сэрвэд хийх, догдолс хийх.
ВСТРЕ́ТИ||ТЬ 1. уулзах, учрах, дайралдах, харгах; ~ **знакомого** танилтайгаа уулзах; 2. угтах, тосох; ~ **гостей на вокзале** төмөр замын буудал дээр зочдыг угтах; 3. хүлээн авах, угтаж авах; **его ~ли хорошо** түүнийг сайнаар хүлээн авлаа.
ВСТРЕ́ТИТЬСЯ уулзалдах, дайралдах.
ВСТРЕ́ЧА 1. учрах, уулзах, золгох; 2. угтлага, уулзалт, угтах; ~ **нового года** шинэ жилийг угтах.
ВСТРЕЧА́ТЬ 1. уулзах, учрах, дайралдах; 2. угтах, тосох; 3. хүлээж авах.
ВСТРЕЧА́ТЬСЯ уулзах, дайралдах, тохиолдох, учрах.
ВСТРЕ́ЧНЫЙ 1. сөрүү, эсрэг, зөрөлцөх; ~ **ветер** сөрүү салхи; ~ **поезд** зөрөлцөх галт тэрэг; 2. угтан, дайралдсан; ~ **бой** угтан байлдах; **первый** ~ аль дайралдсан хүн; ~ **и поперечный** аль уулзсан, дайралдсан хүн.

ВСТРЯ́СКА 1. сэгсрэх, гөвөх; 2. гэгж гинших; 3. гөвдөх.
ВСТРЯ́ХИВАТЬ сэгсрэх, сэгсчих, гөвөх, донслох.
ВСТРЯ́ХИВАТЬСЯ 1. шилгээх, гөвөгдөх; 2. сэргэх, хөхих, цэнгэх.
ВСТРЯХНУ́ТЬ сэгсрэх, сэгсчих, гөвөх, донслох; ~ **шубу** дээл сэгсрэх
ВСТРЯХНУ́||ТЬСЯ 1. шилгээх, гөвөгдөх; **птичка ~лась после дождя** шувуу бороонд дараа шилгээв; 2. сэргэх, хөхих, цэнгэх.
ВСТУПА́ТЬ элсэх, орох; ~ **на военную службу** цэргийн албанд орох; ~ **в партию** намд элсэх; * ~ **в брак** эр эм бололцох, гэрлэх.
ВСТУПА́ТЬСЯ өмгөөлөх, өмөөрөх; ~ **за кого-либо** ямар нэгэн хүнийг өмгөөлөх.
ВСТУПИ́ТЕЛЬН||ЫЙ оролтын, элсэлтийн, эхлэлтийн удиртгал; ~ **взнос** элсэлтийн татвар; **~ое слово** эхлэлтийн үг.
ВСТУПИ́||ТЬ 1. орох; **войска ~ли в город** цэрэг хотод оров; 2. элсэх; ~ **в партию** намд элсэх; 3. оролцох; ~ **в разговор** ярианд оролцох; 4. эхлэх; ~ **в переговоры** хэлэлцээ хийж эхлэх; ~ **в спор** маргаж эхлэх; 5. болох; ~ **в силу** хүчин төгөлдөр болох; ~ **во владение** эзэн болох; ~ **в брак** эр эм болох, гэр бүл болох; **весна ~ла в свои права** гүйцэд хавар боллоо,ёстой хавар боллоо.
ВСТУПИ́ТЬСЯ өмөглөх, өмөөрөх.
ВСТУПЛЕ́НИЕ оролт, элсэлт, удиртгал.
ВСУ́НУ||ТЬ хийх, дүрэх, шургуулах; **~л записную книжку в карман** тэмдэглэлийн дэвтрийг хармаандаа хийв.
ВСУХОМЯ́ТКУ хуурайгаар.
ВСУ́ЧИВАТЬ 1. томох, гөрөх; 2. атгуулах; 3. шааж өгөх.
ВСХЛИ́ПЫВАНИЕ мэгшин уйлах, сугшран ухилах, эхрэх.
ВСХОДИ́||ТЬ гарах, авирах; ~ **на трибуну** индэр дээр гарах; 2. ургах, мандах; **солнце ~т** нар мандаж байна; 3. хөөх, хөөрөх, бүлхийх; 4. цухуйх, соёолох.
ВСХО́ДЫ соёололт, цухуйц, ургалт.
ВСХО́ЖЕСТЬ ургах чанар, ургахуйц, ургамтгай.
ВСХО́ЖИЙ ургах, ургамтгай, ургахуйц.
ВСЫ́ПАТЬ хийх, юүлэх; ~ **муку в мешок** гурил шуудайд хийх.
ВСЮ́ДУ газар бүр, хаяагүй, газар сайгүй.
ВСЯ́К||ИЙ 1. бүр, бүх, ямар ч, аль ч; **во ~ое время** ямар ч цагт; **~ими путями** бүх аргаар; 2. аливаа хүн, ямар ч хүн, хэн ч; ~ **может это сделать** үүнийг хэн ч хийж чадна; * **во ~ом случае** юу ч гэсэн, ямар ч болсон; **на ~ случай** хэрэг болж магадгүй гээд, юу ч болтугай; **~ое бывает** элдвийн юм дайралдана; **~ой твари по паре** аавын хүү алагтай цоогтой, агтны унага алагтай булагтай.
ВСЯ́ЧЕСКИ элдэв аргаар, янз бүрээр.
ВСЯ́ЧЕСКИЙ элдэв, элдэв янзын, янз бүрийн.
ВСЯ́ЧИНА всякая ~ элдвийн юм, элдэв шалдвын юм.
ВТА́ЙНЕ нууцгай, далдуур, битүү, дотроо.
ВТА́ЛКИВАТЬ чихэх, түлхэн оруулах.
ВТА́ПТЫВАТЬ гишгэчих, нухчих.
ВТА́СКИВАТЬ чирж оруулах, зөөж оруулах.
ВТАЧА́ТЬ хавчаас, барьж оёх, хавчааслах.
ВТАЩИ́ТЬ чирж оруулах, зөөж оруулах.
ВТЕКА́ТЬ цутгах, урсаж орох.
ВТЁМНУЮ харалгүй, нүд балай, таамгаар,
ВТЕМЯ́ШИТЬ арай гэж ойлгуулах.
ВТЕМЯ́ШИ||ТЬСЯ хадаж орох; **~лось ему в голову** сэтгэлд нь хадаж орлоо.
ВТЕРЕ́ТЬ түрхэх, үрдэж шингээх; * ~ **очки** нүд алдуулах залилах.
ВТЕРЕ́ТЬСЯ 1. нэвтрэн шингэх; 2. чихэлдэн орох; ~ **в толпу** олны дотор чихэлдэн орох; 3. шургалж орох, нүүр тал олох.
ВТЕЧЬ гоожин орох, урсаж орох.
ВТИРА́НИЕ 1. түрхэж шингээх; 2. түрхлэг.
ВТИРА́ТЬ түрхэх, үрдэж шингээх; * ~ **очки** нүд алдуулах, залилах.
ВТИРА́ТЬСЯ 1. нэвтрэн шингэх; 2. чихэлдэн орох; 3. шургалж орох, нүүр тал олох.
ВТИ́СКИВАТЬ чихэж оруулах, шахаж оруулах, хавчуулах.
ВТИ́СКИВАТЬСЯ чихэлдэн орох, шахалдан орох.
ВТИХОМО́ЛКУ сэмхэн, далдуур, чимээгүйхэн.
ВТОЛКНУ́ТЬ түлхэж оруулах, чигчих.
ВТОЛКОВА́ТЬ тайлбарлан таниулах, сэнхрүүлэх.
ВТОПТА́ТЬ гишгэчих, далдартал гишгэчих; * ~ **кого-либо в грязь** хэн нэгнийг шаварт суулгах, хэн нэгнийг нухчин дарлах.
ВТОРГА́ТЬСЯ халдан орох, цөмрөн орох.
ВТОРЖЕ́НИЕ халдан орох, цөмрөн орох; ~ **в чужую область** хүний газар халдан орох.
ВТО́РИТЬ дахих, давтах, дууриан дугарах, дагалдан хэлэх.
ВТОРИ́ЧНО 1. дахин, дахиж; ~ **просить** дахиж гуйх; 2. хоёрдох.
ВТО́РНИК ангараг, мягмар, хоёрдох өдөр.
ВТОРОГО́ДНИК жил улирсан сурагч, анги дэвшээгүй сурагч.
ВТОР||О́Й 1. хоёрдугаар, дэд; 2. хоёрон, хоёрны өдөр; **~ое число мая** тавдугаар сарын хоёрны өдөр.
ВТОРОКЛА́ССНИК хоёрдугаар ангийн сурагч.
ВТОРОКЛА́ССНИЦА хоёрдугаар ангийн бүсгүй сурагч охин.
ВТОРОПЯ́Х яараад, яарч сандрахдаа, яарахдаа.
ВТОРОРАЗРЯ́ДНЫЙ хоёрдугаар зэргийн.
ВТОРОСО́РТНЫЙ хоёрдугаар зэргийн, зэхийхэн, барагтайхан.
ВТОРОСТЕПЕ́ННЫЙ хоёрдугаар зэргийн, дунд хирийн.
В-ТРЕ́ТЬИХ гуравдугаарт, гуравд.
ВТРИ́ДОРОГА учиргүй үнэтэй, гурван давхар үнэтэй.
ВТРО́Е гурван давхар, гурав дахин; **увеличить** ~ гурав дахин өсгөх.
ВТРОЁМ гурвуул.
ВТРОЙНЕ́ гурав дахин их.
ВТУЗ, *(Высшее техническое учебное заведение)* техникийн дээд сургууль.
ВТУ́ЛКА 1. холхивч, цөн; 2. бөглөө, таглаа.
ВТЫКА́ТЬ хатгах, чичих, шаах.
ВТЫКА́ТЬСЯ хатгагдах, шаагдах, чичигдэх.
ВТЯ́ГИВАТЬ татах, татан оруулах, сорох, хураах.
ВТЯ́ГИВАТЬСЯ 1. татагдан орох; 2. хонхойх; 3. дадах, дадал олгох.
ВТЯНУ́||ТЬСЯ 1. татагдан орох; 2. хонхойх; **у больного щёки ~лись** өвчтэй хүний хацар нь хонхойжээ; 3. дадах, дадал олох; ~ **работу** ажилд дадах.
ВУАЛИ́РОВАТЬ бүрхэгдүүлэх.
ВУА́ЛЬ 1. гивлүүр, торон бүрхэвч; 2. торон шаа; 3. зэвхий толбо.
ВУ́ДСИЯ *бот.* барагжаа.
ВУЗ *(Высшее учебное заведение)* дээд сургууль.
ВУ́ЗОВСКИЙ дээд сургуулийн.
ВУЛКА́Н галт уул; **потухший** ~ сөнөсөн галт уул.
ВУЛКАНИЗА́ЦИЯ халааж нөхөх, халааж боловсруулах.
ВУЛКАНИЗИ́РОВАТЬ хүхэрдүүлэх, резин халааж боловсруулах.
ВУЛКАНИ́ЧЕС||КИЙ галт уулын, дэлхийн дотоод хүчний; **~ие породы** галт уулын чулуулаг.
ВУЛЬГАРИЗА́ТОР хазайлгагч, гуйвуулагч.
ВУЛЬГАРИЗА́ЦИЯ хазайлгах, гуйвуулах.

ВУЛЬГАРИЗИ́РОВАТЬСЯ, хазайх, гуйвах.
ВУЛЬГАРИ́ЗМ баазхан үг, бүдүүлэг үг, балиар үг.
ВУЛЬГА́РНО бүдүүлэг, балиар, булай.
ВУЛЬГА́РНОСТЬ бүдүүлэг, балиар, бузар булай.
ВУЛЬГА́РНЫЙ балиар, бүдүүлэг, булай.
ВХОД 1. орох газар, хаалга үүд; **главный ~** гол хаалга; 2. орох; **~ воспрещён** орж болохгүй; **плата за ~** орохын төлбөр, орох билетийн үнэ.
ВХОДИ́||ТЬ 1. орох; **~ в дом** гэрт орох; 2. оролцох; **он сам ~т во все дела** тэр өөрөө бүх хэрэгт оролцдог; 3. багтах; **в бочонок ~т одно ведро** торхонд ганц хувин багтана; 4. эхлэх, болох; **~т в употребление** хэрэглэгдэж эхлэх; * **~т в долги** өрөнд баригдах; **~ в лета** насжих; **~ в доверие** итгэгдэх; **~ в силу** хүчин төгөлдөр болох.
ВХОДН||О́Й орох, орохын; **~ая дверь** орох үүд.
ВХОДЯ́Щ||ИЙ 1. орох, оролцох; 2. орсон, ирсэн; **~ая бумага** ирсэн бичиг; **~ журнал** ирсэн бичгийн данс; 3. дотор; **~ угол** дотор өнцөг.
ВХОЖДЕ́НИЕ орох, оролт.
ВХО́ЖИЙ оромтгой, явамтгай, ордог; **он вхож в этот дом** энэ гэрт тэр хүн ордог юм.
ВХОЛОСТУ́Ю бүтэцгүй, ашиггүй, урагшгүй; **работать ~** бүтэцгүй ажиллах.
ВЦЕПИ́ТЬСЯ асах, ноцох, зууралдах.
ВЦСПС *(Всесоюзный Центральный Совет профессиональных союзов)* БХҮЭТЗ (Бүх Холбоотын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл).
ВЧЕРА́ өчигдөр.
ВЧЕРА́ШНИЙ өчигдрийн.
ВЧЕРТИ́ТЬ зурах, багтааж зурах.
ВЧЕ́ТВЕРО дөрвөн давхар, дөрөв дахин, дөрөв; **увеличить ~** дөрөв дахин өсгөх; **сложить ~** дөрөв нугалах.
ВЧЕТВЕРО́М дөрвүүл.
В-ЧЕТВЁРТЫХ дөрөвдүгээрт, дөрөвд.
ВЧИТА́ТЬСЯ хянаж унших, сайн унших, уншиж ойлгох.
ВЧУ́ЖЕ хөндлөнгөөс, хажуу талаас; **мне его ~ жаль** би түүнийг хөндлөнгөөс өрөвдөх юм.
ВШЕ́СТЕРО зургаан давхар, зургаа дахин.
ВШИВА́ТЬ зүйх, оёх, үдэх.
ВШИВА́ТЬСЯ зүйх, оёх, үдэгдэх.
ВШИВНО́Й зүйдэлтэй, залгаастай.
ВШИ́ВЫЙ бөөстэй, бөөсөндөө баригдсан.
ВШИРЬ хөндлөөшөө, өргөөшөө, өргөн тийшээ; **раздаться ~** өргөөшөө сунах.
ВШИТЬ 1. зүйх, залгаж оёх; **~ рукав в рубаху** цамцанд ханцуй залгаж оёх; 2. үдэх; **~ бумагу в папку** хавтсанд бичиг үдэх.
ВЪЕДА́ТЬСЯ шингэх, идэж сурах.
ВЪЕЗД орох, нэвтрэн орох, орох газар.
ВЪЕЗЖА́ТЬ орох, орж ирэх, орж суух.
ВЪЕ́ХАТЬ 1. орох, нэвтрэн орох, орж ирэх; **~ во двор** хашаанд орох; 2. орж суух, нүүж орох; **~ в квартиру** байранд орж суух.
ВЫ, та, та нар; **что с вами?** та яагаа вэ? **благодарю вас** танд баярлалаа.
ВЫБА́ЛТЫВАТЬ задруулан чалчих, задруулах; **~ секрет** нууцыг задруулан чалчих.
ВЫБЕГА́ТЬ гүйж гарах.
ВЫБЕЛИ́ТЬ цайруулах, цагаанаар будах, цагаан болгох.
ВЫБИВА́ТЬ ховх цохих, цохих, гөвөх, арилгах.
ВЫБИВА́ТЬСЯ арай чамай гарах, арай гэж мултрах.
ВЫБИРА́ТЬ шилэх, шилж авах, шигших, сонгох.
ВЫБИРА́ТЬСЯ арай гэж гарах, чуу чамай гарах, мултрах.
ВЫБИ́ТЬ 1. ховх цохих, мулт цохих, цөм цохих; **~ из седла** эмээлээс ховх цохих; **~ стекло** шил цөм цохих; 2. гөвөх, сэгсрэх; **~ ковёр** хивс гөвөх; 3. дэлдэх, цутгах; **~ монету** зоос дэлдэх; * **~ из колеи** замыг алдуулах, барилыг алдуулах.
ВЫБИ́ТЬСЯ 1. арай гэж гарах, арайхан мултрах; **~ из толпы** олны дундуур арай гэж гарах; 2. барах, алдах; **~ из сил** хүчээ барах; 3. цухуйх, булталх; **волосы выбились из-под шляпы** малгай доогуур үс нь цухуйв.
ВЫБОИНА хонхор, цөмөрхий газар, сэв гарах.
ВЫБОЛТА́ТЬ үг алдах, үг задруулах, чалчих.
ВЫБО́Р 1. шилэх, шилэлт; **брать на ~** шилж авах; **остановить свой ~** шилж авах; 2. сонгох сонголт; **~ы в совет** зөвлөлийн гишүүдийг сонгох; **собрание избирателей для ~ов** сонголт хийх сонгогчдын хурал; **~ проектного решения** зураг төслийн шийдэл, сонголт.
ВЫБО́РК||А түүвэрлэх, түүвэр; **делать ~и** түүвэрлэн авах, түүвэр хийх.
ВЫБО́РНОСТЬ сонгуульт ёс, сонгож байгуулах, сонгуулиар томилох.
ВЫБО́РНЫЙ 1. сонгуулийн, сонголтын; 2. сонгогдсон хүн.
ВЫБО́РОЧН||ЫЙ түүвэр, түүвэрлэсэн; **~ое обследование** түүвэрлэсэн шинжилгээ.
ВЫБО́РЩИК сонгогч, сонголтын төлөөлөгч.
ВЫБО́РЫ сонгууль, сонголт; **всеобщие, равные и прямые ~ при тайном голосовании** нууц санал хураах журмаар явуулах бүх нийтийн тэгш шууд сонгууль.
ВЫБРА́НИТЬ хараах.
ВЫБРА́СЫВАТЬ хаях, гаргах.
ВЫБРА́СЫВАТЬСЯ харайж буух, үсэрч буух.
ВЫБРА́ТЬ 1. шилэх, шилж авах; **~ профессию** мэргэшил шилж авах; 2. сонгох; 3. ялгах, түүвэрлэх; **~ ягоды** жимс ялгах; 4. уудлах, уудалж гаргах; **~ всё из коробки** хайрцгаас бүгдийг уудалж гаргах.
ВЫБРА́ТЬСЯ 1. арай гэж олж гарах, олж гарах; **~ из леса на дорогу** ой дотроос замаа арай гэж олж гарах; 2. мултрах, ангижрах; **~ из затруднения** бэрхшээлээс ангижрах; 3. зав олох; **найти время ~ в театр** театрт очих зав олох.
ВЫБРИ́ТЬ хусах, авах; **~ голову** үс хусах, үс авах.
ВЫБРИ́ТЬСЯ үсээ хусуулах, үсээ авахуулах, хусах.
ВЫБРОСИ́ТЬ 1. хаях, гадагш хаях; **~ из окна** цонхоор гаргаж хаях; 2. гаргах; **~ товар на рынок** зах зээлд бараа гаргах.
ВЫБРОСИ́ТЬСЯ харайж буух, үсэрч буух.
ВЫБЫВА́ТЬ мордох, гарах, зайлах, огцрох.
ВЫБЫ́ТИ||Е за ~ем очсон дээрээс, явсан учраас.
ВЫБЫ́ТЬ мордох, гарах, зайлах, огцрох; **~ из города** хотоос мордох; **~ из строя** жагсаалаас гарах.
ВЫВА́ЛИВАТЬ унагаах, өнхрүүлэх, алдах.
ВЫВА́ЛИВАТЬСЯ унах, ойчих.
ВЫВА́ЛЯТЬ өнхрүүлэх, хөрвүүлэх, хөлбөрүүлэх.
ВЫВА́ЛЯТЬСЯ өнхрөх, хөлбөрөх, хөрвөх.
ВЫВА́РИВАТЬ чанах, чанаж бэлтгэх, болгох.
ВЫВА́РИВАТЬСЯ чанагдах.
ВЫВА́РКА чанах, үлтэртэл чанах.
ВЫВА́РОЧНЫЙ чанасан, чанах.
ВЫВЕДА́ТЬ сураглах, сурвалжлах, лавлах, заншлах.
ВЫВЕДЕ́НИЕ 1. арилгах, гаргах; 2. ургуулах, бойжуулж гаргах; **~ новых сортов пшеницы** шинэ зүйлийн буудайг бойжуулж гаргах.
ВЫВЕЗТИ 1. гадагш гаргах, зөөх; 2. авчрах; 3. нэвтрүүлэн гаргах.
ВЫВЕРИ́ТЬ шалгах, тааруулах; **~ часы** цаг тааруулах.
ВЫВЕРНУ́ТЬ сугалж авах, мушгиж авах, эрэгдэж авах; **~ лампочку** лампа эрэгдэж авах; 2. булгалах; 3. урвуулах,

гадагш эргүүлэх; ~ **карманы** хавтгаа урвуулах, хармаанаа эргүүлэх.

ВЫВЕРНУТЬСЯ 1. сугарах, эргэж мултрах; 2. булгарах; 3. урвах, гадагш эргэх.

ВЫ́ВЕРТ 1. нахилзах, годгонох, огдгонох; **отплясывать с ~ами** нахилзан бүжиглэх; 2. ороцолдсон үг.

ВЫВЁРТЫВАТЬ урвуулах, сугалах, булгалах.

ВЫВЁРТЫВАТЬСЯ 1. мултрах, сугарах; 2. булгарах; 3. гадагш эргэх.

ВЫВЕРЯ́ТЬ шалгах, тааруулах.

ВЫ́ВЕСИТЬ 1. өлгөх, наах; ~ **флаги** далбаа өлгөх; ~ **объявление** зарлал наах; 2. жигнэж үзэх, чигнэж үзэх, дэнсэлж шалгах.

ВЫ́ВЕСКА 1. илэрхийлэл, өлгөөс, хаяг; 2. халхавч; 3. жинлэх, дэнслэх.

ВЫ́ВЕСТИ 1. гаргах; ~ **лошадь из конюшни** саравчнаас морь гаргах; ~ **из состава президиума** тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнээс гаргах; 2. арилгах; ~ **пятна** толбыг арилгах; 3. бойжуулах; ~ **цыплят** дэгдээхий бойжуулах; 4. барих, босгох; ~ **стену** туурга босгох; 5. дүрслэн үзүүлэх; **писатель вывел в повести тип рабочего** зохиолч туужиндаа ажилчдын нийтлэг дүрийг дүрслэн үзүүлэв; * ~ **из терпения** тэсвэрлэх аргагүй болгох; ~ **на чистую воду** гэмийг илрүүлэх; ~ **на широкую дорогу** цагаан замд оруулах, зөв замд оруулах.

ВЫ́ВЕСТИСЬ 1. алга болох, үгүй болох, устах; 2. гарах, бойжих.

ВЫВЁТРИВАНИЕ салхинд элэгдэх, өгөршил, өгөршил.

ВЫВЁТРИВАТЬ 1. салхи оруулах, салхинд гарах; 2. элэгдэх, өгөрших; 3. мартуулах.

ВЫВЁТРИВАТЬСЯ 1. салхинд цэвэрших; 2. өгөрших, элэгдэх; 3. мартагдах.

ВЫВЁШИВАТЬ 1. өлгөх, наах; 2. дэнсэлж үзэх, чигнэж шалгах.

ВЫВЁШИВАТЬСЯ 1. өлгөгдөх, наагдах; 2. дэнслэгдэх, чигнэгдэх.

ВЫ́ВИНТИТЬ шураг сугалах, шураг мултлах, мушгиж авах.

ВЫ́ВИНТИТЬСЯ мултрах, шураг мултрах.

ВЫ́ВИХ үе мултрах, булгалах, булгарах.

ВЫ́ВИХНУТЬ үе мултрах, булгалах; ~ **ногу** хөлөө булгалах.

ВЫ́ВОД 1. дүгнэлт, гаргалт; **ложный** ~ ташаа дүгнэлт; 2. гаргах; ~ **информации** машинаас мэдээллийг гаргах.

ВЫВОДИ́ТЬ 1. гаргах; 2. арилгах, үгүй болгох; 3. бойжуулах; 4. барих, босгох; 5. дүрслэн үзүүлэх.

ВЫВОДИ́ТЬСЯ 1. алга болох, үгүй болох; 2. гарах, бойжих.

ВЫ́ВОДОК нялх зулзага, улаан цурав, ангаахай.

ВЫ́ВОЗ 1. гадаадад гаргах зүйл, экспорт; 2. зөөж гаргах.

ВЫВОЗИ́ТЬ 1. гадагш гаргах, гадагш нэвтрүүлэх; 2. зөөж гаргах.

ВЫВОЗИ́ТЬСЯ 1. гадагш гаргах, гадаадад нэвтрэх, авчрах; 2. зөөж гаргах.

ВЫ́ВОЗКА зөөж гаргах, гаргах, аваачих.

ВЫВОЗН||О́Й 1. гадагш гаргах; ~**ая пошлина** гадагш гаргахын үүрвэн; 2. зөөж гаргах.

ВЫВОЛА́КИВАТЬ чирж гаргах.

ВЫВОРА́ЧИВАТЬ урвуулах, гадагш эргүүлэх.

ВЫВОРА́ЧИВАТЬСЯ гадагш эргэх.

ВЫ́ВОРОТ шиворот на ~ урвуу.

ВЫ́ВОРОТИТЬ малтаж гаргах, онгилон гаргах, оглоруулах; ~ **камень из земли** газраас чулуу онгилон гаргах; 2. урвуулж гаргах, гадагш эргүүлэх, онгичих.

ВЫ́ВИХ мултрах; ~ **челюсти** эрүү мултрах.

ВЫ́ГАДАТЬ ашиг олох, хонжих, арвилах.

ВЫ́ГИБ матгар, тахигар, нугалаас.

ВЫГИБА́НИЕ нугалах, тахийлгах, матах.

ВЫГИБА́ТЬ матах, нугалах, гүдийх.

ВЫГИБА́ТЬСЯ матийх, хотойх, нугарах.

ВЫ́ГЛАДИТЬ тэнийлгэх, индүүдэх, илүүрдэх.

ВЫ́ГЛЯД||ЕТЬ үзэгдэх, харагдах, царайтай байх; **она ~ит моложе своих лет** тэр овор багатай; **вы хорошо ~ите** таны царай сайхан байна.

ВЫГЛЯ́ДЫВАТЬ 1. шагайх; 2. булталх, цухуйх.

ВЫ́ГЛЯНУ||ТЬ 1. шагайх; ~ **из окна** цонхоор шагайх; 2. булталх, цухуйх; **из-за туч ~ла луна** үүлний цаанаас сар цухуйв.

ВЫ́ГНАТЬ 1. хөөж гаргах; ~ **из дому** гэрээс хөөж гаргах; 2. туух, залах; ~ **скот на пастбище** бэлчээрт мал туух; 3. нэрэх, нэрж гаргах; ~ **дёготь** давирхай нэрэх.

ВЫ́ГНУТЫЙ матгар, матмал, нугархай.

ВЫ́ГНУТЬ матах, нугалах.

ВЫ́ГНУТЬСЯ матайх, нугарах, бөгцийх.

ВЫГОВА́РИВАТЬ 1. дуудах, үгүүлэх; 2. донгодох, зэмлэх; 3. хэлэлцэж тохирох.

ВЫ́ГОВОР 1. аялга, хэллэг; **чистый** ~ цэвэрхэн аялга; 2. донгодох, зэмлэх; **строгий** ~ хатуу донгодох.

ВЫ́ГОДА ашиг, завшаан, хонжоо.

ВЫ́ГОДНО ашигтай, завшаантай.

ВЫ́ГОДНЫЙ дөхөмтэй, ашигтай.

ВЫ́ГОН билчээр, билчээх.

ВЫГОНЯ́ТЬ 1. хөөж гаргах; 2. билчээх; 3. нэрэх.

ВЫГОРА́ЖИВАТЬ 1. хаших, хороолох; 2. хаацайлах, өмгөөлөх; ~ **приятеля** найзыгаа хаацайлах.

ВЫГОРА́||ТЬ 1. бүр шатах, хуу шатах; 2. онгох, гандах; **одежда ~ет на солнце** хувцас наранд гандана.

ВЫ́ГОРОДИТЬ 1. хороолох, хүрээлэх, хаших; 2. хаацайлах, өмгөөлөх.

ВЫ́ГРАВИРОВАТЬ сийлбэрлэх.

ВЫГРЕБА́ТЬ 1. үтгаж гаргах, малтаж авах; 2. сэлэх, самран явах.

ВЫГРЕБН||О́Й асгах, арилгах, бохирын; ~**ая яма** бохирын нүх, муу усны нүх.

ВЫГРУЖА́ТЬ ачаа буулгах.

ВЫГРУЖА́ТЬСЯ ачаа буух, ачаа буулгагдах.

ВЫ́ГРУЗКА ачаа буулгах..

ВЫГРЫЗА́ТЬ химлэх, цоо мэрэх.

ВЫДАВА́ТЬ 1. өгөх, олгох; 2. барьж өгөх, зааж өгөх; 3. мэдэмгийрэх, мэргэмших.

ВЫДАВА́ТЬСЯ 1. цухуйх, хушууран орох; 2. өгтөх, олгогдох, өгөх, олгох; 3. ялгаран гарах.

ВЫ́ДАВИТЬ 1. шахах, шахаж гаргах; ~ **сок из моркови** луувангийн шүүсийг шахаж гаргах; 2. хэмх дарах, цөм дарах; ~ **стекло** шил хэмх дарах; 3. дарах, хэв гаргах; ~ **знак на металле** төмөрлөг дээр тэмдэг дарах; * ~ **слёзы** хүчээр уйлах; ~ **улыбку** хүчээр инээмсэглэх.

ВЫДА́ИВАТЬ саах, сүү саах.

ВЫДА́ЛБЛИВАТЬ 1. төнхөх, нухах; 2. цээжлэх.

ВЫ́ДАТЬ 1. өгөх, олгох; ~ **удостоверение** үнэмлэх олгох; 2. илчлэх; ~ **себя** өөрийгөө илчлэх; 3. мэт болох, шиг дүр үзүүлэх, гэж мэдээрхэх; ~ **себя за знатока** юм мэдэх хүний дүр үзүүлэх.

ВЫ́ДА||ТЬСЯ 1. цухуйж гарах; **дом ~лся углом на площадь** байшин өнцгөөрөө талбай дээр цухуйн гарчээ; 2. болох, тохиолдох, олдох; **~лся солнечный день** нартай өдөр боллоо; **~лся удобный случай** аятайхан учир тохиолдлоо.

ВЫ́ДАЧА 1. түгээх, олгох; ~ **информаций** машинаас мэдээллийг гаргах; 2. олгосон юм; 3. шилжүүлж өгөх.

ВЫДАЮЩИЙСЯ гарамгай сод, товойн гарсан; ~ **учёный** гарамгай эрдэмтэн.
ВЫДВИГА́ТЬСЯ 1. тавих, түрэгдэх, түрж тавих; 2. дэвших, нэр цохогдох; 3. сугарах, хөдлөх, холхих.
ВЫДВИЖЕ́НЕЦ дэвшсэн хүн.
ВЫДВИЖЕ́НИЕ дэвшүүлэх, дэвших.
ВЫДВИЖН||О́Й сугардаг, шургуулга, автах; **шкаф с ~ыми ящиками** шургуулгатай шүүгээ.
ВЫ́ДВИНУТЬ 1. түлхэж тавих, урагш тавих, урагш түлхэх; ~ **стол на середину комнаты** тасалгааны дунд ширээг түлхэж тавих; 2. дэвшүүлэх, нэр гаргах; ~ **на должность** албан тушаалд дэвшүүлэх; 3. тавих, гаргах; ~ **доказательства** нотолгоо гаргах; 4. сугалах, татах; ~ **ящик** шургуулга татах.
ВЫ́ДВИНУТЬСЯ 1. дэвших, урагш ахих; 2. сугарах, татах; 3. тодрон гарах, давшин гарах.
ВЫ́ДВОРИТЬ байраас нь албадан гаргах, албадаж нүүлгэх.
ВЫ́ДЕЛ өмч олгох, оногдсон хувь.
ВЫ́ДЕЛАТЬ 1. элдэх, боловсруулах; 2. урлах.
ВЫДЕЛЕ́НИЕ 1. ялгаруулах, ялгаж өгөх, тасалж өгөх, өмчийг олгох, тусгаарлах; 2. гарах, гоожих, гоождос, ялгадас; ~ **пота** хөлс гарах.
ВЫ́ДЕЛИТЬ 1. хуурааарилж өгөх, гаргаж өгөх; ~ **участок для строительства** барилга барих газар гаргаж өгөх; 2. ялгаж бичих, онцгойлох; ~ **особым шрифтом** тусгай үсгээр ялгаж бичих; 3. гаргах, гоожуулах; ~ **пот** хөлс гаргах; 4. онцлон тэмдэглэх.
ВЫ́ДЕЛИТЬСЯ 1. салах, тусгаарлах; 2. ялгаран гарах, товойх; 3. гарах, гоожих, тусах.
ВЫ́ДЕЛКА элдүүр.
ВЫДЕ́ЛЫВАТЬ 1. элдэх, боловсруулах; 2. хийх, үйлдвэрлэх.
ВЫДЕ́ЛЫВАТЬСЯ 1. элдэх, элдэгдэх; 2. хийх, хийгдэх.
ВЫДЕЛЯ́ТЬ 1. хуваарилж өгөх, гаргаж өгөх; ~ **часть имущества** юмны хэсгийг хуваарилж өгөх; 2. ялгаж тэмдэглэх; 3. гаргах, гоожуулах.
ВЫДЕРГАТЬ сугалах, суга татах,зулгаах, сэмлэх; ~ **все сорняки** бүх хог ургамлыг зулгаах.
ВЫДЁРГИВАТЬСЯ сугарах, мултрах, сэмлэх.
ВЫ́ДЕРЖАННОСТЬ тэвчээр, тэсвэртэй; ~ **характера** тэсвэртэй зан.
ВЫ́ДЕРЖАНН||ЫЙ 1. тэсвэртэй, тэвчээртэй; 2. дарагшмал, удсан, хадгалсан; ~**ое вино** удсан дарс.
ВЫ́ДЕРЖ||АТЬ 1. даах; **лёд ~ит машину** мөс машиныг даана; 2. тэсэж өнгөрөөх, тэсвэрлэх; ~ **операцию** мэс заслыг даах; 3. давж гарах, давах; ~ **экзамен** шалгалтыг давах; 4. хуршуулах, удаан дарах, дарагшуулах; ~ **вино** архи дарагшуулах; 5. байлгах; ~ **больного в постели** өвчтэй хүнийг хэвтүүлж байлгах; * **не ~ивает критику** шүүмжлэл даахгүй юм; ~ **несколько изданий** хэд дахин хэвлэгдэх.
ВЫ́ДЕРЖК||А 1. иш татах; **привести ~у из книги Ленина** Ленины номоос иш татах; 2. тэсвэр, биеэ барьж чадах, тогтвор; 2. барилт, хугацуур; **фотографировать с большой ~ой** удаан барилттай зураг авах.
ВЫ́ДЕРНУТЬ суга татах, мулт татах.
ВЫ́ДЕРНУТЬСЯ сугарах, мулт үсрэх.
ВЫДИРА́ТЬ хуу татах, урж авах.
ВЫДОЛБИТЬ 1. төнхөх, цоолох, ухах, хонхойлгох; 2. цээжлэх.
ВЫ́ДОХ амьсгаа гаргах, гадагш амьсгаалах.
ВЫ́ДОХНУТЬСЯ сулрах, улбайх.
ВЫ́ДРА халиу.
ВЫ́ДРАТЬ 1. хуу татах, урж авах; ~ **лист из тетради** дэвтрээс хуудас урж авах; 2. чангаах, мушгих; ~ **за уши** чихийг мушгих.
ВЫ́ДРЕССИРОВАТЬ сургах, адгуус сургах, дадлагажуулах.
ВЫ́ДУБИТЬ арьс идээлэх, шүүлэх, идээлж элдэх.
ВЫДУВА́НИЕ үлээх.
ВЫДУВА́ТЬ үлээх, хийлэх.
ВЫДУВА́ТЬСЯ үлээгдэх.
ВЫ́ДУМАНН||ЫЙ санаанаас авсан, санаагаараа зохиосон, хуурмаг; ~**ая история** санаагаараа зохиосон явдал.
ВЫ́ДУМАТЬ 1. санаачлах, санаагаар зохиох; 2. худал хэлэх.
ГЕРБ сүлд; тэмдэг; **государственный** ~ төрийн сүлд.
ГЕРБА́РИЙ ургамлын түүвэр; хатаадас.
ГЕ́РБОВ||ЫЙ тэмдэгт; сүлдэт; **~ая бумага** тэмдэгт цаас; ~ **сбор** тэмдэгтийн татвар.
ГЕРБИЦИ́ДЫ гербицид.
ГЕРКУЛЕ́С 1. аварга, баатар; 2. хэмхдэс, овьёос.
ГЕРМА́НЕЦ герман хүн.
ГЕРМАНИЗА́ЦИЯ германчлах.
ГЕРМАНИ́ЗМ германизм, герман хэллэг.
ГЕРМАФРОДИ́Т хиосгон, саармаг хүн амьтан, манин хүн.
ГЕРМЕТИ́ЧЕСКИЙ бин битүү.
ГЕРМЕТИЗА́ЦИЯ бин битүүлэх.
ГЕРОИ́ЗМ баатарлаг, баатар зүттэл.
ГЕРО́ИКА баатар явдал, чин зоригт явдал.
ГЕРОИ́НЯ баатар, эмэгтэй баатар.
ГЕРОНТОЛО́ГИЯ бие махбодийн өтлөлт, хөгшрөлтийг судлах ухаан.
ГЕРОИ́ЧЕСК||ИЙ баатарлаг, баатар зоригт, чин зоригт, хийморьтой, **~ая борьба** баатарлаг тэмцэл; ~ **дух** хий морьтой байдал.
ГЕРО́Й баатар, чин зоригт; ~ **Труда** хөдөлмөрийн баатар; ~ **повести** туужийн баатар.
ГЕРО́ЙСКИЙ баатарлаг, эр зоригт; ~ **поступок** баатарлаг явдал.
ГЕРО́ЙСТВО баатар зориг, баатар явдал.

ГЕРО́ЛЬД зарч.
ГЕ́РЦОГ герцог, бэйс.
ГЕ́РЦОГСТВО 1. герцогийн хэргэм; 2. герцогийн нутаг.
ГЕ́ТМАН гетман дарга.
ГЕ́ТРЫ түрий, шагайвч.
ГЕ́ТТО хорих газар.
ГИАЦИ́НТ хэлгий цэцэг.
ГИ́БЕЛЬ 1. сөнөх, үхэл, сүйрэл; 2. үй түм, тоо томшгүй.
ГИ́БЕЛЬН||ЫЙ аюултай, сөнөхөд хүргэх, аминд хүрэх; **~ые последствия** аюултай уршиг.
ГИ́БК||ИЙ 1. налархай, уян, уяхан; 2. эв зүйг олох, уян хатан; **~ая политика** уян хатан бодлого.
ГИ́БКОСТЬ 1. налархай; 2. эв зүйг олох, эвтэй уяхан.
ГИ́БЛ||ЫЙ баларсан, сүйрсэн; **~ое дело** баларсан хэрэг.
ГИ́БНУТЬ мөхөх, үхэх, үрэгдэх.
ГИБРИ́Д гибрид, эрлийз.
ГИГА́НТ 1. үлэмж биетэн; 2. аварга том, мундаг.
ГИГА́НТСК||ИЙ аврага их, үлэмж их; **~ие успехи** үлэмж их амжилт.
ГИГИЕ́Н||А эрүүл ахуй, ариун цэвэр; **~ труда** хөдөлмөрийн эрүүл ахуй; **соблюдать ~у** ариун цэврийг сахих; **~ питания** хүнсний эрүүл ахуй.
ГИГИЕНИ́ЧЕСКИЙ ~ душ эрүүл ахуйн шүршүүр.
ГИГИЕНИ́ЧН||ЫЙ эрүүл ахуйн ариг цэвэр; **~ая одежда** эрүүл ахуйн хувцас.
ГИГРОСКО́П чийг шалгуур.
ГИГРОСКОПИ́ЧЕСК||ИЙ чийг шингээх; чийг шалгуурын; **~ая вата** чийг татах, шингээх хөвөн.
ГИД 1. газарч, үйлчлэгч, тайлбарч; 2. танилцуулга.
ГИ́ДРА 1. домгийн аврага могой; 2. цэнгэг усны амьтан, хөндий хэвэлтэн.
ГИДРОГРА́ФИЯ гидрографи, ус зүй, усны зүй.
ГИДРОЛИ́З гидролиз, усжин задрах.
ГИДРО́ЛОГ гидрологич, ус судлаач.
ГИДРОЛО́ГИЯ гидрологи, ус судлал.
ГИДРОПЛА́Н усны нисэх онгоц.
ГИДРОСТА́НЦИЯ гидростанци, усан станци, усан цахилгаан станци.
ГИДРОСТА́ТИКА усан тэнцэллэг.
ГИДРОТЕРАПИ́Я усан засал, усан эмнэлэг.
ГИДРОТЕ́ХНИК ус технигч.
ГИДРОТЕ́ХНИКА ус техник, ус ашиглах техник.
ГИДРОТЕХНИ́ЧЕСКИЙ ус техник, ус ашиглах техникийн.
ГИДРОУ́ЗЕЛ гидроузел, усны зангилгаа.
ГИДРОЭЛЕКТРОСТА́НЦИЯ усан цахилгаан станци.
ГИЕ́НА гиена, чононцор.
ГИ́КАНЬЕ гуугалах, хашгирах, гийнгоолох.
ГИ́КАТЬ гуугалах, хашгирах.
ГИ́ЛЬДИЯ зэрэг, зиндаа.
ГИ́ЛЬЗА бортого, хонгио.
ГИЛЬОТИ́НА цаазын заазуур.
ГИМН дуулах; **государственный ~** төрийн дуулал.
ГИМНАЗИ́СТ дунд сургуулийн сурагч.
ГИМНАЗИ́СТКА дунд сургуулийн эмэгтэй сурагч.
ГИМНА́ЗИЯ дунд сургууль.
ГИМНА́СТ тамирч, дасгалч, чадамгай тамирч, гимнастикч.
ГИМНАСТЁРКА гимнастёрк, цэрэг цамц.
ГИМНА́СТИКА тамир дасгал, гимнастик, суниалт; **врачебная ~** эмнэлгийн тамир дасгал.
ГИМНАСТИ́ЧЕСКИЙ тамир дасгалын, гимнастикийн; **~ зал** тамир дасгалын танхим.
ГИНЕКО́ЛОГ эмэгтэйчүүдийн эмч.
ГИНЕКОЛОГИ́ЧЕСКИЙ эмэгтэйчүүдийг анагаах, эмэгтэйчүүдийн өвчний.
ГИНЕКОЛО́ГИЯ эмэгтэйчүүдийг анагаах ухаан, эмэгтэйчүүдийн судлал.
ГИПЕ́РБОЛА хэтэрхийлэл, хэтрүүлэг, даврууллах.
ГИПЕРБОЛИ́ЧЕСКИЙ хэтрүүлсэн, даврууласан.
ГИПЕРТОНИ́Я даралт ихдэх(өвчин); цусны даралт ихдэх; **~ острая** цочмог даралт ихдэх.
ГИПЕРТРОФИ́РОВАННЫЙ хэт томорсон.
ГИПЕРТРОФИ́РОВАТЬСЯ хэт томрох.
ГИПЕРТРОФИ́Я хэт томрох.
ГИПНО́З гипноз, ховс; **лечить ~ом** гипнозоор эмнэх.
ГИПНОТИЗЁР гипнозоч, ховсч.
ГИПНОТИЗИ́РОВАТЬ ховслох.
ГИПНОТИ́ЗМ гипнотизм, ховс ухаан, ховс арга.
ГИПО́ТЕЗА таамнал, тухайламж; **научная ~** шинжилгээний таамнал.
ГИПОТЕНУ́ЗА гипотенуз, бэл (гурвалжны бэл).
ГИПОТЕТИ́ЧЕСКИЙ таамаг; таамналын.
ГИПОЦЕ́НТР дэнсэлгийн төв.
ГИППОПОТА́М армаана.
ГИПС гипс, гөлтгөнө, шохой.
ГИРЛЯ́НДА цэцгийн хэлхээ; хэлхээ цэцэг.
ГИ́РЯ туухай; **~ для весов** жинлүүрийн туухай.
ГИСТО́ЛОГ гистологич, нэхдэс судлалч.
ГИСТОЛО́ГИЯ гистологи, нэхдэс судлал.
ГИТА́РА гитар.
ГИТАРИ́СТ гитарчин.
ГЛАВ||А́ I 1. тэргүүн, тэргүүлэгч; **~ правительства** засгийн газрын тэргүүн; **~ семьи** өрхийн тэргүүн; 2. орой; **~ церкви** шашны тэргүүн; **ставить во ~у угла** хамгийн чухал гэж үзэх.
ГЛАВА́ II бүлэг; **третья ~ романа** романы гуравдугаар бүлэг.
ГЛАВА́РЬ толгойлогч, овгор; **~ шайки** дээрэмчний толгойлогч.
ГЛАВЕ́НСТВО толгойлох, манлайлах.
ГЛАВЕ́НСТВОВАТЬ толгойлох, тэргүүлэх, манлайлах.
ГЛАВК ерөнхий хороо.
ГЛАВНОКОМА́НДУЮЩИЙ ерөнхий жанжин, ерөнхий командлагч.
ГЛА́ВН||ЫЙ 1. гол, чухал, ерөнхий; **~ые силы** гол хүч; **самое ~ое** хамгийн чухал; 2. ерөнхий, ахлагч; **~ врач** ерөнхий эмч; **~ бухгалтер** ерөнхий нягтлан бодох; **~ым образом** их төлөв, гол төлөв, голцуу, голдуу; **~ые члены предложения** өгүүлбэрийн гол гишүүд.
ГЛАГО́Л үйл үг.
ГЛАГО́ЛЬНЫЙ үйл үгийн.
ГЛАДИА́ТОР мэсчин.
ГЛАДИ́ЛЬНЫЙ зүлгэх, индүүдэх.
ГЛАДИ́ЛЬЩИЦА илүүрч, индүүч.
ГЛА́ДИТЬ 1. индүүдэх, илүүрдэх, толийлгох; **~ воротнички** зах индүүдэх; 2. илэх; **~ волосы** үс илэх.
ГЛА́ДК||ИЙ 1. тэгшхэн, өө сэвгүй, цагаан; **~ая дорога** тэгшхэн зам; цагаан зам; **~ая кожа** гөлгөр илэг; 2. жигдхэн гөлгөр, түгдрэлгүй; **~ая речь** түгдрэлгүй ярих, урсган ярих; 3. булцгар, голцгор.
ГЛА́ДК||О 1. тэгш, гөлгөр; 2. жигд, өө сэвгүй; **с него взятки ~и** тэр хүнээс олж авна гэдэг өнгөрсөн.
ГЛАДКОСТВО́ЛЬН||ЫЙ цулгай, гөлгөр; **~ое оружие** цулгай буу.
ГЛАДЬ I усны мандал, мандал; **морская ~** далайн мандал; **тишь да ~** нам гүм, тайван сайхан.
ГЛАДЬ II шаглаа оёдол.

ГЛА́ЖЕН||ЫЙ индүүдсэн, илүүрдсэн; **~ое бельё** индүүдсэн дотуур хувцас, илүүрдсэн дотоож.

ГЛАЗ||А́ 1. нүд; **левый ~** зүүн нүд; 2. харц, хараа, хараа нүд; **хорошие ~** сайн хараатай; **на ~ах** нүдний өмнө, харсаар байтал; **с ~у на ~** хоёулхан байгаад; **хоть ~ выколи** юу ч харагдахгүй, таг харанхуй; **ради прекрасных глаз** нүүр шагнах; **броситься в ~** нүдэнд тусах, содон харагдах; **куда ~ глядят** харсан тийшээ явах, хаашаа ч хамаагүй явах; **за ~ говорить** эзгүйд нь хэлэх, далдуур ярих; **в ~ говорить** өөрт нь хэлэх; 3. мэлмий.

ГЛАЗА́СТЫЙ 1. бүлтгэр нүдтэй; 2. хурц нүдтэй.

ГЛАЗЕ́Т нолом (хоргой).

ГЛАЗЕ́ТЬ сонирхон харах, алмайрах; **~ по сторонам** ийш тийш харж алмайрах.

ГЛАЗИ́РОВАТЬ 1. паалан гүйлгэх, пааландах; 2. чихэр гүйлгэх, гялайлгах, гялгар.

ГЛАЗНИ́К нүдний эмч.

ГЛАЗН||О́Й нүдний; **~ врач** нүдний эмч; **~ая впадина** нүдний ухархай.

ГЛАЗО́К I жаахан нүд; **на ~** багцаалахад, тухайлахад; **взглянуть одним глазком** хальт харах, жирвэс харах.

ГЛАЗО́К II ургамлын гөлөг, нахиа.

ГЛАЗО́К III шагайвар.

ГЛАЗОМЕ́Р барагцаа, нүдэн баримжаа, нүдээр хол ойрыг барагцаалах, нүдээр хэмжих, хэмжих.

ГЛАЗОМЕ́РН||ЫЙ барагцаалах, нүдээр хэмжих, **~ая съёмка** барагцаалж зураг авах.

ГЛАЗУ́НЬЯ хайрсан өндөг.

ГЛАЗУ́РЬ 1. паалан, гялгануур; 2. гүйлгэсэн чихэр, чихэр түрхэц, өнгөлгөө.

ГЛА́НДА найлзуурхай.

ГЛАСИ́||ТЬ хэлэх, бичих, гэх, гэсэн байна, гэж хэлсэн байна, гэж бичсэн байна; **закон ~т,что...** хуульд□ гэсэн байна.

ГЛА́СНО илэрхий, олны өмнө, ил тод.

ГЛА́СНОС||ТЬ ил тод байдал, илэрхий, олонд, олон нийтийн өмнө, олны өмнө; **предать ~ти** олонд сонсгох.

ГЛА́СНЫЙ I, 1. эгшиг; 2. илэрхий, нээлттэй; **~ суд** нээлттэй шүүх.

ГЛА́СНЫЙ II нутгийн захиргааны гишүүн буюу төлөөлөгч, санги.

ГЛАША́ТАЙ зарч, тунхагч.

ГЛЕ́ТЧЕР мөсөн гол.

ГЛИ́Н||А шавар, наанги, шороо; **мазать ~ой** шавар түрхэх, шавардах.

ГЛИНИ́СТ||ЫЙ шаварт, наанги, шороот, шавартай; **~ая почва** шавартай хөрс.

ГЛИНОБИ́ТН||ЫЙ шавар цогцолсон, шавар, шавраар хийсэн; **~ая стена** шавар хана.

ГЛИНОЗЁМ наанги шороо, хөнгөн цагаант шороо.

ГЛИ́НЯН||ЫЙ шавар; **~ая посуда** шавар ваар.

ГЛИ́ССЕР гулгуур завь.

ГЛИСТ цагаан хорхой, буцаш хорхой, уш.

ГЛИСТОГО́НН||ЫЙ цагаан хорхой туух, хорхой туулгах; **~ое средство** хорхой туулгах эм.

ГЛИЦЕРИ́Н амтлаг тос, глицерин.

ГЛИЦЕРИ́НОВ||ЫЙ амтлаг тосны, глицеринийн; **~ое мыло** глицеринийн саван.

ГЛОБАЛИЗА́ЦИЯ даяаршил, даяарчлал.

ГЛОБА́ЛЬНЫЙ дэлхий дахины, бүх дэлхийн.

ГЛО́БУС глобус, бөмбөрцөг, бөмбөрцгийн дүрс.

ГЛОДА́ТЬ 1. мөлжих, мэрэх; **~ кость** яс мөлжих, яс мэрэх; 2. зовоох; дарагдах; **тоска гложет** уйтгар зовооно.

ГЛОТА́НИЕ залгих.

ГЛОТА́ТЬ залгих.

ГЛО́ТК||А багалзуур, залгиур, хоолой; **кричать во всю ~у** хоолой мэдэн бархирах; **заткнуть ~у** амыг таглах, амаа хамхих.

ГЛОТ||О́К балга, оочих; **одним ~ком** ганц балгах, ганцхан оочих.

ГЛО́ХН||УТЬ 1. дүлийрэх; 2. унтрах, дарагдах, намдах; **шум постепенно ~ет** чимээ улмаар намдана; 3. дарагдах, хагдрах; **сад без ухода ~ет** цэцэрлэг арчилгаагүй хагдарч байна.

ГЛУБИН||А́ 1. гүн, гүнзгий; **морские ~ы** далайн гүн; 2. гүн дотор; **в ~е леса** ойн гүн дотор; 3. гүн; **~ мысли** гүн бодол; 4. уг; **в ~е души** сэтгэлийн угт.

ГЛУБИ́ННЫЙ гүний, усны гүн, гүн; **~ лов рыбы** усны гүнээс загас барих.

ГЛУБО́К||ИЙ 1. гүн, гүнзгий; **~ая река** гүн мөрөн; **~ая вспашка** гүнзгий хагалалт; 2. маш их; **~ая тайна** их нууц; 3. гүн, гүнзгий, их; **~ ум** гүнзгий ухаан; их ухаан; 4. орой, бүр орой; **~ая осень** намар орой; **~ой ночи** шөнө орой болтол.

ГЛУБОКО́ 1. гүнзгий, гүнд; **~ зарыть** гүнд булах; 2. ихээр, гүнээ; **~ уважать** гүнээ хүндэтгэх.

ГЛУБОКОВО́ДН||ЫЙ гүн устай, гүн усны; **~ые рыбы** гүн усны загас.

ГЛУБОКОМЫ́СЛЕНН||ЫЙ гүн бодлын, гүн сэтгэлийн, гүнзгий утгатай, их юм бодсон; **~ взгляд** гүн бодлын харц; **с ~ым видом** их юм бодсон байдалтай.

ГЛУБОКОМЫ́СЛИЕ гүн санаа, сэтгэлэг гүн, гүн бодол.

ГЛУБОКОУВАЖА́ЕМЫЙ эрхэм хүндэт.

ГЛУБЬ гүн, гүнзгий.

ГЛУМЛЕ́НИЕ доромжлох, элэг доог хийх.

ГЛУМИ́ТЬСЯ доромжлох, элэг доог хийх.

ГЛУПЕ́ТЬ тэнэг болох, мангуу болох, ухаан муудах, зөнөх.

ГЛУПЕ́Ц тэнэг хүн, мунхаг, мангуу, ухаангүй.

ГЛУПИ́ТЬ *тэнэглэх, мунхаглах, тэнэг юм хийх, дэмий юм хийх.*

ГЛУ́ПО 1. тэнэгээр, тэнэг янзаар; **~ улыбаться** тэнэг янзаар инээмсэглэх; 2. тэнэг явдал, бүр дэмий; **~ так волноваться из-за пустяка** шальгүй юманд ингэж сэтгэлээ зовоох бүр дэмий.

ГЛУПОВА́ТЫЙ тэнэгдүү, тэнэгэвтэр, тэнэг шиг.

ГЛУ́ПОСТ||Ь тэнэг юм, тэнэг явдал; **говорить ~и** тэнэг юм хэлэх; **делать ~** тэнэг юм хийх.

ГЛУ́П||ЫЙ тэнэг, мунхаг, мангуу; **~ человек** тэнэг хүн; **~ поступок** тэнэг явдал; **глуп, как пробка** шал тэнэг, уушгин тэнэг; **глуп, как осёл** ухэр шиг тэнэг, тэнэг мал; **это ~о** энэ тусгүй дээ, тэр тусгүй дээ, энэ дэмий хэрэг.

ГЛУХА́РЬ сойр(шувуу), хөх ногтруу.

ГЛУ́ХО битүү, бүдэг.

ГЛУХ||О́Й 1. дүлий, чих хатуу; **~ старик** дүлий өвгөн; 2. дүлий хүн; **азбука для ~их** дүлий хүмүүсийн үсэг; 3. дүлий хайхрамжгүй; **~ ко всем просьбам** хамаг гуйлтыг хайхрахгүй; 4. бүдэг, хүнгэнэх; **~ шум** бүдэг чимээ. 5. бөглүү, буйд, зэлүүд; **~ое место** буйд газар, **~ая улица** бөглүү гудамж; 6. битүү, үүд хаалгагүй, үүд цонхгүй; **~ая стена** битүү хана, үүд цонхгүй хэрэм; 7. далдуур, цаагуураа, битүүлгээр; **~ое недовольство** битүүлгээр дургүйцэх; **~ согласный** дуугүй гийгүүлэгч.

ГЛУХОНЕМО́Й дүлий, хэлгүй; **~ ребёнок** дүлий хэлгүй хүүхэд.

ГЛУХОТА́ дүлий, чих хатуу.

ГЛУШИ́ТЕЛЬ 1. чимээ намхруулагч, чимээ дарагч; 2. хавчигч; **~ критики** шүүмжлэл хавчигч.

ГЛУШИ́ТЬ 1. дүлийрүүлэх, балмагдуулах, бахардуулах; **~ рыбу** тэслэж загас барих; 2. дарах, дарагдах; 3. хавчих,

хяхах; ~ **критику** шүүмжлэлийг хяхах; ~ **водку** архины лүү оргих.

ГЛУШЬ бөглүү, буйд, зэлүүд, ширэнгэ; **лесная** ~ бөглүү ой, ойн ширэнгэ.

ГЛЫ́БА бөөнцөг, бөөн, бул, том; **каменная** ~ бул чулуу; ~ **льда** бөөн мөс.

ГЛЮКО́ЗА глюкоз, үзмийн чихэр, үзэмлэг.

ГЛЯДЕ́ТЬ 1. харах, үзэх, шагайх; ~ **в окно** цонхоор харах; 2. харах, асрах, бөөцийлөх; ~ **за ребёнком** хүүхэд харах, хүүхэд асрах; 3. харах, хандах; **окна глядят на юг** цонх нь урагшаа харсан; ~ **в оба** сэрэмжтэй байх; ~ **косо** хялайх; **того и гляди** харж байхгүй бол; ~ **сквозь пальцы** хараагүй юм шиг байх, үл мэдэгч болох.

ГЛЯДЕ́ТЬСЯ үзэх, харах, харагдах, тусах; ~ **в зеркало** биеэ толинд харах.

ГЛЯДЬ -тал (тэл), тэгэхнээ, нэг мэдэхнээ; ~, **он идёт** хартал тэр явж байна.

ГЛЯ́НЕЦ гялгар, гилгэр; **навести** ~ гялгар болгох, гялайлгах.

ГЛЯ́НУТЬ ширвэн харах, нүдний өнцгөөр харах, хялам хийж харах, харсхийх.

ГЛЯ́НЦЕВ||ЫЙ гялгар, гилгэр; **~ая бумага** гялгар цаас.

ГМ! хм, ээ дээ! (эргэлзсэн санаа).

ГНАТЬ I 1. хөөх, үлдэх; ~ **из дому** гэрээс хөөх; 2. туух; ~ **стадо** мал туух; 3. шамдах, гарах, давхих, гүйлгэх; ~ **лошадей во весь опор** морины хар хурдаар давхих.

ГНАТЬ II нэрэх; ~ **спирт** спирт нэрэх, архи нэрэх.

ГНА́ТЬСЯ 1. хөөх, нэхэх, мөрдөх; ~ **по пятам** мөрдөн хөөх; 2. хөөцөлдөх; ~ **за славой** алдар нэр хөөцөлдөх.

ГНЕВ хилэн, уур, унтуу; **приступ ~а** хилэн хүрэх, уур хүрэх, уур шатах.

ГНЕВА́ТЬСЯ хилэгнэх, уурлах, цухалдах.

ГНЕ́ВНЫЙ хилэнт, ууртай, ~ **взгляд** ууртай харц.

ГНЕД||О́Й хээр, халтар; **~ая лошадь** хээр морь.

ГНЕЗДИ́ТЬСЯ 1. үүрлэх; **ласточки гнездятся под крышей** хараацай дээвэр дор үүрлэж байна; 2. орогнох; үүрлэх; **тараканы гнездятся в щелях** жоом завсар заалхайгаар нь үүрлэж байна; 3. орших, хоногших; **в голове гнездились назойливые мысли** толгойд өнөөх л санаа хоногшоод байна.

ГНЕЗД||О́ 1. үүр; **вить** ~ үүр засах, үүрлэх; **волчьи ~а** чоныи үүр; 2. үүр, бут; ~ **груздей** сархианы үүр, мөөгийн бут; 3. үүр, уурхай; ~ **заразы** халдварын уурхай; 4. суурь, хаацай.

ГНЕЗДОВА́НИЕ үүрлэх, үүрлэн орших.

ГНЕЗДОВО́Й үүрлэх, үүрэн, үүрлүүлсэн; ~ **посев** үүрэн тарилга.

ГНЕТ 1. дарлал, дарлагдал, дарлах, дарамт; **колониальный** ~ колонийн дарлал; **избавить от ~а** дарлалаас ангижруулах; 2. шахах, дарах; **творог под ~ом** тараг шахах, аарц шүүх.

ГНЕТУ́Щ||ИЙ зовлонтой, зовнилтой, сэтгэлд эвгүй; **~ие мысли** зовнилтой бодол.

ГНИ́ДА хуурс, хуус.

ГНИЕ́НИЕ ялзрах, үжих, өмхрөх.

ГНИЛ||О́Й 1. өмх, ялзархай, үжсэн; **~ое дерево** өмх мод; 2. нойтлог, чийглэг; **~ая погода** нойтлог цаг уур.

ГНИ́ЛОСТН||ЫЙ 1. үжээх, бээлгэх, өмхийрүүлэх, өмхрөх; **~ые бактерии** үжээх нян; 2. өмхий, үжмэл; ~ **запах болота** балчгийн өмхий үнэр.

ГНИЛУ́ШКА өмх мод, өмх юм.

ГНИЛЬ өмх, ялзархай; ~ **древесины** модны өмх.

ГНИЛЬЁ ялзарсан юм, ялзарсан хог, өмхий хог.

ГНИТЬ ялзрах, өмхийрөх, өмхрөх; **сено гниёт** өвс ялзарч байна.

ГНОЕ́НИЕ идээлэх, бээрлэх.

ГНОИ́ТЬ өмхийрүүлэх, ялзруулах, үжээх.

ГНОИ́ТЬСЯ 1. өмхийрөх, ялзрах, идээлэх, бээрлэх; **рана ещё гноится** шарх бээрлэж л байна; 2. нуухдах; **глаза гноятся** нүд нуухдаж байна.

ГНО||Й 1. идээр, бээр; **из нарыва вышло много ~я** идээрлэсэн газраас их бээр гарлаа; 2. нуух; ~ **в глазах** нүдний нуух.

ГНОЙНИ́К 1. буглаа, бээрлэсэн газар; **вскрыть** ~ буглааг хагалах; 2. архаг бузрын голомт.

ГНО́ЙН||ЫЙ идээртэй, бээрлэсэн, бугласан; **~ая рана** бээрлэсэн шарх.

ГНОМ анахай, үлгэрийн одой хүн.

ГНОСЕОЛО́ГИЯ гноселоги, мэдлэгийн онол.

ГНУСА́ВИТЬ гунших.

ГНУСА́ВОСТЬ гуншаа.

ГНУ́СНОСТЬ шившиг, бузар явдал, булай хэрэг; **совершить** ~ шившгээ тарих; бузар явдал гаргах.

ГНУ́СНЫЙ жигшүүртэй, шившгийн муу; ~ **поступок** жигшүүртэй явдал.

ГНУ́Т||ЫЙ матмал, махийсан; **~ая мебель** матмал ширээ сандал.

ГНУТЬ 1. матах, бөхийх, бөхийлгөх; ~ **проволоку** төмөрлөг утсыг матах; ~ **спину** нуруу бөхийх, бөхөлзөх; 2. тахийлгах, нахилзуулах, бөхөлзүүлэх; **буря гнёт деревья** шуурга модыг бөхөлзүүлж байна.

ГНУ́ТЬСЯ матагдах, маталзах, матайх, хотойх, хотолзох, гулзайх; ~ **под тяжестью** хүнд юманд дарагдан хотойх; **дерево гнётся от ветра** мод салхинд гулзайж байна.

ГНУША́ТЬСЯ жигших, дур гутах, тоохгүй, тоож үзэхгүй; ~ **лжи** худлаас жигших, худал үгэнд дур гутах.

ГОБЕЛЕ́Н гобелен хивс, уран хээтэй хивс, хивсэн аравч.

ГОБО́Й жимбүүр.

ГОВЕ́ТЬ мацаг барих, мацаг барьж мөргөл хийх.

ГО́ВОР 1. аман аялгуу; **местный** ~ нутгийн аман аялгуу; 2. дуудлага, аялгуу, **с нерусским ~ом** орос биш аялгуутай; 3. ярих, хөөрөх, ярих үг; **тихий** ~ аяархан ярих.

ГОВОРИ́ЛЬНЯ чалчих газар, сул үгний танхим.

ГОВОРИ́ТЬ 1. хэлэх, ярих, хэл мэдэх, хэлд орох; ~ **по-русски** оросоор ярих; **ребёнок уже говорит** хүүхэд хэлд орж байна; 2. хэлэх, ярих, гэх; ~ **правду** үнэнийг хэлэх; ~ **быстро** түргэн ярих; **иначе говоря** өөрөөр хэлбэл; 3. ярилцах, хэлэлцэх, хөөрөлдөх; ~ **с приятелем** найзтайгаа ярилцах; 4. харуулах, үзүүлэх, гэрчлэх; **этот факт говорит о многом** энэ баримт олон юмыг харуулна; **нечего ~, что и ~** яриагүй, ойлгомжтой; **это говорит не в вашу пользу** энэ бол танд тусгүй юм болж байна; **как говорят** олны хэлэлцдэг ёсоор.

ГОВОРЛИ́ВОСТЬ яримтгай, ярианд дуртай, хэлэмтгий.

ГОВОРЛИ́ВЫЙ 1. яримтгай, ярианд дуртай; 2. дуу чимээтэй, хорчигносон; ~ **ручеёк** хоржигносон булаг.

ГОВОРУ́Н яримгай хүн, хэлэмгий хүн, яриа хүн.

ГОВОРУ́НЬЯ яримгай эхнэр, хэлэмгий эхнэр, яриа эмэгтэй.

ГОВЯ́ДИНА үхрийн мах.

ГОВЯ́ЖИЙ үхрийн, үхрийн махан; ~ **жир** үхрийн өөх.

ГО́ГОЛ||Ь нугас, шунгаач алаг; **ходить ~ем** ганган амьтан, айхтар гоё юм явах.

ГО́ГОЛЬ-МО́ГОЛЬ өндгөн бантан.

ГОГОТА́НЬЕ 1. ганганах, гангар гунгар хийх; 2. тачигнатал инээх.

ГОД 1. жил; **в будущем ~у** ирэх жил, хойт жил; **в прошлом ~у** нодниц жил; ~ **тому назад** нэг жилийн өмнө; **круглый** ~ бүтэн жил; ~ **от ~у** жил тутам, жил ирэх тутам; 2. он; **80-ые ~ы прошлого столетия** өнгөрсөн зууны наяад он; ~ **издания**

хэвлэсэн он; 3. нас; **который ~ ему?** нас нь хэд вэ? хэдэн настай вэ? **молодые ~ы** залуу нас; **он уже в ~ах** тэр настай болж байгаа, нас нь ахиж байгаа; **без ~у неделя** тун саяхан.

ГОДИ́Н||А цаг, үе жилүүд; **в тяжелую ~у** бэрх цагт.

ГОДИ́ТЬСЯ зохих, зохилдох, таарах, хэрэг болох; **сапоги не годятся** гутал таарахгүй байна; **это никуда не годится** энэ юм юунд ч хэрэг болохгүй; **так поступать не годится** тэгж болохгүй.

ГОДИ́ЧНЫЙ нэг жилийн; **~ доход** жилийн орлого; **~ срок** нэг жилийн хугацаа.

ГО́ДНОСТЬ хэрэглэж болох эсэх, тохиромж, таарамж.

ГО́ДНЫЙ 1. тохирох, таарах, хэрэглэж болох, болох; **~ к военной службе** цэргийн албанд тохирох; **~ для питья** ууж болох; **~ в пищу** хоолонд хэрэглэж болох; 2. хүчин төгөлдөр, хүчинтэй, хугацаатай.

ГОДОВА́ЛЫЙ нэг настай, ойндоо хүрсэн; **~ ребёнок** ойндоо хүрсэн хүүхэд; **~ ягнёнок** төлөг.

ГОДОВО́Й 1. жилийн, жил тутмын; **~ план** жилийн төлөвлөгөө; **~ отчёт** жилийн тайлан.

ГОДОВЩИ́Н||А ой, ойн өдөр; **праздновать ~у** ойн баярыг тэмдэглэх; **~ свадьбы** хуримын ой, гэрлэсний ой.

ГОЗНА́К мөнгөн тэмдэгт гаргах улсын удирдах газар.

ГОЛ гол, байны хаалга; забить гол байны хаалганд оруулах, гол цохих (*бөмбөгөөр*).

ГОЛЕНИ́Щ||Е түрий; **головки износились, а ~а совсем целые** зулаг нь урагдаад түрий нь бүтэн үлдлээ.

ГО́ЛЕНЬ шилбэ, шаант.

ГОЛЕ́Ц 1. сардиг, ян уул; 2. толбот малма загас.

ГОЛЛА́НДЕЦ холланд хүн, нидерланд хүн.

ГОЛЛА́НДКА I 1. холланд эмэгтэй, нидерланд эмэгтэй.

ГОЛЛА́НДКА II 1. холланд үнээ; 2. холланд пийшин.

ГОЛЛА́НДСКИЙ холланд, нидерланд; **~ язык** холланд хэл.

ГОЛО́В||А 1. толгой; **понурить ~у** толгойгоо унжуулах, уруу царайлах; **надеть на ~у** толгойд өмсөх; 2. толгой (*ихэнхдээ орчуулахгүй*) **сто голов крупного рогатого скота** зуун үхэр; 3. толгой, тархи, ухаан; **светлая ~** сэргэлэн толгой; **человек с ~ой** ухаантай хүн; 4. тэргүүн, дарга; **он всему делу ~** тэр бүх хэргийн тэргүүн; **вбить в ~у** толгойд нь шингээх; **терять ~у** сандрах, самгардах; **как снег на ~у** гэв гэнэт; **ломать ~у** ойлгож ядах; **уйти с ~ой в работу** шургуу, нөр ажиллах; **валить с больной ~ы на здоровую** өөрийн гэмийг бусдад тохох; **не выходит из ~ы** мартах аргагүй, санаанаас гарахгүй; **~ садовая** алмай амьтан.

ГОЛОВА́СТИК 1. *шанаган хорхой*; 2. том толгойт.

ГОЛОВЕ́ШКА цуцал.

ГОЛО́ВКА 1. бяцхан толгой; 2. ширхэг; **~ чеснока** нэг ширхэг саримсаг; 3. тав; **~ гвоздя** хадаасны тав; **~ полового члена** чивээ, сэлдийн толгой.

ГОЛОВН||О́Й 1. толгойн; **~ая боль** толгойн өвчин; 2. түрүү; **~ отряд** түрүү отряд; **~ убор** малгай.

ГОЛОВНЯ́ 1. цуцал; 2. харуу, харуутах, *хар түрүү*, харанцаг (*тарианы өвчин*).

ГОЛОВОКРУЖЕ́НИЕ толгой эргэх, ташуурах; **~ от успехов** амжилтаас толгой эргэх, амжилтандаа ташуурах.

ГОЛОВОКРУЖИ́ТЕЛЬНЫЙ толгой эргэм, толгой эргэмээр, ташуурмаар.

ГОЛОВОЛО́МКА зулай атируулах юм, түвэгтэй бодлого, ухааны сорилт.

ГОЛОВОМО́ЙКА сургаж загнах, загнах.

ГОЛОВОРЕ́З 1. танхай этгээд, төрхгүй амьтан; 2. яргачин.

ГОЛО́ВУШКА буйная ~ хэцүү эр, горьгүй хүн; **бедная моя ~!** хөөрхий болсон би!

ГОЛОГРА́ФИЯ гурван хэмжээст зураг.

ГО́ЛОД 1. өлсөх, өлбөрөх; **умирать с ~у** өлсөж үхэх; 2. өлсгөлөн.

ГОЛОДА́ТЬ өлсөх, өлбөрөх; **целый день ~** өдөр турш өлсөх.

ГОЛОДА́ЮЩИЙ өлсөж байгаа, өлсгөлөн хүн, өлсгөлөнд нэрвэгдэгсэд.

ГОЛО́ДН||ЫЙ 1. өлөн, өлссөн, өлсөх; **быть ~ым** өлсөж байх; **~ желудок** өлөн ходоод; 2. өлсгөлөн, турах, өлбөрөх, гуринхилах; **~ая смерть** өлбөрч үхэх, турж үхэх; **~ волк** өлөн чоно, гуринхилсан чоно; 3. өл залгах, өлөн, ховор хомс; **~ая степь** өлөн хээр; **~ обед** өл залгах хоол.

ГОЛОДО́ВК||А өлсгөлөн; **объявить ~у** өлсгөлөн зарлах.

ГОЛОЛЕ́ДИЦА төмөр зуд, зуд турхан, халтиргаа.

ГО́ЛОС 1. дуу; **кричать во весь ~** чанга дуугаар хашгирах; **возвышать ~** дуугаа чангатгах; **в один ~** нэг дуугаар; 2. хоолой; **высокий ~** нарийн хоолой; **низкий ~** бүдүүн хоолой; 3. эрх; **решающий ~** таслах эрх; **лишить права ~а** сонгох эрхийг хасах; 4. санал; **большинством ~ов** олонхийн саналаар; **поднять ~** саналаа шууд гаргах; **голос избирателей** сонгогчдын санал.

ГОЛОСИ́СТЫЙ сүрхий дуутай, чанга дуутай.

ГОЛОСИ́ТЬ уйлах, орилох, гиншин гашуудах.

ГОЛОСЛО́ВНО баримтгүй, үндэсгүй, оргүй; **утверждать ~** баримтгүй нотлох, үндэсгүй хэлэх.

ГОЛОСЛО́ВНОСТЬ баримтгүй, үндэсгүй, оргүй үг.

ГОЛОСЛО́ВН||ЫЙ баримтгүй, үндэсгүй, оргүй; **~ое обвинение** баримтгүй зэмлэх.

ГОЛОСОВА́НИЕ санал авах, санал өгөх, санал хураах, гар өргөх; **всеобщее ~** нийтийн санал авах; **открытое ~** илээр санал хураах, гар өргөж таслах; **поставить на ~** гар өргүүлэх, санал хураах.

ГОЛОСОВА́ТЬ 1. санал өгөх, санал хураах; **~ поднятием руки** гар өргөж санал өгөх, гар өргүүлж санал хураах; 2. гар өргөх, гар өргөж таслах; **~ предложение** саналыг гар өргөж таслах.

ГОЛОСОВ||О́Й дууны, хоолойн; **~ые связки** дууны хөвч.

ГОЛУБЕ́||ТЬ цэнхэрлэн харагдах, хөхрөх; **море г~ет** тэнгис цэнхэрлэн харагдана.

ГОЛУБИЗНА́ хөх өнгө, цэнхэр; **~ глаз** цэнхэр нүд.

ГОЛУБИ́КА нэрс.

ГОЛУБИ́Н||ЫЙ 1. тагтаан, тагтааны; **~ая почта** тагтаан *шуудан*; 2. *номхон, тагтаа шиг*; **~ая кротость** тагтаа шиг номхон.

ГОЛУ́БИТЬ энхрийлэх, эрхлүүлэх.

ГОЛУ́БКА 1. эм тагтаа; 2. хүүхэн хонгор, хайртай хонгор.

ГОЛУБОВА́ТЫЙ хөхөвтөр, хөхөмдөг, цэнхэр, цэгээн.

ГОЛУБОГЛА́ЗЫЙ цэнхэр нүдтэй.

ГОЛУБ||О́Йцэнхэр, хөх; ~ая лента цэнхэр тууз; **~ая кровь** язгууртан; 2. гомо.

ГОЛУБО́К1. тагтаа, хүүрзгэнэ; 2. хайртай хонгор.

ГОЛУБЦЫ байцаанд ороосон шанз.

ГОЛУ́БЧИК хонгор минь, чи минь.

ГО́ЛУБЬ тагтаа, хүүрзгэнэ; **почтовый ~** шуудангийн тагтаа; **дикий ~** хүүрзгэнэ, зэрлэг тагтаа; **домашний ~** тэжээмэл тагтаа; **~ мира** энх тайвны тагтаа.

ГОЛУБЯ́ТНИК тагтаа тэжээгч.

ГОЛУБЯ́ТНЯ тагтааны байр.

ГО́Л||ЫЙ 1. нүцгэн; **~ые ноги** нүцгэн хөл; **~ое дерево** нүцгэн мод; **совершенно ~ человек** чармаа нүцгэн хүн; 2. хоосон, нүцгэн, цулгай; **~ая степь** нүцгэн тал, цагаан тал; **~ая стена** цулгай хана; 3. ганц л, ганцхан л, дан; **~ая соль** дан давс; **~ая истина** ганцхан л үнэн; **~ые цифры** дан ганц тоо; ***брать**

~ыми руками улаан гараар барих; **гол как сокол** гон бие гозон толгой, юу ч үгүй хоосон.

ГОЛЫТЬБА́ ядуучууд, гуйлгачид.

ГОЛЫ́Ш 1. нүцгэн хүн; 2. голын чулуу.

ГОЛЬЁ 1. шийр цувдай; 2. сармай.

ГОМЕОПА́Т гомеопат эмч, ижил зүйлээр эмнэгч.

ГОМЕОПАТИ́ЧЕСК||ИЙ гомеопатийн, ижил зүйлээр эмнэх; **~ая доза** гомеопатийн тун.

ГОМЕОПА́ТИЯ гомеопати, ижил зүйлээр эмнэх арга (*эрүүл хүнд ихээр уулгавал нэг зүйл өвчин үүсгэдэг эмийг бага багаар уулгаж мөн төрлийн өвчнийг анагаах арга*).

ГОМЕРИ́ЧЕСКИЙ 1. хомерийн; 2. элэг хөшөл, тачигнатал; **~ смех** элэг хөшөл инээх, тачигнатал инээх.

ГО́МОН шуугиан, дуу чимээ, шулганах, шулганаан; **птичий ~** шувуу шулганах.

ГОМОСЕКСУАЛИ́ЗМ ижил хүйстэнтэйгээ явалдах гаж үзэгдэл.

ГОНГ харанга; **ударить в ~** харанга цохих.

ГОНДО́ЛА 1. гондол завь; 2. дүүжин саг, өлгөө хайрцаг (*агаарын бөмбөрцөгт дүүжилдэг сууц*).

ГОНЕ́НИ||Е хавчих, хяхах; **~ на свободу печати** хэвлэлийн эрх чөлөөг хавчих; **подвергнуться ~ям** хавчигдах, хяхагдах.

ГОНЕ́Ц элч, буухиа.

ГО́НК||А 1. хөөх, хөөцөлдөх, адгах; **~ вооружений** зэвсгээр хөөцөлдөх; 2. уралдаан; **задать ~у** уралдуулах, шавдуулах.

ГО́НКИ 1. уралдаан; **~ на короткую дистанцию** ойрын зайны уралдаан, ойрын уралдаан; **~ на длинную дистанцию** урт хөлийн уралдаан, холын зайны уралдаан.

ГО́НОР их зан, ихэмсэг, нэрэлхүү; **человек с ~ом** их зантай хүн.

ГОНОРА́Р шан, шагнал, харамж; **авторский ~** зохиогчийн шагнал.

ГОНОРРЕ́Я хүйтэн өвчин, заг.

ГО́НОЧНЫЙ уралдааны; **~ автомобиль** уралдааны машин, уралдааны чийчээ.

ГОНЧА́Р ваарч.

ГОНЧА́РН||ЫЙ ваар үйлдэх, ваарын; **~ое искусство** ваар үйлдэх урлаг; **~ые изделия** ваарын үйлдэхүүн.

ГО́НЧИЙ тайга нохой.

ГОНЯ́ТЬ 1. хөөх, хөөж байх, үлдэх; 2. гүйлгэх, байн байн явуулах.

ГОНЯ́ТЬСЯ хөөцөлдөх, хөөх.

ГОПА́К гопак бүжиг, дэвхрэх бүжиг.

ГОР||А́ 1. уул; **жить в ~ах** ууланд суух, ууланд нутаглах; **взбираться на ~у** уул өөд авирах; **по ~ам и по полям** уул талаар; 2. овоо, овоолготой; **~ книг** овоолготой ном; **~ камней** овоо чулуу; **словно ~ свалилась с плеч** санаа амарлаа, дотор онгойлоо; **стоять горой** бүх чадлаар өмөглөх, өмөг түшиг болох; **не за ~ами** удахгүй, ойрхон; **идти в ~у** шууд дэвших, өөдлөх; **сулить золотые ~ы** их олзтой гэж горьдуулах; **пир ~ой** далай их хурим, идээн уул, архин далай.

ГОРА́ЗД сүрхий, чадамгай; **он ~ спать** унтахдаа сүрхий.

ГОРА́ЗДО нэн, улам, бүр илүү, жишээгүй, хавьгүй ойр; **~ важнее** илүү чухал; **в Крыму ~ теплее, чем в Москве** Крымд Москвагаас илүү дулаахан; **~ лучше** хавьгүй дээр.

ГОРБ, бөх; ***на своём ~у испытать** өөрийн биеэр амсах; **своим ~ом жить** өөрийн хөдөлмөрөөр амьдрах.

ГОРБА́ТЫЙ 1. бөгтөр; нуруугүй; **~ мост** бөгтөр гүүр; 2. монхор; **~ нос** монхор хамар.

ГОРБИ́НК||А монхор; **нос с ~ой** монхор хамар.

ГО́РБИТЬ бөгцийлгөх, бөгцийх.

ГО́РБИТЬСЯ бөгтийх, бөгцийх; **он горбится при ходьбе** тэр бөгтийж явдаг.

ГОРБУ́Н бөгтөр хүн, нуруугүй, нуруу муутай хүн.

ГОРБУ́НЬЯ бөгтөр эмэгтэй.

ГОРБУ́ШКА талхны булан, булан талх.

ГОРБЫ́ЛЬ зах банз.

ГОРДЕЛИ́В||ЫЙ омогтой, бардам, ихэмсэг, дээрэлхэг; **~ая осанка** бардам янзтай, ихэмсэг байдалтай.

ГОРДЕ́Ц ихэмсэг бардам, их зантай хүн.

ГОРДИ́ТЬСЯ 1. бахархах; **~ своими успехами** амжилтандаа бахархах; 2. бардах, бардамнах, сайрхах; **что ты гордишься? держись попроще** чи яагаад бардамнав? зүгээр энгийн бай.

ГО́РДОСТЬ 1. бахархал, бахдал, урдаа барих юм; **национальная ~** үндэсний бахархал; 2. бардам, омог; **обвинять кого-нибудь в гордости** хэн нэгийг бардам гэж зэмлэх.

ГО́РДЫЙ бардан сайрхаг, омогтой; **~ человек** бардан хүн.

ГО́Р||Е гаслан, зовлон, гай; **случилось большое ~** их гаслан тохиолдов; **ему и ~я мало** огт ажиггүй; **горе-учёный** гавихгүй эрдэмтэн, асман эрдэмтэн.

ГОРЕВА́ТЬ гаслах, гашуудах, зовних, шаналах.

ГОРЕ́ЛКА дэнгийн толгой, дэнгийн гол, галлуур.

ГОРЕ́Л||ЫЙ хиншүү ханхалсан, шатанги, шатанхай, түлэнхий; **пахнет ~ым** хиншүү ханхална; **~ая доска** түлэнхий банз.

ГОРЕМЫ́КА зовлонт хүн, зол заяагүй амьтан, зовсон, хөөрхий амьтан.

ГОРЕМЫ́ЧНЫЙ зовлонт.

ГОРЕ́НИЕ шатах, ноцох, асах.

ГО́РЕСТНЫЙ гашуудалтай, гаслантай.

ГО́РЕСТ||Ь эмгэнэл, гаслан, зовлон; **пережить много ~ей** их зовлон амсах.

ГОРЕ́ТЬ 1. шатах; **дрова хорошо горят** түлээ сайн шатаж байна; 2. ноцох; **свеча не горит** лаа ноцохгүй байна; 3. гялалзах; **глаза горят от радости** баярлаад нүд нь гялалзаж байна; 4. улайх; **щёки горят от мороза** хацар нь даараад улайж байна; **лицо горит** нүүр улайж байна; 5. халуурах, төөнөрөх; **гореть в жару** халуурах; **гореть желанием** их хүсэх; **земля горит под ногами** байх суух аргагүй болох; **не горит** яаралтай биш.

ГОРЕ́Ц 1. уулын хүн, уулынхан; 2. *(бот)* мэхээр, тарна; **~ тонкий** туяхан тарна.

ГО́РЕЧЬ 1. гашуу, хорсох; **~ во рту** ам гашуу оргих; 2. уйтгар, гаслан; **~ разлуки** хагацлын гаслан; **~ воспоминания** гашуудалтай дурсамж.

ГОРИЗО́НТ 1. тэнгэрийн хаяа, тэнгэрийн хормой, хаяалбар; **скрыться за ~ом** тэнгэрийн хаяанд далдрах; **солнце на ~е** нар тэнгэрийн хаяанд очих; **видимый ~** харагдах хаяалбар; 2. уудам газар, хараагүй газар, нүдний үзүүр; **с горы открылся широкий ~** уулан дээрээс уудам газар харагдав; 3. харц, хараа, мэдлэг; 4. далайц; **большие ~ы** өргөн далайц.

ГОРИЗОНТА́Л||Ь хэвтээ шугам, хэвтээ хямцаа, хөндлөн, хаяалбар; **по ~и** хөндлөн.

ГОРИЗОНТА́ЛЬНОСТЬ хөндлөн чиг, хэвтээ чиг.

ГОРИЗОНТА́ЛЬН||ЫЙ хэвтээ, хөндлөн, хаяалбар; **~ая линия** хэвтээ шугам; **~ая поверхность** хөндлөн гадарга.

ГОРИ́ЛЛА горил мич (*хүн төстэй сармагчин*).

ГОРИСПОЛКО́М (*городской исполнительный комитет*) хотын гүйцэтгэх хороо.

ГОРИ́СТЫЙ уулархаг, уултай; **гористая местность** уулархаг нутаг.

ГО́РКА толгой, болдог, дов.

ГО́РКН||УТЬ гашуун болох, эхүүн болох, хурших; **масло ~ет в тепле** тос дулаан газарт эхүүн болно.

ГОРКО́М (*городской комитет*) хотын хороо; **~ партии** хотын намын хороо.

ГОРЛА́Н их дуутай хүн, бархираа эр.
ГОРЛА́НИТЬ орилох, бархирах; ~ **на всю улицу** гудамжаар нэг бархирах.
ГОРЛА́СТЫЙ чанга дуутай, их дуутай, бархираа; ~ **парень** чанга дуутай хүн.
ГО́РЛИЦА хүүрзгэнэ, хүтгээ, түүтэй.
ГО́РЛО 1. хоолой; **дыхательное** ~ мөгөөрсөн хоолой; 2. хоолой; ~ **Белого моря** Цагаан тэнгисийн хоолой; **кричать во всё** ~ өндөр дуугаар хашгирах, тэнхээ мэдэн бархирах; **быть занятым по** ~ амьсгаа авах ч завгүй байх; **хватать за** ~ багалзуурдах; **я сыт по** ~ би айхтар цадлаа.
ГОРЛОВ||О́Й хоолойн; ~**ая чахотка** хоолойн сүрьеэ; ~**ое пение** хөөмийлөх.
ГО́РЛЫШКО хоолой, амсар, хүзүү, цорго; ~ **бутылки** лонхны хоолой; ~ **сепаратора** сүүний машины цорго.
ГОРМО́Н даавар.
ГОРН I хясаа, хяс.
ГОРН II бүрээ; **играть на** ~**е** бүрээ татах.
ГОРНИ́Л||О гал дөл, ааг; **в** ~**е войны** дайны гал дөл дотор.
ГОРНИ́СТ бүрээч.
ГО́РНИЦА зочлох тасалгаа.
ГО́РНИЧНАЯ үйлчлэгч эмэгтэй.
ГОРНОЗАВОДСК||О́Й уурхайн, уул уурхайн; ~**ая промышленность** уурхайн үйлдвэр.
ГОРНОЛЫ́ЖНЫЙ уулын цанын.
ГОРНОПРОМЫ́ШЛЕННЫЙ уурхайн үйлдвэрийн.
ГОРНОРАБО́ЧИЙ уурхайн ажилчин.
ГОРНОСТА́Й үен.
ГО́РН||ЫЙ 1. уулын; ~ **воздух** уулын агаар; ~**ое ущелье** уулын хавцал; ~**ые породы** уулын чулуулаг; 2. уулархаг; ~**ая страна** уулархаг орон; 3. уурхайн; уул уурхайн; ~ **институт** уул уурхайн дээд сургууль; уурхайн институт; ~**ое дело** уурхайн ажил; ~ **хрусталь** усан болор.
ГОРНЯ́К уурхайч; уурхайн ажилчин.
ГОРНЯ́ЦКИЙ уурхайчны.
ГО́РОД хот, балгас; **главный** ~ төв хот; **поехать за** ~ хотын гадна гарах.
ГОРОДИ́ТЬ 1. хаших, хороолох, хашаа барих; ~ **поле** талбайг хаших; талбайд хашаа барих; 2. донгосох; ~ **чепуху** дэмий донгосох.
ГОРОДИ́ШКО хотын оронцог, хотонцор, тур.
ГОРОДИ́ЩЕ туурь, эвдэрхий балгас, балгас.
ГОРОДНИ́ЧИЙ хотын дарга.
ГОРОДОВО́Й түрүүч цагдаа.
ГОРОДСК||О́Й хотын; ~**ое население** хотын хүн ард; ~ **житель** хотын хүн; ~ **совет** хотын зөвлөл.
ГОРОЖА́НИН хотын хүн.
ГОРОЖА́НКА хотын эмэгтэй.
ГОРООБРАЗОВА́НИЕ уул тогтох.
ГОРО́Х буурцаг, вандуй; **как об стену** ~ хананд будаа цацах шиг, юу ч хэлээд нэмэргүй.
ГОРО́ХОВЫЙ буурцгийн, вандуйн; **шут** ~ *алиа салбадай.*
ГОРО́ШЕК буурцаг, вандуй, хорхиног; **душистый** ~ үнэрт хорхиног; **зелёный** ~ ногоон буурцаг.
ГОРО́ШИНА бяцхан буурцаг.
ГО́РСК||ИЙ уулын, уулынхан, уулынхны; ~**ие племена** уулын аймгууд.
ГОРСОВЕ́Т хотын зөвлөл.
ГО́РСТОЧКА 1. атга, атгын чинээ; 2. хэдхэн, цөөхөн.
ГОРСТЬ атга; ~ **муки** атга гурил, бага, цөөн, хэдхэн, цөөхөн тоотой.
ГОРТА́ННЫЙ төвөнгийн, төвөнгөөр; ~**звук** төвөнгийн авиа.
ГОРТА́НЬ *төвөн, төвөнх.*
ГОРЧА́К I *(бот)* ягаан түрүү.
ГОРЧА́К II рыб.цэнхэр жараахай; хатгуурт жараахай.
ГОРЧИ́||ТЬ гашуун, гашуун амттай, хуршсан амттай; **масло** ~**т** тос гашуун болжээ; **во рту** ~**т** аманд гашуун оргино.
ГОРЧИ́ЦА гич.
ГОРЧИ́ЧНИК гичийн гоюу; **ставить** ~ гоюу тавах.
ГОРЧИ́ЧНИЦА гичийн сав.
ГОРЧИ́ЧНЫЙ гичийн.
ГОРШО́К 1. ваар, бутан, ховоон; **цветочный** ~ цэцгийн ваар; 2. хөтөвч; **ночной** ~ шөнийн хөтөвч.
ГО́РЬК||АЯ 1. гашуун; 2. архи, хар архи; **пить** ~**кую** архи уух.
ГО́РЬК||ИЙ 1. гашуун; ~ **вкус** гашуун амт; ~**ое лекарство** гашуун эм; 2. гашуун; гашуудал; гаслант; уйтгар; ~**ие слёзы** гашуудлын нулимс; ~ **смех** гаслант инээд; 3. аягүй; хэцүүдсэн; зовлонт; ~**ая участь** зовлонт тавилан; ~**ая истина** аягүй үнэн; ~ **пьяница** арчаагүй архичин; ~ **опыт** гашуун туршлага, хал үзэх, хашрах.
ГО́РЬКО 1. гашуун; **это лекарство очень** ~ энэ эм их гашуун байна; 2. гашуудалтай; ~ **думать об этом** энэ тухай бодоход гашуудалтай; 3. зовлонтой, уйтгартай; ~ **на душе** сэтгэл зовлонтой байна; 4. хуримын үед зочид, залуу хосоос үнсэлцэхийг шаардах үг, уриа.
ГОРЮ́ЧЕЕ шатахуун; **жидкое** ~ шингэн шатахуун.
ГОРЮ́Ч||ИЙ 1. шатамхай, шатдаг, шатах; ~ **материал** шатдаг юм; ~ **газ** шатах хий; 2. шатахуун; ~**его не хватило** шатахуун дутав; ~**ие слёзы** гашуун нулимс.
ГОРЯ́НКА уулын эмэгтэй.
ГОРЯ́Ч||ИЙ 1. халуун; ~**ие и холодные напитки** халуун хүйтэн унд; ~**ая пища** халуун хоол; 2. халуун, чин сэтгэлийн; ~ **привет** халуун баярыг хүргэе; 3. түргэн, түргэн ууртай, аагтай, догшин; **у него** ~ **характер** тэр түргэн ууртай; 4. агсам; ~**ая пора** ид ажлын үе,толгой өндийх завгүй цаг; **попасть кому-либо под** ~**ую руку** болдогтүй үеэр нь тааралдах; ууртай байхад нь орох; **по** ~**им следам** халуун мөрөөр нь.
ГОРЯЧИ́ТЬ 1. агсамнуулах, шавдах, ташуурдан шавдах; ~ **лошадь** морио агсамнуулах; 2. халамцуулах.
ГОРЯЧИ́ТЬСЯ хөөрөх, уурлах, түргэдэх, унтуущах; **напрасно** ~ дэмий уурлах.
ГОРЯ́ЧКА 1. халуурах, чичрэг; 2. сандрах, сандруу цаг; ~ **перед отъездом** явахын өмнө сандрах; **экзаменационная** ~ шалгалтын сандруу цаг; **белая** ~ архины галзуу.
ГОРЯ́ЧНОСТЬ 1. түргэдүү, түргэн; ~ **характера** түргэдүү зан; 2. чармайлт; шавдуу.
ГОРЯЧО́ халуун, халуунаар, чин санаанаас.
ГОСБА́НК (государственный банк) улсын банк.
ГОСБЕЗОПА́СНОСТЬ улсыг аюулаас хамгаалах байгууллага.
ГОСБЮДЖЕ́Т (государственный бюджет) улсын төсөв, улсын орлого зарлага.
ГОСИЗДА́Т (государственное издательство) улсын хэвлэлийн газар.
ГОСПИТАЛИЗИ́РОВАТЬ эмнэлгэд хэвтүүлэх, хэвтүүлэн эмчлэх.
ГО́СПИТАЛЬ цэргийн эмнэлгийн газар, **полевой** ~ цэргийн хээрийн эмнэлгийн газар.
ГОСПЛА́Н *(государственный плановый комитет)* улсын төлөвлөгөөний газар.
ГОСПОДА́ ноёд; **дамы и** ~**!** ноёд хатагтай нараа!
ГОСПОДИ́Н эзэн, ноён, эрхэм; ~ **председатель!** Ноён даргаа! **Сам себе** ~ өөрөө өөртөө эзэн, бор гэртээ богд,хар гэртээ хаан.

ГОСПО́ДСКИЙ ноёны, эзний.
ГОСПО́ДСТВО ноёрхол, ноёрхох, ноёлох, зонхилох; ~ **на море** далай дээр ноёрхох; **политическое** ~ улс төрийн ноёрхол.
ГОСПО́ДСТВОВАТЬ ноёрхох, ноёлох, зонхилох; ~ **в воздухе** агаарт ноёрхох.
ГОСПО́ДСТВУЮЩ||ИЙ ноёрхох, ноёлох, зонхилох; ~ **класс** ноёрхогч анги; **~ая высота** ноёлох өндөрлөг.
ГОСПОЖА́ 1. хатан, хатагтай, ноёгтой; 2. авгай.
ГОСПРЕДПРИЯ́ТИЕ (государственное предприятие) улсын худалдаа үйлдвэрийн газар.
ГОСТ стандартын хороо, тогтсон стандарт хэв хэмжээ.
ГОССТРА́Х (государственное страхование) улсын даатгалын газар.
ГОСТЕПРИИ́МН||ЫЙ найрсаг, элэгсэг, зочломтгой; **~ые люди** зочломтгой хүмүүс.
ГОСТЕПРИИ́МСТВО зочлон хүндлэх, зочлох, зочлол.
ГОСТИ́НАЯ зочлох тасалгаа, зочлох өрөө, зочлох танхим.
ГОСТИ́НЕЦ бэлэг, ёсны юм, гарын бэлэг.
ГОСТИ́НИЦ||А зочид буудал; **останавливаться в ~е** зочид буудалд байрлах.
ГОСТИ́ТЬ айлчлах, зочин болох, гийчлэх.
ГО́СТ||Ь айлчин, гийчин, зочин, айлчлах; **быть в ~ях** зочин болж байх; **незваный ~** урилгагүй зочин; **принимать ~ей** зочдыг хүлээн авах; **в ~ях хорошо, а дома лучше** айлд аятай боловч гэртээ бүр аятай.
ГО́СТЬЯ эмэгтэй гийчин, зочин эмэгтэй.
ГОСУДА́РСТВЕННОСТЬ засаг төр, төр.
ГОСУДА́РСТВЕНН||ЫЙ улсын, төрийн, гүрний; ~ **строй** төрийн байгуулал; **~ые органы** төрийн байгууллага; **~ая власть** улсын засаг; **~ая независимость** улсын тусгаар тогтнол; ~ **флаг** төрийн далбаа; **~ая граница** улсын хил.
ГОСУДА́РСТВО улс, гүрэн, засаг төр, төр; **граница** ~ улсын хил; ~ **и революция** төр ба хувьсгал; **многонациональное** ~ олон үндэстнээр бүрэлдсэн улс.
ГОСУДА́РЫНЯ хатан; хатагтай; **милостивая** ~ хүндэт хатагтай.
ГОСУДА́РЬ 1. хаан; 2. ноён; **милостивый** ~ хүндэт ноён.
ГО́ТИКА готик (Баруун Европын хуучин цагийн шовх уран барилгын маяг).
ГОТИ́ЧЕСКИЙ готик, гот(шовх хэлбэртэй).
ГОТОВА́ЛЬНЯ гортиг хэрэгсэл.
ГОТО́ВИТЬ 1. бэлтгэх, бэлдэх, зэхэх; ~ **кадры** боловсон хүчнийг бэлтгэх; 2. бэлдэх, хийх; ~ **уроки** хичээл бэлдэх, хичээлээ хийх; ~ **обед** хоол хийх; 3. бэлтгэл хийх, бэлтгэх; ~ **встречу гостям** зочдыг угтах бэлтгэл хийх.
ГОТО́ВИТЬСЯ бэлтгэх, бэлдэх, бэлтгэгдэх, зэхэх, хийх, төхөөрөх; **книга готовится к изданию** ном хэвлэлд бэлтгэгдэж байна.
ГОТО́ВНОСТЬ бэлэн, бэлхэн, зэхээстэй; **выразить** ~ **ехать** явахад бэлнээ хэлэх.
ГОТО́В||ЫЙ бэлэн, бэлхэн, бэлэн зэлэн; **обед готов** хоол бэлэн; **мы ~ы к экзаменам** бид шалгалтанд бэлэн; **будь готов** бэлэн бай; **готов на всё** яахад ч бэлэн.
ГОФРИРО́ВАНН||ЫЙ атриатай, нугачмал, долгионтой; **~ое железо** атриатай төмөр.
ГОФРИРОВА́ТЬ атриа гаргах, нугачаа гаргах, нугачмал болгох, хуниас гаргах.
ГРАБЁЖ тонуул, дээрэм; **вооружённый** ~ зэвсэгт дээрэм.
ГРАБИ́ТЕЛЬ дээрэмчин, тонуулч.
ГРА́БИТЬ дээрэмдэх, тонох.
ГРА́БЛИ тармуур, **конные** ~ морин тармуур.
ГРАВЁР сийлбэрч.
ГРАВЁРН||ЫЙ сийлбэрийн,сийлэх; **~ое искусство** сийлбэрийн урлаг.
ГРА́ВИЙ хайрга, хайрын чулуу.
ГРАВИ́РОВАТЬ сийлэх; ~ **на меди** зэсэн дээр сийлэх.
ГРАВИРО́ВКА сийлэх, сийллэг.
ГРАВИРО́ВЩИК сийлбэрч.
ГРАВИТА́ЦИЯ дэлхийн таталт.
ГРАВЮ́РА сийлбэр.
ГРАД I 1. мөндөр; **выпал сильный** ~ их мөндөр орлоо; 2. гоожих, ус шиг урсах, үргэлжлэн цувах; **пот льётся ~ом** хөлс гоожих, хөлс ус шиг урсах.
ГРАД II балгас, хот.
ГРАДА́ЦИЯ шатлал, зиндаа.
ГРАДОНАЧА́ЛЬНИК хотын дарга, хотын тэргүүлэгч.
ГРАДУ́ИРОВАТЬ шатлах, шатлан эмжээслэх.
ГРА́ДУС градус (дугуй ба өнцгийг хэмжих нэгж); **угол в шестьдесят ~ов** жаран градусын өнцөг.
ГРА́ДУСНИК халууны хэмжүүр, халууны шил.
ГРА́ДУСН||ЫЙ градуст, хуваарьт, градусын; **~ое измерение** градусын хэмжил.
ГРАЖДАНИ́Н 1. иргэн, харьяат; 2. хүн, нөхөр, эрхэм; **неизвестный ~ пришёл** нэг танихгүй хүн ирсэн; **~! постойте!** ай нөхөөр! зогсоорой!
ГРАЖДА́НКА 1. эмэгтэй иргэн, харьяат эмэгтэй; 2. авгай.
ГРАЖДА́НСК||ИЙ иргэний, ард иргэний; ~ **долг** иргэний үүрэг; **~ие права** иргэний эрх; ~ **кодекс** иргэний хууль; **~ая война** иргэний дайн.
ГРАЖДА́НСТВ||О 1. харьяат, иргэн; 2. сайшаагдах, зөвшөөрөгдөх, нийтэд дэлгэрэх; **получить права ~а** олонд сайшаагдах, нийтэд дэлгэрэх.
ГРАММ грамм(хэмжээс); **сто ~ов** зуун грамм.
ГРАММА́ТИК||А хэл зүй, хэлний зүй; **морфология и синтаксис являются частями ~и** хэлбэр зүй, өгүүлбэр зүй бол хэл зүйн хэсэг болно.
ГРАММАТИ́ЧЕСК||ИЙ хэл зүйн; **~ие ошибки** хэл зүйн алдаа; ~ **строй** хэл зүйн байгуулал.
ГРАММОФО́Н эгшигт хайрцаг, граммофон.
ГРА́МОТ||А 1. бичиг, бичиг үсэг, ном; **обучаться ~е** бичиг заалгах; ном заалгах, бичиг үсэг сурах; 2. жуух, үнэмлэх; **почётная** ~ хүндэт жуух; **верительная** ~ итгэмжлэх жуух бичиг.
ГРА́МОТНО зүгээр, эвтэйхэн, учир мэдэх байдалтай.
ГРА́МОТНОСТЬ 1. бичиг мэдэх, бичиг мэдэх явдал; **всеобщая** ~ нийтээр бичиг мэдэх болох; 2. алдаагүй, зөв зүйтэй, мэдлэг, чадмаг; **политическая** ~ төрийн бодлогын мэдлэг.
ГРА́МОТН||ЫЙ 1. бичиг мэдэх, бичиг үсэг мэдэх; ~ **человек** бичиг мэдэх хүн; 2. алдаагүй, алдаа мадаггүй, зөв; **~ое письмо** алдаагүй бичиг; 3. чадмаг, мэдэц сайтай, мэдлэгтэй; 4. зөв сайн, сайн хийгдсэн; **вполне ~ая работа** нилээд сайн хийгдсэн ажил.
ГРАНА́Т анар, сэмбэрүү.
ГРАНА́ТА гранат, бөмбөг; **ручная** ~ гар бөмбөг.
ГРАНДИО́ЗН||ЫЙ агуу, лут, их, асар их; **~ое здание** лут барилга; **~ые замыслы** асар их санаархал.
ГРАНЁНЫЙ засмал, талстай, цамцаалтай; ~ **стакан** талст шилэн аяга.
ГРАНИ́Т боржин, **набережная облицована ~ом** голын эрэг боржингоор хөвөөлөгджээ.
ГРАНИ́ТН||ЫЙ боржин; **~ая глыба** бөөм боржин; түнтгэр боржин.
ГРАНИ́ТЬ талс гаргах, цамцаал гаргах, цамцааллах; ~ **алмаз** алмаз цамцааллах.

ГРАНИ́Ц||А 1. хил; **государственная ~** улсын хил; 2. хязгаар, хэмжээ; **нашей радости не было границ** бидний баярласан нь хязгааргүй байлаа; **за ~ей** хилийн цаана, гадаадад.

ГРАНИ́ЧИ||ТЬ 1. хил залгах, зах нийлэх; 2. нийлэх, адилсах, ойртох, хүрэх; **его мастерство ~т с искусством** түүний чадвар урлагт ойртоно.

ГРА́НКА өрдөс.

ГРАН||Ь 1. талс, цамцаал; **у куба шесть ~ей** шоо дөрвөлжинд зургаан талс бий; 2. зааг, хязгаар, ирмэг, даваа; **на ~и смерти** үхэхийн даваан дээр.

ГРАТИС үнэгүй, үнэ төлбөргүй.

ГРАФ гүн.

ГРАФА́ хүснэг.

ГРА́ФИК 1. хуваарь; **~ движения поездов** галт тэрэг явах хуваарь; 2. зурмаг, хүснэгт; **производственный ~** үйлдвэрлэлийн зурмаг.

ГРА́ФИКА 1. зураас (будаггүй шугам зураг); 2. үсгийн дүрс; **русская ~** орос үсгийн дүрс.

ГРАФИ́Н галуун хүзүүт лонх, бутан.

ГРАФИ́НЧИК жижиг лонх.

ГРАФИ́НЯ гүнгийн хатан, хатан.

ГРАФИ́Т бал чулуу.

ГРАФИ́ТЬ хүснэгдэх, хүснэг татах.

ГРАФИ́ЧЕСК||ИЙ зурмал, зураасан зургийн; **~ое искусство** зураасан зургийн урлаг.

ГРАФОЛО́ГИЯ бичгийн хэвээр хүний зан байдлыг шинжих ухаан.

ГРАФЛЕ́НИЕ хүснэг татах, шугам татах.

ГРАФЛЁН||ЫЙ хүснэг татсан, шугамтай, шугам татсан; **~ая бумага** шугамтай цаас.

ГРА́ФСКИЙ гүнгийн.

ГРА́ФСТВО 1. гүнгийн хэргэм; 2. гүнгийн харьяат газар, гүнлэг.

ГРАЦИО́ЗН||О, ГРАЦИО́ЗН||ЫЙ гунхсан, гунхалзуур, гунхалзах; **~ая девушка** гунхсан хүүхэн; **~ танец** гунхалзах бүжиг.

ГРА́ЦИЯ гунхах, гунхалзах.

ГРАЧ хар туруу (тороо), хар хэрээ, турлааг.

ГРЕБЁНК||А 1. сам; **расчесать волосы ~ой** самаар үс самнах; 2. дэржигнүүр (зам); **стричь всех под одну ~у** тэгшлэн засах; бүгдийг нэг загвартай болгох.

ГРЕ́БЕНЬ 1. сам; **частый ~** шигүү сам; 2. хяр, хянга; **~ горы** уулын хяр; 3. залаа, цацаг; **петушиный ~** тахианы залаа; 4. цохио; сэрвэн; нуруу; **~ волны** долгионы нуруу.

ГРЕБЕ́Ц сэлүүрч, сэлбүүрч.

ГРЕБЕШО́К 1. бяцхан сам; 2. залаа, цацаг; **петушиный ~** тахианы залаа.

ГРЕ́БЛЯ сэлүүрдэх, сэлбүүрдэх; **парная ~** хосоор сэлүүрдэх.

ГРЕБН||О́Й сэлүүрийн, сэлүүр, сэлэх; **~ая лодка** сэлүүрт завь.

ГРЁЗА сэтгэл зүүдний бодол, мөрөөдөл,хүсэл.

ГРЕ́ЗИТЬ санагалзах, сэтгэл зүүдэндээ бодох, мөрөөдөх.

ГРЕ́ЗИТЬСЯ сэтгэлд ургах, зүүдэнд орох.

ГРЕК грек, эллин хүн.

ГРЕ́ЛКА хөлчлөг, халуун жин.

ГРЕМЕ́ТЬ 1. нижигнэх, нир хийх, хангинах, дуугарах; **гром гремит** тэнгэр дуугарч байна; 2. алдарших, дуурсах, цууриатах.

ГРЕМУ́Ч||ИЙ 1. тэсрэмтгий; **~ газ** тэсрэмтгий хий; 2. хоржигнуурт; **~ая змея** хоржигнуурт могой.

ГРЕ́НА хүр хорхой.

ГРЕНАДЁР гренадёр, өндөр биетэй цэрэг.

ГРЕНКИ́ хайрсан хатаамал (талх).

ГРЕСТИ́ I сэлүүрдэх; сэлбүүрдэх.

ГРЕСТИ́ II тармах, хамах, овоолох.

ГРЕ||ТЬ 1. шарах, дулаацуулах; **солнце ~ет** нар шарж байна; 2. ээх; хөлчих; дулаацуулах; **~ руки** гар хөлчих, гараа ээх; 3. халаах; **~ воду ус** халаах; **~ пищу** хоол халаах; **~ руки** гар дүрэх, завших.

ГРЕ́ТЬСЯ дулаацах, ээх; **~ на солнце** наранд ээх; **~ у огня** галд дулаацах.

ГРЕХ нүгэл, хилэнц; **с ~ом пополам** чуу чамай гэж, арай чүү гэж; ***как на ~** гай болоход, гай болж; **нечего ~а таить** зэмээ нуулгүй; нүглээ нуулгүй; **водится за ним один ~** түүнд нэг гэм бий; **отпустить ~и** нүглий нь арилгах.

ГРЕХО́ВНЫЙ нүгэлт, нүгэлтэй, хилэнцтэй.

ГРЕ́ЦКИЙ ~ орех хушга.

ГРЕЧА́НКА грек эмэгтэй, грек хүүхэн.

ГРЕ́ЧЕСКИЙ грек; **~ язык** грек хэл.

ГРЕЧИ́ХА сагаг, сагадай.

ГРЕЧИ́ШНЫЙ сагагийн, сагадайн.

ГРЕ́ЧНЕВ||ЫЙ сагадайн; **~ая крупа** сагадайн будаа; гурвалжин будаа; **~ая каша** сагадайн зутан; сагадайн агшаамал.

ГРЕШИ́ТЬ 1. хилэнц үйлдэх, нүгэл хийх; 2. зөрчих, алдаа гаргах, эндүүрэх, будлих; **~ против логики** логикийн эсрэг будлих.

ГРЕ́ШНИК нүгэлтэй хүн, нүгэлтэн.

ГРЕ́ШН||ЫЙ нүгэлтэй, хилэнцэт; **~ым делом** гэмээ хэлэхэд; нуулгүй хэлэхэд.

ГРЕШО́К бяцхан нүгэл, нүгэлхэн; гэм.

ГРИБ мөөг; **белый ~** цагаан мөөг; **~ маслёнок** шар хусандай мөөг; **~ подберёзовик** барзгар хусандай мөөг; **~ подосиновик** салбан хусандай мөөг; **собирать ~ы** мөөг түүх; **расти как ~ы** мөөг шиг хурдан ургачхах.

ГРИБКО́ВЫЙ мөөгөнцрийн.

ГРИБН||О́Й мөөгтэй, мөөгний; **~ суп** мөөгний шөл; **~ое место** мөөгтэй газар; **~ дождь** зүс бороо; зөөлөн хур.

ГРИБО́К 1. бяцхан мөөг; 2. мөөгөнцөр.

ГРИ́ВА дэл, зогдор; **конская ~** адууны дэл; **львиная ~** арслангийн зогдор.

ГРИ́ВЕННИК арван мөнгө.

ГРИМ нүүр будах, нүүрний будаг, энгэсэг.

ГРИМА́СА ярвайх, ярвалзах, урвалзах, нүүрээ татгануулах.

ГРИМА́СНИЧАТЬ уравганах, яравганах.

ГРИМЁР нүүр будагч, нүүр хувирагч, нүүр будах.

ГРИМИРОВА́ТЬСЯ нүүрээ будах.

ГРИМИРО́ВКА нүүрээ будах.

ГРИПП томуу, ханиад; **болеть ~ом** ханиад хүрэх.

ГРИППО́ЗНЫЙ томууны, ханиадны.

ГРИФ I 1. тас, нөмрөг тас; 2. гардилаг.

ГРИФ II 1. сийлбэр үсэг; 2. гарын тийз; 3. чавхдас хөгжмийн бариул.

ГРИ́ФЕЛЬ чулуун үзэг.

ГРИ́ФЕЛЬН||ЫЙ занар, чулуун; **~ая доска** чулуун самбар.

ГРО́Б 1. авс; 2. үхлүүд, үхэх; **свести в ~** үхэхэд хүргэх; **верность до ~а** үхтэл үнэнч; **по ~** төрөл арилжих.

ГРОБНИ́ЦА бунхан.

ГРОБОВ||О́Й авсны; **до ~ доски** үхтлээ; **~ое молчание** дув дуугай болцгоох; **~ая тишина** чив чимээгүй болцгоох.

ГРОБОВЩИ́К авсчин.

ГРОЗА́ 1. аадар, ширүүн бороо, аянгатай бороо; **разразилась ~** ширүүн бороо оров; 2. айхтар юм, аянга, аюулт амьтан; **он был ~ою нашего района** тэр бол манай нутгийн аюулт амьтан нь байлаа.

ГРОЗДЬ хонгорцог; **~ винограда** үзмийн хонгорцог.

ГРОЗИ́||ТЬ 1. занах, заналхийлэх, сүрдүүлэх, далайлгах; **~ разрывом** сална гэж далайлгах; 2. аюул тулгарах, аюул

учрах, магадгүй, гэж байх, аюултай болж мэдэх; **ему ~ла гибель** түүнд үхлийн аюул тулгарч байв.

ГРОЗИ́ТЬСЯ занаж зүхэх, сүрдүүлэн занах.

ГРО́ЗНО айхтар, догшин, сүртэй, ууртайгаар.

ГРО́ЗН||ЫЙ 1. айхтар, аюултай, аймшигтай; ~ **час** аюултай цаг; **~ая сила** аймшигт хүч; ~ **взгляд** айхтар харц; 2. догшин, сүртэй, ширүүн; ~ **человек** ширүүн хүн; ~ **правитель** догшин захирагч.

ГРОЗОВ||О́Й аянгатай бороонтой, азарган бороонтой, аюултай; **~ая туча** аянгатай бороонтой үүл.

ГРОМ аянгын дуу, тэнгэрийн дуу, аянга; **послышались раскаты ~а** тэнгэрийн дуу нижигнэж байв; **удар ~а** аянга буух; ***метать ~ы и молнии** ганирах, сүйд майд болох, догшин сахиусаа буулгах; **пока ~ не грянет** айхтар юм болохоос наана; **как ~ среди ясного неба** цэлмэг тэнгэрээс цахилгаан буух шиг, ав ажиггүй байтал аюул болох.

ГРОМА́ДА аварга, их том, мундаг их; ~ **гор** мундаг их уулс.

ГРОМА́ДИНА лут мундаг; аварга том.

ГРОМА́ДНЫЙ маш том, маш их, маш олон.

ГРОМИ́ЛА тонуулчин, бусинулагч.

ГРОМИ́ТЬ 1. сүтгэх, бусниулах; ниргэх; 2. бут цохих; үнсэн товрог болгох; ~ **врага** дайсныг бут цохих.

ГРО́МК||ИЙ 1. чанга дуугаар; ~ **разговор** чанга дуугаар ярих; 2. алдарт, цуутай, цуу; **~ое имя** цуутай нэр; **~ая слава** алдар цуу.

ГРО́МКО чанга, чимээтэй, сүртэй.

ГРОМКОГОВОРИ́ТЕЛЬ дуу чангатгагч.

ГРОМОВ||О́Й 1. аянгын, тэнгэрийн; **~ые раскаты** аянгын дуу; 2. луугийн, ууртай, нижигнэсэн; **~ым голосом** луугийн дуугаар, ууртай дуугаар.

ГРОМОГЛА́СНО өндөр дуугаар; ~ **заявить** өндөр дуугаар зарлах, луугийн дуугаар лужигнаж, барын дуугаар бажигнаж хэлэх.

ГРОМОГЛА́СНЫЙ нижигнэсэн дуутай, өндөр дуугаар, луугийн дуугаар.

ГРОМОЗДИ́ТЬ 1. овоолох; ~ **ящики** хайрцаг овоолох; 2. овооруулах; шавалдуулах; ~ **цитаты** шавалдуулан иш татах.

ГРОМОЗДИ́ТЬСЯ овоорох, овоолдох; **вдали громоздятся прибрежные скалы** эргийн хаднууд алсад овоорон харагдав.

ГРОМО́ЗДК||ИЙ нүсэр, тойвтой, авсаархан бус; **~ая мебель** гэрийн нүсэр тавилга.

ГРОМООТВО́Д аянгын сарниул, аянгын хориг; аянгын хорилт.

ГРОМОПОДО́БНЫЙ аянга мэт, аянга шиг, лууны; ~ **голос** аянга мэт дуу, лууны дуу.

ГРОМЫХА́ТЬ 1. нижигнэх, нирхийх; 2. түжигнэх, тэржигнэх.

ГРОССМЕ́ЙСТЕР 1. шатрын их мастер; 2. их багш.

ГРОТ агуй, засмал агуй.

ГРОТЕ́СК хачин маягтай урлаг, хөгийн зохиол.

ГРО́ХНУТЬ 1. нирхийх, нижигнэх; 2. тар няр хийтэл хаях.

ГРО́ХНУТЬСЯ нирхийж унах, пидхийтэл ойчих.

ГРО́ХОТ нижигнэх, тажигнах, тар няр хийх, тус тас хийх; ~ **пушек** их буу нижигнэх.

ГРОХОТА́НЬЕ нижигнэх чимээ, тачигнах чимээ.

ГРОХОТА́ТЬ нижигнэх, тачигнах.

ГРОШ 1. зэс зоос; 2. сохор зоос, улаан мөнгө; **не иметь ни ~а** сохор зоос ч үгүй; ***~а ломаного не стоит** улаан мөнгөний ч үнэгүй юм; **купить за ~и** хямдхан үнээр авах, зүгээр шахуу авах.

ГРОШО́В||ЫЙ шалихгүй, яльгүй; **~ые расходы** яльгүй зардал; **~ая цена** шалихгүй үнэ.

ГРУБЕ́||ТЬ 1. дарсайх, саарьтах; **кожа ~ет** арьс дарсайна; 2. болхи болох, эв хавгүй болох; дүй муутай болох; **голос ~ет** хоолой эв хавгүй болж байна.

ГРУБИ́ТЬ ширүүн үг хэлэх; авирлах; аашлах; муухай загнах; зүй бус үг хэлэх; **не груби старшим** ах хүнд битгий ширүүн үг хэл.

ГРУБИ́ЯН хэрцгий хүн, ааш муутай хүн.

ГРУ́БО 1. зүй бус, ширүүн; 2. болхи хийцтэй, бүдүүлэг.

ГРУ́БОСТ||Ь бүдүүлэг, хэрцгий, ширүүн; **говорить ~и** ширүүн үг хэлэх.

ГРУ́Б||ЫЙ 1. бүдүүн, бүдүүн хийцтэй; **~ое сукно** бүдүүн цэмбэ; 2. бүдүүлэг, ширүүн, догшин, муухай ааштай; **~ое обращение** ширүүн авирлах; 3. багцаалах, бараглах; **~о говоря** бараглаж хэлэхэд; **~ая сила** хар хүч; **~ая ошибка** муухай алдаа; их алдаа; ~ **голос** бүдүүн хоолой.

ГРУ́Д||А овоо, бөөн; **~ы фруктов** жимсний овоо; **превращать в ~у развалин** үнсэн товрог болгох; эвдэрхий туурь болгох.

ГРУДИ́НКА өвчүү, хэрсэн; **копчёная ~** утсан хэрсэн.

ГРУДНИ́ЦА хөхний хавдар.

ГРУДН||О́Й 1. хөхүүл; ~ **ребёнок** хөхүүл хүүхэд; 2. цээжний; **~ая жаба** цээжний бах; **~ая клетка** цээжний яс, хэнхэрцэг; **~ая железа** хөх, дэлэн.

ГРУДОБРЮ́ШН||ЫЙ цээж хэвлийн; **~ая преграда** өрц.

ГРУ́ДЬ 1. цээж, хэнхдэг; **дышать всей ~ю** бүх цээжээр амьсгалах; **широкая ~** өргөн цээж; **прикрыть ~ю** цээжээр халхлах; 2. хөх; **кормить ребёнка ~ю** хүүхдийг хөхөөр тэжээх; **встать ~ю на защиту родины** амь биеэр эх орноо хамгаалах.

ГРУЖЁНЫЙ ачсан, ачаатай.

ГРУЗ ачаа, тээш; **взваливать ~ на чужие плечи** үүргээ бусдад үүрүүлэх.

ГРУЗДЬ дөрдгөр сархиаг, мөөг.

ГРУЗИ́ЛО живүүр, чивүүр.

ГРУЗИ́Н гүрж хүн.

ГРУЗИ́НКА гүрж эмэгтэй.

ГРУЗИ́НСКИЙ гүрж, гүржийн.

ГРУЗИ́ТЬ 1. ачих, тээх; ~ **дрова** түлээ ачих; ~ **на машину** машинд ачих; 2. зовоох; ядраах.

ГРУЗИ́ТЬСЯ ачаагаа тээх, юмаа ачих.

ГРУ́ЗН||ЫЙ нүсэр лантгар, тойвтой; **~ая фигура** нүсэр бие.

ГРУЗОВИ́К ачааны машин, ачааны тэрэг.

ДЕФИЦИ́Т 1. дутагдах, гарз, гарлага «орлогоос зарлага үлэмж болох»; 2. ховордох, хомсдох, ховор; **~ товаров** бараа ховордох.

ДЕФИЦИ́ТНОСТЬ дутагдал, гарздал, ховордол.

ДЕФИЦИ́ТН||ЫЙ 1. гарзтай; 2. ховордсон, ховор; **~ые товары** ховор бараа.

ДЕФОРМА́ЦИЯ хэв гажил, өөрчлөгдөх.

ДЕФОРМИ́РОВАТЬ хэвийг гажуудуулах, хэлбэр өөрчлөх.

ДЕФОРМИ́РОВАТЬСЯ хэв гажих, хэлбэрээ алдах, хэлбэр өөрчлөгдөх. **ДЕЦЕНТРАЛИЗА́ЦИЯ** **децентрализовать**, төвлөрөх явдлыг багасгах, төвлөн захирах явдлыг хомстгох.

ДЕЦИМЕ́ТР дециметр, арван сантиметр.

ДЕШЕВЕ́ТЬ хямдрах.

ДЕШЕВИ́ЗНА хямд, хямд үнэ.

ДЕШЁВК||А хямдхан, тун хямдхан; **купить по ~е** тун хямдхан авах.

ДЕ́ШЕВО 1. хямд, хямд үнээр; **~ заплатить** хямд төлөх; 2. хялбар, амархан; **~ отделаться** хялбар салах.

ДЕШЁВ||ЫЙ 1. хямд, хямдхан, татаг үнэ; **работать за ~ую цену** хямд үнээр ажил хийх; **~ые ткани** хямдхан бөс, татаг үнэтэй даавуу; 2. базаахгүй, завхай; **~ успех** базаахгүй амжилт; **~ые шуточки** завхай шог яриа.

ДЕ-Ю́РЕ хууль ёсоор; **признать державу ~** гүрнийг хууль ёсоор зөвшөөрөх.

ДЕЯ́НИЕ үйлс; **великое ~** их үйлс.

ДЕ́ЯТЕЛЬ зүтгэлтэн, зүтгэгч; **государственный ~** төрийн зүтгэлтэн; **~ науки** шинжилгээний зүтгэлтэн; **заслуженный ~** гавьяат зүтгэлтэн.

ДЕ́ЯТЕЛЬНОСТЬ ажиллагаа, үйл ажил; **научная ~** шинжилгээний үйл ажил.

ДЕ́ЯТЕЛЬН||ЫЙ оролдлоготой, хичээлтэй, хөдөлгөөнтэй, идэвхтэй; **принимать ~ое участие** идэвхитэй оролцох; **~ человек** оролдлоготой хүн, хөдөлгөөнтэй хүн.

ДЖАЗ джаз, жаз «үлээвэр, цохивор, шуугиант зэвсгийн найрал хөгжим»

ДЖА́ЗОВЫЙ жаз хөгжмийн.

ДЖЕ́МПЕР жемпер, сүлжмэл хантааз, цээживч, цэгдэг.

ДЖЕНТЛЬМЕ́Н боловсон хүн, ёсорхог хүн; **~ское соглашение** аман хэлэлцээр.

ДЖИГИ́Т жигит, гавшгай морьтон, моринд чадамгай хүн.

ДЖУЗГУ́Н азар(улаан түлээ)

ДЖУ́НГЛИ ширэнгэ, ой, битүү шугуй.

ДЗОТ зот, буудлагын хорго, буудлагын бэхэлсэн газар «мод шороогоор бэхэлсэн буудлагын газар».

ДИАБЕ́Т шижин өвчин; **сахарный ~** чихрийн шижин.

ДИА́ГНОЗ оношлогоо; **устанавливать ~** оношлогоо тавих.

ДИАГНО́СТИКА оношлогооны зүй, оношийн зүй, өвчнийг таних ухаан.

ДИАГОНА́Л||Ь ташууч, ташуу шугам, хушуулдах шугам; **располагать по ~и** ташуучлан жагсаах, хушуулдан жагсах.

ДИАГОНА́ЛЬН||ЫЙ диогональ, ташууч, хушуулдах, сөөлжүү; **в ~ом направлении** ташууч чиглэлээр.

ДИАГРА́ММА диаграмм, жишиг зураг, харьцангуй жишиг.

ДИАДЕ́МА титэм, овоодой.

ДИАКРИТИ́ЧЕСКИЙ ялгах, үсгийн дуудлагыг ялгах нэмэлт; **~ знак** ялгах тэмдэг.

ДИАЛЕ́КТ аялгуу, аман аялгуу; **местные ~ы** нутгийн аман аялгуу.

ДИАЛЕ́КТИК диалектикч.

ДИАЛЕ́КТИКА диалектик «байгаль ба хүний нийгмийн хөгжил, хөдөлгөөний нийт хуулиудын тухай шинжлэх ухаан».

ДИАЛЕКТИ́ЧЕСКИЙ диалектик, **~ материализм** диалектик материализм; **~ метод** диалектик арга «*харш зүйлүүдийн зөрчлөөс хөгжил хөдлөл үүснэ гэдэг марксист шинжлэх ухааны арга*»

ДИАЛЕКТОЛО́ГИЯ аялгууны судлал, аман аялгууны судлал.

ДИАЛО́Г харилцан яриа.

ДИАЛОГИ́ЧЕСКИЙ харилцан ярианы.

ДИАМА́Т диалектик материализм.

ДИА́МЕТР диаметр тэнгэлэг, голч.

ДИАМЕТРА́ЛЬН||ЫЙ 1. голч шугамын хоёр үзүүрийн; 2. тэс, огт; **~ая противоположность** тэс өөр.

ДИАПАЗО́Н 1. диапазон, цар, чинээ, хөгжим дууны цар; 2. хэмжээ, багтаамж, мэдэц.

ДИАПОЗИТИ́В зурагт шил, зурагт хальс.

ДИАФРА́ГМА 1. өрц; 2. диафрагм, өрцөн сөхүүр.

ДИВА́Н диван, урт зөөлөн сандал, буйдан.

ДИВЕРСА́НТ хорлон сүйтгэгч.

ДИВЕРСИО́ННЫЙ хорлон сүйтгэх; **~ акт** хорлон сүйтгэх явдал.

ДИВЕ́РСИЯ хорлон сүйтгэх.

ДИВЕРТИСМЕ́НТ зугаа наадам, нэмсэн тоглолт.

ДИВИДЕ́НД ногдол ашиг.

ДИВИЗИО́Н дивизион; **кавалерийский ~** морьт цэргийн дивизион.

ДИВИЗИО́ННЫЙ дивизионы.

ДИВИ́ЗИЯ дивизи «*хэдэн хороо цэрэг*»; **пехотная ~** явган цэргийн дивизи; **стрелковая ~** буудлагын дивизи.

ДИВИ́ТЬ хачирхуулах, гайхуулах.

ДИВИ́ТЬСЯ хачирхах, гайхах; **я дивился его успехам** би түүний амжилтыг хачирхаж байлаа.

ДИ́ВНО хачирхалтай, хачин, гайхалтай.

ДИ́ВН||ЫЙ хачин, хачирхалтай, хачин сайхан, гайхамшиг; **~ые дела** хачин хэрэг; **~ый голос** хачин сайхан хоолой.

ДИ́В||О хачин, хачин сайхан, гайхалтай; **что за ~?** ямар хачин юм бэ? **~у даваться** гайхах, хачирхах; **на ~!** хачин сайхан!

ДИДАКТИ́ЧЕСКИЙ сургаалын сургамжийн.

ДИЕ́Т||А цагаан хоол, сувиллын хоол, эмнэлгийн хөнгөн хоол; **посадить на ~у** цагаан хоол идүүлэх.

ДИЕТИ́ЧЕСК||ИЙ цагаан хоолны, сувиллын, эмнэлгийн хөнгөн хоолны; **~ая столовая** цагаан хоолны гуанз; **~ое питание** сувиллын хоол.

ДИ́ЗЕЛЬ дизель дотоood шаталтын хөдөлгүүр.

ДИЗЕНТЕРИ́Я дизентери, цусан балнад өвчин.

ДИКА́РЬ зэрлэг хүн.

ДИ́К||ИЙ 1. зэрлэг, бүдүүлэг; **~ое животное** зэрлэг амьтан; **~ие племена** зэрлэг аймгууд, бүдүүлэг аймгууд; 2. зэрлэг, хээрийн; **~ая яблоня** зэрлэг алим, өрөл; **~ая утка** хээрийн нугас; 3. аглаг, хээр, зэлүүд, буйд, эзгүй; **~ая местность** аглаг газар, зэлүүд нутаг; 4. ичимхий, зожиг, бишүүрхүү; **~ ребёнок** ичимхий хүүхэд; 5. догшин, зэрлэг; **~ие нравы** догшин зан, зэрлэг араншин; 6. зэрлэг, эмнэг; **~ая лошадь** эмнэг морь, тахь; **~ баран** хонин гөрөөс, аргаль угалз; **~ зверь** араатан.

ДИКОБРА́З үхэр зараа.

ДИКО́ВИН||А хачин, жигтэй; **что за ~?** ямар хачин юм бэ? **в ~у** жигтэй юм.

ДИКО́ВИННЫЙ хачин, жигтэй,ер бусын; **~ случай** жигтэй явдал, ер бусын тохиол.

ДИКОРАСТУ́ЩИЙ зэрлэг, зэрлэг ургадаг, хээрийн, таримал бус.

ДИ́КОСТЬ 1. зэрлэг; 2. дэмий юм, шал дэмий.

ДИКТА́НТ цээж бичиг, цээжээр бичих, сонсож бичих; **писать ~** цээжээр бичих.

ДИКТА́Т шахаж хүлээлгэх; тулгаж хүлээлгэх.

ДИКТА́ТОР диктатор, дарангуйлан захирагч.

ДИКТА́ТОРСК||ИЙ ганцаараа захирах, диктаторын, дарангуйлан захирах; **~ая власть** дарангуйлан захирах засаг.

ДИКТА́ТОРСТВО дарангуйлан захирах, ганцаараа захирах, диктаторлох.

ДИКТАТУ́РА диктатур, дарангуйлан захирах засаг **~ пролетариата** пролетарийн диктатур, ажилчин ангийн дарангуйлан захирах засаг.

ДИКТОВА́ТЬ 1. цээжээр бичүүлэх, хэлж бичүүлэх; **~ ученикам** сурагчдад цээжээр бичүүлэх; **~ письмо машинистке** машины бичээчэд захидал хэлж бичүүлэх; 2. тулгаж хэлүүлэх, тушаах, албадан хүлээлгэх; **~ условия** албадан тулгах; **~ свою волю побеждённому** ялагдсан этгээдэд өөрийн саналыг тушааж хүлээлгэх.

ДИКТО́ВК||А 1. цээжээр бичүүлэх; 2. шахаж бичүүлэх, тулгаж бичүүлэх, тушаалаар бичих; **под ~у** хэлснийг дагаж бичих.

ДИ́КТОР диктор, уншигч, радио нэвтрүүлэгч.

ДИ́КЦИ||Я үгийн дуудлага, дуудлага, үг хэлэх; **речь было трудно понимать вследствие плохой ~и оратора** илтгэгчийн үгийн дуудлага муу учраас ойлгоход хэцүү байлаа.

ДИЛЕ́ММА хоёрын нэгийг шилэх; **перед ним стоит ~** хоёрын нэгийг шилэх явдал түүнд оногдов.

ДИЛЕТА́НТ зөвхөн шохоорхогч, өнгөц сонирхогч, гүехэн мэдлэгтэн.

ДИЛЕТА́НТСКИЙ зөвхөн шохоорхох, өнгөц сонирхох, гүехэн мэдлэгтэй.

ДИЛЕТА́НТСТВО зөвхөн шохоорхох, өнгөц сонирхох, гүехэн мэдлэг.

ДИНА́МИК||А 1. динамик, хүчлэг, бодисын хөдлөлийн ухаан; 2. хөдлөл, явц; **~ общественного развития** нийгмийн хөгжлийн явц; 3. хөдлөц, эрчимтэй хөдлөц, их хөдлөл; **в этой пьесе много ~и** энэ жүжигт эрчимтэй хөдлөц их байна.

ДИНАМИ́Т динамит, «*тэсрэх бодис*».

ДИНАМИ́ТНЫЙ динамитын, динамиттай.

ДИНАМИ́ЧЕСК||ИЙ динамикийн, эрчтэй, хөдлөлтэй; **~ая теория** динамикийн онол; **~ое движение** эрчтэй хөдөлгөөн.

ДИНАМИ́ЧНЫЙ хөдлөнгө, эрчимтэй, эрч хүчтэй; **~ танец** эрчимтэй бүжиг.

ДИНА́МО динам, цахилгаан гаргах машин.

ДИНА́СТИЯ 1. овгийн хаад, нэг угсааны хаад; **~ Романовых** Романов овгийн хаад; 2. улс, гүрэн; **юаньская ~** юань улс.

ДИНОЗА́ВР динозавр, аварга гүрвэл, үлэг гүрвэл.

ДИНЬ динь, жин-жин «хонхны дуу».

ДИПКУРЬЕ́Р элчин яамны буухиа, дипломат элч.

ДИПЛО́М 1. диплом үнэмлэх, сургууль төгссөний үнэмлэх; 2. үзэсгэлэнд шалгарсан үнэмлэх.

ДИПЛОМА́НТ уралдаанд шалгарч дипломоор шагнуулагч.
ДИПЛОМА́Т 1. гадаад харилцааны ажилтан; 2. ухаан зальтай хүн, зальжин хүн.
ДИПЛОМАТИ́ЧЕСКИЙ, дипломатично, харьцахдаа чадамгай, зальжин, догь, ухаан зальтай; ~ **ответ** ухаан зальтай хариу.
ДИПЛОМАТИ́ЧЕСК||ИЙ. дипломат, элчин; **~ое отношение** дипломат харилцаа, элчин харилцаа; **~ая миссия** дипломат элчин яам, дипломат даалгавар; 2. дипломат, харьцахдаа чадамгай, зальжин, догь, ухаан зальтай; ~ **подход к делу** хэрэг ажилд ухаан зальтай хандах.
ДИПЛОМА́ТИ||Я 1. *дипломати, дипломат явдал,* гадаад харилцааны ажил; 2. ухаан заль; **пустить в ход ~ю** ухаан залиа гаргах.
ДИПЛОМИ́РОВАННЫЙ дипломат, дипломтай, дээд сургууль төгссөн үнэмлэхтэй.
ДИПЛО́МНИК дипломч, шалгалтын зохиол бичигч оюутан.
ДИПЛО́МН||ЫЙ дипломын, сургууль төгсөх шалгалтын; **~ая работа студента** оюутны дипломын ажил.
ДИРЕКТИ́В||А удирдамж, захирамж; **давать ~у** удирдамж өгөх.
ДИРЕКТИ́ВН||ЫЙ удирдамжийн, захирамжийн; **~ое указание** удирдамжийн заавар.
ДИРЕ́КТОР захирал, дарга, эрхлэгч; ~ **школы** сургуулийн захирал. **ДИРЕКТО́РИЯ** директори, дээд захиргаа.
ДИРЕ́КТОРСКИЙ захирлын, даргын; ~ **кабинет** захирлын өрөө.
ДИРЕ́КЦИЯ захиргаа; ~ **театра** театрын захиргаа.
ДИРИЖА́БЛЬ *дирижабль,* агаарын хөнгөн онгоц.
ДИРИЖЁР удирдаач, хөгжмийн удирдаач, хөг зохицуулагч; ~ **оркестра** найрал хөгжмийн удирдаач.
ДИРИЖЁРСК||ИЙ удирдаачийн; **~ая палочка** удирдаачийн дохиур.
ДИРИЖИ́РОВАТЬ хөгжим удирдах, хөг зохицуулах; ~ **оркестром** найрал хөгжим удирдах.
ДИСГАРМОНИ́РОВАТЬ дуурсалгүй болгох, дуурсалгүй болгох, зөрөлдүүлэх, зохицолгүй болгох.
ДИСГАРМО́НИЯ дуурсалгүй, дуурсалгүй, зөрөлдөх, зохицолгүй.
ДИСК 1. диск, зээрэнхий, зээрэнцэг, хавтгай дугариг; ~ **для метания** шидэх зээрэнхий; 2. дүгрэг; диск луны сарны дүгрэг.
ДИСКА́НТ нарийн дуу, хангинам шингэн хоолой, *цангинах* дуу.
ДИСКВАЛИФИЦИ́РОВАТЬ1. гүйцэтгэх эрхийг хасах, мэргэжлийн эрхийг хасах; 2. мэргэжилгүй болгох, мэргэжилгүй гэж үзэх, чадваргүй гэж үзэх.
ДИСКРЕДИТА́ЦИЯ нэрийг гутаах, олны өмнө нэрийг гутаах, нэр хугалах, нэр хүндийг бууруулах.
ДИСКРЕДИТИ́РОВАТЬСЯ нэр гутах, нэр хугарах, нэр хүнд буурах.
ДИСКРИМИНА́ЦИЯ гадуурхах, алагчлах,,ялгаварлан хяхах; **расовая ~ в капиталистических странах** хөрөнгөтөн орнуудад арьс өнгөөр ялгаварлан хяхах явдал.
ДИСКУССИО́НН||ЫЙ шүүмжлэн хэлэлцэх, маргаантай; **в ~ом порядке** шүүмжлэн хэлэлцэхээр; ~ **вопрос** маргаантай асуудал.
ДИСКУССИ́РОВАТЬ шүүмжлэн хэлэлцэх, маргах, шүүмжлэлцэх.
ДИСКУ́ССИЯ өргөн шүүмжлэл, шүүмжлэн мэтгэлзэх, шүүмжлэлцээн, маргаан; **свободная ~ чөлөөт** шүүмжлэлцээн.
ДИСЛОКА́ЦИЯ 1. шилжээс, шилжих, зөрөлдөх; ~ **костей** яс шилжих, бэртсэн яс зөрөлдөх; 2. байрлуулах ~ **армии** армийг байрлуулах.
ДИСПАНСЕ́Р эмчлэн сэргийлэх газар.
ДИСПАНСЕ́РНЫЙ диспансерын, эмчлэн сэргийлэх газрын, эмчлэн сэргийлэх.
ДИСПЕ́ТЧЕР мэдээч; ~ **поезда** галт тэрэгний мэдээч.
ДИСПЕ́ТЧЕРСК||ИЙ диспетчерийн, мэдээчийн; **~ая вышка** мэдээчийн цамхаг.
ДИСПОЗИ́ЦИЯ диспозици, байлдаанд бэлэн байрлах, бэлэн жагсах.
ДИСПРОПО́РЦИЯ диспропорци, пропорцигүй болох, тэнцвэргүй болох, хэмжээ таарцгүй болох.
ДИ́СПУТ эрдмийн маргаан; ~ **теологов** ном хаялцах.
ДИСПУТИ́РОВАТЬ эрдмийн маргаан хийх, диспут хийх, ном хаялцах.
ДИССЕРТА́НТ диссертаци хамгаалагч, эрдмийн зэрэг хамгаалагч, эрдмийн зэрэг горилогч.
ДИССЕРТА́ЦИ||Я диссертаци, эрдмийн зэрэг горилох зохиол: **защищать ~ю** диссертаци хамгаалах; **кандидатская** ~ дэд эрдэмтний диссертаци.
ДИССИДЕ́НТ тэрсүүд, тэрс үзэлтэн, өөрөөр сэтгэгчид.
ДИССИМИЛЯ́ЦИЯ ондооших.
ДИССОНА́НС дууны харшлал, ая сөөлжих; 2. харшлал, дэг алдуулах; **внести ~ в работу** ажлын дэг алдуулах.
ДИССОНИ́РОВАТЬ дуу харшлах, ая сөөлжих, дэг алдах.
ДИСТА́НЦИ||Я1. зай, завсар, зайтай газар; **соблюдать ~ю** зайг барих; **на большой ~и** хол зайтай газарт; 2. анги; ~ **пути** замын анги.
ДИСТИЛИРО́ВАНН||ЫЙ нэрсэн; **~ая вода** нэрмэл ус.
ДИСТИЛЛИ́РОВАТЬ нэрэх.
ДИСЦИПЛИ́Н||А I 1. сахилга; **трудовая** ~ хөдөлмөрийн сахилга; **поднять ~у** сахилгыг дээшлүүлэх.
ДИСЦИПЛИ́НА II салбар ухаан, шинжилгээний тусгай ухаан, ухааны зүй; **историческая** ~ түүхийн салбар ухаан.
ДИСЦИПЛИНА́РН||ЫЙ сахилгын; **~ое взыскание** сахилгын шийтгэл; ~ **устав** сахилгын дүрэм.
ДИСЦИПЛИНИ́РОВАННОСТЬ, дисциплинированный, сахилга баттай, журамтай, сахилга сайтай.
ДИСЦИПЛИНИ́РОВАТЬ сахилга журмыг бататгах, сахилгатай болгох.
ДИТЯ́ нялх хүүхэд, балчир хүүхэд.
ДИФИРА́МБ хэтэрхий магтах, магтаал; **петь ~ы** хэтэрхий магтан дуурсгах.
ДИФТЕРИ́ТН||ЫЙ дифтеритный, сахууны; **~ая сыворотка** сахууны шар ус; **~ая прививка** сахууны тарилга.
ДИФТЕРИ́Т, дифтерия, сахуу, хоолойн сахуу.
ДИФТО́НГ хос эгшиг.
ДИФФЕРЕНЦИА́Л ялгал.
ДИФФЕРЕНЦИА́ЛЬН||ЫЙ 1. дифференциал, дифференциаллын; **~ое исчисление** дифференциал тоолол; 2. ялгаварт; **~ая среда** *ялгаварт орчин.*
ДИФФЕРЕНЦИА́ЦИЯ ялгарал, ялгаралт, ялгавар; **классовая** ~ ангийн ялгаралт.
ДИФФЕРЕНЦИ́РОВАТЬ ялгах, ялгаллах.
ДИФФУ́ЗИЯ диффузи, нэвчих, нэвчээслэх, халдан шингэх.
ДИФФУ́ЗНЫЙ нэвчсэн, халдан шингэх, нэвчээ.
ДИЧА́ТЬ1. зэрлэгших, эмнэгших,ардагших.
ДИЧИ́ТЬСЯ бишүүрхэх; ~ **посторонних** бусдаас бишүүрхэх.
ДИЧО́К 1. жимсний зэрлэг мод; 2. бишүүрхэг хүүхэд.
ДИЧЬ 1. ангийн шувуу; 2. шувууны мах; 3. дэмий үг.
ДЛИН||А́ урт, уртаараа, уртаашаа; **~ой в два метра** урт нь хоёр метр, хоёр метр урт; **в ~у** уртаараа; **меры ~ы** уртын хэмжээ.
ДЛИННОНО́ГИЙ урт хөлтэй, урт чацтай.
ДЛИННОНО́СЫЙ урт хамартай, унжуу хамартай.

ДЛИ́ННЫЙ 1. урт; ~ **путь** урт зам; 2. удаан; ~ **перерыв** удаан завсарлал; **у него ~ язык** задгай амтай хүн, урт хушуутай хүн.

ДЛИ́ТЕЛЬНОСТЬ удаан түргэн, урт богино; ~ **рабочего дня** ажлын өдрийн урт богино; ~ **звука** авианы урт богино.

ДЛИ́ТЕЛЬНЫЙ удаан, удаан хугацааны, өнө удаан, урт; ~ **отпуск** удаан хугацааны амралтын чөлөө.

ДЛИ́ТЬСЯ удах, үргэлжлэх; **недолго длилась наша беседа** бидний яриа их удсангүй; **собрание длилось два часа** хурал хоёр цаг үргэлжлэв.

ДЛЯ 1. тул, тулд; тусын тулд, төлөө, төлөө зориулах; **всё ~ победы** ялалтын тул цөмийг, бүгдийг ялалтын төлөө зориулах; **он приехал сюда ~ отдыха** тэр хүн энд амрахын тул ирсэн; ~ **того, чтобы** тэгэхийн тул, ингэхийн төлөө; 2. -д,-т, **вредно ~ здоровья** эрүүл мэндэд хортой, биенд хортой; **эта книга необходима ~ него** энэ ном түүнд заавал хэрэгтэй; **готовить обед ~ вас** танд хоол хийх; 3. зориулах; **книга ~ детей** хүүхдэд зориулсан ном; ~ **юношества** идэрчүүдэд зориулан; 4. **кувшин ~ воды** усны домбо; **папка ~ бумаг** бичгийн хавтас; 5. **он приехал ~ учёбы** тэр хүн сурахаар иржээ, тэр хүн сурах гэж иржээ.

ДНЕВА́ЛЬНЫЙ өдрийн жижүүр.

ДНЕВА́ТЬ өдөржин байх; ~ **и ночевать** өнжих, хонох, хонон өнжин.

ДНЕВНИ́К өдрийн тэмдэглэл, өврийн дэвтэр; **вести ~** өдрийн тэмдэглэл хийх; **школьный ~** сурагчийн өдрийн тэмдэглэл.

ДНЕВНО́Й өдрийн, өдөрчийн; ~ **свет** өдрийн гэрэл; ~ **заработок** өдрийн хөлс, өдрийн цалин; ~ **переход** өдрийн газар; өдөрчийн газар.

ДНЁМ өдөр, өдөртөө; ~ **и ночью** өдөр шөнөгүй.

ДНИ́ЩЕ ёроол.

ДНО 1. ёроол, оёор; ~ **моря** далайн ёроол; **на дне** ёроолд; **достать до дна** ёроолд хүрэх; **идти ко дну** ёроолд орох, живэх; 2. ёроолд, живүүлэх; **пускать ко дну** ёроолд оруулах, живүүлэх; 3. шавхах, дуусгах **пить до дна** шавхан уух, дуустал уух; **использовать ресурсы до дна** нөөц бэлтгэлийг шавхан ашиглах; **перевернуть вверх дном** хөмрөх, хөмрүүлэх, онгичиж урвуулах; **золотое ~** алтны сан, олзтой газар.

ДО 1. хүртэл, болтол, -тал, тэл; ~ **города осталось пять километров** хот хүртэл таван километр үлдэжээ; **ждать ~ вечера** үдэш болтол хүлээх; **отложить ~ его возвращения** түүний буцаж иртэл хойшлуулах; ~ **рассвета** үүр цайтал; **промокнуть ~ костей** ясандаа хүртэл норох, шал нойтон болох; ~ **особого распоряжения** тусгай тушаал гартал; **весом ~ двух килограммов** хоёр килограмм хүртэл жинтэй; 2. хүрэх, очих, тулах, тулж очих; **мы дошли ~ леса** бид ойд хүрэв, бид ойд тулж очив; 3. өмнө, урьд; ~ **революции** хувьсгалын өмнө; ~ **наступления холодов** хүйтэн болохоос урьд; ~ **и после** урьд хожид; 4. шахам, хүрэх, -аад, ээд; **зал вмещает ~ тысячи человек** танхимд мянга шахам хүн багтана; **мороз доходит ~ сорока градусов** хүйтэн дөчөөд градус болж байна, хүйтэн дөчин градус хүрч байна; 5. доош, хүртэл; **дети ~ десяти лет** арваас доош насны хүүхэд, арав хүртэл насны хүүхэд; **ему не ~ вас** таны тухай бодох ч аргагүй байна, таныг бодох байтугай өөрийгөө яая гэж байна; **мне не ~ шуток** над тоглох шоглох ч арга алга; **он так занят, что ему не ~ прогулок** тэр зугаалах ч завгүй их ажилтай байна; **что ~ меня, то я согласен** миний хувьд гэвэл би зөвшөөрч байна; ~ **свидания** баяртай! баяртай учиръя; ~ **чего интресная книга** ямар сонин ном бэ! ~ **сих пор** одоо хүртэл.

ДОБА́ВИТЬ,

ДОБАВЛЯ́ТЬ, нэмэх.

ДОБА́ВКА нэмэр.

ДОБАВЛЕ́НИ||Е нэмэлт, нэмэх; **примечания и ~я** тайлбар нэмэлт; **в ~ к сказанному** хэлсэн үгэндээ нэмэлт болгон.

ДОБА́ВОЧН||ЫЙ нэмэлтийн, нэмсэн, нэмэгдэл; **~ая прибыль** нэмэгдэл ашиг.

ДОБЕГА́ТЬ гүйж хүрэх.

ДОБЕЖА́ТЬ гүйж хүрэх; ~ **до дома** гэртээ гүйж хүрэх.

ДОБЕ́ГАТЬСЯ гүйн гүйсээр, ~ **до простуды** гүйн гүйсээр ханиад хүрэх.

ДОБЕЛА́1. цайтал, гялайтал; **отмыть ~** цайтал угаах, гялайтал угаах; 2. улайстал, улайсгах; **раскалить железо ~** төмөр улайстал халаах, төмөр улайсгах.

ДОБИВА́ТЬ нэрмэх, дуустал цохих, эвдэж дуусах.

ДОБИВА́ТЬСЯ оролдох, уулахыг оролдох, гэж оролдох, хүрэх, чармайх, -уулж чадах; ~ **решения** тогтоол гаргуулахыг оролдох; ~ **успеха** амжилтад хүрэхийг оролдох; **от него слова не добьёшься** түүгээр үг хэлүүлж чадахгүй.

ДОБИРА́ТЬСЯ хүрэх.

ДОБРА́ТЬСЯ 1. хүрэх; ~ **до дома** гэртээ хүрэх; 2. учрыг олох; ~ **до сути дела** хэргийн голд хүрэх, хэргийн учрыг олох.

ДОБИ́||ТЬ нэрмэх, дуустал цохих, хэмхчиж дуусах; ~ **врага** дайсныг дуустал цохих.

ДОБИ́ТЬСЯ олох, оролдох, хүрэх, чармайх; **наша страна добилась больших успехов** манай орон их амжилт олов; ~ **своего** санасандаа хүрэхийг чармайх.

ДО́БЛЕСТН||ЫЙ гавьяат, баатарлаг, чин зоригт; ~ **труд** гавьяат хөдөлмөр; **~ые защитники родины** эх орны баатарлаг хамгаалагчид.

ДО́БЛЕСТЬ гавьяа, гавьяат явдал, баатарлаг зүтгэл; **проявить ~** гавьяа байгуулах; **трудовая ~** хөдөлмөрийн гавьяа.

ДОБРА́ТЬСЯ хүрэх, учрыг олох.

ДОБР||О́ I 1. сайн, сайн юм, тус; **он желает вам ~а** тэр хүн танд сайныг хүсч байна; **сделать много ~а людям** олонд их тус хүргэх; 2. юм, баялаг, эд зөөр, хөрөнгө; **чужое ~** бусдын хөрөнгө, хүний юм.

ДОБРО́ II за, сайн, болно, тэгье; **~! сделаем так** болно, за тегье; ~ **пожаловать** морилон орно уу, тавтай морилно уу, тавтай ажаамуу, орох ажаамуу.

ДОБРОВО́Л||ЕЦ сайн дураар элсэгч, элсэгч, сайн дурын цэрэг, элссэн цэрэг, **пойти в армию ~ьцем** цэрэгт сайн дураар орох, цэрэгт элсэх.

ДОБРОВО́ЛЬНО сайн дураар, хүслээрээ.

ДОБРОВО́ЛЬН||ЫЙ сайн дурын; **~ое общество** сайн дурын нийгэмлэг; **на ~ых началах** сайн дурааараа, өөрсдийн хүслээр.

ДОБРОВО́ЛЬЧЕСКИЙ сайн дурын, сайн дуртны.

ДОБРОДЕ́ТЕЛЬ буян, буянт үйл, ач тус, сайн үйл.

ДОБРОДЕ́ТЕЛЬНЫЙ буянтай, буяны, ач тустай, сайн үйлийн; ~ **человек** буянтай хүн.

ДОБРОДУ́ШИЕ сайн сэтгэл, цагаан сэтгэл, бодь.

ДОБРОДУ́ШНЫЙ сайн сэтгэлтэй, цагаан сэтгэлтэй, бодь сэтгэлтэй.

ДОБРОЖЕЛА́ТЕЛЬ сайныг хүсэгч, сайныг ерөөгч.

ДОБРОЖЕЛА́ТЕЛЬНЫЙ сайныг хүсэх, сайныг ерөөх, сайн санаатай.

ДОБРОЖЕЛА́ТЕЛЬСТВО сайн санаа, сайн ерөөл, сайныг хүсэх явдал.

ДОБРОКА́ЧЕСТВЕННОСТЬ сайн чанар, сайн аястай; ~ **продуктов** хүнсний сайн чанар.

ДОБРОКА́ЧЕСТВЕНН||ЫЙ 1. сайн аястай, сайн чанартай, чансаатай; ~ **товар** сайн чанартай товар; 2. хоргүй; **~ая опухоль** хоргүй хавдар.

ДОБРО́М сайн дураар, хүслээрээ, саналаараа; **лучше ~ отдай** сайн дураар өгчихвэл дээр.

ДОБРОСЕРДЕ́ЧИЕ, добросердечность, сайн сэтгэл, эелдэг найр.

ДОБРОСЕРДЕ́ЧНЫЙ сайн сэтгэлтэй, эелдэг найртай.

ДОБРО́СИТЬ хүртэл шидэх, хүртэл хаях; **~ мяч до сетки** бөмбөгийг торонд хүртэл шидэх.

ДОБРОСО́ВЕСТНО шудрагаар, үнэнчээр, шудрага, сайнаар; **~ относиться к своим обязанностям** *оногдсон* үүргээ шудрагаар гүйцэтгэж байх.

ДОБРОСО́ВЕСТН||ЫЙ шудрага сайн үнэнч, нягт нямбай; **~ работник** шудрага сайн ажилтан; **~ владелец** шударга эзэмшигч.

ДОБРОСОСЕ́ДСК||ИЙ сайн хөршийн, нөхөр ёсны; **~ие отношение** сайн хөршийн харилцаа.

ДОБРОТА́ сайн зан, сайн сэтгэл, буянт сэтгэл.

ДОБРО́ТНОСТЬ яс чанар, чансаа.

ДОБРО́ТН||ЫЙ сайн чанартай, яс чанар сайтай, чансаатай; **~ое сукно** сайн чанартай цэмбэ.

ДО́БР||ЫЙ сайн, сайн чанартай, цагаан санаатай; **~ человек** сайн хүн; **~ молодец** сайн эр; **~ое имя** сайн нэр; **будьте ~ы!**тэгж өгөөч, ингэж өгөөч; **по ~ой воле** сайн дураараа; **всего ~ого** баяртай, сайн суугаарай; **~ день** сайн уу; **чего доброго** яаж ч магад; **~ых три часа** бүхэл гурван цаг.

ДОБРЯ́К сайн сэтгэлт хүн, сайн хүн.

ДОБУДИ́||ТЬСЯ арайхийж сэрээх, арай чамай сэрээх; **с трудом ~лся** арай чамай сэрээв.

ДОБЫВА́НИЕ 1. олох; 2. малтах, гаргах, ухах, уудлах; **~ средств к жизни** амь зуух хөрөнгө олох; **~ каменного угля** чулуун нүүрс малтаж гаргах.

ДОБЫВА́ТЬ,

ДОБЫ́ТЬ, 1. олох; **~ нужную сумму денег** хэрэгцээтэй мөнгийг олох; 2. малтах, гаргах, ухах, уудлах, малтаж гаргах, ашиглах; **~ нефть** нефть гаргах, газрын тос гаргаж авах.

ДОБЫВА́ТЬСЯ малтагдах, гарах.

ДОБЫВА́ЮЩ||ИЙ малтах, гаргах, уурхайн, уудлах, олборлох; **~ая промышленность** олборлох үйлдвэр.

ДОБЫ́Ч||А 1. олсон юм, олз; **охотники вернулись с богатой ~ей** анчид их олзтой буцаж ирэв; **военная ~** цэргийн олз; 2. малтаж авах, ухах, уудлах; **~ каменного угля** чулуун нүүрс малтаж авах; 3. автах, идэгдэх; **дом стал ~ей огня** байшин түймэрт автав.

ДОВА́РИВАТЬ, доварить, болтол чанах, гүйцэд чанах.

ДОВА́РИВАТЬСЯ, свариться гүйцэд болох, сайн чанагдах; **мясо ещё не доварилось** мах гүйцэд болоогүй л байна.

ДОВЕЗТИ́ хүргэх, аваачих; **~ до дому** гэрт нь хүргэх.

ДОВЕ́РЕННОСТ||Ь итгэмжлэл, итгэмжлэх бичиг, итгэмж бичиг; **получить деньги по ~и** итгэмжлэлээр мөнгө авах.

ДОВЕ́РЕНН||ЫЙ *төлөөлөгч*, итгэмжит, төлөөний найдлагатай; **~ое лицо** итгэмжит хүн, төлөөний хүн.

ДОВЕ́РИЕ итгэх, итгэл, итгэмж; **облечённый ~м** итгэл хүлээсэн; **питать ~** итгэж болох; **оправдать ~** итгэл биелүүлэх; **потерять ~** итгэл алдах.

ДОВЕРИ́ТЕЛЬ итгэмжлэгч, итгэгч; даалгавар өгөгч.

ДОВЕ́РИТЬ итгэх, найдах, итгэмжил өгөх, даалгах; **~ получить деньги** мөнгө авах итгэмжил өгөх; **~ тайну** нууцаа даалгах.

ДОВЕ́РИТЬСЯ итгэх, найдах, итгэжлэх.

ДО́ВЕРХУ дүүртэл, бялхтал, амсарт нь хүртэл, оройд нь тултал; **наполнить ведро ~** хувинг амсарт нь хүртэл дүүргэх.

ДОВЕ́РЧИВОСТЬ итгэмтгий, амархан итгэдэг.

ДОВЕРША́ТЬ гүйцээх, дуусгах, төгсгөх, эцэст нь хүргэх.

ДОВЕРШЕ́НИЕ гүйцээх, төгсгөл, дуусвар, эцэст нь хүргэх; **~ всего** түүний дээр, тэгээд бас; **в ~ всех бед** гай дээр гамшиг нэмж, хахсан дээр нударч.

ДОВЕРШИ́ТЬ гүйцээх, дуусгах, төгсгөх, эцэст нь хүргэх; **~ начатое дело** эхэлсэн хэргээ эцэст нь хүргэх.

ДОВЕРЯ́||ТЬ итгэх, найдах, итгэмжлэх; **он мне ~ет во всём** тэр хүн над бүх талаар итгэдэг.

ДОВЕРЯ́ТЬСЯ итгэх, найдах.

ДОВЕ́СИТЬ зохих жинд хүргэх, гүйцээж жигнэх.

ДОВЕ́СОК зохих жинд хүргэх нэмэлт, жингийн нэмэлт.

ДОВЕСТИ́ 1. хүргэх; **~ до дома** гэрт нь хүргэх; **~ дело до конца** хэрэг ажлыг эцэст нь хүргэх; **~ железную дорогу до города** төмөр замыг хот хүргэх; 2. хүргэх, -уулах, -үүлэх; **~ до слёз** уйлахад хүргэх уйлуулах; **~ до сознания** сонорт хүргэх, мэдэгдэх.

ДОВЕСТИ́СЬ тохиолдох, тохиох, тохиол болгох; **довелось встретиться** уулзах тохиол боллоо.

ДОВЛЕ́ТЬ I биеэ дааж байх, хангалуун байх.

ДОВЛЕ́ТЬ II давуу байх, давуутай байх.

ДО́ВОД учир, баримт, учир баримт; **все ~ы за и против** болох эсэхийн учир баримт; **веский ~** ноцтой баримт; **неоспоримый ~** маргашгүй баримт.

ДОВОДИ́ТЬ 1. хүргэх, хүргүүлэх; **~ до нужды** гачигдалд хүргэх; **~ до отчаяния** цөхөхөд хүргэх; 2. хүргэх, -уулах,-үүлэх; **~ до слёз** уйлахад хүргэх, уйлуулах.

ДОВОДИ́ТЬСЯ 1. тохиолдох, тохиох, тохиол болох; **довелось побывать там** тэнд очих завшаан *тохиолдов*; 2. хүргэх; **доводится до всеобщего сведения** нийтийн сонорт хүргэнэ; 3. болох, юм; **он доводится ему братом** тэр хүн түүний ах нь болно.

ДОВОЕ́НН||ЫЙ дайны өмнөх, дайны урьдах; **~ое время** дайны өмнөх үе.

ДОВОЗИ́ТЬ хүргэх, аваачих; **довожу его ежедневно до завода и еду дальше** би түүнийг өдөр бүр заводад хүргээд цааш явдаг.

ДОВО́ЛЬНО 1. болно, боллоо, хүрнэ, хүрлээ; **с меня и этого ~** над энэ ч боллоо; 2. ханамжтай, хангалттай; **~ улыбался** ханамжтай инээмсэглэв; 3. нилээд, нилээн, -втар; **~ хорошо** нилээд сайн байна; **он ~ молод** тэр хүн нилээд залуу, тэр залуувтар хүн; **прошло уже ~ много времени** нилээд олон цаг өнгөрлөө; 4. болъё, зогсъё, цэглэе; **~ спорить** маргаанаа зогсъё, маргахаа болъё.

ДОВО́ЛЬН||ЫЙ ханамжтай, сэтгэл дүүрэн, урамтай; **~ вид** ханамжтай янз; **быть ~ым** ханамжтай байх, урамтай байх.

ДОВО́ЛЬСТВИ||Е хэрэглэл, хангалт, хүнс хувцас; **снабжение ~ем** хэрэглэлийг нийлүүлэх; **снять с ~я** хангалтаас хасах.

ДОВО́ЛЬСТВ||О 1. чинээлэг, элбэг дэлбэг; **жить в ~е** чинээлэг амьдрах; 2. хангалуун байдал, ханамжтай байдал; **лицо выражало ~** царай нь хангалуун байдлыг илэрхийлэв.

ДОВО́ЛЬСТВОВАТЬСЯ сэтгэл ханах, ханамжтай байх, бололцох; **~ малым** бага юмаар сэтгэл ханах; **~ скромным заработком** бага цалингаар *бололцож* байх; 2. хэрэглэх, хангагдах

ДОВЫБО́РЫ нэмж сонгох, нөхөж сонгох

ДОГАДА́ТЬСЯ таах, тааварлах, тааж мэдэх, тухайлах, гадарлах.

ДОГА́ДКА таавар, таамнал, таамаглал; **теряться в ~х** таамаглаж ядах.

ДОГА́ДЛИВОСТЬ ухамсартай, овсоргон, таамтгай, тааж мэдэхдээ сайн.

ДОГА́ДЫВАТЬСЯ таах, тааварлах, таамаглах, гадарлах.

ДОГЛЯДЕ́ТЬ 1. ажиглах, сайн харах; 2. дуустал үзэх; **~ пьесу** жүжгийг дуустал үзэх.

ДО́ГМА догма, тогтсон таалал, ягшмал номлол.
ДО́ГМАТ догмат, шашны номлол, тогтсон таалал ягшмал номлол, улиг номлол.
ДОГМАТИ́ЗМ догматизм, тогтсон таалын суртал, ягшмал номлолын суртал.
ДОГМА́ТИК догмач, тогтсон таалалч, ягшмал номлолч, ягшмал номлолтон.
ДОГМАТИ́ЧЕСКИЙ 1. догматик, тогтсон тааллын, ягшмал номлолын; 2. яг шийдсэн, ягшуулсан.
ДОГНА́ТЬ гүйцэх, нэхэн очих; **~ и перегнать** гүйцээд түрүүлэх.
ДОГОВА́РИВАТЬ, договорить, гүйцээж хэлэх, цөмийг хэлэх, хэлэх; **не ~** дутуу хэлэх, хагас хугас хэлэх.
ДОГОВА́РИВАТЬСЯ, договориться; 1. хэлэлцэн тогтох; **~ о поездке** явах тухай хэлэлцэн тогтох; 2. чалчих, дэндүү чалчих; **договориться до нелепостей** дэмий юм чалчих.
ДОГОВА́РИВАЮЩИЙСЯ хэлэлцэгч, хэлэлцэн тогтогч; **~еся стороны** хэлэлцэн тогтогч этгээд.
ДОГОВО́Р гэрээ; **заключать ~ о ненападении** үл довтолзох гэрээ байгуулах; **~ о взаимной помощи** харилцан туслалцах гэрээ; **подписывать ~** гэрээнд гарын үсэг зурах; **сепаратный ~** дангаар байгуулсан гэрээ; **~ займа** зээлийн гэрээ; **~ о найме имущества** эд хөрөнгө хөлслөх гэрээ; **~ доверения имущества** хөрөнгө итгэмжлэх гэрээ; **стандартные условия ~а** гэрээний стандарт нөхцөл; **~ поручения** даалгаврын гэрээ; **~ в пользу третьего лица** гуравдагч этгээдэд ашигтай гэрээ; **~ купли-продажи** худалдах худалдан авах гэрээ; **~ дарения** бэлэглэлийн гэрээ; **~ подряда** ажил гүйцэтгэх гэрээ..
ДОГОВОРЁННОСТЬ хэлэлцээ, хэлэлцэн тогтох; **действовать на основе ~и** хэлэлцээний ёсоор хийх, хэлэлцэн тогтсон ёсоор үйлдэх.
ДОГОВОРИ́ТЬ гүйцээж хэлэх, цөмийг хэлэх, хэлж гүйцэх, хэлэх; **не ~** дутуу хэлэх; **дать ~** гүйцэд хэлүүлэх.
ДОГОВОРИ́ТЬСЯ 1. хэлэлцэн тогтох; **~ о встрече** уулзах тухай хэлэлцэн тогтох; **нам надо с вами ~** тантай хэлэлцэж тогтох хэрэгтэй байна; 2. чалчих.
ДОГОВО́РНЫЙ гэрээний, гэрээнд дурьдсан, хэлэлцэн тогтсон, хэлэлцсэн; **~ое обязательство** гэрээнд дурьдсан үүрэг; **на ~ых началах** эрээний ёсоор; **~ое право** гэрээний эрх зүй.
ДОГОЛА́ шалдан болтол, нүцгэртэл, чармаа нүцгэртэл, нүцгэлэх; **раздеться ~** хувцсаа тайлж нүцгэлэх.
ДОГОНЯ́ТЬ 1. гүйцэх, нэхэн очих, гүйцэж очих; 2. разг.ойлгох, ухаарах.
ДОГОРА́ТЬ,
ДОГОРЕТЬ ноцож дүүрэх, шатаж гүйцэх.
ДОДА́ТЬ гүйцээж өгөх; **~ оставшиеся десять рублей** үлдсэн арван рублийг гүйцээж өгөх.
ДОДЕ́ЛАТЬ, доделывать, гүйцээх, гүйцээж хийх, хийж дуусгах.
ДОДЕ́ЛКА дуусварын ажил, гүйцээх ажил.
ДОДУ́МАТЬСЯ, додумываться, бодож олох, бодолхийлэх.
ДОЕДА́ТЬ, доесть, идэж дуусах, дуустал идэх, идэж барах.
ДОЕЗЖА́ТЬ, доехать, явж хүрэх, хүрэх; **~ до места назначения** очих газартаа хүрэх.
ДОЕ́НИЕ саах, саалга; **~ коров** үнээ саах.
ДОЖА́РИВАТЬ болтол шарах, гүйцэд шарах.
ДОЖА́РИВАТЬСЯ болтол шарагдах, гүйцэд шарагдах.
ДОЖА́ТЬ хадаж дуусгах, гүйцэд хадах; **~ пшеницу** буудай хадаж дуусгах
ДОЖДА́ТЬСЯ хүлээх, -тал хүлээх; **я его ~лся** би түүнийг иртэл хүлээв; **ждём не дождёмся** хүлээж ядаж байна.
ДОЖДЕВА́ЛЬНЫЙ усалгааны **~ая машина** услагааны машин.
ДОЖДЕВ||О́Й борооны, хурын; **~ая вода** борооны ус; **~ червь** чийгийн улаан хорхой.
ДОЖДЁМ бороо шиг, мөндөр шиг; **пули сыпались ~** бууны сум мөндөр шиг асгарч байв.
ДО́ЖДИК жаахан бороо, зөөлөн бороо.
ДОЖДЛИ́В||ЫЙ хуртай, бороотой, хурархаг, бороорхог; **~ое лето** бороотой зун.
ДОЖДЬ бороо хур; **~ моросит** бороо шивэрнэ; **идёт ~** бороо орно; **мелкий холодный ~** хүйтэн шиврээ бороо; **проливной ~** усархаг бороо.
ДОЖЕ́ЧЬ шатааж дуусгах, дуустал шатаах.
ДОЖИВА́ТЬ 1. наслах, хүртэл амьд байх, -тал амьд байх; **~ до глубокой старости** их өвгөртөл наслах; 2. хүртэл суух, хүртэл байх, болтол суух; **доживём здесь до лета, а потом уедем** энд зун болтол суугаад явна.
ДОЖИДА́ТЬСЯ хүлээх, болтол хүлээх; **~ поезда** галт тэрэг ирэх болтол хүлээх.
ДОЖИНА́ТЬ хадаж дуусгах, дуустал хадах.
ДОЖИ́ТЬ 1. наслах, хүртэл наслах, болтол амьд байх; 2. хүртэл суух, болтол суух.
ДО́ЗА тун, хэмжээ; **~ лекарства** тун эм.
ДОЗВА́ТЬСЯ дуудах, дуудаж ирүүлэх; **никого не дозовёшься** дуудахад хэн ч ирэхгүй.
ДОЗВО́ЛЕННЫЙ зөвшөөрөгдсөн, соёрхогдсон, хориогүй; **~ приём борьбы** барилдааны зөвшөөрөгдсөн аргууд, бөхийн хориогүй мэх.
ДОЗВО́ЛИТЬ зөвшөөрөх, зөвших, соёрхох; **~ отъезд** явахыг зөвшөөрөх.
ДОЗВОНИ́ТЬСЯ 1. утасдаж хариу авах, утасдаж ярилцах; 2. хонх дугарах; **не ~ в квартиру** байрын хонхыг дугаргавч хариугүй.
ДОЗИ́РОВАТЬ тугнах; **~ лекарство** эм тугнах.
ДОЗИРО́ВКА тугнал, хэмжээ.
ДОЗНАВА́ТЬСЯ мэдэхийг хүсэх, лавлах, сураглах; **я не мог дознаться, кто он такой** ямар хүн болохыг сураглаад мэдэж чадсангүй.
ДОЗНА́НИЕ байцаалт, мөшгөлт; **произвести ~** байцаалт явуулах, мөшгөлт хийх.
ДОЗО́Р харуул манаа, хайгуул цэрэг; **выслать ~** хайгуул цэрэг явуулах. **ДОЗО́РНЫЙ** 1. харуулын цэрэг, манааны цэрэг, хайгуулын цэрэг, хайгуул цэрэг; 2. харуулын, манаа, хайгуул; **~ое судно** харуулын онгоц.
ДОЗРЕВА́ТЬ боловсрох, болох; **винограду нужно ещё ~** үзэм арай боловсроогүй байна; **яблоки уже дозрели** алим боловсорсон байна.
ДОИГРА́ТЬ тоглож дуусгах, дуустал тоглох; **~ пьесу** жүжгийг тоглож дуусгах; **~ партию в шахматы** шатрын өргийг тоглож дуусгах.
ДОИГРА́ТЬСЯ тоглоом шоглоом болох.
ДОЙЛЬН||ЫЙ, саах, саалийн; **~ая машина** саах машин.
ДОИСКА́ТЬСЯ уудлах, байцаах, эрж олох, мэдэж авах; **~ правды** үнэнийг мэдэж авах.
ДОИСТОРИ́ЧЕСКИЙ балар эртний; **~ человек** балар эртний хүн
ДОИ́ТЬ саах; **~ корову** үнээ саах.
ДОИ́ТЬСЯ саалгах; **~ хорошо** ивлэх
ДО́ЙКА саах, саалт; **~ коров** үнээ саах.
ДО́ЙНОСТЬ саам, жилбэ; **~ коров** үнээний жилбэ.
ДО́ЙН||ЫЙ саалийн, саах; **~ая корова** саалийн үнээ.
ДОЙТИ́ 1. хүрэх, очих, явж хүрэх, тулах; **~ до станции** станцид хүрэх; **письмо дошло быстро** захидал түргэн хүрлээ; **вода дошла до краев** ус эрэгтээ хүрлээ; ус хөвөөндөө туллаа; **звук**

не дошёл дуу хүрсэнгүй; **счёт дошёл до тысячи рублей** тоо нь мянган рубльд хүрлээ; 2. ухаж мэдэх, ойлгох, ойлгогдох; **смысл речи не дошёл до него** үгийн утга түүнд ойлгогдсонгүй; ~ **своим умом** ухаанаараа бодож ойлгох; 3. болох, боловсрох; **помидоры дошли на солнце** улаан лооль наранд боловсров; **тесто дошло** зуурсан талх бэлэн боллоо.

ДОК док, онгоцны засварын газар; **плавучий** ~ хөвөгч док.

ДО́КА догь хүн; **в этом он** ~ үүнд тэр догь шүү.

ДОКАЗА́ТЕЛЬНЫЙ нотолгоотой, баримттай.

ДОКАЗА́ТЕЛЬСТВ||О *нотолгоо, нотлол, нотлох, баримт*; **служить ~ом** нотолгоо болох; **вещественное** ~ эд юмын нотолгоо, эд мөрийн баримт; **в** ~ нотолгоо болгож, баримт болгож.

ДОКАЗА́ТЬ *нотлох*; ~ **свою невиновность** гэмгүйгээ нотлох; ~ **теорему** теорем нотлох, магадлах үнэнийг нотлох.

ДОКАЗУ́ЕМЫЙ нотлогдмоор, нотолж болмоор; **легко** ~ амархан нотлогдмоор.

ДОКА́НЧИВАТЬ, докончить, дуусах, гүйцээх, эцэст нь хүргэх, төгсгөх.

ДОКАПИТАЛИСТИ́ЧЕСКИЙ капиталист ёсны өмнөх, хөрөнгөт ёсны өмнөх, *капитализмын урьдах*.

ДОКА́ПЫВАТЬ малтаж дуусгах, хүртэл малтах.

ДОКА́ПЫВАТЬСЯ 1. хүртэл малтах, тултал ухах; ~ **до воды** усанд хүртэл малтах; 2. уудалж олох, учрыг олох, ёзоорыг олох; ~ **до сути дела** хэргийн сүнсийг уудалж гаргах.

ДОКАТИ́||ТЬ, докатывать, өнхрүүлж хүргэ, хүртэл өнхрүүлэх; **~ли бочку до сарая** торхыг пинд хүртэл өнхрүүлэв.

ДОКАТИ́ТЬСЯ, докатываться; 1. хүртэл *өнхрөх*, хүртэл, гулгах, өнхөрч хүрэх; **мяч докатился до забора** бөмбөг хашаа хүртэл өнхрөв; 2. орох, хэцүү байдалд орох, арчаагүй болох; ~ **до преступления** ялт хэрэгт орох; **вот до чего он докатился** тэр *ингэж* арчаагүй болоод байна.

ДО́КЕР докч, докийн ажилчин, галт онгоцийг засах газрын ажилчин.

ДОКИ́НУТЬ хүртэл шидэх.

ДОКЛА́Д 1. итгэл; ***отчётный*** ~ тайлан илтгэл; **делать** ~ илтгэл хийх; 2. илтгэх, хэлэх; ~ **директору** захиралд илтгэх; **без ~а не входить** зөвшөөрөлгүй орж болохгүй.

ДОКЛА́ДН||ОЙ итгэлийн, илтгэх; **~ая записка** илтгэх хуудас.

ДОКЛА́ДЧИК илтгэл; илтгэгч.

ДОКЛА́ДЫВАТЬ, доложить; 1. илтгэл хийх; 2. илтгэх, хэлэх, уламжлан мэдэгдэх.

ДОКЛА́ССОВ||ЫЙ *анги* гарахаас өмнөх, анги ялгарахаас урьдах, эртний ангигүй; **~ое общество** анги гарахаас өмнөх нийгэм.

ДОКОНА́ТЬ алах, эцэс болгох.

ДОКО́НЧИТЬ дуусах, төгсгөх, гүйцээх, эцэст нь хүргэх.

ДОКОПА́ТЬ 1. малтаж дуусгах, ухаж дуусгах; ~ **яму до середины** нүхийг дунд нь хүртэл малтах.

ДОКОПА́ТЬСЯ 1. хүртэл малтах, *тултал ухах*; ~ **до слоя глины** шаврын давхаргад хүртэл малтах; 2. уудалж олох, учрыг олох, ёзоорыг олох; ~ **до истины** үнэн учрыг олох.

ДОКРАСНА́ улайтал, ув улаан болтол; **накалить** ~ ув улаан болтол халаах.

ДОКРИЧА́||ТЬСЯ 1. сонстол хашгарах, дуултал бархирах, дуулгах; **наконец я вас ~лся** арай гэж бархирч танд дуулгав; 2. -тал хашгарах; **~лся до хрипоты** сөөтөл хашгирав.

ДО́КТОР 1. доктор; ~ **медицинский наук** анагаах ухааны доктор; 2. доктор, эмч, их эмч; **позвать ~а к больному** өвчтэй хүнд эмч дуудах.

ДОКТОРА́НТ докторант, докторын зэрэг горилогч.

ДО́КТОРСК||ИЙ 1. докторын; **~ая степень** докторын зэрэг; **защищать ~ую диссертацию** докторын зэрэг горилох зохиол хамгаалах; 2. *докторын, эмчийн*.

ДОКТРИ́НА номлол, сургаал.

ДОКТРИНЁР хоосон номлогч, хоосон онолыг баримтлагч, онолыг яг дагагч.

ДОКТРИНЁРСКИЙ хоосон номлолын, хоосон онолыг баримтлах, онолыг яг дагах.

ДОКТРИНЁРСТВО хоосон номлол, хоосон онолыг баримтлах явдал, онолыг яг дагах явдал.

ДОКУ́ДА хаа хүртэл, аль хүртэл, хэдий болтол; ~ **читать рассказ?** өгүүллэгийг аль хүртэл унших вэ?

ДОКУМЕ́НТ үнэмлэх, баримт, баримт бичиг; **предъявить свой** ~ *үнэмлэхээ үзүүлэх*; **расходные ~ы** зарлагын баримтууд.

ДОКУМЕНТА́ЛЬНО баримтаар; ~ **доказать** баримтаар нотлох

ДОКУМЕНТА́ЛЬН||ЫЙ баримттай,баримтат; **~ые данные** баримттай мэдээ; ~ **фильм** баримтат кино зураг; **~ая точность** баримттай яг нарийн, баримт шиг яг нарийн. **ДОКУМЕНТА́ЦИЯ** 1. баримттай болгох,баримтжуулах; **подробная** ~ тодорхой баримттай болгох; 2. баримт бичиг; **техническая** ~ техникийн баримт бичиг.

ДОКУМЕНТИ́РОВАТЬ баримттай болгох, баримтжуулах.

ДОКУПА́ТЬ, докупить нэмж авах, нэмж худалдан авах.

ДОКУ́РИВАТЬ, докурить, тамхи татаж дуусах, тамхиа дуустал татах.

ДОКУЧА́ТЬ залхаах, залхуу хүргэх, нурших, янших.

ДОКУ́ЧЛИВОСТЬ залхуу хүргэх, нурших, янших.

ДОКУ́ЧЛИВЫЙ залхуутай, залхуу хүрэм, *нуршаа үгтэй*, яншаа; ~ **человек** нуршаа үгтэй хүн.

ДОЛ хөндий, **по горам и ~ам** уул ба хөндийгөөр.

ДОЛБИ́ТЬ 1. ухах, төнхөх, цоолох, тогших; ~ **долотом** цүүцээр ухах; 2. *нурших, давтах, давтан хэлэх*.

ДОЛГ, үүрэг, уялга; **по ~у службы** албаны үүргээр; **выполнять свой** ~ үүргээ биелүүлэх; 2. өмнө, урьд; **первым ~ом** юуны урьд, юуны өмнө; 3. өр, өр шир, өгцөө, зээл; **право ареста всего имущества в случае неуплаты ~а** өр төлөөгүй тохиолдолд бүх эд хөрөнгийг нь битүүмжлэх эрх; **давать в** ~ зээл өгөх; **погашать ~и** өрөө дарах, **отдать последний** ~ сүүлчийнхээ хүндэтгэлийг хийх; **не остаться в ~у** өртэй үлдэхгүй, ач хариулах; **давнишний** ~ амбасын үеийн өр.

ДО́ЛГ||ИЙ урт, удаан; ~ **путь** урт зам; ~ **гласный** урт эгшиг; **~ое молчание** удаан дугай байх; **откладывать в** ~ **ящик** *удаашруулах, хойш тавих*.

ДО́ЛГО удаан, удтал, өнө; **пришлось** ~ **ждать** удтал хүлээж байлаа; ~ **ли, коротко ли** удсан ч юм уу, удаагүй ч юм уу; ~ **ли до беды** гай учрах хол биш.

ДОЛГОВЕ́ЧН||ЫЙ 1. урт настай, урт удаан; **~ая дружба** урт удаан найрамдал; 2. бэх, бат, бэх сайн, эвдэршгүй; **~ая кровля** бэх сайн дээвэр.

ДОЛГОВ||О́Й өрийн, өр төлөх; **~ое обязательство** өр төлөх баталгаа.

ДОЛГОВРЕ́МЕНН||ЫЙ, удаан хугацааны, удаан байх, удтал; **~ое укрепление** удаан байх бэхлэлт; **~ое отсутствие** удтал *эзгүй байх, удтал байхгүй байх*.

ДОЛГОВЯ́ЗЫЙ разг. нарийхан өндөр, гонжгор; ~ **юноша** нарийхан өндөр залуу.

ДОЛГОЖДА́НН||ЫЙ удтал хүлээсэн; **~ая встреча** удтал хүлээсэн уулзалт.

ДОЛГОЛЕ́ТИЕ урт нас, урт наслах, урт наслал.

ДОЛГОЛЕ́ТН||ИЙ олон жилийн, өнө удааны; **~яя дружба** олон жилийн найрамдал; **~ее сотрудничество** өнө удааны хамтын ажиллагаа.

ДОЛГОСРО́ЧНЫЙ удаан хугацаатай, удаан хугацааны; ~ **кредит** удаан хугацааны зээл.

ДОЛГОТА́ 1. урт,урт богино; ~ **дня** өдрийн урт, өдрийн урт богино; 2. уртраг; **географическая** ~ газарзүйн уртраг; 3. урт дуудлага, уртаттал; ~ **звука** авианы уртаттал.

ДОЛГУНЕ́Ц зарам, маалинга.

ДОЛЕВ||О́Й 1. уртаашаа, уртааш гулд; ~ **разрез дерева** модыг уртааш нь зүсэх; **разрезать в ~ом направлении** уртааш нь зүсэх; 2. хувийн, хэсгийн, хувь; **~ое отчисление** хувийн ногдол; **~ое участие** хувиар оролцох.

ДО́ЛЕЕ удаан, илүү, цаашаа; ~ **так продолжаться не может** цаашаа ингэж байж чадахгүй.

ДОЛЕЗА́ТЬ хүртэл авирах, авиран гарах авиран хүрэх; ~ **до крыши** дээвэр дээр авиран гарах.

ДОЛЕТА́ТЬ хүрэх, нисч хүрэх; **снаряд долетел до реки** их бууны сум мөрөнд хүрэв; **орёл долетел до облаков** бүргэд үүлэнд нисч хүрэв.

ДОЛЖА́ТЬ *разг.* өрөнд орох, өр тавих, өрөнд унах.

ДО́ЛЖ||ЕН 1. өртэй, өгцөөтэй; 2. ёстой, хэрэгтэй, байвал зохино; **мы ~ны преодолеть все трудности** бид бүх бэрхшээлийг давах ёстой; **ты ~ быть здесь в два часа** чи хоёр цагт энд байх хэрэгтэй.

ДОЛЖЕНСТВОВА́ТЬ зохих, байвал зохих, байх ёстой.

ДОЛЖНИ́К 1. өртөн, өртэй хүн; 2. үүрэг гүйцэтгэгч.

ДО́ЛЖНО хэрэгтэй, ёстой, байвал зохино.

ДОЛЖНО́ ~ быть байхаа, байх ёстой; **~, так** тийм байх ёстой; **~, он не придёт** тэр ирэхгүй байхаа; **~, пойдёт дождь** бороо орох байхаа, бороо орох нь дээ.

ДОЛЖНОСТН||О́Й албаны, албан үүргийн; **~ое лицо** албаны хүн.

ДО́ЛЖНОСТ||Ь албан, албан тушаал, үүрэг, хариуцлага; **выгодная** ~ ашигтай тушаал; **занимать высокую** ~дээд тушаалд орох, их тушаалд орох; **исполнять ~ секретаря** нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх; **освобождать от ~и** албан тушаалаас чөлөөлөх.

ДО́ЛЖН||ЫЙ 1. зохих; **на ~ом уровне** зохих хэмжээнд; **~ое внимание** зохих анхаарал; **~ым образом** зохих ёсоор; 2. зохих зүйл, зохистой; **воздавать ~ое по заслугам** гавьяанд нь зохих хэмжээний анхаарал хүндэтгэл хүртээх **отдать ~ое** зохих ёсоор үнэлэх хэрэгтэй.

ДОЛИВА́ТЬ дүүргэх, нэмж дүүргэх.

ДОЛИ́ТЬ дүүргэх, нэмж дүүргэх, дүүртэл хийх; ~ **молоко в стакан** шилэн аяганд сүү дүүргэх.

ДОЛИ́НА хөндий, хоолой; ~ **реки** голын хөндий.

ДО́ЛЛАР доллар.

ДОЛОЖИ́ТЬ I 1. илтгэх, айлтгах, мэдүүлэх; 2. хэлэх, мэдэгдэх.

ДОЛОЖИ́ТЬ II нэмэх, нэмж тавих.

ДОЛО́Й сөнөтүгэй, тонил; ~ **войну**! Дайн сөнөтүгэй!**уйди с глаз ~**! нүдэнд харагдахгүй газар тонил!

ДОЛОТО́ цүүц.

ДО́ЛЬКА 1. саланхай, салбархай, жаахан хэрэг; **апельсиновая** ~ зүржийн саланхай; 2. разг. тэнэг, маанаг.

ДО́ЛЬШЕ хол, илүү удаан, удаан; **этот путь ~ того** энэ зам түүнээс хол; **я ~ вас живу в этом доме** би энэ байшинд танаас удаан сууж байна.

ДО́Л||Я 1. хувь, хэсэг; **делить на равные ~и** адил хувиар хуваах, адил хэсэгт хуваах; **львиная** ~ ихэнх хувь; **на мою ~ю** над оногдсон хувь; 2. хувь заяа, тавилан; **горькая** ~ зовлонт хувь заяа.

ДОМ 1. байшин; **деревянный** ~ модон байшин; **шестиэтажный** ~ зургаан давхар байшин; 2. гэр; **работать на ~у** гэртээ ажиллах, гэртээ ажил хийх; **быть дома** гэртээ байх; **идти ~ой** гэртээ харих; 3. газар, байшин, ордон; ~ **отдыха** амралтын газар; ~ **культуры** соёлын ордон; **детский** ~ хүүхдийн асрах газар; 4. газар, пүүс, байшин; **торговый** ~ худалдааны пүүс; 5. гэр бүл, гэрийнхэн; **мы знакомы ~ами** манай гэртхэн танил; 6. овгийн хаад, овгийн хүмүүс; 7. разг. толгой.

ДО́МА гэртээ: **его нет** ~ тэр гэртээ алга; **в гостях хорошо, а ~ лучше** айлд аятайхан боловч гэртээ бүр аятайхан; **как ~** гэртээ байгаа шиг; **у него не все ~** тэр согогтой хүн.

ДОМАРКСИ́СТСКИЙ Марксын өмнөх, Марксын урьдах үеийн.

ДОМА́ШН||ИЙ 1. гэрийн; **~ие задания** гэрийн даалгавар; **~яя утварь** гэрийн хогшил; **~яя хозяйка** гэрийн авгай, гэрийн ажилтай эхнэр; 2. тэжээмэл, мал; **~яя птица** тэжээмэл шувуу; **~ее животное** мал; 3. гэрийнхэн, гэр бүл; **мои ~ие** манай гэрийнхэн, гэр бүл; **~яя работница** зарц хүүхэн; ~ **хлеб** гэртээ хийсэн талх, өөрсдийн барьсан талх.

ДО́МБРА доомбор.

ДО́МЕННЫЙ домнын, ширэм хайлах зуухны, өндөр зуухны.

ДО́МЕНЩИК ширэм хайлагч, ширэм хайлах зуухны ажилчин.

ДО́МИК жаахан байшин, жижиг байшин.

ДОМИНИО́Н доминион, өөрөөн засах улс: түшээт улс.

ДОМИНИ́РОВАТЬ 1. товойж харагдах, сүндэрлэж харагдах; **гора доминирует над городом** хот дээгүүр уул сүндэрлэж харагдана; 2. зонхилох.

ДОМИНО́ I багт наадмын дээл.

ДОМИНО́ II домино, нүх шахах тоглоом, даалуу.

ДОМКРА́Т хөшүүр, өргүүл домкрат.

ДО́МНА домна, ширэм хайлах зуух, өндөр зуух.

ДОМОВИ́ТОСТЬ аж ахуй, аж ахуйдаа хичээлтэй.

ДОМОВЛАДЕ́ЛЕЦ орон сууцны эзэн : байшингийн эзэн.

ДОМО́ВНИЧАТЬ гэрээ сахих.

ДОМОВО́Й гэрийн буг, онгон

ДОМО́В||ЫЙ байшингийн, гэр байрын, орон сууцны; **~ая книга** орон сууцны дэвтэр, орон сууцны бүртгэл, байшингийн данс; **~ая контора** орон сууцны захиргаа.

ДОМОГА́ТЕЛЬСТВО улиглал; **его ~ не увенчалось успехом** түүний улиглал амжилтад хүрсэнгүй.

ДОМОГА́ТЬСЯ улиглах, улиглан хүсэх.

ДОМОНОПОЛИСТИ́ЧЕСКИЙ монополист ёсны өмнөх.

ДОМОРО́ЩЕННЫЙ 1. гэртээ байгуулсан, гардаж байгуулсан; 2. энгийн баазхан; ~ **поэт** баазхан шүлэгч.

ДОМОСЕ́Д гэрээс гардаггүй хүн, гэртээ суумтгай хүн, гэрийн буг..

ДОМОСЕ́ДКА гэртээ суумтгай эхнэр, гэрээс гардаггүй эхнэр.

ДОМОСТРОЕ́НИЕ байшин барилга.

ДОМОТКА́НН||ЫЙ гар нэхмэл, гараар нэхсэн; **~ое полотно** гараар нэхсэн бөс.

ДОМОУПРАВЛЕ́НИЕ байшингийн захиргаа.

ДОМОХОЗЯ́ИН гэрийн эзэн.

ДОМОХОЗЯ́ЙКА гэрийн эзэгтэй, гэрийн эзэн эхнэр, гэрийн ажилтай эхнэр.

ДОМОЧА́ДЦ||Ы гэртхэн, гэрийнхэн, гэр бүл; **со всеми чадами и ~ами** бүх хүүхэд шуухадтайгаа, гэрийнхэнтэйгээ.

ДОМРАБО́ТНИЦА гэрийн зарц хүүхэн, зарц хүүхэн, тогооч.

ДО́МЫС||ЕЛ таамаглал, таамнал, таам бодол; **пустые ~лы** хоосон таамнал.

ДОНА́ШИВАТЬ 1. элээх, элтэл өмсөх; ~ **платье** платийг элтэл өмсөх; 2. нярайлах дөхөх.

ДОНГ донг, «Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын мөнгөн тэмдэгт».

ДОНЕ́ЛЬЗЯ туйлдаа хүртэл, дэндүү; **он ~ устал** тэр хүн туйлдаа хүртэл ядарчээ.

ДОНЕСЕ́НИЕ мэдээ, мэдээлэл, айлтгал; **сделать ~** мэдээ явуулах.

ДОНЕСТИ́ I 1. хүргэх, хүргэж өгөх, аваачих; **~ вещи до дома** юмыг гэрт нь хүргэх.

ДОНЕСТИ́ II мэдээлэх, мэдээ хүргэх, айлтгах.

ДОНЕСТИ́СЬ сонсдох, дуулах; **издалека донеслась песня** холоос дуу дуулах сонсдов; донёсся слух цуу үг дуулдлаа.

ДОНЖУА́Н донжуан, дурламтгай эр.

ДО́НИЗУ доод талдаа хүртэл, дор хүртэл, ёроолд хүртэл; **сверху ~** дээрээс дор хүртэл, оройгоос ёроолд хүртэл.

ДОНИМА́ТЬ хашраах, тарчлаах, улиглах.

ДОНЯ́ТЬ хашраах, тарчлаах, улиглах.

ДОНКИХО́Т донкихот «Испанийн уран зохиолын баатар, болшгүй юманд мохошгүй зүтгэгч».

ДО́НОР донор, цусаараа тэтгэгч цусаа өгөгч «өвчтэй буюу шархтай хүнд цусаа өгдөг хүн».

ДО́НОРСКИЙ цус өгөх; **~ пункт** цус өгөх газар.

ДОНО́С хов мэдээ, нууц мэдээ, нууц ховлох.

ДОНОСИ́ТЬ 1. элээх, элтэл өмсөх, дуустал эдлэх.

ДОНЕСТИ 1. элээх, элтэл өмсөх, дуустал эдлэх; **~ старые сапоги** хуучин гутлаа элтэл өмсөх, хүргэх, аваачих; **~ вещи до склада** агуулахад юм хүргэх; 3. мэдээлэх, айлтгах; **~ о приближении противника** дайсан ойртсон тухай мэдээлэх; 4. хов хүргэх, хов мэдээ хүргэх, далдуур ховлох; 5. хугацааг хүргэж нярайлах, сарыг гүйцээж төрөх.

ДОНОР хандивлагч.

ДОНОСИ́ТЬСЯ сонсдох, дуулдах.

ДОНЕСТИСЬ сонсдох, дуулдах; **до меня доносились слухи, что** □гэж над цуу үг сонсдлоо.

ДОНО́СЧИК хөвч, мэдээлэгч хов хүргэгч.

ДОНО́СЧИЦА хов хүргэгч эхнэр.

ДОНЫ́НЕ одоо хүртэл.

ДОНЯ́ТЬ *хашраах, тарчлаах, улиглах;* **~ просьбами** улиглаж гуйх.

ДООКТЯ́БРЬСКИЙ Октябрийн өмнөх, Октябрийн хувьсгалын урьдах.

ДОПАХА́ТЬ хагалж дуусгах, хүртэл хагалах; **~ поле** тариалангийн газрыг хагалж дуусгах.

ДОПЕКА́ТЬ болгох, гүйцэд жигнэх.

ДОПЕ́ЧЬ болгох, гүйцэд жигнэх.

ДОПЕ́ЧЬСЯ болох, гүйцэд жигнэгдэх; **хлеб допёкся** талх гүйцэд жигнэгдэв, талх боллоо.

ДОПИВА́ТЬ ууж дуусгах, дуустал уух.

ДО́ПИНГ сэргээш.

ДОПИ́ТЬ ууж дуусгах, дуустал уух, уучхах; **~ стакан чаю** аягатай цай ууж дуусгах.

ДОПЛА́Т||А нөхөх төлбөр, нэмэлт төлбөр; **письмо с ~ой** нэмэлт төлбөртэй захидал.

ДОПЛАТИ́ТЬ нөхөж төлөх.

ДОПЛА́ЧИВАТЬ нөхөж төлөх, нэмж төлөх; **~ сто рублей** зуун рубль нэмж төлөх.

ДОПЛАТНО́Й нөхөж төлөх, дутууг төлөх.

ДОПЛА́ТН||ЫЙ нэмэлт төлбөртэй, нөхөж төлөх, дутууг төлөх; **~ое письмо** нэмэлт төлбөртэй захидал.

ДОПЛЫВА́ТЬ хүрэх, хөвсөөр хүрэх, самарч хүрэх.

ДОПЛЫ́ТЬ хүрэх, хөвсөөр хүрэх, самарч хүрэх; **~ до берега** эргэнд хөвж хүрэх; **~ до середины реки** мөрний дунд самарч хүрэх.

ДОПО́ДЛИННО яг үнэнээр, ив, тов чухам; **~ известно** ив илэрхий,тов тодорхой.

ДОПО́ДЛИНН||ЫЙ жинхэнэ, бодит, яг үнэн; **~ые сведения** жинхэнэ мэдээ, яг үнэн мэдээ.

ДОПОЗДНА́ орой болтол; **засиделись ~** орой болтол суучихав.

ДОПОЛЗА́ТЬ мөлхөж хүрэх,гулгаж хүрэх.

ДОПОЛНЕ́НИЕ 1. нэмэлт, нэмэр; **~ к резолюции** тогтоолын нэмэлт, тогтоолд нэмэлт хийх; 2. тусагдахуун; **прямое ~ предложения** өгүүлбэрийн шууд тусагдахуун; **косвенное ~** шууд бус тусагдахуун.

ДОПО́ЛНЕНН||ЫЙ нэмсэн, нэмэлт хийсэн; **исправленное и ~ое издание** зассан нэмсэн хэвлэл, засалт нэмэлт хийсэн хэвлэл.

ДОПОЛНИ́ТЕЛЬНО нэмж, нэмэлт болгож; **ему дали ~ десять дней отпуска**түүнд арван өдрийн амралт нэмж олгов.

ДОПОЛНИ́ТЕЛЬН||ЫЙ нэмэх, нэмэлт, нэмэгдэл; **~ая подписка на газеты** сонин нэмж захиалах; **~ые расходы** нэмэгдэл зардал.

ДОПО́ЛНИТЬ гүйцээх, *нэмэх, нэмэлт хийх, нэмэр болох;* **~ статью примечаниями** өгүүлэлд тайлбар нэмэх; **~ сказанное одним замечанием** хэлсэн зүйлд нэг юм нэмэх; **дополнять друг друга** бие биедээ нэмэр болох.

ДОПОТО́ПН||ЫЙ 1. усан галбын өмнөх; 2. дивангарын үеийн, эрт урьдын, хуучин цагийн; **~ые взгляды** хуучин цагийн үзэл.

ДОПРА́ШИВАТЬ байцаах, байцаан асуух,өчиг авах.

ДОПРИЗЫ́ВНИК цэрэгт орох бэлтгэл сургууль хийгч, цэрэгт орохоор бэлтгэгч.

ДОПРИЗЫ́ВНЫЙ цэрэгт татагдахаас өмнөх, цэрэгт орохоос өмнөх; **~ возраст** цэрэгт орохоос өмнөх насны.

ДОПРО́С *байцаах, байцаалт, мөрдөн байцаах, мөрдөлт;* **перекрестный ~** ээлжлэн байцаах; **подвергнуть ~у** байцаалт хийх.

ДОПРОСИ́ТЬ байцаах, байцаан асуух, өчиг авах; **~ обвиняемого** хэрэгтнийг байцаах.

ДОПРОСИ́ТЬСЯ гуйж гувших, гуйж асуух, гуйсаар байх; **не могли ~, кто он такой** түүний хэн болохыг гуйж асуугаад мэдэж чадсангүй.

ДОПРЫ́ГИВАТЬ хүртэл харайх, харайж хүрэх, үсэрч хүрэх.

ДО́ПУСК орох эрх, орох арга; **иметь ~ к больным** өвчтөнд орох эрхтэй байх.

ДОПУСКА́ТЬ 1. *оруулах, орохыг зөвшөөрөх,* орох эрх олгох.

ДОПУСТИ́ТЬ 1. оруулах, орохыг зөвшөөрөх, орох эрх олгох; **~ до экзаменов** шалгалтад оруулах; 2. гэж бодох, гэж санах, гэх; **допустим, что это будет так** үүнийг тийм болно гэж бодъё; **не допускаю этой мысли** ингэж би бодохгүй байна, ийм санаа над төрөхгүй байна; 3. гаргах; **~ ошибку** алдаа гаргах.

ДОПУСКА́ТЬСЯ зөвшөөрөгдөх, зөвшөөрөх.

ДОПУСТИ́М||ЫЙ болмоор, болохуйц; **~ое предложение** болмоор санал; **это вполне ~о** ийм байж болохуйц юм.

ДОПУСТИ́ТЬ 1. оруулах, орохыг зөвшөөрөх, орох эрх олгох; 2. гэж бодох, гэж санах, гэх; 3. гаргах.

ДОПЫТА́ТЬСЯ мэдэхийг оролдох; **я допытался, где вы были** таны хаана байгааг би мэдэхийг оролдов.

ДО́ПЬЯНА согтуурал, шал согтол; **напиваться ~** шал согтол уух.

ДОРАБА́ТЫВАТЬ ажиллаж гүйцээх, хийж гүйцээх, нарийвчлан боловсруулах.

ДОРАБО́ТАТЬСЯ -тал ажиллах; **доработался до повышения по службе** албан тушаалаа дээшилтэл ажиллав; **доработался до чахотки** сүрьеөвчтэй болтлоо ажиллав.

ДОРАБО́ТКА ажиллаж гүйцээх, хийж гүйцээх, нарийвчлан боловсруулах.

ДОРАСТА́ТЬ чацуу болтол, хүртэл ургах; **дерево доросло до самой крыши** мод дээвэр хүртэл ургав; 2. насанд хүрэх, нас болох; **ты ещё не дорос, чтобы ходить в кино** чи кинонд очих насанд хүрээгүй байна.

ДОРВА́ТЬСЯ 1. дайрч орох, шунаж орох; ~ **до еды** хоол руу дайрч орох; 2. дайрагдах, учрах; **шалуны дорвались до беды** дүрсгүй хүүхдүүд гайтай юманд дайрагдав.

ДОРЕВОЛЮЦИО́ННЫЙ хувьсгалын өмнөх

ДОРЕФО́РМЕНН||ЫЙ, реформын өмнөх, өөрчлөлтийн өмнөх; **~ая Россия** реформын өмнөх Орос орон.

ДОРИСОВА́ТЬ зурж дуусах.

ДОРИСО́ВЫВАТЬ зурж дуусгах.

ДОРО́Г||А 1. зам, харгуй; **большая ~** их зам, дардан зам; **железная ~** төмөр зам; **сбиться с ~и** зам төөрөх, зам алдах; **по ~е** зам зуур, зам гудас; 2. аян,зам; **дальняя ~** холын зам, алсын аян; **отправиться в ~у** аянд мордох; **я пробыл в ~е три дня** би замд гурав хонов; ***скатертью ~** дуртай тийшээ яв; **стать поперёк ~и** зам хөндөлдөх, саад хийх.

ДО́РОГО үнэтэй; **очень ~** их үнэтэй, өндөр үнэтэй; **~ купить** үнэтэй авах, худалдаж авахад их үнэтэй; **любо~** аятай гээч нь; **~ бы я дал, чтобы** тэгэхийн төлөө би юугаа ч өгөх байсан.

ДОРОГОВИ́ЗНА үнэ өндөр, үнэд орох, үнэ нэмэгдэх.

ДОРО́ГОЙ замд, замдаа, **поговорим ~** замдаа ярилцъя.

ДОРОГО́Й I хайрт, эрхэм хүндэт; **~ друг !** хүндэт нөхөр, хайрт найз.

ДОРОГ||О́Й II 1. үнэтэй, үнэ ихтэй; **~не вещи** үнэтэй юм; 2. эрхэм үнэтэй, чухал үнэтэй; **ваши советы для меня ~и** таны зөвлөлгөө над чухал үнэтэй байна.

ДОРО́ДНЫЙ мариатай, бадриун.

ДОРОЖА́ТЬ үнэтэй болох, үнэд орох.

ДОРО́ЖЕ илүү үнэтэй.

ДОРОЖИ́ТЬ хайрлах, их үнэлэх, эрхэмлэх; **~ временем** цагаа хайрлах; **~ своим именем** нэрээ хайрлах; **~ хорошим работником** сайн ажилтныг эрхэмлэх.

ДОРОЖИ́ТЬСЯ үнэрхэх.

ДОРО́ЖКА 1. нарийн зам, жим, зөрөг, улбаа; 2. гудаслаг хивс.

ДОРО́ЖН||ЫЙ 1. замын, зам; **~ое строительство** зам барилга; **~ая пыль** замын тоос; 2. аяны, замын; **~ костюм** замын хувцас; **одеться по~ому** аяны байдлаар хувцаслах; **~ые люди** аяны хүмүүс.

ЖЕЛА́ТЬ хүсэх, ерөөх, таалах, хүсэл болох, эрмэлзэх; **~ счастья кому-либо** хүнд жаргалтай байхыг ерөөх.
ЖЕЛА́ЮЩИЙ хүсэгч, хүсэлтэй хүн, дуртай хүн, эрмэлзэгч; **нашёлся только один ~** хүсэлтэй хүн ганцхан байв.
ЖЕЛВА́К булуу, овгор, товгор, ур.
ЖЕЛЕ́ царцмал, цэлцэгнүүр.
ЖЕЛЕЗА́ булчирхай; **миндальная ~** бүйлсэн булчирхай; **поджелудочная ~** нойр булчирхай.
ЖЕЛЕ́ЗИСТ||ЫЙ I төмөрт, төмөртэй, төмрийн; **~ая руда** төмрийн хүдэр; **~ая вода** төмөртэй ус.
ЖЕЛЕ́ЗИСТЫЙ II булчирхайт; **~ая ткань** булчирхайт нэхдэс.
ЖЕЛЕ́ЗКА төмрийн өөдөс, хугархай төмөр.
ЖЕЛЁЗКА найлзуурхай, булчирхай, шүүсэвч.
ЖЕЛЕЗНОДОРО́ЖНИК төмөр замчин.
ЖЕЛЕЗНОДОРО́ЖН||ЫЙ төмөр замын; **!ая станция** төмөр замын өртөө.
ЖЕЛЕ́ЗН||ЫЙ 1. төмөр, төмрийн; **~ лом** а)төмөр царил б) эвдэрхий төмөр; **~ая дорога** төмөр зам; 2. хатан, ган болд, ган төмөр, ган; **~ая воля** хатан зориг, ган зориг; 3. бөх, төмөр шиг; **~ое здоровье** бөх бие; **~ кулак** төмөр шиг нударга.
ЖЕЛЕЗНЯ́К гүр; төмрийн хүдэр; **магнитный ~** соронзон гүр; **красный ~** улаан гүр.
ЖЕЛЕ́ЗО 1. төмөр; **листовое ~** гөлмөн төмөр, **прокатное ~** цувимал төмөр; 2. төмөр эдлэл; 3. төмөртэй эм; **куй ~, пока горячо** төмрийг халуун дээр нь давт, хазайсан дээр нь түлхэж унагах.
ЖЕЛЕЗОБЕТО́Н төмөр бетон.
ЖЕЛЕЗОБЕТО́НН||ЫЙтөмөр бетон, төмөр бетоны; **~ая конструкция** төмөр бетон барилга.
ЖЕЛЕЗОПРОКА́ТНЫЙ *төмөр цувих;* **~ завод** төмөр цувих үйлдвэр.
ЖЁЛОБ ховил, онгоц; **водосточный ~** усны ховил; **~ запальный** түр үүсэх ховил.
ЖЕЛТЕ́||ТЬ 1. шарлах, шар болох; **трава ~ет** өвс шарлаж байна; 2. шарлаж харагдах, шарлах, шаргалтан харагдах, шаргалтах;
ЖЕЛТИЗНА́ шар, шар өнгө, *шар толбо.*
ЖЕЛТО́К өндөгний шар.
ЖЕЛТОПЁР хар хайга.
ЖЕЛТОРО́ТЫЙ 1. шар амтай, шар хошуутай; 2. жулдрай, гэнэн бага; **~ юнец** жулдрай хүү.
ЖЕЛТУ́ШНИК *бот.* гонтог.
ЖЕЛТУ́ХА шар өвчин, шарлах, шарлалт, **~ гемолитическая** цус задран шарлах.
ЖЁЛТ||ЫЙ 1. шар; **~ая краска** шар будаг; 2. бөөрөнхий, эвлэрэгч.
ЖЕЛТУ́ШНОСТЬ арьс шарлах.
ЖЕЛУ́ДОК ходоод; **расстройство желудка** гүйлгэх.
ЖЕЛУ́ДОЧЕК *ховдол.*
ЖЕЛУ́ДОЧНЫЙ ходоодны; **~ сок** ходоодны шүүс.
ЖЁЛУДЬ царсны боргоцой.
ЖЁЛЧН||ЫЙ 1. цөсний; **~ пузырь** цөсний гэр; **~ая колика** цөсний хатгуулах; 2. шартай, хор шартай; **~ человек** шартай хүн
ЖЁЛЧЬ 1. цөс; 2. шар, хор шар, уур; **подавить ~** шараа дарах.
ЖЕМА́НИТЬСЯ маяглах, цэмцэгнэх аашлах, аальгүйтэх.
ЖЕМА́ННИЦА маягтай эмэгтэй, цэмцэгнүүр эхнэр, аальгүй, ангалзуур хүүхэн.
ЖЕМА́ННИЧАТЬ маяглах, цэмцэгнэх, цэмцэгнүүр загнах, нэрэлхэх.
ЖЕМА́НН||ЫЙ маягтай, маягласан, цэмцэгнүүр, цэмцэгнэсэн; **~ое поведение** цэмцэгнүүр зан.
ЖЕМА́НСТВО цэмцэгнэх, маяглах, цэмцэгнүүр зан.
ЖЕ́МЧУГ сувд.
ЖЕМЧУ́ЖИНА 1. сувд; 2. эрдэнэ, чимэг.
ЖЕМЧУ́ЖН||ЫЙ 1. сувдан, сувдын; **~ое ожерелье** сувдан эрх; 2. дун цагаан.
ЖЕНА́ эхнэр, авгай, гэргий
ЖЕНА́ТИК саяхан эхнэр авсан нөхөр.
ЖЕНА́ТЫЙ гэргийтэй, эхнэртэй, авгайтай, гэрлэсэн.
ЖЕНИ́ТЬ гэрлүүлэх, эхнэр авч өгөх, гэргий авахуулах, бэр буулгах.
ЖЕНИ́ТЬБА гэрлэх, эхнэр авах.
ЖЕНИ́ТЬСЯ гэрдэх, эхнэр авах, гэргийтэй болох, авгай авах.
ЖЕНИ́Х хүргэн болох хүн, гэрлэх хүн.
ЖЕНИХА́ТЬСЯ амраглах, янаглах.
ЖЕНОЛЮ́Б хүүхэмсэг.

ЖЕНОНЕНАВИ́СТНИК эмэгтэй хүнийг үзэн ядагч.
ЖЕ́НСК||ИЙ эмэгтэй хүний, эмэгтэйчүүдийн, бүсгүй хүний, эхнэр хүний, эм хүний, эхийн, эхнэр, эм; **~ая обувь** эмэгтэй хүний гутал; **родство по ~ой линии** эхийн талын хамаатан; **~ род** эм хүйс.
ЖЕ́НСТВЕННОСТЬ хүүхэмсэг байх, эмсэг байх, эелэг зөөлөн.
ЖЕ́НЩИН||А эмэгтэй, бүсгүй, эхнэр, эм хүн; **~-врач** эмэгтэй эмч; **~ы обращают внимание не на красивых мужчин, а на мужчин с красивыми ~ами** хүүхнүүд сайхан эрчүүдийг биш сайхан хүүхэн дагуулсан эрчүүдийг анхаарч хардаг.
ЖЕНЬШЕ́НЬ *(хүн)* орхоодой.
ЖЁРДОЧКА 1. нарийн сургааг, унь; 2. хөндлөвч.
ЖЕРДЬ сургааг.
ЖЕРЕБЁНОК унага, даага.
ЖЕРЕБЕ́Ц азарга.
ЖЕРЕБИ́ТЬСЯ унагалах.
ЖЕРЕБЬЁВКА шавга сугалах, шавга татах, шавга орхих.
ЖЕ́РЕХ улаан сэрвээт.
ЖЕ́РЛО ам, амсар, өрх; **~ пушки** их бууны ам; **~ вулкана** галт уулын өрх.
ЖЕ́РНОВ ин, тээрмийн чулуу.
ЖЕ́РТВ||А 1. тахил, тавиг, тайлга, тавилга, тахилга; 2. өргөл, барьц, өглөг; **принести в ~у** өргөл болгон барих, өргөх; 3. биеэ өгөх, амиа өгөх, хохирох; **идти на ~ы** биеэ өргөх, амиа өгөх; 4. амь үрэгдэгч, хохирогч, сүйрэгч.
ЖЕ́РТВЕНН||ЫЙ тахилгын; **~ое мясо** тахилгын шүүс.
ЖЕ́РТВОВАТЬ1. барих, өргөх, өглөг өгөх; 2. биеэ өргөх, амиа өгөх, хохирох; **~ собой** амь биеэ өргөх.
ЖЕРТВОПРИНОШЕ́НИЕ тахил өргөх, өргөл барих, тахих.
ЖЕРУ́ШНИК *бот.*сэрэв.
ЖЕСТ 1. дохио дохих, зангах; **решительный ~** шийдэмгий дохих; 2. үйл хийсэн дүр, өнгөний хэрэг; **сделать благородный ~** сайн үйл хийсэн дүр үзүүлэх.
ЖЕ́СТЕР *бот.* яшил.
ЖЕСТИКУЛИ́РОВАТЬ дохих, дохивчлох, зангах.
ЖЕСТИКУЛЯ́ЦИЯ дохих, дохивчлох, зангах, дохио, дохивчлолт, зангалт.
ЖЁСТК||ИЙ 1. ширүүн, хатуу, гордойсон; **~ диван** хатуу диван; **~ое мясо** хатуу мах, гордойсон мах; 2. ширүүн, хатуу, догшин; **~ характер** ширүүн зан; 3. хатуу, чанга, хөдлөшгүй; **~ие сроки** хатуу хугацаа; **~ условия** чанга болзол; **~ вагон** хатуу вагон; **~ая вода** хатуулагатай ус.
ЖЁСТКОСТЬ хатуулаг; **~ воды** усны хатуулаг.
ЖЁСТКО хатуу, ширүүн.
ЖЕСТО́К||ИЙ 1. харгис, хэрцгий, догшин, хатуу; **~ое обращение с людьми** хүнтэй хэрцгий харилцах; 2. хатуу, ширүүн, айхавтар, хахир; **~ая ошибка** айхавтар алдаа; **~ мороз** хахир хүйтэн.
ЖЕСТО́КОСТЬ харгис хэрцгий, хэрцгий явдал, харгис догшин хэрэг, ширүүн, зан.
ЖЕСТЬ нимгэн төмөр, цагаан төмөр; **кровельная ~** дээврийн нимгэн төмөр.
ЖЕСТЯНО́Й нимгэн төмөр, цагаан төмөр; **~ чайник** төмөр данх.
ЖЕСТЯ́НЩИК нимгэн, төмөрчин, нимгэн төмрийн дархан.
ЖЕТО́Н 1. энгэрийн тэмдэг; 2. дугариг тэмдэг
ЖЕЧЬ 1. галдах, түймэрдэх, шатаах, түлэх; 2. шатаах, түлэх, хуурах; **~ электричество** цахилгаан шатаах; **~ дрова** түлээ түлэх. 3. халаах, түлэх, хорсгох, хайрах; **солнце жжёт спину** нар нуруу халааж байна.
ЖЕ́ЧЬСЯ 1. түлэх, хайрах; **крапива жжется** халгай түлдэг; 2. түлэгдэх.
ЖЖЕ́НИЕ хорсох, халуу оргих.
ЖЖЁНЫЙ болгосон, болсон, түлмэл, хуурсан; **~ кирпич** болсон туйлуу.
ЖИВИ́ТЕЛЬН||ЫЙ сэргээх, бие сэргэдэг, сэргэлэн, мөнхийн; **~ воздух** сэргэлэн агаар; **~ая влага** мөнхийн рашаан.
ЖИ́ВНОСТЬ гэрийн шувуу, тэжээвэр шувуу.
ЖИ́ВО 1. тодорхой, илхэн, дурайн; 2. ихэд, тод; 3. хөгжөөнтэй, хөгжилтэй, урамтай; 4. бушуу, шалавхан, даруйхан; **он ~ сбегал** тэр (хүн) шалавхан гүйж очоод ирэв.
ЖИВ||О́Й 1. амьд, мэнд, амьтай, голтой; **~ая рыба** амьд загас; **застать кого-либо в ~ых** мэнд байхад нь учрах; 2. амьд, амьтай; **~ая природа** амьд байгаль; **~ое существо** амьтан; 3. жинхэнэ, ёстой, одтой, үнэн, амьд; **~ая действительность** үнэн бодит байдал; 4. цовоо, сэргэлэн, хөнгөн, гавшгай, хөгжөөнтэй, хөгжилтэй, урамтай; **~ ребёнок** цовоо хүүхэд; 5. зугаатай, хялбар тодорхой; 6. чухал, амин чухал; **~ое начинание** чухал эхлэлт; 7. гүн, халуун; **~ вес** амьдын жин; **~ые цветы** амьд цэцэг; **~ого места нет** бүтэн газаргүй байна; **~ портрет кого-либо** хүнтэй цутгасан юм шиг адил; **~ язык** амьд хэл; **за ~ое задеть** эмзэг газрыг нь хөндөх, сэтгэлийн нь хөдөлгөх; **ни жив, ни мертв** үхсэн амьдын хооронд; **остаться в ~ых** амьд үлдэх.
ЖИВОПИ́СЕЦ уран зурагч, зураач..
ЖИВОПИ́СН||ЫЙүзэсгэлэнт, зурсан юм шиг сайхан, зураг шиг гоё; **~ая природа** үзэсгэлэнт байгаль.
ЖИ́ВОПИС||Ь 1. уран зураг; **урок ~и** уран зургийн хичээл; 2. зураг; **стенная ~** туурганы зураг.
ЖИ́ВОСТЬ цовоо сэргэлэн.
ЖИВО́Т 1. гэдэс, хэвлий 2. гэдэс дотор, дотор ходоод.
ЖИВОТВО́РН||ЫЙ амьдруулах, тэнхрүүэх, зориг бадруулах, амьдруулан үйлдэгч; **~ое действие сна** нойрын тэнхрүүлэх чадвар.
ЖИВОТНОВО́Д малчин, мал аж ахуйн мэргэжилтэн.
ЖИВОТНОВО́ДСТВО мал аж ахуй.
ЖИВОТНОВО́ДЧЕСКИЙ мал аж ахуйн, мал өсгөх, малын.
ЖИВО́ТНОЕ 1. амьтан, адгуус, мал; **домашнее ~** гэрийн тэжээмэл амьтан, мал; **хищное ~** махчин амьтан, араатан; 2. адгуус, адгуусан амьтан; 3. адгуус, адгуус шиг хүн.
ЖИВО́ТНЫЙ 1. амьтны, адгуусны, адгуусан, малын; **~ мир** амьтны аймаг.
ЖИВОТРЕПЕ́ЩУЩИЙ хойшлуулшгүй чухал, туйлын чухал; **~ вопрос** туйлын чухал асуудал.
ЖИВУ́ЧЕСТЬ 1. бөх голтой (байх); долоон голтой (байх); урт нас.
ЖИВУ́Ч||ИЙ 1. бөх голтой, долоон голтой (байх); урт настай; **~ее растение** урт настай ургамал; **~ человек** бөх голтой хүн; 2. удаан хадгалагддаг, удаан настай, бөх; **~ обычай** бөх заншил.
ЖИ́ВЧИК 1. сэргэлэн, шуурхай хүн; 2. үрийн эс.
ЖИВЬЁМ амьдаар; **захватить ~ в плен** амьдаар нь олзлох.
ЖИ́ДК||ИЙ 1. шингэн; **~ие тела** шингэн бодис; 2. шингэн, сийрэг, армаг тармаг, тачир; **~ лес** сийрэг ой; **~ие волосы** шингэн үс; 3. шингэн, усан; **~ чай** шингэн цай; **~ суп** усан шөл; 4. сул, улбагар, улхгар, дорой; **~ие мускулы** улхгар булчин.
ЖИ́ДКОСТЬ шингэн бодис, шингэн зүйл; **~ брюшной полости** хэвлийн хөндийн шингэн.
ЖИ́ЖА нялцгай шавар, нялгар шивх.
ЖИ́ЖЕ бүр шингэн, улам шингэн.
ЖИЗНЕДЕ́ЯТЕЛЬНЫЙ ажиллагаа сайтай, идэвхитэй.
ЖИЗНЕ́ННОСТЬ амьдрах чадвар.
ЖИ́ЗНЕНН||ЫЙ 1. амьдралын, аж амьдралын; **~ые потребности** амьдралын хэрэгцээ; **~ опыт** амьдралын туршлага;

2. амин чухал, амьдралын чухал; **~ое предложение** амин чухал санал.

ЖИЗНЕОПИСА́НИЕ намтар, цадиг.

ЖИЗНЕРА́ДОСТНОСТЬ баясгалан, цог хөхүүн, цовоо байх.

ЖИЗНЕРА́ДОСТНЫЙ баясгалантай, цогтой, хөхүүн, цовоо; **~ человек** баясгалантай хүн.

ЖИЗНЕСПОСО́БНОСТЬ амьдрах чадвар, амьдрах чадал, амьдралд таарах, амьдралд зохицох.

ЖИЗНЕСПОСО́БНЫЙ амьдрах чадвартай, амьдрах чадалтай, амьдралд таарсан, амьдралд зохицсон.

ЖИЗНЕУТВЕРЖДА́ЮЩИЙ амьдралыг бататгах.

ЖИЗН||Ь 1. амьдрал, ертөнц; **возникновение ~и на земле** дэлхийд амьдрал үүссэн нь, **закон ~и** ертөнцийн жам; 2. амьдрал, амь, амь бие, амь нас, нас; **~ человека** хүний амьдрал, хүний нас, хүний амь; **рисковать ~ью** амь өрсөх; **спасти кому-либо ~** хүний амь аврах; **лишить ~и** алах; 3. амьдрал, аж амьдрал, аж байдал, байдал, явдал суудал; **общественная ~** нийгмийн амьдрал; **семейная ~** гэр бүлийн аж амьдрал; 4. ажил хэрэг, хэрэг; 5. нас, амьд байх, амьд явах, хүн болох; **в течение всей ~и** бүх насны турш; **при ~и** амьд явахдаа; **раз в ~и** хүн болсоор нэг удаа; 6. хөл, *хөдөлгөөн*, цог, жавхаа; **вопрос ~и и смерти** амин гол асуудал, амин сүнс; **между ~ью и смертью** ухлийн даваан дээр; **как ~?** ямар ая зантай байна? амьдрал ямар байна вэ? ***по гроб ~и** энэ насандаа, үхтлээ.

ЖИ́ЛА 1. судас; 2. шөрмөс, шандас, бүлх; 3. судал; **золотая ~** алтны судал.

ЖИЛЕ́Ц суугч, байрлагч, суудаг хүн, хүн; **жильцы дома** байшинд суугчид; **сдать комнату жильцу** тасалгаа хүнд хөлслүүлэх.

ЖИ́ЛИСТ||ЫЙ 1. шөрмөстэй, шандастай, бүлхэрхэг; **~ое мясо** бүлхэрхэг мах; 2. шандсархаг, шөрмөслөг, шандастай, *шөрмөстэй*; **~ые руки** шандсархаг гар.

ЖИЛИ́ЦА суугч эмэгтэй, байр хөлслөгч эмэгтэй, суудаг эмэгтэй.

ЖИЛИ́ЩЕ орон сууц, орон гэр, орон байр, сууц; **благоустройство жилищ** орон сууц барих.

ЖИ́ЛК||А I 1. судас; 2. шөрмөс, шандас, бүлх; 3. (чулуулгийн) судал; 4. судал, зураас, **мрамор с красными ~ами** улаан судалтай гантиг.

ЖИ́ЛКА II авъяас чадвар; **артистическая ~** жүжигчний авъяас; **организаторская ~** зохион байгуулах авъяас.

ЖИЛО́Й сууцны, хүн суух, хүн суудаг; **~ дом** хүн суудаг байшин.

ЖИЛПЛО́ЩАДЬ сууцны талбай, орон сууц.

ЖИЛЬЁ1. хүн оршдог газар; 2. орох оромж, орох газар, хоргодох байр, сууц.

ЖИ́МОЛОСТЬ далан хальс

ЖИР өөх, тос; **животные ~ы** өөх; **растительные ~ы** ургамлын тос; **рыбий ~** загасны тос.

ЖИРА́Ф анааш.

ЖИРЕ́ТЬ өөхлөх, таргалах, бүдүүрэх, махлах.

ЖИ́РН||ЫЙ 1. тарган, өөхтэй, тостой, тослог, хурц; **~ое мясо** тарган мах; **~ суп** тостой шөл; 2. тарган, бүдүүн, махлаг; **~ кот** тарган муур; 3. тостой, тос болсон, тосон; **~ые руки** *тостой* гар; **~ое пятно** тосон толбо; 4. үржилтэй, шимтэй; **~ая земля** шимтэй газар; **~ шрифт** тарган үсэг, тод үсэг.

ЖИРОВИ́К өөхөн хавдар.

ЖИРОВ||О́Й 1. өөхөн, тосон, өөхтэй, *тостой, тослог*; **~ая клетка** өөхний эс. **~ая ткань** өөхөн нэхдэс; 2. өөх тосны.

ЖИТЕ́ЙСК||ИЙ ертөнцийн, орчлонгийн, өдөр тутмын, ердийн; **~ие дела** ертөнцийн хэрэг, ердийн хэрэг; **~ая мудрость** амь зуух ухаан, амь аргалах ухаан.

ЖИ́ТЕЛЬ оршин суугч, хүн; **городской ~** хотын хүн; **деревенский ~** хөдөөгийн хүн; **коренной ~** уул нутгийн хүн.

ЖИ́ТЕЛЬСТВ||О *нутаглах, оршин суух, суурьших*; **место ~а** оршин суух газар.

ЖИ́ТНИЦА 1. сан, хадгалах газар; 2. тарианы сан, тарианы орон.

ЖИ́ТНЫЙ тарианы, үр тарианы.

ЖИ́ТО тариа, үр тариа.

ЖИТЬ 1. амьдрах, наслах; **~ долго** урт наслах; 2. оршин суух, суух, байх; **~ в Москве** Москвад суух; 3. амьдрах, амь зуух, амь тэжээх; **~ своим трудом** хөдөлмөрөөрөө амь зуух; **~ на литературный заработок** зохиолын хөлсөөр амь тэжээх; 4. амьдрах, суух, байх; **~ отшельником** зожиглон суух; 5. *байх, харилцах*; **~ дружно с братьями** ах дүүтэйгээ эвтэй байх; **жил-был, жили были** байжээ; 6. **~ кем-либо, чем-либо** хэн нэгийг ямар нэгэн зүйлийг шүтэн амьдрах.

ЖИТЬ||Ё амьдрал, байдал, амьдрах, аж төрөх, суух, байх; **дом пригодный для ~я** сууж болмоор байшин; **~бытье** аж амьжиргаа.

ЖИ́ТЬСЯ амьжрах, суух, байх; **нам живётся хорошо** бид сайн амьжирч байна; **ему не живётся на одном месте** тэр (хүн) нэг газар байж чаддаггүй.

ЖМУ́РИТЬ анийлгах, онийлгох; **~ глаза** нүдээ анийлгах, нүдээ онийлгох.

ЖМУ́РИТЬСЯ *анийх, онийх*.

ЖМУ́РКИ нүд боож наадах.

ЖМЫ́ХИ шахдас, **подсолнечные ~** наран цэцгийн үрийн шахдас.

ЖНЕ́ЙКА хадах машин, хадуур машин.

ЖНЕЦ тариа хадагч.

ЖНЕЯ тариа хадагч эхнэр.

ЖНИ́ВО 1. тариа хадсан талбай; 2. тарианы ёзоор; 3. тариа хадах цаг.

ЖНИВЬЁ 1. тариа хадсан талбай; 2. тарианы ёзоор; 3. тариа хадах цаг.

ЖНИ́ЦА тариа хадагч эмэгтэй.

ЖОМ 1. шахуур; 2. шахдас.

ЖОНГЛЁР жонглёр, саваачлагч.

ЖОНГЛИ́РОВАТЬ 1. жонглёр тоглох; 2. мэхлэх, хуурах.

ЖРАТЬ чихэх, идэх, гудрах.

ЖРЕ́БИЙ 1. шавга; **бросать ~** шавга орхих, шавга хаях; 2. хувь, тавилан, үйл.

ЖРЕЦ 1. тайлагч, бөө; 2. шүтэгч хүн; **~ науки** шинжлэх ухааныг шүтэгч хүн.

ЖРИ́ЦА тайлагч чавганц, удган.

ЖУЖЖА́НИЕ шунгинах, дүнгэнэх, шүнгэнэлэг, хүнгэнэлэг.

ЖУЖЖА́||ТЬ *шунгинах, шүнгэнэх, дүнгэнэх, хүнгэнэх*; **~т комары** шумуул шунгинах.

ЖУК цох, цох хорхой.

ЖУ́ЛИК луйварчин.

ЖУЛИКОВА́ТЫЙ луйварчин, луйварддаг, луйвар хийдэг; **~ человек** луйвар хийдэг хүн.

ЖУ́ЛЬНИЧАТЬ луйвардах, луйвар хийх, булхайтах, булхай хийх.

ЖУ́ЛЬНИЧЕСТВО луйвар, луйвардах, булхай, булхайтах.

ЖУ́ПЕЛ (хадны) мангаа.

ЖУРАВЛИ́НЫЙ тогорууны, тогоруун.

ЖУРА́ВЛЬ I тогоруу, цэн.

ЖУРА́ВЛЬ II худгийн цах.

ЖУРИ́ТЬ зэмлэх, аяглах.

ЖУРНА́Л1. сэтгүүл; **литературный ~** утга зохиолын сэтгүүл; 2. тэмдэглэлийн дэвтэр; **~ заседания** хурлын тэмдэглэлийн

дэвтэр; 3. бүртгэлийн дэвтэр; **классный ~** ангийн бүртгэлийн дэвтэр.

ЖУРНАЛИ́СТ сэтгүүлч, сурвалжлагч.

ЖУРНАЛИ́СТИКА 1. сэтгүүлчийн ажил; 2. тогтмол хэвлэл, сонин сэтгүүл.

ЖУРНАЛИ́СТКА сэтгүүлч эмэгтэй, сурвалжлагч эмэгтэй.

ЖУРНА́ЛЬН||ЫЙ сэтгүүлийн; **~ая статья** сэтгүүлийн өгүүлэл.

ЖУРЧА́НИЕ хоржигноо, шоржигноо, шорчигноо.

ЖУРЧА́ТЬ хоржигнох, шоржигнох, шорчигнох, хор хор хийх, шор шор гэх, жир жир урсах.

ЖУ́ТК||ИЙ 1. аймшигтай, айдас хүрмээр, зэвүүн, аягүй; **~ое зрелище** айдас хүрмээр үзэгдэл; 2. аюултай, зэвүүн; **~ холод** аюултай хүйтэн, зэвүүн хүйтэн.

ЖУ́ТКО аймшигтай, аймаар, айдас хүрмээр; **мне что-то ~** миний нэг л айдас хүрээд байна.

ЖУТЬ айдас, зэвүүн.

ЖУЧО́К 1. бяцхан цох; 2. разг. нууц чагнах авсаархан төхөөрөмж.

ЖЭК (*сокращение: жилищно-эксплуатационная контора*) ОСАК орон сууц ашиглалтын контор.

ЖЮРИ́ шалгаруулах комисс.

ЗА 1. цаана, цаад талд, тэртээ; **~ рекой** голын цаад талд, голын тэртээ; **~ горой** уулын цаана; **~ домом** байшингийн цаана; 2. дэргэд, гадаа, гадна; **~ столом** ширээний дэргэд; **стоять ~ стаиком** суурь машины дэргэд зогсох; **жить ~ городом** хотын гадна амьдрах; 3. урьд, өмнө; **~ два дня до праздника** баяраас хоёр хоногийн өмнө; **~ час до отхода поезда** галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө; 4. дотор, турш; **эту работу можно сделать ~ два дня** энэ ажлыг хоёр өдрийн дотор хийж болно; **многое сделано ~ неделю** долоо хоногийн дотор их юм хийжээ; 5. учраас, учир, тул; **~ неимением времени** завгүй учраас; **~ молодостью лет** залуу настай учраас; **~ ненадобностью** хэрэггүй байсан учир; 6. төлөө, тулд, тул, гэж; **~ мир во всём мире** дэлхий дахины энх тайвны *төлөө*; **~ родину** эх орны *төлөө*; **пришёл ~ книгой** ном авах гэж ирсэн, ном авахын тулд ирсэн; **я рад ~ вас** таны төлөө би баярлана; **беспокоиться ~ детей** хүүхдүүдийн төлөө сэтгэл зовох; 7. гэж; **обратиться ~ советом** зөвөлгөө авах гэж очих; **ценить ~ ум** ухаантай гэж үнэлэх, ухааныг нь үнэлэх; **принять ~ образец** үлгэр жишээ гэж үзэх, жишээ болгох; **принять кого-нибудь ~ своего знакомого** ямар нэгэн хүнийг танилаа гэж андуурах; **в погоне ~ удачей** амжилт олох гэж хөөцөлдөх; 8. хойноос **один ~ другим** хойно хойноос; **бегать ~ кем-либо** хүний хойноос гүйх; 9. хойно, дараа, дараалан; **~ дождями наступила жара** бороонуудаа дараа халуун болов; **читать книгу ~ книгой** номуудыг дараалуулан унших; **идет месяц ~ месяцем** сарын дараа сар ирэх юм, сар дараалан өнгөрч байна; 10. гарах, өнгөрөх, гаруй; **ему далеко ~ сорок** тэр хүн дөч нилээд гарчээ; **уже ~ полночь** *шөнө* дунд өнгөрлөө; 11. оронд, *төлөө*; **работать ~ двоих** хоёр хүний оронд ажиллах; 12. зөвшөөрөх; **~ и против** зөвшөөрөх эсэх; 13. -аас, -ээс; **взять ~ руку** гараас барих; **держаться ~ перила** хайснаас барих; **~ исключением одного** нэгээс бусдыг нь; 14. —аар, ээр; **выбросить ~ окно** цонхоор хаях;15. -д, -т; **пойти ~ водой** усанд явах; **пойти ~ ягодами** жимсэнд явах; **камень ~ пазухой** муу санах, өс санах; **~ последнее время** сүүлийн үед; **запишите ~ мной** над оноогоод бич; **выйти замуж** хадамд очих; **молчать ~ едой** хоол идэхдээ дуугай байх; **поговорить ~ обедом** хоолны үед *ярилцах*; 16. -ын, -ийн; **заработок ~ один месяц** нэг сарын цалин; 17. -ыг, -ийг; **смотреть ~детьми** хүүхэд харах; **приняться ~ еду** хоолоо идэх; 18. —тай, -тэй; **дело ~ номером таким-то** тийм дугаартай хэрэг; **письмо ~ подписью директора** захирлын гарын үсэгтэй бичиг; **~ ним водится эта дурная привычка** тэр ийм муу зантай юм; **ни ~ что** ямаан ч.

ЗААЛЕ́ТЬ улайх, улайж эхлэх.

ЗААПЛОДИ́РОВАТЬ алга таших, алга ташиж эхлэх.

ЗААРКА́НИТЬ 1. уургалах, бугуйлдах, **~ лошадь** морь бугуйлдах; 2. хэн нэгээр юм хийлгэх.

ЗААРТА́ЧИТЬСЯ ярдаглах, хэдэрлэх, яхирлах, ядрах.

ЗАА́ХАТЬ ай яая гэх, халаглах, ай чааваас гэх.

ЗАБА́В||А зугаа, зугаацал; **детские игры и ~ы** хүүхдийн тоглоом зугаа; **пустая ~** хоосон зугаа.

ЗАБА́ВИТЬ зугаацуулах, **«не мысля гордый свет забавить»** (А.С.Пушкин «Евгений Онегин») «ихэмсэг ноёдыг зугаацуулах гэсэн биш»

ЗАБАВЛЯ́ТЬ зугаацуулах; **~ детей играми** хүүхдийг тоглоомоор зугаацуулах.

ЗАБАВЛЯ́ТЬСЯ зугаацах, наадах; **~ играми** тоглоомоор зугаацах.

ЗАБА́ВНИК *разг.* зугаач, зугаатай хүн, алиа салбадай.

ЗАБА́ВНО инээдтэй, наргианы, хөгийн.

ЗАБА́ВН||ЫЙ инээдтэй, наргианы, хөгийн; **~ ребенок** инээдтэй хүүхэд; **~ случай** хөгийн тохиолдол; **~ая картина** инээдтэй зураг.

ЗАБАЙКА́ЛЬЕ Байгалийн өмнөх, Байгалийн. урд бие

ЗАБА́ЛТЫВАТЬ хутгах,зайлах.

ЗАБАРАБА́НИ||ТЬ нижигнүүлж эхлэх, балбаж эхлэх, тачигнуулж эхлэх; **дождь ~л по крыше** бороо дээврийг тачигнуулан орж эхлэв.

ЗАБАРРИКАДИ́РОВАТЬ гудамж хааж бэхлэлт хийх.

ЗАБАРРИКАДИ́РОВАТЬСЯ шивээ босгох, гудамж хаагдаж шивээ байгуулагдах.

ЗАБАСТОВА́ТЬ ажил хаях.

ЗАБАСТО́ВК||А ажил хаях, ажлаа хаях, **всеобщая ~** нийтээр ажил хаях, **объявить ~у** ажлаа хаяхыг илэрхийлэх.

ЗАБАСТО́ВОЧН||ЫЙ ажил хаягчдын, ажил хаялтын, ажил хаях; **~ое движение** ажил хаях хөдөлгөөн.

ЗАБАСТО́ВЩИК ажил хаягч, ажлаа хаягч.

ЗАБВЕ́НИ||Е мартах, мартагдах; **~ своих обязанностей** үүргээ мартах, **предать ~ю** мартаж орхих.

ЗАБЕ́Г, уралдаан, гүйлт.

ЗАБЕ́ГАТЬ 1. үймэлдэх,гүйлдэх, хөл үймээн болох; 2. бүлтэлзэх, бүлтэгнэх.

ЗАБЕГА́ТЬ 1. орох, орж гарах, **орж байх; ~ далеко в лес** ойн гүнд орох; 2. дайраад гарах, ороод гарах; **~ по пути** замдаа ороод гарах; **~ вперёд** урьдчилан хэлэх.

ЗАБЕ́ГАТЬСЯ гүйгээд ядрах, эцтэлээ гүйх.

ЗАБЕЖА́ТЬ 1. гүйж орох, **~ во двор** хашаанд гүйж орох; 2. ороод гарах, дайрч гарах, **~ к знакомым** танилындаа ороод гарах; 3. хэтэрхий гүйх; 4. урьдчилан хийж эхлэх.

ЗАБЕЛИ́ТЬ 1. цайлгах, цагаанаар будах; **~ стены** ханыг цагаанаар будах; 2. сүүлэх, сүлэх, цайлгах; **~ чай** цай сүлэх, **~ щи** ногоотой шөл цайлгах.

ЗАБЕРЕ́МЕНЕТЬ жирэмсэн болох, бие давхар болох, хөл хүнд болох, хүүхэд олох.

ЗАБЕСПОКО́ИТЬСЯ санаа зовних, сэтгэл зовних, санаа зовох.

ЗАБИВА́ТЬ 1. шаах, хадах; **~ клин** шаантаг *шаах*; **~ гвоздь** хадаас хадах; 2. таглах, бөглөх, чигжих; **~ щели** ангархайг бөглөх; 3. дүүргэх; **трубу ~ песком** төмөр хоолойг элсээр дүүргэх; 4. алах, нядлах; **~ двадцать голов скота** хорин мал нядлах; 5. цохиж оруулах; **~ гол** хаалганд бөмбөг оруулах; **~ голову чем-либо** ямар нэг юмыг үхширтэл бодох, санаашрах.

ЗАБИВА́ТЬСЯ 1. шургах, шигдэх, нуугдах; **~ в угол** буланд нуугдах; 2. бүтэх тагларах; 3. цохилж эхлэх.

ЗАБИНТО́ВАННЫЙ боосон, ороосон.

ЗАБИНТОВА́ТЬ боох, ороох; **~ рану** шарх боох.

ЗАБИРА́ТЬ, ЗАБРА́ТЬ 1. авах, авч очих; **~ с собой книги** номнуудыг авч очих; 2. авах, эзлэн авах, булааж авах; **~ власть** засгийг эзлэн авах, **~ в плен** олзлон авах; 3. барих, хорих; 4. хуних, танах; **~ шов** оёдлыг танах.

ЗАБИРА́ТЬСЯ, ЗАБРА́ТЬСЯ 1. нэвтрэн орох, шургаж орох; **~ в самую глубь леса** ойн гүнд нэвтрэн орох; 2. өгсөх, авиран гарах; **~ на дерево** модонд авиран гарах.

ЗАБИ́ТОСТЬ мохтол нухлагдах.

ЗАБИ́ТЫЙ 1. шаагдсан, хадагдсан, хадсан; ~ **гвоздь** хадсан хадаас; 2. мохтол нухлагдсан, мохоо болсон, түгжмэл хоцорсон; ~ **человек** нухлагдсан хүн.

ЗАБИ́||ТЬ 1. цохиж эхлэх; ~ **в барабаны** хэнгэрэг цохиж эхлэх; 2. шаах хадах; ~ **клин** шаантаг шаах; 3. таглах, бөглөх, чигжих; ~ **щели** ангархайг бөглөх; 4. цохиж оруулах; ~ **мяч в ворота** хаалганд бөмбөг оруулах; 5. дүүргэх, чихэх; ~ **сарай дровами** пинг түлээгээр дүүргэх; 6. оргилох, оргилон гарах; **во время визита президента П. Очирбата из скважины ~ла нефть** Ерөнхийлөгч П. Очирбатын айлчлалын үеэр цооногоос газрын тос оргилон гарав. 7. алах, нядлах; ~ **десять голов скота** арван толгой мал нядлав; 8. дарах; **сорняк ~л цветы** хогийн ургамал цэцгийг дарав; ~ **голову кому-либо** хэн нэгний толгойг эргүүлэх; ~ **себе голову** үхширтлээ санах, толгойгоо гашилтал бодох; ~ **тревогу** түгшүүр зарлах.

ЗАБИ́ТЬСЯ 1. цохиж эхлэх; **сердце забилось** зүрх цохилж эхлэв; 2. нуугдах, хоргодох, шигдэх; ~ **в угол** буланд хоргодох; 3. тагларах, бөглөрөх, битүүрэх; **труба забилась грязью** яндан хогоор битүүрэв.

ЗАБИЯ́КА ярдаг үн, хэрүүл өдөгч, зодоон өдөөгч.

ЗАБЛАГОВРЕ́МЕННО урьдаас, эртхэн, хэдийний; **известить** ~ эртхэн мэдэгдэх; **готовиться к чему-либо** ~ ямар нэгэн юманд эртхэн бэлтгэх.

ЗАБЛЕСТЕ́||ТЬ 1. гялалзаж эхлэх, гялалзах; **на небе ~ли звёзды** огторгуйд одод гялалзав; 2. мэлмэрэх; **на глазах ~ли слёзы** нүдэнд нь нулимс мэлмэрэв.

ЗАБЛЕ́ЯТЬ майлах.

ЗАБЛУДИ́ТЬСЯ төөрөх; ~ **в лесу** ойд төөрөх, ~ **в трех соснах** харагдаж байхад хажуугаар нь төөрөх.

ЗАБЛУЖДА́ТЬСЯ 1. төөрөлдөх; 2. эндүүрэх.

ЗАБЛУЖДЕ́НИЕ эндүүрэх, эндүүрэл, төөрөх, төөрөгдөх; **вводить** ~ эндүүрүүлэх; **впасть в** ~ төөрөгдөлд орох.

ЗАБОДА́||ТЬ 1. мөргөх, мөргөж орхих, олих; 2. залхаах, ядаргаа болох; **он меня ~л** тэр намайг залхааж байна.

ЗАБО́Й I уурхайн хонгил, уурхайн мөргөцөг.

ЗАБО́Й II нядлах, нядлал; ~ **скота** мал нядалгаа.

ЗАБО́ЙЩИК мөргөцөг малтагч, уурхайчин.

ЗАБОЛА́ЧИВАНИЕ намагших, балчиг болох.

ЗАБОЛА́ЧИВАТЬСЯ намагших, намагтай болох, балчиг болох.

ЗАБОЛЕВА́НИ||Е өвдөх, өвчин тусах, өвчтөн; **число ~й** өвчлөлтийн тоо.

ЗАБОЛЕВА́ТЬ өвдөх, өвчлөх; ~ **ангиной** сахуугаар өвдөх.

ЗАБОЛЕ́||ТЬ өвдөж эхлэх; **у меня ~ла голова** миний толгой өвдөж эхлэв.

ЗА́БОЛОНЬ зулам налхи.

ЗАБОЛО́ЧЕННЫЙ намаг болсон, намагшсан, намагтай; ~ **луг** намагтай нуга.

ЗАБОЛТА́ТЬ 1. унжгануулах, санжгануулах, займчуулах, хөдөлгөх; ~ **ногами** хөлөө санжгануулах; 2. холих, хутгах; ~ **в суп яйцо** шөлөнд өндөг хутгах.

ЗАБОЛТА́ТЬСЯ I чалчих, бурах, үгэндээ согтох, дэмий юм ярих; **она заболталась со знакомыми, потому и опоздала** тэр хүүхэн танилуудтайгаа дэмий ярьсаар байгаад хожимджээ.

ЗАБОЛТА́ТЬСЯ II унжилзах, холхих, дайвалзах.

ЗАБО́Р хашаа, хороо, хайс; **сад был обнесён высоким ~ом** цэцэрлэг өндөр хашаагаар хашигдсан байв.

ЗАБО́РИСТЫЙ хатуу, чанга, арзгар; ~ **табак** хатуу тамхи.

ЗАБО́Т||А 1. зовнил, сэтгэл зовнил, санаа зовох; ~ **о своём будущем** ирээдүйнхээ төлөө санаа зовних; 2. халамж, элбэрэл, арчлал, санаа тавих; ~ **о благосостоянии народа** ард түмний чинээлэг амьдралын тухай санаа тавих; **окружать кого-нибудь ~ами** хүнд халамж үзүүлэх; **отеческая** ~ эцэг ёсны халамж; 3. аж явдал; **домашние ~ы** гэрийн аж явдал; **без забот** хайхрамжгүй; **ему и ~ы мало** тэр, бүр хайхрахгүй.

ЗАБО́ТИ||ТЬ санаа зовох; **его сильно ~т болезнь ребёнка** хүүхэд нь өвдөөд санаа нь их зовж байна.

ЗАБО́ТИТЬСЯ 1. халамжлах, санаа тавих, элбэрэх, арчлах; ~ **о детях** хүүхдээ элбэрэх; ~ **о благе народа** ард түмний тусын тулд санаа тавих; 2. сэтгэл зовох, санаа зовох; **ему ни о чём не придётся** ~ түүнд санаа зовох юм огт байхгүй.

ЗАБО́ТЛИВО арчилж, элбэрч, халамжилж.

ЗАБО́ТЛИВОСТЬ арчлал, элбэрэл, халамж, санаа тавих.

ЗАБРАКОВА́ТЬ голох, шаарлах, заазлах.

ЗАБРА́Л||О нүүрийн халхавч, дуулгын унжлага; **выступить с открытым ~ом** эрс шулуун хэлэх, ил шууд хийх.

ЗАБРА́СЫВАТЬ 1. чулуудах, шидэх; ~ **мяч** бөмбөг шидэх; 2. булах, хаяж дүүргэх, дарах; ~ **землёй** шороогоор булах; ~ **вопросами** асуултаар дарах, нэгэн зэрэг асууцгаах; 3. хаях, орхих, болих;4. илгээх, явуулах; ~ **товары** бараа явуулах.

ЗАБРА́СЫВАТЬСЯ хаягдах, шидэгдэх.

ЗАБРА́ТЬ 1. авах, авч явах; ~ **собой деньги** мөнгө биедээ авч явах; 2. авах, зээлэн авах, булааж авах; ~ **в плен** олзлон авах; 3. барих, хорих; 4. хуних, танах; 5. хаах, таглах; ~ **окно досками** цонхыг банзаар таглах; ~ **голову** ямар нэгэн бодолд автагдах; ~ **силу** хүчтэй болох, нөлөөтэй болох;

ЗАБРА́ТЬСЯ 1. авирч гарах; ~ **на верхушку дерева** модны үзүүрт авирч гарах; 2. шургаж орох, дайрч орох, нэвтэрч орох; ~ **под одеяло** хөнжилдөө шургаж орох; ~ **в самую глубь леса** ойн гүнд нэвтэрч орох;

ЗАБРЕ́ЗЖ||ИТЬ 1. цайх, хаяарах, гэгээрэх; **~ал рассвет** үүр гэгээрлээ; 2. сүүмэлзэх, улсхийх, гялсхийх; **в темноте ~ил огонь** харанхуйд гал улсхийв.

ЗАБРЕСТИ́ 1. хэсгээр орох, зайж орох, зайж явсаар орох; ~ **далеко в лес** зайж явсаар ойн гүнд орох; 2. ороод гарах, дайраад гарах; **изредка забредёт случайный посетитель** хааяа тохиолдсон хүн ороод гарна.

ЗАБРОНИ́РОВАТЬ 1. захиалах, захиалгаар үлдээх; ~ **место в поезде** галт тэргэнд суудал захиалгаар үлдээх; 2. хуяглах.

ЗАБРОСА́ТЬ 1. булах, булагдтал дарах; ~ **яму землёй** нүхийг шороогоор булах; 2. шидэх, хаях; 3. дарах; ~ **вопросами** асуултаар булах.

ЗАБРО́СИ||ТЬ 1. шидэх, чулуудах; ~ **мяч в сад** бөмбөгийг цэцэрлэгт шидэх; 2. хаях, орхих, болих; ~ **хозяйство** аж ахуйгаа хаях; **Алтанчимэг совсем ~ла себя** Алтанчимэг өөрийгөө гаргуунд хаяжээ.

ЗАБРО́ШЕННОСТЬ 1. хаягдал, орхигдол, эзэнгүйдэх; 2. алслагдах, зэлүүд бөглүү.

ЗАБРО́ШЕННЫЙ 1. хаясан, шидсэн, шидэгдсэн; ~ **мяч** шидсэн бөмбөг; 2. хаягдсан, орхигдсон; ~ **сад** орхигдсон цэцэрлэг, арчилгаагүй цэцэрлэг.

ЗАБРЫ́ЗГА||ТЬ 1. үсэргэх, цацах; ~ **грязью** шавхай үсэргэх; 2. үсэргэж эхлэх, дусалж эхлэх; **~л дождь** бороо дусалж эхлэв.

ЗАБРЫ́ЗГИВАТЬ 1. үсэргэх, цацах; 2. үсэргэж эхлэх, дусалж эхлэх.

ЗАБУГО́РНЫЙ гадаадын, гадаадад үйлдвэрлэсэн.

ЗАБУЛДЫ́ГА танхай архичин.

ЗАБУЛДЫ́ЖНИК архичин баагий.

ЗАБУРЕ́ТЬ *разг.* томрох, хамартаа баас наасан мэт явах.

ЗАБУРЛИ́||ТЬ долгилж эхлэх; **~ло море** далай долгилж эхлэв.

ЗАБУХА́ТЬ бамбайх, бэлхийх, бэмбийх, дэвтэх.

ЗАБУ́ХНУТЬ бамбайх, бэлхийх, бэмбийх, дэвтэх; **бочка забухла** торх дэвтлээ.

ЗАБУШЕВА́||ТЬ шуугих, шуурах, бургилах; **ветер снова ~л** шуурга дахиад л шуурав.

ЗАБЫВА́ТЬ 1. мартах; **быстро ~** хурдан мартах; **~ о поручении** өгсөн даалгаварыг мартах; 2. орхих, болих, мартах; **забудь думать об этом** энэ тухай бодохоо боль.

ЗАБЫВА́ТЬСЯ 1. мартах, мартагдах; 2. зүүрмэглэх; 3. ухаан алдах, муужрах; 4. хэтрэх, биеэ барихгүй.

ЗАБЫ́ВЧИВОС||ТЬ мартамхай; **по ~ти** мартамхай учраас; **страдать ~тью** мартамхай болох.

ЗАБЫ́ВЧИВЫЙ мартамхай; **~ человек** мартамхай хүн.

ЗАБЫ́ТЫЙ мартагдсан, мартсан; **~ монголовед** мартагдсан монгол судлаач.

ЗАБЫ́ТЬ 1. мартах, мартагдах; **~ номер дома** байшингийн дугаарыг мартах; **~ книгу дома** номоо гэртээ мартах; 2. орхих, болих; **и думать забудь** санахаа ч боль.

ЗАБЫ́ТЬЁ 1. мэдээ алдах, ухаан алдах, манарч ойчих; **больной впал в ~** өвчтэй хүн ухаан алдав; 2. зүүрмэглэх.

ЗАБЫ́ТЬСЯ 1. мартагдах; 2. ухаан алдах, манарч унах; **больной забылся** өвчтэй хүн манарч унав; 3. үгширтэл бодох, санаашрах; **~ в мечтах** мөрөөдлөөр санаашрах; 4. зүүрмэглэх; 5. хэтрэх, дэндэх; **так забылся, что стал грубить старшим** тэгж дэндээд ахмад хүнийг аашлах болов.

ЗАВ *разг.* эрхлэгч.

ЗАВА́ЖНИЧАТЬ ихэрхэх, ихэрхэж эхлэх, биеэ тоох.

ЗАВА́Л саад, овоорсон юм, хунгар; **снежный ~** цасан хунгар; 2. *разг.* дээд зэргийн, онцгой юм.

ЗАВА́ЛЕННЫЙ дарагдсан; **~ работой** ажилд дарагдсан.

ЗАВАЛИ́ТЬ 1. бөглөх, дүүргэх; **~ яму песком** нүхийг элсээр бөглөх; 2. овоолох; **~ проход мешками** гудамд шуудай овоолох; 3. нураах; **~стену** туургыг нураах; 4. дарах; **~ двор мусором** хашааг хогоор дарах; **~ срочной работой** яаралтай ажлаар дарах, яаралтай ажилд дарагдах.

ЗАВА́ЛИТЬСЯ 1. цаагуур унах, завсраар *ойчих*; 2. хэвтэх; **~ спать** унтах гэж хэвтэх; 3. нурах; **стена завалилась** хана нурав.

ЗАВА́ЛИНКА байшингийн хаяавч, байшингийн хашаас.

ЗА́ВАЛЬ дарагдсан бараа, новш.

ЗАВАЛЯ́||ТЬСЯ 1. дарагдах; **письмо ~лось на почте** захидал шуудан дээр дарагдав; 2. гүйлгээгүй хэвтэх.

ЗАВА́РИВАТЬ 1. идээшүүлэх, хандлах, чанах, үйх; **~ чай** цай үйх, цай чанах; 2. хутгах, будлиан хутгах; **~ дело** хэрэг будлиантуулах; **~ кашу** бантан хутгах, холион бантан хийх.

ЗАВА́РК||А үйх идээших, чанах; **чаю осталось на одну ~у** нэг цай чанах үлджээ.

ЗАВАРНО́Й 1. юм чанах, чаналт; **~ котел** юм чанах тогоо; 2. халуун усаар зуурч хийсэн, зуурч хийсэн.

ЗАВЕДЕ́НИЕ газар, сургууль; **высшее учебное ~** дээд сургуулийн газар, дээд сургууль.

ЗАВЕ́ДОВАНИЕ эрхлэх, захирах; **~ хозяйством** аж ахуйг эрхлэх; **~ учреждением** албан газрыг захирах.

ЗАВЕ́ДОМО мэдсээр, мэдээжийн; **~ ложное показание** мэдээжийн худал өчиг.

ЗАВЕ́ДОМ||ЫЙ мэдээжийн, илт; **~ая ложь** мэдээжийн худал.

ЗАВЕ́ДУЮЩАЯ эрхлэгч эмэгтэй.

ЗАВЕ́ДУЮЩИЙ эрхлэгч; **~ хозяйством** аж ахуйн эрхлэгч.

ЗАВЕ́ДЫВАНИЕ, ЗАВЕ́ДЫВАТЬ эрхлэх, захирах; **~ финансами** санхүүг эрхлэх.

ЗАВЕСТИ́ 1. далимаар хүргэх; 2. аваачиж хүргэх.

ЗАВЕРБОВА́ТЬ элсүүлэх, татан оролцуулах.

ЗАВЕРЕ́НИЕ баталгаа; **давать ~** баталгаа өгөх.

ЗАВЕРИ́ТЕЛЬ баталгаа гаргагч, батлагч, баталгаа өгөгч.

ЗАВЕ́РИТЬ 1. батлах, батлан хэлэх; **~ в своей преданности** үнэнч байгаагаа батлан хэлэх; 2. батлах, үнэн гэж батлах; **~ подпись** гарын үсэг батлах; **~ копию** хуулбарыг үнэн гэж батлах.

ЗАВЕРНУ́ТЬ 1. боох, ороох, хуйлах; **~ книгу в бумагу** номыг цаасаар ороох, номыг цаасаар боох; 2. мушгих, эргүүлэх, эргэдэж хаах, хаах; **~ кран** цоргыг хаах; 3. шамлах, шуух; **~ рукава** ханцуй шамлах; 4. тойрох, тойроод далдрах **~ за угол** буланг тойроод далдрах; 5. ороод гарах, *далимд орох*; **~ к приятелю** найзындаа ороод гарах; 6. орох, болох; **~ ребенка в одеяло** хүүхэд манцуйлах, хүүхдийг хөнжилд ороох.

ЗАВЕРНУ́||ТЬСЯ 1. биеэ ороох, ороогдох; **~ в одеяло** хөнжлөөр биеэ ороох; 2. шамрах; **~лась пола шубы** дээлийн хормой шамрав.

ЗАВЕРТЕ́||ТЬ 1. эргүүлэх, эргэлдүүлэх, эргэлдүүлж эхлэх; **ямщик ~л кнутом** улаач ташуураа эргэлдүүлж эхлэв; 2. автагдах, толгойг эргүүлэх, аванхайлах.

ЗАВЕРТЕ́||ТЬСЯ 1. эргэлдэх, эргэлдэж эхлэх; **колесо ~лось** дугуй эргэлдэж эхлэв; 2. мунгинах; **~ с детьми** хүүхдүүдтэй мунгинах.

ЗАВЁРНУТЫЙ 1. ороолттой, ороосон, хуйлсан, бооллтой; 2. мушгисан; 3. шуусан шамласан.

ЗАВЁРТЫВАТЬ 1. боох, хуйлах, ороох; 2. мушгих, эргүүлэх, эргэдэж хаах, хаах; **~ гайку** эрэг мушгих; 3. Эргээд далдрах, эргээд явах; **автомобиль завернул направо** *машин* баруун тийш эргээд явав. 4. шамлах, шуух; 5. ороод гарах, далимаар орох.

ЗАВЁРТЫВАТЬСЯ 1. ороох, хучих; 2. ороогдох, хучигдах; 3. шамрах.

ЗАВЕРША́ТЬ төгсгөх, дуусгах, шувтлах; **~ начатое дело** эхэлсэн хэргийг дуусгах.

ЗАВЕРША́ТЬСЯ төгсөх, дуусах, шувтрах; **строительство завершилось** барилга дуусав.

ЗАВЕРШЕ́НИЕ төгсгөл, төгсөх,дуусгавар, дуусах.

ЗАВЕРЯ́ТЬ 1. батлах, батлан хэлэх; **~ в своей дружбе** найрамдалтайгаа батлах; 2. үнэн гэж батлах, баталгаа өгөх; **~ копию** хуулбар үнэн болохыг батлах.

ЗАВЕРЯ́ТЬСЯ батлагдах, итгэгдэх.

ЗАВЕ́СА хөшиг, халхавч; **дымовая ~** утаан хөшиг.

ЗАВЕ́СИТЬ 1. хөшиг татах; 2. өлгөх.

ЗАВЕСТИ́ 1. хүргэх, аваачих, авчрах; **~ детей в школу** хүүхдүүдийг сургульд хүргэх; **куда ты завел нас?** чи биднийг хаана авчрав? 2. оруулах, аваачиж оруулах; **~ в болото** намагт аваачиж оруулах; 3. -тай болох, **~ молочное хозяйство** сүүний аж ахуйтай болох; 4. эхлэх; **~ разговор** ярьж эхлэх; **~ знакомство** танилцаж эхлэх, танилтай болох; 5. түлхэх, **~ часы** цагаа түлхэх; 6. галлах, хөдөлгөх, явуулах; **~ мотор** мотор асаах.

ЗАВЕСТИ́СЬ 1. бий болох, -тай болох; **у него завелись друзья** түүнд найз нар бий болжээ; **завелись деньги** мөнгөтэй боллоо; 2. хөдлөх, явах; **часы не завелись** цаг явахгүй байв.

ЗАВЕ́Т гэрээс.

ЗАВЕ́ТН||ЫЙ нандин, ариун; **~ые мечты** нандин мөрөөдөл; **~ое кольцо** нандин бэлэг.

ЗАВЕ́ТРЕНН||ЫЙ салхигүй, нөмөр; **~ая сторона** салхигүй тал, нөмөр газар.

ЗАВЕ́ШАТЬ хөшиг татах, халхлах, дүүрэн өлгөх; **~ все стены картинами** бүх ханаараа дүүрэн зургуудыг өлгөх.

ЗАВЕЩА́НИЕ гэрээс; **делать ~** гэрээс хийх; **~ учителя своим ученикам** шавь нартаа өгсөн багшийн гэрээс.

ЗАВЕЩА́ТЕЛЬ гэрээслэгч.

ЗАВЕЩА́ТЕЛЬНЫЙ гэрээсийн.
ЗАВЕЩА́ТЬ гэрээслэх; ~ **имущество сыну** өв хөрөнгөө хүүдээ гэрээслэх;
ЗАВЗЯ́ТЫЙ шуналтай, хорхойтой, гаажтай; ~ **охотник** анд шуналтай хүн, хорхойтой анчин; ~ **сплетник** гаажтай ховч.
ЗАВИВА́ТЬ буржийлгах; ~ **волосы** үсээ буржийлгах.
ЗАВИВА́ТЬСЯ буржийлгах, үсээ буржийлгах, буржийх.
ЗАВИ́ВКА 1. буржгар болгох, буржийлгах; 2. буржгар үс, буржгар шанх.
ЗАВИ́ДН||ЫЙ атаархам, атаархмаар; **~ое здоровье** атаархмаар эрүүл бие.
ЗАВИ́ДОВАТЬ атаархах; **я завидую его успехом** би түүний амжилтанд атаархана.
ЗАВИЗИ́РОВАТЬ виз олгох, цохолт хийх.
ЗАВИНТИ́ТЬ шурагдах, эрэгдэх; ~ **гайку** эрэг эргэдэх.
ЗАВИРА́ТЬСЯ дэгсдүүлэх, ам хадуурах.
ЗАВИ́С||ЕТЬ болох, шалтгаалах; **все ~ит от этого** бүх юм үүнээс шалтгаална; **это от нас не ~ит** энэ биднээс шалтгаалахгүй.
ЗАВИ́СИМОСТ||Ь 1. харьяалагдал, хараат байдал, хамаарагдал; **колониальная** ~ колонийн харьяалагдал; 2. шалтгаалах, шүтэлцэх; харгалзах; **взаимная** ~ харилцан шалтгаалах, харилцан шүтэлцэх; **в ~и от обстоятельств** учир байдлаас шалгаалах; **в ~и от местных условий** орон нутгийн байдлаас шалтгаалан; 3. хамаарах чанар; хамаарагдах.
ЗАВИ́СИМ||ЫЙ харьяалагдлын, хараат, харьяалагдах, бие даасан бус; **~ое положение** харьяалагдлын байдал.
ЗАВИ́СТЛИВО атаархах, атаархан.
ЗАВИ́СТЛИВ||ЫЙ атаархаг, жөтөөрхөг; **~ые взгляды** атаархаг харц; ~ **человек** атаархуу хүн, жөтөөрхүү хүн.
ЗАВИ́СТНИК атаач, жөтөөч.
ЗАВИ́СТНИЦА атаач эмэгтэй, жөтөөрхүү хүүхэн.
ЗА́ВИСТЬ атаа, атаархах, атаархал, жөтөө; **возбуждать** ~ атаа хүргэх, атаархуулах; **смотреть с ~ью** атаархаж харах.
ЗАВИ́Т||ЫЙ буржгар, буржийлгасан; **~ые волосы** буржийлгасан үс.
ЗАВИТО́К буржгар, мушгиа, мушгимал, гөрлөө, сариу; ~ **волос** гөрлөө үс, мушгиа үс.
ЗАВИ́ТЬ буржийлгах, мушгих; ~ **волосы** үс буржийлгах.
ЗАВИ́ТЬСЯ буржгар болох, буржийлгуулах; ~ **у парикмахера** үсчнээр үсээ буржийлгуулах.
ЗАВЛАДЕ́ТЬ 1. эзлэх, эзлэн авах, эзэмдэх; ~ **чужим имуществом** бусдын юмыг эзлэн авах; 2. татах, булаах; ~ **чьим либо вниманием** хүний анхаарлыг татах.
ЗАВЛЕКА́ТЬ татаж оруулах, дур татах, өдөөх, өдөөж оруулах.
ЗАВО́Д I үйлдвэр; **кожевенный** ~ булигаарын үйлдвэр; **мыловаренный** ~ савангийн үйлдвэр; **конный** ~ морин завод.
ЗАВО́Д II түлхэх, түлхэц, мушгих; ~ **часов** цагийн түлхэц; **игрушка с ~ом** түлхэцтэй тоглоом.
ЗАВОДИ́ТЬ 1. хүргэх, авчрах, аваачих; **куда ты нас завёл?** чи биднийг хаана авчрав?; 2. оруулах, авчирч оруулах; ~ **в лес** ойд оруулах; 3. —тай болох, -тай болгох; ~ **привычку** зуршилтай болгох.~ **собаку** нохойтой болгох; 4. түлхэх, асаах, галлах; ~ **часы** цаг түлхэх; ~ **мотор** хөдөлгүүр асаах; 5. эхлэх, үүсгэх, өдөөх; ~ **разговор** яриа үүсгэх; ~ **ссору** хэрүүл маргаан өдөөх.
ЗАВОДИ́ТЬСЯ 1. бий болох, -тай болох; **завелись знакомые** танилуудтай болох, танилтай болох; 2. түлхэгдэх, асах.
ЗАВОДН||О́Й оньстой, баадуутай; **~ая игрушка** оньстой тоглоом.
ЗАВОДОУПРАВЛЕ́НИЕ үйлдвэрийн захиргаа.
ЗАВОДСК||О́Й үйлдвэрийн, үйлдвэрчний эвлэлийн; ~ **комитет** үйлдвэрчний эвлэлийн хороо; **~ое оборудование** үйлдвэрийн тоноглол.
ЗА́ВОДЬ усны булан тохой, татуур.
ЗАВОЕВА́НИЕ 1. эзлэн авах, байлдан дагуулах; ~ **власти** засгийн эрхийг байлдан авах; 2. ололт.
ЗАВОЕВА́ТЕЛЬ байлдан дагуулагч, байлдан эзлэгч.
ЗАВОЕВА́ТЬ 1. байлдан дагуулах, байлдан эзлэх, эзлэн авах; ~ **город** хотыг байлдан эзлэх; 2. олох, тэмцэж олох, хүлээх; ~ **авторитет** нэр хүндийг олох; ~ **свободу** эрх чөлөөг тэмцэж олох; ~ **доверие** итгэл олох.
ЗАВО́З хүргэх, аваачих, авчрах, зөөх; ~ **товаров** таваар зөөх.
ЗАВОЗИ́ТЬ, ЗАВЕСТИ́ 1. хүргэж өгөх, аваачиж өгөх; ~ **детей в школу** хүүхдүүдийг сургууль руу хүргэж өгөх; ~ **товар в магазин** бараг дэлгүүрт аваачиж өгөх; 2. бохир болгох, хиртэй болгох.
ЗАВОЗИ́||ТЬСЯ 1. хүргэгдэх, авчрагдах; 2. бий болох; **под полом мыши ~лись** шалан доор хулгана бий болжээ; 3. ноолдож эхлэх.
ЗАВОЛА́КИВАТЬ бүрхэх, дүүрэх.
ЗАВОЛО́||ЧЬ бүрхэх, дүүрэх; **небо ~кло тучами** тэнгэрийг үүл бүрхлээ; **глаза ~кло слезами** нүдийг нулимс бүрхлээ.
ЗАВОЛА́КИВАТЬСЯ бүрхэх, бүрхэгдэх; **небо заволоклось тучами** тэнгэр үүлээр бүрхэгдэв.
ЗАВОЛНОВА́||ТЬСЯ 1. долгилж эхлэх; **море ~лось** далай долгилж эхлэв; 2. сэтгэл хөдлөх, санаа зовних.
ЗАВОПИ́ТЬ хашгирах, орилох, чарлах.
ЗАВОРА́ЖИВАТЬ дур булаах, сэтгэл татах.
ЗАВОРА́ЧИВАТЬ 1. ороох, боох хуйлах; ~ **пакет в бумагу** боодолтой юмыг цаасаар ороох; 2. мушгих, эргүүлэх, эргэдэж хаах, хаах; ~ **кран** цоргыг хаах; 3. шамлах, шуух; **~рукава** ханцуй шамлах; 4. тойрох, тойроод далдрах, эргэх; ~ **за угол** буланг тойрох; 5. ороод гарах, далимд орох; 6. орох, болох.
ЗАВОРА́ЧИВАТЬСЯ 1. биеэ ороох, ороогдох; 2. шамрах.
ЗАВОРКОВА́||ТЬ хүхтнэх, хүхтнэлдэх, гунганах; **голуби ~ли** тагтаанууд хүхтнэлдэв.
ЗАВОРОЖИ́ТЬ дур булаах, сэтгэл татах.
ЗА́ВОРОТ 1. мушгирах, эвхрэх, зангирах; ~ **кишок** гэдэс зангирах; 2. соронзон.
ЗАВОРО́ЧАТЬСЯ эргэлдэх, эргэлдэж эхлэх; эргэх.
ЗАВРА́ТЬСЯ худлаа ярих, худлаа шаах.
ЗАВСЕГДА́ТАЙ үргэлж явах хүн, байнга очдог хүн; **театральный** ~ театрт үргэлж очдог хүн.
ЗА́ВТРА маргааш, маргаадар; ~ **утром** маргааш өглөө; ~ **вечером** маргааш орой; **до** ~ маргааш хүртэл.
ЗА́ВТРАК өглөөний хоол, өглөөний унд, өглөөний зоог; **лёгкий** ~ өглөөний хөнгөн хоол.
ЗА́ВТРАКАТЬ өглөөний зоог барих, өглөө хооллох.
ЗА́ВТРАШН||ИЙ маргаашийн; ~ **день** маргааш өдөр; **не думать о ~ем дне** маргаашийн өдрийг бодохгүй байх.
ЗАВУАЛИ́РОВАТЬ бүрхэгдүүлэх, балартуулах, далдлах.
ЗА́ВУЧ хичээлийн эрхлэгч.
ЗАВХО́З аж ахуйн эрхлэгч.
ЗАВЫВА́НИЕ улих, сүнгэнэх, шуугих, сүүгэх; ~ **бури** шуурга сүнгэнэх.
ЗАВЫВА́ТЬ улих, сүүгэх, сүнгэнэх, сүүгэх.
ЗАВЫСИ́ТЬ хэтрүүлэх, дээгүүрдүүлэх; ~ **расценки** үнийг хэтрүүлэх; ~ **отметку на экзамене** шалгалт дээр үнэлгээг дээгүүрдүүлэх.
ЗАВЫ||ТЬ 1. улих; **~ла собака** нохой улив; 2. сүнгэнэх, сүүгэх, шуурах; **~л ветер** салхи сүнгэнэв.

ЗАВЫШЕ́НИЕ дээгүүрдүүлэх, хэтрүүлэх.
ЗАВЯ́ДШИЙ гандсан; ~ **цветок** гандсан цэцэг.
ЗАВЯЗА́ТЬ 1. уях, зангилах, боох; ~ **узел** зангилаа уях; ~ **галстук** зангиа зангидах.2. тогтоох, болох, үүсгэх, эхлэх; ~ **отношения** харилцаа тогтоох; ~ **дружбу** найрамдалтай болох; ~ **беседу** яриа үүсгэх; ~ **бой** тулалдаж эхлэх; ~ **знакомство** танилцаж эхлэх.
ЗАВЯ́ЗНУТЬ 1. шавардах, шигдэх; ~ **в болоте** намагт *шигдэх*; 2. баригдах, бэрхшээлд орох; ~ **в долгах** өрөнд баригдах.
ЗАВЯЗА́||ТЬСЯ 1. уягдах, зангирах, зангилагдах, боогдох; **галстук плохо ~лся** зангиа тааруухан зангилагджээ; 2. эхлэх, үүсэх; 3. боловсрох, бойжих, бий болох; **плод ~лся** үр боловсров.
ЗАВЯ́ЗКА 1. уяа, бүч, зангилаа; 2. эх үүсвэр, эхлэлт, ~ **драмы** жүжгийн эхлэлт.
ЗА́ВЯЗЬ үрэвч, цэцгийн товчирхой.
ЗАВЯ́ЛЫЙ хатсан, гандсан.
ЗАВЯ́НУТЬ хатах, гандах, хагдрах.
ЗАГАДА́ТЬ 1. таах, тааварлах; ~ **загадку** оньсого таах; ~ **число** тоо таах; 2. мэргэлэх; ~ **на картах** хөрөөр мэргэлэх.
ЗАГА́ДИТЬ буртаглах, бохиртуулах.
ЗАГА́ДК||А оньсого, таавар; **отгадать ~у** оньсого таах.
ЗАГА́ДОЧНОСТЬ жигтэй, хачин, битүүлэг.
ЗАГА́ДОЧН||ЫЙ жигтэй, хачин, битүүлэг; **~ое явление** хачин үзэгдэл.
ЗАГА́ДЫВАТЬ таах, тааварлах.
ЗАГА́ЖИВАТЬ буртаглах, бохиртуулах.
ЗАГА́Р наранд түлэгдэх.
ЗАГАСИ́ТЬ бүхээх, унтраах; ~ **костёр** түүдэг унтраах.
ЗАГА́СНУТЬ унтраах, бүхэх.
ЗАГВО́ЗДКА саад, төвөг, оньс; **вот в чём ~** оньс нь энд байжээ.
ЗАГИ́Б нугалаа; ~ **листа** хуудасны нугалаа; **левый ~** зүүний нугалаа.
ЗАГИБА́ТЬ нугалах; ~ **страницу** хуудас нугалах.
ЗАГИБА́ТЬСЯ нугарах; **страница загнулась** хуудас нугарчээ; ~ **вверх** эзтийх.
ЗАГИПНОТИЗИ́РОВАТЬ ховслох, ховсдох.
ЗАГЛА́ВИЕ гарчиг, зохиолын нэр; ~ **книги** номын гарчиг.
ЗАГЛА́ВН||ЫЙ эхний, гарчгийн; **~ая буква** эхний үсэг, том үсэг.
ЗАГЛА́ДИТЬ 1. илүүрдэх, индүүдэх, толийлгох; ~ **складки утюгом** индүүгээр үрчлээг толийлгох; 2. засах, цагаатгах, наминчлах; ~ **вину** гэмээ засах.
ЗАГЛА́ЖИВАТЬ 1. илүүрдэх, индүүдэх, толийлгох; ~ **складки утюгом** индүүгээр үрчлээг толийлгох; 2. засах, цагаатгах, наминчлах; ~ **вину** гэмээ засах.
ЗАГЛАЗА́ 1. далдуур, эчнээр, үзэлгүй; **купить что-нибудь ~** юмыг үзэлгүйгээр авах; **ругать ~** далдуур хараах; 2. бардаагаар, элбэг; **этого ~ достаточно** энэ бардаагаар хүрэлцэнэ.
ЗАГЛО́Х||НУТЬ 1. намхрах, унтрах; **звуки ~ли** чимээ намхрав; 2. Балрах, харах, хувхайрах; **сад заглох** цэцэрлэг хувхайрлаа.
ЗАГЛУША́||ТЬ дарах; **сорные травы ~ют овёс** *шарилж овьёосыг* дарж байна; 2. дарах, намдуулах; **оркестр заглушил голос певца** найрал хөгжим дуучийн дууг дарж байна.
ЗАГЛУША́ТЬСЯ чимээ дарагдах, дуу намсах.
ЗАГЛЯДЕ́НЬЕ хараад л баймаар, хараад ханашгүй; **эти ребятишки прямо ~!** Хараад л баймаар хүүхдүүд байна!; **конь — одно ~** харж ханашгүй адуу байна.
ЗАГЛЯДЕ́ТЬСЯ, ЗАГЛЯ́ДЫВАТЬСЯ ширтэх, ширтэж харах; ~ **на ветрину магазина** дэлгүүрийн цонхны үзмэрийг ширтэж харах.
ЗАГЛЯ́ДЫВАТЬ, ЗАГЛЯНУ́ТЬ шагайх; ~ **в окно** цонхоор шагайх; ~ **в дверь** хаалгаар шагайх; 2. сөхөх, сөхөж үзэх; ~ **в книгу** номоо шагайж харах; 3. ороод гарах; ~ **к приятелю** найзындаа ороод гарах; ~ **вперёд** урагшаа харах.
ЗАГНА́ИВАТЬСЯ ялзрах, бээх.
ЗАГНА́ТЬ, ЗАГОНЯ́ТЬ 1. тууж оруулах, хөөж оруулах; ~ **скот во двор** мал хашаанд хөөж оруулах; 2. цохиж оруулах, өшиглөж оруулах; ~ **мяч в ворота** бөмбөгийг хаалгаар өшиглөж оруулах; 3. шаах; **глубоко ~ гвоздь в доску** банзанд хадаас гүнзгий шаах; 4. зүдрээх, эцээх, сульдуулах; ~ **лошадь** морь эцээх.
ЗАГНИВА́НИЕ ялзрал, өмхрөх, үжих.
ЗАГНИВА́ТЬ ялзрах, өмхрөх, үжих.
ЗАГНИ́||ТЬ ялзрах, өмхрөх, үжих; **капуста ~ла** байцаа ялзрав; **рыба ~вает с головы** загас толгойноосоо ялзардаг.
ЗАГНОЙ||ТЬСЯ 1. ялзрах, үжих, идээлэх, өмхрөх; **рана ~лась** *шарх идээлэв*; 2. нуухдах; **в глазах ~лось** нүд нуухдах.
ЗАГНУ́ТЬ нугалах, дарах; ~ **страницу** хуудас нугалах; ~ **палец** хуруу дарах; хуруу нугалах.
ЗАГНУ́||ТЬСЯ нугарах, шамрах; **угол страницы ~лся** хуудасны сэжүүр нугарлаа.
ЗАГОВА́РИВАТЬ ярьж эхлэх, үг хэлж эхлэх.
ЗАГОВОРИ́||ТЬ, 1. ярьж эхлэх, үг хэлж эхлэх, хэлд орох; **ребёнок скоро ~т** хүүхэд *удахгүй хэлд орно*; **все ~ли сразу** бүгд зэрэг ярьж эхлэв; 2. үгээр соготоох, дүүртэл ярих; ~ **собеседника** ярилцаж байгаа хүнийг үгээр соготоох; ~ **зубы** үгээр дүйрүүлэх; 3. гэмшиж эхлэх; **в нём ~ла совесть** тэр хүн гэмшиж эхлэв.
ЗАГОВА́РИВАТЬСЯ 1. донгосох, дэмийрэх; 2. далан хэлээ дэлгэх, үгэндээ соготох.
ЗА́ГОВОР 1. хуйвалдаан; **раскрыть ~** хуйвалдааныг илрүүлэх; 2. шившлэг; ~ **от болезни** өвчинд шившлэг хийх.
ЗАГОВОРИ́||ТЬСЯ далан хэлээ дэлгэх, үгэндээ соготох; **он ~лся и забыл, что пора домой** тэр хүн үгэндээ соготоод харихаа мартжээ.
ЗАГОВО́РЩИК хуйвалдагч.
ЗАГОВО́РЩИЦКИЙ хуйвалдааны, хуйвалдагчийн.
ЗАГОЛО́ВОК гарчиг, нэр; ~ **книги** номын нэр.
ЗАГО́Н 1. малын хашаа; 2. хөөлт, туулт; **быть в ~е** гадуурхагдах, шоовдорлогдох.
ЗАГО́НЩИК туугч.
ЗАГОРА́ЖИВАТЬ 1. хашаа барих; шивээлэх, хороолох; 2. хаах, боох, халхлах; ~ **дорогу** зам хаах.
ЗАГОРА́ЖИВАТЬСЯ 1. хашигдах, хаагдах; 2. халхлагдах, халхлах.
ЗАГОРА́ТЬ, ЗАГОРЕ́ТЬ түлэгдэх борлох, гандах; ~ **на солнце** наранд бордох.
ЗАГОРА́||ТЬСЯ, ЗАГОРЕ́ТЬСЯ 1. асах, ноцох; **лампы ~ются** дэн асаж байна; 2. шатах; **здание ~ется** байшин шатаж байна; 3. гялалзах, гялбалзах; **глаза загорелись радостью** баярлан нүд нь гялалзав. 4. их хүсэх; **загорелось ему ехать** явахсан гэж их хүсдэг байв; 5. үүсэх гэрэх; **загорелся спор** маргаан гарав.
ЗАГОРДИ́ТЬСЯ ихэрхэх, их зантай болох.
ЗАГОРЕ́ЛЫЙ наранд *борлох, наранд борлосон*.
ЗАГОРОДИ́ТЬ 1. хашаа барих, шивээлэх, хороолох; ~ **двор забором** гэрийн гадуур хашаа барих; 2. хаах, боох, халхлах; ~ **свет** гэрэл халхлах, ~ **кому-либо дорогу** хүний зам хаах.
ЗАГОРОДИ́ТЬСЯ 1. хашигдах, хаагдах; 2. халхлах, халхлагдах; ~ **рукой от солнца** гараар нарыг халхлах.
ЗАГОРО́ДКА хашаа, шивээ, шөрөг.
ЗА́ГОРОДН||ЫЙ хотын гаднах, хотын захын; ~ **рабочий поселок** ажилчны хотын гаднах гацаа; **~ая прогулка** хотын гаднах зугаалга.

ЗАГОСТИ́ТЬСЯ удаан айлчлах, айлчилсаар байх.
ЗАГОТОВИ́ТЕЛЬ бэлтгэгч.
ЗАГОТОВИ́ТЕЛЬН||ЫЙ бэлтгэх, бэлтгэлийн; ~ **пункт** бэлтгэх газар; **~ая цена** бэлтгэл үнэ.
ЗАГОТО́ВИТЬ бэлтгэх, зэхэх; ~ **справки** лавлах бичиг бэлтгэх; ~ **дров на зиму** өвлийн түлээ бэлтгэх.
ЗАГОТОВЛЯ́ТЬ бэлтгэх, зэхэх; ~ **справки** лавлах бичиг бэлтгэх; ~ **дров на зиму** өвлийн түлээ бэлтгэх; **мы заготовим для отъезда** мордоход хэрэгтэй бүх зүйлийг бид бэлдэнэ.
ЗАГОТО́ВКА 1. бэлтгэл; ~ **шерсти** ноос бэлтгэл; 2. зэхсэн, хагас бүтээгдэхүүн.
ЗАГОТОВЛЯ́ТЬСЯ бэлтгэгдэх.
ЗАГОТПУ́НКТ бэлтгэх газар, бэлтгэлийн газар.
ЗАГРАДИ́ТЕЛЬНЫЙ хаах, хориглох, шөргөн; ~ **огонь** шөргөн гал.
ЗАГРАДИ́ТЬ, ЗАГРАЖДА́ТЬ хаах, хориглох; ~ **путь** зам хаах.
ЗАГРАЖДЕ́НИЕ хаалт, хориг, саад; **проволочное** ~ торон хаалт.
ЗАГРАНИ́Ц||А гадаад, гадаад улс, хилийн гадна; **торговля с ~ей** гадаад улстай хийх худалдаа.
ЗАГРАНИ́ЧНЫЙ гадаадын, гадаад, хилийн гаднах; ~ **паспорт** гадаадын паспорт, гадаад явах паспорт; ~ **товар** гадаад бараа.
ЗАГРЕБА́ТЬ 1. хамах, хураах, тармах; ~ **сено** өвс тармах; **сосчитав деньги, продавец загреб их рукой с прилавка** мөнгөө тоолоод худалдагч түүнийг лангуун дээрээс гараар хамж авав; 2. сэлэх, сэлбүүрдэх; ~ **веслом** сэлүүрээр сэлэх; ***чужими руками жар** ~ хүний гараар могой барих.
ЗАГРЕМЕ́||ТЬ 1. дуугарах, нижигнэх, нажигнуулах; хангинуулах; **гром ~л** тэнгэр дуугарав; ~ **посудой** сав суулгаа хангинуулах; 2. унах, хэрэгт орох; ~ **под фанфары** будлиант хэрэгт ороолдох.
ЗАГРЕСТИ́ 1. цуглуулж авах, хамж авах, тармах; ~ **деньги со стола** ширээн дээрээс мөнгийг цуглуулж авах; 2. сэлэх, сэлүүрдэх; 3. (*разг.*) хүрч ирэх; **загребай к нам** манайд гялс хүрээд ир.
ЗАГРИ́ВОК 1. шилэн хүзүү; 2. онгон дэл, мундааны дэл, хур дэл; **векакивая на лощадь, схватиться за** ~ моринд харайж мордоод хур дэлнээс шүүрэн барих.
ЗАГРИМИРОВА́ТЬ нүүр будах..
ЗАГРИМИРОВА́ТЬСЯ нүүр будах.
ЗАГРО́БН||ЫЙ хойт төрлийн, хойт насны; **~ая жизнь** хойт нас.
ЗАГРОМОЖДА́ТЬ овоорох, овоолох, дүүргэх.
ЗАГРОМОЗДИ́ТЬ овоорох, овоолох, дүүргэх; ~ **выход вещами** гудамд юм овоолох; ~ **рассказ подробностями** өгүүллэгийг нуршаа үгээр дүүргэх.
ЗАГРОМОЖДЕ́НИЕ овоолол, овоорол, дүүргэх.
ЗАГРОХОТА́ТЬ нижигнэх; **загрохотал гром** аянга нижигнэв.
ЗАГРУБЕ́Л||ЫЙ хатуурсан, бархайсан; **~ая кожа** хатуурсан арьс; **~ые руки** бархайсан гар.
ЗАГРУБЕ́ТЬ хатуурах, бархайх.
ЗАГРУЖА́ТЬ тээх, ачих.
ЗАГРУЗИ́ТЬ 1. тээх, ачих; 2. дүүртэл хийх, багтахуйц ачих; ~ **все подвалы картошкой** бүх зоорийг дүүртэл төмс хийх; 3. дүүрэн ажиллуулах, ажил давхцуулах; ~ **рабочий день** ажлын өдөр дүүрэн ажиллуулах; ~ **преподавателей** багш нарыг дүүрэн ажиллуулах; 4. нээнтэглэх.
ЗАГРУ́ЖЕНОСТЬ дүүрэн ажилтай байх.
ЗАГРУЖЁННО́СТЬ 1. дүүрэн ажилтай байх, чөлөөгүй байх; ~ **железных дорог** төмөр зам дүүрэн ажилтай байх; 2. давхцах, дарагдах; ~ **работой** ажил давхцах, ажилд дарагдах.
ЗАГРУ́ЗК||А 1. дүүрэн хийх, тасралтгүй хангах; ~ **руды в плавильную печь** хайлуулах зууханд хүдрийг дүүрэн хийх; хайлуулах зуухыг хүдрээр хангах; 2. бүрэн хангах, бүрэн хангагдах, гүйцэд ашиглах; **завод имеет полную ~у** завод ажлаар бүрэн хангагдаж байна.
ЗАГРУСТИ́ТЬ гуних, гуниглах, уйтгарлаж эхлэх.
ЗАГРЫЗА́ТЬ барих, барьж идэх.
ЗАГРЫЗ||ТЬ 1. барих, барьж идэх; **кошка ~ла мышь** муур оготныг барьж идэв; 2. мэрэх, химлэх; 3. автагдах, дарагдах; **тоска ~ла** уйтгарт дарагдав.
ЗАГРЯЗНЕ́НИЕ бохир болгох, хир оруулах, буртаг болох, буртаглах; ~ **раны** шарханд хир оруулах.
ЗАГРЯЗНИ́ТЬ, ЗАГРЯЗНЯ́ТЬ бохир болгох, хир болгох, халтартуулах; ~ **помещение** байрыг бохир болгох.
ЗАГРЯЗНИ́ТЬСЯ, ЗАГРЯЗНЯ́ТЬСЯ бохир болох, хир болох, хиртэх, халтартах.
ЗАГС (отдел записей актов гражданского состояния) иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх товчоо.
ЗАГУБИ́ТЬ 1. үрэх, сүйтгэх; 2. амь бусниулах, үгүй хийх.
ЗАГУДЕ́||ТЬ дуугарч эхлэх, дүнгэнэж эхлэх, хангинаж эхлэх; **гудок на заводе ~л** заводын яндан дуугарч эхлэв; **колокола ~ли** хонх хангинаж эхлэв.
ЗАГУЛЯ́ТЬ наргиж зугаацуулах, халамцаж наргих.
ЗАГУСТЕ́ТЬ өтгөрөх.
ЗАД 1. ар, ар тал; ~ **автомобиля** машины ар тал; 2. бөгс, хондлой
ЗАДА́БРИВАТЬ аргадах.
ЗАДА́БРИВАНИЕ аргадал.
ЗАДАВА́ТЬ, ЗАДА́ТЬ 1. даалгах, даалгавар өгөх; ~ **работу** ажил даалгах; ~ **урок** хичээлийн даалгавар өгөх; 2. тавих; ~ **вопрос** асуулт тавих; 3. өгөх; ~ **лошади овса** моринд овьёос өгөх; 4. хийх, зохиох; ~ **бал** бүжигт үдэшлэг хийх; 5. удах, татах, гаргах; ~ **хлопот** төвөг удах.
ЗАДАВА́ТЬСЯ тавих; ~ **целью изучать языки** хэл сурах зорилго тавих.
ЗАДАВИ́||ТЬ 1. няц дарах, дарж алах; **трамвай ~л собаку** гудамжны галт тэрэг нохойг няц дарав; 2. багалзуурдаж алах, барьчихах; **собака ~ла лисицу** нохой үнэгийг барьчихав.
КРУЖКОВ||О́Й дугуйлангийн, бүлгэмийн; **~ые занятия** дугуйлангийн хичээл.

КРУ́ЖНЫЙ ~ путь тойруу зам.

КРУЖО́К 1. бяцхан цагариг, гархи, бинт; 2. дугуйлан, бүлгэм.

КРУП 1. сахуулай; 2. морины ууц, хондлой.

КРУПА́ 1. будаа, хэмхдэг амуу; **манная ~** буудайн амуу, хүүхдийн будаа; **гречневая ~** сагагийн хэмхдэг амуу; **ячменевая ~** арвайн амуу; 2. туйлдас.

КРУПИ́НКА үртэс, өөдөс.

КРУПИ́ТЧАТ||ЫЙ ~ая мука нарийн гурил.

КРУПИ́ЦА өөдөс, өчүүхэн юм.

КРУ́ПКА *бот.* хамбил.

КРУ́ПНО том томоор; **писать ~** том бичих.

КРУПНОКАЛИ́БЕРНЫЙ калибр, их урт, калибрын, том амтай.

КРУ́ПН||ЫЙ 1. бүдүүн, том, малигар, бод; **~ые черты** лица малигар нүүр; **~ скот** бод мал; 2. мантгар, тэнтгэр; **~ ребёнок** мантгар хүүхэд; 3. их том; **~ успех** их амжилт.

КРУПНЯ́К *разг.* их хэмжээ, их тоо, бөөн.

КРУПО́ЗН||ЫЙ сахуулайт; **~ое воспаление лёгких** уушигны сахуулайт үрэвсэл.

КРУПОРУ́ШКА будааны машин.

КРУПЧА́ТКА *нарийн гурил.*

КРУТИЗНА́ 1. эгц, огцом; **~ берега** эгц эрэг; 2. эрэг, хясаа; 3. овгордуу.

КРУТИ́ТЬ 1. эргүүлэх, орчуулах; 2. томох, эрчлэх; 3. ороох; **~ папиросу** тамхи ороох; 4. мушгих, имрэх; **~ усы** сахлаа

имрэх; 5. хуйлруулах, бужигнуулах; **ветер крутит пыль по дороге** салхи замын тоос хуйлруулна; 6. мушгин хүлэх, эргүүлэн хүлэх.

КРУТИ́ТЬСЯ 1. мушгиралдах, эргэлдэх; 2. маш идэвхтэй амьдрах, ажиллах.

КРУ́ТО 1. эгц, огцом; **дорога ~ поднималась в гору** зам уул өөд эгц гарав; 2. эрс, огцом; **лошадь ~ повернула вправо** морь буруу тийш огцом эргэв; 3. ширүүн, хатуу; **~ расправиться с кем-либо** хүнийг хатуу гэсгээн цээрлүүлэх; 4. хатуу, өтгөн; **~ замесить тесто** гурил хатуу зуурах; **~ посолить** шорвог болгох.

КРУТ||О́Й 1. эгц, огцом, цавчим; **~ берег** огцом эрэг; 2. эрс, огцом; **~ поворот дороги** зам огцом эргэх; 3. ширүүн, огцом, хатуу; **~ нрав** огцом зан; **~ые меры** хатуу арга хэмжээ; 4. хатуу, өтгөн, аргуун; **крутое тесто** хатуу зуурсан гурил; 5. атаман, овгор; * **~ кипяток** буцалмай халуун ус; **~ прикид** *разг.* маш гоё хувцастай, ганган.

КРУ́ЧА хясаа, огцом эрэг, эгц ганга.

КРУЧЁНИЕ мушгих, томох, эрчлэх.

КРУЧЁНЫЙ томсон, эрчилсэн.

КРУЧИ́НА гуниг, уйтгар.

КРУЧИ́НИТЬСЯ гуниглах, уйтгарлах.

КРУШЕ́НИЕ 1. сүйдэх, сүйрэх, сүйдэл, сүйрэл; **потерпеть ~** сүйдэх, сүйрэх; 2. тасрах, сөнөх; **~ надежд** горьдлого тасрах.

КРУШИ́ТЬ хэмхлэх, хэмх хамх цохих.

КРЫЖО́ВНИК морин хад, тошлой.

КРЫЛА́Т||ЫЙ жигүүртэй, далавчтай; * **~ые слова** мэргэн үг.

КРЫЛО́ 1. далавч, жигүүр; 2. далавч, далбаа; **~ самолёта** онгоцны далавч; **~ автомашины** автомашины далбаа; 3. жигүүр, гуя; **левое ~ дома** байшингийн зүүн жигүүр; 4. жигүүр.

КРЫ́ЛЫШКО бяцхан далавч, жигүүр.

КРЫЛЬЦО́ үүдэн шат.

КРЫ́НКА ваар сав.

КРЫ́СА 1. үхэр хулгана, харх; 2. ааш муутай эмэгтэй.

КРЫСЁНОК үхэр хулганын зулзага.

КРЫСИ́Н||ЫЙ үхэр хулганын; **~ая нора** үхэр хулганын нүх.

КРЫСОЛО́ВКА занга.

КРЫ́ТАЯ *разг.* шорон, хорих газар.

КРЫ́Т||ЫЙ 1. хучлагатай, хучаастай, бүрхээстэй; 2. саравчтай, дээвэртэй; **~ая повозка** мухлаг тэрэг.

КРЫТЬ 1. хучих, бүрэх, дээвэрлэх; **~ крышу железом** төмрөөр дээвэрлэх; 2. дарах, идэх; **~ матом** сүрхий загнах.

КРЫ́ТЬСЯ орших; **причина этого кроется в том, что** үүний шалтгаан.... - нд оршино.

КРЫ́Ш||А 1. дээвэр; 2. арын хаалга, ивээл, хамгаалалт; * **жить под одной ~ей** нэг гэрт суух; 3. *разг.* **у тебя поехала ~** чи солиорчээ.

КРЫ́ШКА таг, хавхаг.

КРЮК 1. гох дэгээ; 2. хажуунаас цохих.

КРЮЧКОВА́ТЫЙ махир дэгээ шиг, гох шиг; **~ нос** дэгээ хамар.

КРЮЧКОТВО́Р элдэв ов гаргагч.

КРЮЧКОТВО́РСТВО элдэв ов гаргах.

КРЮЧО́К дэгээ, чагт; **~ у одежды** хувцасны дэгээ.

КРЯ́ДУ дараалаад, турш, тасралтгүй; **десять дней ~ шёл дождь** арван өдөр тасралтгүй бороо оров.

КРЯЖ гүдэн, гүвээ.

КРЯ́ЖИСТЫЙ чийрэг, бадриун, яс томтой.

КРЯ́КАНЬЕ нугас шувууны дуу, гангар гунгар гэх, ганганах.

КРЯ́КАТЬ нугас шувуу дугарах, гангар гунгар гэх, ганганах.

КРЯ́КВА цоно нугас.

КРЯ́КНУТЬ 1. нугас шувуу нэгэнтээ дугарах; 2. *разг.* дуу алдах.

КРЯХТЕ́ТЬ янцаглах, аахилах.

КСЕ́РИТЬ хувилж авах, канондох.

КСЕРОКОПИ́РОВАТЬ канондох, хувилах.

КСЕРОКО́ПИЯ канон, олшруулалт.

КСИ́ВА *разг.* баримт бичиг үнэмлэх.

КСТА́ТИ 1. цагий нь олж; **сказать что-либо ~** цагий нь олж юм хэлэх; 2. далимд нь, дашрамд нь; **~ зайти и за книгами** далимд нь ном авахаар орох; 3. харин, үгүй, ингэхэд; **а я, ~ сказать, этого и не знал** харин би үүнийг чинь мэдээгүй.

КТО 1. хэн; **~ там?** хэн бэ? 2. хэн, хүн, хэн.... хүн; **всякий, ~ может** чадах хүн бүр; 3. зарим; 4. хүн; **если ~ придёт, скажи** хүн ирвэл хэл; **~ бы ни** хэн ч гэсэн.

КТО́-ЛИБО хэн хүн, ямар нэгэн хүн, хүн.

КТО́-НИБУДЬ хэн хүн, хэн нэгэн хүн, хүн.

КТО́-ТО нэг хүн; **~ заходил к вам** танайд нэг хүн ороод гарсан.

КУБ 1. шоо дөрвөлжин, куб; 2. куб, гүүп; **~ дров** гүүп түлээ; 3. тогоо; **перегонный ~** нэрэх тогоо.

КУБА́НКА 1. кубан малгай; 2. кубан буудай.

КУ́БАРЕМ өнхрөн; **скатиться с горы ~** уул уруу өнхрөн унах.

КУБАТУ́РА кубатур, шоо дөрвөлжин хэмжээ.

КУ́БИК *разг.* шоо

КУБИ́ЧЕСКИЙ куб, шоо дөрвөлжин метр, куб метр, шоо дөрвөлжин метр.

КУ́БОВЫЙ хөв хөх; **~ цвет** хөв хөх өнгө.

КУ́БОК цом; **~ вина** цом дарс; **переходящий ~** шилжин явах цом.

КУБОМЕ́ТР кубметр, шоо дөрвөлжин метр.

КУ́БРИК галт онгоцны командын байр.

КУБЫ́ШК||А мөнгөний бутан; **набивать ~у** авдар саваа мөнгөөр дүүргэх.

КУВА́ЛДА лантуу.

КУВШИ́Н домбо.

КУВШИ́НКА удвал цэцэг.

КУВЫРКА́НИЕ тонгорцоглох.

КУВЫРКА́ТЬСЯ тонгорцоглох, хөрвөх.

КУВЫРКНУ́ТЬСЯ тонгорцоглох, хөрвөх.

КУВЫРКО́М тонгорцоглон; **полететь ~** тонгорцоглон унах.

КУДА́ 1. хаана, хааш; **~ вы меня ведёте?** та хааш нь намайг аваачиж байна вэ? 2. ийш тийш юманд; **~ бы ни** хааш ч; **~ ни кинь** хаашаа ч харсан.

КУДА́-ЛИБО нэг газар, нэгтээ.

КУДА́-НИБУДЬ нэг газар, нэгтээ, нэг тийшээ.

КУДА́-ТО нэгтээ, хаашаа ч.

КУДА́ХТАНЬЕ эм тахиа дугарах.

КУДА́ХТАТЬ эм тахиа дугарах.

КУДЕ́СНИК бөө, увьдистан.

КУДЛА́ТЫЙ сэгсгэр үстэй.

КУ́ДРИ буржгар үс.

КУДРЯ́В||ЫЙ 1. буржгар үстэй; 2. саглагар; **~ые листья** саглагар навч.

КУЗИ́НА 1. үеэл эгч, дүү; 2. нууц амраг.

КУЗИ́НИЯ *бот.* арзгана.

КУЗНЕ́Ц төмрийн дархан, төмөрч, балтач.

КУЗНЕ́ЧИК дэвхрэг.

КУЗНЕ́ЧНЫЙ төмөрчний, төмрийн дархны.

КУ́ЗНИЦА төмрийн дархны газар, төмөрчний газар.

КУ́ЗОВ I тэвш, хашлага.

КУ́ЗОВ II саг, гөрмөл сав.

КУКАРЕ́КАТЬ тахиа донгодох.

КУ́КИШ 1. салаавч; **показать кому-либо ~** салаавч тавих; 2. амбан явахгүй.

КУ́КЛА 1. хүүхэлдэй, наадгай; 2. хүүхэн; 3. *разг.* мөнгө шиг боосон хоосон цаас.
КУКОВА́ТЬ хөхөө донгодох, гүг гүүг гэх.
КУ́КОЛКА I бяцхан хүүхэлдэй.
КУ́КОЛКА II авгалдай.
КУ́КОЛЬНЫЙ хүүхэлдэйн; ~ **театр** хүүхэлдэйн театр.
КУ́КСИТЬСЯ ярдаглах, уурлах, шантрах.
КУ-КУ́ гүг гүү.
КУКУРУ́ЗА 1. эрдэнэ шиш; 2. *разг.* эр эрхтэн.
КУКУРУ́ЗНЫЙ эрдэнэ шишийн.
КУКУ́ШКА 1. хөхөө; 2. хүүхдээ хүнд өргүүлсэн эх.
КУЛА́К I нударга, зангидсан гар.
КУЛА́К II нударган *(баян).*
КУЛА́ЦК||ИЙ нударганы, нударган баяны; **~ое хозяйство** нударганы аж ахуй.
КУЛА́ЧЕСТВО нударган баячууд.
КУЛАЧК||Й на ~, на ~ах нударгаараа.
КУЛА́ЧНЫЙ ~ бой нударгаар зодолдох.
КУЛЕБЯ́КА гонзгой бялуу *(дотор нь мах, загас зэргийг хийсэн бялуу).*
КУЛЁК хүүдий, шуудай.
КУЛИ́БИН зохион бүтээгч, санаачлагч.
КУЛИ́К цууцаль; ***всякий ~ своё болото хвалит** хүн бүхэн нутгаа магтдаг.
КУЛИНА́РИЯ тогоочийн мэргэжил.
КУЛИНА́РН||ЫЙ тогоочийн; **~ые курсы** тогоочийн түр сургууль.
КУЛИ́С||А халхавч; ***за ~ами** 1)тайзны ард, тайзны халхавчийн цаана 2)далдуур, нууцаар.
КУЛИ́Ч бортого хэлбэртэй нарийн талх.
КУЛИ́ЧК||И у чёрта на ~ах, к чёрту на ~ ертөнцийн хязгаарт.
КУЛО́Н 1. чулуун шиггтгээ, эрдэнийн чулуу, шүр; 2. кулон *(цахилгаан хэмжих нэгж).*
КУЛУА́РН||ЫЙ албан бус, сул; **~ые разговоры** албан бус яриа, сул яриа.
КУЛУА́РЫ кулуар, гадаад өрөө *(хурлын тасалгааны гадаад өрөө, гудам).*
КУЛЬ том хүүдий, шуудай.
КУЛЬМИНАЦИО́НН||ЫЙ дээд туйлын; **~ая точка** дээд туйлын цэг.
КУЛЬМИНА́ЦИЯ 1. уртрагийг од хөндлөн огтлох; 2. дээд туйл, оргил.
КУЛЬТ 1. шүтээн, шүтлэг, тахил; **~овая музыка** тахилгын хөгжим; 2. тахин шүтэх, шүтлэг; **~ личности** нэг хүнийг тахин шүтэх.
КУЛЬТИВА́ТОР сийрүүлүүр (*газар сийрүүлдэг зэвсэг).*
КУЛЬТИВА́ЦИЯ сийрүүлэх.
КУЛЬТИВИ́РОВАНИЕ 1. тарих, өсгөх; 2. дэлгэрүүлэх, заншуулах.
КУЛЬТИВИ́РОВАТЬ 1. тарих, өсгөх; 2. дэлгэрүүлэх, заншуулах.
КУЛЬТТОВА́РЫ соёлын бараа.
КУЛЬТУ́Р||А 1. соёл, соёл боловсрол; 2. боловсрол, соёл; **человек высокой ~ы** их боловсролтой хүн; 3. тарих, өсгөх; 4. өсгөвөр, ургамал, нян; **технические ~ы** техник өсгөвөр; **физическая ~** биеийн тамир.
КУЛЬТУ́РНОСТЬ соёлын хэмжээ.
КУЛЬТУ́РН||ЫЙ 1. боловсон, боловсронгуй, соёлын, соёл боловсролын; 2. соёл боловсролын, гэгээрэл боловсролын; 3. таримал, өсгөмөл; **~ые растения** таримал ургамал.
КУЛЬТЯ́ мухар гар, мухар хөл.
КУЛЬТЯ́ПКА мухар гар, мухар хөл.
КУМ загалмай зүүсэн эцэг.
КУМА́ загалмай зүүлгэсэн эх, найз авгай.
КУМА́РИТЬ *разг.*бензин үнэртэж кайф авдаг.
КУМА́РЧИК *бот.* цулхир.
КУМА́Ч улаан даавуу.
КУМАЧО́ВЫЙ улаан даавуун.
КУМЕ́КАЛКА толгой, ухаан тархи.
КУМИ́Р 1. бурхны хөрөг; 2. шүтээн.
КУМОВСТВО́ худ ургийн харьцаа, тал тохой татах.
КУ́МПОЛ *разг.*толгой.
КУ́МУШКА 1. найз ахай; 2. ховч эхнэр.
КУМЫ́С айраг.
КУМЫСОЛЕЧЕ́БНИЦА айргийн эмнэлэг.
КУМЫСОЛЕЧЕ́БНЫЙ айргийн эмнэлгийн.
КУМЫСОЛЕЧЕ́НИЕ айргаар эмнэх.
КУНЖУ́Т гүнжид *(ургамал).*
КУНЖУ́ТН||ЫЙ гүнждийн; **~ое масло** гүнждийн тос.
КУНИ́ЦА 1. суусар; 2. суусрын арьс.
КУ́ПА зуун мод.
КУПА́ЛЬНЫЙ усанд ордог; **~ костюм** усанд ордог хувцас.
КУПА́ЛЬНЯ усанд орох газар.
КУПА́НИ||Е усанд орох; **здесь хорошее место для ~я** энд усанд ороход сайхан газар.
КУПА́ТЬ усанд оруулах, угаах.
КУПА́ТЬСЯ усанд орох, биеэ угаах.
КУПЕ́ тасалгаа.
КУПЕ́НА *бот.* мухар цагаан, аримба.
КУПЕ́Ц наймаачин, худалдаачин.
КУПЕ́ЧЕСКИЙ наймаачны, худалдаачны.
КУПЕ́ЧЕСТВО наймаачид, худалдаачид.
КУПИ́РОВАННЫЙ тасалгаатай.
КУПИ́ТЬ худалдан авах, авах.
КУПЛЕ́Т бадаг.
КУ́ПЛЯ худалдан авах.
КУ́ПОЛ бөмбөгөр орой, пөмбөгөр орой.
КУПО́Н 1. купон, тасалбар; 2. лоожийн билет, купон; 3. эсгүүр, купон.
КУПОРО́С байван; **цинковый ~** цагаан байван.
КУПОРО́СНЫЙ байвангийн.
КУ́ПЧАЯ худалдан авсан бичиг.
КУПЧИ́ХА 1. наймаачин эхнэр; 2. наймаачны эхнэр.
КУПЫ́РЬ *бот.* хашилж.
КУПЮ́РА 1. товчлол; **статья печатается без купюр** уул өгүүллийг товчлолгүй хэвлэв; 2. дэвсгэр; **крупная ~ займа** зээллэгийн том дэвсгэр.
КУРА́ЖИТЬСЯ омгорхох, агсамнах.
КУРА́НТЫ жүн, баян хуурт цаг; **кремлёвские ~** кремлийн жүн цаг.
КУ́РВА *разг.* янхан, гичий.
КУРГА́Н булш, овоо, дов.
КУРГУ́ЗЫЙ 1. оодон, мухар сүүлтэй; 2. тоодгор, оодон.
КУРДЮ́К хонины сүүл.
КУРДЮ́ЧН||ЫЙ 1. *(хонины)* сүүлний; 2. *(уугаан)* сүүлтэй; **~ая овца** уугаан сүүлтэй хонь.
КУ́РЕВО ганц хоёр сорох юм, утаа гаргах юм.
КУРЕ́НИЕ 1. тамхи татах; 2. үнэртэн, утлага.
КУРЕ́НЬ 1. байшин; 2. хүрээ; 3. Запорожийн казак цэргийн нэг анги.
КУРИ́ЛКА тамхины өрөө.
КУРИ́ЛЬСКИЙ ~ чай боролзгоно.
КУРИ́ЛЬЩИК тамхич.
КУРИ́ЛЬЩИЦА тамхич эмэгтэй.

КУРИ́Н||ЫЙ тахианы; **~ые перья** тахианы өд.
КУРИ́ТЕЛЬНЫЙ ~ табак амны тамхи.
КУРИ́ТЬ 1. татах; **~ трубку** гаанс тамхи татах, тамхи нэрэх; 2. нэрэх; **~ смолу** давирхай нэрэх; 3. утах.
КУРИ́ТЬСЯ 1. ноцох, асах; **сырой табак не курится** нойтон тамхи ноцохгүй байна; 2. утаа гарах, баагих, уугих, манантах, униартах; **вулкан курится** галт уулнаас утаа гарч байна.
КУ́РИЦА тахиа; *** мокрая ~** усанд орсон хулгана.
КУ́РИЯ сонгогчийн зэрэг.
КУРКУ́ЛЬ *разг.* харамч баян хүн.
КУРКУ́МА гүргэм.
КУРЛЫ́КАТЬ тогоруу, гуруу гуруу гэх.
КУРНО́САЯ *разг.* үхэх, мажийх.
КУРНО́СЫЙ шантгар, шагнагар хамартай.
КУРО́К 1. бууны гох, чавх; 2. *разг.* хэлүү.
КУРОЛЕ́СИТЬ дүрсгүйтэх.
КУРОПА́ТКА ятуу.
КУРО́РТ рашаан эмнэлэг.
КУРО́РТНИК рашаан эмнэлэгт сувилуулагч.
КУРО́РТНЫЙ рашаан эмнэлгийн.
КУРС I 1. чиг, чиглэл; **взять ~ на юг** урд чиг барих; 2. мөнгөний ханш; **биржевой ~** биржийн ханш; *** быть в ~е** мэдэх.
КУРС II дамжаа; **студент третьего ~а** гуравдугаар дамжааны оюутан.
КУРСА́НТ 1. түр сургуулийн сурагч; 2. цэргийн сургуулийн сурагч.
КУРСА́НТКА түр сургуулийн сурагч эмэгтэй.
КУРСА́НТСКИЙ цэргийн сургуулийн сурагчийн.
КУРСИ́В бичмэл үсэг.
КУРСИ́ВН||ЫЙ бичмэл *(үсгийн)*; **~ая строка** бичмэл үсгийн мөр.
КУРСИ́РОВАТЬ тогтмол явах, явж байх.
КУРСИ́СТКА оюутан эмэгтэй.
КУРСОВ||О́Й ангийн, курсын; **~ая работа** курсын ажил.
КУ́РСЫ түр сургууль, дамжаа.
КУ́РТКА хүрэм, куртк.
КУРЧА́ВИТЬСЯ буржийх.
КУРЧА́ВКА *бот.* эмгэн шилбэ.
КУРЧА́ВЫЙ бужгар, буржгар.
КУРЬЁЗ хачин юм, сонин юм, инээдтэй юм.
КУРЬЁЗНЫЙ хачин, сонин, инээдтэй; **~ случай** хачин тохиол; **~ рассказ** сонин өгүүллэг.
КУРЬЕ́Р зарлага, элч.
КУРЬЕ́РСКИЙ яаруу; **~ поезд** түргэн галт тэрэг.
КУРЬЕ́РША зарлага эмэгтэй.
КУРЯ́ГА нэвширсэн тамхичин, улаан тамхичин.
КУРЯ́ТИНА тахианы мах.
КУРЯ́ТНИК тахианы чингэлэг, тахианы байр.
КУРЯ́Щ||ИЙ тамхи татдаг хүн, тамхичин; **вагон для ~их** тамхи татагчдын суух тасалгаа.
КУСА́||ТЬ 1. хазах, зуух; 2. хатгах; **змея ~ет** могой хатгана; 3. түлэх; **крапива ~ет** халгай түлнэ.
КУСА́ТЬСЯ хазах, зуух.
КУСКОВО́Й хагалсан, хэсэг хэсэг, бөөн; **~ сахар** бөөн бөөн чихэрт ёотон.
КУСО́К хэсэг, зүсэм, хэрчим, толгой; **~ шелка** толгой торго; **~ хлеба** аяга хоол, үмх мах.
КУСО́ЧЕК хэсэгхэн, зүсэмхэн.
КУСТ бут сөөг.
КУСТА́РНИК бутас, сөөг; **заросший ~ом** бутас ургасан.
КУСТА́РНИКОВ||ЫЙ бутлаг, сөөг; **~ые растение** бутлаг ургамал.
КУСТА́РНИЧАТЬ 1. гараар хийх, гараар үйлдвэрлэх; 2. бүдүүлэг ажиллах, бааз борог ажиллах.
КУСТА́РНИЧЕСТВО бүдүүлэг ажиллагаа, бааз борог ажил.
КУСТА́РН||ЫЙ 1. гар гараар хийсэн; **~ая промышленность** гар үйлдвэр; **~ое изделие** гараар хийсэн; 2. бүдүүлэг, бааз борог.
КУСТА́РЬ гар үйлдвэрч.
КУ́СТИК 1. жижиг бут, сөөг; 2. *разг.* жорлон.
КУСТИ́СТ||ЫЙ өтгөн, сахлаг; **~ая пшеница** сахлаг буудай.
КУ́ТАТЬ боох, ороох, дулаалах.
КУ́ТАТЬСЯ биеэ ороох, дулаалах.
КУТЁЖ архидаан, наргиан.
КУТИ́ЛА архич, наргигч.
КУТИ́ТЬ архидах, наргих.
КУТРО́ВЫЕ *бот.* чонын хорны овог.
КУТЬЯ́ бэрээсий.
КУХА́РКА тогооч эхнэр.
КУ́ХНЯ тогооны байшин, тогооны гэр, гал тогоо.
КУ́ХОННЫЙ гал тогооны; **~ газ** гал тогооны хиншүү.
КУ́ЦЫЙ оготор, тоодон сүүлтэй.
КУ́ЧА 1. овоо, бөөн, бөөм; **~ снега** цасан овоо; 2. бөөн, олон; **~ народа** бөөн хүн, олон хүн; **~ детей** бөөн хүүхэд, олон хүүхэд; **~ неприятностей** бөөн гай.
КУЧЕВ||О́Й ~ые облака бөөн үүл.
КУ́ЧЕР 1. дэлбэг, жолооч, улаач; 2. *разг.* жолооч, танил.
КУ́ЧК||А 1. овоо, бөөм; 2. бүлэгхэн, хэсэгхэн; **собираться ~ами** хэсэгхэн, хэсэгхэнээрээ цуглах.
КУ́ЧНЫЙ бөөн, шавааралдсан.
КУШ бөөн мөнгө, бүс мөнгө, бүс юм.
КУША́К бүс.
КУ́ШАНЬЕ хоол, идээ.
КУ́ШАТЬ идэх, зооглох.
КУШЕ́ТКА 1. вандан ор; 2. дэртэй диваан.
КУЩЕ́НИЕ, сахлаг ургах, өтгөн ургах.

Л

ЛАБА́ЗНИК *бот.* туулайн тагнай.
ЛАБА́З 1. гурилын дэлгүүр; 2. бүхээг.
ЛАБИРИ́НТ хавис, онги, лабиринт.
ЛАБИ́ЛЬНЫЙ тогтворгүй.
ЛАБОРА́НТ лабораторич,
ЛАБОРА́НТКА лабораторич эмэгтэй.
ЛАБОРА́НТСКИЙ лабораторичийн,
ЛАБОРАТО́РИЯ лабораторн. ~ **бактериологическая** нян судлалын лабораторн; ~ **серологическая** ийлдэс судлалын лабораторн;
ЛАБОРАТО́РНЫЙ лабораторийн;
ЛА́В||А I лав, хайлмаг, нурма; **потоки ~ы** хайлмагийн урсгал.
ЛА́ВА II морин цэргийн дайралт.
ЛАВИ́НА 1. цасан уруй, бөөн цас, цасан нураг; 2. тоо тоймгүй олон, харанхуй олон.
ЛАВИ́РОВАНИЕ 1. салхи өөд, самрах; 2. булгах, булгах зайлах, зайлах.
ЛАВИ́РОВАТЬ 1. *(онгоц)* салхи өөд самрах; 2. булгах, булгах зайлах, зайлах.
ЛА́ВКА I вандан, тууш сандал.
ЛА́ВКА II мухлаг, дэлгүүр.
ЛА́ВОЧКА I бяцхан бандан, бяцхан тууш сандал.
ЛА́ВОЧКА II бяцхан мухлаг, бяцхан дэлгүүр.
ЛА́ВОЧНИК дэлгүүрч, мухлагч, дэлгүүрийн эзэн, мухлагийн эзэн.
ЛАВР 1. лавр, лаавар; 2. лаавар титэм, лаавар чимэг; **почить на ~ах** амжилтандаа санаа амрах; ололтондоо ташуурах; **пожинать ~ы** амжилтынхаа үр шимийг эдлэх, ялсан буянаа эдлэх.
ЛАВРО́ВЫЙ лаврын, лааврын; ~ **венец** лаавар титэм.
ЛА́ГЕРНЫЙ лагерийн, лаагарын; ~ **период** лагерийн үе.
ЛА́ГЕР||Ь 1. лагерь, лаагар, хүрээ; **укреплённый** ~ бэхэлсэн лагерь, хүрээ; **учебный** ~ сургуулийн лагерь; **расположиться ~ем** лагерьлах; 2. лагерь, тал.
ЛАГУ́НА далайгаас тасарсан булан.
ЛАГОТИ́С *бот.* хонлин.
ЛАГО́ПСИС *бот.* туулайн уруул.
ЛАД I 1. эв, эв нийц, таарамж, нийлэмж; **жить с кем-либо в ~ах** эв нийцтэй байх; **быть не в ~ах** эв нийцгүй байх; 2. янз, маяг; **на новый ~** шинэ янзаар; **на свой ~** өөрийнхөө маягаар, өөрийнхөөрөө; **дело идёт на ~** хэрэг бүтэх тийшээ хандаж байна.
ЛАД II 1. цомнол; 2. үелээс.
ЛА́ДАН хөхөн, гүгэл; **дышать на ~** амьсгалын тоо хариугүй барагддаг дээрээ, дөнгөж амьтай голтой байх; **бежать как чёрт от ~а** үхтлээ айж зугтаах.
ЛА́ДАНКА *сахиус.*
ЛА́ДИТЬ 1. засах, эвлүүлэх; 2. хөглөх, хөг нийлүүлэх; 3. янших, чихний *чийр болох.*
ЛА́ДИТЬСЯ бүтээх, бүтэмжтэй байх, урагштай байх.
ЛА́ДНО за, *болно;* за яах вэ; ~, **будь по-твоему** за яах вэ, чинийхээр болог.
ЛА́ДН||ЫЙ *болохтой,* зүгээр, сайн; **~ая жизнь** болохтой амьдрал.
ЛАДО́Н||Ь алга; **быть видным, как на ~и** *алган дээр байгаа юм шиг ил харагдах.*
ЛАДО́ШИ алга; **бить в ~** *алгаа таших.*
ЛАДЬЁМ *бот.* шүрэн үндэс.
ЛАДЬЯ́ I том завь.
ЛАДЬЯ́ II *тэрэг.*
ЛАЗАРЕ́Т цэргийн эмнэлгийн газар.
ЛАЗЕ́ЙК||А 1. завсар, нүх сүв; ~ **в заборе** хашааны шурган орох завсар; 2. арга сүв, нүх сүв; **найти ~у** арга сүв олох, нүх сүв олох; 3. арга *мөр.*
ЛА́ЗЕР лазер.
ЛА́ЗИТЬ 1. авирах, асах; 2. *шургах, шурган орох.*
ЛА́ЗОРЕВЫЙ хөх цэнхэр, номин хөх.
ЛАЗУ́РН||ЫЙ *хөх цэнхэр, номин хөх;* **~ое небо** *номин хөх* тэнгэр; **~ое море** хөх цэнхэр тэнгис.
ЛАЗУ́РЬ 1. хөх цэнхэр *өнгө, номин өнгө;* 2. хөх цэнхэр будаг.
ЛАЗУ́ТЧИК туршуул, тагнуул.
ЛАЙ хуцах, хуцалдах.
ЛА́ЙКА I илэг.
ЛА́ЙКА II ангууч нохой.
ЛА́ЙКОВ||ЫЙ илгэн; **~ые перчатки** илгэн бээлий.
ЛА́ЙМОВЫЙ далдуу.
ЛАК чий; **покрыть ~ом** чийдэх.
ЛАКА́НИЕ долоох, долоон идэх.
ЛАКА́ТЬ долоох, долоон идэх; ~ **молоко** сүү долоох.
ЛАКЕ́Й 1. зарц; 2. зарц, боол.
ЛАКЕ́ЙСК||ИЙ зарцын, боолын; **~ая натура** боолын шинж.
ЛАКЕ́ЙСТВО бялдуучлал, долдгонох.
ЛАКЕ́ЙСТВОВАТЬ бялдуучлах, долдгонох.
ЛАКИРО́ВАНН||ЫЙ чийтэй, чийдсэн; **~ые ботинки** чийтэй ботинк гутал.
ЛАКИРОВА́ТЬ чийдэх, чий түрхэх, гоёчлох.
ЛАКИРО́ВКА 1. чийдэх, чийдлэх; 2. чий; **тусклая ~** бүдэх чий.
ЛАКИРО́ВЩИК чийдэгч.
ЛА́КОВ||ЫЙ 1. чийний, чийтэй; ~ **раствор** чийний уусмал; 2. чийтэй, чийдсэн; **~ая обувь** чийтэй гутал.
ЛА́КОМИТЬСЯ амттай юм идэх, амтархан идэх, хужирлах; ~ **вареньем** чанамал жимс амтархан идэх.
ЛА́КОМКА амттай юманд дуртай хүн.
ЛА́КОМСТВО амттай идээ.
ЛА́КОМЫЙ амттай, хорхой хүрэм, арааны шүлс асгармаар; ~ **кусок** хорхой хүрэм юм.
ЛАКОНИ́ЗМ товч тодорхой.
ЛАКОНИ́ЧЕСКИЙ товч тодорхой, товч, цөөн үгтэй.
ЛАКОНИ́ЧНОСТЬ товч тодорхой байх, цөөн үгтэй байх.
ЛАКОНИ́ЧНЫЙ товч тодорхой, товч, цөөн үгтэй; ~ **стиль** товч тодорхой найруулга.
ЛАКТА́ЦИЯ сүү шимжих, сүүжих
ЛА́МА I тэмээн гөрөөс.
ЛА́МА II лам, **Далай-~** далай лам.
ЛАМАИ́ЗМ шарын шашин.
ЛА́МПА дэн, лаампа, чийдэн; **электрическая** ~ цахилгаан чийдэн; ~ **газоразрядная** цахилгаан чийдэн; ~ **дуговая** нуман цахилгаан чийдэн; ~ **кварца** хөх гэрлийн лаамп.
ЛАМПА́ДА,
ЛАМПА́ДКА, зул.
ЛАМПА́ДН||ЫЙ зулын; **~ое масло** зулын тос.
ЛАМПА́С хавчаар, хажлага.
ЛА́МПОВ||ЫЙ 1. дэнгийн; **~ое стекло** дэнгийн шил; 2. лаампын, лаампатай.
ЛА́МПОЧКА 1. бяцхан дэн, бяцхан лаампа; 2. чийдэнгийн шил; **электрическая** ~ чийдэнгийн шил.

ЛАНГУ́СТ лангуст.
ЛАНДСКНЕ́ХТ хөлсний цэрэг, хөлсний хүн.
ЛАНДША́ФТ төрх байдал, газар, ландшафт; **горный** ~ уулархаг газар; **живописный** ~ үзэсгэлэнтэй газар; ~ **антропогенный** зохиомол ландшафт.
ЛА́НДЫШ май цэцэг, хонхлой цэцэг.
ЛА́НДЫШЕВЫЙ май цэцгийн, хонхлой цэцгийн.
ЛАНЦЕ́Т хоёр иртэй хутга.
ЛАНЦЕ́ТНЫЙ хоёр иртэй хутгын.
ЛАНЬ марал гөрөөс.
ЛА́П||А 1. савар, год; **медвежья** ~ баавгайн савар; ~ **якоря** бархагийн савар, зангууны савар; 2. шилмүүс; ~**ы ели** гачуурын шилмүүс.
ЛАПАРОСКОПИ́Я хэвлий дурандах.
ЛАПИДА́РНЫЙ товч;товч тодорхой.
ЛА́ПКА бяцхан савар.
ЛА́ПОТЬ долон маахай, дурсан маахай.
ЛАПТА́ лаптуу, бөмбөг цохих.
ЛАПЧА́ТКА хүрэн шарилж.
ЛА́ПЧАТНЫЙ 1. савар мэт, савралхуу; 2. сарьслаг савартай.
ЛАПША́ мянтууз, гурилтай шөл.
ЛАРЁК бүхээг; **табачный** ~ тамхины мухлаг.
ЛАРЕ́Ц гоё хайрцаг.
ЛА́РЧИК бяцхан хайрцаг; ~ **просто открывался** цэцэрхэх хэрэггүй юм байжээ.
ЛАРИНГИ́Т төвөнх үрэвсэх.
ЛАРИНГОТОМИ́Я төвөнхийг зүсэх.
ЛАРЬ авдар, хүнгэрцэг.
ЛА́СКА I энхрийлэх.
ЛА́СКА II оготны чоно.
ЛАСКА́ТЕЛЬН||ЫЙ энхрийлсэн, эрхлүүлсэн, эрх; ~**ое имя** энхрийлсэн нэр, эрх нэр;
ЛАСКА́ТЬ 1. энхрийлэх, эрхлүүлэх, таалах; 2. аятай байх, /нүдэнд/ дулаан байх, /чихний/ чимэг болох; ~ **взор** нүдэнд дулаан байх; ~ **слух** чихний чимэг болох; 3. санаа засах, сэтгэл тэжээх, биеэ хураах; ~ **себя надеждой** горилж сэтгэлээ тэжээх.
ЛАСКА́ТЬСЯ эрхлэх; ~ **к матери** эхдээ эрхлэх.
ЛА́СКОВЫЙ энхрий, наалинхай, энхрэг, урин зөөлөн, элдэг зөөлөн; ~ **взгляд** элдэг зөөлөн харц, дулаан харц.
ЛАСТ хавтаг, хав загас мэтийн далайн амьтаны сэлүүр, хөл.
ЛА́СТИК 1. ластик даавуу; 2. баллуур.
ЛАСТИ́ТЬСЯ эрхлэх, наалдах.
ЛА́СТОЧКА хараацай; **деревенская** ~ алтан хараацай; **первая** ~ түрүүчийн тэмдэг.
ЛА́СТОЧКИН хараацайн; ~**о гнездо** хараацайн үүр.
ЛАТА́ТЬ нөхөөс тавих, нөхөх.
ЛАТВИ́ЙСКИЙ латви, латвийн.
ЛА́ТЕКС латекс.
ЛАТЕ́НТНЫЙ далд.
ЛАТИНИ́СТ латинч, латин хэлний мэргэжилтэн.
ЛАТИ́НИЦА латин үсэг.
ЛАТИ́НСКИЙ латин; ~ **язык** латин хэл.
ЛАТИФУНДИ́Я том эдлэн.
ЛА́ТКА нөхөөс.
ЛАТУ́К *бот.* зираа.
ЛАТУ́ННЫЙ гуулин.
ЛАТУ́НЬ гууль.
ЛА́ТЫ хуяг.
ЛАТЫ́НЬ латин хэл.
ЛАТЫ́Ш латыш хүн.
ЛАТЫ́ШСКИЙ латышийн, латвийн; ~ **язык** латыш хэл.
ЛАУРЕА́Т шагналтан; ~ **Нобелевской премии** Нобелийн шагналтан.
ЛАФЕ́Т их буугийн суурь, үхэр буугийн суурь.
ЛА́ЦКАН энгэр.
ЛАЧУ́ГА муу байшин, овоохой, урц; **бедная** ~ ядуу муу байшин, хар овоохой.
ЛА́ЯТЬ хуцах; **собака лает** нохой хуцаж байна.
ЛГАТЬ 1. худал хэлэх; **лжёт и не краснеет** жишим ч үгүй худал хэлнэ; барин тавин худал хэлнэ; 2. гөрдөх, гүжирдэх.
ЛГУН худалч хүн.
ЛГУ́НЬЯ худалч эмэгтэй.
ЛЕБЕДА́ шорной, загалмай өвс, луйл өвс.
ЛЕБЕДИ́НЫЙ хунгийн, хун шувууны; ~**ая песня** сүүлчийн үйл, сүүлчийн зохиол.
ЛЕ́БЕДЬ хун *(шувуу).*
ЛЕБЕЗИ́ТЬ нялганах, шарвалзах.
ЛЕБЁДКА I эм хун.
ЛЕБЁДКА II эргүүлэг, дамарт эргүүлэг.
ЛЕБЯ́ЖИЙ хун шувууны; ~ **пух** хун шувууны хээлүүр.
ЛЕВ I арслан; **морской** ~ далайн арслан.
ЛЕВ II лев *(Болгарын мөнгөний нэгж).*
ЛЕВА́К зүүнтэн.
ЛЕВА́ЦКИЙ зүүний загиб зүүний нугалаа.
ЛЕВА́ЧЕСТВО зүүний үзэл, явуулга.
ЛЕВЕ́ТЬ зүүн болох, зүүнтэн болох, зүүний үзэлтэн болох.
ЛЕВИЗНА́ зүүн, зүүний үзэл.
ЛЕВИТА́ЦИЯ жингүйдэх, жингүйдэж нисэх.
ЛЕВКО́Й манжхуй цэцэг.
ЛЕВОБЕРЕ́ЖН||ЫЙ зүүн биеийн, зүүн эргийн, голын буруу талын, голын урсгалын зүүн гар талын; ~**ая сторона** зүүн бие, голын урсгалын зүүн гар тал.
ЛЕВША́ солгой хүн.
ЛЕ́В||ЫЙ 1. зүүн, зүүн талын, буруу, бүруу талын; ~**ая рука** буруу гар, солгой гар; ~**ая сторона** а) буруу тал; б) морь малын зөв тал; в) зүүний; ~ **уклон** зүүний хэлбэрэл.
ЛЕГА́В||ЫЙ ~**ая собака** анч нохой.
ЛЕГАЛИЗА́ЦИЯ ил байдалтай болох, хуулиар зөвшөөрсөн байдалтай болох, хуульчдах.
ЛЕГАЛИЗОВА́ТЬ ил байдалтай болох; хуулиар зөвшөөрсөн байдалд оруулах, хуульчлах.
ЛЕГАЛИЗОВА́ТЬСЯ ил байдалтай болох; хуулиар зөвшөөрсөн байдалд орох.
ЛЕГА́ЛЬНО ил, хуулийн зөвшөөрөлтэйгөөр.
ЛЕГА́ЛЬНОСТЬ ил байдал, хуулиар зөвшөөрсөн байдал.
ЛЕГА́ЛЬНЫЙ хуулиар зөвшөөрсөн.
ЛЕГЕ́НД||А 1. домог, түүх домог; 2. домог, үлгэр домог, үлгэр түүх; **о нём рассказывают** ~**ы** түүний тухай үлгэр домог хэлдэг болж; 3. таних тэмдэг.
ЛЕГЕНДА́РНЫЙ 1. домгийн, үлгэр домог болсон, үлгэр түүхэнд гардаг; 2. гайхамшигт; ~ **герой** гайхамшигт баатар.
ЛЕГИО́Н 1. легион *(зарим орны тусгай цэргийн ангийн нэр);* 2. үй түм, тоо томшгүй.
ЛЕГИОНЕ́Р легионч.
ЛЕГКО́ 1. хөнгөн, хялбар; ~ **ступать** хөнгөн гишгэх; 2. хөнгөн байх, хялбар байх; ~ **понять его** түүнийг ухахад хялбар; ~ **сказать** хэлэхэд амархан, хийхэд хэцүү.
ЛЕГКОАТЛЕ́Т *хөнгөн атлетикч.*
ЛЕГКОВЕ́РИЕ гэнэн зан,итгэмтгий зан.
ЛЕГКОВЕ́РНЫЙ гэнэн, итгэмтгий.
ЛЕГКОВЕ́СНЫЙ 1. хөнгөхөн, хөнгөн; 2. хөнгөмсөг, өнгөцхөн.
ЛЕГКОВО́Й хөнгөн, суудлын; ~ **автомобиль** суудлын машин.

ЛЕГКОМЫ́СЛЕННОСТЬ хөнгөмсөг зан, бодолгүй явдал,хөнгөн сэтгэл.
ЛЕГКОМЫ́СЛЕННЫЙ наагуур, хуумгай, өнгөцхөн, бодолгүй.
ЛЕГКОМЫ́СЛИЕ хөнгөмсөг зан, бодолгүй явдал, хөнгөн сэтгэл.
ЛЕГКОПЛА́ВКИЙ амархан хайлах, хайламтгай, хайлц сайтай.
ЛЕГО́НЬКО аяархан, сэмээрхэн; ~ **ударить** аяархан цохих; ~ **поднять** сэмээрхэн өргөх.
ЛЕГЧА́||ТЬ 1. багасах, сулрах, зөөлрөх; **мороз ~ет** хүйтэн зөөлөрч байна; 2. сайжрах, наашлах, хөнгөрөх; **больному не ~ет** өвчтөний бие хөнгөрөхгүй байна.
ЛЕ́ГЧЕ, хөнгөн; хялбар; **дерево ~ металла** мод төмөрлөгөөс хөнгөн; **час от часу не ~** цаашлах тусам дордоно.
ЛЁГК||ИЙ 1. хөнгөн; **~ая ноша** хөнгөн үүрэг; 2. хөнгөн, хялбар; **~ способ** хөнгөн арга; 3. хөнгөн, зөөлөн; **~ое наказание** хөнгөн шийтгэл; ~ **ветерок** зөөлөн салхи; 4. өнгөцхөн, хөнгөмсөг, хуудам; **~ое поведение** хөнгөмсөг зан; 5. нийцтэй; ~ **характер** нийцтэй хүн; 6. хөнгөн, хөл хөнгөн; **~ая промышленность** хөнгөн үйлдвэр; **~ое вино** зөөлөн дарс; **девушка ~ого поведения** янхан, банзал; **лёгок на помине** сайн хүн санаагаар.
ЛЁГКОЕ уушиг; **воспаление лёгких** уушигны хатгалгаа.
ЛЁГКОСТЬ хөнгөн *(чанар)*; ~ **движения** хөнгөн хөдөлгөөн; ~ **в мыслях** хөнгөмсөг бодол; хуудам явдал.
ЛЁГОЧН||ЫЙ уушигны; **~ое заболевание** уушигны өвчин; **~ая доля** уушигны хэлтэр.
ЛЁД мөс; **вечные льды** мөнх мөс; **толстый слой льда** зузаан мөс; **руки холодные, как ~** мөс шиг хүйтэн гар; ~ **разбит, ~ сломан** мөр гаргах, шав тавих; ~ **тронулся** ажил урагшиллаа, байдал тодорхой боллоо.
ЛЕДЕНЕ́||ТЬ 1. мөсрөх, мөхөөлтөх, мөстөх; **вода начинает ~** ус мөхөөлтөж байна; 2. даарах, бээрэх; **руки ~ют** гар бээрч байна; **кровь ~ет** оройны үс орвойно.
ЛЕДЕНЕ́Ц мөсөн чихэр.
ЛЕДЕНИ́||ТЬ хөргөх, хүйт даалгах, хайрах; **ветер ~т лицо** жавар нүүр хайрна.
ЛЕДНИ́К I мөсөн гол, мөсөн оргил, уулын оройн мөс.
ЛЕДНИ́К II мөсөн зоорь.
ЛЕДНИКО́ВЫЙ мөсөн; ~ **период** мөсөн галав.
ЛЕДОВИ́ТЫЙ мөсөн; **Северный ~ океан** Хойд мөсөн далай.
ЛЕДОВ||О́Й ~ое плавание мөстэй усанд хөвөн явах.
ЛЕДО́ВЫЙ мөсөн дээр, мөстэй усанд.
ЛЕДОКО́Л *мөс хагалагч онгоц.*
ЛЕДОСТА́В гол мөрөн хөлдөх.
ЛЕДОХО́Д цөн.
ЛЕДЫ́ШКА хэсэгхэн мөс
ЛЕДЯН||О́Й 1. мөсөн; **~ая гора** мөсөн уул; 2. мөсөн, мөст; **~ая вершина** мөст оргил; 3. хүв хүйтэн, цэв хүйтэн, мөхөөлдсөн; **~ая вода** цэв хүйтэн ус; 4. даарчсан, бээрчсэн; **~ые пальцы** бээрсэн хуруу; 5. хүйтэн; ~ **взгляд** хүйтэн харц.
ЛЕЖА́ЛЫЙ хуучирсан, хуучиртлаа хэвтсэн; ~ **товар** хуучирсан бараа.
ЛЕЖА́НИЕ хэвтэх.
ЛЕЖА́НКА ханз, халуун хэвтэр.
ЛЕЖА́ТЬ 1. хэвтэх; ~ **на боку** хажуудлан хэвтэх; 2. хэвтэх, өвдөн хэвтэх; 3. байх; **книга лежит на столе** ном ширээн дээр байна; 4. орших, байх; **город лежит на берегу реки** хот голын эрэгт оршино; 5. хүлээх, үүрэх; **ответственность за это лежит на правительстве** үүний хариуцлагыг засгийн газар үүрнэ; **все дело лежит на нём** хамаг хэргийг тэр үүрч байна; 6. *(санаа)* зовох; ~ **на душе** санаа зовоох; ~ **на совести** сэтгэлд цөв оруулах; ~ **в основе** суурь болох; **душа не лежит** дур хүрэхгүй, таалагдахгүй.
ЛЕЖА́Ч||ИЙ хэвтээ, хэвтэгч, хэвтэж байгаа; **~не деревья** хэвтээ мод; ~ **камень** хэвтээ чулуу.
ЛЕЖЕБО́КА залхуу хүн, залхууран хэвтэгч.
ЛЁЖК||А 1. хэвтэр, хэвтэш; 2. удаан хэвтэх; **лежать в ~у** өвдөж удаан хэвтэх.
ЛЕ́ЗВИЕ ир; ~ **ножа** хутганы ир.
ЛЕЗТЬ 1. авирах, асах, гарах; ~ **на гору** ууланд гарах; 2. орох, түрэн орох, шурган орох; ~ **в воду** усанд орох; 3. уудлах, уудлан авах; ~ **в карман за табаком** тамхи авахаар халаасаа уудлах; 4. оролцох; ~ **не в свое дело** хөндлөнгийн хэрэгт оролцох; 5. багтах, таарах; **сапог не лезет на ногу** гутал хөлд багтахгүй байна; 6. ноцох,төвөглөх; ~ **с пустяками** дэмий хэргээр төвөглөх; 7. унах, сэмрэх; **волосы лезут** үс унана; **материя лезет** бөс сэмэрнэ; ~ **из кожи вон** махран зүтгэх; ~ **в карман за словом** үг олж ядах.
ЛЕЙБОРИ́СТСК||ИЙ лейборист; **~ая партия** лейборист нам.
ЛЕЙБОРИ́СТ *лейборист.*
ЛЕЙБЛ шошго.
ЛЕ́ЙКА цутгуур, услуур.
ЛЕЙКОЦИ́Т цусны цагаан бөөм, цусны цагаан бөмбөлөг.
ЛЕЙКО́З цагаан эсийн хавдар.
ЛЕЙКОПЕНИ́Я цагаан эс цөөрөх.
ЛЕЙКОПЛА́СТЫРЬ шархны лент.
ЛЕЙТЕНА́НТ дэслэгч; **старший ~** ахлагч дэслэгч; **младший ~** бага дэслэгч.
ЛЕЙТМОТИ́В 1. товойлгох аялга *(хөгжмийн зохиолд байн байн давтдаг гол аялга)*; 2. гол утга, үндсэн баримт.
ЛЕКА́ЛО 1. угалзан шугам, муруй шугам, татахад хэрэглэх шугам; 2. хэв.
ЛЕКА́РСТВЕНН||ЫЙ эмийн; **~ые растения** эмийн ургамал; **~ая аллергия** эмийн харшил.
ЛЕКА́РСТВО эм; **прописывать ~** эм бичиж өгөх; **принять ~** эм уух; **сильно действующее ~** хатуу эм.
ЛЕ́КАРЬ эмч, оточ.
ЛЕ́КСИКА үгийн сан; үг (аливаа хэлний буюу зохиолчийн зохиолд гардаг бүх үгс) ~ **монгольского языка** монгол хэлний үгийн сан.
ЛЕКСИКОГРА́Ф толийн зүйч; толь зохиогч.
ЛЕКСИКОГРАФИ́ЧЕСК||ИЙ толийн зүйн; толь зохиох; **~ая работа** толь зохиох ажил.
ЛЕКСИКОГРА́ФИЯ толийн зүй (толь зохиох онол практик).
ЛЕКСИКОЛО́ГИЯ үгийн сангийн зүй (хэлний үгсийн бүрэлдэхүүнийг судлах ухаан).
ЛЕКСИКО́Н 1. толь бичиг; 2. хэл үг; **у него богатый ~** баялаг хэлтэй хүн.
ЛЕКСИ́ЧЕСКИЙ үгсийн; үгийн сангийн; ~ **состав языка** хэлний үгсийн бүрэлдэхүүн.
ЛЕ́КТОР лектор; лекц уншигч.
ЛЕКТО́РИЙ 1. лекцийн газар; 2. лекцийн тасалгаа.
ЛЕ́КТОРСКИЙ лекторын.
ЛЕКЦИО́ННЫЙ лекцийн; ~ **зал** лекцийн танхим.
ЛЕ́КЦИЯ лекц; **публичная ~** нийтийн лекц.
ЛЕЛЕ́ЯТЬ 1. бөмбийлөх, энхрийлэх; 2. санагалзах; ~ **надежду** найдан санагалзах.
ЛЕНИ́ВЕЦ залхуу хүн; залхуу хойрго хүн.
ЛЕНИ́В||ЫЙ залхуу, хойрго, хашин; ~ **человек** залхуу хүн; **~ая лошадь** хашин морь.
ЛЕ́НИНЕЦ ленинч, лениний сурталтан.
ЛЕНИНИ́ЗМ ленинизм, лениний сургаал.
ЛЕНИ́ТЬСЯ залхуурах, хойргоших, хашигнах.

ЛЕНО́К зэвэг (загас).
ЛЕ́НОСТЬ залхуурал, хойрго явдал, залхуу зан.
ЛЕ́НТА 1. тууз; **шёлковая** ~ торгон тууз; **клейкая** ~ наалдамхай тууз; 2. тасам; лент; **телеграфная** ~ цахилгаан мэдээний лент.
ЛЕ́НТОЧН||ЫЙ туузын; **~ое производство** туузын үйлдвэрлэл.
ЛЕНТЯ́Й залхуу хүн, хойрго хүн, хашин хойрго хүн.
ЛЕНТЯ́ЙКА хойрго эмэгтэй.
ЛЕНТЯ́ЙНИЧАТЬ залхуурах, хойргоших, хашигнах.
ЛЕНЦ||А́ с ~ой залхуувтар; залхуухан; **человек с ~ой** залхуувтар хүн.
ЛЕ́НЧИК эмээлийн мод.
ЛЕНЬ 1. залхуу, залхуу хүрэх; **меня обуяла** ~ залхуу хүрээд болдоггүй; **побороть в себе** ~ залхуугаа дийлэх; 2. залхуутай байх; ~ **пойти** явах залхуутай байна; **все, кому не** ~ дуртай хүн бүхэн.
ЛЕНЕ́Ц *бот.* майлингар.
ЛЕОПА́РД ирвэс.
ЛЕПЕСТО́К (цэцгийн) дэлбээ, хэлтэс; ~ **розы** цэцгийн дэлбээ.
ЛЕ́ПЕТ шулганаан, шулганах; **детский** ~ хүүхэд шулганах; ~ **ручья** горхины шулганах.
ЛЕПЕТА́НИЕ *шулганах, шулганалт.*
ЛЕПЕТА́ТЬ шулганах; **ребёнок лепечет** хүүхэд шулганана.
ЛЕПЁШКА 1. бин; 2. хавтгай үрэл.
ЛЕПИТЬ 1. шавах, шавраар хийх; 2. барих; ~ **гнездо** үүр барих; 3. наах; ~ **марки на конверт** дугтуйд марк наах.
ЛЕПИ́ТЬСЯ шавах, шавааралдах, наалдах.
ЛЕ́ПК||А шавах, шавраар хийх; **заниматься ~ой** шавраар юм хийх; шавраар юм хийж сурах..
ЛЕПН||О́Й 1. шавсан, шавж хийсэн; **~ые украшения** шавж хийсэн чимэглэл; 2. баримал чимэгтэй, барималтай; ~ **потолок** баримал чимэгтэй адар.
ЛЕ́ПТ||А *нэмэр, хандив;* **внести свою ~у** *нэмэр хандиваа өргөх*
ЛЕС 1. ой, ой мод; **дремучий** ~ харанхуй ой; 2. мод; **строевой** ~ барилгын мод; **сплавлять** ~ мод урсгах; ~ **рубят — щепки летят** далайд дусаал гарз болохгүй; их хэрэгт бага хэрэг үрэгдэнэ.
ЛЕС||А́ I (*барилгын*) шат; **здание в ~ах** эргэн тойрон шат тавьсан барилга.
ЛЕСА́ II загасны дэгээний утас.
ЛЕ́СЕНКА бяцхан шат.
ЛЕСИ́СТ||ЫЙ ойрхог, ойлог, ой модтой; **~ая местность** ойрхог нутаг.
ЛЕ́СКА *загасны дэгээний утас.*
ЛЕСНИ́К ойн цагдаа,
ЛЕСНИ́ЧЕСТВО ойн хэлтэс.
ЛЕСНИ́ЧИЙ ойн хэлтсийн ажилтан.
ЛЕСН||О́Й ойн, ойн модны; **~ое хозяйство** ойн аж ахуй; ~ **пожар** ойн түймэр; ~ **институт** ойн дээд сургууль, ой судлах хүрээлэн
ЛЕСОВО́Д модны мэргэжилтэн.
ЛЕСОВО́ДСТВО ой модны судлал.
ЛЕСОЗАГОТОВИ́ТЕЛЬНЫЙ мод бэлтгэлийн.
ЛЕСОЗАГОТО́ВКИ мод бэлтгэл.
ЛЕСОЗАЩИ́ТА *ой хамгаалалт.*
ЛЕСОМАТЕРИА́ЛЫ юм хийх мод, хэрэглэгдэхүүн мод.
ЛЕСОНАСАЖДЕ́НИЕ 1. мод тарих; 2. таримал мод
ЛЕСОПИ́ЛКА модны завод, мод хөрөөдөх завод.
ЛЕСОПИ́ЛЬНЫЙ мод хөрөөдөх; ~ **завод** мод хөрөөдөх үйлдвэр.
ЛЕСОПОЛОСА́ зурвас ой мод.
ЛЕСОПРОМЫ́ШЛЕННОСТЬ модны үйлдвэр.
ЛЕСОРУ́Б мод огтлогч.
ЛЕСОСЕ́КА мод огтлох газар.
ЛЕСОСПЛА́В мод урсгах.
ЛЕСОСТЕПНО́Й ойтой хээрийн; ~ **район** ойтой хээр газар.
ЛЕСОСТЕ́ПЬ ойтой хээр.
ЛЕСОТУ́НДРА ойт тундра.
ЛЁСС алтан химэрлэг.
ЛЕ́СТНИЦ||А шат; **приставная** ~ түшүүлдэг шат; **чёрная** ~ арын шат; **подниматься по ~е** шатаар гарах; **спускаться по ~е** шатаар буух.
ЛЕ́СТНИЧН||ЫЙ шатны; **~ая ступенька** шатны гишгүүр.
ЛЕ́СТН||ЫЙ тааламжтай, бахдалтай; **~ая оценка** тааламжтай үнэлэлт.
ЛЕСТ||Ь зусар; **говорить без всякой ~и** огт гоёлчлохгүй хэлэх.
ЛЕСХО́З *(лесное хозяйство)*, ойн аж ахуй.
ЛЕТА́ 1. нас; **сколько вам лет?** та хэдэн настай вэ? **во цвете лет** идэр насандаа; ид дунд насандаа; **средних** ~ дунд насны; **на старости лет** өтөлсөн хойноо; **развитой не по ~м** нас бага боловч ухаан нээсэн; **с самых детских лет** хар бага наснаасаа; 2. жил, он жил; **пять лет** таван жил; **прошло много лет** олон жил өнгөрөв, он жил удав
ЛЕТА́ЛЬНЫЙ үхэлд хүргэх, үхлийн.
ЛЕТАРГИ́ЧЕСКИЙ үхширэх өвчний, үхширсэн, үхширэх; ~ **сон,** үхширсэн нойр.
ЛЕТАРГИ́Я үхширэх өвчин, үхширэл.
ЛЕТА́ТЕЛЬНЫЙ нисэх, нисдэг; ~ **аппарат** нисэх аппарат
ЛЕТЕ́ТЬ 1. нисэх, нисэж байх; 2. давхих, гүйх, харайх; **~, сломя голову** нүүр нүдгүй гүйх; 3. үсрэн унах; ойчих; ~ **со стула** сандлаас ойчих; 4. нисэх мэт өнгөрөх; **время летит** цаг нисэх мэт өнгөрнө.
ЛЕ́ТН||ИЙ зуны, зун цагийн; **~яя пора** зуны цаг; ~ **костюм** зуны хувцас; ~ **отдых** зуны амралт; **~яя жара** зуны халуун
ЛЁТН||ЫЙ 1. нисч болох, нисэхэд тохиромжтой, нислэгийн; **~ая погода** нисч болох цаг уур; 2. нисэх онгоцны; **~ая школа** нисэх онгоцны сургууль
ЛЕ́ТО зун, зун цаг; **бабье** ~ *намрын шар нар.*
ЛЕТО́К зөгийн үүрийн үүд.
ЛЕ́ТОМ зун, зундаа, зун цагт.
ЛЕТОПИ́СЕЦ он дараалсан бичиг зохиогч.
ЛЕТОПИ́СНЫЙ он дараалсан бичгийн; ~ **свод** он дараалсан бичгийн цуглуулбар.
ЛЕ́ТОПИСЬ 1. он дараалсан бичиг; **древнерусская** ~ эртний оросын он дараалсан бичиг; 2. түүх; ~ **военной славы** цэргийн ялалтын түүх.
ЛЕТОСЧИСЛЕ́НИЕ он тоолол; **христианское** ~ христосын он тоолол, аргын тоолол.
ЛЕТУ́Н 1. *нисэгч*; 2. *ажил солих дуртай хүн.*
ЛЕТУ́Ч||ИЙ 1. нисэгч, нисдэг; 2. түргэн ширгэдэг; **~ие эфирные масла** түргэн ширгэдэг эфирийн тос; 3. түр зуурын, **~ее собрание** түр зуурын хурал; **~ая мышь** сарьсан багваахай
ЛЕТУ́ЧКА 1. товч мэдээтэй хуудас; 2. түр зуурын хурал.
ЛЕТЧИК нисгэгч, нисэгч; **школа ~ов** нисгэгчийн сургууль.
ЛЕЧЕ́БНИК эмийн судар.
ЛЕЧЕ́БНИЦА эмнэлгийн газар; **детская** ~ хүүхдийн эмнэлгийн газар
ЛЕЧЕ́БН||ЫЙ эмнэлгийн, эмнэх; **~ое учреждение** эмнэлгийн байгууллага; **~ые воды** эмчилгээний ус; **~ое свойство** эмчилгээний чанар.
ЛЕЧЕ́НИЕ эмнэлэг, эмчлэг, анагаах; ~ **электричеством** цахилгаанаар эмчлэх; ~ **гормональное** даавраар эмчлэх.
ЛЕЧИ́ТЬ эмчлэх, анагаах, эмнэх; ~ **лекарствами**; эмээр анагаах; ~ **туберкулёз** сүрьеэ анагаах

ЛЕЧИ́ТЬСЯ эмчлүүлэх, эмнүүлэх, анагаалгах, эмнэх, аргалах; ~ **у кого-либо** хүнээр эмнүүлэх; ~ **чем-либо** нэг юмаар аргалах

ЛЕЧЬ 1. хэвтэх; 2. бүрхэх; 3. оногдох, тусах, дарах; **ответственность ляжет на него** хариуцлага нь түүнд оногдоно; 4. орж явах, барьж явах; ~ **на новый курс** өөр чиг барьж явах.

ЛЁШИЙ ойн эзэн, ойн савдаг.

ЛЕЩ зоодой загас, хайга.

ЛЁН I маалинга.

ЛЁН II ~ **горный** шөрмөсөн чулуу.

ЛЁСС *(геол)* химэрлэг.

ЛЁТ нисэх; **на лету** 1. нисэж байхад нь; 2. явуут дунд нь.

ЛЁТЧИЦА нисгэгч эмэгтэй.

ЛЖЕНАУ́КА хуурамч шинжлэх ухаан.

ЛЖЕНАУ́ЧНЫЙ хуурамч шинжлэх ухааны.

ЛЖЕСВИДЕ́ТЕЛЬ хуурамч гэрч.

ЛЖЕСВИДЕ́ТЕЛЬСТВО хуурамч гэрчлэх.

ЛЖЕУЧЕ́НИЕ хуурамч сургаал.

ЛЖЕЦ худалч.

ЛЖИ́ВОСТЬ хуурамч, худал.

ЛЖИ́В||ЫЙ худал, хуурмаг, худал хуурмаг; ~**ое заявление** худал хуурмаг мэдэгдэл.

ЛИ (ЛЬ) I уу, юү; **вряд** ~ хай даа; **едва** ~ юү бол доо; **едва** ~ не бараг; арай л; **мало** ~ бага гэж үү

ЛИ (ЛЬ) II уу□уу, алин боловч, уу, эсэхүл□уу; **рано** ~, **поздно, но приду** эрт, орой алин боловч ирнэ; **видел** ~ **он это или не видел —неизвестно** тэр үүнийг харсан уу, үгүй юу, мэдэхгүй; **сегодня** ~, **завтра ли** өнөө юү, маргааш уу.

ЛИА́НА ороонго, чөдөр ургамал.

ЛИБЕРА́Л 1. либерал, либерализмыг баримтлагч; 2. либерал намын гишүүн; 3. эвлэрэнгүй үзэлтэн

ЛИБЕРА́ЛЬНИЧАТЬ эвлэрэнгүй үзэл гаргах, хэт хүлцэх.

ЛИБЕРА́ЛЬН||ЫЙ 1. либерал; ~**ая партия** либерал нам; ~ **взгляд** либерал үзэл; 2. эвлэрэнгүй, хүлцэнгүй; ~**ые речи** хүлцэнгүй үг.

ЛИ́БО нэг бол, эсэхүүл, уу, үү; ~ **уехать,** ~ **остаться** нэг бол явах, нэг бол үлдэх; ~ **тот — ~ другой** энэ нь үү, нөгөөдөх нь үү.

ЛИБРЕ́ТТО цомог зохиол, сэдэв зохиол (*дуурь, хөгжмийн зохиолын үг*).

ЛИ́ВЕНЬ ширүүн бороо, аадар бороо.

ЛИ́ВЕР хярамцаг, гэдэс дотор; **телячий** ~ тугалын хярамцаг.

ЛИ́ВЕРНЫЙ хярамцгийн, гэдэс дотроор хийсэн.

ЛИВРЕ́Я зарцын хувцас, хаалгачийн хувцас.

ЛИ́ГА холбоо, нэгдэл; ~ **Наций** Олон Үндэстний Холбоо.

ЛИГАТУ́РА I холио, хайлш, холиотой металл.

ЛИГАТУ́РА II нийлмэл үсэг.

ЛИГНИ́Т хүрэн нүүрс.

ЛИ́ДЕР 1. удирдагч; ~ **партии** намын удирдагч; 2. магнай; ~ **турнира** тэмцээний магнай.

ЛИ́ДЕРСТВО 1. удирдах, удирдагч болох; 2. магнайлах; магнайлал.

ЛИДИ́РОВАТЬ магнайлах.

ЛИЗА́ТЬ долоох, нахилзах, долдгонох.

ЛИ́ЗИНГ санхүүгийн түрээс, лизинг.

ЛИЗИНГОДА́ТЕЛЬ түрээслүүлэгч.

ЛИЗИНГОПОЛУЧА́ТЕЛЬ түрээслэгч.

ЛИЗНУ́ТЬ долоогоод авах, долоочлох.

ЛИЗОБЛЮ́Д улы нь долоогч, зусарч, долигонуур.

ЛИЗОБЛЮ́ДНИЧАТЬ улы нь долоох, зусардах, долигонох.

ЛИК нигуур, гэгээ, царай, дүр.

ЛИКВИДА́ТОР ликвидатор, устгагч.

ЛИКВИДАЦИО́НН||ЫЙ устгах, татан буулгах; ~**ая комиссия** татан буулгах комисс

ЛИКВИДА́ЦИЯ 1. устгах, устгалт; ~ **безграмотности** бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах; 2. татан буулгах, дуусган буулгах; ~ **треста** трестийг татан буулгах; ~ **дел** хэргийг дуусган буулгах.

ЛИКВИ́ДНОСТЬ хөрвөх чадвар.

ЛИКВИДИ́РОВАТЬ 1. устгах, үгүй хийх; 2. татан буулгах, дуусган татах, ~ **свои дела** хэргээ дуусгах.

ЛИКЁР ликёр дарс.

ЛИКЁРН||ЫЙ ликёрийн; ~**ая рюмка** ликёрийн жүнз.

ЛИКОВА́НИЕ хөхөх, хөөрөх.

ЛИКОВА́ТЬ хөхөх, хөөрөх; **народ ликует** ард түмэн хөөрнө; **сердце ликует** сэтгэл хөөрнө.

ЛИЛИПУ́Т одой хүн.

ЛИ́ЛИЯ сараана, сараанын цэцэг.

ЛИЛО́ВЫЙ хөх ягаан.

ЛИМА́Н мөрний адгийн булан.

ЛИМИ́Т хэмжээ хязгаар; ~ **импорта** гадаадаас бараа оруулах хэмжээ хязгаар; **максимальный** ~ хамгийн их хэмжээ хязгаар.

ЛИМИТИ́РОВАТЬ хэмжээ хязгаар тогтоох.

ЛИМИ́ТН||ЫЙ хэмжээ хязгаар болох, хэмжээ хязгаартай; ~**ые цены** хэмжээ хязгаар болох үнэ.

ЛИМО́Н нимбэг.

ЛИМОНА́Д нимбэгийн ундаа.

ЛИМО́ННЫЙ нимбэгийн; ~ **сок** нимбэгийн шүүс; ~**ая кислота** нимбэгийн хүчил.

ЛИМУЗИ́Н лимузин тэрэг, тансаг машин.

ЛИ́МФА тунгалаг (хүн амьтны бүхий биед тарж байдаг шингэн зүйл).

ЛИМФАТИ́ЧЕСКИЙ тунгалагийн; ~ **проток** шар усны урсуур.

ЛИНГВИ́СТ хэлний шинжлэгч.

ЛИНГВИ́СТИКА хэлний шинжлэл; **общая** ~ ерөнхий хэлний шинжлэл.

ЛИНГВИСТИ́ЧЕСК||ИЙ 1. хэлний шинжлэлийн; ~**ое исследование** хэлний шинжлэлийн шинжилгээ; 2. хэлний; ~**ие явления** хэлний үзэгдэл.

ЛИНЕ́ЙК||А шугам; **тетрадь в косую** ~**у** ташуу шугамтай дэвтэр; **логарифмическая** ~ логарифмын шугам.

ЛИНЕ́ЙН||ЫЙ 1. уртын, шугамын, зураасан; ~ **поток** шугаман урсгал; ~**ые меры** уртын хэмжүүр; 2. жагсаалын; ~**ые войска** жагсаалын цэрэг; ~ **корабль** жагсаалын онгоц.

ЛИ́НЗА 1. галт шил; 2. линз.

ЛИ́НИ||Я 1. шугам зураас; **прямая** ~ шулуун шугам; ~ **горизонтальная** хэвтээ шугам; 2. чиг, чиглэл, хил, зааг; ~ **горизонта** газар тэнгэрийн зааг; ~ **прицела** шагайх чиг; 3. шугам, эгнээ; ~ **укрепления** бэхлэлтийн шугам; 4. зам, шугам; **пароходная** ~ галт, хөлөг онгоцны зам; ~ **электропередачи** цахилгаан дамжуулах шугам; 5. тал, шугам, зүг; **по профсоюзной** ~**и** үйлдвэрчний эвлэлийн шугамаар; 6. зураа; ~ **лопаточная** далны зураа.

ЛИНКО́Р жагсаалын онгоц.

ЛИНОВА́ЛЬН||ЫЙ шугамдах; ~**ая машина** шугамдах машин.

ЛИНО́ВАНН||ЫЙ шугамтай, шугамдсан; ~**ая бумага** шугамтай цаас.

ЛИНОВА́ТЬ шугамдах,

ЛИНО́ЛЕУМ зузаан хулдаас, линолеум.

ЛИНОТИ́П линотип (*үсэг мөр мөрөөр нь цутгадаг машин*).

ЛИНОТИ́ПНЫЙ линотипын; ~ **набор** линотипын өрлөг.

ЛИНТ хөвөөр; ~ **хлопковый** хөвөнгийн хөвөөр.

ЛИНЧ суд **~а** линчийн шүүх.
ЛИ́НЬКА гуужих, зулмах, хөөвөр.
ЛИНЮ́ЧИЙ онгодог, ганддаг, будаг нь гардаг.
ЛИНЯ́ЛЫЙ өнгө алдсан, онгосон, гандсан.
ЛИНЯ́НИЕ гуужих, зулмах.
ЛИНЯ́ТЬ 1. өнгө алдах, онгох, гандах; 2. хөөвөрлөх, гуужих, зулмах.
ЛИ́ПА I далдуу мод, зөөлөн цагаан мод.
ЛИ́ПА II хуурамч юм.
ЛИПАРИ́Т *минер.* аралж.
ЛИПИ́ДЫ өөх, липид.
ЛИ́ПК||ИЙ *наалданги, наалдангир;* **~ая грязь** *наалданги шавар.*
ЛИПНУ́ТЬ 1. наалдах; **платье, насквозь промокшее от дождя, липло к телу** бороонд нэвтэрсэн хувцас биенд наалдав; 2. наалдах; наалдаад салахгүй байх, салахгүй хоргоох.
ЛИ́ПОВЫЙ I далдуугийн, зөөлөн цагаан; **~ цвет** далдуугийн цэцэг.
ЛИ́ПОВ||ЫЙ II, хуурамч; **~ая работа** хуурамч ажил.
ЛИПУ́ЧКА *бот.* ноцоргоно.
ЛИ́РА I 1. лир хөгжим (*эртний грекийн чавхдаст хөгжим*); 2. яруу найргийн сүлд.
ЛИ́РА II лир зоос (*Италийн мөнгөний нэгж*).
ЛИРИ́ЗМ 1. уянга, уянгат чанар; 2. уяралт сэтгэл, уярал.
ЛИ́РИК утга уянгач.
ЛИ́РИКА 1. утга уянга; 2. утга уянгын зохиол; 3. уяралт сэтгэл, уярал.
ЛИРИ́ЧЕСК||ИЙ 1. утга уянгат, уянгат, утга уянгын; **~ое стихотворение** утга уянгын шүлэг; 2. утга уянгын, уянгат, уянгат хоолойтой; **~ тенор** уянгат цээл хоолой; 3. уяралт, уяралтай; **~ое отступление** а) утга уянгын гажилт; гажих уянгалан өгүүлэх; б) яриандаа болж шал ондоо юм хэлэх.
ЛИС||А́ үнэг; **~ой прикидываться** үнэг шиг шарваганах; үнэгэн заль гаргах; **хитрый как ~** үнэг шиг зальтай
ЛИСЁНОК гавар (*үнэгний зулзага*).
ЛИ́С||ИЙ үнэгний; үнэгэн; **~ья шапка** үнэгэн малгай; **~ мех** үнэгний арьс.
ЛИСИ́ЦА үнэг; эм үнэг; **чёрно-бурая ~** халтар үнэг.
ЛИСИ́ЧКА үнэгхэн, бяцхан үнэг.
ЛИСИ́ЧКИ үнэгэн мөөг.
ЛИСТ I навч; **зелёные ~ья** ногоон навчис; **дрожать как осиновый ~** улиасны навч шиг чичрэгнэх.
ЛИСТ II 1. хуудас, гөлөм; **~ из тетради** дэвтрийн хуудас; **~ железа** гөлөм төмөр; **~ гофрированный** долгионтой хуудас; 2. хуудас; **авторский ~** зохиогчийн хуудас; 3. бичиг баримт; хуудас; **опросный ~** байцаах хуудас.4. **~ ожидания** хүлээлгэнд.
ЛИСТА́Ж хэвлэлийн хуудасны тоо.
ЛИСТА́ТЬ хуудас эргүүлэх; **~ страницы** хуудас эргүүлэх.
ЛИСТВА́ навчис, навч намаа, навч нахиа; **молодая ~** шинэ навчис; залуу навчис.
ЛИ́СТВЕННИЦА шинэс.
ЛИ́СТВЕННЫЙ навчит; **~ лес** навчит мод, навчит ой.
ЛИСТО́ВКА агитационная ~ ухуулах хуудас.
ЛИСТОВ||О́Й нимгэн хавтгай, навчин гөлөм, хуудсан; **~ табак** навчин тамхи; **~ое железо** гөлөм төмөр.
ЛИСТО́К I бяцхан навч.
ЛИСТО́К II хуудас; **контрольный ~** шалгах хуудас.
ЛИСТОПА́Д навч унах; навч зулгарах.
ЛИТА́ВРЫ яруу хэнгэрэг.
ЛИТЕ́ЙНАЯ цутгах газар.
ЛИТЕ́ЙН||ЫЙ цутгах, цутгадаг; **~ завод** цутгах завод; **~ая форма** цутгах хэв; **~ые поддоны** хэвийн суурь
ЛИТЕ́ЙЩИК цутгагч, цутгуурч.
ЛИ́ТЕР үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй явах үнэмлэх.
ЛИ́ТЕРА үсэг, үсгийн хэв.
ЛИТЕРА́ТОР зохиолч, бичгийн хүн.
ЛИТЕРА́ТОРСКИЙ зохиолчийн, бичгийн хүний.
ЛИТЕРАТУ́Р||А утга зохиол, зохиол; **художественная ~** уран зохиол; **теория ~ы** утга зохиолын онол; **политическая ~** улс төрийн зохиол.
ЛИТЕРАТУ́РН||ЫЙ 1. утга зохиолын, зохиолын, бичгийн; **~ язык** бичгийн хэл; 2. бичгийн хэлний; **~ стиль** бичгийн хэлний найруулга; **~ое выражение** хэлний хэллэг, бичгийн хэлний үг; 3. зохиолчийн, бичгийн хүмүүсийн; **~ые круги** зохиолчдын хүрээ; бичгийн хүмүүс.
ЛИТЕРАТУРОВЕ́Д утга зохиолч, утга зохиол судлагч.
ЛИТЕРАТУРОВЕ́ДЕНИЕ утга зохиолын судлал.
ЛИ́ТЕРН||ЫЙ, үсэгтэй; **~ая ложа** үсгээр тэмдэглэсэн лоож.
ЛИТО́ВЕЦ литв хүн.
ЛИТО́ВКА 1. литв эмэгтэй; 2. гар хадуур.
ЛИТО́ВСКИЙ литв, литвийн; **~ язык** литва хэл.
ЛИТОГЕНЕ́З чулуулаг үүсэх үйл явцын цогц.
ЛИТО́ГРАФ чулуун барч.
ЛИТОГРАФИ́РОВАТЬ барлах, чулуун бараар хэвлэх.
ЛИТОГРА́ФИЯ 1. чулуун хэв, чулуун бар; 2. чулуун барт үйлдвэр; 3. чулуун барын зураг.
ЛИТОГРА́ФСКИЙ чулуун барын.
ЛИТО́Й цутгамал, цутгасан; **~ые изделия** цутгамал эдлэл.
ЛИТР литр (*эзлэхүүний хэмжүүр*).
ЛИТРО́В||ЫЙ литрийн; **~ая бутылка** литрийн шил.
ЛИТЬ I 1. асгах, цутгах, хийх; **~ воду** ус асгах; 2. асгарах, цутгарах; гоожих; **дождь льёт** бороо цутгаж байна; 3. анхилах, цацрах; **лампа льёт свет** дэнгийн гэрэл цацарна.
ЛИТЬ II цутгах, **~ пушки** их буу цутгах.
ЛИТЬЁ 1. цутгах; 2. цутгамал (эдлэл); **чугунное ~** ширмэн цутгамал
ЛИ́ТЬСЯ 1. асгарах, гоожих; **кровь льётся из раны** шархнаас цус гоожно; 2. цацрах, хангинан жингэнэх; **песня лилась** дуу хангинан жингэнэнэ.
ЛИ́ФТ өргүүр; лифт; өргөдөг шат.
ЛИФТЁР өргүүрч; лифтэч.
ЛИ́ФЧИК хөхөвч, хүүхдийн мөрөвч; цээжний даруулга.
ЛИХА́Ч идэрхэгч, хавархагч.
ЛИХА́ЧЕСТВО идэрхэгч зан; хавархсан явдал.
ЛИХВ||А́ с ~ой бардаагаар, илүүдэлтэйгээр; **хватит с ~ой** бардаагаар хүрнэ.
ЛИ́ХО I муу; **не поминай меня ~м** намайг битгий муу хэлээрэй.
ЛИ́ХО II идэрхэг, хавархаг.
ЛИХОДЕ́Й хорлогч.
ЛИХОИ́МСТВО хахууль авах; хүү үржүүлэх; мөнгө хүүлэх.
ЛИХ||О́Й I муу, хорон; **~а беда начало** эхлэх л хэцүү байдаг.
ЛИХО́Й II идэрхэг, хавархаг, эрдүү; **~ вид** идэрхэг байдал.
ЛИХОРА́ДИТЬ халуурах, чичрэглэх.
ЛИХОРА́ДК||А чичрэг; **перемежающаяся ~** улирах чичрэг, хумхаа, догонцог халуурал; **приступ ~и** чичрэг хөдлөх.
ЛИХОРА́ДОЧН||ЫЙ 1. халууны, чичрэгийн, халуунтай; **~ озноб** халуурч жихүүцэх; 2. тэчьяадсан; **~ое нетерпение** тэчьяадан хүлээх.
ЛИ́ХОСТЬ идэрхэг явдал, хавархаг зан, эрдүү.
ЛИЦЕВА́ТЬ эргүүлэн оёх, дотры нь гадагш гарган оёх,
ЛИЦЕВ||О́Й 1. нүүрний; **~ нерв** нүүрний нерв; 2. гадна, гадар, өнгөн, зөв; **~ая сторона материи** бөсийн зөв тал; 3. урд, нүүр; **~ая сторона здания** барилгын нүүр тал.
ЛИЦЕЗРЕ́ТЬ нүүр учрах, нүүр тулах.

ЛИЦЕ́ИСТ лицейн сурагч.
ЛИЦЕ́Й лицей.
ЛИЦЕ́ЙСКИЙ лицейн, лицейн үеийн.
ЛИЦЕМЕ́Р бялангач, гоёч хүн, засдаг хүн.
ЛИЦЕМЕ́РИЕ бялангач зан, гоёч явдал, засдаг зан.
ЛИЦЕМЕ́РИТЬ бялангачлах, гоёчлох, засдаглах.
ЛИЦЕМЕ́РНЫЙ гоёч, засдаг.
ЛИЦЕ́НЗИЯ тусгай зөвшөөрөл, бараа нэвтрүүлэх зөвшөөрөл, лицензи.
ЛИЦ||О́ лица, лиц, лицам 1. нүүр, царай, зүс; **~ом к ~у** нүүр нүүрээрээ; улаан нүүрээрээ; 2. хүн; **должностное ~** албаны хүн; 3. нүүр, нүүр царай, өнгө зүс; 4. гадар; нүүр, өвөр тал; өнгөн тал; зөв тал; **показать товар ~ом** юмны сайн талыг харуулах; **~ом к чему-либо** анхаарлаа хандуулах; **от ~а кого-либо** хүний нэрийн өмнөөс; **перед ~ом кого-либо** хүний өмнө; **стереть с ~а земли** газрын хөрснөөс арилган устгах.
ЛИ́ЧИКО бяцхан нүүр, бяцхан царай; **миловидное ~** хөөрхөн царай, цэвэрхэн нүүр; **открой ~, Гульчатай!** царайгаа харуулаач Гульчатай!
ЛИЧИ́Н||А хуурамч царай, хуурамч нүүр; **под ~ой** хуурамч царай гаргаж.
ЛИЧИ́НКА авгалдай, өт; **~ моли** хүрд.
ЛИЧИ́НОЧНЫЙ авгалдай, өтний.
ЛИ́ЧНО нүүрээрээ, биеэрээ, өөрөө; **явиться ~** биеэрээ ирэх, өөрөө ирэх.
ЛИ́ЧНОСТ||Ь бие, хүн; **удостоверение ~и** биеийн үнэмлэх; **известная ~** нэрд гарсан хүн
ЛИ́ЧН||ЫЙ 1. амины; хувийн; өөрийн; **~ое дело** амины хэрэг; хувийн хэрэг; 2. биеийн, **~ое местоимение** биеийн төлөөний үг.
ЛИША́Й I хаг өвс.
ЛИША́Й II үлд; **~ блестящий** гялгар үлд.
ЛИША́ЙНИК хаг өвс.
ЛИША́ТЬ хасах, салгах, үгүй болгох.
ЛИША́ТЬСЯ үгүй болох, алдах, хагацах, хасагдах.
ЛИ́ШЕК илүү, гаран; **отдать ~ назад** илүүгийн нь буцааж өгөх; **два часа с лишком** хоёр цаг гаран.
ЛИШЕ́НИЕ 1. хасах; хасагдах; хасалт; **~ прав** эрхээ хасагдах, эрхий нь хасах; 2. гачигдал, гачигдал дутагдал; **терпеть ~** гачигдаж дутагдах.
ЛИШИ́ТЬ хасах, салгах, үгүй хийх; **~ куска хлеба** аяга хоолноос нь салгах; **~ кого-либо прав** эрхий нь хасах; **~ себя жизни** амиа хорлох.
ЛИШИ́ТЬСЯ үгүй болох, алдах, хагацах, хасагдах; **~ сна и аппетита** нойр хоолноос гарах, нойр хоол алдах; **~ места** албан ажлаас хасагдах; **~ чувств** муужрах, ухтгэн унах.
ЛИ́ШН||ИЙ 1. илүү; **~не деньги** илүү мөнгө; 2. илүү, илүүц; хэрэггүй; **~ие расходы** илүү зардал; **кто покупает ~ее, в конце концов продает необходимое** илүүц юм худалдан авдаг хүн эцсийн эцэст хэрэгтэй юмаа худалдахад хүрдэг; 3. бас; **взглянуть ~ раз** бас дахин харах.
ЛИ́ШЬ 1. дөнгөж л; **одного человека ~ нет** нэг л хүн үгүй байна; 2. **~ только солнце взошло, мы отправились в путь** нар гармагц бид хөдлөв.
ЛОБ магнай, дух; **высокий ~** өргөн магнай; **в ~ халз; семи пядей во лбу** их ухаантай; **на лбу написано** царайгий нь харахад илхэн духан дээр нь бичээстэй.
ЛО́ББИ улс төр эдийн засгийн шийдвэр гаргахаар нөлөөлөх зуучлагчид.
ЛОБЗА́НИЕ озох.
ЛОБЗА́ТЬ озох.
ЛО́БН||ЫЙ магнайн, духны; **~ая кость** магнайн яс; **~ая доля** магнайн хэлтэрхий; **~ое место** цаазын индэр.
ЛОБОВ||О́Й халз, чанх урдаас; **~ая атака** чанх урдаас нь дайрах, халз дайрах.
ЛОБОГРЕ́ЙКА хадуур машин.
ЛОБО́К умдаг.
ЛОБОТРЯ́С занхгар амьтан, хоосон цээж, ханхалзуур.
ЛОБЫЗА́ТЬ озох.
ЛОВ, барих, агнах, гөрөөлөх.
ЛОВЕЛА́С эмсэг хүн, охидын эрлэг.
ЛОВЕ́Ц загасчин, анчин, гөрөөчин; **на ловца и зверь бежит** сайн хүн санаагаараа.
ЛОВИ́ТЬ ~ рыбу в мутной воде сайн эр самбаанд, саарал чоно бороонд; **~ момент** самбаачлах; **~ кого-либо на слове** ам алдуулах.
ЛОВКА́Ч арга баширтай хүн, арга мэхтэй хүн.
ЛО́ВКИЙ 1. дүйтэй, шаламгай, онгтой; 2. арга баширтай, арга мэхтэй.
ЛО́ВКОСТЬ дүй, онч, шаламгай, арга, башир, ид.
ЛО́ВЛЯ барих, агнах, гөрөөлөх; **рыбная ~** загас барих.
ЛОВУ́ШК||А занга, хавх, урхи, анаа; **попасть в ~у** урхинд орох; хавханд орох.
ЛОГ жалга, судаг.
ЛОГАРИ́ФМ логарифм; **таблица ~ов** логарифмын хүснэгт.
ЛОГАРИФМИ́ЧЕСК||ИЙ логарифмын; **~ая линейка** логарифмын шугам.
ЛО́ГИКА 1. учир зүй; учир шалтгааны ухаан; логик; 2. дотоод зүй тогтоол; **~ вещей** юмсын дотоод зүй тогтоол
ЛОГИ́ЧЕСК||ИЙ 1. учир зүйн; логикийн; **~ая категория** учир зүйн ай; логикийн ай; 2. зүй тогтоолтой; зүйд нийлсэн; эрэмбэ дараатай; **~ вывод** зүй тогтоолтой дүгнэлт.
ЛОГИ́ЧНОСТЬ зүй тогтоолтой юм, зүйд нийлсэн явдал, эрэмбэ дараатай юм; **~ поступка** зүй тогтоолтой явдал.
ЛОГИ́ЧНЫЙ зүй тогтоолтой, зүйд нийлсэн, эрэмбэ дараатай.
ЛО́ГОВИЩЕ,
ЛО́ГОВО ичээ, хэвтэш, ноохой, үүр; **~ врага** дайсны үүр.
ЛО́ДК||А завь, суман онгоц; **спасательная ~** аврах завь; **кататься на ~е** завиар зугаацах.
ЛО́ДОЧКА бяцхан завь.
ЛО́ДОЧНИК завьч.
ЛО́ДОЧНЫЙ завийн; **~ спорт** завийн спорт.
ЛОДЫ́ЖКА шагай.
ЛО́ДЫРНИЧАТЬ дэмий сэлгүүцэх, залхуурах.
ЛО́ДЫРЬ дэмий сэлгүүцэгч, залхууч, анхаг, залхуу.
ЛО́ЖА I хуй мод (*бууны*).
ЛО́ЖА II лоож.
ЛОЖБИ́НА нарийн судаг.
ЛО́ЖЕ 1. хэвтэр, хэвтэш; 2. гулдрил.
ЛО́ЖЕЧКА I бяцхан халбага.
ЛО́ЖЕЧК||А II болит под ~ой аюулхай өвдөж байна.
ЛОЖИ́ТЬСЯ 1. хэвтэх; 2. бүрхэх, хучих; 3. оногдох, тусах, дарах; 4. орж явах, барьж явах.
ЛО́ЖК||А халбага; **чайная ~** цайны халбага; жижиг халбага; **столовая ~** хоолны халбага; том халбага; **в час по чайной ~е** их удаан.
ЛО́ЖНОСТЬ хуурмаг юм, худал юм; **~ сведений** худал мэдээ.
ЛО́ЖН||ЫЙ 1. хуурмаг; худал, буруу; **~ые слухи** худал цуурхал; 2. хуурамч, өнгөний; **~ая скромность** хуурамч даруу зан.
ЛОЖЬ худал хуурмаг юм; **сплошная ~** далан худал; **явная ~** илэрхий худал; илт худал.
ЛОЗА́ лоз, лозам, ороонго; **виноградная ~** үзмийн ороонго.
ЛОЗНЯ́К удын бут, уд.
ЛО́ЗУНГ уриа, лоозон.

ЛОКАЛИЗА́ЦИЯ байршуулах, нэг газар тогтоох, хязгаарлах; **~ болезненных процессов** өвчний явцын байршил.
ЛОКАЛИЗОВА́ТЬ байршуулах, нэг газар тогтоох, хязгаарлах.
ЛОКАЛИЗОВА́ТЬСЯ байрших, нэг газар тогтох.
ЛОКА́ЛЬНЫЙ нутгийн, тус газрын.
ЛОКОМОБИ́ЛЬ уурын хөдөлгүүр, локомобиль.
ЛОКОМОТИ́В бух тэрэг, локомотив (*галт тэрэгний толгой*); зүтгүүр.
ЛОКОМОТИ́ВНЫЙ бух тэрэгний, локомотивын; зүтгүүрийн.
ЛО́КОН туг үс, мушгиа үс
ЛО́КОТЬ тохой; **с продранными локтями** тохой нь цоорсон; **близок ~, да не укусишь** хазъя гэхэд алга хол, харъя гэхэд чих хол.
ЛОКТЕВ||О́Й тохойн, царвууны; **~ая кость** царвууны яс, богтос; **~ отросток** залаа яс, тохойн сэртэн.
ЛОМ 1. царил; 2. эвдэрхий төмөр; хаягдал, **~ рельсов** хаягдал зам төмөр.
ЛОМА́КА маягтай хүн; тунирхуу хүн.
ЛО́МАНН||ЫЙ 1. эвдэрхий; хугархай; **~ые вещи** эвдэрхий юм; 2. хазгай; **говорить на ~ом русском языке** орос хэлээр хазгай ярих; **это ~ого гроша не стоит** сохор зоосны үнэгүй юм.
ЛОМА́НЬЕ маяглах, тунирхах.
ЛОМА́ТЬ 1. эвдэх; хугалах; хагалах; **~ лёд** мөс хагалах; 2. эвдэх; нуга дарах; эрс өөрчлөх; **~ старые порядки** хуучин журам эвдэх; **~ сопротивление врага** дайсны эсэргүүцлийг дарах; 3. янгинах; шархирах; **меня всего ломает** миний хамаг бие янгинаж байна; **~ голову над чем-либо** юмыг ойлгож ядах.
ЛОМА́ТЬСЯ I 1. эвдрэх; хагарах; хугарах; 2. хувилах; бүдүүн болох; **у мальчика ломается голос** энэ хүүгийн хоолой нь бүдүүн болж байна.
ЛОМА́ТЬСЯ II маяглах, тунирхах; **не ломайся!** битгий маягла!
ЛОМБА́РД ломбард, барьцаалан зээлдүүлэх газар; **заложить в ~** ломбардад юм барьцаалуулах.
ЛОМБА́РДНЫЙ ломбардын.
ЛОМБЕ́РНЫЙ ~ стол хөзрийн ширээ
ЛОМИ́ТЬ1. нахийлгах; хотойлгох; нугалах; **спелые яблоки ломят сучья** болсон алим мөчрөө нахийлгана; 2. түрэн орох; **~ напролом** шууд түрэн орох; 3. ярхирах; жингэнэн өвдөх; **ломит поясницу** зоо нуруугаар ярхиран өвдөнө.
ЛОМИ́ТЬСЯ 1. хотойх; нахийх; **полки ломятся от книг** ном дарж тавиур хотойж байна; 2. (*хүчээр*) түрэн орох гэх **~ в дверь** хаалгаар түрэн орох гэх.
ЛО́МКА эвдэх, хугалах, хагалах.
ЛО́МКИЙ хэврэг, эвдрэмтгий, хугарамтгай.
ЛО́МКОСТЬ хэврэг байх, эвдрэмтгий байх, хугарамтгай байх.
ЛОМОВ||О́Й ачааны, тээврийн; **~ая лошадь** тээврийн морь..
ЛОМОНО́С *бот.* зөдгөр өвс.
ЛОМОТА́ яс ярхирах, янгинах.
ЛОМО́ТЬ зүсэм, хэрчим; **отрезанный ~** толгойгоо даасан хүн, амиа тээхтэй болох.
ЛО́МТИК зүсэм, хэрчим; **~ лимона** зүсэм нимбэг.
ЛОНЖЕРО́Н тэрэгний арлын гуя.
ЛО́Н||О өвөр, хормой; **на ~е природы** эрүүл салхинд.
ЛОНША́К нас хүрээгүй бамбарууш.
ЛО́ПАСТН||ЫЙ далавчтай, хүрзтэй, сэлүүртэй; **~ое колесо** сэлүүртэй дугуй.
ЛО́ПАСТЬ далавч, хүрз, сэлүүр; **~ винта** сэнсний далавч.
ЛОПА́ТА хүрз.
ЛОПА́ТКА I бяцхан хүрз.
ЛОПА́ТК||А II дал; **положить кого-либо на обе ~и** хоёр далы нь шороодох; *** бежать во все ~и** тэнхээ мэдэн гүйх; хар гүйхээрээ дутаах.
ЛО́ПАТЬСЯ дэлбэрэх, тэсрэх, хагарах.
ЛОПА́ТОЧНЫЙ далны; **~бугор** далны товгор.
ЛОПНУ́||ТЬ 1. хагарах; тэсрэх; дэлбэрэх, тасрах; **струна ~ла** чавхдас тас үсрэв; 2. балрах; сүйрэх; **всё дело ~ло** бүх хэрэг балрав; 3. үгүй болох; тасрах; **терпение ~ло** тэсэх арга тасрав.
ЛОПОТА́ТЬ шулганах, тол тол гэх.
ЛОПОУ́ХИЙ дэлдэн, дэлбэгэр чихтэй.
ЛОПУ́Х даливс өвс.
ЛОРД лорд; **палата ~ов** лордын танхим.
ЛОРНЕ́Т лорнет; бариултай нүдний шил.
ЛОСЁНОК ходол (*хандгайн зулзага*).
ЛОСИ́НА хандгайн арьс.
ЛОСИ́Н||ЫЙ хандгайн; **~ые рога** хандгайн эвэр.
ЛОСИ́ХА сүндэс (*эм хандгай*).
ЛОСК 1. гялгар; гөлгөр; **наводить ~** гялгар болгох; 2. гялгар цалгар; **внешний ~** өнгөний гялгар цалгар.
ЛОСКУ́Т өөдөс, үртэс.
ЛОСКУ́ТН||ЫЙ өөдсөөр хийсэн; **~ое одеяло** өөдсөөр хийсэн хөнжил.
ЛОСНИ́ТЬСЯ гялалзах, гөлийх.
ЛОСО́СЬ яргай загас, хулд загас.
ЛОСЬ хандгай, **~ самец** манж.
ЛОТ далайн гүний хэмжүүр.
ЛОТЕРЕ́ЙНЫЙ сугалааны; **~ билет** сугалааны билет
ЛОТЕРЕ́||Я сугалаа; **разыгрывать ~ю** сугалаа сугалах.
ЛОТО́ лотоо тоглоом.
ЛОТО́К 1. хайрцаг; 2. ховоо, хошуу.
ЛО́ТОС бадам лянхуа.
ЛОТО́ЧНИК хайрцгийн худалдаачин.
ЛОХ 1. *бот.* жигд; 2. түмпэн толгой, маанаг; **~ов разводить** түмпэн толгойт хүмүүсийг панаалдах.
ЛОХА́НКА торх, модон онгоц; **почечная ~** бөөрийн тэвш.
ЛОХА́НЬ торх, модон онгоц.
ЛОХМА́ТИТЬ бүрзийлгэх, сэглийлгэх, сэгсийлгэх; **~ волосы** үс сэгсийлгэх; **~ бабушку** (*разг*) дэмий ярих, цаасан малгай өмсгөх.
ЛОХМА́ТИТЬСЯ бүрзийх, сэглийх, сэгсийх.
ЛОХМА́ТЫЙ 1. сахлаг үстэй, бавгар; 2. бүрзгэр, сэглэгэр, сэгсгэр.
ЛОХМО́ТЬЯ ноорхой, уранхай, навтархай; **в ~х** навтархай болсон хувцастай.
ЛОХОТРО́Н *разг.* тэнэг хүмүүсээс мөнгө сэгсрэх.
ЛО́ЦМАН лоцман, усан онгоцны замчин.
ЛОШАДИ́Н||ЫЙ морины, адууны; **~ая доза** их тун эм.
ЛОША́ДКА морьхон, морь.
ЛО́ША́Д||Ь морь, адуу; **упряжная ~** тэрэгний морь; **скаковая ~** хурдан морь; **ехать на ~и** мориор явах; **~ разуздывать** морь амгайвчлах.
ЛОША́К хөдий луус (*азарга*; *гүү илжиг хоёроос гарна*).
ЛОЩЁНЫЙ гөлгөр, гялгар, зүлгэсэн.
ЛОЩИ́НА хотгор, хөндий.
ЛОЩИ́ТЬ гялайлгах, гөлийлгөх, зүлгэх.
ЛОЯ́ЛЬНОСТЬ зүйг баримтлах, төвийг сахих.
ЛОЯ́ЛЬНЫЙ зүйг баримталсан, төвийг сахисан.
ЛУБ лубья, дол, дурс.
ЛУБО́К 1. дол, дурс; 2. чиг; **накладывать лубки** чиг барьж уях; 3. *модон барын* бүдүүн зураг; ардын зураг хуудас
ЛУГ нуга; хадлан; **зелёный ~** ногоон нуга; **альпийские луга** уулын нуга; **заливные ~а** усанд автдаг хадлан.
ЛУГОВО́ДСТВО нуга ашиглах, нуга ашиглалт.
ЛУГОВ||О́Й нугын, хадлангийн; **~ая трава** нугын өвс.

ЛУДИ́ЛЬЩИК тугалга зайлагч.
ЛУДИ́ТЬ тугалга зайлах.
ЛУ́ЖА шалбаа, шалбааг.
ЛУЖА́ЙКА ойн цоорхой, ойн захын нуга.
ЛУЖЕ́НИЕ тугалга гүйлгэх, тугалга зайлах.
ЛУЖЁН||ЫЙ тугалга зайлсан; **~ая посуда** тугалга зайлсан сав.
ЛУ́ЗА бильярдын ширээний нүх.
ЛУЗГА́ хальс.
ЛУ́ЗГАТЬ цөмөх; ~ **орехи** самар цөмөх.
ЛУ́ЗЕР *разг* баартаг.
ЛУК I нум; **стрелять из ~а** нум сум харвах; ~ **и стрела** нум сум хоёр
ЛУК II сонгино; **головка ~а** сонгинын толгой; **алтайский ~** зэрлэг сонгино; ~ **многокорешковый** таана; **~порей** гогод; ~ **монгольский** хөмөл; ~ **репчатый** бөөрөнхий сонгино; ~ **шалот** ногоон сонгино.
ЛУКА́ I тохой голын.
ЛУКА́ II эмээлийн бүүрэг.
ЛУКА́ВЕЦ бачтай хүн, бааштай хүн.
ЛУКА́ВИТЬ бачлах, баашлах.
ЛУКА́ВОСТЬ бач, бааш, бачтай (байх), бааштай (байх).
ЛУКА́ВСТВО бач, бааш, бачлах, баашлах.
ЛУКА́ВЫЙ 1. муу зальтай, мэхтэй; 2. бачтай, бааштай.
ЛУ́КОВИЦА 1. төмс; булцуу; ~ **тюльпана** алтан зул цэцгийн төмс; ~ **волоса** үсний булцуу; 2. (*сонгино, саримсийн*) толгой.
ЛУ́КОВИЧН||ЫЙ төмст; булцуут; **~ые растения** булцуут ургамал
ЛУКОМО́РЬЕ тэнгисийн булан.
ЛУКО́ШКО дурсан саго, шээгий.
ЛУН||А́ сар; **полная** ~ тэргэл сар; **ущерб ~ы** дордын хагас; **при свете ~ы** сарны гэрэлд; **фазы ~ы** шинэ хуучин сар; **серп ~ы** хавирган сар.
ЛУНАТИ́ЗМ зүүдэн өвчин.
ЛУНА́ТИК зүүдэн өвчтэй хүн.
ЛУ́НКА хонхорхой, нүх; углуурга.
ЛУ́НН||ЫЙ сарны, сартай, билгийн; ~ **свет** сарны гэрэл; **~ая ночь** сартай шөнө; ~ **месяц** билгийн сар
ЛУНЬ сар (*шувуу*); **седой как ~, белый как** ~ сар шувуу шиг буурал; цал буурал.
ЛУ́ПА томруулдаг шил, галт шил; ~ **бинокулярная** хоёр нүдний томрулагч шил..
ЛУПИ́ТЬ I хальсы нь арилгах, хуулах, аагалах.
ЛУПИ́ТЬ II жанчих, балбах, арьсы нь хуулах; ~ **лошадь кнутом** морио ташуураар балбах.
ЛУПИ́ТЬ III *(разг)* ~ **деньги с кого-либо** хэн нэгнээс мөнгө салгах, саах.
ЛУПИ́ТЬСЯ 1. хогжрох; хуурах; **кожа** ~ арьс нь хогжирч байна; 2. ховхрох; холтрох; **штукатурка лупится** (*ханын*) шаваас холторч байна.
ЛУПОГЛА́ЗЫЙ бүлтэн, бүлтгэр нүдтэй.
ЛУЧ туяа, гэрэл, цацраг; **~и солнца** нарны гэрэл, нарны туяа; **рентгеновские ~и** рентген цацраг; **ультрафиолетовые ~и** хэт ягаан цацраг.
ЛУЧЕВ||О́Й 1. туяаны, гэрлийн, цацрагийн, туяатай, гэрэлтэй, цацраггай; **~ая болезнь** цацрагийн өвчин; 2. туяарсан; **~ая кость** богт чөмөг; 3. ~ **нерв** шууны нерв.
ЛУЧЕЗА́РНЫЙ туяатай, гэрэлтэй, туяаран гэрэлтсэн.
ЛУЧИ́НА гэрээ, зомгол.
ЛУЧИ́НКА бяцхан гэрээ, зомгол.
ЛУЧИ́СТ||ЫЙ 1. гэрэлтэй, цогтой; ~ **взгляд** цогтой харц; 2. цацралын, туяарлын; **~ая теплота** цацралын илч; ~ **венец** цацраг титэм.
ЛУЧИ́ТЬ гэрээдэх; ~ **рыбу** загас гэрээдэх.
ЛУЧИ́ТЬСЯ цацрах, туяарах, гэрэлтэх.
ЛУ́ЧШЕ 1. *сайн*; дээр; **старый друг ~ двух новых** нэг хуучин найз хоёр шинэ найзаас дээр; нөхрийн хуучин нь дээр; эдийн шинэ нь дээр; **как можно** ~ болохуйц сайн; 2. дээр (байх), сайн (байх); ~ **меньше, да** ~ бага боловч чанартай нь дээр; **тем** ~ тэгэх тусмаа сайн; 3. дээр; **пойдём-ка** ~ **домой** гэртээ харивал дээр байгаа.
ЛУ́ЧШ||ИЙ 1. сайн; дээр; илүү сайн; **всё к ~ему** цөм сайн тийшээ хандаж байна; 2. нэн сайн, эрхэм; **самый** ~ **ученик** гоц сайн сурагч; ~ **из всех** хамгийн эрхэм; ~ **сорт** эрхэм зэрэг; **в ~ем случае** сайндаа.
ЛУЩЕ́НИЕ 1. хальсыг нь арилгах; 2. тарианы газар самнуурдах, дагнуурдах.
ЛУЩЁНЫЙ аагалсан, хальсалсан, хальсы нь арилгасан.
ЛУЩИ́ЛЬН||ЫЙ хальслах, хальсы нь арилгах; **~ая машина** хальслах машин.
ЛУЩИ́ТЬ 1. хальслах, хальсы нь арилгах, аагалах; 2. цөмөх; 3. тарианы газар самнуурдах, дагнуурдах
ЛЫЖ||И цана; **ходить на ~ах** цанаар гулгах; **крепление для лыж** цаныг тогтоогч; **навострить** ~ (*зүгтаахын тул*) хормойгоо шуух
ЛЫ́ЖНИК цаначин.
ЛЫ́ЖН||ЫЙ цанын; **~ая станция** цанын өртөө.
ЛЫЖНЯ́ цанын зам мөр.
ЛЫ́К||О дурс; **лапти из ~а** дурсан маахай; **он ~а не вяжет** шал согтуу.
ЛЫСЕ́ТЬ халзрах, халзан болох.
ЛЫ́СИНА халзан.
ЛЫС||ЫЙ 1. халзан, ~ **старик** халзан өвгөн; 2. нүцгэн; өвс ургамалгүй; **~ые горы** нүцгэн уулс.
ЛЬВЁНОК гүег.
ЛЬВИ́Н||ЫЙ арсланы; **~ая грива** арсланы зогдор; ***~ая доля** хамгийн их хувь, дээж.
ЛЬВИ́ЦА эм арслан.
ЛЬГО́Т||А хөнгөлөлт; **предоставить ~у** хөнгөлөлт олгох.
ЛЬГО́ТН||ЫЙ хөнгөлөлттэй; **на ~ых условиях** хөнгөлөлттэйгээр.
ЛЬДИ́НА бөөн мөс.
ЛЬНЯ́НКА *бот.* хонин зажхуур.
ЛЬНОВО́Д маалинга таригч.
ЛЬНОВО́ДСТВО маалинга тарих.
ЛЬНОТРЕПА́ЛКА маалинга савах машин.
ЛЬНУ́ТЬ 1. наалдах; ~ **к матери** эхдээ наалдах; 2. дотно болохыг хүсэх; шадарлахыг хүсэх.
ЛЬНЯН||О́Й маалингын; **~ое семя** маалингын үр.
ЛЬСТЕ́Ц зулгуйч, бялангач, бялдууч.
ЛЬСТИ́ВЫЙ зулгуйч, бялангач, бялдууч.
ЛЬСТИ́ТЬ 1. бялангачлах; бялдуучлах; 2. бахы нь ханаах; бах нь ханах; 3. горьдох; ~ **себя надеждой на успех** бүтэх бол уу гэж горьдох.
ЛЬСТИ́ТЬСЯ хорхой хүрэх, өнгөлзөх.
ЛЮБ дур булаах, сэтгэл татах; **Юра мне** ~ Юра миний сэтгэлийг татна.
ЛЮБВЕОБИ́ЛЬНЫЙ янагламтгай, амрагламтгай, дурламтгай, амрагийн сэтгэл төгс.
ЛЮБЕ́ЗНИЧАТЬ эелдэг аашлах, найрсаг загнах, хошуу холбох.
ЛЮБЕ́ЗНОСТ||Ь 1. эелдэг ааш; найрсаг зан; 2. эелдэг үг; найрсаг үг; **говорить ~и** эелдэг үг хэлэх; **оказать** ~ тус хүргэх
ЛЮБЕ́ЗН||ЫЙ 1. эелдэг; найртай; ялдам; ~ **человек** эелдэг хүн; 2. хайрт эрхэм; ~ **друг** эрхэм нөхөр; **будьте ~ы** ажаамуу.

ЛЮБИ́МЕЦ хайртай хүн.
ЛЮБИ́МИЦА хайртай эмэгтэй.
ЛЮБИ́МЧИК эрх хүн.
ЛЮБИ́М||ЫЙ амраг, янаг, хайртай, дуртай; **~ая жена** янаг эхнэр.
ЛЮБИ́ТЕЛЬ 1. сонирхогч; дуртай хүн; **~ музыки** хөгжимд дуртай хүн; 2. сайн дураараа оролдогч; **садовод-~** сайн дурын цэцэрлэгч; цэцэрлэг сонирхогч.
ЛЮБИ́ТЕЛЬНИЦА 1. сонирхогч эмэгтэй, дуртай эмэгтэй; 2. сайн дураараа оролдогч эмэгтэй.
ЛЮБИ́ТЕЛЬСКИЙ сайн дурынхны; **~ спектакль** сайн дурынхны тавьсан жүжиг.
ЛЮБИ́ТЬ 1. янаглах; амраглах; дурлах; хайрлах; 2. дуртай (*байх*); **он любит охотиться** тэр хүн ан агнах дуртай; 3. хэрэгтэй (*байх*); **цветы любят воду** цэцэгт ус хэрэгтэй.
ЛЮ́БО таатай, бахтай, аятай; **~ смотреть** харахад бахтай.
ЛЮБОВА́ТЬСЯ бахдах, бахдан харах, бахдан сайшаах; **~ природой** байгаль дэлхийг бахдан харах.
ЛЮБО́ВНИК амраг, амрагийн холбоотой хүн.
ЛЮБО́ВНИЦА амраг эмэгтэй; **французы ревнуют к своим ~м, а не к своим женам** францууд авгайтайгаа биш амрагтайгаа харддаг.
ЛЮБО́ВН||ЫЙ янагийн, амрагийн, янаг амрагийн, дуртай; **~ые песни** янаг амрагийн дуу.
ЛЮБО́ВЬ 1. амраг, янаг амраг, хайр, амрагийн сэтгэл; **по любви** сэтгэл зохин; **~ — это то, что случается с мужчинами и женщинами, которые не знают друг друга (С. Моэм)** дурлал-бие биеэ мэдэхгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд болдог зүйл; **~ к родине** эх орноо хайрлах; 2. авъяас, дур.
ЛЮБОЗНА́ТЕЛЬНОСТЬ сонирхдог зан..
ЛЮБОЗНА́ТЕЛЬНЫЙ хэрэгт дуртай хүн, сонирхдог.
ЛЮБ||О́Й 1. ямар ч, хэдий ч, аль ч; **~ ценой** ямар ч үнээр; **~ым способом** ямар ч аргаар; 2. хэн ч, юу ч, аль ч, юу ч, аль ч; **~ из вас** та нарын хэн (та) нь ч.
ЛЮБОПЫ́ТНЫЙ 1. соньч, сониуч; 2. сонин, сонирхолтой; **~ случай** сонин явдал.
ЛЮБОПЫ́ТСТВО соньч зан, сониуч зан, сонирхох, шохоорхох; **удовлетворить чье-либо ~** хүний сонирхсоныг үзүүлэх (хэлэх).
ЛЮБОПЫТСТВОВАТЬ сониучирхах, сонирхох, шохоорхох.
ЛЮ́БЯЩ||ИЙ дурлагч, дуртай, хайртай, энхрийлэгч; **~ая мать** энхрийлэгч эх.
ЛЮД хүмүүс, улс, олон; **рабочий ~** ажилчин олон.
ЛЮ́ДИ 1. хүн, хүмүүс, улс; **молодые ~** залуу хүмүүс, залуу хүн; **старые ~** хөгшин хүн, настан; 2. зарц нар; **выйти в ~** хүн болох; **вывести в ~** хүн болгох.
ЛЮ́ДНО хүн олонтой, хөл ихтэй.
ЛЮ́ДН||ЫЙ олон хүнтэй, хөлтэй; **~ая улица** хөл ихтэй гудамж.
ЛЮДОЕ́Д махчин.
ЛЮДОЕ́ДСТВО махчин байх; хүн идэх..
ЛЮДСКА́Я зарц нарын байр.
ЛЮДСКО́Й хүний, хүмүүсийн; **~ род** хүн төрөлхтөн.
ЛЮК онгоцны тагтай үүд, нүх, нээлхий.
ЛЮ́ЛЬКА I өлгий.
ЛЮ́ЛЬКА II богино гаанс.
ЛЮ́СТРА цэцэг дэн.
ЛЮТЕРА́НИН лютерийн сурталтан.
ЛЮТЕРА́НСТВО лютерийн суртлын, лютерийн шажны, лютерийн сурталтны.
ЛЮ́ТИК холтсон цэцэг.
ЛЮ́ТНЯ пийпаа (*хөгжмийн зэвсэг*).
ЛЮ́ТЫЙ 1. хэрцгий; догшин; **~ зверь** догшин араатан; 2. тасхийм; **~ мороз** тасхийм хүйтэн.
ЛЮЦЕ́РНА царгас (*буурцагт ургамал*).
ЛЯГА́НИЕ өшиглөх, тийрэх, хайрах.
ЛЯГА́ТЬ өшиглөх, тийрэх, хайрах.
ЛЯГА́ТЬСЯ өшиглөх, тийрэх, тангарах.
ЛЯГНУ́ТЬ өшиглөх тийрэх, хайрах.
ЛЯГУ́ШКА мэлхий; **лягушачьи лапки** мэлхийн сарвуу.
ЛЯГУШО́НОК мэлхийн зулзага, зулзаган мэлхий.
ЛЯДВИ́НЕЦ *(бот)* хошоонцор.
ЛЯ́ЖКА гуя.
ЛЯЗГ 1. хангир, жингэр гэх; хангинах; **~ цепей** гинж хангир жингэр гэх; 2. шүд хавирах.
ЛЯЗГА́ТЬ 1. хангир, жингэр гэх; хангинах; **~ цепями** гинж хангир жингэр гэх; 2. шүд хавирах.
ЛЯ́МК||А мөрөвч; **тянуть ~у** үйлээ үзэх.
ЛЯ́ПАТЬ 1. үг алдах санамсаргүй хэлэх; 2. гадилах, хааш хэрэг хийх.
ЛЯ́ПСУС эндүүрэл, андуурал, алдаа.
ЛЯ́СЫ точить ~ чалчаа үг дэлгэх.

М

МАВЗОЛЕ́Й бунхан.
МАВР мавр эрэгтэй.
МАВРИТА́НКА мавр эмэгтэй.
МАВРИТА́НСКИЙ мавр, маврын, ~ **стиль** мавр загвар (Испанид 7-8р зууны үеэс мавр нар ноёрхож байхад гарсан барилгын загвар).
МА́ВРСКИЙ мавр, маврын.
МАГ шидтэн, идтэн.
МАГАЗИ́Н 1. дэлгүүр; **универсальный** ~ их дэлгүүр, **продовольственный** ~ идэш уушны дэлгүүр; **оптовый** ~ бөөнөөр худалдаалах дэлгүүр; **розничный** ~ жижиглэн худалдаалах дэлгүүр; **парфюмерный** ~ үнэртний дэлгүүр; 2. (бууны) хүхээ; 3. агуулах (газар); **артиллерийский** ~ их бууны сум агуулах газар.
МАГАЗИ́ННЫЙ 1. дэлгүүрийн; 2. (бууны), хүхээт, хүхээний; **~ое ружьё** хүхээт буу.
МАГАРА́ДЖА махранз (энэтхэгийн засаг ноёдын дээд зэрэг цол).
МАГАРЫ́Ч (ямар нэгэн юмны шан болгон тавьсан) архи; **поставить** ~ (ямар нэгэн юмны шан болгон) архи тавих, сөн тавих.
МАГИ́СТР магистр.
МАГИСТЕ́РСКИЙ магистрийн, ~ **экзамен** магистрийн шалгалт.
МАГИСТРА́ЛЬ гол шугам, гол зам, гол хоолой; **железнодорожная** ~ төмөр замын гол шугам, гол төмөр зам; **водная** ~ усан замын гол шугам, гол усан зам; **водопроводная** ~ усны хоолойн гол шугам, усны гол хоолой.
МАГИСТРА́ЛЬНЫЙ гол; ~ **путь** гол зам.
МАГИСТРА́Т *(зарим орны)* хотын захиргаа.
МАГИСТРАТУ́РА1. *(зарим орны)* шүүх таслах газар; 2. шүүгчид.
МАГИ́ЧЕСКИЙ 1. шидийн, идийн, шившлэгийн; 2. шидтэй мэт, ид шидтэй мэт, арвис тарни.
МА́ГИЯ шид, ид, ид шид, арвис тарни..
МА́ГМА магма, (дэлхийн хайлмал бодис).
МАГМАТИ́ЧЕСК||ИЙ 1. магма, магмаар бүтсэн, **~ие породы** магма чулуулгууд; 2. халуун хайлмал; **~ое состояние** породы чулуулгын халуун хайлмал байдал.
МАГНА́Т 1. том газрын эзэн; 2. том хөрөнгөтөн; **финансовый** ~ санхүүгийн том хөрөнгөтөн.
МАГНЕЗИ́Т магнезит (нүүрс хүчилт магни).
МАГНЕ́ЗИЯ магнийн эсэл, магнийн давс; **жжёная** ~ магнийн эсэл; **белая** ~ магнийн давс.
МАГНЕТИ́ЗМ 1. соронзон, соронзон чанар; **земной** ~ газрын соронзон; 2. соронзонгүй, *(соронзон үзэгдлийн сургаал).*
МАГНЕТИ́Т соронзон гүр.
МАГНЕТИ́ЧЕСК||ИЙ соронзон, соронзны, соронзонт, соронзонтой; **~ие явления** соронзон үзэгдэл.
МАГНЕ́ТО *спец.* магнето, *(цахилгаан соронзон машин).*
МАГНЕТРО́Н *(электроны лампа).*
МА́ГНИЕВЫЙ магнийн, магнитай.
МА́ГНИЙ магни, (нүд гялбам цагаан дөл гарган шатдаг зөөлөн, мөнгө шиг цагаан металл).
МАГНИ́Т соронзон; **естественный** ~ байгалийн соронзон.
МАГНИ́ТИТЬ соронзлох, соронзтой болгох.
МАГНИ́ТН||ЫЙ соронзон, соронзны, соронзонт, соронзтой; **~ое поле** соронзон орон; ~ **железняк** соронзон гүр; ~ **полюс** соронзон туйл, **~ая аномалия** соронзны гаж.
МАГНИТО́ЛОГ соронзон зүйч.
МАГНИТОМЕ́ТР соронзон хэмжүүр.
МАГНИТО-ЭЛЕКТРИ́ЧЕСК||ИЙ соронзон цахилгаан; **~ая машина** соронзон цахилгаан машин.
МАГНО́ЛИЕВ||ЫЙ замбага, замбагын; **~ые цветы** замбагын цэцэг.
МАГНО́ЛИЯ замбага, мовь.
МАГОМЕТА́НИН лалын шажинтан эрэгтэй.
МАГОМЕТА́НКА лалын шажинтан эмэгтэй.
МАГОМЕТА́НСТВО лалын шажин.
МАДА́М (Франц зэрэг улсад нөхөртэй эмэгтэйд хандах үг.), хатагтай.
МАДО́ННА *(католик),* эх дагина, тэнгэрийн эх.
МАДРИГА́Л 1. алиа дуу, өхөөрдөх дуу, мадригал шүлэг; 2. энхрийлэх үг.
МАДЬЯ́Р мажар эрэгтэй.
МАДЬЯ́РКА мажар эмэгтэй, мажар эхнэр.
МАДЬЯ́РСКИЙ мажар, мажарын.
МАЁВКА хувьсгалын өмнөх оросын ажилчны майн нэгний нууц хурал.
МАЖО́Р арга эгшиг.
МАЖОРИТА́РНЫЙ дийлэнхийг үндэслэсэн, дийлэнхийн саналаар болдог.
МАЖО́РНЫЙ 1. арга эгшгийн; ~ **тон** арга эгшгийн хөг; 2. сэргэлэн, зугаатай.
МА́ЗАНКА шавар байшин.
МА́ЗАН||ЫЙ1. шавар, шавраар шавсан, шавардмал, шавардсан; **~ая хата** шавар байшин; 2. шавартай, хиртэй, балиар.
МА́ЗАТЬ 1. түрхэх, нялах, нийвийдэх, шавах, будах; 2. балиартуулах, хиртүүлэх; 3. зурагчаан болох, эрээчих; 4. дэгс буудах, дэгслэх; ~ **из ружья** дэгс буудах.
МА́ЗАТЬСЯ 1. нүүрээ будах, нүүртээ түрхэх; 2. будах, будаг болгох.
МАЗНЯ́ хааш яаш зурсан зураг.
МАЗО́К 1. түрхэц, зурц; 2. түрхэц, өнгөр.
МАЗУ́РКА мазур, (бүжиг, хөгжим).
МАЗУ́Т мазут тос.
МАЗУ́ТНЫЙ мазут тосны, мазутын, мазуттай.
МАЗЬ1. тосон эм, түрхэц; **цинковая** ~ цайртай тосон эм; 2. түрхэх тос.
МАЙС эрдэнэ шиш.
МАЙСОВЫЙ эрдэнэ шишийн.
МАЙ́ май, тавдугаар сар.
МАЙДА́Н зах, зээл, зах зээлийн талбай.
МА́ЙКА майк, ханцуйгүй цамц.
МАЙО́ЛИКА 1. паалантай ваар; 2. паалантай ваар, сав суулга.
МАЙО́ЛИКОВ||ЫЙ паалантай ваар, паалантай ваараар хийсэн; **~ое блюдо** паалантай ваар таваг.
МАЙОНЕ́З 1. майонез, сүмс, (өндөгний шар, гич, самрын тос, цуугаар хийсэн сүмс); 2. майонез хоол (ногоо хачиртай, майонез, сүмс дусаасан загас буюу зэрлэг шувууны махан хүйтэн хоол).
МАЙО́Р хошууч; ~ **вихрь** хошууч хуй.
МАЙО́РСК||ИЙ хошууч, хошуучийн, **~ое звание** хошууч цол.
МА́ЙСК||ИЙ 1. майн, тавдугаар сарын; **~ая демонстрация** майн жагсаал; 2. хаврын, урин, дулаан; ~ **воздух** хаврын агаар, дулаан агаар; ~ **жук** хаврын цох.

МАК 1. намуу цэцэг; **дикий ~** шар цэцэг; **альпийский ~** хурган засаа, хуцын хуух; 2. намуу цэцгийн үр.

МАКА́КА макак, нохой сармагчин.

МАКАРО́ННЫЙ хөндий гоймонгийн.

МАКАРО́НЫ хөндий гоймон.

МАКА́ТЬ дүрэх; **~ перо в чернила** үзэг бэхэнд дүрэх.

МАКЕ́Т загвар; **~ здания** барилгын үлгэр.

МАКЕ́ТН||ЫЙ үлгэрийн, загварын; **~ая мастерская** загвар урлах газар.

МАКИНТО́Ш эрэзэндсэн даавуун цув.

МАКЛА́К (жижиг худалдааны) зууч, дамжуулагч.

МА́КЛЕР (том худалдаа, биржийн) зуучлагч, дамжуулагч.

МА́КЛЕРСТВО (том худалдаа, биржид) зуучлах, дамжуулах.

МА́КЛЕРСТВОВАТЬ (том худалдаа, биржид) зуучлах, дамжуулах.

МАКНУ́ТЬ дүрээд авах; **~ перо в чернила** үзэг бэхэнд дүрээд авах.

МА́КОВ ~ цвет, улаан ягаан (царай зүс).

МА́КОВКА 1. намуу цэцгийн үр жимс; 2. барилгын пүмбэгэр орой; 3. зулай, орой, 4. намуу цэцгийн үрт чихэр.

МА́КОВ||ЫЙ 1. намуу цэцгийн; **величиной с ~ое зёрнышко** намуу цэцгийн үрийн чинээ; 2. намуу цэцгийн үрээр хийсэн, намуу цэцгийн үртэй, **~ое молоко** намуу цэцгийн үрийн сүү; **у меня ~ой росинки во рту не было** би хэлэн дээрээ юу ч тавиагүй.

МАКРЕ́ЛЬ балмад загас, амар загас.

МАКРОКО́СМ одон орон, ертөнц.

МАКРОСКОПИ́ЧЕСКИЙ (энгийн нүдэнд) үзэгдэх.

МАКСИМА́ЛЬНО туйлын их, туйлын сайн.

МАКСИМА́ЛЬН||ЫЙ туйлын (их), эн их; **~ая стоимость** туйлын өртөг.

МА́КСИМУМ 1. хамгийн их (хэмжээ), туйлын их (тоо), эн их; 2. хамгийн ихдээ, хамгийн сайндаа, ихдээ л; 3. туйлын (их), эн их, максимум; **программа — ~** максимум программ.

МАКУЛАТУ́РА 1. хэвлэлийн гологдол, хаягдал цаас; 2. гологдмол зохиол, хэрэггүй зохиол.

МАКУЛАТУ́РНЫЙ гологдсон, хэрэггүй,

МАКУ́ШК||А 1. (модны) орой, (уул хадны) орой, оргил, хяр; 2. зулай орой; **ушки на ~е у кого-либо** чих тавин сонсох.

МАЛА́ГА малага дарс.

МАЛА́ЕЦ малай эрэгтэй.

МАЛА́ЙКА малай эмэгтэй.

МАЛАХА́Й том, үстэй малгай.

МАЛАХИ́Т ногоолин.

МАЛАХИ́ТОВ||ЫЙ 1. ногоолин; **~ые колонны** ногоолин багана; **~ая шкатулка** ногоолин хайрцаг; 2. цэл ногоон, ногоолин (шиг) өнгөт (эй); **~ое море** ногоолин өнгөт тэнгис.

МАЛЕВА́ТЬ 1. алаглан будах, алаглан зурах; 2. зурагчаа болох, эрээчих, сараачих; ***не так страшен чёрт, как его малюют** айхаасаа арзайх нь.

МАЛЕ́ЙШ||ИЙ хамгийн бага, тун өчүүхэн; **~ее затруднение** өчүүхэн төдий бэрхшээл төвөг.

МАЛЁК жижиг жараахай.

МА́ЛЕНЬК||ИЙ 1. бага, өчүүхэн, жаахан; **~ домик** өчүүхэн байшин; 2. өчүүхэн, цөөн, цөөн тооны; 3. өчүүхэн, жаахан, бага зэргийн; **~ая неприятность** жаахан аягүй явдал; 4. бага, балчир, жижиг, бяцхан, бага насны; **~ие дети** бага хүүхдүүд; 5. бяцхан хөвгүүн, бяцхан охин, хүүхэд, багачууд; **вести себя, как ~** хүүхэд шиг аашлах; **моё дело ~ое** би өчүүхэн хүн, над хамаагүй.

МАЛЕ́НЬКО бага зэрэг, өчүүхэн, жаахан; **подожди ~** жаахан хүлээ.

МАЛЕ́Ц жаал, жаал хүү, банди.

МАЛИ́НА I 1. бөөрөлзгөнө, бөөрөлзгөнийн бут; 2. бөөрөлзгөнө, бөөрөлзгөнийн жимс.

МАЛИ́НА II хэсэг бүлгээрээ нийлж дарвидаг газар.

МАЛИ́ННИК бөөрөлзгөний ширэнгэ.

МАЛИ́ННЫЙ бөөрөлзгөнийн; **~ сок** бөөрөлзгөний шүүс.

МАЛИ́НОВКА I тогойлон бялзуухай.

МАЛИ́НОВКА II бөөрөлзгөнийн архи.

МАЛИ́НОВ||ЫЙ 1. бөөрөлзгөнийн; **~ая наливка** бөөрөлзгөнийн идээшмэл архи; 2. хөх ягаан; **~ое сукно** хөх ягаан цэмбэ.

МА́ЛО 1. бага, өчүүхэн, жаахан, бага сага, цөөн; **слишком ~** хэтэрхий бага; 2. бага байна, муу байна, цөөн байна, багатай байна, муутай байна, цөөнтэй байна; **у меня ~ свободного времени** би зав чөлөө муутай байна; ***~ ли у нас людей** манай хүмүүс цөөн гэж үү; **~ ли что бывает на свете** хорвоо дээр юу ч байж болно; **~мальски** багахан ч, бага зэрэг ч, өчүүхэн төдий ч, **~помалу** бага багаар, байн байсаар; **~ того** түүнээс гадна, бас; **ни ~, ни много** их ч үгүй, бага ч үгүй, илүү ч үгүй, дутуу ч үгүй;

МАЛОБЛАГОПРИЯ́ТНЫЙ ивээлгүй, зохиц муутай, аягүй, таарамж муутай, тохиромжгүй.

МАЛОВА́ЖН||ЫЙ ялихгүй, шалихгүй; **~ая причина** ялихгүй шалтаг.

МАЛОВА́Т багавтар байна, жижгэвтэр байна, арай л багадаж байна.

МАЛОВА́ТО 1. багавтар, багашиг, багахан; **делать ~** багавтар хийх; 2. багавтар байх, багашиг байх, арай л багадах.

МАЛОВЕ́Р үл үнэмшигч, үл итгэгч.

МАЛОВЕ́РНЫЙ үл үнэмших, үл итгэдэг.

МАЛОВЕРОЯ́ТН||ЫЙ үнэмших аргагүй, үнэмшихэд бэрх, итгэхэд хэцүү, эргэлзээтэй; **~ые слухи** итгэхэд хэцүү цуурхал.

МАЛОВЕ́СНЫЙ дутуу жинтэй хөнгөн; **~ груз** хөнгөн ачаа.

МАЛОВО́ДН||ЫЙ 1. бага устай, ус багатай, гүехэн; **~ые реки** ус багатай голууд; 2. чийг багатай, ус багатай; **~ая местность** чийг багатай газар.

МАЛОВО́ДЬЕ 1. ус татрах, ус татах, татаал; 2. чийг дутах, ус чийг дутах, ус дутах.

МАЛОВРАЗУМИ́ТЕЛЬНЫЙ тодорхой бус, ойлгомж муутай.

МАЛОВЫ́ГОДН||ЫЙ ашиг багатай, ашиг муутай; **~ая работа** ашиг муутай ажил.

МАЛОГОВОРЯ́ЩИЙ утга тодорхойгүй, ойлгоц муутай.

МАЛОГРА́МОТНОСТЬ бичиг үсэг муу мэдэх, бичиг муу мэдэх.

МАЛОГРА́МОТН||ЫЙ 1. бичиг үсэг муутай, бичиг үсэгт муу, бичиг муутай, бичигт муу; 2. бичиг үсэг муу мэдэгч; **школа для ~ых** бичиг үсэг муу мэдэгчийн сургууль; 3. алдаатай, дутагдалтай, дүрэм гажуу (хийсэн)

МАЛОДО́ЙКА сүү багатай үнээ.

МАЛОДО́ЙНЫЙ сүү багатай, сүү муутай; **~ скот** сүү муутай мал.

МАЛОДОСТОВЕ́РНЫЙ арай л магадтай бус, магадтай магадгүй.

МАЛОДОСТУ́ПН||ЫЙ 1. бараг олдошгүй, бараг оногдошгүй, бараг хүртэшгүй 2. бараг хүчрэшгүй, бараг чадашгүй; **~ые цены** бараг хүчрэшгүй үнэ, бараг төлж чадашгүй үнэ.

МАЛОДОХО́ДН||ЫЙ ашиг орлого багатай; **~ое предприятие** ашиг орлого багатай үйлдвэр.

МАЛОДУ́ШЕСТВОВАТЬ зүрх алдах, зориг мохох, хулчийх; **нельзя ~ при неудачах** хэрэг бүтэхгүй зориг мохож болохгүй.

МАЛОДУ́ШИЕ зүрх алдах, зориг мохох, хулчийх.

МАЛОДУ́ШНЫЙ 1. зүрхгүй, зориг муутай хулчгар; ~ **человек** зүрхгүй хүн, зориг муутай хүн, хулчгар хүн.

МАЛОЕ́ЗЖЕННЫЙ 1. цагаашаагүй, (морь), муу сургасан, амаа мэдэхгүй (морь); ~ **жеребец** цагаашаагүй азарга, амаа мэдэхгүй азарга; 2. (хүн амьтан) бага явсан, балархай (зам).

МАЛОЕ́ЗЖ||ИЙ (хүн амьтан) бага явдаг (зам); **ехали ~ей дорогой** хүн амьтан бага явдаг замаар явж байв.

МАЛОЗАМЕ́ТНЫЙ 1. мэдэгдэх төдий, харагдах төдий, үзэгдэх төдий; 2. эгэл жирийн, ердийн, энгийн; ~ **случай** ердийн тохиолдол.

МАЛОЗАСЕЛЁННЫЙ хүн ам цөөнтэй, хүн ам сийрэг (нутаг); ~ **край** хүн ам цөөтэй нутаг.

МАЛОЗЕМЕ́ЛЬЕ (тариалангийн) газар багатай байх, (тариалангийн) газар дутах.

МАЛОЗЕМЕ́ЛЬНЫЙ (тариалангийн) газар багатай, (тариалангийн) газраар дутмаг.

МАЛОЗНАКО́М||ЫЙ таних төдий, сайн танихгүй, муу таньдаг; ~**ые люди** таних төдий хүмүүс.

МАЛОЗНА́ЧАЩИЙ ач холбогдол багатай, утга учир багатай, ялигүй; ~ **разговор** ач холбогдол багатай яриа.

МАЛОЗНАЧИ́ТЕЛЬН||ЫЙ ач холбогдол багатай, учир утга багатай, чухал бус, нөлөө багатай; ~**ое событие** ач холбогдол багатай явдал, ач холбогдол багатай хэрэг.

МАЛОЗНА́ЮЩИЙ мэдэц багатай, мэдэц муутай.

МАЛОИЗВЕ́СТНЫЙ нэрд төдийлөн гараагүй, төдийлэн алдаршаагүй; ~ **писатель** нэрд төдийлэн гараагүй зохиолч.

МАЛОИМУ́ЩИЙ хөрөнгө багатай, хөрөнгө нимгэн, ядуу.

МАЛОИНТЕРЕ́СНЫЙ сонирхол багатай; ~ **очерк** сонирхол багатай найруулал.

МАЛОКРО́ВИЕ цус багадах, цус багадах өвчин; **страдать ~м** цус багадалт.

МАЛОКРО́ВНЫЙ цус багатай, ~ **человек** цус багатай хүн.

МАЛОКУЛЬТУ́РНЫЙ соёл багатай, төдий л боловсон бус; ~ **человек** боловсрол багатай хүн.

МАЛОЛЕ́ТКА хүүхэд, жаал.

МАЛОЛЕ́ТН||ИЙ 1. бага настай, нас багатай, бага насны; ~**ие дети** бага хүүхдүүд; ~ **возраст** бага нас; 2. бага хүүхэд.

МАЛОЛЕ́ТСТВ||О бага нас; **с ~** бага наснаас, багаасаа; **в ~е** бага насанд, багадаа.

МАЛОЛИТРА́ЖНЫЙ шатахуун бага хэрэглэдэг, шатахуун бага зардаг, шатахуун бага ордог.

МАЛОЛЮ́ДНОСТЬ хүн ам цөөн, хүн цөөн, хөл (үймээн) бага.

МАЛОЛЮ́ДН||ЫЙ хүн ам цөөтэй, хүн цөөнтэй, цөөн хүнтэй, хөл багатай, ~**ая улица** хөл багатай гудамж.

МАЛО-МА́ЛЬСКИ өчүүхэн ч, өчүүхэн төдий ч, багахан ч, бага зэрэг ч.

МАЛОМО́ЧНЫЙ чадал чинээ муутай, хөрөнгө чинээ багатай.

МАЛОМО́ЩНЫЙ чадал багатай, хүч муутай, чадал чинээ муутай, хүч чадал багатай.

МАЛОНАДЁЖНЫЙ найдвар багатай, горьдлого муутай, *итгэлгүй*.

МАЛОНАСЕЛЁННЫЙ хүн ам цөөнтэй, хүн цөөнтэй; ~ **край** хүн ам цөөнтэй нутаг.

МАЛООБРАЗО́ВАННЫЙ боловсрол муутай, мэдлэг багатай; ~ **человек** боловсрол багатай хүн.

МАЛООБЩИ́ТЕЛЬНЫЙ (хүнтэй) нийцгүй, зожиг; ~ **человек** хүнтэй нийц муутай хүн.

МАЛО́ОПЫТНЫЙ туршлага багатай, дадлага муутай.

МАЛООСНОВА́ТЕЛЬНЫЙ үндэс багатай, баримт муутай, үндэс баримтаар дутмаг; 2. томоогүйвтэр.

МАЛОПИТА́ТЕЛЬНЫЙ шим муутай, шим тэжээл багатай, өл муутай, өег бус.

МАЛОПЛОДОРО́ДН||ЫЙ шим муутай, үржил багатай, ургац муутай; ~**ая почва** шим муутай хөрс.

МАЛОПОДВИ́ЖНЫЙ 1. хөдөлгөөн багатай, хөдлөц муутай, хөдлөхдөө муу; ~ **сустав** хөдлөц муутай үе; 2. хөдлөхдөө муу, явдал багатай; ~ **образ жизни** явдал багатай байх.

МАЛОПОДГОТО́ВЛЕННЫЙ бэлтгэл муутай, бэлтгэл багатай.

МАЛОПОДЕ́РЖАННЫЙ бага өмссөн, төдий л хуучраагүй, элэгдээгүй шахуу; ~ **костюм** бага өмссөн хувцас.

МА́ЛО-ПОМА́ЛУ бага багаар, байн байсаар.

МАЛОПОНЯ́ТЛИВЫЙ ухвар муутай, ой муутай.

МАЛОПОНЯ́ТН||ЫЙ ойлгомж муутай; ~**ая фраза** ойлгомж муутай үг.

МАЛОПРИ́БЫЛЬНЫЙ ашиг муутай, олз багатай, орлого муутай.

МАЛОПРИГО́ДН||ЫЙ хэрэг багатай, тохиромж муутай, тэнцэхгүй; ~**ая для посева** земля тариаланд тохиромж муутай газар.

МАЛОПРОДУКТИ́ВНЫЙ үр багатай, үр бүтээл муутай, үр шим багатай; ~ **скот** үр шим муутай мал.

МАЛОРА́ЗВИТЫЙ 1. бие гүйцээгүй, дутуу гүйцсэн; 2. ухаан гүйцээгүй, ухаан нээгдээгүй.

МАЛОРО́СЛЫЙ бие багатай, бие бялдар бага, нуруугаар давжаа, бага навтгар; ~ **скот** бие багатай мал.

МАЛОСВЕ́ДУЩИЙ мэдлэг багатай, мэдэхээр бага.

МАЛОСЕМЕ́ЙН||ЫЙ гэр бүл багатай, (ам) бүл цөөнтэй; ~**ые люди** ам бүл цөөнтэй хүмүүс.

МАЛОСИ́ЛЬНЫЙ хүч багатай, чадал муутай ~ **двигатель** хүч муутай хөдөлгүүр.

МАЛОСОЗНА́ТЕЛЬНЫЙ ухамсар муутай, ухамсар багатай.

МАЛОСО́ЛЬН||ЫЙ давс багатай; ~**ые огурцы** давс багатай өргөст хэмх.

МАЛОСОСТОЯ́ТЕЛЬНЫЙ 1. хөрөнгө багатай, чинээ муутай, чадал муутай, ~ **человек** чинээ муутай хүн; 2. нотолгоо муутай, үндэс багатай, ~**ые доводы** үндэс муутай баримт.

МАЛОСПОСО́БНЫЙ авьяас багатай, билэг муутай.

МА́ЛОСТЬ 1. жижиг сажиг юм, аар саар юм, ялигүй юм, шалигүй юм; 2. ялигүй, шалигүй, жаахан; ~ **нездоровится** бие жаахан эвгүй байна.

МАЛОСУЩЕ́СТВЕННЫЙ төдий л чухал биш; ~ **довод** төдий л чухал бус баримт.

МАЛОТИРА́ЖН||ЫЙ хувь цөөнтэй; ~**ая газета** хувь цөөнтэй сонин.

МАЛОУБЕДИ́ТЕЛЬН||ЫЙ төдий л үнэмшмээр бус, төдий л итгэмээр бус; ~**ое доказательство** төдий л итгэмээр бус баталгаа.

МАЛОУДО́ЙНЫЙ сүү багатай, сүү муутай.

МАЛОУПОТРЕБИ́ТЕЛЬН||ЫЙ хэрэгцээ багатай, бага (цөөн) хэрэглэгддэг; ~**ое выражение** цөөн хэрэглэгддэг хэллэг.

МАЛОУРОЖА́ЙНЫЙ ургац муутай, газрын гарц багатай; ~ **год** ургац муутай жил.

МАЛОЧИ́СЛЕННОСТЬ цөөн тоо.

МАЛОЧИ́СЛЕННЫЙ цөөн тоотой, цөөн, цөөхөн, цөөн хүнтэй; ~ **отряд** цөөн хүнтэй отряд.

МАЛОШЕ́РСТН||ЫЙ ноос багатай, үс нимгэн, тачир үстэй; ~**ые овцы** ноос багатай хонь.

МА́Л||ЫЙ I 1. бага жаахан, жижиг; ~ **рост** нуруу бага; 2. бага байх, багадах **эти сапоги мне малы** энэ гутал над багадаж байна; 3. бусад үгтэй нийлж юмны нэр бүтээнэ. **Малая Медведица** Алтан Мөнгөн Шаргууд, ~ **театр** Бага театр; **без ~ого, без мала** шахам, шахуу; **самое ~ое** доод зах нь, багадаа; **за ~ым делом стало** ялигүй юмнаас хэрэг саатав; **мал мала**

меньше нэг нэгнээсээ бага; **от ~а до велика** их багагүй; **стар и млад** хөгшин залуугүй; **с ~ых лет** бага наснаасаа.

МА́ЛЫЙ II 1. хүү жаал, залуу; 2. эр хүн; **он славный ~** тэр (хүн) овоо хүн.

МАЛЫ́Ш бяцхан хүүхэд, хүү.

МА́ЛЬВА замба цэцэг, жамба цэцэг.

МА́ЛЬЧИК хөвгүүн, хүү, нуган; **я не ~** би хүүхэд биш; **~ с пальчик** эрхийн чинээ хүү, чихэн төдий хүү.

МАЛЬЧИКО́ВЫЙ хөвгүүн, хүү, хөвгүүний, эрэгтэй хүүхдийн.

МАЛЬЧИ́ШЕСК||ИЙ 1. эрэгтэй хүүхдийн, хөвгүүний, хөвгүүн; **пробор придает ей ~ вид** үсний нь заадас түүнийг хөвгүүн дүртэй *болгож байна*; 2. *хөнгөмсөг, томоогүй, дүрсгүй*; **~не поступки** томоогүй явдал.

МАЛЬЧИ́ШЕСТВО хөвгүүн зан, томоогүй явдал; **непростительное ~** уучлашгүй томоогүй явдал.

МАЛЬЧИ́ШКА хүүхэд, балчир хүүхэд; **вести себя как ~** хүүхэд шиг зан гаргах.

МАЛЬЧУГА́Н, бяцхан хүү, өчүүхэн хөвгүүн.

МАЛЮ́СЕНЬКИЙ жижигхэн, бяцхан, өчүүхэн.

МАЛЮ́ТКА бичилхэн, нялх хүүхэд.

МАЛЯ́ВКА жараахай.

МАЛЯ́Р будагчин.

МАЛЯРИ́ЙНЫЙ хумхаагийн, хумхаатай; **~ комар** хумхаагийн шумуул; **~ больной** хумхаатай хүн.

МАЛЯРИ́Я хумхаа, (чичирдэг өвчин); **тропическая ~** халуун орны хумхаа.

МАЛЯ́РН||ЫЙ, будгийн; **~ые работы** будгийн ажил.

МА́МА ээж, эжий.

МА́МЕНЬКИН ~ сынок ээжийн эрх хүвгүүн.

МА́МКА 1. сувилагч ээж; 2. эжий.

МА́МОНТ арслан заан.

МА́МОНТОВ||ЫЙ арслан зааны; **~ая кость** арслан зааны яс.

МА́МОЧКА ээж.

МА́НГО амра, (жимс, мод), амраагийн жимс.

МАНДАРИ́Н I *хятадын түшмэл, сайд.*

МАНДАРИ́Н II бэрсүүт жүрж.

МАНДА́Т 1. мандат, эрхийн үнэмлэх; **депутатский ~** депутатын эрхийн үнэмлэх; 2. мандат, захирах эрх.

МАНДА́ТН||ЫЙ 1. мандатын, эрхийн үнэмлэхний; **~ая комиссия** эрхийн үнэмлэхийн комисс; **~ая система голосования** мандатын системтэй сонгууль; 2. мандаттай, захирах, эрхтэй.

МАНДОЛИ́НА мандолин (хөгжим).

МАНДРА́Ж айх, сандрах.

МАНЁВР 1. манёвр; **тактический ~** тактикийн манёвр; 2. арга мэх, арга заль, арга; **это был только ~** энэ нь зөвхөн арга мэх байв.

МАНЁВРЕННОСТЬ манёврлах чадвар; **высокая ~ войск** цэргийн сайн манёврлах чадвар.

МАНЁВРЕНН||ЫЙ маневрын; **~ая война** маневрын дайн.

МАНЕВРИ́РОВАНИЕ манёврлах.

МАНЕВРИ́РОВАТЬ 1. манёврлах, манёвр хийх; 2. зайчлан явах, булган явах; 3. арга мэх гаргах, арга заль хийх; 4. эвий нь олох, аятайхан ашиглах.

МАНЁВРЫ байлдааны сургууль, манёвр; **военные ~** байлдааны сургууль.

МАНЕ́Ж морин сургуулийн газар, сургуулийн талбай.

МАНЕКЕ́Н 1. *хувцас тааруулан оёхын тул хүний биеийн* хэмжээгээр хийсэн модон загвар; 2. уульхай хүн.

МАНЁР на ~ шиг, мэт, янзаар, маягаар; **на новый ~** шинэ янзаар, шинэ маягаар; **на ~ кого, чего** шиг мэт, адил, зангаар, авираар; **таким ~ом** тэгж тийм маягаар, тийм янзаар.

МАНЕ́Р||А ааш маяг, ааш байдал, маяг заншил; **~ держать себя** өөрийн нь ааш байдал; **~ говорить** ярих маяг; **дурные ~ы** муу маяг, муу заншил.

МАНЕ́РКА бяцхан дашмаг.

МАНЕ́РНИЧАТЬ маяглах, цэмцэгнэх.

МАНЕ́РНОСТЬ маяглах, цэмцэгнэх, маяглал, цэмцэгнүүр зан.

МАНЕ́РНЫЙ маягтай цэмцэгнүүр; **~ стиль** маягтай найруулга.

МАНЖЕ́ТА 1. (цамцны) нударга ханцуй; 2. давхарга

МАНИАКА́ЛЬНЫЙ хөөрөх, ин хөдлөх; **~ психоз** хөөрөх хий өвчин.

МАНИКЮ́Р хумс засал; **сделать ~** хумс засал хийх, хумс засах.

МАНИКЮ́РША хумс засагч эмэгтэй.

МАНИ́ЛОВЩИНА маниловын хоосон бодол, (Гоголийн «Амьгүй албат» гэдэг зохиолын нэг баатрын нэрээс үүссэн үг.)

МАНИПУЛИ́РОВАТЬ 1. нарийн төвөгтэй арга хийх, нарийн төвөгтэй үйл хийх; 2. арга заль хийх.

МАНИПУЛЯ́ЦИЯ 1. нарийн төвөгтэй арга, нарийн төвөгтэй үйл ажиллагаа; 2. арга заль.

МАНИ́ТЬ 1. даллах, дохих; **~ к себе** даллах; 2. татах, дур татах, хорхой хүргэх.

МАНИФЕ́СТ тунхаг, тунхаглал.

МАНИФЕСТА́ЦИЯ сүрт жагсаал.

МАНИФЕСТИ́РОВАТЬ сүрт жагсаал хийх.

МА́НИЯ 1. ин; **~ преследования** мөрдлөгийн ин; **~ величия** ихсийн ин; 2. шунал.

МАНКИ́РОВАТЬ үл тоомсорлох хааш хэрэг хандах; **~ своими обязанностями** үүрэгтээ хааш хэрэг хандах.

МА́НН||ЫЙ ~ая крупа талхалсан буудай, хүүхдийн будаа.

МАНОВЕ́НИ||Е даллах, дохих; **~ем руки** гараар даллан; **как по ~ю** илбээр бүтээсэн мэт.

МАНО́К шовшуур.

МАНО́МЕТР манометр, даралт хэмжүүр.

МАНОМЕТРИ́ЧЕСК||ИЙ манометрийн, даралт хэмжүүрийн; **~ая трубка** *манометрийн гуурс.*

МА́НТИЯ жанч, нөмрөг.

МАНТО́ манто (эмэгтэй хүний халхгар пальто).

МАНУСКРИ́ПТ эртний (гар) бичмэл.

МАНУФАКТУ́РА, мануфактур, хөдөлмөрийн хуваарьтай гар үйлдвэр; 2. бөс даавуу.

МАНУФАКТУ́РНЫЙ 1. мануфактурын; 2. бөс даавууны.

МАНЬЧЖУ́Р манж хүн.

МАНЬЧЖУ́РСКИЙ манж, манжийн; **~ язык** манж хэл.

МАНЬЯ́К инт, интэй хүн.

МАНЯ́Щ||ИЙ дур татам, сэтгэл татам, хорхой хүрэм, шунамаар; **~ая красота** дур татам сайхан; **~ая цель** сэтгэл татам зорилго.

МАРА́ЗМ 1. зөнөг; **старческий ~** зөнөг; 2. өмхрөл.

МАРА́Л *(самец)* буга, *(самка)* согоо.

МАРА́НЬЕ 1. хир болгох, муухай болгох, бузарлах; 2. эрээчээс, сараачаас.

МАРА́ТЬ бялах, будах, хир болгох, муухай болгох; **~ платье** хувцаа муухай болгох; 2. нэр хугалах, гутаах, бузарлах; **~ честное имя** сайн нэр хугалах, 3. эрээчих, цоохорлох, сараачих; **~ стихи** шүлэг сараачих; **~ бумагу** цаас эрээчих.

МАРА́ТЬСЯ 1. хир болох, муухай (хар) болох, бузарлагдах; 2. нэр хугарах, гутах, нэрээ хугалах, гутаах, бузарлах; **не стоит ~** тэгж *нэрээ* хугалах хэрэггүй.

МАРАФО́НСКИЙ ~ бег холын явган уралдаан (42 км. 95м. газар)

МА́РГАНЕЦ манган, марганец, хүрэнз (хар хүрэн өнгийн төмөрлөг).

МА́РГАНЦЕВ||ЫЙ манганы, марганецын, мангантай, марганецтай, **~ая соль** манганы давс.
МАРГАРИ́Н хиймэл тос, маргарин.
МАРГАРИ́НОВЫЙ маргарины, хиймэл тосны.
МАРГАРИ́ТКА хонин нүдэн цэцэг.
МА́РЕВО 1. зэргэлгээ; 2. униар, будан.
МА́РИ 1. мари нар; 2. мари хүн.
МАРИ́НА далайн зураг.
МАРИНА́Д 1. халуун амттантай цуу; **селдь в ~е** (халуун амттантай) цуунд дарсан май загас; 2. цуунд дарсан идэшний зүйл, дармал идэшний зүйл.
МАРИНИ́СТ далай зурдаг зураач.
МАРИНОВА́НИЕ дарах.
МАРИНО́ВАНН||ЫЙ дарсан; **~ые грибы** дарсан мөөг.
МАРИНОВА́ТЬ 1. дарах; **~ грибы** мөөг дарах; 2. дарах, хойш татах; **~ дело** хэрэг хойш татах.
МАРИОНЕ́ТКА 1. оньст хүүхэлдэй; 2. бусдын гар хөл бологч, тоглоомын этгээд.
МАРИОНЕ́ТОЧН||ЫЙ 1. оньст хүүхэлдэйн 2. **~ театр** оньст хүүхэлдэйн театр; 2. тоглоомын; **~ое правительство** тоглоомын засгийн газар
МА́РК||А 1. марк; **почтовая ~** шуудангийн марк 2. тэмдэг; **фабричная ~** үйлдвэрийн тэмдэг; 3. шошго; 4. марк (Герман, Финляндийн мөнгөний нэгж); 5. нэр, нэр төр; **держать ~у** нэр төрөө бодож явах.
МАРЕВЫ́Е *бот.* луулийн овог.
МАРКЕ́ТИНГ маркетинг, зохион байгуулах иж бүрэн тогтолцоо; **сетевой ~** сүлжээний худалдаа.
МАРКЁР I бильярд тоглогчдыг үйлчлэгч.
МАРКЁР II шан татах зэвсэг.
МА́РЖА худалдаа, бирж, банкны салбар дахь хоёр үзүүлэлтийн хоорондын зөрүү, ялгаа.
МАРКИ́З маркиз (Франц, Англи, Итали, Исландийн дээд зэрэг тайж).
МАРКИ́ЗА I марикизын хатан, маркизын гүнж, гүнж маркиз.
МАРКИ́ЗА II цонхны саравч.
МАРКИЗЕ́Т маркизет даавуу.
МАРКИЗЕ́ТОВЫЙ маркизет даавуун.
МА́РКИЙ хир халдамтгай.
МАРКИРОВА́ТЬ 1. (барааны) тэмдэг дарах; 2. (тариалангийн) шан татах.
МАРКИРО́ВКА тэмдэг дарах,
МАРКИРО́ВЩИК 1. (барааны) тэмдэг дарагч; 2. (тариалангийн) шан татагч.
МАРС Ангараг.
МАРСИА́НИН ангарагийн иргэн.
МАРКСИ́ЗМ марксизм, Марксын суртал.
МАРКСИ́ЗМ-ЛЕНИНИ́ЗМ марксизм-ленинизм
МАРКСИ́СТ марксист, Марксын сурталтан.
МАРКСИ́СТСКИЙ *марксист.*
МА́РЛЕВЫЙ марли, самбай, марлийн, самбайн; **~ бинт** марли боолт.
МА́РЛЯ марли, самбай.
МАРМЕЛА́Д бүржмэл чихэр.
МАРОДЁР 1. тонуулчин цэрэг; 2. шунахай худалдаачин, шулаачин, адгийн шаар.
МАРОДЁРСТВОВАТЬ 1. *тонох;* 2. *шулах, мөлжих.*
МА́РОЧН||ЫЙ дээгүүр зэргийн, дугаар зэрэгт; **~ое вино** дээгүүр зэргийн дарс.
МАРТ гуравдугаар сар, гурван сар.
МАРТЕ́Н 1. мартен болд; 2. мартен зуух.
МАРТЕ́НОВСК||ИЙ мартен, мартены, **~ая сталь** мартен болд, **~ая печь** мартен зуух.
МА́РТОВСКИЙ гуравдугаар сарын, гурван сарын, мартын.
МАРТЫ́ШКА сармагчин.
МАРЦИПА́Н бүйлсний гурилаар хийсэн боов, бүйлсэн боов.
МАРШ I 1. алхаа, марш; **форсированный ~** хурдалсан алхаа; **церемониальный ~** ёслолын алхаа; 2. аялал, аян; **трёхдневный ~** гурван өдрийн аян; **на ~е** аялалд; 3. марш, жагсаалын хөгжим.
МАРШ II 1. марш; **шагом ~ !** алхаад марш ! 2, зайл, тонил, яв; **~ отсюда!** зайл эндээс!.
МАРШ III шат, шатны хэсэг.
МА́РШАЛ маршал, өрлөг; **~ Советского Союза** Зөвлөлт Холбоот Улсын маршал.
МА́РШАЛЬСК||ИЙ маршалын, өрлөгийн, маршал, өрлөг; **~ое звание** маршал цол.
МА́РШЕВ||ЫЙ 1. маршийн, аяны, аяллын; **~ порядок** аяны журам; 2. маршийн *(бэлтгэл цэргээс байлдаж байгаа цэрэгт илгээх);* **~ая рота** маршийн суман.
МАРШИРОВА́ТЬ *(цэрэг ёсоор)* алхлах, маршлах.
МАРШИРО́ВКА алхлах, алхлалт, маршлах,
МАРШИРО́ВОЧНЫЙ алхлах, маршлах.
МАРШРУ́Т зам; **~ перелёта** нисэх зам; **~ путешествия** жуулчлах зам.
МАРШРУ́ТНЫЙ тууш замын, тууш явах.
МА́СК||А 1. баг; **надеть ~у** баг өмсөх; **человек в ~е** багтай хүн 2. (үхсэн хүний нүүрээс буулган авсан) нүүрний хэв; 3. баг; **противогазовая ~** хорт утааны баг; **сбросить с себя ~у** багаа авч хаях, үнэн царайгаа үзүүлэх; **~ защитная** хамгаалах баг.
МАСКАРА́Д 1. багт наадам; 2. хуурамч дүр.
МАСКАРА́ДНЫЙ багт наадмын; **~ костюм** багт наадмын хувцас.
МАСКИРО́ВАННЫЙ 1. баг өмссөн, багт наадмын хувцас өмссөн; 2. далдалсан, нуусан.
МАСКИРОВА́ТЬ 1. баг өмсөх, багт наадмын хувцас өмсөх; 2. нуух, далдлах; **~ свои намерения** санаагаа нуух; 3. далдлах, нуух, өнгөлөн далдлах, битүүлэх.
МАСКИРОВА́ТЬСЯ баг өмсөх, багт наадмын хувцас өмсөх; 2. хуурамч дүр үзүүлэх, үнэн дүрээ нуух, янз үзүүлэх; 3. (биеэ) далдлах, (биеэ) нуух, (биеэ) өнгөлөн далдлах; 4. далдлагдах, нуугдах.
МАСКИРО́ВКА 1. баг өмсөх, зүсээ хувиргах, үнэн дүрээ нуух; 2. өнгөлөн далдлах арга.
МАСКИРО́ВОЧНЫЙ далдлах, өнгөлөн далдлах; 2. нуух, далдлах.
МА́СЛЕНИЦА шар тосны баяр, (өвлийг үдэх баяр)
МА́СЛЕНИЧНЫЙ шар тосны баярын.
МАСЛЁНКА тосны сав, тослуур.
МАСЛЁНОК шар сархиаг.
МА́СЛЕННЫЙ тослогдсон.
МА́СЛЕН||ЫЙ 1. тостой, тосдосон, тос түрхсэн, тосонд шарсан; **~ блин** тосонд шарсан шүүрмэг бин; 2. нялуун, нялганасан нялга нялга гэсэн; **~ голос** нялуун дуу; 3. тачаангуй, хуялтай; **~ые глаза** тачаангуй харц, хуялтай нүд.
МАСЛИ́НА 1. тослог мод; 2. тослог жимсгэнэ, чидун жимс.
МА́СЛИТЬСЯ тосдох, тос болгох.
МА́СЛИЧН||ЫЙ *тост;* **~ое дерево** *тослог мод;* **~ая ягода** *тослог жимсгэнэ.*
МА́СЛ||О 1. тос; **сливочное ~** цөцгийн тос; **топлёное ~** шар тос; **сбивать ~** тос бүлэх; **намазать хлеб ~м** талханд тос түрхэх; **подсолнечное ~** наран цэцгийн тос; **касторовое ~** тосон

туулга; **ореховое** ~ самрын тос; 2. тосон будаг; **писать ~м** тосон будгаар зурах; **подлить ~а в огонь** дайран дээр нь давс хийх, улам гааруулах; ***идёт как по ~у** сэтгэлчлэн бүтэж байна, саад тотгоргүй явж байна.

МАСЛОБО́ЙНЫЙ тосны, тос бүлдэг; ~ **завод** тосны завод.

МАСЛОДЕ́Л тосны мэргэжилтэн, тосчин.

МАСЛОДЕ́ЛИЕ тос үйлдвэрлэх.

МАСЛОЗАВО́Д тосны завод.

МАСЛОТО́ПНЫЙ тос хайлуулдаг, тос хайлуулах, тос шахдаг.

МАСЛЯНИ́СТЫЙ тослог, тосовхи; ~ **сыр** тослог бяслаг.

МА́СЛЯН||ЫЙ 1. тосон тосны, **~ое пятно** тосон толбо; 2. тосон, тосон будгаар зурсан; **~ая краска** тосон будаг; **писать ~ыми красками** тосон будгаар зурах.

МАСО́Н масон, (масонлигийг баримтлагч, масоны байгууллагын гишүүн)

МАСО́НСК||ИЙ масоны; **~ая ложа** масоны бүлгэм; ~ **знак** масоны тэмдэг.

МА́СС||А I 1. масс, цул; **единица ~ы** массын нэгж; 2. лаагалдсан эд; **фарфоровая** ~ шаазангийн лаагалдсан эд; **древесная** ~ модны лаагалдсан эд (цаас хийдэг хагас бүтээгдэхүүн) 3. дүнхэгэр, лүглэгэр, сүндэр.

МА́СС||А II 1. үй олон, учиргүй их, учиргүй олон; ~ **пыли** учиргүй их тоос; **тратить ~у сил** учиргүй их хүч гаргах; 2. олон түмэн, өргөн олон, өргөн түмэн; **в ~е** ихэнх нь, олонхидоо, ерөнхийдөө, бүхэлдээ.

МАССА́Ж барихуй, илбэхүй; **лечение ~ем** илбэн эмчлэх.

МАССАЖИ́СТ бариач, илбэн эмчлэгч.

МАССАЖИ́СТКА бариач эмэгтэй, илбэн эмчлэгч эмэгтэй.

МАССИ́В 1. хөвч, шил; **горный** ~ хөвч уулын шил; 2, хөвч хүлх; **лесные ~ы** ой хөвч, хүлх ой.

МАССИ́ВНОСТЬ хүдэр том (байх), мантгар (байх), цул (байх), бараатай (байх)

МАССИ́ВН||ЫЙ хүдэр том, мантгар, цул, бараатай; **~ая дверь** хүдэр том хаалга; **~ая фигура** хүдэр том биё.

МАССИ́РОВАНИЕ цуглуулах, хуримтлуулах, бөөгнөрүүлэх.

МАССИ́РОВАННЫЙ хуримталсан, бөөгнөрсөн.

МАССИ́РОВАТЬ I барих, илбэх, засах; ~ **место ушиба** няцарсан газрыг барих.

МАССИ́РОВАТЬ II цуглуулах, хуримтлуулах, бөөгнөрүүлэх.

МАССОВИ́К олон нийтийн зохион байгуулагч.

МАССО́ВКА 1. өчүүхэн цуглаан, 2. кинонд туслах тоглогчид.

МА́ССОВОСТЬ нийтийн чанар, өргөн олныг хамарсан (байх); ~ **спорта** өргөн олныг хамарсан спорт.

МА́ССОВ||ЫЙ 1. олон түмний, өргөн олны, өргөн түмний, олон нийтийн; **в ~ом масштабе** өргөн олноороо; 2. олон түмний, өргөн олны, нийтийн, өргөн олон; 3. олон түмний, олон түмний дунд явуулдаг, өргөн олны; 4. өргөн олон, нийт олон; ~ **читатель** өргөн олон уншигч.

МА́ССЫ олон түмэн, өргөн олон, өргөн түмэн, олон.

МАСТА́К чадмаг хүн.

МА́СТЕР 1. мастер чадварчин; **сменный** ~ээлжийн мастер; 2. дархан, -чин; **золотых дел** ~ алт мөнгөний дархан; **сапожный** ~ гуталчин, часовой ~ цагчин; 3. мастер; ~ **спорта** спортын мастер; 4. уран мэргэн, чадамгай хүн; **он ~ рассказывать** ярих хөөрхдөө чадамгай; * **на все руки** ~ гартаа дүйтэй хүн, арван хуруу тэгш.

МАСТЕРИ́ТЬ урлах, дархлах.

МАСТЕРИ́ЦА 1. оёдолчин (эмэгтэй); 2. уран эмэгтэй; **она ~ вышивать** хатгамаллахдаа уран эмэгтэй.

МАСТЕРОВО́Й үйлдвэрийн ажилчин.

МАСТЕРСКАЯ 1. дархны газар, засварын газар; **столярная** ~ мужааны газар, модны дарханы газар; **часовая** ~ цагчны газар, цаг засварын газар; 2. тасаг; **инструментальная** ~ багаж зэвсгийн тасаг.

МА́СТЕРСКИ уран чадамгай, чадварлаг; **он ~ рисует** тэр (хүн) уран зурна.

МА́СТЕРСК||ИЙ уран чадамгай чадварлаг; **~ое исполнение симфонии** симфони чадамгай хөгжимдөх.

МАСТЕРСТВО́ 1. дарх; 2. чадвар, уран чадвар; **педагогическое** ~ багшийн чадвар, сурган хүмүүжүүлэх чадвар.

МАСТИ́КА 1. давирхайлаг шаваас; 2. (шалны) лавтай тос; 3. гүгэл.

МАСТИ́ТЫЙ алдар гавьяат, хүндэт гавьяат; ~ **учёный** хүндэт гавьяат эрдэмтэн.

МАСТ||Ь 1. зүс, зүсэм; **лошадь вороной ~и** хар зүсмийн морь; 2. (хөзрийн) өнгө; **бубновая** ~ дөрвөлжний өнгө; **ходить в ~** өнгө тааруулан гарах.

МАСТИ́Т хөхний үрэвсэл.

МАСШТА́Б, 1. хураангуй хэмжээ, хураангуйлсан хэмжээ, масштаб; 2. далайц хэмжээ; **в городском ~е** хотын хэмжээн дээр; **в маленьком ~е** бага хэмжээгээр.

МАТ I мад; **объявить** ~ мад тавих, мадлах; **сделать ~ в три хода** гурав нүүгээд мадлах (шатарт).

МАТ II сүлжмэл; ~ **соломенный** сүлжмэл сүрэл.

МАТ III бүдэх, биржгэр.

МАТ IV кричать благим ~ом чадал мэдэн хашгирах.

МАТЕМА́ТИК 1. тооны ухааны эрдэмтэн, (мэргэжилтэн), математикч; 2. тооны ухааны багш, тооны багш.

МАТЕМА́ТИКА тооны ухаан, математик; **высшая** ~ дээд тооны ухаан.

МАТЕМАТИ́ЧЕСК||ИЙ 1. тооны ухааны, математикийн; **~ая задача** тооны ухааны бодлого; ~ **анализ** тооны ухааны задлаг; 2. нарийн нягт; **определить что-либо с ~ой точностью** юмыг нарийн нягт тодорхойлох.

МАТЕРИА́Л хэрэглэгдэхүүн, (түүхий эд), материал; **строительные ~ы** барилгын хэрэглэгдэхүүн; 2. хэрэглэгдэхүүн материал, мэдээ; 3. даавуу эд материал.

МАТЕРИАЛИ́ЗМ материализм; **исторический** ~ түүхэн материализм.

МАТЕРИАЛИ́СТ I материалист.

МАТЕРИАЛИ́СТ II ашиг харагч, олз харагч.

МАТЕРИАЛИСТИ́ЧЕСКИЙ материалист.

МАТЕРИАЛИСТИ́ЧНЫЙ ашиг харсан, олз хардаг.

МАТЕРИА́ЛЬНО эд мөнгөний талаар, эд мөнгөөр; **обеспечить** ~ эд мөнгөний талаар хангах, эд мөнгөөр хангах.

МАТЕРИА́ЛЬН||ЫЙ 1. эд хэрэглэгдэхүүний, эд материалын; **~ые склады** эд хэрэглэгдэхүүний агуулах; 2. эд хөрөнгөний, эд мөнгөний.

МАТЕРИ́К тив эх газар; **Африканский** ~ Африк тив, Үхэр эдлэгч тив.

МАТЕРИКО́В||ЫЙ тивийн эх газрын; **~ые острова** эх газраас тасарсан арлууд; **~ое обледенение** эх газрын мөстлөг.

МАТЕРИ́НСК||ИЙ эхийн; **~ая ласка** эхийн энхрийлэл; **~ая любовь** эхийн хайр.

МАТЕРИ́НСТВ||О 1. эх болох; **охрана ~а и младенчества** эх нялхсыг хамгаалах явдал; 2. эхийн сэтгэл; **чувство ~а** эхийн сэтгэл.

МАТЕ́РИ||Я I 1. матери, бод; 2. бодис, матери; **строение ~и** бодисын бүтэц.

МАТЕ́РИЯ II бөс даавуу, бөс бараа; **шерстяная** ~ ноосон даавуу.

МАТЕ́РЧАТЫЙ бөс, даавуун.

МАТЁРЫЙ 1. азарган, мундаг, лут; ~ **волк** азарган чоно, хашир чоно; ~ **дуб** мундаг царс мод; 2. дүүрсэн, догьширсон, хашир; ~ **бюрократ** дүүрсэн хүнд сурталтан.

МА́ТИЦА дам нуруу.
МА́ТКА 1. умай сав, хэвтэш; 2. эм охин, эх мал, хээлтэгч мал; **пчелиная ~** эм зөгий, хатан зөгий.
МА́ТОВ||ЫЙ 1. бүдэх, бүдэг, цайвгар; **~ая кожа лица** цайвгар арьстай нүүр; 2. бүүдгэр бүдэх; **~ое стекло** бүдэх шил.
МА́ТОЧНИК 1. хатан зөгийн үүр, эх мал маллагч.
МА́ТОЧН||ЫЙ 1. умайн савны, хэвтшийн; 2. эм малын, эх малын, хээлтэгч малын; 3. эх; **~ куст** эх бут; **~ая порода** эх чулуулаг; **~ раствор** эх уусгамал.
МАТРА́С дэвсгэр; **пружинный ~** пүрштэй дэвсгэр.
МАТРА́СН||ЫЙ дэвсгэрийн; **~ая ткань** дэвсгэрийн даавуу, дэвсгэр бүрэх даавуу.
МАТРИАРХА́ЛЬН||ЫЙ эхийн эрхт (ёсны); **~ые отношения** эхийн эрхт харьцаа.
МАТРИАРХА́Т эхийн эрхт ёс.
МАТРИМОНИА́ЛЬНЫЙ гэрлэхийн, гэрлэх.
МА́ТРИЦА үсгийн хэв, матриц.
МАТРИЦИ́РОВАТЬ үсгийн хэв хийх, матриц хийх.
МАТРО́С усан цэрэг.
МАТРО́СКА усан цэрэг цамц.
МАТРО́ССКИЙ усан цэргийн; **~ танец** усан цэргийн бүжиг.
МА́ТУШКА 1. эх, ээж, 2. авгай, эмээ.
МАТЧ тэмцээн; **шахматный ~** шатрын тэмцээн.
МАТЬ эх.
МА́УЗЕР маузер буу, сэлээдий.
МАХ (дугуй, сэнсний) нэг эргэлт, далайлт; *** дать ~у** алдаа хийх, гэнэдэх; **одним ~ом** нэг амьсгаагаар; **с ~у** гэнэт.
МАХА́ЛОВКА *разг.* зодоон, цохион.
МАХА́ТЬ 1. даллах, дэвэх, сэвэх, шарвалзуулах; **~ платком** алчуураар даллах; **~ крыльями** жигүүрээ дэвэх; 2. даллах, даллан дохио өгөх; **маши им рукой, чтобы шли сюда** тэднийг наашаа ир гэж далал.
МАХИ́НА данхгар юм, лут юм, лужгар юм.
МАХИНА́ЦИЯ ов, заль мэх, бааш.
МАХНУ́ТЬ 1. даллах, дэвэх; 2. даллан дохио өгөх; 3. харайн гарах. үсрэн гарах; **~ рукой на кого, что** зөнгөө мэдэг гээд орхих, зөнгөөрөө болог гээд орхих.
МАХОВИ́К эрчлүүр, ээрцэг дугуй.
МАХОВ||О́Й ~ое колесо эрчлүүр ээрцэг дугуй; **~ые перья** урт өд; **~ая сажень** алд.
МА́ХОМ тэр дорхноо, тэр даруй, агшин зуур.
МАХО́РКА мохоор тамхи.
МАХО́РОЧНЫЙ мохоорын.
МАХРО́В||ЫЙ 1. саглагар, хэлтсэрхэг; **~ая астра** саглагар гэсэр цэцэг; 2. хэтэрхий.
МАХРЫ́ сэмэрхий.
МА́ЧЕХА хойт эх.
МА́ЧТА (онгоцны) сураг, шураг.
МА́ЧТОВЫЙ сургийн, сураг хийх, **~ лес** сургийн мод.
МАШИ́НА1. машин; **паровая ~** уурын машин; **швейная ~** оёдлын машин; **~ электронно-вычислительная** цахим тооцон бодох машин 2. машин; **личная ~** хувийн машин; 3. байгуулалт, зохион байгуулалт.
МАШИНА́ЛЬНО санамсаргүй, өөрөө мэдэлгүй, аяндаа.
МАШИНА́ЛЬНЫЙ санамсаргүй (өгсөн), санаанд үгүй (хийсэн), өөрөө мэдэлгүй (хийсэн), аяндаа (болсон); **~ ответ** санамсаргүй өгсөн хариу.
МАШИНИ́СТ *машинч.*
МАШИНИ́СТКА бичээч эмэгтэй.
МАШИ́НК||А 1. машин; 2. (бичгийн) машин; **печатать на ~е** машинаар цохих.
МАШИ́НН||ЫЙ машинын, машинаар; **~ое масло** машинын тос.
МАШИНОПИ́СНЫЙ машиндсан, цохисон, машиндах, машинаар цохих.
МАШИ́НОПИСЬ машиндах, машинаар цохих.
МАШИНОСТРОЕ́НИЕ машин бүтээх.
МАШИНОСТРОИ́ТЕЛЬНЫЙ машин бүтээх.
МАЯ́К гэрэлт цамхаг.
МА́ЯТНИК дүүжмэг; **часовой ~** цагийн дүүжмэг.
МА́ЯТЬСЯ зовох, энэлэх.
МАЯ́ЧИТЬ бөртөлзөх, бөртийх, сүүдийх, сүүдэлзэх.
МГЛА 1. униар, будан, 2. бүрэнхий харанхуй.
МГЛИ́СТЫЙ униартай, будантай, униар татсан, будан татсан.
МГНОВЕ́НИЕ агшин зуур; **в одно ~** агшин зуур; **в ~ ока** нүд ирмэх зуур, нүд цавчих зуур.
МГНОВЕ́ННО агшин зуур, дорхноо, төдхөн гэнэт.
МГНОВЕ́ННЫЙ агшин зуурын, гэнтийн, дорхноо (хийсэн); **~ое сгорание** агшин зуур ноцох, дорхноо асах.
МЕ́БЕЛЬ (гэрийн) тавил, гэрийн хэрэгсэл; **мягкая ~** (гэрийн) зөөлөн тавил.
МЕ́БЕЛЬНЫЙ (гэрийн) тавилын, гэрийн хэрэгслийн; **~ магазин** (гэрийн) тавилгын дэлгүүр.
МЕ́БЕЛЬЩИК (гэрийн) тавилын дархан, (гэрийн) тавилч.
МЕБЛИРО́ВАНН||ЫЙ (гэрийн) тавилтай, (гэрийн) тавил тавьсан; **~ая квартира** (гэрийн) тавилтай байр.
МЕБЛИРОВА́ТЬ (гэрийн) тавил тавих.
МЕБЛИРО́ВКА 1. (гэрийн) тавил тавих; 2. гэрийн тавил.
НАПЛАСТОВА́НИЕ 1. давхраастах, үетэх, үетэн тогтох; 2. давхраас; **песчаное** ~ элсэн давхраас.

НАПЛАСТОВА́ТЬ 1. давхрааслан тавих, давхрааслах, үелэн тавих; 2. үелэх, үе үеэр болгох.

НАПЛАСТОВА́ТЬСЯ давхраастах, давхраастан тунах, үетэх, үетэн тогтох.

НАПЛЕВА́ТЕЛЬСК||ИЙ тоомсоргүй, доорд үзэх; ~**ое отношение** тоомсоргүй хандах, доорд үзэх хандлага.

НАПЛЕВА́ТЬ 1. нулимах; 2. эс тоох, үл тоомсорлох; **мне на это** ~ би үүнийг эс тоожээ.

НАПЛЕСКА́ТЬ цалгиулах, цалгиулан асгах, цацах; ~ **воды** на пол шал дээр ус цацах.

НАПЛЕСКА́ТЬСЯ цалгих, цалгин асгарах, цацран асгарах.

НАПЛЁСКИВАТЬ цалгиулах, цалгиулан асгах, цацах.

НАПЛЕСТИ́ 1. гөрөх, сүлжих; ~ **корзинку** саг сүлжих; 2. худал чалчих.

НАПЛЕ́ЧНЫЙ мөрний, мөр дээрх; ~ **ремень** мөрөвч.

НАПЛОДИ́ТЬ өсгөх, үржүүлэх.

НАПЛОДИ́ТЬСЯ өсөх, үржих.

НАПЛЫ́В 1. хаг; ~ **в котле** тогооны хаг; 2. ур; 3. илүү туурай; 4. олноор ирэх, олноор цугларах; ~ **гостей** зочин олноор ирэх.

НАПЛЫВА́ТЬ,

НАПЛЫ́ТЬ 1. хөвсөөр мөргөх, дайрах; ~ **на камень** хөвсөөр чулуу мөргөх, 2. олноор ирэх, олноор цугларах.

НАПОВА́Л убить ~ дор нь алах, зогсоогоор алах.

НАПОДО́БИЕ адил, мэт, шиг, шуу (*шүү*); **скала** ~ **стены** хэрэм мэт хад.

НАПОИ́ТЬ 1. уулгах, услах; ~ **ребёнка** молоком хүүхдэд сүү уулгах; 2. шингэх, анхилах, дүүрэн байх; **воздух напоён запахом цветов** агаарт цэцгийн үнэр анхилна.

НАПОКА́З олны нүдэн дээр, хүнд үзүүлэхээр, олны нүд хуурах гэж; **делать что-либо** ~ юмыг нүд хуурах гэж хийх.

НАПОЛЗ||ТИ́ 1. мөлхөөр мөргөх, мөлхөөр дайрах; ~ **на пень** мөлхөөр хожуул мөргөх; 2. орох, мөлхөж орох; ~**ли тараканы** олон жоом оржээ.

НАПОЛНЕ́НИЕ дүүрэх, дүүргэх.

НАПО́ЛНИТЬ дүүргэх, дүүртэл хийх, дүүрэх; ~ **комнату дымом** тасалгаанд утаа дүүрэх.

НАПОЛНИ́ТЕЛЬ дүүргүүр.

НАПО́ЛНИ||ТЬСЯ дүүрэх; **аудитория ~лась студентами** оюутан танхим дүүрэв.

НАПОЛНЯ́ТЬ дүүргэх, дүүрэн хийх.

НАПОЛНЯ́ТЬСЯ дүүрэх.

НАПОЛОВИ́НУ хагас, хагасыг; **дом** ~ **пуст** гэрийн хагас хоосон байна; **делать дело** ~ хэргийнхээ хагасыг бүтээх.

НАПОМИНА́НИЕ сануулах, дурдах, сануулга, дуртгал.

НАПО́МНИ||ТЬ 1. сануулах, дурдах; ~ **обещание** амласныг нь сануулах; 2. санагдуулах; **он ~л мне старого товарища** тэр (*хүн*)хуучин нөхрийг минь санагдуулав.

НАПО́Р 1. түрц, түлхэц, түрэлт, даралт, шахалт; ~ **воды** усны түрц; ~ **подземных вод** газар доорхи усны даралт; 2. эрс зориг; **действовать с ~ом** эрс зоригтой үйлдэх.

НАПО́РИСТОСТЬ шургуу байх, даамай зан.

НАПО́РИСТЫЙ шургуу, даамай; ~ **человек** шургуу хүн.

НАПОРО́ТЬ адах, урах; ~ **руку на гвоздь** хадаасанд гараа адах.

НАПОРО́ТЬСЯ 1. адах, урах; ~ **на гвоздь** хадаасанд адах; 2. гэнэт учрах, дайралдах, орох; ~ **на неприятность** аягүй байдалд гэнэт орох.

НАПОРОШИ́||ТЬ бургих, бургиж орох; ~**ло снегу** цас бургив.

НАПО́РТИТЬ 1. эвдэх, муудуулах, гутаах; 2. хор хүргэх, хорлох.

НАПОСЛЕ́ДОК, сүүлд нь, эцэст нь, хожим нь, чингэсээр.

НАПРА́ВИТЬ 1. чиглүүлэх, зүглүүлэх, хандуулах, залах, харуулах; ~ **основной удар** гол цохилтыг чиглүүлэх; ~ **внимание** анхаарлаа хандуулах; 2. илгээх, явуулах, томилох; ~ **заявление в суд** шүүхэд өргөдөл илгээх; ~ **больного к врачу** өвчтөнийг эмчид явуулах; ~ **на работу** ажилд томилох; 3. хурцлах, билүүдэх, ирлэх, таллах; ~ **бритву** тонгорог ирлэх; 4. залах, эмхлэх; ~ **работу** ажлыг эмхлэх.

НАПРА́ВИТЬСЯ 1. чиглэх, зүглэх, мордох, одох; ~ **на юг** өмнө зүг одох,2. эмхрэх, бүтэх.

НАПРА́ВКА хурцлах, билүүдэх, ирлэх; ~ **бритвы** тонгорог хурцлах.

НАПРАВЛЕ́НИ||Е 1. чиглэх, зүглэх, одох; 2. зүг, чиг; **во всех ~ях** зүг бүрд, зүг бүхэнд; 3. чиглэл, зам; 4. фронтын хэсэг,

чиглэл; 5. чиглэл, бүлэглэл; **литературные ~я** утга зохиолын чиглэл; 6. томилолтын бичиг; **вручить ~** томилолтын бичиг гардуулах.

НАПРА́ВЛЕННОСТЬ зорилгын чиглэл; **идейная ~** үзэл санаany зорилгын чиглэл.

НАПРАВЛЯ́ТЬ 1. чиглүүлэх, зүглүүлэх,хандуулах, залах, харуулах; 2. илгээх, явуулах, томилох; 3. хурцлах, билүүдэх, ирлэх, таллах; 4. залах, эмхлэх.

НАПРАВЛЯ́ТЬСЯ 1. чиглэх, зүглэх, одох, мордох; 2. эмхрэх, бүтэх.

НАПРА́ВО баруун тийш, баруунш, өрнө тийш, баруунтаа; **повернуть ~** баруун тийш эргэх; **~ от дома** байшингийн баруунтаа, гэрийн баруунтаа.

НАПРАКТИКОВА́ТЬСЯ туршлага олох, дадлага олох.

НАПРА́СЛИН||А гүтгэх, гүжирдэх, гөрдөх; **взвести ~у на кого-либо** хүнийг гүтгэх.

НАПРА́СНО хий, дэмий, хоосон, талаар.

НАПРА́СН||ЫЙ 1. дэмий, хоосон, үргүй; **~ые усилия** хоосон зүтгэл; **~ труд** дэмий ажил, үргүй ажил; **~ые хлопоты** дэмий төвөг; 2. дэмий, хоосон, үндэсгүй, хэрэгтүй; **~ страх** дэмий айх.

НАПРА́ШИВА||ТЬСЯ 1. эрэх, сануулах, гэх, гэсэн байдалтай байх; 2. гарах, мэдэгдэх; **выводы ~ются сами** собой дүгнэлт нь өөрөө гарч байна.

НАПРИМЕ́Р жишээлбэл, үлгэрлэвэл; **был, ~, такой случай** жишээлбэл, ийм явдал болсон юм.

НАПРОКА́ЗИТЬ,

НАПРОКА́ЗНИЧАТЬ дүрсгүйтэх, томоогүйтэх.

НАПРОКА́Т түр хөлсөөр; **брать пианино ~** төгөлдөр хуур хөгжим түр хөлсөөр авах.

НАПРОЛЁТ турш, туж, тужжин; **он и не спал всю ночь ~** тэр хоёр шөнөжин унтаагүй.

НАПРОЛО́М 1. шууд дайран, шууд цохин,шууд татан; 2. зориг мэдэн, зол мэдэг гээд; **действовать ~** зориг мэдэн үйлдэх.

НАПРОПАЛУ́Ю ухаан жолоогүй, сэхээ намаагүй; **веселиться ~** сэхээ намаагүй цэнгэх.

НАПРОРО́ЧИТЬ зөгнөх, совин татах, ёрлох; **~ гибель кому-либо** хүний үхэхийг ёрлох.

НАПРОСИ́ТЬСЯ 1. эрэх, сануулах, гэх, гэсэн байдал үзүүлэх; **~ в гости** зочлохыг сануулах, зочлох гэх; **~ на комплимент** магтуулах гэсэн байдал үзүүлэх.

НАПРО́ТИВ I 1. урд,эсрэг харж, өмнө талд, нөгөөтээ; **сидеть ~** урд нь суух, урдаас харж суух; **он живёт ~** тэр (*хүн*)эсрэг талд суудаг; 2. эсрэг, огт өөр, шал ондоо, урвуу, 3. үгүй, харин, байтугай, харин; **здесь плохо? — напротив, хорошо** энд баргтайхан уу? — үгүй харин зүгээр.

НАПРО́ТИВ II урд,өмнө; **~ дома** байшингийн урд.

НАПРУ́ЖИТЬ чангалах, хүчлэх, зангируулах; **~ мускулы** булчин чангалах, зангируулах.

НАПРУЖИ́ТЬСЯ чангарах, зангирах; **мускулы напружились** булчин чангарав.

НАПРЯ́Г *разг.* хүнд байдал ядаргаа.

НАПРЯГА́ТЬ 1. чангаруулах, зангидах; **~ мышцы** булчин зангидах; 2. шавхах, хүчирлэх, хурцатгах, сонор болгох, ширтэх; **~ все силы** бүх хүчээ шавхах; **~ зрение** ширтэн харах; **~ слух** чихээ сонор болгох.

НАПРЯГА́ТЬСЯ 1. чангарах, зангирах; 2. хүчирлэх, хүчээ зангидах, чадал гаргах.

НАПРЯЖЕ́НИ||Е 1. хүчирлэх, хүч гаргах; 2. сонор болгох, хурцатгах, их анхаарах; **слушать с ~ем** их анхааралтай сонсох; 3. бэрхтэй байх, түгшүүртэй байх; 4. хүчдэл; **ток высокого ~я** өндөр хүчдэлийн гүйдэл; **~ переменное** хувьсах хүчдэл; **~ условное** томьёолсон хүчдэл.

НАПРЯЖЁННО хүчирлэн, хүч гарган; **~ работать** хүчирлэн ажиллах.

НАПРЯЖЁННОСТЬ чангарах, бэрх болох, төвөгтэй болох, түгшүүртэй болох; **~ положения** байдал түгшүүртэй байх, түгшүүртэй байдал.

НАПРЯЖЁНН||ЫЙ 1. чадал гаргах, хүч гаргах, хүчирлэх, хүч зангидах; **~ая работа** хүч гаргах ажил; 2. хүчилсэн, хүчээр гаргасан; **~ смех** хүчээр инээх; 3. бэрхтэй, төвөгтэй, түгшүүртэй, муудалцах; **~ые взаимоотношения** хоорондоо муудалцах.

НАПРЯМИ́К 1. эгц, шууд, шулуун, цэх явах; 2. шулуун, шууд; **сказать ~** шулуун хэлэх.

НАПРЯ́СТЬ ээрэх; **~ льну** маалинга ээрэх.

НАПРЯ́ЧЬ 1. чангаруулах, зангидах; 2. шавхах, хүчирлэх, хурцатгах, сонор болгох, ширтэх.

НАПРЯ́ЧЬСЯ 1. чангарах, зангирах; 2. хүчирлэх, хүчээ зангидах, чадлаа гаргах.

НАПУГА́ТЬ айлгах, цочоох, үргээх.

НАПУГА́ТЬСЯ айх, цочих, үргэх.

НАПУ́ДРИТЬ оодох, оо тавих, оо түрхэх.

НАПУ́ДРИТЬСЯ нүүрээ оодох, нүүртээ оо тавих, нүүртээ оо түрхэх.

НАПУСКА́ТЬ 1. тавих, хийх, оруулах, дүүргэх; 2. дүр үзүүлэх, байдал гаргах; 3. тухирах, тавих.

НАПУСКА́ТЬСЯ зандрах, хараах, дайрах.

НАПУСКН||О́Й нүд хуурсан, дүр үзүүлсэн, хуурамч; **~ая важность** ихэмсэг дүр үзүүлэх.

НАПУСТИ́ТЬ, 1. тавих, хийх, оруулах, дүүргэх; **~ воды в ванну** онгоцонд ус хийх, ус тавих; **~ дым в комнату** тасалгаанд утаа оруулах; 2. дүр үзүүлэх, байдал гаргах; **~ на себя важность** ихэмсэг дүр үзүүлэх; 3. турхирах, тавих; **~ собак на зверя** анд нохой тухирах; **~ страху на кого-либо** хүнийг ихэд айлгах.

НАПУСТИ́ТЬСЯ зандрах, харааж дайрах.

НАПУ́ТАТЬ 1. эдрээх, ороцолдуулах; 2. хутгах, будлиантуулах; **~ в подсчётах** тоолохдоо будлиантуулах.

НАПУ́ТСТВЕННН||ЫЙ мордоход захисан, явахад нь ерөөсөн, үдсэн; **~ое слово** мордоход захисан үг.

НАПУ́ТСТВИЕ үдэх ерөөл, үдэх захиа.

НАПУ́ТСТВОВАТЬ мордоход захих, үдэх ерөөл хэлэх.

НАПУХА́ТЬ хавдах, хөөх.

НАПЫ́ЖИТЬСЯ 1. хүчирлэх; 2. маадайх, маадгар байх.

НАПЫЛИ́ТЬ 1. тоос бужигнуулах, тоос дэгдээх; 2. тоос болгох.

НАПЫ́ЩЕННОСТЬ 1. маадгар зан, подгор байдал, маадайх, подойх; 2. гоёмсоглосон үг.

НАПЫ́ЩЕННЫЙ 1. маадгар, подгор; **~ вид** маадгар байдал; 2. гоёмсоглосон, гоёмсоглосон үгтэй; **~ стиль** гоёмсоглосон найруулга.

НАПЯ́ЛИВАТЬ,

НАПЯ́ЛИТЬ, 1. чихэж өмсөх, чуу гэж багтаах; **~ сапоги** гутлаа чуу гэж багтаах; 2. эвгүй хувцас өмсөх, тараагүй хувцаслах.

НАРАБО́ТАТЬ 1. хийх; 2. ажиллаж олох.

НАРАВНЕ́ 1. чацуу, тэнцүү, адил; **~ с крышей** дома байшингийн дээвэртэй чацуу; 2. адил, тэгш.

НАРА́ДОВАТЬСЯ баясаж ханах, баярлаж ханах; **не могу ~ на детей** хүүхдээ харан баясаж ханахгүй байна.

НАРАСПА́ШКУ энгэр задгай, заам задгай, энгэр заам задгай; **идти в пальто ~** пальтоныхоо энгэр заам задгай явах; **душа ~** цагаан санаа, юмаа нуудаггүй.

НАРАСПЕ́В гиншин, гингэнэн; **читать ~** гингэнэн унших.

НАРАСТА́НИЕ 1. өрнөлт, өрнөх; 2. өсөх, нэмэх, үржих; 3. ургах.

НАРАСТА́ТЬ ургах.

НАРАСТИ́ 1. ургах; **мох нарос на камнях** чулуун дээр хөвд ургажээ; 2. өсөж, нэмэх; **наросли проценты** хүү өсөв; 3. өрнөх; **волнение наросло** үймээн өрнөв.

НАРАСТИ́ТЬ 1. ургуулах; **~ новую кожу** шинэ арьс ургуулах; 2. залгах, нэмэх; **~ канат** татлага залгах.

НАРАСХВА́Т булаалдан, өрсөлдөн; **покупают ~** булаалдан авч байна.

НАРАЩЕ́НИЕ,

НАРА́ЩИВАНИЕ улам их болгох, улам нэмэгдүүлэх; **~ сил** хүчээ улам нэмэгдүүлэх.

НАРА́ЩИВАТЬ 1. ургуулах; 2. залгах, нэмэх.

НАРВА́Л далайн хирс.

НАРВА́ТЬ I 1. түүх, зулгаах; **~ цветов** цэцэг түүх; 2. урах, тасдах; **~ бумаги** цаас урж хаях.

НАРВА́||ТЬ II хувилах, буглах, идээлэх; **~ло палец** хуруу идээлэв.

НАРВА́ТЬСЯ аргагүй дайралдчих, мөргөлдчих, дээр орчих; **~ на неприятность** эвгүй юмтай аргагүй дайралдчих.

НАРЕ́З гурви, ховил, хэрчлээ; **винтовой ~** шургийн ховил, шургийн эрэг.

НАРЕ́ЗАТЬ 1. огтлох, зүсэх, хэрчих, хөшиглөх; **~ хлеба** талх зүсэх; **~ сало ломтиками** өөх хөшиглөх; 2. гурви гаргах, ховил гаргах, хэрчлээ хийх, эрэг гаргах; **~ винт** эрэг гаргах; 3. тасалж өгөх, хувааж өгөх.

НАРЕ́ЗКА 1. тасалж өгөх, хувааж өгөх; 2. эрэг шургийн говил; **~ винта стерлась** шургийн эрэг элчихжээ.

НАРЕЗНО́Й гурвитай, ховилтой, хэрчээтэй, эрэгтэй; **~ ствол** ховилтой гол төмөр.

НАРЕ́ЗЫВАТЬ 1. огтлох, зүсэх, хэрчих, хөшиглөх; 2. гурви гаргах, ховил гаргах, хэрчлээ хийх, эрэг гаргах; 3. тасалж өгөх, хувааж өгөх.

НАРЕКА́НИ||Е зэмлэл, донгодлого; **вызвать ~я** донгодуулах.

НАРЕЧЁННЫЙ ёст, хувьт, тавилант, болзорт.

НАРЕ́ЧИЕ I аялгуу; **северновеликорусское ~** хойт орос аялгуу.

НАРЕ́ЧИЕ II дайвар үг.

НАРЕ́ЧНЫЙ дайвар үгийн, дайвар үгт.

НАРЗА́Н нарзан (*рашаан*).

НАРЗА́ННЫЙ нарзаны, нарзант; **~ источник** нарзаны булаг.

НАРИСОВА́ТЬ 1. зурах; 2. дүрслэн үзүүлэх, дүрийг харуулах.

НАРИСОВА́ТЬСЯ *разг.* харагдах хүрч ирэх.

НАРИЦА́ТЕЛЬН||ЫЙ нэрийтгэл; **~ое имя** нэрийтгэл нэр; **~ая стоимость** нэрийтгэл өртөг, заасан өртөг.

НАРКО́З наркоз, бадайруулах, мэдээ алдуулах.

НАРКО́М (*народный комиссар*) ардын комиссар.

НАРКОМА́Н мансуурагч.

НАРКОМА́Т (*народный комиссариат*) ардын комиссарын яам.

НАРКО́ТИК 1. наркотик (*мэдээ алдуулах, унтуулах бодис*), 2. хар тамхи.

НАРКОТИ́ЧЕСК||ИЙ наркотик, наркотиктай; **~ое вещество** наркотик бодис; **~ие растения** наркотиктай ургамал.

НАРО́Д 1. ард, ард түмэн; 2. үндэстэн, ард түмэн; **великий русский ~** их оросын ард түмэн, их орос үндэстэн; **выходцы из ~а** ардын дундаас гарагсад; 3. хүн, улс; **на собрании было много ~у** хүрэлд олон хүн байв.

НАРОДИ́ТЬ төрүүлэх, гаргах; **~ много детей** олон хүүхэд төрүүлэх.

НАРОДИ́||ТЬСЯ 1. төрөх, гарах; **сын ~лся** хүү төрөв; 2. бий болох; **~лись новые отрасли промышленности** үйлдвэрийн шинэ салбар бий болов.

НАРО́ДНИК народник (*народник үзэлтэн;народник хөдөлгөөнд оролцогч*).

НАРО́ДНИЧЕСТВО народник үзэл,народник хөдөлгөөн (*тариачны хүй нэгдлийг сайшаан магтаж ажилчин ангийн удирдах үүргийг үгүйсгэдэг байсан 19 дүгээр зууны хоёрдугаар хагасын оросын жижиг хөрөнгөтний сэхээтний нийгэм улс төрийн хөдөлгөөн*).

НАРО́ДНО-ДЕМОКРАТИ́ЧЕСКИЙ ардын ардчилсан; **~ строй** ардын ардчилсан байгуулал.

НАРО́ДНОСТ||Ь 1. ястан; **~и Востока** дорно зүгийн ястнууд; 2. ардач чанар; **~ советской литературы** Зөвлөлтийн утга зохиолын ардач чанар.

НАРОДНОХОЗЯ́ЙСТВЕННЫЙ улс ардын аж ахуйн; **~ план** улс ардын аж ахуйн төлөвлөгөө.

НАРО́ДН||ЫЙ 1. ардын, ард түмний; **~ое хозяйство** ардын аж ахуй; **~ое имущество** ардын хөрөнгө; **~ая республика** бүгд найрамдах ард улс; **~ая демократия** ардын ардчилал; **~ учитель** ардын багш; **широкие ~ые массы** өргөн олон ард түмэн; 2. улс ардын, ардын; 3. ардын чанартай; **поэзия Пушкина ~а** Пушкины яруу найраг ардын чанартай.

НАРОДОВЕ́ДЕНИЕ угсаатны зүй.

НАРОДОВО́ЛЕЦ «Ардын зориг» гэдэг нууц народник байгууллагын гишүүн.

НАРОДОНАСЕЛЕ́НИ||Е хүн ам; **увеличение ~я** хүн ам өсөх.

НАРОЖДА́ТЬСЯ 1. төрөх, гарах; 2. бий болох.

НАРОЖДЕ́НИЕ төрөх, бий болох, төрөлт; **~ нового** шинэ юм бий болох.

НАРО́СТ 1. ур, ашиг, булуу; **~ на стволе дерева** модны ур; 2. хаг, өнгөр, ээрмэг; **образовался ~ на стенках котла** тогоо хагтав.

НАРОЧИ́Т||О санаатай, зориуд; **~ая невнимательность** зориуд хайхрахгүй байв.

НАРО́ЧНО 1. зориуд, зориогоор, санаатайгаар, хэрэг болгож; **я ~ пришёл, чтобы предупредить вас** танд мэдэгдэх гэж би зориуд ирлээ; 2. тоглож, тоглоом болгон; **~ это сказал, вы не сердитесь** та бүү уурла, би тоглож хэлсэн юм.

НА́РОЧНЫЙ зарлага, элч.

НАРСУ́Д ардын шүүх (*народный суд*).

НА́РТЫ наарт чарга.

НАРУБА́ТЬ,

НАРУБИ́ТЬ хагалах, цавчих, огтлох, хэрчих, хөшиглөх; **~ дров** түлээ хагалах; **~ капусты** байцаа хэрчих, байцаа хөшиглөх.

НАРУ́ЖНО гаднаас, гаднаа, гадаад талаараа, гадаад байдлаараа, царайгаараа, царай зүс нь.

НАРУ́ЖНОСТЬ царай, зүс, гадаад үзэгдэл, өнгө зүс, царай зүс; **приятная ~** аятай царай; **обманчивая ~** хуурамч царай, хуурамч дүр.

НАРУ́ЖН||ЫЙ 1. гадаад, гаднахь, гадаа, гадар, гадар өнгөний; **~ вид дома** байшингийн гадаад байдал; **~ое лекарство** гадар өнгөний эм; 2. өнгөний, гаднын, өнгөндөө, гаднаа; **~ое спокойствие** өнгөндөө амгалан байх.

НАРУ́ЖУ гадагш, гадаа; **выйти ~** гадаа гарах; **шуба мехом ~** үсийг нь урвуулсан дээл.

НАРУКА́ВНИК ханцуйвч.

НАРУКА́ВНЫЙ ханцуйн, ханцуй дээрх; **~ знак** ханцуй дээрх тэмдэг.

НА́РУКУ ашигтай, дөхөмтэй, тустай, хэрэгтэй; **это мне ~** энэ над ашигтай.

НАРУМЯ́НИВАТЬ улайлгах.

НАРУМЯ́НИТЬ 1. улайлгах; 2. улаанаар будах, энгэсэг тавих.

НАРУМЯ́НИТЬСЯ хацраа будах, нүүртээ энгэсэг тавих, энгэсэгдэх.

НАРУ́ЧНИКИ гав.

НАРУША́ТЬ1. алдуулах, алдагдуулах, таслах; 2. зөрчих, тэрслэх, гажих, давах, няцах, буцах.

НАРУША́ТЬСЯ алдагдах, тасрах.

НАРУШЕ́НИЕ зөрчих, зөрчилт; **~ договора** гэрээ зөрчих.
НАРУШИ́ТЕЛЬ зөрчигч, эвдэгч, давагч; **~ общественного порядка** нийтийн дэглэм эвдэгч; **~ границы** хил зөрчигч.
НАРУ́ШИТЬ 1. алдуулах, алдагдуулах, таслах; **~ покой** амгаланг алдагдуулах; **~ сон** нойр таслах; 2. зөрчих, тэрслэх, гажих, давах, няцах, буцах; **~ общественный порядок** нийтийн дэглэм тэрслэх, нийтийн дэглэм эвдэх; **~ закон** хууль зөрчих; **~ границу** хил давах; **~ обещание** амласнаа няцах.
НАРУ́ШИТЬСЯ алдагдах, тасрах; **сон нарушился** нойр тасрав.
НА́РЫ ханз,спать на нарах ханзан дээр унтах.
НАРЫ́В идээрлэсэн газар, бугшсан хавдар, хувилдас.
НАРЫВА́ТЬ I 1. түүх, зулгаах; 2. урах, тасдах.
НАРЫВА́ТЬ II хувилах, буглах, идээрлэх.
НАРЫВНО́Й идээр хөхүүлэх; **~ пластырь** гоюу.
НАРЫ́ТЬ ухах, малтах; **~ канав** суваг ухах; **~ картофеля** төмс малтах.
НАРЯ́Д I гоёл, гоёлын хувцас; **смешной ~** инээдэмтэй хувцас.
НАРЯ́Д II 1. цохдос, нариад; **~ на уголь** нүүрс авах цохдос; 2. жижүүр, нариад, жижүүрлэх, нариадлах; **внутренний ~** дотор жижүүр.
НАРЯДИ́ТЬ I гоёх, чимэх, гоюулах,г оё хувцаслах,өмсүүлэх.
НАРЯДИ́ТЬ II илгээх, томилох, томилон явуулах; **~ в караул** харуулд томилох; **~ подводы за лесом** хөсөг модонд илгээх.
НАРЯДИ́ТЬСЯ гоёх, гангалах, гоё хувцаслах, өмсөх; **~, как на бал** наадамд очих мэт гоёх; **~ в маскарадный костюм** багт наадмын хувцас өмсөх.
НАРЯ́ДНО гоё, ганган, гоёмсог; **~ одеться** гоё хувцаслах.
НАРЯ́ДН||ЫЙ 1. гоё, ганган, гоёмсог; **~ая девушка** гоё хүүхэн; 2. гоёмсог, гоё, сайхан, ганган; **~ое платье** гоёмсог хувцас.
НАРЯДУ́ зэрэгцээгээр, хажуугаар, хамт; **~ со взрослыми** томчуудын зэрэгцээгээр, насанд хүрэгсдийн хамт.
НАРЯ́ДЧИК даамал.
НАРЯЖА́ТЬ I гоёх,чимэх, гоюулах, гоё хувцаслуулах,өмсөх.
НАРЯЖА́ТЬ II илгээх, томилох, томилон явуулах.
НАРЯЖА́ТЬСЯ гоёх, гангалах, гоё хувцаслах, өмсөх.
НАС бидний, биднийг, маны, маныг; **у ~** бидэнд, манд, биднээс; **у ~ нет квартиры** бид гэргүй, бид байргүй; **он говорит о ~** тэр бидний тухай ярьж байна, тэр биднийг хэлж байна.
НАСАДИ́ТЬ I хатгах, углах, суулгах; **~ червяка на крючок** дэгээнд хорхой хатгах; **~ топор на топорище** сүхэнд иш углах, сүх ишлэх.
НАСАДИ́ТЬ II 1. суулгах,оруулах; **~ людей в вагон** вагонд хүн суулгах; 2. суулгах, тарих; **~ тополей** улиангар тарих; **~ смородины** үхрийн нүд суулгах.
НАСА́ДКА 1. суулгах; 2. илбээс.
НАСАЖА́ТЬ 1. суулгах, оруулах; 2. суулгах, тарих.
НАСАЖДА́ТЬ дэлгэрүүлэх, нэвтрүүлэх, заншуулах; **~ грамотность** бичиг үсэг дэлгэрүүлэх; **~ новую технику** шинэ техник нэвтрүүлэх.
НАСАЖДЕ́НИЕ I.дэлгэрүүлэх, нэвтрүүлэх, заншуулах; **~ просвещения** гэгээрэл дэлгэрүүлэх.
НАСАЖДЕ́НИ||Е II 1. суулгах, тарих, тарилга; 2. таримал мод, ургамал; **зеленые ~я** ногоон таримал мод.
НАСА́ЖИВАТЬ I 1. суулгах, оруулах; 2. суулгах,тарих.
НАСА́ЖИВАТЬ II хатгах, углах, суулгах.
НАСВИ́СТЫВАТЬ исгэрэх.
НАСЕВА́ТЬ 1. тарих; 2. шигших.
НАСЕДА́ТЬ 1. суух, тунах, дарах, тогтох; 2. түрэх, хаших.
НАСЕ́ДКА өндөг дарсан тахиа.
НАСЕКА́ТЬ 1. хэрчээс гаргах, сийлэх; 2. ир гаргах; 3. хөшиглөх, хэрчих.
НАСЕКО́МОЕ шавьж, хорхой, хорхой шавьж.
НАСЕКОМОЯ́ДН||ЫЙ шавьж тэжээлт; **~ое животное** шавьж тэжээлт амьтан.
НАСЕЛЕ́НИЕ 1. хүн ам; **городское ~** хотын хүн ам; **сельское ~** хөдөө тосгоны хүн ам; **самостоятельное ~** ажлын чадвар бүхий хүн ам; 2. хүн амтай болгох, хүнтэй болгох, хүн суулгах.
НАСЕЛЁННОСТЬ хүн амын тоо, хүн амын олон цөөн, хүн амын нягт сийрэг.
НАСЕЛЁНН||ЫЙ хүн олонтой; **~ая квартира** хүн олонтой байр; **~ пункт** суурин газар.
НАСЕЛИ́ТЬ хүн амтай болгох, хүнтэй болгох, хүн суулгах, нутагшуулах; **~ край** орон нутагт хүн суулгах.
НАСЕЛЯ́||ТЬ 1. хүн амтай болгох, хүнтэй болгох, хүн суулгах, нутагшуулах; 2. нутаглах, суух, оршин суух; **Среднюю Азию ~ют многие народы** Дундат Азид олон үндэстэн оршин сууна.
НАСЕ́СТ хонуур (*тахианы сууж хонодог хөндлөвч мод*).
НАСЕ́СТЬ I суух, багтан орох.
НАСЕ́||СТЬ II 1. суух, тунах, дарах, тогтох; **~ла пыль** тоос дарав; 2. түрэх, хаших; **~ на противника** дайсныг түрэх.
НАСЕ́ЧК||А 1. хэрчлээс гаргах, сийлэх, хээлэх; 2. хээ, сийлбэр; **ружьё с золотой ~ой** алтан сийлбэртэй буу.
НАСЕ́ЧЬ 1. хэрчлээс гаргах, сийлэх; **~ метки на бревнах** гуалинд тэмдэг сийлэх; 2. ир гаргах; **~ напильник** хуурай ирлэх; 3. хөшиглөх, хэрчих; **~ капусты** байцаа хөшиглөх.
НАСЕ́ЯТЬ 1. тарих; **~ пшеницу** буудай тарих; 2. шигших; **~ муки** гурил шигших.
НАСИДЕ́ТЬ өндөг дарах.
НАСИ́ЛИ||Е 1. хүч хэрэглэх, хар хүчээр хийх, хүчирхэх; **следы ~я на теле** биед нь хүч хэрэглэсний ор мөр; 2. хүчирхэх, хүчирхийлэх, хүчлэх, хүч хэрэглэх, албадах; **применить ~** хүч хэрэглэх, хүчирхэх.
НАСИ́ЛОВАТЬ 1. хүчирхэх, хүчирхийлэх, хүчлэх, албадах; **~ чью-либо волю** дургүй хүнийг албадах; 2. хүчирхэх, хүчирхийлэх, хүчирхэн явалдах.
НАСИ́ЛУ арай хийж, чуу гэж, арай мурий, арай чамай; **~ его добудился** арай чарай сэрээв; **~ поднял** арай гэж өргөв.
НАСИ́ЛЬНИК хүчирхэгч, түрэмгийлэгч; фашистские насильники фашист түрэмгийлэгчид.
НАСИ́ЛЬНО хүчээр, албаар, баалж; **~ увезли** хүчээр аваачив.
НАСИ́ЛЬСТВЕНН||ЫЙ хүчээр хийсэн, хүчээр гүйцэтгэсэн, албадан явуулсан; **~ая смерть** цаг бусын үхэл.
НАСКАКА́ТЬ 1. харайн дайрах, мөргөх; 2. давхих, давхин ирэх.
НАСКА́КИВАТЬ харайн дайрах, мөргөх.
НАСКВО́ЗЬ 1. нэвт, шувт, цоо; **валенки промокли ~** эсгий гутал нэвт норов; 2. огт, бүрмөсөн; **~ лживое заявление** бүрмөсөн худал мэдэгдэл; **видеть кого-либо ~** нэвт харах, дотор нь орсон шиг мэдэх.
НАСКО́К гэнэтийн дайралт, уулга; **с ~а делать что-либо** явуут хийх, морин дэл дээрээс хийх.
НАСКО́ЛЬКО 1. хир, хир зэрэг, хичнээн, хэдий чинээ; **~ это верно?** Энэ хир зөв вэ?; 2. хичнээн, ямар, (*заримдаа үгүлэн орчуулагдахгүй*); **~ здесь лучше!** энд ямар сайхан юм бэ?
НА́СКОРО яаран, санд мэнд, яаруу; **~ написанная статья** санд мэнд бичсэн өгүүлэл; **~ пообедать** яаран хооллоод гарах.
НАСКОЧИ́ТЬ харайн дайрах, мөргөх.
НАСКРЕСТИ́ 1. савардан цуглуулах; 2. арай чамай цуглуулах.
НАСКУ́ЧИ||ТЬ залхуутай болгох, залхуу хүргэх, хашраах, залхаах, хашрах, залхуурах; **дождь всем ~л** бороо бүгдийг залхаав.

НАСЛАДИ́ТЬСЯ цэнгэх, жаргах, цэнгэл хийх, жаргал эдлэх, бах ханах, бахдах.

НАСЛАЖДА́ТЬСЯ цэнгэх, жаргах, цэнгэл хийх, жаргал эдлэх, бах ханах, бахдах; ~ **музыкой** хөгжим чагнаж цэнгэх.

НАСЛАЖДЕ́НИЕ жаргалан, жаргал, цэнгэл, жаргах, цэнгэх, бах ханах, бахдах; **слушать с ~м** бахдан сонсох.

НАСЛА́ИВАТЬ 1. давхарлан тавих, давхарлах, үелэн тавих, давхарлан наах; 2. үетүүлэх, үетүүлэн хийх, давхарлан хийх, далан давхар болгох; 3. үелэх, үе үеэр болгох, үелэн салгах, хуулах.

НАСЛА́ИВАТЬСЯ давхраатах, үетэх.

НАСЛЕ́ДИЕ культурное ~ *соёлын өв*; **литературное** ~ утга зохиолын өв; **идейное** ~ **революционных демократов** хувьсгалч ардчилсан үзэлтнүүдийн үлдээсэн үзэл суртлын өв.

НАСЛЕДИ́ТЬ мөр үлдээх, мөр гаргах, гишгэлж муухай болгох; ~ **на полу** шал дээр мөр үлдээх.

НАСЛЕ́ДНИК 1. голомт залгамжлагч, өв залгамжлагч, угсаа залгагч; 2. залгамжлагч; **~и революционных традиций** хувьсгалт уламжлалыг залгамжлагчид.

НАСЛЕ́ДНЫЙ угсаа залгамжлах, ширээ залгамжлах; ~ **принц** хун тайж, ширээ залгамжлах агъ, жонон.

НАСЛЕ́ДОВАНИ||Е залгамжлах, өв залгамжлах, угсаа залгамжлах; **право ~я** өв залгамжлах эрх.

НАСЛЕ́ДОВАТЬ 1. залгамжлах, өвлөх; ~ **имущество** хөрөнгө өвлөх, өв залгамжлах; ~ **лучшие традиции** эрхэм уламжлалыг залгамжлах; 2. өв залгамжлах, өвлөх эрхтэй байх; **сын наследует отцу** хүү нь эцгийн өвийг залгамжилна.

НАСЛЕ́ДСТВЕННОСТ||Ь удамшил, удам; **Мичуринское учение о ~и** удамшлын тухай Мичурины сургаал.

НАСЛЕ́ДСТВЕНН||ЫЙ 1. өв, өвийн, өвлөх, өв залгамжлах; **~ое имущество** өв хөрөнгө; 2. удмын, удам дагах, удамшлын, удамшсан; **~ые болезни** удмын өвчин, удам дагасан өвчин.

НАСЛЕ́ДСТВО 1. өв, өв хөрөнгө; **культурное** ~ соёлын өв; 3. өвлөх, өв залгамжлах; **право наследства** өвлөх эрх.

НАСЛОЕ́НИЕ 1. давхарлах, үетэх; 2. давхраа; **песчаное** ~ давхраа элс; 3. хожмын зүйл, хөндлөнгийн юм, хожмын шинж.

НАСЛОИ́ТЬ 1. давхарлан тавих, давхарлах, үелэн тавих, давхарлан наах; ~ **резину** эрзээн давхарлан наах; 2. үетүүлэх, үетүүлэн хийх, давхарлан хийх, далан давхар болгох; ~ **тесто** зуурсан гурил үеэр болгох, үелэн салгах, хуулах; ~ **слюдо** гялтгануур үелэн хуулах.

НАСЛОЙ́ТЬСЯ давхраатах, үетэх.

НАСЛУ́ШАТЬСЯ сонсож ханах, цадтал дуулах, чагнаж ханах; ~ **разных новостей** элдэв сонин сонсож ханах.

НАСЛЫ́ШАТЬСЯ олон юм сонсох, их дуулах.

НАСМА́РКУ идти ~, пойти ~ балрах; **всё пошло** ~ бүр балрав.

НА́СМЕРТЬ үхтэл, алан; **разбиться** ~ үхтлээ бэртэх; **сразить пулей** ~ буудаж алах; **испугать** ~ үхтэл нь айлгах, сүнсий нь зайлтал айлгах; **стоять** ~ нэг нэгийгээ үзэх, амь өрсөн тулалдах.

НА́СМЕХ инээдэм, тоглоом, наадам; **поднять кого-либо** ~ хүнийг инээдэм болгох; **сказать** ~ тоглоом болгон хэлэх.

НАСМЕХА́ТЬСЯ шоолох, элэглэх, инээдэм болгох, дооглох,элэг барих.

НАСМЕШИ́ТЬ инээлгэх, инээд хүргэх.

НАСМЕ́ШК||А элэг доог, тоглоом тохуу, шоо; **сказать что-либо в ~у** дооглож юм хэлэх; **подвергаться ~ам** элэг доог болох, дооглуулах.

НАСМЕ́ШЛИВОСТЬ шооч зан,шог зан.

НАСМЕ́ШЛИВ||ЫЙ 1. доогтой, элэглэсэн, элэг барьсан, элэг доог хийсэн, инээд шоодтой, **~ая улыбка** доогтой инээд; 2. шооч, шогч; ~ **человек** шогч хүн.

НАСМЕ́ШНИК шооч хүн, шогч хүн.

НАСМЕЯ́ТЬСЯ 1. ханатал инээх, инээж ханан; 2. элэглэх, дооглох, наадам болгох, доог хийх; ~ **над чьими-либо чувствами** хүний сэтгэлийг наадам болгох.

НАСМОЛИ́ТЬ давирхайдах; ~ **веревку** татлага давирхайдах.

НА́СМОРК шуухинаа, хамрын ханиад, хамар тагжрах, хамар битүүрэх; **хронический** ~ архаг хамрын ханиад; **получить** ~ хамрын шуухинаа хүрэх.

НАСМОТРЕ́ТЬСЯ 1. олон үзэх, үзэж үзчихэх; ~ **новых картин** шинэ кинонуудыг үзэж үзчихэх; 2. харж ханах, ханатал харах; **смотрю, не насмотрюсь** хараад хараад ханахгүй байна.

НАСОЛИ́ТЬ 1. давслах, давсанд дарах; ~ **огурцов** өргөст хэмх давслах; 2. давс их хийх, их давслах, давс ихдүүлэх; ~ **суп** шөлөнд давс их хийх; 3. гэм хийх, хорлох, төвөг удах.

НАСОРИ́ТЬ хог тарих, хог шороо татах.

НАСО́С I хөөрөг, хагшаас; **нагнетательный** ~ шахах хөөрөг; **поршневой** ~ бүлэх хөөрөг; **пожарный** ~ түймрийн хөөрөг.

НАСО́С II тагнайтах, тагнайн хавдар.

НАСОСА́ТЬСЯ, цадтал хөхөх, хөхөж ханах; **ребёнок насосался молока** хүүхэд сүүгээ хөхөж ханав.

НАСО́СН||ЫЙ хөөргийн, сордог; **~ая машина** сордог машина.

НАСО́Х||НУТЬ барилдан хатах, наалдан хатах; **на колёсах ~ла грязь** мөөрт шавар наалдан хатжээ.

НА́СПЕХ яаруу, шамдуу, бачим; **делать что-либо** ~ юмыг бачим хийх.

НАСПЛЕ́ТНИЧАТЬ ховлох, хов хэлэх, хов жив зөөх.

НАСТ цар, цой, царцанги цас.

НАСТАВА́ТЬ ирэх.

НАСТАВИ́ТЕЛЬНЫЙ сургасан, заасан, зааварласан; ~ **тон** сургасан янзаар хэлэх.

НАСТА́ВИТЬ I 1. тавих, олныг тавих, өрөх; ~ **стульев** олон сандал тавих, сандал өрөх; 2. залгах; 3. тулгах, чиглүүлэх, залгах; ~ **дуло револьвера** гар буу тулгах, гар бууны ам чиглүүлэх.

НАСТА́ВИТЬ II сургах, заах, зааварлах, багшлах, номлох, сургаал тавих, зааж өгөх, оруулах; ~ **на ум** ухаан зааж өгөх, ухааруулах; ~ **на путь истины** зөв зам зааж өгөх, зөв замд оруулах.

НАСТА́ВКА залгаа.

НАСТАВЛЕ́НИЕ 1. сургамж, сургаал; **отцовское** ~ эцгийн сургаал; 2. заавар; ~ **по противовоздушной обороне** агаарын хамгаалалтын заавар.

НАСТАВЛЯ́ТЬ I 1. тавих, олныг тавих, өрөх; 2. залгах; 3. тулгах, чиглүүлэх, залгах.

НАСТАВЛЯ́ТЬ II сургах, заах, зааварлах, багшлах, номлох, сургаал тавих, зааж өгөх, оруулах.

НАСТА́ВНИК 1. багш, сургагч; 2. халамжлан хүмүүжүүлэгч.

НАСТА́ВНИЧЕСКИЙ сурганги, сургасан зааварланги, зааварласан; ~ **тон** сурганги янз.

НАСТАВН||О́Й 1. залгамал, залгаатай; **~ые рукава** залгаатай ханцуй; 2. залгах; **~ая труба** залгах хоолой.

НАСТА́ИВАТЬ I зүтгэх, шахах, зүтгэж биелүүлэх, шахаж болгох.

НАСТА́ИВАТЬ II буйлуулах, хандлах, идээшүүлэх.

НАСТА́ИВАТЬСЯ идээшлэх, ханд болгох.

НАСТА́||ТЬ болох, ирэх; **~ло утро** өглөө болов; **~ла весна** хавар болов.

НАСТЕГА́ТЬ хавах, хөших; ~ **ватное одеяло** хөвөнтэй хөнжил хавах.

НА́СТЕЖЬ цэлийтэл; **отворить дверь** ~ хаалга цэлийтэл нээх.

НАСТЕЛИ́ТЬ дэвсэх.

НАСТЕ́ННЫЙ ханын, туурганы; ~ **календарь** ханын хуанли.
НАСТИГА́ТЬ,
НАСТИ́ГНУТЬ гүйцэх, гүйцэн очих.
НАСТИ́Л 1. дэвсэх, хучих; 2. дэвсгэр, хучлага; **дощатый** ~ банзан дэвсгэр, дэвсгэр банз.
НАСТИЛА́ТЬ дэвсэх.
НАСТИЛА́ТЬСЯ дэвсэгдэх.
НАСТИ́ЛКА 1. дэвсэх, хучих; ~ **пола** шал дэвсэх; 2. дэвсгэр, хучлага.
НАСТИ́ЛЬНЫЙ цэх, хэвтээ; ~ **огонь** цэх гал, хэвтээ гал.
НАСТИРА́ТЬ олныг угаах; ~ **рубах** цамц олныг угаах.
НАСТИ́РЫВАТЬ олныг угаах.
НАСТИ́ЧЬ гүйцэх, гүйцэн очих; ~ **беглецов** оргодлуудыг гүйцэх.
НАСТЛА́ТЬ дэвсэх, хучих; ~ **досок** банз дэвсэх.
НА́СТОВЫЙ царын, цойн, царцанги цасны.
НАСТО́Й ханд, буйлуулмал, идээшмэл, хандалсан, идээшүүлсэн, буйлуулсан; ~ **крепкого чая** өтгөн цайны ханд.
НАСТО́ЙКА 1. ханд, идээшмэл, хандалсан, идээшүүлсэн; ~ **йода на спирту** спиртэд хандалсан иод; 2. буйлуулмал, буйлуулсан; **вишнёвая** ~ интоорын буйлуулмал архи, интоор буйлуулсан архи.
НАСТО́ЙЧИВО шургуу, цөхрөлтгүй.
НАСТО́ЙЧИВОСТЬ шургуу зан, цөхрөлтгүй оролдлого, няцашгүй зориг; **проявлять** ~ шургуу зангаа үзүүлэх, цөхрөлтгүй оролдох.
НАСТО́ЙЧИВ||ЫЙ шургуу, цөхрөлтгүй, цөхөрдөггүй; ~ **характер** шургуу зан; ~ **человек** цөхөрдөггүй хүн; ~**ое требование** шургуу шаардах.
НАСТО́ЛЬКО өчнөөн, өдийчинээ, төчнөөн, тэдийчинээ, -тлаа (*-тлээ,-тлоо,-тлөө*); **он не ~ умен, чтобы сразу понять все это** тэр,энэ бүгдийг дор нь ойлгохоор ухаантай хүн биш.
НАСТО́ЛЬН||ЫЙ 1. ширээний; ~**ая лампа** ширээний дэн; 2. өврийн, байнга хэрэглэдэг; ~**ая книга** өврийн ном.
НАСТОРА́ЖИВАТЬ ~ **уши** чихээ сэртийлгэх, чих тавих.
НАСТОРА́ЖИВАТЬСЯ,сонор болох, сонор сэрэмжтэй болох, чихээ сэртийлгэх.
НАСТОРОЖЕ́ сонор соргог, сонор сэрэмжтэй; **быть** ~ сонор соргог байх, сэрэмжлэх.
НАСТОРО́ЖЕННОСТЬ сонор сэргэг байх, сэрэмж.
НАСТОРО́ЖЁННЫЙ сонор сэргэг, сэрэмжтэй сэргэг; ~ **взгляд** сэрэмжтэй харц.
НАСТОРОЖИ́ТЬ ~ **уши** чихээ сэртийлгэх, чих тавих, чихээ соотойлгох.
НАСТОРОЖИ́||ТЬСЯ соргог болох сонор сэрэмжтэй болох, чихээ сэртийлгэх; **волк ~лся** чоно чихээ сэртийлгэв.
НАСТОЯ́НИ||Е шаргаах, шалах, шалж шаардах; **по его ~ю** түүний шаардаснаар
НАСТОЯ́ТЕЛЬ ширээт лам, даа лам.
НАСТОЯ́ТЕЛЬНИЦА ширээт гэлэнмаа, даа гэлэнмаа.
НАСТОЯ́ТЕЛЬНО гүнээ ихэд, шургуу.
НАСТОЯ́ТЕЛЬН||ЫЙ 1. гүн, ихэд чанга, шаргуу; ~**ая просьба** шаргуу хүсэлт, гүнээ хүсэх нь; 2. хойшлуулшгүй амин чухал; ~**ая нужда** амин чухал хэрэгцээ.
НАСТОЯ́ТЬ I зүтгэх, шахах, зүтгэж биелүүлэх шахаж болгох; ~ **на своём** өөрийнхөөрөө зүтгэх, шахаж өөрийнхөөрөө болгох.
НАСТОЯ́ТЬ II буйлуулах, хандлах, идээшлүүлэх; ~ **водку на вишне** интоор хийж архи буйлуулах.
НАСТОЯ́||ТЬСЯ I идээших, ханд болох; **чай хорошо ~лся** цай сайн идээшжээ.
НАСТОЯ́ТЬСЯ II удах, удаан зогсох; ~ **в ожидании кого-либо** хүн хүлээж удах.
НАСТОЯ́ЩЕЕ одоо үе, эдүүгээ цаг, өнөө үе.
НАСТОЯ́Щ||ИЙ 1. одоо, эдүүгээ, өнөө, эдүүгээ үеийн, одоо цагийн, өнөө үеийн; **в ~ее время** эдүүгээ, одоо цагт; 2. энэ, энэхүү, тус; **в ~ем году** энэ жил; **в ~ей статье речь идет о ...** тус өгүүлэлд тухай өгүүлнэ; 3. жинхэнэ, ёстой, үнэн, мөн; ~**ая фамилия** жинхэнэ овог, мөн овог; ~ **друг** үнэн нөхөр, ёстой анд; ~**ее время глагола** үйл үгийн одоо цаг; **по-~ему** үнэхээр, зохих ёсоор.
НАСТРАДА́ТЬСЯ ихэд зовох, зовж зүдрэх.
НАСТРА́ИВАТЬ I барих, босгох.
НАСТРА́ИВАТЬ II 1. хөглөх, хөг нийлүүлэх, хөг тааруулах; 2. тохируулах; захируулах; 3. засах,засварлах; 4. санаатай болгох,тухирах, хандуулах.
НАСТРА́ИВАТЬСЯ 1. завдах, зэхэх, завдаад байх; 2. уур хүрэх, хор буцлах.
НАСТРЕЛЯ́ТЬ буудах, буудаж алах; ~ **уток** нугас буудаж алах.
НА́СТРИГ хайчилсан ноос, ноосны хэмжээ.
НАСТРИ́ЧЬ хайчлах, хяргах; ~ **килограмм шерсти кило** ноос хяргах.
НАСТРОГА́ТЬ I харуулдах, зорох; ~ **досок** банз харуулдах.
НАСТРОГА́ТЬ II *разг.* олон хүүхэд хийх.
НА́СТРОГО чангад, чанд, чандлан; ~ **запретить** чангад хорих; **строго** ~ чанд гэгчийн, чангаас чанга, хатуугийн хатуу.
НАСТРОЕ́НИ||Е 1. сэтгэл, санаа, ааш зан; **быть в дурном ~и** муухай ааштай байх, муу зан хөдлөх; **хорошее** ~ сайхан ааш, сайхан зан, урамтай байх; 2. дур хүсэл, урам; **нет ~я играть** тоглох хүсэл алга.
НАСТРО́ЕННОСТЬ сэтгэл, санаа, ааш зан, урам.
НАСТРО́ИТЬ 1. хөглөх, хөг нийлүүлэх, хөг тааруулах; ~ **пианино** төгөлдөр хуур хөглөх; 2. тохируулах, зохируулах; ~ **приёмник на короткую волну** хүлээн авагчийг богино долгионд тохируулах; 3. засах, засварлах; 4. санаатай болгох, тухирах, хандуулах; ~ **против кого-либо** хүний эсрэг хандуулах.
НАСТРО́И||ТЬСЯ 1. завдах, зэхэх, завдаад байх, зэхээд байх; **я ~лся пойти в кино** би кинонд явахаар зэхээд байв; 2. уур хүрэх, хор буцлах.
НАСТРО́ЙКА хөглөх, хөг нийлүүлэх, хөг тааруулах; ~ **музыкальных инструментов** хөгжим хөглөх.
НАСТРО́ЙЩИК хөглөгч; ~ **роялей** рояль хөглөгч; төгөлдөр хуур хөглөгч.
НАСТРОЧИ́ТЬ 1. шаглах, шаглан оёх; ~ **складок** хуниас шаглах; 2. татлах, татлан бичих, татлаад орхих; ~ **письмо** бичиг татлаад орхих.
НАСТРУГА́ТЬ харуулдах, зорох.
НАСТРЯ́ПАТЬ хийх, тогоо барих; ~ **пельменей** банш хийх.
НАСТУДИ́ТЬ хөргөх, хүйт оруулах.
НАСТУПА́ТЕЛЬНЫЙ давших, давшилтын; ~ **бой** дэвших тулалдаан.
НАСТУПА́||ТЬ I 1. гишгэх; 2. давших; **войска ~ют** цэрэг давшиж байна; 3. хавчих, шахах, халдах.
НАСТУПА́ТЬ II болох, ирэх.
НАСТУПИ́ТЬ I ~ **кому-либо на ногу** хүний хөл гишгэх.
НАСТУПИ́||ТЬ II болох, ирэх; ~**ло утро** өглөө болов.
НАСТУПЛЕ́НИЕ I давшилт; **перейти в** ~давшин орох.
НАСТУПЛЕ́НИ||Е II болох; **при ~и ночи** шөнө болоход.
НАСТУ́РЦИЯ алтан лицэх цэцэг.
НАСУЛИ́ТЬ амлах, их сануулах, их горьдуулах; ~ **с три короба** уулын чинээ амлах, их санасан газар хоосон байх.
НАСУ́ПИТЬ ~ **брови** хөмсөг зангидах, хөмсөг атируулах.
НАСУ́ПИТЬСЯ хөмсөг зангидах, хөмсөг атируулах, царайгаа барайлгах.

НАСУ́ПЛИВАТЬ ~ брови хөмсөг зангидах, хөмсөх атируулах.
НАСУ́ПЛИВАТЬСЯ хөмсгөө зангидах, хөмсгөө атируулах, царайгаа барайлгах.
НА́СУХО хаттал, хуурай болтол; **вытереть руки ~** гараа хаттал арчих; **сухо~** хув хуурай болтол.
НАСУЧИ́ТЬ нийтгэх, томох, эрчлэх, имрэх; **~ниток** утас нийтгэх.
НАСУ́ШИВАТЬ,
НАСУШИ́ТЬ хатаах; **~ грибов** мөөг хатаах.
НАСУ́ЩНОСТЬ амин чухал чанар, амин гол болох.
НАСУ́ЩН||ЫЙ амин чухал, амин гол; **~ая потребность** амин чухал хэрэгцээ; **~ые задачи** амин чухал зорилт; **хлеб ~** амин тэжээл.
НАСЧЁТ тухай; **говорить ~** работы ажлын тухай ярих.
НАСЧИТА́ТЬ тоолох, тоогий нь авах, тоолон мэдэх.
НАСЧИ́ТЫВА||ТЬ 1. тоолох, тоогий нь авах, тоолон мэдэх; 2. -тай (*-тэй, -той*); **этот город ~ет свыше миллиона жителей** энэ хот сая гаруй хүн амтай.
НАСЧИ́ТЫВА||ТЬСЯ бий, хүрэх; **в области ~ются сотни школ** тус мужийн сургууль хэдэн зуу хүрнэ.
НАСЫ́ПАТЬ 1. хийх, юүлэх; **~ ячмень в мешок** арвай шуудайд хийх; 2. дүүргэх; **~ мешок крупой** шуудайнд будаа дүүргэх; 3. асгах; **~ песка на дорожку** зам дээр элс асгах; 4. овоолох, босгох; **~ курган** овоо босгох.
НАСЫ́ПАТЬСЯ гоожих, асгарах.
НАСЫПНО́Й овоолсон, шороо овоолж хийсэн; **~ холм** шороо овоолж хийсэн дов.
НА́СЫПЬ 1. овоолсон шороо, овоо, далан, овоолго; **железнодорожная ~** төмөр замын далан; 2. сул асгасан, сул овоолсон; **песок перевозят ~ью** элс сул асгаж зөөдөг.
НАСЫ́ТИТЬ 1. цатгах,ханаах,цадтал идүүлэх; 2. шингэх, дүүрэх, анхилах; **воздух насыщен парами** агаарт уур дүүрэн байна.
НАСЫ́ТИ||ТЬСЯ 1. цадах, ханах, идэж ханах; 2. шингээх, уусгах, дүүрэх; **вода ~лась солью** ус давс уусгав.
НАСЫХА́ТЬ барилдан хатах, наалдан хатах.
НАСЫЩА́ТЬ 1. цатгах, ханаах, ханатал идүүлэх; 2. шингэх, дүүрэх, анхилах.
НАСЫЩА́ТЬСЯ 1. цадах, ханах, идэж цадах; 2. шингээх, уусгах, дүүрэх.
НАСЫЩЕ́НИ||Е 1. цадах, ханах, цатгах, хангах; **наесться до полного ~я** цадталаа идэх; 2. шингээх, уусгах.
НАСЫ́ЩЕННОСТЬ 1. ханах, ханалт, ханац; **~ раствора** ханасан уусгамал; 2. төгс байх, төгөлдөр байх; **идейная ~ романа** романы утга төгөлдөр байх, утга төгс роман.
НАСЫ́ЩЕНН||ЫЙ 1. ханасан; **~ раствор** ханасан уусгамал; 2. төгс, утга төгөлдөр; **идейно ~ая музыка** утга төгс хөгжим.
НАТА́ЛКИВАТЬ 1. түлхэх, чихэх; 2. төрүүлэх, оруулах, олуулах.
НАТА́ЛКИВАТЬСЯ 1. мөргөх, дайрах, мөргөлдөх, дайралдах; 2. тохиолдох, гэнэт олох.
НАТА́ПЛИВАТЬ I түлэх, галлах, халаах, дулаацуулах.
НАТА́ПЛИВАТЬ II 1. хайлуулах, шахах; 2. хөөрүүлэх.
НАТА́ПТЫВАТЬ гишгэлэх, мөр үлдээх.
НАТАСКА́ТЬ,
НАТА́СКИВАТЬ 1. авчрах, оруулах, зөөх; **~ дров** түлээ зөөх; 2. хуулах, хуулан авах; 3. анд сургах, сургуулилуулах; **~ собаку** нохой анд сургах; 4. бэлдүүлэгчээ болох, бэлдүүлэгч аялах; **~ учеников к экзамену** сурагчдыг шалгалтанд бэлдүүлэгчин аялах.
НАТА́ЧИВАТЬ билүүдэх, гуранздах, ирлэх, хурцлах.
НАТАЩИ́ТЬ 1. татаж хучих; **~ на себя одеяло** хөнжил татаж хучих; 2. авчрах, чирч авчрах, зөөж авчрах, авчрах, зөөх, оруулах; **~ хворосту** гишүү авчрах, гишүү чирч авчрах.
НАТА́Я||ТЬ 1. хайлах; **~ло много снегу в погребе** зөөрөнд зөндөө цас хайлжээ; 2. хайлуулах; **~ льду** мөс хайлуулах.
НАТВОРИ́||ТЬ *өдөөх, тарих, хийх*; **что ты ~л?** *чи ямар хэрэг өдөөв?*
НА́ТЕ май, май, та ав; **~ книгу** ном май; **~ вам ваш билет** май, та билетээ ав.
НАТЕ́ЛЬН||ЫЙ дотуур; **~ая рубаха** дотуур цамц.
НАТЕРЕБИ́ТЬ сэмлэх, үлтлэх; **~ льну** маалинга үлтлэх.
НАТЕРЕ́ТЬ 1. түрхэх; **~ руки вазелином** гартаа вазелин түрхэх; 2. арчих, толийтол арчих, арчиж өнгөлөх; **~ пол** шал арчих; 3. холгох, үрэх; **~ себе ноги** хөлөө холгох; 4. үрэх, үрүүлдэх; **~ редьки** цагаан лууван үрэх.
НАТЕРПЕ́ТЬСЯ ихэд зовох, ихэд зүдрэх, зовлон эдлэх.
НАТЕСА́ТЬ,
НАТЁСЫВАТЬ хангинуурдах, хангинуурдан засах.
НАТЕ́ЧЬ нэлийтэл гоожих, нэвтэрч нэлийх, дусаж урсах.
НАТЕ́ШИТЬСЯ бах ханах, ханатал цэнгэх; **~ игрой** тоглож бах ханах.
НАТИРА́НИЕ түрхэх, арчих, холгох, үрэх.
НАТИРА́ТЬ 1. түрхэх, арчих, толийтол арчих, арчиж өнгөлөх; 2. холгох, үрэх; 3. үрэх, үрүүлдэх.
НАТИ́РКА толийтол арчих, арчиж өнгөлөх.
НА́ТИСК шахах, түрэх, шахалт, түрэлт; **~ превосходящих сил противника** давуу хүчтэй дайсныг түрэх.
НАТКА́ТЬ нэхэх; **~ полотна** бөс нэхэх.
НАТКНУ́ТЬСЯ 1. адах, урах; **~ на гвоздь** хадаасанд адах; 2. мөргөх, дайрах, торох, мөргөлдөх, дайралдах; **~ на телеграфный столб** утасны мод мөргөх; **~ на засаду** бүгүүлтэй дайралдах; 3. тохиолдох, гэнэт олох; **~ на интересную мысль в книге** номд сонирхолтой санал тохиолдох.
НАТОЛКНУ́ТЬ 1. түлхэх, чихэх; **~ кого-либо** на стол хүнийг ширээ рүү түлхэх; 2. төрүүлэх, оруулах, олуулах; **~ на правильное решение** зөв шийдвэр олуулах.
НАТОЛКНУ́ТЬСЯ 1. мөргөх, дайрах; 2. мөргөлдөх, дайралдах.
НАТОЛО́ЧЬ нүдэх, талхлах, нунтаглах, нухах; **~ соли** давс нунтаглах.
НАТОПИ́ТЬ I түлэх, галлах, халаах, дулаацуулах; **~ квартиру** гэртээ галлах, байраа дулаацуулах.
НАТОПИ́ТЬ II 1. хайлуулах, шахах; **~ воск** лав хайлуулах; 2. хөөрүүлэх; **~ молоко** сүү хөөрүүлэх.
НАТОПТА́ТЬ гишгэлэх, мөр гаргах, гишгэлж муухай болгох, мөр үлдээх; **~ на полу** шал гишгэлэх.
НАТОЧИ́ТЬ билүүдэх, гуранздах, ирлэх, хурцлах; **~ нож** хутга хурцлах.
НАТОЩА́К өлөн элгэн дээр, өлөн бие дээр, өлөн; **принимать лекарство ~** өлөн элгэн дээр эм уух.
НАТР натр,натрийн эсэл.
НАТРАВИ́ТЬ I тухирах, туу гэх, тухиран тавих; **~ собак на зверя** нохой анд тухирах.
НАТРАВИ́ТЬ II хороор идүүлж хээ гаргах; **~ узоров** хороор идүүлж угалз гаргах.
НАТРА́ВЛИВАТЬ I,
НАТРАВЛЯ́ТЬ I тухирах, туу! гэх, тухиран тавих.
НАТРА́ВЛИВАТЬ II,
НАТРАВЛЯ́ТЬ II хороор идүүлж хээ гаргах.
НАТРЕНИРО́ВАННЫЙ дадсан, дадлагатай; **~ спортсмен** *дадлагатай биеийн тамирчин.*
НАТРЕНИРОВА́ТЬ дасгал хийлгэх.
НАТРЕНИРОВА́ТЬСЯ дасгал хийх.
НА́ТРИЕВЫЙ натрийн,натритай.
НА́ТРИЙ натри (*химийн махбод*); **хлористый ~** хлорт натри.

НА́ТРОЕ гурван хэсэг, гурав; **разрезать ~** гурван хэсэг огтлох.
НАТРУДИ́ТЬСЯ ихэд хөдөлмөрлөх, ханатал хөдөлмөрлөх; **~ за день** өдөртөө ханатал хөдөлмөрлөх.
НАТРЯСТИ́ сэгсрэх, сэгсэрч унагах; **~ опилок на пол** шал дээр модны үртэс сэгсрэх.
НАТРЯСТИ́СЬ сэгсрэгдэх, донсолгоонд сэгсрэгдэх; **~ в грузовике** ачааны машинын донсолгоонд сэгсрэгдэх.
НАТУ́Г||А хүчдэх, хүчлэх; **от ~и** ихэд хүчилсэндээ.
НА́ТУГО их чанга, чанга татаж; **затянуть ~ ремень** бүсээ чанга татаж бүслэх.
НАТУ́ЖИВАТЬ чангаруулах, чангатгах, хүчдэх, хүчлэх, дүлүүлэх.
НАТУ́ЖИВАТЬСЯ,
НАТУ́ЖИТЬСЯ хүчдэх, дүлэх.
НАТУ́ЖИТЬ чангаруулах, чангатгах, хүчдэх, хүчлэх, дүлүүлэх.
НАТУ́Р||А 1. зан, аашзан, зан авир, зантай хүн; **пылкая ~** түргэн зантай хүн; 2. эд агуурс, бүтээгдэхүүн, бие (*тэй*)юм, эдлэхүүн; **платить ~ой** бүтээгдэхүүнээр төлөх, бие (*тэй*)юмаар төлөх,эдлэхүүнээр төлөх; **рисовать с ~ы** бодит байдлаас нь зурах.
НАТУРА́Л *разг.* эр эмийн ажилд үнэнч эх хүн.
НАТУРАЛИЗА́ЦИЯ өөрийн харьяат болгох.
НАТУРАЛИ́ЗМ натурализм (*нийгмийн хөгжлийн хуулийг байгалийн хуультай адил гэж үздэг, бодит байдлын гадаад талыг яг хуулан дүрслэгд, утга чанарын нь хайхардаггүй, урлаг утга зохиолын чиглэл*).
НАТУРАЛИЗОВА́ТЬ өөрийн харьяат болгох.
НАТУРАЛИЗОВА́ТЬСЯ харьяат болох.
НАТУРАЛИ́СТ 1. байгальч; **юный ~** залуу байгальч; 2. натуралист, натурализмыг баримтлагч.
НАТУРАЛИСТИ́ЧЕСКИ натуралист ёсоор, натуралист маягаар,натуралист янзаар; **описать что-либо ~** юмыг натуралист ёсоор бичих.
НАТУРАЛИСТИ́ЧЕСКИЙ натуралист.
НАТУРА́ЛЬН||ЫЙ 1. эдлэхүүний; **~ое хозяйство** эдлэхүүний аж ахуй; 2. бодит; **~ая величина** бодит хэмжээ; 3. жинхэнэ, ёстой, үнэн; **~ шёлк** жинхэнэ торго.
НАТУ́РНЫЙ байгалиас буулган зурдаг, байгалиас буулгах.
НАТУРОПЛА́ТА бие төлбөр, бүтээгдэхүүн төлбөр,эд агуурсын төлбөр, эдлэхүүн төлбөр.
НАТУ́РЩИК биеэ зуруулагч.
НАТУ́РЩИЦА биеэ зуруулагч эмэгтэй.
НАТЫ́КАТЬ хатгах, шаах, хатгаж, хатгачхах; **~ булавок** тавтай зүү хатгах.
НАТЫКА́ТЬСЯ 1. урах; 2. мөргөх, дайрах, торох, мөргөлдөх, дайралдах; 3. тохиолдох, гэнэт очих.
НАТЯ́ГИВАТЬ 1. татах, чангаах, тэлэх, татаж чангалах; 2. арай чамай углах, арай хийж багтаах, татаж нөмрөх, татаж хучих.
НАТЯ́ГИВАТЬСЯ татагдах, чангарах.
НАТЯЖЕ́НИЕ татах, чангаах, тэлэх, сунах.
НАТЯ́ЖК||А 1. татах, чангаах, тэлэх, сунаах, татаж чангалах; **~ струн** чавдас татаж чангалах; 2. яахав гэх, яамай гэх, тэгс ингэс хийх; **допустить с большой ~ой** яамай даа л гэж зөвшөөрөх.
НАТЯ́НУТОСТЬ хөндийрөх, хүйтрэх; **~ в отношениях** харилцаа хүйтрэх, хүйтэн харилцаа.
НАТЯ́НУТЫЙ хүйтэн, хүйтэрсэн, хөндий, хөндийрсөн; **~ вид** хүйтэрсэн байдал, хүйтэн царай; **~ смех** хүйтэн инээд, худал инээд.
НАТЯНУ́ТЬ 1. татах, чангаах, тэлэх, сунаах, татаж чангалах; **~ струны** чавдас татаж чангалах; 2. арай чамай углах; **~ на себя одеяло** хөнжлөө татаж нөмрөх.
НАТЯНУ́ТЬСЯ татагдах, чангарах.
НАУГА́Д таамгаар, таагаад, таамаглан; **идти ~** таамгаар явах; **сказать ~** таамаглан хэлэх.
НАУДАЛУ́Ю зориг мэдэн, зөнгөө мэдэг гээд; **ринуться ~** зориг мэдэн давхин орох.
НАУДА́ЧУ нүдэн балай, чихэн дүлий, аз мэдэн, заяа мэдэг гэж; **идти ~** нүдэн балай, чихэн дүлий явах.
НАУДИ́ТЬ гөхийдөх, хахуулдах.
НАУ́К||А 1. шинжлэх ухаан, эрдэм, ухаан; **Академия Наук** Шинжлэх Ухааны Академи; **общественные ~и** нийгмийн ухаан; 2. сургамж; **вперёд тебе ~а** хойшид чамд сургамж болог.
НАУ́СЬКАТЬ тухирах, туу! гэх; **~ собак** нохой тухирах.
НАУ́СЬКИВАТЬ тухирах, туу! гэх.
НАУТЁК хар хурдаар; **пуститься ~** хар хурдаар зугтах.
НАУ́ТРО маргааш өглөө нь, өглөө нь.
НАУЧИ́ТЬ сургах, заах, багшлах; **~ ездить верхом** морь унаж сургах.
НАУЧИ́ТЬСЯ сурах, дасах; **~ русскому языку** орос хэл сурах.
НАУ́ЧНО шинжлэх ухааны ёсоор.
НАУ́ЧНО-ИССЛЕ́ДОВАТЕЛЬСК||ИЙ эрдэм шинжилгээний; **~кая работа** эрдэм шинжилгээний ажил; **~ институт** эрдэм шинжилгээний хүрээлэн.
НАУ́ЧНОСТЬ шинжлэх ухааны чанар; **~ преподования** шинжлэх ухааны чанартай заах, шинжлэх ухааны ёсоор багшлах.
НАУ́ЧНО-ТЕХНИ́ЧЕСК||ИЙ шинжлэх ухаан техникийн; **~ая конференция** шинжлэх ухаан техникийн бага хурал.
НАУ́ЧН||ЫЙ 1. эрдэм шинжилгээний, шинжлэх ухааны; **~ работник** эрдэм шинжилгээний ажилтан; **~ое учреждение** шинжлэх ухааны, байгууллага; 2. шинжлэх ухааны; **~ая теория** шинжлэх ухааны онол; **~социализм** шинжлэх ухааны социализм.
НАУ́ШНИК I 1. чихэвч, чих; **шапка с ~ами** чихтэй малгай; 2. чихэвч; **надеть ~и** чихэвч углах.
НАУ́ШНИК II ховч.
НАУ́ШНИЧАТЬ ховлох, ховхэлэх, ховзөөх.
НАУ́ШНИЧЕСТВ||О ховлох, ховхэлэх, ховжив; **уличить кого-либо в ~е** ховчийг нь илрүүлэх, ховзөөдгий нь барих.
НАУЩА́ТЬ хатгах, өдөөх, тухирах.
НАУЩЕ́НИЕ хатгах, өдөх тухирах.
НАФТАЛИ́Н нафталин.
НАХА́Л увайгүй хүн, ичгүүргүй хүн.
НАХА́ЛКА увайгүй эмэгтэй, ичгүүргүй эхнэр.
НАХА́ЛЬНИЧАТЬ увайгүй, ичгүүргүй аашлах.
НАХА́ЛЬНО увайгүй, ичгүүргүй.
НАХА́ЛЬНЫЙ увайгүй, ичгүүргүй, ичгүүр сонжуургүй; **~ человек** увайгүй хүн.
НАХА́ЛЬСТВО увайгүй зан, ичгүүргүй ааш, ичгүүр сонжуургүй явдал.
НАХВА́ЛИВАТЬ,
НАХВАЛИ́ТЬ хэт магтах.
НАХВАЛИ́ТЬСЯ 1. биеэ ихэд магтах, хэт сайрхах; 2. магтаж ханах.
НАХВАТА́ТЬ шүүрэн авах, хамах.
НАХВАТА́ТЬСЯ зах сэжүүрээс нь мэдэж авах, сонсчих.
НАХИ́МОВЕЦ нахимовч (*Нахимовын нэрэмжит усан цэргийн сургуулийн сурагч*).
НАХИ́МОВСКИЙ Нахимовын, **Нахимовское военно-морское училище** Нахимовын (*нэрэмжит*)усан цэргийн сургууль.
НАХЛЕ́БНИК 1. айлд мөнгөөр хооллуулагч; 2. тэжээвэр хүн.
НАХЛЕСТА́ТЬ гуядах,ташуурдах.

НАХЛОБУ́ЧИВАТЬ,
НАХЛОБУ́ЧИТЬ дорогш дарж өмсөх, дарж өмсөх; ~ **шапку на глаза** малгайгаа нүд рүүгээ дарж өмсөх.
НАХЛОБУ́ЧКА хатуу зэмлэл, донго; **получить** ~ хатуу зэмлүүлэх, донгодуулах.
НАХЛЫ́НУ||ТЬ 1. цутган ирэх, нөмрөн ирэх, эргэлдэн ирэх; **волны ~ли на берег** долгио эрэг тийш эргэлдэн ирэв; 2. гэнэт санаанд орох, гэнэт бодогдох; **~ли воспоминания** өнгөрсөн явдал гэнэт бодогдов.
НАХМУ́РИВАТЬ,
НАХМУ́РИТЬ атируулах, зангидах, царай барайлгах; ~ **брови** хөмсөг зангидах.
НАХМУ́РИВАТЬСЯ,
НАХМУ́РИТЬСЯ хөмсөг зангидах, царай барайх, царайгаа барайлгах.
НАХОДИ́ТЬ I 1. олох; 2. (*зүгаа*) болгох, (*сэтгэл*) ханах, тайвшруулах; 3. үзэх, санах, тоолох, тооцох.
НАХОДИ́ТЬ II 1. дайрах, дайралдах, мөргөх, тулах, уулзах; 2. халхлах, таглах, хаах; 3. хүрэх; 4. цугларах, бөөгнөрөх, дүүрэх.
НАХОДИ́ТЬСЯ I 1. олдох, байх; 2. олох, санах; 3. орших, байх; **дача находилась недалеко от станции** зуслан өртөөнөөс холгүй оршиж байв.
НАХОДИ́ТЬСЯ II явж ханах, явж эцэх; ~ **по городу** хотоор явж эцэх.
НАХО́ДК||А 1. олз, олбор, олдвор; **археологические ~и** эртний судлалын олдвор; 2. олдошгүй хүн, олзуурхмаар хүн.
НАХО́ДЧИВОСТЬ аргатай байх, овлог байх, сэхээ.
НАХО́ДЧИВЫЙ аргатай, овтой, сэхээтэй; ~ **человек** сэхээтэй хүн; ~ **ответ** овтой хариу.
НАХОЖДЕ́НИ||Е 1. олох; ~ **общего делителя** ерөнхийлөн хуваагчийг олох; 2. орших, байх, суух; **установить место ~я** байсан газры нь нотлох.
НАХО́ХЛИТЬ сэрвийлгэх, өрвийлгөх, үрзийлгэх.
НАХО́ХЛИТЬСЯ 1. (*өдөө*) сэрвийлгэх, өрвийх, үрзийх; 2. гонсойх, үрчийх.
НАХРА́ПОМ цочмог, далайлган, загнаж; **действовать** ~ загнаж гарах, далайлгах.
НАЦАРА́ПАТЬ маажих, савардах, зураас гаргах.
НАЦЕДИ́ТЬ шүүх, шүүж хийх, шүүж гоожуулах
НАЦЕ́ЖИВАТЬ шүүх, шүүж хийх, шүүж гоожуулах; ~ **квас** квас шүүх,квас шүүж хийх.
НАЦЕ́ЛИВАТЬ 1. шагаах, чиглүүлэх; 2. чиглүүлэх, хандуулах, зориулах.
НАЦЕ́ЛИТЬСЯ шагаах, чиглүүлэх.
НА́ЦЕЛО цөмөөрөө, бүхэлдээ, бултаараа, үлдэгдэлгүй; **это число делится** ~ энэ тоо үлдэгдэлгүй хуваагдана.
НАЦЕ́НИВАТЬ,
НАЦЕНИ́ТЬ үнэ нэмэгдүүлэх, үнэ нэмэх.
НАЦЕ́НК||А 1. үнэ нэмэгдүүлэх, үнэ нэмэх; **произвести ~у** үнэ нэмэгдүүлэх; 2. нэмэгдэл үнэ; **снижение наценок на товары** барааны нэмэгдэл үнийг бууруулах.
НАЦЕПИ́ТЬ, 1. өлгөх, чагтлах; ~ **вёдра на коромысло** хувин дамнуурганд өлгөх; 2. зүүх; ~ **значок** тэмдэг зүүх.
НАЦЕПЛЯ́ТЬ 1. өлгөх, чагтлах; 2. зүүх.
НАЦИ́ЗМ нацизм.
НАЦИОНАЛИЗА́ЦИЯ улсад хураах, улсын мэдэлд авах; ~ **промышленности** үйлдвэрийг улсад хураах.
НАЦИОНАЛИЗИ́РОВАТЬ улсад хураах, улсын мэдэлд авах; ~ **землю** газрыг улсын мэдэлд авах.
НАЦИОНАЛИЗИ́РОВАТЬСЯ улсад хураагдах, улсад хураалгах, улсын мэдэлд орох.
НАЦИОНАЛИ́ЗМ үндсэрхэх үзэл; **буржуазный** ~ хөрөнгөтний үндсэрхэх үзэл.
НАЦИОНАЛИЗОВА́ТЬ *улсад хураах, улсын мэдэлд авах.*
НАЦИОНАЛИЗО́ВАТЬСЯ улсад хүрааагдах, улсад хурааалгах, улсын мэдэлд орох.
НАЦИОНАЛИ́СТ үндсэрхэх үзэлтэн.
НАЦИОНАЛИСТИ́ЧЕСК||ИЙ үндсэрхэх үзлийн, үндсэрхэх үзэлт, үндсэрхэх үзэлтний, үндсэрхэх; **буржуазная ~ая политика** хөрөнгөтний үндсэрхэх бодлого.
НАЦИОНА́Л-СОЦИАЛИ́СТ национал социалист (*Гитлерийн фашист намын гишүүн*).
НАЦИОНА́ЛЬНО-ОСВОБОДИ́ТЕЛЬН||ЫЙ үндэсний эрх чөлөөний; **~ое движение народов колониальных и зависимых стран колонии** хараат орны ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн.
НАЦИОНА́ЛЬНОСТ||Ь 1. ястан, угсаатан, үндэстэн; 2. угсаатай (*байх*), ясны хүн (*байх*); **монгол по ~и** монгол угсаатай, монгол ясны хүн.
НАЦИОНА́ЛЬН||ЫЙ 1. үндэсний; **~ое движение** үндэсний хөдөлгөөн; ~ **вопрос** үндэсний асуудал; **культура ~ая по форме, социалистическая по содержанию** үндэсний хэлбэртэй социалист агуулгатай соёл; ~ **язык** үндэсний хэл; ~ **костюм** үндэсний хувцас; 2. улсын, төрийн; ~ **флаг** төрийн далбаа; 3. бага үндэстний; ~ **район** бага үндэстний район; **~ое меньшинство** бага үндэстэн.
НАЦИ́СТ нацист (*герман фашист*).
НАЦИ́СТСКИЙ *нацист.*
НА́ЦИ||Я үндэстэн; **социалистические ~и** социалист үндэстэн; **буржуазные ~и** хөрөнгөтөн үндэстэн; **Организация Объединённых Наций** Нэгдсэн Үндэстний Байгууллага.
НАЧ *разг.* бэлэн мөнгө.
НАЧАДИ́ТЬ үнэртүүлэх, хиншүү оргиулах, утаа баагиулах.
НАЧА́Л||О 1. эх, анх, түрүү, түрүүч, эхлэлт; ~ **учебного года** хичээлийн жилийн эх; **от ~а до конца** эхнээс эцэс хүртэл; **положить ~ чему-либо, дать ~ чему-либо** юм эхлэх; ~ **грозы** аадрын түрүү; **с самого ~а** анхнаасаа, эхнээсээ; ~ **спектакля** жүжгийн эхлэлт; 2. эх; ~ **улицы** гудамжны эх; 3. үүсэл, эх булаг, уг сурвалж; **некультурность — ~ многих недостатков** боловсронгуй бус байх нь олон дутагдлын эх булаг мөн; 4. **начала** үндэс, үндсэн зүйл; ~ **химии** хувилахуй ухааны үндэс; 5. **начала** ёс, журам, үндэс, арга; **на коллективных ~ах** хамтын журмаар, хамтран; **на добровольных ~ах** сайн дурын үндсэн дээр, сайн дурыг үндэслэн; **организовать дело на новых ~ах** ажлыг шинэ журмаар зохион байгуулах.
НАЧА́ЛЬНИК дарга.
НАЧА́ЛЬНИЦА дарга эмэгтэй.
НАЧА́ЛЬНИЧЕСК||ИЙ 1. даргын; **~ие обязанности** даргын үүрэг; 2. дарга маягийн, дарга янзтай, даргалхаг, даргалхуу; ~ **тон** даргалхаг дугарах.
НАЧА́ЛЬН||ЫЙ 1. эхэн, анхан, түрүү, эхний, анхны, түрүүний; ~ **период** анхны үе; **~ая глава** книги номын эхний бүлэг; 2. бага, анхны, анхан шатны; **~ая школа** бага сургууль; **~ое образование** анхны боловсрол.
НАЧА́ЛЬСТВЕННЫЙ дарга янзын, дарга маягтай, даргалхаг, даргалхуу.
НАЧА́ЛЬСТВ||О 1. дарга нар; **по распоряжению ~а** дарга нарын тушаалаар, захирамжаар; 2. даргын тушаал, захиргаа; **служить под чьим-либо ~ом** хүний захиргаанд алба хаах.
НАЧА́ЛЬСТВОВАТЬ ахлах, даргалах, захирах.
НАЧА́ЛЬСТВУЮЩИЙ даргалагч, захирагч; ~ **состав** армии цэргийн захирагч бүрэлдэхүүн.

НАЧА́ТКИ анхны мэдэгдэхүүн; ~ **знаний** эрдмийн анхны мэдэгдэхүүн.

НАЧА́ТЬ 1. эхлэх; ~ **постройку** барилга барьж эхлэх, барилга эхлэх; ~ **сенокос** хадлан эхлэх, өвс хадаж эхлэх; 2. хэрэглэж эхлэх, задлах; ~ **новую бочку** пива өөр торхтой пивээс ууж эхлэх.

НАЧА́||ТЬСЯ эхлэх, үүсэх, гарах; ~**лся новый год** шинэ он гарав.

НАЧЕКА́НИТЬ цутгах, цутган хийх, хээ цохих; ~ **серебряные монеты** мөнгөн зоос цутгах.

НАЧЕКУ́ бэлхэн, сонор, соргог, сэргэг; **быть** ~ бэлхэн байх, сэргэг байх.

НАЧЁРКА́ТЬ зурах, зурж зурчхах.

НАЧЕРНО́ ноороглож, бүдүүн төлвийг нь; **написать письмо** ~ бичиг нооролгох.

НАЧЕ́РПАТЬ утгах, утгаж авах; ~ **воды** ус утгаж авах.

НАЧЕРТА́НИЕ зураг, дүрс, зурлага, бичлэг; ~ **букв** үсгийн дүрс.

НАЧЕРТА́ТЬ 1. бичих, зурах, дүрслэх; 2. зөгнөн хэлэх, заах, заан өгүүлэх;.

НАЧЕРТИ́ТЬ 1. зураас татах, зурах; ~ **карту Азии** Азийн газрын зураг зурах; 2. зурах, зурж зурчхах; ~ **много карт** газрын зураг олныг зурах.

НАЧЕ́РЧИВАТЬ зурах, зурж зурчхах.

НАЧЁС 1. самнаж бэлтгэх, самнан авах; 2. даавууны үс, цэцмэн; **густой** ~ өтгөн цэлмэн; 3. гөхөл, цагариглуулсан үс.

НАЧЕСА́ТЬ 1. самнаж бэлтгэх, самнаж авах; ~ **льну** маалинга самнаж бэлтгэх; 2. маажих, маажчих; ~ **руку до крови** гараа цус гартал маажих.

НАЧЁСТЬ дутагдал төлүүлэх, дутагдалд тоолох.

НАЧЁТ батлагдаагүй зарлага, дутагдал; **сделать** ~ **на кого-либо** хүнээр дутагдал төлүүлэх.

НАЧЁТНИЧЕСТВО хоосон цээжлэх.

НАЧЁТЧИК хоосон цээжлэгч.

НАЧИНА́НИЕ эхлэлт, санаачлага.

НАЧИНА́ТЕЛЬ эхлэгч, санаачлагч.

НАЧИНА́ТЬ 1. эхлэх; 2. хэрэглэж эхлэх, задлах.

НАЧИНА́ТЬСЯ эхлэх, үүсэх, гарах.

НАЧИНА́ЮЩ||ИЙ эхлэгч; ~ **писатель** эхлэн бичигч; ~ **художник** эхлэн зурагч; **книга для ~их** эхлэн сурагчдын ном.

НАЧИ́НИВАТЬ I дотор хийх, дүүргэх, чихэх.

НАЧИ́НИВАТЬ II нөхөж хадах, оёж хадах, нөхөж оёх, нөхөх, нөхөөслөх.

НАЧИНИ́ТЬ I дотор хийх, дүүргэх, чихэх; ~ **пирог капустой** бялууны дотор байцаа хийх.

НАЧИНИ́ТЬ II нөхөж хадах, оёж хадах, нөхөж оёх, нөхөх, нөхөөслөх; ~ **много белья** олон дотуур хувцас нөхөж хадах.

НАЧИНИ́ТЬ III үзүүрлэх; ~ **карандашей** харандаа үзүүрлэх.

НАЧИ́НК||А 1. дотор хийх, дүүргэх, чихэх; 2. идээ, доторхи юм; **пирог с мясной ~ой** дотроо махтай бялуу; 3. *разг.* чөмөг.

НАЧИНЯ́ТЬ дотор хийх, дүүргэх,чихэх.

НАЧИНЯ́ТЬСЯ дүүрэх, чихэгдэх, чихүүлэх.

НАЧИСЛЕ́НИЕ 1. нэмэх, нэмэгдүүлэх, оногдуулах; 2. нэмэлт, оногдол.

НАЧИ́СЛИТЬ нэмэх, нэмэгдүүлэх, оногдуулах.

НАЧИСЛЯ́ТЬ нэмэх, нэмэгдүүлэх, оногдуулах; ~ **проценты на капитал** хөрөнгөнд хүү оногдуулах.

НАЧИ́СТИТЬ 1. арилгах, хальслах; ~ **овощей** ногоо арилгах; ~ **картофеля** төмс хальслах; 2. арчих, өнгөлөх, цэвэрлэх, арилгах; ~ **сапоги** гутал арчих, гутал арилгах; 3. *разг.* ~ **морду, лицо** зодох.

НА́ЧИСТО сийрүүлэх; **переписать** ~ сийрүүлэн бичих.

НАЧИСТОТУ́ ний нуугүй, нуух хаахгүй; **объясниться** ~ нуух хаахгүй хэлэх.

НАЧИ́ТАННОСТЬ уншиж олсон мэдлэг, ном их уншсан (*байх*); **обладать большой ~ю** ном их уншсан, ном их үзсэн.

НАЧИ́ТАННЫЙ ном их уншсан, их ном үзсэн, эрдэмтэй; ~ **человек** ном их үзсэн хүн.

НАЧИТА́ТЬСЯ их унших, уншиж ханах; ~ **романов** роман их унших.

НАЧИ́ТЫВАТЬ дутагдал төлүүлэх, дутагдалд тоолох.

НАЧИЩА́ТЬ 1. арилгах, хальслах; 2. арчих, өнгөлөх, арилгах, цэвэрлэх.

НАЧСОСТА́В дарга нарын бүрэлдэхүүн.

НАЧУДИ́ТЬ хачин загнах, жигтэйхэн аашлах, хачирхуулах.

НАШ 1. манай бидний, маны; ~ **долг** маны үүрэг; **~а родина** манай эх орон; 2. **~и** манайхан, өөрийнхэн, **өөрсдийнхэн**; **живём у ~их** өөрсдийнхэндээ байна; 3. манай юм, манайх, өөрийн юм, өөрсдийн юм, өөрсдийнх, өөрийнх; **~его не дадим никому** өөрсдийнхөөгөө хэнд ч өгөхгүй, өөрийнхийгөө хэнд ч өгөхгүй; **по ~ему** маныхаар, биднийхээр маны бодлоор, бидний санахад; **и ~им и вашим** манай танайгүй, аль аль талыг, хоёр талын аль алийг (бялдуу *члах, үйлчлэх*); **знай ~их!** өөрсдийнхнийгөө мэдэж ав!; **~а взяла** манайхан дийлэв.

НАША́ТЫРНЫЙ жацын, навшийн; **спирт** навшийн шүүтэр жацын спирт.

НАША́ТЫРЬ жац,навш,уусгамал шүүтэр.

НАШВЫРЯ́ТЬ хаялах, шидлэх, шидэж хаях, чулуудах; ~ **поленьев** хэрчим хаялах.

НАШЕЛУШИ́ТЬ хальслах, хальсыг нь арилгах.

НАШЕПТА́ТЬ шивэгнэх, чихэнд нь хэлэх.

НАШЁПТЫВАТЬ шивэгнэх, чихэнд нь хэлэх.

НАШЕ́СТ хонуур (*тахианы сууж хонодог хөндлөвч мод*).

НАШЕ́СТВИЕ байлдан довтлох, халдан орох; ~ **вражеских** орд дайсны сүрэг халдан орох.

НАШИВА́ТЬ 1. хадах; 2. оёх.

НАШИ́ВКА хадмал тэмдэг; ~ **на рукавах** ханцуйн тэмдэг.

НАШИВН||О́Й хадмал, хадсан, хадаатай; **~ые карманы** хадмал халаас.

НАШИНКОВА́ТЬ хэрчих; ~ **капусты** байцай хэрчих.

НАШИ́ТЬ 1. хадах; ~ **карман** халаас хадах; 2. оёх; ~ **платьев** хувцас оёх.

НАШЛЕПАТЬ алгадах.

НАШПИГОВА́ТЬ,

НАШПИГО́ВЫВАТЬ, өөх хавчуулах; ~ **дичь салом** шувууны маханд өөх хавчуулах.

НАШТУКАТУ́РИТЬСЯ *разг.* хэт их хийх.

НАШУМЕ́ВШ||ИЙ цуу гаргасан, цууд гарсан, шуугиан болсон; **~ее дело** шуугиан болсон хэрэг.

НАШУМЕ́ТЬ 1. шуугиан гаргах, шуугиах; ~ **в квартире** байрандаа шуугиан гаргах; 2. цуу гаргах, цууд гарах, шуугиан болох.

НАЩЁЛКАТЬ цөмөх.

НАЩИПА́ТЬ 1. зулгаах, чимхлэх; ~ **травы** өвс зулгаах, өвс чимхлэх; 2. чимхэх; ~ **руки** гар чимхэх.

НАЩУ́ПАТЬ тэмтрэх,тэмтрэн олох.

НАЩУ́ПЫВАТЬ 1. тэмтрэх,тэмтрэн олох; ~ **опухоль** хавдрыг тэмтрэн олох; 2. тэнсэж мэдэх, хайж олох; ~ **почву для переговоров** хэлэлцээ хийх үндэс хайж олох.

НАЭЛЕКТРИЗОВА́ТЬ 1. цахилгаанчлах, цахилгаан оруулах; 2. сэтгэл хөдөлгөх, сэтгэл булаах; ~ **слушателей** сонсогчдын сэтгэлийг хөдөлгөх.

НАЭЛЕКТРИЗОВА́ТЬСЯ, НАЭЛЕКТРИЗО́ВЫВАТЬСЯ 1. цахилгаанчлагдах, цахилгаанчлуулах, цахилгаан орох; 2. сэтгэл санаагаа булаагдах.

НАЭЛЕКТРИЗО́ВЫВАТЬ 1. цахилгаанчлах, цахилгаан оруулах; 2. сэтгэл хөдөлгөх, сэтгэл булаах.

НАЯ́БЕДНИЧАТЬ ховлох, хов хүргэх, хов жив зөөх.

НАЯВУ́ үнэхээр, сэрүүндээ, сэрүүн байхдаа; **не во сне, а ~** зүүдэндээ биш, сэрүүндээ.

НЕ 1. -гүй, үгүй, биш, үл, эс, бүү, битгий; **я ~ пойду домой** би гэртээ харихгүй; **~ уходи** битгий яв; **он ~ любитель гулять** тэр (*хүн*) зугаалах дуртай хүн биш; 2. аргагүй, болохгүй — шгүй; **он так изменился, что его ~ узнать** тэр (*хүн*) таних аргагүй хувирчээ; **мне больше его ~ увидеть** би түүний нүүрийг дахин харшгүй болов; 3. биш, гэхэд биш; гэхэд □-гүй; **человек ~ человек, дерево ~ дерево** хүн гэхэд хүн биш, мод гэхэд мод биш; **работает, ~ работает** ажиллана гэхэд ажиллахгүй; 4. -гүй □-гүй,-гүй биш,-гүй □ биш, *заримдаа орчуулахгүй*; **нельзя ~ согласиться** зөвшөөрөхгүй байж болохгүй; **уходи, ~ то прогонят** зайл,зайлахгүй бол хөөнө; **~ то ехать, ~ то нет** явах уу, эсхүл болих уу; **~ знаете ли** □ та мэдэхгүй юү?

НЕАККУРА́ТН||ЫЙ 1. нямбай бус (*хийсэн*), салан (*хийсэн*), замбараагүй; **~ая работа нямбай** бус хийсэн ажил; 2. нямбай бус, салан,салан задгай, цалгар назгай; **~ человек** салан хүн.

НЕАНТАГОНИСТИ́ЧЕСК||ИЙ эсрэг тэсрэг бус; харш бус; эвлэршгүй бус; **~ие противоречия** харш бус зөрчил; **~ие классы рабочих и крестьян** ажилчин тариачны харш бус хоёр анги.

НЕБЕЗОПА́СНЫЙ аюултай, гэмтэй, аюулгүй бус гэмгүй биш.

НЕБЕЗОСНОВА́ТЕЛЬНЫЙ дэмий биш, үндэсгүй бус, нилээд үндэстэй.

НЕБЕЗРАЗЛИ́ЧНЫЙ хайхармаар, хайхралтай, анхаармаараргүй биш.

НЕБЕЗУПРЕ́ЧНЫЙ өөгүй биш, өө сэвгүй биш.

НЕБЕЗЫЗВЕ́СТНЫЙ нилээд нэртэй, нэлээд нэрд гарсан; **~ писатель** нилээд нэрд гарсан зохиолч.

НЕБЕЗИНТЕРЕ́СНЫЙ сонирхолгүй биш, нилээд сонирхолтой.

НЕБЕЛЁН||ЫЙ цайруулаагүй; **~ домашний холст** гэрт нэхсэн цайруулаагүй ёрог; **~ая бумага** цайруулаагүй цаас.

НЕБЕРЕЖЛИ́ВЫЙ гамгүй, хэмнэлтгүй.

НЕБЕСА́ тэнгэр, огторгуй.

НЕБЕСКОРЫ́СТНЫЙ ашиг бодоогүй биш, ашиг боддог, *шуналтай*.

НЕБЕ́СНО-ГОЛУБО́Й хөх цэнхэр.

НЕБЕ́СН||ЫЙ 1. тэнгэрийн, огторгуйн; **~ свод** тэнгэр, огторгуй; **~ые светила** тэнгэрийн одон гариг; 2. хөх тэнгэрийн өнгө, хөх цэнхэр.

НЕБЕСПРИСТРА́СТН||ЫЙ нүүр хараагүй биш, өрөөсгөл, хэлтгий; **~ое суждение** хэлтгий санал.

НЕБЛАГОВИ́ДНЫЙ *аягүй*, зохисгүй; **~ поступок** зохисгүй явдал.

НЕБЛАГОВОСПИ́ТАННЫЙ хүмүүжил муутай;

НЕБЛАГОДА́РНОСТЬ ач хариулахгүй байх, тусч бус зан.

НЕБЛАГОДА́РНЫЙ 1. ач хариулдагтүй, тусч зангүй, ач тус мэдэхгүй; **~ ученик** ач тус мэдэхгүй сурагч; 2. ашиггүй, үнэлэгддэггүй, тоогддоггүй; **~ труд** ашиггүй хөдөлмөр; үнэлэгддэггүй бүтээл; 3. тохирохгүй, таарахгүй;

НЕБЛАГОЖЕЛА́ТЕЛЬН||ЫЙ эс ойшоох, найртай бус; **~ое отношение** эс ойшоон хандах.

НЕБЛАГОЗВУ́ЧН||ЫЙ яруу бус, эвгүй дуутай, харш дуутай, хөг нийлэмжгүй; **~ая музыка** яруу бус хөгжим.

НЕБЛАГОНАДЁЖНЫЙ итгэлгүй, итгэлийг барсан, найдваргүй.

НЕБЛАГОПОЛУ́ЧНО 1. урагшгүй, барагтайхан, муу; 2. урагшгүй байх; барагтайхан болох, муу байх; **дела у них обстоят ~** хэрэг нь урагшгүй байна.

НЕБЛАГОПОЛУ́ЧНЫЙ урагшгүй, бүтэлгүй, барагтайхан, муу; **~ исход дела** хэрэг бүтэлгүй төгсөх.

НЕБЛАГОПРИЯ́ТНЫЙ тааламжгүй, таагүй; тохиромжгүй; **~ результат** тааламжгүй дүн.

НЕБЛАГОРАЗУ́МНЫЙ ухаангүй, бодолгүй, болгоомжгүй.

НЕБЛАГОРО́ДН||ЫЙ муухай, зохимжгүй, энгийн, доод төрлийн, язгуур муутай; **~ поступок** муухай явдал; **~ые металлы** (*эрдэнэ бус төмөр зэс зэргийн*) энгийн төмөрлөг.

НЕБЛАГОУСТРО́ЕНН||ЫЙ тохигүй, тавгүй, төвхнүүн биш, төхөөрөмж муутай; **~ая квартира** тохигүй байр.

НЁБН||ЫЙ тагнайн; **~ые согласные** тагнайн гийгүүлэгч.

НЁБ||О тэнгэр, огторгуй; **синее ~** хөх тэнгэр; **превозносить до ~ес** тэнгэр тултал магтах; **быть на седьмом ~е** тэсгэлгүй баярлах, дэвхцэн баярлах; **это — ~ и земля** тэнгэр газар хоёр шиг юм, тэмээ ямаа хоёр шиг юм; **под открытым ~ом** гадаа; **попасть пальцем в ~** эс оноож буудах, огт зөрүү хэлэх; **(жить, находиться) между ~ом и землёй** тэнгэр газар хоёрын хооронд, орох оронгүй (*байх*); **коптить ~** дэмий цаг нөгчөөх.

НЁБО тагнай; **мягкое ~** нармай; **твёрдое ~** тагнай.

НЕБОГА́ТЫЙ 1. баян биш, ядуу, үгээгүү, үгүйтэй; 2. ховор, хомс, бага, цөөн; **~ выбор товаров** цөөн төрлийн бараа.

НЕБОЕСПОСО́БНЫЙ байлдах чадваргүй, дайтах хүчгүй.

НЕБОЛЬШ||О́Й 1. жаахан, бага, их биш, цөөн; **~ая комната** жаахан тасалгаа; **~ая сумма** жаахан мөнгө, цөөн төгрөг; 2. сулхан; **с ~им** илүүхэн, жаахан илүү, гаруй, гаран; **килограмм с ~им** кило гаран; **дело стало за ~им** өчүүхэн зүйлээс хэрэг саатав.

НЕБОСВО́Д тэнгэр, огторгуй.

НЕБОСКЛО́Н *тэнгэрийн хаяа, тэнгэрийн хормой*.

НЕБОСКРЁБ тэнгэр баганадсан байшин.

НЕБО́СЬ хай, биз, байх; **~ устали в дороге** замд ядраа биз.

НЕБРЕ́ЖНО салан, хааш яаш, тэгс ингэс.

НЕБРЕ́ЖНОСТЬ осол, хааш яаш ажил, цалгар байдал, салан явдал; **непростительная ~** хүлцэшгүй салан явдал.

НЕБРЕ́ЖН||ЫЙ 1. салан, хааш яаш, цалгар, назгай; **~ работник** цалгар назгай ажилтан; **~ кивок головы** толгойгоо хааш хэрэг дохих; 2. хааш яаш хийсэн, цалгар хийсэн, салан хийсэн; **~ые записи** салан хийсэн тэмдэглэл.

НЕБРИ́ТЫЙ сахлаа хусаагүй, сахлаа ургуулсан.

НЕБЫВА́Л||ЫЙ үзэгдээгүй, үзэгдэж харагдаагүй, урьд хожид байгаагүй, ер бусын; **~ое происшествие** үзэгдээгүй хэрэг.

НЕБЫЛИ́Ц||А далан худал, худал; **рассказывать ~ы** далан худал хэлэх.

НЕБЫТИ́Е хоосон ахуй.

НЕБЬЮЩ||ИЙСЯ эвдэрдэггүй, хагардаггүй, бутардаггүй; **~еся стекло** хагардаггүй шил.

НЕВА́ЖНО 1. барагтай, тааруухан, өөдгүй, сулхан, муухан; **я себя чувствую ~** бие барагтай байна; 2. чухал бус, хамаагүй; **это ~** энэ чухал бус.

НЕВА́ЖН||ЫЙ 1. чухал бус, шалигүй, ялихгүй, өчүүхэн; **~ вопрос** чухал бус асуудал, өчүүхэн асуудал; 2. барагтай, тааруухан, сулхан, муухан, олигтүй; **~ое здоровье** сулхан биетэй, бие муутай.

НЕВДАЛЕКЕ́ хол бус, ойрхон, дөт; **он живёт ~** тэр ойрхон суудаг, тэднийх ойрхон байдаг.

НЕВДОМЁК ухаарахгүй, ойлгохгүй, ухахгүй, тааж ядах; **ему и ~** тэгээд тэр хүн ухаарч ядна.

НЕВЕ́ДЕНИ||Е мэдэхгүй, балай байх; **быть в ~и** мэдэхгүй байх; **сделать по ~ю** мэдэхгүйн харгайгаар үйлдэх; **пребывать в блаженном ~и** гэнэн хонгор байх.

НЕВЕ́ДОМО мэдэгдэхгүй, бүү мэд; **явился ~ откуда** хаанаас ирсэн нь бүү мэд орж ирэв.

НЕВЕ́ДОМЫЙ үл мэдэх, үл таних; **~ край** үл мэдэх хязгаар.

НЕВЕ́ЖА бүдүүлэг хүн, ёс мэдэхгүй хүн.

НЕВЕ́ЖДА хүдлэг хүн, харанхуй мунхаг хүн, юм мэдэхгүй хүн, «а, э» —гүй хүн; **полный ~ в музыке** хөгжмийн «а, э» — гүй хүн.

НЕВЕ́ЖЕСТВЕННОСТЬ мунхаг харанхуй, мунхаг явдал, харанхуй байдал, бүдүүлэг зан.

НЕВЕ́ЖЕСТВЕННЫЙ мунхаг харанхуй, юм мэдэхгүй, харанхуй бүдүүлэг; **~ человек** мунхаг харанхуй хүн.

НЕВЕ́ЖЕСТВО 1. юм мэдэхгүй байх, харанхуй бүдүүлэг; **обнаружить свое ~** харанхуй бүдүүлгээ гаргах; 2. бүдүүлэг зан, ёсгүй байдал.

НЕВЕ́ЖЛИВЫЙ бүдүүлэг, ёс мэдэхгүй, зелдэг бус, эгүй; **~ ответ** эвгүй хариу.

НЕВЕЗЕ́НИЕ азгүй байх, хийморь доройтох, урагшгүй явдал, бүтэлгүй байдал.

НЕВЕЛИ́ЧКА өчүүхэн юм, бяцхан юм; **ростом ~** бяцхан биетэй хүн, оодгор хүн; **птичка—~** бяцхан шувуухай.

НЕВЕ́РИЕ үл итгэх, үнэмшихгүй байх; **~ в собственные силы** хүчиндээ үл итгэх.

НЕВЕ́РНОСТЬ 1. буруу байх, ташаа юм, алдаатай байх; 2. итгэл эвдэх, урвалт, буруу санаа; **~ друга** итгэл эвдсэн нөхөр.

НЕВЕ́РН||ЫЙ 1. буруу, ташаа, алдаатай; ташаа мэдээ; 2. үлгэн салган, гуйвганасан; **~ая походка** гуйвганасан алхаа; 3. батгүй, итгэлийг тэсэлсэн, буруу санаатай, уравсан; **~ая жена** итгэл алдсан эхнэр.

НЕВЕРОЯ́ТНОСТ||Ь байж болшгүй юм, итгэшгүй зүйл, ер бусын юм; **до ~и** ёсон бус, ер бусын.

НЕВЕРОЯ́ТН||ЫЙ 1. байж болшгүй, итгэмээргүй, бүтэшгүй; **~ые слухи** итгэмээргүй цуу үг; 2. ер бусын, гайхалтай; **~ успех новой пьесы** шинэ жүжгийн ер бусын амжилт.

НЕВЕ́РУЮЩИЙ 1. сүсэггүй, шүтлэггүй, шашингүй; 2. сүсэггүй хүн, шүтлэггүй хүн, шашингүй хүн.

НЕВЕСЁЛЫЙ уйтгартай, цэнгэлгүй.

НЕВЕСО́М||ЫЙ 1. жингүй, хөнгөн чанартай; 2. итгэл муутай, үндэс муутай; **~ые аргументы** итгэл муутай баримт.

НЕВЕСО́МОСТЬ жингүйдэх.

НЕВЕ́СТА сүйлсэн хүүхэн, хадамтай хүүхэн.

НЕВЕ́СТКА бэр, бэргэн, дүү бэр, авьсан.

НЕВЕ́СТЬ мэдэхгүй, хэн мэдэх вэ; **наговорил ~ чего** мэдэхгүй юу юу ярьчихав.

НЕВЕЩЕ́СТВЕННЫЙ биегүй, бодгүй, хий хоосон.

НЕВЗГО́Д||А гай, зовлон, гамшиг; **душевные ~ы** сэтгэлийн зовлон.

НЕВЗИРА́Я харалгүй, хайхралгүй; **~ на лица** нүүр харалгүй; **~ на непогоду** тэнгэр муухайг хайхралгүй.

НЕВЗНАЧА́Й санамсаргүй, бодолгүй, мэдэлгүй; **мы встретились ~** бид санамсаргүй уулзав.

НЕВЗРА́ЧН||ЫЙ үзэмж муу, урвагар, дорой; **~ая фигура** үзэмжгүй бие.

НЕВЗЫСКА́ТЕЛЬНОСТЬ шаардлага муутай, эрэлт хүсэлт багатай, эрээгүй зан.

НЕВЗЫСКА́ТЕЛЬНЫЙ шаардлага муутай, эрэлт хүсэлт багатай, шилэмтгий биш, эрээгүй, ямбагүй; **~ человек** эрээгүй хүн.

НЕ́ВИДАЛЬ үзэгдэж харагдаагүй юм, гайхмаар юм, гайхал; **вот ~!** Гайхуулах юм аа мөн олов оо!

НЕВИ́ДАННЫЙ үзэгдээгүй, үзэгдэж харагдаагүй, гайхалтай; **~ урожай** үзэгдээгүй их ургац; **~ успех** үзэгдээгүй их амжилт.

НЕВИДИ́МКА үл үзэгдэгч, үл харагдах юм; **человек-~** үл үзэгдэгч хүн; **шапка-~** далдын хар малгай.

НЕВИ́ДИМО үзэгдэхгүй; харагдашгүй; **видимо-~** нүд алдам, зах хязгааргүй, зах үзүүргүй.

НЕВИ́ДИМЫЙ үзэгдэшгүй, харагдашгүй; **~ шов** нүдэнд харагдашгүй оёдол.

НЕВИ́ДЯЩ||ИЙ ажиггүй, алмай; **смотреть ~им взором** алмай нүдээр харах.

НЕВИ́ННОСТЬ 1. гэмгүй байх, буруугүй явдал, гэм хоргүй байх; 2. гэнэн зан, гэнэн хонгор зан; 3. хурьцал үзээгүй байх.

НЕВИ́НН||ЫЙ 1. гэмгүй, буруугүй; **~ая жертва** гэмгүй хэрэгт орсон хүн; хилсдсэн хүн; 2. гэнэн, гэнэн хонгор; **~ ребёнок** гэнэн хүүхэд; 3. хоргүй, хөнөөлгүй; **~ые шалости** хоргүй дүрсгүйдэх; 4. хурьцал үзээгүй; **~ая девушка** хурьцал үзээгүй хүүхэн.

НЕВИ́ННОСТЬ гэмгүй явдал, ялт хэрэг хийгээгүй.

НЕВИНО́ВНЫЙ гэмгүй, ялт хэрэг хийгээгүй.

НЕВКУ́СНЫЙ амтгүй, заваан.

НЕВМЕНЯ́ЕМОСТЬ мэдээгүй байх, ухаан солиу байх.

НЕВМЕНЯ́ЕМ||ЫЙ 1. мэдээгүй, мэдээ алдсан, ухаан солиу; **~ое состояние** ухаан солиу байх; 2. биеэ барихаа больсон.

НЕВМЕША́ТЕЛЬСТВ||О (*хөндлөнгөөс*) үл оролцох, хөндлөнгийн оролцоогүй; **политика ~а во внутренние дела других государств** бусад улсын дотоод хэрэгт үл оролцох бодлого.

НЕВМОГОТУ́ тэсхүйеэ бэрх, тэсвэрлэхийн аргагүй, хүлцэшгүй; **стало ~** хүлцэшгүй болов, тэсэшгүй болов.

НЕВМО́ЧЬ тэсэшгүй, яах ч аргагүй.

НЕВНИМА́НИЕ анхааралгүй байх, анхаарамжгүй байдал,

НЕВНИМА́ТЕЛЬНОСТ||Ь 1. анхааралгүй байх, анхаарамжгүй байдал, хүндэтгэхгүй байх; **~ к интересам покупателя** худалдан авагчийн эрх ашгийг эс анхаарах, худалдан авагчийн эрх ашгийг эс тоох, худалдан авагчийн эрх ашгийг эс хүндлэх; 2. хайхрамжгүй байх, болгоомжгүй байх, эс хайхрах; **сделать ошибку по ~и** хайхрамжгүйгээс алдаа гаргах.

НЕВНИМА́ТЕЛЬН||ЫЙ 1. анхааралгүй, анхаарамжгүй, мартамхай, хичээдэггүй; **~ слушатель** анхааралгүй сонсогч; **~ ученик** хичээдэггүй сурагч; 2. эгүй, найргүй; **~ая хозяйка** эгүй эзэгтэй; 3. хайхрамжгүй болгоомжгүй, халамжгүй; **~ое отношение к больному** өвчтөнд халамжгүй байх.

НЕВНЯ́ТНО тод бус, тод сонсдохгүй, мэдэгдэхгүй, ойлгогдохгүй; **~ говорить** тод бус өгүүлэх, мэдэгдэхгүй ярих.

НЕВНЯ́ТН||ЫЙ тод бус, тод бус сонсдох, мэдэгдэхгүй, ойлгогдохгүй; **~ое произношение** тод бус дуудлага.

НЕ́ВОД гувчуур, өөш, загасны тор.

НЕВОЗВРАТИ́М||ЫЙ буцалтгүй, эргэшгүй, нөхөшгүй; **~ое время** эргэшгүй цаг

НЕВОЗВРА́ТН||ЫЙ буцалтгүй, эргэшгүй, нөхөшгүй; **невозвратная потеря** нөхөшгүй гарз.

НЕВОЗВРАЩЕ́НЕЦ *разг.* гадаадаас буцаж ирээгүй хүн.

НЕВОЗДЕ́РЖАННОСТЬ биеэ барихгүй байх, задгай байдал.

НЕВОЗДЕ́РЖАННЫЙ 1. биеэ барьдаггүй, сэтгэлээ барьж чаддаггүй, хэтрүүлдэг; **~ в пище** хоол хэтрүүлдэг, хоол хэт иддэг; 2. задгай; болгоомжгүй; **~ на язык** задгай амтай.

НЕВОЗДЕ́РЖАНОСТЬ биеэ барихгүй байх, задгай байдал.

НЕВОЗДЕ́РЖАНЫЙ 1. биеэ барьдаггүй, сэтгэлээ барьж чаддаггүй, хэтрүүлдэг; 2. задгай, болгоомжгүй.

НЕВОЗМО́ЖНО болохгүй, бүтэхгүй, болшгүй, бүтэшгүй; **это ~** ингэж болохгүй; 2. тэсэшгүй, яахын аргагүй, нөхцөлгүй; **~ жарко** тэсэшгүй халуун.

НЕВОЗМО́ЖНОСТ||Ь боломжгүй байдал, аргагүй учир, болшгүй болох; **в случае ~и** аргагүй учир гарвал, аргагүй болбол; **до ~и** хэтэрхий, яахын ч аргагүй.

НЕВОЗМО́ЖН||ЫЙ 1. бүтээж болохгүй, бүтэшгүй, болохгүй; **нет ничего не ~ого** бүтээж болохгүй юм гэж байхгүй; **~ое стало возможным** бүтэшгүй юм бүтэв; 2. тэсэшгүй, тэсвэрлэшгүй, яахын аргагүй, тэсгэлгүй; **~ая жара** тэсвэрлэшгүй халуун; **~ая боль** тэсгэлгүй өвдөх.

НЕВОЗМУТИ́МОСТЬ тайвуу зан, амгалан байдал, тайвуу байх, санаа зовиургүй байх.

НЕВОЗМУТИ́МЫЙ *тайвуу, амгалан, санаа зовуурьгүй;* **~ человек** тайвуу хүн.

НЕВОЗНАГРАДИ́МЫЙ нөхөшгүй, зүйрлэшгүй.

НЕВО́ЛЕЙ волей-~ өөрийн эрхгүй, дуртай ч дургүй ч.

НЕВО́ЛИТЬ албадах, албадан хаших, хаших.

НЕВО́ЛЬНИК боол, олзны хүн.

НЕВО́ЛЬНИЦА боол шивэгчин.

НЕВО́ЛЬНИЧЕСТВО боолчлол, боолын байдал.

НЕВО́ЛЬНИЧИЙ боолын, бусдын эрхний; **~ труд** боолын хөдөлмөр.

НЕВО́ЛЬНО өөрийн эрхгүй, аяндаа, мэдэлгүй, зөндөө, яригаараа; **~ улыбнуться** өөрийн эрхгүй инээмсэглэх.

НЕВО́ЛЬН||ЫЙ өөрийн эрхгүй (*хийсэн*), санамсаргүй (*тохиолдсон*), аяндаа (*болсон*), өөрийн мэдэлгүй (*хийсэн*), зөндөө (*болсон*), яригаараа (*болсон*), **~ые слезы** аяндаа асгарсан нулимс; **~ свидетель** санамсаргүй тохиолдсон гэрч.

НЕВО́Л||Я 1. боолчлол, олзонд, байх бусдын эрхэнд байх; **жить в ~е** бусдын эрхэнд байх; 2. зайлшгүй юм, гарцаагүй тохиол; **охота пуще ~и** хүсэл зайлшгүй юмаас хүчтэй, хүсэл үхлээс хүчтэй.

НЕВООБРАЗИ́МЫЙ 1. ухаанд оршгүй, сэргэмжгүй, санашгүй; 2. санаанд оромгүй их, туйлын их; **~ шум** туйлын их шуугиан.

НЕВООРУЖЁНН||ЫЙ зэр зэвсэггүй, зэвсэггүй, гар хоосон; **~ыми глазами** энгийн нүдээр, дурангүй.

НЕВОСПИ́ТАННОСТЬ сургаалгүй байх, хүмүүжилгүй байдал, бүдүүлэг зан.

НЕВОСПИ́ТАННЫЙ сургаал муутай, хүмүүжилгүй, бүдүүлэг.

НЕВОСПЛАМЕНЯ́ЕМ||ЫЙ ноцдоггүй, шатдаггүй, түлэгддэггүй; **~ое вещество** шатдаггүй бодис.

НЕВОСПРИИ́МЧИВОСТЬ 1. тогтооц муу байх, ойлгоцгүй байх; 2. халддаггүй байх.

НЕВОСПРИИ́МЧИВЫЙ 1. тогтооц муутай, ойлгоцгүй; **~ ребёнок** ойлгоц муутай хүүхэд; 2. халдаггүй; **~ к скарлатине организм** улаан эсэргэнэ халддаггүй бие махбод.

НЕВОСТРЕ́БОВАННЫЙ нэхэгдээгүй; нэхэж аваагүй; **~ багаж** нэхэгдээгүй тээш.

НЕВПОПА́Д эс онож, солиу гажуу; **отвечать ~** эс онож хариулах; **говорить ~** солиу гажуу ярих.

НЕВПРОТЫ́К *разг.* хэт их, олон.

НЕВРАЗУМИ́ТЕЛЬНЫЙ ухаарагдахгүй, ойлгошгүй, учир нь олдохгүй; **~ ответ** учир нь олдохгүй хариу.

НЕВРАЛГИ́ЧЕСК||ИЙ мэдрэлийн судасны, хуянгийн; **~ие боли** мэдрэлийн судасны өвчин.

НЕВРАЛГИ́Я мэдрэлийн судас өвдөх, хуян.

НЕВРАСТЕ́НИК мэдрэл муудсан хүн, хийрхүү хүн.

НЕВРАСТЕНИ́ЧЕСКИЙ мэдрэл муудсан, хийрхүү.

НЕВРАСТЕНИ́ЧКА мэдрэл муутай эмэгтэй, хийрхүү эхнэр.

НЕВРАСТЕНИ́Я мэдрэл муудах; хийрхэх.

НЕВРЕДИ́МЫЙ гэмтээгүй, гэмгүй, бүтэн; **цел и невредим** гэмтээгүй, мэнд сайн; эсэн мэнд.

НЕВРО́З мэдрэлийн өвчин.

НЕВРОПАТО́ЛОГ мэдрэлийн эмгэг судлагч.

НЕВРОПАТОЛО́ГИЯ мэдрэлийн эмгэг судлал.

НЕВТЕРПЁЖ *хүлцэшгүй, тэсхүйеэ бэрх, тэсвэрлэхийн аргагүй;* **стало ~** тэсвэрлэхийн аргагүй болов.

НЕВЫ́ГОДН||ЫЙ 1. ашиггүй, тусгүй, гарзтай, алдагдалтай; **~ая сделка** ашиггүй хэлэлцээ; 2. тохиромжгүй, зохимжгүй; **~ые климатические условия** тохиромжгүй цаг уур; 3. таагүй, эвгүй; **~ое впечатление** таагүй сэтгэгдэл.

НЕВЫ́ДЕЛАННЫЙ элдээгүй.

НЕВЫ́ДЕРЖАНН||ЫЙ 1. гүйцэд болоогүй, гүйцэд эсээгүй, бүрэн боловсроогүй, бэлэн болоогүй; **~ое вино** гүйцэд эсээгүй дарс; 2. биеэ барьдаггүй, тэсгэлгүй, олон зантай; **~ человек** биеэ барьдаггүй хүн; 3. жигдгүй, тууштай биш, туйлбаргүй; **~ стиль** *жигдгүй найруулга.*

НЕВЫ́ЕЗД нэг нутгаас гарахгүй; **дать подписку о ~е** нэг нутгаас гарахгүй гэж ам өгөх, гарын үсэг зурах.

НЕВЫЕЗДНО́Й *разг.* гадаад явж болохгүй хүн.

НЕВЫ́ЛАЗН||ЫЙ гарахын аргагүй, явах нөхцөлгүй; **~ая грязь** явахын аргагүй шавар шавхай.

НЕВЫНОСИ́М||ЫЙ тэсэшгүй, тэсүйеэ бэрх; тэсэхийн нөхцөлгүй; **~ая боль** тэсхүйеэ бэрх өвдөх.

НЕВЫПОЛНЕ́НИЕ гүйцэтгэхгүй, биелүүлээгүй; **~ своего обязательства** үүргээ гүйцэтгээгүй; **~ плана** төлөвлөгөө биелүүлээгүй.

НЕВЫПОЛНИ́МЫЙ *гүйцэтгэшгүй, биелүүлшгүй;* биелшгүй; гүйцэтгэхийн аргагүй, бүтэшгүй.

НЕВЫРАЗИ́М||ЫЙ өгүүлшгүй, хэлэхийн аргагүй, амлашгүй; **~ая красота** өгүүлэшгүй гоо үзэсгэлэн.

НЕВЫСО́К||ИЙ 1. балтгар, навтгар, намхан, нам; **человек ~ого роста** намхан нуруутай хүн; 2. өөдгүй, барагтайхан, муухан; **товар ~ого качества** барагтайхан чанартай бараа; **я ~ого мнения о нём** би түүнийг өөдгүй хүн гэж боддог.

НЕВЫ́ХОД гарахгүй байх; **~ на работу** ажилдаа гарахгүй байх.

НЕ́ГА 1. энхрийлэх, эрхлүүлэх, бөмбийлгөх; 2. эрх дураараа байх, жаргалан.

НЕГА́ДАННО ***нежданно-~*** санамсаргүй байтал, гэв гэнэт.

НЕГА́ДАННЫЙ санамсаргүй, санагдаагүй, гэнэтийн.

НЕГАТИ́В 1. негатив, сөргүү; 2. *разг* негр.

НЕГАТИ́ВНЫЙ I үгүйсгэсэн, арцсан, бууруушаасан, мэлзсэн.

НЕГАТИ́ВНЫЙ II негатив, сөргүү, сөрөг; **~ процесс** сөрөг процесс.

НЕГАШЁН||ЫЙ ~ая известь түүхий шохой.

НЕ́ГДЕ 1. зайгүй, газаргүй, завсаргүй; **~ сесть** суух зайгүй; 2. газар алга, хаанаас ч... —гүй; **~ достать** олох газар алга, хаанаас ч олохгүй.

НЕГИ́БКИЙ уян бус, уян хатан бус.

НЕГЛА́СНЫЙ нууц, далд; **~ надзор** нууц хяналт.

НЕГЛУБО́КИЙ 1. гүнзгий биш, гүехэн, нимгэн; **~ ров** гүехэн нүх; 2. мөчид, өнгөцхөн, гүн биш, утга нимгэн; **~ доклад** утга нимгэн илтгэл.

НЕГЛУ́ПЫЙ овоо ухаантай, гайгүй сэргэлэн.

НЕГО́ДНИК олигтүй хүн.

НЕГО́ДНОСТЬ хэрэггүй (*байх*), хэргээ алдах, таарахгүй (*байх*), тохирохгүй (*болох*).

НЕГО́ДН||ЫЙ 1. хэрэггүй, хэргээ алдсан, тэнцэхгүй, таарахгүй, зохисгүй, болохгүй; **~ к военной службе** цэргийн албанд тэнцэхгүй; **~ая для питья вода** ундаанд таарахгүй ус; 2. хэрэггүй, олиггүй, үл бүтэх; **~ человек** олиггүй хүн.

НЕГОДОВА́НИЕ эгдүү, зэвүү; **прийти в ~** эгдүү хүрэх, тэчьяадах, тачаадах.

НЕГОДОВА́ТЬ зэвүү хүрэх, эгдүүцэх, зэвүүрхэх, эгдүү хөдлөх, зэвүүцэх.

НЕГОДУ́ЮЩИЙ эгдүүцсэн, зэвүүрхсэн, зэвүүцсэн.
НЕГОДЯ́Й үл бүтэх эттээд, шившигт эттээд.
НЕГОДЯ́ЙКА шившигт эмэгтэй, бузар эхнэр.
НЕГР негр.
НЕГРА́МОТНО үсгийн алдаатай.
НЕГРА́МОТНОСТ||Ь бичиг (*үсэг*) үл мэдэх (*явдал*), мэдлэг багатай (*байх*); **ликвидация ~и** бичиг үл мэдэх явдлыг устгах.
НЕГРА́МОТН||ЫЙ 1. бичиг (*үсэг*) үл мэдэх, бичиг мэдэхгүй; **~ человек** бичиг мэдэхгүй хүн; 2. эрдэмгүй, боловсролгүй, чадвар муутай, мэдлэг багатай, юм мэдэхгүй; **~ техник** мэдлэг багатай техник; 3. алдаатай (*хийсэн*) муу; **~ая рукопись** алдаатай гар бичмэл.
НЕГРИТЁНОК бяцхан негр, негр хүүхэд.
НЕГРИТЯ́НКА негр эмэгтэй, негр эхнэр.
НЕГРИТЯ́НСКИЙ негр, негрийн.
НЕГРО́МК||ИЙ чанга бус, аяархан; **сказать что-либо ~им голосом** аяархан дуугаар юм хэлэх.
НЕДА́ВН||ИЙ саяын, саяхны, сая ойрын, сая болсон; **с ~их пор** саяхнаас.
НЕДА́ВНО сая, саяхан.
НЕДАЛЁК||ИЙ 1. ойр, дөт, дөтийн, ойрхны, ойрын; **на ~ом расстоянии** ойр газарт; 2. сая, ойр, саяын, ойрын, саяхны, ойрхны; **в ~ом прошлом** сая өнгөрсөн цаг, саяхан; **в ~ом будущем** ойрын ирээдүйд; 3. холыг бодоогүй, ухвар муутай; **~ человек** ухвар муутай хүн.
НЕДАЛЕКО́ 1. ойр, дөт, ойрхон, энүүхэнд, холгүй; **он живёт ~** тэр (*хүн*) энүүхэнд суудаг; 2. ойр болох, ойрхон болох; **~ то время, когда...** х цаг ойрхон болоод байна.
НЕДАЛЕ́КО, 1. ойр, дөт, ойрхон, энүүхэнд, холгүй; **он живёт ~** тэр (*хүн*) энүүхэнд суудаг; 2. ойр болох, ойрхон болох; **~ то время, когда...** х цаг ойрхон болоод байна.
НЕДАЛЬНОВИ́ДНОСТЬ холч бодлогогүй байх, холыг харахгүй байх, бодлого мөчид байх.
НЕДАЛЬНОВИ́ДНЫЙ холч бодлогогүй, холыг хардаггүй, бодлого мөчид; **~ человек** бодлого мөчид хүн.
НЕДА́РОМ талаар... бус, дэмий... биш, учиртай; **он пришёл ~** тэр (*хүн*) дэмий ирсэн биш.
НЕДВИ́ЖИМОСТЬ үл хөдлөх хөрөнгө.
НЕДВИ́ЖИМ||ЫЙ үл хөдлөх; **~ое имущество** үл хөдлөх хөрөнгө.
НЕДВУСМЫ́СЛЕННЫЙ хоёрдмол утгагүй, хоёрдмол ойлголтгүй; **~ ответ** хоёрдмол ойлголтгүй хариу.
НЕДЕЕСПОСО́БНЫЙ 1. хариуцлага хүлээж чадахгүй; 2. юм бүтээх чадалгүй, хөдөлмөрлөх чадалгүй.
НЕДЕЙСТВИ́ТЕЛЬНЫЙ хүчингүй, хүчин төгөлдөр бус; **~ документ** хүчин төгөлдөр бус баримт бичиг.
НЕДЕЛИ́МЫЙ хуваагдахгүй, хуваагдашгүй.
НЕДЕ́ЛЬНЫЙ долоо хоногийн; **~ срок** долоо хоногийн хугацаа.
НЕДЕ́Л||Я долоо хоног; **через ~ю** долоо хоноод.
НЕДЕНАТУРИРОВАННЫЙ ~ этиловый спирт, *бот* этилийн хувилаагүй спирт.
НЕДЕРЖА́НИЕ ~ мочи шээс алдрах.
НЕДЁШЕВО 1. хямд биш үнэтэй; 2. арай ядаж, чуу чамай; **это досталось мне ~** би үүнийг арай ядаж олж авав.
НЕДИСЦИПЛИНИ́РОВАННОСТЬ сахилга батгүй явдал, сахилгагүй байдал.
НЕДИСЦИПЛИНИ́РОВАННЫЙ сахилга батгүй, сахилгагүй; **~ ученик** сахилгагүй сурагч.
НЕДОБИРА́ТЬ,
НЕДОБРА́ТЬ дутуу авах, дутуу түүх, дутуу хураах, дутуу элсүүлэх.
НЕДОБО́Р дутуу хураалт, дутуу элсүүлэлт.
НЕДО́БРОЕ замышлять ~, задумать ~ муу юм санах, муу санаа агуулах.
НЕДОБРОЖЕЛА́ТЕЛЬ муу санагч, хар санаат хүн.
НЕДОБРОЖЕЛА́ТЕЛЬНИЦА муу санагч эмэгтэй, хар санаат эхнэр.
НЕДОБРОЖЕЛА́ТЕЛЬН||ЫЙ муу санаатай, хар санаатай; **~ое отношение** хар санаатай хандах.
НЕДОБРОКА́ЧЕСТВЕННОСТЬ чанар муу, яс муу.
НЕДОБРОКА́ЧЕСТВЕНН||ЫЙ чанар муутай, яс муутай; **~ товар** яс муутай бараа; **~ая работа** чанар муутай ажил.
НЕДОБРОСО́ВЕСТНОСТЬ шударгагүй явдал, сэтгэлгүй байх, нүүргүй зан, (*хүний*) мөс муу.
НЕДОБРОСО́ВЕСТН||ЫЙ 1. шударгагүй, сэтгэлгүй, нүүргүй, мөс муутай; **~ человек** мөс муутай хүн; 2. шударга бус (*хийсэн*), сэтгэлгүй (*хийсэн*); **~ая работа** шударга бус хийсэн ажил.
НЕДО́БР||ЫЙ 1. муу санаатай, найгүй, хялайн харсан; **~ человек** муу санаатай хүн; 2. муу, олиггүй; **~ая весть** муу мэдээ, олиггүй мэдээ.
НЕДОВАРИ́ТЬ дутуу чанах, дутуу болгох.
НЕДОВЕ́РИ||Е 1. итгэхгүй (*байх*), итгэлгүй (*явдал*), найдлагагүй (*байх*); **отнестись с ~ем** итгэлгүй хандах, итгэхгүй байх; 2. үл итгэх; **вотум ~я** үл итгэх шийдвэр.
НЕДОВЕ́РЧИВОСТЬ итгэхгүй (*явдал*), итгэлгүй (*байх*), найдлагагүй (*байх*).
НЕДОВЕ́РЧИВЫЙ 1. итгэдэггүй, муу санаатай, сэжигч; **~ человек** итгэдэггүй хүн; 2. итгэлгүй, сэжиг төрсөн, сэжиглэсэн; **~ взгляд** сэжиглэсэн харц.
НЕДОВЕ́С дутуу жигнэх, жин дутуу байх.
НЕДОВЕ́СОК дутуу жинтэй юм.
НЕДОВЕ́ШИВАТЬ дутуу жигнэх.
НЕДОВО́ЛЬНЫЙ сэтгэл ханаагүй, дургүйцсэн, чамласан, дур гутанги; **~ вид** дургүйцсэн янз, чамласан янз.
НЕДОВО́ЛЬСТВО дургүйцэл, сэтгэл эс ханах, дур гутах, чамлах, голох; **выразить ~** сэтгэл эс ханаснаа илтгэх; **~ самим собою** өөрөө өөрийгөө чамлах, өөрөө өөрийгөө голох.
НЕДОВЫПОЛНЕ́НИЕ дутуу гүйцэтгэх, дутуу биелүүлэх.
НЕДОВЫПО́ЛНИТЬ,
НЕДОВЫПОЛНЯ́ТЬ дутуу гүйцэтгэх, дутуу биелүүлэх.
НЕДОГА́ДЛИВОСТЬ авхаалж муу байх, ухваргүй (*байх*).
НЕДОГА́ДЛИВЫЙ авхаалж муутай, ухваргүй.
НЕДОГЛЯДЕ́ТЬ дутуу ажиглах, эс ажих, харахгүй өнгөрөх, харахгүй байж алдах; **~ ошибки** алдаа харахгүй өнгөрөх.
НЕДОГОВА́РИВАТЬ дутуу хэлэх, гүйцэд эс өгүүлэх, (*юм*) орхиж ярих, иг маг гэх.
НЕДОГОВОРЁННОСТ||Ь 1. дутуу хэлэх, гүйцэд эс өгүүлэх, (*юм*) орхиж ярих, иг маг гэх; 2. хэлэлцэн тогтоогүй (*байх*), хэлэлцээргүй (*байх*), дутуу хэлэлцэх; **из-за ~и** хэлэлцээргүйгээс, дутуу хэлэлцсэнээс.
НЕДОДЕ́ЛКА дутуу хийх, дуусаагүй ажил, дутуу хийсэн юм.
НЕДОДЕ́ЛАННЫЙ *разг.* тэнэг, маанаг.
НЕДОЕДА́НИ||Е цадахгүй байх, цадтал идэхгүй байх, дутуу хоолтой байх; **истощение организма от ~я** дутуу ядуу хоолтой байснаас бие тамирдах.
НЕДОЕДА́ТЬ цадахгүй байх, цадтал идэхгүй байх, идэш хоол дутмаг байх.
НЕДОЕ́СТЬ цадтал эс идэх, дутуу идэх; **~ за обедом** үдийн хоолноор цадтал эс идэх.
НЕДОЗВО́ЛЕННЫЙ цаазтай, хориулттай, хориотой, хоригтой.
НЕДОЗРЕ́ЛЫЙ гүйцэд болоогүй, дутуу боловсорсон.

НЕДОЙМКА албан татварын дутуу.
НЕДОЛГА́ (вот) и вся недолга *(разг.)* ингээд л боллоо.
НЕДО́ЛГИЙ удаан биш, өнө биш, түргэн, урт биш, жаахан.
НЕДО́ЛГО 1. удаан биш, жаахан, удаангүй...-гүй; ~ **думая** жаахан бодоод, удаан бодолгүй; 2. хол биш, амархан; **в такой реке утонуть** ~ ийм усанд живж үхэх хол байна даа.
НЕДОЛГОВЕ́ЧН||ЫЙ 1. богино настай, насгүй; **~ое растение** богино настай ургамал; 2. өнө биш, түр зуурын; **~ое счастье** түр зуурын жаргал.
НЕДОЛЁТ эс хүрэх, хүрэхгүй байх; ~ **пули** сум эс хүрэх.
НЕДОЛЮ́БЛИВАТЬ хялайн үзэх, таалахгүй байх.
НЕДОМЕ́РИВАТЬ,
НЕДОМЕ́РИТЬ, дутуу хэмжих.
НЕДОМЕ́РОК дутуу хэмжээтэй юм, багадсан хувцас.
НЕДОМОГА́НИЕ бие эвгүйрхэх, эмгэглэх, бие тавгүй болох, чилээрхэх; **лёгкое** ~ бие жаахан эвгүйрхэх.
НЕДОМОГА́ТЬ бие эвгүйрхэх, эмгэглэх, бие тавгүй болох, чилээрхэх.
НЕДОМО́ЛВКА дутуу зуурмаг хэлэх, зуурмаглан өгүүлэх; **говорить ~ми** дутуу зуурмаг ярих, эг маг гээд байх.
НЕДОМЫ́СЛИ||Е мөчид бодол, мөчид бодох; **сделать что-либо по ~ю** мөчид бодож юм хийх.
НЕДОНО́СОК дутуу хүүхэд, зулбадас.
НЕДОНО́ШЕННЫЙ дутуу сартай (*гарсан*), дутуу төрсөн; ~ **ребёнок** дутуу сартай хүүхэд.
НЕДООЦЕ́НИВАТЬ,
НЕДООЦЕНИ́ТЬ дор үзэх, дутуу үнэлэх.
НЕДООЦЕ́НКА дор үзэх, дутуу үнэлэх, дутуу үнэлэлт.
НЕДОПИВА́ТЬ,
НЕДОПИ́ТЬ дутуу уух, уугаад үлдээх.
НЕДОПЛА́ТА дутуу төлөх, гүйцэд эс төлөх.
НЕДОПЛАТИ́ТЬ,
НЕДОПЛА́ЧИВАТЬ дутуу төлөх, гүйцэд эс төлөх.
НЕДОПОЛУЧА́ТЬ,
НЕДОПОЛУЧИ́ТЬ, дутуу авах, гүйцэд эс авах.
НЕДОПРОИЗВО́ДСТВО дутуу үйлдвэрлэл, дутуу үйлдвэрлэх.
НЕДОПУСТИ́МЫЙ тэсвэрлэшгүй, байлгаж болшгүй, зөвшөөршгүй; ~ **поступок** тэсвэрлэшгүй явдал, гаргаж болшгүй хэрэг.
НЕДОРА́ЗВИТОСТЬ гүйцэд боловсроогүй, дутуу боловсрох, гүйцэд өсөөгүй, дутуу өсөлт; ~ **мозга** тархи дутуу боловсрох.
НЕДОРА́ЗВИТЫЙ гүйцэд боловсроогүй, дутуу боловсорсон, гүйцэд өсөөгүй, дутуу өссөн; ~ **организм** дутуу өссөн бие махбодь.
НЕДОРАЗУМЕ́НИ||Е 1. эндүүрэл, учрыг ойлголцохгүй явдал; **по ~ю** *учрыг ойлгоогүйгээс, эндүүрснээс*; 2. арцалдаан, маргаан; **крупное** ~ том маргаан.
НЕДО́РОГО хямд, хямдхан, хямд үнээр; **купить** ~ хямд авах.
НЕДОРОГО́Й хямд, хямдхан, хямд үнэтэй, үнэтэй биш.
НЕ́ДОРОСЛЬ 1. эрдэмгүй залуу тайж; 2. эрдэмгүй хүн, дүйнгэ хүн.
НЕДОСЁВ дутуу тарих.
НЕДОСЛЫ́ШАТЬ дутуу *сонсох, мөчид сонсох*, дуулахгүй өнгөрөх.
НЕДОСМО́ТР дутуу харах, ажиглахгүй өнгөрөх, цалгар байх; **по ~у** дутуу харснаас, цалгар байснаас.
НЕДОСМОТРЕ́ТЬ дутуу харах, ажиглахгүй өнгөрөх.
НЕДОСО́Л дутуу давслах.
НЕДОСПА́ТЬ дутуу унтах, нойр алдах, нойр эс ханах.
НЕДОСПЕ́ЛЫЙ дутуу болсон, гүйцэд боловсроогүй.
НЕДОСТАВА́||ТЬ дутах, хүрэхгүй, хүрэлцэхгүй; **~ёт опыта** туршлага дутаж байна; **этого ещё только ~ло** бас ингэх л дутаа юу.
НЕДОСТА́Т||ОК 1. дутуу, дутмаг, хүрэхгүй, хүрэлцэхгүй, дутагдал; **за ~ком чего-либо** юм дутагдалтайгаас; ~ **в квалифицированных рабочих** мэргэжилтэй ажилтан дутмаг; 2. дутагдал, алдаа дутагдал; **~ки в работе** ажлын дутагдал; 3. гэм; ~ **зрения** *нүдний харааны гэм.*
НЕДОСТА́ТОЧНОСТЬ дутмаг байх, хүрэлцэхгүй байх, дутуу ядуу.
НЕДОСТА́ТОЧН||ЫЙ 1. дутмаг, хүрэлцээ багатай, хүрэхгүй, дутуу ядуу; **~ая сумма** хүрэлцээ багатай *мөнгө*; 2. хангалтгүй, дутагдалтай; ~ **ответ** дутагдалтай хариу.
НЕДОСТА́ЧА дутагдал, дутагдах, дутах; ~ **в кассе** кассад мөнгө дутах.
НЕДОСТАЮ́Щ||ИЙ дутуу, дутагдаж байгаа, дутсан; **~ие страницы** дутуу хуудсууд.
НЕДОСТИЖИ́МЫЙ хүршгүй, гүйцэтгэшгүй, *биелүүлэхийн* аргагүй, бүтэшгүй.
НЕДОСТОВЕ́РНОСТЬ лавтай биш байх, нуттай биш байх, нутгүй байх.
НЕДОСТОВЕ́РНЫЙ лавгүй, нуттай биш, магадгүй.
НЕДОСТО́ЙН||ЫЙ 1. зохисгүй, даахгүй, хүнддэх, хэрэггүй, -уушгүй (*-үүшгүй*); ~ **внимания** анхаарах зохисгүй, анхааруушгүй; 2. ёс журамгүй, шударга бус, зүй бус; **~ая личность** ёс журамгүй этгээд.
НЕДОСТУ́ПНОСТЬ 1. ойртоход бэрх (*байх*), хүршгүй (*байх*), халдашгүй (*байх*); 2. ойлгогдохгүй (*байх*), ухахад хэцүү (*байх*).
НЕДОСТУ́ПН||ЫЙ 1. ойртох аргагүй, хүршгүй, давшгүй, халдашгүй; **~ая скала** давшгүй хад; 2. ойртоход бэрх, чанга хэцүү; ~ **человек** ойртоход бэрх хүн; 3. ойлгогдохгүй, ухахад хэцүү; 4. хүрч, хүршгүй үнэтэй, дийлшгүй үнэтэй.
НЕДОСУ́Г 1. чөлөөгүй, завгүй, зав зайгүй, зав чөлөөгүй; 2. чөлөөгүй байх, завгүй байх, зав зайгүй байх, зав чөлөөгүй байх; **мне** ~ би завгүй байна.
НЕДОСЧИТА́ТЬСЯ,
НЕДОСЧИ́ТЫВАТЬСЯ, тоолоход дутах, хүрэхгүй байх, дутуу байх, алга байх.
НЕДОСЫПА́НИЕ дутуу унтах, нойр дутуу байх.
НЕДОСЫПА́ТЬ дутуу унтах, нойр алдах, нойр эс ханах.
НЕДОСЯГА́ЕМ||ЫЙ хүртэшгүй, хүртээлгүй, хүртээл болохгүй, хувь хүрэхгүй; **на ~ой высоте** хүртээл болохгүй дээр, хүршгүй дээр.
НЕДОТЁПА болхи хүн.
НЕДОТРО́ГА 1. эмзэг хүн, маягтай хүн; 2. хумсан будаг (*ургамал*).
НЕДОУ́ЗДОК ногт.
НЕДОУМЕВА́ТЬ эргэлзэх, тээнэгэлзэх.
НЕДОУМЕ́НИ||Е эргэлзэл, тээнэгэлзэл; **быть в ~и** эргэлзэл төрөх, тээнэгэлзэх.
НЕДОУМЁННЫЙ эргэлзсэн, тээнэгэлзсэн; ~ **взгляд** тээнэгэлзсэн харц.
НЕДОУ́ЧКА дутуу сурсан хүн, эрдэм багатай хүн.
НЕДОЧЁТ 1. алдаа, алдагдал, дутуу дутагдал; ~ **суммы** мөнгөний алдагдал, мөнгөний дутагдал; 2. алдаа дутагдал, алдаа ташаарал; **исправить ~ы в работе** ажлын алдаа дутагдлыг засах.
НЕ́ДРА газрын хэвэл, газрын баялаг; **в недрах земли** газрын хэвэлд, газар дор; **разработка недр** газрын баялгийг ашиглах.
НЕДРЕ́МЛЮЩ||ИЙ соргог, сонор, сэргэлэн, сэрэмжтэй; **~ее око** соргог нүд.
НЕ́ДРУГ муу хүн, хартан, дайсан.
НЕДРУЖЕЛЮ́БН||ЫЙ найгүй, хүйтэн, дайсагнасан; **~ое *отношение*** найгүй, хүйтэн харьцаа.

НЕДУ́Г эмгэг, өвчин; **тяжкий ~** хүнд өвчин.
НЕДУ́РНО гайгүй, гэмгүй, нуруутай, голтой.
НЕДУРНО́Й 1. гайгүй, гэмгүй, нуруутай, голтой; 2. гайгүй цэвэр, овоо аятайхан.
НЕДЮ́ЖЕННЫЙ гоц, товойн гарсан; **~ ум** гоц ухаан; **~ человек** товойн гарсан хүн.
НЕЕСТЕ́СТВЕННО 1. хуурамч, худал, хуурмаг, хиймэл; **~ улыбаться** хуурамч инээмсэглэх; 2. ер бусын, ердийн бус; **~ большая голова** ер бусын том толгой.
НЕЕСТЕ́СТВЕННОСТЬ 1. хуурамч (*байх*), хуурмаг (*байх*), хиймэл (*байх*); 2. ер бусын (*байх*), ердийн бус (*байх*) ёсон бус (*байх*).
НЕЕСТЕ́СТВЕНН||ЫЙ 1. хуурамч, худал, хуурмаг, хиймэл; **~ смех** худал инээд; 2. ер бусын, ердийн бус, ёсон бус; **~ая величина** ер бусын их юм.
НЕЖДА́ННО ~негаданно санамсаргүй байтал, гэв гэнэт.
НЕЖДА́ННЫЙ ирнэ гэж бодоогүй, санамсаргүй, гэнэтийн; **~ гость** ирнэ гэж бодоогүй хүн, гэнэтийн зочин.
НЕЖЕЛА́НИЕ дургүй (*байх*), хүсэхгүй (*байх*).
НЕЖЕЛА́ТЕЛЬНЫЙ хүсмээргүй, санаанд таарахгүй, таалалд нийцэхгүй, хэрэггүй, зохисгүй; **~ расход** хэрэггүй зарлага.
НЕ́ЖЕЛИ илүү; **он умнее, ~ кажется сначала** анх санаснаас илүү ухаантай хүн.
НЕЖЕНА́ТЫЙ эхнэргүй, гэрлээгүй, эхнэр аваагүй.
НЕ́ЖЕНКА танхилган хүн, танхил хүн, эрх танхи хүн.
НЕЖИВ||О́Й 1. үхсэн; **младенец родился ~** үхсэн хүүхэд төрөв; 2. амьгүй, амьд бус; **~ая природа** амьгүй байгаль; 3. хийморьгүй, цоггүй; **~ взгляд** хийморьгүй харц.
НЕЖИ́ЗНЕНН||ЫЙ хэрэглээж болохгүй, биелэхгүй, хэрэгцээгүй, чухал биш, хоосон; **~ое предложение** хэрэглээж болохгүй санал, хоосон санал.
НЕЖИЗНЕСПОСО́БНОСТЬ амьдрах чадваргүй (*байх*), насгүй (*байх*).
НЕЖИЗНЕСПОСО́БНЫЙ амьдрах чадваргүй, насгүй.
НЕЖИЛО́Й хүн суудаггүй, эзэнгүй, хоосон, хөндий; **~ дом** хүн суудаггүй байшин, эзэнгүй байшин.
НЕ́ЖИТЬ эрхлүүлэх, энхрийлэх, танхилуулах.
НЕ́ЖИТЬСЯ эрхлэх, танхилах, биеэ бөмбийлөх; **~ на солнышке** наранд танхилах.
НЕ́ЖНИЧАТЬ наалинхайтах, танхитах.
НЕ́ЖНОСТ||Ь 1. энхрийлэл, эрхлүүлэх; **~ матери** эхийн энхрийлэл; 2. хэврэг (*байх*), булбарай (*байх*); **~ кожи** булбарай арьс; 3. нялуун үг, наалинхай зан, эрх байдал; **говорить ~и** нялуун үг ярих.
НЕ́ЖН||ЫЙ 1. наалинхай, энхрий, эрх, танхи, нүд талимаарам; **~ые чувства** энхрий сэтгэл; **~ взгляд** нүд талимаарах; 2. ялгуун, ялдам, элдэг зөөлөн; **~ голос** ялгуум дуу; 3. булбарай, зөөлөн; **~ая кожа** булбарай арьс; 4. эмзэг, хэврэг; **~ цветок** эмзэгхэн цэцэг.
НЕЗАБВЕ́НН||ЫЙ үл мартагдах, мартагдашгүй үе; **~ друг** үл мартагдах анд; **~ая пора** мартагдашгүй үе.
НЕЗАБУ́ДКА хонин зангуу (*цэцэг*), дурсгал цэцэг.
НЕЗАБУ́ДОЧНИК *бот* батга.
НЕЗАБЫВА́ЕМ||ЫЙ марташгүй, мартагдашгүй; **~ая встреча** марташгүй уулзалт.
НЕЗАВИ́ДН||ЫЙ атаархмааргүй, хүсэмгүй; **~ое положение** атаархмааргүй байдал.
НЕЗАВИ́СИМО биеэ дааж, өөрийн эрхээр, бусадтай эн чацуу; **держать себя ~** бусадтай эн чацуу байх.
НЕЗАВИ́СИМОСТЬ тусгаар тогтнол, биеэ даасан байдал; **национальная ~** үндэсний тусгаар тогтнол; **~ взглядов** биеэ даасан үзэл.
НЕЗАВИ́СИМ||ЫЙ тусгаар тогтносон, биеэ даасан, толгойгоо даасан, бусадтай эн чацуу, хүний мэдэлд ордоггүй, өөрийн эрхтэй; **~ая страна** тусгаар тогтносон орон; **~ человек** өөрийн эрхтэй хүн, биеэ даасан хүн; **~ характер** хүний мэдэлд ордоггүй зан.
НЕЗАВИ́СЯЩ||ИЙ хамаарахгүй, шалтгаалахгүй, болохгүй; **по ~им от кого-либо обстоятельствам** хүнээс болоогүй учир шалтгаанаар.
НЕЗАДА́ЧА азгүй явдал, урагшгүй хэрэг.
НЕЗАДА́ЧЛИВЫЙ 1. азгүй, хувьгүй, заяа муутай; **~ день** азгүй өдөр; 2. урагшгүй; **~ парень** урагшгүй хүү.
НЕЗАДО́ЛГО өмнөхөн, урьдхан, өмнөтээ, урьдтаа; **~ до праздника** баярын өмнөхөн, баярын урьдтаа.
НЕЗАКОННОРОЖДЁННЫЙ бутач.
НЕЗАКО́НН||ЫЙ хууль бус, ёс бус; **~ые действия** хууль бус үйл ажиллагаа.
НЕЗАКО́НЧЕННЫЙ дуусаагүй, төгсөөгүй, гүйцээгүй, дүүрээгүй.
НЕЗАМЕДЛИ́ТЕЛЬНО үтэр түргэн, нэн даруй; **~ явиться** үтэр түргэн ирэх.
НЕЗАМЕДЛИ́ТЕЛЬНЫЙ үтэр түргэн, нэн даруй; **~ ответ** үтэр түргэн өгсөн хариу.
НЕЗАМЕНИ́МЫЙ олдошгүй, сольшгүй, сольж болшгүй; **~ работник** олдошгүй ажилтан.
НЕЗАМЕ́ТНО үзэгдэхгүй, мэдэгдэхгүй, чимээгүй; **~ уйти** чимээгүй гарч одох.
НЕЗАМЕ́ТН||ЫЙ 1. үзэгдэхгүй, мэдэгдэхгүй, үл мэдэг, балархай; **~ая тропинка** үл мэдэг зөрөг; 2. бий үгүй нь мэдэгдэхгүй, хүний анхааралд өртдөггүй, өчүүхэн; **~ человек** бий үгүй нь мэдэгддэггүй хүн.
НЕЗАМУ́ЖНЯЯ нөхөргүй, эргүй, хадамд гараагүй, хүнд очоогүй.
НЕЗАМЫСЛОВА́ТЫЙ бааз, бүдүүн; **~ узор** бааз угалз.
НЕЗАПА́МЯТН||ЫЙ балар, балархай, эрт, эрт урьдын; **с ~ых времен** балар цагаас, балар эрт цагаас.
НЕЗАПЯ́ТНАНН||ЫЙ хиргүй, сэвгүй, өөгүй, ариун; **~ое имя** хиргүй нэр, ариун нэр.
НЕЗАРА́ЗН||ЫЙ халдваргүй; **~ая болезнь** халдваргүй өвчин.
НЕЗАСЛУ́ЖЕННО хилс, зүгээр байтал нь, хий, дэмий.
НЕЗАСЛУ́ЖЕНН||ЫЙ хилс, зүгээр байтал нь (*хийсэн*), хий дэмий; **~ое оскорбление** хий доромжлох, зүгээр байтал нь доромжлох.
НЕЗАТЕ́ЙЛИВ||ЫЙ түвэг багатай, бааз; **~ые украшения** түвэг багатай чимэг.
НЕЗАТОПЛЯ́ЕМЫЙ усанд живээгүй.
НЕЗАУРЯ́ДН||ЫЙ жирийн бус; **~ые способности** жирийн бус авъяас.
НЕ́ЗАЧЕМ хэрэггүй, дэмий; **~ ходить туда** тиишээ очих хэрэггүй.
НЕЗВА́НЫЙ эс уригдсан, уригдаагүй; **~ гость** уригдаагүй зочин.
НЕЗДЕ́ШНИЙ эндхийн биш, энэ нутгийн биш; **~ человек** эндхийн хүн биш.
НЕЗДОРО́ВИТЬСЯ бие эвгүйрхэх, бие тавгүйдэх, бие муу байх, чилээрхэх; **мне нездоровится** миний бие эвгүйрхэж байна.
НЕЗДОРО́В||ЫЙ 1. эрүүл бус, өвчтэй, бие муутай; **~ вид** эрүүл бус царай, царай муу; 2. эрүүл мэндэд харш, эрүүл мэндэд муу; **~ климат** эрүүл мэндэд харш уур амьсгал; 3. буруу, зохисгүй, үл зохилдох; **~ая обстановка** үл зохилдох байдал.
НЕЗДОРО́ВЬЕ бие эвгүйрхэх, бие тавгүйрхэх, бие муудах, чилээрхэх.

НЕЗЛОБИ́ВЫЙ хоргүй, сайхан сэтгэлтэй, номхон; ~ **человек** сайхан сэтгэлтэй хүн.

НЕЗЛОПА́МЯТНЫЙ өшөө санадаггүй, өшөө өвөрлөдөггүй; ~ **человек** өшөө санадаггүй хүн.

НЕЗНАКО́МЕЦ танихгүй хүн, танил биш хүн.

НЕЗНАКО́МКА үл таних эмэгтэй, танил биш эмэгтэй.

НЕЗНАКО́МСТВО танихгүй байх, мэдэхгүй байх; ~ **с географией** газарзүй мэдэхгүй байх.

НЕЗНАКО́МЫЙ үл таних, мэдэхгүй.

НЕЗНА́НИ||Е мэдэхгүй (*байх*), танихгүй (*байх*); **по ~ю** мэдэхгүйгээс.

НЕЗНА́ЧАЩИЙ утгагүй, дэмий, хоосон; ~ **разговор** хоосон яриа.

НЕЗНАЧИ́ТЕЛЬН||ЫЙ өчүүхэн, ялихгүй, шалихгүй; **~ая сумма** ялыгүй мөнгө.

НЕЗРЕ́Л||ЫЙ 1. болоогүй, боловсроогүй, түүхий; **~ое яблоко** түүхий алим 2. гүйцэд боловсруулаагүй, түүхий, нээгдээгүй; **~ое произведение** гүйцэд боловсруулаагүй зохиол, түүхий бүтээл; ~ **ум** нээгдээгүй ухаан.

НЕЗРИ́МЫЙ үл харагдах, үл үзэгдэх.

НЕЗЫБЛЕМО хөдөлбөргүй бат.

НЕЗЫБЛЕМОСТЬ хөдөлбөргүй бат (*байх*).

НЕЗЫБЛЕМ||ЫЙ хөдөлбөргүй (*бат*), гайхашгүй; **~ая основа** хөдөлбөргүй бат суурь.

НЕИЗБЕ́ЖНО зайлшгүй.

НЕИЗБЕ́ЖНОСТЬ зайлшгүй (*байх*), хойшлуулшгүй (*байх*); ~ **краха капитализма** капитализм сүйрэх нь зайлшгүй.

НЕИЗБЕ́ЖНЫЙ зайлшгүй, хойшлошгүй.

НЕИЗВЕ́ДАНН||ЫЙ 1. судлаагүй, шинжлээгүй; ~ **край** судлаагүй хязгаар; 2. танигдаж мэдэгдээгүй, урьд үзээгүй, урьд мэдээгүй, урьд урьдаас өөр; **~ое чувство** урьд урьдаас өөр сэтгэл.

НЕИЗВЕ́СТНО мэдэгдээгүй, танигдаагүй; ~ **кто** хэн болох нь мэдэгдээгүй; **место жительства его** ~ түүний хаана суудаг нь мэдэгдээгүй.

НЕИЗВЕ́СТНОСТ||Ь мэдэгдээгүй (*байх*), мэдэхгүй (*байх*); **быть в ~и** мэдэгдээгүй байх, нэрд гараагүй байх.

НЕИЗВЕ́СТНЫЙ 1. мэдэгдээгүй, мэдэхгүй, судлагдаагүй; ~ **остров** судлагдаагүй арал; 2. нэрд гараагүй, алдаршаагүй, нэршээгүй, нэр үл мэдэгдэх; ~ **художник** нэрд гараагүй зураач. нэр үл мэдэгдэх зураач; 3. танихгүй, үл таних, танигдаагүй, үл мэдэх; **какой-то** ~ **человек** нэг үл таних хүн, нэг үл мэдэх хүн.

НЕИЗГЛАДИ́М||ЫЙ баларшгүй, арилшгүй, марташгүй; **~ое впечатление** мартагдашгүй сэтгэгдэл.

НЕИЗДАННЫЙ нийтлээгүй, хэвлэгдээгүй.

НЕИЗЛЕЧИ́МЫЙ эдгэршгүй, эдгэшгүй, анагаашгүй, арилшгүй.

НЕИЗМЕ́ННО үргэлж, хувиршгүй.

НЕИЗМЕ́НН||ЫЙ 1. хувиршгүй, хувирдаггүй, тогтмол, байнгын, үргэлжийн; **~ые привычки** тогтмол заншил; 2. үнэнч, шударга журамт; ~ **друг** үнэнч найз.

НЕИЗМЕРИ́МО хэмжээлшгүй, хэмжээгүй; **наша жизнь стала ~ лучше прежней** манай аж амьдрал урьдынхаас хэмжээлшгүй дээр болов.

НЕИЗМЕРИ́М||ЫЙ хэмжээлшгүй, хэмжээгүй, хязгааргүй, өргөн уудам, өргөн дэлгэр; **~ые пространства** өргөн уудам зай.

НЕИЗЪЯСНИ́МЫЙ тайлбарлашгүй, тайлшгүй, ойлгогдохгүй, учир нь үл мэдэгдэх.

НЕЙЛО́Н нейлон.

НЕИМЕ́НИЕ, үгүй (*байх*), -гүй (*байх*); **за ~м лучшего** өөр сайн юмгүйн тулд.

НЕИМОВЕ́РНО итгэмээргүй, гайхалтай их, маш их; ~ **жарко** гайхалтай их халуун.

НЕИМОВЕ́РНЫЙ итгэмээргүй, гайхалтай их, *маш их*; ~ **холод** маш их хүйтэн, тасхийм хүйтэн.

НЕИМУ́ЩИЙ үгийгүй хоосон, үгүйтэй, ядуу, юмгүй.

НЕИСКОРЕНИ́МЫЙ арилгашгүй, устгашгүй.

НЕЙСКРЕННИЙ хуурмаг, гоёч, өнгө үзүүлсэн, үнэнч биш; ~ **смех** хуурмаг инээд.

НЕЙСКРЕННО хуурмаг, өнгө үзүүлэн, гоёчлон.

НЕЙСКРЕННОСТЬ хуурмаг зан, өнгө үзүүлэх, гоёчлох.

НЕИСКУ́СНЫЙ болхи, толхи, борог, ургүй.

НЕИСКУШЁННОСТЬ юм мэдэхгүй байх, хаширгүй байх.

НЕИСКУШЁННЫЙ юм үзээгүй, юм мэдэхгүй, хашир суугаагүй, догшроогүй; ~ **в политике** улс төрийн талаар хашир суугаагүй.

НЕИСПОЛНЕ́НИЕ гүйцэтгээгүй явдал, дагахгүй байх.

НЕИСПОЛНИ́М||ЫЙ гүйцэтгэшгүй, дагаж болшгүй, биелүүлэх аргагүй, хангаж болшгүй; **~ое требование** биелүүлэх аргагүй шаардлага; **~ое желание** хангаж болшгүй хүсэл.

НЕИСПО́ЛЬЗОВАННЫЙ хэрэглээгүй, ашиглаагүй, аваагүй; ~ **отпуск** аваагүй амралт.

НЕИСПРАВИ́МЫЙ засаршгүй, засрахаа больсон, дүүрсэн.

НЕИСПРА́ВНОСТЬ эвдэрхий байх; ~ **радиоприёмника** эвдэрхий радио хүлээн авагч.

НЕИСПРА́ВН||ЫЙ 1. эвдэрхий, засвартай; **~ая машина** засвартай машин; 2. нямбай биш, оролдлогогүй, хааш хэрэг, замбараа муутай; ~ **работник** оролдлогогүй ажилтан.

НЕИССЯКА́ЕМЫЙ барагдашгүй, дуусашгүй, дүүршгүй, ширгэшгүй; ~ **источник** барагдашгүй эх булаг.

НЕЙСТОВСТВО,1. галзуурах, догшрох; **приходить в** ~ галзуурах, догшрох; 2. зэрлэг догшин явдал, галзуу ширүүн зан.

НЕЙСТОВСТВОВАТЬ ганирах, галзуурах, догшрох, галзуу ширүүн загнах.

НЕЙСТОВ||ЫЙ 1. *догшин ширүүн*, зэрлэг догшин, галзуу ширүүн; **~ая буря** догшин шуурга; 2. галзуу юм шиг, ганирсан; **~ые аплодисменты** ганиран алга таших.

НЕИСТОЩИ́М||ЫЙ барагдашгүй, бууршгүй; **~ая энергия** бууршгүй эрчим хүч.

НЕИСЦЕЛИ́МЫЙ анагаашгүй, эдгэршгүй, эдгэшгүй.

НЕИСЧЕРПА́ЕМЫЙ баршгүй, шавхашгүй, ундарч байдаг; ~ **родник народной инициативы** ард түмний санаачилгын ундрал.

НЕИСЧИСЛИ́МЫЙ тоолшгүй, тоо томшгүй, тоймгүй их.

НЕЙТРАЛИЗОВА́ТЬ 1. төвийг сахиулах; 2. саармаглуулах.

НЕЙТРАЛИТЕ́Т төвийг сахих (*явдал*), (*бусад гурний дайнд үл оролцох*); **соблюдать** ~ төвийг сахих; **нарушить** ~ төвийг сахих явдлыг зөрчих, төвийг сахихаа болих.

НЕЙТРА́ЛЬНОСТЬ төвийг сахих.

НЕЙТРА́ЛЬН||ЫЙ 1. төвийг сахьсан, төвийг сахигч; **~ое государство** төвийг сахьсан улс 2. эрс, саармаг; **~ые гласные** саармаг эгшиг; 3. саармаг; ~ **раствор** саармаг уусмал; **~ая реакция** саармаг урвал.

НЕЙТРО́Н нейтрон (*атомын цөмийн цахилгаан цэнэггүй өчүүхэн хэсэг*).

НЕКАЗИ́СТЫЙ сүлдгүй, сүр сүлдгүй, хиймоpьгүй.

НЕКВАЛИФИЦИ́РОВАННЫЙ мэргэшилгүй, мэргэшил багатай, *мэргэшээгүй*, хар; ~ **рабочий** мэргэшилгүй ажилчин.

НЕ́КИЙ нэгэн, нэг хүн, ямар нэгэн, аль нэгэн.

НЕ́КОГДА I завгүй (*байх*), чөлөөгүй (*байх*); ~ **гулять** зугаалах завгүй; **мне сегодня** ~ би өнөөдөр чөлөөгүй; өнөөдөр би завгүй.

НЕ́КОГДА II урьд, урьд нэгэн цагт, эрт урьд, эрт нэгэн цагт; ~ **здесь было озеро** урьд нэгэн цагт энд нуур байжээ.

НЕ́КОГО хүн үгүй, хүн байхгүй, хүн хэн ч үгүй; ~ **послать** илгээх хүн үгүй; **мне не о ком вспомнить** миний дурсмаар хүн хэн ч үгүй; надад дурсах хүн байхгүй.

НЕПОКОЛЕБИ́МЫЙ хэлбэршгүй.

НЕКОМПЕТЕ́НТНОСТЬ мэдэцгүй (*байх*), мэдлэггүй (*байх*).

НЕКОМПЕТЕ́НТНЫЙ мэдэцгүй, мэдлэггүй.

НЕКОМПЛЕ́КТНЫЙ иж бүрэн биш, иж дутуу.

НЕКОНДИЦИО́НН||ЫЙ болзолт чанаргүй, болзолд тохироогүй; **~ые семена** болзолт чанаргүй үр, болзолд тохироогүй үр.

НЕКОРРЕ́КТНЫЙ эвлэг биш, эвч биш, ёсноос гажуу, журамгүй.

НЕ́КОТОР||ЫЙ 1. нилээд, нэг хэдэн, хэдэн; **с ~ого времени** нилээд хэдийнээс; **~ое количество** хэдэн (*тоо*); 2. **~ые** зарим, зарим хүн; **~ые деревья** зарим мод; **~ые любят читать лежа** зарим хүн хэвтээгээрээ ном унших дуртай.

НЕКРАСИ́ВО 1. муухай; ~ **написать** муухай бичих; 2. муухай, зохисгүй, эвгүй, шударга биш; **так поступать** ~ ингэх эвгүй байна.

НЕКРАСИ́ВЫЙ 1. муухай, царай муутай; ~ **почерк** муухай хэлбэртэй үсэг; ~ **человек** царай муутай хүн; 2. муухай, зохисгүй, эвгүй, шударга биш; ~ **поступок** эвгүй явдал.

НЕКРИТИ́ЧЕСКИЙ шүүмжлэлгүй.

НЕКРОЛО́Г эмгэнэл, гашуудлын өгүүлэл.

НЕКСТА́ТИ цагийг ололгүй, зохимжгүй цагт, тохиромжгүй үед; **пришёл** ~ тохиромжгүй цагт ирэв; **сказать что-нибудь** ~ цагийг ололгүй юм хэлэх.

НЕКТА́Р (*цэцгийн*) шүүс, рашаан.

НЕ́КТО нэгэн хүн, гэдэг нэг хүн; **подошёл** ~ **в чёрной шляпе** хар малгайтай нэгэн хүн ойртов; ~ **Иванов** Иванов гэдэг нэг хүн.

НЕ́КУДА газар байхгүй, газар үгүй, хаашаа ч... аргагүй; **идти** ~ явах газар байхгүй, хаашаа ч явах аргагүй; **отступать** ~ ухрах газар үгүй.

НЕКУЛЬТУ́РНО боловсон бус.

НЕКУЛЬТУ́РНОСТЬ боловсон бус (*байх*), соёл боловсролгүй (*байх*), соёлгүй байх, бүдүүлэг зан.

НЕКУЛЬТУ́РН||ЫЙ 1. боловсон бус, соёлгүй, соёл боловсролгүй, бүдүүлэг; ~ **человек** боловсон бус хүн, бүдүүлэг хүн; **~ое отношение** боловсон бус харьцаа, бүдүүлэг харьцаа; 2. зэрлэг; **~ые растения** зэрлэг ургамал.

НЕКУРЯ́Щ||ИЙ 1. тамхи татдаггүй; ~ **человек** тамхи татдаггүй хүн; 2. тамхи татдаггүй хүн; **вагон для ~их** тамхи татдаггүй хүмүүсийн вагон.

НЕЛА́ДН||ЫЙ барагтай, тусгүй, эвгүй; **у него н~о со здоровьем** түүний бие барагтай байна; **здесь что-то ~о** үүнд нэг эвгүй юм байна, үүнд нэг учир бий.

НЕЛАДЫ́ эвгүй болох, эвдрэл, хэрүүл; **семейные** ~ гэр бүлийн хэрүүл.

НЕЛА́СКОВЫЙ наалинхай биш, эелдэг биш, энхрийлдэггүй, эрхэлдэггүй; ~ **ребёнок** эрхэлдэггүй хүүхэд.

НЕЛЕГА́ЛЬНО ил биш, нууц, цаастай.

НЕЛЕГА́ЛЬН||ЫЙ ил биш, нууц, цаастай; **~ое положение** нууц байдал; **~ая литература** хориотой зохиол.

НЕЛЁГКАЯ ~ **принесла** (*занесла, дернула и т.п.*) (*кого разг. неодобр*) гай, чөтгөр, гай газар дороос гэж; **куда его** ~ **занесла** түүнийг чөтгөр хаашаа аваад явчихав; **вот** ~ **его принесла** гай газар доороос гэж тэр (*хүн*) орж ирлээ.

НЕЛЁГК||ИЙ хөнгөн биш, хүндэвтэр, нилээд хүнд; **~ая задача** нилээд хүнд зорилт.

НЕЛЕ́ПОСТ||Ь утгагүй юм, дэмий юм, янзын үг, тэнэг явдал; ~ **обвинения** утгагүй яллах; **наделать ~ей** утгагүй юм хийх; **говорить ~и** янзын үг хэлэх, тэнэг үг хэлэх.

НЕЛЕ́ПЫЙ 1. утгагүй, дэмий, тэнэг; ~ **ответ** утгагүй хариу; 2. янзын, эв хавгүй; **~ костюм** эв хавгүй хувцас.

НЕЛЕ́СТН||ЫЙ таашаагаагүй, ойшоогоогүй; **~ые слова** таашаагаагүй үг.

НЕЛИ́ШНЕ илүүц биш; ~ **заметить что.....** гэж тэмдэглэх нь илүүц биш.

НЕЛО́ВК||ИЙ 1. шаламгай биш, дүйгүй, будлиу, бойдго, эв хавгүй; **~ие движения** бойдго хөдөлгөөн; **Одно неловкое движение — и вы отец. (М.Жванецкий)** Эв хавгүй нэг хөдөлгөөн хийхэд л та эцэг болно. (М.Жванецкий); 2. эвгүй, тавгүй; **лежать в ~ом положении** эвгүй хэвтэх; 3. аягүй, эвгүй; **попасть в ~ое положение** эвгүй байдалд орох; 4. ганзага татуу, ганзага муутай.

НЕЛО́ВКО 1. шаламгай бус, дүйгүй, эвгүй, бойдго; ~ **прыгнуть с лошади** мориноос эвгүй харайж буух; 2. эвгүй байх, тавгүй байх; ~ **писать лежа** хэвтээгээрээ бичих эвгүй байдаг; 3. аягүй байх, эвгүй байх, ичгэвтэр байх; **мне стало** ~ би баахан ичлээ.

НЕЛО́ВКОСТЬ 1. шаламгай биш (*байх*), дүйгүй (*байх*), бойдго байдал; 2. эвгүй байх, аягүй болох, ичгүүр; **чувствовать** ~ аягүй болох, ичих.

НЕЛОГИ́ЧНЫЙ авцалдаагүй, зөрөлдөөнтэй.

НЕЛЬЗЯ́ 1. болохгүй, горьгүй; **об этом** ~ **и подумать** үүний тухай бодож ч болохгүй; 2. үл болно, хориотой; **здесь курить** ~ энд тамхи татаж үл болно; **как** ~ нэн; **как** ~ **лучше** нэн сайн; ~ **не** -гүй гэх аргагүй; ~ **не согласиться** зөвшөөрөхгүй гэх аргагүй; ~ **ли** болохгүй юу; ~ **сказать, чтобы..** гэх аргагүй, гэж болохгүй; ~ **сказать, чтобы он был прав** түүний зөв гэж болохгүй.

НЕЛЮБЕ́ЗНЫЙ хүйтэн, эегүй; ~ **приём** хүйтэн хүлээн авах, хүйтэн угтах.

НЕЛЮБИ́М||ЫЙ хайргүй, дургүй, сэтгэлд зохисгүй, шоовдор; **~ое дитя** шоовдор хүүхэд.

НЕЛЮБО́ВЬ дургүй (*байх*).

НЕЛЮДИ́МЫЙ зожиг; ~ **человек** зожиг хүн.

НЕМА́ЛО багагүй, цөөн бус, олон.

НЕМАЛОВА́ЖН||ЫЙ нилээдгүй чухал, **~ые события** нилээдгүй чухал үйл явдал.

НЕМА́ЛЫЙ багагүй, бага бус, нилээд их.

НЕМА́РК||ИЙ хир болдоггүй, хир халддаггүй; **~ая материя** хир болдоггүй бөс.

НЕМЕ́ДЛЕННО үтэр, даруй, яаралтай; ~ **принять соответствующие меры** зохих арга хэмжээг даруй авах.

НЕМЕ́ДЛЕННЫЙ үтэр, даруй, яаралтай; ~ **ответ** яаралтай хариу.

НЕМЕ́ДЛЯ үтэр, даруй, яаралтай.

НЕМЕ́РКНУЩ||ИЙ бууршгүй, унтаршгүй, бадрангуй; ~ **свет** унтаршгүй гэрэл; **~ая слава** бууршгүй алдар.

НЕМЕ́РЕНО *разг.* их, арвин.

НЕМЕ́||ТЬ 1. хэлгий болох, дуугүй болох, чимээгүй, болох; ~ **от восторга** баярласандаа дуугүй болох; 2. хөших, мэдээ алдах; **пальцы ~ют от холода** хүйтэнд хуруу хөшнө, бээрнэ.

НЕ́МЕЦ герман хүн.

НЕМЕ́ЦКИЙ герман, германы; ~ **язык** герман хэл.

ОСТРИ́ЧЬ хайчлах, хяргах, танах, тайрах, авах засах; **~ овцу** хонь хайчлах; **~ когти** хумс авах; **~ волосы** үс авах, үс засах.

ОСТРИ́ЧЬСЯ үсээ засуулах, авуулах.

О́СТРОВ арал.

ОСТРОВИТЯ́НИН арлын хүн.

ОСТРОВН||О́Й арлын; **~ая растительность** арлын ургамал; **~ город** арлын хот.

ОСТРОВО́К бяцхан арал.

ОСТРО́Г 1. шивээ, шивээлсэн хот; 2. гяндан.

ОСТРОГ||А́ сэрээ; **бить рыбу ~ой** загас сэрээдэх.

ОСТРОГА́ТЬ зорох.

ОСТРОГЛА́ЗЫЙ хурц нүдтэй, өлөн нүдтэй.

ОСТРОКОНЕ́ЧН||ЫЙ хурц үзүүртэй, шовх, шовгор, шовхгор, шөнтгөр, шөмбөгөр; **~ая башня** шовгор оройтой цамхаг.

ОСТРОНО́СЫЙ шөнтгөр хамартай.

ОСТРОТА́ I. 1. хурц, сонор; **~ зрения** хурц нүд; **~ слуха** сонор чих; 2. хэцүү, бэрх, **~ положения** хэцүү байдал.

ОСТРОТА́ II шог үг, хошин үг.

ОСТРОУ́МИЕ цэцэн ухаан, хурц ухаан; **щеголять ~м** цэцнээ гайхуулах; **проявить ~ в решении вопроса** хурц ухаан зарж асуудал шийдэх.

ОСТРОУ́МНО цэцэн, ухаан сийлэн, уран ухаантай, аргыг нь олж, аятайхан; **~ ответить** цэцэн хариулах.

ОСТРОУ́МН||ЫЙ цэцэн, уран ухаантай, ухаан сийлсэн, аргыг нь олсон, аятайхан, **~ человек** цэцэн хүн; **~ое решение** ухаан сийлж шийдэх.

О́СТР||ЫЙ 1. хурц, иртэй; **~ нож** хурц хутга, иртэй хутга; 2. шовх, шовхгор, шөнтгөр, шөмбөгөр; **~ угол** шовх өнцөг; 3. хурц, хурдан; **~ глаз** хурц нүд; **~ умом мальчик** хурц ухаантай хүү, авхаалж сайтай хүү; 4. хошин, хорон, ёжтой, хурц; **~ая шутка** хошин шог; **у него ~ язык** хорон үгтэй хүн; 5. хурц, дарвигнуулсан, хатуу, халуун ногоотой; **~ вкус** дарвигнуулсан амт, халуун амт; **~ое блюдо** халуун ногоотой хоол; **~ запах** хурц үнэр; 6. цочмог; **~ое воспаление** цочмог үрэвсэх, цочмог үрэвсэл; 7. хурц, ширүүн, хэцүү, бэрх; **~ недостаток чего-либо** юм бэрх дутагдах; **~ая борьба** хурц тэмцэл.

ОСТРЯ́К *разг.* шогч, хошин.

ОСТУДИ́ТЬ,

ОСТУЖА́ТЬ хөргөх, сэвлэх, зөөгшрүүлэх.

ОСТУПА́ТЬСЯ,

ОСТУПИ́ТЬСЯ хий гишгэх, бүдрэх.

ОСТЫ||ВА́ТЬ,

ОСТЫ||ТЬ, 1. хөрөх, хүйтэн болох, зөөсгөрөх, сэрүүн болох; **чай ~л** цай зөөсгөрлөө; 2. гарах, намхрах; **гнев его ~л** уур нь гарчээ.

ОСТЬ ургамлын сор.

ОСУДИ́ТЬ шийтгэх, шийтгэл үзүүлэх, залхаан цээрлүүлэх.

ОСУЖДА́ТЬ 1. шийтгэх, шийтгэл үзүүлэх, залхаан цээрлүүлэх; **~ военных преступников** цэргийн гэмт хэрэгтнийг залхаан цээрлүүлэх; 2. буруушаах, зэмлэх; 3. тавилантай байх, цондонтой байх.

ОСУЖДЕ́НИЕ 1. буруушаах, буруушаалт, буруушаал; 2. шийтгэх, шийтгэл.

ОСУЖДЁННЫЙ шийтгэгдсэн, ялтан.

ОСУ́НУТЬСЯ царай алдах, цонхийх.

ОСУША́ТЬ,

ОСУШИ́ТЬ 1. ширгээх, хатаах; **~ болото** намаг ширгээх; 2. хуурайлах, хуурайлан уух, шавхах, шавхан уух; **~ стакан** шил аягатай юм шавхан уух, аяга хуурайлах; **~ глаза** уйлахаа болих; **~ слезы кому-нибудь** хүнийг тайтгаруулах.

ОСУШЕ́НИЕ ширгээх, хатаах, ширгээлт, хатаалга; **~ болот** намаг ширгээх.

ОСУШИ́ТЕЛЬН||ЫЙ ширгээх, хатаах, ширгээлтийн, хатаалгын; **~ые работы** ширгээх ажил.

ОСУ́ШКА ширгээх, хатаах, ширгэлэг, хатаалга.

ОСУЩЕСТВИ́МОСТЬ биелмээр байх, биелүүштэй байх.

ОСУЩЕСТВИ́МЫЙ биелмээр, гүйцэтгэж болом, биелүүштэй; **~ проект** биелж болох төсөл.

ОСУЩЕСТВИ́ТЬ биелүүлэх, гүйцэтгэх, хэрэгжүүлэх, хийх; **~ что-либо на практике** юмыг хэрэгжүүлэн биелүүлэх.

ОСУЩЕСТВИ́||ТЬСЯ биелэх, биелэгдэх, хэрэгжих, гүйцэлдэх, бүтэх; **мечта о счастливой жизни ~лась** жаргалтай амьдралын хүслэн биелэв.

ОСУЩЕСТВЛЕ́НИЕ биелүүлэх, гүйцэтгэх, биелүүлэлт, гүйцэтгэлт, биелэх, бүтэх, биелэлт, бүтэмж; **~ плана** төлөвлөгөө биелүүлэх; **~ желаний** хүсэл биелэх.

ОСУЩЕСТВЛЯ́ТЬ биелүүлэх, гүйцэтгэх, хэрэгжүүлэх, хийх.

ОСУЩЕСТВЛЯ́ТЬСЯ 1. биелэх, биелэгдэх, хэрэгжих, гүйцэлдэх, бүтэх; 2. гүйцэтгэгдэх, биелүүлэгдэх.

ОСЧАСТЛИ́ВИТЬ гийгүүлэх, гялайлгах, жаргаах.

ОСЫПА́НИЕ унах, сарних.

ОСЫ́ПА||ТЬ 1. асгах, үрэх, цацах; **~ мукой** гурил үрэх; 2. шавах, хучих; 3. чимэх, шигтгэх; 4. унагах, гээх, нүцгэрэх; **яблоня ~ла листья** алимын мод навчаа гээв; 5. тараах, сарниулах.

ОСЫПА́ТЬСЯ унах, сарнин унах, сарних, тарах.

ОСЬ тэнхлэг, гол; **задняя ~** хойт тэнхлэг, хойт гол; **~ вращения** эргэлтийн тэнхлэг; **~ рычага** хөшүүргийн гол, **~ захвата** түгжих гол.

ОСЬМИНО́Г нядмар.

ОСЯЗА́ЕМ||ЫЙ мэдэгдэхүйц, товойгосон, бариа тавиа; **~ые результаты** товойсон үр дүн.

ОСЯЗА́НИЕ хүртэхүй, тэмтрэхүй.

ОСЯЗА́ТЕЛЬНЫЙ 1. хүртэх, тэмтрэн мэдрэх; **~ орган** хүртэх эрхтэн; 2. овойж товойсон, илэрхий, мэдэгдэхүйц; **~ результат** овойж товойсон үр.

ОСЯЗА́ТЬ хүртэх, тэмтрэх, тэмтрэн мэдрэх.

ОТ... ДО 1. -аас (-ээс-, -оос,-өөс); **~ начала ~ конца** эхнээсээ адаг хүртэл; **~ Москвы ~ Улан-Батора** Москвагаас Улаанбаатар хүртэл; **узнать что-нибудь ~ друга** найзаасаа юм дуулах; **избавиться ~ опасности** аюулаас гэтлэх; 2. -ын (-ийн), -ы (-ий); -н; **люди ~ науки** шинжлэх ухааны хүмүүс; **пуговица ~ шубы** дээлийн товч; 3. -аас (-ээс, -оос, -өөс), -даа (-дээ, -доо, -дөө), учраас, -ж; -н; **дрожать ~ страха** айснаас чичрэх, айж чичрэх; **~ нечего делать** хийх юмгүй учраас, хийх юмгүйдээ; **страдать ~ голода** өлсч зовох; **плакать ~ радости** баярлан уярах; 4. -аас (-ээс, -оос; -өөс), (орчуулахгүй ч байж болно); **отличить добро ~ зла** муу сайныг ялгах, хар цагааныг ялгах; **отделить нужные книги ~ ненужных** хэрэггүй номоос хэрэгтэй номыг тусгаарлах; 5. -ын (-ийн), -ы (-ий); -д гарсан; -аас (-ээс; -оос, өөс); **время ~ времени** үе үе.

ОТА́ВА хэнз ногоо.

ОТА́ПЛИВАТЬ галлах, гал түлэх, галлаж дулаацуулах.

ОТА́ПЛИВАТЬСЯ дулаацуулагдах, галлах, галлаж дулаацуулах.

ОТА́РА хонин сүрэг.

ОТБА́ВИТЬ дундруулах, хорогдуулах, ҳасах.

ОТБАВЛЯ́||ТЬ дундруулах, хорогдуулах, хасах; **хоть ~й** хоршгүй их.

ОТБЕГА́ТЬ,

ОТБЕЖА́ТЬ гүйж зайлах, гүйн холдох, гүйж одох, гүйх.

ОТБЕЛИ́ТЬ цайлгах, цагаан болгох, цагаанаар будах.

ОТБИВА́ТЬ 1. цохих, хариулан цохих, цохиж буцаах, няцаах; 2. булаах, булаан авах, булаан эзлэх; 3. зайлуулах, холдуулах, хөндийрүүлэх, таслах; 4. эмх цохих, хуга цохих, булгалах, мулт цохих; 5. дарах, даруулах, арилгах; 6. давтах, давтаж тэгшлэх; 7. тогших, тонших.

ОТБИВА́ТЬСЯ 1. няцаах, хориглон тулалдах, мултран тарах, зайлах; 2. хоцрох, тасрах, гээгдэх; 3. хэлтрэх, хуга үсрэх, булгарах.

ОТБИ́ВКА давтах, давтаж тэгшлэх, давталт.

ОТБИРА́ТЬ 1. булаах, булаан авах, хураах; 2. хураан авах, эргүүлэн авах, буцаан авах; 3. сонгож авах, шилж авах, ялгах; 4. байцаан авах.

ОТБИ́ТЬ 1. цохих, хариулан цохих, цохиж буцаах, няцаах; **~ мяч рукой** бөмбөг цохих; 2. булаах, булаан авах, булаан эзлэх; **~ орудие** их буу булаан авах; 3. зайлуулах, холдуулах, хөндийрүүлэх таслах; **~ носик у чайника** гүцний цорго булгалах; 4. дарах, даруулах, арилгах; **~ запах** үнэр дарах; 5. давтах, давтаж тэгшлэх; **~ косу** хадуур давтах; 6. тогших, тонших; **~ такт рукой** гараар айзам тогших.

ОТБИ́ТЬСЯ 1. няцаах, хориглон тулалдах, мултран гарах, зайлах; **~ от врага** дайсныг няцаах, дайснаас мултран гарах; 2. хоцрох, тасрах, гээгдэх; **~ от своих** ижлээсээ тасрах, нөхдөөсөө тасрах; 3. хэлтрэх, хуга үсрэх, булгарах; **ручка у чайника отбилась** гүцний бариул булгарав; **~ от рук** үг дагахаа болих.

ОТБЛАГОДАРИ́ТЬ ачийг хариулах, талархах.

О́ТБЛЕСК туяа; **~и пламени** галын туяа.

ОТБО́Й 1. дууссаны дохио, төгсгөлийн дохио, төгсгөлийн бүрээ; **бить ~** 1) төгсгөлийн дохио өгөх, төгсгөлийн, хэнгэрцэг цохих, төгсгөлийн бүрээ татах; 2) үгээ буцах.

ОТБО́ЙКА хэмх цохих, хэмхлэх; **механическая ~ каменного угля** механизмын хүчээр нүүрс хэмхлэх.

ОТБО́ЙНЫЙ давтах, *хэмх цохих, нураах*; **~ молоток** нураах алх, доргиот алх.

ОТБО́Р 1. шилэх, сонгох, ялгах; 2. шилэлт, шигшил, шилэх, шигших, шалгарал, ялгарал, шалгарах, ялгарах; **естественный ~** байгалийн шалгарал.

ОТБО́РН||ЫЙ шилмэл, шилдэг, шигшээ, сонгомол, сонгодог, шалгарсан, шалгармал; **~ые яблоки** шилмэл алим; **~ые войска** шилдэг цэрэг.

ОТБО́РОЧН||ЫЙ, шалгаруулах; **~ая комиссия** шалгаруулах комисс.

ОТБРА́СЫВАТЬ 1. шидэж хаях, таягдан хаях, шидэх, чулуудах; 2. ухруулах, цохиж хөөх; 3. болих, орхих, таягдан хаях; 4. тусгах.

ОТБРО́СИ||ТЬ 1. шидэж хаях, таягдан хаях, шидэх, чулуудах; **~ ненужную вещь** хэрэггүй юмыг чулуудах; 2. ухруулах, цохиж хөөх; 3. болих, орхих, таягдан хаях; **~ сомнения** тээнэгэлзэхээ болих; 4. тусгах; **дерево ~ло длинную тень** модны урт сүүдэр тусав.

ОТБРО́С||Ы хаягдал, шаар, хог, орхидос; **яма для ~ов** хогийн нүх; **~ общества** нийгмийн орхидос.

ОТБЫВА́ТЬ одох, мордох, явах

ОТБЫ́||ТЬ 1. одох, мордох, явах; **делегаты ~ли в Москву** төлөөлөгчид Москва руу мордов; 2. хаах, дуусгах, өнгөрүүлэх; **~ военную службу** цэргийн алба хааж дуусгах; хаах.

ОТВА́Г||А чин зориг, аймшиггүй зориг, зүрх, зориг; **наградить за ~у** чин зориг гаргасан тул шагнах.

ОТВА́ДИТЬ гаргах, болиулах; **~ от курения** тамхинаас гаргах.

ОТВА́ЖИВАТЬ гаргах, болиулах.

ОТВА́ЖИВАТЬСЯ,

ОТВА́ЖИТЬСЯ, зүрхлэх, зориглох, зориг гаргах, зүрх хүрэх; **не отважился спросить** асуух зүрх хүрсэнгүй.

ОТВА́ЖНО аймшиггүй, зоригтой, зүрхтэй.

ОТВА́ЖНОСТЬ чин зориг, аймшиггүй зориг.

ОТВА́ЖНЫЙ аймшиггүй, зоригтой, зүрхтэй; **~ мореплаватель** аймшиггүй далайчин.

ОТВА́Л I 1. зайлуулах; 2. анжисны хомбого; 3. хаягдал; **наесться до ~а** хагартлаа идэх.

ОТВА́Л сэлж холдох.

ОТВА́ЛИВАТЬ I 1. зайлуулах, өнхрүүлэн зайлуулах, авч хаях; 2. пад хийтэл барих, пад хийтэл өгөх.

ОТВА́ЛИВАТЬ II зайлах, сэлж холдох, цааш самрах.

ОТВА́ЛИВАТЬСЯ ховхорч унах, хэмхэрч унах, ойчих.

ОТВАЛИ́ТЬ I 1. зайлуулах, өнхрүүлэн зайлуулах, авч хаях; **~ камень от входа** хаалганаас чулуу зайлуулах; 2. пад хийтэл барьчих, пад хийтэл өгчих.

ОТВАЛИ́ТЬ II зайлах, *сэлж холдох, цааш самрах*.

ОТВАЛИ́||ТЬСЯ ховхорч унах, хэмхэрч унах, ойчих; **штукатурка ~лась** туурганы шаваас ховхорч унав.

ОТВА́Р ханд, хорхог шөл, **мясной ~** махны хорхог шөл.

ОТВА́РИВАТЬ чанах, буцалгах, болгох.

ОТВА́РИВАТЬСЯ болох, бушлах, чанагдах.

ОТВАРИ́ТЬ чанах, буцалгах, болгох; **~ грибы** мөөг чанах.

ОТВАРИ́||ТЬСЯ болох, бушлах, чанагдах, **овощи ~лись** ногоо болжээ.

ОТВАРН||О́Й чанасан, буцалсан, буцалгасан; **~ая говядина** чанасан үхрийн мах, үхрийн бүхэл мах.

ОТВЕ́ДАТЬ 1. амсах; **~пирога** бялуунаас амсах; 2. амсах, эдлэх, үзэх.

ОТВЕ́ДЫВАТЬ 1. амсах, эдлэх, үзэх.

ОТВЕЗТИ́ 1. аваачих, хүргэх; ~ **письма на почту** захидал шууданд хүргэх; 2. зөөж зайлуулах, зөөж холдуулах; ~ **камень в сторону от дороги** замын чулууг зөөж зайлуулах.

ОТВЕРГА́ТЬ голох, хэрэгсэхгүй байх, хүлээж авахгүй байх.

ОТВЕРГА́ТЬСЯ гологдох, хэрэгсэгдэхгүй байх.

ОТВЕ́РГНУТЬ голох, хэрэгсэхгүй байх, хүлээж авахгүй байх; ~ **проект** төслийг хэрэгсэхгүй байх;

ОТВЕРДЕ́Л||ЫЙ хатуурсан, хатуу болсон; **~ая опухоль** хатуурсан хавдар.

ОТВЕРДЕ́НИЕ хатуурах, хатуурал.

ОТВЕРДЕ́ТЬ хатуурах, хатуу болох, горзойх.

ОТВЕ́РЖЕННЫЙ орхигдсон, хүний хүрээнээс хасагдсан,

ОТВЕРНУ́ТЬ 1. буруулах, буруу харуулах, цааш харуулах; ~ **лицо** нүүрээ буруулах; 2. эргүүлэх, шуух, сөхөх; ~ **полу шубы** дээлийн хормой эргүүлэх; 3. эргүүлэх, эргүүлэн онгойлгох; ~ **кран** гоожуур онгойлгох; 4. эргүүлж сулруулах, эргүүлж авах; ~ **винт** эрэг сулруулах, эрэг эргүүлэн авах; 5. тас мушгих, мулт татах; ~ **кукле ногу** хүүхэлдэйн хөл тас мушгих.

ОТВЕРНУ́||ТЬСЯ 1. буруу харах, цааш харах, нүүрээ буруулах; ~, **чтобы не видеть** харахгүйн тул буруу харах; 2. шуугдах, эргэх, сөхөгдөх; 3. онгойх; **кран ~лся** гоожуур онгойлоо; 4. эргэж сулрах, тарах, мултрах; 5. харилцаа тасрах.

ОТВЕ́РСТИ||Е нүх, амсар, сүв; **заделать ~я** нүх битүүлэх.

ОТВЕРТЕ́ТЬ 1. эргүүлж сулруулах, эргүүлэн авах; 2. тас мушгих, мулт татах.

ОТВЕРТЕ́ТЬСЯ I эргэж сулрах, мултрах.

ОТВЕРТЕ́ТЬСЯ II мултрах, салах, хагацах; ~ **от поручения** даалгавраас мултрах.

ОТВЁРТКА халив.

ОТВЁРТЫВАТЬ 1. буруулах, буруу харуулах, цааш харуулах; 2. шуух, эргүүлэх, сөхөх; 3. эргүүлэх; эргүүлэн онгойлгох; 4. эргүүлж сулруулах, эргүүлэн авах; 5. тас мушгих, мулт татах.

ОТВЕРТЫВАТЬСЯ 1. буруу харах, цааш харах, нүүрээ буруулах; 2. шуугдах, эргэх, сөхөгдөх; 3. онгойх; 4. эргэж сулрах, гарах, мултрах; 5. харилцаа тасрах.

ОТВЕ́С эгц хажуу; **по ~у** эгц хажуугаар.

ОТВЕ́СИТЬ жигнэж өгөх, чигнэж олгох; ~ **кило муки** килограм гурил жинлэж өгөх.

ОТВЕ́СНО эгц, чанх уруугаа, цэх доошоо.

ОТВЕ́СН||ЫЙ эгц, чанх уруу харсан, цэх доош малтсан; **~ая скала** эгц хад; **~ая черта** цэх доош татсан зураас.

ОТВЕСТИ́ 1. хүргэж өгөх, аваачих; 2. аваачих, хөтөлж очих; ~ **собеседника к окну** ярилцагчийгаа цонх руу хөтөлж очих; 3. зайлуулах, хажуу тийш нь болгох, өөр тийш нь татах; ~ **удар** цохих гэснийг зайлуулах; ~ **реку** голын урсгалыг өөр тийш болгох; 4. няцаах, хэрэгсэхгүй бол-гох, хасах; ~ **чью-либо кандидатуру** хүнийг нэр дэвшигсдийн жагсаалтаас хасах; 5. олгох, гаргаж өгөх, тасалж өгөх; ~ **участок под опытную станцию** туршлагын өртөөнд газар олгох; ~ **душу** санаагаа хэлж амрах; ~ **глаза** нүд хуурах, анхаарлыг өөр тийш татах.

ОТВЕ́Т 1. хариу; **получить ~ на письмо** захидлын хариу авах; **сказать что-нибудь в ~** хариуд нь нэг юм хэлэх; 2. хариуцлага; **призвать кого-либо к ~у** хүнийг хариуцлагад татах.

ОТВЕТВИ́ТЬ салаатуулах, салбарлуулах, салаалж гаргах.

ОТВЕТВИ́ТЬСЯ салаатах, салбарлах, салаалж таргах.

ОТВЕТВЛЕ́НИ||Е 1. салаа; **тополь даёт много ~й** улиангар олон салаа болж ургадаг; 2. салаа, татуур; ~ **канала** сувгийн татуур; 3. замын салаа, салбар зам; ~ **железной дороги** төмөр замын салаа; 4. салбар.

ОТВЕТВЛЯ́ТЬ салаатуулах, салбарлуулах, салаалж гаргах.

ОТВЕ́ТИТЬ 1. хариулах, хариу өгөх, хариу хэлэх; ~ **на вопрос** асуултанд хариулах; 2. хариуцах, хариуцлага хүлээх, хариуг даах; ~ **за свой поступок** хийсэн хэргээ хариуцах, хийсэн хэргийнхээ хариуцлагыг хүлээх.

ОТВЕ́ТН||ЫЙ хариу, хариу болгох; **~ое письмо** хариу захидал.

ОТВЕ́ТСТВЕННО хариуцлагатай.

ОТВЕ́ТСТВЕННОСТ||Ь 1. хариуцлагатай байх, хариуцлага; **нести ~** хариуцлага хүлээх, хариуцах; **привлечь кого-либо к ~и** хүнийг хариуцлагад татах; **возложить на кого-либо ~** хариуцлага хүлээлгэх, хариуцуулах; **уклониться от ~и** хариуцлагаас зайлсхийх; 2. хариуцлагатай зүйл, чухал зүйл.

ОТВЕ́ТСТВЕНН||ЫЙ 1. хариуцлагатай; ~ **редактор** хариуцлагатай эрхлэгч; 2. хариуцлагатай, чухал; **~ая работа** хариуцлагатай ажил; **~ое решение** чухал шийдвэр.

ОТВЕ́ТЧИК 1. хариуцагч, хэрэгтэн; 2. хариуцлага хүлээсэн хүн, хариуцагч.

ОТВЕЧА́ТЬ 1. хариулах, хариу өгөх, хариу хэлэх; 2. хариуцах хариуцлага, хүлээх, хариуг даах; 3. хариуцах; ~ **за порученное дело** даалгасан хэргийг хариуцах; 4. таарах, тохирох, нийлэх, ~ **чьим-либо интересам** хүний эрх ашигтай нийлэх.

ОТВЕ́ШИВАТЬ жигнэж өгөх, жигнэж олгох.

ОТВИ́ЛИВАТЬ зайлсхийх, мултрахыг оролдох

ОТВИЛЬНУ́ТЬ зайлсхийх, мултрахыг оролдох; ~ **от ответа** хариу өгөхөөс зайлсхийх.

ОТВИНТИ́ТЬ эргүүлж авах, эргүүлж гаргах; ~ **винт** эрэг эргүүлж гаргах.

ОТВИНТИ́ТЬСЯ мултрах, эргэж гарах.

ОТВИ́НЧИВАТЬ эргүүлж авах, эргүүлж гаргах.

ОТВИ́НЧИВАТЬСЯ мултрах, эргэж гарах.

ОТВИСА́ТЬ унжих, санжих, холхойх.

ОТВИ́СЛ||ЫЙ унжуу, санжуу, холхгор, унжсан, санжсан, холхойсон; **~ые губы** унжуу уруул.

ОТВИ́СНУТЬ унжих, санжих, холхойх; **щеки отвисли** хацар нь унжсан.

ОТВЛЕКА́ТЬ I самууруулах, алмайруулах, саатуулах, алгасуулах.

ОТВЛЕКА́ТЬ II хийсвэрлэх, хийсвэрлэн үзэх.

ОТВЛЕКА́ТЬСЯ самуурах, алмайрах, саатах, алгасах.

ОТВЛЕЧЕ́НИЕ I 1. самууруулах, алмайруулах, саатуулах; 2. самууруулалт, алмайруулалт, саатуулалт.

ОТВЛЕЧЕ́НИЕ II хийсвэрлэх, хийсвэрлэл.

ОТВЛЕЧЁННО хийсвэрлэн, хийсвэр, хийсвэрээр; **рассуждать ~** хийсвэр ярих.

ОТВЛЕЧЁННОСТЬ хийсвэр байх, хийсвэр, чанар.

ОТВЛЕЧЁНН||ЫЙ 1. хийсвэр; **~ое понятие** хийсвэр ухагдахуун; 2. хийсвэр, бодит байдлаас тасархай; ~ **разговор** хийсвэр яриа; **~ое число** хийсвэр тоо.

ОТВЛЕ́ЧЬ I самууруулах, алмайруулах, саатуулах, алгасуулах; ~ **внимание** анхаарал самууруулах, алмайруулах.

ОТВЛЕ́ЧЬ II хийсвэрлэх, хийсвэрлэн үзэх.

ОТВЛЕ́ЧЬСЯ самуурах, алмайрах, саатах, алгасах; ~ **на минуту от работы** ажиллаж байгаад түр саатах.

ОТВО́Д 1. олгох; ~ **земель** газар олгох; 2. (урсгал) өөр тийш болгох, өөр тийш татах; 3. зайлуулах, хасах, татгалзах, эсэргүүцэх; **заявить ~ против кого-либо** хүнийг эсэргүүцэн мэдүүлэх; **для ~а глаз** анхаарлыг нь зайлуулах гэж нүд хуурахын тул.

ОТВОДИ́ТЬ 1. хүргэж өгөх, аваачих; 2. хөтөлж очих, аваачих; 3. зайлуулах, хажуу тийш болгох, өөр тийш татах; 4. няцаах, хэрэгсэхгүй болгох, хасах; 5. олгох, гаргаж өгөх, тасалж өгөх.

ОТВОДНО́Й ~ **канал** татах суваг.
ОТВОДЯ́ЩИЙ гарах; ~ **патрубок** гарах бүдүүн хоолой.
ОТВОЕВА́ТЬ 1. байлдан авах, дайтан эргүүлэх; ~ **свою землю у захватчиков** эзлэгдсэн газраа байлдан авах; 2. дайснаа дарах, дайтаж дуусах.
ОТВОЕВА́ТЬСЯ дайснаа дарах, байлдаж дуусах.
ОТВОЁВЫВАТЬ 1. байлдан авах, дайтан эргүүлэх; 2. дайснаа дарах, дайтаж дуусах.
ОТВОЗИ́ТЬ 1. аваачих, хүргэх; 2. зөөж зайлуулах, зөөж холдуулах.
ОТВОРА́ЧИВАТЬ 1. буруулах, буруу харуулах, цааш харуулах; 2. шуух, эргүүлэх, сөхөх.
ОТВОРА́ЧИВАТЬСЯ 1. буруу харах, цааш харах, нүүрээ буруулах; 2. шуугдах, эргэх, сөхөгдөх.
ОТВОРИ́ТЬ нээх, тайлах, онгойлгох; ~ **дверь** хаалга тайлах.
ОТВОРИ́||ТЬСЯ нээгдэх, тайлагдах, онгойх; **окно ~лось** цонх онгойв.
ОТВОРО́Т эргэмэл энгэр, эргэмэл түрий, нудрага; **сапоги с ~ами** эргэмэл түрийтэй гутал.
ОТВОРЯ́ТЬ нээх, тайлах, онгойлгох.
ОТВОРЯ́ТЬСЯ нээгдэх, тайлагдах, онгойх.
ОТВРАТИ́ТЕЛЬНО *ой гутмаар, зэвүүрхмээр, дур гутам, үзэшгүй муухай.*
ОТВРАТИ́ТЕЛЬНЫЙ ой гутмаар зэвүүрхэм, жигшүүртэй, дур гутам, үзэшгүй, муухай, булай; ~ **запах** ой гутмаар үнэр; ~ **поступок** булай явдал.
ОТВРАТИ́ТЬ зайлуулах, хариулах, тойруулах, далдруулах; ~ **беду** гай далдруулах.
ОТВРАЩА́ТЬ зайлуулах, хариулах, тойруулах, далдруулах
ОТВРАЩЕ́НИЕ жигших, зэвүүрхэх, жигшүүр, зэвүүрхэл; **испытывать ~ к кому- чему-либо** хүн юмыг жигших, жигшүүр төрөх.
ОТВЫКА́ТЬ хөндийрөх, гарах.
ОТВЫ́КНУТЬ хөндийрөх, гарах; ~ **от дома** гэр бүлээсээ хөндийрөх; ~ **от курения** тамхинаас гарах.
ОТВЯЗА́ТЬ тайлах, тавих; ~ **лошадь** морь тавих.
ОТВЯЗА́||ТЬСЯ 1. тайлагдах, тайлах, алдуурах; **веревка ~лась** татлага тайлагдав; 2. салах, мултрах, зайлах; **еле ~лся от назойливого человека** хаширтай хүнээс арай гэж саллаа.
ОТВЯ́ЗЫВАТЬ тайлах, тавих.
ОТВЯ́ЗЫВАТЬСЯ салах, мултрах, зайлах.
ОТГАДА́ТЬ таах, тайлах, тааварлах; ~ **загадку** оньсого тайлах.
ОТГА́ДК||А таавар, тайлбар; **найти ~у** тайлбарыг нь олох.
ОТГА́ДЫВАТЬ таах, тайлах, тааварлах.
ОТГА́ДЫВАТЬСЯ таагдах, тайлагдах, тааварлагдах.
ОТГИБА́ТЬ 1. тэнийлгэх; 2. нугалах; 3. шамлах, эргүүлэх.
ОТГИБА́ТЬСЯ тэнийх.
ОТГЛАГО́ЛЬН||ЫЙ үйл үгээс үүссэн; **~ое существительное** үйл үгээс үүссэн жинхэнэ нэр.
ОТГЛА́ДИТЬ индүүдэх, илүүрдэх.
ОТГЛА́ЖИВАТЬ индүүдэх, илүүрдэх; ~ **швы** оёдлыг нь илүүрдэх, оёдлыг нь индүүдэх.
ОТГНИ́ТЬ өмхөрч унах, ялзран ойчих.
ОТГОВА́РИВАТЬ ятган болиулах, хориглох, хорих.
ОТГОВА́РИВАТЬСЯ шалтаг заах, шалтаглах.
ОТГОВОРИ́ТЬ ятган болиулах, хориглох, хорих; ~ **кого-либо от поездки** хүний явахыг ятган болиулах.
ОТГОВОРИ́ТЬСЯ шалтаг заах, шалтаглах; ~ **нездоровьем** өвчтэй гэж шалтаглах.
ОТГОВО́РКА шалтаг, шалтаг заах; **пустая ~** хоосон шалтаг.
ОТГОЛО́СОК цуурай, чимээ; ~ **крика** хашгирсны цуурай; ~ **событий** үйл явдлын цуурай.
ОТГО́Н 1. нэрэх, нэрэлт; 2. нэрдэс, нэрсэн юм; 3. билчээрлүүлэх.
ОТГО́НКА *1. нэрэх, нэрлэг; 2. нэрдэс, нэрсэн юм.*
ОТГО́ННЫЙ билчээрийн, билчээрлүүлэх; **~ое животноводство** билчээрийн мал аж ахуй.
ОТГОНЯ́ТЬ I үргээх, хөөх, үлдэх, хөөн зайлуулах, үлдэн хөөх.
ОТГОНЯ́ТЬ II нэрэх, нэрж гаргах.
ОТГОРА́ЖИВАТЬ хаах, халхлах, хаших.
ОТГОРА́ЖИВАТЬСЯ 1. хаах, халхлах, хаших; 2. тасрах, холдох.
ОТГОРА́ТЬ шатаж дуусах, улайхаа болих.
ОТГОРЕ́||ТЬ 1. шатаж дуусах, улайхаа болих; **закат ~л** нар жаргаж тэнгэрийн хаяа улайхаа болив; 2. түлэгдэж ойчих; **сучок ~л** *гишүү түлэгдэж ойчив.*
ОТГОРОДИ́ТЬ хаах, халхлах, хаших.
ОТГОРОДИ́ТЬСЯ 1. хаах, халхлах, хаших; 2. тасрах, холдох; ~ **от своих старых друзей** хуучин нөхдөөсөө тасрах.
ОТГРАНИ́ЧИТЬ, ялгах, ялган салгах, зааглах; ~ **одно понятие от другого** нэг ухагдахууныг нөгөөгөөс нь ялган салгах.
ОТГРЕБА́ТЬ I хамах, хаман зайлуулах.
ОТГРЕБА́ТЬ II сэлүүрдэн зайлах, сэлүүрдэн холдох.
ОТГРЕМЕ́||ТЬ нижигнэхээ болих, нижигнэн дуусах; **гром ~л** тэнгэр нижигнэхээ болив; **~ли бои** тулалдаан нижигнэж дуусав.
ОТГРЕСТИ́ I хамах, хамж зайлуулах.
ОТГРЕСТИ́ II сэлүүрдэн зайлах, сэлүүрдэн холдох; ~ **от берега** эргээс сэлүүрдэн холдох.
ОТГРУЖА́ТЬ,
ОТГРУЗИ́ТЬ ачиж илгээх, тээж явуулах; ~ **уголь** нүүрс ачиж илгээх.
ОТГРУ́ЗКА ачиж илгээх, тээж явуулах, ачих, тээх ачилт, тээлт.
ОТГРЫЗА́ТЬ,
ОТГРЫ́ЗТЬ тас хазах, тас химлэх, тас мэрэх.
ОТГУ́Л нөхөн амрах, нөхсөн амралт; **получить ~** нөхөн амрах.
ОТГУ́ЛИВАТЬ,
ОТГУЛЯ́ТЬ 1. зугаалж дуусах, амарч дуусах; 2. нөхөн амрах; ~ **день** нэг өдөр нөхөн амрах.
ОТДАВА́ТЬ I 1. үнэртэх, үнэр гарах, амттай байх; 2. маягтай байх, янзтай байх, өнгөтэй байх, үнэртэх, үнэртэй *байх;* **это отдаёт стариной** үүнээс хуучин цаг үнэртэж байна.
ОТДАВА́ТЬ II 1. эргүүлж өгөх, буцааж өгөх, эргүүлэх; 2. өгөх, зориулах; 3. хүнд өгөх, хадамд өгөх; 4. оруулах, шилжүүлэх, өгөх; 5. өгөх, худалдах, зарах; 6. тийрэх; 7. суллах, тайлах, хаях.
ОТДАВА́ТЬСЯ 1. бууж өгөх, биеэ тушаах, эрхэнд орох; 2. биеэ зориулах, шунаг оролдох; 3. цуурайтах, дууриалах, харвах, *нөлөөлөх.*
ОТДАВИ́ТЬ,
ОТДА́ВЛИВАТЬ хавчих, гишгэх; ~ **кому-либо ногу** хүний хөл гишгэх.
ОТДАЛЕ́НИ||Е 1. холдуулах, хол болгох, холдох, хол болох; 2. хол, алс хол газар; **держать в ~и** хол байлгах.
ОТДАЛЁННО 1. алс хол; 2. ялигүй, тун өчүүхэн.
ОТДАЛЁННОСТЬ алс байх, алс хол байх, таслагдсан байх, алслагдах; ~ **от центра** төвөөс алслагдах.
ОТДАЛЁНН||ЫЙ 1. алсын, алс холын, алслагдсан, алсалсан; ~ **район** алслагдсан нутаг; 2. өнө, хол, алс; **~ое будущее** алс ирээдүй; 3. холын; 4. ялигүй, холын; **~ое сходство** ялигүй төсөө, холын төсөө.
ОТДАЛИ́ТЬ 1. холдуулах, хол болгох, цаашлуулах; ~ **предмет от глаз** нүднээс юм холдуулах; 2. *хойшлуулах, цаашлуулах,* холдуулах; ~ **разлуку** салах цагийг хойшлуулах;

3. хөндийрүүлэх, холдуулах; ~ **сына от товарищей** хүүгээ нөхдөөс нь холдуулах.

ОТДАЛИ́ТЬСЯ 1. холдох, хол болох, цаашлах; ~ **от берега** эргээс холдох; 2. хойшлох, цаашлах, холдох; 3. хөндийрөх; холдох; ~ **от старых друзей** хуучин найз нараасаа хөндийрөх; 4. хазайх; ~ **от темы разговора** ярианыхаа сэдвээс хазайх.

ОТДАЛЯ́ТЬ 1. холдуулах, хол болгох, цаашлуулах; 2. хойшлуулах, холдуулах, цаашлуулах; 3. хөндийрүүлэх, холдуулах.

ОТДАЛЯ́ТЬСЯ 1. холдох, хол болох, цаашлах; 2. хойшлох, цаашлах, холдох; 3. хөндийрөх, холдох.

ОТДА́||ТЬ 1. эргүүлж өгөх, буцааж өгөх, эргүүлэх; ~ **долг** өрөө эргүүлж өгөх; 2. өгөх, зориулах; ~ **жизнь за свободу и независимость родины** эх орныхоо эрх чөлөө тусгаар тогтнолд амь насаа зориулах; ~ **все силы науке** шинжлэх ухаанд бүх хүчээ зориулах; 3. хүнд өгөх, хадамд өгөх; ~ **за старика** өвгөн хүнд өгөх; 4. оруулах, шилжүүлэх, өгөх; ~ **книгу в переплет** хавтас хийлгэхээр ном шилжүүлэх; ~ **ребёнка в детский сад** хүүхэд цэцэрлэгт оруулах; 5. өгөх, худалдах, зарах; ~ **за бесценок** зүгээр шахуу өгөх; 6. тийрэх; **ружьё ~ло в плечо** буу мөр лүү тийрэв; 7. суллах, тайлах, хаях; ~ **приказ** тушаал өгөх; ~ **честь** ёслох; ~ **себе отчет в чем-либо** ухаарч авах.

ОТДА́ТЬСЯ 1. бууж өгөх, биеэ тушаах, эрхэнд орох; ~ **врагу** дайсанд бууж өгөх, дайсны эрхэнд орох; ~ **на волю победителей** ялагчдын дур зоргонд автах; 2. биеэ зориулах, шунаг оролдох; ~ **музыке** хөгжим шунаг оролдох; 3. цуурайтах, харвах, нөлөөлөх.

ОТДА́ЧА 1. эргүүлж өгөх; 2. тийрэх, тийрэлт; 3. ашигт үйл; 4. өгөмж, өгөөж.

ОТДЕЖУ́РИТЬ 1. жижүүрлэж дуусах, жижүүр хийж дуусах; 2. жижүүрлэх, жижүүр хийх.

ОТДЕ́Л 1. хэлтэс, ~ **кадров** боловсон хүчний хэлтэс; 2. бүлэг; **библиографический ~ в журнале** сэтгүүлийн ном зүйн бүлэг.

ОТДЕ́ЛАТЬ 1. янзалж дуусах, засч дуусах, боловсруулж дуусах; ~ **квартиру** байр янзалж дуусах; 2. янзлах, чимэглэх, чимэх; ~ **шляпу** бүрх малгайгаа янзлах.

ОТДЕ́ЛАТЬСЯ 1. гарах, салах, мултрах; **от него легко не ~** түүнээс амар салахгүй; 2. төдийхнөөр өнгөрөх, ангижрах; ~ **испугом** айсан төдийхнөөр өнгөрөх.

ОТДЕЛЕ́НИ||Е I 1. салгах, тусгаарлах; 2. ялгадас, гоождос, гардас; **гнойные ~я** идээ ялгадас, гоожсон идээ.

ОТДЕЛЕ́НИ||Е II 1. тасаг, хэлтэс, анги, салбар; **хирургическое** ~ мэс заслын тасаг; ~ **милиции** цагдан сэргийлэхийн тасаг; 2. тасаг, **командир ~я** тасгийн дарга.

ОТДЕЛИ́ТЬ 1. салгах, ялгах; ~ **мясо от кости** яснаас махыг нь салгах, шулах; 2. тусгаарлах, гаргаж өгөх; ~ **заразного больного** халдварт өвчтөнийг тусгаарлах; 3. тусгаарлах, тасалж өгөх.

ОТДЕЛИ́ТЬСЯ 1. салах, ялгарах, тасрах; ~ **от толпы** олноос тасран гарах; 2. тусгаарлах, тусгаар болох.

ОТДЕ́ЛКА 1. янзалж дуусах, засах; 2. засал, янзлал; **кружевная ~ на платье** хувцасны сүлжмэг засал.

ОТДЕ́ЛЫВАТЬ 1. янзалж дуусах, засч дуусах, боловсруулж дуусах; 2. янзлах, чимэглэх, чимэх.

ОТДЕ́ЛЫВАТЬСЯ 1. гарах, салах, мултрах; 2. төдийхнөөр өнгөрөх, ангижрах; 3. янзлагдах, чимэглэгдэх.

ОТДЕ́ЛЬНО тусгаар, тусгай, амиараа, салангид, ангидаа; **он живёт ~ от родных** тэр хүн төрөл төрөгсдөөсөө тусдаа амьдардаг.

ОТДЕ́ЛЬНОСТ||Ь в ~и тус тусдаа, хувь хувьдаа; **каждому в ~и** тус тусад нь, хүн нэг бүрд.

ОТДЕ́ЛЬН||ЫЙ 1. тусгаар, тусгай анги, саланги; **~ая квартира** тусгаар байр; 2. **зарим, ганц нэг, ~ые лица** ганц нэг хүн.

ОТДЕЛЯ́||ТЬ 1. салгах, ялгах; 2. тусгаарлах, гаргаж өгөх; 3. тусгаарлах, тасалж өгөх; 4. зааг болох, зааг дээр байх, хооронд байх; **река ~ет один район от другого** тэр гол хоёр нутгийн зааг болно.

ОТДЕ́ЛЯТЬСЯ 1. салах, ялгарах, тасрах; 2. тусгаарлах, тусгаар болох; 3. салгагдах, тусгаарлагдах.

ОТДЁРГИВАТЬ угз татах, угзран нээх.

ОТДЁРНУТЬ угз татах, угзран нээх; ~ **руку** гараа угз татах; ~ **занавеску** хөшиг угзран нээх.

ОТДИРА́ТЬ 1. хуулах, хуу татах, ховхлох, ховх татах, тас татах, таслах; 2. чангаах, тас шавхрах.

ОТДИРА́ТЬСЯ хуурах, ховхрох.

ОТДОХНУ́ТЬ амрах, амсхийх; ~ **после работы** ажлын дараа амрах, ажиллаад амсхийх.

ОТДУ́ШИНА хий татах нүх.

О́ТДЫХ амрах, амралт; **право на** ~ амрах эрх; **день ~а** амралтын өдөр; **дом ~а** амралтын газар, **не зная ~а** амрахгүй.

ОТДЫХА́ТЬ амрах.

ОТДЫША́ТЬСЯ амьсгаа авах, амьсгаа дарах.

ОТЁК хаван, хавагнах, сэлхрэх, сэлхрэх, хөөх.

ОТЕКА́ТЬ 1. хавдах, хавагнах, сэлхрэх, хөөх; 2. урсах, хайлах.

ОТЁЛ тугаллах, тугаллалт.

ОТЕЛИ́ТЬСЯ тугаллах.

ОТЁЛЬ зочид буудал.

ОТЕПЛЕ́НИЕ дулаалах, дулаалалт.

ОТЕПЛИ́ТЬ дулаалах.

ОТЕПЛЯ́ТЬ дулаалах.

ОТЕСА́ТЬ хангинуурдан засах, өөлөх.

ОТЕ́Ц эцэг, аав; **родной** ~ төрсөн эцэг, **названный** ~ хуурай эцэг, өргөсөн эцэг; 2. **отцы** өвөг дээдэс; **наши отцы** бидний өвөг дээдэс.

ОТЕ́ЧЕСКИ эцэг ёсоор; ~ **нежный** эцэг ёсоор энхрийлдэг.

ОТЕ́ЧЕСК||ИЙ эцгийн, эцэг ёсны; **~ая забота** эцгийн халамж.

ОТЕ́ЧЕСТВЕНН||ЫЙ эх орны, эцэг орны, өөрийн орны, манай орны, тус орны; **~ая промышленность** эх орны үйлдвэр, манай орны үйлдвэр; **товары ~ого производства** эх орны үйлдвэрийн бараа, өөрийн орны үйлдвэрийн бараа; **Великая Отечественная война** Агуу Их Эх орны дайн.

ОТЕ́ЧЕСТВ||О эх орон, эцэг орон; **любовь к ~у** эх орноо хайрлах.

ОТЕ́ЧЬ 1. хавдах, хавагнах, сэлхрэх, хөөх; **ноги отекли** хөл хавагнав; 2. урсах, хайлах.

ОТЖА́ТЬ I 1. мушгих, базах; ~ **бельё** угааж базах, дотуур хувцас мушгих; 2. шахах.

ОТЖА́ТЬ II хадаж дуусах.

ОТЖИВА́ТЬ 1. хөгшрөх, өвгөрөх, өнгөрөх, өнгөрөөх, барах; 2. хуучрах, хэргээс гарах; үеэ өнгөрөөх.

ОТЖИМА́ТЬ 1. мушгих, базах; 2. шахах.

ОТЖИНА́ТЬ хадаж дуусах.

ОТЖИ́||ТЬ 1. хөгшрөх, өвгөрөх, өнгөрөх, өнгөрөөх, барах; ~ **свой век** насаа барах, насаа өнгөрөөх; 2. хуучрах, хэргээс гарах, үеэ өнгөрөөх; **обычай ~л** энэ заншил хуучирчээ.

ОТЗВОНИ́ТЬ дуггараж дуусах.

О́ТЗВУК 1. дууриа, цуурай; 2. чимээ, доргио; ~ **взрывов** дэлбэрэх чимээ; 3. ул мөр, цуурай; **~и прошлого** өнгөрсөн үеийн ул мөр, урьдын цагийн цуурай.

ОТЗВУЧА́ТЬ дуугарахаа болих, цуурай тасрах, чимээгүй болох.

О́ТЗЫВ 1. татах; ~ **посла** элчин сайдыг татах; 2. үнэлэлт, санал; ~ **о книге** номын үнэлэлт.

ОТЗЫВА́ТЬ 1. дуудах; 2. татах.

ОТЗЫВА́ТЬСЯ 1. хариу өгөх, хариулах, чимээ гарах, аа гэх; 2. үнэлэлт өгөх, үнэлэх, саналаа хэлэх, гэх; 3. болох, байх, нөлөөлөх.

ОТЗЫ́ВЧИВОСТЬ уриалагхан зан, өр зөөлөн, ханш.

ОТЗЫ́ВЧИВЫЙ уриалаг, өр нимгэн, ханш сайтай; ~ **человек** уриалаг хүн.

ОТКА́З 1. үл зөвшөөрөх, татгалзах, үгүй гэх; **получить** ~ татгалзсан хариу авах; ~ **на просьбу** гуйхад үгүй гэх; 2. зогсолт, эвдрэл; **машина работает без ~а** машин эвдрэлгүй ажиллаж байна; **до ~а** пиг дүүрэн, багтаж ядтал, чинээнд нь тултал; **повернуть до ~а** *чинээнд нь тултал эргүүлэх.*

ОТКАЗА́||ТЬ 1. үл зөвшөөрөх, татгалзах, үгүй гэх; ~ **наотрез** эрс татгалзах, огт үл зөвшөөрөх; 2. -гүй гэх, -гүй байх, байх, болих; **ему нельзя ~ в таланте** түүнийг билэгтүй гэх аргагүй; 3. халах, хөөх; 4. гэрээслэн өгөх ~ **имущество** хөрөнгө гэрээслэн өгөх; 5. зогсох, эвдрэх, ажиллахаа байх; **мотор ~л** хөдөлгүүр ажиллахаа байв.

ОТКАЗА́ТЬСЯ 1. татгалзах, хүлээхгүй байх, цээрлэх, -гүй гэх, байх, болих; ~ **от поездки** явахаас татгалзах; 2. буцах, мэлзэх; ~ **от своей подписи** гарынхаа үсгийг биш гэж мэлзэх.

ОТКА́ЗЫВАТЬ 1. үл зөвшөөрөх, татгалзах, үгүй гэх; 2. -гүй гэх, -гүй байх, байх, болих; 3. халах, хөөх; 4. гэрээслэн өгөх, өвлүүлэх; 5. зогсох, эвдрэх, ажиллахаа болих.

ОТКА́ЗЫВА́ТЬСЯ 1. татгалзах, хулээхгүй байх, цээрлэх, -гүй гэх, байх, болих; 2. буцах, мэлзэх; 3. арга алга байх, аргаа барах; **я ~юсь понимать его слова** түүний үгийг ойлгох арга алга.

ОТКА́ЛЫВАТЬ I 1. хэлтлэх, эмтлэх, түгдлэх; 2. салгаж авах, сугалж авах.

ОТКА́ЛЫВАТЬ II хэлэх, хийх.

ОТКА́ЛЫВАТЬСЯ 1. хэлтрэх, эмтрэх, түгдрэх; 2. тасрах, салах, тусгаарлах; 2. хэлтлэгдэх, эмтлэгдэх, түгдлэгдэх.

ОТКА́ПЫВАТЬ 1. малтаж гаргах, ухаж гаргах, малтаж олох; 2. эрж олох, олж авах.

ОТКА́РМЛИВАНИЕ бордох, шахах, таргалуулах, бордолт, шахалт, таргалуулалт.

ОТКА́РМЛИВАТЬ бордох, шахах, таргалуулах.

ОТКА́РМЛИВАТЬСЯ таргалах, өөхлөх.

ОТКА́Т 1. эргээд өнхрөх; 2. *разг.* хахууль.

ОТКАТИ́ТЬ түлхэж өнхрүүлэх, мухриулан зайлуулах; ~ **колесо** дугуй түлхэж өнхрүүлэх.

ОТКАТИ́||ТЬСЯ 1. цаашаа өнхрөх, мухрин зайлах; **бревно ~лось в сторону** *гуалин хажуу тийш өнхрөв*; 2. бушуу зайлах, бушуу ухирах, сандран ухиран гарах.

ОТКА́ТКА зөөх; **механическая ~ угля в шахтах** уурхайн нүүрсийг механизмын хүчээр зөөх.

ОТКА́ТЧИК зөөгч, ~ **угля** нүүрс зөөгч.

ОТКА́ТЫВАТЬ түлхэж, өнхрүүлэх, мухриулан зайлуулах.

ОТКА́ЗЫВАТЬСЯ 1. цаашаа өнхрөх, мухрин зайлах; 2. бушуу зайлах, бушуу ухирах, сандран ухиран гарах.

ОТКАЧА́ТЬ I хөөрөгдөж гаргах; ~ **воду** ус хөөрөгдөж гаргах.

ОТКАЧА́ТЬ II сэхээх; ~ **утопленника** усанд унасан хүнийг сэхээх.

ОТКА́ЧИВАТЬ I хөөрөгдөж гаргах.

ОТКА́ЧИВАТЬ II муйхруулан сэхээх.

ОТКА́ШЛИВАТЬСЯ ханиаж нулимах.

ОТКА́ШЛЯТЬСЯ 1. ханиаж нулимах; 2. хоолойгоо засах.

ОТКИ́ДЫВАТЬ 1. авч хаях, цааш чулуудах, шидэх; 2. буулгах, задгай тавих, сөхөх; 3. гэдийлгэх, гэдрэг болгох.

ОТКИ́ДЫВАТЬСЯ 1. гэдрэг налах, налж суух; 2. чулуудагдах, шидэгдэх, сөхөгдөх.

ОТКИ́НУТЬ 1. авч хаях, цааш нь чулуудах, шидэх; ~ **камень в сторону** чулуу хажуу тийш нь шидэх; 2. буулгах, задгай тавих, сөхөх; ~ **воротник шубы** *дээлийнхээ захыг буулгах*; 3. гэдийлгэх, гэдрэг болгох; ~ **голову** толгойгоо гэдийлгэх.

ОТКИ́НУТЬСЯ 1. гэдрэг налах, налж суух; ~ **на спинку стула** сандлын түшлэг налж суух; 2. чулуудагдах, шидэгдэх; сөхөгдөх.

ОТКЛА́ДЫВАТЬ 1. хажуу тийш нь тавих, хойш нь болгох, тусгай тавих; 2. хадгалах, хуримтлуулах; 3. цацах, хаях, орхих, баах; 4. хойшлуулах, хойш тавих.

ОТКЛА́ДЫВА||ТЬСЯ хойшлогдох, хойшлох, хойшлуулагдах; **заседание ~ется** хурал хойшлогдов.

ОТКЛА́НИВАТЬСЯ,

ОТКАЛА́НЯТЬСЯ ёс хийх, мэхэсхийгээд гарах.

ОТКЛЕ́ИВАТЬ хуулах, ховхлох, салгаж авах.

ОТКЛЕ́ИВАТЬСЯ хуурах, ховхрох.

ОТКЛЕ́ИТЬ хуулах, ховхлох, салгаж авах; ~ **марку с конверта** дугтуйнаас марк хуулах.

ОТКЛЕ́И||ТЬСЯ хуурах, ховхрох; **марка ~лась** марк хуурав.

ОТКЛЕПА́ТЬ ховхлох, ховх татах, хуу татах, ~ **заклёпку** тав хуу татах.

О́ТКЛИК 1. хариу, аа гэх; 2. талархал; **призыв нашёл горячий** ~ уриа халуун талархал хүлээв, уриаг халуунаар хүлээн авав; 3. үнэлэлт; **благоприятные ~и** тааламжтай үнэлэлт; 4. тусгал, ор мөр; **~и прошлого времени** урьд цагийн ор мөр.

ОТКЛИКА́ТЬСЯ хариу дугарах, аа гэх, дугарах.

ОТКЛИ́КНУТЬСЯ 1. хариу дугарах, аа гэх, дугарах; ~ **на зов** дуудахад аа гэх; 2. хариулах, саналаа хэлэх; ~ **на призыв** уриалгыг хариулах.

ОТКЛОНЕ́НИЕ 1. гажих, хэлбийх, хазайх, гажилт, хэлбийлт, хазайлт; ~ **стрелки** зүү хэлбийх, хажуу тийш болох; 2. хэрэгсэхгүй болгох, татгалзах; ~ **предложений** саналыг хэрэгсэхгүй болгох, ~ **средне арифметической величины** арифметикийн дунджаас хазайх..

ОТКЛОНИ́ТЬ 1. гажаах, хэлбийлгэх, хазайлгах, зайлуулах; 2. *хэрэгсэхгүй болгох, татгалзах, эс зөвшөөрөх.*

ОТКЛОНИ́||ТЬСЯ 1. гажих, хэлбийх, хазайх, зайлах; **стрелка ~лась** зүү хэлбийв; 2. хадуурах, хазайх; ~ **от темы разговора** ярианыхаа сэдвээс хадуурах.

ОТКЛОНИ́ТЬ 1. гажаах, хэлбийлгэх, хазайлгах, зайлуулах; 2. хэрэгсэхгүй болгох, татгалзах, эс зөвшөөрөх.

ОТКЛОНЯ́ТЬСЯ 1. гажих, хэлбийх, хазайх, зайлах; 2. хадуурах, хазайх.

ОТКЛЮЧА́ТЬ таслах, салгах.

ОТКЛЮЧИ́ТЬ таслах, салгах.

ОТКОВА́ТЬ 1. тахалж дуусах; 2. давтаж хийх; ~ **подкову** тах давтаж хийх.

ОТКО́ВЫВАТЬ 1. тахалж дуусах; 2. давтаж хийх.

ОТКОВЫ́РИВАТЬ,

ОТКОВЫРЯ́ТЬ төнхөж унагах, ухаж гаргах; ~ **штукатурку** шаваас төнхөж унагах.

ОТКОЛА́ЧИВАТЬ цохиж салгах, ховх цохих.

ОТКОЛОТИ́ТЬ *разг.* 1. цохиж салгах, ховх цохих; 2. зад зодох, хэмх занчих.

ОТКОЛО́ТЬ I 1. хэлтлэх, эмтлэх, түгдлэх; ~ **глыбу льда** бөөн мөс хэлтэлж авах; 2. салгаж авах, сугалж авах; ~ **булавку** тавтай зүү сугалж авах.

ОТКОЛО́ТЬ II хэлчих, хийчхэх; ~ **словцо** хачин үг хэлчих.

ОТКОЛО́ТЬСЯ 1. хэлтрэх, эмтрэх, түгдрэх; 2. тасрах, салах, тусгаарлах; ~ **от товарищей** нөхдөөсөө тасрах.

ОТКОМАНДИРОВА́ТЬ,

ОТКОМАНДИРО́ВЫВАТЬ томилон явуулах, томилон илгээх, шилжүүлэх.

ОТКОМАНДИРО́ВЫВАТЬСЯ томилогдон явах, шилжих, илгээгдэх.

ОТКОПА́ТЬ 1. малтаж гаргах, ухаж гаргах, малтаж олох; 2. эрж олох, олж өгөх; ~ **интересную книгу** сонин ном олж авах.

ОТКО́РМ бордох, шахах, таргалуулах, бордолт, шахалт, таргалуулалт; ~ **скота** мал бордох.

ОТКОРМИ́ТЬ бордох, шахах, таргалуулах; ~ **поросёнка** гахайн торой бордох.

ОТКО́РМЛЕННЫЙ бордсон, шахсан бордмол, шахмал; ~ **бык** шахмал шар.

ОТКО́С хэвгий газар, хажуу, ташлуур; ~ **холма** болдгийн хажуу; **пустить под ~ поезд** галт тэрэг замын ташлуур руу унагах.

ОТКОСИ́ТЬ хойш суух, бултах; ~ **от армии** цэргээс бултах.

ОТКРЕПИ́ТЬ 1. салгах, тайлах, суллах; ~ **лодку** завийн дөрийг тайлах; 2. бүртгэлээс хасах.

ОТКРЕПИ́ТЬСЯ 1. салах, тайлах, сулрах; 2. бүртгэлээс хасагдах.

ОТКРЕПЛЕ́НИЕ 1. салгах, тайлах, суллах; 2. бүртгэлээс хасах, бүртгэлээс хасагдах.

ОТКРЕПЛЯ́ТЬ 1. салгах, тайлах, суллах; 2. бүртгэлээс хасах.

ОТКРЕПЛЯ́ТЬСЯ 1. салгах, тайлдах, сулрах; 2. бүртгэлээс хасагдах.

ОТКРОВЕ́НИЕ далдыг мэдэх, нүдийг нээх; **это полное ~ для всех** энэ нь бүгдийн нүдийг нээлээ.

ОТКРОВЕ́ННИЧАТЬ ний нуугүй ярилцах, илэн далангүй ярих.

ОТКРОВЕ́ННО ний нуугүй, илэн далангүй, шууд; ~ **говоря** ний нуугүй хэлэхэд.

ОТКРОВЕ́ННОСТ||Ь ний нуугүй байх, илэн далангүй байх; **излишние ~и** хэт илэн далангүй байх.

ОТКРОВЕ́НН||ЫЙ 1. ний нуугүй, илэн далангүй; ~ **разговор** илэн далангүй яриа; 2. илэрхий, ил, нууж хаагаагүй; ~**ое бесстыдство** илэрхий ичгүүргүй явдал.

ОТКРОМСА́ТЬ хэрчих, зүсэх, тас огтлох, тас хайчлах.

ОТКРУТИ́ТЬ мушгиж задлах, эргүүлэн тайлах, эргүүлж гаргах, нээх; ~ **кран** гоожуур эргүүлж нээх.

ОТКРУТИ́ТЬСЯ задрах, эргэж гарах, мултрах.

ОТКРУ́ЧИВАТЬ мушгиж задлах, эргүүлэн тайлах, эргүүлж гаргах, нээх.

ОТКРУ́ЧИВАТЬСЯ, задрах, эргэж гарах, мултрах.

ОТКРЫВА́ТЬ 1. нээх, онгойлгох, тайлах; 2. нээх, задгай тавих, сул орхих; 3. ярах, задгай тавих, нүцгэлэх; 4. дэлгэх, нээх; 5. тавих, гаргах, нээх; 6. ил хэлэх, илрүүлэх, задруулах; 7. олгох, буй болгох, нээх, эхлэх; 9. олох, нээх; 10. илчлэх, илрүүлэх.

ОТКРЫВА́ТЬСЯ 1. нээгдэх, онгойх, тайлах; 2. сэдрэх, задрах; 3. харагдах, ил гаргах; 4. илрэх, болох; 5. илэн далангүй хэлэх.

ОТКРЫ́ТИЕ 1. нээх, нээлт, ~ **съезда** их хурал нээх; 2. нээлт, нээх; **научное ~** шинжлэх ухааны нээлт; **сделать ~** нээлт хийх, шинэ юм нээх.

ОТКРЫ́ТКА ил захиа.

ОТКРЫ́ТО ил шуудан, нууж хаалгүй; ~ **признать свои ошибки** алдаагаа шууд хүлээх.

ОТКРЫ́Т||ЫЙ 1. нээлттэй, онгорхой, задгай, сул, дэлгээстэй; **~ая книга** дэлгээстэй ном; 2. уудам, задгай; **~ая степь** уудам тал, **~ое море** задгай тэнгис; **под ~ым небом** задгай газар; 3. нээлттэй; 4. ил, илэрхий, шууд нууж хаагаагүй; **~ое голосование** ил санал хураах; 5. илэн далангүй, шулуун; ~ **вопрос** шийдээгүй асуудал; **~ое письмо** ил захидал; ~ **способ разработки** дээрээс нь малтаж авах.

ОТКРЫ́ТЬ 1. нээх, онгойлгох, тайлах; ~ **сундук** авдар нээх; ~ **дверь** хаалга тайлах; 2. нээх, задгай тавих, сул орхих; ~ **путь** зам нээх; 3. ярах, задгай тавих, нүцгэлэх; ~ **грудь** хэнхдэг ярах; 4. дэлгэх, нээх; ~ **зонтик** шүхэр дэлгэх; ~ **глаза** нүдээ нээх; 5. тавих, гаргах, нээх; ~ **воду** ус тавих; 6. ил хэлэх, илрүүлэх, задруулах; ~ **правду** үнэнийг ил хэлэх, үнэнийг илрүүлэх; ~ **свое имя** нэрээ хэлэх; 7. олгох, буй болгох; ~ **возможность** бололцоо олгох; 8. нээх, эхлэх; ~ **митинг** цуглаан нээх; ~ **огонь** гал нээх; 9. олох, нээх; ~ **залежи руды** хүдрийн уурхай олох; 10. илчлэх, илрүүлэх; ~ **заговор** хуйвалдаан илчлэх; ~ **кредит** зээлийн эрх олгох.

ОТКРЫ||ТЬСЯ 1. нээгдэх, онгойх, тайлдах; **окно ~лось** цонх онгойлоо; 2. сэдрэх, задрах; **рана ~лась** шарх сэдрэв; 3. харагдах, ил гарах; **перед нами ~лся красивый вид** бидний өмнө үзэсгэлэнтэй газар харагдлаа; 4. илрэх, болох; 5. илэн далангүй хэлэх; **он во всём ~лся другу** найздаа бүгдий нь илэн далангүй хэлэв.

ОТКУ́ДА, 1. хаанаас; ~ **ты идёшь?** чи хаанаас явж байна?; 2. хаанаас тийшээ, дотроос нь, тийшээ; ~ **ни возьмись** гэнэт хаанаас ч юм бүү мэд.

ОТКУ́ДА-ЛИ́БО ямар нэг газраас, аль нэгэн зүгээс, хаа нэгэн газраас, хаа нэгтэйгээс; ~ **достанет** хаа нэг газраас олно.

ОТКУ́ДА-НИБУ́ДЬ ямар нэг газраас, аль нэгэн зүгээс, хаа нэгэн газраас.

ОТКУ́ДА-ТО үл мэдэх нэг газраас, хаанаас ч юм дээ; ~ **доносился мягкий голос матери** нэг газраас ээжийн зөөлөн дуу сонсдов.

О́ТКУП түрээслэн авах, түрээслэн авалт.

ОТКУПА́ТЬ,

ОТКУПИ́ТЬ түрээслэн авах.

ОТКУПИ́ТЬСЯ биеэ золиослох, золиос өгч салах, хахууль өгч гарах.

ОТКУ́ПОРИВАТЬ задлах, бөглөө авах.

ОТКУ́ПОРИВАТЬСЯ бөглөө сугарах, нээгдэх, задрах.

ОТКУ́ПОРИТЬ задлах бөглөө авах; ~ **бутылку** лонхны бөглөө авах.

ОТКУСИ́ТЬ 1. хазах, өм хазах, тас хазах, хазаад авах; ~ **кусок хлеба** талх хазаад авах; 2. тас хавчих; ~ **конец проволоки** утасны үзүүр тас хавчих.

ОТКУ́СЫВАТЬ хазах, өм хазах, тас хазах, хазаад авах.

ОТЛАГА́ТЕЛЬСТВ||О хойшлуулах, хойш нь тавих; **это дело не терпит ~а** энэ хэргийг хойшлуулж болохгүй, хойшлуулшгүй хэрэг мөн.

ОТЛАГА́ТЬ 1. хажуу тийш нь тавих, хойш нь болгох, тусгай тавих; 2. хадгалах, хуримтлуулах; 3. цацах, хаях, орхих, баах; 4. хойшлуулах, хойш тавих,

ОТЛА́МЫВАТЬ хуга татах, хугалах, хэлтлэх, эмтлэх, өмлөх.

ОТЛА́МЫВАТЬСЯ хугарах, хуга буух, хэлтрэх, эмтрэх.

ОТЛЕЖА́ТЬ чилтэл хэвтэх, хөштөл хэвтэх; ~ **ногу** хэвтэж хөлөө хөшөөх.

ОТЛЕЖА́ТЬСЯ 1. хэвтэж амрах, хэвтэж тэнхээ авах, тамир ортлоо хэвтэх; 2. болтол нь дарах.

ОТЛЁЖИВАТЬ чилтэл хэвтэх, хөштөл хэвтэх.

ОТЛЁЖИВАТЬСЯ 1. хэвтэж амрах, хэвтэж тэнхээ авах, тамир ортлоо хэвтэх; 2. дарж болгох.

ОТЛЕПИ́ТЬ *разг.* хуулах, ховхлох.

ОТЛЕПИ́ТЬСЯ хуурах, ховхрох.

ОТЛЕПЛЯ́ТЬ хуулах, ховхлох.

ОТЛЕПЛЯ́ТЬСЯ хуурах, ховхрох.

ОТЛЁТ нисч буцах, нисэн одох; **время ~а птиц на юг** шувуу буцах цаг; **быть на ~е** явахаар зэхэх; **жить на ~е** захад суух.

ОТЛЕТА́ТЬ I 1. нисэн одох, нисэн холдох; 2. тасрах, тас үсрэх, ойчих; 3. ойх, үсрэн ойчих; 4, арилан одох.

ОТЛЕТА́ТЬ II 1. нисч дуусах, нисэхээ болих; 2. нисгэгч байх, нисэх.

ОТЛЕТЕ́||ТЬ 1. нисэн одох, нисэн холдох; 2. тасрах, тас үсрэх, ойчих; **пуговица ~ла** товч тас үсрэв; 3. ойх, үсрэн ойчих; 4. арилан одох.

ОТЛЕ́ЧЬ *сэвхийх, уужрах;* **отлегло от сердца** дотор уужирлаа.

ОТЛИ́В I 1. дундруулах, дундлах, юүлэх, хийх; 2. татрах, татах, таграл; **начался ~** ус татарч эхэллээ; 3. буурах, бууралт.

ОТЛИ́В II туяа; **чёрный с синим ~ом** хөх туяатай хар өнгө, **серый с серебристым ~ом** мөнгөлөг туяатай бор өнгө.

ОТЛИВА́ТЬ I дундуурлах, дундлах, юүлэх, хийх.

ОТЛИВА́ТЬ II цутгах, цутгаж хийх.

ОТЛИВА́||ТЬ III туяа татах, туяарах; **морская вода ~ет зелёным** далайн ус ногоон туяа татна.

ОТЛИ́ВКА 1. цутгах, цутгалт; 2. цутгамал; **чугунная ~** ширмэн цутгамал.

ОТЛИПА́ТЬ хуурах, салах.

ОТЛИ́ПНУТЬ хуурах, салах.

ОТЛИ́ТЬ I дундруулах, дундлах, юүлэх, хийх; **~ немного молока** сүү жаахан юүлэх.

ОТЛИ́ТЬ II цутгах, цутгаж хийх; **~ статую** хөшөө цутгах.

ОТЛИ́ТЬ III *разг.* шээх.

ОТЛИЧА́ТЬ 1. ялгах, ялгаварлах, ялгаруулах, ялган мэдэх, ялгаруулан таних; 2. шагнах, сайшаан тэмдэглэх, ялгавартай үзэх.

ОТЛИЧА́ТЬСЯ 1. шал гарах, товойн гарах; 2. ялгарах, ялгаварлагдах, ялгаатай байх;

ОТЛИ́ЧИ||Е 1. ялгавар, ялгаа, ялгал; **незначительные ~я** ялихгүй ялгавар; 2. гавьяа, шалгарал, шалгарах; **боевое ~** байлдааны гавьяа; **знаки ~я** гавьяаны тэмдэг; **служить с ~ем** албандаа шалгарах.

ОТЛИЧИ́ТЕЛЬН||ЫЙ ялгах, таних, онцгой; **~ые знаки** таних тэмдэг; **~ признак** онцгой шинж тэмдэг.

ОТЛИЧИ́ТЬ 1. ялгах, ялгаварлах, ялгаруулах, ялган мэдэх, ялгаруулан таних; **~ правду от лжи** үнэн худлыг ялгах; 2. шагнах сайшаан тэмдэглэх, ялгавартай үзэх; **~ храбреца** зоригтныг шагнах.

ОТЛИЧИ́ТЬСЯ шалгарах, товойх, шалгаран гарах, товойн гарах; **~ в состязаниях** тэмцээнд шалгарах.

ОТЛИ́ЧНИК 1. онц сайн сурагч, онц сурлагатан; **~и школы** сургуулийн онцчууд, онц сурлагатан сурагчид; 2. онц сайн ажилтан.

ОТЛИ́ЧН||ЫЙ онц сайн, маш сайн, онц; **продукция ~ого качества** маш сайн чанарын бүтээгдэхүүн.

ОТЛО́Г||ИЙ налуу, ташуу, хэвгий; **~ие берега** налуу эрэг.

ОТЛО́ГО ташиж, налуу, хэвгий; **тропинка ~ спускается к реке** жим голруу ташиж ордог.

ОТЛОЖИ́ТЬ 1. хажуу тийш нь тавих, хойш нь болгох, тусгай тавих; 2. хадгалах, хуримтлуулах; **~ деньги на поездку** юманд явах гэж мөнгө хуримтлуулах; 3. цацах, хаях, орхих, баах; **~ личинку** авгалдай орхих, өт баах; 4. хойшлуулах, хойш тавих; **~ решение вопроса** асуудал шийдвэрлэхийг хойшлуулах.

ОТЛОЖНО́Й ~ воротник сөхдөг зах.

ОТЛОМА́ТЬ хуга татах, хугалах, хэлтлэх, эмтлэх, өмлөх; **~ ручку двери** хаалганы бариул хуга татах.

ОТЛОМА́ТЬСЯ хугарах, хуга үсрэх, хэмхрэх, эмтрэх.

ОТЛОМИ́ТЬ хуга цохих, булга татах, мулт татах, хэлтлэх, эмтлэх, өм татах; **~ ветку** мөчир хуга цохих, мөчир хуга татах; **~ кусок хлеба** талх өмлөх.

ОТЛОМИ́||ТЬСЯ хуга тусах, хугарах, булга ойчих, хэлтчих, эмтрэх; **ветка ~лась** мөчир хуга тусав.

ОТЛУЧА́ТЬ салгах, хагацуулах, хөөх.

ОТЛУЧА́ТЬСЯ эзгүй байх, гадагш гарах.

ОТЛУЧИ́ТЬ салгах, хагацуулах, хөөх.

ОТЛУЧИ́ТЬСЯ *разг.* гадагш гарах, эзгүй байх; **~ на минуту** хоромхон зуур эзгүй байх.

ОТЛУ́ЧКА гадагш гарах, юманд явах, эзгүй байх; **самовольная ~** дураараа юманд явах.

ОТЛЫНИВА́ТЬ зайлсхийх; **~ от занятий** хичээлээс зайлсхийх.

ОТМА́ЛЧИВАТЬСЯ дугай өнгөрөх, чимээгүй өнгөрөх, хариулахгүй өнгөрөх.

ОТМА́ТЫВАТЬ задлах, цувах, сунгах.

ОТМА́ХИВАТЬ ширвэж үргэх, шарваж үргээх.

ОТМА́ХИВАТЬСЯ 1. гараараа ширвэж үргээх, сүүлээ шарваж үргээх; 2. булгах, биеэсээ түлхэх.

ОТМАХНУ́ТЬ ширвэж үргээх, шарваж үргээх; **~ мух** ялаа ширвэж үргээх.

ОТМАХНУ́ТЬСЯ 1. гараараа ширвэж үргээх, сүүлээ шарваж үргээх; **~ от комара** шумуул үргээх; 2. булгах, биеэсээ түлхэх; **~ от решения вопроса** асуудал шийдвэрлэхээс булгах.

ОТМА́ЧИВАТЬ 1. дэвтээж хуулах, норгож салгах; 2. норгох, дэвтээх.

ОТМЕЖЕВА́ТЬ зааглах, зааг тавих, зааглан хуваах; **~ участок** газар зааглах.

ОТМЕЖЕВА́ТЬСЯ 1. зааглагдах, зааг тавигдах; 2. холтгох, зайлах, хөндийрөх; **~ от вредной теории** хөнөөлтэй онолоос хөндийрөх.

ОТМЕЖЁВЫВАТЬ зааг тавих, зааглан хуваах.

ОТМЕЖЁВЫВАТЬСЯ 1. зааглагдах, зааг тавигдах; 2. холдох, зайлах, хөндийрөх.

О́ТМЕЛЬ харгиа, гүехэн газар; **песчаная ~** элсэн харгиа.

ОТМЕ́НА хүчингүй болгох, халах, устгах, үгүй болгох; **~ приказания** тушаалыг хүчингүй болгох.

ОТМЕНИ́ТЬ хүчингүй болгох, цуцлах, халах, устгах.

ОТМЕНЯ́ТЬ 1. хүчингүй болгох, цуцлах, халах, устгах; **~ закон** хууль хүчингүй болгох; 2. болиулах, зогсоох, хорих.

ОТМЕНЯ́ТЬСЯ хүчингүй болох, цуцлагдах, болих.

ОТМЕРЕ́ТЬ 1. хатах, мөхөх, үхэх; **побеги отмерли** модны гөлөг хатав; 2. мөхөх, сөнөх, устах, арилах; **старые обычаи отмерли** хуучин заншил устлаа.

ОТМЕРЗА́ТЬ хөлдөх.

ОТМЁРЗ||НУТЬ хөлдөх; **молодые побеги ~зли** цурав ногоо хөлдөв.

ОТМЕ́РИВАТЬ хэмжих, хэмжиж огтлох, хэмжиж өгөх, хэмжиж авах.

ОТМЕ́ТИТЬ хэмжих, хэмжиж өгөх, хэмжиж авах.

ОТМЕРЯ́ТЬ хэмжих, хэмжиж огтлох, хэмжиж өгөх, хэмжиж авах; **~ три метра ткани** гурван метр даавуу хэмжиж огтлох.

ОТМЕСТИ́ 1. шүүрдэх, туужуудах, хамах; 2. таягдан хаях, няцаах, **~ доводы противника** эсэргүүцэл этгээдийн гаргасан баримтыг няцаах.

ОТМЕ́СТК||А *разг.* хариу өшөө, хариугаа авах, өшөөгөө авах; **сделать что-либо в ~у** хариугаа авах гэж юм хийх.

ОТМЕТА́ТЬ 1. шүүрдэх, туужуудах, хамах; 2. таягдан хаях, няцаах.

ОТМЕ́ТИН||А халзан, сар, цагаан; **телёнок с ~ой на лбу** духандаа цагаантай тугал, халзан тугал.

ОТМЕ́ТИТЬ 1. тэмдэглэх, тэмдэг тавих, тэмдэг хийх; 2. тэмдэглэх, тэмдэглэн өнгөрүүлэх, **~ праздник** баяр тэмдэглэн өнгөрүүлэх; 3. харах, анхаарах; 4. тэмдэглэх, дурдах; 5. сайшаан тэмдэглэх; 6. бүртгэлээс хасах, тэмдэглэх.

ОТМЕ́ТИТЬСЯ 1. тэмдэглүүлэх, бүртгүүлэх; ~ **в ведомости** дансанд бүртгүүлэх; 2. бүртгэлээс хасуулах.

ОТМЕ́ТК||А 1. тэмдэг; **сделать ~у** тэмдэг тавих; тэмдэглэх; 2. дүн; үнэлэлт, тэмдэг; **получить хорошую ~у на экзамене** шалгалтад сайн дүн авах.

ОТМЕЧА́ТЬ 1. тэмдэглэх, тэмдэг тавих, тэмдэг хийх; 2. тэмдэглэх, тэмдэглэн өнгөрүүлэх; 3. харах, анхаарах; 4. тэмдэглэх, дурдах; 5. сайшаан тэмдэглэх; 6. бүртгэлээс хасах, тэмдэглэх.

ОТМЕЧА́ТЬСЯ 1. тэмдэглүүлэх, бүртгүүлэх; 2. бүртгэлээс хасуулах; 3. гарах; 4. тэмдэглэгдэх, тэмдэглэх.

ОТМИРА́НИЕ мөхөх, сөнөх, мөхөл, сөнөл.

ОТМИРА́ТЬ 1. хатах, мөхөх, үхэх; 2. мөхөх, сөнөх, устах, арилах.

ОТМОКА́ТЬ дэвтэх, нороод хуурах.

ОТМО́КНУТЬ дэвтэх, нороод хуурах.

ОТМОЛЧА́ТЬСЯ дуугүй өнгөрөх, чимээгүй өнгөрөх, хариулахгүй өнгөрөх.

ОТМОРА́ЖИВАТЬ хөлдөөх.

ОТМОРО́ЗИТЬ хөлдөөх; ~ **себе нос** хамраа хөлдөөх.

ОТМОТА́ТЬ задлах, цувах, сунгах; ~ **моток шерсти** ороолттой унгас цувах.

ОТМОЧИ́ТЬ 1. дэвтээж хуулах, норгож самнах: ~ **марку от конверта** дугтуйны маркийг норгож хуулах; 2. норгох, дэвтээх; ~ **кожу** арьс дэвтээх.

ОТМЫВА́ТЬ угаах, угааж арилгах, цэвэрлэх.

ОТМЫВА́ТЬСЯ угаагдах, угаагдаж арилах, цэвэр болох.

ОТМЫКА́ТЬ 1. тайлах, түлхэх, онгойлгох; 2. мултлах, салгах, мулталж авах, салгаж авах.

ОТМЫКА́ТЬСЯ 1. тайлдах, тайлагдах, түлхэгдэх, онгойх; 2. мултрах, салах.

ОТМЫ́ТЬ угаах, угааж арилгах, цэвэрлэх; ~ **грязь с руки** гарынхаа хирийг угаах.

ОТМЫ́ТЬСЯ угаагдах, угаагдаж арилах, цэвэр болох; **чернила не отмылась от рук** гарын бэх угаагдсангүй.

ОТМЫ́ЧКА дэгээ түлхүүр.

ОТНЕ́КИВАТЬСЯ *разг.* мэлээх, үгүй гэх.

ОТНЕС||ТИ́ 1. аваачих, ачаачиж өгөх, хүргэж өгөх; ~ **книгу в библиотеку** номын санд ном аваачиж өгөх; 2. урсгаж аваачих, урсгаад явчих, хийсгэж аваачих, хийсгээд явчих; **лодку ~ло течением вниз** завийг доош нь урсгаад явжээ; 3. тоонд оруулах, тоолох, тооцох, оногдуулах; ~ **событие к числу самых обычных** үүнийг эв энгийн хэргийн тоонд оруулах; ~ **расход на чей-либо счёт** зардлыг хүнд оногдуулах.

ОТНЕСТИ́СЬ харилцах, хандах, байх; ~ **с полным доверием** итгэл төгс хандах, итгэл төгс байх; ~ **высокомерно** ихэмсэг зан гаргах.

ОТНИМА́ТЬ 1. булаах, булаан авах; 2. авах, алдуулах, салгах, барах, дарах; 3. гарздуулах, үрүүлэх, заруулах; 4. гаргах. салгах, зайлуулах; 5. огтлох, тайрах, огтлон авах. тайрч авах; 6. хасах.

ОТНИМА́ТЬСЯ татах.

ОТНОСИ́ТЕЛЬНО I овоо, зүгээр, нилээд, харьцангуй; **опыт прошёл ~ удачно** туршлага овоо амжилттай болов.

ОТНОСИ́ТЕЛЬНО II тухай, талаар; ~ **его возвращения сведений нет** түүний буцаж ирэх тухай сураг алга.

ОТНОСИ́ТЕЛЬНОСТ||Ь харьцангуй чанар; **теория ~и** харьцангуйн *онол.*

ОТНОСИ́ТЕЛЬН||ЫЙ 1. харьцангуй; **~ая истина** харьцангуй үнэн; 2. төдий л, их биш, бага зэрэг, төдий л ихгүй, овоо, нилээд; **он пользовался ~ым влиянием** тэр хүн овоо нөлөөтэй байлаа; **~ая удача** бага зэрэг амжилт.

ОТНОСИ́ТЬ 1. **аваачих, аваачиж өгөх,** хүргэж өгөх; 2. урсган аваачих, урсгаж **авах; хийсгэн** аваачих, хийсгэж явах; 3. тоонд оруулах, тоолох, тооцох, оногдуулах.

ОТНОСИ́ТЬСЯ 1. харилцах, хандах; байх; 2. холбогдох, холбогдолтой байх, хамаарах; **это к делу не относится** энэ холбогдолгүй зүйл.

ОТНОШЕ́НИ||Е 1. хандах, харьцах, **харилцах,** хандлага, харьцаа, харилцаа, **внимательное ~ к делу** ажил хэрэгт анхааралтай хандах; **хорошее ~ к детям** хүүхдэд сайн байх; 2. холбогдох, хамаарах, холбогдол, **хамаа; иметь ~ к какому-либо делу** нэг хэрэгт холбогдолтой **байх;** 3. харьцаа, харилцаа; **производственные ~я** үйлдвэрлэлийн **харьцаа; дипломатические ~я** дипломат харицаа; 4. **харьцаа; ~ между двумя величинами** хоёр хэмжигдэхүүний харьцаа; 5. тал; **в этом ~и я согласен с ним** энэ тал дээр түүнтэй **санал** нэгтэй байна; **во всех ~ях** тал талаараа, бүх **талаараа;** 6. албан бичиг; **в ~и** тухай; **по ~ю** -д; -т; **добр по ~ю к нему** түүнд сайн.

ОТНЫ́НЕ өнөөгөөс эхлэх, одоогоос хойш.

ОТНЮ́ДЬ огт, хэрхэвч, ер; ~ **нет** хэрхэвч тийм биш.

ОТНЯ́ТЬ 1. булаах, булаан авах; ~ **деньги** мөнгий нь булаах; 2. авах, алдуулах, салгах, барах, дарах; ~ **жизнь у кого-либо** хүний амийг авах, амь алдуулах; 3. гарздуулах, үрүүлэх, заруулах; ~ **много времени у кого-либо** хүний цагий нь их гарздуулах; 4. гаргах, салгах, зайлуулах; ~ **ребёнка от груди** хүүхдийг хөхнөөс нь салгах; 5. огтлох, тайрах, огтолж авах, тайрч авах; ~ **руку** гарыг нь огтолж авах; 6. хасах; **от десяти ~ пять** арваас тавыг хасах.

ОТНЯ́||ТЬСЯ татах, **у него ~лась нога** өрөөсөн хөл нь татжээ.

О́ТО 1. -аас (-ээс- гоос; -вес); 2. -ын (чин); -ы (-ий).

ОТОБЕ́ДАТЬ үдийн хоол идэж дуусах.

ОТОБРАЖА́ТЬ дүрслэн үзүүлэх, харуулах.

ОТОБРАЖА́ТЬСЯ дүрслэгдэх.

ОТОБРАЖЕ́НИЕ дүрслэн үзүүлэх, дүрслэл; **верное ~** үнэн зөв дүрслэн үзүүлэх.

ОТОБРАЗИ́ТЬ дүрслэн үзүүлэх, харуулах; ~ **жизнь в искусстве** урлагт амьдралыг дүрслэн үзүүлэх.

ОТОБРАЗИ́ТЬСЯ дүрслэгдэх.

ОТОБРА́ТЬ 1. булаах, булаан авах, хураах; ~ **имущество** хөрөнгийг хураах; 2. хураан авах, эргүүлэн авах, буцааж авах; 3. сонгож авах, шилж авах, ялгах; 4. байцаан авах.

ОТОВА́РИВАНИЕ бараа нийлүүлэх, бараа нийлүүлэлт.

ОТОВА́РИВАТЬ,

ОТОВА́РИТЬ бараа нийлүүлэлт, бараа өгөх, бараагаар хангах.

ОТОВСЮ́ДУ газар бүрээс, газар газраас хаа хаанаас, зүг зүгээс.

ПА́ЗУХ||А II хонгил, хөндий; **лобные ~и** магнайн хөндий.

ПАЙ хувь; **вступительный** ~ элсэлтийн хувь; **на паях** мөнгө нийлүүлэх.

ПА́ЙКА I гагналт, гагнах.

ПА́ЙКА II ноогдол хувь, *разг.* шоронгийн хоол.

ПА́ЙЩИК хувь нийлүүлэгч.

ПАКГА́УЗ агуулах газар; **железнодорожный** ~ төмөр замын агуулах газар.

ПАКЕ́Т 1. багц, боодол, уут; **завернуть вещи в** ~ юмыг уутанд хийх; ~ **данных** өгөгдөхүүний багц; 2. албан бичиг, битүүмж; **вскрыть** ~ битүүмж задлах; **индивидуальный** ~ шархны боолт.

ПАКЕ́ТН||ЫЙ багцалсан; **~ая сделка** багцалсан гүйлгээ.

ПА́КЛ||Я 1. сэвлэг, олс, олсны хивэг, үлтэс; 2. **~и** *разг.* үе, замбараагүй үе.

ПАКОВА́ТЬ баглах, боох, ороож уях; ~ **книги** ном баглах.

ПА́КОСТИТЬ 1. балиартуулах, бохиртуулах, бузарлах; 2. гутаах; ~ **работу** ажил гутаах; 3. хорлох.

ПА́КОСТНИК 1. хорлогч, хүний муу ухчилдаг хүн; 2. булай амьтан.

ПА́КОСТНЫЙ1. бузар, булай, жигшүүртэй; ~ **поступок** жигшүүртэй үйл явдал; 2. хорлогч; ~ **человек** хорлогч хүн.

ПА́КОСТ||Ь1. бузар, булай, жигшүүртэй юм, муухай юм; **не говорите ~ей** булай юм бүү яриач дээ; 2. хор хүргэх явдал, гутаах хэрэг.

ПАКТ гэрээ, пакт; ~ **мира** энх тайвны гэрээ; ~ **о ненападении** үл довтлолцох тухай гэрээ.

ПАЛАНКИ́Н жууз, жуузан тэрэг.

ПАЛА́ТА I 1. танхим; 2. танхим, газар; **торговая** ~ худалдааны танхим.

ПАЛА́Т||А II 1. ордон; **каменные ~ы** чулуун ордон; 2. тасаг, өрөө; **у него ума** ~ тэр цэцэн хүн.

ПАЛА́ТК||А 1. майхан, бүрхэл, чачир, цомцог; **разбить ~у** майхан шаах; 2. бүхээг, мухлаг; **хлебная** ~ талхны мухлаг.

ПАЛА́ТНЫЙ тасгийн; ~ **врач** тасгийн их эмч.

ПАЛА́ТОЧНЫЙ майхант, бүхээгт.

ПАЛА́Ч алуурчин, зандалчин.

ПАЛА́Ш илд, жад.

ПА́ЛЕВЫЙ шарга, шаргал, хул.

ПАЛЁНКА *разг.* хуурамчаар үйлдсэн бараа.

ПАЛЁН||ЫЙ 1. хуйхалсан, хуйхлагдсан, хиншүү; **пахнет ~ым** хуйхалсан үнэр гарч байна, хиншүү үнэртэж байна; 2. *разг.* найдваргүй, сэжигтэй, аюултай.

ПАЛЕО́ГРАФ эртний бичиг зүйч.

ПАЛЕОГРА́ФИЯ,эртний бичиг зүй.

ПА́ЛЕЦ 1. хуруу; **большой** ~ эрхий хуруу; **указательный** ~ долоовор хуруу; **безымянный** ~ ядам хуруу, нэргүй хуруу;

показывать пальцем хуруугаар заах; 2. хуруу; **поршневой ~** бүлүүрийн хуруу; 3. **знать, как свои пять пальцев** таван хуруу шигээ мэдэх, сайн мэдэх; **сквозь пальцы смотреть** зориуд тоомсорлохгүй байх, анхаарахгүй өнгөрөөх; **~ о ~ не ударить** юу ч хийхгүй; **~ в рот не клади** *өөрөө* аманд нь бүү ор *(гэнэдүүзэй)*; **по пальцам пересчитать можно** хуруу даран тоолж болно; **пальцем никого не тронет** өчүүхэн ч гэмгүй; **обвести вокруг пальца** дов дээр долоо мэхлэх.

ПАЛИСА́ДНИК үүдний цэцэрлэг.

ПАЛИ́ТРА 1. будгийн нийлүүр; 2. туслах арга; **богатая ~** туслах олон арга.

ПАЛИ́ТЬ I 1. хуйхлах, хярваслах; **~ гуся** галуу хуйхлах, галуу хярваслах; 2. шарах; **солнце палит** нар шарна; 3. өрдөх, *түлэх, шатаах*; **~ дрова** түлээ өрдөх; 4. шарлуулах, түлэх.

ПАЛИ́ТЬ II буудах, галлах; **~ из пушек** их буугаар галлах.

ПА́ЛИЦА шийдэм, бороохой.

ПА́ЛК||А 1. саваа, мод, бэрээ, бялуу, шийдэм; **опираться на ~у** мод тулах; 2. *разг.* эрэгтэй хүний бэлэг эрхтэн; **кинуть, бросить, забить ~у** хүүхэн ноцоох; **вставлять ~и в колеса** саад хийх.

ПАЛО́МНИК мөргөлчин, бадарчин.

ПАЛО́МНИЧЕСТВО 1. мөргөл хийж явах, бадарчлах; 2. олноороо жуулчлах.

ПА́ЛОЧК||А 1. дохиур, савх, саваа; **барабанные ~и** бөмбөрийн дохиур; **есть ~ами** савхаар идэх; 2. савханцар, нян хорхой; **~ Коха** Кохын савханцар *(сурьеэгийн)*.

ПАЛОЧКОЯ́ДЕРНЫЙ савхан бөөмт; **~ базофил** савхан бөөмт суурьсаг эд.

ПА́ЛОЧН||ЫЙ 1. модон; **~ая изгородь** модон хашлага, модон хашаа; 2. модоор, торлогоор; **~ые удары** торлогоор цохих; 3. ташуурын, хавчлагын; **~ая дисциплина** ташуурын сахилга.

ПА́ЛУБА тавцан *(хөлөг онгоцны)*.

ПА́ЛУБНЫЙ тавцангийн.

ПА́ЛЫЙ үхсэн; **~ скот** үхсэн мал.

ПАЛЬБА́ буудлага, галлах; **пушечная ~** их буугаар галлах.

ПА́ЛЬМА дал мод, мод; **кокосовая ~** наргил мод, хялгаст мод; **финиковая ~** хасарвангийн мод; **~ первенства** тэргүүн суурь.

ПА́ЛЬМОВ||ЫЙ дал модны; **~ая ветвь** дал модны мөчир.

ПАЛЬПА́ЦИЯ *бот.* тэмтрүүл, тэмтрэх; **~ большой кривизны желудка** ходоодны том махиаг тэмтрэх.

ПАЛЬТО́ пальто, хувцас, хүрэм, дулаан дээл.

ПАЛЬЦЕВА́ТЬ *разг.* дээрэлхүү зан гаргах.

ПАЛЬЦЕВ||О́Й хурууны; **~ сустав** хурууны үе; **~ые подушки** өндөг.

ПА́ЛЬЦЫ 1. хуруу, хуруунууд; 2. **~ веером показывать** сагсуу зан гаргах.

ПА́ЛЬЧИК бяцхан хуруу, хуруухан; **~и оближешь** шүлс Гоожмоор амттай; **мальчик с ~** хуруун чинээ хүү.

ПАЛЯ́Щ||ИЙ цоргим халуун, шарам; **~ие лучи солнца** шарам халуун нар, нарны шарам илч.

ПАМПУ́ШКА *разг.* суумай, мантуу.

ПАМФЛЕ́Т хочлолын бичиг, шог зохиол мэтгэл.

ПАМФЛЕТИ́СТ хочлолын зохиолч, мэтгэлийн зохиолч.

ПАМФЛЕ́ТНЫЙ хочлолын, мэтгэлийн; **~ стиль** хочлолын маяг.

ПА́МЯТКА сануулга, санамж, дурсгалын тэмдэг; **~ садовода** цэцэрлэгчийн санамж.

ПА́МЯТЛИВЫЙ ой сайтай, тогтоомтгой, цээж сайтай.

ПА́МЯТНИК 1. дурсгалын хөшөө, хөшөө; **надмогильный ~** *шарил* дээрх хөшөө; 2. дурсгал; **~и письменности** үсэг бичгийн дурсгал; 3. *разг.* **«память»** гэж үндсэрхэх нийгэмлэгийн гишүүн.

ПА́МЯТН||ЫЙ 1. дурсгалт, мартагдашгүй; **~ые события** дурсгалт үйл явдал; 2. тэмдэглэлийн, санамжийн.

ПА́МЯТ||Ь *1.* ой, цээж, цээжлэх, санаа; **врезаться в ~** *ойд орох*; **выучить на ~** цээжлэх; **прийти на ~** санаанд орох; 2. дурсах, дурсгах; **хранить ~ о погибших героях** амь үрэгдсэн баатруудаа дурсч байх; **вечная ~** мөнх дурсгал; **подарить на ~** дурсгал болгон бэлэглэх; 3. ухаан, дуртгал; **лежать без ~и** ухаангүй хэвтэх; **любить без ~и** ухаангүй дурлах; **куриная ~** таг мартчихдаг.

ПАН пан, ноён; **либо ~, либо пропал** нэг бол дэрийнэ, эсхүл дэлдийнэ, дарайх далдрах хоёрын нэг.

ПАНА́МА 1. панам малгай, дэлбэгэр малгай; 2. *разг.* луйвар.

ПАНАРИ́ЦИЙ гөгий.

ПАНБА́РХАТ панбархат, нарийн хилэн, хамба хилэн.

ПАНДЕМИ́Я цар, тахал; **~ гриппа** томуугийн цар.

ПАНЕГИ́РИК магтаал, хэтэрхий магтаал.

ПАНЕГИРИ́СТ 1. магтагч; 2. хэтэрхий магтагч.

ПАНЕГИРИ́ЧЕСК||ИЙ 1. магтаал, магтсан; **~ая речь** магтсан үг; 2. хэт магтсан.

ПАНЕ́ЛЬ 1. явган зам; 2. модон хананцар; 3. хавтгайлж.

ПАНИБРА́ТСК||ИЙ дотночилсон, эрээгээ алдсан, эрээгүй, тал тохой татсан, нүүр тал харсан, эрээгүй харьцаа; **~ое отношение** чолх зан.

ПАНИБРА́ТСТВО дотно, эрээгээ алдах авир, эрээгүй зан, тал тохой татах, нүүр тал харах.

ПА́НИК||А их тэвдэх, мэгдэх, үймээн, бажгадах; **впадать в ~у** их тэвдэх; **наводить ~у** сандраах, үймүүлэх, тэвдүүлэх.

ПАНИКЁР 1. сандрагч, мэгдэгч; 2. сандаргагч, мэгдүүлэгч.

ПАНИКЁРСТВО сандрах, мэгдэх.

ПАНИКЁРСТВОВАТЬ сандрах, мэгдэх.

ПАНИХИ́ДА хойтын буян үйлдэх; **гражданская ~** салах ёс гүйцэтгэх цуглаан.

ПАНИ́ЧЕСКИЙ сандран, мэгдэн, сандралын; **~ ужас** сандран айх.

ПАНКРЕАНЕКРО́З нойр булчирхай үхжих.

ПАНКРЕАТИ́Т нойр булчирхайн үрэвсэл.

ПАННО́ 1. панно, том зураг; 2. туурга, таазын чимэглэлт хөрөг.

ПАНОРА́МА 1. үзэмж; **~ города** хотын үзэмж; 2. тойруулган хөрөг, өргөн дэлгэц; 3. их бууны өнцөг хэмжүүрийн дуран.

ПАНСИО́Н 1. дотуур байртай дунд сургууль; **~ для благородных девиц** *(хаант оросын)* язгуурtаны охидын сурдаг байсан дотуур байртай дунд сургууль; 2. бэлэн хоолтой буудал; 3. хоол унд, үйлчилгээ бүхий хөлсний байр.

ПАНТАЛО́НЫ 1. эмэгтэйн өмд; 2. шуумагтай өмд, шалбуур, хүгд.

ПАНТАЛЫ́К сбить с ~у учрыг нь олохгүй болгох, хэн нэгнийг аванхайлах; **сбиться с ~у** бахардах,самуурах, дэмийрэх.

ПАНТЕЙЗМ байгалийг шүтэх үзэл.

ПАНТЕО́Н 1. гарамгай зүтгэлтний шарилыг оршуулах харш, шарилын харш; 2. нийт бурхны сүм.

ПАНТЕ́РА ирвэс, цоохондой.

ПАНТОМИ́МА үгүй жүжиг, цам.

ПА́НТЫ цусан эвэр.

ПАНЦЕ́РИЯ *бот.* нохойн хэл.

ПА́НЦИР||Ь хуяг, мэлхийн хавтас; **скрытый ~** бэгтэр хуяг; **~ные рыбы** хуягт загас.

ПА́ПА I аав.

ПА́ПА II римский ~ ромын пап *(хутагт хамба)*

ПА́ПА III *разг.* **~ Карло** хамаг ажлаа хийдэг хүн.

ПАПА́ХА папах малгай.

ПА́ПИК *разг.* залуухан хүүхэнтэй явж буй дунд насны эрэгтэй.

ПАПИЛЛО́МА хучуур эдийн хавдар.
ПАПИРО́СА папироска, папирос тамхи, папирос.
ПАПИРО́СН||ЫЙ папиросны; тамхины; **~ая бумага** тамхины цаас, торгон цаас.
ПАПИ́РУС 1. халуун орны зэгс; 2. муутуу цаас; 3. зэгсэнд бичсэн дурсгал.
ПА́ПКА 1. хавтас; **~ для дел** албан бичгийн хавтас; 2. хатуу хавтас.
ПА́ПОРОТНИК ойм, тагнай өвс, сал мод; **~овые** ойм хэлбэртэй.
ПА́ПРИКА улаан чинжүү.
ПАПУА́СЫ папуасууд.
ПА́ПУЛА гүвдрүү.
ПАПЬЕ́-МАШЕ́ цаасан наамал, зуурмал цаас.
ПАР I уур; **~ водяной** усны уур; **превращение жидкости в ~** шингэн бодис уур болон хувирах; **на всех ~ах** хар хурдаар; **быть под ~ами** явахад бэлэн, хөдлөхөд бэлэн байх.
ПАР II пар, хагалсан газар, өнжөөсөн газар; **земля под ~ом** хагалсан газар.
ПАР III *разг.* тэнхээ.
ПА́Р||А 1. хос; **~ сапог** хос гутал; 2. хослох, хосолсон; **ездить на ~е лошадей** морь хослон хөллөх; 3. хоёр, ижил; **влюблённая ~ янаг** хоёр; 4. хос өмд цамц, костюм; 5. хэд гурван, хэдхэн, цөөхөн; **вызвать на ~у слов** хэд гурван үг солих; **два сапога — ~** өрөөсөн бөөр, ижил хоёр, тэнцүү хоёр; **~ пустяков** амархан, хялбархан, юмгүй.
ПАРАБЕ́ЛЛУМ парабеллум *(автомат ажиллагаатай гар буу).*
ПАРА́ГРАФ зүйл.
ПАРА́Д ёслолын жагсаал.
ПАРАДИ́ГМА жишээ, үг хувирлын хүснэгт.
ПАРА́ДН||ЫЙ ёслолын, гоёлын; **~ая форма** ёслолын хувцас.
ПАРАДО́КС хачин санал.
ПАРАДОКСА́ЛЬНОСТЬ гаж буруу тал, хачин зүйл.
ПАРАДОКСА́ЛЬНЫЙ гаж буруу, хачин; **~ вывод** гаж буруу дүгнэлт, хачин дүгнэлт.
ПАРАЗИ́Т 1. шимэгч; 2. бусдын хүчээр амьдрагч, бусдыг мөлжигч.
ПАРАЗИТА́РНЫЙ 1. шимэх; 2. бусдын хүчээр амьдрах, бусдыг мөлжих.
ПАРАЗИТИ́ЗМ 1. шимэлт; 2. бусдын хүчийг мөлжих.
ПАРАЗИТИ́ЧЕСКИЙ 1. шимэгч; 2. мөлжигч.
ПАРАЗИ́ТНЫЙ шимэгч.
ПАРАЛИЗО́ВАННЫЙ 1. саа дайрсан, мэдээгүй болсон; 2. бууруулсан, тамирдуулсан, хөдлөх чадалгүй болсон.
ПАРАЛИЗОВА́||ТЬ 1. саа дайрах, мэдээгүй болох; **рука ~на** саа өвчин гарт туслаа; 2. тамирдуулах, хөдөлгөөнгүй болгох, хөдлөх чадалгүй болгох.
ПАРАЛИ́ТИК саа өвчтэй хүн.
ПАРАЛИТИ́ЧЕСКИЙ саа өвчтэй.
ПАРАЛИ́Ч саа өвчин, сүүдэр өвчин, гариг өвчин; **~ ноги** хөлийн саа; **его разбил ~** түүнд саа өвчин тусжээ.
ПАРАЛИ́ЧНЫЙ саа өвчтэй.
ПАРАЛЛЕЛЕПИ́ПЕД параллелепипед *(зэрэгцээ сацуу эсрэг зургаан талст).*
ПАРАЛЛЕЛИ́ЗМ 1. зэрэгцээ, зэрэгцүүлэг; 2. нэг юмыг хоёр зэрэг хийх, давхардуулах.
ПАРАЛЛЕЛОГРА́ММ параллелограм *(зэрэгцээ сацуу хажуутай дөрвөн өнцөгт).*
ПАРАЛЛЕ́ЛЬ 1. параллель, зэрэгцээ, зэргэл; 2. зэрэгцүүлэх, харьцуулах, жиших; **провести ~** зэрэгцүүлэн харуулах.
ПАРАЛЛЕ́ЛЬНЫЙ 1. параллель, зэрэгцээ; 2. зэрэгцсэн.
ПАРА́МЕТР параметр *(юмны гол шинжийг заасан хэмжээ).*
ПАРАМЕТРИ́Т *вет.* параметрит, савны гадрын эсийн үрэвсэл.
ПАРАНДЖА́ гивлүүр, нүүрний халхавчтай хувцас.
ПАРАНЕКРО́З *вет.* орчин үхших.
ПАРАНО́ЙЯ дон, гажиг.
ПАРАПРОКТИ́Т *вет.* хошногоны амсрын эдийн үрэвсэл, парапроктит.
ПАРАТИ́Ф иж балнад.
ПАРАФИ́Н парафин тос, лааны тос.
ПАРАФИ́РОВАТЬ урьдчилан үсэг зурах.
ПАРАФРА́З өөрөөр хэлэх, мөн үгийг өөрөөр хэлэх.
ПАРА́ША *разг.* 1. жорлон, шоронгийн жорлон; 2. чанар муутай юм, бараа.
ПАРАШЮ́Т шүхэр; **прыгать с ~ом** шүхрээр үсрэх; **сбросить с ~ом** шүхрээр буулгах.
ПАРАШЮТИ́СТ эрэгтэй шүхэрчин.
ПАРАШЮТИ́СТКА эмэгтэй шүхэрчин.
ПАРАШЮ́ТНЫЙ шүхрийн, шүхэрт.
ПАРАЩИТОВИ́ДН||ЫЙ ~ая железа бамбай булчирхай.
ПАРЕ́З дутуу мэдээтэй, тал саа.
ПАРЕНЁК банди, жаал хүү.
ПАРЕ́НИЕ 1. халих, элэх, элэн халин нисэх; 2. мөрөөдөлд автах, хөвөлзөх; **~ мысли** сэтгэл мөрөөдөлд автах.
ПАРЕНХИ́МА цуллаг.
ПА́РЕН||ЫЙ жигнэсэн, шүүсэнд нь болгосон; **~ые овощи** жигнэсэн ногоо.
ПА́РЕНЬ залуу хүн; **здоровый ~** чийрэг хүү; **рубаха-~** цайлган хүн, хээгүй залуу.
ПАРЕСТЕЗИ́Я *вет.* 1. бадайрах, чилэх, чинэх; 2. өөрчлөгдөх, чилээрхэх.
ПАРИ́ мөрий, мэлзээ; **держать ~** мөрийцөх, мөрий тавих, бооцоолдох; **выиграть ~** бооцоо хожих; **проиграть ~** мөрий алдах.
ПАРИ́К хиймэл үс.
ПАРИКМА́ХЕР үсчин.
ПАРИКМА́ХЕРСКАЯ үсчний газар, үс засах газар.
ПАРИКМА́ХЕРША үсчин эмэгтэй.
ПАРИ́ЛКА *разг.* халуун газар.
ПАРИ́РОВАТЬ 1. хариулах, зайлуулах; 2. няцаах; **~ аргумент** баримтыг няцаах.
ПАРИТЕ́Т 1. адил, эрх тэгш; 2. харьцаат хэмжээ, тэнцэх үнэ.
ПАРИТЕ́ТНЫЙ адил, эрх тэгш.
ПА́РИТЬ I 1. жигнэх, шүүсэнд нь болгох; 2. буцалгаж ариутгах; 3. уураар устгах; 4. хөлслөх, хөлс гаргах; 5. бүгчим болох.
ПА́РИТЬ II парлах, өнжөөх.
ПАРИ́ТЬ элэх, халин нисэх; **~ в небесах** хоосон бодолд автах.
ПА́РИТЬСЯ 1. хөлслөх, халууцуулах, хөлс гаргах; 2. бүгчимдэж зовоох.
ПАРК I цэнгэлдэх хүрээлэн.
ПАРК II 1. буйр, буйрлах газар; **трамвайный ~** трамвайн засварын газар; 2. хөдлөх бүрэлдэхүүн, ерөнхий тоо, бүх парк.
ПАРКЕ́Т паркет, шалны царс; **настилать ~** паркетан шал дэвсэх.
ПАРКЕ́ТНЫЙ царсан, зүсмэл царсан.
ПАРЛА́МЕНТ парламент, улсын хурал.
ПАРЛАМЕНТАРИ́ЗМ парламентат ёс, улсын хуралт ёс.
ПАРЛАМЕНТА́РИЙ 1. парламентын гишүүн, улсын хурлын гишүүн; 2. парламентын ёс баримтлагч.
ПАРЛАМЕНТА́РНЫЙ парламентат, улсын хуралт; **~ строй** парламентат байгуулалт.
ПАРЛАМЕНТЁР цэргийн элч, цэргийн итгэмжит төлөөлөгч.

ПАРЛА́МЕНТСКИЙ парламентын, улсын хурлын.
ПАРНИ́К хүлэмж.
ПАРНИКО́ВЫЙ хүлэмжинд ургуулсан.
ПАРНИ́ШКА жаал хүү.
ПАРН||О́Й 1. сая саасан, шинэхэн, халуунаараа; **~ое молоко** сая саасан сүү; **~ое мясо** сая гаргасан мах, загсаагүй мах; **~ воздух** бүгчим агаар.
ПАРНОКОПЫ́ТНЫЕ туурайтан, салаа туурайтан.
ПАРНОЛИ́СТНИК *бот.* чэсэн хотир.
ПА́РН||ЫЙ 1. хос, хоёр, хосмолжин; **~ экипаж** хос морьтой цэрэг; 2. хосоор; **~ое катанье** хосоор гулгах.
ПАРОВИ́К 1. уурын тогоо; 2. бух тэрэг; 3. уурын хөлөг.
ПАРОВО́З уурын тэрэг, паровоз, уурын зүтгүүр.
ПАРОВО́ЗН||ЫЙ уурын тэрэгний; **~ое депо** уурын тэрэгний депо.
ПАРОВОЗОРЕМО́НТНЫЙ уурын тэрэгний засварын; **~ завод** уурын тэрэгний засварын үйлдвэр.
ПАРОВОЗОСТРОЕ́НИЕ уурын тэрэгний үйлдвэрлэл, уурын тэрэг үйлдвэрлэх.
ПАРОВ||О́Й I 1. уурын, уураар; **~ое отопление** уурын халаалт, уураар дулаацуулах; **~ двигатель** уурын хөдөлгүүр; 2. жигнэсэн; **~ая рыба** жигнэсэн загас.
ПАРОВ||О́Й II өнжөөсөн; **~ое поле** өнжөөсөн газар.
ПАРОДИ́ЙН||ЫЙ элэглэлт, дууриаллын; **~ое произведение** элэглэлт дууриаллын зохиол.
ПАРОДИ́РОВАТЬ 1. элэглэн дууриах; 2. инээд хүрмээр харуулах, олиггүй дууриах, бүдүүвч үлгэр.
ПАРО́ДИЯ 1. элэглэн дуурайх, элэглэлт, дуурайл; **~ на роман** романы элэглэн дуурайх; 2. бүдүүвч үлгэр, дуураймал.
ПАРОДОНТИ́Т шүд тойрны үрэвсэл, шүд сулрах.
ПАРОКСИ́ЗМ хөдлөх, догдлох, ордос; **~ смеха** инээд хөдлөх; **~ кашля** ханиадны ордос.
ПАРО́ЛЬ нууц үг, түлхүүр үг, танилцах үг.
ПАРО́М гатлага онгоц, гүнз, бярвааз.
ПАРО́МН||ЫЙ гатлага онгоцоор, гатлагаа онгоцот; **~ая переправа** гатлага онгоцоор ус гатлах.
ПАРО́МЩИК гаталгагч.
ПАРОХО́Д хөлөг онгоц, галт онгоц; **ехать на ~е** хөлөг онгоцоор явах.
ПАРОХО́ДНЫЙ хөлөг онгоцны, галт онгоцны.
ПАРОХО́ДСТВО 1. хөлөг онгоц эрхлэх газар; **речное ~** гол мөрний хөлөг онгоц эрхлэх газар; 2. хөлөг онгоцны хөдөлгөөн, хөлөг онгоцны тээвэр.
ПА́РОЧКА хос, хоёр.
ПА́РТ||А парт, сандалт ширээ, хичээлийн ширээ; **сесть за ~у** сандалт ширээн дээр суух.
ПАРТАКТИ́В намын идэвхтэн.
ПАРТБИЛЕ́Т намын бат илэрхийлэх, намын батлах.
ПАРТБЮРО́ намын товчоо.
ПАРТВЗНО́СЫ намын татвар.
ПАРТВЗЫСКА́НИЕ намын шийтгэл, намын арга хэмжээ.
ПАРТГРУ́ППА намын хэсэг.
ПАРТЕ́Р гол суудал, голын суудал; **сидеть в ~е** голын суудалд суух.
ПАРТИ́ЕЦ намын гишүүн.
ПАРТИЗА́Н партизан, журамт цэрэг.
ПАРТИЗА́НИТЬ партизаны тэмцэл хийх, партизан явах.
ПАРТИЗА́НСКИЙ партизаны журамт цэргийн; **~ отряд** партизаны отряд.
ПАРТИ́ЙНОСТЬ 1. намч чанар; 2. аль намд хамаатай болох, намын гишүүн мөн эсэх.
ПАРТИ́ЙН||ЫЙ I намын; **~ая организация** намын байгууллага.
ПАРТИ́ЙНЫЙ II намын хүн, намын гишүүн.
ПАРТИТУ́РА нэгтгэсэн аялгуу.
ПА́РТИЯ I Монгольская Народно-Революционная ~ *(МНРП)* Монгол Ардын Хувьсгалт Нам.
ПА́РТИ||Я II 1. анги; **геологическая изыскательская ~** геологи шинжилгээний анги; 2. хэсэг, бөөм, суурь; **~ товаров** бөөм бараа; **~ обуви** хэсэг гутал; 3. хувимж, ангилга; 4. тавил, өрөг; **сыграть ~ю в шахматы** өрөг шатар тавих; 5. тохирох хань; **он тебе не ~** тэр чамд тохирох хань биш.
ПАРТКО́М намын хороо.
ПАРТКОНФЕРЕ́НЦИЯ намын бага хурал.
ПАРТНЁР хоршоо нөхөр, түнш, хамт тоглогч.
ПАРТНЁРСТВО түншлэхүй.
ПАРТНЁРША хоршоо эмэгтэй, хамт тоглогч эмэгтэй.
ПАРТО́РГ намын зохион байгуулагч.
ПАРТОРГАНИЗА́ЦИЯ намын байгууллага.
ПАРТСОБРА́НИЕ намын хурал.
ПАРТСЪЕ́ЗД намын их хурал.
ПАРТУЧЁБА намын сурлага, намын суралцал.
ПАРТШКО́ЛА намын сургууль.
ПА́РУС дарвуул, далбаа; **подобрать ~а** дарвуулыг хураах, дарвуулгыг хумих; **поднять ~а** дарвуулыг дэлгэх; **на всех ~ах** хар хурдаар.
ПАРУСИ́НА зотон, таар.
ПАРУСИ́НОВЫЙ зотонгоор хийсэн, тааран; **~ плащ** зотонгоор хийсэн цув.
ПА́РУСНИК дарвуулт онгоц, далбаат онгоц; **~-рыба** дорнотын далбаат загас.
ПА́РУСН||ЫЙ дарвуулт, далбаат; **~ая лодка** дарвуулт завь; **~ спорт** далбаат завийн спорт.
ПАРФЮМЕ́РИЯ үнэртэн.
ПАРФЮМЕ́РНЫЙ үнэртний; **~ магазин** үнэртний дэлгүүр.
ПАРЧА́ хоргой, нулам.
ПАРЧО́ВЫЙ хоргой.
ПАРШИ́ВЕТЬ хожгор яртах, бужуутах.
ПАРШИ́ВЫЙ 1. хожгор яртай, бужуутай; 2. муухай ягир.
ПАС I 1. *(хөзөрдөхөд)* болих, наадахгүй байх; **объявить ~** болилоо гэх; 2. мэдэхгүй, мэддэггүй, таг; **в таких вещах я ~** би ийм юм мэдэхгүй, би ийм юманд таг шүү.
ПАС II дамжуулах *(бөмбөг тоглоход)*, пас; **точный ~** мэргэн дамжуулах.
ПА́СЕКА зөгий тэжээх газар.
ПА́СЕЧНИК зөгийч.
ПА́СЕЧН||ЫЙ зөгий тэжээх газрын; **~ое хозяйство** зөгийн аж ахуй.
ПАСКУ́ДА *разг. новш.*
ПАСПОРТИЗА́ЦИЯ паспортжуулах, паспорттой болгох, паспортын систем тогтоох.
ПА́СПОРТНЫЙ паспортын; **~ стол** паспортны тасаг.
ПАССА́Ж 1. цуваа дэлгүүр, худалдааны дэлгээс; 2. зорчуулга, шудруулга *(хөгжимд)*.
ПАССАЖИ́Р явагсад, зорчигчид; **зал для ~ов** зорчигчдын тасалгаа.
ПАССАЖИ́РКА зорчигч эмэгтэй.
ПАССАЖИ́РСКИЙ суудлын; **~ поезд** суудлын галт тэрэг.
ПАССА́Т хуурай салхи.
ПАССИ́В 1. идэвхгүй, назгай; 2. пассив, өртэй.
ПАССИ́ВНОСТЬ 1. идэвхгүй байдал, назгай; 2. өртэй байдал.
ПАССИ́ВНЫЙ 1. идэвхгүй, назгай; **~ человек** идэвхгүй хүн; 2. өртэй; **~ баланс** өртэй баланс; 3. *(хэл зүйн)* идэвхгүй; **~ залог** идэвхгүй хэв.
ПА́СТА нойтон оо; **зубная ~** шүдний нойтон оо.

ПА́СТБИЩЕ бэлчээр; **отгонное ~** отрын бэлчээр.
ПА́СТБИЩН||ЫЙ бэлчээрийн; **~ые угодья** бэлчээрийн газар.
ПАСТЕ́ЛЬ өнгийн харандаа, өнгийн цэрд.
ПАСТЕРИЗА́ЦИЯ хүнсний зүйл халааж ариутгах.
ПАСТИ́ 1. хариулах, бэлчээрлүүлэх; **~ скот** мал хариулах; 2. *разг.*маллах гэсэн үг, хэн нэгнийг тагнах, мөрдөх, салахгүй байх.
ПАСТИЛА́ пастила чихэр.
ПАСТИ́СЬ 1. бэлчих; 2. *разг.* цагаа өнгөрүүлэх; **эти девушки всегда пасутся в Сити-кафе** энэ охидууд дандаа Сити-кафед цагаа өнгөрүүлдэг.
ПА́СТОР христосын протестантын санваартан, христосын шажны лам.
ПАСТУ́Х малчин.
ПАСТУ́ШЕСКИЙ малчны.
ПАСТУ́ШИЙ малчны; **~ рожок** малчны бэрээ, цуур.
ПАСТУ́ШКА малчин бүсгүй.
ПАСТЬ I 1. унах, ойчих; 2. амь үрэгдэх; **~ в бою** тулаанд амь үрэгдэх; 3. бууж өгөх; 4. устах; 5. нэрээ хугалах, хүндээ барах; 5. *разг.*ам, уруул; **разинуть ~** гайхан зогсох; **закрой ~** чалчихаа боль; **~ духом** урам хугарах, сэтгэлээр унах, зориг шантрах.
ПАСТЬ II раскрыть ~ амаа ангайх; **львиная ~** арслангийн ам.
ПАСТЬБА́ хариулга, мал хариулах.
ПА́СХА улаан өндөгний баяр.
ПА́СЫНОК дагуул хүү.
ПАСЬЯ́НС хүлцээрт тавил.
ПАТЕ́НТ эрхийн бичиг, зохиогчийн эрхийн бичиг.
ПАТЕНТО́ВАННЫЙ эрхийн бичигэй, зөвшөөрөлтэй.
ПАТЕНТОВА́ТЬ тэмдэглүүлэх, бүртгүүлэх.
ПАТЕТИ́ЧЕСКИЙ оргилсон, сэтгэл хөдөлсөн, цогтой.
ПАТЕТИ́ЧНЫЙ оргилсон, сэтгэл хөдөлсөн, цогтой.
ПАТЕФО́Н эгшигт хайрцаг.
ПА́ТИ *разг.*үдэшлэг, найз нарын уулзалт.
ПАТОГЕНЕ́З эмгэг жам.
ПА́ТОКА цардуулын бурам.
ПАТОЛО́ГИЯ эмгэг судлал, патологи.
ПАТОМОРФОЛО́ГИЯ эмгэг хэлбэрийн судлал.
ПА́ТОЧНЫЙ цардуулын бурмаар хийсэн, бурмын.
ПАТРИА́РХ 1. овгийн өвөг, тайшаа; 2. тэргүүн хамба; 3. хамгийн ахмад, хүндтэй хүн.
ПАТРИАРХА́ЛЬНОСТЬ балар бүдүүлэг байдал.
ПАТРИАРХА́ЛЬНЫЙ 1. патриархаль, эцэг өвгөдийн, уламжлалт; 2. балар бүдүүлэг.
ПАТРИАРХА́Т эцгийн эрхт ёс.
ПАТРИА́РХИЯ үнэн алдартны жас.
ПАТРИ́НИЯ *бот.* сэрхэлэг.
ПАТРИО́Т эх орноо хайрлагч, эх оронч.
ПАТРИОТИ́ЗМ эх орноо хайрлах үзэл, эх оронч үзэл.
ПАТРИОТИ́ЧЕСКИЙ,
ПАТРИОТИ́ЧНЫЙ эх оронч; **~ подвиг** эх оронч гавьяа.
ПАТРИ́ЦИЙ патрици *(эртний ромын язгууртан)*, язгууртан.
ПАТРО́Н I 1. ивээгч, тэтгэгч; 2. үйлдвэрийн эзэн, аж ахуйн эзэн.
ПАТРО́Н II 1. сум, хонгиотой сум; **боевые ~ы** галт сум; 2. бортого, хонгио; 3. патрон, углуурга, толгой; **электрический ~** чийдэнгийн толгой.
ПАТРО́Н III хэв, загвар.
ПАТРОНА́Ж нярайн үзлэг *(гэрээр)*.
ПАТРО́ННИК сумын хэвтэр.
ПАТРО́ННЫЙ сумын; **~ая гильза** сумын хонгио.
ПАТРОНТА́Ш дайз.
ПАТРУЛИ́РОВАТЬ эргүүл хийх.
ПАТРУ́ЛЬ эргүүл.
ПАТРУ́ЛЬН||ЫЙ эргүүлийн; **~ая служба** эргүүлийн алба.
ПА́УЗА завсарлагаа, зогсоц, түдлэг, зай.
ПАУ́К аалз.
ПАУПЕРИ́ЗМ үй олны үгүйрэл, нийтээр хооорох.
ПАУТИ́НА 1. аалзны тор; 2. урхи.
ПАУТИ́ННИК арваа.
ПА́ФОС урамшил, бахдал, бадрангуй хөгжил.
ПАХ цавь, хавьцаг; **~овая грыжа** цавины эвэрхий.
ПАХА́Н *разг.*атаман, овгор.
ПА́ХАРЬ 1. газар хагалагч,тариачин; 2. *разг.*ажилсаг хүн.
ПАХА́ТЬ 1. хагалах; **~ поле** газар хагалах; 2. ажиллах.
ПА́ХНУТЬ I 1. үнэртэх, анхилах, ханхлах; **пахнет сеном** өвс үнэртэж байна; 2. гарах, болох төлөвтэй, болох даг; **дело пахнет ссорой** хэрэг явсаар хэрүүл болох төлөвтэй, энэ ч хэрүүл болох даг; **пахнет порохом** дайн болж мэдэшгүй.
ПАХНУ́||ТЬ II үлээх; **~ло свежестью** цэвэр агаар үлээв.
ПАХОВО́Й цавины.
ПА́ХОТА газар хагалах.
ПА́ХОТН||ЫЙ хагалах, тариалангийн; **~ая земля** хагалах газар, тариалангийн газар.
ПАХУ́ЧЕСТЬ ханхлах.
ПАХУ́Ч||ИЙ үнэрт, үнэртэй; **~не травы** үнэрт өвс.
ПАЦА́Н 1. жулдрай хүү, бацаан, банди; 2. хулгайч.
ПАЦИЕ́НТ өвчтөн, эмчлүүлэгч.
ПАЦИЕ́НТКА өвчтөн эмэгтэй, эмчлүүлэгч эмэгтэй.
ПАЦИФИ́ЗМ пацифизм *(ямар ч дайныг эсэргүүцэх үзэл)*.
ПАЦИФИ́СТ пацифист, пацифизмыг баримтлагч, ямар ч дайныг эсэргүүцэгч.
ПА́ЧЕ улам, тэгэх тусам, бүр тийм, учраас; **~ чаяния** санамсаргүй.
ПА́ЧКА 1. баглаа, хайрцаг, багц, боодол; **~ писем** баглаа захидал; **~ папирос** хайрцаг тамхи; 2. **балетная ~** балетчиний гутал; 3. *разг.*олон тооны.
ПА́ЧКА||ТЬ 1. муухай болгох, будах, бохирлох, балиартуулах; **~ руки** гараа будах; 2. эрээчих; **он не рисует, а ~ет** тэр зурж байгаа биш эрээчиж байна; **~ доброе имя** сайн нэрийг гутаах.
ПА́ЧКАТЬСЯ 1. муухай болох, будагдах, хиртэх, балиартах; 2. олиггүй юманд оролцох; **~ не хочется** олиггүй юманд оролцмооргүй байна.
ПАЧКУ́Н эрээчигч, хиртүүлэгч, балиартуулагч.
ПАША́ паша, их сайд *(хуучин турк, египетийн дээд тушаалтан ба түүний цол)*.
ПА́ШЕННИК *бот.* гуурсны өвс.
ПА́ШНЯ хагалсан газар, тариалангийн газар.
ПАШТЕ́Т татмаг, нухаш, амас.
ПА́ЮСН||ЫЙ шахмал; **~ая икра** шахмал түрс.
ПАЯ́ЛЬНИК 1. гагнуурын алх; 2. төөнүүр.
ПАЯ́ЛЬНЫЙ гагнуурын.
ПАЯ́ЛЬЩИК гагнуурч.
ПАЯ́НИЕ гагналга, гагнуур.
ПАЯ́СНИЧАТЬ алиалах, элдвээр аашлах, маяглах.
ПАЯ́ТЬ гагнах.
ПАЯ́ТЬСЯ *разг.* 1. эр эмийн ажил хийх; 2. залхаах.
ПЕВЕ́Ц дууч, дуулагч.
ПЕВИ́ЦА дууч хүүхэн, дууч эмэгтэй.
ПЕВУ́ЧЕСТЬ яруу, уянгалаг.
ПЕВУ́ЧИЙ яруу, уянгалаг.
ПЕ́ВЧ||ИЙ I донгоддог, дууч, жиргээч; **~ая птица** донгоддог шувуу.
ПЕ́ВЧ||ИЙ II дуулагч, дууч; **хор ~их** дуучдын найрал дуу.

ПЕ́Г||ИЙ алаг; **~ая лошадь** алаг морь.
ПЕДАГО́Г багш, сурган хүмүүжүүлэгч.
ПЕДАГО́ГИКА сурган хүмүүжүүлэх ухаан, сурган хүмүүжүүлэх зүй.
ПЕДАГОГИ́ЧЕСК||ИЙ 1. сурган хүмүүжүүлэхийн, сурган хүмүүжүүлэх; **~ институт** сурган хүмүүжүүлэхийн дээд сургууль; 2. багшийн, багш нарын; **~ совет** багш нарын зөвлөл; **~ое училище** багшийн сургууль.
ПЕДА́ЛЬ дөрөө, гишгүүр, чангалуур; **~ рояля** төгөлдөр хуурийн гишгүүр; **~ велосипеда** унадаг дугуйн дөрөө; **нажимать на ~** дөрөөг жийх, гишгүүр дарах.
ПЕДА́НТ ёсорхог хүн, ёсорхогч; **невыносимый ~** тэсэшгүй ёсорхог хүн.
ПЕДАНТИ́ЗМ ёсорхол, ёсорхог, нарийн ёсорхох үзэл.
ПЕДАНТИ́ЧНЫЙ ёсорхог, дэндүү ёсорхох; **~ человек** ёсорхог хүн.
ПЕДИА́ТР хүүхдийн эмч.
ПЕДИАТРИ́Я хүүхдийн эмнэл зүй, хүүхдийн эмчлэх зүй.
ПЕДИКУЛЁЗ бөөстэй, бөөстөх.
ПЕДИКЮ́Р хөлний хуруу арчлах арга.
ПЕДИНСТИТУ́Т сурган хүмүүжүүлэхийн дээд сургууль, багшийн дээд сургууль.
ПЕДОФИЛИ́Я хүүхдэд донтох тачаал.
ПЕДТЕ́ХНИКУМ *(педагогический техникум)* сурган хүмүүжүүлэх техникум, багшийн сургууль, багш нарыг бэлтгэх техникум.
ПЕ́ЙДЖЕР пейжер.
ПЕЙЗА́Ж 1. газар нутгийн байдал, уул усны байдал, байгаль; 2. газар нутгийн зураг, байгалийн зураг.
ПЕЙЗАЖИ́СТ байгалийн зураач.
ПЕЙС *разг.* жүүд.
ПЕКА́РНЫЙ талх барих, эздмэг хийх.
ПЕКА́РНЯ талх барих газар, талх хийх газар.
ПЕ́КАРЬ талх баригч.
ПЕКИНЕ́С Бээжин хав.
ПЕ́КЛ||О аагим халуун, төөнөм халуун; **сидеть на самом ~е** *төөнөм* халуун газарт суух.
ПЕЛЕНА́ битүү харанхуй; **~ тумана** харанхуй манан; **сплошная ~ облаков** үргэлжилсэн битүү үүл.
ПЕЛЕНА́ТЬ манцуйлах, өлгийдөх; **~ младенца** хүүхэд өлгийдөх.
ПЕ́ЛЕНГ луужингаар чигийг олох арга *(үзэгдэх юм, сонсогдох дууны чиг ба луужингийн зүүний чигийн хоорондох өнцөг).*
ПЕЛЕНГА́ТОР пеленгатор, чиглэлийг олох багаж.
ПЕЛЕНГОВА́ТЬ *пеленглэх*, пеленг өнцгөөр чигийг олох.
ПЕЛЕРИ́НА захавч, цээжич, додъёг.
ПЕЛЁНКА манцуй, өлгий, ороолт; *** с пелёнок** өлгийтэй байхаасаа, хар нялхаасаа.
ПЕЛИКА́Н хотон шувуу, хорд шувуу.
ПЕЛЛА́ГРА *вет.* арьс ясжих.
ПЕЛЬМЕ́НИ банш, хясаа, боорцог.
ПЕ́МЗА уушгин чулуу.
ПЕ́Н||А хөөс; **морская ~** далайн хөөс; **мыльная ~** савангийн хөөс; **с ~ой рта говорить** амнаасаа хөөс цахруулан ярих.
ПЕНА́Л үзгийн сав, харандааны хайрцаг.
ПЕНА́ТЫ төрсөн нутаг, эцгийн голомт.
ПЕНЁК жижиг хожуул.
ПЕ́НИЕ 1. дуулах, дуулал, дуу; **хоровое ~** найрал дуу; 2. донгодох, жиргэх; **~ птицы** шувуу донгодох.
ПЕ́НИС эрэгтэй хүний бэлэг эрхтэн.
ПЕ́НИСТ||ЫЙ хөөстэй, хөөсөрсөн; **~ые волны** хөөстэй долгион; **~ое пиво** хөөсөрсөн пийв, шар айраг.
ПЕНИТЕНЦИА́РНЫЙ засан хүмүүжүүлэх, хорихын.
ПЕ́НИТЬ хөөсрүүлэх.
ПЕ́НИТЬСЯ хөөсрөх, хөөс бурах; **пиво пенится в кружке** аяган дахь шар айраг хөөсөрч байна.
ПЕНИЦИЛЛИ́Н пенициллин.
ПЕ́НК||А өрөм; **молоко с ~ами** өрөмтэй сүү; **снимать ~и** өрмий нь хамах, сайны нь самардах, соры нь цөлбөх.
ПЕ́ННИ пенни *(англий бутархай мөнгө).*
ПЕ́ННЫЙ хөөстэй.
ПЕНСИОНЕ́Р тэтгэвэр авагч, сул цалин авагч.
ПЕНСИОНЕ́РКА тэтгэвэр авагч эмэгтэй, сул цалинт эмэгтэй.
ПЕНСИО́ННЫЙ тэтгэврийн, сул цалингийн; **~ая книжка** тэтгэврийн дэвтэр.
ПЕ́НСИ||Я тэтгэвэр, сул цалин; **получить ~ю** тэтгэвэр авах; **быть на ~и** тэтгэвэрт гарах, тэтгэвэрт байх.
ПЕНСНЕ́ хавчдаг шил, нүдний хавчуурт шил.
ПЕ́НТЮХ болхи, үхээнц хүн, *разг.* баагий.
ПЕНЬ хожуул, төгцөг; **корчевать пни** хожуул арилгах, хожуул булгалах; **через ~ колоду** хааш хэрэг, хааш яваш; **как ~ стоит** модон өмдтэй юм шиг зогсох.
ПЕНЬКА́ олс, түүхий олс.
ПЕНЬКО́ВЫЙ олсон, олсны; **~ канат** олсон аргамж.
ПЕ́НЯ анз, торгууль.
ПЕНЯ́||ТЬ зэмлэх, гоморхох, гомдох; **~йте сами на себя** хар толгойдоо гомд, өөртөө гомд.
ПЕ́ПЕЛ үнс, үнсэн товрог, чандруу; **обращать в ~** үнс болгох, үнсэн товрог болгох.
ПЕПЕЛИ́ЩЕ 1. түймрийн цурам, цурам; 2. төрсөн нутаг.
ПЕ́ПЕЛЬНИЦА үнсний сав, тамхины цохилуур.
ПЕ́ПЕЛЬН||ЫЙ үнсэн, үнсний, зэвхий, зэвхий буурал; **~ые волосы** зэвхий буурал үс.
ПЕПСИ́Н хайлгуур, пепсин.
ПЕРВА́Ч 1. тэргүүн зэргийн, нэгдүгээр зэргийн, шилдэг; 2. ганц удаа нэрсэн самогон.
ПЕ́РВЕНЕЦ 1. ууган, түрүүчийн; **сын - ~** ууган хүү; 2. ууган, анхных.
ПЕ́РВЕНСТВО тэргүүн суурь, түрүүлэх, аварга; **Баттулга завоевал ~ мира по вольной борьбе** Баттулга чөлөөт бөхөөр дэлхийн аварга болсон.
ПЕ́РВЕНСТВОВАТЬ түрүүлэх, тэргүүн суурийг эзлэх, аварга болох; **~ в спорте** спортод түрүүлэх.
ПЕРВИ́ЧНЫЙ 1. анхдагч, анхны; **~ слой** анхдагч давхарга; **~ период болезни** өвчний анхны үе; 2. анхан шатны.
ПЕРВОБЫ́ТН||ЫЙ балар цагийн, балар эртний; **~ человек** балар цагийн хүн; **~ое общество** балар эртний нийгэм; **~ая община** балар эртний хүй нэгдэл.
ПЕРВОИСТО́ЧНИК тулгуур бичиг, тулгуур баримт, уг сурвалж; **исследование по ~ам** тулгуур баримтаар судлах.
ПЕРВОКЛА́ССНИК нэгдүгээр ангийн сурагч.
ПЕРВОКЛА́ССНИЦА нэгдүгээр ангийн эмэгтэй сурагч.
ПЕРВОМА́ЙСКИЙ майн нэгний, тавдугаар сарын нэгний.
ПЕРВОНАЧА́ЛЬН||ЫЙ 1. анхны, түрүүчийн, эхний; **~ проект** анхны төсөл; **~ взнос** анхны хураамж; **~ капитал** анхны капитал; 2. анхны, хамгийн наад талын, ойр зуурын; **~ое накопление** эхний хуримтлал.
ПЕРВООСНО́ВА анхны суурь, үндэс, суурь; **материя — ~ всего существующего** бодис бол байгаа бүх зүйлийн *анх* үндэс мөн.
ПЕРВООЧЕРЕДН||О́Й хамгийн түрүүчийн, нэгдүгээр, чухал, нэн түрүүчийн; **~ая задача** хамгийн түрүүчийн зорилго, нэн тэргүүний зорилт.
ПЕРВОПЕЧА́ТНИК хамгийн түрүүчийн хэвлэгч, анхны хэвлэгч.

ПЕРВОПЕЧА́ТН||ЫЙ анхны хэвлэлийн, анх хэвлэгдсэн, анхны дармал; **~ые книги** анх хэвлэгдсэн ном, анхны дармал ном.
ПЕРВОПРЕСТО́ЛЬНАЯ Москва хот.
ПЕРВОПРИЧИ́НА анхны шалтгаан, уг шалтгаан, анх түрүүчийн шалтгаан.
ПЕРВОПУ́ТОК шинэ цасны зам, цасан дээгүүрх шинэ харгуй; **ехать по первопутку** цасан дээрх шинэ харгуйгаар явах.
ПЕРВОРАЗРЯ́ДНЫЙ тэргүүн зэргийн, шилдэг сайн.
ПЕРВОРО́ДНЫЙ ууган, анх төрсөн; **~ сын** ууган хүү; **~ грех** анхны нүгэл, үүсгэл хилэнц.
ПЕРВОРОДЯ́ЩАЯ тулгар эх, анхны төрлөг.
ПЕРВОСО́РТНЫЙ нэгдүгээр зэргийн, эрхэм зэргийн; **~ товар** нэгдүгээр зэргийн бараа.
ПЕРВОСТЕПЕ́ННЫЙ эрхэм чухал, онц чухал, нэгдүгээр зэргийн; **вопрос ~ой важности** эрхэм чухал асуудал, онц чухал асуудал.
ПЕРВОЦВЕ́Т түрүүчийн цэцэг, анхны ногоо, хаварсал.
ПЕ́РВ||ЫЙ 1. нэгдүгээр, нэгдэх, анхдугаар, тэргүүн; **во-~ых** нэгдүгээрт; **~ том** нэгдүгээр боть, тэргүүн боть; **~ съезд** анхдугаар их хурал; **~ из них** нэгдэх нь; 2. нэгэн, шинийн нэгэн; 3. анх, эх, анхны, эхний, түрүүчийн; **в ~ое время** анхны үед; **~ раз в жизни** насандаа анх удаа; 4. тэргүүн, шилдэг; **выдвинуть на ~ое место** тэргүүн суурьд дэвшүүлэх; **~ым делом** юуны өмнө; **не ~ой молодости** их залуу биш; **на ~ых порах** дав дээр; **с ~ого взгляда** хармагц.
ПЕРГА́МЕНТ 1. илэг, сарьс, илгэн цаас; 2. пергамент, ус нэвтрэхгүй цаас, тослог цаас.
ПЕРЕАДРЕСОВА́ТЬ адресийг сольж явуулах, хаягийг солих.
ПЕРЕАТТЕСТОВА́ТЬ цол мэргэшлийг дахин хянах.
ПЕРЕБАЗИ́РОВАТЬ өөрчлөн суурилуулах, суурилуулах баазыг шилжүүлэх, өөр баазад шилжүүлэх.
ПЕРЕБАЗИ́РОВАТЬСЯ өөрчлөн суурилах, өөр баазад шилжих.
ПЕРЕБА́РЩИВАТЬ дэндүүлэх, хэтрүүлэх.
ПЕРЕБЕГА́ТЬ,
ПЕРЕБЕЖА́ТЬ, 1. хөндлөн гарах, гүйж гарах, огтолж гарах; **~ через улицу** гудамж хөндлөн гарах; **~ дорогу** зам хөндлөн гарах; 2. дагаж орох, урвах.
ПЕРЕБЕ́ЖЧИК дагаж орогч, урвагч, оргож очигч.
ПЕРЕБЕ́ЛИВАТЬ 1. дахин шохойдох; 2. цайруулж бичих, дахин хуулах.
ПЕРЕБЕЛИ́ТЬ1. дахин шохойдох; **~ потолок** таазыг дахин шохойдох; 2. цайруулж бичих, дахин хуулах; **~ рукопись** бичмэлийг цайруулж бичих.
ПЕРЕБЕСИ́ТЬСЯ 1. ганирцгаах, галзуурцгаах; 2. ганирсаар, томоожих.
ПЕРЕБИВА́ТЬ, 1. хядах, хиартал алах; 2. хэмхчих, эвдэх; 3. хугалах, бэртээх; 4. засаж хадах, сэлбэх.
ПЕРЕБИВА́ТЬ II 1. хүний яриаг тасалж үг хэлэх; 2. булаах, шүүрч авах, өрсөж авах.
ПЕРЕБИВА́ТЬСЯ 1. хагарах, хэмхрэх, яйрах; 2. дөнгөж амьдрах, амь улжих.
ПЕРЕБИРА́ТЬ 1. ялгах, ялган салгах, цэгцлэх, эмхлэх; 2. дурсах, дурсаж бодох; 3. дахин эвлүүлэх, дахиж засах, дахин өрөх; 4. дараалан дарах; 5. авцгаах, аваад л байх; 6. дэндүү авах, илүү авах.
ПЕРЕБИРА́ТЬСЯ 1. давах, дамжих, гатлах, шилжих; 2. нүүж орох, шилжих, шилжиж орох.
ПЕРЕБИ́ТЬ I 1. хядах, хиаруулах, хиартал алах; **~ врагов** дайсныг хядах; 2. хэмхчих, эвдчих; **~ посуду** сав суулга хэмхчих; 3. хугалах, бэртээх; **~ ногу** хөл хугалах; 4. засах, сэлбэж хадах; **~ кресло** түшлэгтэй сандлыг сэлбэж хадах.
ПЕРЕБИ́ТЬ II 1. хүний яриаг тасалж үг хэлэх; **~ оратора** илтгэгчийн үгийг тасалж үг хэлэх; 2. булаах, шүүрч авах, өрсөж авах.
ПЕРЕБИ́ТЬСЯ I хэмхэрцгээх, яйрих, хэмхэрч дуусах.
ПЕРЕБИ́ТЬСЯ II дөнгөх, амь улжих; **~ до получения денег** мөнгөө автал дөнгөх.
ПЕРЕБО́Й доголдох, тасалдах; **~ в доставке** товаров, бараа хүргэх явдал доголдох.
ПЕРЕБОЛЕ́ТЬ I 1. өвдөцгөөх; 2. өвчинд ороогдох, өвчинд өртсөөр байх.
ПЕРЕБОЛЕ́ТЬ II өвчин илаарших, зовлон гайгүй болох.
ПЕРЕБО́Р 1. илүү авах, нэмүү авах; 2. тогших.
ПЕРЕБО́РКА 1. ялгах, цэгцлэх; 2. халхавч хана.
ПЕРЕБОРО́ТЬ 1. давах, дийлэх; **~ всех соперников** бүх өрсөлдөгчийг дийлэх; 2. дарах, барих; **~ страх** айснаа дарах; **~ себя** биеэ барих.
ПЕРЕБОРЩИ́ТЬ хэтрүүлэх, дэндүүлэх; **не переборщи в остротах** хурц үгээ битгий дэндүүл.
ПЕРЕБРАНИ́ТЬСЯ хараалдах, хараал тавих, муу үг хаялцах.
ПЕРЕБРА́НКА хараалдах, хараал тавилцах, муу үг хаялцаан.
ПЕРЕБРА́СЫВАТЬ 1. дээгүүр шидэх, хаях; 2. тавих; 3. хаях, эгэлдрэх, бөгтрөх; 4. шилжүүлэх, илгээх, аваачих, явуулах.
ПЕРЕБРА́СЫВАТЬСЯ 1. шилжих, дамжих, тарах; 2. хаялцах, шидэлцэх, солилцох.
ПЕРЕБРА́ТЬ 1. ялгах, цэгцлэх, эмхлэх; **~ ягоды** жимсгэнэ ялгах; **~ старые** бумаги хуучин бичиг цаас цэгцлэх; 2. дурсах, дурсаж бодох; **~ что-нибудь в памяти** юмыг санаандаа дурсаж бодох; 3. дахин эвлүүлэх, дахин засах, дахин өрөх; 4. дараалан дарах, тогших; **~ струны** чавхдасыг дараалан дарах; 5. авцгаах, аваад л байх; 6. дэндүү авах, илүү авах; **~ пять очков в игре** тоглоомд 5 оноо илүү авах.
ПЕРЕБРА́ТЬСЯ 1. давах, дамжих, гатлах, гаталж гарах; **~ на другой берег** нөгөө эрэгт гаталж гарах; 2. нүүж орох шилжих, шилжиж орох; **~ на новую квартиру** шинэ байранд шилжин орох.
ПЕРЕБРОДИ́||ТЬ их эсэх, эсэж хатуурах; **кумыс ~л** айраг их эсжээ.
ПЕРЕБРО́СИТЬ 1. дээгүүр шидэх, хаях; **~ мяч через забор** хашаан дээгүүр бөмбөг шидэх; 2. тавих; **~ мост через реку** гол дээгүүр гүүр тавих 3. хаях, эгэлдрэх, бөгтрөх, тавьж унжуулах; 4. шилжүүлэх, илгээх, явуулах.
ПЕРЕБРО́СИ||ТЬСЯ 1. шилжих, дамжих, тарах; **огонь ~лся на соседний дом** түймэр дэргэдэх байшинд шилжив; 2. хаялцах, шидэлцэх; **~ мячом** бөмбөг хаялцах; 3. солилцох; **~ несколькими словами** хэдэн үг солилцох.
ПЕРЕБРО́СКА зөөх, нүүлгэх, шилжүүлэх, шилжүүлж аваачих, илгээх; **~ войск** цэрэг шилжүүлж илгээх.
ПЕРЕБЫВА́ТЬ орцгоож байх, хэсэх, явж үзэх; **~ у всех знакомых** танилуудаараа хэсэх.
ПЕРЕВА́Л даваа.
ПЕРЕВА́ЛИВАТЬ 1. давах; 2. гарах, өнгөрөх; 3. зөөх, шилжүүлэх, овоолох.
ПЕРЕВА́ЛИВАТЬСЯ 1. давж ойчих, дээгүүр нь ойчих; 2. салганаж явах.
ПЕРЕВАЛИ́||ТЬ 1. давах, давж гарах; **~л хребет** нурууг давав; 2. гарах, өнгөрөх; **~ло за полночь** шөнө дунд өнгөрчээ.
ПЕРЕВАЛИ́ТЬСЯ 1. давж ойчих, дээгүүр нь ойчих; **~ через забор** хашаан дээгүүр давж ойчих; 2. хөлбөрөх, өнгөрөх; **~ на другой бок** нөгөө хажуугаар хөлбөрөх.
ПЕРЕВА́ЛОЧНЫЙ дамжуулгын, дамжлагын; **~ пункт** дамжлагын газар.
ПЕРЕВАЛЯ́ТЬ 1. өнхрүүлэх, хөлбөрүүлэх; 2. дахин өнхрүүлэх.

ПЕРЕВАЛЯ́ТЬСЯ ширэлдэх, өнхрөлдөх.

ПЕРЕВА́РИВА||ТЬ 1. дахин чанах; 2. улбас болгох, шалз чанах, үлтэртэл чанах; 3. шингээх, боловсруулах; 4. хүлцэх, тэсвэрлэх; **он его не ~ет** тэр түүнийг хүлцэж чаддаггүй, тэр түүнд дургүй юм.

ПЕРЕВАРИ́ТЬ 1. дахин чанах; ~ **засахарившееся варенье** өтгөрсөн чанамлыг дахин чанах; 2. улбас болгох, шалз чанах, үлтэртэл чанах; 3. шингээх, боловсруулах; ~ **пищу** хоол шингээх; 4. хүлцэх, тэсвэрлэх.

ПЕРЕВАРИ́||ТЬСЯ 1. улбас болгох, үлтрэх, хэтэрхий чанагдах; **яйцо ~лось** өндөг хэтэрхий чанагджээ; 2. шингэх, боловсрох; **пища ~лась** хоол шингэв.

ПЕРЕВЕЗТИ́ 1. зөөх, тээвэрлэх, аваачих; 2. гаргах, гаталгах, давуулах.

ПЕРЕВЕРНУ́ТЬ 1. эргүүлэх; ~ **страницу** хуудас эргүүлэх.

ПЕРЕВЕ́СИ||ТЬ 1. дахин чигнэх, дахин хэмжих; ~ **груз** ачааг дахин чигнэх; 2. өөр газарт өлгөх; ~ **картины** зургийг өөр газарт өлгөх; 3. хүнд байх; **одна чашка весов ~ла другую** чигнүүрийн нэг тогоо нь нөгөөгөөс хүнд байв; 4. давуу байх; **наше мнение ~ло** бидний санал давуу байна.

ПЕРЕВЕ́СИТЬСЯ бөгтрөх, өлгөгдөх; ~ **через перила** шатны хайсан дээр бөгтрөх.

ПЕРЕВЕСТИ́ I 1. гаргаж өгөх; ~ **детей через улицу** хүүхдийг гудамж гаргаж өгөх; 2. нүүлгэх, оруулах; ~ **учреждение в другое здание** албан газрыг өөр байшинд нүүлгэх; 3. шилжүүлэх, өөрчлөн томилох; ~ **на новую должность** шинэ тушаалд өөрчлөн томилох; 4. урагшлуулах, ухруулах, тавих; ~ **стрелки часов**.... цагийн зүүг...тавих; 5. орчуулах, хөрвүүлэх; 6. гуйвуулах; ~ **деньги по почте** шуудангаар мөнгө гуйвуулах; 7. оруулах, шилжүүлэх; 8. буулгах, хуулах; ~ **картину** зураг хуулах; ~ **дух** амсхийх.

ПЕРЕВЕСТИ́ II 1. хиаруулах, хядах; 2. дэмий сүйтгэх, үрэн таран хийх.

ПЕРЕВЕСТИ́СЬ I нүүх, шилжих; ~ **на работу в другой город** өөр хотод шилжиж ажиллах.

ПЕРЕВЕСТИ́СЬ II дуусах, барагдах.

ПЕРЕВЕ́ШАТЬ I дахин чигнэцгээх, дахин хэмжицгээх.

ПЕРЕВЕ́ШАТЬ II дүүжилж алцгаах, цөмийг дүүжлэх.

ПЕРЕВЕ́ШИВАТЬ дахин чигнэцгээх, дахин хэмжицгээх.

ПЕРЕВЕ́ШИВАТЬСЯ 1. дахин чигнэгдэх, дахин хэмжигдэх; 2. өлгөгдөх, дүүжлэгдэх.

ПЕРЕВИВА́ТЬ томох, гөрөх, сүлжих.

ПЕРЕВИВА́ТЬСЯ томогдох, гөрөгдөх, ширэлдэх, эздрэх.

ПЕРЕВИДА́||ТЬ олон юм үзэх, юм үзэж хаширжих; **сколько он всего ~л на своём веку** бүх насандаа тэр их юм үзэж өнгөрүүлжээ.

ПЕРЕВИРА́ТЬ буруу хэлэх.

ПЕРЕВИ́ТЬ 1. гөрөх, томох, нийлүүлж гөрөх; ~ **косы лентамы** гэзгэнд бүч гөрөх; 2. дахин гөрөх, дахин томох.

ПЕРЕВИ́ТЬСЯ 1. гөрөгдөх, томогдох; 2. ширэлдэх, эздрэх.

ПЕРЕВО́Д 1. орчуулах, орчуулга; **хороший** ~ сайн орчуулга; 2. нүүлгэх, шилжүүлэх, шилжүүлж оруулах; 3. гуйвуулах, гуйвуулга, гуйвуулсан.

ПЕРЕВОДИ́ТЬ 1. орчуулах, хөрвүүлэх; 2. нүүлгэх, шилжүүлэх; 3. гуйвуулах; 4. буулгах, хуулах; 5. хиаруулах, хядах; 6. дэмий сүйтгэх, үрэн таран хийх.

ПЕРЕВОДИ́ТЬСЯ I 1. орчуулагдах; 2. нүүх, шилжих.

ПЕРЕВОДИ́ТЬСЯ II дуусах, барагдах.

ПЕРЕВОДН||О́Й 1. орчуулгын, орчуулсан; **~ая литература** орчуулгын зохиол; ~ **роман** орчуулгын роман; 2. гуйвуулгын, гуйвуулсан; 3. буулгах, буулгасан, хуулах, хуулсан; **~ая бумага** буулгах цаас.

ПЕРЕВО́ДЧЕСКИЙ орчуулгын, орчуулах; ~ **труд** орчуулгын хөдөлмөр.

ПЕРЕВО́ДЧИК орчуулагч, хэлмэрч; ~ **с русского языка на монгольский** оросоос монгол хэлэнд орчуулагч.

ПЕРЕВО́З 1. зөөлт, тээвэр, тээвэрлэх; ~ **товаров** бараа тээвэрлэх, 2. гатлага, гарц, бярвааз; **остановка у ~а** гатлагын дэргэд буух, гатлагын дэргэд зогсох.

ПЕРЕВОЗБУЖДЕ́НИЕ хэт хөөрөл.

ПЕРЕВОЗИ́ТЬ 1. зөөх, тээвэрлэх, тээх; ~ **товаров** бараа тээвэрлэх; 2. гаргах, гаталгах; ~ **через реку** гол гаталгах.

ПЕРЕВО́ЗНЫЙ тээвэрлэх, тээврийн, зөөврийн; ~ **пункт** тээврийн тасаг; 2. гатлага, гатлагын.

ПЕРЕВО́ЗОЧН||ЫЙ тээврийн, зөөлтийн; **~ые средства** тээврийн хэрэгсэл.

ПЕРЕВО́ЗЧИК бярваазчин, гаталгагч, тээвэрлэгч.

ПЕРЕВОЛНОВА́ТЬ санаа зовоох, сэтгэл донсолгох.

ПЕРЕВОЛНОВА́ТЬСЯ санаа зовох, сэтгэл донслох.

ПЕРЕВООРУЖА́ТЬ 1. шинэчлэн зэвсэглэх, шинээр зэвсэглэх, зэвсэг шинэчлэх; 2. шинэчлэн тоноглох, шинээр тоноглох.

ПЕРЕВООРУЖА́ТЬСЯ 1. шинэчлэн зэвсэглэх, зэвсэг шинэчлэх; 2. шинэчлэн тоноглох, тоног шинэчлэгдэх.

ПЕРЕВООРУЖЕ́НИЕ 1. шинэчлэн зэвсэглэх, зэвсэг шинэчлэх; 2. шинэчлэн тоноглох, тоног шинэчлэх.

ПЕРЕВООРУЖИ́ТЬ 1. шинэчлэн зэвсэглэх, шинээр зэвсэглэх, зэвсэг шинэчлэх; ~ **армию** цэргийг шинэчлэн зэвсэглэх; 2. шинэчлэн тоноглох, шинээр тоноглох.

ПЕРЕВООРУЖИ́ТЬСЯ 1. шинэчлэн зэвсэглэх, зэвсэг шинэчлэх; 2. шинэчлэн тоноглох, тоног шинэчлэгдэх.

ПЕРЕВОПЛОТИ́ТЬ биелүүлэх, амьжруулах, амилуулах.

ПЕРЕВОПЛОТИ́ТЬСЯ биелэх, биеллээ олох, амьжрах, амилах, хувилах.

ПЕРЕВОПЛОЩА́ТЬ биелүүлэх, амьжруулах, амилуулах.

ПЕРЕВОПЛОЩА́ТЬСЯ биелэх, амьжрах, амилах, хувилах.

ПЕРЕВОПЛОЩЕ́НИЕ биелэл, амьжрал, амилал.

ПЕРЕВОРА́ЧИВАТЬ 1. эргүүлэх; 2. хөмрөх, тонгоруулах, хөнтрөх.

ПЕРЕВОРА́ЧИВАТЬСЯ эргэх, хөмрөх, хөрвөх.

ПЕРЕВОРО́Т эргэлт, гэнэтийн эргэлт, хувьсалт; ~ **в науке** шинжлэх ухааны эргэлт; **государственный** ~ төрийн эргэлт.

ПЕРЕВОРОШИ́ТЬ онгичих, удруулах; ~ **все бумаги** хамаг бичиг цаасаа онгичих.

ПЕРЕВОСПИТА́НИЕ засаж хүмүүжүүлэх, сургаж хүмүүжүүлэх.

ПЕРЕВОСПИТА́ТЬ өөрчлөн хүмүүжүүлэх, засаж хүмүүжүүлэх, сурган хүмүүжүүлэх.

ПЕРЕВОСПИТА́ТЬСЯ өөрчлөгдөн хүмүүжих, засарч хүмүүжих, сурч хүмүүжих.

ПЕРЕВОСПИ́ТЫВАТЬ өөрчлөн хүмүүжүүлэх, засаж хүмүүжүүлэх, сурган хүмүүжүүлэх.

ПЕРЕВОСПИ́ТЫВАТЬСЯ өөрчлөгдөн хүмүүжих, засарч хүмүүжих, сурч хүмүүжих.

ПЕРЕВРА́ТЬ буруу хэлэх, хазгай хэлэх; ~ **фамилию** овгийг хазгай хэлэх; ~ **все факты** бүх баримтыг буруу хэлэх.

ПЕРЕВЫБИРА́ТЬ дахин сонгох.

ПЕРЕВЫБИРА́ТЬСЯ дахин сонгогдох.

ПЕРЕВЫ́БОРН||ЫЙ дахин сонгуулийн, дахин сонголтын; **~ое собрание** дахин сонгуулийн хурал.

ПЕРЕВЫ́БОРЫ дахин сонгох, шинээр сонгох, сонгууль, сонголт.

ПЕРЕВЫБРА́ТЬ дахин сонгох, шинээр сонгох.

ПЕРЕВЫПОЛНЕ́НИЕ давуулан биелүүлэх, илүү гүйцэтгэх, хэтрүүлэн гүйцэтгэх.

ПЕРЕВЫПОЛНИ́ТЬ давуулан биелүүлэх, илүү гүйцэтгэх, хэтрүүлж гүйцэтгэх.

ПЕРЕВЫПОЛНЯ́ТЬ давуулан биелүүлэх, илүү гүйцэтгэх, хэтрүүлэн гүйцэтгэх.
ПЕРЕВЫПОЛНЯ́ТЬСЯ давж биелэх, илүү гүйцэтгэх.
ПЕРЕВЯЗА́ТЬ 1. боох, уях; ~ **рану** шархыг боох; 2. хүлэх, ногтлон боох, хэрж хүлэх, баглах; ~ **пакет верёвкой** боодолтой юмыг шидмэсээр баглах; 3. дахин боох, шинээр боох, дахин сүлжих.
ПЕРЕВЯЗА́ТЬСЯ 1. боох, хүлэх, ороох; 2. боогдох, хүлэгдэх, ороогдох.
ПЕРЕВЯ́ЗК||А боох, боолт; **сделать ~у раны** шархны боолт хийх, шарх боох.
ПЕРЕВЯ́ЗОЧН||ЫЙ боолтын, боолт хийх, *(шарх)* боох; ~ **пункт** боох газар, боолтын тасаг; **~ые материалы** боох хэрэгсэл, боолтын хэрэглэгдэхүүн, боолт хийх материал.
ПЕРЕВЯ́ЗЫВАТЬ 1. боох, уях; 2. хүлэх, ногтлон боох, хэрж хүлэх; 3. дахин боох, шинээр сүлжих.
ПЕ́РЕВЯЗЬ мөрөвч, оосор, өлгөж уях, боолт.
ПЕРЕГА́Р архины үнэр, эхүүн үнэр; **несёт ~ом** архины үнэр үнэртэж байна.
ПЕРЕГИ́Б нугалах, нугалаа; **на ~е листа** хуудасны нугалаан дээр.
ПЕРЕГИБА́ТЬ бөхийлгөх, нугалах, нуга дарах.
ПЕРЕГИБА́ТЬСЯ бөхийх, нугарах, нугалагдах.
ПЕРЕГЛА́ДИТЬ дахин индүүдэх, хуу индүүдэх, цөмийг индүүдэх; ~ **всё бельё** бүх дотоожийг хуу индүүдэх.
ПЕРЕГЛА́ЖИВАТЬ дахин индүүдэх, хуу индүүдэх, цөмийг индүүдэх.
ПЕРЕГЛЯ́ДЫВАТЬСЯ харалцах, бие биеэ харалцах.
ПЕРЕГЛЯНУ́ТЬСЯ харалцах, бие биеэ харалцах.
ПЕРЕГНА́ТЬ 1. түрүүлэх, урд нь орох, гүйцээд түрүүлэх; ~ **всадника** морьтой хүнийг гүйцэж түрүүлэх; 2. туух, тууж аваачих; 3. нэрэх; ~ **нефть** нефть нэрэх.
ПЕРЕГНИВА́ТЬ өмхрөх, үжих, ялзмагших.
ПЕРЕГНО́Й ялзмаг.
ПЕРЕГНУ́ТЬ бөхийлгөх, нугалах; ~ **лист бумаги пополам** хуудас цаасыг голоор нь нугалах; * ~ **палку** дэндүүлэх, хэтрүүлэх, нугалаа гаргах.
ПЕРЕГНУ́ТЬСЯ бөхийх, нугарах, нугалагдах; ~ **через перила** хайсан дээгүүр бөхийх.
ПЕРЕГОВА́РИВАТЬ 1. ярилцах, хэлэлцэх, хөөрөлдөх; ~ **по телефону** телефон утсаар ярилцах; 2. ярьж янших, үглэх, үгээр давах, гартаах.
ПЕРЕГОВА́РИВАТЬСЯ ярилцах, үг солилцох, хөөрөлдөх; ~ **с соседом** хөрштэйгээ ярилцах.
ПЕРЕГОВО́РНЫЙ ярилцах, хэлэлцэх, хөөрөлдөх; ~ **телефонный пункт** телефон утсаар ярилцах тасаг.
ПЕРЕГОВО́РЫ 1. хэлэлцээ; **мирные** ~ энх тайвны хэлэлцээ; **вести** ~ хэлэлцээ хийх; 2. яриа, ярилцах, хөөрөлдөөн; ~ **по телефону** телефон утсаар ярилцах.
ПЕРЕГО́Н 1. хоорондох зай, хоорондын зам; 2. туух, туулт, туулга; ~ **скота** мал туух.
ПЕРЕГО́НКА нэрэх, нэрэлт, нэрлэг; ~ **нефти** нефть нэрэх.
ПЕРЕГО́ННЫЙ нэрэх, нэрэлтийн; ~ **куб** нэрэх тогоо.
ПЕРЕГОНЯ́ТЬ 1. түрүүлэх, урд нь орох, гүйцээд түрүүлэх; 2. туух, тууж аваачих; 3. нэрэх.
ПЕРЕГОРА́ЖИВАТЬ халхлах, далдавчлах, ханаар өрөөг таслах.
ПЕРЕГОРА́ЖИВАТЬСЯ халхлагдах, далдавчлагдах, таслагдах.
ПЕРЕГОРА́ТЬ 1. шатах; 2. ялзмагших, үжих.
ПЕРЕГОРЕ́||ТЬ 1. шатах; **электрическая лампочка ~ла** чийдэн шатав; 2. ялзмагших, үжих; **навоз ~л** өтөг үжжээ, буурцын ялзмаг халжээ.
ПЕРЕГОРОДИ́ТЬ халхлах, далдавчлах, ханаар өрөөг таслах.
ПЕРЕГОРО́ДКА ташаалавч, далдавч, гүйлгээ хана, таславч хана, хананцар.
ПЕРЕГРЕ́В хэт халах, хэт халаах; ~ **котлов** тогоо хэт халах.
ПЕРЕГРЕВА́ТЬ хэт халаах, дэндүү халаах.
ПЕРЕГРЕВА́ТЬСЯ хэт халах, дэндүү халах.
ПЕРЕГРЕ́ТЬ хэт халаах, дэндүү халаах.
ПЕРЕГРЕ́ТЬСЯ хэт халах, дэндүү халах.
ПЕРЕГРУЗИ́ТЬ 1. хэтэрхий ачих, дэндүү ачих, ачааг ихдүүлэх, ачаа хүнддүүлэх; 2. дарах; ~ **работой** ажлаар дарах; 3. шилжүүлж ачих, зөөж ачих.
ПЕРЕГРУ́ЖЕННОСТЬ 1. ачаа хүнддэх, ихдэх; 2. дарагдах, дарах.
ПЕРЕГРУ́ЗКА хэт хүндрэх, хэтэрхий ачих; 2. шилжүүлж ачих, зөөж ачих.
ПЕРЕГРУ́ЗОЧНЫЙ шилжүүлж ачих, дамжуулж ачих.
ПЕРЕГРУППИРОВА́ТЬ өөрчлөн бүлэглэх, өөрчлөн хуваах.
ПЕРЕГРУППИРОВА́ТЬСЯ өөрчлөн бүлэглэх, өөрчлөн хуваагдах.
ПЕРЕГРУППИРО́ВКА өөрчлөн бүлэглэх, өөрчлөн хуваах.
ПЕРЕГРУППИРО́ВЫВАТЬСЯ өөрчлөн бүлэглэх, өөрчлөн хуваагдах.
ПЕРЕГРЫЗА́ТЬ 1. тас химлэх, тас мэрэх; 2. химлэцгээх, мэрцгээх, дуустал химлэчхэх, хуу мэрчхэх.
ПЕРЕГРЫ́ЗТЬ 1. тас химлэх, тас мэрэх; 2. химлэцгээх, мэрцгээх, дуустал химлэчхэх, хуу мэрчхэх.
ПЕРЕГРЫЗ||ТЬСЯ 1. мэрэлдэх, химлэлдэх; **собаки ~лись** нохой химлэлдэв; 2. хэрэлдэцгээх, хэрүүл зарга болох.
ПЕ́РЕД 1. өмнө, урд; ~ **домом** гэрийн өмнө, байшингийн урд; ~ **ним** өмнө нь; **~о мной** миний өмнө, урд нь; 2. өмнө, урьд; **мыть руки ~ едой** хоолны өмнө гараа угаах; 3. өмнө; **отвечать ~ законом** хуулийн өмнө хариуцах; **я ~ вами виноват** би таны өмнө буруутай; 4. дэргэд, жишихэд.
ПЕРЕДАВА́ТЬ 1. өгөх, дамжуулах, дамжуулан өгөх; 2. шилжүүлэн өгөх; 3. мэдээлэх, дуулгах, сонсгох, уламжлан мэдэгдэх; 4. хүргэх; 5. нэвтрүүлэх, 6. уламжлах, илэрхийлэх, гаргаж үзүүлэх; 7. илүү өгөх.
ПЕРЕДАВА́ТЬСЯ 1. нэвтрэх, дамжих, уламжлах, дамжигдах; ~ **из уст в уста** амнаас аманд дамжих; 2. шилжих, шилжин очих; 3. халдах, дамжин халдах.
ПЕРЕДАВИ́ТЬ няц дарах, бяц гишгэх.
ПЕРЕДА́ТОЧНЫЙ дамжилгын, дамжуулах, дамжуулж өгөх.
ПЕРЕДА́ТЧИК дамжуулагч, дамжуулга.
ПЕРЕДА́ТЬ 1. өгөх, дамжуулах, дамжуулж өгөх; 2. шилжүүлэх, шилжүүлэн өгөх; ~ **дело в суд** шүүхэд хэргийг шилжүүлэх; ~ **свои права наследникам** өв залгамжлагчдад эрхээ шилжүүлэн өгөх; 3. мэдээлэх, дуулгах, сонсгох, уламжлан мэдэгдэх; ~ **важную новость** чухал сониныг уламжлан мэдэгдэх; 4. хүргэх; ~ **привет** мэнд хүргэх; 5. нэвтрүүлэх; 6. уламжлах, илэрхийлэх, гаргаж үзүүлэх; 7. илүү өгөх.
ПЕРЕДА́ТЬСЯ 1. нэвтрүүлэх, нэвтрэх, уламжлах, уламжлагдах, дамжуулах, дамжих; **мне передалось его волнение** түүнийг хараад би бас зовчхов; 2. шилжих, шилжиж очих; 3. халдах, халдварлах, дамжин халдах.
ПЕРЕДА́ЧА 1. өгөх, дамжуулах, өгөх, шилжүүлж өгөх; ~ **имущества** эд хөрөнгийг шилжүүлэн өгөх; 2. өгөх юм, эргэлт, дамжуулах юм; 3. нэвтрүүлэг; 4. дамжуулга, араа; ~ **управления** дамжуулга араа, залгах араа.
ПЕРЕДВИГА́ТЬ хөдөлгөх, шилжүүлэх, зайлуулах, цааш нь болгох, нааш нь болгох; ~ **стол** ширээ зайлуулах.
ПЕРЕДВИГА́ТЬСЯ хөдлөх, явах, зайлах, цааш болох, нааш болох.

ПЕРЕДВИЖЕ́НИ||Е явах унаа; **средства ~я** унах унаа, явах хөсөг.
ПЕРЕДВИ́ЖКА нүүдлийн, нүүлт, нүүдэл, цөн түрэлт; **~ льдов в Арктике** умард туйлын цөн түрэлт.
ПЕРЕДВИЖНО́Й 1. нүүдлийн; 2. гүймэг; **~ стол** гүймэг ширээ.
ПЕРЕДВИ́НУТЬ 1. хөдөлгөх, шилжүүлэх, зайлуулах, цааш нь болгох; 2. хойшлуулах, өөрчлөх.
ПЕРЕДВИ́НУТЬСЯ хөдлөх, өөрчлөгдөх, ийш болох, тийш болох.
ПЕРЕДЕ́Л дахин хуваах, хуваах.
ПЕРЕДЕ́ЛАТЬ 1. өөрчлөн засах, засаж хийх, дахиж засах; 2. хийх, бүтээх; **~ много дел за день** өдөртөө их юм хийх.
ПЕРЕДЕЛИ́ТЬ дахин хуваах.
ПЕРЕДЕ́ЛК||А засан сэлбэх, өөрчлөн засах, засаж хийх, дахиж засах, **~ проекта** төслийг өөрчлөн засах; **попасть в ~у** ярших, төвөгт учрах, хэцүү байдалд орох.
ПЕРЕДЕ́ЛЫВАТЬ 1. өөрчлөн засах, дахиж засах; 2. хийх, бүтээх.
ПЕРЕДЕ́ЛЫВАТЬСЯ засрах, засагдах, хувирах.
ПЕРЕДЕРЖА́ТЬ дэндүү удаах, хэтэрхий удаан байлгах; **~ суп на плите** шөл богших.
ПЕРЕДЕ́РЖИВАТЬ дэндүү удаах, хэтэрхий удаан байлгах.
ПЕРЕДЁРГИВАТЬ 1. угзран татах; 2. гуйвуулах, урвуулах, гажуудуулах; 3. булхайлах; 4. татвалзах, зарсхийх.
ПЕРЕДЁРГИВАТЬСЯ татвалзах, татвас хийх, зарс хийх.
ПЕРЕДЁРНУТЬ 1. угзран татах; 2. гуйвуулах, урвуулах, гажуудуулах; **~ факты** баримтыг гуйвуулах; 3. булхайцах; **~ карту** хөзөр булхайцах; 4. татвалзах, зарсхийх.
ПЕРЕДЁРНУТЬСЯ татвалзах, татвас хийх, зарс хийх.
ПЕРЕДНЕЯЗЫ́ЧНЫЙ хэлний урдуурх.
ПЕРЕ́ДН||ИЙ өмнөх, урд, тэргүүн; **~ее колесо** урд дугуй; **на ~ем плане** тэргүүн эгнээнд.
ПЕРЕ́ДНИК хормогч, элгэвч.
ПЕРЕ́ДН||ЯЯ үүдний тасалгаа; **долго ждать в ~ей** үүдний тасалгаанд удаан хүлээх.
ПЕ́РЕДО өмнө, урд, урьд, дэргэд; **~ мной** миний өмнө.
ПЕРЕДОВЕ́РИТЬ,
ПЕРЕДОВЕРЯ́ТЬ итгэмжлэн шилжүүлэх, итгэмжийг шилжүүлэх, дам найдах, дам итгэх.
ПЕРЕДОВИ́К тэргүүн хүн, сайчууд.
ПЕРЕДОВИ́ЦА тэргүүний өгүүлэл.
ПЕРЕДОВО́Й тэргүүний; **~ опыт** тэргүүн туршлага.
ПЕРЕДО́К 1. тэрэгний өмнөх хэсэг, тэрэгний дэлбээ *(дэлбээлж явахад* суух *газар)*; 2. *разг.* эмэгтэй хүний умдагны хэсэг.
ПЕРЕДО́ХНУТЬ үхэж барагдах, үхэцгээх.
ПЕРЕДОХНУ́ТЬ амсхийх.
ПЕРЕДРА́ЗНИВАТЬ,
ПЕРЕДРАЗНИ́ТЬ элэглэх, дуурайж шоолох.
ПЕРЕДРА́ТЬСЯ ноцолдох, ноцолдоцгоох, зодолдох, зодолдоцгоох.
ПЕРЕДРО́ГНУТЬ бээрэх, их даарах.
ПЕРЕДРЯ́Г||А яршигтай байдал, хэцүү юм; **попасть в ~у** яршигтай байдалд орох, хэцүү юманд учрах.
ПЕРЕДУ́МА||ТЬ 1. байх, болих, санаснаа өөрчлөх; **я ~л и завтра не поеду** би маргааш явахаа байлаа; 2. бодсоор байх, бодож бодох, олон юм бодох; **много ~л за это время** энэ хугацаанд олон юм бодлоо.
ПЕРЕДУ́МЫВАТЬ 1. байх, болих, санаснаа өөрчлөх; 2. бодсоор байх, бодож бодох, олон юм бодох.
ПЕРЕДУШИ́ТЬ бүгдийг боож багалзуурдаж алах.
ПЕРЕДЫ́ШК||А 1. амсхийх, амсхийх зав, амрах зав, зай зав өгөх; **гнаться без ~и** амсхийхгүй хөөх; **не давать ~и** амьсгаа авахуулахгүй байх; 2. түр завсарлах, түр зогсох.
ПЕРЕЕДА́ТЬ бялуурах, шартах, пологтох, хэтэрхий идэх; 2. зэврэх, идэх.
ПЕРЕЁЗД 1. нүүх, гатлах; 2. гатлага, гарам, гарц.
ПЕРЕЕЗЖА́ТЬ 1. гатлах, хөндлөн гарах; 2. дайрах, дайрч гарах, дээгүүр нь гарах; 3. нүүх, шилжих.
ПЕРЕЕ́СТЬ 1. бялуурах, шартах, пологтох, хэтэрхий идэх; 2. зэврэх, зэврүүлэх, идэх.
ПЕРЕЕ́ХАТЬ 1. гатлах, хөндлөн гарах; **~ дорогу** зам хөндлөн гарах; 2. дайрах, дайрч гарах, дээгүүр нь гарах; 3. нүүх, шилжих; **~ в новый дом** шинэ байшинд нүүх.
ПЕРЕЖА́РИВАТЬ 1. хэт хайрах, дэндүү шарах, хаттал хуурах; 2. хайрцгаах, шарцгаах, хуурцгаах, цөмийг хайрах, цөмийг шарах.
ПЕРЕЖА́РИТЬ 1. хэт хайрах, дэндүү шарах, хаттал хуурах; 2. хайрах, шарах, хуурах, цөмийг хайрах, цөмийг шарах.
ПЕРЕЖА́РИ||ТЬСЯ хэтэрхий хайрагдах, дэндүү шарагдах, их хуурагдах; **мясо ~лось** мах дэндүү хайрагджээ.
ПЕРЕЖДА́ТЬ тогтохыг хүлээх, өнгөрөхийг хүлээзнэх, дуустал хүлээх; **~ грозу** цахилгаантай бороо өнгөрөхийг хүлээзнэх.
ПЕРЕЖЕВА́ТЬ зажлах, үлтэртэл зажлах, хивэх; **~ пищу** хоол зажлах.
ПЕРЕЖЕНИ́ТЬ гэрлүүлцгээх.
ПЕРЕЖЕ́ЧЬ 1. шатаачхах, дэндүү шатаах, түлчхэх, хэт түлэх; **~ кирпич** туйпуу шатаачхах; 2. түлж дуусах, цөмийг шатаачхах; 3. шатааж болгох; **~ дерево на уголь** мод шатааж нүүрс болгох; 4. тас идэх, зэврүүлж таслах, улайсгаж таслах, шатааж таслах.
ПЕРЕЖЁВЫВАТЬ 1. зажлах, хивэх, үлтэртэл зажлах; 2. улиглаж байх, давтан нурших; **~ всем известные истины** хэн бүхний мэдэх юмыг улиглаж байх.
ПЕРЕЖИВА́НИ||Е сэтгэл хөдлөх, сэтгэл догдлох, гансрал, гаслан; **глубокие ~я** сэтгэл их догдлох.
ПЕРЕЖИВА́ТЬ үзэх, амсах, тэсвэрлэх, сэтгэл догдлох, сэтгэл хөдлөх; **~ трудности** бэрхшээлийг амсах, хэцүү юмыг үзэх.
ПЕРЕЖИГА́ТЬ 1. шатаачхах, дэндүү шатаах, түлчхэх, хэт түлэх; 2. цөмийг шатаачхах; 3. шатааж болох; 4. тас идэх, зэврүүлж таслах, улайсгаж таслах.
ПЕРЕЖИДА́ТЬ тогтохыг хүлээх, өнгөрөөхийг хүлээзнэх, дуустал хүлээх. **ПЕРЕЖИ́ТОЕ** үзсэн юм, өнгөрүүлсэн явдал, амссан зовлон.
ПЕРЕЖИ́ТОК үлдэгдэл; **~ старины** хуучны үлдэгдэл.
ПЕТЛ||Я́ 1. гогцоо, сэгэлдрэг, хөвөрхий; **завязать ~ю** гогцоо зангилах, гогцоо гаргах; 2. гогцоо, шидэл, түдүүл; 3. углуурга, нугас; **дверь соскочила с петель** хаалганы нугас мултрав; 4. дүүжлүүр, дүүжлэх; 5. годройтох, дугуйрах; **мёртвая** ~ годройтох нисэлт; **хоть в ~ю лезь** яах ийх аргагүй болох.
ПЕТРОГРА́ФИЯ чулуулгийн зүй.
ПЕТРУ́ШКА 1. яншуй; 2. овын хөхдэй; 3. алиа салбадай, алиа хүүхэлдэй.
ПЕ́ТТИНГ хурьцал үйлдэхгүйгээр дур хангах.
ПЕТУ́Х 1. эр тахиа, эрэгчин тахиа, азарган тахиа; 2. нанчилдагч, зодолдох дуртай хүн; **встать с ~ами** үүр цүүрээр босох; **пустить красного ~а** түймэр тавих.
ПЕТУ́ШИЙ тахианы; ~ **гребень** тахианы залаа.
ПЕТУШИ́||ТЬСЯ хаахалзах, сагалзах, омогдох, таахалзах; **что ты ~шься?** яагаад чи хаахалзаад байна.

ПЕТУШО́К эр тахиа, жаахан эр тахиа.
ПЕТЬ 1. дуулах; ~ **песню** дуу дуулах; ~ **тенором** цээл хоолойгоор дуулах; 2. донгодох, жиргэх; **соловей поёт** алтан гургалдай донгодож байна.
ПЕХО́ТА явган цэрэг.
ПЕХОТИ́НЕЦ явган цэрэг, явган цэргийн байлдагч.
ПЕХО́ТН||ЫЙ явган цэргийн; **~ые части** явган цэргийн ангиуд.
ПЕЧА́ЛИТЬ гутраах, сэтгэл зовоох, гашуудуулах, гуниглуулах.
ПЕЧА́ЛИТЬСЯ гутрах, сэтгэл зовох, гашуудах, гуниглах; **что ты печалишься?** юунд чи гутрана вэ?
ПЕЧА́Л||Ь 1. гутрал, гуниг, гашуудал, уй гашуу; **в глубокой ~и** гүн гашуудал болох, их уй гашуу болох; 2. зовох, гай; **тебе-то какая ~** чамд зовох хэрэг юу байна; **вот не было ~и** газар дороос гай дэгдэж.
ПЕЧА́ЛЬНО 1. гутрангуй, уй гашуутайгаар, гунигтайгаар; ~ **улыбаться** гунигтайгаар инээмсэглэх; 2. харамсалтай, тоогүй, гунигтай; **~, надо расставаться** салах болсон маань харамсалтай.
ПЕЧА́ЛЬН||ЫЙ 1. уйтгартай, гунигтай, уй гашуутай; **~ая песня** гунигтай дуу; 2. гашуудмаар, харамсмаар; ~ **случай** харамсмаар явдал.
ПЕЧА́ТАНИЕ хэвлэх, барлах, дармаллах.
ПЕЧА́ТАТЬ 1. хэвлэх, барлах, дармаллах; ~ **книги** ном хэвлэх; 2. цохих, машиндах; ~ **на пишущей машине** бичгийн машинаар машиндах; 3. ~ **на компьютере** шивэх.
ПЕЧА́ТАТЬСЯ 1. хэвлэгдэх, барлагдах; **эта книга печатается** энэ ном хэвлэгдэж байна; 2. цохигдох, машиндагдах; 3. хэвлүүлэх, нийтлэх.
ПЕЧА́ТНИК хэвлэгч, хэвлэлийн ажилтан.
ПЕЧА́ТНО хэвлэлээр; ~ **заявить** хэвлэлээр илэрхийлэх.
ПЕЧА́ТН||ЫЙ 1. хэвлэлийн, хэвлэдэг, хэвлэх; **~ая машина** хэвлэх машин; ~ **лист** хэвлэлийн хуудас; 2. хэвлэгдсэн, хэвлэсэн, дармал; **писать ~ыми буквами** дармал үсгээр бичих; 3. хэвийн, шахмал; ~ **пряник** хэвийн боов.
ПЕЧА́Т||Ь I 1. хэвлэл, хэвлэгдэж, хэвлэх нийтлэх; **свобода ~и** хэвлэн нийтлэх эрх чөлөө; ~ **молчания** хэлэхгүйн тангараг.
ПЕЧА́Т||Ь II 1. тамга тэмдэг, тийз; **удостоверить подпись ~ью** гарын үсгийг тамга дарж батлах; **наложить ~и** тамга дарах; 2. хэв, үсгийн хэв; 3. нөлөө.
ПЕ́ЧЕН||Ь 1. элэг; **воспаление ~и** элэг үрэвсэх; 2. **за печёнку брать** аазгай нь хөдлөх.
ПЕЧЕ́НЬЕ хэвийн боов, хайрсан боорцог.
ПЕЧЁН||ЫЙ жигнэсэн, болгосон; **~ая картошка** жигнэсэн төмс.
ПЕ́ЧК||А зуух, пийшин; **истопить ~у** пийшин галлах; **танцевать от ~и** өнөөхөөсөө эхлэх, тулга тойрох.
ПЕЧНИ́К зуухч, зуух хийгч, пийшин хийгч.
ПЕЧН||О́Й зуухны, зуухаар, пийшингийн; **~ое отопление** пийшин түлдэг, зуухаар халдаг; **~ая заслонка** зуухны ам.
ПЕЧУ́РКА 1. зууханцар, жижиг пийшин; 2. зуухны ухмай.
ПЕЧЬ I 1. жигнэх, болгох; 2. шарах, төөнөх; **солнце печёт голову** нар толгой төөнөж байна.
ПЕЧЬ II зуух, пийшин; **железная ~** төмөр зуух; **плавильная ~** хайлуулах пийшин.
ПЕ́ЧЬСЯ I жигнэгдэх, болгогдох.
ПЕ́ЧЬСЯ II бөөцийлэх, асрамжлах, санаа зовох; ~ **о детях** хүүхдийн төлөө санаа зовох.
ПЕШЕХО́Д явган хүн, явгачууд; **дорога для ~ов** явган хүний зам, явган зам.
ПЕШЕХО́ДН||ЫЙ явган, явган хүний; **~ая тропинка** явган зам; ~ **мост** явган хүний гүүр.
ПЕ́ШИЙ явган, явган хүн; ~ **конному не товарищ** явган хүн морьтой хүнд нөхөр биш.
ПЕ́ШК||А 1. хүү, шатрын хүү; **пойти ~ой** хүүгээр нүүх; 2. аялдан дагалдагч, дагалдаахай.
ПЕШКО́М явган, явгаар; **идти ~** явган явах.
ПЕЩЕ́РА агуй; **горная ~** уулын агуй.
ПЕЩЕ́РНЫЙ агуйн, хонгилын; ~ **человек** агуйн хүн.
ПЁС нохой, хав.
ПЁСИЙ нохойн; **пёсья морда** нохойн хоншоор.
ПЁСТР||ЫЙ 1. цоохор, тарлан, эрээн; ~ **ковёр** эрээн хивс; **~ая ткань** цоохор сүлжмэл; 2. цоохор, элдэв янзын, жигд биш.
ПИА́ЛА аяга, онхор аяга.
ПИАНИ́НО төгөлдөр хуур; **играть на ~** төгөлдөр хуураар тоглох.
ПИАНИ́СТ төгөлдөр хуурч.
ПИАНИ́СТКА төгөлдөр хуурч эмэгтэй.
ПИА́НО аяархан.
ПИВНА́Я пивний газар.
ПИВН||О́Й пивийн, шар айргийн; **~ая пена** пивний хөөс.
ПИ́ВО пиво, шар айраг.
ПИВОВА́Р пиво хийгч, пиво эсгэгч, пийвч.
ПИВОВА́РЕННЫЙ пиво хийх, пиво чанах; ~ **завод** пивний завод.
ПИ́ГАЛИЦА 1. зааpаг шувуу; 2. доожгүй хүн, доожоо хүн.
ПИГМЕ́Й 1. өөдсөн хүн, алцаахай, атигар хүн; 2. үхээнц хүн, зэхий хүн.
ПИГМЕ́НТ 1. нөсөө; 2. будаг, бодис, будаг.
ПИДЖА́К костюмын цамц, пиджак.
ПИЖА́МА пижам, гэрийн костюм, унтлагын хувцас.
ПИЙТ шүлэгч, яруу найрагч.
ПИК 1. оргил, шовх орой; 2. ид, ид цаг, хөл ихтэй үе.
ПИ́КА I 1. жад; 2. гилбэр.
ПИ́К||А II зориуд, хорон санаагаар; **в ~у сделать** хорон санаагаар хийх.
ПИКА́НТНЫЙ 1. аагтай, хурц, нялуун; ~ **соус** аагтай хольц; 2. хачин сонин, жигтэй сонирхолтой, гайхалтай; ~ **случай** гайхалтай тохиолдол.
ПИКА́П пикап, суудлын задгай машин, «аавын цээж».
ПИКЕ́ 1. сүлжмэл хээтэй бөс; 2. доошоо нисэх.
ПИКЕ́Т харуул.
ПИ́КИ гилбэр, гилбэрийн.
ПИКИ́РОВАНИЕ доошоо нисэх, доош харваж нисэх, шумбан нисэх.
ПИКИ́РОВАТЬ доошоо нисэх, доош харваж нисэх, шумбан нисэх.
ПИКИ́РОВАТЬСЯ чичилцэх, үг шөргөөлдөх.
ПИКНИ́К хөдөө цайлах, хөдөө наргих.
ПИ́КНУТЬ 1. гинших, гингэнэх, гонгинох; **жалобно ~** хөөрхийлөлтэй гинших; 2. анир гаргах; **он и ~ не смеет** юу ч хэлж зүрхлэхгүй.
ПИ́КОВ||ЫЙ 1. гилбэрийн; **~ая дама** гилбэрийн хатан; 2. хэцүү, ярвигтай, азгүй; **~ое положение** хэцүү байдал, азгүй байдал.
ПИКТОГРА́ФИЯ зураг бичээс.
ПИЛА́ хөрөө; **ленточная ~** гинжин хөрөө.
ПИЛА-РЫБА эдэн загас.
ПИЛЁНЫЙ хөрөөдсөн зүсмэл; ~ **лес** хөрөөдсөн мод.
ПИЛИГРИ́М аянчин, бядан явагч.
ПИЛИ́КАТЬ хяхатнуулах, чарлуулах.
ПИЛИ́ТЬ 1. хөрөөдөх, хэрчих; ~ **дрова** түлээ хөрөөдөх; 2. талхидах, янших.
ПИЛИ́ТЬСЯ хөрөөдөгдөх, хөрөөн даагдах.
ПИ́ЛКА 1. хөрөөдөх; ~ **и колка дров** түлээ хөрөөдөх, хагалах; 2. гар хөрөөд 3. хуурай; ~ **для ногтей** хумсны хуурай.

ПИЛО́Т нисэгч, нисэх онгоцны жолооч.
ПИЛОТА́Ж нисэх чадвар, нисэх мэргэжил; **высший** ~ дээд зэргийн нисэх чадвар.
ПИЛОТИ́РОВАНИЕ жолоодох, нисэх онгоц жолоодох; ~ **самолёта** нисэх онгоц жолоодох.
ПИЛО́ТКА зуны цэрэг малгай, пилотк малгай, нимээхэй малгай.
ПИЛЮ́Л||Я үрэл, үрлэн юм, мөхлөг; ~ **от кашля** ханиалганы үрэл; **подсластить ~ю** гэмээ цагаатгахыг оролдох.
ПИНА́ТЬ өшиглөх.
ПИНГВИ́Н пингвин шувуу, оцон шувуу.
ПИНГ-ПОНГ ширээний теннис.
ПИНО́К өшиглөх, хөлөөр ёврох; **дать пинка** хөлөөр ёврох.
ПИНЦЕ́Т хямсаа.
ПИО́Н цээнэ цэцэг.
ПИОНЕ́Р 1. пионер; 2. үүсгэгч, эхлэгч; ~ **естествознания** байгалийн шинжлэлийг үүсгэгч; 3. анх нутаглагч.
ПИОНЕРВОЖА́ТЫЙ пионерийн удирдагч.
ПИОНЕ́РСКИЙ пионерийн.
ПИПЕ́ТКА дусаагуур.
ПИР найр, хурим; ~ **на весь мир** далай их найр, хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи уух.
ПИРАМИ́ДА 1. цац, суварга, сүндэр, босоо гурвалжин; **финансовая** ~ санхүүгийн суварга; 2. олон шатлалт сүлжээний луйвар.
ПИРАМИДА́ЛЬНЫЙ цац суварган, шувтан, шовх; ~ **тополь** шувтан улиангар.
ПИРА́Т 1. далайн дээрэмчин, дээрэмчин, зандалчин; 2. оюуны өмчийн хулгайч.
ПИРА́ТСК||ИЙ далайн дээрмийн, дээрэмчний, зандалчны; **~ое судно** далайн дээрэмчний онгоц.
ПИРА́ТСТВО далайн дээрэм, дээрэм, муу хулгай.
ПИРИ́Т галтмар.
ПИРОВА́ТЬ найрлах, найр хийх, хуримлах.
ПИРО́Г бялуу, пирог; **воздушный** ~ уушгин бялуу.
ПИРО́ЖНОЕ амттай боорцог.
ПИРОЖО́К хуушуур; ~ **с рисом** цагаан будаатай хуушуур.
ПИРУ́ШКА наргиан, найр цэнгээн.
ПИ́РШЕСТВО их найр, найр хурим.
ПИ́РШЕСТВОВАТЬ найр хийх, найрлах, найр хурим хийх.
ПИСА́КА бичигчээн бологч, бичмэрлэгч, цаас эрээчигч.
ПИСА́НИЕ 1. бичих, зохиох; ~ **под диктовку** цээжээр хэлснийг бичих; 2. бичсэн юм, бичиг, зохиол; **многословное** ~ олон үгтэй бичиг, нуршаа зохиол.
ПИСАНИ́НА бичгэрхүү юм, бичмэр болсон юм; **безграмотная** ~ алдаатай бичгэрхүү юм.
ПИ́САН||ЫЙ бичмэл, бичсэн; **говорить как по ~ому** бичсэн юм шиг ярих, ~ **документ** бичмэл баримт; **~ая красота** зураг шиг сайхан; **это не про него ~о** энэ түүнд хамаагүй.
ПИСА́ТЕЛЬ зохиолч, уран зохиолч.
ПИСА́ТЕЛЬНИЦА зохиолч, уран зохиолч эмэгтэй.
ПИСА́ТЕЛЬСКИЙ зохиолчийн, зохиол бичих; ~ **талант** зохиолчийн билиг, зохиол бичих билиг.
ПИСА́||ТЬ 1. бичих; ~ **мелко** жижгээр бичих; 2. бичих, зохиох, бичиж мэдэгдэх, захидал бичих, зурах, дүрслэх; ~ **портрет хөрөг зурах; ~ акварелью** усан будгаар зурах; 3. бичих, цохих; ~ **на компьютере** шивэх; ~ **на машинке** машиндах, цохих; **дуракам закон не ~н** тэнэгийн дотор уужуу; **не про нас ~но** бидэнд ойлгогдох юм биш.
ПИСА́ТЬСЯ бичих, бичигдэх.
ПИСК час гэх, чарлах.
ПИСКЛИ́ВЫЙ гонгинуур, чарлаа, чарламтгай, гангинах; ~ **голос** гонгинуур дуу.
ПИ́СКНУТЬ час гэх, чарлах, гонгинох.
ПИСКУ́Н гонгинуур, чарлаач.
ПИСТОЛЕ́Т гар буу, ташуур буу.
ПИСТОЛЕ́ТНЫЙ гар бууны, гар буугаар; ~ **выстрел** гар буугаар буудах.
ПИСТО́Н бялт, сумны гал, бүлүүр.
ПИСЧЕБУМА́ЖНЫЙ бичгийн цаасны, цаасны.
ПИ́СЧ||ИЙ бичгийн; **~ая бумага** бичгийн цаас.
ПИСЬМЕНА́ үсэг, үсэг бичиг, эртний үсэг.
ПИ́СЬМЕННОСТЬ 1. бичиг үсэг, бичиг; **древнерусская** ~ эртний оросын бичиг үсэг; 2. бичиг үсэг; **иероглифическая** ~ дүрс бичиг, ханз бичиг; 3. бичиг мэдэх явдал.
ПИ́СЬМЕНН||ЫЙ 1. бичгийн, бичиж сурах; **~ые занятия** бичгийн хичээл, бичиж сурах хичээл; 2. бичгийн; ~ **стол** бичгийн ширээ; **~ые принадлежности** бичгийн хэрэгсэл; 3. бичиг, бичгээр, бичсэн; **изложить просьбу в ~ом виде** хүсэлтээ бичгээр илэрхийлэх.
ПИСЬМ||О́ 1. захидал, захиа, бичиг; **написать** ~ захидал бичих; **заказное** ~ баталгаатай захидал; **открытое** ~ ил захидал; **поздравительное** ~ баяр хүргэх бичиг; 2. бичиг, бичиг хэрэглэх, бичиж; **учиться ~у** бичиж сурах; 3. бичиг, үсэг; **славянское** ~ славян үсэг; **квадратное** ~ дөрвөлжин үсэг.
ПИСЬМОВОДИ́ТЕЛЬ бичиг хэрэг хөтлөгч, бичиг хэргийн эрхлэгч.
ПИТА́НИ||Е 1. тэжээх, хооллох; **искусственное** ~ **больного** өвчтөнийг зохиомол аргаар тэжээх; 2. тэжээл, хоол, идээ, хүнс; **молочное** ~ цагаан идээ; **диетическое** ~ цагаан хоол; **продукты ~я** хүнсний зүйл; 3. хангах, тэжээл; ~ **парового котла водой** уурын тогоог усаар хангах; 4. хүнсний байгууллага, нийлүүлэх явдал.
ПИТА́ТЕЛЬНОСТЬ өл шим, шим тэжээл, өвс; ~ **молочной пищи** цагаан идээний шим тэжээл.
ПИТА́ТЕЛЬН||ЫЙ 1. шимтэй, өлтэй, өег, тэжээлтэй; **~ая пища** өлтэй хоол, өег хоол; 2. хангах, тэжээгүүр; ~ **насос** тэжээгүүр хөөрцөг; 3. тэжээлт, зохимжтой.
ПИТА́ТЬ 1. тэжээх, хооллох; ~ **больного** өвчтөнийг хооллох; 2. хангах, өгөх; ~ **надежду** найдах, итгэх, горьдох; ~ **сочувствие** өрөвдөх; ~ **доверие** итгэж байх; ~ **ненависть** жигшиж байх.
ПИТА́ТЬСЯ 1. хооллох, идэх; ~ **фруктами** жимсээр хооллох; 2. тэжээгдэх, тэжээл хийх; 3. хэрэглэх, хангагдах.
ПИТО́МЕЦ хүмүүжигч, хүмүүжсэн хүн; ~ **университета** их сургуулиар хүмүүжсэн хүн.
ПИТО́МНИК өсгөх газар, бойжуулах газар, торниулах газар.
ПИТЬ 1уух, ундаасах; ~ **чай** цай уух; **мне хочется** ~ би юм уумаар байна; 2. уух, дугараа барих; ~ **за здоровье друзей** найз нарын эрүүл мэндийн төлөө уух; 3. уух, балгах, архидах; **как ~ дать** заавал.
ПИТЬЕВ||О́Й уух, ууж болох, унд; **~ая вода** уух ус, ундны ус.
ПИТЬ||Ё унд, ууж, уух; **годный для ~я** ууж болох; **очень вкусное** ~ их аятайхан ундаа.
ПИХНУ́ТЬ 1. түлхэх, ёврох; ~ **кого-нибудь локтями** хүнийг тохойгоор ёврох; 2. чихэх, гудрах.
ПИ́ХТА жодоо, цөөрс, шар харгай.
ПИ́ЦЦА пицца.
ПИ́ЧКАТЬ шахах, шахаж идүүлэх, шахаж сургах, шавдах; ~ **едой** хоолоор шахах.
ПИЧУ́ГА шувуухай.
ПИ́ШУЩИЙ 1. бичигч,бичиж байгаа хүн; ~ **эти строки** үүнийг бичигч, энэ мөрүүдийг бичиж байгаа хүн; 2. бичих, бичгийн.
ПИ́Щ||А 1. хоол, идээ хүнс; **здоровая** ~ эрүүл хүнс; **лёгкая** ~ хөнгөн хоол 2. тэжээл, сайхан хужир, сэдэв, шалтаг; **духовая**

~ сэтгэлийн тэжээл; ~ **для размышления** шүүмжлэн бодох сэдэв; **дать ~у чему-нибудь** юманд шалтаг олгох.

ПИЩА́ЛЬ үхэр буу, их буу, онгоронз буу.

ПИЩА́ТЬ час гэх, гонгинох, гангиналдах; **птенцы пищат** дэгдээхэй гангиналдаж байна.

ПИЩЕВАРЕ́НИ||Е хоол шингээх, хоол боловсруулах; **расстройство ~я** хоол шингэхгүй болох, хоол шингэхээ болих.

ПИЩЕВАРИ́ТЕЛЬН||ЫЙ хоол шингээх, хоол боловсруулах; **~ые процессы** хоол шингээх явц.

ПИЩЕВО́Д улаан хоолой.

ПИЩЕВ||О́Й хүнсний, хоол хүнсний; **~ая промышленность** хүнсний үйлдвэр.

ПИЩУ́ХА үхэр огдой.

ПИЯ́ВК||А хануур хорхой, цус сорох хорхой; **ставить ~и** хануур хорхой тавих.

ПЛА́ВАНИЕ 1. усчлах, сэлэх, самрах, оймох; 2. усаар явах, далайн аян, усан замаар явах, туулах; **кругосветное ~** дэлхийг тойрон усаар явах; **дальнее ~** алсын далайн аян, алсад усан замаар явах.

ПЛА́ВАТЕЛЬНЫЙ усчлах самрах хөвөх, шумбах; ~ **бассейн** шумбах цөөрөм.

ПЛА́ВА||ТЬ 1. самрах, усчлах, оймох, сэлэх; **он хорошо ~ет** тэр сайн сэлдэг; 2. хөвөх; 3. тээнэгэлзэх, таамаглан хариулах; ~ **на экзамене** шалгалт дээр таамаглан хариулах; **мелко ~** хөвөөгөөр нь хөвөх, ялигүй усанд шалигүй хөвөх.

ПЛАВИ́ЛЬНИК хайлуур.

ПЛАВИ́ЛЬН||ЫЙ хайлах, хайлуулах; **~ая печь** хайлах зуух.

ПЛА́ВИТЬ хайлуулах, хайлах; ~ **металл** төмөрлөгийг хайлах.

ПЛА́ВИТЬСЯ хайлах.

ПЛА́ВКА 1. хайлуулах, хайлах; ~ **чугуна** ширэм хайлах; 2. хайлмаг, хайлуулалт; **первая ~ чугуна** ширмийн түрүүчийн хайлмаг.

ПЛА́ВКИЙ хайламтгай; ~ **металл** хайламтгай төмөрлөг.

ПЛА́ВКОСТЬ хайламтгай чанар.

ПЛАВЛЕ́НИ||Е хайлах, хайллага, хайлалт; **точка ~я** хайлах цэг.

ПЛА́ВЛЕНЫЙ зөөлөн, зөөлхөн; ~ **сыр** зөөлөн бяслаг.

ПЛАВНИ́К сэрвээ, загасны сэрвээ, живэр.

ПЛА́ВНОСТЬ 1. намуухан, жигд зөөлөн; 2. урсах, жигд урсах.

ПЛА́ВН||ЫЙ 1. намуухан, жигд зөөлөн; ~ **танец** намуухан бүжиг; **~ая походка** жигд зөөлөн явах; 2. урсах, жигд урсах.

ПЛАВУ́ЧЕСТЬ хөвөх чанар, хөвш.

ПЛАВУ́Ч||ИЙ хөвдөг, хөвүүр, хөвөх; ~ **мост** хөвүүр гүүр; **~ая льдина** хөвөх мөс, цөн.

ПЛАГИА́Т зохиолын, оюуны бүтээлийн хулгай.

ПЛАГИА́ТОР зохиолын хулгайч.

ПЛА́ЗМА 1. плазма, цусны шингэн; 2. сийвэн.

ПЛАКА́Т плакат, зурагт хуудас, зарлал зураг.

ПЛАКА́ТНЫЙ зурагт хуудасны, зургийн; ~ **рисунок** зурагт хуудасны зураг.

ПЛА́КА||ТЬ уйлах, ухилах; ~ **от радости** баярлаж уйлах; **горько ~** гашуудан ухилах; * **~ли мои денежки** мөнгө маань үрэгдлээ; **денег кот наплакал** туулай шээсэн мөнгөтэй. **«и ~, и смеяться»** инээхэд ихдэх, уйлахад багадах хэрэг.

ПЛА́КАТЬСЯ уйлах, гоморхох, гомдох; ~ **на свою судьбу** хувь заяандаа гомдох.

ПЛА́КСА уйламтгай, уйлагнуур, уйланхай,

ПЛАКСИ́ВЫЙ 1. уйламтгай, уйланхай; ~ **ребёнок** уйламтгай хүүхэд; 2. уйлагнуур, уйлагнасан.

ПЛАКУ́Ч||ИЙ унжгар, салбагар; **~ая ива** унжгар уд; **~ая берёза** салбагар хус.

ПЛАМЕНЕ́||ТЬ улалзах, улайх, дөл гарах; **закат ~ет** шингэх нарны туяа улайна.

ПЛА́МЕНН||ЫЙ 1. хурц туяа, бадрангуй, гиймэл; ~ **закат** шингэх нарны хурц туяа; 2. цогтой, цогт, халуун, дүрэлзсэн; **~ая любовь** дүрэлзсэн янаг сэтгэл.

ПЛА́М||Я дөл улалзах; **охваченный ~енем** дөлд автагдсан; **из искры возгорится ~** очоос дөл бадарна.

ПЛАН 1. төлөвлөгөө; **выполнить ~** төлөвлөгөө биелүүлэх; 2. дэвсгэр зураг, зураг; ~ **города** хотын дэвсгэр зураг; 3. тал; **передний ~ картины** зураг дээрх дүрслэлийн наад тал; 4. зэрэг; **выдвинуть на первый ~** тэргүүн зэрэгт дэвшүүлэх; **на первом ~е** хамгийн түрүүнд.

ПЛАНЕРИ́ЗМ планёраар нисэх чадвар.

ПЛАНЕРИ́СТ планерист, хөдөлгүүргүй онгоцоор нисэгч.

ПЛАНЁР планёр, хөдөлгүүргүй нисэх онгоц, дэгдүүр.

ПЛАНЁРНЫЙ планёрын, хөдөлгүүргүй нисэх онгоцны.

ПЛАНЕ́Т||А гараг, гариг; **большие ~ы** том гаригууд.

ПЛАНЕТА́РИЙ одон гараг үзүүлэх газар, од гараг үзүүлэх хэрэгсэл, планетари, одны бөмбөгөр.

ПЛАНЕ́ТН||ЫЙ гаригийн; **~ая система** од гаригийн систем, гаригийн тогтолцоо.

ПЛАНИ́РОВАНИЕ I төлөвлөлт.

ПЛАНИ́РОВАНИЕ II халин буух, халин нисэх.

ПЛАНИ́РОВАТЬ I төлөвлөх, төлөвлөгөө зохиох; ~ **здание** байшин барих төлөвлөгөө зохиох.

ПЛАНИ́РОВАТЬ II халин буух, халин нисэх.

ПЛАНИРО́ВКА 1. *төлөвлөлт, төлөвлөмж*; ~ **участка земли** хэсэг газрын төлөвлөмж; 2. тэгшлэх, тэгшлэн засах.

ПЛАНИРО́ВЩИК төлөвлөгөө гаргагч, төлөвлөн зурагч.

ПЛА́НКА 1. самбар, харуулдсан банз; 2. хөндлөвч.

ПЛАНОВИ́К төлөвлөгч, төлөвлөгөөний мэргэжилтэн.

ПЛА́НОВОСТЬ төлөвлөгөөтэй байдаг, төлөвлөгөөтэй явдал.

ПЛА́НОВ||ЫЙ 1. төлөвлөгөөт, төлөвлөгөөтэй; **~ая экономика** *төлөвлөгөөт эдийн засаг*; 2. *төлөвлөгөөний*; **~ая комиссия** төлөвлөгөөний комисс; ~ **отдел** төлөвлөгөөний хэлтэс.

ПЛАНОМЕ́РНО тогтсон төлөвлөгөөтэй, төлөвлөгөөтэй жигд.

ПЛАНОМЕ́РНОСТЬ тогтсон төлөвлөгөөт журам, төлөвлөгөөтэй жигд байдаг нь.

ПЛАНОМЕ́РН||ЫЙ тогтсон төлөвлөгөөт, төлөвлөгөөтэй жигд, жигд журамтай, тогтмол; **~ые занятия** төлөвлөгөөтэй жигд хичээл.

ПЛАНТА́ТОР тариалангийн эзэн.

ПЛАНТА́ЦИЯ 1. онцгой тариалан, тариалангийн онцгой газар; 2. плантаци, тариалах аж ахуй.

ПЛАНШЕ́Т планшет, самбар, зураглалын самбар, гэрэлтүүр цүнх.

ПЛАСТ давхарга, давхарлаас; ~ **снега** цасны давхарга; ~ **почвы** хөрсний давхарга; **лежать ~ом** сунаж хэвтэх.

ПЛА́СТИКА 1. пластик, дүрслээ, овор дүрсэлбэр, оворт урлаг; 2. гунхалзал, нахилзал, уран хөдлөл; 3. сэлбэх, сэлбэх ажилбар.

ПЛАСТИЛИ́Н пластилин, тосон шавар, тослог шавар, баримлын шавар.

ПЛАСТИ́НА ялтас, хавтас; **железная ~** төмөр ялтас; **замочная ~** цоожлох хавтас.

ПЛАСТИ́НКА 1. ялтас; **цинковая ~** цайран ялтас; 2. пянз; **долгоиграющая ~** удаан тоглох пянз.

ПЛАСТИ́НОЧНЫЙ 1. ялтас хэрэглэдэг, ялтаст; 2. пянз хэрэглэдэг, пянзат.

ПЛАСТИ́НЧАТЫЙ 1. ялтаст, ялтсан, ялтастай; 2. салбант.

ПЛАСТИ́ЧЕСК||ИЙ 1. пластик, оворт урлагийн; 2. гунхалзах; **~ое движение** гунхалзах хөдлөл; 3. нөхөх, сэлбэх; **~ая операция** сэлбэх мэс засал.

ПЛАСТИ́ЧНОСТЬ 1. уран хөдлөл, гунхалзал; 2. харимхай, уянцар, туялзуур.
ПЛАСТИ́ЧНЫЙ 1. уран хөдлөлт, гунхалзсан; 2. уян харимхай, уянцар, туялзуур.
ПЛАСТМА́СС||А хуванцар; **изделия из ~ы** хуванцраар хийсэн эдлэл.
ПЛАСТОВА́ТЬ давхарлах, үелэн давхарлах, явтлах.
ПЛА́СТЫРЬ гоюу, наалтуур; **липкий ~** наалдангир гоюу.
ПЛА́Т||А 1. төлбөр төлөх; **производить ~у** төлбөрийг төлөх; 2. цалин хөлс, ацаг; **заработная ~** ажлын хөлс, цалин; 3. төлбөр, хөлс; **квартирная ~** байрын хөлс; **арендная ~** түрээсний төлбөр; 4. ачийн хариу, харамж.
ПЛАТЕ́ЛЬЩИК төлөгч; **~ налогов** татвар төлөгч.
ПЛАТЁЖ 1. төлбөр, төлөх, тооцоо; **~ налогов** татвар төлөх; **соглашение о торговле и ~ах** худалдаа тооцооны хэлэлцээр; 2. төлбөрийн мөнгө.
ПЛАТЁЖЕСПОСО́БНОСТЬ төлөх чадал, өр төлөх чадвар, төлөх бололцоо.
ПЛАТЁЖЕСПОСО́БНЫЙ төлөх чадалтай, өр төлөх чадвартай, төлөх бололцоотой.
ПЛАТЁЖН||ЫЙ өр төлөх, төлбөрийн; **~ день** төлөх өдөр; **~ое обязательство** төлөх үүрэг, төлөх уялга; **~ая ведомость** төлбөрийн хүснэгт; **~ баланс** төлбөрийн баланс.
ПЛА́ТИНА цагаан алт, платин.
ПЛА́ТИНОВ||ЫЙ цагаан алтан, цагаан алтны; **~ые изделия** цагаан алтан эдлэл; **~ая руда** цагаан алтны хүдэр.
ПЛАТИ́ТЬ 1. төлөх, хураалгах; **~ за покупку** авсан юмны үнийг төлөх; **~ наличными** бэлэн мөнгөөр төлөх; **~ за квартиру** байрын хөлсийг хураалгах; 2. хариулах, ач хариулах; **~ услугой за услугу** тусыг тусаар хариулах; **~ той же монетой** мөн тийм л янзаар хариулах.
ПЛАТИ́ТЬСЯ хохирох, хохироох.
ПЛА́ТНЫЙ 1. төлбөртэй, мөнгө төлж; 2. хөлсний.
ПЛАТО́ бэгэлцэг хавтгай.
ПЛАТО́К алчуур; **носовой ~** нусны алчуур.
ПЛАТОНИ́ЧЕСК||ИЙ зөвхөн сэтгэлийн, хийсвэр, хуурай, хоосон; **~ интерес** хийсвэр сонирхол; **~ие мечты** хоосон мөрөөдөл.
ПЛАТФО́РМА 1. тавцан; **~ пассажирская** зорчигчдын тавцан; 2. хашлагат вагон; 3. мөрийн хөтөлбөр.
ПЛА́ТЬЕ 1. хувцас, хувцас хунар; 2. тэрлэг, даашинз.
ПЛАТЯНО́Й хувцасны, хувцасны шүүгээ.
ПЛАФО́Н таазны зураг, хэзтэй тааз; 2. дэнгийн хагас бүрхүүл.
ПЛА́ХА 1. хэрчим мод, хагас хэрчим мод; 2. цаазаар аваачих тавцан.
ПЛАЦ талбай, дэвжээ; **учебный ~** цэрэг сургуулилах талбай.
ПЛАЦДА́РМ түшиц газар, байлдааны түшиц газар.
ПЛАЦКА́РТНЫЙ суудалтай билетийн; **~ вагон** хагас зөөлөн суудалтай вагон.
ПЛАЧ 1. уйлаан, орилоон, уйлах, орилох; 2. гашуудлын дуу.
ПЛАЧЕ́ВН||ЫЙ 1. уйлагнасан, гонгиносон; 2. хөөрхийлөлтэй, харамсалтай, гаслалтай; **~ое положение** хөөрхийлөлтэй байдал; **~ результат** харамсалтай үр дүн; **~ конец** гаслалтай төгсгөл.
ПЛА́ЧУЩИЙ уйлж байгаа, уйлагнасан; **~ ребёнок** уйлж байгаа хүүхэд; **~ голос** уйлагнасан хоолой.
ПЛАШМЯ́ 1. хавтгай, хажуу; 2. гэдрэг, уруугаа харж; **упасть ~** гэдрэг унах, уруугаа харж унах.
ПЛАЩ цув; **~ непромокаемый** борооны цув; **~ с капюшоном** юүдэнтэй цув.
ПЛАЩ-ПАЛА́ТКА цуван майхан, борооны майхан.
ПЛЕБЕ́Й плебей, борчууд, сумын ард.
ПЛЕБИСЦИ́Т бүх хүн амын санал хураалт.
ПЛЕ́ВА хальс, налхи, онгон хальс.
ПЛЕВА́ТЕЛЬНИЦА нулимуур.
ПЛЕВА́ТЬ 1. нулимах, нялмах; 2. хамаагаа алдах, тоохоо болих, хамаагүй болох; **ему ~ на всё** тэр хамаагаа алдсан хүн, түүнд яасан ч хамаагүй болжээ; **~ на всё** өөдөө харж өвчүүндээ нулимж хэвтэх.
ПЛЕВА́ТЬСЯ нулимах, нулималдах, түй гэж нулимах.
ПЛЕВО́К нулимдас, нулимсан шүлс.
ПЛЕ́ВРА цээжний гялтан, хальс; **~ сердечной сорочки** үнхэлцгийн гялтан.
ПЛЕВРИ́Т плеврит, гялтантас, уушигны хальс үрэвсэх.
ПЛЕД нөмрөх алчуур, том ноосон алчуур.
ПЛЕ́ЕР соронзон хуурцаг тоглуулагч.
ПЛЕЙБО́Й алиа салбадай, хүүхний тэнгэртэй залуу.
ПЛЕКСИГЛА́С тунгалаг, өнгөгүй хуванцар.
ПЛЕМЕННО́Й 1. аймгийн, угсааны, аймаг угсааны; **~ быт** аймаг угсааны аж байдал; 2. сайн үүлдрийн, үржлийн; **~ скот** сайн үүлдрийн мал.
ПЛЕ́М||Я 1. аймаг угсаатан, ястан, овогтон; **кочевые ~ена** нүүдэлчин аймгууд; 2. үеийнхэн.
ПЛЕМЯ́ННИК ач, ач хүү, зээ, зээ хүү.
ПЛЕМЯ́ННИЦА 1. ач охин, зээ охин; 2. *разг.* нууц амраг.
ПЛЕН 1. олзлох, олзлогдох, бууж өгөх; **брать в ~** олзлох; **сдаваться в ~** олзлогдох; 2. автагдах, эрхэнд орох; **в ~у предрассудков** мухар сүсэгт автагдах.
ПЛЕНА́РН||ЫЙ бүгд, өргөн; **~ое заседание** бүгд хуралдаан.
ПЛЕНИ́ТЕЛЬН||ЫЙ дур булаам, сэтгэл татмаар; **~ая красота** дур булаам үзэсгэлэн.
ПЛЕНИ́ТЬ I олзлох, олзолж авах, барьж авах.
ПЛЕНИ́ТЬ II дур булаах, сэтгэл татах; **~ своей красотой** үзэсгэлэнгээрээ дур булаах; **~ своим умом** ухаанаараа хүний сэтгэл татах.
ПЛЕНИ́ТЬСЯ дур булаагдах, сэтгэл татагдах; **~ красотой** үзэсгэлэнд сэтгэл татагдах.
ПЛЕ́ННИК олзлогдсон хүн, баригдсан хүн.
ПЛЕ́ННЫЙ олзлогдсон; **~ воин** олзлогдсон цэрэг.
ПЛЕ́НУМ бүгд хурал.
ПЛЕНЯ́ТЬ I олзлох, олзолж авах, барьж авах.
ПЛЕНЯ́ТЬ II дур булаах, сэтгэл татах.
ПЛЕНЯ́ТЬСЯ дур булаагдах, сэтгэл татагдах.
ПЛЕОНА́ЗМ ойролцоо үг давтах.
ПЛЕ́СЕНЬ хөгц, бурь, буриваа, хинэ; **покрыться ~ю** хөгцөөр бүрхэгдэх, хөгцрөх.
ПЛЕСК цалгах, цалгиа; **~ моря** тэнгисийн цалгиа; **~ весел** сэлүүрийн цалгиа.
ПЛЕСКА́ТЬ 1. цалгих, цалгиж цохих, дэлдэх; **волны плещут о берег** долгио эргээ дэлдэнэ; 2. сүрших, цацах; 3. цалгиулах, асгах; **~ на пол** шал руу цалгиулах; 4. намилзах, таших.
ПЛЕСКА́ТЬСЯ 1. цалгилах, цалгиж дэлдэх, цохилох; **вода плещется о берег** ус эргээ дэлдэж цалгилна; 2. сүршилцэх.
ПЛЕ́СНЕВЕТЬ бурьтах, хөгцрөх.
ПЛЕСНЕВО́Й хөгцийн, бүрийн; **~ грибок** хөгцийн мөөгөнцөр.
ПЛЕСНУ́ТЬ 1. цалгих, цалгиж цохих, цалгиж дэлдэх; 2. сүршиж цацах.
ПЛЕСТИ́ 1. сүлжих, гөрөх; **~ венок** титэм гөрөх; **~ кружева** сүлжмэл угалз сүлжих; **~ корзину** шээзгий сүлжих, саг сүлжих; 2. **хөнөөх, хийх, гаргах; ~ интригу** далдуур хөнөөх; **~ козни** хор хөнөөл хийх; 3. дэлгэх, чалчих; **~ чушь** дэмий үг дэлгэх.
ПЛЕСТИ́СЬ гэлдрэх, сажилж явах; **~ в хвосте** сүүлд нь гэлдэрч явах.

ПЛЕТЕ́НИЕ 1. гөрөх, сүлжих; 2. гөрлөөс, сүлжээс, гөрмөл юм.
ПЛЕТЕ́НЬ бургасан хашаа, гөрмөл хашаа.
ПЛЕТЁНКА сүлжмэл сав, гөрмөл саг.
ПЛЕТЁН||ЫЙ сүлжмэл, гөрмөл; ~ **стол** сүлжмэл ширээ; **~ая корзина** гөрмөл шээзгий.
ПЛЕТЬ 1. гөрмөл ташуур, хөгнөн иш, хөгнүүр, иш зэл; ~ **тыквы** гуаны зэл.
ПЛЕЧЕВ||О́Й мөрний, бугалганы, харьтын; ~ **сустав** мөрний үе, буталганы үе; **~ая кость** бугалга, атгаал.
ПЛЕ́ЧИКИ 1. мөрөвч; 2. өлгөөс, бөгтрөө мод; 3. мөрний цаваг, мөрний зузаалга.
ПЛЕ́ЧИКО *мөр, бөгтрөө өлгүүр.*
ПЛЕЧИ́СТЫЙ мөрөлхөг, өргөн мөртэй, өргөн цээжтэй, ханхар; ~ **мужчина** өргөн цээжтэй эр, ханхар эр.
ПЛЕЧ||О́ 1. мөр, бугалга; **взвалить на ~** мөрөндөө үүрэх; **~ом к ~у** мөр зэрэгцэн; **похлопать по ~у** мөрийг алгадах; **пожимать ~ами** мөрөө хавчих, гав гайхах, ердөө мэдэхгүй байдал үзүүлэх; **как гора с плеч свалилась** айхтар юмнаас салж амрах; **с плеч долой** мултарч санаа амрах; **по ~у** чадал хүрмээр; **выносить на своих ~ах** бүгдийг өөрөө хийх.
ПЛЕШИ́ВЕТЬ халзан болох, халзрах, хожгор болох.
ПЛЕШИ́ВЫЙ халзан, хожгор.
ПЛЕ́ШИН||А халцархай, халцгай; **собака с ~ой на боку** халцархай бөөртэй нохой.
ПЛЕШЬ халзан.
ПЛЕЯ́ДА жавхаатан, цолмонгууд, гялалзсан однууд.
ПЛЕЯ́ДЫ мичид, зургаан мичид, хэртиг.
ПЛЁВЫЙ өөдлөхгүй, шалихгүй, хялбархан.
ПЛЁНК||А 1. хальс, хөрс, өрөм; 2. плёнк, хальс; **проявить ~у** хальс угаах.
ПЛЁНОЧНЫЙ хальст, хальстай.
ПЛЁС цүнхээг.
ПЛЁТКА ташуур, мянаа; **ремённая ~** суран ташуур.
ПЛИ́НТУС шалны хөвөө, ханын хажаас.
ПЛИС хилэн.
ПЛИССЕ́ хуниас, хуниадас.
ПЛИССИРО́ВАНН||ЫЙ хунисан, хуниастай; **~ая юбка** хуниастай банзал.
ПЛИССИРОВА́ТЬ хуних, хуниас хийх.
ПЛИТ||А́ 1. хавтан, хавтгай; **мраморная ~** хавтан гантиг, хавтгай гантиг; 2. зуух; **жарить на ~е** зуухан дээр шарах.
ПЛИ́ТКА 1. хавтанцар, хавтгай, дөрвөлжин, тэвхэр; ~ **шоколада** хавтгай шоколад; 2. зуух, хоовон; **электрическая ~** цахилгаан зуух.
ПЛИ́ТОЧНЫЙ хавтан, дөрвөлжин, тэвхэр, шахмал.
ПЛОВ полоов, плов, цагаан будаатай хуурга.
ПЛОВЕ́Ц усч, усчилагч, самрагч, сэлэгч; **искусный ~** чадамгай усчилагч.
ПЛОД 1. жимс; **съедобные ~ы** иддэг жимс; 2. үр, хүүхэд, ураг, хээл; ~ **в утробе матери** эхийн умай дахь ураг; 3. үр, дүн, ач, арандаг; **~ы размышлений** эргэцүүлэн бодсоны ач; **пожинать ~ы своего труда** хийсэн ажлынхаа үрийг амсах; ~ **небрежности** анхаарамжгүйн арандаг, **запретный ~** хоригтой зүйл, цээртэй юм.
ПЛОДИ́ТЬ 1. төрөх, гаргах; 2. үржүүлэх, олшруулах.
ПЛОДИ́ТЬСЯ үржих, өсөх, олшрох; **кролики быстро плодятся** молтогчин туулай хурдан үрждэг.
ПЛО́ДНЫЙ 1. үртэй, үрийн, жимстэй, жимсний; 2. үр өгөх, жимс өгөх. **ПЛОДОВИ́ТОСТЬ** 1. үржилт, өсөлт, олшролт; 2. бүтээмж, их юм бичих.
ПЛОДОВИ́ТЫЙ 1. үржих, олшрох; 2. бүтээмжтэй, их юм бичдэг; ~ **учёный** их юм бичдэг эрдэмтэн.
ПЛОДОВО́ДСТВО жимс тарих, жимсний аж ахуй.
ПЛОДОВО́ДЧЕСКИЙ жимс тарих, жимс тариалах, жимс үржүүлэх.
ПЛОДОНОСИ́ТЬ жимс өгөх, ургац өгөх; **молодая яблоня начала ~** лимын залуу мод жимс өгч эхлэв.
ПЛОДОНО́СН||ЫЙ жимс өгөх, жимстэй; **~ые растения** жимстэй ургамал.
ПЛОДОРО́ДИЕ ургац сайтай, үржил шим, өн; ~ **почвы** хөрсний шим.
ПЛОДОРО́ДН||ЫЙ үржил шимтэй, ургац сайтай; **~ая почва** үржил шимтэй хөрс.
ПЛОДОТВО́РНОСТЬ үр бүтээл, ач тус.
ПЛОДОТВО́РНЫЙ үр бүтээлтэй, ач тустай; ~ **труд** үр бүтээлтэй хөдөлмөр.
ПЛО́МБ||А 1. ломбо, пломба, хавчуур, тийз; **наложить ~у на дверь** хаалганд ломбо тавих; 2. ломбо, гагнаа, бөглөө; **установить ~у в зуб** шүдэнд ломбо тавих, шүдэнд гагнаа тавих.
ПЛОМБИРОВА́ТЬ 1. ломбодох, ломбо тавих, тийздэх; **накладывать пломбу на товар** бараа ломбодох; 2. ломбодох, гагнаа тавих, бөглөх; ~ **зубы** шүдэнд ломбо тавих, шүдэнд гагнаа тавих.
ПЛОМБИРО́ВАНН||ЫЙ 1. ломбодсон, ломботой, ломбо тавьсан, тийзэдсэн; ~ **товар** ломбодсон бараа; 2. ломбодсон, ломботой, гагнаа тавьсан, бөглөөсөн; **~ые зубы** ломбо тавьсан шүд, гагнаа тавьсан шүд.
ПЛО́СК||ИЙ 1. хавтгай; **~ая крыша** хавтгай дээвэр; **~ая поверхность** хавтгай гадарга; **~ая тарелка** хавтгай таваг, хавтгай пял; 2 заваан; **~ая шутка** заваан шог.
ПЛОСКОГО́РЬЕ шил, ухаа, өндөр тэгш газар; **холмистое ~** дов толгодтой шил.
ПЛОСКОГРУ́ДЫЙ хавчгар цээжтэй.
ПЛОСКОГУ́БЦЫ өрөлбө, бахь.
ПЛОСКОДО́ННЫЙ хавтгай ёроолтой; **~ая лодка** хавтгай ёроолтой завь.
ПЛОСКОСТО́ПИЕ хавтгай тавхай, хавтгай өлмий.
ПЛО́СКОСТ||Ь 1хавтгай, хавтаг, талбай; ~ **поверхности** хавтгай гадарга; **наклонная ~** налуу хавтгай; **горизонтальная ~** хэвтээ хавтгай; **линия на ~и** хавтаг дээрх шугам; **спинная ~** нурууны талбай; 2. тал, талаар, талаас; 3 заваан; **говорить ~и** заваан юм ярих.
ПЛОТ сал, дүнз, **дрова шли по реке ~ами** голын усанд салаар түлээ урсаж явав.
ПЛОТВА́ улаан нүдэн.
ПЛОТИ́НА далан, хаалт, ус хаах далан.
ПЛО́ТНИК модчин, модоч, модны дархан, мужаан.
ПЛО́ТНИЧАТЬ модны дарх хийх, мод дархлах, мужааны ажил хийх.
ПЛО́ТНИЧ||ИЙ модоч дархны, мужааны, мод дархлах; **~ьи инструменты** мужааны багаж.
ПЛО́ТНО 1. нягтаар, шигүү, чанга; 2. тулгаж, яг тулгаж; 3. сайн, чанга; ~ **закрыть дверь** үүд сайн хаах; ~ **сжать зубы** шүдээ чанга зуух; 4. цадтал, сайн; ~ **поесть** цадтал идэх, сайн идэх.
ПЛО́ТНОСТЬ нягт, нягтрал, нягтшил, шигүү; ~ **ткани** нэхмэлийн нягт нь; ~ **населения** хүн амын нягт сийрэг; ~ **снега** цасны нягт.
ПЛО́ТН||ЫЙ 1. нягт; **~ая ткань** нягт нэхмэл; 2. нягт, шигүү; 3. зузаан, чамбай; 4. шигүү, чихмэл, зузаан; ~ **бумажник** зузаан хэтэвч; 5. бадируун; 6. өөг, цатгалан, сайн; ~ **обед** өөг хоол, үдийн сайн хоол.
ПЛОТОВО́Д салчин.

ПЛОТОВЩИ́К 1. сал хийдэг ажилчин; 2. юм салаар тээвэрлэдэг хүн.

ПЛОТОЯ́ДН||ЫЙ 1. махчин, махч; ~ **зверь** махчин араатан; 2. хурьцангуй, тачаангуй; **~ая улыбка** хурьцангуй инээмсэглэх.

ПЛО́ТСК||ИЙ хүсэл, тачаангуй; **~ое желание** тачаангуй шунал.

ПЛОТ||Ь бие, мах, махбод; ~ **от ~и** мах яснаасаа; **облечь в ~ и кровь** бие махбодтой болгох, бодит биеийг олгох; **войти в ~ и кровь** мах цусанд шингэх.

ПЛО́ХО муу, муу юм, муугаар; ~ **поступать с кем-либо** хүнд муу юм хийх; **Лида ~ говорит по-монгольски** Лида монголоор муу ярьдаг; **из рук вон ~** авах танаггүй муу; **ему ~** тэр муу байна; **кончить ~** муугаар төгсөх; ~ **лежит** дэл сул юм.

ПЛОХОВА́ТЫЙ муухан.

ПЛОХ||О́Й муу, муусайн, муутай; **~ая репутация** муу нэр; ~ **человек** муу хүн; **больной очень плох** өвчтэй хүн их муу байна; **на него надежда ~ая** найдвар муутай хүн дээ; **~ие вещи** муусайн новш, муусайн юм.

ПЛО́ХОНЬКИЙ муухан, муу.

ПЛО́ШКА цөгц, дийз.

ПЛОЩА́ДКА 1. дэвжээ, талбар, талбай; **спортивная ~** спортын дэвжээ; **строительная ~** шатны тавцан.

ПЛО́ЩАДЬ 1. талбай; **посевная ~** тариалангийн талбай; 2. талбар; ~ **круга** цагригийн талбар; 3. талбай; **жилая ~** байрын талбай.

ПЛУГ анжис; **конный ~** морин анжис.

ПЛУТ мэхчин, зуйгуурч, булхайчин, зальтай гайхал, гөнтэй хүн; **ах ты ~ этакий** а чи ийм зальтай гайхал уу.

ПЛУТА́ТЬ төөрөх, төөрч явах; ~ **по лесу** ойд төөрөх.

ПЛУ́ТНИ мэх гох, булхай, муу заль, гөн, зуйгуур.

ПЛУТОВА́ТЫЙ мэхтэйхэн, муу зальтайхан, хуурамчхан, гөнтэй; ~ **мальчик** гөнтэйхэн хөвгүүн.

ПЛУТОВА́ТЬ мэхлэх, залилах, булхай гаргах, зуйгуурлах, гөн гаргах; ~ **в карточной игре** хөзөр тоглоход булхай гаргах.

ПЛУТО́ВКА мэхтэй хүүхэн, гөнтэй хүүхэн, мэхтэй гайхал.

ПЛУТОВСК||О́Й мэх гохын, мэхтэй, муу зальтай, гөнтэй; **~ие манеры** мэхтэй янз.

ПЛУТОВСТВО́ мэх гох, булхай гаргах, муу заль, гөн; ~ **в игре** тоглоомд булхай гаргах.

ПЛЫВУ́Ч||ИЙ шингэн, хөвөлзүүр, бамбалзуур; **~ая глина** шингэн шавар; **~ая почва** бамбалзуур хөрс.

ПЛЫТЬ 1. самрах, усчлах, сэлж явах; **по реке** голын усанд сэлэн явах; ~ **против течения** урсгал өөд самрах; 2. явах, хөвөх, хөвж явах; ~ **на пароходе** уурын онгоцоор явах; 3. хөвөх, элэн халих; **облака плывут по небу** тэнгэрт үүл хөвнө; 4. хэлбэлзэх, хөвөлзөх.

ПЛЮГА́ВЫЙ үхээнц, зутруу, ~ **парнишка** үхээнц хөвүүн, зутруу жаал.

ПЛЮ́НУТЬ нулимах, нулимчхах.

ПЛЮС 1. нэмэх тэмдэг, нэмэх, тоонолжин тэмдэг; 2. нэмэх, нэмэхэд; **два ~ три равно пяти** хоёр дээр гурвыг нэмэхэд тав болно; 3. сайн тал, давуу зүйл.

ПЛЮСНА́ 1. мэхэрхий, улын яс, өлмийн дөрөөвч; 2. хойт шилбэ.

ПЛЮ́ХАТЬСЯ лүг хийн суучхах, ёлхос хийтэл суух, паг суух; ~ **на стул** сандал дээр ёлхос хийтэл суух.

ПЛЮШ зузаан хилэн, үстэй хилэн.

ПЛЮ́ШЕВЫЙ хилэн, үстэй хилэн.

ПЛЮЩ ороонго өвс.

ПЛЮ́ЩИТЬ хавтгайлах; ~ **железо** төмөр хавтгайлах.

ПЛЯЖ хаялгана, жалгай, ~ **морской** ~ тэнгисийн хаялгана; **песчаный ~** элсэн пляж, элсэн жалгай.

ПЛЯС бүжиг, бүжиглэх; **пуститься в ~** бүжигт орох, бүжиглэж гарах.

ПЛЯСА́ТЬ бүжиглэх, биелэх, бүжиг хийх; ~ **русскую** орос бүжиг хийх.

ПЛЯ́СК||А бүжиг бүжиглэх, **весёлые ~и** цэнгэлтэй бүжиг.

ПЛЯСОВА́Я бүжгийн хөгжим.

ПЛЯСУ́Н бүжигч.

ПЛЯСУ́НЬЯ эмэгтэй бүжигч.

ПНЕВМА́ТИКА пневматик, хий шахуурын багаж хэрэгсэл.

ПНЕВМАТИ́ЧЕСКИЙ хийгээр ажиллах, хий шахуурын, шахсан хийт; ~ **насос** хийгээр ажиллах хөөрөг,шахсан хийт хийлүүр.

ПНЕВМОНИ́Я уушигны үрэвсэл, уушигны хатгалгаа.

ПНУТЬ өшиглөх, ёврох.

ПО 1. аар; **идти ~ дороге** замаар явах; **идти ~ улице** гудамжаар явах; **ходить ~ театрам** театраар явах; **послать ~ почте** шуудангаар явуулах; **говорить ~ телефону** утсаар ярилцах; **идти ~ следу зверя** ангийн мөрөөр явах; **хлопотать ~ хозяйству** аж ахуйгаар оролдох; **отличный ~ качеству** чанараар онц; ~ **старинному обычаю** хуучин заншлаар; ~ **происхождению** уг гарлаараа; **звать ~ имени** нэрээр нь нэрлэх; **старший ~ возрасту** насаар ах; 2. ~ **приказанию** тушаал ёсоор; **поступать ~ закону** хууль ёсоор явуулах; ~ **моей просьбе** миний гуйсан ёсоор; ~ **обязанности** үүргийн ёсоор; 3. -ыг, -ийг, г, **гладить ~ голове** толгойг илэх; **скучать ~ детям** хүүхдээ санах; 4. -ын, -ийн, -ны, -ний, -н, **чемпион ~ шахматам** шатрын аварга; **соревнование ~ шахматам** шатрын тэмцээн; 5. -д,-т; **товарищ ~ оружию** зэвсэг нэгт нөхөр; ~ **моему мнению** миний санахад; 6 —тай, той, тэй; **работать ~ плану** төлөвлөгөөтэй ажиллах; 7. учраас; **он не приехал ~ болезни** тэр өвчтэй учраас ирсэнгүй; 8. -тул, 9. хүртэл; **прочитать с первой ~ десятую главу** нэгдүгээрээс аравдугаараас бүлэг хүртэл унших; **войти в воду ~ пояс** усанд бэлхүүсээ хүртэл орох; 10. турш; **работать ~ целым дням** бүхэл өдөр турш ажиллах; 11. -уур, үүр **ходить ~ комнате** тасалгаа дотуур явах; **гулять ~ утрам** өглөөгүүр зугаалах, өглөө бүр зугаалах; 12. дагуу, уруу, руу; **плыть ~ течению** урсгал дагуу хөвөх; 13. -ч,ж **сделать что-либо ~ ошибке** юм эндүүрч хийх, ~ **рассеянности** салангаас болж.

ПОБАГРОВЕ́||ТЬ улайх, хүрэн болох; **небо ~ло от зарева** үдшийн гэгээнд тэнгэр улайв; ~ **от гнева** урлаж царай улайх.

ПОБА́ИВАТЬСЯ айсхийх, ширвээтэх, эмээх.

ПОБА́ЛИВА||ТЬ өвдөх, жаахан өвдөх, хааяа өвдөх; **поясница ~ет** зоо нуруугаар жоохон өвдөнө.

ПОБАСЁНКА хошин яриа.

ПОБЕ́Г найлзуур, мөчир; **яблоня дала ~и** алимын модны найлзуур ургав.

ПОБЕ́ГАТЬгүйж явах, гүйлдэх.

ПОБЕ́Д||А ялалт, ялах; **сдержать ~у** ялалт хийх, ялж гарах, ялалт байгуулах.

ПОБЕДИ́ТЕЛЬ ялагч, дийлэгч, түрүүлэгч, ялсан хүн, дийлсэн хүн.

ПОБЕДИ́ТЬ 1ялах, дийлэх; ~ **врага** дайсныг ялах; 2 гартаах; 3 давах, болих, дарах; ~ **засуху** ганг давах; ~ **сомнение** эргэлзэхээ болих.

ПОБЕ́ДН||ЫЙ ~ая песня ялалтын дуу.

ПОБЕДОНО́СНЫЙ 1. ялгуусан; 2. давамгай, бардам.

ПОБЕЖА́||ТЬ 1. гүйх, гүйлдэх; **все ~ли вперёд** бүгдээрээ урагшаа гүйлдэв; 2. зугтаах, дутаах; 3. урсах; **с гор ~ли ручьи** уулнаас горхинууд урслаа.

ПОБЕЖДА́ТЬ 1. ялах, дийлэх; 2. гартаах, 3. давах, дарах.

ПОБЕЖДЁННЫЙ ялагдсан, дийлдсэн, дийлэгдсэн.

ПОБЕЛЕ́||ТЬ цайрах, зэвхий даах; **от мороза ~ли деревья** хүйтэнд мод зэвхий даажээ.
ПОБЕЛИ́ТЬ цагаанаар будах, шохойдох; ~ **стены** туургa шохойдох.
ПОБЕ́ЛКА цагаанаар будах, шохойдох.
ПОБЕРЕ́ЖЬЕ эрэг, эрэг хавийн газар, хөвөө; **морское ~** тэнгисийн эрэг хавийн газар.
ПОБЕРЕ́ЧЬ 1. хадгалах, 2. гамнах; ~ **своё здоровье** биеэ гамнах; 3. арчлах, асрах; ~ **больного отца** өвчтэй эцгээ асрах.
ПОБЕРЕ́ЧЬСЯ биеэ гамнах.
ПОБЕСЕ́ДОВАТЬ ярилцах, хөөрөлдөх; ~ **с друзьями** найз нартайгаа ярилцах.
ПОБЕСПОКО́ИТЬ жаахан төвөг учруулах, жаахан саад хийх, жаахан алжаах; **разрешите вас ~** танд жаахан саад хийж болох уу, таныг жаахан алжааж болно уу.
ПОБЕСПОКО́ИТЬСЯ зовних, санаа зовох, санаа тавих.
ПОБИРА́ТЬСЯ гуйлга гуйх, гуйланчлах.
ПОБИ́ТЫЙ зодуулсан, цохигдсон; **он ушёл как ~** тэр, зодуулсан юм шиг болоод явчихлаа.
ПОБИ́||ТЬ 1. цохих, зодох, гөвдөх; 2. ялах, дарах; ~ **всех врагов** бүх дайснаа дарах; 3. дийлэх, түрүүлэх; **рысак ~л всех лошадей на скачках** хатирч морь уралдаанд бүх морьдоос түрүүлэв; 4 эвдэх, хэмхлэх; ~ **посуду** хувин сав хэмхлэх.
ПОБИ́||ТЬСЯ 1хэмхрэх, хамхрах, няцрах, хагарах; **вся посуда ~лась** бүх сав суулга хэмхэрчээ; 2. мөрийцөх, бооц тавих; ~ **об заклад** бооц тавих.
ПОБЛАГОДАРИ́ТЬ талархах, баярлалаа гэх.
ПОБЛА́ЖК||А сул тавих, уучлах, уучлал; **не давайте ему ~и** түүнийг сул тавьж болохгүй.
ПОБЛЕДНЕ́ТЬ 1. барсхийх, үнсэн хөх болох; ~ **от страха** айж барсхийх; 2. цонхийх, зэвхийрэх.
ПОБЛЁК||НУТЬ гандах, онгох, өгөрөх; **цветы уже ~ли** цэцэг нэгэнтээ ганджээ.
ПОБЛИ́ЗОСТИ ойр, хавь, дөт.
ПОБО́||Й зодох, зодуулах, зодоон; **следы ~ев** зодуулсны сорви.
ПОБО́ИЩЕ тулалдаан; **ледовое ~** мөсөн дээрх тулалдаан.
ПОБО́ЛЬШЕ ихээхэн, ихээр, илүүхэн.
ПОБО́РНИК өмгөөлөгч, өмөг түшиг, хамгаалагч, хамгаалан тэмцэгч.
ПОБОРО||ТЬ 1дийлэх, давах, унагах; **борец легко ~л своего противника** нэг бөх нөгөөгөө амархан унагав; 2 дарах; ~ **свой страх** айдсаа дарах.
ПОБОРО́ТЬСЯ 1. барилдах, 2. үзэлцэх, тулалдах.
ПОБО́РЫ их татвар, хэтэрхий алба, авилга.
ПОБО́ЧН||ЫЙ 1. хажуугийн, дагалдсан, дашрамын; ~ **вопрос** хажуугийн асуудал; 2. нэхлээ, нуудгай, татвар эмээс төрсөн; ~ **сын** нуудгай хүү; **~ое действие** гаж үйлчилгээ.
ПОБОЯ́||ТЬСЯ айх; **он ~лся сказать правду** тэр, үнэнийг хэлэхээс айж байна.
ПОБРАНИ́ТЬ зэмлэх.
ПОБРАТА́ТЬСЯ ах дүү болох, анд болох.
ПОБРАТИ́М анд.
ПО-БРА́ТСКИ ах дүү мэт, ах дүүгийн ёсоор.
ПОБРЕ́ЗГА||ТЬ 1. сэжиглэх; 2. голох; **не ~йте** биттий голоорой.
ПОБРЕСТИ́ гэлдрэх; ~ **в сторону** хажуу тийшээ гэлдрэх.
ПОБРИ́ТЬ хусах, авах, засах; ~ **бороду** сахал хусах.
ПОБРИ́ТЬСЯ сахлаа хусуулах.
ПОБРОДИ́ТЬ хэсэж явах, зайж явах, зугаалах, тэнэх; ~ **по лесу** ой дотуур хэсэж явах.
ПОБРОСА́ТЬ хаялах; ~ **вещи** юм хаялах.
ПОБРЫЗГАТЬ сүрших, сүрчих, түсэргэх.
ПОБРЯКУ́ШКА 1. хангинуур, хоржигнуур; 2. нялх, холбого.
ПОБУДИ́ТЕЛЬ цочруул.
ПОБУДИ́ТЕЛЬН||ЫЙ 1. өдүүлбэр, өдүүлэх; **~ая причина** өдүүлбэр шалтгаан; 2. үйлдүүлэх; ~ **залог** үйлдүүлэх хэв.
ПОБУДИ́ТЬ өдөөх; ~ **кого-либо уехать** хүнийг өдөж байгаад явуулах.
ПОБУЖДЕ́НИЕ санаа, санал, өгүүлбэр.
ПОБУРЕ́ТЬ хүрэн болох, борлох.
ПОБЫВА́||ТЬ 1. явж байх, явж үзэх, яваад ирэх; ~ **на юге** өмнөд нутагт яваад ирэх; 2. ороод гарах, орчхох; **завтра я у вас ~ю** би маргааш танайхаар ороод гарна.
ПОБЫВКА хэд хоногийн чөлөөгөөр, түр хугацаагаар; **приехать домой на ~у** гэртээ хэд хоногийн чөлөөгөөр ирэх.
ПОБЫТЬ байзнах, суух, суузнах.
ПОВА́ДИТЬСЯ амтших, байсгээд ирэх, байсгээд очих; ~ **к нам ходить** байсгээд манайд ирдэг болов.
ПОВА́ДК||А зан, авир зан; **оставь эту ~у** энэ зангаа орхи.
ПОВА́ДНО чтобы не было ~ амтшуулахгүйн тул.
ПОВАЛИ́||ТЬ 1. унагах, унагаах; **ветер ~л дерево** салхи модыг унагав; 2. нөрөн орох, шавалдан орох; **~л снег** цас шавалдан оров; 3. шавааралдах, багтан ядах; 4. баагих, басгах; **дым ~л из трубы** утаа яндангаар басгарав.
ПОВАЛИ́||ТЬСЯ унах, уначхах, ойчих, нурах; **забор ~лся** хашаа нурав.
ПОВА́ЛЬН||ЫЙ 1. бүгдийг хамарсан, бүгдийн; **~ое увлечение** бүгдийн сонирхол; 2. хүчир; **п~ая болезнь** хүчир хижиг, хүчир тахал.
ПОВАЛЯ́ТЬ хөлбөрүүлэх, хөрвүүлэх, мухируулах; ~ **по полу** шал дээгүүр хөлбөрүүлэх.
ПО́ВАР тогооч.
ПОВА́РЕНН||ЫЙ хоолны, хоолны заавар; **~ая соль** хоолны давс; **~ая книга** хоолны заавар ном.
ПОВАРЁШКА шанага.
ПОВАРИ́ТЬ чанах, жаахан чанах.
ПОВАРИ́ТЬСЯ чанагдах.
ПОВАРСКО́Й тогоочийн.
ПО-ВА́ШЕМУ таныхаар, таны саналаар, таны санахад; **будь ~** таны саналаар болог.
ПОВЕ́ДАТЬ хэлэх, мэдэгдэх; ~ **тайну кому-либо** хүнд нууцыг хэлэх.
ПОВЕДЕ́НИЕ зан явдал, зан байдал, зан авир, зан; **скромное ~** даруу зан.
ПОВЕЗТИ́ аваачих; ~ **вещи на вокзал** юмаа галт тэрэгний буудалд аваачих.
ПОВЕЛЕВА́ТЬ 1. ноёлох, захирах, ноёлон захирах; ~ **подданными** албат нараа ноёлон захирах; 2. айлдах, зарлиг болох, тушаах, тушаал өгөх.
ПОВЕЛЕ́НИЕ зарлиг, айлдал, тушаал.
ПОВЕЛЕ́ТЬ айлдах, зарлиг болох, тушаах.
ПОВЕЛИ́ТЕЛЬ дээд эзэн, богд ноён, зарлиг буулгагч, зарлигч.
ПОВЕЛИ́ТЕЛЬНИЦА дээд хатан, айлдагч хатан, зарлигч хатан.
ПОВЕЛИ́ТЕЛЬН||ЫЙ захирах, тушаах; **говорить ~ым тоном** тушаах байдлаар хэлэх; **~ое наклонение** захирах хүсэх төлөв.
ПОВЕНЧА́ТЬ сүмд ёсолж гэрлүүлэх.
ПОВЕНЧА́ТЬСЯ сүмд ёсолж гэрлэх.
ПОВЕРГА́ТЬ 1. унагах; **буря повергла старый дуб** шуурга өтөлсөн царсыг унагав; 2. эрсдүүлэх, хүргэх, учруулах; **это весть повергла его в отчаяние** энэ мэдээ түүнийг цөхрөхөд хүргэв; ~ **в опасность** аюулд учруулах.
ПОВЕ́РЕНН||ЫЙ 1. хамаарсан, хамаарагч, төлөөлөгч; ~ **в делах** төлөөлөгч; 2. итгэсэн хүн, итгэлтэй хүн, найдлагат хүн; **избрать кого-нибудь своим ~ым** итгэлтэй хүнээ сонгож

олох; **присяжный ~** заргын өмгөөлөгч; **временный ~ый в делах** хэргийг түр хамаарагч.

ПОВЕ́РИТЬ 1. үнэмших, итгэх; **~ на слово** үгэнд үнэмших, үгэнд нь итгэх; 2. итгэж хэлэх.

ПОВЕ́РК||А 1. шалгах, магадлах, тааруулах; 2. нэр дуудлага, тооллого; **на ~у пришли все** тооллого дээр бултаараа ирэв; **вечерняя ~ в лагере** лагерийн үдшийн тооллого; **на ~у** чухамдаа, жинхэнэ хэрэг дээрээ.

ПОВЕРНУ́ТЬ 1. эргүүлэх, мушгих; **~ ключ в замке** цоожин дотор түлхүүр эргүүлэх; **~ кран** цорго мушгих; 2. эргэж явах, эргүүлж явуулах; **~ на право** баруун гар тийш эргэж явах; **~ назад** гэдрэг эргэж явах; 3. өөр тийш хандуулах, өөрчлөх; **~ разговор** яриаг өөр тийш хандуулах.

ПОВЕРНУ́||ТЬСЯ 1. эргэх; **~ на другой бок** нөгөө хажуугаар эргэх; **ключ ~лся в замке** цоожин дотуур түлхүүр эргэв; 2. тийш хандах, өөрчлөгдөх; **дело ~лось к лучшему** хэрэг сайн тийшээ хандав.

ПОВЕ́РХ дээгүүр, дээрээс; **смотреть ~ очков** нүдний шил дээгүүр харах.

ПОВЕ́РХНОСТНО өнгөцхөн, хуумгай; **судить ~** хуумгай бодох.

ПОВЕ́РХНОСТН||ЫЙ 1. дээрх, дээд, өнгөн талын, өнгөн; **~ слой почвы** хөрсний дээд давхарга; **~ое нагноение** өнгөц бээрлэх; 2. өнгөц, өнгөцхөн, хуумгай; **~ое знание** өнгөцхөн мэдлэг; **~ человек** хуумгай хүн.

ПОВЕ́РХНОСТ||Ь гадар, гадаргуу, гадарга; **~ земли** газрын гадарга, **скользить по ~и** өнгөн дээгүүр нь бөмбөрөх.

ПО́ВЕРХУ дээгүүр нь, дээрээс нь.

ПОВЕ́РЬЕ домог үг, мухар сүжгийн яриа; **старинное ~** хуучин домог үгс.

ПОВЕРЯ́ТЬ 1. магадлах, шалгах; 2. итгэж хэлэх.

ПОВЕ́СА алиа салбадай, наргианы хүн.

ПОВЕСЕЛИ́ТЬСЯ цэнгэх, хөхих, зугаацах; **вдоволь ~** ханатал цэнгэх.

ПОВЕСЕЛЕ́ТЬ цэнгэх, хөхих, зугаацах.

ПО-ВЕСЕ́ННЕМУ хаврын янзаар; **солнце греет ~** нар хаврын янзаар зөөж байна.

ПОВЕ́СИТЬ 1. өлгөх, дүүжлэх; **~ картину на стену** туурганд зураг өлгөх; 2. дүүжлэх, дүүжилж алах; **~ голову** толгойгоо унжуулах.

ПОВЕ́СИТЬСЯ боож үхэх.

ПОВЕСТВОВА́НИЕ хүүрнэх, хүүрнэсэн.

ПОВЕСТВОВА́ТЬ хүүрнэх, илтгэн өгүүлэх.

ПОВЕСТИ́ 1. аваачих, дагуулж аваачих, оруулах, тавих; **~ гостя в сад** зочныг цэцэрлэгт дагуулж аваачих; 2. хийх, эхлэх; **~ разговор** яриа хийх; 3. хөдөлгөх; **~ бровями** хөмсгөө хөдөлгөх; **~ плечами** мөрөө хөдөлгөх, гайхах; **глазом не ~** ав ажигтүй байх, огт анхаарахгүй байх.

ПОВЕСТИ́СЬ 1. тэгдэг болох, ингэдэг болох, заншилтай болох; **так повелось исстари** хэдийний тэгдэг болсон юм; **уж так повелось** бүр тэгдэг болчихлоо; 2. нөхөрлөх, ойртох; **с кем поведёшься, от того и наберёшься** хэнтэй нөхөрлөвөл түүнтэй ижилсэнэ.

ПОВЕ́СТКА 1. зарлах хуудас, дуудах хуудас; **~ в суд** шүүхэд дуудах хуудас; 2. хэлэлцэх асуудал, хэлэлцэх хэргийн жагсаалт; **~ дня** хурал хэлэлцэх асуудал.

ПО́ВЕСТЬ тууж; **написать ~** тууж бичих.

ПОВЕ́ТРИЕ 1. тахал дэлгэрэх; 2. өвчигнөл, өвчигнөх; **модное ~** шинэ маягийн хувцас заслын өвчигнөл.

ПОВЕ́ШЕНИЕ дүүжлэх, дүүжилж алах.

ПОВЕ́Я||ТЬ үлээх, амьсгалах, оргих; **~л тёплый ветерок** бүлээн салхи үлээв; **~ло прохладой** сэрүү амьсгалах, хүйт оргих.

ПОВЗДО́РИТЬ тар түр хийлцэх, муудалцах.

ПОВЗРОСЛЕ́ТЬ том болох, их болох, өөлэй болох, өсөж өндийх.

ПОВИВА́ЛЬН||ЫЙ эх барих; **~ая бабка** эх барих эмгэн.

ПОВИДА́ТЬ уулзах, учрах.

ПОВИДА́ТЬСЯ уулзах; **~ с родными** садантайгаа уулзах.

ПО-ВИ́ДИМОМУ байх, байхаа, бололтой; **весна, ~, будет ранняя** хавар эрт болох байхаа; **он, ~, был не здоров** тэр өвчтэй байсан бололтой.

ПОВИ́ДЛО үрдэс, жимсний үрдэс, повидло.

ПОВИЛИ́КА чөдөр өвс, орсонго.

ПОВИНИ́ТЬСЯ буруугаа хүлээх, гэмээ мэдэх, гэмших.

ПОВИ́ННОСТЬ алба, албан журмын; **отбывать воинскую ~** цэргийн алба хаах.

ПОВИ́НН||ЫЙ буруу, буруутай, гэмтэй; **ни в чём не повинен** ямар ч буруу байхгүй; **явиться с ~ой** биеэ илчлэх, гэмээ илчлэх.

ПОВИНОВА́ТЬСЯ дагах, захирагдах, дуулгавартай сонсох; **~ родителям** эцэг эхдээ захирагдах.

ПОВИНОВЕ́НИ||Е дагах, захирагдах, дуулгартай байх; **выйти из ~я** захирагдахаа болих; **быть в ~и** дуулгавартай байх, захирагдаж байх.

ПОВИСА́ТЬ унжих, зүүгдэх; **ребёнок повис на шее матери** хүүхэд эхийнхээ хүзүүнд зүүгдэв; **вопрос повис в воздухе** асуудал шийдвэрлэгдсэнгүй орхигдов.

ПОВИСЕ́ТЬ өлгөөтэй байх, дүүжлээстэй байх.

ПОВИТУ́ХА эх баригч авгай.

ПОВЛЕ́ЧЬ 1. татах, чирэх, чирж аваачих; 2. хүргэх, шалтгаан болох, болох.

ПОВЛИЯ́ТЬ нөлөөлөх, нөлөө үзүүлэх.

ПО́ВОД I 1. шалтаг, шалтгаан; **~ для ссоры** хэрүүлийн шалтаг; **дать ~** шалтаг олгох; **без всякого ~а** ямар ч шалтгаангүйгээр; **по всякому ~у** шалтаг л гарвал, юм л болбол; 2 учир, тухай; **разговор шёл по ~у новой книги** шинэ номын тухай ярилцаж байв.

ПО́ВОД I жолоо, цулбуур, бурантаг; **натянуть ~ья** жолоогоо татах; **быть на ~у у кого-либо** хүний мэдлээр явах, бусдын эрхэнд байх.

ПОВОДИ́ТЬ хөтөлж явах; **~ лошадь** морь хөтөлж явах.

ПОВОДИ́ТЬ 1. хөтлөх, явах, оруулах; 2. хөдөлгөх, заах; **~ указкой по карте** зураг дээр саваагаар заах.

ПОВОДО́К цулбуур, оосор, хөтлүүр.

ПОВОДЫ́РЬ хөтлөгч, хөтөлж явагч, хөтөч; **~ слепого** сохор хүний хөтлөгч.

ПОВОЗИ́ТЬСЯ оролдох, үлхээцэлдэх; **~ над задачей** тоо бодох гэж оролдох.

ПОВО́ЗКА мухлаг тэрэг, тэрэг; **парная ~** хос морь хөллөсөн тэрэг.

ПОВО́ЛЖСКИЙ ижил мөрний хавийн.

ПОВОЛО́КА дураал, угсаал.

ПОВОРА́ЧИВАТЬ 1. эргүүлэх; 2. эргэж явах, эргүүлж явуулах; 3. өөр тийш хандуулах, өөрчлөх.

ПОВОРА́ЧИВАТЬСЯ 1. эргэх; 2. эргэлдэх; 3. тийш хандах, өөрчлөгдөх.

ПОВОРО́Т 1. эргэх, тойрох; **~ кругом** тойрон эргэх; 2. эргэлт, муруйх; **на ~е дороги** замын эргэлт дээр, зам муруйхад; 3. эргэлт, эргэх, **новый ~** шинэ эргэлт; **~ дела в нашу пользу** хэрэг ажил бидэнд ашигтайгаар эргэх; **от ворот ~** үгүйгээс өөр үггүй.

ПОВОРОТИ́ТЬ 1. эргүүлэх, мушгих; 2. эргэж явах, эргүүлж явуулах; 3. өөр тийш хандуулах, өөрчлөх.

ПОВОРОТИ́ТЬСЯ 1. эргэх; 2. тийш хандах, өөрчлөгдөх.

ПОВОРО́ТЛИВЫЙ шаламгай, шуумгай; **он человек ~** тэр шаламгай хүн

ПОВОРО́ТНЫЙ 1. эргэх, тойрох, эргүүлэх, тойруулах; **~ механизм** эргүүлэх механизм; 2. эргэлтийн **~ пункт в развитии** хөгжил дэх эргэлтийн цэг.

ПОВРЕДИ́ТЬ 1. хорлох, хор хүргэх; 2. гэмтээх, бэртээх; **~ ногу** хөлөө гэмтээх, хөлөө бэртээх.

ПОВРЕЖДЕ́НИЕ гэмтэх, бэртэх; **~ костей** яс бэртэх.

ПОВРЕМЕНИ́ТЬ азнах, хүлгэлзэх, байзнах; **~ несколько дней** хэдэн өдөр азнах; **~ с отъездом** явахаа байзнах.

ПОВРЕМЕ́ННЫЙ 1. тогтмол, хугацаат; 2. цагаар төлөх, цагаар хэмжих; **~ая оплата** цагаар төлөх хөлс.

ПОВСЕДНЕ́ВНО *өдөр бүр, өдөр тутам, өдөр болгон.*

ПОВСЕДНЕ́ВНЫЙ өдөр бүрийн, өдөр тутмын; **~ая работа** өдөр бүрийн ажил.

ПОВСЕМЕ́СТНЫЙ газар бүрийн, газар сайгүй, хааяагүй; **~ое явление** газар сайгүй болдог үзэгдэл.

ПОВСТА́НЕЦ бослого гаргагч, бослогод оролцогч.

ПОВСТРЕЧА́ТЬ уулзах, учрах.

ПОВСТРЕЧА́ТЬСЯ *дайралдах, харгалдах;* **~ на улице** гудамжинд дайралдах.

ПОВСЮ́ДУ газар бүрийн, газар сайгүй, хаяагүй.

ПОВТОРЕ́НИЕ 1. давтах, давтлага; **~ пройденного материала** үзсэн зүйлээ давтах; 2. давтсан зүйл, давтсан юм; 3. дахих, дахилт; **~ болезни** өвчин дахих.

ПОВТОРИ́ТЬ давтах, дахих, дахиж өгөх, давтаж гаргах; **~ урок** хичээлээ давтах; **~ ошибки** дутагдлыг дахин гаргах.

ПОВТОРИ́ТЬСЯ давтах, давтагдах, дахих; **старое не повторится** хуучин юм давтагдахгүй.

ПОВТО́РНЫЙ давтах, дахих, давтлагын, дахилтын; **~ое заболевание** дахин өвдөх.

ПОВЫСИ́ТЬ 1. нэмэх, нэмэгдүүлэх, дээшлүүлэх; **ветер ~л уровень воды** салхи усны түвшний дээшлүүлэв; 2. нэмэх, нэмэгдүүлэх, дээшлүүлэх; **~ производительность труда** хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх;~ **требования** шаардлагыг дээшлүүлэх; **~ знания** мэдлэгээ дээшлүүлэх; 3. дээшлүүлэх, сайжруулах; 4. дэвшүүлэх, ахиулах; **~ по службе** албан тушаалд дэвшүүлэх; 5. өндөр болгох, чангаруулах; **~ голос** дуугаа чангаруулах.

ПОВЫСИ́ТЬСЯ 1. нэмэгдэх, дээшлэх; **уровень воды ~лся** усны түвшин дээшлэв; **температура ~лась** халуун нэмэгдэв; 2. нэмэгдэх, дээшлэх, сайжрах; **интерес ~лся** сонирхол нэмэгдэв; 3. нэр хүнд нэмэгдэх, хүндтэй болох; **~ в общественном мнении** *олон нийтийн* дотор хүндтэй болох; 4. дэвших, ахих; **~ по службе** албан тушаал ахих.

ПОВЫШЕ́НИЕ 1. нэмэгдэх, дээшлэх, сайжрах; **~ жизненного уровня** амьдралын хэмжээ дээшлэх; **~ квалификации** мэрэгшил сайжрах; 2. дэвших, ахих; **~ по службе** албан тушаал дэвших.

ПОВЫ́ШЕННЫЙ үлэмж, нэмүү; **~ая температура** их халуурах; **~ интерес** *их сонирхол.*

ПОВЯЗА́ТЬ ороох, боох; **~ галстук** зангиа зүүх.

ПОВЯЗА́ТЬСЯ ороох, боох, уях; **~ платком** алчуураар боох.

ПОВЯ́ЗКА 1. боолт, ороолт, боох, ороох; **головная ~** толгойн боолт, **наложить ~у на рану** шарханд боолт хийх, шарх боох; 2. тасам уях; **траурная ~ на рукаве** ханцуй дээр гашуудлын тасам уях.

ПОГАДА́ТЬ 1. мэргэлэх, төлөг үзэх; 2. таах, тааварлах.

ПОГА́НКА хортой мөөг, хар мөөг.

ПОГА́ННЫЙ 1. идэж болохгүй, хортой; **~ гриб** хортой мөөг; 2. бохирын, буртгийн хиртэй; 3. бузар, бөөдий; **~ая пища** бузар идээ, бөөдий хоол.

ПОГАСА́ТЬ 1. унтрах, бөхөх, замхрах; **огонь в печке погас** зууханд гал унтрав; 2. сөнөх, өнгөрөх.

ПОГАСИ́ТЬ 1. унтраах, бөхөөх; **~ лампу** *дэн унтраах;* 2. төлж дуусгах, дансаа бодох; **~ долги** өрийг төлж дуусгах.

ПОГАША́ТЬ төлж дуусгах, дансаа бодох.

ПОГАШЕ́НИЕ төлөх, төлж дуусгах; **~ задолженности** өрийг төлж дуусгах, өр дарах.

ПОГИБА́ТЬ үхэх, мөхөх, сөнөх; **цветы ~ют от мороза** хүйтэнд цэцэг үхэж байна.

ПОГИ́БЕЛЬ I үхэл, сөнөл.

ПОГИ́БЕЛЬ II нуга дарах, нугалах; **согнуться в три ~и** гурав нугалах, нуга дарах, дарлаж давтах.

ПОГИ́БНУТЬ үхэх, мөхөх; **~ смертью храбрых** зоригтны үхлээр үхэх.

ПОГИ́БШИЙ 1. нас барсан, амь үрэгдсэн; 2. сүйдсэн, сөнөсөн; **~ корабль** сүйдсэн хөлөг онгоц; 3. баларсан, завхарсан.

ПОГЛА́ДИТЬ 1. илэх, илбэх; **~ голову** толгойг илэх; 2. индүүдэх, илүүрдэх, толийлгох; **~ рубашку** цамц индүүдэх.

ПОГЛОТИ́ТЬ 1. шингээх, биедээ шингээх, шингэх, шингэж орох; **~ лучи** цацрагийг шингээх; 2. анхаарлыг татах, эзлэх, хэрэглэх; **новая идея ~ла его целиком** шинэ үзэл санаа түүний бүх анхаарлыг татлаа.

ПОГЛОЩЕ́НИЕ шингээлт, шингэх, шингээх, залгих.

ПОГЛУПЕ́ТЬ тэнэг болох, мунхрах.

ПОГЛЯДЕ́ТЬ 1. харах, ширтэх, үзэх; **~ на вошедшего** орж ирсэн хүнийг харах; 2. харах, харуулах, харгалзах; **~ за ребёнком** хүүхэд харуулах, хүүхэд харгалзах.

ПОГЛЯ́ДЫВАТЬ 1. харж байх, ажиглаж байх, шагайж байх; 2. харж байх, харгалзаж байх; **~ за детьми** хүүхэд харж байх.

ПОГНА́ТЬ хөөх, туух, элдэх, давхиулах; **~ лошадь во весь опор** морио бүх чадлаар нь давхиулах.

ПОГНА́ТЬСЯ 1. хөөх; **за двумя зайцами погонишься — ни одного ни поймаешь** хоёр туулайг хөөвөл нэгийг нь ч гүйцэхгүй; 2. *хөөцөлдөх;* **~ за славой** *алдар нэр хөөцөлдөх.*

ПОГНУ́ТЬ матийлгах, махийлгах, муруйлгах.

ПОГНУ́ТЬСЯ матийх, махийх, муруйх.

ПОГОВА́РИВАТЬ 1. ярьдаг, гэдэг; **он начал ~ об отъезде** тэр явна гэж ярьдаг болов, 2. ярьцгаах, гэцгээх, гэлцэх.

ПОГОВОРИ́ТЬ ярих, ярилцах, хэлэлцэх; **~ по душам** зүрхнийхээ үгийг ярилцах; **~ о делах** ажил хэргийн тухай хэлэлцэх.

ПОГОВО́РК||А хууч үг, хошоо үг, зүйр үг; **войти в ~у** зүйр үгэнд орох.

ПОГО́Д||А цаг уур, тэнгэр, өдөр; **сводка ~ы** цаг уурын мэдээ, **перемена ~ы** цаг уур солигдох; **~ устанавливается** тэнгэр цэлмэж байна; **хорошая ~** цэлмэг өдөр; **это не делает ~ы** энэ шийдвэрлэх юм биш, үүнээс шалтгаалахгүй **ждать у моря ~ы** заяандаа горьдож суух.

ПОГОДИ́ТЬ азнах, байзнах, хүлгэлзэх, жаахан хүлээх; **немного погодя** жаахан азнаад; **погоди, сейчас приду** жаахан хүлээ, одоо ирнэ.

ПОГО́ДОК нэг нас дүү, нэг нас зөрөөтэй; **мы с сестрой — погодки** эгч бид хоёр нэг насны зөрөөтэй.

ПОГО́ЖИЙ цэлмэг, сайхан, даяараа.

ПОГОЛО́ВНО толгой тоолон, булталараа, даяараа.

ПОГОЛО́ВНЫЙ толгой дараалан, бүх, бүгдийг хамарсан; **~ая перепись населения** бүх хүн амын бүртгэл.

ПОГОЛО́ВЬ||Е *тоо толгой, толгой;* **рост ~я скота** малын тоо өсөх; **~ овец** хонины тоо.

ПОГО́НЩИК туугч, тууварчин; **~ скота** мал туугч.

ПОГО́Н||Я 1. мөрдөн хөөх, нэхэн хөөх; 2. нэхүүл, хөөгчид, **~ мчалась следом за ним** нэхүүл хойноос нь мөрдөн хөөв;

3. **хөөцөлдөх; в ~е за славой** нэр цол хөөцөлдөж; **~ за прибылью** ашиг хонжоо хөөцөлдөж.

ПОГОНЯ́||ТЬ 1шамдан явуулах, давхиулах; **~ коня кнутом** морийг ташуурдан давхиулах; 2. шамдуулах, яаруулах; **не ~й меня, успею** намайг битгий яаруул, амжина.

ПОГОРЕ́ЛЕЦ түймэрт эрсэдсэн хүн, түймэрт дайрагдсан хүн.

ПОГОРЕ́Л||ЫЙ шатсан, шатанхай, цурам түнэр; **~ое место** цурам, түнэр газар.

ПОГОРЕ́||ТЬ 1. гэр хогшил шатах, түймэрт дайрагдах, галын аюулд автах; 2. шатах; **деревня ~ла** тосгон шатав; 3. гандах, хагдрах, ялзрах; 4. дүрэлзэж ноцох, гялсхийх.

ПОГОРЯЧИ́ТЬСЯ цухалдах, унтуущах, адгах.

ПОГО́СТ оршуулах газар, булш, хүүрийн газар.

ПОГОСТИ́ТЬ айлчлах, гийчин болох, зочлуулах.

ПОГРАНИ́ЧНИК хил хамгаалагч, хилчин.

ПОГРАНИ́ЧН||ЫЙ 1. хилийн, хил хязгаарын; **~ая полоса** хилийн зурвас; **~ столб** хилийн шон; **~ инцидент** хилийн будлиан; 2. хилийн, хил хамгаалах; **~ые войска** хилийн цэрэг.

ПО́ГРЕБ зоорь; **~ со льдом** мөсөн зоорь; **пороховой ~** дарины зоорь.

ПОГРЕБА́ЛЬНЫЙ оршуулах; **~ обряд** оршуулах журам ёс.

ПОГРЕБА́ТЬ оршуулах, хөдөөлүүлэх; **~ с почестями** хүндтэйгээр оршуулах.

ПОГРЕБЕ́НИЕ оршуулах, хөдөөлүүлэх.

ПОГРЕМУ́ШКА торжигнуур, хорчигнуур, хонхолдой.

ПОГРЕ́ТЬ дулаацуулах, ээх; **~ руки у печки** зууханд гараа ээх.

ПОГРЕ́ТЬСЯ дулаацах, ээх.

ПОГРЕШ||А́ТЬ хазайлгах, гуйвуулах, нүгэл хийх; **~ить против истины** үнэнийг гуйвуулах.

ПОГРЕ́ШНОСТЬ алдаа, мадаг, доголдол; **допустить ~ в правописании** зөв бичлэгийн талаар алдаа гаргах.

ПОГРОЗИ́ТЬ занах.

ПОГРО́М хядлага, бусниулах, түйвээх.

ПОГРО́МЩИК хядагч, бусниулагч, түйвээгч.

ПОГРУЖА́ТЬ 1. живүүлэх; **~ тело в воду** усанд ном живүүлэх; 2. ачих, зөөх.

ПОГРУЖА́ТЬСЯ 1. живэх; 2. бүрхэгдэх, хучигдах, шингэх; 3. автах, шурган орох, бясалгах; **~ в размышления** бясалгал бясалгах; 4. ачигдах, тээгдэх, суух.

ПОГРУ́ЗКА ачих, ачаа ачих, тээх, ачаа тээх.

ПОГРУ́ЗОЧН||ЫЙ ачааны, ачлагын ачих; **~ые машины** ачааны машинууд; **~ая работа** ачих ажил.

ПОГРУ́ЗЧИК ачлагын машин, ачих буулгах машин.

ПОГРЫ́ЗТЬ мэрж байх, химлэж байх.

ПОГРЯЗ||А́ТЬ,

ПОГРЯ́З||НУТЬ 1. шавардах, шигдэх; **колёса ~ли в глине** дугуй шаварт шигдэв; 2. дарагдах, автах; **~ в невежестве** бүдүүлэг байдалд дарагдах; 3 баригдах; **~ в долгах** өрөнд баригдах.

ПОГУБИ́ТЬ үхүүлэх, хөнөөх, сүйтгэх, бусниулах; **~ своё здоровье** биеэ сүйтгэх.

ПОГУЛЯ́ТЬ зугаалах, зугаацах, салхинд гарах.

ПОД 1дор; **поставить ~ стол** ширээн доор тавих; **находиться ~ столом** ширээн доор байна; **~ руководством** удирдлагын дор, удирдлагаар; **~ охраной закона** хуулийн хамгаалалт дор; 2. -ын, ийн, н, **отвести участок ~ сад** цэцэрлэгийн газар болгох; **в ночь ~ новый год** шинэ жил гарахын шөнө, 3. -д, т; **попасть ~ дождь** бороонд дайрагдах; **~ свою защиту** хамгаалалтдаа авах; 4. -тай, **петь ~ аккомпанемент рояля** төгөлдөр хуурын найруу хамтдаа дуулах; 5. -аар, **писать ~ диктовку** хэлж өгснөөр бичих; **~ действием солнечных лучей** нарны цацрагийн үйлдлээр; **~ предлогом** нэрийдлээр, **~ видом** янзаар; **~ влиянием гнева** уур хилэнгийн нөлөөгөөр; 6. ойр, дэргэд; **жить ~ Москвой** Москвагийн ойр суух; 7. шиг, мэт, шигээр, **мэтээр; ~ золото** алт шиг; 8. шахам, шахаж байх,болж байх, **болох гэж байх; ей ~ сорок** тэр авгай дөч шахам настай, **~ старость** настай болж байх; **~ вечер** үдэш болж байхад; **~ утро өглөө** болж байхад; 9. -ж, аад; **взять деньги ~ расписку** гарын үсэг зурж мөнгө авах; 10. гэдгийг, гэдэгт, гэхдээ; **что надо понимать ~ ощущением** мэдрэхүй гэдэгт юу гэж ойлгох хэрэгтэй вэ; **~ руку** сугадаж явах; **~ открытым небом** гадаа ил.

ПОДАВА́ТЬ 1авч өгөх, авчирч; өгөх; 2. **шилжүүлэх;** дамжуулан өгөх; 3. үзүүлэх; ухруулах; **~ надежды найдуулах,** найдаж болмоор.

ПОДАВА́ТЬСЯ 1. болох, давших, ухрах, **хазайх;** 2. явах, хандах; 3. үгэнд орох.

ПОДАВИ́ТЬ 1. дарах, шахах; **~ больное место** хөндүүр газрыг дарах; 2. бяцлах, няцлах, бяц дарах, алж устгах; 3. дарах, устгах; **~ восстание** бослогыг дарах; 4. болих, булих, дарах; **~ страх** айхаа болих, айдсаа булих; 5. дарах, сүрдүүлэх.

ПОДАВИ́ТЬСЯ хахах; **~ костью** ясанд хахах.

ПОДАВЛЕ́НИЕ дарах; **~ мятежа** үймээн дарах.

ПОДА́ВЛЕННОСТЬ гутах, уруу царайлах, шантрах, урам хугарах.

ПОДА́ВЛЕНН||ЫЙ 1. гутсан, уруу царайтай, шантарсан, урам хугарсан; **~ое настроение** уруу царайтай байх; 2. сүүмгэр, гиншиx; **~ стон** сүүмгэр дуугаар ёолох, гэгж гинших.

ПОДАВЛЯ́ТЬ 1. дарах, сөнөөх; 2. сүрдүүлэх, сүрээр дарах.

ПОДАВЛЯ́ЮЩ||ИЙ дийлэх, олонх; **~ее большинство голосов** зонхилох олонхийн санал; **в ~ем числе случаев** тохиолдлын олонх нь.

ПОДА́ВНО бүр ч, нэн ч; **он согласен, а я и ~** тэр зөвшөөрчээ, би бүр ч зөвшөөрнө, **он ума не нажил, смелости и ~** түүнд ухаан байхгүй, зориг бүр ч байхгүй.

ПОДА́ГРА тулай өвчин.

ПОДА́ЛЬШЕ холхон, цаана, цаагуур, цааш; **отодвинь стул ~** сандлыг цааш болго.

ПОДАРИ́ТЬ бэлэглэх, бэлэг өгөх; **~ что-либо на память** дурсгал болгож юм бэлэглэх.

ПОДА́РОК бэлэг; **получить ~** бэлэг авах; **преподнести ~** бэлэг барих, **сделать ~** бэлэг өгөх.

ПОДА́ТЕЛЬ өгөгч, бариулагч, биеэр хүргэгч; **~ письма** захидал өгөгч.

ПОДА́ТЕЛЬНИЦА өгөгч эмэгтэй, бариулагч эмэгтэй, биеэр хүргэгч эмэгтэй.

ПОДА́ТЛИВ||ЫЙ 1. дуулгартай, үгэнд оромтгой; **~ человек** дуулгартай хүн; 2. уян, зөөлөн; **~ая глина** зөөлөн шавар.

ПО́ДАТЬ алба, албан татвар.

ПОДА́||ТЬ 1. авч өгөх, авчирч өгөх; **~ пальто** дээл авч өгөх; **~ стул** сандал авчирч өгөх; **~ обед** хоол авчирч өгөх; 2. авчрах, бэлэн байлгах, бэлэн болгох; **~ экипаж** хөсөг бэлэн болгох; 3. бэлдэж өгөх; 4 оруулах, хийх; **~ пар в котёл** тогоонд уур оруулах; 5 өгөх; **~ заявление** өргөдөл өгөх; 6. өгөх, шилжүүлэх; 7. өгөх, давуулах, дамжуулж өгөх; **игрок хорошо ~л мяч** тоглогч бөмбөг сайн давууллаа; 8. үзүүлэх; **~ пример** жишээ үзүүлэх; 9. ухруулах; **~ лошадь назад** морио гэдэрэг ухруулах; **~ голос** дуугарах, саналаа өгөх; **~ рукой** энүүхэнд; **~ урок** хашраах.

ПОДА́ТЬСЯ 1. болох, давших, ухрах, хазайх; **~ вперёд** урагшаа боох, давших; **~ назад** гэдрэг болох, ухрах; 2. явах, хандах; **~ на юг** урагшаа явах; 3 үгэнд орох.

ПОДА́ЧА 1. өгөх, өгөлт; **~ заявления** өргөдөл өгөх; **~ сигнала** дохио өгөлт; 2. өгөх, өгөлт, давуулах; **~ мяча** бөмбөг өгөх,

бөмбөг давуулах; 3. өгөх, оруулах; ~ **пара в котёл** тогоонд уур оруулах.

ПОДА́ЧК||А 1. цөвдөл, амьтанд өгсөн идээ; 2. хишиг, өглөг; **выпрашивать ~и** хишиг гуйх.

ПОДАЯ́НИ||Е гуйлга, бадар; **жить ~ями** гуйлгаар амьдрах.

ПОДБЕГА́ТЬ гүйж очих, гүйж ирэх; ~ **к дому** байшинд гүйж очих.

ПОДБЕРЁЗОВИК барзгар хусандай мөөг, хусны сархиаг.

ПОДБИВА́ТЬ доторлох; ~ **пальто мехом** арьсаар дээл доторлох; 2. зан тавих, загнах, хадах; ~ **подкову** тах хадах, морь тахлах; 3. цохиж гэмтээх, няц цохих; ~ **глаз** нүд цохиж гэмтээх; 4. цохиж унагах, буудаж унагах; 5. тухирах, өдөөх.

ПОДБИРА́ТЬ 1. түүж авах, цуглуулж авах, хамж авах; ~ **рассыпанные вещи** асгарсан юмыг хамж авах; 2. засаж залах, шуух, хумих; ~ **вожжи** жолоо хумих; 3. олж авах, бүрдүүлэх, шилж авах, тааруулах; ~ **ключ** түлхүүр тааруулах.

ПОДБИРА́ТЬСЯ 1. цугларах, эмхлэгдэх, бүрдэх; 2. мярааж ойртох, гэтэж очих, сэмхэн дөтлөх; ~ **к двери** үүдэнд сэмхэн дөтлөх.

ПОДБОДРИ́ТЬ санааг засах, урам сэргээх, урам оруулах; ~ **больного** өвчтэй хүний урам сэргээх.

ПОДБОЛТА́ТЬ хийж хутгах; ~ **молоко в суп** шөлөнд сүү хийж хутгах.

ПОДБО́Р 1. шилж авах, шилж авсан, тохируулж авах, тааруулж авах, сонгож цуглуулах; 2. цуглуулга, шилмэл цуглуулга; **интересный ~ картин** зургийн сонин цуглуулга.

ПОДБО́РКА шилж тааруулах, тааруулах; ~ **материалов** хэрэглэгдэхүүнийг шилж таарулах.

ПОДБОРО́ДОК үрүү, эрүү, ооч; **второй ~** давхар эрүү, бойног.

ПОДБОЧЕ́НИТЬСЯ ташаа тулах, ташаагаа тулах.

ПОДБРА́СЫВАТЬ 1. өөд хаях, өөд шидэх; ~ **мяч** бөмбөг дээш шидэх; 2. нэмэх, нэмж хийх, хийх; 3. нэмж илгээх, явуулах, хүргэж өгөх; 4. далдуур илгээх; ~ **письмо** захидал далдуур илгээх.

ПОДВА́Л 1. зоорь, хонгил; ~ **для дров** түлээний хонгил; 2. хормой, хаяа, **статья на два ~а** сонины хоёр хормойд таарах өгүүлэл.

ПОДВА́ЛИВАТЬ 1. овоолох, хураах, асгах, гуалин хураах; 2. нэмж хийх, хийх, хаялах; 3. ирэх, хүрч ирэх, хөвж ирэх.

ПОДВА́ЛЬН||ЫЙ 1. газар доорх, зоорийн; **~ое помещение** газар доорх тасалгаа; 2. сонины хормойн, сонины хаяа; **~ая статья** сонины хормойн өгүүлэл.

ПОДВЕДЕ́НИЕ 1. тавих; ~ **фундамента** суурь тавих; 2. гаргах; ~ **итогов** дүн гаргах.

ПОДВЕ́ДОМСТВЕНН||ЫЙ харьяа, харьяат; **~ые министерству учреждения** яамны харьяа албан газрууд.

ПОДВЕЗТИ́ хүргэж өгөх.

ПОДВЕРГА́ТЬ эрсдүүлэх, учруулах; ~ **свою жизнь опасности** амь насаа аюулд эрсдүүлэх; ~ **анализу** задлан шинжлэх; ~ **испытанию** туршиж үзэх.

ПОДВЕРГА́ТЬСЯ учрах, орох, -гдэх, -гдах, -уулах, -үүлэх; ~ **опасности** аюулд эрсдэх; ~ **критике** шүүмжлэлд орох, шүүмжлэгдэх; ~ **обстрелу** буудуулах; ~ **побоям** зодуулах.

ПОДВЕ́РЖЕННЫЙ эмзэг, - мтгай, - мтгэй, үргэлж; ~ **болезням** өвчинд эмзэг, өвдөмтхий; **человек, ~ припадкам** үргэлж ухаан алдаж унадаг хүн.

ПОДВЕРНУ́ТЬ 1. шамлах, шуух; ~ **рукава** ханцуй шамлах; ~ **брюки** өмд шуух; 2. хумих, хумлайдах, мухлайдах; ~ **одеяло** хөнжил хумлайдах; 3. эрэгдэх, шөрөвдөх, чангалах; 4. булга гишгэх, тулгаруулах, мөлт гишгэх; ~ **ногу** хөлөө булга гишгэх.

ПОДВЕРНУ́||ТЬСЯ 1. нугарах, шамрах, хумирах; **воротник ~лся** зах нугарав; 2. мушгигдах, тулгарах; **нога ~лась** хөл тулгарав; 3. дайралдах; **он ~лся очень кстати** түүний дайралдсан нь аз боллоо.

ПОДВЕ́СИТЬ өлгөх, дүүжлэх; ~ **лампу под потолком** таазнаас ламп дүүжлэх.

ПОДВЕ́СК||А унжлага, зүүлт, замбалзгуй; **люстра с ~ами** унжлагатай цэцэг дэн.

ПОДВЕСНО́Й өлгөмөл, дүүжин; ~ **мост** дүүжин гүүр.

ПОДВЕСТИ́ 1. авчрах, хөтөлж авчрах, авчирч өгөх, хүргэх; 2. тавих, хийх; ~ **фундамент под здание** барилгын дор суурь тавих; 3. хүргэж тавих, хүртэл тавих; ~ **дорогу к заводу** заводад хүртэл зам тавих, оруулах, тооцох; 5. болгох, баримттай болгох; 6. гаргах, хийх; ~ **итоги** дүн гаргах; 7. будах, жирвийлгэх; ~ **брови** хөмсгөө будах; 8. хөдөх, найдлагыг алдагдуулах; **он меня едва не подвёл** тэр миний найдлагыг алдагдуулах шахлаа; ~ **под выговор** хөдөж донгодуулах; 9. эвхийх, тасрах шахах.

ПОДВЕ́ТРЕНН||ЫЙ нөмөр; **~ая сторона дома** байшингийн нөмөр тал.

ПОДВЕ́ШИВАТЬ өлгөх; **у него хорошо подвешен язык** тэр хэлэмгий хүн.

ПОДВИВА́ТЬ жаахан буржийлгах, буржгархан болгох.

ПО́ДВИГ гавьяа, гавьяа зүтгэл; **трудовой ~** хөдөлмөрийн гавьяа; **воинский ~** цэргийн гавьяа.

ПОДВИ́ГАТЬ дохилзуулах, гозолзуулах, ганхалзуулах.

ПОДВИГА́ТЬ 1. ойртуулах, дөхүүлэх, хөдөлгөх; 2. урагш явуулах, дөхүүлэх.

ПОДВИ́ГАТЬСЯ хөдөлж байх, хөдөлцгөөх.

ПОДВИГА́ТЬСЯ ойртох, дөтлөх, хөдлөх; ~ **к окну** цонх руу ойртох.

ПОДВИ́Д салбар зүйл.

ПОДВИ́ЖНИК 1. арш, хутагт; **христианские ~и** христосын шажны арш нар; 2. зүтгэлтэн, зүтгэгч; ~ **науки** шинжлэх ухааны зүтгэлтэн.

ПОДВИЖНО́Й 1хөдлөх, гүйх; ~ **блок** хөдлөх эргэлдүүр; 2. нүүдлийн, нүүх.

ПОДВИ́ЖНОСТЬ гавшгай хөдлөл, хөдлөмтгэй, түргэн хөдлөц, **отличаться ~ю** гавшгай хөдлөлөөр ялгарах, хурдан хөдөлгөөнтэй.

ПОДВИ́ЖНЫЙ хөдлөмтгэй, түргэн хөдлөцтэй, дэгдэлзүүр, гавшгай; ~ **ребёнок** дэгдэлзүүр хүүхэд.

ПОДВИНТИ́ТЬ эрэгдэх, чангалах; ~ **гайку** эрэг чангалах.

ПОДВИ́НУТЬ 1. ойртуулах, дөтлүүлэх, хөдөлгөх; ~ **стул к столу** сандлыг ширээнд ойртуулах; 2. урагш явуулах, дөхүүлэх; ~ **свою работу** ажлаа дөхүүлэх.

ПОДВИ́НУ||ТЬСЯ 1ойртох, дөтлөх, хөдлөх; ~ **к окну** цонх руу ойртох; 2. ахих, дөхөх.

ПОДВИ́НЧИВАТЬ эрэгдэх, чангалах.

ПОДВИ́ТЬ жаахан буржийлгах, буржгардуу болгох; ~ **волосы** үс жаахан буржийлгах.

ПОДВЛА́СТНЫЙ эрхшээлд орох, захирагдах.

ПОДВО́ДА улаа, хөсөг.

ПОДВОДИ́ТЬ, 1. авчрах, хөтөлж авчрах, авчирч өгөх, хүргэх; 2. тавих, хийх; ~ **фундамент** суурь тавих;3. хүртэл тавих; 4. оруулах, тооцох; 5. болгох, баримттай болгох; 6. гаргах, хийх; ~ **итоги** дүн гаргах, дүгнэлт хийх;7. будах, жирвийлгэх; ~ **брови** хөмсөг будах; 8. гай болох, хөдөх, найдлагыг алдагдуулах; **он его подвёл** тэр түүний найдлагыг алдагдуулав.

ПОДВО́ДНИК шумбадаг онгоцны цэрэг; 2. шумбадаг онгоцны мэргэжилтэн.

ПОДВО́ДН||ЫЙ 1. усан дорх; ~ **камень** усны ёроолын чулуу; 2. шунгадаг, шунгах, ~**ая лодка** шумбадаг завь, шумбах онгоц.
ПОДВО́З авчрах, зөөх; ~ **товаров** бараа зөөх.
ПОДВОЗИ́ТЬ авчрах, хүргэх, зөөх.
ПОДВО́ЗКА авчрах, хүргэх, зөөх.
ПОДВОРА́ЧИВАТЬ 1шамлах, шуух; 2. булга гишгэх, тулгаруулах; 3. муруйж очих, дайраад гарах.
ПОДВОРА́ЧИВАТЬСЯ 1нугарах, шамарах, хумирах; 2. булгарах, тулгарах.
ПОДВОРО́ТНЯ 1. босгоны завсар; 2. хаалганы босго мод.
ПОДВО́Х хөөдөх, муу юм хийх, гай; **устроить** ~ хөөдөх; **неожиданный** ~ гэнэтийн гай.
ПОДВЫ́ПИТЬ ам халах, жаахан халамцах.
ПОДВЯЗА́ТЬ уях, зүүж уях, боох, зүүх; ~ **ведро под телегу** тэргэн дор хувин уях.
ПОДВЯЗА́ТЬСЯ биеэ ороох, бүслэх; ~ **кушаком** бүсээр биеэ ороох, бүс бүслэх.
ПОДВЯ́ЗКА 1. уях, боох; 2. татуур, оймсны татаас.
ПОДГАДА́ТЬ тааруулж хийх, амжиж хийх.
ПОДГА́ДИТЬ хор хүргэх, гай учруулах.
ПОДГИБА́ТЬ дороос нугалах, дороо нугалах; ~ **подол** хормойг дороос нугалах; ~ **ноги под себя** хөлөө дороо нугалах.
ПОДГИБА́ТЬСЯ нугарах, дороос нугарах, хумирах.
ПОДГЛЯДЕ́ТЬ сэмхэн харах, шагайх, гэтэж харах, мяраах.
ПОДГНИВА́ТЬ дооройос өмхрөх, ялзрах.
ПОДГОВА́РИВАТЬ далдуур ятгах, битүүхэн тухирах, битүүхэн өдөөх.
ПОДГОЛО́СОК 1. дагах хоолой; 2. аядан дагалдагч, дуурайн жиргэгч.
ПОДГО́НКА тааруулах, тааруулж суулгах, хоноох; ~ **оконных рам** цонхны жаазыг тааруулах.
ПОДГОНЯ́ТЬ 1. тууж авчрах; 2. хурдасгах, шамдуулах; ~ **лошадей** морины явдлыг хурдасгах, морьдыг ташуурдах; 3. тааруулах.
ПОДГОР||А́ТЬ түлэгдэх, хайрагдах, дороос шатах; **хлеб ~ел** талх түлэгдэв.
ПОДГОРЕ́ЛЫЙ түлэгдсэн, шатсан, түлэнхий, шатанхай; ~ **хлеб** түлэнхий талх.
ПОДГОТА́ВЛИВАТЬ бэлтгэх, бэлдэх, зэхэх; **подготовить доклад** илтгэл бэлтгэх.
ПОДГОТА́ВЛИВАТЬСЯ бэлтгэх, бэлдэгдэх.
ПОДГОТОВИ́ТЕЛЬН||ЫЙ бэлтгэл, бэлтгэлийн, бэлтгэх; ~**ая работа** бэлтгэх ажил; ~ **курс** бэлтгэл анги.
ПОДГОТО́ВКА 1. бэлтгэх, бэлтгэл; ~ **кадров** боловсон хүчний бэлтгэх; ~ **к севу** тарилгад бэлтгэх; 2. бэлтгэлтэй, мэдлэгтэй.
ПОДГОТО́ВЛЕННОСТЬ бэлтгэл, мэдлэг; ~ **кадров** боловсон хүчний мэдлэг.
ПОДГРЕБА́ТЬ I 1. хамах, хамж цуглуулах, шүүрдэх.
ПОДГРЕБА́ТЬ II сэ́лж очих, сэлүүрдэж ойртох.
ПОДГРУ́ППА салбар бүлэг, салбар бүлгэм, бүлгийн хэсэг.
ПОДДАВА́ТЬ 1. өөд нь цохих, дээш нь хаях, хаяж өгөх; 2. өгч идүүлэх; 3. нэмэх, түргэсгэх, оргилуулах, манаргах.
ПОДДАВА́ТЬСЯ 1. түлхэгдэх, нэгдэх, түргэгдэх; 2. автагдах, орох; **не ~ описанию** тодорхойлон бичихийн аргагүй.
ПОДДАВКИ́ идүүлэх, идэгдэх, нүцгэрэх, өгөгдөл, жиргээ буг; **играть в** ~ идүүлэх даам тоглох, нүцгэрэх даам тоглох.
ПОДДА́КИВАТЬ заа заа гэх, аа аа гэх, ам дагах.
ПО́ДДАННЫЙ харьяат, албат.
ПО́ДДАНСТВО харьяалал.
ПОДДА́ТЬ 1. өөд нь цохих, дээш нь хаях, хаяж өгөх, өшиглөх; ~ **мяч ногой** бөмбөгийг өшиглөж өгөх; 2. нэмэх, түргэсгэх, оргиулах, манаргах; ~ **ходу** явцыг түргэсгэх; ~ **пару** уур манаргах; ~ **жару** халууныг оргилуулах, эрчийг чангалах.
ПОДДА́||ТЬСЯ 1. түлхэгдэх, нээгдэх, түргэгдэх; **дверь с трудом ~лась** үүд арай гэж нээгдэв; 2. автах, автагдах, орох; ~ **на уговоры** үгэнд орох; ~ **угрозам** заналд автагдах; **не ~ искушению** дур шуналд автахгүй.
ПОДДЕВА́ТЬ I дотуур өмсөх.
ПОДДЕВА́ТЬ II 1. өлгөх, гогдох, дэгээдэх, сэмлэх; 2. ёжлох, өөлөх өөнтөгдөж хэлэх.
ПОДДЕ́ЛАТЬ дуурайлгаж хийх, дуурайлгаж бичих, хуурмаг хийх; ~ **чужую подпись** бусдын гарын үсгийг дуурайлган бичих; ~ **ключ** түлхүүр дуурайлгаж хийх; түлхүүр тааруулах.
ПОДДЕ́ЛАТЬСЯ 1. дуурайх, дуурайж дугарах; ~ **под детскую речь** хүүхдийн үгийг дуурайж дугарах; 2. зулгуйдах, аядан дагалдах.
ПОДДЕ́ЛКА 1. хуурмаг, хуурамч, хуурмагаар үйлдэх; ~ **подписи на документы** баримт бичиг дээр гарын үсгийг хуурамчаар үйлдэх; 2. хуурамч, дуураймал юм.
ПОДДЕ́ЛЬНЫЙ хуурамч, хуурмаг, дуураймал; ~ **документ** хуурамч баримт; ~ **алмаз** дуураймал алмаз.
ПОДДЁРГИВАТЬ угз татах, дээш татах.
ПОДДЕРЖА́НИ||Е сахиулах, -тай байлгах, дэмжих; ~ **порядка** журамтай байлгах; **для ~я семейства** гэр бүлээ дэмжихийн тул.
ПОДДЕРЖА́ТЬ 1түших; ~ **под руку** гараас нь түших, туслан дэмжих, туслах; ~ **друга в минуту опасности** аюултай цагт нь найзыгаа дэмжих; 3. дэмжих, сайшаах; ~ **чьё-нибудь предложение** хүний саналыг дэмжих; 4. үргэлжлүүлэх, таслахгүй байх, -тай байлгах, тордох; ~ **огонь в печке** зууханд гал таслахгүй байх, зууханд галтай байлгах; ~ **порядок** журамтай байлгах; ~ **разговор** яриаг үргэлжлүүлж байх; ~ **своё здоровье** биеэ тордох.
ПОДДЕ́РЖИВАТЬ 1. үргэлжлүүлэх, таслахгүй байх, -тай байлгах; ~ **приятельские отношения** найз харьцааг үргэлжлүүлэх, найз харьцаагаа таслахгүй байх; 2. тулах, түших, тулгуурлах.
ПОДДЕ́РЖК||А 1. түшиг, тулгуур; 2. дэмжлэг, тусламж; **материальная** ~ эд юмаар дэмжих; **дружеская** ~ нөхөрсөг тусламж; **оказать ~у** дэмжлэг үзүүлэх.
ПОДДЕ́ТЬ I дотуур өмсөх, дотуур нөмрөх.
ПОДДЕ́ТЬ II 1. дэгээдэх, гогдож, өргөх, сэдлэх, 2 ёжлох, өөлж ёгөх, өөнтөглөж хэлэх.
ПОДДУВА́ЛО үнсний хүхээ, үнсний гоожуур, зуухны доод ам, сийгүүр.
ПОДДУВА́||ТЬ сийгэх, үлээх; **из-под пола ~ет** шалны завсраас сийгэж байна.
ПОДЕ́ЙСТВОВА||ТЬ тус болох, үйлдэл үзүүлэх, нөлөөлөх; **лекарство ~ло на больного** өвчтөнд эм тус болов; **мои слова на него не ~ли** миний үг түүнд нөлөөлсөнгүй, миний үгэнд ороогүй.
ПОДЕ́ЛА||ТЬ хийх, үйлдэх; **что бы мне ещё** ~ дахиад юу хийе дээ; **ничего не ~ешь** яах ч аргагүй.
ПОДЕЛИ́ТЬ хуваах.
ПОДЕЛИ́ТЬСЯ хуваах, хуваалдах, хуваалцах, ярьж өгөх, ~ **своим опытом** туршлагаа ярьж өгөх.
ПОДЕ́ЛК||А 1. хийх, үйлдэх; 2. хийсэн юм, жижиг сажиг юм хийх; ~**и из кости** ясаар хийсэн юм.
ПОДЕЛО́М хохь, хийсэн хэрэг; ~ **ему за это** хохь нь тэр; ~ **тебе** хохь чинь.
ПОДЁНН||ЫЙ өдрийн, өдөржийн, өдөөр тооцох; ~**ая плата** өдрийн хөлс; ~**ая работа** өдөөр тооцох ажил.
ПОДЁНЩИК өдрийн ажилчин, өдөөр тооцох ажилчин, өдөөр тооцогч.

ПОДЁНЩИН||А өдөржин, ажил, өдрөөр тооцох; **работать на ~е** өдрөөр тооцож ажиллах.
ПОДЁРГАТЬ угзчих, татах, татлах; **~ за руку** гараас угзчих.
ПОДЁРГИВАНИЕ татганах, татвалзах; **нервное ~ лица** мэдрэл муудаж царай нь татганах.
ПОДЁРГИВА||ТЬ 1. угзчих, татах, татлах; **~ свою бородку** сахлаа татлах, 2 татганах, татвалзах; **его всего ~ло** бүх бие нь татвалзав.
ПОДЕ́РЖАНН||ЫЙ хуучин, эдэлсэн, хэрэглэгдсэн, хэрэглэж байсан; **~ая книга** хэрэглэгдсэн ном.
ПОДЕРЖА́ТЬ байх, байлгах; **~ ребёнка** хүүхэд барьж байх; **~ дверь открытой** үүдээ нээлттэй байлгах.
ПОДЁРНУ||ТЬ бүрхэх, бүрхэгдэх; **реку ~ло льдом** голын ус нимгэн мөсөөр бүрхэгдэв.
ПОДЁРНУТЬСЯ бүрхэх, бүрхэгдэх, зайрмагтах.
ПОДЕШЕВЕ́ТЬ хямдрах.
ПОДЖА́РЕННЫЙ шарсан, хайрсан, хуурсан.
ПОДЖА́РИВАТЬ шарах, хайрах, хуурах.
ПОДЖА́РИВАТЬСЯ шарагдах, хайрагдах, хуурагдах.
ПОДЖА́РИСТЫЙ сайн шарагдсан, сайн хайрагдсан, жаахан түлэнхий.
ПОДЖА́РИТЬ шарах, хайрах, хуурах, жаахан шарах; **~ мясо** мах хуурах.
ПОДЖА́РИ||ТЬСЯ шарагдах, хайрагдах, хуурагдах; **картофель ~лся** төмс шарагдав.
ПОДЖА́РЫЙ хагссан, хагсаасан, хавчгар, мэхгэр; **~ конь** хагсаасан морь.
ПОДЖА́||ТЬ завилах, цомцойх, жимийх, хавчих; **~ под себя ноги** завилж суух, цомцойж суух; **~ губы** уруулаа жимийх; **собака ~ла хвост** нохой сүүлээ хавчив.
ПОДЖЕ́ЧЬ 1. гал ноцоох, гал асаах; **~ дрова** түлээнд гал асаах; 2. шатаах, түймэр тавих, түймэрдэх, галдах; **~ дом** байшин шатаах.
ПОДЖИВА́ТЬ эдгэрэх, эдгэх.
ПОДЖИГА́ТЕЛЬ шатаагч, галдан шатаагч, түймэр тавигч.
ПОДЖИГА́ТЬ 1. гал ноцоох, гал асаах; 2. шатаах, түймэр тавих, түймэрдэх.
ПОДЖИДА́ТЬ хүлээх; **~ гостя** зочныг хүлээх.
ПОДЖИ́ЛКИ хонгоны шөрмөс, тахимын шөрмөс; **~ трясутся** өвдөг нь чичирч байна, хормой нь чичирч байна.
ПОДЖИМА́ТЬ завилах, цомцойх, жимийх, хавчих.
ПОДЖИ́||ТЬ эдгэх, эдгэрэх; **рана уже ~ла** шарх нэгэнтээ эдгэрчээ.
ПОДЖО́Г шатаах, түймэр тавих, түймэрдэх, галдах.
ПОДЗАГОЛО́ВОК доод гарчиг, давхар гарчиг, дагавар нэр.
ПОДЗАДО́РИВАТЬ турхирах, өдөөх, өдөөн хатгах.
ПОДЗАДО́РИТЬ турхирах, өдөөх, хатгах.
ПОДЗАТЫ́ЛЬНИК шилэн хүзүү; **дать ~** шилэн хүзүү рүү нудрах.
ПОДЗАЩИ́ТНЫЙ өмгөөлүүлэгч.
ПОДЗЕМЕ́ЛЬЕ зоорь, агуй.
ПОДЗЕ́МН||ЫЙ газар доорхи; **~ые воды** газар доорхи ус; **~ сток** газар доорхи урсац.
ПОДЗЕРКА́ЛЬНИК толины тавиур, толины ширээ.
ПОДЗО́Л үнсэн саарал хөрс, чандруун хөрс.
ПОДЗО́ЛИСТ||ЫЙ үнсэн саарал; **~ая почва** үнсэн саарал хөрс.
ПОДЗО́Р 1. зээг, хиаг; 2. угалзтай хөвөө, хөлтрөг.
ПОДЗО́РН||ЫЙ ~ая труба дуран авай.
ПОДЗЫВА́ТЬ дуудах, дуудаж ирүүлэх, дуудаж уулзах.
ПОДИ́ 1. ир, яв; **~ сюда** нааш ир; **~ прочь** цаашаа яв; 2. байхаа, бололтой; 3. даан ч хөө.
ПОДИВИ́ТЬ гайхуулах, хачирхуулах.
ПОДИВИ́ТЬСЯ гайхах, хачирхах.
ПОДКА́ЛЫВАТЬ хатгаж торгох, хавсаргаж үндэх, хавсаргах.
ПОДКА́ПЫВАТЬ доогуур нь малтах, онгилох.
ПОДКА́ПЫВАТЬСЯ 1. малтаж орох; 2. өө сэв эрэх, улыг шагайх.
ПОДКАРАУ́ЛИВАТЬ,
ПОДКАРАУ́ЛИТЬ отох, отож байх.
ПОДКА́РМЛИВАТЬ 1. тэжээлийг сайжруулах, тэжээн тэнхрүүлэх; 2. бордох, нэмж бордох.
ПОДКА́РМЛИВАТЬСЯ тэжээгдэх, тэнхрэх.
ПОДКАТИ́ТЬ 1. өнхрүүлж ойртуулах, өнхрүүлж авчирах; 2. хүрч ирэх, хүрч очих.
ПОДКАТИ́ТЬСЯ өнхөрч очих, өнхөрч ойртох, бөмбөрч орох.
ПОДКАЧА́ТЬ 1. хөөрөгдөх, хөөрөгдөж нэмэх; 2. доголдох.
ПОДКА́ШИВАТЬ 1. хадуураар хадах, хадах; 2. дайрч унагах, түлхэж унагах, ойчих; 3. тамирдуулах, тэнхээг барах, арчаагүй болгох.
ПОДКА́ШИВАТЬСЯ чичрэх, нугарах.
ПОДКИДНО́Й хаялуур.
ПОДКИ́ДЫВАТЬ 1. дээш нь хаях, өөд шидэх, 2. нэмж хийх, хийх; 3. хаяж орхих, тавьж орхих.
ПОДКИ́ДЫШ орхигдсон хүүхэд.
ПОДКЛА́ДКА ивээс, нөхөөс.
ПОДКЛАДНО́Й ивүүр, ивээс, тосгуур; **~ брус** ивүүр мод.
ПОДКЛА́ДЫВАТЬ 1. ивэх, тавих; 2. хавсаргах; 3. нэмэх, хийх; 4. сэмхэн тавих, сэмхэн орхих.
ПОДКЛЕ́ИВАТЬ наах, дотроос наах.
ПОДКО́ВА тах.
ПОДКО́ВАННЫЙ 1. тахтай, тахалсан; 2. бэлтгэлтэй, мэдлэгтэй.
ПОДКОВА́ТЬ 1. тахлах; **~ лошадь** морь тахлах; 2. бэлтгэх, мэдлэгтэй болгох.
ПОДКО́ВЫВАТЬ 1. тахлах; 2. мэдлэгтэй болгох.
ПОДКО́ЖНЫЙ арьсан доогуур, арьсан доорхи.
ПОДКОЛО́ТЬ хатгаж торгох, хавсаргаж үдэх, хавсаргах.
ПОДКОМИ́ССИЯ салбар комисс.
ПОДКОНТРО́ЛЬНЫЙ хяналт доорхи, хяналтанд байгаа.
ПОДКО́П 1. доогуур малтах; 2. нүх малтах; 3. өө сэв эрэх, улыг шагайх.
ПОДКОПА́ТЬ доогуур малтах, онгилох.
ПОДКОПА́ТЬСЯ 1. малтаж, орох; 2. өө сэв эрэх, улыг шагайх; **~ под соперника** өрсөлдөгчийнхөө улыг шагайх.
ПОДКО́РМ 1тэжээх, тэнхрүүлэх, тэжээлийг сайжруулах, сайн бордох; 2. нэмэгдэл тэжээл, нэмэгдэл бордоо.
ПОДКОРМИ́ТЬ 1. тэжээлийг сайжруулах, тэжээж тэнхрүүлэх; 2. бордох, нэмж бордох.
ПОДКОРМИ́ТЬСЯ тэжээгдэж тэнхрэх.
ПОДКО́РМКА нэмэгдэл тэжээл, нэмэгдэл бордоо.
ПОДКОСИ́||ТЬ 1. хадах, хадуураар хадах; 2. дайрч унагах, түлхэж унагах, ойчих; **пуля его ~ла** түүнд сум тусаж унагав; 3. тамирдуулах, сульдуулах, арчаагүй болгох; **болезнь ~ла его** өвчин түүнийг сульдуулжээ.
ПОДКОСИ́||ТЬСЯ чичрэх, нугарах; **ноги ~лись от страха** айж өвдөг чичрэв; **ноги ~лись от усталости** ядарч хөл нугарав.
ПОДКО́ШЕННЫЙ хадсан өвс шиг, хяргагдсан юм шиг; **упал как ~** хяргагдсан юм шиг унав.
ПОДКРА́ДЫВАТЬСЯ гэтэх, мяраах, гэтэж очих, мярааж ирэх.
ПОДКРА́СИТЬ будах, жаахан будах, өнгө оруулах; **~ губы** уруулаа жаахан будах.
ПОДКРА́СИТЬСЯ жаахан будах, энгэсэг тавих.
ПОДКРА́СТЬСЯ 1. гэтэж очих, мярааж ирэх; 2. ирчхэх, болчихох; **смерть подкралась внезапно** үхэл гэнэт ирчхэв;

незаметно подкралась зима мэдэгдэлгүй байгаад өвөл болчихов.

ПОДКРЕП||И́ТЬ 1. бэхлэх, бататгах; ~ **забор подпоркой** хашааг тулгуураар бэхлэх; 2. тэнхрүүлэх, тамир оруулах; 3. батлах, нотлох; ~ **решение делом** шийдвэрээ ажил хэргээр батлах; **~лять своё мнение доводами** саналаа учир баримтаар нотлох.

ПОДКРЕПИ́ТЬСЯ өл залгах, өегшиж авах, зуушилж авах; ~ **перед дорогой** мордохын өмнө өл залгах, замд явахын өмнө зуушилж авах.

ПОДКРЕПЛЕ́НИ||Е 1. өл залгах, тамир орох; 2. туслах хүч, нэмэгдэл цэрэг; **свежие ~я** шинэ туслах хүч, шинэ нэмэгдэл цэрэг.

ПОДКРУТИ́ТЬ чангалж мушгих, чангалах, эрэгдэх; ~ **гайку** эрээс чангалах.

ПОДКУЗЬМИ́ТЬ молигодох, молиго үмхүүлэх, дөнгөх.

ПО́ДКУП авилга, хахууль өгөх.

ПОДКУПА́ТЬ 1. далдуур эгэх, хахуульдах, авилгадаж авах; ~ **свидетелей** гэрчийг авилгадаж авах; 2. биедээ татах, дурыг татах, таалагдах; ~ **всех своей добротой** сайн сэтгэлээрээ бүгдийг биедээ татах.

ПОДЛА́ДИТЬСЯ 1. тааруулах, таарах; 2. аясыг дагалдах, таалалд нийлүүлэх.

ПОДЛА́МЫВАТЬСЯ цөмөрөх, хугарах.

ПО́ДЛЕ дэргэд, хажууд, зэргэлдээ.

ПОДЛЕЖ||А́ТЬ зохих, болох, явдал; **не ~ит оглашению** зарлаж үл болно; **это не ~ит сомнению** үүнд эргэлзэх явдалгүй.

ПОДЛЕЖА́ЩЕЕ өгүүлэгдэхүүн.

ПОДЛЕЖА́ЩИЙ зохих ёстой, зохих; **вопрос, ~ рассмотрению** хянаж үзвэл зохих асуудал.

ПОДЛЕЗА́ТЬ шургаж орох, шургах, мөлхөж орох; ~ **под стол** ширээн доогуур шургаж орох.

ПОДЛЕ́СОК ширэнгэ, ширэнгэ ой.

ПОДЛЕТ||А́ТЬ 1нисэж хүрэх, нисэж ойртох; **самолёт ~ел к лесу** нисэх онгоц ойд нисэж хүрэв; 2. үсрэх, үсэрч хүрэх, үсэрч тулах.

ПОДЛЕ́Ц өөдгүй золиг, хүний шаар нь, адгийн амьтан.

ПОДЛЕ́ЧИВАТЬ жаахан эмнэх, бага сага эмнэх, аргалах.

ПОДЛЕ́ЧИВАТЬСЯ жаахан эмнүүлэх, бага сага эмнүүлэх, эмнүүлсхийх; **подлечиться на курорте** рашаан амралтад жаахан эмнүүлэх.

ПОДЛИВА́ТЬ нэмэх, нэмж хийх.

ПОДЛИ́ВК||А шүүс, сүмс; **мясо с ~ой** сүмстэй мах, шүүс дусаасан мах.

ПОДЛИ́ЗА бялдууч, зусарч.

ПОДЛИЗА́ТЬ долоож гүйцэх, долоож арилгах.

ПОДЛИЗА́ТЬСЯ бялдуучлах, зусардах.

ПО́ДЛИННИК жинхэнэ эх, уг эх, эх бичиг; **Агиймаа читает Шекспира в ~е** Агиймаа Шекспирын зохиолыг жинхэнэ эхээр нь уншиж байна.

ПО́ДЛИННОСТЬ жинхэнэ эх, мөн, бодитой эх; **заверить ~ подписи** гарын үсгийг мөн гэж батлах.

ПО́ДЛИНН||ЫЙ жинхэнэ, бодитой, лавтай, ёстой; ~ **текст** жинхэнэ эх бичиг, **это ~ая правда** энэ лавтай үнэн хэрэг.

ПОДЛИ́ТЬ нэмэх, нэмж хийх; ~ **масла в огонь** гал руу тос хийх, улам гааруулах.

ПОДЛО́Г хуурамчаар хийх, хуурамч юм үйлдэх; **предать суду за ~** документов хуурамч баримт үйлдсэн учир шүүхэд өгөх.

ПОДЛО́ДКА ***(подводная лодка)*** шумбах онгоц.

ПОДЛОЖИ́ТЬ1. ивэх, хийх; ~ **камень под колесо** дугуй дор чулуу ивэх; ~ **подушку под голову** толгой дор жинтүү хийх; 2. хавсаргах; ~ **документ к делу** баримт бичгийг уг хэрэгт нь хавсаргах; 3. нэмэх, хийх, нэмж хийх; ~ **дров в печь** зууханд түлээ нэмэх, 4. сэмхэн тавих, сэмхэн орхих.

ПОДЛО́ЖНОСТЬ, хуурамч, хуурмаг, хуурамч болох; **установить ~ документа** баримт бичгийн хуурамч болохыг тогтоох.

ПОДЛО́ЖНЫЙ хуурамч, хуурмаг; ~ **документ** хуурамч баримт.

ПОДЛОКО́ТНИК сандлын тохойлуур.

ПОДЛОМИ́ТЬ хугалах, хагалах; ~ **сук** мөчир хугалах.

ПОДЛОМИ́||ТЬСЯ хугарах, хагарах, цөмрөх; **лёд ~лся под ногами** хөл дорхи мөс цөмрөв.

ПО́ДЛОСТЬ жигшүүртэй юм, өөдгүй явдал, шившиг; **сделать ~ жигшүүртэй юм хийх, өөдгүй явдал гаргах.**

ПОДЛУ́ННЫЙ нарт, саран тусгалт; ~ **мир** нарт ертөнц, саран тусгалт дэлхий.

ПО́ДЛЫЙ жигшүүртэй, өөдгүй шившигт, шившгийн; ~ **поступок** жигшүүртэй явдал; ~ **человек** өөдгүй хүн.

ПОДМА́ЗАТЬ 1. жаахан тослох, дороос нь тослох, түрхэх.

ПОДМА́ЗЫВАТЬ 1. жаахан тослох, дороос нь тослох, түрхэх; ~ **сковородку** хайруулаа жаахан тослох; ~ **сапоги дёгтем** гуталд давирхай түрхэх, 2. юм атгуулчхах.

ПОДМА́ЗАТЬСЯ 1. будах, уруул хөмсгөө будах, 2. зулгуйдах, нялганах.

ПОДМА́НИВАТЬ дуудах, даллах.

ПОДМАНИ́ТЬ дуудах, даллах, дуудаж аваачих, даллаж ирүүлэх.

ПОДМАСТЕ́РЬЕ мастерын дагалдан, дагалдах мастер, дархны туслах.

ПОДМА́ЧИВАТЬ жаахан норгох, дэвтээх, чийглэх.

ПОДМЁН солих, сэм солих.

ПОДМЕ́Н||А солих, сэм солих, сольсон, сэлгэсэн, **обнаружить ~у** сольсоныг илрүүлэх.

ПОДМЕ́НИВАТЬ,

ПОДМЕНИ́ТЬ,

ПОДМЕНЯ́ТЬ солих, сэмхэн солих, сэлгэх; ~ **карту** хөзөр сэм солих.

ПОДМЕРЗ||А́ТЬ 1. мөхөөлдөх, **лужи ~ли** шалбааг мөстөв; 2. жаахан хөлдөх, мөхөөлдөж гэмтэх; **овощи и ~ли** хүнсний ногоо мөхөөлдөж гэмтэв.

ПОДМЕСИ́ТЬ нэмж зуурах, нэмж нухах; ~ **муку в тесто** бэмбийд гурил нэмж зуурах.

ПОДМЕСТИ́,

ПОДМЕТА́ТЬ шүүрдэх, хамах, шүүрдэж хийх, ~ **пол** шал шүүрдэх.

ПОДМЕ́ТИТЬ,

ПОДМЕЧА́ТЬ ажих, ажиж мэдэх, ажиглаж мэдэх; ~ **недостатки** дутагдлыг ажиж мэдэх.

ПОДМЁТК||А подбивать ~и зан тавих, **в ~и не годится** чигчийд нь ч хүрэхгүй.

ПОДМЕША́ТЬ,

ПОДМЕ́ШИВАТЬ холих, хутгах, хольж хутгах; ~ **песку в цемент** цементэнд элс холих.

ПОДМИ́ГИВАТЬ,

ПОДМИГНУ́ТЬ нүд ирмэх, анивчих.

ПОДМИНА́ТЬ дороо дарах, дарж унагах.

ПОДМО́Г||А дэмжих, дэмжлэг үзүүлэх, тусламж элбэх, хамсах, **прийти на ~у** дэмжих гэж ирэх.

ПОДМОКА́ТЬ,

ПОДМО́КНУТЬ жаахан норох, дороосоо норох, чийгтэх, чийг авах, **сахар подмок** чихэр чийг авчээ.

ПОДМОРА́ЖИВАТЬ хөргөх, хөлдөөх, мөхөөлтүүлэх.

ПОДМОРО́ЗИ||ТЬ1. хөргөх, хөлдөөх, мөхөөлтүүлэх; ~ **мясо** мах мөхөөлтүүлэх, 2. хүйтрэх, жавар орох, **утром ~ло** өглөөгүүр хүйтрэв.

ПОДМОСКО́ВНЫЙ Москва хавийн.
ПОДМО́СТКИ тайз, тавцан, модон индэр, **театральные ~** театрын тайз.
ПОДМО́ЧЕНН||ЫЙ норсон, дэвтсэн, чийгтсэн, чийг авсан; **~ая репутация** нэр хугарах, нэр хүндээ барах.
ПОДМОЧИ́ТЬ жаахан, норгох, чийгтүүлэх, чийг авахуулах; **~ табак** тамхи чийг авахуулах.
ПОДМЫВА́||ТЬ 1. доогуур нь угаах, жаахан угаах; 2. асан гэж санах, асан гэж хорхой хөдлөх, гэж хорхой гозгонох; **меня так и ~ло сказать об этом** энэ тухай хэлэх асан гэж миний хорхой хөдөлж байна.
ПОДМЫ́ТЬ 1. доогуур нь угаах, жаахан угаах; **~ ребёнка** хүүхдийг жаахан угаах, 2. угаамаар болох, угаасхийх; **~ пол** шалаа угаамаар болох, 3. угааж нураах, угааж элээх, хөндийлөн идэх.
ПОДМЫ́ШК||А нести книгу ~ой ном сугандаа хавчуулаад явах.
ПОДМЯ́||ТЬ дарж унах, унагаж дарах, дороо дарж ойчих, **медведь ~л охотника** баавгай анчныг дарж унагав.
ПОДНАДЗО́РНЫЙ харгалзаатай, харгалзаанд байгаа, хяналтад байгаа.
ПОДНАЖА́ТЬ шавдах, шавдуулах, шахах; **~, чтобы успеть к сроку** хугацаанд амжуулахын төлөө шавдах; **~ на лентяя** хойргуудыг шавдуулах.
ПОДНАРЯ́Д өлмийн улавч, улавч, хүүхэн ул.
ПОДНЕБЕ́СНАЯ тэнгэрийн дорх, бүх дэлхий, ертөнц.
ПОДНЕБЕ́СЬЕ огторгуй, **орёл взлетел в ~** бүргэд огторгуйд нисэв.
ПОДНЕВО́ЛЬНЫЙ 1. өөрийн эрх мэдэлгүй, өөрийн эрхгүй, хүний мэдэлд байдаг; **~ человек** өөрийн эрхгүй хүн, 2 албадлагын.
ПОДНЕСТИ́ 1. ойртуулах, дөтлүүлэх, ойртуулж үзэх; **~ книгу к глазам** номыг нүдэндээ ойртуулж үзэх, 2. ойртуулж өгөх, авчирж өгөх, хүргэж өгөх, 3. бэлэглэх, өгөх, бэлэглэж өгөх, өргөх; **~ букет цветов** баглаа цэцэг бэлэглэх.
ПОДНИМА́ТЬ, ПОДНЯ́ТЬ 1. өргөх; **~ тяжесть** хүнд юм өргөх; 2 өргөж гаргах; 3 авах; **~ платок** ойчсон алчуурыг авах, 4 дээшлүүлэх; **~ дисциплину** сахилга журмыг дээшлүүлэх, 5 нэмэх, нэмэгдүүлэх, ахиулах; **~ цены** үнэ нэмэгдүүлэх, 6. өргөж босгох, босгох; **~ упавшего** ойчсон хүнийг өргөж босгох; ~ 7. барьж босгох, босох, 8. дэгдээх; **~ шум** шуугиан дэгдээх, 9. өөд татах, дээш татах, 10. өндөрлөх, овоолох, 11. тавих; **~ вопрос** асуулт тавих, 12. урамшуулах, зоригжуулах.
ПОДНИМА́ТЬСЯ 1. гарах, өөд гарах, өгсөх, авирах; 2. дэгдэх, нисэж гарах; 3. босох, өндийх; 4. сөхөгдөх, өргөгдөх; 5. нэмэх, нэмэгдэх; 6. сайжрах, дээшлэх; 7. хөдлөх; 8. сэргэх; 9. хөвсийх, хөөх, бэмбийх; 10. гарах.
ПОДНОВИ́ТЬ шинэтгэх.
ПОДНОВЛЯ́ТЬСЯ шинэтгэгдэх.
ПОДНОГО́ТН||АЯ нууж хаасан, дарж далдалсан, нууц; **узнать всю ~ую** хамаг нууж хаасныг нь мэдэх, хамаг нууцыг нь мэдэх.
ПОДНО́ЖИЕ 1. бэл, хормой; **~ горы** уулын бэл, 2. суурь, оёор.
ПОДНО́ЖКА 1. гишгүүр, 2. дэгээдэх, хөлөөр таших.
ПОДНО́ЖНЫЙ бэлчээр, хагд; **~ корм** бэлчээрийн өвс.
ПОДНО́С 1. тосгуур, 2. ойртуулж өгөх, хүргэж ирэх.
ПОДНОСИ́ТЬ 1. ойртуулах, ойртуулж үзэх, 2. ойртуулж өгөх, авчирч өгөх, хүргэж өгөх, бэлэглэж өгөх.
ПОДНО́СЧИК хүргэгч, зөөгч; **~ патронов** сум зөөгч.
ПОДНОШЕ́НИЕ 1. бэлэглэх, бэлэг өгөх, 2 бэлэг; **получить ~** бэлэг авах.
ПОДНЯ́ТИЕ 1. өргөх, сөхөх, хийсгэх, мандуулах; **~ флага** далбаа мандуулах, 2 нэмэгдэх; **~ уровня воды** ус нэмэгдэх; 3 дээшлэх, ахих; **~ производительности труда** хөдөлмөрийн бүтээмж дээшлэх.
ПОДНЯ́||ТЬСЯ 1. гарах, өөд гарах, өгсөх, авирах; **~ по лестнице** шат өөд гарах, шатаар гарах; **~ на гору** уул өгсөх, уул өөд гарах, 2. дэгдэх, нисэж гарах; **~ в воздух** агаарт дэгдэх, 3. босох, өндийх; **~ со стула** сандлаас босох; **~ на борьбу** тэмцэхээр босох; 4. сөхөгдөх, өргөгдөх; **занавес ~лся** хөшиг сөхөгдөв; 5. нэмэх, нэмэгдэх; **температура ~лась** халуун нэмэгдэв; **цены ~лись** үнэ нэмэгдэв; **~лся интерес к чему-либо** юманд сонирхол нэмэгдэв; 6. сайжрах, дээшлих, дэгжих, сайжрав; 7. хөдлөх, босох; **~лся сильный ветер** хүчтэй салхи хөдлөв; 8. сэргэх; **у него ~лось настроение** сэтгэл санаа нь сэргэв; 9. хөвсийх, хөөх, бэмбийх, **хлеба ~лись** ээдмэг хөвсийв; 10. гарах; **~лся шум** шуугиан гарав; **~лся с постели** орноосоо өндийх, эдгэж босох.
ПОДО өмнө, дор; **~ мной** миний өмнө; **~ льдом** мөсөн дор.
ПОДОБА́||ТЬ зохилдох, зохих, таарах; **так поступать не ~ет** тэгж таарахгүй; **тебе не ~ет говорить это** чи ингэж хэлж зохилдохгүй; **как ~ет** зохих ёсоор нь; **сделать как ~ет** зохих ёсоор нь хийх.
ПОДОБА́ЮЩ||ИЙ зохилдох, зохих; **~ее положение** зохилдох байдал; **~им образом** зохих ёсоор нь.
ПОДО́БИ||Е төс, төсөө, төсөөтэй, адилавтар, мэт; **создать что-нибудь по своему образу и ~ю** өөрийн янз төсөөний юмыг үйлдэх; **~ двух треугольников** хоёр гурвалжны төсөө.
ПОДО́БЛАЧН||ЫЙ үүлэн дорх, огторгуй; **~ая высь** огторгуйн гүн.
ПОДО́БНО шиг, мэт, адил; **~ муравью трудолюбив мужик** тариачин шоргоолж шиг ажилсаг юм; **~ ему** түүн шиг, түүний адил.
ПОДО́БН||ЫЙ 1. шиг, мэт, адилавтар, төстэй, төсөөтэй, иймэрхүү, тиймэрхүү, ингэж, тэгж; **происшествие, ~ое этому, было в прошлом году** энүүн шиг адал явдал нөднин жил болсон юм; **в ~ых случаях** иймэрхүү тохиолдол болоход; **он поступил ~ым же образом** тэр бас тэгж л хийсэн; **~ые треугольники** төсөөтэй гурвалжнууд; 2. ийм, тийм; **никогда не встречал ~ых упрямцев** ийм зөрүүд хүмүүстэй ердөө дайралдаж яваагүй; **ничего ~ого** огт тийм биш, гэх мэт.
ПОДОБОСТРА́СТИЕ саймсрах, зусар.
ПОДОБОСТРА́СТНОСТЬ саймсрах, зусар.
ПОДОБОСТРА́СТНЫЙ саймсрах, саймсархуу, зусар; **~ человек** саймсархуу хүн; **~ взгляд** зусар харц.
ПОДОБРА́ТЬ 1. түүж авах, цуглуулж авах, хамж авах; **~ бумаги с пола** шалан дээрээс цаасыг хамж авах; 2. засаж залах, шуух, зайдах, хумих; **~ волосы** үсээ засаж залах; 3. олж авах, бүрдүүлэх, шилж авах, тааруулж авах; **~ хороших работников** сайн ажилтныг олж авах; **~ хорошую библиотеку** сайн номын санг бүрдүүлэх; **~ книги для чтения** унших ном шилж авах; **~ ключ к замку** цоожинд түлхүүр тааруулах.
ПОДОБРА́||ТЬСЯ 1. цугларах, бүрдэх; **~лся хороший коллектив** сайн хамт олон цугларав; 2. мярааж ойртох, гэтэж очих; **кошка ~лась к птице** муур бялзуухайд гэтэж очив.
ПОДОБРЕ́ТЬ 1. зан нь сайжрах, зан нь засрах, сайжрах, засрах; 2. мариажих.
ПОДОБРУ́-ПОЗДОРО́ВУ мэнд дээрээ, бүтэн бүлээн дээрээ; **уходи ~** мэнд дээрээ яв.
ПОДОГНА́ТЬ 1. тууж, авчрах; **~ скот к воротам** мал хашааны үүдэнд тууж авчрах; 2. хурдасгах, шамдуулах; **~ лошадь** морины явдлыг хурдасгах; **~ отстающих** хожимдогсдыг

шамдуулах; 3. тааруулах; ~ **стекло к раме** жаазанд шил тааруулах.

ПОДОГНУ́ТЬ 1. нугалах, эвхэх; ~ **край листа** хуудасны захыг нугалах; 2. хумхих; ~ **под себя ноги** хөлөө хумхих.

ПОДОГНУ́||ТЬСЯ нугарах, эвхрэх, хумхирах; **воротничок рубашки ~лся** цамцны зах нугарчээ; **ноги ~лись** хөл салганав.

ПОДОГРЕ́В халаах, бүлээсгэх, дулаацуулах.

ПОДОГРЕВА́НИЕ халаах, бүлээсгэх, дулаацуулах.

ПОДОГРЕВА́ТЬ халаах, бүлээсгэх, дулаацуулах.

ПОДОГРЕВА́ТЬСЯ халах, бүлээсэх, дулаацах.

ПОДОГРЕ́ТЫЙ халаасан, бүлээссэн, дулаацсан; ~ **обед** халаасан хоол.

ПО́ДОГРЕТЬ халаах, бүлээсгэх, дулаацуулах; ~ **суп** шөл халаах; ~ **чай** цай бүлээсгэх.

ПОДОДВИГА́ТЬ ойртуулах, дөхүүлэх.

ПОДОДВИГА́ТЬСЯ ойртох, дөхөх, ойртож суух, дөхөж суух.

ПОДОДВИ́НУТЬ ойртуулах, дөхүүлэх; ~ **стул к столу** ширээнд сандал ойртуулах.

ПОДОДВИ́НУТЬСЯ ойртох, дөхөх, ойртож суух, дөхөж суух; ~ **к соседу** дэргэдэх хүндээ ойртож суух.

ПОДОДЕЯ́ЛЬНИК хөнжлийн бүрээс, хөнжлийн даавуу.

ПОДОЖД||А́ТЬ хүлээх, хүлгэлзэх, хүлээж байх, азнах; ~ **поезда** галт тэрэг хүлээх; **~и, я завтра узнаю и скажу** азнаж бай, би маргааш мэдээд хэлье.

ПОДОЗВА́ТЬ дуудаж ирүүлэх, дуудах; ~ **прохожего** өнгөрч яваа хүнийг дуудаж ирүүлэх.

ПОДОЗРЕВА́||ТЬ 1. сэжиглэх, хардах; ~ **кого-либо в обмане** мэхлэв үү гэж хүнийг сэжиглэх; 2. төсөөлөх, таамаглах, тухайлах; **я ~ла, что он заболел** би түүнийг өвдөө байх даа гэж таамаглаж байв.

ПОДОЗРЕВА́ТЬСЯ сэжиглэгдэх, хардагдах.

ПОДОЗРЕ́НИ||Е сэжиглэх, сэжигдэх, сэжиг, сэжиглэгдэх, хардах, хардлага; **арестован по ~ю в краже** хулгайд сэжиглэгдэж баригдсан; **возбудить ~** сэжиг төрүүлэх.

ПОДОЗРИ́ТЕЛЬНОСТЬ сэжигтэй, сэжиглэх, сэжигдэх, хардах, өөнтөглөх, өөнтөгч; **отличаться излишней ~ю** дэндүү өөнтөгч зантай байх, хэтэрхий хардаж байх.

ПОДОЗРИ́ТЕЛЬНЫЙ 1. сэжигтэй, сэжигдмээр, эргэлзэлтэй; ~ **человек** сэжигтэй хүн; 2. сэжиглэмтгий, сэжигч, хардлагатай; ~ **характер** сэжиглэмтгий зан.

ПОДОИ́ТЬ саах; ~ **корову** үнээ саах.

ПОДО́ЙНИК саалын хувин, хөнөг.

ПОДОЙТИ́ 1. очих, ойртох, хүрэх, ойртож очих, хүрч очих, тулж очих; ~ **к берегу** эрэгт ойртож очих; **поезд подошёл к станции** галт тэрэг өртөөнд хүрч очив; 2. эхлэх, шууд хэлэлцэх, тулах; **вплотную ~ к вопросу** асуултыг шууд хэлэлцэх; 3. хандах, харьцах; **критически ~ к чему-либо** юманд шүүмжлэлтэйгээр хандах; **уметь ~ к людям** хүнтэй харьцаж чадах; 4. таарах; **это прозвище ему подойдёт** энэ хоч нэр түүнд таарна.

ПОДОКО́ННИК цонхны ирмэг, цонхны дэвсэг, тавцан.

ПОДО́Л хормой; ~ **юбки** банзалын хормой.

ПОДО́ЛГУ ~ жить в Москве Москвад удаан суух.

ПОДО́НКИ 1. шаар, шавхруу; ~ **чая** цайны шаар, цайны шавхруу; 2. шаар, шааран; ~ **общества** нийгмийн шаар; ~ **человечества** хүн төрөлхтний шаарангууд.

ПОДОПЕ́ЧНЫЙ асрамжийн, асрамжит, асрамжид байгаа; ~ **ребёнок** асрамжийн хүүхэд.

ПОДОПЛЁК||А цаад шалтгаан, далд шалтгаан; **узнать ~у интриги** өдөөж хатгах явдлын цаад шалтгааныгмэдэх.

ПОДОПРЕ́||ТЬ нэхших, үжих; **сено ~ло** хадсан өвс нэгшив.

ПОДО́ПЫТН||ЫЙ туршлагын, туршлага хийгдэж байгаа; **~ое животное** туршлагын амьтан.

ПОДОРВА́ТЬ 1. дэлбэлэх, тэслэх; ~ **мост** гүүр дэлбэлэх; 2. муудуулах, муутгах, **гутаах**.

ПОДОРВА́||ТЬСЯ 1. дэлбэрэх, дэлбэрэлтэд дайрагдах, дэлбэ цохиулж үхэх; 2 муудах; **здоровье ~лось** бие муудчихлаа.

ПОДОРОЖА́ТЬ үнэтэй болох, үнэд орох, үнэ нэмэгдэх.

ПОДОРО́ЖНАЯ улааны бичиг, улаа хэрэглэх үнэмлэх.

ПОДОРО́ЖНИК таван салаа, үүргэнэ.

ПОДОСИ́НОВИК салбан хусандай мөөг, улиасны сархиаг.

ПОДОСЛА́ТЬ илгээх, явуулах, заншлуулах.

ПОДОСНО́В||А шалтгаан, ёзоор; **вскрыть ~у явления** үзэгдлийн уг шалтгааныг нээн олох.

ПОДОСПЕ́||ТЬ хүрч ирэх, хүрэлцэж ирэх; **помощь ~ла вовремя** тусламж цаг тухайд нь хүрч ирлээ.

ПОДОСТЛА́ТЬ дор нь дэвсэх, дэвсэж өгөх; ~ **простыню** цагаан даавуу дэвсэж өгөх.

ПОДОТКНУ́ТЬ доогуур нь ивэх, хумих, хумлайдах; ~ **край одеяла** хөнжлийн хөвөөг хумлайдах.

ПОДОТЧЁТН||ЫЙ 1. тайлан, гаргах, дараа тайлан гаргах, тооцооны, **~ая сумма** дараа тайлан гаргах мөнгө; 2 харьяа, харьяалагдах, тайлагнадаг; **~ые организации** харьяа байгууллагууд.

ПОДО́Х||НУТЬ үхэх, турж үхэх; **овцы ~ли** хонь үхлээ.

ПОДОХО́ДНЫЙ ашгийн, ашиг орлогын; ~ **налог** олз ашгийн татвар.

ПОДО́ШВ||А хормой, ул; ~ **горы** уулын хормой; **на двойной ~е** давхар ултай.

ПОДПАДА́ТЬ орох, автагдах; ~ **под чьё-либо влияния** бусдын нөлөөнд орох.

ПОДПА́ИВАТЬ согтоох, согттол уулгах.

ПОДПА́ЛИНА толбо, цайруу толбо, алаг; **кобель с ~ми** алаг нохой.

ПОДПАЛИ́ТЬ 1. шатаах, түлэх; ~ **дом** байшин шатаах; 2 хуйхлах; ~ **себе усы папиросой** тамхины галаар сахлаа хуйхлах.

ПОДПА́РЫВАТЬ ханзлах.

ПОДПА́СТЬ орох, автагдах; ~ **под чьё-нибудь влияние** бусдын нөлөөнд орох, хүний нөлөөнд автагдах.

ПОДПЕВА́ЛА 1. дагалдан дуулагч; 2. даган дуурайгч, аялдан дагалдагч.

ПОДПЕВА́ТЬ 1. дагалдан дуулах; 2. даган дуурайх, аялдан дагалдах.

ПОДПЕРЕ́ТЬ тулах, түших; ~ **забор кольями** хашааг модоор тулах; ~ **щёку рукой** гараараа шанаагаа тулах; ~ **голову рукой** гараар толгойгоо түших.

ПОДПЕРЕ́ТЬСЯ тулах, түших; **рукой ~ в бок** гараар ташаагаа тулах.

ПОДПИ́ЛИВАТЬ 1. тайрах, хөрөөдөж тайрах; 2. хөрөөдөх, жаахан хөрөөдөх; ~ **дерево** мод хөрөөдөх.

ПОДПИ́ЛОК хуурай.

ПОДПИРА́ТЬ тулах, түших.

ПОДПИРА́ТЬСЯ тулах, түших.

ПОДПИСА́НИЕ гарын үсэг зурах; ~ **договора** гэрээнд гарын үсэг зурах.

ПОДПИСА́ТЬ 1. гарын үсэг зурах; ~ **заявление** өргөдөлд гарын үсэг зурах; ~ **договор** гэрээнд гарын үсэг зурах; 2. бичих, нэмж бичих; ~ **на конверте свой адрес** дугтуй дээр хаягаа бичих.

ПОДПИСА́ТЬСЯ 1. гарын үсэг зурах, бичих; ~ **под статьей** өгүүлэл дээр гарын үсгээ зурах; 2. захиалах; ~ **на журнал** сэтгүүл захиалах.

ПОДПИ́СК||А 1. захиалга, захиалах; **приём ~и на газеты и журналы** сонин сэтгүүлийн захиалга хүлээн авах; 2. баталгаа өгөх, амлах, батлах бичиг, гарын үсэг; **дать ~у о невыезде** гадагш явахгүй гэж гарын үсэг өгөх.

ПОДПИСН||О́Й захиалгын; **~ое издание** захиалгын хэвлэл.

ПОДПИ́СЧИК захиалагч, захигч; **~ на газету** *сонин* захиалагч.

ПОДПИ́СЫВАТЬ 1. гарын үсэг зурах; **~ договора** гэрээнд гарын үсэг зурах; 2. бичих, нэмж бичих.

ПОДПИ́СЫВАТЬСЯ 1. гарын үсэг зурах, 2 захих, захиалах.

ПО́ДПИСЬ 1гарын үсэг; **поставить свою ~** гарын үсгээ зурах, 2. гарын үсэг зурах, гарын үсэг зуруулах; **отдать бумаги на ~** бичигт гарын үсэг зуруулахаар өгөх.

ПОДПЛЫВА́ТЬ сэлж хүрэх, сэлж очих; **~ к берегу** эрэгт сэлж хүрэх.

ПОДПОЙ́ТЬ согтоох, согттол уулгах, жаахан согтоох.

ПО́ДПОЛ зоорь.

ПОДПОЛЗА́ТЬ 1. мөлхөж очих, мөлхөж хүрэх; **раненый подполз к кусту** шархтай хүн бутанд мөлхөж хүрэв; **~** 2. мөлхөж орох; **~ под кровать** *орон доогуур мөлхөж орох*.

ПОДПОЛКО́ВНИК дэд хурандаа.

ПОДПО́ЛЬЕ 1. зоорь; **спуститься в ~** зооринд орох; 2. нууц, далд, нууц ажиллагаа, хориглогдсон ажил.

ПОДПО́ЛЬН||ЫЙ нууц хоригтой, хориглогдсон, хориултай; **~ая работа** нууц ажил.

ПОДПО́ЛЬЩИК нууц ажилтан, нууц байгууллагын гишүүн, хоригтой ажилтан.

ПОДПО́РА тулгуур, тулга, түшиг; **~ к забору** хашааны тулгуур; **~ для цветов** цэцгийн сөр.

ПОДПОРО́ТЬ ханзлах, дороос нь ханзлах, дотроос нь ханзлах; **~ шов** оёдлыг ханзлах.

ПОДПОРУ́ЧИК бага дэслэгч (Хаант оросын офицерийн хэргэм).

ПОДПО́ЧВЕНН||ЫЙ хөрсөн дорх; **~ые воды** хөрсөн дорх ус.

ПОДПОЯ́САТЬ,

ПОДПОЯ́СЫВАТЬ бүслэх, бүслүүлэх.

ПОДПОЯ́САТЬСЯ,

ПОДПОЯ́СЫВАТЬСЯ бүслэх, бүсээ бүслэх.

ПОДПРА́ВИТЬ,

ПОДПРА́ВЛЯТЬ засах, жаахан засах, засаж залруулах, **~ написанную букву** бичсэн үсгийг жаахан засах.

ПОДПРУ́Г||А олом, олом жирэм, цавилуур; **затянуть ~у** олмоо татах, олмоо чангалах; **ослабить ~у** олмоо сулруулах.

ПОДПРЫ́ГИВАТЬ,

ПОДПРЫ́ГНУТЬ дэвхрэх, дэвхцэх, цовхрох; **~ до потолка** тааз тултал дэвхрэх; **~ от радости** баярлаад дэвхцэх, баярлаж хөл хөнгөрөх.

ПОДПУСКА́ТЬ ойртуулах, дөхүүлэх, ойрхон ирүүлэх, халгах.

ПОДПУСТИ́ТЬ 1. ойртуулах, дөхүүлэх, ойрхон ирүүлэх, халгах; **~ зверя на расстояние выстрела** араатныг сум хүрэхүйц газарт ойртуулах; 2. тавих, нийлүүлэх; **~ телёнка к корове** тугалыг үнээнд нийлүүлэх; 3. холих, нэмэх; **~ белил в краску** будагт цагаан будаг холих; 4. шургуулчхах; **~ шутку** хошин яриа шургуулчхах; **~ колкость** ёжтой үг шургуулчхах; 5. *разг* **~ шпильку** аазгайгий нь хөдөлгөх.

ПОДРАБА́ТЫВАТЬ халтуур хийх, илүү мөнгө олох.

ПОДРАБО́ТАТЬ 1. олз олох, нэмэгдэл олз олох, хажуугаар нь ашиг олох; **~ денег** нэмэгдэл мөнгө олох; 2. боловсруулах, цэгцлэх, бэлдэх. **ПОДРА́ВНИВАТЬ** *тэгшлэх, тэгшитгэх*.

ПОДРАЖА́НИЕ дуурайх, дуурайлт; **~ взрослым** насанд хүрэгсдийг дуурайх.

ПОДРАЖА́ТЕЛЬ дуурайгч, сажаагч.

ПОДРАЖА́ТЕЛЬН||ЫЙ дуураймал, дуурайсан, дуурайх; **~ая поэзия** *дуураймал яруу найраг*; **~ые способности** дуурайх авьяас.

ПОДРАЖА́ТЬ *дуурайх, сажаах*; **~ пению птиц** шувууны жиргэхийг дуурайх.

ПОДРАЗДЕЛЕ́НИЕ 1. хуваах, таслах; 2. анги, хэсэг, салбар анги. **ПОДРАЗДЕЛИ́ТЬ,**

ПОДРАЗДЕЛЯ́ТЬ хуваах, ангилах; **~ главу на параграфы** бүлгийг зүйлүүдэд хуваах.

ПОДРАЗНИ́ТЬ гоочлох, даажигнах.

ПОДРАЗУМЕВА́||ТЬ тухайлах, *уйтгартайгаар хэлэх, ойлгож байх*; **что вы ~ете под этими словами?** энэ үгийг та ямар утгатайгаар хэлж байна? **ПОДРАЗУМЕВА́ТЬСЯ** тухайлагдах, тааварлагдах, аяндаа ойлгогдох, аяндаа мэдэгдэх.

ПОДРАСТА́ТЬ ургах, өсөх; **за лето деревья заметно подросли** зундаа энэ моднууд мэдэхүйц ургажээ; **ваш мальчик подрос за этот год** танай хүү энэ жил их өсчээ.

ПОДРАСТА́ЮЩ||ИЙ ургах, өсөх; **~ее поколение** өсөх залуус, өсвөрийн залуу үе.

ПОДРА́ТЬСЯ зодолдох, ноцолдох.

ПОДРЕ́ЗАТЬ тайрах, тэгшлэн засах, танах, хирвэх, зүсэх; **~ деревья в саду** цэцэрлэгийн модыг тэгшлэн засах; **~ подол у платья** хувцасны хормойг танах; **~ волосы** үс тайрах, үс хяргах; **~ хлеб** талх зүсэх; **~ крылья** далавчий нь огтлох, сортойг нь дарах.

ПОДРЕМА́ТЬ зүүрмэглэх, үүрэглэх.

ПОДРИСОВА́ТЬ нэмж зурах, засаж зурах.

ПОДРО́БНО тодорхой, тодорхойлж, дэлгэрэнгүй; **~ описать виденное** үзсэн юмаа тодорхой бичих.

ПОДРО́БНОСТ||Ь тодорхой, тодорхойлох, нарийн учир, жижиг зүйлүүд, дэлгэрэнгүй; **рассказать во всех ~ях** бүгдийг тодорхой ярих.

ПОДРО́БНЫЙ тодорхой, дэлгэрэнгүй; **~ отчёт** тодорхой тайлан.

ПОДРО́СТОК өсвөрийн хүүхэд, өөлэй хүүхэд.

ПОДРУБ||А́ТЬ 1. тайрах, танах; 2. огтлох, дооронос нь *огтлох*; **~ить дерево** мод огтлох; 3. хөвөөлөх, имхэрдэх, хөвөрдөх; **~ить носовые платки** нусны алчуурыг имхэрдэх.

ПОДРУ́Г||А эмэгтэй хань, найз хүүхэн, хань, найз; **школьные ~и** сургуулийн найз хүүхнүүд; **~ жизни** учирсан хань.

ПОДРУЖИ́ТЬСЯ *нөхөрлөх, найзлах, үерхэх*.

ПОДРУ́ЖКА найз хүүхэн, үерхдэг охин.

ПОДРУМЯ́НИВАТЬ улайлгах, улаан болгох, улайх, улаан болох.

ПОДРУМЯНИВАТЬСЯ улайлгах, улаан болгох, улайх, улаан *болох*.

ПОДРУМЯ́НИ||ТЬ 1. улайлгах, улаан болгох, улайх, улаан болох; **мороз ~л детям щёки** хүйтэнд хүүхдийн хацар улайв; 2. энгэсэг түрхэх.

ПОДРУМЯ́НИ||ТЬСЯ 1. улайх, улаан болох; **щёки ~лись от мороза** хүйтэнд хацар улайв; 2. энгэсэг түрхэгдэх; 3. улайрах, хүрэнтэх, улаа бутрах; **хлеб ~лся** эздмэг хүрэнтэж боллоо.

ПОДРУЧНЫЙ 1. *ойр зуурын, гарын авлагын*; **~ инструмент** ойр зуурын багаж; 2. туслах, дагалдан; **~ сталевара** болд хайлагчийн туслах.

ПОДРЫ́В 1. дэлбэлэх, тэслэх; **~ скалы** хад тэслэх; 2. гутаах, муудуулах; **~ авторитета** нэр хүндийг гутаах.

ПОДРЫВА́ТЬ I 1. дэлбэлэх, тэслэх; **~ здоровье** эрүүл мэндийг муудуулах.

ПОДРЫВА́ТЬ II *доогуур малтах, дороос ухах*; 2. нэмж малтах, цааш нь ухах.

ПОДРЫВА́ТЬСЯ 1. дэлбэрэх, дэлбэрэлтэнд дайрагдах, дэлбэ цохиулж үхэх; 2. муудах.

ПОДРЫВНИ́К тэслэгч, дэлбэлэгч.

ПОДРЫВНО́Й 1. тэслэх,тэсэлгээний, дэлбэлэх; ~ **материал** тэслэх хэрэглэгдэхүүн, 2. хорлон сүйтгэх.

ПОДРЫ́ТЬ 1. доогуур малтах, дороос ухах; ~ **дерево** модон доогуур малтах; 2. нэмж малтах, цааш нь ухах.

ПОДРЫ́ТЬСЯ малтаж орох, ухаж орох.

ПОДРЯ́Д I ажлын гэрээ, гэрээниий ажил, тохиролцоо; **постройка по ~у** гэрээгээр хийх барилга.

ПОДРЯ́Д II дэс дараагаар нь, үргэлж, залгалдуудан; **я прочёл ~ сто страниц** би зуун хуудас дэс дараагаар нь уншлаа; **несколько дней ~** хэдэн өдөр дараалан.

ПОДРЯДИ́ТЬ түр хөлслөх, түрээслэх.

ПОДРЯДИ́ТЬСЯ хэлэлцээрээр хийх, хэлэлцээрээр, эдэх.

ПОДРЯ́ДН||ЫЙ гэрээний, хэлэлцээний, гэрээгээр хийх, тохиролцоогоор хийх; **~ые работы** хэлэлцээгээр хийх ажил.

ПОДРЯ́ДЧИК ажил гүйцэтгэгч, гэрээгээр барилга барих газар, хэлэлцээгээр ажиллагч, тохиролцогч, даамал.

ПОДРЯЖА́ТЬ түр хөлслөх, түр хөлсөлж авах.

ПОДРЯЖА́ТЬСЯ ажил хэлэлцээрээр, хийх.

ПОДСАДИ́ТЬ 1. суулгах, дэмжин суулгах, түшиж мордуулах; 2. дэргэд суулгах, хажууд суулгах; 3. нэмж тарих, нэмж суулгах; ~ **капусты** байцаа нэмж тарих.

ПОДСА́ЖИВАТЬ суулгах, дэмжин суулгах, түшиж мордуулах.

ПОДСА́ЖИВАТЬСЯ дэргэд суух, хажууд суух.

ПОДСВЕ́ЧНИК лааны суурь, лааны тосгуур.

ПОДСЕКА́ТЬ тас цавчих.

ПОДСЕ́ЧЬ 1. тас цавчих; 2. угзрах, угз татах.

ПОДСЕ́СТЬ дэргэд суух, хажууд суух, ойртож суух; ~ **к столу** ширээний дэргэд суух, ширээнд ойртож суух; 2. ~ **на наркотики** хар тамхинд орох, хар тамхинд донтох.

ПОДСЕ́ЧКА 1. цавчилт; 2. угзралт.

ПОДСЕВА́ТЬ,

ПОДСЕ́ИВАТЬ нэмж тарих.

ПОДСИ́НИВАТЬ хөхрүүлэх, цэнхэртүүлэх, хөхөмдөг болгох.

ПОДСИНИ́ТЬ хөхрүүлэх, цэнхэртүүлэх, хөхөмдөг болгох; ~ **бельё** дотуур хувцас хөхрүүлэх.

ПОДСКАЗА́ТЬ хэлж өгөх, сэмхэн хэлэх, шив хийх.

ПОДСКА́ЗЫВАТЬ1. хэлж өгөхөр сэмхэн хэлэх, шив хийх; ~ **во время экзамена** шалгалтын үед хэлж өгөх, шалгалтан дээр шив хийх; 2. санаа авахуулах, санаа оруулах; **опыт подсказал правильное решение** туршлага зөв шийдвэрлэх санааг оруулав.

ПОДСКА́ЗКА хэлж өгөх сэмхэн хэлэх, шив хийх.

ПОДСКА́ЗЧИК хажуунаас хэлж өгөгч, сэм хэлэгч, шив хийгч.

ПОДСКАКА́ТЬ,

ПОДСКА́КИВАТЬ давхиж ирэх.

ПОДСКА́КИВАТЬ дэвхцэх, дэвхрэх.

ПОДСКОЧИ́||ТЬ 1. дэвхцэх, дэвхрэх; ~ **от радости** баярлаад дэвхцэх; 2. гүйж: очих, хараилгаж ирэх; 3. гэнэт нэмэгдэх, хурдан ихсэх; **температура ~ла** халуун нь гэнэт нэмэгдэв.

ПОДСКРЕБА́ТЬ,

ПОДСКРЕСТИ́ хусах, хусаж цэвэрлэх; ~ **сковородку** хайруулыг хусаж цэвэрлэх.

ПОТРЯСА́||ТЬ 1. далайх, далайлгах, заналхийлэх, сүрдүүлэх; **~ют кулаками, грозят** зангидсан гараа далайн занаж байна; **~ оружием** буу зэвсгээр далайлгах; 2. донсолгох, доргиулах; **~ землю** дэлхийг донсолгох; 3. гайхуулах, гайхагдах, хачирхуулах, долгилуулах; **~ зрителей** үзэгчдийг гайхуулах; **~ сердца** зүрх долгилуулах.
ПОТРЯСА́ЮЩ||ИЙ тун сүрхий, донсолгох, доргиулах, хачин; **~ее впечатление** тун сүрхий сэтгэгдэл; **~ая красота** хачин сайхан.
ПОТРЯСЕ́НИЕ донсолгоо, донсолгох, доргих, цочирдол; **нервное ~** мэдрэлийн донсолгоо, сэтгэл их зовох.
ПОТРЯС||ТИ́ 1. сэгсрэх, гөвөх; **~ одеяло** хөнжил сэгсрэх; 2. занах, далайлгах; 3. донсолгох, доргиулах; **взрыв потряс здание** дэлбэрэлт байшинг донсолгов; 4. сэтгэл долгилуулах; **речь его ~ла слушателей** түүний үг сонсогчдын сэтгэлийг долгилуулав.
ПОТРЯ́ХИВА||ТЬ сэгсрэх, шилгээх; **конь ~ет гривой** морь дэлээ сэгсэрч шилгээв.
ПОТУ́ГИ 1. дүлэх, агзайх; 2. дэмий оролдох, хоосон чармайлт.
ПОТУЖИ́ТЬ санаа зовох, гуниглах; **~ о сыне** хүүгийнхээ тухай санаа зовох.
ПОТУ́ПИВШИСЬ тонгойж, уруугаа харж; **сидеть ~** уруугаа харж суух.
ПОТУПЛЯ́ТЬ тонгойх, тонгойлгох, духайх, уруугаа харах, доошоо ширтэх; **~ голову** толгойгоо тонгойлгох.
ПОТУПИ́ТЬСЯ,
ПОТУПЛЯ́ТЬСЯ тонгойх, духайх, доошоо харах, уруугаа ширтэх; **~ от смущения** ичингүйрч доошоо харах.
ПОТУСКНЕ́||ТЬ 1. бүдэг болох, бүдгэрэх, зэвхийрэх, өнгө буурах, өнгөө алдах; **медные подсвечники ~ли** лааны зэс тавиур өнгөө алджээ; 2. бүүдийх, сулрах; **взор его ~л** харц нь бүүдийжээ.
ПОТУХА́ТЬ унтрах, бөхөх, сөнөх.
ПОТУ́Х||НУТЬ унтрах, бөхөх, сөнөх; **сигарета ~ла** тамхи унтрав.

ПОТУ́ХШ||ИЙ 1. унтарсан, сөнөсөн, бөхсөн; ~ **костёр** унтарсан түүдэг гал; ~ **вулкан** сөнөсөн галт уул; 2. бүүдийсэн, цог жавхаагүй; **~ие глаза** цог жавхаагүй нүд.

ПОТУШИ́ТЬ I унтраах; ~ **свет** гэрэл унтраах; ~ **пожар** түймэр унтраах.

ПОТУШИ́ТЬ II битүү жигнэх, битүү шарах, шүүсэнд нь чанах, шуузлах; ~ **мясо** мах битүү шарах.

ПО́ТЧЕВАТЬ хүндлэх, зоог өргөх, зооглуулах; ~ **гостей** зочдыг хүндлэх.

ПОТЯГА́ТЬСЯ үзэлцэх, чадлаа үзэлцэх, сорилцох, туршилцах; ~ **в знаниях** мэдлэгээ сорилцох.

ПОТЯ́ГИВА||ТЬ 1. чангаах, чангааж байх, татах, татаж байх; **~й верёвку, но не дёргай** дээсийг угзралгүй татаж бай; 2. шимж байх, сорж байх; ~ **дым из трубки** гансаа сорж байх.

ПОТЯ́ГИВАТЬСЯ суниах; ~ **в постели** орондоо суниах.

ПОТЯНУ́||ТЬ 1. татах, чангаах; ~ **за рукав** ханцуйнаас татах; 2. хүнд байх, болох; 3. сэвэлзэх, үлээх; **~л предрассветный ветерок** үүрийн сэвшээ салхи сэвэлзэв; * **~ло домой** харихсан гэдэг болов.

ПОТЯНУ́||ТЬСЯ 1. суниах; 2. цувалдах; **~лись обозы один за другим** ачаатай тэрэгнүүд хойно хойноосоо цувалдав; 3. сарвайх, гараа сунгах; **~лся через стол** ширээн дээгүүр гараа сунгах; 4. дагалдах; 5. үргэлжлэх, дараалан өнгөрөх; **~лись долгие зимние ночи** өвлийн урт шөнө дараалан өнгөрсөөр л байв.

ПОУ́ЖИНАТЬ үдшийн хоол идэх.

ПОУМНЕ́ТЬ ухаантай болох, ухаан орох, хашир суух.

ПОУТРУ́ өглөөгүүр, өглөө эртхэн; **выехать из дому ~** өглөөгүүр гэрээс мордох.

ПОУЧА́ТЬ сургах, сургамжлах, заах; ~ **молодёжь** залуучуудыг сургах; ~ **уму-разуму** ухаан заах.

ПОУЧЕ́НИ||Е сургаал, сургамж; **надоели мне твои ~я** чиний сургамж над улиг боллоо.

ПОУЧИ́ТЕЛЬНЫЙ сургаалтай, сургамжтай, сургаал болохоор, сургамж болгомоор; ~ **совет** сургаал болохоор зөвлөлгөө; ~ **случай** сургамжтай учрал; ~ **пример** сургамж болохоор жишээ.

ПОУЧИ́ТЬ 1. үзэх, цээжлэх; ~ **уроки** хичээлээ цээжлэх; 2. сургах, заах.

ПОУЧИ́ТЬСЯ 1. сурах, суралцах; ~ **переплетать книги** ном хавтаслаж сурах; 2. үзэх, цээжлэх; **немного поучусь, а потом погуляю** номоо жаахан үзээд дараа нь гарч зугаацъя.

ПОХА́БН||ЫЙ шившигтэй, булай, балиар; **~ые слова** балиар үг.

ПОХВАЛ||А́ магтаал, магтах; **отозваться о ком-либо с ~ой** хүнийг магтаж хэлэх; **рассыпаться в ~ах** магтаж саймсрах; **расточать ~ы** их магтах; **заслужить ~у** магтахаар юм хийх.

ПОХВАЛИ́ТЬ магтах, сайшаах.

ПОХВАЛИ́ТЬСЯ биеэ магтах, сайрхах, саймсрах; * **не могу ~** магтахаар юм байхгүй.

ПОХВАЛЯ́ТЬСЯ биеэ магтах, сайрхах, саймсрах.

ПОХВАЛЬБА́ биеэ магтах, сайрхах.

ПОХВА́ЛЬН||ЫЙ магтсан, магтууштай, магтаалтай, сайшаасан, сайшаалтай; **~ое усердие** магтууштай чармайлт; **~ая грамота** сайшаалын жуух.

ПОХВА́СТАТЬ сайрхах.

ПОХВА́СТАТЬСЯ сайрхах, гайхуулах; * **не могу ~** сайрхах юм байхгүй.

ПОХИТИ́ТЕЛЬ хулгайлагч, хулгайч, нууж авагч.

ПОХИ́ТИТЬ хулгайлах, нууж авах.

ПОХИЩЕ́НИЕ хулгай, хулгайлах, нууж авах, булааж авах.

ПОХЛЁБКА бантан, зутан, сөмс; **чечевичная ~** сэвэг зармын бантан.

ПОХЛО́ПАТЬ 1. алгадах, зөөлөн алгадах, пад пад хийтэл алгадах; ~ **друга по плечу** найзынхаа мөрөн дээр алгадах; 2. алга таших.

ПОХЛОПОТА́ТЬ оролдох, оролдож үзэх, оролдлого хийх.

ПОХМЕ́ЛЬЕ мангар, архины мангар, шартах; * **в чужом пиру ~** архий нь хүртэлгүй, мангары нь хүртэх, хүний төлөө юманд өртөгдөх.

ПОХО́Д I аян, дайн, довтолгоо; **выступать в ~** аян дайнд мордох; **культурный ~** соёлын довтолгоо.

ПОХО́Д II илүү, гаруй, нэмэр; **мясо три кило с ~ом** гурван кило илүү мах; **взвесить с ~ом** нэмэртэй чигнэх.

ПОХОДА́ТАЙСТВОВАТЬ зуучлах, төлөөлөн гуйх, оролдлого хийх, ачлах.

ПОХОДИ́||ТЬ I 1. явах, явж байх; ~ **по базару** зах дээгүүр явах; **больной ~л и опять слёг** өвчтөн босдог болсноо дахин хэвтэрт орсон.

ПОХОДИ́||ТЬ II адил, адилхан, төстэй; **сын очень ~т на отца** хүү нь эцэгтэйгээ их адилхан юм.

ПОХО́ДКА алхаа, явах байдал, явдал; **лёгкая ~** хөнгөн алхаа.

ПОХО́ДН||ЫЙ аяны, замын; **~ая колонна** аяны цуваа; **в ~ом порядке** аяны журмаар; **~ая кухня** аяны зуух тогоо.

ПО́ХОДЯ явуут; **закусывать ~** явуут идэх; 2. далимд, дашрамаар, яаруу; **нельзя решать эти вопросы ~** энэ асуудлыг *(яаруу)* шийдвэрлэж болохгүй.

ПОХОЖДЕ́НИЕ явдал, замын явдал, адал явдал; ~ **странствующего актёра** хэсүүлч жүжигчний явдал; **любовное ~** янаг амрагийн явдал.

ПОХО́Ж||ИЙ 1. адил, адилхан, төстэй, төсөөтэй; 2. ингэмээр, тэгмээр, ингэхлээр, тэгэхээр; **это на тебя не ~е** чи арай тэгмээргүй юм; **это на него не ~е** энэ тэгэхээр хүн биш; 3. шиг, юм шиг, бололтой; **вы, ~е, не здоровы** та эрүүл биш шиг байна; 4. яаж; **на что это похоже** энэ чинь яаж байна; **это ни на что не ~е** ингэж яаж болох вэз.

ПОХОЛОДА́НИЕ хүйтрэх, хүйт; **наступило ~** хүйтэрч эхлэв.

ПОХОЛОДА́||ТЬ хүйтрэх; **к вечеру ~ло** үдшээр хүйтрэв.

ПОХОЛОДЕ́||ТЬ 1. хүйтрэх, даарах; **у него ~ли руки и ноги** гар хөл нь даарчээ; 2. хүйт оргих шиг болох, хүйт даах, дагжих; ~ **от ужаса** айсандаа бие хүйт оргих шиг болох.

ПОХОРОНИ́ТЬ 1. хөдөөлүүлэх, оршуулах; 2. мартах, мартаж орхих, санахаа болих.

ПОХОРО́НН||ЫЙ 1. хөдөөлүүлэх, оршуулах, оршуулгын; **~ое бюро** иргэдэд үйлчлэх товчоо; 2. гашуудлын; **~ая процессия** гашуудлын жагсаал.

ПО́ХОРОНЫ хөдөөлүүлэх, оршуулах, оршуулах ёслол.

ПОХОРОШЕ́||ТЬ сайхан болох, цэвэрхэн болох; **эта девушка ~ла** энэ бүсгүй гоо үзэсгэлэнтэй болжээ.

ПОХОТЛИ́В||ЫЙ тачаангуй, хуялч, хурьцах; ~ **взгляд** тачаангуй харц; **~ое желание** хурьцах шунал.

ПО́ХОТЬ хурьцал, хуял, дочиг, тачаал, тачаангуй.

ПОХУДЕ́||ТЬ эцэх, эцэнхий болох, турах, туранхай болох; **он ~л, побледнел и осунулся** тэр турж царай алдаж ёнхойсон юм болжээ.

ПОЦАРА́ПАТЬ шалбалах, шулгалах, урах, сэвтүүлэх, зурччих; ~ **себе руку о проволоку** гараа төмөр утсанд шалбалах.

ПОЦЕЛОВА́||ТЬ үнсэх, озох; **он ~л меня** тэр намайг үнсэв; ***~л пробой и пошёл домой** хаалгыг чинь мөргөөд гэртээ харьсан.

ПОЦЕЛОВА́ТЬСЯ үнсэлдэх, озолдох.

ПОЦЕЛУ́Й үнсэх, үнсэлт, үнсүүлэх, озох; **жаркий ~** халуун үнсэлт; **дать ~** үнсүүлэх, ***воздушный ~** дохиогоор үнсэх; ~ **Иуды** хуурамч үнсэлт.

ПОЧАСОВ||О́Й, цаг бүрийн, цагаар бодох; **~ая оплата труда** цагаар төлөх хөдөлмөр.

ПОЧА́ТОК түрүү, залаа; **~ кукурузы** эрдэнэ шишийн залаа.

ПО́ЧВ||А 1. хөрс, шороо; **черноземная ~** хар шороот хөрс; **плодородная ~** шимтэй хөрс; 2. суурь, түшиг, тулгуур; **терять ~у под ногами** түшиг тулгуургүй болох (хөл алдах); **подготовить ~у для переговоров** хэлэлцээний суурийг бэлтгэх; **нащупать ~у** байрыг мэдэх, байдлыг тухайлах; **преступление на ~е ревности** хардсан шалтгаанаас үйлдсэн гэмт хэрэг; **осложнение на ~е гриппа** томуу үгдрэх.

ПО́ЧВЕННЫЙ хөрсний, газрын хөрсний; **~ые воды** хөрсний ус.

ПОЧВОВЕ́Д хөрс судлаач.

ПОЧВОВЕ́ДЕНИЕ хөрс судлал.

ПОЧВОВЕ́ДЧЕСКИЙ хөрс судлалын.

ПОЧЕМ яаж, яаж өгөх, ямар үнэтэй; **~ я знаю** би яаж мэдэх вэ.

ПОЧЕМУ́ 1. юунд, яагаад; 2. учраас, ийм учраас, ийм дээрээс.

ПОЧЕМУ́-ЛИ́БО ямар нэг шалтгаанаас, ямар нэг учраас.

ПОЧЕМУ́-НИБУ́ДЬ ямар нэг шалтгаанаас, ямар нэг учраас.

ПОЧЕМУ́-ТО *ямар нэг үл мэдэгдэх шалтгаанаас, яагаад ч юм.*

ПО́ЧЕРК үсгийн хэлбэр, бичгийн хэв, гар бичиг, бичиг; **разборчивый ~** үсгийн хэлбэр тодорхой, гаргадах сайтай бичиг; **не разборчивый ~** үсгийн хэлбэр тодорхой биш, гаргагдах муутай бичиг; **разбирать древние ~и** эрт цагийн гар бичгийг унших.

ПОЧЕРНЕ́ТЬ харлах, хар болох.

ПОЧЕРПА́ТЬ утгах.

ПОЧЕРПНУ́ТЬ 1. утгах; **~ воды** ус утгах; 2. шүүрдэж олох, олж авах; **~ нужные сведения из книги** номноос хэрэгтэй мэдээг олж авах.

ПОЧЕРСТВЕ́ТЬ 1. хатах, хатачхах; 2. хатуу болох, хатуурах.

ПОЧЕСА́ТЬ 1. маажих; **~ затылок** шилээ маажих; 2. самнах, цэвэрлэх; **~ лён** маалинга самнах.

ПОЧЕСА́ТЬСЯ 1. маажих, биеэ маажих; 2. загатнах.

ПО́ЧЕСТ||Ь хүндлэл, хүндлэх, ёсолж хүндлэх, хүндэтгэх; **оказать кому-либо ~и** хүнийг ёсолж хүндлэх.

ПОЧЁСЫВАТЬ маажих, маажиж байх; **~ за ухом** чихнийхээ ард маажих.

ПОЧЁСЫВАТЬСЯ биеэ маажих.

ПОЧЁТ хүнд, ямба, өргөмж, хүндлэх, хүндэтгэл; **быть в ~е** хүндтэй байх.

ПОЧЁТН||ЫЙ хүндэт; **~ое звание** хүндэт цол; **~ президиум** хүндэт тэргүүлэгчид; **~ая грамота** хүндэт жуух бичиг; **~ая обязанность** хүндэт үүрэг.

ПО́ЧЕЧНЫЙ 1. бөөрний; **~ камень** бөөрний чулуу; 2. нахианы.

ПОЧИВА́ТЬ нойрсох, унтах.

ПОЧИ́Н санаачилга, үүсгэл, эхлэл.

ПОЧИНИ́ТЬ сэлбэх, засах; **~ часы** цаг засах.

ПОЧИНЯ́ТЬ сэлбэх, засах.

ПОЧИ́НКА засах, засуулах, засалт, сэлбэх, сэлбүүлэх; **~ белья** дотуур хувцас сэлбэх.

ПОЧИ́НОЧН||ЫЙ засах, засалтын, сэлбэх, сэлбэлтийн; **~ая мастерская** хувцас сэлбэх газар.

ПОЧИ́СТИТЬ цэвэрлэх, арилгах, арчих; **~ туфли** гутал цэвэрлэх.

ПОЧИ́СТИТЬСЯ 1. биеэ цэвэрлэх, хувцсаа цэвэрлэх; 2. цэвэрлэгдэх.

ПОЧИТА́НИЕ хүндлэх, хүндлэл, хүндэтгэл, бишрэх, бишрэл; **~ законов** хуулийг хүндэтгэх.

ПОЧИТА́ТЕЛЬ хүндэтгэгч, хүндлэгч, бишрэгч, тоогч, тоодог хүн; **~ Пушкина** Пушкиныг бишрэгч.

ПОЧИТА́ТЕЛЬНИЦА хүндэтгэгч эмэгтэй, хүндлэгч эмэгтэй, бишрэгч эмэгтэй.

ПОЧИТА́ТЬ I ном унших, уншиж байх; **~ в дороге** замдаа ном унших. **ПОЧИТА́ТЬ II** хүндлэх, хүндэтгэх, бишрэх, тоох; **~ память великих людей** их хүмүүсийн дурсгалыг хүндэтгэх.

ПОЧИТА́ТЬ III гэж үзэх; **~ своим долгом** өөрийн үүрэг гэж үзэх.

ПОЧИ́ТЫВАТЬ *(разг.).* хааяа, жаахан унших, уншисхийж байх, уншигчаан болох.

ПОЧИ́ТЬ 1. амарлих; 2. нойрсох; 3. таалал төгсөх, нас барах; **~ на лаврах** амжилтандаа ханаж амарлих.

ПОЧИ́ЩЕ 1. цэвэрхэн, цэврээс нь; **выбери лист бумаги ~** цэврээс нь хуудас цаас шилээд ав; 2. -аас цэвэрхэн, илүү цэвэр, дээр; **он ~ тебя рисует** тэр чамаас цэвэрхэн зурдаг.

ПО́ЧКА I бөөр; **воспаление почек** бөөр үрэвсэх; **правая ~** баруун бөөр.

ПО́ЧК||А II нахиа, гөлөг; **~и на деревьях** модны нахиа.

ПОЧКОВА́НИЕ нахиалах, нахиалж үржих.

ПОЧКОВА́ТЬСЯ нахиалах, нахиалж үржих.

ПО́ЧТ||А 1. шуудан, шуудангийн хороо, холбоо, холбооны хороо; **сдать письмо на ~у** шууданд захидал өгөх; **работники ~ы** холбооны ажилтан; 2. шуудан; **послать письмо ~ой** шуудангаар захидал илгээх; 3. шуудан, бичиг захидал; **утренняя ~** өглөөний шуудан; **разносить ~у** бичиг захидал тараах.

ПОЧТАЛЬО́Н захидал түгээгч, шуудан хүргэгч.

ПОЧТА́МТ шуудан бичгийн хороо, төв шуудан.

ПОЧТЕ́НИЕ хүндлэх, хүндлэл, хүндэтгэх, бишрэх; **относиться к кому-либо с ~м** *хүнийг хүндэтгэж үзэх;* **оказывать ~** хүндлэх, хүндлэл үйлдэх; **с совершенным ~м** гүн хүндэтгэн ёслогч (захидлын төгсгөлд), **моё ~** амрыг эрье.

ПОЧТЕ́ННЫЙ 1. хүндтэй, хүндэт, **~ учёный** хүндэт эрдэмтэн; 2. өндөр; **~ возраст** өндөр нас.

ПОЧТИ́ бараг, чацуу, шахах; **он ~ выздоровел** тэр бараг эдгэрчээ; **~ одинаковые платья** бараг адилхан хувцас; **я ~ закончил работу** *би ажлаа бараг дуусгав, би ажлаа дуусгах шахав.*

ПОЧТИ́ТЕЛЬНОСТЬ хүндэтгэл, хүндлэл, тахимдуу, элбэрэл.

ПОЧТИ́ТЕЛЬН||ЫЙ 1. хүндэтгэх, тахимдуу, элбэрэлтэй; **~ое отношение к кому-либо** хүнийг хүндэтгэж үзэх; **~ сын** тахимдуу (элбэрэлтэй) хүү; 2. нилээд хол, холоос хол; **~ое расстояние** нилээд хол газар.

ПОЧТИ́||ТЬ ёслох, хүндэтгэх, хүндлэх, бишрэх, тоох; **~ память умершего вставанием** нас барагчийн дурсгалд босож ёслох; **~те нас своим присутствием** биднийг тоож бидэнтэй байлцах ажаамуу.

ПОЧТМЕ́ЙСТЕР шуудангийн хорооны эрхлэгч.

ПОЧТОВИ́К шуудангийн ажилтан.

ПОЧТО́ВО-ТЕЛЕГРА́ФНЫЙ шуудан цахилгаан мэдээний.

ПОЧТО́В||ЫЙ шуудангийн; **~ ящик** шуудангийн хайрцаг; **~ая бумага** шуудангийн цаас (захидлын цаас); **~ая марка** шуудангийн марк; **~ перевод** шуудангаар (мөнгө) гуйвуулах.

ПОЧУ́ВСТВОВАТЬ мэдрэх, байх, шиг болох, хүрэх, ойлгох; **~ себя плохо** бие муу байх; **~ себя больным** өвчин хүрэх шиг болох; **~ озноб** бие даарах, (дагжих) шиг болох; **~ злобу** зэвүү хүрэх; **дать ~** мэдрүүлэх.

ПОЧУ́ДИ||ТЬСЯ үзэгдэх шиг болох, сонсдох шиг болох; **мне ~лись огоньки** гал үзэгдэх шиг боллоо; **мне ~лись шаги** надад хүний хөлийн чимээ сонсдох шиг боллоо.

ПОЧУ́Я||ТЬ 1. анир авах, чимээ авах, үнэр авах; **собака ~ла зверя и насторожилась** нохой араатны анир аваад отож байна; 2. гэж мэдэх; **~ опасность** аюултай гэж мэдэх.

ПОША́РИТЬ тэмтрэх, тэмтэрч үзэх; **~ в карманах** халаасандаа тэмтрэх.

ПОШАТНУ́ТЬ 1. хазайлгах, ганхуулах; ~ **забор** хашааг хазайлгах; сулруулах, эргэлзээ төрүүлэх; ~ **своё здоровье** биеийн эрүүл мэндийг сулруулах (биеэ муудуулах); ~ **чьи-нибудь убеждения** хүний иттэсэн үзэлд эргэлзээ төрүүлэх.

ПОШАТНУ́||ТЬСЯ 1 хазайх, ганхах, найгах; **дерево ~лось** мод хазайв; **раненый ~лся и упал** шархадсан хүн найгаад ойчив; 2. сулрах, муудах, эргэлзээ төрөх; **здоровье ~лось** бие муудав.

ПОША́ТЫВАТЬ ганхалзуулах, найгалзуулах, займчуулах.

ПОША́ТЫВА||ТЬСЯ ганхалзах, найгалзах, дайвалзах, холхих, хөдлөх; **идти ~ясь** ганхалзаж явах; **зуб ~ется** шүд хөдөлж байна.

ПОШВЫРЯ́ТЬ шидэх, шидлэх, хаях, хаялах; ~ **все книги в ящик** бүх номыг хайрцагт хаялав.

ПОШЕВЕ́ЛИВАТЬ хөдөлгөх, хутгах, шилээх.

ПОШЕВЕЛИ́ТЬ 1. хөдөлгөх, хутгах, шилээх; ~ **угли в печке** зуухны гал (цог) шилээх; ~ **вожжами** жолоогоо хөдөлгөх; 2. түргэл, бушуул.

ПОШЕВЕ́ЛИВА||ТЬСЯ хөдлөх, хөдөлгөх; 2. бушуул, түргэл; **ну, ~йся** за бушуул.

ПОШЕВЕЛИ́ТЬ хөдөлгөх, хөдөлгөөн хийх; ~ **ногой** хөлөө хөдөлгөх.

ПОШЕВЕЛЬНУ́ТЬ хөдөлгөх, хөдөлгөөн хийх.

ПОШЕВЕЛИ́ТЬСЯ хөдөлгөх, хөдөлгөсхийх.

ПОШЕВЕЛЬНУТЬСЯ так тесно, что ~ невозможно их давчуухан болоод хөдлөх ч аргагүй.

ПОШЕПТА́ТЬ шивнэж хэлэх, шивнэж ярих.

ПОШЕПТА́ТЬСЯ шивнэлдэх, шивнэлдэж ярих.

ПОШИ́В оёдол, оёх; **индивидуальный ~ одежды** хувцас тусгайлан оёх, хувцас тааруулж оёх.

ПОШИ́ВКА оёх, оёдол; ~ **брюк** өмд оёх.

ПОШИ́ВОЧНАЯ оёдлын газар, үйлчилгээний газар.

ПОШИ́ВОЧН||ЫЙ оёдлын, сайпангийн; **~ая мастерская** оёдлын газар.

ПОШИ́ТЬ оёх, хийх, хийлгэх; ~ **пальто** пальто оёх, пальто хийлгэх; ~ **обувь** гутал хийх, гутал хийлгэх.

ПО́ШЛИН||А гааль, гааль сүй, татвар, цүүвэн; **обложить ~ой** гааль оногдуулах; **таможенная ~** гаалийн татвар.

ПО́ШЛИННЫЙ гаалийн; ~ **сбор** гаалийн татвар.

ПО́ШЛОСТ||Ь заваан юм, олиггүй юм, балиар үг; **не говори ~ей** заваан юм битгий ярь.

ПО́ШЛЫЙ заваан, олиггүй, улиг; ~ **анекдот** олиггүй шог яриа.

ПОШЛЯ́К заваан явдалтай хүн, билэнч.

ПОШТУ́ЧНО нэжгээдээр, ширхэгээр, ширхэг бүрээр, ширхгээр бодож; **платить ~** ширхгээр бодож төлөх; **продавать папиросы ~** тамхи ширхгээр худалдах.

ПОШТУ́ЧН||ЫЙ нэжгээдээр, ширхэгээр бодох; **~ая оплата** нэжгээдээр төлөх төлбөр.

ПОШУТИ́||ТЬ хошигнох, тоглох, тоглож хэлэх, шоглох, наадах; **насмеялся, ~л над моей простотой** миний хөдөөх байдлыг инээж хошигнов.

ПОЩА́Д||А өршөөл, уучлал, хайр, хайр найр; **просить ~ы** өршөөл гуйх; **без ~ы** хайр найргүй.

ПОЩАДИ́||ТЬ хайрлах, өршөөх, уучлах; **для науки и жизни не пощажу** би шинжлэх ухааны төлөө амь насаа ч хайрлахгүй; **время не ~ло этого здания** цагийн урсгал энэ байшинг уучилсангүй.

ПОЩЕКОТА́ТЬ гижигдэх.

ПОЩЁЧИН||А 1. алгадах; **влепить ~у** хацрыг алгадах, тас алгадах; 2. цохилт, доромжлол.

ПОЩИПА́ТЬ 1. зулгаах, зулгааж идэх, зулгааж хаях, чимхлэх; ~ **траву** ногоо зулгаах; 2. зэмлэх, шүүмжлэх; 3. хорсгох.

ПОЩИ́ПЫВАТЬ зулгаах, зулгааж идэх, зулгааж хаях, чимхлэх.

ПОЩУ́ПАТЬ барих, барьж үзэх, тэмтрэх; ~ **пульс** судас барих; ~ **материю** юмыг барьж үзэх; 2. сорих, сорьж үзэх; ~ **знания нового ученика** шинэ сурагчийг сорьж үзэх.

ПОЭ́ЗИЯ яруу найраг; ~ **и проза** яруу найраг ба үргэлжилсэн зохиол.

ПОЭ́МА найраглал, шүлэглэл, шүлэг, шүлэгт үлгэр.

ПОЭ́Т яруу найрагч, шүлэгч.

ПОЭТЕ́ССА яруу найрагч эмэгтэй, эмэгтэй шүлэгч.

ПОЭТИЗИ́РОВАТЬ үвтэгш болгох, үвтэгш сайхнаар үзүүлэх, яруу найруулах; ~ **действительность** чухам байдлыг үвтэгш сайхнаар үзүүлэх.

ПОЭ́ТИКА шүлгийн ухаан, яруу найргийн ухаан, яруу найраг.

ПОЭТИ́ЧЕСК||ИЙ 1. яруу найргийн, найргийн, шүлэглэсэн; **~ое произведение** яруу найргийн зохиол; 2. уран бүтээлийн; ~ **замысел** уран бүтээлийн утга санаа; **~ая жилка** уран бүтээлийн авъяас.

ПОЭТИ́ЧНЫЙ яруу сайхан, дурлам сайхан, дурайсан сайхан; ~ **пейзаж** яруу сайхан үзэмж.

ПОЭ́ТОМУ тийм тул, учраас, тул; **я спешил, ~ не зашёл за тобой** би яарч байсан учраас танайхаар орж чамтай уулзаж чадсангүй.

ПОЯВИ́||ТЬСЯ үзэгдэх, харагдах; **на горизонте ~лся корабль** тэнгэрийн хаяанд хөлөг онгоц харагдав; 2. гарах, гарч ирэх, бий болох, суух; **~лась луна** сар гарав; **~лось новое затруднение** шинэ бэрхшээл гарч ирэв; **на лбу ~лись морщины** духан дээр үрчлээ суув; **внезапно ~** гэнэт бий болох.

ПОЯВЛЯ́ТЬСЯ үзэгдэх, харагдах.

ПОЯВЛЕ́НИЕ үзэгдэх, харагдах, бий болох, гарч ирэх.

ПОЯ́РКОВ||ЫЙ хурганы ноосон, хурган, нарийн эсгий; **~ая шляпа** хурганы ноосон малгай (товь, тоорцог).

ПОЯ́РОК хурганы ноос, сэгсүүрэг ноос.

ПО́ЯС 1. бүс; **затянуть ~** бүсээ бүслэх; **кожаный ~** суран бүс; **спасательный ~** хөвөх бүс, аврах бүс; 2. бэлхүүс; **по ~ в воде** бэлхүүсээ хүртэл усанд байх; 3. бүс, бүслүүр; **умеренный ~** (дэлхийн) сэрүүн бүс; **~ осадков** агаарын тундасын бүс.

ПОЯСНЕ́НИЕ тайлбар, тайлбарлах; **давать ~** тайлбар өгөх.

ПОЯСНИ́ТЕЛЬН||ЫЙ тайлбар, тайлбарласан, тайлбарлах, тодруулсан; **~ая иллюстрация к тексту** эх бичгийн тайлбар зураг; **~ое замечание** тайлбарласан тэмдэглэл; **~ая записка** тайлбарлах бичиг; **~ое слово** тодруулсан үг.

ПОЯСНИ́ТЬ,

ПОЯСНЯ́ТЬ тайлбар-лах, тодруулах, тодорхой болгох; ~ **свои слова** үгээ тайлбарлах; **поясните, пожалуйста примером** жишээгээр тодруулж өгөөч.

ПОЯСНИ́Ц||А зоо, зоо нуруу, бэлхүүс; **боль в ~е** зоо нуруу өвдөх.

ПОЯСН||О́Й 1. бүсний; **~ые застёжки** бүсний чагт; 2. цээж, бэлхүүсэн; ~ **портрет** цээж хөрөг; 3. мэхийн; ~ **поклон** мэхийн ёслох; 4. бүсийн; **~ое время** бүсийн цаг.

ПОЯСНЯ́ТЬСЯ тайлбарлагдах, тодрох, тодорхой болох.

ПОЯСО́К нарийхан бүс.

ПРАБА́БКА,

ПРАБА́БУШКА элэнц эх, нагац элэнц эх.

ПРА́ВД||А 1. үнэн; **это сущая ~** энэ чухам үнэн; **по ~е говоря** үнэнийг хэлбэл, үнэндээ; **сказать кому-либо всю ~у** хэн нэгэнд бүхий үнэнийг хэлэх; **принимать за ~у** үнэмших; 2. үнэн, зөв; ~ **на вашей стороне** үнэн таны талд байна, таных зөв байна; 3. үнэхээр, үнэхээр, үнээр; **~, что мне письмо?** нээрээ надад захидал байна уу?; **я, ~, не знал этого**

би нээрээ үүнийг мэдээгүй; ~, **он уезжает** нээрээ тэр явах гэж байна.

ПРАВДИ́ВОСТЬ 1. үнэнч, шударга, голч; 2. лавтай, магад.

ПРАВДИ́ВЫЙ 1. үнэнч, шударга; ~ **человек** үнэнч хүн; ~ **характер** шударга зан; 2. үнэн, зөв; ~ **рассказ** үнэн өгүүллэг.

ПРАВДОПОДО́БИЕ үнэмшмээр байдал, үнэн байдалтай, үнэн шиг зүйл.

ПРАВДОПОДО́БНЫЙ үнэн шиг, үнэмшмээр, үнэн байдалтай; ~ **рассказ** үнэмшмээр яриа, үнэн байдалтай өгүүллэг.

ПРА́ВИЛ||О дүрэм; ~**а уличного движения** гудамжны хөдөлгөөний дүрэм; ~**а внутреннего распорядка** дотоод дүрэм; **грамматические** ~**а** хэл зүйн дүрэм; **соблюдать** ~**а языка** хэлний дүрмийг баримтлах; **по всем** ~**ам искусства** урлагийн бүх дүрэм журмын ёсоор; 2. журам; ~**а социалистического общежития** хамтран амьдрах социалист журам; 3. зарчим, ёс; **он человек строгих правил** тэр хатуу зарчимтай хүн; **взять себе за** ~ өөртөө зарчим болгох; **как общее** ~ ер нь, дандаа.

ПРАВИ́ЛО 1. шугам; 2. тэгшлүүр; 3. сэлүүр.

ПРА́ВИЛЬНО *зөв, зөвөөр;* ~ **поступать** *зөв хийх;* **совершенно** ~ туйлын зөв, тун зөв; ~ **решить** задачу бодлогыг зөв бодох.

ПРА́ВИЛЬН||ЫЙ 1. зөв; ~**ая политика** зөв бодлого; ~ **вывод** зөв дүгнэлт; 2. зөв, дүрэмт; ~**ое произношение** зөв дуудлага; ~ **глагол** дүрэмт үйл үг; 3. тэгш, тэгшхэн; ~ **нос** тэгшхэн хамар; ~ **треугольник** тэгш өнцөгт гурвалжин.

ПРАВИ́ЛЬНЫЙ засах, ирлэх; ~ **ремень** нийлүүр.

ПРАВИ́ТЕЛЬ 1. төр баригч, төрийн эзэн, засгийн эрх баригч; 2. захирагч, захи́ран шийтгэгч.

ПРАВИ́ТЕЛЬСТВЕННЫЙ засгийн газрын, засгийн; ~**ое распоряжение** засгийн газрын захирамж; ~**ые органы** засгийн газрын байгууллагууд; ~**ая делегация** засгийн газрын төлөөлөгчид.

ПРАВИ́ТЕЛЬСТВ||О засгийн газар, засаг; **глава** ~**а** засгийн газрын тэргүүн.

ПРА́ВИТЬ I 1. захирах, удирдах, барих; ~ **государством** улсыг (гүрнийг) захирах, төр барих; 2. жолоодох, жолоо барих; ~ **лошадью** морь жолоодох; ~ **машиной** машин жолоодох.

ПРА́ВИТЬ II 1. засах, хянах; ~ **корректуру** үсэг хянах; 2. ирлэх, хурцлах, билүүдэх, засах; ~ **пилу** хөрөө ирлэх; ~ **бритву** тонгорог билүүдэх.

ПРА́ВКА 1. засах, засалт, хянах, хяналт; 2. ирлэх, хуршлах, билүүдэх.

ПРАВЛЕ́НИ||Е 1. ерөнхий хороо; **председатель** ~**я** ерөнхий хорооны дарга; **член** ~**я банка** банкны ерөнхий хорооны гишүүн; 2. захирах, захиргаа, жолоо; **форма** ~**я** захиргааны хэлбэр; **бразды** ~**я** төрийн жолоо.

ПРА́ВНУК жич хүү.

ПРА́ВНУЧКА жич охин.

ПРА́В||О I хууль, ёс, хууль ёс, цааз, шүүх цааз; **гражданское** ~ иргэний хууль; **уголовное** ~ эрүүгийн хууль; **крепостное** ~ хамжлагат ёс; 2. эрх; ~**а и обязанности граждан** иргэний эрх үүрэг; ~ **на труд** хөдөлмөрлөх эрх; **избирательное** ~ сонгуулийн эрх; **водительские** ~**а** (машин) жолоодох эрх.

ПРА́ВО II нээрээ чухамдаа * **я,** ~, **не знаю, что мне делать** би нээрээ, яахаа мэдэхгүй байна.

ПРАВОБЕРЕ́ЖН||ЫЙ баруун эргийн, баруун хөвөөний, баруун бүсийн; ~**ая Украина** баруун эргийн Украин.

ПРАВОВО́Й хуулийн, хууль ёсны, шүүх цаазны.

ПРАВОМЕ́РНЫЙ хууль ёсны, зөв зүйтэй; ~ **поступок** зөв зүйтэй явдал.

ПРАВОМО́ЧИЕ эрх, эрх төгөлдөр, эрх мэдэл.

ПРАВОМО́ЧНЫЙ эрхтэн, хуулийн эрхтэй, төгөлдөр эрхтэй, эрх мэдэлтэй; ~ **депутат** хуулийн эрхтэн, депутат.

ПРАВОНАРУШЕ́НИЕ хууль зөрчих, гэмт хэрэг өдүүлэх.

ПРАВОНАРУШИ́ТЕЛЬ хууль зөрчигч, гэмт хэрэг өдүүлэгч.

ПРАВОПИСА́НИЕ зөв бичих зүй, үсгийн дүрэм.

ПРАВОСЛА́ВИЕ грек оросын христосын шажин, үнэн алдартын шажин.

ПРАВОСЛА́ВНЫЙ үнэн алдартын шажин.

ПРАВОСОЗНА́НИЕ хуулийн ухамсар, хуулийг мэдрэх.

ПРАВОСУДО́БНЫЙ хуулийн эрхтэй, эрхээ эдлэх чадвартай, эрх чадвар бүхий.

ПРАВОСУ́ДИЕ хууль зүй, шүүх; **искать** ~ хууль зүй эрэх.

ПРАВОТ||А́ үнэн, зөв, үнэн зөв; **доказать свою** ~**у** үнэн зөвөө нотлох.

ПРА́В||ЫЙ I 1. баруун; ~**ая рука** баруун гар; ~ **берег реки** голын баруун эрэг; ~**ая сторона** баруун тал.

ПРА́В||ЫЙ II 1. зөв зүйтэй, шударга; 2. гэмгүй, зэмгүй, буруугүй; **суд признал его** ~**ым** шүүх түүнийг гэмгүйд тооцов.

ПРА́ВЯЩ||ИЙ эрх баригч, засгийн эрх баригч; ~**ие круги** эрх баригчид.

ПРАГМАТИ́ЗМ прагматизм, ашиглааны ёс.

ПРА́ДЕД элэнц эцэг, нагац элэнц Эцэг; ~**ы** элэнц хуланц нар.

ПРАДЕ́ДУШКА элэнц аав, нагац элэнц аав.

ПРА́ЗДНЕСТВО баяр, баяр ёслол, найр наадам.

ПРА́ЗДНИК 1. баяр, баяр ёслол, найр наадам; **национальный** ~ *үндэсний баяр;* 2. *сайн өдөр, амралтын өдөр;* **гулять в** ~ амралтын өдөр зугаалах; **будет и на нашей улице** ~ манай талд баяр ирнэ.

ПРА́ЗДНИЧНЫЙ баярын, сайн өдрийн, гоёлын; ~ **день** баярын өдөр.

ПРА́ЗДНО юу ч хийхгүй, дэмий, гоёсон; ~ **провести день** юу ч хийхгүй өдөр өнгөрүүлэх.

ПРА́ЗДНОВАНИЕ *баяр ёслол хийх, баяр ёслол, баярыг ёслох.*

ПРА́ЗДНОВАТЬ баяр ёслол хийх, баярыг ёслох, баярыг тэмдэглэх; ~ **день рождения** төрсөн өдрийн баярыг ёслох.

ПРА́ЗДНОСТ||Ь дэмий суух, зүгээр суух, юу ч хийхгүй; **жить в** ~**и** юу ч хийхгүй суух.

ПРАЗДНОШАТА́ЮЩИЙСЯ зайгуул, дэмий хэсүүчлэгч.

ПРА́ЗДН||ЫЙ 1. юу ч хийхгүй. зүгээр; ~**ая жизнь богачей** баячуулын юу ч хийхгүй амьдрал; 2. дэмий, хоосон, зүгээр; ~**ые слова** дэмий үг; ~ **разговор** хоосон яриа; ~**ое любопытство** зүгээр сонирхох.

ПРА́КТИК 1. практикч, дадлагач, туршлагач; **он хороший теоретик и** ~ тэр сайн онолч туршлагатай хүн; 2. дадлагагай хүн, туршлагатай хүн, хашир хүн.

ПРА́КТИК||А 1. бодит хэрэг, ажил хэрэг, практик; **сочетать теорию с** ~**ой** онолыг практиктай хослох; **проводить что-либо на** ~**е** юмыг бодит хэрэг болгож гуйцэтгэх; 2. дадлага, туршлага; ~ **преподавания** багшлах дадлага; **летняя** ~ **студентов** оюутны зуны дадлага; **у него большая** ~ **по ремонту машин** машин засварлах талаар тэр их туршлагатай хүн.

ПРАКТИКА́НТ дагалдан сурагч, дадлагажигч.

ПРАКТИКОВА́ТЬ хэрэглэх, жинхэнэ хэрэглэх; ~ **новый метод работы** ажлын шинэ аргыг хэрэглэх.

ПРАКТИКОВА́ТЬСЯ 1. хэрэглэгдэх, хэрэглэх; **на заводе практикуются новые методы работы** завод дээр ажлын шинэ аргыг хэрэглэж байна; 2. сурах, дадлагажих, чаддаг болох; ~ **в плавании** усанд сэлж сурах.

ПРА́КТИКУМ дадлагын хичээл.

ПРАКТИЦИ́ЗМ 1. ажил хэрэгч явдал, дүй дөршилтэй байх; **здоровый ~** эрүүл ажил хэрэгч байдал; **узкий ~** явцуу ажил хэрэгч явдал; 2. туршлагыг баримтлах.

ПРАКТИ́ЧЕСК||ИЙ 1. практик, бодит, жинхэнэ; **~ая деятельность** практик ажил; **он далек от ~ой жизни** тэр жинхэнэ амьдралаас хол байна; 2. туршлагын, дадлагын; **~ие занятия** дадлагын хичээл; 3. ажиллагааны, дадлагажлын, дадлагын; **~ курс иностранного языка** гадаад хэлний дадлагын курс.

ПРАКТИ́ЧНОСТЬ 1. хашир, догъ, ажил хэрэгч; 2. ашиг тустай, тохиромжтой; **~ нового метода** шинэ аргын тохиромжтой нь.

ПРАКТИ́ЧНЫЙ 1. хашир, догъ, ажил хэрэгч; **~ человек** хашир хүн; 2. ашигтай сайн, тохиромжтой; **~ способ обработки металла** төмөрлөгийг боловсруулах тохиромжтий арга.

ПРАОТЕ́Ц өвөг, эцэг өвөг, уг удам; **отправиться к праотцам** эрлэгт бараалхах.

ПРАПРА́ВНУК жүчинцэр.

ПРАХ, 1. үнсэн товрог, тоосон товрог; **развеять в ~** үнсэн товрог болгох; 2. шарил, чандар; **~ом пойти** балрах, сүйдэх.

ПРА́ЧЕЧНАЯ юм угаах газар, угаалгын газар.

ПРА́ЧКА угаагч эмэгтэй, хувцас угаагч хүүхэн.

ПРАЩА́ дүүгүүр, гүйвүүр.

ПРА́ЩУР уг удам, элэнц хуланц.

ПРЕА́МБУЛА удиртгал, оршил.

ПРЕБЫВА́НИ||Е орших, байх, байгаа; **изменить место своего ~я** байгаа газраа солих.

ПРЕБЫВА́ТЬ байх, байгаа нь, орших; **~ в столице** нийслэл хотод байх; **~ в унынии** гутарч байх; **~ в неведении** юу ч мэдэхгүй байх.

ПРЕВАЛИ́РОВАТЬ зонхилох, давуу байх.

ПРЕВЗО||ЙТИ́ давах, давж гарах, илүү болох, гартаах; **~ прежний уровень развития** урьдын хөгжлийн хэмжээг давж гарах; **доходы ~шли расходы** орлого нь зарлагаас илүү болов.

ПРЕВОЗМОГА́ТЬ,

ПРЕВОЗМО́ЧЬ даах, давах, дийлэх; **~ боль** өвчнийг даах; **~ сон** нойроо дийлэх.

ПРЕВОЗНЕСТИ́,

ПРЕВОЗНОСИ́ТЬ хэт магтах, хэт өргөмжлөх, дөвийлгөн хэлэх, даврууллж ярих; **~ чей-либо талант** хүний билгийг хэт магтах.

ПРЕВОСХОДИ́ТЕЛЬСТВО эрхэм ноён, дээд ноён.

ПРЕВОСХОДИ́ТЬ давах, давж гарах, илүү болох, гартаах.

ПРЕВОСХО́ДН||О,

ПРЕВОСХО́ДН||ЫЙ эрхэм сайн, төгс сайн; **~ое средство** эрхэм сайн юм, төгс сайн хэрэглүүр; **~ая степень** давуу зэрэг.

ПРЕВОСХО́ДСТВО давуу, давуу байх, давамгай; **доказать своё ~** давуугаа нотлох; **численное ~** тоогоор давуу байх.

ПРЕВРАТИ́ТЬ болгох, хувиргах, болгож хувиргах; **~ воду в пар** усыг уур болгох; **~ дело в шутку** юмыг тоглоом болгох, хувиргах; **~ возможность в действительность** бололцоог бодит хэрэг болгож хувиргах.

ПРЕВРАТИ||ТЬСЯ болох, хувирах, болж хувирах; **вода ~лась в лед** ус мөс болж хувирав; **~ в слух** чих тавих, чагнах; * **~ в выжатый лимон** бүүр аарц болгох.

ПРЕВРА́ТНО буруу, шал буруу, ташаа, урвуулж; **~ понимать** буруу ойлгох; **~ истолковывать** урвуулж тайлбарлах.

ПРЕВРА́ТНОСТЬ 1. хувирал, хувирах, хувирамтгай, тогтворгүй; **~ судьбы** заяаны хувирал, хувирах тавилан; 2. буруу, тас буруу, тонгоруу; **~ толкования** тас буруу тайлбарлах.

ПРЕВРА́ТН||ЫЙ 1. хувирах, хувирамтгай, хуурмаг; **~ое счастье** хувирах жаргал; 2. буруу, тас буруу, тонгоруу, урвуулж; **~ое представление о чём-либо** юмыг тонгоруу ойлгох.

ПРЕВРАЩА́ТЬ болгох, хувиргах, болгож хувиргах.

ПРЕВРАЩА́ТЬСЯ болох, хувирах, болж хувирах.

ПРЕВРАЩЕ́НИЕ болох, хувирах, болж хувирах; **~ куколки в бабочку** авгалдай эрвээхэй болж хувирах.

ПРЕВЫСИ́ТЬ давуулах, давуулан биелүүлэх.

ПРЕВЫША́ТЬ 1. давуулах, давуулан биелүүлэх; **~ норму** нормоо давуулан биелүүлэх; 2. хэтрүүлэх, дэндүүлэх; **~ свои полномочия** эрх мэдлээ хэтрүүлэх.

ПРЕВЫ́ШЕ эрхэм, давуу, илүү; **служение народу ~ всего** ард түмэндээ үйлчлэх нь юунаас ч эрхэм.

ПРЕГРА́Д||А хаалт, саад, саад тотгор; **водная ~** усан хаалт; **непреодолимая ~** давшгүй саад; **преодолеть все ~ы** бүх саад тотгорыг давах.

ПРЕГРАДИ́ТЬ,

ПРЕГРАЖДА́ТЬ хаах боох, саад хийх; **~ путь** зам хаах

ПРЕД (ПРЕ́ДО), урьд, урьдахь; **~ мной** миний өмнө; **~ ним** түүний өмнө; **я помню море ~ грозою** би цахилгаант бороонь урьдахь далайг дурсан санана; **~ лицом** тулгараад байхад.

ПРЕДАВА́ТЬ орхих; **~ забвению** мартаж орхих; **~ земле** булж орхих; **~ огню** шатааж орхих; 2. өгөх, шилжүүлэх; **~ суду** шүүхэд өгөх; 3. урвах, барьж өгөх, дайсанд тушаах; **~ друга** нөхрөө барьж өгөх.

ПРЕДАВА́ТЬСЯ 1. эрхэнд орох, эрхэнд автах; **~ врагу** дайсны эрхэнд орох; 2. болох, мүн болох, автах, дарагдах, ташуурах; **~ мечтам** мөрөөдөл болох; **~ тоске** уйтгарт дарагдах; **~ своим страстям** шуналдаа ташуурах.

ПРИДА́НИЕ домог, хууч үг; **старое ~** хуучин домог; **живое ~** одоо ярьдаг хууч үг.

ПРЕДА́НИЕ 1. орхих; **~ полному забвению** бүрмөсөн мартаж орхих; 2. өгөх, шилжүүлэх; **~ суду** шүүхэд шилжүүлэх; 3. урвах, барьж өгөх, дайсанд тушаах.

ПРЕ́ДАННОСТЬ шударга, үнэнч.

ПРЕ́ДАННЫЙ үнэнч, итгэлт, шударга; **~ друг** итгэлт нөхөр.

ПРЕДА́ТЕЛЬ урвагч, урван тэрслэгч; **низкий ~** олиггүй урвагч.

ПРЕДА́ТЕЛЬСК||ИЙ 1. урваж, урвасан, тэрслүү; **~ поступок** урвасан явдал; 2. найдваргүй, хуурмаг; **~ая погода** найдваргүй цаг уур.

ПРЕДА́ТЕЛЬСТВО урвалт, урвах, итгэлийг эвдэх.

ПРЕДА́ТЬ 1. орхих; **~ забвению** мартаж орхих; **~ земле** булж орхих (оршуулах); **~ огню** шатааж орхих; 2. өгөх, шилжүүлэх; 3. урвах, барьж өгөх, дайсанд тушаах.

ПРЕДА́ТЬСЯ эрхэнд орох, эрхэнд автах; **~ врагу** дайсны эрхэнд автах; **~ другу** нөхрийн эрхэнд орох; 2. болох, дарагдах, мүн болох, автах, ташуурах; **~ мечтам** мөрөөдөл болох, бодол болох.

ПРЕДБА́ННИК халуун усны өмнөх өрөө, банийн наад тасалгаа.

ПРЕДВАРИ́ТЕЛЬНО урьдаар, урьдчилан эртхэн.

ПРЕДВАРИ́ТЕЛЬН||ЫЙ, урьдчилан, урьдчилсан, анхны; **~ое обсуждение** урьдчилан шүүмжилж хэлэлцэх.; **~ые сведения** урьдчилсан мэдээ; **~ое заключение** урьдчилан хорих, урьдчилан дүгнэх; **~ое следствие** урьдчилан мөрдөх, анхны байцаалт; **~ая продажа билетов** билетийг урьдчилан худалдах.

ПРЕДВАРИ́ТЬ 1. урьдчилан мэдэгдэх; **~ приезд** ирэхээ урьдчилан мэдэгдэх; 2. урьтах, урьтаж амжих, түрүүлж хийх; **~ события** хэрэг явдлаас рьтах.урьдчилан мэдэгдэх.

ПРЕДВЕ́СТИЕ тэмдэг, болохын тэмдэг, шинж орох, ёр орох; **~ бури** шуурга болохын тэмдэг; **~ весны** хаврын шинж орох.

ПРЕДВЕ́СТНИК,

ПРЕДВЕ́СТНИЦА 1. ёрч, зөнч; 2. тэмдэг, болохын тэмдэг, шинж орох. ёр; ~ **весны** хавар болохын тэмдэг.

ПРЕДВЕЩА́||ТЬ дохио болох, зөгнөх, ёрлох, иш үзүүрлэх, бошиг үзүүлэх; **тучи ~ли грозу** хар үүл аадар орохын дохио болов; **молодому артисту всё ~ло успех** залуу жүжигчинд амжилт олохын дохио бүрдэв.

ПРЕДВЗЯ́ТОСТ||Ь урьдаас тааварлах, буруу таамаглал, этгээд санал; **судить без ~и** урьдаас тааварлахгүй.

ПРЕДВЗЯ́Т||ЫЙ шүүмжлэж үзээ, урьдаас тааварласан, буруу таамаг, этгээд санаа; **~ое мнение** урь-даас тааварласан санал.

ПРЕДВИ́ДЕНИЕ урьдаас мэдэх, *төсөөлөл, ирээдүйг төсөөлөх*, зөн билэг; **научное** ~ шинжлэх ухааны төсөөлөл, шинжлэх ухааны зөн билэг.

ПРЕДВИ́ДЕТЬ урьдаас мэдэх, угтаж мэдэх, урьдаас төсөөлөх; ~ **ход событий** үйл явдлын өрнөлийг урьдаас мэдэх; **чтобы руководить, надо** ~ удирдахын тул угтаж мэдэх хэрэгтэй.

ПРЕДВИ́ДЕ||ТЬСЯ болмоор байх, гармаар байх, урьдаас мэдэгдэх; **изменений не ~тся** өөрчлөлт гарахгүй; **ничего интересного там не ~тся** тэнд сонирхолтой юм болмооргуй байна.

ПРЕДВКУСИ́ТЬ,

ПРЕДВКУША́ТЬ *гэж баярлах, угтаж бахдах*; ~ **удовольствие** сэтгэл ханана гэж баярлах; ~ **радость свидания** уулзахын баярыг угтаж бахдах, уулзана гэж баярлах.

ПРЕДВКУШЕ́НИЕ гэж баярлах, угтаж баярлах, угтаж бахдах, урьдаас бахдах.

ПРЕДВОДИ́ТЕЛЬ манлайлагч, толгойлогч, тэргүүлэгч, ахлагч; ~ **племени** отгийн тэргүүлэгч; ~ **дворянства** тайж нарын ахлагч.

ПРЕДВОДИ́ТЕЛЬСКИЙ манлайлагчийн, толгойлогчийн, тэргүүлэгчийн.

ПРЕДВОДИ́ТЕЛЬСТВО толгойлох, манлайлах, тэргүүлэх.

ПРЕДВОДИ́ТЕЛЬСТВОВАТЬ толгойлох, манлайлах, тэргүүлэх; ~ **войсками** цэрэг манлайлах

ПРЕДВОЕ́ННЫЙ дайны өмнөх, дайны урьдахь; ~ **период** дайны өмнөх үе.

ПРЕДВОСХИ́ТИТЬ,

ПРЕДВОСХИЩА́ТЬ, урьдаас мэдэх, урьдаас төсөөлөх.

ПРЕДВЫ́БОРН||ЫЙ сонгуулийн урьдахь, сонгуулийн өмнөх; **~ое собрание избирателей** сонгуулийн өмнөх сонгогчдын хурал.

ПРЕДГО́РЬЕ уулын бойр, уулын дэвсэг, хаяа уул.

ПРЕДДВЕ́РИ||Е 1. өмнөхөн, урьдхан, эгээ эхэн; **в ~и грядущих событий** *болох их явдлын эгээ эхэнд*; 2. үүдэвч; ~ **гортани** төвөнхийн үүдэвч.

ПРЕДЕ́Л 1. хил, зааг, зах; **за ~ами страны** тус орны хилийн цаана; **вернуться в родные ~ы** нутгийнхаа *хил дотор буцаж ирэх*; **~ы города** хотын зааг; **выйти из ~ов дозволенного** зөвшөөрсөн заагаас гарах (давах); 2. дотор, хугацаа; **в ~ах года** жилийн дотор; 3. туйл, хязгаар; ~ **нагрузки машины** машины ачаа даах туйл; **дойти до ~а** туйлд хүрэх (мухарт тулах); **всему есть** ~ юм бүхэнд хязгаар бий.

ПРЕДЕ́ЛЬН||ЫЙ туйл, туйлт, цаад захын; **~ая усталость** туйлын ядрах; **~ая скорость** туйлын хурд; ~ **срок** цаад захын хугацаа.

ПРЕДЗНАМЕНОВА́НИЕ бэлэг тэмдэг, зөн, совин, ёр; **доброе** ~ сайн бэлэг тэмдэг; **дурное** ~ муу ёр.

ПРЕДИКА́Т өгүүлэхүүн, учир зүйн өгүүлэхүүн: ~ **суждения** бодомжийн өгүүлэхүүн.

ПРЕДИСЛО́ВИ||Е оршил, өмнөх үг; **без всяких ~й** олон таван үггүй.

ПРЕДЛАГА́ТЬ дуртгах, санал оруулах, санал дэвшүүлэх.

ПРЕДЛО́Г I шалтаг, нэрийдэл, далимдуулал; **найти ~ для отказа** татгалзах шалтаг олох; **под ~ом усталости** ядарсан гэдэг нэрийдлээр; ~ **для ссоры** *хэрэлдэхийн шалтаг*.

ПРЕДЛО́Г II угтвар үг (үгийн өмнө хэрэглэгддэг, өөрөө биеэ даасан утгагүй туслах үг).

ПРЕДЛОЖЕ́НИЕ I 1. дуртгал, дуртгах, санал; **внести** ~ санал оруулах; **принимать** ~ санал зөвшөөрөх; 2. нийлүүлэлт; 3. гэрлэхийг дуртгах, гэрлэе гэх; **сделать** ~ гэрлэе гэж хэлэх.

ПРЕДЛОЖЕ́НИЕ II өгүүлбэр; **простое** ~ энгийн өгүүлбэр: **сложное** ~ нийлмэл өгүүлбэр; **придаточное** ~ хавсарсан өгүүлбэр, гишүүн өгүүлбэр.

ПРЕДЛОЖИ́||ТЬ 1. оруулах, санал оруулах, дуртгах, дэвшүүлэх; ~ **новый проект** шинэ төсөл оруулах; ~ **председателя** *даргаар сонгох санал оруулах*; 2. гэх, гэж дуртгах; ~ **свои услуги** үйлчилье гэж дуртгах, туслалцья гэх; **~ли закончить работу в недельный срок** нэг долоо хоногт ажлаа дуусгая гэх; ~ **построить дом** байшин барья гэх; ~ **явиться в суд** шүүхэд ирээрэй гэх; 3. тавих, оруулах; ~ **вопрос** асуулт тавих; ~ **руку** эхнэр болохыг гуйх; ~ **тост** хундага өргөх.

ПРЕДЛО́ЖНЫЙ угтвар үгт; ~ **падеж** угтвар үгт зүйн ялгал; ~ **оборот** угтвар үгт хэлхэц.

ПРЕДМА́ЙСК||ИЙ майн өмнөх, майн нэгнийн урьдахь, майн баярыг угтах; **~ое соревнование** майн өмнөх уралдаан, майн баярыг угтсан уралдаан.

ПРЕДМЕ́СТЬЕ дүүрэг, дэргэдэх *тосгоны*; ~ **Москвы** Москвагийн дэргэдэх тосгоны.

ПРЕДМЕ́Т 1. юм. эд, өлөг; **~ы широкого потребления** нийтийн хэрэгцээний юм, өргөн хэрэглээний юм; 2. юм, сэдэв; ~ **разговора** ярих юм; ~ **спора** маргах юм; ~ **насмешек** шоолох юм; 3. хичээл, зүйл; **сдать экзамены по всем ~ам** бүх хичээлээр шалгалт өгөх; ~ **изучения** судлах зүйл.

ПРЕДМЕ́ТН||ЫЙ юмын, бодитой, зүйлчлэн, зүйлчлэх; **~ое имя** юмны нэр; **~ая система обучения** зүйлчлэл заах систем; ~ **каталог** номын зүйлчлэх товъёг; ~ **указатель** зүйлчлэх бүгд хэлхээ; ~ **урок** үзвэртэй хичээл.

ПРЕДНАЗНАЧА́ТЬ зориулах, оногдуулах, залах.

ПРЕДНАЗНА́ЧИТЬ зориулах, оногдуулах, заяах; ~ **деньги на поездку** юманд явахад мөнгө зориулах.

ПРЕДНАЗНАЧЕ́НИЕ 1. зориулчих, урьдаас зориулах; 2. оноо, тавилан; **высокое ~ писателя** зохиолчийн эрхэм тавилан.

ПРЕДНАЗНА́ЧЕННЫЙ 1. зориулагдсан, урьдаас зориулагдсан; 2. оноогдсон, оноотой, тавилантай; **он предназначен для науки** тэр шинжлэх ухаанд оноотой хүн.

ПРЕДНАМЕ́РЕНН||ЫЙ санаатай, зориуд санаатай, зориуд хийсэн; **~ое действие** зориуд хийсэн үйл.

ПРЕДНАЧЕРТА́НИ||Е төлөвлөн заах, урьдаас өгсөн заалт; **следовать чьим-нибудь ~ям** хүний төлөвлөн заасныг мөрдөх.

ПРЕДНАЧЕРТА́ТЬ төлөвлөн заах, урьдаас заах, зааж зурах; ~ **порядок действий** үйл явдлын журмыг зааж зурах.

ПРЕ́ДО өмнө, урьд, урд; ~ **мной** миний өмнө.

ПРЕ́ДОК уг удам, дээд ёс.

ПРЕДОПРЕДЕЛЕ́НИЕ 1. урьдаас тогтоох, урьдаас шийдвэрлэх; 2. тавилан заяа.

ПРЕДОПРЕДЕЛ||И́ТЬ,

ПРЕДОПРЕДЕЛ||ЯТЬ урьдаас тогтсон, урьдаас шийдвэрлэх; **удачное начало ~ило дальнейший успех** аятайхан эхэлсэн нь цаашдын амжилтыг урьдаас шийдвэрлэв.

ПРЕДОПРЕДЕЛИ́ТЬСЯ,

ПРЕДОПРЕДЕЛЯ́ТЬСЯ урьдаас тогтох, урьдаас шийдвэрлэгдэх.

ПРЕДОСТА́ВИТЬ хэрэглүүлэх, барьзнуулах, өгөх.

ПРЕДОСТАВЛЯ́ТЬ 1. хэрэглүүлэх, барьзнуулах, өгөх; ~ **комнату кому-нибудь** тасалгааг хүнд хэрэглүүлэх; ~ **свою библиотеку в распоряжение товарища** номын сангаа нөхрийн мэдэлд өгөх; 2. зөвшөөрөх, олгох, эрх олгох.

ПРЕДОСТАВЛЕ́НИЕ олгох, хэрэглүүлэх, барьзнуулах, өгөх; ~ **кредитов** зээл олгох.

ПРЕДОСТЕРЕГА́ТЬ болгоомжлуулах, урьдаас сануулах, сэрэмжлүүлэх.

ПРЕДОСТЕРЕ́ЧЬ болгоомжлуулах, урьдаас сануулах, сэрэмжлүүлэх, цэнэх; ~ **от опасности** аюулаас сэрэмжлүүлэх.

ПРЕДОСТЕРЕЖЕ́НИЕ урьдаас сануулах, сэрэмжлэх, сэргийлэх, болгоомжлох, цэнэх, **сделать** ~ урьдаас сануулж хэлэх.

ПРЕДОСТОРО́ЖНОСТ||Ь болгоомж, болгоомжлох, сэрэмж, цэнэх, сэргийлэх; **принять меры ~и** болгоомжлох арга хэмжээг авах.

ПРЕДОСУДИ́ТЕЛЬНЫЙ сонжилтой, буруушаамаар, зохисгүй; ~ **поступок** сонжилтой явдал, буруушаамаар хэрэг.

ПРЕДОТВРАТИ́ТЬ,

ПРЕДОТВРАЩА́ТЬ арилгах, үгүй болгох, царж зайлуулах; ~ **бедствие войны** дайны гай зовлонг арилгах.

ПРЕДОТВРАЩЕ́НИЕ арилгах, үгүй болгох, царж зайлуулах; ~ **агрессии** түрэмгийлэн халдахгүй болгох.

ПРЕДОХРАНЕ́НИЕ хамгаалах; ~ **дерева от гниения** модыг өмхрөхөөс хамгаалах.

ПРЕДОХРАНИ́ТЕЛЬ хамгаалуур, хамгаалагч, сойлт; **ружейный** ~ бууны сойлт.

ПРЕДОХРАНИ́ТЕЛЬН||ЫЙ хамгаалах, сэргийлэх; **~ая прививка** хамгаалах тарилга; **~ые меры** сэргийлэх арга хэмжээ.

ПРЕДОХРАНИ́ТЬ,

ПРЕДОХРАНЯ́ТЬ, хамгаалах, сэргийлэх; ~ **от повреждения** гэмтэхээс хамгаалах.

ПРЕДПИСА́ТЬ тушаах, тушаал бичиж өгөх.

ПРЕДПИ́СЫВАТЬ 1. тушаах, тушаал бичиж өгөх; ~ **выехать** морд гэж тушаах; 2. зааварлах, зөвлөх, гэх; **врач предписал ему постельный режим** эмч түүнийг үргэлж хэвтэж бай гэсэн юм.

ПРЕДПИСА́НИЕ 1. тушаал; **секретное** ~ нууц тушаал; **получить ~ выехать** мордох тушаал авах; 2. заавар; ~ **врача** эмчийн заавар.

ПРЕДПЛЕ́ЧЬЕ шуу, бугуй.

ПРЕДПОЛАГА́ЕМ||ЫЙ төлөвлөж байгаа, тухайлсан, багцаалсан; **~ая поездка** төлөвлөж байгаа аян.

ПРЕДПОЛАГА́||ТЬ 1. төсөөлөх, багцаалах, тухайлах; 2. санаатай байх; **я ~ю окончить работу скоро** би ажлаа түргэн дуусгах санаатай байна; 3. хэрэгтэй байх; **эта работа ~ет большой опыт** энэ ажилд их туршлага хэрэгтэй байна.

ПРЕДПОЛАГА́||ТЬСЯ төлөвтэй байх, болмоор байх; **заседание ~ется устроить вечером** хурал үдэш хуралдах төлөвтэй байна.

ПРЕДПОЛОЖЕ́НИЕ 1. тэгнэ байгаа, тийм байх гэж таамаглах; **высказать** ~ тийм байх гэж хэлэх; 2. -маар байх; **у него было ~ уехать** отсюда тэр эндээс явчмаар байв; **терять-ся в ~х** тааварлаж ядах.

ПРЕДПОЛОЖИ́ТЕЛЬНО 1. барагцаалж, тухайлж; **назначить ~ день отъезда** явах өдрөө барагцаалж болзох; 2. барагцаалахад; **все путешествие, ~, продлится три недели** бүх жуулчлал барагцаалахад гурван долоо хоног үргэлжлэх байх.

ПРЕДПОЛОЖИ́ТЕЛЬНЫЙ барагласан, багцаалсан; ~ **результат** багцаалсан үр дүн.

ПРЕДПОЛОЖИ́||ТЬ багцаалах, барагцаалах, таамаглах; **можно с достоверностью** ~ нилээд ноттойгоор таамаглаж болно; 2. байх гэж бодох; **~м, что ты прав** чиний зөв гэж бодъё.

ПРЕДПОСЛЕ́ДНИЙ шувтарганы өмнөх, сүүлчийн өмнөх, сүүлээсээ хоёрдахь; ~ **номер газеты** сонины сүүлчийн дугаарын өмнөх нь.

ПРЕДПОСЫ́ЛК||А 1. урьдчилсан нөхцөл; ~ **успеха** амжилтын урьдчилсан нөхцөл; 2. үүд, баримжаа; **исходить из правильной ~и** зөв баримжаанаас үүсгэж хэлэлцэх.

ПРЕДПОЧЕ́СТЬ шилэхэрхэмлэх; 2. дээртэх, дээр гэж бодох; ~ **полезное приятному** аятай юмнаас ашигтай юмыг дээр гэх, дээр гэж бодох.

ПРЕДПОЧТЕ́НИЕ эрхэмлэх, шилэх, дээдлэх; **отдать** ~ **кому-либо** хүнийг эрхэмлэн хүндлэх.

ПРЕДПОЧТИ́ТЕЛЬНО илүү эрхэмлэж, дээр гэж бодож, бүр сайн; **нужно сделать об этом сообщение, ~ в письменной форме** энэ тухай мэдэгдэх хэрэгтэй, тэгэхдээ бичгээр бол бүр сайн.

ПРЕДПОЧТИ́ТЕЛЬНЫЙ илүү, дээр, хамгийн зохимжтой; **наиболее предпочтителен** хэрэг тийм болбол (тэгж дуусвал) бүр дээр; ~ **срок предоставления доклада — следующая неделя** илтгэл тавих хамгийн зохимжтой хугацаа бол дараагийн долоо хоног болно.

ПРЕДПРА́ЗДНИЧН||ЫЙ баярын өмнөх; **~ая торговля** баярын өмнөх худалдаа.

ПРЕДПРИИ́МЧИВЫЙ самбаатай, самбаа зальтай, арга зальтай, овжин; ~ **человек** самбаа зальтай хүн.

ПРЕДПРИНИМА́ТЕЛЬ үйлдвэрийн эзэн, худалдаа үйлдвэрийн эзэн.

ПРЕДПРИНИМА́ТЕЛЬСКИЙ үйлдвэрийн эзний, эзний; ~ **доход** эзний орлого.

ПРЕДПРИНИМА́ТЬ,

ПРЕДПРИНЯ́ТЬ эхлэх, хийж эхлэх, гэж оролдох, үүсгэх; ~ **исследование** судалж эхлэх, судалгаа хийж эхлэх; ~ **необходимые меры** чухал арга хэмжээг авч эхлэх.

ПРЕДПРИЯ́ТИ||Е үйлдвэрийн газар, үйлдвэр; **работать на ~и** үйлдвэр дээр ажиллах 2. хэрэг, ажил; **рискованное** ~ аз турших хэрэг; **интересное** ~ сонирхолтой ажил.

ПРЕДРАСПОЛАГА́ТЬ,

ПРЕДРАСПОЛОЖИ́ТЬ аятай болгох, ялгуум болгох; ~ **кого-нибудь в свою пользу** хүнийг өөрийн тусын тул ялгуум болгох.

ПРЕДРАСПОЛОЖЕ́НИЕ дүйтэй, дуршилтай, ялдам.

ПРЕДРАСПОЛО́ЖЕННОСТЬ 1. дүйтэй, дуршилтай, ялдам; ~ **к музыке** хөгжимд дүйтэй; ~ **к научным изысканиям** шинжлэл судлалд дуршилтай; 2. тусамтгай, өртөмгий, амархан хүрэх; ~ **к туберкулёзу** сүрьеэ өвчинд өртөмтгий.

ПРЕДРАСПОЛО́ЖЕННЫЙ 1. дүйтэй, дуршилтай, ялдам; 2. тусамтай, өртөгдөх, амархан хүрдэг; **он предрасположен к простуде** тэр амархан салхи цохиулдаг хүн.

ПРЕДРАССВЕ́ТНЫЙ үүрийн өмнөх, үүрийн хяраа; ~ **туман** үүрийн хярааны манан.

ПРЕДРАССУ́Д||ОК атгаг сэжиг, балай заншил; **мещанский** ~ бэртэгчний атгаг сэжиг; **человек без ~ков** атгаг сэжиг байхгүй хүн.

ПРЕДРЕКА́ТЬ,

ПРЕДРЕ́ЧЬ урьдаас айлдах, лүндэгнэх.

ПРЕДРЕША́ТЬ урьдаас шийдвэрлэх, үгтаж шийдэх; **не следует ~ события** аливаа явдлыг урьдаас шийдвэрлэж болохгүй; ~ **вопрос** асуултыг үгтаж шийдэх.

ПРЕДСЕДА́ТЕЛЬСК||ИЙ даргын; **~ое место** даргын суудал.

ПРЕДСЕДА́ТЕЛЬСТВО даргалах.
ПРЕДСЕДА́ТЕЛЬСТВУЮЩИЙ даргалагч, даргалж байгаа хүн, дарга.
ПРЕДСЕ́РДИЕ зүрхний тосгуур.
ПРЕДСКАЗА́НИЕ урьдаас мэдэх, ирээдүйг мэдэх, мэргэлэх; ~ **погоды** цаг уурыг урьдаас мэдэх.
ПРЕДСКАЗА́ТЕЛЬ урьдаас мэдэгч, төлөгч, мэргэн хүн; ~ **погоды** цаг уурыг урьдаас мэдэгч.
ПРЕДСКАЗА́ТЕЛЬНИЦА урьдаас мэдэгч эмэгтэй, мэргэн хүүхэн.
ПРЕДСКАЗА́ТЬ урьдаас мэдэх, угтаж мэдэх, ирээдүйг мэдэх.
ПРЕДСКА́ЗЫВАТЬ 1. урьдаас мэдэх, угтаж мэдэх, ирээдүйг мэдэх; **правильно ~ погоду** тэнгэр ямар болохыг урьдаас зөв мэдэх; 2. мэргэлэх, бошиг үзүүлэх.
ПРЕДСМЕ́РТНЫЙ амьсгаа хураахын өмнө, сүүлийн; ~ **час** үхэхийн өмнөх цаг; ~ **вздох** сүүлийн амьсгал.
ПРЕДСТАВА́ТЬ урд зогсох; ~ **перед судом** шүүхийн өмнө зогсох.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬ 1. төлөөлөгч, төлөөний хүн; ~ **учреждения** албан газрын *төлөөний хүн*; ***полномочный*** ~ бүрэн эрхт төлөөлөгч, элчин сайд; 2. төлөөлөгч, жишээ, нэг нь, нэг амьтан, нэг ургамал; ~ **класса млекопитающих** хөхтөны аймгийн нэг амьтан.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬНИЦА төлөөлөгч эмэгтэй.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬНОСТЬ намба, сүр.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬН||ЫЙ I сонгогдсон төлөөлөгчдийн, сонголтын, сонгуультай; **~ое собрание** сонгогдсон төлөөлөгчдийн хурал; ~ **образ правления** сонголтын журмаар захирах; **~ое учреждение** сонгуультай албан газар.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬНЫЙ II намбатай, сүрлэг; ~ **мужчина** намбатай эр.
ПРЕДСТАВИ́ТЕЛЬСТВ||О төлөөлөгчийн газар; **торговое ~** худалдааны төлөөлөгчийн газар; 2. төлөөлөх явдал, төлөөлөгчийн эрх үүрэг; 3. төлөөлөгчийн, төлөөлөгчийг сонгох журам; **норма ~а** төлөөлөгчдийн тоо.
ПРЕДСТА́ВИТЬ 1. өгөх, гаргах, үзүүлэх, хүргэж өгөх; **~ список сотрудников** ажилтны нэрийн жагсаалтыг гаргаж өгөх; ~ **доказательства** нотолгоо гаргах; 2. танилцуулах; ~ **гостя собравшимся** цуглагсдад зочныг танилцуулах; 3. дэвшүүлэх; ~ **к награде** шагнуулахаар дэвшүүлэх; 4. учруулах, -тай юм; **это не представит затруднений** энэ бэрхшээл учруулах юм биш, энэ төвөгтэй юм биш; 5. санаанд багтах, сэтгэлдээ ургуулан бодох; **не могу себе этого ~** энэ ч миний санаанд багтахгүй *юм байна*; **~ картину боя** байлдааныг сэтгэлдээ ургуулан бодох; 6. үзүүлэх, харуулах, дүрслэх; ~ **дело в смешном виде** юмыг инээдтэйгээр дүрслэх.
ПРЕДСТА́ВИТЬСЯ танилцах, нэрээ хэлж танилцах.
ПРЕДСТАВЛЯ́ТЬСЯ танилцах, нэрээ хэлж танилцах, өөрийгөө танилцуулах; ~ **собравшимся** цуглагсдад нэрээ хэлж танилцах; 2. юм шиг болох, маяг үзүүлэх; ~ **больным** өвчтэй *юм шиг болох*; ~ **спящим** *унтсан маяг* үзүүлэх; 3. санагдах, сэтгэлд ургах; **это тебе только представилось** чамд тэгж санагдаж л дээ; 4. тохиолдох, дайралдах, учрах; **представился удобный случай** аятайхан бололцоо дайралдлаа; **если представится случай** хэрэг тохиол дайралдвал.
ПРЕДСТАВЛЕ́НИ||Е 1. дэвшүүлэх; ~ **к награде** шагналд нэр дэвшүүлэх; 2. мэдүүлэх, үзүүлэх, илэрхийлэх; ~ **о новых штатах** шинэ орон тооны тухай мэдүүлэх; 3.гаргалт, тоглолт, жүжиг; **первое ~ новой пьесы** шинэ жүжгийн анхны тоглолт; **новое** ~ шинэ жүжиг; 4. санагдах, сэтгэлд дахин ургах; 5. ойлгомж, мэдэх, төсөөлөл; **иметь неправильное ~** буруу ойлгомжтой байх; **не иметь ни малейшего ~я о чём-нибудь** ямар нэг юмны тухай огт юу ч мэдэхгүй байх.
ПРЕДСТАВЛЯ́||ТЬ 1. учруулах, татах, -тай; **это не ~ет затруднений** энэ төвөг учруулах юм биш, энэ төвөг татах юм биш; **работа ~ет для меня значительный интерес** уг ажил надад нилээд сонирхолтой байна; 2. төлөөлөх; ~ **учреждение** албан газрыг төлөөлөх.
ПРЕДСТА́ТЬ зогсох, ирэх, үзэгдэх; ~ **перед судом** шүүхийн өмнө зогсох; ~ **перед зрителями** үзэгчдийн өмнө гарч ирэх.
ПРЕДСТО||Я́ТЬ болох, гэж байх, хийх болж байх, гарах гэж байх, 1. тохиолдох; **~ит интересная работа** сонирхолтой ажил хийх болж байна; **нам ~ит значительный расход** биднээс их зардал гарах гэж байна; **~ят крупные события** их хэрэг гарах гэж байна.
ПРЕДСТОЯ́Щ||ИЙ ирэх, болох гэж байгаа, айсуй; **в ~ем году** ирэх жилд; **на ~ем собрании** болох гэж байгаа хурал дээр.
ПРЕДТЕ́ЧА ууган; **Ломоносов — ~ многих великих русских учёных** Ломоносов — Оросын олон их эрдэмтдийн ууган нь *мөн*.
ПРЕДУБЕЖДЕ́НИЕ урьдаас хэлбэрүү санах, атгаг санаа, буруу атгаг, сэжиглэл, сэжиг таавар; **относиться к чему-нибудь с ~м** юманд урьдаас сэжиглэлтэй хандах.
ПРЕДУБЕЖДЁННЫЙ урьдаас хэлбэрүү санаалах, атгаг санаатай, сэжиг таавартай; **человек ~ против нас** бидний тухай атгаг санаатай хүн.
ПРЕДУГАДА́ТЬ тааварлаж мэдэх, урьдаас мэдэх.
ПРЕДУГА́ДЫВАТЬ тааварлаж мэдэх, урьдаас мэдэх; ~ **намерение врага** дайсны санааг урьдаас мэдэх.
ПРЕДУМЫ́ШЛЕННО муу санаагаар хийсэн, зориуд, хорон сэтгэлтэй.
ПРЕДУМЫ́ШЛЕННЫЙ муу санаагаар хийсэн, зориуд, хорон сэтгэлтэй.
ПРЕДУПРЕДИ́ТЕЛЬНОСТЬ *их анхаарал тавих, тун эелдэг, голшиг.*
ПРЕДУПРЕДИ́ТЕЛЬН||ЫЙ 1. анхааруулах, болгоомжлох, сэргийлэх, сэрэмжлэх; ~ **сигнал** анхааруулах дохио; **~ые меры** сэргийлэх арга хэмжээ; 2 их анхааралтай, их эелдэг, голшиг, ууриалагхан; **~ое отношение к кому-либо** хүнд их эелдэг байх.
ПРЕДУПРЕДИ́ТЬ мэдэгдэх, урьдчилан мэдэгдэх, урьдаас мэдэгдэх, урьдаас сануулах; ~ **об отъезде** явахаа урьдаас мэдэгдэх; 2. гарахааргүй болох, сэрэмжлэх; ~ **пожар** түймэр гарахааргүй болгох; 3. урьтах, урьтаж амжих, өрсөх, түрүүлэх; ~ **события** үйл явдлаас өрсөх.
ПРЕДУПРЕЖДЕ́НИ||Е 1. мэдээлэх, урьдаас мэдэгдэх, мэдээ чимээ; **пришёл без всяких ~й** огт мэдээ чимээгүй байгаад (гэнэт) ирэв; 2. сануулга, урьдаас сануулах, анхааруулах, **строгий выговор с ~ем** урьдаас сануулж хатуу донгодох; **серьёзное** ~ хатуу сануулга.
ПРЕДУСМА́ТРИВАТЬ урьдаас мэдэх, урьдаас заах, анхааруулга авах.
ПРЕДУСМОТРЕ́||ТЬ урьдаас мэдэх, урьдаас заах, анхааруулга авах, хараандаа авах, урьдчилан мэдэх; ~ **все возможности** бүх бололцоог хараандаа авах; **в договоре такой случай не ~н** гэрээнд ийм явдлыг урьдаас заасангүй.
ПРЕДУСМОТРИ́ТЕЛЬНОСТЬ болгоомжлох, хаширлах, урьдаас мэдэх.
ПРЕДУСМОТРИ́ТЕЛЬНЫЙ болгоомжтой, хашир, урьдаас анхаарах; ~ **человек** хашир хүн.
ПРЕДЧУ́ВСТВИЕ совин, урьдаас мэдрэх; **радостное** ~ баярын совин.

ПРЕДЧУ́ВСТВОВАТЬ зөгнөх, совин татах, урьдаас мэдрэх; ~ **радостное событие** баярт явдлыг зөгнөх.

ПРЕДШЕ́СТВЕННИК өмнөх зүтгэлтэн, өмнөх хүн, түрүүчийн хүн.

ПРЕДШЕ́СТВЕННИЦА түрүүчийн эмэгтэй.

ПРЕДШЕ́СТВОВА||ТЬ 1. өмнө явагдах, урьд болох; **принятию решения ~ло длительное обсуждение** шийдвэр гаргахын өмнө удтал шүүмжлэл явагдав; 2. түрүүлж явах.

ПРЕДШЕ́СТВУЮЩИЙ өмнөх, урьдах; ~ **год** урьдахь жил.

ПРЕДЪЯВИ́ТЕЛ||Ь 1. үзүүлэгч; **прошу выдать деньги ~ю этого письма** энэ захидлыг үзүүлэгчид мөнгө олгохыг гуйя; 2. мэдүүлэгч; ~ **иска** зарга мэдүүлэгч.

ПРЕДЪЯВЛЕ́НИ||Е 1. үзүүлэх; **уплачиваемый по ~ю** үзүүлмэгц тавин олгоно; 2. мэдүүлэх, мэдүүлэг, тавих; ~ **претензий** гомдол мэдүүлэх; ~ **требований** шаардлага тавих.

ПРЕДЫДУ́Щ||ИЙ 1. өнгөрсөн өмнөх, урьдах; ~ **год** өнгөрсөн он; **өмнөх жил**; 2. дээр дурдсан, урьд хэлсэн; **из ~его следует вывод** дээр дурдсанаас гарах дүгнэлт нь.

ПРЕЕ́МНИК залгамжлагч; **выбрать себе ~а** залгамжлагчаа сонгож авах.

ПРЕЕ́МСТВОВАТЬ залгамж, удамшил.

ПРЕЕ́МСТВЕННЫЙ замгамжилсан, үе залгасан, залгамжлагдсан.

ПРЕ́ЖДЕ 1. урьд өмнө, тугаар; 2. урьдаар, түрүүнд нь; ~ **подумай — потом скажи** урьдаар бодоод сүүлд нь хэл; 3. урьтаж, болоогүй байхад; ~ **всего** юуны өмнө.

ПРЕЖДЕ́ВРЕМЕНН||ЫЙ 1. цагаас урьд, цагаас өмнө, эрт; 2. цаг бусаар, зуурдаар; **~ая смерть** зуурдаар нас барах; 3. дутуу; **~ые роды** дүтуу төрөх; 4. яагаа ч үгүй байхад, урьдаас, дэндүү эртээс; **~ое беспокойство** урьдаас сэтгэл зовних.

ПРЕ́ЖН||ИЙ урьдын, урьдынх, урьдахь; **в ~ие времена** урьдын цагт; **от ~его мало что осталось** урьдынхаас бараг юм үлдсэнгүй.

ПРЕЗЕНТОВА́ТЬ бэлэглэх, бэлэг барих.

ПРЕЗЕРВАТИ́В бэлгэвч, сэрэмжлэх хэрэгсэл, хаацай.

ПРЕЗИДЕ́НТ ерөнхийлөгч.

ПРЕЗИ́ДИУМ тэргүүлэгчид, тэргүүлэгчидын газар; ~ **академии наук** шинжлэх ухааны академийн тэргүүлэгчид.

ПРЕЗИРА́ТЬ 1. жигших, зэвүүцэх, басамжлах, шоовдорлох; 2. тоохгүй байх, хайхрахгүй байх, ~ **опасность** аюулыг тоохгүй байх.

ПРЕЗРЕ́НИЕ 1. жигших зэвүүцэх, үзэн ядах, **относиться с ~м** жигшиж үзэх; 2. тоохгүй хайхрахгүй.

ПРЕЗРЕ́ННЫЙ жигшүүрт, зэвүүцмээр, эгдүү хүрмээр; ~ **трус** эгдүү хүрмээр аймхай амьтан.

ПРЕЗРИ́ТЕЛЬНЫЙ жигшмээр, зэвүүцмээр, эгдүүтэй, тоомсоргүй, ~ **взгляд** тоомсоргүй харц

ПРЕЗУ́МПЦИЯ 1. үнэнд баримтлах таамаглал; 2. үнэнд авзнах баримт ~ **невиновности** нотлогдоогүй бол буруугүйд тооцох.

ПРЕИМУ́ЩЕСТВЕННО ялангуяа, нэн ялангуяа, гол төлөв, голлож, их төлөв.

ПРЕИМУ́ЩЕСТВЕНН||ЫЙ давуу, илүү **предоставить ~ое право** бусдаас илүү эрх олгох.

ПРЕИМУ́ЩЕСТВ||О 1. давуу, илүү, давуу чанар, илүүтэй зүйл, эрхэмлэгдэх зүйл; **иметь** ~ давуу байх; **сохранить** ~ давуу чанараа хадгалах; 2. онцгой эрх; **по ~у** ихэнхдээ

ПРЕИСПО́ДНЯЯ там, тамын орон.

ПРЕИСПО́ЛНЕННЫЙ дүүрэн бялхам дүүрэн; ~ **благодарностью** баяр талархлаар бялхам дүүрэн.

ПРЕИСПО́ЛНИТЬ багтаж ядах, дүүрэх, бялхам, оргилох, баршгүй; ~ **гневом** багтаж ядтал хилэгнэх.

ПРЕИСПО́ЛНИ||ТЬСЯ багтаж ядах, дүүрэх, бялхах, оргилох, баршгүй; **сердца ~лись радостью** сэтгэл баяраар дүүрэв.

ПРЕЙСКУРА́НТ үнийн жагсаалт.

ПРЕКЛОНЕ́НИЕ бишрэх, бөхийж бишрэх, мэхийж хүндлэх.

ПРЕКЛОНЯ́ТЬ бөхийлгөх, тонгойлгох, сөгдөх; ~ **голову** толгой тонгойл-гох;~ **знамена** туг бөхийлгөх; ~ **колена** өвдөг сөгдөх.

ПРЕКЛОНЯ́ТЬСЯ бөхийх, тонгойх, сөгдөх, бишрэн хүндлэх.

ПРЕКЛО́ННЫЙ өтөлсөн, өвөгжөөл, өндөр настай; ~ **возраст** өвөгжөөл нас.

ПРЕКОСЛО́В||ИТЬ сөргөх, зөрөх, хэдэрлэх, ярдаглах; **не ~ь старшим** ахмад хүний үгийг бүү сөргө.

ПРЕКРА́СНО 1. сайхан, сайн; **я всё ~ понял** би цөмийг сайхан ойлголоо; **он ~ играет в шахматы** тэр хүн шатар сайн тоглодог; *2.* за тэгье; **~, я завтра приду** за тэгье, би маргааш ирье.

ПРЕКРА́СНОЕ сайхан юм.

ПРЕКРА́СН||ЫЙ сайхан, гоё, их сайн, үзэсгэлэнтэй; **~ые горы** сайхан уул; ~ **человек** их сайн хүн; **в один ~ день** нэг сайхан өдөр, гэнэт байтал; ~ **пол** эмэгтэйчүүд

ПРЕКРАЩА́ТЬ зогсоох, болиулах, таслах; ~ **работу** ажил зогсоох.

ПРЕКРАЩА́ТЬСЯ зогсох, болих, тасрах, арилах; **дождь прекратился** бороо зогсов (арилав).

ПРЕКРАЩЕ́НИЕ зогсоох, зогсох; ~ **работы** ажил зогсох

ПРЕЛЕ́СТНЫЙ сайхан, хөөрхөн, үзэсгэлэнтэй; **какой ~ ребёнок!** ямар хөөрхөн хүүхэд вэ!

ПРЕ́ЛЕСТЬ сайхан, хөөрхөн, тааламжтай нь; ~ **детской улыбки** хүүхдийн инээмсэглэхийн хөөрхөн нь.

ПРЕЛОМЛЯ́ТЬ хугаруулах, нугаруулах; **призма преломила солнечный луч** талст шил нарны цацрагийг хугалав.

ПРЕЛОМИ́ТЬСЯ 1. хугарах, хугалагдах, нугарах; 2. өөр ойлгогдох.

ПРЕЛОМЛЕ́НИЕ 1. хугарах; ~ **света** гэрэл хугарах; 2. өөрмөц ухаарал.

ПРЕ́Л||ЫЙ нэхэшсэн,ялзарсан, үжирсэн, халсан; **~ые яблоки** ялзарсан алим, **~ое зерно** халсан үр тариа.

ПРЕ́ЛЬ нэхэшмэл, нэхэшмэл үнэр, ялзармал; **пахнет ~ю** нэхэшмэл үнэр ханхалж байна.

ПРЕЛЬСТИ́ТЬ,

ПРЕЛЬЩА́ТЬ 1. сэтгэл татах, дур булаах; ~ **своим умом** ухаанаараа сэтгэл татах; 2. сайхан санагдах, жилбэрхэх, хорхой хүргэх; **Ариуну прельстила поездка во Францию** Ариунад Францаар аялах нь сайхан санагдав.

ПРЕЛЬСТИ́ТЬСЯ,

ПРЕЛЬЩА́ТЬСЯ сэтгэл татагдах, дур булаагдах, аванхайлагдах, жилбэрхэх.

ПРЕЛЮБОДЕЯ́НИЕ шалиг явах, нүгэлт хурьцал.

ПРЕМИА́ЛЬНЫЙ шагналын, шагнах журмын.

ПРЕМИРОВА́НИЕ шагнах, шагнал олгох.

ПРЕМИРОВА́ТЬ шагнах; ~ **за лучшую работу** шилдэг ажлын төлөө шагнах.

ПРЕ́МИ||Я шагнал, шан; **денежная** ~ мөнгөн шагнал; **давать ~ю** шагнал олгох; **получить ~ю** шагнал авах, шан хүртэх.

ПРЕМНО́ГО маш их; ~ **вам благодарен** танд маш их талархана.

ПРЕМУ́ДРОСТ||Ь 1. төгс билэг. 2. хэцүү юм; **никакой ~и тут нет** ямарч хэцүү юм үүнд байхгүй.

ПРЕМУ́ДРЫЙ төгс билэгт, мэргэн сэцэн.

ПРЕМЬЕ́Р ерөнхий сайд.

ПРЕМЬЁРА жүжиг, кино, эхний тоглолт.

ПРЕМЬЕ́Р-МИНИ́СТР ерөнхий сайд.

ПРЕНЕБРЕ́ГАТЬ,

ПРЕНЕБРЕ́ЧЬ басамжлах, тоомсорлохгүй байх, хайхрахгүй байх; ~ **опасностью** аюулыг тоомсорлохгүй байх.

ПРЕНЕБРЕ́ЖЕНИЕ басамжлал, тоомсоргүй, эс тоомсорлол, хайхрамжгүй; **относиться с ~м** басамжилж харьцах.

ПРЕНЕБРЕЖИ́ТЕЛЬН||ЫЙ хайхрамжгүй, тоомсоргүй; **~ое отношение** хайхрамжгүй харьцаа.

ПРЕ́НИЯ шүүмжлэл; **прекратить ~** шүүмжлэлийг таслах.

ПРЕОБЛАДА́НИЕ ихэнх, олонх, дийлэнх; ~ **облачности** ихэнхдээ тэнгэр бүрхэг байх.

ПРЕОБЛАДА́||ТЬ зонхилох, олонх нь болох, ихэнхдээ байх, дийлэнх болох; **на севере ~ют хвойные леса** хойд зүгт шилмүүст ой зонхилж ургана.

ПРЕОБЛАДАЮ́Щ||ИЙ зонхилох, олонх, ихэнх дийлэнх; **~ая растительность** зонхилох ургамал.

ПРЕОБРАЖА́ТЬ,

ПРЕОБРАЗИ́ТЬ өөрчлөх, хувиргах, ондоо болгох, өнгийг өөрчлөх, үзэмжийг хувиргах; **зима преобразила всю природу** өвөл бүх байгалийн үзэмжийг хувиргав.

ПРЕОБРАЖА́ТЬСЯ,

ПРЕОБРАЗИ́ТЬСЯ өөрчлөгдөх, өнгө өөрчлөгдөх, үзэмж хувирах, ондоо болох.

ПРЕОБРАЗОВА́НИЕ өөрчлөн байгуулах, өөрчлөх, хувьсгах, төгс өөрчлөх, эрс хувиргах.

ПРЕОБРАЗОВА́ТЕЛЬ өөрчлөгч, төгс өөрчлөгч, өөрчлөн шинэтгэгч, хувиргагч.

ПРЕОБРАЗОВА́ТЬ,

ПРЕОБРАЗО́ВЫВАТЬ өөрчлөн байгуулах, өөрчлөн шинэтгэх, хувиргах; ~ **переменный ток в постоянный** хувьсах цахилгаан гүйдлийг тогтмол гүйдэл болгож өөрчлөх.

ПРЕОДОЛЕ́НИЕ давах, даван туулах, дийлэх, дарах, булих; ~ **трудностей** бэрхшээлийг давах.

ПРЕОДОЛИ́М||ЫЙ давагдмаар, давж чадмаар, дийлэгдмээр; **~ое затруднение** давагдмаар бэрхшээл.

ПРЕПАРА́Т бэлдмэл, бэлдсэн эм.

ПРЕПАРИ́РОВАТЬ бэлдмэл хийх; ~ **лягушку** мэлхийн бэлдмэл хийх

ПРЕПИНА́НИ||Е цэг,тэмдэг, цэглэл; **знаки ~я** цэг тэмдэг.

ПРЕПИРА́ТЬСЯ дэмий маргах, хоосон мэтгэлцэх, хэл ам гаргах.

ПРЕПОДАВА́НИ||Е багшлах, заах; **метод ~я** заах арга.

ПРЕПОДАВА́ТЕЛЬ багш, ~ **математики** тоо бодлогын багш.

ПРЕПОДАВА́ТЕЛЬНИЦА багш эмэгтэй.

ПРЕПОДАВА́ТЕЛЬСКИЙ багшийн, багш нарын.

ПРЕПОДАВА́ТЬ заах, багшлах; ~ **урок** хичээл заах.

ПРЕПОДНЕСТИ́,

ПРЕПОДНОСИ́ТЬ 1. өргөх, барих, өгөх; ~ **подарок** бэлэг барих; 2. сонсгох, мэдэгдэх; ~ **приятную новость** сайхан сонин сонсгох.

ПРЕПОДНОШЕ́НИЕ 1. өргөх, барих, бэлэглэх; 2. өргөл, барьц, бэлэг.

ПРЕПОДО́БНЫЙ хутагт гэгээн.

ПРЕПО́Н||А саад тотгор, барцад; **чинить ~ы кому-нибудь** хүнд барцад учруулах.

ПРЕПОРУЧА́ТЬ даалгах, найдах.

ПРЕПРОВОДИ́ТЕЛЬН||ЫЙ дагалдуулан хүргэх, дагалдуулах, хавсарган илгээх; **~ая записка** дагалдуулах бичиг.

ПРЕПРОВОДИ́ТЬ,

ПРЕПРОВОЖДА́ТЬ илгээх, явуулах, хүргүүлэх; ~ **документы** бичиг баримт илгээх.

ПРЕПРОВОЖДА́ЕМЫЙ дагалдуулан хүргэх, хүргүүлэх; **при сем ~** үүний хамт хүргүүлэх.

ПРЕПРОВОЖДЕ́НИЕ өнгөрүүлэх, хүргүүлэх; ~ **времени** цаг өнгөрүүлэх.

ПРЕПЯ́ТСТВИ||Е саад тотгор, барцад; **чинить ~я** саад учруулах; **служить ~ем** тотгор болох.

ПРЕПЯ́ТСТВОВАТЬ саад хийх, тотгор болох, барцад учруулах.

ПРЕРВА́ТЬ,

ПРЕРЫВА́ТЬ 1. зогсоох, огцом зогсоох, завсарлуулах, таслах; ~ **работу** ажлыг завсарлуулах; ~ **молчание** дуугүй байхыг таслах, дуугүй байтал дуугарах; 2. үгийг таслах, завсраар нь асуух (хэлэх); ~ **учителя вопросом** багшийн үгийн завсраар асуух.

ПРЕРВА́||ТЬСЯ зогсох, тасрах, тасалдах, завсарлагдах; **разговор ~лся** яриа тасрав.

ПРЕРЕКА́НИ||Е зөрөлдөх, хэл ам гаргах; **выступить в ~я** үг зөрөлдөх.

ПРЕРЕКАТЬСЯ үг зөрөлдөх, хэл ам гаргах.

ПРЕРОГАТИ́ВА онцгой эрх; ~ **власти** засаг захиргааны онцгой эрх.

ПРЕРЫВА́ТЕЛЬ таслуур.

ПРЕРЫ́ВИСТ||ЫЙ тасалданг, сүйлхлэх; **~ое дыхание** тасалдан амьсгалах.

ПРЕСЕКА́ТЬ,

ПРЕСЕ́ЧЬ үгүй хийх, тас огтлох, тас цохих, эрс зогсоох, арилгах; ~ **зло в корне** муу явдлыг үндсээр нь үгүй хийх.

ПРЕСЕЧЕ́НИ||Е эрс зогсоох, тас огтлох, тас цохих, арилгах, үгүй хийх; **меры ~я** эрс зогсоох арга хэмжээ.

ПРЕСЛЕ́ДОВАНИЕ 1. мөрдөх, мөрдөн хөөх, мөшгөх, нэхэх; ~ **врага** дайсныг мөрдөн хөөх; 2. хяхах, хавчих, хөнөөх, отох.

ПРЕСЛЕ́ДОВАТЕЛЬ 1. мөрдөгч, нэхэгч, хөөгч; 2. хяхагч, хөнөөгч, отогч.

ПРЕСЛЕ́ДОВАТЬ 1. мөрдөх, мөрдөн хөөх, мөшгөх, нэхэх; ~ **зверя** араатныг мөрдөн хөөх; 2. отох, хяхах, хөнөөх.3. цөхөөх, илээх, сэтгэл зовоох, амар заяа үзүүлэхгүй; **его преследуют воспоминания** элдэв дурсамж сэтгэлий нь зовооно; 4. хөөцөлдөх.

ПРЕСЛЕ́ДОВАТЬСЯ 1. мөрдөгдөх, мөшгөгдөх, мөрдүүлэх; 2. отуулах, хяхагдах; 3. хөөцөлдөх.

ПРЕСЛОВУ́ТЫЙ улигт, өнөөх улигт, цуутай, муу цуутай.

ПРЕСМЫКА́ТЕЛЬСТВО 1. мөлхөх, гулгаж явах, хэвлээр явах; 2. бялдуучилж мөлхөх, борив бохилзох, гар газарт хөл хөсөрт тавих.

ПРЕСМЫКА́ТЬСЯ 1. хэвлээр явах, мөлхөх, гулгаж явах; 2. бялдуучилж мөлхөх, хөл хөсөрт гар газарт тавих, бохилзох.

ПРЕСМЫКА́ЮЩИЕСЯ хэвлээр явагчид, мөлхөө амьтад, гүвгэнэгчид.

ПРЕСНОВО́ДН||ЫЙ цэнгэг усны, давсгүй усны; **~ые рыбы** цэнгэг усны загас.

ПРЕ́СН||ЫЙ 1. цэнгэг, ариг; **~ая вода** цэнгэг ус; 2. заваан улбагар; 3. сонирхолгүй, бүлбэгэр; **~ые рассказы** сонирхолгүй өгүүллэг.

ПРЕСПОКО́ЙНЫЙ 1. ав ажиггүй; 2. амгалан номхон, амар жимэр.

ПРЕСС 1. шахуурга, шахуур; **вертикальный ~** босоо шахуурга; 2. хүнд юм; **положить что-либо под ~** юмыг хүнд юман дор дарах.

ПРЕ́СС||А хэвлэл сонин сэтгүүл, тогтмол хэвлэл, хугацаат хэвлэл; **следить за ~ой** сонин сэтгүүл ажиж (уншиж) байх.

ПРЕСС-БЮРО́ хэвлэлийн товчоо, мэдээлэх товчоо.

ПРЕСС-КОНФЕРЕ́НЦИЯ хэвлэлийн бага хурал.
ПРЕССО́ВАНН||ЫЙ багалсан, шахмал; **~ое сено** багласан өвс.
ПРЕССОВА́ТЬ баглах, шахах, дарагшуулах.
ПРЕССО́ВКА баглах, шахах.
ПРЕСС-ПАПЬЕ́ бэх шингээгч, бэх уулгуур, цаас дарлуур.
ПРЕСС-СЛУ́ЖБА хэвлэл мэдээллийн алба.
ПРЕСС-ЦЕНТР хэвлэл мэдээллийн төв.
ПРЕСТАВЛЕ́НИЕ юүтгэх; **свето~** галав юүлэх.
ПРЕСТАРЕ́ЛЫЙ өвгөн, өндөр настай, өтөлсөн.
ПРЕСТИ́Ж алдар нэр, нэр хүнд; **~ власти** засгийн нэр хүнд.
ПРЕСТО́Л хаан ширээ, ширээ; **выступить на ~** хаан ширээнд суух; **свергнуть с ~а** ширээнээс шилжүүлэх; **наследник ~а** хаан ширээ залгамжлагч.
ПРЕСТУПИ́ТЬ зөрчих, гажуудуулах; **~ закон** хууль зөрчих.
ПРЕСТУПЛЕ́НИ||Е ялт хэрэг, гэмт хэрэг; **совершить ~** ялт хэрэг хийх; **поймать на месте ~я** гэмт хэргийг газар дээр нь барих.
ПРЕСТУ́ПНИК ялтан, хэрэгтэн.
ПРЕСТУ́ПНИЦА ялтан эмэгтэй, хэрэгтэн эмэгтэй.
ПРЕСТУ́ПНОСТЬ ялт хэрэг, ялт хэрэг үйлдэх явдал, гэмт хэрэг.
ПРЕСТУ́ПН||ЫЙ 1. ялт, гэмт; **~ое действие** ялт хэрэг; 2. ялтан, хэрэгтэн
ПРЕСЫ́ТИТЬСЯ,
ПРЕСЫЩА́ТЬСЯ цадаж ханах, цатгалдах, өегших бялуурах; **~ развлечениями** цадаж ханатлаа цэнгэх.
ПРЕСЫЩЕ́НИЕ цадаж ханах, цатгалдах, өегших, бялуурах, шалай болох, шалиарах.
ПРЕСЫЩЕННЫЙ цатгалан, цатгалдсан, өегшсөн, шалиарсан.
ПРЕТВОРЕ́НИЕ биелүүлэх, хэрэгжүүлэх; **~ в жизнь** амьдралд хэрэгжүүлэх.
ПРЕТВОРИ́ТЬ биелүүлэх, хэрэгжүүлэх.
ПРЕТВОРИ́ТЬСЯ биелэх, биелэгдэх, хэрэгжих.
ПРЕТВОРЯ́ТЬ биелүүлэх, хэрэгжүүлэх.
ПРЕТВОРЯ́ТЬСЯ биелэх, биелэгдэх, хэрэгжих.
ПРЕТЕНДЕ́НТ эрмэлзэгч, өрсөлдөгч, горилогч; **~ на престол** хаан ширээг эрмэлзэгч.
ПРЕТЕНДОВА́ТЬ 1. эрмэлзэх, горилох, өрсөлдөх; 2. гэгдэхийг оролдох; **~ на остроумие** хурц ухаантай гэгдэхийг оролдох.
ПРЕТЕ́НЗИ||Я 1. эрмэлзэл, эрмэлзэх, горилох, горилол, санаархал; **~ на наследство** өв горилох; 2. гомдол; **быть в ~и** гомдолтой байх; 3. их санаархал, дээгүүр санаа; **человек с ~ями** дээгүүр санаатай хүн.
ПРЕТЕНЦИО́ЗНЫЙ 1. дээгүүр санаатай, их санаархуу; 2. маягтай.
ПРЕТЕРПЕВА́ТЬ 1. үзэх, амсах, туулах; **~ лишения** гачигдал үзэх; 2. орох, өртөх, ирэх.
ПРЕТЕРПЕ́ТЬ 1. үзэх, амсах, туулах; **~ лишения** гачигдал үзэх; 2. орох, өртөх, ирэх.
ПРЕТИ́ТЬ ой гутах, дургүй хүргэх; лесть претит саймсрах явдлаас ой гутна.
ПРЕТКНОВЕ́НИ||Е камень ~я бүдрүүлэх чулуу хэцүү даваа, даваадах газар.
ПРЕТЬ 1. үжих, ялзрах, нэхших; 2. чийгтэх, чийг даацлах, норох, хөлрөх **земля весной преет** хавар газар чийгтэж байна; 3. үлтрэх,
ПРЕУВЕЛИЧЕ́НИ||Е дэвүүлэх, нэмэрлэх, ихэсгэх хөөргөх; **говоря без ~й** нэмэрлэхгүй хэлэхэд.
ПРЕУВЕЛИ́ЧИВАТЬ 1. дэвүүлэх, нэмэрлэх; 2. хөөргөж ярих, дэгслэх.
ПРЕУВЕЛИ́ЧИТЬ 1. дэвүүлэх, нэмэрлэх, ихэсгэх, ихээр бодох, их гэж бодох; 2. хөөргөж ярих, дэгслэх, давуулж хэлэх; **он любит немножко ~** тэр жаахан хөөргөж ярих дуртай юм.
ПРЕУМЕНЬША́ТЬ,
ПРЕУМЕ́НЬШИТЬ бага гэж бодох, багаар бодох, чамлах; **~ трудности** бэрхшээлийг бага гэж бодох.
ПРЕУМЕНЬШЕ́НИЕ бага гэж бодох, багаар бодох, багасгах.
ПРЕУСПЕВА́ТЬ 1. амжилтыг олох; 2. завшаантай явах, зол завшаантай явах; **~ в жизни** амьдралдаа завшаантай явах.
ПРЕУСПЕ́ТЬ амжилтыг олох; **~ в науках** шинжлэх ухаанд амжилтыг олох.
ПРЕ́ФИКС угтвар; **~ глагола** үйл үгийн угтвар.
ПРЕЦЕДЕ́НТ анхны жишээ, үлгэрчлэх жишээ, урьд тохиолдсон зүйл.
ПРИ 1. дэргэд, ойр, хажууд; **сказать ~ свидетелях** гэрчийн дэргэд хэлэх; 2. өмнө; **~ всех** олны өмнө; 3. дэргэдэх; **столб ~ дороге** замын дэргэдэх шон; 4. үед; 5. -д; **~ свете лампы** чийдэнгийн гэрэлд; 6. -д, -даа; **~ встрече** уулзахдаа; 7. -д, байхад; **при жизни** амьдад нь, амьд байхад; 8. байх, явах; **иметь ~ себе** биедээ авч явах; **быть ~ оружии** зэвсгээ авч байх; 9. байвал, байтлаа боловч; **~ желании можно всего добиться** хүсэл байвал юуг ч бүтээж болно; **~ всех его достоинствах, он скучный человек** түүнд дориун тал олон байтлаа, тэр уйтгартай хүн; 10. болохоор, учраас, тул, **~ его знаниях он сможет это сделать** тэр тийм эрдэмтэй болохоор үүнийг хийж чадна; 11. -аар; **~ помощи друзей** найз нөхдийн тусламжаар; **~ этом тэгэхдээ; ~ всем том** хэдий тийм боловч, гэсэн ч.
ПРИБА́ВИТЬ,
ПРИБАВЛЯ́ТЬ 1. нэмэх **~ соли в суп** шөлөнд давс нэмэх; 2. нэмэгдүүлэх, ахиулах, түргэсгэх; **~ денег** мөнгө нэмэгдүүлэх; **~ шагу** алхаагаа түргэсгэх; 3. өргөтгөх, уртатгах; **~ в плечах** мөрийг өргөтгөх; 4. нэмэгдэх, хүндрэх, хүнд болох; **~ в весе** жин нэмэгдэх.
ПРИБА́В||ИТЬСЯ,
ПРИБАВ||ЛЯ́ТЬСЯ, 1. нэмэгдэх; **воды в реке ~илось** голын ус нэмэгдэв; 2, уртсах; **день ~ился** өдөр уртсав.
ПРИБА́ВК||А нэмэгдэл, нэмэлт, нэмэх; **получить ~у** нэмэгдэл авах.
ПРИБАВЛЕ́НИЕ 1. нэмэх, нэмэгдэх; **~ воды** ус нэмэгдэх; **~ семейства** хүүхэд нэмэгдэх *(хүүхэд төрөх);* 2. нэмэлт, хавсралт.
ПРИБА́ВОЧН||ЫЙ нэмсэн, нэмүү; **~ая стоимость** нэмүү өртөг.
ПРИБАЛТИ́ЙСКИЙ Балтийн *(тэнгисийн)* орчны.
ПРИБАУ́ТКА наргианы үг, ёж, хууч үг; **говорить с ~ми** наргианы үг оруулан ярих,
ПРИБЕГА́||ТЬ гүйж ирэх, түрүүлж ирээд байх; **несколько раз ~л первым** хэдэн удаа түрүүлж ирээд байв.
ПРИБЕГА́ТЬ II 1. хэрэглэх; **~ к силе** хүч хэрэглэх; 2. гуйх, хандах; **~ к помощи** тусламж гуйх.
ПРИБЕ́ГНУТЬ 1. хэрэглэх, хэрэгтэй болох; **~ к оружию** зэвсэг хэрэглэх; 2. хандах, гуйх.
ПРИБЕДНЯ́ТЬСЯ эвэх, эвүүр зан гаргах, ядуу байдал гаргах, ядуугаа урдаа барих.
ПРИБЕ́ЖИЩЕ өмөг, өмөг түшиг, хоргодох газар; **последнее ~** эцсийн хоргодох газар.
ПРИБЕРЕГА́ТЬ нөөц, нөөцлөх, гамнах.
ПРИБЕРЕ́ЧЬ нөөц, нөөцлөх, гамнах.
ПРИБИВА́ТЬ 1. хадах, 2, дайрах, дарагдах; 3. шахагдах, туугдаж очих, тууж аваачих, очиж шахагдах.
ПРИБИ́ТЬ 1. хадах, **~ картину к стене** хананд зураг хадах; 2. дайрах, дарагдах; 3. шахагдах, туугдаж очих, тууж аваачих, очиж шахагдах.

ПРИБИРА́ТЬ юм хумаа эмхлэх, цэгцлэх, засацгаах, цэвэрлэх.
ПРИБИ́ТЬ 1. хадах; 2. дарах, дарагдах; 3. шахагдах, туугдаж очих.
ПРИБЛИЖА́ТЬ 1. ойртуулах, дөтлүүлэх; 2. наашлуулах, дөхүүлэх.
ПРИБЛИЖА́ТЬСЯ 1. ойртох, дөтлөх, айсуй; 2. наашлах, дөхөх.
ПРИБЛИЖЕ́НИЕ ойртох, дөтлөх, айсуй; ~ **поезда** галт тэрэг айсуй; ~ **весны** хавар ойртох.
ПРИБЛИЖЁННЫЙ 1. дөт, хавьдуу, ойролцоо; ~ **результат вычислений** тооцоолсон ойролцоо дүн.
ПРИБЛИ́ЖЕНН||ЫЙ шадар, шадар хүн; **~ые царя** хааны шадар хүмүүс.
ПРИБЛИЗИ́ТЕЛЬНО 1. бараглаж, барагцаалж, бараг.
ПРИБЛИЗИ́ТЕЛЬН||ЫЙ бараг, барагцасан, багцаалсан; ~ **итог** барагцасан дүн; **~ая сумма** барагцаалсан нийлбэр.
ПРИБЛИ́ЗИТЬ 1. ойртуулах, дөтлүүлэх; 2. наашлуулах; ~ **срок отъезда** явах хугацааг наашлуулах.
ПРИБЛИ́ЗИТЬСЯ 1. ойртох, дөтлөх, айсуй, ~ **к окну** цонхонд ойртох.
ПРИБО́Й дэлсээ, дэлсгээ, долгионы цохилго; **морской** ~ тэнгисийн дэлсгээ.
ПРИБО́Р 1. багаж; **измерительный** ~ хэмжүүрийн багаж; 2. хэрэгсэл, хэрэглэл; **письменный** ~ бичгийн хэрэгсэл; **бритвенный** ~ сахал хусах хэрэгсэл; **столовый** ~ хоолны хэрэгсэл (хутга, сэрээ, халбага).
ПРИБОРОСТРОЕ́НИЕ багаж үйлдвэрлэх.
ПРИБРА́ТЬ юм хумаа эмхлэх, цэгцлэх, засацгаах, цэвэрлэх; ~ **в доме** гэртээ юм хумаа цэгцлэх; ~ **к рукам** гартаа атгаж авах.
ПРИБРЕ́ЖН||ЫЙ эргийн, эрэг хавийн; **~ая полоса** эрэг хавийн зурвас газар.
ПРИБЫ́ВАТЬ 1. ирэх,хүрч ирэх, ирж буух; 2. нэмэгдэх, нэмэх.
ПРИ́БЫЛЬ 1. ашиг, хонжоо; **чистая** ~ цэвэр ашиг; **приносить** ~ хонжоо олох; 2. олшрох, нэмэгдэх.
ПРИ́БЫЛЬН||ЫЙ ашигтай, хонжоотой; **~ое хозяйство** ашигтай аж ахуй.
ПРИБЫ́ТИЕ ирэлт, ирэх, хүрч ирэх.
ПРИБЫ́||ТЬ 1. ирэх, ирж буух; **поезд ~л** галт тэрэг хүрч ирэв; 2. нэмэх, нэмэгдэх; **вода в реке ~ла** голын ус нэмэгдэв.
ПРИВА́Л 1. үдлэх, амралт, зогсолт, бууж амрах; **устроить** ~ үдлэх; 2. үдлэх газар, буух газар.
ПРИВА́ЛИВАТЬ 1. налуулах, налуулж тавих, түшүүлэх; 2. ирж зогсох, тулж ирэх; 3. дайрах, овоорох.
ПРИВАЛИ́||ТЬ 1. налуулах, налуулж тавих, түшүүлэх; 2. ирж зогсох, тулж ирэх; 3. дайрах, овоорох; **счастье ему ~ло** түүний аз дайрчээ.
ПРИВАЛИ́ТЬСЯ налах, түших, налж ойчих.
ПРИВАРИ́ТЬ гагнах, ширээх; ~ **рукоятку к ковшу** шанаганд бариул гагнах.
ПРИВЕДЕ́НИЕ 1. гаргах, ~ **доказательств** нотолгоо гаргах; ~ **примера** жишээ гаргах; 2. оруулах, болгох, гүйцэтгэх; ~ **дробей к общему знаменателю** бутархай тоог ерөнхий хуваарьтай болгох; ~ **в порядок** журамтай болгох; ~ **в исполнение** гүйцэтгэх; ~ **в действие** хөдөлгөөнд оруулах (явуулах); 3. өргүүлэх; ~ **к присяге** тангараг өргүүлэх.
ПРИВЕЗТИ́ авчрах, хүргэж ирэх; ~ **письмо** захидал авчрах; ~ **товаров** бараа авчрах.
ПРИВЕРЕ́ДЛИВЫЙ цамаан, голомтгой; ~ **ребенок** цамаан хүүхэд.
ПРИВЕРЕ́ДНИК цамаан хүн, голомтгой хүн.
ПРИВЕРЕ́ДНИЦА цамаан эмэгтэй, голомтгой эмэгтэй.
ПРИВЕРЕ́ДНИЧАТЬ цамаархах, тумархах.
ПРИВЕ́РЖЕНЕЦ баримтлагч, дагагч, тал баригч, сүслэгч.
ПРИВЕ́РЖЕННОСТЬ дагах, баримтлах, тал барих, сүслэх.
ПРИВЕ́РЖЕННЫЙ баримталдаг, дагадаг, тал барьдаг, сүсэлдэг; **человек, ~ наукам** шинжлэх ухааны тал баримталдаг хүн.
ПРИВЕРНУ́ТЬ 1. шүрэвдэх, эрэгдэх; ~ **гайку** эрэг эрэгдэх; 2. доош нь мушгих, эргүүлж багасгах; ~ **фитиль** дэнгийн голыг эргүүлж багасгах.
ПРИВЕРТЕ́ТЬ шүрэвдэх, эрэгдэх.
ПРИВЁРТЫВАТЬ шүрэвдэх, эрэгдэх.
ПРИВЕ́С өсөлтийн жин, хүндрэх жингийн нэмэгдэл.
ПРИВЕ́СИТЬ унжуулж хадах, өлгөх, зүүх, дүүжлэх;
ПРИВЕСТИ́ 1. авчрах, хөтөлж ацрах; ~ **детей** домой хүүхдийг гэрт нь авчрах; 2. хүргэх; ~ **к победе** ялалтанд хүргэх; 3. оруулах, болгох; ~ **в чувство** мэдээ оруулах; ~ **в порядок** цэгцтэй болгох; ~ **в негодность** хэрэггүй болгох, хэрэглэж болохгүй болгох; 4. гүйцэтгэх, ёсоор гүйцэтгэх, биелүүлэх; ~ **приговор в исполнение** шийтгэх тогтоолыг ёсоор гүйцэтгэх; 5. татах, гаргах; ~ **цитату** иш татах; ~ **пример** жишээ гаргах.
ПРИВЕ́Т мэнд, баяр, амрыг эрэх; **передайте ~ всем вашим** гэрийхэндээ мэнд хүргээрэй; **горячий** ~ халуун баярыг хүргэе.
ПРИВЕ́ТЛИВОСТЬ сайхан ааш, элэгсэг, эелдэг зантай;
ПРИВЕТЛИВЫЙ ~ человек сайхан ааштай хүн.
ПРИВЕ́ТСТВЕНН||ЫЙ баяр хүргэх, баяр хүргэж хэлэх; **~ая речь** баяр хүргэж хэлэх үг.
ПРИВЕ́ТСТВИ||Е баярыг хүргэх, мэндлэх, мэндчилэх, **обратиться к кому-либо с ~ем** хүнд баяр хүргэж үг хэлэх; **обменяться ~ями** харилцан мэндлэх, харилцан баяр хүргэх.
ПРИВЕ́ТСТВОВАТЬ 1. баяр хүргэх, мэндлэх, мэндчилэх; 2. сайшаах, сайшаан зөвшөөрөх; 3. ёслох, ёсолж мэндлэх.
ПРИВЕ́ШИВАТЬ унжуулж хадах, өлгөх, зүүх, дүүжлэх.
ПРИВИВА́ТЬ 1. тарих, тарилга хийх; тарьц хийх; ~ **оспу** цэцэг өвчний тарилга хийх; 2. дуртай болгох, сургах, заншилтай болгох; ~ **вкус к музыке** хөгжимд дуртай болгох; 3. залгаж ургуулах.
ПРИВИ́ВКА 1. тарих, тарилга хийх; ~ **от оспы** цэцгийн тарилга хийх; 2. тарилгын эм; 3. залгаж ургуулах.
ПРИВИДЕ́НИЕ боохолдой, хоосон сүг, сүүмгэр үзэгдэл.
ПРИВИ́ДЕТЬСЯ үзэгдэх, үзэгдэх шиг болгох.
ПРИВИЛЕГИРО́ВАННЫЙ ямбатай, онцгой эрхтэй, тусгай эрхтэй, эрхшээлт; **~ое положение** онцгой эрхтэй байдал.
ПРИВИЛЕ́ГИЯ онцгой эрх, тусгай эрх, тусгай эрх ямба, эрхшээл, эрх дарх.
ПРИВИНТИ́ТЬ шүрэвдэх, эрэгдэх, эрэг чангалах.
ПРИВИ́НЧИВАТЬ шүрэвдэх, эрэгдэх, эрэг чангалах.
ПРИВИРА́ТЬ дэгс ярих, худал ярих.
ПРИВИ́ТЬ тарих, тарилга хийх; 2. дуртай болгох, сургах, заншилтай болгох; ~ **любовь к чтению** ном унших дуртай болгох; 3. залгаж ургуулах.
ПРИВИ́ТЬСЯ 1. тарилга туурах, тариа боловсрох; 2. дуртай болох, заншилтай болох; 3. залгагдаж ургах.
ПРИ́ВКУС амт, ондоо амт, гаж буруу амт; ~ **соды в тесте** зуурсан гурилд хужрын амт байна.
ПРИВЛЕКА́ТЕЛЬН||ЫЙ сэтгэл татах, сүндлэг, үзэсгэлэнтэй, аятайхан; **~ая внешность** аятайхан царай.
ПРИВЛЕКА́ТЬ 1. дур татах, анхаарал татах, сүндлэх; 2. оролцуулах; 3. хүлээлгэх.
ПРИВЛЕКА́ТЬСЯ оролцох, татагдах; ~ **к ответственности** хариуцлагад татагдах.
ПРИВЛЕЧЕ́НИЕ оролцуулах, татах; ~ **к ответственности** хариуцлагад татах.

ПРИВЛЕ́ЧЬ 1. дур татах, татах, сонирхогдох, ~ **внимание** анхаарал татах, 2. оролцуулах, ~ **молодёжь к общественной работе** залуучуудийг олон нийтийн ажилд оролцуулах, 3. татах, хүлээлгэх, ~ **к ответственности** хариуцлагад татах.

ПРИВНЕСТИ́,

ПРИВНОСИ́ТЬ оруулах, нэмэлт оруулах.

ПРИВО́Д 1. авчрах, ацрах, 2. дамжлага, дамжуур, татуурга.

ПРИВОДИ́ТЬ 1. авчрах ацрах, хөтөлж авчрах, ~ **ребёнка** домой хүүхэд гэрт нь ацрах, ~ **к победе** ялалтад хүргэх 3. оруулах, болгох, ~ **в порядок** цэгцтэй болгох 4. гүйцэтгэх. ёсоор гүйцэтгэх, биелүүлэх, ~ **в исполнение** ёсоор гүйцэтгэх,5. татах, гаргах, ~ **пример** учрыг гаргах, жишээ татах.

ПРИВОДИ́ТЬСЯ I завшаан тохиолдох

ПРИВОДИ́ТЬСЯ II болох, татах.

ПРИВОДНО́Й дамжуулгын, дамжуурын, татуургын,~ **ремень** дамжуургын сур

ПРИВО́З 1. авчрах, нэвтрүүлэх оруулах, ~ **товаров** бараа авчрах 2. авчирсан бараа,нэвтрүүлэн оруулсан бараа.

ПРИВОЗИ́ТЬ авчран, авчрах, хүргэж ирэх.

ПРИВОЗНО́Й авчирсан, ацарсан.

ПРИВОЛОЧИ́ТЬ,

ПРИВОЛО́ЧЬ чирч авчрах, чирч оруулах.

ПРИВО́ЛЬЕ 1. уудам газар, задгай газар, өргөн талбай, дайд,2. чөлөөтэй, бүрэн чөлөөтэй, сул чөлөө, дураараа туйлах, **жить в** ~ бүрэн чөлөөтэй амьдрах, **тут детям** ~ энд хүүхэд дураараа туйлна.

ПРИВО́ЛЬН||ЫЙ чөлөөтэй, бүрэн чөлөөтэй, сул чөлөөтэй, илдэн, ~**ое житьё** чөлөөтэй аж төрөх.

ПРИВОРА́ЖИВАТЬ,

ПРИВОРОЖИ́ТЬ увдислах, увдисаар татах, илбэдэж дурлуулах, ховслох.

ПРИВРАТНИК хаалгач, үүдний манаач гонир.

ПРИВРА́ТЬ дэгс ярих, нэмэрлэж хэлэх,худал хэлэх, ~ **для красного словца** үгээ гоёх гээд дэгс ярих.

ПРИВСКА́КИВАТЬ,

ПРИВСКОЧИ́ТЬ дав хийж босох, босон харайх, ~ **от неожиданности** гэнэт тулгараад дав хийж босох.

ПРИВСТАВА́ТЬ,

ПРИВСТА́ТЬ өндөс хийх, өндийх.

ПРИВХОДЯ́Щ||ИЙ нэмэгдсэн, ондоотэгээс нэмэгдсэн, хөндлөнгөөс орсон, ~**ее обстоятельство** нэмэгдсэн нөхцөл.

ПРИВЫКА́ТЬ,

ПРИВЫ́КНУТЬ 1. занших, дадах, сурах, 2. дасах, ижил дасал болох, дамы нь авах, **привык к товарищам** нөхдөөс дасах

ПРИВЫ́ЧК||А заншил, зуршил, **войти в** ~**у** заншилд орох, зуршил болох, **по** ~**е** заншлаараа

ПРИВЫ́ЧН||ЫЙ 1. заншсан, дадсан, сурамгай, ~ **образ жизни** амьдралын заншсан байдал, ~**ая работа** дадсан ажил 2. дассан, ерийн, ~**ое явление** ерийн үзэгдэл.

ПРИВЯ́ЗАННОСТЬ дасал болох, дотно байх, хайртай байх, **она — его старая** ~ тэр хүүхэн, түүний хуучин дотнын хүн, **иметь к кому-либо** ~ хүнд хайртай байх.

ПРИВЯЗА́ТЬ,

ПРИВЯ́ЗЫВАТЬ 1. уях, ~ **коня** морь уях, ~ **верёвку к забору** хашаанд дээс уях, 2. дасгах, хайртай болгох, ~ **к себе ребёнка** хүүхдийг биедээ дасгах.

ПРИВЯЗА́ТЬСЯ,

ПРИВЯ́ЗЫВАТЬСЯ 1. уягдах, 2. дасах, хайртай болох, ~ **к товарищам** нөхдөөс дасах 3. зэрэх, орооцолдох, хоргоох, ~ **с вопросами** асуултаар зэрэх.

ПРИВЯЗН||О́Й уяатай, уядаг, ~**ые лыжи** уядаг цана.

ПРИВЯ́ЗЧИВОСТЬ 1. дасамтгай, 2. зэрэх, орооцолдох, хоргоох.

ПРИВЯ́ЗЧИВЫЙ 1. дасамтгай; 2. зэрэгд салдаггүй, хоргоодог, ~ **посетитель** хоргоодог хүн.

ПРИВЯ́ЗЫВАТЬ 1. уях, 2. дасгах, хайртай болгох.

ПРИВЯ́ЗЫВАТЬСЯ 1. уягдах, хайртай болох, 3. зэрэх, орооцолдох, хоргоох.

ПРИ́ВЯЗ||Ь уяа, **держать собаку на** ~**и** нохойг уяатай байлгах.

ПРИГА́РЬ түлэнхий амт, **суп с** ~**ю** түлэнхий амттай шөл.

ПРИГВОЖДА́ТЬ хадах.

ПРИГВОЗДИ́ТЬ 1. хадах, ~ **к позорному столбу** жигшлийн багананд хадах, 2. хөдлөхгүй байлгах, гөлрүүлэх, ~ **кого-нибудь гневным взглядом** хүнийг хилэнт харцаар харж гөлрүүлэх.

ПРИГИБА́ТЬ бөхийлгөх, тонгойлгох.

ПРИГИБА́ТЬСЯ бөхийх, тонгойх.

ПРИГЛА́ДИТЬ,

ПРИГЛА́ЖИВАТЬ илэх, илбэх, илж засах, ~ **волосы** үсээ илэх.

ПРИГЛАША́ТЬ урих,залах; ~ **на службу** албан хаахыг урих, албан ажилд урих.

ПРИГЛАШЕ́НИ||Е урилга, урих, **по** ~**ю** урилгаар, **получить** ~ урилга хүлээн авах, **разослать** ~**я** урилга тараах

ПРИГЛУША́ТЬ,

ПРИГЛУШИТЬ намжаах, бүдэгрүүлэх, бүдэгшүүлэх, багасгах, ~ **звук** дуу чимээг намжаах.

ПРИГЛЯДЕ́ТЬ 1. харах, харгалзах, харж байх, ~ **за детьми** хүүхэд харах, 2. хайх, эрэх, эрж олох, ~ **себе шубу** өвртөө өвлийн дээл хайх.

ПРИГЛЯ́ДЫВАТЬ 1. харах, харгалзах, харж байх, 2. хайх, эрэх, эрж олох.

ПРИГЛЯДЕ́ТЬСЯ 1. ажиглах, ажиглаж харах, ажих,2. дасах, ~ **к темноте** харанхуйд нүдээ дасгаж харах, харанхуйд нүд дасах.

ПРИГЛЯ́ДЫВАТЬСЯ 1. ажиглах, ажиглаж харах, ажих,2. дасах

ПРИГЛЯНУ́||ТЬСЯ нүдэнд дулаан үзэгдэх, аятайхан харагдах, **вещь ему** ~**лась** юм түүнд аятайхан харагдав.

ПРИГНА́ТЬ I тууж ирэх; ~ **скот домой** малыг гэртээ тууж ирэх.

ПРИГНА́ТЬ II тааруулах; ~ **оконную раму** цонхны жаазыг тааруулах.

ПРИГНУ́ТЬ бөхийлгөх, тонгойлгох, ~ **ветку к земле** мөчрийг газарт бөхийлгөх.

ПРИГНУ́||ТЬСЯ тонгойх **ветка** ~**лась к земле** мөчир газарт бөхийв.

ПРИГОВА́РИВА||ТЬ 1. хамт үглэх, хэлж байх, **колотит и** ~**ет** цохихын хамт үглэж байна, үглээд л цохиод байв; 2. шийтгэх, шийтгэхээр тогтоох.

ПРИГОВО́Р тогтоол шийтгэх, шийтгэх тогтоол, **вынести** ~ шийтгэх тогтоол гаргах, **приводить** ~ **в исполнение** тогтоол ёсоор гүйцэтгэх.

ПРИГОВО́РИТЬ ял оногдуулах, шийтгэх, ~ **к тюремному заключению** шоронд хорихоор шийтгэх.

ПРИГОДИ́||ТЬСЯ хэрэг болох, хэрэгтэй болох, **тебе это** ~**тся** энэ чамд хэрэг болно.

ПРИГО́ДНОСТЬ хэрэг болох, болохуйц, тэнцэх, **показать свою** ~ **к работе** ажилд тэнцэхээ үзүүлэх.

ПРИГО́ДНЫЙ болохуйц, хэрэг болмоор, болох, тэнцэх, танагтай, ~ **к употреблению** хэрэглэж болохуйц.

ПРИГО́ЖИЙ 1. аруухан, гуалиг; ~ **парень** аруухан хөвүүн 2. сайхан, цэлмэг ~ **денёк выдался** сайхан өдөр боллоо.

ПРИГОЛУ́БИТЬ энхрийлэх, таалах.

ПРИГО́Н 1. туух, тууж ирэх; ~ **скота** мал туух 2. малын хашаа, хороо.

ПРИГО́НКА тааруулах; ~ **седел лошадям** эмээлийг моринд тааруулах.

ПРИГОНЯ́ТЬ тааруулах, ~ **крышку к ящику** хавхгийг хайрцагт тааруулах.

ПРИГОР||А́ТЬ,

ПРИГОР||Е́ТЬ 1. түлэгдэх, хайрагдах; **мясо ~ело** мах түлэгдэв 2. хусамтах, түлэнхий болох, хиншүү үнэртэх; **молоко ~ело** сүү хусамтав.

ПРИГОРЕ́Л||ЫЙ түлэнхий, түлэнхий амттай; **~ое молоко** түлэнхий амттай сүү.

ПРИ́ГОРОД хотын дэргэдэх гацаа, дүүрэг, хотын зах, хотын хаяа.

ПРИ́ГОРОДН||ЫЙ хотын захын, хотын хаяа, хот орчмын, хот зуур, **~ая местность** хотын хаяа газар, ~ **поезд** хот зуур явах галт тэрэг.

ПРИГО́РОК дов, довцог, болдог.

ПРИГОРШНЯ́ атга, ~ **ягод** атга жимсгэнэ, **полными ~ми** атга атгаар, бөөм цөөмөөр

ПРИГОРЮ́НИТЬСЯ гуних, гуниглах.

ПРИГОТА́ВЛИВАТЬ бэлдэх, бэлтгэх, зэхэх, төхөөрөх, базаах.

ПРИГОТО́ВИТЬ бэлдэх, бэлтгэх, зэхэх төхөөрөх, базаах, ~ **рукопись к набору** гар бичмэлийг өрөлтөнд бэлдэх, ~ **обед** үдийн хоол бэлтгэх, ~ **вещи в дорогу** замд явах юмаа төхөөрөх.

ПРИГОТОВЛЯ́ТЬ бэлдэх, бэлтгэх, зэхэх төхөөрөх, базаах.

ПРИГОТА́ВЛИВАТЬСЯ,

ПРИГОТОВЛЯ́ТЬСЯ бэлдэх, зэхэх, ~ **к отъезду** мордоход бэлдэх, ~ **к докладу** илтгэл бэлдэх.

ПРИГОТОВЛЕ́НИЕ бэлдэх, бэлтгэх, бэлтгэл, төхөөрөх, базаах, ~ **уроков** хичээлээ бэлдэх; ~ **к отъезду** явахад бэлтгэх.

ПРИГРЕВА́ТЬ зэх, дулаацуулах

ПРИГРЕ́||ТЬ 1. зэх, дулаацуулах, **солнце ~ло землю** нар газрыг зэж байв,2. асрах, тэжээх, ~ **сироту** өнчин хүүхдийг асрах.

ПРИГРОЗИ́ТЬ занах; ~ **наказанием** шийтгэнэ гэж занах.

ПРИГУБИ́||ТЬ амсах, уруулаа хүргэх; **не выпил, а только ~л рюмку** хундагатайг нь уугаагүй, зөвхөн уруулаа хүргэсэн.

ПРИГУ́ЛЬНЫЙ ~ **скот** алдуул мал.

ПРИДАВА́ТЬ 1. нэмж олгох, нэмж өгөх 2. нэмэх, нэмэгдүүлэх, төрүүлэх, оруулах 3. болгох, гаргах, 4. ойшоож үзэх, санах.

ПРИДА́ВЛИВАТЬ,

ПРИДАВИ́ТЬ дарах, хавчих, хавчуулах; **дверь придавила** палец хаалганд хуруугаа хавчуулав.

ПРИДА́НИЕ болгох, олгох, оруулах; ~ **законной силы постановлению** тогтоолыг хуулийн чанартай болгох.

ПРИДА́НОЕ инж; **за ней дали большое** ~ хүүхэндээ их инж өгөв.

ПРИДА́ТОК дагалт, дагуур, хавсрага; ~ **к машине** машины хавсрага, ~ **яичка** бөөсгийн дагуур, ~ **мозга** өнчин тархи.

ПРИДА́ТОЧН||ЫЙ 1. хавсарсан, гишүүн, **~ое предложение** хавсарсан өгүүлбэр, гишүүн өгүүлбэр, 2. дагуур, дагалт, хавсралт, **~ая половая железа** бэлгийн дагуур булчирхай.

ПРИДА́||ТЬ 1. нэмж олгох, нэмэгдүүлж өгөх; **к прежним деньгам ~л ещё триста рублей** урьдахь мөнгөн дээрээ дахин гурван зуун рубль нэмж олгов, 2. нэмэх, нэмэгдүүлэх, төрүүлэх, оруулах, ~ **храбрости** зориг нэмэгдүүлэх, **любовь ~ёт ему бодрости и силы** янаг сэтгэл түүнд урамшил ба чадал оруулна; 3. болгох, гаргах; ~ **серьёзное выражение своему лицу** царайдаа их томоотой янз гаргах, ~ **законную форму документу** баримт бичгийг хууль ёсны хэлбэртэй болгох; 4. ойшоож үзэх, санах, тоох; **я не ~л этому никакого значения** үүнийг би утга чанартай юм гэж огт санасангүй, үүнийг би огт тоогоогүй юм; ~ **исключительное значение** хамгийн чухал гэж үзэх.

ПРИДА́Ч||А 1. нэмж олгох, ~ **отряду артиллерий** отрядад их буу нэмж олгох; 2. болгох; ~ **чему-нибудь большей устойчивости** юмыг тогтвортой болгох; 3. нэмэр; **в ~у** нэмэр болгож.

ПРИДВИГА́ТЬ,

ПРИДВИ́НУТЬ ойртуулах,түлхэж ойртуулах, дөтлүүлэх; ~ **стул к столу** сандлыг ширээнд ойртуулах.

ПРИДВИГА́ТЬСЯ ойртох, дөтлөх, ~ **к столу** ширээнд ойртох.

ПРИДВО́РН||ЫЙ 1. ордны, шадар, ~ **поэт** ордны шүлэгч; 2. ордныхон, ордны хүн, шадар бараа бологч; **царские ~ые хааны** ордныхон.

ПРИДЕ́ЛАТЬ хийх,тааруулах; ~ **ручку к корзинке** сагсанд бариул хийх, ~ **замки к дверям** хаалганд цоож хийх.

ПРИДЕРЖА́ТЬ,

ПРИДЕ́РЖИВАТЬ 1. барих, барьж байх, барьж зогсоох; ~ **вазу** ваарыг (унагахгүй) барьж байх, ваарыг түшиж байх; 2. татах, зогсоох; ~ **лошадь** морины жолоог татах,3. нөөх, нөөж байх; ~ **деньги** мөнгөө нөөж байх; ~ **язык** амаа татах, дугай байх.

ПРИДЕ́РЖИВАТЬСЯ 1. барих, барьж явах; ~ **за перила лестницы** шатны хайснаас барьж явах; 2. дагаж явах, барьж явах; ~ **правой стороны** баруун талаа дагаж явах; 3. баримталж явах, баримтлах; ~ **твёрдых принципов** хатуу зарчмыг баримталж явах; ~ **правил уличного движения** гудамжны хөдөлгөөний дүрмийг баримтлах.

ПРИДИ́РА өө эрэгч.

ПРИДИРА́ТЬСЯ өө сэв ирэх, гоочлох, ~ **к каждому слову** үг бүрд өө сэв эрэх.

ПРИДИ́РКА өө сэв эрэх, гоочлох.

ПРИДИ́РЧИВОСТЬ өө сэв эрэх, гоочлох.

ПРИДИ́РЧИВЫЙ өө сэв эрдэг, гоочилдог, ~ **человек** өө сэв эрдэг хүн

ПРИДОРО́ЖН||ЫЙ зам орчмын, зам хавийн, замын хажуу дахь; **~ая канава** замын хажуу дахь суваг.

ПРИДРА́ТЬСЯ өө сэв эрэх, гоочлох; ~ **к пустяку** ялигүй юманд өө сэв эрэх, ~ **к случаю** юм л болбол гоочлох.

ПРИДТИ́ 1. ирэх, ~ **домой** гэртээ ирэх; 2. болох; **пришла пора учиться** суралцах цаг боллоо; 3. хүрэх; ~ **к выводу** дүгнэлтэд хүрэх; 4. орох; ~ **в чувство** ухаан орох; ~ **в голову** толгойд орох, санаанд орж ирэх.

ПРИДУ́МАТЬ санаачлах, бодож олох, сүвэгчлэх, арга сүвэгчлэх

ПРИДУ́МЫВАТЬ санаачлах, бодож олох, сүвэгчлэх, арга сүвэгчлэх; ~ **развлечение для детей** хүүхэд зугаацуулах юм санаачлах; ~ **выход из такого положения** тийм байдлаас мултрах арга сүвэгчлэх.

ПРИДУРКОВА́ТЫЙ донгио, ухаан муутай, мангуу.

ПРИ́ДУРЬ 1. уймар, уймраа, үсэд; **человек с ~ю** уймар хүн; 2. ярдаг, яхир; **лошадь с ~ю** ярдаг морь, аалтай морь.

ПРИДУШИ́ТЬ багалзуурдан алах, багалзуурдах, бүгтрүүлж алах, бүтээх; ~ **цыплёнка** зулзаган тахиаг бүгтрүүлж алах, тахианы дэгдээхэйг алах.

ПРИДЫХА́НИЕ хийн түрлэг; **произносить с ~м** хийн түрлэгтэй дуудах.

ПРИДЫХА́ТЕЛЬНЫЙ хийн түрлэгтэй; ~ **согласный** хийн түрлэгтэй гийгүүлэгч авиа.

ПРИДА́ТЬСЯ залхуурмаар болох, залхуутай болох, хаширмаар болох, шалай болох.

ПРИЕ́ЗД ирэх, хүрэх, хүрч ирэх; **в день ~а** ирэх өдөр нь; **с ~ом** сайн явж ирэв үү.

ПРИЕЗЖА́ТЬ ирдэг байх,ирэх, хүрч ирэх.

ПРИЕ́ЗЖИЙ ирүүл хүн, ирэгч, гаднаас ирэх хүн, явуулын хүмүүсийн зочид буудал.

ПРИЁМ 1. элсүүлэх, элсэлт, авах; ~ **в партию** намд элсүүлэх; ~ **в институт** дээд сургуулийн элсэлт; 2 үзүүлэх, орох; **явиться на ~ к врачу** эмчид үзүүлэх гэж ирэх; 3. хүлээж авах, авах; ~ **заявлений** өргөдөл хүлээн авах; 4. хүлээн авах, хүлээн авалт, уулзалт, дайллага; **речь на ~е работников школы** сургуулийн ажилтны уулзалт дээр хэлсэн үг; 5. угтаж уулзах,угтаж авах; **оказать тёплый** ~ халуунаар угтаж авах; 6. удаа, дахин; **выпить лекарства в два ~а** эмийг хоёр удаа уух; 7. арга,барил, арга барил, авцал, барьц; **художественный** ~ уран сайхны арга мэх.

ПРИЁМКА хүлээж авах.

ПРИЕ́МЛЕМ||ЫЙ болмоор,зөвшөөрч болхуйц, зүйтэй,тохиромжтой; ~ **план** зөвшөөрч болмоор төлөвлөгөө; **вполне ~ое предложение** ер нь зүйтэй санал; **~ая цена** тохиромжтой үнэ.

ПРИЁМНАЯ хүлээх тасалгаа, хүлээн авах тасалгаа, уулзах өрөө; **приёмная у врача** эмчийг хүлээх тасалгаа.

ПРИЁМНИК хүлээн авагч, хүлээн авах аппарат, **радио~** радио хүлээн авагч.

ПРИЁМН||ЫЙ 1. хүлээн авалтын, хүлээн авах, уулзах, уулзалтын; ~ **день** хүлээн авах өдөр; 2. элсэлтийн; ~ **экзамен** элсэлтийн шалгалт; **~ая комиссия** элсэлтийн комисс, 3. өргөсөн, өргөмөл, үрчилсэн, ~ **отец** өргөсөн эцэг, ~ **сын** өргөмөл хүү, **~ая дочь** үрчилсэн охин.

ПРИЁМОЧНЫЙ хүлээн авах, тушаах, тушааж, өгөх; ~ **пункт** хүлээн авах газар, тушаах газар.

ПРИЁМЩИК хүлээн авагч; ~ **отдела технического котроля** техник шалгалтын хэлтсийн хүлээн авагч.

ПРИЕ́СТЬСЯ захуурмаар болох, ханачхах, хаширмаар болох, шалхай болох; **все развлечения приелись** бүх зугаа цэнгэлд ханачихлаа.

ПРИЕ́ХАТЬ ирэх, хүрч ирэх; ~ **домой** гэртээ ирэх,1. дарах, шахах; ~ **к стене** хананд шахах; 2. хавчих; хавчигдуулах, гачигдуулах; ~ **к сердцу** тэврэх.

ПРИЖА́ТЬСЯ наалдах, биеэ шахах; ~ **к матери** эхдээ наалдах.

ПРИЖЕ́ЧЬ 1. төөнөх, хайрах; ~ **горячим железом** халуун төмрөөр хайрах; 2. түрхэх; ~ **ранку йодом** шарханд йод түрхэх.

ПРИЖИВА́ЛКА айлд хоргодогч эмэгтэй.

ПРИЖИВА́ТЬСЯ дасах, нутагших, идээшлийг олох.

ПРИЖИГА́НИЕ 1. хайрах,төөнөх; 2. түрхэх.

ПРИЖИГА́ТЬ 1. хайрах, төөнөх; 2. түрхэх.

ПРИЖИГА́ЮЩ||ИЙ 1. түлэх, төөнөх; **~ее средство** түлэх юм, төөнөх эм.

ПРИЖИ́ЗНЕННЫЙ амьд байхад.

ПРИЖИМА́ТЬ дарах, хавчих, шахах, тэврэх; ~ **к своей груди** элгэндээ тэврэх.

ПРИЖИМА́ТЬСЯ наалдах, шахагдах.

ПРИЖИ́ТЬСЯ дасах, нутагших, идээшлийг олох; ~ **на новом месте** шинэ нутагт дасах.

ПРИЗ шагнал, шан, бай; **получить первый** ~ нэгдүгээр шагналыг авах.

ПРИЗАДУ́МАТЬСЯ,

ПРИЗАДУ́МЫВАТЬСЯ бодлого болох, санаашрал болох,санагалзах.

ПРИЗВА́НИЕ 1. дүйтэй, горьдоотой, авьяастай; **чувствовать ~ к науке** шинжлэх ухаанд дүйтэйгээ мэдрэх; 2. тавилан, оноо, хувь ерөөл, ноогдсон үүрэг.

ПРИЗВА́ТЬ 1. уриалах, урих, гуйх; ~ **на помощь** тусламж үзүүлэхийг гуйх; 2. татах, дайчлах, дуудах; ~ **на военную службу** цэргийн албанд татах; 3. шаардах, уриалах; ~ **к порядку** журамтай байхыг шаардах.

ПРИЗЕ́МИСТЫЙ намхан, пагдгар, тогдгор; ~ **домик** намхан байшин; ~ **старик** пагдгар өвгөн.

ПРИЗЕМЛЕ́НИЕ газардал, газарт буух, ~ **самолета** нисэх онгоц газарт буух.

ПРИЗЕМЛИ́||ТЬСЯ газарт буух, газар буух, доош буух; **самолет ~лся** нисэх онгоц газар буув.

ПРИ́ЗМ||А олон талст, олон цамцаалт; **сквозь ~у** дам үзэх, ташир үзэх, ташир харах.

ПРИЗНАВА́ТЬ 1. хүлээх, зөвшөөрөх; 2. тоох, ойшоох; **он никого не ПРИзнает** тэр, хэнийг ч тоодоггүй юм.

ПРИЗНАВА́ТЬСЯ үнэнээ хэлэх, шууд хэлэх, хүлээх, улайх.

ПРИ́ЗНАК шинж тэмдэг; **не подавать ~ов жизни** амьдын шинжгүй байх; ~ **весны** хаврын шинж орох.

ПРИЗНА́НИЕ 1. хүлээх, зөвшөөрөх, хүлээн зөвшөөрөх; ~ **доводов правильными** учир шалтгааныг зөв гэж зөвшөөрөх; 2. хэргээ хүлээх, улайх; ~ **преступника** ялтан хэргээ хүлээх, ялтан улайх; 3. хүндлэл, хүндлэгдэх, сайшаагдах, тоогдох; 4. үнэнээ хэлэх; **выслушать чье-либо** ~ хүний үнэнээ хэлэхийг сонсох.

ПРИ́ЗНАННЫЙ олонд нэртэй, тоогдсон; **всеми** ~ **поэт** олонд тоогдсон шүлэгч.

ПРИЗНА́ТЕЛЬНОСТЬ талархал, ачийг санах; **выразить кому-либо** ~ хүнд талархлаа илэрхийлэх.

ПРИЗНА́ТЕЛЬНЫЙ талархах, талархалтай, баярласан, ачийг санах; **я вам очень признателен за содействие** намайг дэмжсэний тул би танд маш их талархаж байна; ~ **взгляд** талархалтай харц.

ПРИЗНА́ТЬ 1. таних; 2. хүлээх, зөвшөөрөх, хүдээн зөвшөөрөх, ойшоож үзэх; ~ **свои ошибки** алдаагаа хүлээх; ~ **себя побеждённым** дийлдсэнээ хүлээх (бууж өгөх); 3. үзэх, гэж үзэх; ~ **нужным** хэрэгтэй гэж үзэх.

ПРИЗНА́ТЬСЯ үнэнээ хэлэх, шууд хэлэх, хүлээх, улайх; ~ **в любви** хайртай болсноо шууд хэлэх.

ПРИЗО́Р харгалзаа, харж байх, хүн.

ПРИ́ЗРАК хий үзэгдэл, сүүдэгнэл; **ночные ~и** шөнийн сүүдэгнэл.

ПРИ́ЗРАЧН||ЫЙ хий үзэгдлийн, сүүдэгнэлийн, сүүдэгнэсэн; **~ое видение** сүүдэгнэсэн үзэгдэл.

ПРИЗРЕ́ТЬ тэтгэх, халамжлах, халамж үзүүлэх; ~ **сироту** өнчин хүүхдийг тэтгэх.

ПРИЗЫ́В 1. уриа; 2. цэрэг татлага, цэрэг дайчлах, дуудлага; **прошлогодний** ~ коднин жилийн цэрэг татлага.

ПРИЗЫВА́ТЬ1. уриалах, гуйх; 2. татах, дайчлах, дуудах; 3. шаардах.

ПРИЗЫВА́ТЬСЯ татагдах, дайчлагдах, дуудагдах, цэрэгт мордох.

ПРИЗЫВНИ́К цэрэгт мордох хүн, дайчлагдах насны хүн, цэрэгт нас тэнцэгч.

ПРИЗЫВНО́Й цэргийн насны, цэрэгт мордох, цэрэг татлагын, цэрэгт татах; ~ **возраст** цэргийн насанд хүрсэн; ~ **пункт** цэрэг татлагын байр.

ПРИЗЫ́ВНЫЙ дуудлагын, дуудах, гуйх, гуугалах; ~ **крик** дуудаж хашгирах.

ПРИ́ИСК уурхай; **золотые ~и** алтны уурхай.

ПРИИСКА́ТЬ эрж олох, хайж олох; ~ **удобную квартиру** аятайхан байр эрж олох.

ПРИИСКО́ВЫЙ уурхайн.

ПРИЙТИ́1. ирэх; ~ **на занятия** хичээлдээ ирэх; 2. ирэх, болох; **пришла весна** хавар болов; 3. болох, ~ **в ярость** уур хилэнболох; ~ **в ветхость** өгөршил болох; 4. хүрэх; ~ **к**

выводу дүгнэлтэнд хүрэх; 5. орох; ~ **в себя** сэхээ орох, ухаан орох; ~ **на память** санаанд орох, 6. тохирох; ~ **к соглашению** хэлэлцэж тохирох; ~ **к власти** засгийн эрхийг авах.

ПРИЙТИ́СЬ 1. таарах; **сапоги пришлись по ноге** гутал хөлд таарах; 2. болох дайралдах,тусах; 3. хэрэгтэй болох,ёстой болох,аргагүйдэх; **ему пришлось уехать** тэр явах хэрэгтэй болов; 4. тохиолдох,оногдох; **им пришлось нелегко на чужбине** тэдэнд харь газарт бэрх байдал тохиолдов; **на каждого пришлось по вкусу** санаанд нь таарав.

ПРИКА́З 1. тушаал; **выполнить** ~ тушаал биелүүлэх; **отдать** ~ тушаал өгөх; 2. захиргаа, захирах газар.

ПРИКАЗА́НИЕ тушаал,тушаах; **устное** ~ ам тушаал; **исполнить** ~ тушаал биелүүлэх.

ПРИКАЗА́||ТЬ 1. тушаах; **командир полка ~л выступить с рассветом** хорооны дарга,үүр цаймагц давш гэж тушаав; 2. гэх хэлэх, зохих; **как прикажете понимать ваши слова?** таны үгийг яаж ойлговол зохих вэ?; **~л долго жить** таалал төгсжээ.

ПРИКА́ЗЧИК 1. захирагч, шадар.

ПРИКА́ЛЫВАТЬ 1. хатгах, торгох; 2. хатгаж алах, бүлж алах.

ПРИКА́НЧИВАТЬ 1. шавхах, шавхан дуусгах, барах; ~ **все запасы** бүх нөөцийг шавхан дуусгах, 2. үгүй хийх, гүйцэд алах.

ПРИКАСА́ТЬСЯ хүрэх, аяархан хүрэх, дөнгөж хүрэлцэх, шүргэх.

ПРИКАТИ́ТЬ өнхрүүлж авчрах, бөмбөрүүлж авчрах.

ПРИКИ́ДЫВАТЬ барагцаалах, багцаалах; ~ **на счётах** сампингаар барагцаалан тоолох; ~ **на весах** жинг барагцаалах; ~ **в уме** дотроо багцаалах.

ПРИКИ́ДЫВАТЬСЯ дүрэм үзүүлэх, янз үзүүлэх, -гч болох; ~ **спящим** унтсан янз үзүүлэх.

ПРИКЛА́Д I бууны бөгс мод, мөрлүүр мод, хундаг.

ПРИКЛА́Д II оёдлын жижиг хэрэгсэл, товч цаваг зэрэг хэрэгсэл.

ПРИКЛАДН||О́Й хавсарга; **~ая наука** хавсарга шинжлэх ухаан, **~ое искусство** хавсарга урлаг.

ПРИКЛА́ДЫВАТЬ 1. тавих, дахах, дарах, 2. хавсаргах, 3. гаргах, зориулах, 4. хэрэглэх.

ПРИКЛЕ́ИВАТЬ наах, наалдуулах; ~ **объявление к стене** хананд зарлал наах.

ПРИКЛЕ́ИВАТЬСЯ наагдах, наалдах; **объявление хорошо приклеилось** зарлал сайн наагдав.

ПРИКЛЕПА́ТЬ тавлах, ~ **гвоздь** хадаас тавлах.

ПРИКЛОНИ́ТЬ бөхийлгөх, тонгойлгох; **негде голову** ~ толгой шургах газаргүй.

ПРИКЛЮЧА́ТЬСЯ учрах, тохиолдох, найралдах.

ПРИКЛЮЧЕ́НИ||Е 1. учрал, явдал, тохиолдол, уршигтай хэрэг; **забавное** ~ хөгийн явдал, 2. адал явдал; **искатель ~й** адал явдлыг эрэгч.

ПРИКЛЮЧЕ́НЧЕСКИЙ адал явдлын, уршигт явдалтай; ~ **роман** адал явдлын роман.

ПРИКЛЮЧИ́ТЬСЯ учрах, тохиолдох, дайралдах; **приключилась неприятность** гайтай явдал учрав.

ПРИКОВА́||ТЬ 1. хадах, давтаж хадах, гавлах, гадаслах, гинжилж уях; 2. хэвтрийн болгох, хөдлөхгүй болгох, хөдөлж чадахгүй болгох; **болезнь ~ла его к постели** өвчин түүнийг хэвтрийн болгов; **страх ~л его к месту** айгаад хөдөлж чадахгүй байв; ~ **к себе внимание** анхаарлыг биедээ татах.

ПРИКО́Л 1. хавтгах, 2. шаасан гадас, уяа, онгоц уях сэргэ; 3. шог, тохуу; **лошадь ходит на ~е** морь аргамжаатай байв.

ПРИКОЛА́ЧИВАТЬ хадах; ~ **доску** банз хадах.

ПРИКОЛО́ТЬ 1. хатгах, торгох; ~ **булавкой** зүүгээр хатгах, зүүгээр торгох, 2. хатгаж алах, бүлж алах; ~ **врага штыком** дайсныг жадаар бүлж алах, дайсныг жадалж алах.

ПРИКОМАНДИРОВА́ТЬ томилж явуулах, томилолтоор илгээх, түр явуулах.

ПРИКО́НЧИ||ТЬ 1. барчхах, шавхах, шавхан дуусгах; **все запасы ~ли** бүх нөөцөө барчихлаа, 2. үгүй хийх, гүйцэд алах.

ПРИКО́РМ 1. тэжээх, тэжээл өгөх; 2. тэжээл, нэмэгдэл тэжээл; ~ **для скота** малын тэжээл.

ПРИКОРНУ́ТЬ налж дуг хийх, атийж зүүрмэглэх.

ПРИКОСНОВЕ́НИЕ аяархан хүрэх, хүргэх, дөнгөж хүрэлцэх, шүргэх; **лёгкое ~ руки** гараа аяархан хүргэх.

ПРИКОСНОВЕ́ННОСТЬ холбогдол, холбогдох.

ПРИКОСНОВЕ́ННЫЙ холбогдох, холбогдсон, холбогдолтой, хамаатай.

ПРИКОСНУ́ТЬСЯ хүрэх, аяархан хүрэх, дөнгөж хүрэлцэх, шүргэх.

ПРИКРА́СИТЬ гоёх, нэмж чимэх, чимэх.

ПРИКРА́СА гоёл,чимэг, нэмж чимэх; **рассказывать без прикрас** нэмж чимэхгүй ярих.

ПРИКРЕПИ́ТЕЛЬНЫЙ хамжуулсан, хамаадуулсан; ~ **талон** хамжуулсан талон.

ПРИКРЕПИ́ТЬ 1. хадах, торгох, бэхэлж тогтоох; 2. хамжуулах, хамаадуулах, даалгаж өгөх, ордог болгох.

ПРИКРЕПИ́ТЬСЯ 1. хадагдах, торгогдох, бэх тогтох; 2. хамжих, хамаадах; 3. бүртгүүлэх, бүртгэгдэх.

ПРИКРЕПЛЕ́НИЕ 1. хадах, торгох, тогтоох; 2. хамжуулах, хамаадуулах.

ПРИКРЕПЛЯ́ТЬСЯ 1. хадагдах, торгогдох, бэх тогтох; 2. хамжих, хамаадах; 3. бүртгүүлэх, бүртгэгдэх.

ПРИКРИ́КИВАТЬ зандчих, зандрах, хашгирах, загнах.

ПРИКРИ́КНУТЬ зандчих, зандрах, хаахирах, загнах.

ПРИКРУТИ́ТЬ 1. хүлэх, мушгиж хүлэх, шургуулж хүлэх, мушгиж уях; 2. багасгах, доош нь мушгих; ~ **фитиль в лампе** дэнгийн голыг доош нь мушгих.

ПРИКРУ́ЧИВАТЬ 1. хүлэх, мушгиж хүлэх, шургуулж хүлэх, мушгиж уях; 2. багасгах, доош нь мушгих.

ПРИКРЫВА́ТЬ,

ПРИКРЫ́ТЬ 1. хаах, хамхих; ~ **дверь** үүд хамхих; 2. таглах, хавхаглах, тавих; 3. далдлах, халхлах; ~ **обман** мэхэлснийг далдлах; 4. халхлах, хаацайлах, өмөглөх, хамгаалах.

ПРИКРЫВА́ТЬСЯ,

ПРИКРЫ́ТЬСЯ 1. халхлагдах, хучих, хучигдах; 2. хаагдах, хамхигдах; **дверь прикрылась** үүд хамхигдав; 3. далдлах, халхлах; ~ **хвастливыми словами** сайрхаг үгээр халхлах.

ПРИКРЫ́ТИЕ 1. халхавч, халх; ~ **от дождя** борооны халхавч; 2. халхлах, халхавч.

ПРИКУПА́ТЬ,

ПРИКУПИ́ТЬ нэмж авах, нэмж худалдан авах, бас авах.

ПРИКУ́РИВАТЬ тамхи асаах, галаа өгөх.

ПРИКУРИ́ТЬ тамхи асаах, галаа өгөх; **позвольте** ~ галаа, өгөөч.

ПРИ́КУС зуулт; **правильный** ~ шүдний зөв тэгш зуулт.

ПРИКУСИ́ТЬ хазах, татах; ~ **язык** 1. хэлээ хазах; 2. ам хэлээ татах.

ПРИКУ́СЫВАТЬ хазах, татах.

ПРИЛА́ВОК лангуу.

ПРИЛАГА́ТЕЛЬНОЕ, хавсрал нэр, тэмдэг нэр; **имя ~ узнаётся по вопросам: какой? чей?** хавсрал нэрийг ямар, юуны гэж асуулт тавьж мэднэ.

ПРИЛАГА́ТЬ 1. хавсаргах; ~ **к заявлению документы** өргөдөлд баримт бичгийг хавсаргах; 2. гаргах, зориулах; ~

все силы бүх хүчээ гаргах; 3. хэрэглэх; ~ **теорию к практике** онолыг туршлага дээр хэрэглэх.

ПРИЛА́ДИТЬ,

ПРИЛА́ЖИВАТЬ тааруулах, тааруулж хийх; ~ **замок к двери** үүдэнд цоож тааруулах.

ПРИЛАСКА́ТЬ энхрийлэх, таалах; ~ **ребенка** хүүхдийг энхрийлэх.

ПРИЛАСКА́ТЬСЯ эрхлэх, таалуулах; ~ **к матери** ээждээ эрхлэх.

ПРИЛЕГА́||ТЬ 1. тулах, нийлэх, наалдаж байх, таарах, давж байх; **платье хорошо ~ет к телу** дээл биенд сайн таарч байна; 2. зах нийлэх, зэргэлдээ байх, хажууд байх; **сад ~ет к реке** цэцэрлэг мөрний хажууд байна, цэцэрлэг голд тулж байна.

ПРИЛЕЖА́НИЕ хичээл оролдлого, чармайлт; **отличаться ~м** хичээл оролдлогоороо шалгарах.

ПРИЛЕЖА́Щ||ИЙ налсан, хэвтээ, хажуу; **~ая сторона угла** өнцгийн налсан тал.

ПРИЛЕ́ЖНО хичээж, чармайж, мэрийж; ~ **учиться** мэрийж суралцах.

ПРИЛЕ́ЖНЫЙ хичээлтэй, оролдлоготой, чармайлттай; ~ **ученик** хичээлтэй сурагч.

ПРИЛЕПИ́ТЬ наах.

ПРИЛЕПИ́ТЬСЯ наалдах, наагдах.

ПРИЛЕПЛЯ́ТЬ наах.

ПРИЛЁТ нисэж ирэх, ирэх; ~ **птиц** шувуу нисэж ирэх.

ПРИЛЕТА́ТЬ нисэж ирэх, ирэх.

ПРИЛЕТЕ́||ТЬ нисэж ирэх, ирэх; **птицы ~ли** харьсан шувуу ирлээ; **самолёт ~л** нисэх онгоц нисэж ирэв.

ПРИЛЕ́ЧЬ 1. жаахан хэвтэх, хажуулах; ~ **после обеда** үдийн хоолны дараа хажуулах; 2. хэвтэх, бөхийх, налах; 3. наалдуулж хэвтэх; ~ **ухом к земле** чихээ газарт наалдуулж хэвтэх.

ПРИЛИ́В түлхэлт, хөөрөлт, хөөрөх; ~ **моря** тэнгисийн түлхэлт, далайн хөөрөлт; ~ **крови** цус хөөрөх.

ПРИЛИВА́ТЬ хөөрөх.

ПРИЛИ́ЗАНН||ЫЙ 1. долоогдсон; 2. гялгар, гөлчийсөн; **~ые волосы** гялгар үс.

ПРИЛИЗА́||ТЬ 1. долоох; **кошка ~ла шерсть** муур үсээ долоов; 2. гялайлгах, гөлгөр болгох, гөлчийлгөх; ~ **волосы** үсээ гялайлгах.

ПРИЛИПА́ТЬ,

ПРИЛИ́ПНУТЬ наалдах, наалдалдах; **клей прилип к руке** цавуу гарт наалдав.

ПРИЛИ́ПЧИВЫЙ 1. наалдамхай; 2. халдвартай; 3. залхуутай, хашраадаг; ~ **человек** хашраадаг хүн, наалдуур хүн.

ПРИЛИ́||ТЬ хөөрөх; кровь ~ла к голове цус толгойд хөөрөв.

ПРИЛИ́ЧИЕ ёс зүй, зүй ёс; **соблюдать ~** зүй ёсыг дагах.

ПРИЛИ́ЧН||ЫЙ 1. зохимжтой, аятай томоотой; **~о вести себя** биеэ аятай авч явах; **~ое поведение** томоотой байх; 2. зүгээр, сайн, болохтой; **пальто еще ~о** зүгээр сайн пальто.

ПРИЛОЖЕ́НИЕ 1. хавсралт; **журнал с ~м** хавсралттай сэтгүүл, 2. хэрэглэх; ~ **знаний на практике** мэдлэгээ туршлага дээр хэрэглэх.

ПРИЛОЖИ́ТЬ 1. тавих, дахах, дарах; ~ **руку ко лбу** гараа духандаа дарах; **~ к заявлению документы** өргөдөлд баримт бичиг хавсаргах; 3. гаргах, зориулах; **~ все силы для выполнения плана** төлөвлөгөөг биелүүлэхэд бүх хүчээ зориулах; 4. хэрэглэх; ~ **теорию на практике** онолыг туршлага дээр хэрэглэх.

ПРИЛОЖИ́ТЬСЯ 1. наалдуулах, дахах, тулгах; ~ **ухом к двери** чихээ үүдэнд дахах; 2. шагайх; ~ **и выстрелить** шагайгаад буудах.

ПРИЛУНИ́ТЬСЯ саран дээр буух.

ПРИЛЬНУ́ТЬ наалдах, дахах, налах.

ПРИ́МА нэгц, голлох чавхдас.

ПРИМАДО́ННА голлох дуучин эмэгтэй.

ПРИМА́ЗАТЬСЯ,

ПРИМА́ЗЫВАТЬСЯ 1. тосолж гялайлгах; 2. шургалж орох.

ПРИМА́НИВАТЬ,

ПРИМАНИ́ТЬ, зангаж дуудах, даллах, аргадаж татах, урамдах.

ПРИМА́НКА хахуул, илбээс, өгш хилбэ, мэн; ~ **для рыб** загас барих илбээс.

ПРИМА́Т анхдагч, манлайлах.

ПРИМЕЛЬКА́||ТЬСЯ нүдэнд дасах, үзэгдээд л байх, танил болох; **его лицо мне ~лось** тэр над үзэгдээд л байдаг хүн.

ПРИМЕНЕ́НИЕ 1. хэрэглэх, хэрэглэгдэх; **находить ~** хэрэглэгдэх болох; 2. зохицох, дасах; ~ **к новым условиям** шинэ нөхцөлд дасах.

ПРИМЕНИ́МЫЙ хэрэглэж болохуйц, хэрэглэж болмоор, хэрэглэж болох, **вполне ~ способ** бүр хэрэглэж болох арга.

ПРИМЕНИ́ТЕЛЬНО зохицуулж тааруулж, **действовать ~ к обстановке** тухайн ахуй байдалд зохицуулж ажиллах.

ПРИМЕНИ́ТЬ,

ПРИМЕНЯ́ТЬ хэрэглэх, ~ **новый метод работы** ажлын шинэ аргыг хэрэглэх.

ПРИМЕНЯ́ТЬСЯ 1. зохицох, тохирох, таарах, дасах, ~ **к обстоятельствам** ахуй байдалд зохицох,2. хэрэглэгдэх.

ПРИМЕНЯ́ЕМОСТЬ хэрэглэгдэх нь

ПРИМЕ́Р жишээ, үлгэр, дууриал, **приводить ~** жишээ гаргах, **служить ~ом** жишээ болох, **брать ~** жишээ авах, **по ~у** жишээгээр, **к ~у** жишээ нь.

ПРИМЕРЗА́ТЬ наалдаад хөлдөх, барилдаж хөлдөх.

ПРИМЁРЗ||НУТЬ наалдаад хөлдөх, барилдаж хөлдөх, **полено ~ло к земле** хэрчим мод газарт наалдаад хөлджээ.

ПРИМЕ́РИВАТЬ,

ПРИМЕ́РИТЬ өмсөж үзэх,хэмжиж үзэх, хэмжих, ~ **сапог** гутал өмсөж үзэх, **семь раз примерь, один раз отрежь** долоон удаа хэмжиж нэг удаа хайчил.

ПРИМЕ́РКА өмсөж үзэх, өмсөж тааруулах.

ПРИМЕ́РНО 1. жишээ болохуйц, ~ **вести** себя биеэ жишээ болохуйц авч явах, 2. барагцаалбал, бараглахад, хирийн.

ПРИМЕ́РНЫЙ 1. жишээ болохоор, дууриал болохоор, ~ **ученик** жишээ болохоор сурагч,2. барагцаалсан, барагласан, ~ **срок окончания работы** ажлыг дуусгах барагцаалсан хугацаа

ПРИ́МЕСЬ хольцоо, хольц; **глина с ~ю песка** элсэн хольцоотой шавар.

ПРИМЕ́Т||А 1. тэмдэг, шинж; **особые ~ы** онцгой тэмдэг, 2. ёр, **дурная ~** муу ёр.

ПРИМЕТИ́||ТЬ ажих, ажиглах, анзаарах, анхаарах, **не ~ли самого главного** хамгийн чухлы нь анзаарсангүй.

ПРИМЕ́ТН||ЫЙ мэдэгдэх, мэдэгдэхүйц, харагдах, харагдахуйц, илэрхий, **едва ~ая трещина** дөнгөж харагдах цав.

ПРИМЕЧА́НИЕ тайлбар, тайлбарлах, ажиглалт, зүүлт.

ПРИМЕЧА́ТЕЛЬН||ЫЙ гайхамшигтай, анхаарууштай, **~ое событие** гайхамшигтай явдал

ПРИМЕЧА́ТЬ ажих, анзаарах, анхаарах.

ПРИМЕША́ТЬ холих, хутгах, нэмж хутгах.

ПРИМЕ́ШИВАТЬ холих, хутгах, нэмж хутгах.

ПРИМИНА́ТЬ 1. дарах, дарж хонхойлгох, навтайлгах; 2. гишгэчих, чийрлах.

ПРИМИРЕ́НИЕ эвлэх, зохицох.

ПРИМИРЕ́НЧЕСКИЙ эвсэх, эвсэн дагалдах.
ПРИМИРЕ́НЧЕСТВО эвсэх явдал, эвсэн дагалдах явдал.
ПРИМИРИ́ТЕЛЬН||ЫЙ эвлэх, эвлэрсэн, эвлэрүүлэх; **~ые слова** эвлэрүүлэх үг.
ПРИМИ́РИТЬ эвлэрүүлэх, эвтэй болгох.
ПРИМИРИ́||ТЬСЯ 1. эвлэх, эвлэрэх, эвтэй болох; 2. эрхийг дагах; **я ~лся с судьбой** би заяаны эрхийг дагав.
ПРИМИТИ́В бааз, эгэл, болхи.
ПРИМИТИ́ВНОСТЬ бааз, эгэл, болхи.
ПРИМИТИ́ВН||ЫЙ бааз, эгэл, болхи; **~ое устройство машины** бааз хийсэн машин; **~ подход к делу** ажил хэрэгт болхи хандах.
ПРИМКНУ́ТЬ 1. нийлэх, ойлгох; 2. углах, залгах, хийх.
ПРИМО́ЛКНУТЬ 1. дуугүй болгох, чимээгүй болгох.
ПРИМО́РСКИЙ 1. далайн дэргэдэх, далайн хавийн; **~ курорт** далайн дэргэдэх рашаан амралт.
ПРИМО́РЬЕ далайн хавь газар, тэнгисийн эрэг хавийн нутаг.
ПРИМОСТИ́ТЬ дөнгөөд багтаах, яаж ийгээд тавих.
ПРИМОСТИ́ТЬСЯ дөнгөж багтах, яаж ийгээд суух, өнцөгдөж сандайлах.
ПРИМО́ЧКА нойтон жин, шавших; **~ для глаз** нүдэнд нойтон жин тавих.
ПРИ́МУС цоргио зуух, цоргилуур.
ПРИМЧА́ТЬСЯ гүйж ирэх, давхиж ирэх; **~ на лошади** мориор давхиж ирэх.
ПРИМЫКА́НИЕ 1. нийлэх, шадарлах; 2. хамжих, хамжуулах, нийлбэр; **~ пути** замын нийлбэр.
РАЗЖА́ЛОВАНИЕ (*тушаал*) бууруулах, зэрэг хэргэм бууруулах.

РАЗЖА́ЛОВАННЫЙ 1. (*тушаал*) буурсан, зэрэг хэргэм буурсан; 2. (*тушаал*) буурсан хүн, зэрэг хэргэм буурсан хүн.

РАЗЖА́ЛОВАТЬ (*тушаал*) бууруулах, зэрэг хэргэм бууруулах; **~ в рядовые** бууруулж энгийн цэрэг болгох.

РАЗЖА́ТЬ тавих, тэнийлгэх, сунгах, ангайлгах, нээх; **~ кулак** зангидсан гараа тэнийлгэх.

РАЗЖА́||ТЬСЯ тэнийх, сунах, ангайх, ангайлгах, нээгдэх; **сомкнутые губы ~лись** жимийсэн уруул ангайв.

РАЗЖЕВА́ТЬ,

РАЗЖЁВЫВАТЬ 1. зажлах, хивэх; **~ пищу** идэх юм зажлах; 2. тайлбарлаж өгөх, хэлж өгөх; **~ и положить в рот** ойнд нь ортол хэлж өгөх.

РАЗЖЕ́ЧЬ 1. асаах, ноцоох; **~ огонь** гал ноцоох; 2. хөдөлгөх, дэврүүлэх, дэгдээх, өрнүүлэх.

РАЗЖЕ́ЧЬСЯ 1. асах, ноцох; **дрова разожглись** түлээ ноцов; 2. хөдлөх, дэврэ́х, дэгдэх, өрнөх.

РАЗЖИГА́ТЬ 1. асаах, ноцоох; 2. хөдөлгөх, дэврүүлэх, дэгдээх, өрнүүлэх.

РАЗЖИГА́ТЬСЯ 1. асах, ноцох; 2. хөдлөх, дэврэх, дэгдэх, өрнөх.

РАЗЖИЖА́ТЬ шингэрүүлэх.

РАЗЖИЖЕ́НИЕ шингэрүүлэх, шингэрүүлэлт.

РАЗЖИМА́||ТЬ тавих, тэнийлгэх, сунгах, ангайлгах, нээх; **сидеть, не ~я рта** ам нээлгүй суух, амаа хамхин суух.

РАЗЖИМА́ТЬСЯ тэнийх, сунах, ангайх, ангайлгах, нээгдэх.

РАЗЖИРЕ́ТЬ таргалах, өөхлөх.

РАЗЗАДО́РИВАТЬ өдөөх, дэврээх, хоры нь хөдөлгөх; хорхойгий нь хүргэх.

РАЗЗАДО́РИВАТЬСЯ дэврэх, хор хөдлөх.

РАЗЗАДО́РИТЬ өдөөх, дэврээх, хоры нь хөдөлгөх; хоры нь хөдөлгөх; хорхойгий нь хүргэх.

РАЗЗАДО́РИТЬСЯ дэврэх, хор хөдлөх.

РАЗЗВОНИ́ТЬ зар тараах, хүн хүнд хэлэх.

РАЗЗНАКО́МИТЬСЯ эвдрэх, эвгүй болох, эв тасрах, түнжин хагарах.

РАЗИ́НУТЬ ангайх; **~ рот** ам ангайх.

РАЗИ́НЯ алмай, алмайрагч.

РАЗИ́ТЕЛЬН||ЫЙ гайхалтай, гайхам; **~ое сходство** гайхалтай адилхан.

РАЗИ́ТЬ I алмай амьтан, алмайрагч.

РАЗИ́ТЬ II үнэр гутах, үнэр танар гарах, үнэртэх; **от него разит перегаром** түүнээс архи үнэртэж байна.

РАЗЛАГА́ТЬ 1. задлах, ялгах, хуваах; 2. ялзруулах, завхруулах, ёс журамгүй болгох; самуурууллах, эмх замбараагий нь алдуудах.

РАЗЛАГА́ТЬСЯ 1. задрах, завхрах, ёс журамгүй болох, самуурах, эмх замбараагаа алдах.

РАЗЛАГА́ЮЩ||ИЙ ялзруулах, завхруулах, задруулах; **оказать ~ее влияние** муу нөлөө үзүүлж задруулах.

РАЗЛА́Д 1. эмхгүй байдал, эмх цэгцгүй байх, эмх замбараагүй болох; 2. хэрүүл, эвдрэл, эв тасрах; **семейный ~** гэр бүлийн хэрүүл.

РАЗЛА́ДИТЬ 1. эвдрэх, гэмтэх; **~ часы** цаг эвдрэх; 2. бүтэлгүй болгох, сандаах; **~ дело** хэрэг бүтэлгүй болгох.

РАЗЛА́ДИ||ТЬСЯ 1. эвдрэх, гэмтэх; 2. бүтэхгүй болох, сандаах; **дело ~лось** энэ хэрэг бүтэхгүй болов.

РАЗЛА́ЖИВАТЬ 1. эвдэх, гэмтээх; 2. бүтэлгүй болох, сандах.

РАЗЛА́ЖИВАТЬСЯ 1. эвдрэх, гэмтэх; 2. бүтэлгүй болох, сандах.

РАЗЛА́МЫВАТЬ хуга хуга татах, хэмх татах, бутлах, хэмхлэх, эвдлэх.

РАЗЛА́МЫВАТЬСЯ хуга хуга буух, хагарах, бутрах, хэмх хэмх үсрэх, хэмхрэх, эвдрэх.

РАЗЛЕЗА́ТЬСЯ сэмрэх, яз үсрэх, удрах, зад буух, урагдах.

РАЗЛЕНИ́ТЬСЯ залхууч болох, залхуудаа баригдах.

РАЗЛЕПИ́ТЬ наалдсан юмыг хуулах, салгах.

РАЗЛЕПИ́ТЬСЯ наалдахгүй хуурах, наалдалгүй салах.

РАЗЛЕПЛЯ́ТЬ наалдсан юмыг хуулах, салгах.

РАЗЛЕПЛЯ́ТЬСЯ наалдахгүй хуурах, наалдалгүй салах.

РАЗЛЕТА́||ТЬСЯ 1. зүг зүг нисэх, тархан нисэх, бутран нисэх; 2. хийсэх, хийсэн сарних, тарж унах; 3. бут үсрэх, бутрах; 4. сарних, арилах, тасрах; 5. хурдлах; 6. хийсэх, дэврэх; **полы платья ~ются** хувцасны хормой дэрвэнэ.

РАЗЛЕТЕ́||ТЬСЯ 1. зүг зүг нисэх, тархан нисэх, бутран нисэх; **птицы ~лись** олон шувуу зүг зүг нисэв; 2. хийсэх, хийсэн сарних, тарж унах; **листья ~лись** навчис хийсэн сарнив; 3. бут үсрэх, бутрах; 4. сарних, арилах, тасрах; 5. хурдлах; **~вшись, удариться о столб** хурдалж шон мөргөх.

РАЗЛЕ́ЧЬСЯ тарайн хэвтэх, налайн хэвтэх; **~ на траве** ногоон дээр тарайн хэвтэх.

РАЗЛИ́В 1. хийх, аягалах, савлах, юүлэх; 2. үер, үерлэх, халих.

РАЗЛИВА́ТЬ 1. асгах, 2. хийх, аягалах,савлах, юүлэх; 3. цацруулах, түгээх.

РАЗЛИВА́ТЬСЯ 1. асгарах, 2. бялхах, халих, үерлэх; 3. тархах, түгэх, цацрах; 4. сайхан дуулах, донгодох, жиргэх; 5. олон юм ярих.

РАЗЛИВНО́Й 1. савгүй зардаг, юүлж худалддаг; 2. савлах, юүлэх; **~ аппарат** савлах аппарат.

РАЗЛИНОВА́ТЬ,

РАЗЛИНО́ВЫВАТЬ шугамдах; **~ тетрадь** дэвтэр шугамдах.

РАЗЛИ́ТЬ 1. асгах; 2. хийх, аягалах, савлах, юүлэх; **~ чай гостям** зочдод цай аягалах; 3. цацруулах, түгээх; **их водой не разольёшь** тэд зүү шивэх зайгүй нөхөд.

РАЗЛИ́||ТЬСЯ 1. асгарах; 2. бялхах, халих,үерлэх; **река ~лась** гол үерлэв; 3. тархах, дэлгэрэх, түгэх, цацрах.

РАЗЛИЧА́ТЬ, ялгах, ялгаж харах, харах.

РАЗЛИЧА́ТЬСЯ 1. ялгаатай байх, ялгагдах; 2. ялгарах, ялгаран харагдах.

РАЗЛИ́ЧИ||Е 1. ялгаа, өөрөөр (*байх*); **~ во взглядах** үзэл ялгаатай байх; 2. ялгавар, ялгаа, ялгах тэмдэг; **знаки ~я** ялгах тэмдэг; 3. ялгал, ялгаа, ялгавар; **делать ~** ялгаж үзэх; **без ~я** ялгалгүй, ялгаагүй, ялгаваргүй.

РАЗЛИЧИ́ТЕЛЬНЫЙ ялгах.

РАЗЛИЧИ́ТЬ ялгах, ялгаж харах, харах; **с трудом ~ что-либо в темноте** харанхуйд юмыг арай гэж харах.

РАЗЛИ́ЧНО өөр өөр, янз янз.

РАЗЛИ́ЧН||ЫЙ 1. өөр өөр, янз янз, ялгаатай; **~ые мнения** өөр өөр санал; 2. янз бүрийн, төрөл бүрийн, зүйл зүйлийн, элдвийн; **занят ~ыми делами** элдвийн ажилтай.

РАЗЛОЖЕ́НИЕ 1. задлах, ялгах, хуваах; 2. ялзрах, өмхийрөх, өмхрөх; 3. задрах, сарних, ялзрах, завхрах, самуурах.

РАЗЛОЖИ́ВШИЙСЯ 1. ялзарсан, өмхийрсөн; 2. ялзарсан, ёс журмаа алдсан, завхарсан.

РАЗЛОЖИ́ТЬ I 1. тавих, өрөх, дэлгэх; **~вещи** юмаа дэлгэх, юмаа өрөх; 2. дэлгэх, дэлгэж тавих; **~ ковёр** хивс дэлгэх;

3. хуваарилах, оногдуулах; 4. (*зэрэглэж*) асаах, (*өрж*) ноцоох; ~ **костёр** түүдэг гал ноцоох.

РАЗЛОЖИ́ТЬ II 1. задлах, ялгах, хуваах; ~ **воду на кислород и водород** усыг хүчил төрөгч, устөрөгч хоёр болгон задлах.

РАЗЛОЖИ́ТЬСЯ I юмаа тавих, өрөх, дэлгэх.

РАЗЛОЖИ́||ТЬСЯ II 1. задрах, ялгарах, хуваагдах; **окись ртути ~лась на ртуть и кислород** мөнгөн усны исэл нь мөнгөн ус, хүчилтөрөгч хоёр болон задрав; 2. ялзрах, өмхийрөх, өмхрөх; 3. ялзрах, завхрах, ёс журамгүй болох, самуурах, эмх замбараагаа алдах.

РАЗЛО́М 1. хугалах, хагалах, эвдэх; 2. эвдэрхий, хагархай, хугархай газар; **по линии ~а** эвдэрхий газраар нь.

РАЗЛОМА́ТЬ хуга татах, хугалах, бутлах, хэмхлэх, хэмх татах, эвдлэх; ~ **старый сарай** хуучин саравч эвдлэх.

РАЗЛОМА́ТЬСЯ хуга буух, хугарах, бутрах, хэмх үсрэх, хэмхрэх, эвдрэх.

РАЗЛОМИ́ТЬ хуга татах, хугалах, хэсэглэх, хэмхлэх.

РАЗЛОМИ́ТЬСЯ хуга үсрэх, хугарах, (*хоёр*) хэсэг болох, бутрах, хэмхрэх.

РАЗЛУ́К||А салах, хагацах; **наступил день ~и** хагацах цаг болов.

РАЗЛУЧА́ТЬ салгах, хагацаах.

РАЗЛУЧА́ТЬСЯ салах, хагацах.

РАЗЛУЧИ́ТЬ салгах, хагацаах; ~ **друзей** анд нөхдийг хагацаах.

РАЗЛУЧИ́ТЬСЯ салах, хагацах; ~ **ненадолго** түр зуур салах.

РАЗЛЮБИ́ТЬ хайрлахаа болих, дургүй болох.

РАЗМАГНИ́ТИТЬ соронзонгүй болгох; ~ **стал** болдыг соронзонгүй болгох.

РАЗМАГНИ́ТИТЬСЯ соронзонгүй болгох.

РАЗМАГНИ́ЧИВАТЬ соронзонгүй болгох.

РАЗМАГНИ́ЧИВАТЬСЯ соронзонгүй болгох.

РАЗМА́ЗАТЬ будах, түрхэх, нялах, халтарлах; ~ **грязь по лицу** нүүрээ халтарлах.

РАЗМА́ЗА||ТЬСЯ наалдах, халдах, болох; **грязь ~лась по полу** шал шавхай болжээ.

РАЗМАЗНЯ́ 1. шингэн будаа; 2. дорой хүн, үхээнц амьтан.

РАЗМА́ЗЫВАТЬ будах, түрхэх, нялах, халтарлах.

РАЗМА́ЗЫВАТЬСЯ халдах, болох.

РАЗМАЛЕВА́ТЬ бялах, бялдах, эрээлж мяраалах.

РАЗМАЛЁВЫВАТЬ бялах, бялдах, эрээлж мяраалах.

РАЗМА́ЛЫВАТЬ тээрэмдэх, нүдэх, талхлах.

РАЗМА́ЛЫВАТЬСЯ 1. гурил болох, талх болох; 2. тээрэмдэгдэх, нүдэгдэх, талхлагдах.

РАЗМА́ТЫВАТЬ тайлах, задлах, дэлгэх, цувах.

РАЗМА́ТЫВАТЬСЯ задрах, цувах, тайлах.

РАЗМА́Х 1. далайх, далайц, эрч; **ударить с ~у** далайн цохих; **перескочить с ~у** эрчиндээ харайн гарах; 2. алд, дэлэц, далайц; ~ **крыльев самолета** онгоцны далавчны дэлэц; 2. далайц.

РАЗМА́ХИВАТЬ дэвэх, дэлэх, сарваганууулах, даллах, дэрвэх, дэрвэлзүүлэх; ~ **руками** гараа сарваганууулах.

РАЗМА́ХИВАТЬСЯ далайх.

РАЗМАХНУ́ТЬСЯ далайх.

РАЗМА́ЧИВАТЬ дэвтээх, норгох.

РАЗМА́ШИСТО сийрүү таталган, далайц, дэлэц, хол; ~ **писать** сийрүү таталган бичих.

РАЗМА́ШИСТЫЙ далайц ихтэй, далайсан, дэлсэн, хол, сийрүү таталгасан; ~ **шаг** хол алхаа; ~ **почерк** сийрүү таталгасан бичиг.

РАЗМЕЖЕВА́ТЬ 1. заагласх, заар гаргах; ~ **землю** газар заагласх; 2. заагласх, заар тогтоох, тодорхойлох.

РАЗМЕЖЕВА́ТЬСЯ 1. заагласхдах, заагласн тусгаарлах; 2. (*үйл ажиллагааныхаа*) заагийг тогтоох, тодорхойлох, заагласн тусгаарлах; 3. заагласн салах, заагласн холдох, хөндийрөх.

РАЗМЕЖЁВЫВАТЬ 1. заагласх, заар гаргах; 2. заагласх, заар тогтоох, тодорхойлох.

РАЗМЕЖЁВЫВАТЬСЯ 1. заагласхдах, заагласн тусгаарлах; 2. (*үйл ажиллагааныхаа*) заагийг тогтоох, тодорхойлох, заагласн тусгаарлах; 3. заагласн салах, заагласн холдох, хөндийрөх.

РАЗМЕЛЬЧА́ТЬ нүдэх, талхлах, бутлах, жижиглэх, үйрүүлэх.

РАЗМЕЛЬЧЕ́НИЕ нүдэх, талхлах, бутлах, жижиглэх, үйрүүлэх, нүдлэг, бутлалт, үйрүүллэг, нунтаглах.

РАЗМЕЛЬЧИ́ТЬ нүдэх, талхлах, бутлах, жижиглэх, үйрүүлэх.

РАЗМЕ́Н 1. задлах, бутлах, жижиглэх; ~ **денег** мөнгө задлах; 2. солио, арилжаа, солих, арилжих.

РАЗМЕ́НИВАТЬ 1. задлах, бутлах, жижиглэх; 2. солих, арилжих.

РАЗМЕ́НИВАТЬСЯ 1. солих, арилжих; 2. солигдох, арилжигдах.

РАЗМЕ́НН||ЫЙ 1. задгай, бутархай, жижиг; **~ые деньги** задгай мөнгө; **~ая монета** жижиг мөнгө; 2. солионы, арилжааны, солих, арилжих.

РАЗМЕНЯ́ТЬ 1. задгай, бутархай, жижиг; 2. солих, арилжих.

РАЗМЕНЯ́ТЬСЯ солих, арилжих; ~ **пешками** шатрын хүү арилжих; ~ **на мелочи, по мелочам** аар саар юманд авьяас чадлаа барах.

РАЗМЕ́Р хэм, хэмжээ; ~ **костюма** хувцасны хэмжээ.

РАЗМЕ́РЕНН||ЫЙ жигд хэмнэлтэй; **~ые движение** жигд хөдөлгөөн.

РАЗМЕ́РИТЬ,

РАЗМЕРЯ́ТЬ хэмжих.

РАЗМЕСИ́ТЬ зуурах; ~ **тесто** гурил зуурах.

РАЗМЕСТИ́ шүүрдэх, хамах; ~ **снег** цас хамах.

РАЗМЕСТИ́ТЬ 1. тавих, өрөх, байрлуулах, байрыг олгох, суулгах; 2. тараах, оногдуулах; ~ **заём** зээллэг тараах, зээллэг захиалуулах.

РАЗМЕСТИ́ТЬСЯ багтах, байраа олох, сууж авах.

РАЗМЕТА́ТЬ I шүүрдэх, хамах.

РАЗМЕТА́ТЬ II тараах, тарааж хаях.

РАЗМЕТА́ТЬСЯ 1. тэлчилж эхлэх, тэлчигнэж эхлэх; ~ **во сне** унтаагаараа тэлчигнэж эхлэх; 2. тарайн хэвтэх, тэрийн хэвтэх.

РАЗМЕ́ТИТЬ тэмдэглэх, тэмдэг тавих.

РАЗМЕ́ТКА 1. тэмдэглэх, тэмдэг тавих; 2. тэмдэг; 3. хэмжээ тавилт, тэмдэглэгээ.

РАЗМЕ́ТЫВАТЬ тараах, тарааж хаях.

РАЗМЕЧА́ТЬ тэмдэглэх, тэмдэг тавих.

РАЗМЕША́ТЬхутгах, холих; ~ **сахар в чае** цайнд сахар хийж хутгах.

РАЗМЕЩА́ТЬСЯ 1. багтах, байраа олох, сууж авах; 2. тавигдах, өрөгдөх; 3. тараагдах.

РАЗМЕЩЕ́НИЕ 1. тавих, өрөх, байрлуулах, байрыг олгох, суулгах; 2. тараах, оногдуулах.

РАЗМИНА́ТЬ 1. нидчих, нухчих, элдэх; 2. зуурах, багсрах, нухах, эвлүүлэх, нийлүүлэх; 3. чилээ гаргах, нухлах, дарах, барих.

РАЗМИНА́ТЬСЯ 1. нухлагдах, элдэгдэх, зөөлрөх; 2. зуурагдах, багсрагдах, нухагдах, эвлэх, нийлэх; 3. биеийнхээ чилээг гаргах.

РАЗМИНИ́РОВАНИЕ мина арилгах, мина хураах, мина арилгалт, мина хураалт.

РАЗМИНИ́РОВАТЬ мина арилгах, мина хураах.

РАЗМИНУ́ТЬСЯ зөрөх, зөрөн гарах, зөрөн өнгөрөх; ~ **с товарищем** нөхөртэйгөө зөрөх.

РАЗМНОЖА́ТЬ 1. олон болгох, олшууруулах; 2. үржүүлэх, өсгөх.

РАЗМНОЖА́ТЬСЯ 1. олон болох, олшрох; 2. үржих, өсөх.
РАЗМНОЖЕ́НИЕ 1. олон болгох, олшууруулах; 2. үржих, үржил, өсгөх; **половое ~** бэлгийн үржил; **бесполое ~** бэлгийн бус үржил.
РАЗМНО́ЖИТЬ 1. олон болгох, олшууруулах; **~ рукопись** (*бичмэл*) *бичиг олон хувь болгох*; 2. үржүүлэх, өсгөх.
РАЗМНО́ЖИТЬСЯ 1. олон болох, олшрох; 2. үржих.
РАЗМОЗЖИ́ТЬ бяцлах, бяц цохих; **~ голову** толгой бяц цохих.
РАЗМОКА́ТЬ,
РАЗМО́КНУТЬ дэвтэх, нялцайх.
РАЗМО́Л 1. тээрэмдэх, нүдэх; 2. (*гурилын*) чанар, ширхэг, тээрэмдэлт; **мука крупного ~а** бүдүүн (*ширхэгтэй*) гурил.
РАЗМО́ЛВКА муудах, эвгүй болох; **~ между друзьями** найз нар муудах.
РАЗМОЛО́ТЬ тээрэмдэх, нүдэх, талхлах; **~ пшеницу** улаан буудай тээрэмдэх.
РАЗМОЛО́ТЬСЯ гурил болох, талх болох.
РАЗМОРИ́||ТЬ тэнхээ алдруулах, зүдрээх; **жара меня ~ла** халуунд тэнхээ алдрав.
РАЗМОРИ́ТЬСЯ тэнхээ алдрах, зүдрэх.
РАЗМОТА́ТЬ тайлах, задлах, дэлгэх, цувах; **~ повязку с раны** шархны боолт задлах.
РАЗМОТА́ТЬСЯ задрах, цувах, тайлах.
РАЗМО́ТКА задлах, цувах, **~ пряжи** зэрмэл цувах.
РАЗМОЧИ́ТЬ дэвтээх, норгох.
РАЗМЫ́В 1. усанд идэгдэх; **~ плотины** далан усанд идэгдэх; 2. усанд идэгдсэн газар.
РАЗМЫВА́НИЕ усанд идэгдэх, нурах.
РАЗМЫВА́ТЬ идэх,эвдэх, нураах.
РАЗМЫВА́ТЬСЯ усанд идэгдэх, нурах.
РАЗМЫКА́ТЬ таслах, таслан салгах, салгах, нээх.
РАЗМЫ́СЛИТЬ бодох, бодож үзэх, эргэцүүлэх; **~ о своих делах** ажил явдлаа бодох.
РАЗМЫ́ТЫЙ усанд идэгдсэн, нурсан; **~ берег** усанд идэгдсэн эрэг.
РАЗМЫ́||ТЬ идэх, нураах, эвдэх; **река ~ла берег** гол эргээ нураажээ.
РАЗМЫ́ТЬСЯ усанд идэгдэх, нурах.
РАЗМЫШЛЕ́НИ||Е 1. бодох, бодож үзэх, эргэцүүлэн бодох, бодлого болох, шүүж үзэх, тунгааж бодох; **дать время на ~** эргэцүүлэн бодох; **человек өгөх**; 2. бодлого, бодол, бодлого болох, бодож үзэх, эргэцүүлэн бодох; **быть погруженным в ~я** бодлого болж байх; **после долгих ~й** удаан эргэцүүлэн бодоод; **наводить на ~** *бодлого болгох*.
РАЗМЫШЛЯ́ТЬ бодох, бодож үзэх, эргэцүүлэн бодох, бодлого болох, шүүж үзэх, тунгааж бодох;
РАЗМЯГЧА́ТЬ 1. зөөлрүүлэх, зөөлөн болгох, дэвтээх; 2. уяруулах, зөөлрүүлэх.
РАЗМЯГЧА́ТЬСЯ 1. зөөлрөх, зөөлөн болох, дэвтэх; 2. уярах, зөөлрөх.
РАЗМЯГЧЕ́НИЕ зөөлрөх; **~ костей** яс зөөлрөх.
РАЗМЯГЧИ́ТЬ 1. зөөлрүүлэх, зөөлөн болгох, дэвтээх; **~ кожу** арьс дэвтээх; 2. уяруулах, зөөлрүүлэх; **~ сердце** сэтгэлий нь уяруулах.
РАЗМЯГЧИ́||ТЬСЯ 1. зөөлрөх, зөөлөн болох, дэвтэх; **кожа ~лась** арьс дэвтжээ; 2. уярах, зөөлрөх; **сердце ~лось** сэтгэл нь уярав.
РАЗМЯКА́ТЬ 1. зөөлрөх, зөөлөн болох, дэвтээх, няшлах; 2. хийморь нь буух, сүлд нь буурах.
РАЗМЯ́ТЬ 1. нидрэх, нухлах, элдэх; **~ кожу** арьс элдэх; 2. зуурах, багсрах, нухах, эвлүүлэх, нийлүүлэх; **~ глину** шавар эвлүүлэх; 3. чилээ гаргах, нухлах, дарах, барих; **~ ноги** хөлийнхөө чилээг гаргах.
РАЗМЯ́||ТЬСЯ 1. нухчигдах, элдэгдэх, зөөлрөх; **кожа ~лась** арьс зөөлрөв; 2. зуурагдах, багсрагдах, нухагдах, эвлэх, нийлэх; **глина ~лась** шавар эвлэв; 3. биеийнхээ чилээг гаргах.
РАЗНАРЯ́ДКА цохдос; **~ на лесные материалы** модны цохдос.
РАЗНА́ШИВАТЬ өмсөж хэлбэх.
РАЗНА́ШИВАТЬСЯ хэлбэгдэх.
РАЗНЕ́ЖИТЬСЯ 1. нялуурхах, уярах; 2. таатай байх, танхилах.
РАЗНЕСЕ́НИЕ бичиж тэмдэглэх.
РАЗНЕС||ТИ́ 1. тараах, түгээх, хүргэх; 2. тархаах, дэлгэрүүлэх; **~ слух** цуурхал тархаах; 3. хэмхлэх, хэмх татах; **буря ~ла лодку в щепки** шуурга завийг зомгол болгов; 4. хөөх, сарниулах; 5. хавдах, бамбайх, бандайх; **щёку ~ло** хацар хавдав; 6. зад загнах; **~ в пух и прах** зад загнах.
РАЗНЕСТИ́СЬ 1. тархах, тархан дэлгэрэх, дэлгэх; **~ слухи** цуу үг тархах; 2. гарах, дуулах, сонсдох; **разнёсся звон** хангинах дуу сонсдов.
РАЗНИМА́ТЬ 1. салгах, задлах; 2. салгах, тусгаарлах.
РА́ЗНИЦ||А 1. зөрөө; 2. ялгаа, ялгавар, ялгал; **~ в цене** үнийн ялгаа; **с той ~ей, что** тийм ялгаатай; **это большая ~** энэ ч их *өөр байна*; **какая ~?** *ямар ялгаа байна аа?*
РА́ЗНО элдвээр, янз янз, өөр өөр; **об этом можно думать ~** үүнийг элдвээр бодож болно.
РАЗНОБО́Й зөрөө, зөрөлдөөн; **~ в правописании** үсгийн дүрмийн зөрөө.
РАЗНОВЕ́С жижиг годил, туухай.
РАЗНОВИ́ДНОСТЬ (*нэг*) зүйл; **~ пшеницы** нэг зүйл улаан буудай; **РАЗНОВИ́ДНЫЙ** *зүйл зүйлийн, зүйл бүрийн, элдэв зүйлийн*.
РАЗНОВРЕМЕ́ННЫЙ өөр, өөр цагт болсон.
РАЗНОГЛА́СИ||Е 1. зөрөө, зөрөлдөөн, өөр өөр үзэлтэй байх; 2. зөрөлдөөн, зөрчил, зөрөх, зөрөлдөх; **~я в показаниях свидетелей** гэрч нарын мэдүүлэг зөрөх.
РАЗНОГОЛО́СИЦА 1. хоолой нийлэхгүй дуулах, ам амандаа дуулах; 2. зөрөлдөөнтэй байх, өөр өөр саналтай байх.
РАЗНОГОЛО́С||ЫЙ 1. хоолой нийлээгүй; **~ое пение** хоолой нийлээгүй дуулах, ам амандаа дуулах; 2. өөр өөр дуутай өөр донгоддог.
РА́ЗНОЕ бусад асуудал, бусад зүйл.
РАЗНОЗНА́ЧАЩИЙ,
РАЗНОЗНА́ЧНЫЙ өөр утгатай, утга ондоо.
РАЗНОИМЁННЫЙ,өөр өөр нэртэй.
РАЗНОКАЛИ́БЕРНЫЙ элдэв калибрын, өөр өөр калибртай.
РАЗНОЗМА́СТНЫЙ элдэв зүсний, янз янз зүстэй, өөр өөр зүсмийн.
РАЗНООБРА́ЗИЕ элдэв янз байх, олон янз байх; **~ впечатлений** элдэв янз сэтгэгдэл.
РАЗНООБРА́ЗИТЬ элдэв янз болгох, олон янз болгох.
РАЗНООБРА́ЗНОСТЬ элдэв янз байх, олон янз байх.
РАЗНООБРА́ЗНЫЙ элдэв янзын, олон янзын, янз янзын.
РАЗНОПЛЕМЁННЫЙ олон угсаатны, олон ястнаас бүрдсэн, *олон хэлтэн*.
РАЗНОРЕЧИ́В||ЫЙ зөрөөтэй, зөрчилтэй, элдвийн; **~ые слухи** элдвийн цуурхал.
РАЗНОРО́ДН||ЫЙ элдэв төрлийн, элдэв янзын; **~ые вещества** элдэв төрлийн бодис; **~ые явления** олон янзын үзэгдэл.
РАЗНО́С 1. тараах, түгээх, хүргэх; 2. загнах, донгодох.
РАЗНОСИ́ТЬ I өмсөж хэлбэх; **~ обувь** гутал өмсөж хэлбэх.
РАЗНОСИ́ТЬ II 1. тараах, түгээх, хүргэх; 2. бичиж тэмдэглэх; 3. тараах, дэлгэрүүлэх; 4. хэмхлэх, хэмх татах; 5. хөөх, сарниулах; 6. хавдах, бамбайх, бандайх; 7. зад загнах.
РАЗНОСИ́||ТЬСЯ I хэлбэгдэх; **~лись сапоги** савхин гутал хэлбэгджээ.

РАЗНОСИ́ТЬСЯ II 1. тархах, тархан дэлгэрэх, дэлгэрэх; 2. гарах, дуулдах, сонсдох.
РАЗНО́СКА тараах, түгээх, хүргэх.
РАЗНО́СН||ЫЙ 1. тараах, түгээх; **~ая книга** түгээх данс; 2. дамнуурын, ганзагын, хайрцгийн; **~ая торговля** дамнуурын худалдаа.
РАЗНОСО́Л 1. элдвээр давслах, дарах; 2. янз бүрийн идээ, тансаг идээ.
РАЗНОСТОРО́ННЕ||ИЙ 1. тэгш бус талтай; **~ треугольник** тэгш бус талтай гурвалжин; 2. олон янзын, зүйл зүйлийн, олон талын, тал бүрийн, арван хуруу тэгш, тал бүрийн авъяастай; **~яя деятельность** олон янзын үйл ажиллагаа; **~ человек** арван хуруу тэгш хүн, тал бүрийн авъяастай хүн.
РАЗНОСТОРО́ННОСТЬ 1. тэгш бус талтай (*байх*); 2. олон янз талтай (*байх*); 3. зүйл зүйлийн талтай (*байх*), олон талтай (*байх*), арван хуруу тэгш (*байх*), өвтэгш (*байх*).
РА́ЗНОСТЬ 1. ялгавар, ялгаа; **~ потенциалов** чадавхийн ялгаа; 2. ялгаа, ялгал, өөр өөр (*байх*); **~ взглядов** үзлийн ялгаа, өөр өөр үзэл.
РАЗНО́СЧИК 1. тархаагч, хүргэгч; **~ газет** сонин тархаагч; 2. дамнуурын худалдаачин.
РАЗНОЦВЕ́ТН||ЫЙ элдэв өнгийн, олон өнгийн, өнгө өнгийн, өнгө бүрийн; **~ые ткани** өнгө бүрийн бөс.
РАЗНОЧИ́НЕЦ тайж бус сэхээтэн.
РАЗНОЧТЕ́НИЕ өөр найруулга.
РАЗНОШЁРСТН||ЫЙ 1. элдэв зүсмийн, зүс бүрийн; **~ые лошади** зүс бүрийн адуу; 2. зүсэн зүйлийн, зүс бүрийн, өнгө бүрийн; **~ая публика** зүсэн зүйлийн хүмүүс.
РАЗНОЯЗЫ́ЧНЫЙ элдэв хэлтэн, янз бүрийн хэлтний, олон хэлний.
РАЗНУ́ЗДАННЫЙ 1. ужид самуун, өж нөр; 2. зоргоороо аашилсан, зоргондоо загнадаг, жолоогүй, галзуу.
РАЗНУЗДА́ТЬ I амгайчлах; 2. зоргонд нь тавих, зоргоор нь орхих.
РАЗНУЗДА́ТЬСЯ I амгайчлагдах, амгай мултрах; 2. зоргондоо болох, зоргоороо болох.
РАЗНУ́ЗДЫВАТЬ I амгайчлах; 2. зоргонд нь тавих, зоргоор нь орхих.
РАЗНУ́ЗДЫВАТЬСЯ I амгайчлагдах, амгай мултрах; 2. зоргондоо болох, зоргоороо болох.
РА́ЗН||ЫЙ 1. өөр, өөр өөр, онд ондоо; **~ые взгляды** өөр өөр үзэл; 2. элдэв, янз янзын, өнгийн, янз бүрийн; **букет ~ых цветов** өнгийн цэцгийн баглаа; 3. зүсэн зүйлийн, өнгө бүрийн, элдвийн.
РАЗНЮ́ХАТЬ,
РАЗНЮ́ХИВАТЬ 1. үнэртэх, шиншлэх, үнэрлэж мэдэх; 2. далдуур мэдэх.
РАЗНЯ́ТЬ 1. салгах, задлах; **~ на части** хэсэг хэсгээр нь задлах; 2. салгах, тусгаарлах; **~ дерущихся** зодолдогчдыг салгах.
РАЗОБЛАЧА́ТЬ 1. нүцгэлэх; 2. илрүүлэх, хулгайг барих.
РАЗОБЛАЧА́ТЬСЯ 1. хувцаа тайлах, нүцгэлэх; 2. илрэх, мэдэгдэх.
РАЗОБЛАЧЕ́НИЕ илрүүлэх, хулгайг барих.
РАЗОБЛАЧИ́ТЬ 1. нүцгэлэх; 2. илрүүлэх, хулгайг барих.
РАЗОБЛАЧИ́ТЬСЯ 1. хувцаа тайлах, нүцгэлэх; 2. илрэх, мэдэгдэх.
РАЗОБРА́||ТЬ 1. цөмийг авчих, бултыг худалдан авах; **все *лучшие книги уже ~ли*** хамаг сайн номыг нь бултыг худалдан авчээ; 2. задлах, салган тавих, эвдлэх; **~ часы** цаг задлах; 3. хураах, хурааж тавих, задлан тавих, цэгцлэх; 4. тараах; **~ набор** ерсөн үсэг тараах; 5. судлах, шүүх, байцаах; 6. задлан шинжлэх, шүүмжлэн үзэх; **~ предложение** өгүүлбэр задлан шинжлэх, задлах; 7. мэдэх, таних, ойлгох, гаргах; **~ подпись** гарын үсгийг гаргах; 8. автах, төрөх; **его ~ла зависть** атаархах сэтгэлд автав; 9. согтоох, толгойд гарах; **вино его быстро ~ло** архи түүнийг түргэн согтоов.
РАЗОБРА́ТЬСЯ 1. юмаа хураах, эмхлэх, цэгцлэх; 2. учрыг олох, ойлгох, мэдэх; **~ в деле** хэргийн учрыг олох.
РАЗОБЩА́ТЬ 1. салгах, тусгаарлах, ялгах, хөндийрүүлэх, холдуулах; 2. задлах, салгах, таслах.
РАЗОБЩА́ТЬСЯ 1. холдох, хөндийрөх, холбоо тасрах; 2. салах, холдох, хөндийрөх.
РАЗОБЩЁННОСТЬ 1. салгах, тусгаарлах, ялгах, хөндийрүүлэх, холдуулах; 2. задлах, салгах, таслах.
РАЗОБЩИ́ТЬСЯ 1. холдох, хөндийрөх; 2. задрах, салах, тасрах.
РА́ЗОВЫЙ нэг удаагийн; **~ пропуск** нэг удаагийн нэвтрэх хуудас.
РАЗОГНА́||ТЬ 1. тараах, үлдэн хөөх; **~ толпу** цугласан хүмүүсийг тараах; 2. сэргээх, гаргах, дарах; **~ скуку** уйтгар гаргах; 3. улам хурдлуулах, хар хурдаар давхих; **~ машину** машиныхаа хар хурдаар давхих; 4. хөөх, сарниулах; **ветер ~л тучи** салхи үүл сарниулав.
РАЗОГНУ́ТЬ шулуутгах, тэгшлэх, тэнийлгэх; **~ гвоздь** хадаас шулуутгах; **~ спину** 1) нуруугаа тэнийлгэх, 2) хүнд дарамтаас ангижрах.
РАЗОГНУ́ТЬСЯ тэнийх, шулуун болох, цэх болох.
РАЗОГРЕВА́ТЬ бүлээсгэх, халаах.
РАЗОГРЕВА́ТЬСЯ халуун бүлээн болох, халах.
РАЗОГРЕ́ТЬ бүлээсгэх, халаах; **~ мотор** мотор халаах; **~ обед** хоол халаах.
РАЗОГРЕ́ТЬСЯ халуун бүлээн болох, халах.
РАЗОДЕ́ТЬ гоёх, гоё хувцас өмсгөх.
РАЗОДЕ́ТЬСЯ гоёх, гоё хувцаслах.
РАЗОДРА́ТЬ урах, ураад хаячих, цуу татах, ханз татах, хуу татах, тас татах; **~ брюки** өмдөө цуу татах.
РАЗОДРА́ТЬСЯ урагдах, цуурах, ханзрах.
РАЗОЗЛИ́ТЬ уурыг нь бадруулах, ихэд уурлуулах.
РАЗОЗЛИ́ТЬСЯ уур бадрах, ихэд уурлах.
РАЗОЙТИ́СЬ 1. тарах, тархах; **~ по домам** гэр гэртээ тарах; 2. тарах, тархах, сарних; **тучи разошлись** үүл сарнив; 3. тэнийх, арилах; **морщины на лбу разошлись** магнайн атираа тэнийв; 4. салах, хагацах; **~ с женой** эхнэрээсээ салах; 5. ярагдах, завсар гарах, ангайх; **половицы разошлись** шалд завсар гарав; 6. нийлэхээ байх, таарахгүй болох, зөрөх; **их пути разошлись** тэдний зам нийлэхээ байв; **~ во взглядах** үзэл зөрөх, 7. үрэгдэх, дуусах, барагдах, зарж дуусах; **деньги разошлись** мөнгө үрэгдэв; 8. зөрөх, алгасах; **~ в темноте** харанхуйд зөрөх; 9. харих, намдах; **опухоль разошлась** хавдар харив; 10. хайлах, шингэх, уусах; 11. гаарах, ширүүсэх; **буря разошлась** шуурга гаарав; 12. хөөрөх, хөгжих.
РАЗО́К дахиад нэг, нэг удаа; **ещё ~** бас дахиад нэг; **~-другой** нэг хоёр удаа.
РА́ЗОМ 1. нэг зэрэг, зэрэг зэрэг, нэг дор, дор дороо; **все закричали ~** бүгдээрээ зэрэг хашгиралдав; 2. бүгд, зэрэг, нэг амиар, нэг мөсөн; **прочесть всё ~** цөмийг нэг амиар уншчих; 3. дор нь, агшин зуур; **~ покончить с чем-либо** юмыг дор нь үгүй хийх.
РАЗО́МКНУТЫЙ дэлгэмэл, таранги; **~ строй** дэлгэмэл жагсаал.
РАЗОМКНУ́ТЬ таслах, таслан салгах, нээх, дэлгэх; **~ цепь** гинж таслах.
РАЗОМКНУ́||ТЬСЯ тасрах, тасран салах, нээгдэх; **~лась цепь** гинж тасрав.

РАЗОМЛЕ́ТЬ тэнхэл алдрах, сульдах, тамирдах; ~ **от жары** халуунд тэнхэл алдрах.

РАЗОПРЕ́||ТЬ хөөх, өсөх, үлтрэх; **горох ~л** буурцаг өсөв, буурцаг үлтрэв.

РАЗОРВА́||ТЬ 1. урах, тасар татах, таслах; ~ **бумагу** цаас урах; 2. тэсрэх, тэс үсрэх; **котёл ~ло** тогоо тэсрэв; 3. таслах; ~ **отношения** харилцаа таслах.

РАЗОРВА́ТЬСЯ урагдах, тасрах, яз үсрэх; **не ~ же ему** тэр хүн нэг биеэ хуваалтай биш дээ.

РАЗОРЕ́НИЕ 1. үгүйрэх, хоосрох, ядуурах; 2. хоосруулах, сүйтгэх, сандаах, эвдэх.

РАЗОРИ́ТЕЛЬН||ЫЙ, *хоосруулах, үгүйрүүлэх, сүйтгэх;* **~ые траты** хоосруулах үрлэг.

РАЗОРИ́ТЬ 1. үгүйрүүлэх, хоосруулах, ядууруулах; 2. хоосруулах, сүйтгэх, сандаах, эвдэх; ~ **птичье гнездо** шувууны үүр сандаах.

РАЗОРИ́ТЬСЯ хоосрох, үгүйрэх, ядуурах.

РАЗОРУЖА́ТЬ 1. зэвсэг хураах, зэвсгийг мухарлах; 2. гар мухарлах, гар мухар болгох, аргагүй болгох.

РАЗОРУЖА́ТЬСЯ 1. зэвсгээ хураах; 2. гар мухар болох, арга барагдах; 3. зэвсгээ хураагдах.

РАЗОРУЖЕ́НИЕ зэвсэг хураах; **всеобщее** ~ бүх нийтээрээ зэвсгээ хураах.

РАЗОРУЖИ́ТЬ 1. зэвсэг хураах, зэвсгийг мухарлах; 2. гар мухарлах, гар мухар болгох, аргагүй болгох.

РАЗОРУЖИ́ТЬСЯ 1. зэвсгээ хураах; 2. гар мухар болох, арга барагдах; **идейно** ~ үзэл суртлын талаар арга барагдах.

РАЗОРЯ́ТЬ 1. үгүйрүүлэх, хоосруулах, ядууруулах; 2. хоосруулах, сүйтгэх, сандаах, эвдэх.

РАЗОРЯ́ТЬСЯ хоосрох, үгүйрэх, ядуурах.

РАЗОСЛА́ТЬ тараах, түгээх, (*газар газар*) илгээх, явуулах; ~ **письма** бичиг тараах.

РАЗОСПА́ТЬСЯ унтаж, унтачхах.

РАЗОСТЛА́ТЬ дэвсэх, дэлгэх; ~ **ковёр** хивс дэвсэх.

РАЗОСТЛА́ТЬСЯ татах, суунаглах, бүрхэх.

РАЗОТКА́ТЬ хатгах, зүү ороох; ~ **узорами** угалз хатгах.

РАЗОХО́ТИТЬСЯ дур хүрэх, хүсэл төрөх.

РАЗОЧАРОВА́НИЕ урам хугарах, итгэлгүй болох; ~ **в жизни** амьдрах урам хугарах.

РАЗОЧАРО́ВАННОСТЬ урам хугарсан байдал.

РАЗОЧАРО́ВАННЫЙ урам хугарсан; ~ **человек** урам хугарсан хүн.

РАЗОЧАРОВА́ТЬ урам хугалах, итгэл алдах.

РАЗОЧАРОВА́ТЬСЯ урам хугарах, итгэлгүй болох, итгэхээ болих; ~ **в друзьях** нөхдийгөө итгэхээ болих.

РАЗОЧАРО́ВЫВАТЬ урам хугалах, итгэл алдах.

РАЗОЧАРО́ВЫВАТЬСЯ урам хугарах, итгэлгүй болох, итгэхээ болих.

РАЗРАБА́ТЫВАТЬ 1. боловсруулах, тохижуулан засах; 2. боловсруулах, сайжруулах; 3. боловсруулах, судлан бэлтгэх; 4. малтахад бэлтгэх, малтах, ашиглаж дуусах.

РАЗРАБА́ТЫВАТЬСЯ боловсруулагдах.

РАЗРАБО́ТАННОСТЬ боловсруулах, боловсруулалт.

РАЗРАБО́ТАТЬ 1. боловсруулах, тохижуулан засах; ~ **землю под огород** ногоо тарих газар боловсруулах; 2. боловсруулах, сайжруулах; ~ **голос** хоолойгоо сайжруулах; 3. боловсруулах, судлан бэлтгэх; ~ **вопрос** асуудал боловсруулах; 4. малтахад бэлтгэх, малтах, ашиглаж дуусах.

РАЗРАБО́ТК||А 1. боловсруулах, боловсруулалт; ~ **новых методов лечения** эмчилгээний шинэ арга барил боловсруулах; 2. ~**и** малтах, малтлага; 3. малтах газар, огтлох газар.

РАЗРА́ВНИВАТЬ тэгшлэх, толигор болгох.

РАЗРАЖА́ТЬСЯ,

РАЗРАЗИ́ТЬСЯ 1. *нижигнэх, нижигнэж эхлэх, шир хийх,* асгарах; **разразилась гроза** дуутай бороо нижигнэж эхлэв; 2. тачигнатал... гарах, тавих; ~ **смехом** тачигнатал инээж гарах; ~ **бранью** хараал тавих, харааж гарах.

РАЗРАСТА́ТЬСЯ ургах, саглайх, саглагар болох; **кусты разрослись** бут саглагар болжээ.

РАЗРЕВЕ́ТЬСЯ орилоон майлаан болох, орилох.

РАЗРЕДИ́ТЬ 1. сийрэг болгох, сийрэгжүүлэх, тармаг болгох; ~ **кусты** бут тармаг болгох; 2. шингэрүүлэх, сийрүүлэх; ~ **воздух** агаар сийрүүлэх.

РАЗРЕДИ́||ТЬСЯ шингэрэх, сийрэх; **туман ~лся** манан сийрэв.

РАЗРЕЖА́ТЬ 1. сийрэг болгох, сийрэгжүүлэх, тармаг болгох; 2. шингэрүүлэх, сийрүүлэх.

РАЗРЕЖА́ТЬСЯ шингэрэх, сийрэх.

РАЗРЕЖЕ́НИЕ шингэрүүлэх, сийрүүлэх, шингэрэх, сийрэх; ~ **воздуха** агаар сийрэх.

РАЗРЕЖЁННОСТЬ сийрэг байх, шингэн байх; ~ **воздуха на высоте** өндөр газрын сийрэг агаар.

РАЗРЕЖЁННЫЙ 1. сийрэг, тармаг, шингэн; 2. сиймгэр, сиймийсэн, сийрсэн, шингэрсэн.

РАЗРЕ́З 1. огтлох, зүсэх; ~ **вертикальный** босоо зүсэх; 2. эгэлсэн газар, огтолсон газар; ~ **на руке** гараа эгэлсэн газар; 3. оноо; ~ **платья** хувцасны оноо; 4. огтлоос, огтлол, яралт, яраас; **поперечный** ~ хөндлөн огтлоос, хөндлөн яраас; **продольный** ~ дагуу огтлоос, дагуу яраас; **в ~е** үүднээс, ёсоор; ~ **глаз** нүд.

РАЗРЕ́ЗАТЬ,

РАЗРЕЗА́ТЬ эгэх, ярах, огтлох, зүсэх; ~ **на части** хэсэг хэсэг огтлох; ~ **хлеб** талх зүсэх.

РАЗРЕЗНО́Й 1. огтлох, зүсэх, эгэх; ~ **нож** зүсүүр, огтлуур; 2. оноотой.

РАЗРЕКЛАМИ́РОВАТЬ хэтэрхий магтах.

РАЗРЕША́ТЬ 1. *зөвшөөрөх;* 2. шийдвэрлэх, шийдэх, таслах; 3. тайлах, таслах.

РАЗРЕША́ТЬСЯ 1. тайлагдах; 2. шийдвэрлэгдэх, шийдэгдэх; 3. хориогүй байх, үл цээрлэх.

РАЗРЕШЕ́НИЕ 1. зөвшөөрөл, зөвшөөрөх; **дать** ~ зөвшөөрөл олгох; 2. зөвшөөрөл, зөвшөөрлийн бичиг; **получить письменное** ~ зөвшөөрлийн бичиг авах; 3. шийдвэрлэх, таслах; ~ **вопроса** асуудал шийдвэрлэх; ~ **конфликта** будлиан таслах.

РАЗРЕШИ́МЫЙ шийдвэрлэж болох, шийдэж болмоор, зөвшөөрч болох, тайлж болмоор; ~ **вопрос** шийдвэрлэж болох асуудал.

РАЗРЕШИ́||ТЬ 1. зөвшөөрөх, зөвшөөрөл өгөх, эрх олгох, (*болно*) гэх; 2. шийдвэрлэх, шийдэх, таслах, нэг тийш болгох; 3. тайлах, таслах; ~ **сомнения** сэжиг тайлах; ~ **конфликт** шийдвэрлэх, шийдэх, таслах; будлиан таслах; ~**те зөвшөөрнө үү, зөвшөөрмүү; ~те объявить заседание открытым** хурал нээснийг мэдэгдье.

РАЗРЕШИ́||ТЬСЯ тайлагдах; **загадка ~лась** оньсого тайлагдав; 2. шийдвэрлэгдэх, шийдэгдэх, нэг тийш болох; 3. хөнгөрөх, хоёр яс хагацах, төрөх; ~ **от беременности** хоёр яс хагацах, төрөх.

РАЗРИСОВА́ТЬ эрээлэн зурах, хээлэх.

РАЗРИСО́ВКА эрээлэн зурах, хээлэлт.

РАЗРИСО́ВЫВАТЬ эрээлэн зурах, хээлэх.

РАЗРОВНЯ́ТЬ тэгшлэх, толигор болгох; ~ **площадь** талбай тэгшлэх.

РАЗРО́ЗНЕННОСТЬ салангад байх, тархай бутархай байх.

РАЗРО́ЗНЕННЫЙ 1. салангад, ганц нэг, хэсэг бусаг, ижил буруу, холимог.
РАЗРУ́ХА эвдрэл, задрал.
РАЗРУШЕ́НИЕ эвдрэл, сүйдэл, эвдлэх, нураах.
РАЗРЫ́В хагарсан газар.
РАЗУЗНАВА́ТЬ,
РАЗУЗНА́ТЬ сураглаж мэдэх, асууж лавлах.
РАЗУКРА́СИТЬ гоёж чимэглэх, гоёж чимэх.
РАЗУКРА́СИТЬСЯ гоёж гоёчих, чимэг зүүх, чимэх.
РАЗУКРА́ШИВАТЬ гоёж гоёх, гоёж чимэглэх.
РАЗУКРА́ШИВАТЬСЯ гоёж гоёчих, чимэг зүүх, чимэх.
РАЗУКРУПНЕ́НИЕ жижиглэх.
РАЗУКРУПНИ́ТЬ жижиглэх, жижиг болгох, хэсэглэн жижиглэх.
РАЗУКРУПНИ́ТЬСЯ жижиг болох, хуваагдан жижгэрэх.
РАЗУКРУПНЯ́ТЬ жижиглэх, (*жижиг*) жижиг болгох, хэсэглэн жижиглэх.
РАЗУКРУПНЯ́ТЬСЯ жижиг болох, хуваагдан жижгэрэх.
РА́ЗУМ оюун ухаан, ой; **у него ~ помутился** тэр (*хүн*) элий балай болжээ.
РАЗУМЕ́ЕТСЯ мэдээжийн хэрэг; **~, он придёт** түүний ирэх нь мэдээжийн хэрэг; **само собой ~** аяндаа мэдээжийн хэрэг.
РАЗУМЕ́НИЕ ухах, ойлгох.
РАЗУМЕ́||ТЬ 1. ухах, ойлгох; 2. гэж хэлэх гэх, гэх санаатай байх; **что он ~ет под этими словами?** ингэж хэлдэг нь юу гэх гэсэн юм бэ?
РАЗУМЕ́||ТЬСЯ ухаж болох, ойлгож болох, тухайлж болох; **под этим выражением ~ется следующее...** энэ үгийг... гэж ухаж болно.
РАЗУ́МНО ухаантай бодлоготой, **~ поступить** ухаантай хийх.
РАЗУ́МНОСТЬ ухаалаг байх, бодлоготой байх.
РАЗУ́МНЫЙ 1. оюунтай, ухамсартай, ухаантай; 2. ухаалаг, бодлоготой.
РАЗУ́ТЫЙ хөл нүцгэн.
РАЗУ́ТЬ гутал тайлах, хөл нүцгэлэх; **~ ребёнка** хүүхдийн гутлыг тайлах.
РАЗУ́ТЬСЯ гутлаа тайлах, хөл нүцгэлэх.
РАЗУ́ЧИВАНИЕ цээжлэх, тогтоох, цээжлэлт, тогтоолт.
РАЗУ́ЧИВАТЬ цээжлэх, тогтоох.
РАЗУ́ЧИВАТЬСЯ чадахаа байх, мартах.
РАЗУЧИ́ТЬ цээжлэх, тогтоох; **~ песню** дуу цээжлэх, дуу сурах.
РАЗУЧИ́ТЬСЯ чадахаа байх, мартах.
РАЗЪЕДА́||ТЬ идэх; **ржавчина ~ет железо** төмөр зэвэнд идэгдэнэ.
РАЗЪЕДА́ТЬСЯ таргалах, бандайтал таргалах.
РАЗЪЕДИНЕ́НИЕ 1. тасрах, салах; 2. таслах, салгах.
РАЗЪЕДИНИ́||ТЬ таслах, салгах, хагацаах; **~ провода** утас таслах; **судьба их ~ла** тавилан нь тэднийг хагацаав.
РАЗЪЕДИНИ́ТЬСЯ тасрах, салах, хагацах.
РАЗЪЕДИНЯ́ТЬ таслах, салгах, хагацаах.
РАЗЪЕДИНЯ́ТЬСЯ тасрах, салах, хагацах.
РАЗЪЕ́ЗД 1. тарах, тархах; 2. явах, хэсэж явах, аялах, жуулчлах; 3. зөрлөг; 4. хэсүүл.
РАЗЪЕЗДНО́Й 1. хэсэх, хэсүүл; 2. зам хоногийн, замын; 3. зөрлөг; **~ путь** зөрлөг зам.
РАЗЪЕЗЖА́ТЬ аялах, жуулчлах, хэсэж явах, хэрэх; **~ по стране** тус орноор аялах; **~ по делам службы** албан хэргээр явах.
РАЗЪЕЗЖА́ТЬСЯ 1. тарах, тархах; 2. зөрөх, зөрж өнгөрөх; 3. зөрөх, дайралдаагүй өнгөрөх; 4. салах, хагацах; 5. язрах, элэгдэж, урагдах; 6. хоёр тийш гулгарих, халтирах;
РАЗЪЕ́||СТЬ идэх, **ржавчина ~ла железо** зэв төмөрийг идэв.
РАЗЪЕ́СТЬСЯ таргалах, бандайтал таргалах
РАЗЪЕ́ХА||ТЬСЯ 1. тарах, тархах; **гости ~лись** зочид тарав; 2. зөрөх, зөрж гарах; 3. зөрчхөх, дайралдаагүй өнгөрөх; 4. салах, хагацах; **супруги ~лись** эр эм хоёр салав; 5. язрах, элэгдэж, урагдах; 6. хоёр тийш гулгарих, халтирах; **лыжи ~лись** цана хоёр тийш гулгарив.
РАЗЪЯРЁННЫЙ улайрсан, гаарсан, хилэн бадарсан.
РАЗЪЯРИ́ТЬ улайруулах, гааруулах, хилэн бадруулах; **~ льва** арслангийн хилэнг бадруулах.
РАЗЪЯРИ́ТЬСЯ улайрах, гаарах, хилэн бадрах.
РАЗЪЯСНЕ́НИЕ тайлбар, таниулга, тайлбарлах, тайлбарлан таниулах; **официальное ~** албан ёсны тайлбар, албан ёсны таниулга; **давать ~** тайлбарлаж өгөх, тайлбарлах.
РАЗЪЯСНИ́ТЕЛЬН||ЫЙ таниулгын, тайлбарлан таниулах; **~ая работа** таниулгын ажил.
РАЗЪЯСНИ́ТЬ тайлбарлан таниулах, тайлбарлах, таниулах; **~ правила** дүрэм тайлбарлан таниулах.
РАЗЪЯ́СНИ||ТЬСЯ I тунгалаг болох, цэлмэх; **погода ~лась** тэнгэр цэлмэв.
РАЗЪЯСНИ́ТЬСЯ II тодорхой болох, илэрхий болох, тодрох, ойлгомжтой болох.
РАЗЪЯСНЯ́ТЬ тайлбарлан таниулах, тайлбарлах.
РАЗЪЯСНЯ́ТЬСЯ тодорхой болох, илэрхий болох, тодрох, ойлгомжтой болох.
РАЗЫГРА́ТЬ 1. тоглох, наадах; 2. сугалах, тоглох, сугалуулж олгох; **~ по жребию** шавга сугалах, сугалуулж олгох; 3. дүр үзүүлэх, болж маяглах; **~ невинно пострадавшего** гэмгүй хохирсон хүний дүр үзүүлэх; 4. тоглох, наадах, тавих; **~ партию в шахматы** нэг өрөг шатар тавих; шатар нэг удаа тавих, 5. доог хийх, наадам болгох, тоглох, молигодох; **~ приятеля** найзаараа доог хийх, найзыгаа молигодох; **~ дурака** мангуутуулах.
РАЗЫГРА́||ТЬСЯ 1. тоглоомч болох, тоглоомд шунах, шуналтай тоглосоор байх; 2. сайн тоглож эхлэх, 3. чангарах, гаарах; **буря ~лась** шуурга чангарав.
РАЗЫ́ГРЫВАТЬ 1. тоглох, наадах; 2. сугалах, тоглох, сугалуулж олгох; 3. дүр үзүүлэх, болж маяглах; 4. тоглох, наадах, тавих; 5. доог хийх, наадам болгох, тоглох, молигодох.
РАЗЫ́ГРЫВАТЬСЯ 1. тоглоомч болох, тоглоомд шунах, шуналтай тоглосоор байх; 2. сайн тоглож эхлэх, 3. чангарах, гаарах.
РАЗЫСКА́НИ||Е 1. эрэл, эрэх, эрж олох; 2. **~я** шинжлэл, шинжилгээний зохиол; **научные ~я** эрдэм шинжилгээний зохиол.
РАЗЫСКА́ТЬ эрж олох, **~ пропавших без вести** сураггүй алга бологсдыг эрж олох.
РАЗЫСКА́||ТЬСЯ олдох, **пропавшая вещь ~лась** алга болсон юм олдов.
РАЗЫ́СКИВАТЬ эрж олох.
РАЗЫ́СКИВАТЬСЯ олдох
РАЙ 1. диваажин, сухваади; 2. жаргалын орон, диваажин; **земной ~, ~ земной** энэ ертөнцийн диваажин.
РАЙИСПОЛКО́М *(районный исполнительный комитет)* районы гүйцэтгэх хороо.
РАЙКО́М (*районный комитет*) районы хороо, **~ партий** районы намын хороо.
РАЙО́Н 1. нутаг, газар, орон; **степной ~** тал нутаг, тал газар; **промышленный ~** үйлдвэртэй газар, үйлдвэртэй нутаг; 2. хэсэг, хороо, район; **рабочий ~** ажилчны район, ажилчны хороо; 3. газар, хавь, орчим; **~ наводнения** үер болсон газар; 4. дүүрэг; **~ административный** засаг захиргааны дүүрэг; 5. **~ жилой** орон сууцны дүүрэг, хороолол.

РАЙОНИ́РОВАНИЕ районлах, мужлал.
РАЙОНИ́РОВАТЬ районлах, район болгон хуваах.
РАЙО́ННЫЙ районы; ~ **совет** районы зөвлөл; ~ **комитет** районы хороо.
РА́ЙСК||ИЙ 1. диваажингийн; 2. жаргалын, жаргалант, гайхамшигт сайхан; **здесь у вас ~ уголок** танай энд жаргалын орон байна; **~ое дерево** гаслангүйн мод.
РАЙСОВЕ́Т *(районный совет)* районы зөвлөл.
РАК I хавч; **когда ~ свистнет** тэхийн эврийг тэнгэрт хүрэхэд, тэмээн сүүлийг газарт хүрэхэд.
РАК II өмөн, өмөн үү, ~ **желудка** ходоодны өмөн, ходоодны нарийн; ~ **атрофический** хатингар өмөн.
РАКЕ́Т||А пуужин, **пустить ~у** пуужин хөөргөх; **сигнальная ~** дохионы пуужин; **космическая ~** сансрын пуужин.
РАКЕ́ТА-НОСИ́ТЕЛЬ зөөгч пуужин.
РАКЕ́ТНЫЙ пуужингийн, пуужинт, пуужин.
РАКЕТОДРО́М пуужин тавих талбай.
РАКЕТОСТРОЕ́НИЕ пуужин үйлдвэрлэл.
РАКЕ́ТЧИК 1. пуужингийн ангийн цэрэг, 2. дохиочин.
РАКЕ́ТЧИЦА эмэгтэй дохиочин.
РА́КОВИНА 1. дун, ювуу, лавай; 2. тосуур; **кухонная ~** сав угаах тосуур, **ушная ~** чихний дэлбэ.
РА́КОВ||ЫЙ I дигваранзын; **~ые шейки** диваранзын хүзүү.
РА́КОВЫЙ II өмөнгийн.
РАКООБРА́ЗНЫЕ хавч хэлбэртэн.
РАКУ́ШКА бяцхан дун, ювуу.
РА́М||А 1. жааз, гуу, хүрээ; **~ы для картин** зургийн гуу, жааз; **дверная ~** хаалганы хүрээ; 2. арал, жааз; **вагонная ~** вагоны арал; ~ **плуга** анжисны жааз.
РАМЕ́ШИЯ *(бот)* туурцаг.
РА́МК||А 1. бяцхан жааз, гуу, хүрээ; **фотографическая карточка в ~е** бяцхан жаазтай гэрэл зураг, 2. **~и** хэм хэмжээ, хүрээ; **выйти из рамок данной темы** тухайн сэдвийн хүрээнээс халих.
РА́МН||ЫЙ жаазан; **~ая опора** жаазан тулгуур.
РА́Н||А 1. шарх, **пулевая ~** сумны шарх; **перевязать ~ы** шарх боох; ~ **колотая** хатгагдсан шарх; ~ **колоторезная** хутгалсан шарх; ~ **проникающая** нэвтэрсэн шарх; 2. сэв; **душевная ~** сэтгэлийн шарх; **женщины всегда жалеют нас за ~ы, которые нанесли не они** эмэгтэйчүүд биднийг (эрчүүдийг) дандаа, өөрсдийнхөө үүсгээгүй сэтгэлийн шархны төлөө өрөвддөг.
РАНГ зэрэг; **капитан первого ~а** нэгдүгээр зэргийн ахмад.
РА́НЕЕ 1. *(-аас, -ээс, -оос, -өөс)* урьд, өмнө, түрүү, эрт; 2. *(-аас, -ээс, -оос, -өөс)*, нааш, өмнө, урьд; 4. урьд, урьдын цагт, эрт цагт.
РАНЕ́НИЕ 1. шархдах, шархдуулах; 2. шарх; **тяжёлое ~** хүнд шарх, ~ **закрытое** битүү шархдал.
РА́НЕННЫЙ шархадсан; **тяжело ~** хүнд шархадсан.
РА́НЕНЫЙ шархадсан, шархтай.
РА́НЕЦ үүргэвч.
РАНЖИ́Р по ~у 1. өндөр намаар; **выстроиться по ~у** өндөр намаараа жагсах; 2. зиндаа зиндаагаар нь.
РА́НИТЬ 1. шархдуулах; 2. сэв оруулах, сэв суулгах; **слова его ранят душу** үг нь сэтгэлд сэв оруулна.
РА́НН||ИЙ 1. эрт үеийн, эхэн үеийн, анхан үеийн, залуу үеийн, эртийн, эрт, хар; **~им утром** өглөө эрт, хар өглөөгүүр; **~ее детство** хар бага нас; 2. эрт *орсон, эрт болсон, эрт хийсэн*; **в этом году ~яя зима** энэ жил өвөл эрт оров; 3. эрт боловсордог, эрт боловсорсон ногоо; **~яя птичка** эрт босдог хүн.
РА́НО 1. эрт; ~ **утром** өглөө эрт; 2. эрт цагаас, урьд; **весна наступила ~** эрт хавар болов; 3. эртхэн; **мы ~ выехали, чтобы не опоздать** хождохгүйн тулд бид эртхэн гарсан; 4. эрт байх; ~ **или поздно** эрт орой алин боловч, хэзээ нэгэн цагт.
РАНОВА́ТО эртэвтэр, эртхэн, арай эрт.
РАНТЬЕ́ рантье.
РА́НЬ эрт, **в такую ~** ийм эрт.
РА́НЬШЕ 1. *(-аас, -ээс, -оос, -өөс)* урьд, өмнө, түрүү, эрт; 2. *(-аас, -ээс, -оос, -өөс)* нааш, өмнө, урьд; 3. эхлээд, урьд; ~ **выслушай, а потом говори** урьд нь сонсоод дараа нь ярь; 4. урьд, урьдын цагт, дээр цагт.
РА́ПОРТ илтгэмж, рапорт; **отдавать ~** илтгэмж хүргэх, рапорт өгөх.
РАПОРТОВА́ТЬ илтгэмж хүргэх, рапорт өгөх.
РАПСО́ДИЯ уран аялгуу (*ардын дуу, домгийн сэдвээр зохиосон хөгжмийн аялгуу*).
РА́СА арьстан, арьс.
РАСИ́ЗМ арьсны үзэл.
РАСИ́СТ арьсны үзэлтэн.
РАСИ́СТСКИЙ арьсны үзлийн, арьсны үзэлтний.
РАСКА́ИВАТЬСЯ гэмших, гэмээ хүлээх, нүглээ наминчлах, гашуудах.
РАСКАЛЁНН||ЫЙ улайссан, халуун; **~ое железо** улайссан төмөр, ~ **песок** халуун элс.
РАСКАЛИ́ТЬ улайсгах, халаах; ~ **железо докрасна** төмөр улайсгах, төмөр улайстал халаах.
РАСКАЛИ́||ТЬСЯ улайсах, халах, халуун болох, **утюг ~лся** индүү улайсчээ.
РАСКА́ЛЫВАНИЕ цуурах.
РАСКА́ЛЫВАТЬ 1. хагалах, хага цохих, цуу татах, бутлах; 2. хагарал гарах.
РАСКА́ЛЫВАТЬСЯ 1. хагалах, хага цохих, цуу татах, бутлах; 2. хагарал гарах.
РАСКАЛЯ́ТЬ улайсгах, халаах.
РАСКАЛЯ́ТЬСЯ улайсах, халах, халуун болох.
РАСКА́ПЫВАТЬ 1. малтах, ухах; 2. малтаж олох; ухаж гаргах, 3. олох.
РАСКА́РМЛИВАТЬ бордох, шахах.
РАСКА́Т 1. нижигнэх, тачигнах, нижигнээн, тачигнаан; **~ы грома** тэнгэр нижигнэх, **~ы смеха** тачигнатал инээх; 2. хурд, эрч.
РАСКАТА́ТЬ 1. дэлгэх, задлах; ~ **ковёр** хивс дэлгэх; 2. хавтгайлах, элдэх, тэгшлэх, жигдлэх, өнхрүүлэх, эргүүлэх.
РАСКАТА́ТЬСЯ 1. дэлгэгдэх, задрах; 2. хавтгайлагаах, хавтайх, элдэгдэх
РАСКА́ТИСТЫЙ нижигнэсэн, тачигнасан; ~ **удар грома** тэнгэрийн нижигнэсэн чанга дуу, аянга нижигнэх.
РАСКАТИ́ТЬ өнхрүүлэн, хурдасгах, эргүүлэн хурдлуулах, эрч оруулах
РАСКАТИ́ТЬСЯ 1. өнхрөн хурдлах, эргэлдэн хурдсах, эрч орох, хурдлах; 2. өнхрөн тархах, зүг зүг тийш өнхрөх, бөмбөрөн тарах.
РАСКА́ТЫВАТЬ I 1. дэлгэх, задлах; 2. хавтгайлах, элдэх, тэгшлэх, жигдлэх, өнхрүүлэх, эргүүлэх; 3. ихэд давхих, ихэд гулгах.
РАСКА́ТЫВАТЬ II өнхрүүлэх, хурдасгах, эргүүлэн хурдлуулах, эрч оруулах.
РАСКА́ТЫВАТЬСЯ I 1. дэлгэгдэх, задлагдах; 2. хавтгайлагдах, элдэгдэх, тэгшлэгдэх, өнхрүүлэгдэх.
РАСКА́ТЫВАТЬСЯ II 1. өнхрөн хурдлах, эргэлдэн хурдсах, эрч орох, хурдлах; 2. өнхрөн тархах, зүг зүг тийш өнхрөх, бөмбөрөн тарах.

РАСКАЧА́||ТЬ 1. савлуулах, найгуулах; ~ **качели** дүүжин савлуулах; 2. холхиулах, ганхуулах; ~ **кол** гадас ганхуулах; 3. хөдөлгөх; **его не ~ешь** юманд хөдлөхгүй хүн.

РАСКАЧА́||ТЬСЯ 1. савлаж эхлэх найгаж эхлэх; **маятник ~лся** дүүжмэг савлаж эхлэв; 2. ганхах, холхих; **столб ~лся** шон ганхав; 3. хөдлөх.

РАСКА́ЧИВАТЬ 1. савалзуулах, найгалзуулах; 2. ганхалзуулах, холхилзуулах; 3. хөдөлгөх.

РАСКА́ЧИВА||ТЬСЯ 1. савалзах, найгалзах; 2. ганхалзах, холхилзох; 3. хөдлөх; 4. найгах, гунхах; **он ходит, ~ясь** тэр хүн найгаж явдаг.

РАСКА́ШЛЯТЬСЯ мэгшүүлэн ханиалгах.

РАСКА́ЯНИЕ гэмших, гэмээ хүлээх, наманчлах, гэмшил; **принести ~** гэмээ хүлээх, гэмшиж байгаагаа илтгэх.

РАСКА́ЯТЬСЯ гэмших, гэмээ хүлээх, нүглээ наманчлах, гашуудах; ~ **в своих проступках** буруу хэрэг гаргасандаа гэмших.

РАСКВАРТИРОВА́НИЕ тархаан байрлуулах, байранд нь оруулах, байрлуулах, байрлуулалт.

РАСКВАРТИРОВА́ТЬ тархаан байрлуулах, байранд оруулах, байрлуулах.

РАСКВА́СИТЬ няц дэлсэх, няц цохих; ~ **нос** хамар няц дэлсэх.

РАСКВИТА́ТЬСЯ 1. дансаа бодолцох, өр ширээ дуусгах, өглөг авлагаа дуусгах; 2. өшөөгөө авах; ~ **с врагами** дайснаас өшөөгөө авах.

РАСКИДА́ТЬ тархаан хаях, тархаах, бутаргах, цацах.

РАСКИ́ДИСТЫЙ сагалгар; ~ **дуб** сагалгар царс.

РАСКИ́ДЫВАТЬ I тархаан хаях, тархаах, бутаргах, цацах.

РАСКИ́ДЫВАТЬ II 1. алдлах, дэлэх, алцайлгах; 2. дэлгэх, бүрхэх; 3. дэлгэрүүлэх, тархаан дэлгэрүүлэх; 4. босгох, шаах.

РАСКИ́ДЫВАТЬСЯ 1. тарайн хэвтэх, тэрийн хэвтэх, налайж хэвтэх; 2. орших, налайх; 3. дэлгэрэх, тархах дэлгэрэх.

РАСКИ́НУТЬ 1. алдлах, дэлэх, алцайлгах; ~ **руки** гараа алдлах; 2. дэлгэх, бүрхэх; ~ **сеть** тор дэлгэх; 3. дэлгэрүүлэх, тархаан дэлгэрүүлэх; ~ **торговую сеть** худалдааны газруудыг тархаан дэлгэрүүлэх; 4. босгох.

РАСКИ́НУТЬСЯ 1. тарайн хэвтэх, тэрийн хэвтэх, налайж хэвтэх; ~ **на постели** орон дээрээ тарайн хэвтэх; 2. орших, налайх; 3. дэлгэрэх, тархах дэлгэрэх.

РАСКИСА́ТЬ,

РАСКИ́СНУТЬ 1. гашлах, эсэх; **тесто раскисло** зуурсан гурил эслэх; 2. бие сулрах, сүлд буух.

РАСКЛА́ДКА 1. дэлгэх, өрөх; 2. хуваарилах, оногдуулах.

РАСКЛАДН||О́Й эвхдэг; **~ая кровать** эвхдэг ор.

РАСКЛА́ДЫВАТЬ 1. тавих, өрөх, дэлгэх; 2. дэлгэх, дэлгэж тавих; 3. хуваарилах, оногдуулах; 4. (*зэрэглэж*) асаах, (*өрж*) ноцоох

РАСКЛА́ДЫВАТЬСЯ 1. юмаа тавих, өрөх, дэлгэх; 2. тавигдах, өрөгдөх, багтах.

РАСКЛА́НИВАТЬСЯ мэхэсхийн ёслох.

РАСКЛЕ́ИВАТЬ 1. (*наалт*) салгах, ховхлох; 2. наах.

РАСКЛЕ́ИВАТЬСЯ салах, ховхрох, задрах.

РАСКЛЕ́ИТЬ 1. (*наалт*) салгах, ховхлох; ~ **коробку** хайрцгийн наалт салгах; 2. наах.

РАСКЛЕ́И||ТЬСЯ 1. (*наалдаас*) салах, ховхрох, задрах; 2. бүтэлгүй болох, бүтэмжгүй болох; **дело ~лось** хэрэг бүтэлгүйтэв.

РАСКЛЕ́ЙКА наах, наалт; ~ **афиш** зарлал наах.

РАСКЛЕПА́ТЬ тав салгах, тавыг нь мултлах.

РАСКЛЕПА́ТЬСЯ тав нь салах, тав нь мултарч унах.

РАСКЛЁПКА тав салгах, тавыг нь мултлах.

РАСКЛЁПЫВАТЬ тав салгах, тавыг нь мултлах.

РАСКОВА́ТЬ 1. тахыг авах, тахыг мултлах; ~ **лошадь** морины тахыг салгах; 2. гинжийг мултлах, гав гинжийг салгах; 3. давтаж хавтгайлах, хавтгайлах.

РАСКОВА́ТЬСЯ тахаа гээх, тахаа алдах.

РАСКО́ВЫВАТЬ 1. тахыг авах, тахыг мултлах; 2. гинжийг мултлах, гав гинжийг салгах; 3. давтаж хавтгайлах, хавтгайлах.

РАСКО́ВЫВАТЬСЯ тахаа гээх, тахаа алдах.

РАСКОВЫ́РИВАТЬ,

РАСКОВЫРЯ́ТЬ 1. ухах, ухаж төнхөх, төнхөх, сийчих, зурчих; 2. маажих, урах, ухчлах.

РАСКО́Л 1. хагарал; 2. үнэн алдартны шашны хагарал.

РАСКОЛА́ЧИВАТЬ цохих, зад цохих, зад татах, хага татах.

РАСКОЛО́ТЬ 1. хагарах, хага буух, цуу үсрэх, бутлах; ~ **дрова** түлээ хагалах; 2. хагарал гаргах.

РАСКОЛО́ТЬСЯ 1. хагарах, хага буух, цуу үсрэх, бутрах; 2. хагарал гарах.

РАСКО́ЛЬНИК үнэн алдартны шашны хагарал гаргагч, эсэргүү.

РАСКО́ЛЬНИЧЕСКИЙ үнэн алдартны шашны хагарал гаргагчдын; эсэргүүний.

РАСКОПА́||ТЬ 1. малтах, ухах; ~ **землю** газар ухах; 2. малтан олох, ухаж гаргах; **археологи ~ли древний город** хуучны археологчид эртний хот малтаж гаргав; 2. олох.

РАСКО́ПК||А 1. малтах, ухах; ~ **кургана** хиргисүүр малтах; 2. малтлага; **археологические ~и** эртний судлалын малтлага.

РАСКОРМИ́ТЬ бордох, шахах; ~ **свинью на убой** нядлах гахай бордох.

РАСКО́С||ЫЙ жартгар, сөлөр, долир; **~ые глаза** жартгар нүд.

РАСКРА́ДЫВАНИЕ хулгайлах, цөлмөн хулгайлах.

РАСКРА́ДЫВАТЬ хулгайлж дуусах, цөлмөн хулгайлах, нэгд нэгэнгүй хулгайлах, хулгайлах.

РАСКРА́ИВАТЬ 1. эсгэх; 2. хага цавчих, цоо цохих.

РАСКРА́СИТЬ (*өнгөөр*) будах, ширдэх.

РАСКРА́СКА 1. (*өнгөөр*) будах, ширдэх; 2. өнгөтэй хэв, өнгө.

РАСКРАСНЕ́ТЬСЯ (*царай*) улайх, улаан болох; ~ **на морозе** хүйтэнд царай улайх.

РАСКРА́СТЬ хулгайлж дуусах, цөлмөн хулгайлах, нэгд нэгэнгүй хулгайлах, хулгайлах.

РАСКРА́ШИВАНИЕ (*өнгөөр*) будах, ширдэх, будалт.

РАСКРА́ШИВАТЬ I (*өнгөөр*) будах, ширдэх.

РАСКРА́ШИВАТЬ II үйрүүлэх, яйруулах, хэмхчих, өшиглөх.

РАСКРА́ШИВАТЬСЯ I (*өнгөөр*) будагдах, ширдэгдэх.

РАСКРА́ШИВАТЬСЯ II үйрэх, бутрах.

РАСКРЕПЮСТИ́ТЬ 1. хамжлагат ёсноос ангижруулах, чөлөөлөх; 2. эрх чөлөө олгох, чөлөөлөх; ~ **женщину** эмэгтэйчүүдэд эрх чөлөө олгох.

РАСКРЕПОСТИ́ТЬСЯ 1. хамжлагат ёсноос ангижрах, чөлөөлөгдөх; 2. эрх чөлөө олох, чөлөөлөгдөх.

РАСКРЕПОЩА́ТЬ 1. хамжлагат ёсноос ангижруулах, чөлөөлөх; 2. эрх чөлөө олгох, чөлөөлөх.

РАСКРЕПОЩА́ТЬСЯ 1. хамжлагат ёсноос ангижрах, чөлөөлөгдөх; 2. эрх чөлөө олох, чөлөөлөгдөх.

РАСКРЕПОЩЕ́НИЕ 1. хамжлагат ёсноос ангижруулах, чөлөөлөх; 2. эрх чөлөө олгох, чөлөөлөх.

РАСКРИТИКОВА́ТЬ хатуу шүүмжлэх, ширүүн шүүмжлэх.

РАСКРИЧА́ТЬСЯ зандрах, зандран хараах, хашгирах.

РАСКРОИ́ТЬ 1. эсгэх; 2. хага цавчих, цоо цохих; ~ **череп топором** тархий нь сүхээр цоо цохих.

РАСКРОШИ́ТЬ үйрүүлэх, яйруулах, юйрүүлэх, хэмхчих, хөшиглөх; ~ **хлеб** талх үйрүүлэх.

РАСКРОШИ́||ТЬСЯ үйрэх, яйрах, юйрэх, хэмх, хэмх ойчих; **зуб совсем ~лся** шүд бүр яйрав.

РАСКРУТИ́ТЬ задлах, эрчийг гаргах, хариулах; ~ **верёвку** аргамжийн эрчийг хариулах.
РАСКРУТИ́ТЬСЯ задрах, эрч нь гарах, харих.
РАСКРЫВА́ТЬ 1. нээх, онгойлгох, (*таг*) сөхөх; 2. дэлгэх, задгай тавих, тайлах, задлах; 3. нээх, онгойлгох, тайлах; 4. нээх, ангайлгах; 5. дэлгэх, нээх; 6. тайлж өгөх, хэлэх; 7. илрүүлэх, илчлэх, уудлан илрүүлэх.
РАСКРЫВА́ТЬСЯ 1. нээгдэх, онгойх, (*таг*) сөхөгдөх; 2. дэлгэгдэх, задгай болох, тайлагдах, задрах; 3. нээгдэх, онгойх, тайлдах; 4. нээгдэх, ангайх; 5. дэлгэгдэх, нээгдэх; 6. илрэх, илчлэгдэх; 7. дэлгэрэх.
РАСКРЫ́ТИЕ 1. задрах, нээгдэх, ангайх; 2. илрүүлэх, илчлэх, уудлан илрүүлэх; ~ **преступления** гэмт хэргийг илрүүлэх.
РАСКРЫ́ТЬ 1. нээх, онгойлгох, (*таг*) сөхөх; ~ **сундук** авдар нээх; 2. дэлгэх, задгай тавих, тайлах, задлах; 3. нээх, онгойлгох, тайлах; ~ **глаза**; 1) нүдээ нээх, харах; 2) мэл гайхах, гайхах; 4. нээх, ангайлгах; ~ **рот**; 1) амаа ангайх; 2) гайхах; 5. дэлгэх, нээх; ~ **тетрадь** дэвтэр дэлгэх; 6. тайлж өгөх, хэрэглэх; ~ **тайну** нууцыг тайлж өгөх; 7. илрүүлэх, илчлэх; ~ **свои карты** санаагаа илрүүлэх, нууцаа илчлэх.
РАСКРЫ||ТЬСЯ 1. нээгдэх, онгойх, сөхөгдөх; 2. дэлгэгдэх, задгай болох, тайлагдах, задрах; 3. нээгдэх, онгойх, тайлдах; **дверь ~лась** хаалга нээгдэв; 4. нээгдэх, ангайх; **глаза ~лись** 1) нүд нь нээгдэв; 2) нүд нь нээгдэв, учрыг нь мэдэв; 5. дэлгэгдэх, нээгдэх; 6. илрэх, илчлэгдэх; **преступление ~лось** гэмт хэрэг илрэв; 7. дэлгэрэх; **цветы ~лись** цэцэг дэлгэрэв.
РАСКУДА́ХТАТЬСЯ чанга чанга дуугарах.
РАСКУЛА́ЧИВАНИЕ 1. нударганы хөрөнгийг хураах; 2. хүнээс юм салгаж авах.
РАСКУЛА́ЧИВАТЬ нударганы хөрөнгийг хураах.
РАСКУЛА́ЧИТЬ нударганы хөрөнгийг хураах.
РАСКУПА́ТЬ худалдан авцгаах, худалдан авч дуусах.
РАСКУПА́ТЬСЯ худалдагдах, гүйлгээтэй байх.
РАСКУПИ́||ТЬ худалдан авцгаах, худалдан авч дуусах; **монголо-русский словарь ~ли в несколько дней** монгол-орос хэлний толь бичгийг хэдхэн хоногт худалдан авч дуусчээ.
РАСКУПО́РИВАТЬ нээх, задлах, бөглөө авах.
РАСКУПО́РИВАТЬСЯ нээгдэх, бөглөө автах.
РАСКУ́ПОРИТЬ нээх, задлах, бөглөө авах; ~ **бутылку** лонхны бөглөө авах.
РАСКУ́РИВАТЬ асаах, нэрэх.
РАСКУ́РИВАТЬСЯ асах.
РАСКУРИ́ТЬ асаах, нэрэх; ~ **трубку** гаанс тамхи асаах, нэрэх.
РАСКУРИ́ТЬСЯ асах.
РАСКУСИ́ТЬ,
РАСКУ́СЫВАТЬ 1. хага хазах, тас хазах; ~ **орех** самар хага хазах; 2. учрыг олох, таних, мэдэх; ~ **в чём дело** учир юунд байгааг мэдэх; **его не легко** ~ тэр хүний учрыг олох бэрхтэй.
РАСКУ́ТАТЬ ороосныг тайлах, задлах.
РАСКУ́ТАТЬСЯ ороосон нь тайлагдах, задрах.
РАСКУ́ТЫВАТЬ ороосныг тайлах, задлах.
РАСКУ́ТЫВАТЬСЯ ороосон нь тайлагдах, задрах.
РА́СОВ||ЫЙ арьстны, арьсны; **~ые отличия** арьстны ялгаа, арьсны ялгаа.
РАСПА́Д 1. задрах, задралт, ялзран задралт; 2. задрал, унал.
РАСПАДА́ТЬСЯ 1. задрах, бутрах, хэсэг хэсэг болох; 2. ажиллахаа болих; 3. задрах, сарних, унах.
РАСПАДЕ́НИЕ 1. задрах, задралт; 2. задрал, унал.
РАСПА́ИВАТЬ гагнаас хайлуулах, гагнаас салгах.
РАСПА́ИВАТЬСЯ гагнаас хайлах, гагнаас салах.
РАСПАКОВА́ТЬ задлах, баглааг тайлах; ~ **вещи** юм задлах.
РАСПАКОВА́ТЬСЯ 1. юмаа задлах, юмаа гаргах, юмныхаа баглааг тайлах; 2. задрах, баглаа тайлдах.
РАСПАКО́ВЫВАТЬ задлах, баглааг тайлах.
РАСПАКО́ВЫВАТЬСЯ 1. юмаа задлах, юмаа гаргах, юмныхаа баглааг тайлах; 2. задрах, баглаа тайлдах.
РАСПАЛИ́ТЬСЯ 1. их халах, улайстал халах; 2. (*сэтгэл*) хөөрүүлэх.
РАСПАЛЯ́ТЬ 1. их халаах, улайстал халаах; 2. (*сэтгэл*) хөөрүүлэх.
РАСПАЛЯ́ТЬСЯ 1. их халах, улайстал халах; 2. (*сэтгэл*) хөөрөх, цухалдах.
РАСПА́РИВАТЬ 1. уурт жигнэх, халуун усанд дэвтээх, зөөлрүүлэх; 2. халууцуулж хөлөргөх, *хөлөргөх, халууцаж* хөлрөх, хөлрөх.
РАСПА́РИТЬ 1. уурт жигнэх, халуун усанд дэвтээх, зөөлрүүлэх; ~ **кожу** арьс уурт жигнэж зөөлрүүлэх; 2. халууцуулж хөлөргөх, хөлөргөх, халууцаж хөлрөх, хөлрөх.
РАСПА́РИТЬСЯ 1. уурт жигнэгдэх, халуун усанд дэвтэх, зөөлрөх; 2. халууцаж хөлрөх, хөлрөх.
РАСПА́РЫВАТЬ 1. ханзлах, ханз татах; 2. огло татах, хүүлэх.
РАСПА́РЫВАТЬСЯ 1. ханзрах, ханз үсрэх; 2. огло үсрэх, хүүрэх.
РАСПА́СТЬСЯ 1. задрах, бутрах, хэсэг хэсэг *болох*; **молекулы распались на атомы** молекул атом болон задрав; **камень распался** чулуу хэсэг хэсэг болов; 2. ажиллахаа болих, тарах; 3. задрах, сарних, унах.
РАСПАХА́ТЬ хагалах; ~ **целину** атар хагалах.
РАСПА́ХИВАНИЕ хагалах, хагалалт; ~ **нови** шинэ газар хагалах.
РАСПА́ХИВАТЬ I хагалах.
РАСПА́ХИВАТЬ II 1. цэлийтэл нээх, дэлгэх, тэлэх; ~ **дверь** үүд дэлгэх; 2. энгэдэх, задгай тавих; ~ **пальто** пальто энгэдэх.
РАСПАХНУ́ТЬ 1. цэлийтэл нээх, дэлгэх, тэлэх; ~ **дверь** үүд дэлгэх; 2. энгэдэх, задгай тавих; ~ **пальто** *пальто* энгэдэх.
РАСПАХНУ́||ТЬСЯ 1. цэлийтэл нээгдэх, тэлэгдэх; **окно ~лось** цонх тэлэгдэв; 2. хувцаа энгэдэх, задгай тавих; **идти ~вшись** хувцаа энгэдээд явах.
РАСПА́ШКА 1. хагалах, хагалалт; **вторичная ~ земли** газрыг дахин хагалах; 2. хагалсан газар.
РАСПАШО́НКА баривч.
РАСПАЯ́ТЬ гагнаас хайлуулах, гагнаас салгах; ~ **чайник** данхны гагнаас хайлуулах.
РАСПАЯ́ТЬСЯ гагнаас хайлах, гагнаас салах.
РАСПЕВА́ТЬ дуулах.
РАСПЕКА́ТЬ зэмлэх, загнах.
РАСПЕЛЕНА́ТЬ манцуй тайлах.
РАСПЕЛЕНА́ТЬСЯ манцуйгаа тайлах, манцуйнаасаа гарах.
РАСПЕРЕ́ТЬ дэлбэ татах, дэлбэлэх; **льдом распёрло бочку** ус торхоо дэлбэ хөлджээ.
РАСПЕ́ТЬСЯ олон дуу дуулах, дуулж дуулчих.
РАСПЕЧА́ТАТЬ 1. лацыг эвдэх, битүүмжийг задлах; ~ **комнату** тасалгааны битүүмжийг задлах; 2. задлах; ~ **конверт** дугтуй задлах.
РАСПЕЧА́ТАТЬСЯ задрах.
РАСПЕЧА́ТЫВАТЬ 1. лацыг эвдэх, битүүмжийг задлах; 2. задлах.
РАСПЕЧА́ТЫВАТЬСЯ 1. задрах; 2. лац нь унах, битүүмж нь задрах; 3. задлагдах.
РАСПЕ́ЧЬ зэмлэх, загнах; ~ **нерадивого ученика** оролдлогогүй сурагчийг загнах.

РАСПИВА́ТЬ 1. хамт уух, хувааж уух; 2. ууж цаг нөхцөөх, ууж суух.

РАСПИ́ЛИВАТЬ хөрөөдөх, хөрөөдөж огтлох; ~ **бревно** гуалин хөрөөдөх.

РАСПИЛИ́ТЬ хөрөөдөх, хөрөөдөж огтлох; ~ **бревно** гуалин хөрөөдөх.

РАСПИ́ЛКА хөрөөдөх, хөрөөдөлт.

РАСПИНА́ТЬ загалмайлан алах.

РАСПИНА́ТЬСЯ чармайх, амиа тавих гэх, сүйд майд болох.

РАСПИСА́НИ||Е цагийн хуваарь; ~ **уроков** хичээлийн цагийн хуваарь; ~ **поездов** галт тэрэгний цагийн хуваарь; **по ~ю** цагийн хуваариар.

РАСПИСА́ТЬ 1. бичих, тарааж бичих; 2. хэлэх, будаж чимэх; ~ **стены** туургыг хэлэх; 3. гоёж ярих, чимэглэж бичих.

РАСПИСА́ТЬСЯ 1. гарын үсэг зурах; ~ **в получении зарплаты** цалин авсан гэж гарын үсэг зурах; 2. хүлээх, мэдэх; 3. гэрлэснээ бүртгүүлэх, гэрлэх.

РАСПИ́СК||А 1. гарын үсэг зурах; 2. баримт; **дать ~у кому-либо** баримт гаргах; 3. бичих, тарааж бичих; 4. хэлэх, будаж чимэх; ~ **стен** туурга будаж чимэх.

РАСПИСНО́Й хэлсэн, будаж чимсэн; ~ **потолок** хэлсэн тааз.

РАСПИ́СЫВАТЬ 1. бичих, тарааж бичих; 2. хэлэх, будаж чимэх; 3. гоёж ярих, чимэглэн бичих.

РАСПИ́СЫВАТЬСЯ 1. гарын үсэг зурах, тавих; 2. хүлээх, мэдэх; 3. гэрлэснээ бүртгүүлэх, гэрлэх; 4. хэлэгдэх.

РАСПИ́ТЬ хамт уух, хувааж уух, уулцах; ~ **бутылку вина** лонх дарс хувааж уух.

РАСПИХА́ТЬ,

РАСПИ́ХИВАТЬ 1. түлхэн зайлуулах, түлхлэх; ~ **людей** хүмүүсийг түлхэн зайлуулах; 2. чихэх, чихлэх; ~ **мелкие вещи по карманам** аар саар юмыг халаасандаа чихлэх.

РАСПЛА́ВИТЬ хайлуулах; ~ **стекло** шил хайлуулах.

РАСПЛА́ВИ||ТЬСЯ хайлах; **металл ~лся** төмөрлөг хайлав.

РАСПЛАВЛЯ́ТЬ хайлуулах.

РАСПЛАВЛЯ́ТЬСЯ хайлах.

РАСПЛА́КАТЬСЯ уйлж гарах, зогсоо жолоогүй уйлах; ~ **от досады** гомдоод уйлж гарах.

РАСПЛАНИ́РОВАТЬ 1. төлөвлөх, хуваарилан төлөвлөх; 2. төлөвлөгөө хийх.

РАСПЛАСТА́ТЬ 1. хавтгайлан зүсэх, хавтгай хавтгайгаар зүсэх; 2. хавтгайлах; 3. дэлгэх, дэлэх; ~ **крылья** далавчаа дэлэх.

РАСПЛАСТА́ТЬСЯ тэрийх, тэрийн хэвтэх, тэрийж ойчих; ~ **по полу** шал дээр тэрийж хэвтэх.

РАСПЛА́Т||А 1. төлөх; ~ **по счётам** баримтаар төлөх; 2. өр төлөөс, хариулал, залхамж; **настанет час ~ы** өр төлөөсний цаг ирнэ, залхамж үзэх цаг ирнэ.

РАСПЛАТИ́ТЬСЯ,

РАСПЛА́ЧИВАТЬСЯ 1. төлөх, төлж дуусах; ~ **с долгами** өрөө төлж дуусах; 2. хариу авах, өшөө авах, өшөө хариулах; ~ **с врагами** дайснаас хариугаа авах; 3. залхамж үзэх, хашрах; ~ **за беспечность** сэрэмжгүй байж хашрах.

РАСПЛЕСКА́||ТЬ цалгиулах, цалгиулж асгах, асгах; **всю воду из ведра ~л** хувинтай усаа бүгдийг цалгиулж асгав.

РАСПЛЕСКА́||ТЬСЯ цалгих, цалгиж асгарах, асгарах; **молоко ~лось по полу** сүү шал дээр асгарав.

РАСПЛЁСКИВАТЬ цалгиулах, цалгиулж асгах, асгах.

РАСПЛЁСКИВАТЬСЯ цалгих, цалгиж асгарах, асгарах.

РАСПЛЕСНУ́ТЬ цалгичхах, цалгиад асгачих, асгачхах.

РАСПЛЕСТИ́ задлах; ~ **косу** гээг задлах.

РАСПЛЕСТИ́СЬ задрах; **коса расплелась** гээг задрав.

РАСПЛЕТА́ТЬ задлах.

РАСПЛЕТА́ТЬСЯ задрах.

РАСПЛОДИ́ТЬ 1. өсгөх, үржүүлэх, олшруулах; 2. дүүргэх, их гаргах.

РАСПЛОДИ́ТЬСЯ 1. өсөх, үржих, олшрох; 2. дүүрэх, их гарах.

РАСПЛЫВА́ТЬСЯ 1. тарах, гүйх, урсах; 2. бантайх, банхайх, бэлхийх.

РАСПЛЫ́ВЧАТОСТЬ 1. балархай, бүдэг юм; 2. тод бус байх, тодорхой бус байх, бүрэг байх.

РАСПЛЫ́ВЧАТ||ЫЙ 1. балархай, бүдэг, бүүдгэр; **~ые линии** балархай зураас, бүдэг шугам; 2. тод бус, тодорхой бус, бүрэг; **~ая формулировка** тодорхой бус томъёолол, бүрэг томъёолол.

РАСПЛЫ́ТЬСЯ 1. нүүх, тарах, гүйх, урсах; 2. бантайх, банхайх, бэлхийх.

РАСПЛЮ́ЩИВАТЬ,

РАСПЛЮ́ЩИТЬ хавтгайлах, хавтгай болгох, бяцлах, няцлах, бяц цохих, няц дарах.

РАСПЛЮ́ЩИ||ТЬСЯ хавтгайрах, хавтгай болох, бяцрах, няцрах, бяц үсрэх, няц дарагдах; **~лся орех** самар няцрав.

РАСПЛЯСА́ТЬСЯ бүжиглэсээр халах, онгод орох.

РАСПОЗНАВА́ЕМ||ЫЙ танигдмаар, мэдэгдүүштэй, таньж болох; **~ые признаки** танигдмаар шинж тэмдэг.

РАСПОЗНАВА́НИ||Е таних, мэдэх; **наука о ~и болезней называется диагностикой** өвчнийг хэрхэн таних тухай ухааныг оношлогоо гэдэг.

РАСПОЗНАВА́ТЬ,

РАСПОЗНА́ТЬ 1. таних, мэдэх; ~ **болезнь** өвчнийг таних; 2. мэдэх, тааж мэдэх; ~ **чьи-нибудь намерения** хүний санааг тааж мэдэх.

РАСПОЛАГА́ТЬ I байх, мэдэлд байх.

РАСПОЛАГА́||ТЬ II 1. өрөх, тавих; 2. байрлуулах, байр олгох; 3. байрыг олж оруулах, хуваарилах; 4. (*сэтгэл*) татах, талдаа оруулах; 5. зохистой байх; **обстановка ~ет к работе** байдал ажиллахад зохистой байна.

РАСПОЛАГА́ТЬСЯ буух, байрлах, байр эзлэх, орших.

РАСПОЛАГА́ЮЩИЙ (*сэтгэлд*) зохистой, тааламжтай, сэтгэл татам; ~ **вид** тааламжтай дүр.

РАСПОЛЗА́ТЬСЯ 1. гүйлдэх, тарж гүйх, язганах; 2. ханзрах, удрах; 3. эвдрэх, хэмхрэх.

РАСПОЛЗТИ́СЬ 1. гүйлдэх, тарж гүйх, язганах; 2. ханзрах, удрах; 3. эвдрэх, хэмхрэх.

РАСПОЛОЖЕ́НИЕ I 1. байрлуулах, байр олгох; 2. байр, байрласан газар.

РАСПОЛОЖЕ́НИЕ II 1. талархах, талтай болох; **чувствовать к кому-либо** ~ хүнийг талархдаг болох, хүнд талтай болох; 2. уур, хүсэл, ааш, оёг; 3. халдамтгай байх, эмзэг байх.

РАСПОЛО́ЖЕНН||ЫЙ 1. барьсан, байрласан, байрлуулсан; **неудобно ~ые комнаты** эвгүй байрлуулсан өрөөнүүд; 2. талархдаг, талтай байдаг; 3. дуртай, хүсэлтэй.

РАСПОЛОЖИ́ТЬ I 1. өрөх, тавих; 2. байрлуулах, байр олгох; ~ **войска** цэрэг байрлуулах; 3. байрыг олж оруулах, хуваарилах.

РАСПОЛОЖИ́ТЬ II татах, талдаа оруулах; ~ **кого-либо в свою пользу** хүнийг талдаа оруулах; ~ **к себе** биедээ татах.

РАСПОЛОЖИ́ТЬСЯ буух, байрлах, байр эзлэх, орших; ~ **в вагоне** вагонд байр эзлэх.

РАСПО́РКА хөндлөвч.

РАСПО́РОТЫЙ ханзалсан, ханз татсан, огло татсан, хүүлсэн.

РАСПОРО́ТЬ 1. ханзлах, ханз татах; ~ **платье** хувцаа ханз татах; 2. огло татах, хүүлэх; ~ **рукав об гвоздь** ханцуйгаа хадаасанд хүүлэх.

РАСПОРО́||ТЬСЯ 1. ханзрах, ханз үсрэх; **швы ~лись** оёдол ханзрав; 2. огло үсрэх, хүүрэх.

РАСПОРЯДИ́ТЕЛЬ захирагч, захирамжлагч, зохион явуулагч.
РАСПОРЯДИ́ТЕЛЬНОСТЬ захирах чадвар, захирамжлах авъяас, зохион явуулах чадвар; **проявить ~** захирах чадвар үзүүлэх.
РАСПОРЯДИ́ТЕЛЬН||ЫЙ 1. захирах чадвартай, захирамжлах авъяастай, зохион явуулах авъяастай; **быть ~ым** захирах чадвартай байх; 2. захирах, захирамжлах, зохион явуулах; **~ орган** захирамжлах байгууллага.
РАСПОРЯДИ́ТЬСЯ 1. захирах, тушаах, захирамжлах; 2. зохион явуулах, эрхлэх; 3. ашиглах, хэрэглэх; **~ отпущенными суммами** олгосон мөнгийг ашиглах.
РАСПОРЯ́ДОК журам; **внутренний ~** дотоод журам.
РАСПОРЯЖА́ТЬСЯ 1. захирах, тушаах, захирамжлах; 2. зохион явуулах, эрхлэх; 3. ашиглах, хэрэглэх; 4. захирах, хэрэг явуулах; **~, как у себя дома** гэртээ байгаа юм шиг байх.
РАСПОРЯЖЕ́НИ||Е 1. захирах, захирамжлах, мэдэх, захиргаа, мэдэл; 2. захирамж; **отдать ~** захирамж өгөх; **в ~ кого-либо** хүний мэдэлд; **в своём ~и** өөртөө, өөрийн мэдэлд.
РАСПОЯ́САТЬ нөмгөлүүлэх, бүс тайлах.
РАСПОЯ́САТЬСЯ 1. нөмгөлөх, бүсээ тайлах; 2. танхайрах, дураараа дургих.
РАСПОЯ́СЫВАТЬ нөмгөлүүлэх, бүс тайлах.
РАСПОЯ́СЫВАТЬСЯ 1. нөмгөлөх, бүсээ тайлах; 2. танхайрах, дураараа дургих.
РАСПРА́В||А дарах, хэрцгийлэн дарах, гэсгээн шийтгэх; **кровавая ~** цус урсган дарах; **короткая ~** амархан дарах, хэнэггүй устгах; **творить суд и ~у** шүүх гэсгэх, гэсгээн шийтгэх.
РАСПРА́ВИТЬ 1. шулуутгах, цэхлэх, тэгшитгэх, тэнийлгэх, (*урчлээг*) гаргах; **~ проволоку** сунгал шулуутгах; **~ лист бумаги** цаас тэнийлгэх; 2. дэлгэх, тэнийлгэх, дэлэх, алдлах; **~ крылья** 1) далавчаа дэлгэх; 2)оролдох, зүтгэх; 3. суниалгах; **~ все члены** суниалгах.
РАСПРА́ВИ||ТЬСЯ I 1. шулуутах, цэх болох, тэгштэх, тэнийх, (*урчлээ нь*) гарах; **складки на платье ~лись** хувцасны нугалаас гарав; 2. дэлгэгдэх, тэнийх, дэлэгдэх, алдлагдах.
РАСПРА́ВИТЬСЯ II дарах, хэрцгийлэн дарах; гэсгээн шийтгэх.
РАСПРАВЛЯ́ТЬ 1. шулуутгах, цэхлэх, тэгшитгэх, тэнийлгэх, (*урчлээг*) гаргах; 2. дэлгэх, тэнийлгэх, дэлэх, алдлах; 3. суниалгах.
РАСПРАВЛЯ́ТЬСЯ дарах, хэрцгийлэн дарах, гэсгээн шийтгэх.
РАСПРЕДЕЛЕ́НИЕ хуваарилах, хуваах, түгээх, хуваарилалт, хуваалт, түгээлт; **~ национального дохода** үндэсний орлогыг хуваарилах.
РАСПРЕДЕЛИ́ТЕЛЬ хуваарилагч, хуваагч, түгээгч.
РАСПРЕДЕЛИ́ТЕЛЬН||ЫЙ хуваарилах, хуваарилагч; **~ пункт** хуваарилах тасаг; **~ая доска** хуваарилах самбар; **~ щит** удирдах зангилааны хаалт.
РАСПРЕДЕЛИ́ТЬ,
РАСПРЕДЕЛЯ́ТЬ хуваарилах, хуваах, түгээх.
РАСПРЕДЕЛЯ́ТЬСЯ хуваарилагдах, хуваагдах, түгээгдэх.
РАСПРОДАВА́ТЬ худалдаж, дуусах, зарж дуусах, бүгдийг худалдах.
РАСПРОДОВА́ТЬСЯ худалдагдаж дуусах, бүгд зарагдах.
РАСПРОДА́ЖА худалдаж дуусах, зарж дуусгах; **~ товаров** бараа худалдаж дуусгах.
РАСПРОДА́ТЬ худалдаж дуусах, зарж дуусгах, бүгдийг худалдах, наймаалж дуусах; **~ весь товар** бүх бараагаа худалдаж дуусах.
РАСПРОПАГАНДИ́РОВАТЬ ухуулж итгүүлэх, ятгаж үнэмшүүлэх.
РАСПРОСТЕРЕ́ТЬ 1. дэлэх, дэлгэх, алдлах; **~ руки** гараа алдлах; 2. дэлгэрүүлэх, тараах, бүрхүүлэх, чиглүүлэх; **~ свое влияние на что-либо** нөлөөгөө юманд дэлгэрүүлэх.
РАСПРОСТЕРЕ́ТЬСЯ 1. сунаж хэвтэх, тэрийн унах; 2. налайх, цэлийх; 3. дэлгэрэх, тархах, бүрхэх.
РАСПРОСТЁРТ||ЫЙ дэлгэсэн, сарвайсан, алдалсан; **встретить с ~ыми объятиями** хөл алдан угтах.
РАСПРОСТИРА́ТЬ 1. дэлэх, дэлгэх, алдлах; 2. дэлгэрүүлэх, тараах, бүрхүүлэх, чиглүүлэх.
РАСПРОСТИРА́ТЬСЯ 1. *суниаж хэвтэх, тэрийн ойчих*; 2. налайх; 3. дэлгэрэх, тархах, бүрхэх.
РАСПРОСТИ́ТЬСЯ 1. хагацах, салах, хагацах ёс гүйцэтгэх, салах ёс хийх; **~ с друзьями** найз нартайгаа салах ёс хийх; 2. орхих, гээх; **~ с мечтой** мөрөөдлөө орхих.
РАСПРОСТРАНЕ́НИЕ дэлгэрүүлэх, тархаах, түгээх, нэвтрүүлэх; дэлгэрэх, тархах, түгэх, нэвтрэх; **~ опыта** туршлага дэлгэрүүлэх.
РАСПРОСТРАНЁННОСТЬ дэлгэрэх, дэлгэрсэн байх, тархах, тархсан байх.
РАСПРОСТРАНЁННЫЙ дэлгэрсэн, түгсэн, түгээмэл, дэлгэрмэл, дэлгэрэнгүй; **~ взгляд** түгээмэл үзэл.
РАСПРОСТРАНИ́ТЕЛЬ тархаагч, дэлгэрүүлэгч.
РАСПРОСТРАНИ́ТЬ 1. өргөтгөх, ихэсгэх; **~ свои владения** эзэмшлээ өргөтгөх; 2. өргөтгөх, дэлгэрүүлэх, нэвтрүүлэх; **~ своё влияние** нөлөөгөө нэвтрүүлэх; 3. дэлгэрүүлэх, тархаах, түгээх; **~ учение** сургаал дэлгэрүүлэх; 4. анхилуулах, ханхлуулах, үнэртүүлэх; 5. тарааж худалдах, тархаан өгөх, түгээх; **~ книгу** ном тарааж өгөх.
РАСПРОСТРАНЯ́||ТЬСЯ 1. уудам болох, дэлгэр болох, ихсэх, үргэлжлэх; 2. дэлгэрэх, тархах, нэвтрэх; 3. тарах, дэлгэрэх, түгэх; **слухи быстро ~лись по городу** цуурхал хотоор түргэн тарав; 4. анхилах, ханхлах, үнэртэх; **запах цветов ~лся по саду** цэцгийн үнэр цэцэрлэг дүүрэн анхилав.
РАСПРОСТРАНЯ́ТЬ 1. өргөтгөх, ихэсгэх; 2. өргөтгөх, дэлгэрүүлэх, нэвтрүүлэх; 3. дэлгэрүүлэх, тархаах, түгээх; 4. анхилуулах, ханхлуулах, үнэртүүлэх; 5. тарааж худалдах, тархаан өгөх, түгээх.
РАСПРОСТРАНЯ́ТЬСЯ 1. уудам болох, дэлгэр болох, ихсэх, үргэлжлэх; 2. дэлгэрэх, тархах, нэвтрэх; 3. тарах, дэлгэрэх, түгэх; 4. анхилах, ханхлах, үнэртэх.
РАСПРОЩА́ТЬСЯ 1. хагацах, салах, хагацах ёс гүйцэтгэх, салах ёс хийх; 2. орхих, гээх.
РАСПРЫ́СКАТЬ сүрших, цацах, түрхэх.
РАСПРЫ́СКИВАТЕЛЬ шүршүүл.
РАСПРЫ́СКИВАТЬ сүрших, цацах, түрхэх.
РА́СПРЯ хэрүүл тэмцэлдэн, хэрүүл маргаан, тэмцэлдэн, хямралдаан.
РАСПРЯГА́ТЬ мултлах, буулгах.
РАСПРЯГА́ТЬСЯ мултрах.
РАСПРЯМИ́ТЬ 1. шулуутгах, цэхлэх, залах, тэнийлгэх; **~ железный прут** төмөр саваа залах, тэнийлгэх, цэх болгох; **~ спину** нуруугаа тэнийлгэх.
РАСПРЯМИ́||ТЬСЯ 1. шулуутгах, шулуун болох, тэнийх; 2. тэнийх, цэх болох; **спина ~лась** нуруу тэнийв.
РАСПРЯМЛЯ́ТЬ 1. шулуугах, цэхлэх, залах, тэнийлгэх; 2. тэнийлгэх, шулуун болгох.
РАСПРЯМЛЯ́ТЬСЯ 1. шулуутгах, шулуун болох, тэнийх; 2. тэнийх, цэх болох.
РАСПРЯ́ЧЬ мултлах, буулгах; **~ лошадей** морьдоо мултлах.
РАСПРЯ́ЧЬСЯ мултрах.
РАСПУГА́ТЬ,
РАСПУ́ГИВАТЬ үргээх, айлгах; **волк распугал стадо** чоно мал үргээв.

РАСПУСКА́НИЕ 1. дэлгэрэх; ~ **цветов** цэцэг дэлгэрэх; 2. уусах; 3. задрах, удрах.

РАСПУСКА́ТЬ 1. тараах, чөлөө тавих; 2. тараах, татан буулгах; 3. задрах, ах захгүй болгох; 4. дэлгэх, задлах; 5. дэлгэх, тэнийлгэх; 6. сулруулах, султавих; 7. задлах, задгай тавих; 8. уусгах; 9. дэгдээх, тараах.

РАСПУСКА́ТЬСЯ 1. дэлбэрэх, дэлгэрэх, цэцэглэх; 2. тайлдах, алдуурах; 3. задрах, сэгсийх; 4. задрах, ах захгүй болох.

РАСПУСТИ́ТЬ 1. тараах, чөлөө тавих; ~ **собравшихся** цугларагсдыг тараах; 2. тараах, татан буулгах; ~ **парламент** парламентыг тараах; 3. задраах, дэг алдуулах, ах захгүй болгох; 4. дэлгэх, задлах; ~ **паруса** далбаа дэлгэх; 5. дэлэх, тэнийлгэх; 6. сулруулах, сул тавих, тайлах; ~ **пояс** бүсээ сулруулах; 7. задлах, задгай тавих, сэгсийлгэх; ~ **косы** гээгээ задлах 8. уусгах; 9. дэгдээх, тараах; ~ **слухи** цуурхал дэгдээх; распустить нюни уйлаан майлаан болох.

РАСПУСТИ́||ТЬСЯ 1. дэлбэрэх, дэлгэрэх, цэцэглэх; **цветы ~лись** цэцэг дэлгэрэв; 2. тайлдах, алдуурах; **пояс ~лся** бүс тайлдав; 3. задрах, сэгсийх; **волосы ~лись** үс сэгсийв; 4. задрах, дэгээ алдах, ах захгүй болох; **ученики ~лись** сурагчид задарчээ.

РАСПУ́ТАТЬ 1. тайлах, (*эздрээ*) гаргах; ~ **веревку** татлаганы эздрээ гаргах; 2. чөдөр тайлах, тушаа тайлах; ~ **лошадь** морины чөдөр тайлах; 3. тодорхой болгох, шийдвэрлэх; ~ **сложный вопрос** ярвигтай асуудлыг тодорхой болгох.

РАСПУ́ТА||ТЬСЯ 1. тайлдах, (*эздрээ*) гаргах; **узел ~лся** зангилаа тайлдав; 2. чөдрөө мултлах, тушаагаа тайлах; **лошадь ~лась** мөрь чөдрөө мултлажээ; 2. тодорхой болох, ойлгомжтой болох; **это дело теперь окончательно ~лось** одоо энэ хэрэг бүрэн тодорхой болов; 4. ангижрах, салах; ~ **с долгами** өрнөөс ангижрах.

РАСПУ́ТИЦА зам муудах, шавар шавхай болох; **осенняя** ~ намар зам муудах.

РАСПУ́ТНИК завхай хүн садар эр, садар самуун хүн, ужид самуун эр.

РАСПУ́ТНИЦА завхай эмэгтэй, садар эм, садар самуун эмэгтэй, ужид самуун эхнэр.

РАСПУ́ТНИЧАТЬ садарлах, садар самуун явах, завхайрах, ужидлах.

РАСПУ́ТНЫЙ завхай, садар самуун, садар, ужид самуун; ~ **человек** завхай хүн.

РАСПУ́ТСТВО завхай явдал, садар самуун, садар, ужид.

РАСПУ́ТЫВАТЬ 1. тайлах, (*эздрээ*)гаргах; 2. чөдөр тайлах, тушаа тайлах; 3. тодорхой болгох, шийдвэрлэх.

РАСПУ́ТЫВАТЬСЯ 1. тайлдах, (*эздрээ*) гаргах; 2. чөдрөө мултлах, тушаагаа тайлах; 3. тодорхой болох, ойлгомжтой болох; 4. ангижрах, салах; 5. тайлагдах, задрах.

РАСПУ́ТЬЕ замын бэлчир; **быть на** ~ хойшид юу хийхээ мэдэхгүй байх.

РАСПУХА́НИЕ хавдах, хавагнах, хөөх; 2. тэсгийх, тэнтийх, хэт ихсэх.

РАСПУШИ́ТЬ савах, сагсгар болгох; ~ **шерсть** ноос савах.

РАСПУШИ́||ТЬСЯ 1. сагсгар болох, сагсайх; **волосы ~лись** үс сагсайжээ; 2. өдөө сагсайлгах, үсээ үрзийлгэх, үрзийх.

РАСПУ́ЩЕННОСТЬ 1. задрах, задгай байдал, дэггүй явдал, ах захаа алдах; 2. завхай явдал, ужид самуун.

РАСПУ́ЩЕНН||ЫЙ 1. тараасан, чөлөө тавьсан; 2. дэлгэсэн, задалсан; **~ые знамёна** дэлгэсэн туг; 3. задарсан, задгай, дэггүй, ах захгүй, зоргоороо; **~ые дети** дэггүй хүүхдүүд, зоргоороо хүүхдүүд; 4. завхай, ужид самуун; ~ **человек** ужид самуун хүн.

РАСПЫЛЁННОСТЬ тархай байдал.

РАСПЫЛЁННЫЙ тархай, тархай бутархай.

РАСПЫЛИ́ТЬ 1. тархаах, сарниулах, бутаргах, цацах; ~ **силы** хүч сарниулах; 2. цацах, шүрших, хийсгэх.

РАСПЫЛИ́||ТЬСЯ 1. тархах, сарних, бутрах, хуваагдах; **силы ~лись** хүч сарнив; 2. бутрах, үйрэх, үйрэмдэг болох.

РАСПЯ́ТИЕ 1. загалмайлан дүүжлэх; 2. христосын дүртэй загалмай.

РАСПЯ́ТЬ загалмайлан дүүжлэх.

РАССА́ДА үрслэгч; **капустная** ~ үрслэгч байцаа.

РАССАДИ́ТЬ 1. суулгах, байр байранд нь суулгах; ~ **гостей по местам** зочдыг байр байранд нь суулгах; 2. салгаж суулгах, тус тус суулгах; 3. тараан суулгах, сийрэг тарих.

РАССА́ДНИК 1. үрслүүр; ~ **цветов** цэцгийн үрслүүр; 2. эх булаг, уурхай, сан, хөрөнгө; **племенной** ~ үүлдрийн сан.

РАССА́ЖИВАТЬ 1. суулгах, байр байранд нь суулгах; 2. тус тус суулгах, салгаж суулгах; 3. тараан суулгах, сийрэг тарих.

РАССА́ЖИВАТЬСЯ 1. суух, сууцгаах; 2. тухлан суух, налайн суух.

РАССА́СЫВАНИЕ тарах, таран шингэх, хөхөгдөх; ~ **опухоли** хаван тарах.

РАССА́СЫВАТЬ хөхөх, хөхөж шингээх, хөхөж тараах.

РАССА́СЫВАТЬСЯ тарах, хөхөгдөн шингэх, хөхөгдөх.

РАССВЕ́Т 1. үүр, үүр цайх, үүр гийх; **на ~е** үүрээр, үүр цайхад, нар битүүгээр; 2. эхэн үе, соёолох үе, үүр гийх үе; **на ~е жизни** амьдралын соёолох үед.

РАССВЕТА́||ТЬ үүр цайх, үүр гийх, үүр гэгээрэх, гэгээ орох, үүр хаяарах, үүр хяраалах; **~ет** үүр гэгээрч байна, үүр гийж байна.

РАССВИРЕПЕ́ТЬ ихэд уурдах, догшрох, хэрцгийлэх.

РАССЕДЛА́ТЬ эмээл авах; ~ **лошадь** морины эмээл авах.

РАССЕ́ИВАНИЕ тарих, цацах; ~ **семян** үр цацах.

РАССЕ́ИВАТЬ 1. сарниулах, хөөх; 2. -гүй болгох, дарах; 3. сарниулах, сулруулах, бууруулах.

РАССЕ́ИВАТЬСЯ 1. сарних, арилах; 2. сарних, бутран зугтах, бутран алга болох; 3. арилах, дарагдах, мартагдах; 4. сэргэх, уйтгараа гаргах, мартах.

РАССЕКА́ТЬ 1. цавчих, хагалах; 2. сэт цохих, сэтлэх, ярах; 3. ярах, зүсэх, хагалах.

РАССЕЛЕ́НИЕ нутаглуулах, тараан суулгах.

РАССЕ́ЛИНА ан гав; ~ **утёса** цохионы ан.

РАССЕЛИ́ТЬ 1. нутаглуулах, тараан суулгах; 2. салгаж суулгах, тус тус байрлуулах.

РАССЕЛИ́ТЬСЯ 1. нутаглах, таран суух; ~ **по реке** гол даган таран нутаглах; 2. салж суух, тус тус байрлах.

РАССЕЛЯ́ТЬ 1. нутаглуулах, тараан суулгах; 2. салган суулгах, тус тус байрлуулах.

РАССЕЛЯ́ТЬСЯ 1. нутаглах таран суух; 2. салж суух, тус тус байрлах.

РАССЕРДИ́ТЬ уурлуулах.

РАССЕРДИ́ТЬСЯ уурлах, уур хүрэх.

РАССЕ́СТЬСЯ I 1. суух, сууцгаах; ~ **по местам** байр байрандаа суух; 2. тухлан суух, налайн суух.

РАССЕ́СТЬСЯ II ан гарах, антах, гав суух, гавтах; **скала расселась** хад гавтжээ.

РАССЕЧЕ́НИЕ цавчих, сэт цохих, ярах.

РАССЕ́ЧЬ 1. цавчих, хагалах; ~ **полено** хэрчим хагалах; 2. сэт цохих, сэтлэх, ярах; ~ **губу** уруул сэтлэх; 3. ярах, зүсэх, хагалах; **пароход рассек волны** галт онгоц давалгаа зүсэв.

РАССЕ́ЯННО алмайран, хайнга.

РАССЕ́ЯННОСТЬ 1. алмай, хайнга байх, сэтгэл самуурах; 2. сийрэг байх, сийрүү байх.

РАССЕ́ЯНН||ЫЙ 1. алмай, хайнга, сэтгэл самуурсан, мартамхай; ~ **взгляд** алмай харц; 2. сийрэг, сийрүү; **~ое население** сийрэг хүн ам;3. сарниун; ~ **свет** сарниун гэрэл.

РАССЕ́Я||ТЬ 1. тарих, цацах; ~ **семена** үр цацах; 2. сарниулах, хөөх; **ветер ~л тучи** салхи үүл сарниулав; 3. арилгах; **подозрения ~лись** сэжиг арилгав; 4. сарниулах, сулруулах, бууруулах; ~ **свет** гэрэл сарниулах.

РАССЕ́Я||ТЬСЯ 1. сарних, арилах, буурах, **лучи ~лись** цацраг сарнив; 2. сарних, бутран зугтах, бутран алга болох; 3. арилах, дарагдах, мартагдах; **грусть ~лась** гуниг дарагдав; 4. сэргэх, уйтгараа гаргах, мартах.

РАССКА́З 1. өгүүлэх, ярих, өгүүлэл яриа; ~ **очевидца** харсан хүний яриа; 2. өгүүллэг; **сборник повестей и ~ов** тууж, өгүүллэгийн эмхэтгэл.

РАССКАЗА́ТЬ өгүүлэх, ярих, хэлэх, хөөрөх; ~ **сказку** үлгэр хэлэх; ~ **обо всём виденном** үзсэн бүхнээ ярих.

РАССКА́ЗЧИК өгүүлэгч, яриач, хэлэгч, өгүүлдэг хүн; **он хороший** ~ тэр сайхан ярьдаг хүн.

РАССКА́ЗЧИЦА өгүүлэгч эмэгтэй, яриач эмэгтэй, хэлэгч эмэгтэй, сайхан өгүүлдэг эмэгтэй.

РАССКА́ЗЫВАТЬ өгүүлэх, ярих, хэлэх, хөөрөх.

РАССЛАБЛЕ́НИЕ *сульдах*, тэнхэл доройтох, бие доройтох, бие сулрах, сульдах.

РАССЛА́БЛЕННОСТЬ сульдсан байдал, тэнхэл доройтсон байх, бие суларсан байдал.

РАССЛА́БЛЕННЫЙ сульдсан (*тэнхэл*) доройтсон, тамир тасарсан, бие суларсан.

РАССЛА́ИВАТЬ 1. давхраагий нь хуулах, үе үеэр салгах; давхраатуулах, үетүүлэх; 2. анги бүлэг болгох, анги давхрага болгон хуваах.

РАССЛА́ИВАТЬСЯ 1. давхраа нь хуурах, үе үеэрээ салах, давхраатах, үетэх; 2. анги бүлэг болох, анги давхрага болон хуваагдах.

РАССЛЕ́ДОВАНИЕ 1. шүүх, байцаах, судлах; **строгое** ~ хатуу шүүх, шалгах; 2. шүүх, мөрдөх, мөрдөн байцаах, мөрдөн байцаалт, мөрдлөг; ~ **дела** хэрэг шүүх; **вести** ~ мөрдөн байцаах.

РАССЛЕ́ДОВАТЬ 1. шүүх, байцаах, судлах; ~ **сообщённые факты** мэдээлсэн баримтыг судлах, шалгаж үзэх; 2. шүүх, мөрдөх, мөрдөн байцаах; ~ **дело** хэрэг шүүх.

РАССЛОЕ́НИЕ 1. давхраа нь хуурах, үе үеэрээ салах, давхраатах, үетэх; ~ **почвы** хөрсний давхраатах; 2. анги бүлэг болох, анги давхрага болон хуваагдах.

РАССЛОЙ́ТЬ 1. давхраагий нь хуулах, үе үеэр нь салгах, давхраатуулах, үетүүлэх; ~ **почву** хөрс давхраатуулах; 2. анги бүлэг болгох, анги бүлэг болгон хуваах.

РАССЛОЙ́ТЬСЯ 1. давхраа нь хуурах, үе үеэрээ салах, давхраатах, үетэх; 2. анги бүлэг болох, анги давхрага болон хуваагдах.

РАССЛЫ́ШАТЬ сонсох, дуулах; я не расслышал би сонсоогүй.

РАССМА́ТРИВАТЬ 1. харах, үзэх; 2. хэлэлцэх, хянан үзэх, байцаах; 3. үзэх тооцох.

РАССМА́ТРИВАТЬСЯ 1. харагдах, үзэгдэх; 2. хэлэлцэгдэх, судлагдах; 3. тооцогдох, тоологдох.

РАССМЕШИ́ТЬ *инээлгэх, инээд хүргэх.*

РАССМЕЯ́ТЬСЯ инээд алдах, инээд хүрэх.

РАССМОТРЕ́НИ||Е 1. хэлэлцэх, хянаж үзэх, байцаан үзэх; **при ближайшем ~и** сайтар хянан үзэхэд; ~ **проекта** төсөл хэлэлцэх; 2. хянан шийдвэрлэх, хянах, хянуулан шийдвэрлүүлэх, хянуулах; **передать дело на новое** ~ дахин хянуулахаар өгөх.

РАССМОТРЕ́ТЬ 1. харах, үзэх, таних; ~ **предмет в микроскоп** микроскопоор юм харах; **в темноте было трудно** ~ **его лицо** харанхуйд нүүрийг нь таних бэрхтэй байлаа; 2. хэлэлцэх, хянан үзэх, байцаах; ~ **заявление** өргөдөл хянан үзэх.

РАССОВА́ТЬ *чихэх, хийх.*

РАССО́Л давсалсан ус; **огуречный** ~ (*өргөст*) хэмх давсалсан ус.

РАССО́ЛЬНИК давсалсан хэмхтэй шөл.

РАССО́РИТЬ хэрэлдүүлэх, эвдрүүлэх; ~ **друзей** найз нарыг эвдрүүлэх.

РАССО́РИ||ТЬСЯ хэрэлдэх, эвдрэх, муудах; **мы с ним ~лись** бид хоёр эвдэрсэн.

РАССОРТИРОВА́ТЬ ялгах, зэрэглэн ялгах, зэрэглэх, дугаарлан ялгах, дугаарлах; ~ **товары** бараа ялгах.

РАССОРТИРО́ВКА ялгах, зэрэглэх, дугаарлах, ялгалт, зэрэглэлт, *дугаарлалт.*

РАССОРТИРО́ВЫВАТЬ ялгах, зэрэглэн ялгах, зэрэглэх, дугаарлан ялгах, дугаарлах.

РАССОСА́ТЬ хөхөх, хөхөж шингээх, хөхөж тараах.

РАССОСА́ТЬСЯ тарах, хөхөгдөн шингэх, хөхөгдөх.

РАССО́ХНУТЬСЯ хагсчих; **бочка рассохлась** торх хагсчихжээ.

РАССПРА́ШИВАТЬ,

РАССПРОСИ́ТЬ асууж сураглах, асуун сурах, /олон юм/ асуух, сурах.

РАССПРО́СЫ асуух. **РАССРЕДОТО́ЧИВАТЬ,**

РАССРЕДОТО́ЧИТЬ тархаан байрлуулах; ~ **войска** цэрэг тархаан *байрлуулах.*

РАССРЕДОТО́ЧИВАТЬСЯ,

РАССРЕДОТО́ЧИТЬСЯ тархан байрлах.

РАССРО́ЧИТЬ хугацаа сунгах; ~ **погашение долга** өр төлөх хугацааг сунгах.

РАССРО́ЧК||А цуврyулан төлөх; **купить в ~у** цуврyулан төлөхөөр авах.

РАССТАВА́НИ||Е хагацах, салах; **при ~и** хагацахдаа, салахдаа.

РАССТАВА́ТЬСЯ 1. хагацах, салах, ангижрах, орхих; 2. орхих, салах, хаях.

РАССТА́ВИТЬ 1. тавих, өрөх, жагсаах, байрлуулах; ~ **шахматы** шатар өрөх; ~ **запятые** тасалга тавих; 2. хуваарилан тавих, хуваарилах; 3. алцайлгах, алцайх, заах; ~ **ноги** алцайх; 4. өргөн болох, тавьж өгөх, оруулга оруулах.

РАССТАНО́ВК||А 1. тавих, өрөх, жагсаах, байрлуулах, 2. хуваарилан тавих, хуваарилах; 3. нугалбар, завсарлага, зогсоц; **читать с ~ой** нугалбартай унших.

РАССТА́ТЬСЯ 1. хагацах, салах, ангижрах, орхих; ~ **с любимыми вещами** хайртай юмнаасаа салах.

РАССТЁГИВАТЬ тайлах, мултлах, задгай тавих.

РАССТЁГИВАТЬСЯ 1. тайлдах, алдуурах, мултрах, тайлагдах; 2. хувцасныхаа товчий нь тайлах, энгэрээ задгай тавих.

РАССТЁГНУТ||ЫЙ задгай тавьсан, товчий нь тайлсан; **с ~ым воротом** зах нь задгай.

РАССТЕГНУ́ТЬ тайлах, мултлах, задгай тавих; ~ **пальто** пальтогоо задгай тавих; ~ **пуговицы** товч тайлах.

РАССТЕГНУ́ТЬСЯ 1. тайлдах, алдуурах, мултрах, тайлагдах; 2. хувцасныхаа товчий нь тайлах, энгэрээ задгай тавих; **идти расстегнувшись** /пальтоныхоо/ энгэрийг задгай тавьж явах.

РАССТЕЛИ́ТЬ дэвсэх, дэлгэх.

РАССТЕЛИ́ТЬСЯ суунаглах, татах, бүрхэх.

РАССТИЛА́ТЬ дэвсэх, дэлгэх.

РАССТИЛА́ТЬСЯ 1. суунаглах, татах, бүрхэх; 2. цэлийх, мэлтийн харагдах.

РАССТОЯ́НИ||Е 1. зай, газар, хол ойр; ~ **между двумя городами** хоёр хотын хоорондохь зай; 2. /хол/ зай /байх/; **держать кого-либо на ~и** нэг хүнтэй дотно болохоос зайлсхийх.

РАССТРА́ИВАТЬ 1. эвдэх, замбараагий нь алдуулах, сандаах; 2. хохирол учруулах, эмхгүй болгох; 3. хор хүргэх, өвчлүүлэх, муудуулах; 4. саад хийх, эвдэх; 5. урам хугалах, гуниг төрүүлэх; 6. хөг алдуулах, хөггүй болгох.

РАССТРА́ИВАТЬСЯ 1. замбараагаа алдах, сандрах, эвдрэх; 2. хохирол учрах, эмхгүй болох; 3. муудах, өвчлөх; 4. саад тохиолдох, бүтэхгүй болох; 5. хөг алдах, хөггүй болох; 6. урам хугарах, гуниг төрөх.

РАССТРЕ́Л буудан алах, буудан алах ял; **приговорить к ~у** буудан алах ял оногдуулах.

РАССТРЕ́ЛИВАТЬ 1. буудан алах; 2. дуустал буудах, буудаж дуусах; 3. ихэд буудах.

РАССТРЕЛЯ́ТЬ 1. буудан алах; 2. дуустал буудах, буудаж дуусах; 3. ихэд буудах.

РАССТРО́ЕННЫЙ 1. замбараагаа алдсан, сандарсан; 2. бүтэлгүй болсон, эмхгүй болсон; 3. муудсан, өвчилсөн; 4. хөг алдсан, хөггүй болсон; 5. урам хугарсан, гунигласан.

РАССТРО́И||ТЬ 1. эвдэх, замбараагий нь алдуулах, сандаах; 2. хохирол учруулах, эмхгүй болгох, бүтэмжгүй болгох; 3. хор хүргэх, өвчлүүлэх, муудуулах; **~ здоровье** эрүүл мэндэд хор хүргэх; 4. саад хийх, эвдэх; **~ планы** төлөвлөгөө эвдэх; 5. урам хугалах, гуниг төрүүлэх; **эта весть ~ла его** энэ мэдээ урмыг нь хугалав; 6. хөг алдуулах, хөггүй болгох; **~ скрипку** хийлийн хөгийг алдуулах.

РАССТРО́И||ТЬСЯ 1. замбараагаа алдах, сандрах, эвдрэх; 2. хохирол учрах, эмхгүй болох, бүтэлгүй болох; 3. муудах, өвчлөх; **здоровье ~лось** бие өвчлөв; 4. саад тохиолдох, бүтэхгүй болох; **его планы ~лись** түүний төлөвлөгөөнд саад тохиолдов; 5. хөг алдах, хөггүй болох; 6. урам хугарах, гуниг төрөх; **~ от неудачи** азгүй явдлаас урам хугарах.

РАССТРО́ЙСТВО 1. замбараагаа алдах, сандрах, сандрал; 2. бүтэлгүй болох, сүйдэх; 3. муудах, өвчлөх, эвгүй болох; **~ желудка** дотор эвгүй болох, ходоод муудах; 4. уйтгар, гуниг, муу оёг; **прийти в ~** гуниг төрөх, муу оёг хүрэх.

РАССТУПА́||ТЬСЯ,

РАССТУПИ́||ТЬСЯ, 1. зам тавьж өгөх, зай гаргах, зайлах; **толпа ~лась** цуглагсад зам тавьж өгөв; 2. ан гарах, цуу үсрэх; **скала ~лась** хад цуу үсрэв.

РАССУДИ́ТЕЛЬНОСТЬ бодлоготой байх, тунгаан бодохдоо сайн.

РАССУДИ́||ТЬ 1. туйвруулах, таслах, тасалж өгөх, нэг тийш болгох; **~ спор** маргаан таслах; 2. бодох, эргэцүүлэн бодох, шийдэх; **~те, как быть** яавал зохихыг эргэцүүлэн бодогтун.

РАССУ́Д||ОК бодлого, ухаан; **быть в полном ~ке** ухаан бүрэн байх, ухаан эрүүл байх; **лишиться ~ка, потерять ~** ухаан солиорох.

РАССУ́ДОЧНОСТЬ бодлоготой байх, ухаантай байх.

РАССУЖДА́ТЬ 1. бодох, тунгаан бодох; **научиться ~** тунгаан бодож сурах; 2. шүүмжлэн хэлэлцэх, шүүмжлэн хэлэх.

РАССУЖДЕ́НИ||Е 1. бодох, тунгаан бодох, бодлого; **правильное ~** зөв тунгаан бодох; 2. шүүмжлэн хэлэлцэх, шүүмжлэн хэлэх; **пускаться в ~я** шүүмжлэн хэлж гарах, элдэв юм хэлэх.

РАССУ́ЧИВАТЬ задлах, эрчий нь гаргах; **~ верёвку** олс задлах.

РАССЧИ́ТАНН||ЫЙ 1. ончийг нь олсон, тааруулсан, баримжааг нь олсон; 2. зориуд /хэлсэн/, санаатай; **~ая грубость** зориуд хэлсэн ширүүн үг.

РАССЧИТА́ТЬ 1. тооцоолох, тооцоо хийх, бодож гаргах, бодох; **~ стоимость чего-либо** юмны өртгийг бодож гаргах; 2. баримжаалах, барагцаалан мэдэх; **не ~ своих сил** хүчээ барагцаалан мэдэхгүй; 3. халах, гаргах; 4. тоолуулах, бүртгэх.

РАССЧИТА́||ТЬСЯ 1. төлөн дуусгах, өр ширгүй болох; 2. дансаа бодолцох, хариугаа авах; **я ещё с тобой ~юсь!** Би чамтай дансаа бодолцоно доо!; 3. тоолох.

РАССЧИ́ТЫВА||ТЬ 1. тооцоолох, тооцоо хийх, бодож гаргах, бодох; 2. баримжаалах, барагцаалан мэдэх; 3. халах, гаргах; 4. тоолуулах, бүртгэх; 5. гэх, гэж бодох, бодох, найдах, горьдох; **он ~л прийти** тэр ирэхийг бодож байв; 6. найдах, итгэх; **~ на старого друга** хуучин найздаа найдах.

РАССЧИ́ТЫВАТЬСЯ 1. төлөн дуусгах; өр ширгүй болох, дансаа бодолцох, хариугаа авах; 2. тоолох; 3. даах, хариуцлагыг хүлээх; **~ за свои ошибки** алдааныхаа хариуцлагыг хүлээх.

РАССЫЛА́ТЬ тараах, түгээх /газар газар/ илгээх, явуулах.

РАССЫЛА́ТЬСЯ түгээгдэх, /газар газар/ илгээгдэх.

РАССЫ́ЛКА тараах, түгээх; **~ газет** сонин түгээх.

РАССЫ́ЛОЧНЫЙ тараах, түгээх, илгээх, тараадаг, түгээдэг, илгээдэг.

РАССЫ́ЛЬНЫЙ зарлага.

РАССЫ́ПАТЬ 1. асгах, үрэх, үйрүүлэх, цацах; **~ крошки по столу** талх ширээн дээр үйрүүлэх; 2. хийх, асгах; 3. тархаах, зайтай байлгах.

РАССЫПА́ТЬСЯ 1. асгарах, үйрэх, цацагдах; 2. бутрах, задрах, зад үсрэх; 3. тархах, зайтай байх; 4. задран унах, устах, балрах; 5. үг урсгах.

РАССЫПНО́Й 1. үйрмэг, бутархай, элсэн; 2. ширхгээр зардаг.

РАССЫ́ПЧАТЫЙ үйрэм, үйрэмдэг, үйрдэг.

РАССЫХА́ТЬСЯ хагсах.

РАСТА́ЛКИВАТЬ 1. түлхэх, түлхэж салгах, түлхэж зайлуулах; 2. түлхэж сэрээх.

РАСТА́ПЛИВАНИЕ 1. гал түлэх, галлах; 2. хайлуулах; **~ воска** лав хайлуулах.

РАСТА́ПЛИВАТЬ I галлах, гал түлэх, ноцоох.

РАСТА́ПЛИВАТЬ II хайлуулах.

РАСТА́ПТЫВАТЬ гишгэлэх, хага гишгэлэх, няц гишгэлэх, бяц дэвсэх.

РАСТАСКА́ТЬ,

РАСТА́СКИВАТЬ 1. зөөх, аваачих, зөөж дуусах; 2. хулгайлах, үрэх; **~ казённое имущество** сангийн эд хогшил хулгайлах.

РАСТАСОВА́ТЬ холих; **~ карты** хөзөр холих.

РАСТА́ЧИВАТЬ зорж ихтгэх, зорж засах.

РАСТАЩИ́ТЬ 1. аваачих, зөөж дуусах; 2. салгах; **~ дерущихся** зодолдогсдыг салгах.

РАСТА́Я||ТЬ 1. хайлах, урсах; **снег ~л** цас хайлав; 2. замхрах; 2. уярах, зөөлрөх.

РАСТВО́Р I ам, ангархай; **~ циркуля** гортигийн ам; 2. ангархай, онгорхой завсар.

РАСТВО́Р II уусмал, зуурмаг; **насыщенный ~** ханасан уусмал; **известковый ~** шохойн зуурмаг.

РАСТВОРЕ́НИЕ уусах, уусгах.

РАСТВОРИ́МОСТЬ уусах чанар, уусац.

РАСТВОРИ́М||ЫЙ уусах, уусдаг; **~ые вещества** уусдаг эд.

РАСТВОРИ́ТЕЛЬ уусгагч, зууураг.

РАСТВОРИ́ТЬ I нээх, тайлах; **~ двери** хаалга нээх.

РАСТВОРИ́ТЬ II уусгах, хайлуулах, зуурах; **~ соль в воде** давс усанд уусгах.

РАСТВОРИ́||ТЬСЯ I нээгдэх, тайлдах; **калитка ~лась** суга хаалга нээгдэв.

РАСТВОРИ́ТЬСЯ II 1. уусах, хайлах; 2. алга болох, уусах.

РАСТВОРЯ́ЕМОСТЬ уусах чанар, уусац.

РАСТВОРЯ́ТЬСЯ I нээгдэх, тайлах, нээгдэх.

РАСТВОРЯ́ТЬСЯ II уусгах, хайлуулах, зуурах.

РАСТВОРЯ́ТЬСЯ III 1. уусах, хайлах; 2. алга болох, уусах.

РАСТЕКА́ТЬСЯ 1. урсах, тархах, гүйх; 2. нүүх, баах; 3. дүүрэн байх.
РАСТЕ́НИ||Е ургамал; **однолетнее ~** нэг наст ургамал; **сельскохозяйственные ~я** хөдөө аж ахуйн ургамал.
РАСТЕНИЕВО́Д, ургамлын мэргэжилтэн.
РАСТЕНИЕВО́ДСТВО 1. ургамал тарих; 2. ургамал тарих ухаан.
РАСТЕНИЕВО́ДЧЕСКИЙ ургамал тарих, ургамал тарихын.
РАСТЕРЕ́ТЬ 1. нухах, нүдэх, нунтаглах; **~ в порошок** нунтаглах, нунтаг болгох; 2. нялзаах, нялах, түрхэх; 3. илэх, барих, илбэх; **~ ушибленное место** бэртсэн газрыг илэх, барих.
РАСТЕРЕ́ТЬСЯ 1. нунтаграх, нунтаг болох, нухагдах, нүдэгдэх; 2. биеэ арчих; **~ полотенцем** алчуураар биеэ арчих.
РАСТЕРЗА́||ТЬ тасар татах; **волк ~л ягнёнка** чоно хурга тасар татжээ.
РАСТЕ́РЯННОСТЬ мэгдсэн байдал, сандрал.
РАСТЕ́РЯННЫЙ 1. гээсэн, хаясан, унагасан; 2. мэгдсэн, сандарсан, мэгдэнгэ, сандранги; **~ вид** сандранги байдал.
РАСТЕРЯ́ТЬ 1. гээх, хаях, алга болгох; **~ вещи** юмаа гээх; 2. алдах, сураггүй болох; **~ родных** төрлөөсөө сураггүй болох.
РАСТЕРЯ́||ТЬСЯ I гээгдэх, хаягдах, алга болох; **все вещи ~лись в пути** замд бүх юм алга болжээ.
РАСТЕРЯ́ТЬСЯ II сандрах, мэгдэх, самгардах; **~ от неожиданности** цочсондоо мэгдэх.
РАСТЕ́||ЧЬСЯ 1. урсах, тархах, гүйх; 2. дүүрэн байх; **по лицу ~клась улыбка** нүүр дүүрэн инээмсэглэв.
РАСТИ́ 1. өсөх, ургах, том болох; **дети на глазах растут** хүүхдүүд харсаар байтал өсч байна; 2. өсөх, торних, хүмүүжих; **он рос в городе** тэр хотод өссөн хүн; 3. өсөх, арвижих, их болох; 4. өсөх, өрнөх, хөгжих; 5. өсөх, ургах, нэмэгдэх, боловсрох.
РАСТИРА́НИЕ 1. нухах, нүдэх, нунтаглах; 2. илэх, барих, илбэх.
РАСТИРА́ТЬ 1. нухах, нүдэх, нунтаглах; 2. нялзаах, нялах, түрхэх; 3. илэх, илбэх.
РАСТИРА́ТЬСЯ 1. нунтаграх, нунтаг болох, нухагдах, нүдэгдэх; 2. биеэ арчих.
РАСТИ́ТЕЛЬНОСТЬ 1. өвс ургамал, ургамалын зүйл, ургамал; 2. үс, үс сахал, сахал.
РАСТИ́ТЕЛЬН||ЫЙ I 1. ургамлын, ургамлаар хийсэн; **~ мир** ургамлын аймаг; 2. ургамлын, ургамлаас гаргадаг; **~ое масло** ургамлын тос.
РАСТИ́ТЕЛЬНЫЙ II өсөх, ургах; **~ процесс** өсөх явц.
РАСТИ́ТЬ 1. өсгөх, хүмүүжүүлэх, торниулах; **~ детей** хүүхэд өсгөх; 2. өсгөх, ургуулах, тавих; **~ цветы** цэцэг ургуулах; **~ бороду** сахал ургуулах, тавих.
РАСТЛЕ́НИЕ 1. /хүүхдийг/ хүчирхэх, хүчирхэн явалдах, бузарлах; 2. ёсгүй явдал, зарчимгүй хэрэг.
РАСТЛЕ́ННЫЙ ёсгүй, ёс суртахуунгүй, зарчимгүй.
РАСТЛИ́ТЬ 1. /хүүхдийг/ хүчирхэх, хүчирхэн явалдах, бузарлах; 2. завхайруулах, ёсгүй явдалд сургах.
РАСТОЛКА́ТЬ 1. түлхэх, түлхэн салгах, түлхэн зайлуулах; 2. түлхэн сэрээх.
РАСТОЛКОВА́ТЬ тайлбарлах, тайлбарлан ойлгуулах, ухуулах.
РАСТОЛКО́ВЫВАТЬ тайлбарлах, тайлбарлан ойлгуулах, ухуулах.
РАСТОЛО́ЧЬ нүдэх, нунтаглах; **~ перец** поваари нүдэх.
РАСТОЛСТЕ́ТЬ бүдүүрэх, таргалах.
РАСТОПИ́ТЬ I галлах, гал түлэх, асаах; **~ печь** пийшин галлах.
РАСТОПИ́ТЬ II хайлуулах; **~ масло** тос хайлуулах.
РАСТОПИ́ТЬСЯ I галлагдах, гал асах, ноцох.
РАСТОПИ́ТЬСЯ II хайлах.
РАСТОПТА́ТЬ гишгэх, хага гишгэх, няц гишгэх, бяц дэвсэх.
РАСТОПЫ́РИВАТЬ,
РАСТОПЫ́РИТЬ арвайлгах, сарвайлгах, алцайлгах, ёрвойлгох, цорвойлгох; **~ губы** уруулаа ёрвойлгох.
РАСТОПЫ́РИВАТЬСЯ,
РАСТОПЫ́РИТЬСЯ, арвайх, сарвайх, алцайх, ёрвойх, цорвойх; **пальцы растопырились** хуруу нь арвайв.
РАСТОРГА́ТЬ,
РАСТОРГНУ́ТЬ, цуцлах; **~ договор** гэрээ цуцлах.
РАСТОРЖЕ́НИЕ цуцлах, цуцлалт.
РАСТОРМОШИ́ТЬ 1. татаж сэрээх, хөдөлгөж сэрээх; 2. идэвхжүүлэх.
РАСТОРО́ПНОСТЬ шаламгай байх, гавшгай байх.
РАСТОРО́ПНЫЙ шаламгай, гавшгай, шалбалзсан, шалав хийсэн; **~ человек** шаламгай хүн.
РАСТОЧА́ТЬ 1. үрэх, үрэгдүүлэх; **~ деньги** мөнгө үрэх; 2. нөгцөөх, үрэх; 3. дэндүүлэх, өнгөрүүлэх; **~ улыбки** дэндүү их инээмсэглэх; **~ похвалы** өнгөрүү магтах.
РАСТОЧА́ТЬСЯ үрэгдэх.
РАСТОЧИ́ТЕЛЬНОСТЬ үрэмтгий байх, үрэмхий зан, үрлэгч явдал.
РАСТОЧИ́ТЕЛЬНЫЙ үрэмтгий, үрэмхий, үрлэгч; **~ человек** үрэмтгий хүн, үрлэгч.
РАСТОЧИ́ТЕЛЬСТВО үрэмтгий байх, үрлэгч зан, үрэх.
РАСТОЧИ́ТЬ I 1. үрэх, үрэгдүүлэх; 2. нөгцөөх, үрэх; 3. дэндүүлэх, өнгөрүүлэх.
РАСТОЧИ́ТЬ II зорж ихтгэх, зорж засах.
РАСТО́ЧКА зорох, зорж засах.
РАСТРА́ВИТЬ,
РАСТРА́ВЛИВАТЬ 1. сэдрээх, хөндөх; **~ рану** шарх сэдрээх; 2. хөндөх, сэргээх, /юм/ санагдуулах; 3. хордуулах.
РАСТРАНЖИ́РИТЬ үрэх, үрэн таран хийх, сүйтгэх; **~ деньги** мөнгө үрэн таран хийх.
РАСТРА́Т||А шамшигдал, шамшигдуулах, шамших; **покрыть ~у** шамшсаныг төлөх.
РАСТРА́ТИТЬ 1. зарах, үрэх; **~ деньги на мелочи** аар саар юманд мөнгө үрэх; 2. шамшигдуулах, шамших, үрэгдүүлэн сүйтгэх; **~ казённые деньги** сангийн мөнгө шамшигдуулах.
РАСТРА́ТЧИК шамшигдуулагч, шамшигч.
РАСТРА́ТЧИЦА шамшигдуулагч эмэгтэй, шамшигч эхнэр.
РАСТРА́ЧИВАТЬ 1. үрэх, үрэгдүүлэх; 2. шамшигдуулах, шамших, үрэгдүүлэн сүйтгэх.
РАСТРА́ЧИВАТЬСЯ 1. үрэгдэх, үрэх; 2. шамшигдах, үрэгдэн сүйдэх.
РАСТРЕВО́ЖИТЬ сэтгэл зовоох, цочоох, сандаргах, үймүүлэх, сэдрээх.
РАСТРЕВО́ЖИТЬСЯ сэтгэл зовох, цочих, сандрах, сэдрэх.
РАСТРЕЗВО́НИТЬ зар тараах, цуу тараах.
РАСТРЁПАНН||ЫЙ 1. үнгэгдсэн, навтархай, навтас болсон; 2. сэглэгэр, сэглийсэн, сэгсийсэн; **~ые волосы** сэглэгэр үс.
РАСТРЕПА́ТЬ 1. сэглийлгэх, сэгсийлгэх; **~ волосы** үс сэгсийлгэх; 2. үнгэх, навтархай болгох; 3. гүвэх, савах.
РАСТРЕПА́ТЬСЯ 1. сэглийх, сэгсийх; 2. үнгэгдэх, навтархай болох.
РАСТРЕСК||А́ТЬСЯ,
РАСТРЕ́СК||ИВАТЬСЯ, хагачих, ан гав гарах, цав болох; **потолок ~ался** тааз хагачив.
РАСТРО́ГАННО уяран, сэтгэл уяран, сэтгэл хөдлөн.
РАСТРО́ГАНН||ЫЙ уярсан, сэтгэл уярсан сэтгэл хөдөлсөн; уян; **все были растроганы** бүгдийн сэтгэл уярсан байв; **говорить ~ым голосом** сэтгэл уярсан дуугаар хэлэх.

РАСТРО́ГАТЬ уяруулах, сэтгэл уяруулах, сэтгэл хөдөлгөх.
РАСТРО́ГАТЬСЯ уярах, сэтгэл уярах, сэтгэл хөдлөх.
РАСТРУ́Б 1. амсар, хоолой; ~ **трубы** хоолойн амсар; 2. бугалга; ~ **духового инструмента** үлээвэр хөгжмийн бугалга; 3. шамраас, эргээс; **сапоги с ~ами** шамраастай савхин гутал.
РАСТРУБИ́ТЬ цуу дэгдээх, зар гаргах.
РАСТРЯС||ТИ́ 1. тараах, зулах; ~ **сено для просушки** хатаах гэж өвс тараах; 2. дэмий үрэх, алга хийх; ~ **деньги** мөнгө дэмий үрэх; 3. аянших, донсолгоонд ядрах, аяншиж ядрах; **в дороге меня ~ло** би замд аяншиж ядрав.
РАСТЯ́ГИВАТЬ 1. сунгах, сунгаж дэлгэх, тэлж дэлгэх, дэлгэх; 2. сунаах, сунгах; 3. уртдуулах, хэт урт болгох; 4. шидрэх, сунах; 5. сунжуулах, унжруулах, удаашруулах.
РАСТЯ́ГИВАТЬСЯ 1. сунаж хэвтэх; 2. тэрийн унах, тэрийх 3. сунах; 4. уртдах, хэт урт болох; 5. сунжих, унжрах, удаашруулах.
РАСТЯЖЕ́НИЕ 1. сунаах, сунгах, сунах; 2. шидрэх, сунах; ~ **связок** шөрмөс сунах.
РАСТЯЖИ́МОСТЬ олон утгатай /байх/, янз янз тайлбарлагдах.
РАСТЯЖИ́М||ЫЙ олон утгатай, янз янз тайлбарлагдах; **~ое понятие** олон утгатай ухагдахуун.
РАСТЯ́НУТОСТЬ 1. сунжирхай байх, унжирсан байх; 2. сунац; ~ **шерсти** үсний сунац.
РАСТЯ́НУТЫЙ 1. сунгамал, сунаасан, сунгасан, тэлсэн, дэлгэсэн; 2. уртадсан, хэт урт; 3. сунжсан унжирсан, удааширсан; ~ **роман** унжирсан роман.
РАСТЯНУ́ТЬ 1. сунгах, сунгаж дэлгэх, тэлж дэлгэх; дэлгэх; ~ **сырую кожу** нойтон арьс тэлж дэлгэх; 2. сунаачих, сунгачих; ~ **резинку** эрзээн сунаачих; 3. уртдуулах, хэт урт болгох; ~ **фасад дома** байшингийн нүүр талыг уртдуулах; 4. шидрэх, сунах; ~ **связку** шөрмөс шидрэх; 5. сунжуулах, унжруулах, удаашруулах; ~ **доклад** илтгэл сунжуулах; ~ **работу на месяц** ажлаа сараар удаашруулах.
РАСТЯНУ́||ТЬСЯ 1. сунаж хэвтэх; ~ **на диване** диван дээр сунаж хэвтэх; 2. тэрийн унах, тэрийх; ~ **во весь рост** тэрийн унах; 3. суначих, сунах; **подтяжки ~лись** мөрөвч суначив; 4. уртдах, хэт урт болох; 5. сунжих.
РАСТЯ́ПА молхи амьтан, бойдон хүн.
РАСФАСО́ВАННЫЙ хэмжин савласан, жигнэж, боосон, хэмжин багласан, багцалсан.
РАСФАСОВА́ТЬ хэмжин савлах, жигнэн боох, хэмжин баглах, багцлах.
РАСФАСО́ВКА хэмжин савлах, багцлах, хэмжин савлалт, багцлалт.
РАСФАСО́ВЫВАТЬ хэмжин савлах, жигнэн боох, хэмжин баглах, багцлах.
РАСФОРМИРОВА́НИЕ тараах, тараалт; ~ **полка** хороог тараах.
РАСФОРМИРОВА́ТЬтараах, өөрчлөн байгуулах.
РАСФОРМИРО́ВЫВАТЬ, тараах, өөрчлөн байгуулах.
РАСФОРМИРО́ВЫВАТЬСЯ тараагдах, өөрчлөгдөн байгуулагдах.
РАСФРАНТИ́ТЬСЯ гангалах, дэгжирхэх.
РАСФРАНЧЁННЫЙ гангалсан, дэгжин хувцасласан.
РАСХА́ЖИВАТЬ алхлах; ~ **взад и вперед** хойш урагшаа алхлах; ~ **по комнате** тасалгаан дотуураа алхлах.
РАСХВА́ЛИВАТЬ,
РАСХВАЛИ́ТЬ ихэд магтах, магтах; ~ **до небес** тэнгэр тултал магтах.
РАСХВАСТА́ТЬСЯ сайрхах, бардамнах.
РАСХВАТА́ТЬ,
РАСХВА́ТЫВАТЬ яаран авцгаах, шүүрэн авцгаах, булаалдан авцгаах.
РАСХВОРА́ТЬСЯ хүнд өвчлөх, өвдөх.
РАСХИТИ́ТЕЛЬ хулгайлагч, шамшигч.
РАСХИ́ТИТЬ,
РАСХИЩА́ТЬ хулгайлах, шамших; ~ **имущество** эд хогшил хулгайлах.
РАСХИЩЕ́НИЕ хулгайлах, шамших явдал.
РАСХЛЕБА́ТЬ учир начрыг нь олох; **заварил кашу, теперь расхлёбывай** хутгаж орхисон юмныхаа учир начрыг нь одоо ол.
РАСХЛЯ́БАННОСТЬ цалгар байх, цалгардал.
РАСХЛЯ́БАНН||ЫЙ 1. холхисон, сул болсон, ганхсан; 2. ганхсан, салтирганасан; **~ая походка** салтирганасан явдал, салтирганан явах; 2. цалгар, замбараагүй; **~ое поведение** цалгар зан.
РАСХО́Д 1. зарлага, зардал суйтгэл; **~ы производства** үйлдвэрлэлийн зарлага; **мелкие ~ы** аар саар зардал; **ввести кого-либо в ~** хүнийг зардалд унагах; **покрыть ~ы** зардлаа таглах; 2. зарцуулах, зарах, хэрэглэх, зарлага, гарлага; ~ **топлива** түлш зарах; ~ **материалов** хэрэглэгдэхүүний гарлага; 3. зарлага, зарлагын хүснэгт; **приход и ~** орлого зарлага; **списать что либо в ~** юм зарлагад гаргах; зарлагын хүснэгт бичих; **вывести в ~, пустить в ~, списать в ~** гарзанд гаргах.
РАСХОДИ́ТЬСЯ I 1. тарах, тархах; 2. тарах, тархах, сарних; 3. тэнийх, арилгах; 4. салах, хагацах; 5. ярагдах, завсар гарах, ангайх; 6. нийлэхээ байх, таарахгүй болох, зөрөх; 7. үрэгдэх, дуусах, барагдах, зарж дуусах; 8. зөрөх, алгасах; 9. харих, намдах; 10. хайлах, шингэх, уусах; 11. гаарах, ширүүсэх; 12. хөөрөх, хөгжих.
РАСХОДИ́ТЬСЯ II ихэд уурлах, хилэгнэх.
РАСХО́ДН||ЫЙ зарлагын, зардлын; **~ые статьи** зарлагын зүйл.
РАСХО́ДОВАНИЕ зарцуулах, зарах, зарцуулга.
РАСХО́ДОВАТЬ зарцуулах, зарах, хэрэглэх; ~ **деньги** мөнгө зарцуулах.
РАСХО́ДОВАТЬСЯ 1. мөнгө зарах, мөнгө зарцуулах; 2. зарагдах, зарцуулагдах.
РАСХОЖДЕ́НИЕ 1. салах, тарах, цацрах; ~ **солнечных лучей** нарны гэрэл цацрах; 2. зөрөх, нийлэхээ байх, таарахгүй болох; ~ **между приходом и расходом** орлого зарлага зөрөх; ~ **во взглядах** үзэл нийлэхээ байх.
РАСХОЛА́ЖИВАТЬ урам хариулах, урам хугалах.
РАСХОЛОДИ́ТЬ урам хариулах, урам хугалах.
РАСХОТЕ́||ТЬ дургүй болох, хүсэхгүй болох; **я ~л есть** би хоол идэх дургүй болов.
РАСХОТЕ́||ТЬСЯ хүсэлгүй болох, хүрэхээ болих; **мне ~лось спать** миний нойр хүрэхээ болив.
РАСХОХОТА́ТЬСЯ тачигнатал инээх, хөхрөх; **громко ~** тачигнатал инээх.
РАСХРАБРИ́ТЬСЯ зүрх орох, шийдэх.
РАСЦАРА́ПАТЬ зулга маажих, зулга татах.
РАСЦАРА́ПАТЬСЯ 1. зулга маажуулах, зулга татуулах; 2. зулга маажилцах.
РАСЦВЕ||СТИ́,
РАСЦВЕ||ТА́ТЬ 1. цэцэглэх, дэлгэрэх; **розы ~ли** сарнай цэцэг дэлгэрэв; 2. эрүүл саруул болох, сайхан болох, үзэсгэлэн бүрдэх; 3. тодрох, баясах; **лицо её ~ло улыбкой** тэр баясан инээмсэглэв; 4. цэцэглэх, цэцэглэн дэлгэрэх, мандах, цэцэглэн мандах, цэцэглэн хөгжих.
РАСЦВЕ́Т 1. цэцэглэх, дэлгэрэх; ~ **яблонь** алимын мод цэцэглэх; 2. цэцэглэлт, мандалт, бадралт, цэцэглэн хөгжилт, ид; **в ~е сил и здоровья** хүч чадлынхаа ид дунд.

РАСЦВЕТА́ТЬ 1. цэцэглэх, дэлгэрэх; 2. эрүүл саруул болох, үзэсгэлэн бүрдэх; 3. тодрох, баясах; 4. цэцэглэх, цэцэглэн дэлгэрэх, мандах, цэцэглэн мандах, цэцэглэн хөгжих.

РАСЦВЕ́ТИТЬ I 1. алаглан будах, эрээлэн будах, будах; ~ **красками** өнгө өнгөөр будах; 2. өнгийн юмаар чимэглэх.

РАСЦВЕ́ТИТЬ II алаг болох, эрээн болох.

РАСЦВЕ́ТКА 1. алаглан будах, эрээлэн будах; 2. өнгө, зүс; у **этой материи неприятная** ~ энэ муухай өнгөтэй бөс байна.

РАСЦВЕ́ЧИВАТЬ 1. алаглан будах, эрээлэн будах; 2. өнгийн юмаар чимэх.

РАСЦВЕ́ЧИВАТЬСЯ 1. алаг өнгөөр будагдах, эрээн өнгөөр будагдах; 2. өнгийн юмаар чимэглэгдэх.

РАСЦЕЛОВА́ТЬ чанга озох, озож озчих, чанга үнсэх.

РАСЦЕЛОВА́ТЬСЯ озолдох, үнсэлдэх.

РАСЦЕ́НИВА||ТЬ 1. үнэ зохиох, үнэ тогтоох, үнэлэх; 2. үнэлэх, үзэх; **как вы ~ете его предложение?** Түүний саналыг та юу гэж үзэж байна?

РАСЦЕ́НИВАТЬСЯ үнэлэгдэх.

РАСЦЕНИ́ТЬ үнэ зохиох, үнэ тогтоох, үнэлэх; расценить товар барааны үнэ тогтоох.

РАСЦЕ́НКА 1. үнэлэх, үнэ зохиох, үнэ зохиол; 2. үнэ, хөлс.

РАСЦЕ́НОЧНЫЙ үнэ зохиох, үнэ зохиолын.

РАСЦЕПИ́ТЬ салгах, таслах; ~ **вагоны** вагон салгах.

РАСЦЕПИ́ТЬСЯ салах, тасрах.

РАСЦЕПЛЯ́ТЬ салгах, таслах.

РАСЦЕПЛЯ́ТЬСЯ 1. салах, тасрах; 2. салгагдах, таслагдах.

РАСЧЕРТИ́ТЬ шугамдах, шугам татах, зураас гаргах; ~ **карту квадратами** зурғийг дөрвөлжин шугамдах.

РАСЧЕСА́ТЬ 1. самнах; ~ **волосы** үс самнах; 2. зулга маажих; маажих ~ **руку** гараа маажих.

РАСЧЕСА́ТЬСЯ 1. үсээ самнах; 2. маажиж гарах.

РАСЧЁСКА сам.

РАСЧЁСТЬ 1. бодох, бодож гаргах; 2. баримжаалах, барагцаалан мэдэх; 3. халах, гаргах.

РАСЧЁСЫВАНИЕ 1. самнах, самналт; 2. маажих, маажилт.

РАСЧЁСЫВАТЬ 1. үсээ самнах; 2. маажиж гарах; 3. самнуулах; 4. маажуулах.

РАСЧЁТ 1. тооцоо, тооцоолох, тооцоо хийх; **правильный** ~ зөв тооцоо; **ошибка в ~е** тооцоолохдоо хийсэн алдаа; 2. төлөх, тооцоолох; **за наличный** ~ бэлэн мөнгөөр төлж, бэлэн мөнгөөр тооцоолж; **по безналичному ~у** дансаар *тооцоолон*; 3. *тооцоо хийж халах*, тооцоо хийж халагдах; **дать** ~ тооцоо хийж халах; **взять** ~ тооцоо хийж халагдах; 4. *бодол, бодох, санаа, тааварлал*; **по моим ~ам, он скоро должен приехать** миний бодоход тэр хүн удахгүй ирэх ёстой; **мои ~ы не оправдались** *миний бодсон* буруу болов; 5. хэрэг, ашиг тус; **нет никакого ~а ехать** явах ямар ч ашиг алга; 6. болгоомж, бодол, *хямга*; **жить с ~ом** болгоомжтой амьдрах, хямгатай амьдрах; 7. бүлэг /цэрэг/; **орудийный** ~ их бууны бүлэг; в расчёте *өр ширгүй болгоо*; **из ~а** гэж бодон, харгалзан; **принимать в** ~ харгалзах, бодолцох; **исполнитель ~ов** төлбөр тооцоо гүйцэтгэгч.

РАСЧЁТЛИВОСТЬ 1. хямгатай байх, нарийн байх; 2. болгоомжтой, бодолтой байх.

РАСЧЁТЛИВЫЙ 1. хямгатай, нарийн; 2. болгоомжтой бодолтой.

РАСЧЁТН||ЫЙ 1. тооцооны; ~**ая книжка** *тооцооны данс*; 2. тооцоот; ~**ое сопротивление** тооцооны эсэргүүцэл.

РАСЧИ́СЛИТЬ,

РАСЧИСЛЯ́ТЬ бодож гаргах, бодож хуваах.

РАСЧИ́СТИТЬ арилгах, цэвэрлэх; ~ **лес** ой цэвэрлэх.

РАСЧИСТИ́||ТЬСЯ арилах, цэлмэх, цэвэрлэгдэх, цэвэр болох; **небо ~лось от туч** тэнгэр арилав.

РАСЧИ́СТКА *арилгах*, цэвэрлэх; ~ **садовых дорожек** цэцэрлэгийн зөрөг цэвэрлэх.

РАСЧИХА́ТЬСЯ найтааж гарах.

РАСЧИЩА́ТЬ арилгах, цэвэрлэх.

РАСЧИЩА́ТЬСЯ арилах, цэлмэх, цэвэрлэгдэх, цэвэр болох.

РАСЧЛЕНЕ́НИЕ хуваах, хэсэглэх, хуваалт, хэсэглэлт.

РАСЧЛЕНИ́ТЬ,

РАСЧЛЕНЯ́ТЬ хуваах, хэсэглэх, хэсэг хэсгээр нь салгах.

РАСЧЛЕНЯ́ТЬСЯ хуваагдах, хэсэглэгдэх.

РАСЧУ́ВСТВОВАТЬСЯ уярах, сэтгэл хөдлөх.

РАСШАЛИ́ТЬСЯ дүрсгүйтэх, томоогүй *аашлах*.

РАСША́РКАТЬСЯ,

РАСША́РКИВАТЬСЯ, 1. /*өсгийгөө товшин/ мэхийн ёслох*; 2. бялдуучлан мэхэлзэх, дохигонох.

РАСША́ТАННЫЙ 1. ганхсан, холхисон, *хөдөлсөн*; 2. доройтсон, муудсан.

РАСШАТА́ТЬ 1. ганхуулах, холхиулах, *хөдөлгөх*; 2. доройтуулах, муудуулах; ~ **нервы** мэдрэл муудуулах.

РАСШАТА́||ТЬСЯ, 1. ганхах, холхих, *хөдлөх*; **зуб ~лся** шүд хөдлөв; 2. доройтох, муудах; **здоровье ~лось** бие муудав.

РАСША́ТЫВАТЬ 1. ганхуулах, холхиулах, *хөдөлгөх*; 2. доройтуулах, муудуулах.

РАСША́ТЫВАТЬСЯ 1. ганхах, холхих, *хөдлөх*; 2. доройтох, муудах.

РАСШВЫ́РИВАТЬ,

РАСШВЫРЯ́ТЬ шидэх, шидлэх, хаях, хаялах.

РАСШЕВЕ́ЛИВАТЬ,

РАСШЕВЕЛИ́ТЬ *хөдөлгөх*, сэрээх, сэргээх, идэвхжүүлэх; ~ **зрителей** үзэгчдийг сэргээх.

РАСШЕВЕЛИ́ТЬСЯ хөдлөх, сэрэх, сэргэх, идэвхжих.

РАСШИБА́ТЬ гэмтээх, хөх няц болгох.

РАСШИБА́ТЬСЯ гэмтэх, хөх няц болох.

РАСШИБИ́ТЬ гэмтээх, хөх няц болгох; ~ **ногу об камень** хөлөө чулуунд хөх няц болгох.

РАСШИБИ́ТЬСЯ гэмтэх, хөх няц болох.

РАСШИВА́ТЬ 1. ханзлах, ханз татах; 2. хатгамаллах, угалз хатгах.

РАСШИРЕ́НИЕ 1. өргөтгөх, тэлэх; ~ **границ** хил хязгаар тэлэх; 2. өргөтгөх, их болгох, олшруулах; 3. тэлэх, томрох, бүдүүрэх; ~ **желудка** ходоод тэлэх; ~ **сердца** зүрх томрох; 4. тэлэх, их болох; ~ **жидкости** шингэн бодисын тэлэх; 5. амсар хоолой; **труба с ~м** амсартай хоолой.

РАСШИ́РЕНН||ЫЙ 1. өргөтгөсөн, тэлсэн; **площадь посевов значительно расширена** тариалангийн талбайг нилээд өргөтгөсөн байна; 2. өргөтгөсөн, өргөн; ~**ое заседание** өргөтгөсөн хуралдаан; ~**ое воспроизводство** өргөтгөж нөхөн үйлдвэрлэх; 3. утгыг өргөтгөсөн, дэлгэрүүлсэн, дурааран хийсэн; ~**ое толкование чего-либо** юмны утгыг өргөтгөн тайлбарлах.

РАСШИРИ́ТЕЛЬ тэлүүр.

РАСШИ́РИТЬ 1. өргөтгөх, уудам болгох, тэлэх, уужимсгах; ~ **дорогу** зам өргөтгөх; 2. өргөтгөх, өргөжүүлэх, их болгох, олшруулах; ~ **производство** үйлдвэрлэлийг өргөтгөх; 3. ихтгэх, уудам болгох, гүнзгийрүүлэх; ~ **кругозор** мэдлэгээ гүнзгийрүүлэх.

РАСШИ́РИ||ТЬСЯ 1. өргөтөх, уудам болох, уужимсах; **овраг ~лся** жалга өргөтөв, өргөсөв; 2. өргөжих, их болох, олшрох; 3. ихтэх, уудам болох, гүнзгийрэх.

РАСШИРЯ́ТЬ 1. өргөтгөх, уудам болгох, тэлэх, уужимсгах; 2. өргөтгөх, өргөжүүлэх, их болгох, олшруулах; 3. ихтгэх, уудам болгох, гүнзгийрүүлэх.

РАСШИРЯ́ТЬСЯ 1. өргөтөх, уудам болох, уужимсах; 2. өргөжих, их болох, олшрох; 3. ихтэх, уудам болох, гүнзгийрэх.

РАСШИ́Т||ЫЙ хаттамалласан, үгалз хатгасан; **~ая рубашка** хатгамалласан цамц.

РАСШИ́ТЬ 1. ханзлах, ханз татах; 2. хатгамаллах, угалз хатгах; **~ что-либо золотом** алтан утсаар хатгамаллах.

РАСШИ́ТЬСЯ ханз үсрэх, ханзрах.

РАСШИФРОВА́ТЬ 1. /нууц түлхүүрт бичгийг/ тайлах; **~ телеграмму** цахилгаан мэдээ тайлах; 2. тайлбарлах; **как ~ его слова?** Түүний үгийг юу гэж тайлбарлах вэ?

РАСШИФРО́ВКА /нууц түлхүүрт бичиг/ тайлах, тайлбар.

РАСШИФРО́ВЫВАТЬ 1. /нууц түлхүүрт бичиг/ тайлах; 2. тайлбарлах.

РАСШНУРОВА́ТЬ оосор тайлах, уяа тайлах; **~ ботинки** гутлын оосор тайлах.

РАСШНУРОВА́ТЬСЯ оосор алдуурах, уяа тайлдах.

РАСШНУРО́ВЫВАТЬ үдээс тайлах, уяа тайлах.

РАСШНУРО́ВЫВАТЬСЯ үдээс алдуурах, уяа тайлдах.

РАСШУМЕ́ТЬСЯ шуугиан болох, шуугиан тавих.

РАСЩЕ́ДРИТЬСЯ өгөөмөрч болох, өглөгч хүн болох.

РАСЩЕ́ЛИНА 1. нарийн хавцал; 2. /модны/ ан, гав.

РАСЩЕПИ́||ТЬ 1. цуу татах, цуулах; **ударом молнии ~ло берёзу** аянга хусыг цуу ниргэв; 2. задлах, бутаргах.

РАСЩЕПИ́||ТЬСЯ 1. цуу үсрэх, цуурах; **дощечка ~лась** бяцхан банз цуу үсрэв; 2. задрах, бутрах.

РАСЩЕПЛЕ́НИЕ 1. цуу татах, цуулах; 2. задлах, задлалт, бутаргах, бутаргалт; **~ атома** атом задлах.

РАСЩЕПЛЯ́ТЬ 1. цуу татах цуулах; 2. задрах, бутрах.

РАТИФИКА́ЦИЯ батлах, батлалт.

РАТИФИЦИ́РОВАТЬ батлах; **~ договор** гэрээ батлах.

РА́ТУША хотын захиргааны байшин.

РАТЬ 1. цэрэг; 2. дайн, тулалдаан.

РА́УНД үе, раунд.

РАФИНА́Д ёотон.

РАФИНА́ДНЫЙ ёотонгийн.

РАФИНИ́РОВАНИЕ 1. тунгаах; **~ спирта** спирт тунгаах; 2. ёотон болгох, ёотон хийх.

РАФИНИ́РОВАНН||ЫЙ 1. тунгаасан, тунгаамал; **~ое масло** тунгаамал тос; 2. тансаг, нарийн.

РАФИНИ́РОВАТЬ 1. тунгаах; **~ металл** төмөрлөг тунгаах; 2. ёотон болгох, ёотон хийх; **~ сахар** элсэн чихрийг ёотон болгох.

РАХИ́Т сульдаа /өвчин/.

РАХИ́ТИК сульдаа өвчтөн.

РАХИТИ́ЧЕСКИЙ, РАХИТИ́ЧНЫЙ сульдаа өвчтөн; **~ ребёнок** сульдаа өвчтэй хүүхэд.

РАЦИО́Н хувь, рацион; **суточный ~** хоногийн хувь.

РАЦИОНАЛИЗА́ТОРСК||ИЙ оновчтой санаачлагчийн, оновчтой болгох, оновчтой; **~ое предложение** оновчтой санал; **~ие мероприятия** оновчтой арга хэмжээ.

РАЦИОНАЛИЗА́ЦИЯ оновчтой болгох явдал.

РАЦИОНАЛИЗИ́РОВАТЬ оновчтой болгох; **~ методы работы** ажлын аргыг оновчтой болгох.

РАЦИОНАЛИ́ЗМ 1. рационализм, оюуныг сурвалж болгох үзэл /хүний оюуныг мэдрэхүйгээс тусгаарлаад, танин мэдэхүйн уг сурвалж нь гагцхүү оюун мөн гэж үздэг гүн ухааны чиглэл/; 2. оюунаа шүтэх, ухаантай амьдрах, ухаантай явах.

РАЦИОНАЛИ́СТ рационалист, рационализмыг баримтлагч.

РАЦИОНАЛИСТИ́ЧЕСКИЙ рационалист, рационализмыг баримтлагч.

РАЦИОНАЛИСТИ́ЧНЫЙ оюуныг сурвалж болгосон.

РАЦИОНА́ЛЬНО зүй зохистой, оновчтой, **~ использовать** оновчтой ашиглах.

РАЦИОНА́ЛЬНОСТЬ оновчтой байх, зүй зохистой байх.

РАЦИОНА́ЛЬН||ЫЙ I оновчтой, зүй зохистой; **~ая организация производства** үйлдвэрлэлийг оновчтой зохион байгуулах; **~ое использование рабочей силы** ажлын хүчийг оновчтой ашиглах.

РАЦИОНА́ЛЬН||ЫЙ II рационал; **~ое число** рационал тоо.

РАЦИОНИ́РОВАТЬ хувь болгох, хувилах.

РА́ЦИЯ радио хороо, радио өртөө.

РАЧИ́ТЕЛЬНЫЙ хямгатай; **~ хозяин** хямгатай эзэн.

РА́ШПИЛЬ өрөвтөл.

РАЩЕ́НИЕ ургуулах; **средство для ~ волос** үс ургуулах арга хэрэглүүр.

РВАНУ́||ТЬ 1. угзрах, угз татах; **~ за руку** гараас угзрах; 2. дав хийх, ухас гэх, сэрс хийх; **лошади ~ли** морьд ухас гэв; **~л ветер** салхи сэрс хийв.

РВАНУ́ТЬСЯ дав хийх, ухасхийх; **~ вперёд** урагш ухасхийх.

РВА́Н||ЫЙ 1. уранхай, навтархай, нооронхой; **~ые сапоги** уранхай гутал; 2. хэвгүй, хэлбэргүй; **~ая рана** хэлбэргүй шарх.

РВА́||ТЬ I 1. суга татах, сугалах, ховх татах, ховхлох; **~ зуб** шүд сугалах, шүд авах; **буря ~ла деревья с корнями** шуурга ургаа модыг ховх ховх татав; 2. зулгаах, түүх; **~ траву** өвс зулгаах; 3. урах, тасдах, таслах, цуу татах, хүү татах; **~ платье** хувцас урах; **машина рвёт нитку** машин утсаа таслаад байна; 4. тэслэх; **~ динамитом что-либо** юм динамитаар тэслэх; 5. таслах, болих; **~ отношения** харилцаа таслах; 6. шархирах, хатгаж өвдөх; **рану рвёт** шарх шархирна; **~ на себе волосы** толгойтой үсээ зулгаах, цохрөнгөө барах; **~ и метать** учир зүггүй дурлах.

РВА́ТЬ II бөөлжих; **больного рвёт** өвчтөн бөөлжинө.

РВА́ТЬСЯ I 1. урагдах, тасрах, цуурах, хүүрэх, хагарах; 2. тэсрэх; **снаряды рвутся** их бууны сум тэсэрнэ.

РВА́ТЬСЯ II зүтгэх, тэмүүлэх, ухасхийх; **ребёнок рвётся к матери** хүүхэд эх рүүгээ тэмүүлнэ.

РВА́Ч завшигч, завшаач.

РВА́ЧЕСК||ИЙ завшааанч, завшаан хийх; **~ие наклонности** завшаан хайх зан.

РВА́ЧЕСТВО завшаан хайх явдал; **искоренить ~** завшаан хайх явдлыг устгах.

РВЕ́НИЕ идэвх хичээл, оролдлого зүтгэл; **с ~м приняться за работу** идэвх хичээлтэй ажиллаж эхлэх.

РВО́ТА 1. бөөлжих; 2. бөөлжис, бөөлждөс.

РВО́ТНОЕ бөөлжүүлэх эм.

РВО́ТНЫЙ бөөлжүүлэх; рвотное средство бөөлжүүлэх эм.

РДЕСТ *(бот)* усан хөрш.

РДЕТЬ улалзах, улайх.

РЕАБИЛИТА́ЦИЯ цагаатгах, цагаатгал.

РЕАБИЛИТИ́РОВАТЬ цагаатгах, цагаатгал.

РЕАБИЛИТИ́РОВАТЬСЯ цагаатах.

РЕАГИ́РОВА||ТЬ тосон хариуцах, хариуцах; **он никак не ~л на мои слова** тэр миний үгэнд огт хариуцсангүй.

РЕАКТИ́В урвалж, реактив.

РЕАКТИ́ВНОСТЬ урвал үүсгэх чанар.

РЕАКТИ́ВН||ЫЙ 1. урвал үүсгэх, урвалж болдог, урвалын; **~ые вещества** урвал үүсгэх бодис; 2. тийрэлтэт; **~ самолёт** тийрэлтэт онгоц; **~ двигатель** тийрэлтэт хөдөлгүүр.

РЕАКЦИОНЕ́Р харгис этгээд, харгис үзэлтэн.

РЕАКЦИО́ННОСТЬ харгис чанар; **~ взглядов** үзлийн харгис чанар.

РЕАКЦИО́НН||ЫЙ харгис, харгис үзэлтэй, харгис үзлийн; **~ая печать** харгис хэвлэл, харгис үзлийн хэвлэл.

РЕА́КЦИ||Я I 1. тосон хариуцах, хариуцах; 2. тэнхэлдэх, тэнхээдэх; 3. урвал; **химические ~и** химийн урвал.
РЕА́КЦИЯ II харгислал.
РЕАЛИЗА́ЦИЯ 1. биелүүлэх, биелүүлэлт; ~ **плана** төлөвлөгөө биелүүлэх; 2. борлуулах, борлуулалт; ~ **имущества** эд хогшил борлуулах.
РЕАЛИ́ЗМ I /бодит байдлыг түүний нийтлэг шинжүүдээр нь үнэн зөв дүрслэн харуулах зорилго бүхий утга зохиол, урлагийн чиглэл/.
РЕАЛИ́ЗМ II бодит байдлыг ойлгох, бодит байдлаас үндэслэх.
РЕАЛИЗОВА́ТЬ 1. биелүүлэх; ~ **все планы** бүх төлөвлөгөөг биелүүлэх; 2. борлуулах; ~ **товар** бараа борлуулах; ~ **заём** зээллэг борлуулах.
РЕАЛИЗОВА́||ТЬСЯ 1. биелэгдэх, биелэх; **все наши предложения ~лись** бидний бүх хүсэл биелэв; 2. борлох; **заём успешно ~лся** зээллэг амжилттай борлов.
РЕАЛИ́СТ I реалист, реализмыг баримтлагч.
РЕАЛИ́СТ II бодит байдлыг ойлгогч.
РЕАЛИСТИ́ЧЕСК||ИЙ I реалист, реализмыг баримталсан; **~ое направление** реалист чиглэл.
РЕАЛИСТИ́ЧЕСКИЙ II бодит байдлыг ойлгосон, бодит байдлаас үндэслэсэн.
РЕА́ЛЬНО бодитой, биелмээр.
РЕА́ЛЬНОСТЬ 1. биелэгдмээр байх, биелэхээр байх, бодитой байх; ~ **предложения** биелэхээр санал, бодитой санал; 2. бодит байдал, бодитой юм; **объективная ~ мира** ертөнцийн үнэн бодит байдал.
РЕА́ЛЬН||ЫЙ I 1. бодитой, бодит, **~ая действительность** бодит байдал; 2. биелэгдмээр, биелэхээр, бодитой; ~ **план** бодитой төлөвлөгөө; 3. бодит байдлыг тусгасан, бодит байдлаас, үндэслэсэн; **~ая заработная плата** бодит цалин.
РЕА́ЛЬНЫЙ II реальное училище /Хувьсгалын өмнө орос улс, эртний хэл заадаггүй, тооны ухаан, байгалийн ухааныг гол болгон үздэг/ дунд сургууль.
РЕБЁНОК хүүхэд; **грудной ~** хөхүүл хүүхэд.
РЁБЕРН||ЫЙ хавирганы, хавьсны; **~ые кости** хавирганы яс; **~ая плевра** хавирганы гялтан.
РЕБРО́ 1. хавирга, хавьс; **так похудел, что рёбра видны** хавиргаа хэрдийтэл турах; 2. ирмэг, хавирга, хажуу; **поставить кирпич на ~** туйпуу хавиргалуулан тавих; 3. ирмэг; **~ многогранного угла** олон талт өнцгийн ирмэг; **поставить вопрос ~м** асуудлыг эрс тавих.
РЕ́БУС таавар, оньсого.
РЕБЯ́ТА 1. хүүхдүүд, багачууд; 2. залуус, залуучууд.
РЕБЯТИ́ШКИ бяцхан хүүхдүүд, багачуул.
РЕБЯ́ЧЕСКИЙ 1. хүүхдийн; 2. гэнэн, хөнгөн, хүүхдийн; ~ **поступок** хүүхдийн явдал, гэнэн хэрэг.
РЕБЯ́ЧЕСТВО хүүхэд зан, хүүхдийн явдал; **думать так было бы ~м** ингэж бодвол хүүхдийн явдал болно.
РЕБЯ́ЧЛИ́ВЫЙ хүүхэд шиг, хүүхдийн, хүүхэд; ~ **нрав** хүүхэд ааль.
РЁВ 1. урхираан, хүрхээн, мөөрөөн; ~ **зверей** ан амьтны урхираан; 2. хашгираан, бархираан, шуугиан; 3. хүнгэнэх, шүнгэнэх; ~ **ветра** салхи шүнгэнэх; ~ **моторов** мотор хүнгэнэх; 4. нүжигнэх, нүжгэнээн; ~ **пушек** их бууны нүжгэнээн; 5. орилоон, чарлаан; **дети подняли ~** хүүхдүүд орилоон болов.
РЕВА́НШ даага, хариу, хонзон; **взять ~** даагаа нэхэх, хариугаа авах.
РЕВАНШИ́СТ хонзогногч.
РЕВАНШИ́СТСК||ИЙ хонзогногч; **~ая политика** хонзогногч бодлого.
РЕВЕ́ННЫЙ гишүүнийн; ~ **порошок** гишүүний нунтаг, талхалсан гишүүнэ.
РЕВЕ́НЬ гишүүнэ.
РЕВЕРА́НС өвдөг нуг асхийн ёслох, борви бохирон ёслох.
РЕВЕ́ТЬ 1. урхирах, хүрхрэх, мөөрөх; 2. хашгирах, бархирах, шуугих; 3. хүнгэнэх, шүнгэнэх, шүүгих, шуугих; 4. нүжгэнэх, пир пар хийх, нирхийх; 5. орилох, чарлах; **дети ревут** хүүхдүүд орилно.
РЕВИЗИОНИ́ЗМ ревизионизм, засварлах үзэл.
РЕВИЗИОНИ́СТ засварлах үзэлтэн.
РЕВИЗИОНИ́СТСКИЙ ревизионизмын, засварлах үзлийн.
РЕВИЗИО́НН||ЫЙ шалган байцаах; **~ая комиссия** шалган байцаах комисс.
РЕВИ́ЗИЯ 1. шалган байцаах, шалган байцаалт; 2. засварлах, хянах; 3. бүртгэл, шалгалт.
РЕВИЗОВА́ТЬ шалган байцаах; ~ **кассу** /байгууллагын/ мөнгөн санг шалган байцаах.
РЕВИ́ЗОР байцаагч, шалган байцаагч.
РЕВКО́М *(революционный комитет)* хувьсгалт хороо.
РЕВМАТИ́ЗМ хэрэх өвчин, шархираа /өвчин/.
РЕВМА́ТИК хэрэх өвчтэй хүн, шархираатай хүн.
РЕВМАТИ́ЧЕСКИЙ хэрэх өвчний, шархираагийн.
РЕВНИ́ВО 1. хартай, жөтөөрхөн; ~ **посмотреть на кого-либо** хүнийг жөтөөрхөн харах; 2. нуун, даран; ~ **оберегать свою работу** хийсэн юмаа нуун дарах.
РЕВНИ́ВЫЙ хартай, жөтөөрхөг, атаархуу; ~ **муж** хартай эр; ~ **взгляд** жөтөөрхөг харц.
РЕВНОВА́ТЬ хардах, жөтөөрхөх, атаархах.
РЕ́ВНОСТЬ I хар, жөтөө, атаа.
РЕ́ВНОСТЬ II идэвх оролдлого, хичээл зүтгэл, **с большой ~ю взяться за дело** их идэвх оролдлоготой ажил хэргээ эхлэх.
РЕВОЛЬВЕ́Р гар буу.
РЕВОЛЬВЕ́РНЫЙ гар бууны.
РЕВОЛЮЦИОНЕ́Р 1. хувьсгалч; 2. эргэлт гаргасан хүн, хувьсгал гаргасан хүн; ~ **в науке** шинжлэх ухаанд эргэлт гаргасан хүн.
РЕВОЛЮЦИОНЕ́РКА хувьсгалч эмэгтэй.
РЕВОЛЮЦИОНИЗИ́РОВАТЬ 1. хувьсгалжуулах, хувьсгах; 2. эргэлт гаргах, хувьсгал гаргах.
РЕВОЛЮЦИОНИЗИ́РОВАТЬСЯ 1. хувьсгалжих, хувьсах; 2. эргэлт гарах, хувьсгал гаргах.
РЕВОЛЮЦИ́ОННО-ДЕМОКРАТИ́ЧЕСКИЙ хувьсгалч ардчилсан.
РЕВОЛЮЦИО́ННОСТЬ хувьсгалч үзэл, хувьсгалт чанар.
РЕВОЛЮЦИО́НН||ЫЙ хувьсгалт, хувьсгалч, хувьсгалын; **~ая борьба** хувьсгалт тэмцэл.
РЕВОЛЮ́ЦИЯ 1. хувьсгал; **Великая Октябрьская Социалистическая Революция** Октябрийн Социалист Их Хувьсгал; 2. эргэлт, хувьсгал; **культурная ~** соёлын хувьсгал; ~ **в технике** техникт гарсан эргэлт.
РЕВТРИБУНА́Л *(революционный трибунал)* хувьсгалт онц шүүх.
РЕВЮ 1. нийгэтгэсэн үзвэр, сэдэвчилсэн үзвэр; 2. /гадаадын/ сэтгүүл.
РЕГА́ЛИЯ 1. бэлэг тэмдэг; 2. одон тэмдэг; 3. онц эрх.
РЕ́ГЕНТ /хааны оронд/ засаг баригч.
РЕ́ГЕНТСКИЙ засаг баригчийн.
РЕ́ГЕНТСТВО засаг барих. **РЕГИОНА́ЛЬНЫЙ** регионал, тив улсын; ~ **пакт** тив улсын гэрээ.
РЕГИ́СТР 1. цэс бүртгэл; 2. /авианы/ чалх; 3. /хөгжмийн зэвсгийн авианы/ өнгө солиур; 4. /бичгийн машины/ үсгийн эгнээ.

РЕГИСТРА́ТОР бүртгэгч.
РЕГИСТРА́ТОРША бүртгэгч эмэгтэй.
РЕГИСТРАТУ́РА бүртгэх газар.
РЕГИСТРАЦИО́ННЫЙ бүртгэх, бүртгэлийн; ~ **лист** бүртгэх хуудас.
РЕГИСТРА́ЦИЯ 1. бүртгэх, цэслэх, данслах, бүртгэлт; ~ **почты** шуудан бичгийг бүртгэх; 2. бүртгэх, бүртгэн батлах; ~ **делегатов** төлөөлөгчдийг бүртгэх; ~ **брака** гэрлэгсдийг бүртгэх; 3. тэмдэглэх, бүртгэх; ~ **колебаний почвы** газрын хэлбэлзэхийг тэмдэглэх.
РЕГИСТРИ́РОВАТЬ 1. бүртгэх, данслах, цэслэх, дансанд тэмдэглэх; ~ **документы** баримт бичгийг данслах; 2. бүртгэх, бүртгэн бичих, бүртгэн батлах; 3. тэмдэглэх, бүртгэх.
РЕГИСТРИ́РОВАТЬСЯ 1. бүртгүүлэх, дансанд тэмдэглүүлэх; 2. бүртгэгдэх, тэмдэглэгдэх; 3. бүртгүүлэх, бүртгүүлэн батлуулах.
РЕГЛА́МЕНТ дотоод дүрэм, **установить ~ заседания** хурлын дотоод дүрмийг тогтоох; **придерживаться ~а** дотоод дүрмийг сахих.
РЕГЛАМЕНТА́ЦИЯ дүрэм тогтоох, дүрэм тогтоолт.
РЕГЛАМЕНТИ́РОВАТЬ дүрэм тогтоох, дүрэмтэй болгох.
РЕГРЕ́СС ухралт, буурал, доройтол.
РЕГРЕССИ́ВН||ЫЙ 1. ухарсан, ухралт болсон, буурсан, доройтсон; 2. харгис, ухралт болсон, ухарсан; **~ые меры** харгис арга хэмжээ.
РЕГРЕ́ССН||ЫЙ буцааж нэхэмжлэх; **~ое требование** буцаан нэхэмжлэх шаардлага.
РЕГРЕССИ́РОВАТЬ ухрах, буурах, доройтох.
РЕГУЛИ́РОВАНИЕ 1. зохицуулах, зохицуулалт; ~ **уличного движения** гудамжны хөдөлгөөн зохицуулах; 2. тохируулах, тааруулах, тохируулалт, тааруулалт.
РЕГУЛИ́РОВАТЬ 1. зохицуулах, журамтай болгох; ~ **рыночные цены** зах зээлийн үнийг зохицуулах; 2. тохируулах, тааруулах; ~ **мотор** мотор тохируулах.
РЕГУЛИРО́ВКА 1. зохицуулах, зохицуулалт; 2. тохируулах, тохируулалт, тааруулалт.
РЕГУЛИРО́ВОЧНЫЙ зохицуулах, тохируулах.
РЕГУЛИРО́ВЩИК зохицуулагч; ~ **уличного движения** гудамжны хөдөлгөөн зохицуулагч.
РЕГУЛЯ́РНО тогтмол, байнга; **собираться ~ раз в месяц** сард тогтмол нэг удаа цугларах.
РЕГУЛЯ́РНОСТЬ тогтмол болж байх, байнга болж байх.
РЕГУЛЯ́РН||ЫЙ 1. тогтмол байнгын; **~ое лечение** тогтмол эмчлэх; 2. жинхэнэ; **~ая армия** байнгын арми.
РЕГУЛЯ́ТОР тохируул.
РЕДАКТИ́РОВАНИЕ редакторлах, хянан засах, эрхлэх, редакторлалт.
РЕДАКТИ́РОВАТЬ 1. хянан засах, редакторлах; ~ **статью** өгүүлэл хянан засах; 2. эрхлэх; ~ **журнал** сэтгүүл эрхлэх; 3. найруулах.
РЕДА́КТОР эрхлэгч, редактор; **главный ~** ерөнхий эрхлэгч; **ответственный ~** хариуцлагатай редактор.
РЕДА́КТОРСК||ИЙ эрхлэгчийн, редакторын; **~ие обязанности** эрхлэгчийн үүрэг.
РЕДАКЦИО́НН||ЫЙ 1. хянан засах, хянан тогтоох, редакторлах; **~ая работа** хянан засах ажил, редакторлах ажил; 2. /хэвлэл/ эрхлэх зөвлөл; 3. эрхлэгчийн, редакторын, эрхлэгчдийн /хэвлэл/ эрхлэх газрын; **~ые поправки** эрхлэх газрын засвар.
РЕДА́КЦ||ИЯ 1. хянан засах, редакторлах; **под ~ей** хянан зассан, редакторласан; 2. найруулах, найруулга; **новая ~ повести** туужийн шинэ найруулга, туужийг шинээр найруулах; 3. хянан тогтоох, редакторлах; 4. эрхлэгчид, редакци; **новая ~ журнала** сэтгүүлийн шинэ эрхлэгчид; 5. хэвлэлд бэлтгэгчид, хэвлэлийн тасаг; 6. /хэвлэл/ эрхлэх газар, редакци; **адрес ~и журнала** сэтгүүл эрхлэх газрын хаяг. **РЕДЕ́||ТЬ** шингэрэх, сийрэгших, ховордох, цөөрөх; **лес ~ет** ой сийрэгшиж байна.
РЕДИ́С редиска, улаан лууван.
РЕ́ДК||ИЙ 1. сийрэг, таруу, шингэн, оочин цоочин; **~ие волосы** шингэн үс; ~ **лес** сийрэг ой; 2. сиймгэр, сэржгэр; **~ая ткань** сиймгэр эд; 3. хааяа ирдэг, ховор тохиолддог, ховор, чухаг; ~ **гость** хааяа ирдэг зочин; **~ая книга** ховор ном.
РЕ́ДКО 1. сийрэг, таруу, шингэн, оочин цоочин; 2. хааяа, ховор, цөөн; ~ **писать письма** захидал хааяа бичих; ~ **встречаться** ховор уулзах.
РЕДКОЛЕ́СЬЕ сийрэг ой.
РЕДКОЛЛЕ́ГИЯ ***(редакционная коллегия)*** хэвлэл эрхлэх коллеги.
РЕ́ДКОСТНЫЙ ховор, чухаг, хааяа тохиолддог.
РЕ́ДКОСТ||Ь ховор юм, чухаг зүйл, ховор тохиолдол; **коллекция ~ей** ховор юмны цуглуулга.
РЕДУ́КЦИЯ 1. сулрах; ~ **гласных** эгшиг сулрах; ~ **давления пара** уурын даралт сулрах; 2. шилжилт /нарийн юмны хялбар болох нь/.
РЕДУ́Т хүрээ бэхлэлт.
РЕДУЦИ́РОВАНН||ЫЙ суларсан, балархайшсан, балархай; **~ый гласный** суларсан эгшиг.
РЕДУЦИ́РОВАТЬ 1. огцом болгох, агшаах; 2. сулруулах, балархайшуулах.
РЕДУЦИ́РОВАТЬСЯ 1. огцом болох, агших; 2. сулрах, балархайших.
РЕДЧА́ЙШ||ИЙ маш чухаг, их ховор **~ая книга** их ховор ном.
РЕ́ДЬК||А цагаан лууван; **надоел хуже горькой ~и** бүр залхаачихлаа, бүр залхуу хүргэлээ.
РЕЕ́СТР цэс, данс; ~ **имущества** эд хогшлын цэс.
РЕЖИ́М 1. журам, дэглэм, байгуулал; **царский ~** хаант байгуулал; **старый ~** хуучин дэглэм; **демократический ~** ардчилсан дэглэм, ардчилсан байгуулал; 2. журам, дэглэм; цагийг нь олох, тогтмол цагтай байх; **школьный ~** сургуулийн дэглэм; **правильный ~ питания** цагийг нь зөв олж хооллох; 3. ёс, журам, арга; ~ **экономии** арвилан хэмнэх ёс; **скоростной ~** резания хурдан зүсэх арга.
РЕЖИССЁР найруулагч.
РЕЖИССЁРСК||ИЙ найруулагчийн; **~ие обязанности** найруулагчийн үүрэг.
РЕЖИССИ́РОВАТЬ найруулах; ~ **спектакль** жүжиг найруулах.
РЕЖИССУ́РА 1. найруулагчийн мэргэжил; 2. найруулагчид; 3. жүжиг найруулан тавих.
РЕ́ЖУЩ||ИЙ 1. огтлох, зүсдэг; чимчигнэсэн, хатгасан; **~ая боль** чимчигнэн өвдөх.
РЕ́ЗАТЕЛЬН||ЫЙ огтлох, зүсдэг; **~ая машина** огтлох машин.
РЕ́ЗАТЬ 1. огтлох, таслах, зүсэх; ~ **сыр** бяслаг зүсэх; 2. ярах, хага зүсэх; 3. даах; **ножницы не режут** хайч юм даахгүй байна; 4. алах, гаргах, төхөөрөх, хага татах; ~ **барана** хонь гаргах; 5. сийлэх, сийлбэрлэх; ~ **по металлу** төмөрлөг сийлэх; 6. чимчигнэх, эвэршээх, хатгах, мушгих, хорсгох, холгох, ши гдэж өвтгөх; **ремень режет плечо** сур мөрөнд шигдэж өвтгөнө; 7. гялбуулах, эвгүй байх, дөжрүүлэх; **этот свет режет глаза** энэ гэрэл нүд гялбуулна; 8. шууд хэлэх, илэн далангүй хэлэх; ~ **правдой глаза** илэн далангүй хэлэх.
РЕ́ЗАТЬСЯ 1. цухуйх, гарах; **у ребёнка режутся зубы** хүүхдийн шүд цухуйж байна; 2. огтлогдох, зүсэгдэх; 3. алагдах, төхөөрөгдөх; 4. сийлэгдэх, сийлбэрлэгдэх.

РЕЗВИ́ТЬСЯ тоглох, наадах, гүйлдэх.
РЕ́ЗВОСТЬ 1. цовоо байх, хөнгөн шаламгай байх; 2. хурдан байх.
РЕ́ЗВЫЙ 1. цовоо хөнгөн шаламгай; ~ **ребёнок** цовоо хүүхэд; 2. хурдан, *сэргэлэн*; ~ **ум** *сэргэлэн ухаан*; 3. хурдан омголон; ~ **конь** омголон морь.
РЕЗЕ́РВ 1. нөөц; **~ы промышленности** үйлдвэрийн нөөц; **иметь** ~ нөөцтэй байх; 2. бэлтгэл, нөөц, бэлтгэл цэрэг; **отвести полк в** ~ хороог нөөц болгох; 3. бэлтгэл хүчин; **трудовые ~ы** хөдөлмөрийн бэлтгэл хүчин.
РЕЗЕРВИ́РОВАТЬ нөөцлөх, нөөц болгох; ~ **запасы нефти** бэлтгэл нефтийг *нөөцлөх*; ~ **своё мнение** саналаа *нөөцлөх*, саналаа хожим хэлэх эрх өөртөө үлдээх.
РЕЗЕРВИ́СТ бэлтгэл цэрэг.
РЕЗЕ́РВНЫЙ 1. бэлтгэл, сул; 2. бэлтгэл, нөөц; ~ **фонд** бэлтгэл хөмрөг.
РЕЗЕРВУА́Р нөөцлүүр /шингэн бодис буюу хий агуулах том сав/.
РЕЗЕ́Ц 1. зоруул, сийлүүр; ~ **скульптора** барималчны сийлүүр; 2. үүдэн шүд.
РЕЗИДЕ́НТ 1. төлөөний сайд; 2. гадаадын харъяат; 3. тагнуулын удирдагч.
РЕЗИДЕ́НЦИЯ өргөө.
РЕЗИ́Н||А эрзээн, сунадаг; **изделия из ~ы** эрзээнээр хийсэн эдлэл.
РЕЗИ́НК||А 1. баллуур; ~ **для карандашей** харандааны баллуур; 2. резин, эрзээн сунадаг; **подвязка из ~и** сунадаг татуурга.
РЕЗИ́НОВ||ЫЙ резинийн, эрзээнийн; резин, эрзээн; **~ые перчатки** резин бээлий.
РЕ́ЗКА зүсэх, огтлох; ~ **хлеба** талх зүсэх.
РЕ́ЗК||ИЙ 1. ширүүн, тасхийм, чанга; ~ **ветер** ширүүн салхи; ~ **мороз** тасхийм хүйтэн; 2. эрс, гэнэт; **~ое падение температуры** гэнэт хүйтрэх; 3. хурц цоргисон; ~ **запах** хамар цоргисон үнэр; 4. янгиа, хахир; ~ **звук** янгиа дуу; 5. тод, хурц; **~ие тени** тод сүүдэр; 6. сархгар; **~ие черты лица** сархгар нүүр; 7. огцом, ширүүн, эрс, хатуу; ~ **ответ** ширүүн хариу; **подвергать ~ой критике** эрс хатуу шүүмжлэх.
РЕ́ЗКО 1. эрс, гэнэт; **погода** ~ **изменилась** тэнгэр гэнэт өөр болов; 2. янгинан, хахир; **его голос прозвучал** ~ түүний хоолой янгинах сонсдов; 3. огцом, ширүүн, эрс хатуу; **он ответил** ~ тэр хүн ширүүн хариулав.
РЕ́ЗКОСТ||Ь 1. хурц байх; ~ **света** хурц гэрэл; 2. огцом зан, *ширүүн байх*, эрс хатуу байх; ~ **ответа** ширүүн хариу; 3. огцом үг, ширүүн үг; **говорить ~и** ширүүн үг хэлэх.
РЕЗНО́Й сийлмэл, сийлбэрлэсэн, цоолборлосон.
РЕЗНУ́ТЬ 1. огтолчихох, зүсчхэх; 2. хатгах, час гэх; 3. цохичих.
РЕЗНЯ́ алаан хядаан, алалдаан.
РЕЗОЛЮТИ́ВНЫЙ дүгнэлт бүхий, дүгнэсэн тогтоолын.
РЕЗОЛЮ́ЦИ||Я 1. тогтоол; **принять ~ю** тогтоол батлах; тогтоол гаргах; 2. цохолт, *цохдос*; **наложить ~ю** цохох.
РЕЗО́Н учир зүй, учир; **в этом есть свой** ~ үүнд учир бий.
РЕЗОНА́НС 1. цуурай; 2. сонсдохуй, сонсдох; **в этом зале плохой** ~ энэ юм муу сонсогддог танхим; 3. нөлөөтөхүй, нөлөөлөх; 4. цуурай, сэтгэгдэл.
РЕЗОНА́ТОР цууриалуур.
РЕЗОНЁР цэцэрхэгч, сургагч.
РЕЗОНЁРСКИЙ цэцэрхсэн, сургах; ~ **тон** сургах маяг.
РЕЗОНИ́РОВАТЬ цууриатах.
РЕЗО́НН||ЫЙ зүйтэй, учирзүй бүхий; **~ое объяснение** зүйтэй тайлбар.
РЕЗУЛЬТА́Т үр дүн, үр дүн; ~ **конкурса** уралдааны дүн; **прекрасный ~ работы** ажлын сайхан үр дүн; **в ~е** эцэст, үр дүнд.
РЕЗУЛЬТАТИ́ВНЫЙ үр болох, үр дүн болох, үртэй, дүнтэй.
РЕ́ЗЧИК 1. сийлбэрч; 2. зүсэгч, огтлогч; ~ **бумаги** цаас зүсэгч.
РЕ́ЗЬ мушгих; мушгилах; ~ **в животе** гэдэс мушгилах.
РЕЗЬБ||А́ 1. сийлэх, сийлбэр; **специалист по художественной ~е** уран сийлбэрийн мэргэжилтэн; 2. сийлбэр; **красивая** ~ сайхан сийлбэр; 3. эргээс.
РЕЗЮМЕ́ товчоо, товч, товч дүн; ~ **статьи** өгүүллийн товчоо, өгүүллийн товч.
РЕЗЮМИ́РОВАТЬ товчлох, товч дүгнэх; ~ **прения** санал шүүмжлэлийг товч дүгнэх.
РЕЙД I онгоцны зогсоол.
РЕЙД II 1. дайсны ар талд цөмрөн орох, уулгалах; **кавалерийский** ~ морин цэрэг уулгалах; 2. гэнэт шалган байцаах.
РЕ́ЙКА 1. нарийн банз; 2. (банзан) шугам.
РЕЙС рейс, нислэг; **совершить** ~ рейс хийх; **обратный** ~ буцах рейс, ирэх рейс.
РЕ́ЙСОВЫЙ рейсийн; ~ **самолёт** рейсийн нисэх онгоц.
РЕЙСФЕ́ДЕР рейсфедер, шугам зургийн багаж.
РЕЙСШИ́НА рейсшина,нэг үзүүртээ хөндөлтэй шугам зургийн урт шугам.
РЕЙТУ́ЗЫ бариу өмд, нарийн өмд.
РЕЙХСТА́Г рейхстаг /1945 он хүртэл байсан Германы *парламент, мөнхүү парламентын байшин*/.
РЕК||А́ 1. гол, мөрөн, ус; **берега ~и** голын эрэг, мөрний эрэг; **вниз по ~е** гол урууда; **вверх по ~е** гол өгсөн; 2. мөрөн, далай; **~и крови** цусан мөрөн, цусан далай.
РЕКВИЗИ́РОВАТЬ улсын болгох, албанд авах.
РЕКВИЗИ́ЦИЯ улсын болгох, албадан авах.
РЕКЛА́М||А 1. зарлал, реклам; **театральная** ~ театрын зарлал; 2. зар, тунхаг; **устроить ~у книге** номын тухай зар гаргах.
РЕКЛАМА́ЦИЯ гомдлын шаардлага.
РЕКЛАМИ́РОВАТЬ 1. зарлах, зар гаргах, тунхаглах; 2. магтан зар тараах.
РЕКЛА́МНЫЙ зарлалын, зарын, рекламын.
РЕКЛАМИ́СТ реклам зохиогч.
РЕКЛАМИ́СТКА реклам зохиогч эмэгтэй.
РЕКОГНОСЦИ́РОВАТЬ 1. тагнаж мэдэх, тагнан судлах; ~ **расположение противника** дайсны байрласан газрыг тагнаж мэдэх; 2. *урьдчилан шинжлэх, хайгуулчлан шинжлэх*; ~ **местность** газрыг урьдчилан шинжлэх.
РЕКОГНОСЦИРО́ВК||А 1. тагнан мэдэх, тагнуул; 2. урьдчилан шинжлэх, урьдчилсан шинжилгээ; **вернуться из ~и** урьдчилан шинжлээд эргэх.
РЕКОГНОСЦИРО́ВОЧНЫЙ 1. тагнан мэдэх, тагнан судлах; 2. урьдчилан шинжлэх.
РЕКОМЕНДА́ТЕЛЬН||ЫЙ 1. сайшаан зөвлөсөн, *сайшаасан*, зуучлах; **~ое письмо** сайшаасан захидал, зуучлах бичиг; 2. зөвлөсөн, санаа авахуулах; ~ **список литературы** санаа авахуулах зохиолын цэс, уншууштай номын цэс.
РЕКОМЕНДА́ЦИ||Я 1. сайшаах, сайшаан зөвлөх, зуучлах; 2. /сайшаасан/ үнэлэлт, сайшаасан бичиг, зуучлах захидал; **дать ~ю** үнэлэлт өгөх, зуучлах бичиг өгөх.
РЕКОМЕНДОВА́ТЬ 1. сайшаах, сайшаан зөвлөх, зуучлах, гэрчлэх; ~ **опытного работника** туршлагатай ажилтныг зуучлах; **это его плохо рекомендует** энэ нь түүний муу хүнийг гэрчилнэ; 2. зөвлөх, гэх; 3. нэрийг нь дурдаж танилцуулах.
РЕКОМЕНДОВА́ТЬСЯ 1. зуучлуулах, сайшаалгах, сайшаах, зөвлөх; 2. нэрээ дурдаж танилцах.

РЕКОНСТРУ́ИРОВАТЬ шинэчлэх, сэлбэн байгуулах.
РЕКОНСТРУ́ИРОВАТЬСЯ шинэчлэгдэх, сэлбэн байгуулагдах.
РЕКОНСТРУКТИ́ВНЫЙ шинэчлэх, сэлбэн байгуулах; ~ **период** сэлбэн байгуулах үе.
РЕКОНСТРУ́КЦИЯ шинэчлэх, сэлбэн байгуулах, шинэчлэл, сэлбэн байгуулалт.
РЕКО́РД 1. аварга /амжилт/, рекорд; поставить рекорд аварга амжилт гаргах; **побить** ~ аварга шалгарах; **мировой** ~ дэлхийд аварга амжилт; 2. дээд зэргийн амжилт.
РЕКО́РДН||ЫЙ аварга, дээд зэргийн рекорд; **~ые достижения** аварга ололт.
РЕКОРДСМЕ́Н аварга, рекордлогч.
РЕКОРДСМЕ́НКА аварга эмэгтэй, рекордлогч эмэгтэй.
РЕ́КРУТ шинэ цэрэг.
РЕКРУТИ́РОВАТЬ 1. шинэ цэрэгт татах; 2. элсүүлэх, татах, оруулах; ~ **сторонников** талдаа хүн элсүүлэх.
РЕКРУТИ́РОВАТЬСЯ татагдах, элсэх.
РЕ́КРУТСКИЙ шинэ цэргийн; ~ **набор** шинэ цэрэг татлага.
РЕ́КТОР ректор, захирал; ~ **университета** их сургуулийн захирал.
РЕКТОРА́Т ректорын газар, захирах газар.
РЕ́КТОРСКИЙ ректорын, захирлын.
РЕЛИГИО́ЗНОСТЬ сүсэг, сүсэг бишрэл, сүсэгтэй байх.
РЕЛИГИО́ЗНЫЙ 1. шашны; ~ **дурман** шашны мунхруулах суртал; 2. сүсэгтэй, сүсэг бишрэлтэй; ~ **человек** сүсэгтэй хүн, сүсэгтэн.
РЕЛИ́КТОВЫЙ эртний үлдэс болсон.
РЕЛЬЕ́Ф 1. хотгор гүдгэр, гадаргуу; **горный** ~ **местности** уулархаг гадаргуутай газар, уулархаг газар; 2. товгор юм, товойлгон хийсэн зүйл; **глобус с ~ами** товойлгон хийсэн бөмбөрцөг.
РЕЛЬЕ́ФНО 1. товгор, товойлгон; 2. тод, хурц.
РЕЛЬЕ́ФНОСТЬ 1. товгор байх; 2. тод байх.
РЕЛЬЕ́ФН||ЫЙ 1. товгор, товойлгон хийсэн; **~ые буквы** товгор үсэг; 2. тод, тодорхой, хурц.
РЕ́ЛЬС зам төмөр; **поставить на ~ы что-либо** замд нь оруулах, бүтэмжтэй болгох.
РЕ́ЛЬСОВ||ЫЙ зам төмрийн, зам төмөртэй, төмөр; **~ый путь** төмөр зам; **~ая цепь** зам төмрийн хэлхээ.
РЕЛЬСОПРОКА́ТНЫЙ зам төмөр цувих, зам төмөр хийх.
РЕМА́РКА 1. тэмдэглэл; 2. анхааруулал, жич тэмдэглэх.
РЕМЕ́ННЫЙ суран; ~ **кнут** суран ташуур.
РЕМЕ́НЬ 1. сур, оосор, тасам; **поясной** ~ суран бүс; ~ **для правки бритв** нийлүүр; ~ **для кнута** ташуурын сур; 2. суран бүс, тэлээ.
РЕМЕ́СЛЕННИК I 1. уран дархан, гар урлалч, гар урч; 2. бааз дархан, борог бүдүүн хийгч.
РЕМЕ́СЛЕННИК II уран дархны сургуулийн сурагч.
РЕМЕ́СЛЕННИЧАТЬ 1. дархлах, дарх хийх; 2. борог хийх, бааз бүдүүн хийх.
РЕМЕ́СЛЕННИЧЕСКИЙ бүдүүн, бааз бүдүүн, хадуун.
РЕМЕ́СЛЕННИЧЕСТВО 1. дархлах, дарх хийх; 2. борог хийх, бүдүүн хадуун хийх.
РЕМЕ́СЛЕНН||ЫЙ уран дархны; **~ое училище** уран дархны сургууль.
РЕМЕСЛО́ дарх, гар ур, ажил; **столярное** ~ модны дарх; **заниматься каким-либо ~м** ямар нэгэн ажил хийх.
РЕМЕШО́К нарийхан сур, оосор.
РЕМИЛИТАРИЗА́ЦИЯ дахин цэрэгжүүлэх, дахин цэрэгжүүлэлт.
РЕМИЛИТАРИЗОВА́ТЬ дахин цэрэгжүүлэх.
РЕМИНИСЦЕ́НЦИЯ 1. бүрэг бараг санах, бүүр түүр санах; 2. санамсаргүй дууриах, санамсаргүй нөлөө.
РЕМО́НТ 1. засвар, сэлбэлэг, засварлах, сэлбэх; ~ **обуви** гутал сэлбэх; **капитальный** ~ их засвар; **текущий** ~ ээлжийн засвар; 2. төлжүүлэх, төлөөр нөхөх; 3. агт сэлбэх.
РЕМОНТИ́РОВАТЬ засварлах, сэлбэх, засах; ~ **квартиру** байр засварлах; ~ **судно** хөлөг онгоц засварлах.
РЕМО́НТН||ЫЙ засварын, засварлах, сэлбэх, засах; **~ая мастерская** засварын газар; **~ые работы** засварлах ажил.
РЕНЕГА́Т урвагч, тэрс бологч.
РЕНЕГА́ТСТВО урвах, тэрс болох, урвалт.
РЕНЕССА́НС сэргэн мандах, сэргэн мандалт.
РЕ́НТА рент, түрээс /эзэн нь ямар ч ажил эрхэлдэггүй, капитал, эд хогшил, газрын орлого/; **земельная** ~ газрын рент.
РЕНТА́БЕЛЬНОСТЬ ашигтай байх.
РЕНТА́БЕЛЬН||ЫЙ ашигтай; **~ое хозяйство** ашигтай аж ахуй.
РЕНТГЕ́Н 1. рентген, рентгений гэрэл, рентгений цацраг; 2. рентгенээр харах; **назначить больного на** ~ өвчтөнийг рентгенээр харуулах.
РЕНТГЕНИЗИ́РОВАТЬ 1. рентгенээр харах; 2. рентгенээр эмнэх.
РЕНТГЕ́НОВСКИЙ рентгений, рентгентэй, рентген; ~ **кабинет** рентген тасаг.
РЕНТГЕНОГРА́ММА рентген зураг.
РЕНТГЕНОГРА́ФИЯ 1. рентген зүй */рентгений цацрагаар судалгаа хийх аргын тухай ухаан/*; 2. рентген зураг авах.
РЕНТГЕНО́ЛОГ рентген судлагч.
РЕНТГЕНОЛОГИ́ЧЕСКИЙ рентген судлалын.
РЕНТГЕНОЛО́ГИЯ рентген судлал.
РЕНТГЕНОСКОПИ́ЧЕСКИЙ рентгенээр харж шинжлэх, рентгенээр харж судалсан.
РЕНТГЕНОСКОПИ́Я рентгенээр харж судлах.
РЕНТГЕНОТЕРАПИ́Я рентгенээр эмнэх.
РЕОРГАНИЗАЦИО́ННЫЙ шинэтгэн байгуулах, өөрчлөн байгуулах; ~ **период** шинэтгэн байгуулах үе.
РЕОРГАНИЗА́ЦИЯ шинэтгэн байгуулах, шинэтгэн байгуулалт, өөрчлөн байгуулах, өөрчлөн байгуулалт; ~ **юридического лица** хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах.
РЕОРГАНИЗОВА́ТЬ, РЕОРГАНИЗО́ВЫВАТЬ шинэтгэн байгуулах, өөрчлөн байгуулах.
РЕ́ПА сармаг, лууван.
РЕПАРА́ЦИЯ дайны төлбөр.
РЕПАРАЦИО́ННЫЙ дайны төлбөрийн; ~ **фонд** дайны төлбөрийн хөмрөг.
РЕПАТРИА́НТ нутагтаа буцсан хүн.
РЕПАТРИА́ЦИЯ нутагт нь буцаах, буцаалт.
РЕПАТРИИ́РОВАТЬ нутагт нь буцаах.
РЕПАТРИИ́РОВАТЬСЯ нутагтаа буцах.
РЕПЕ́ЙНИК лошго.
РЕПЕРТУА́Р 1. жүжгийн нөөц, репертуар, **классический** ~ сонгодог жүжгийн нөөц; 2. дуу хөгжмийн нөөц, репертуар; 3. нөөц.
РЕПЕРТУА́РНЫЙ жүжгийн нөөцийн, дуу хөгжмийн нөөцийн, репертуарын.
РЕПЕТИ́РОВАТЬ 1. давтах, сургуулилах; ~ **пьесу** жүжиг сургуулилах; 2. давтуулах, давтлага хийлгэх.
РЕПЕТИ́ТОР давтуулагч, сургагч багш.
РЕПЕТИЦИО́ННЫЙ давтах, сургуулилах; ~ **зал** сургуулилах танхим.
РЕПЕТИ́ЦИЯ 1. /жүжгийн/ сургууль, давтлага, давтах, сургуулилах; **генеральная** ~ эцсийн давтлага, эцсийн удаа сургуулилах; 2. бэлтгэл, урьдатгал.

РЕ́ПЛИК||А эсэргүүцсэн үг, хариу үг, сөрөг үг, хажууны үг; **~и с мест** сонсогчдоос хэлсэн сөрөг үг; **подать ~у** сөрөг үг хэлэх.
РЕПОРТА́Ж 1. мэдээ сурвалжлага; 2. мэдээ сурвалжлагчийн ажил.
РЕПОРТЁР мэдээ сурвалжлагч.
РЕПОРТЁРСК||ИЙ мэдээ сурвалжлагчийн; **~ая заметка** мэдээ сурвалжлагчийн тэмдэглэл.
РЕПРЕССИ́ВН||ЫЙ залхаалын, залхаах, хавчлагын, хавчих; **~ые меры** залхаах арга хэмжээ.
РЕПРЕ́ССИЯ залхаал, хавчлага.
РЕПРОДУ́КТОР чанга дугарагч, репродуктор.
РЕПРОДУКЦИО́НН||ЫЙ буулгаварлах, хуулбарлах, буулгаварын, хуулбарын; **~ая мастерская** буулгаварлах газар, хуулбарлах газар.
РЕПРОДУ́КЦИЯ 1. буулгаварлах, хуулбарлах */гэрэл зураг авах, хэвлэх зэрэг арга хэрэглэн аливаа зургийг буулгаж олон болгох/*; 2. хуулбар зураг, буулгавар зураг.
РЕПУТА́ЦИ||Я нэр алдар, нэр, алдар; **незапятнанная ~** хиргүй нэр алдар; **пользоваться плохой ~ей** муу нэртэй байх.
РЕСНИ́ТЧАТЫЙ сормуусархуу үстэй.
РЕСНИ́Ц||А сормуус; **густые ~ы** өтгөн сормуус.
РЕСНИ́ЧКА 1. бяцхан сормуус, сормуусхан; 2. сормуусархуу үс.
РЕСНИ́ЧНЫЙ 1. сормуусны; 2. сормуусархуу үстэй.
РЕСПЕКТА́БЕЛЬНОСТЬ намба.
РЕСПЕКТА́БЕЛЬНЫЙ намбатай; **~ вид** намбатай байдал.
РЕСПИРА́ТОР амьсгалуур.
РЕСПУ́БЛИКА бүгд найрамдах улс; **Монгольская Народная Республика** Бүгд Найрамдах Монгол Ард Улс.
РЕСПУБЛИКА́НЕЦ бүгд найрамдах үзэлтэн.
РЕСПУБЛИКА́НСКИЙ бүгд найрамдах улсын, бүгд найрамдах.
РЕССО́РА нум; **на ~х** нумтай.
РЕССО́РНЫЙ нумтай.
РЕСТАВРА́ТОР 1. *сэлбэн шинэтгэгч, шинэтгэгч*; **художник-~** шинэтгэгч зураач; 2. хуучныг сэргээгч, харгис сэргээгч.
РЕСТАВРА́ЦИ||Я 1. сэлбэн шинэтгэх шинэтгэх; **~ картины** зургийг шинэтгэх; 2. сэлбэн шинэтгэсэн зүйл, шинэтгэсэн юм; **эта статуя является ~ей** энэ шинэтгэсэн хөшөө юм; 3. хуучныг сэргээх, сэргээн босгох.
РЕСТАВРИ́РОВАТЬ 1. сэлбэн шинэтгэх, шинэтгэх; **~ картину** зураг сэлбэн шинэтгэх; 2. хуучныг сэргээх, сэргээн босгох.
РЕСТОРА́Н зоогийн газар, ресторан.
РЕСТОРА́ННЫЙ зоогийн газрын, ресторан.
РЕСУ́РС 1. баялаг, сан; 2. арга; **последний ~** эцсийн арга.
РЕТИ́ВОСТЬ идэвх зүтгэл, оролдлого.
РЕТИ́ВЫЙ 1. идэвх зүтгэлтэй, оролдлоготой; 2. хөөрүү, долгин, цовоо; **~ конь** долгин морь, хөөрүү морь.
РЕТИРОВА́ТЬСЯ ухран зайлах, ухрах.
РЕТРОСПЕКТИ́ВНЫЙ гэдрэг үзэх, өнгөрсөн тийш хандсан; **~ взгляд** өнгөрсөн тийш хандсан үзэл.
РЕТУШЁР зураг тодруулагч.
РЕТУШИ́РОВАНИЕ зураг тодруулах, тодруулалт.
РЕТУШИ́РОВАТЬ зураг тодруулах, тодруулан засах.
РЕ́ТУШЬ зураг тодруулалт.
РЕФЕРЕ́НДУМ бүх нийтийн санал хураалт
РЕФЕРА́Т 1. товчилсон илтгэл, реферат; 2. товчлол
РЕФЕРЕ́НТ референт, илтгэн зөвлөгч.
РЕФЕРИ́РОВАТЬ товчлох, товчлон бичих.
РЕФЛЕ́КС 1. рефлекс, тусгал; **безусловный ~** болзолгүй рефлекс, болзолгүй тусгал; **условный ~** болзолт рефлекс, болзолт тусгал; 2. тусгал, үр; 3. туяа тусах.
РЕФЛЕКСИ́Я 1. туяа ойх, ойлго; 2. бодол болох, эргэцүүлэн бодох.
РЕФЛЕ́КТОР 1. *толин дуран*; 2. ээлүүр.
РЕФО́РМА шинэтгэл, реформ; **денежная ~** мөнгөний шинэтгэл, мөнгөний реформ; **земельная ~** газрын шинэтгэл, газрын реформ.
РЕФОРМА́ТОР шинэтгэгч, реформач.
РЕФОРМА́ТОРСКИЙ шинэтгэгчийн, реформачийн, шинэтгэгч, реформач.
РЕФОРМА́ЦИЯ реформаци /Баруун Европод; 16-р зууны үед католик шашин, папын засгийг эсэргүүцэн, шашны тэмцлийн хэлбэрээр гарч феодалын ёсыг эсэргүүцсэн нийгэм улс төрийн хөдөлгөөн/
РЕФОРМИ́ЗМ реформизм.
РЕФОРМИ́РОВАТЬ шинэтгэл хийх, шинэтгэх, реформалах, шинэчлэх.
РЕФОРМИ́СТСКИЙ реформист, реформизмыг баримтлагч.
РЕХНУ́ТЬСЯ солиорох, галзуурах, өвчин тусах.
РЕЦЕНЗЕ́НТ шүүмжич, шүүмж бичигч.
РЕЦЕНЗИ́РОВАТЬ шүүмж бичих; **~ статью** өгүүллийн шүүмж бичих.
РЕЦЕ́НЗИЯ шүүмж.
РЕЦЕ́ПТ 1. жор; **написать ~** жор бичих; 2. арга барил, заавар, жор.
РЕЦЕПТУ́РА жор судлал.
РЕЦИДИ́В 1. *дахих, дахин гарах*; 2. *дахих, дахин өвдөх*; **~ болезни** өвчин дахих; 3. дахин хэрэг үйлдэх, дахин ял хийх; **~ кражи** дахин хулгай хийх.
РЕЦИДИВИ́СТ дахин хэрэг үйлдэгч, дахин хэрэг хийгч; **вор-~** дахин хулгай хийгч, дахин хулгайлагч.
РЕЧЕВО́Й өгүүлэх, ярих; **~ аппарат** өгүүлэх эрхтэн.
РЕЧИ́СТЫЙ хэлэмгий, аманцар, яриа.
РЕЧИТАТИ́В ярилцах дуу.
РЕЧИТАТИ́ВНЫЙ ярилцах дууны.
РЕ́ЧКА бяцхан гол, горхи.
РЕЧН||О́Й голын, мөрний, горхины, усны; **~ берег** голын эрэг, усны хөвөө; **~ое судно** мөрний хөлөг онгоц.
РЕ́Ч||Ь 1. өгүүлэх, ярих; **органы ~и** өгүүлэх эрхтэн; **дар ~и** ярих чадвар, ярих авъяас, уран ярих; 2. үг хэл, хэл найруулга, найруулга, хэл; **стихотворная ~** шүлгийн үг найруулга; **устная ~** аман хэл; 3. яриа, хөөрөлдөөн; **о чём идёт ~?** Юуны тухай яриа болж байна? Юун тухай ярьж байна?; **об этом не может быть и ~и** үүн тухай яриа ч байж болохгүй, үүний тухай ярьсны ч хэрэггүй; 4. үг, хэлсэн үг; **выступить с ~ью** үг хэлэх; **части ~и** үгсийн аймаг.
РЕША́ТЬ 1. шийдэх, болох, тогтоох; 2. шийдвэрлэх, тогтоох, шийдвэр гаргах, тогтоол гаргах; 3. бодох.
РЕША́ТЬСЯ 1. шийдэх, тогтох, зүрхлэх; 2. шийдэх, шийдвэр гарах.
РЕША́ЮШ||ИЙ шийдвэрлэх, таслах, хамгийн чухал, гол; **~ голос** таслах эрх; **~ее условие** хамгийн чухал нөхцөл.
РЕШЕ́НИ||Е 1. бодох; биться над решением задачи бодлого бодож ядах; 2. шийдвэрлэх, шийдэх; **~ срочных вопросов** яаралтай асуудлыг шийдвэрлэх; 3. шийдвэр, тогтоол; **~ суда** шүүхийн шийдвэр; 4. шийдэх, тогтох; **я пришёл к ~ю уехать** би явахаар шийдлээ.
РЕШЁННЫЙ шийдсэн, шийдвэрлэсэн, тогтсон; **значит, решено** за, шийдлээ; **этот вопрос уже ~** энэ нэгэнт шийдсэн асуудал.
РЕШЁТК||А хайс, сараалж; **железная ~** төмөр сараалж; **садовая ~** цэцэрлэгийн хайс; **за ~ой** хар гэрт.
РЕШЕТО́ шигшүүр, элхэг, шүүр; **сеять сквозь ~** шигшүүрээр шигших; **носить воду ~м** ёроолгүй саваар ус зөөх.

РЕШЁТЧАТЫЙ,
РЕШЁТЧАТЫЙ хайсан, сараалжин, ханан, элхэг; ~ **забор** сараалжин хашаа.
РЕШИ́МОСТ||Ь зориг, зүрх, шийдвэр; **проявлять** ~ зориг гаргах; зүрх гаргах; **полный ~и** шийдвэр төгс.
РЕШИ́ТЕЛЬНО 1. зоригтой, зүрхтэй шийдэмгий; **действовать** ~ шийдэмгий хийх; 2. эрс, эрс тас, шийдвэртэй, шууд; ~ **потребовать** шийдвэртэй шаардах; 3. огт, бүр, тас; **я** ~ **ничего не понимаю** би ор тас ойлгохгүй байна; 4. хоцролгүй, бүрэн; ~ **каждый** хүн бүр хоцролгүй.
РЕШИ́ТЕЛЬНОСТЬ эрс шийдвэртэй байх, шийдэмгий зан.
РЕШИ́ТЕЛЬН||ЫЙ 1. шийдэмгий, эрс шууд, зоригтой, зүрхтэй; ~ **характер** шийдэмгий зан; 2. эрс шийдвэртэй, эрс; **заявить** ~ **протест** эрс шийдвэртэй эсэргүүцэл илэрхийлэх; 3. шийдвэртэй, эрс тас, эрс шууд; ~ **ответ** эрс тас хариу; 4. эрс, эрс хатуу; **принять ~ые меры** эрс хатуу арга хэмжээ авах; 5. шийдвэрлэх, нэгэн тийш болгох, хамгийн чухал; **~ая борьба** шийдвэрлэх тэмцэл.
РЕШИ́||ТЬ 1. шийдэх, болох, тогтох; **~л остаться дома** гэртээ хоцрохоор шийдэв; 2. шийдвэрлэх, тогтох, шийдвэр гаргах, тогтоол гаргах; 3. бодох; ~ **задачу** бодлого бодох.
РЕШИ́||ТЬСЯ 1. шийдэх; тогтох, зүрхлэх; **~лся ехать** явахаар шийдэв; 2. шийдэх, шийдвэр гаргах; **спор ~лся в нашу пользу** маргааныг бидний зөв гэж шийджээ.
РЕ́ШКА буруу тал, тоотой тал, сүлдгүй тал.
РЕЭВАКУАЦИО́ННЫЙ нүүлгэн буцаах.
РЕЭВАКУА́ЦИЯ нүүлгэн буцаах, нүүлгэн буцаалт.
РЕЭВАКУИ́РОВАТЬ нүүлгэн буцаах.
РЕЭВАКУИ́РОВАТЬСЯ нүүн буцах.
РЕ́ЯТЬ 1. халих, элэх, элэн дэвэх; ~ **в вышине** тэнгэрийн оройд элэх; 2. намалзах, намирах, далбалзах; **реют знамёна** туг намирна.
РЖАВЕ́||ТЬ зэврэх, зэв болох; **железо ~ет** төмөр зэвэрнэ.
РЖА́ВЧИН||А 1. зэв; **изъедены ~ой** зэвд идэгдсэн; 2. /усны/ өрөм.
РЖА́В||ЫЙ 1. зэвтэй, зэвэрсэн, зэвийн; ~ **гвоздь** зэвэрсэн хадаас; 2. өрөмтсөн; **~ая вода** өрөмтсөн ус.
РЖА́НИЕ янцгаах, унгалдах.
РЖАНО́Й хөх тарианы, хар; ~ **колос** хөх тарианы түрүү.
РЖАТЬ янцгаах, унгалдах, янцгаалах.
РИ́ГА хадсан тариа хатаах саравч, тариа хатаагуур.
РИДИКЮ́ЛЬ эмэгтэй хүний цүнх.
РИ́ЗА занч.
РИКОШЕ́Т1. ойлт; ойх; **пуля попала в него ~ом** сум ойж түүнийг онов; 2. хүний төлөө, хоморгонд.
РИ́КША рикша, дугуйт зөөвөрчин, хүн тэрэгчин.
РИНГ тэмцээний давцан, дэвжээ.
РИ́НУТЬСЯ гүйн орох; дайран орох; ~ **в бой** тулалдаанд дайран орох.
РИС тутрага; цагаан будаа.
РИСК 1. аюул; **с ~ом для жизни** аминдаа аюултайгаар; амь өрөн; 2. аз үзэх, аз турших; **на свой страх и** ~ хамаг хариуцлагыг нь биедээ хүлээн, өөрөө даан; 3. эрсдэл.
РИСКНУ́||ТЬ үзээд алдах, үзэх, туршаад үзэх; **~л спросить** асуугаад үзэв.
РИСКО́ВАННОСТЬ аюултай байх; аюул тохиолдлоор байх.
РИСКО́ВАНН||ЫЙ 1. аюултай, аюул тохиолдмоор; ~ **поступок** аюул тохиолдмоор явдал; 2. аягүй, зохимжгүй; **~ое выражение** аягүй үг; 3. эрсдэлтэй.
РИСКОВА́ТЬ 1. аз үзэх, аз турших, зүрх гаргах; 2. хайргүй явах, хамаагүй явах, /амь/ өрөх; ~ **жизнью** амь хамаагүй явах, амь өрөх; 3. завдах, гэх; **вы рискуете опоздать** та хоцдох гэж байна шүү.
РИСОВА́ЛЬЩИК /гар/ зурагч.
РИСОВА́НИ||Е зурах, зураг; **учиться ~ю** зураг зурж сурах; **учитель ~я** зургийн багш.
РИСОВА́ТЬ 1. зурах, зураг зурах; ~ **карандашом** харандаагаар зурах; 2. дүрслэн өгүүлэх, дүрслэн бичих; ~ **что-либо в ярких красках** юмыг гоё сайхан дүрслэн өгүүлэх.
РИСОВА́||ТЬСЯ 1. харагдах, үзэгдэх; **вдали ~лись очертания гор** алсад уулсын бараа харагдав; 2. шиг санагдах; 3. маяглах, маяг гаргах; **он слишком рисуется** тэр /хүн/ хэтэрхий маяглана.
РИСО́ВКА маяг гаргах, маяглах.
РИ́СОВЫЙ тутраган, цагаан будаан, тутраганы, цагаан будааны, тутрагатай, цагаан будаатай; ~ **отвар** тутрагын зутан; рисовый суп цагаан будаатай шөл; ~ **пудинг** бэрээсий.
РИСУ́НОК /гар/ зураг, **акварельный** ~ усан будгийн зураг.
РИТМ хэмнэл, нугалбар; ~ **стиха** шүлгийн хэмлэл; ~ **танца** бүжгийн нугалбар.
РИ́ТМИКА 1. хэмнэлийн тогтолцоо, хэмлэл зүй; 2. хэмнэл зүй, хэмнэлийн тухай сургаал; 3. хэмнэлт гимнастик.
РИТМИ́ЧЕСК||ИЙ хэмлэлт, хэмнэлттэй; нугалбар; нугалбартай, жигд; **~ое движение** хэмнэлт хөдөлгөөн.
РИТМИ́ЧНО хэмнэлтэй; нугалбартай, жигд.
РИТМИ́ЧНОСТЬ хэмнэлтэй байх, нугалбартай байх, жигд байх; ~ **движений** хэмнэлтэй хөдөлгөөн.
РИТМИ́ЧНЫЙ хэмнэлт; нугалбартай, жигд.
РИТО́РИКА 1. яруу илтгэх зүй; 2. гоёмсог үг, хоосон гоё үг.
РИТОРИ́ЧЕСКИЙ 1. яруу илтгэх зүйн, яруу илтгэх зүйд нийлсэн; 2. яруу илтгэх, яруу илтгэгчийн; ~ **приём** яруу илтгэх арга барил; 3. гоёмсог, гоёрхог, хоосон гоё.
РИТОРИ́ЧНЫЙ гоёрхог, хэтэрхий гоёмсог.
РИТУА́Л 1. ёслол, мөргөл ёслол; ритуал погребения хүн оршуулах ёслол; 2. ёслол, журам ёслол; ~ **приёма послов** элчин сайдыг бараалхуулах ёслол, хүлээн авах ёслол.
РИТУА́ЛЬН||ЫЙ ёслолын, оршуулгын ёслолын; **~ые услуги** буяны үйлчилгээ.
РИФ /усан доорхи/ хад; **коралловые ~ы** шүрэн хад.
РИФЛЕ́НИЕ биржгэр болгох, биржийлгэх.
РИФЛЁН||ЫЙ биржгэр болгосон, арласан, биржийлгэсэн; **~ое железо** биржгэр болгосон төмөр.
РИ́ФМА /шүлгийн/ холбоц, сүүл холбох; **мужская** ~ эр холбоц /эцсийнхээ үед өргөлттэй/; **женская** ~ эм холбоц /сүүлээсээ хоёрдахь үед өргөлттэй/.
РИФМО́ВАНН||ЫЙ холбоцтой, сүүл холбосон; **~ые стихи** холбоцтой шүлэг, сүүл холбосон шүлэг.
РИФМОВА́ТЬ 1. холбоц таарах, холбоцтой болох; 2. сүүл холбох, холбоц тааруулах, шүлэглэн холбох; 3. сүүл холбох, шүлэглэх.
РИФМОВА́ТЬСЯ холбоц таарах, холбоцтой байх; **часто стихи рифмуются попарно** шүлэг ихэнхдээ хос хос холбоцтой байдаг.
РИФМО́ВКА холбоцын тогтолцоо, холбоцын журам.
РИФМОПЛЁТ сүүл холбогч, шүлэглээчин.
РИЭ́ЛТОР үл хөдлөх хөрөнгийн зуучлагч.
РОБЕ́ТЬ зүрх алдах, зүрхших, хулчганах, хулчийх.
РО́БК||ИЙ зүрхгүй, хулчгар, аймтгай; **он не ~ого десятка** айдаг аравных биш, айх хүн бус.
РО́БКО зүрх алдан, хулчганан, эмээн.
РО́БКОСТЬ хулчгар зан, зүрхгүй байдал, эмээх.
РОВ гуу, суваг; **противотанковый** ~ танк эсэргүүцэх гуу.
РОВЕ́СНИК чацуу хүн, үеийн хүн, чацуутан, үетэн.

РОВЕ́СНИЦА чацуу эмэгтэй, үеийн эмэгтэй.

РО́ВНО 1. тэгш, 2. яг, мухар; ~ **в десять часов** яг арван цагт; 3. огт, бүр, таг; ~ **ничего не понял** бүр юу ч ойлгосонгүй; 4. /нэг/ жигд; **сердце билось** ~ зүрх жигд цохилж байлаа.

РО́ВН||ЫЙ 1. тэгш, цагаан; **~ая дорога** тэгш зам; **~ая местность** цагаан газар; 2. шулуун, цэх; **~ая линия** шулуун шугам; 3. адил, тэгш; 4. /нэг/ жигд, нэг янз; ~ **шаг** жигд алхаа; 5. нэг маяг, түвшин, төлөв; ~ **характер** түвшин зан; ~ **счёт** мухар тоо, бүхэл тоо; **~ым счётом ничего не знает** тэр /хүн/ огт юу ч мэдэхгүй байна.

РО́ВНЯ ижил хүн, жишээний хүн.

РОВНЯ́ТЬ *тэгшлэх, тэгш болгох.*

РОГ 1. эвэр; **бараний** ~ хонины эвэр; 2. бүрээ, урам; **охотничий** ~ урам; **как из ~а изобилия** далай баян; **обломать /сломать/ ~а кому-либо** омгий нь дарах, номхруулах; **согнуть кого-либо в бараний** ~ хав дөрвөлжин барих; **брать быка за ~а** эршүүд загнах; **наставить ~а** араар нь тавих.

РОГА́СТЫЙ эвэрэлхэг, том эвэртэй; ~ **бык** эвэрэлхэг бух, эвэр ихт бух.

РОГА́ТИНА ангийн жад.

РОГА́ТК||А 1. замын хаалт; 2. саад, тотгор; **ставить ~и кому либо** хүнд тотгох хийх; 3. чавх; **стрелять из ~и** чавх харвах, чавхдах; 4. бүлүүр; 5. малын дөнгө.

РОГА́ТЫЙ эвэртэй, эвэрт; **крупный ~ скот** үхэр; ~ **жаворонок** баалинз.

РОГА́Ч 1. эвэрт цох; 2. буга, эвэртэй эр амьтан; 3. ац бариул; 4. *(бот)* сээтэн.

РОГОВИ́ДНЫЙ эвэрэлхүү, эвэр шиг, эвэр хэлбэртэй.

РОГОВИ́ЦА /нүдний/ эвэр бүрхэвч.

РОГОВ||О́Й эвэр, эврээр хийсэн; ~ **гребень** эвэр сам; **~ые очки** эвэр хүрээтэй шил; **~ая оболочка** глаза нүдний эвэр бүрхэвч.

РОГО́ЖА чийрс.

РОГО́ЖНЫЙ чийрсэн, чийрсээр хийсэн.

РОГО́З усны зэгс.

РОГОНО́СЕЦ давхар малгайт, эхнэртээ *маллуулдаг* хүн, араараа тавиулагч.

РОД I 1. омог, овог, отог; **старейшина ~а** омгийн тэргүүлэгч; 2. үе, угсаа, язгуур, уг гарал; **из ~а в** ~ үеэс үед; **без ~у, без племени** язгуур сурвалжгүй, золбин; **ни ~у, ни племени** төрөл садангүй; ~ **людской, человеческий** ~ хүн төрөлхтөн; **от ~у** хүн болсоор, эхээс төрсөөр; **ему от ~у двадцать лет** тэр /хүн/ эхээс төрсөөр хорин настай.

РОД II 1. /амьтан, ургамлын/ төрөл; 2. зүйл, янз төрөл, чиглэл; ~ **занятий** *ажил төрөл*; **такого ~а** ийм, ийм янзын, ийм маягийн; **в этом ~е** иймэрхүү, ингэсэн янзтай, ийм ухааны; **он что-то в этом ~е и сказал** тэр иймэрхүү л юм хэлсэн; **в некотором ~е** нэг ёсондоо, заримдаа; **в своём ~е** 1. зарим талаар, хувьдаа; **он в своём ~е талантлив** тэр зарим талаар авъяастай хүн; 2. өвөрмөц, өөр; **два брата, и каждый в своём ~е** ах дүү хоёр, тэгээд нэг нэгнээсээ өөр; **своего ~а** нэг өвөрмөц, нэг ёсны.

РОД III хүйс; **мужской** ~ эр хүйс; **средний** ~ эрс хүйс; **женский** ~ эм хүйс.

РОДИ́ЛЬНИЦА нялх биетэй эх, нярайлсан эмэгтэй, сая төрсөн эх.

РОДИ́ЛЬНЫЙ төрөх, амаржих, нярайлах; ~ **дом** төрөх газар, амаржих газар, нярайлах газар.

РОДИ́М||ЫЙ 1. төрсөн, эх; **край** ~ төрсөн нутаг; эх нутаг; 2. хонгор, хайрт; **~ое пятно**, 1. мэнгэ; 2. үлдэгдэл.

РО́ДИН||А 1. эх орон; **защита ~ы** эх орноо хамгаалах; **любовь к ~е** эх орноо хайрлах; 2. төрсөн нутаг, төрөлх газар, уг нутаг, нутаг; **жить на ~е** нутагтаа суух; 3. анх гарсан орон, эх нутаг, эх орон.

РО́ДИНКА мэнгэ.

РОДИ́ТЕЛИ эцэг эх.

РОДИ́ТЕЛЬНЫЙ ~ **падеж** *харъяалахын тийн ялгал.*

РОДИ́ТЕЛЬСК||ИЙ эцэг эхийн, төрсөн; **~ие заботы** эцэг эхийн халамж; ~ **комитет** эцэг эхийн хороо; ~ **дом** төрсөн гэр.

РОДИ́||ТЬ 1. төрөх, амаржих, төрүүлэх, нярайлах, хөнгөрөх /хоёр/ яс хагацах; ~ **сына** хүү төрөх; 2. төрүүлэх; гаргах, буй болгох; 3. ургац гаргах; **в чём мать ~ла** чармаа нүцгэн.

РОДИ́||ТЬСЯ 1. төрөх, гарах, мэндлэх; **~лся сын** хүү төрөв; 2. төрөх, буй болох, үүсэх; 3. ургах, гарах.

РО́ДИЧ 1. нэг омгийн хүн, нэг омогтон; 2. төрөл, садан.

РОДНИ́К булаг, шанд.

РОДНИКО́В||ЫЙ булгийн; **~ая вода** булгийн ус.

РОДНИ́ТЬ хамаатан болгох, ойртуулах, төстэй болгох.

РОДНИЧО́К I зулай.

РОДНИЧО́К II бяцхан булаг, шанд.

РОДН||О́Й 1. төрсөн, төрүүлсэн; ~ **отец** төрсөн эцэг; **~ая мать** төрүүлсэн эх; ~ **брат** төрсөн ах; төрсөн дүү; **~ая сестра** төрсөн эгч, төрсөн дүү; 2. **родные** төрөл төрөгсөд, садан төрөл, ах дүү; **у него много ~ых** тэр /хүн/ ах дүү олуулаа; 3. өөрийн, төрөлх эх; ~ **край** төрөлх нутаг; **~ой язык** эх хэл; 4. дотно, хонгор.

РОДНЯ́ 1. төрөл төрөгсөд, садан төрөл, хамаатан; **близкая** ~ ойрын хамаатан; **дальняя** ~ холын хамаатан; 2. төрөл садан, төрлийн хүн; **он мне** — ~ тэр миний төрөл.

РОДОВИ́ТОСТЬ сурвалж, язгуур.

РОДОВИ́ТЫЙ сурвалжит, язгууртай.

РОДОВ||О́Й I 1. омгийн, өвгийн, отгийн; ~ **строй** омгийн байгуулал; 2. овгийн, өв залгамжилсан, өвлөсөн; **~ое имение** овгийн эдлэн; 3. төрлийн, төрлөөр ялгасан; **~ые и видовые названия** төрөл зүйлээр ялгасан нэр; 4. хүйсийн; **~ое окончание** хүйсийн сүүл; ~ **признак** төрлийн шинж.

РОДОВ||О́Й II төрөх, нярайлах; **~ые боли** төрөх гэж өвдөх.

РОДОДЕНДРО́Н тэрэлж.

РО́ДОМ *төрсөн, гаралтай*; **он ~ из Москвы** Москвад төрсөн хүн.

РОДОНАЧА́ЛЬНИК 1. өвөг, дээд өвөг; 2. эхийг тавигч, үндэслэгч.

РОДОНАЧА́ЛЬНИЦА эхийг тавигч, үндэслэгч /эмэгтэй/.

РОДОСЛО́ВИЕ,

РОДОСЛО́ВНАЯ, гэрийн үеийн бичиг, угийн бичиг.

РОДОСЛО́ВН||ЫЙ гэрийн үеийн; **~ая книга** гэрийн үеийн бичиг.

РО́ДСТВЕННИК төрөл, ураг, төрөл садны хүн, садан, хамаатан; ~ **по матери** цусан төрөл, махан төрөл, эхийн төрөл, нагац; ~ **по отцу** ясан төрөл, эцгийн талын хамаатан.

РО́ДСТВЕННИЦА төрөл эмэгтэй, хамаатан эмэгтэй.

РО́ДСТВЕННОСТЬ 1. төрөл байх, нэг төрлийн байх, төстэй байх; 2. дотно байх, ойр байх.

РО́ДСТВЕНН||ЫЙ 1. төрлийн, садан төрлийн, ургийн; **~ая связь** төрлийн холбоо; 2. төрөл, нэг төрлийн, гарал нэгтэй, төстэй; **~ые языки** төрөл хэлнүүд; 3. дотно, ойр, халуун; ~ **приём** дотно угтах.

РОДСТВ||О́ 1. төрөл, ураг төрөл, төрлийн холбоо; **быть в ~е** төрлийн холбоотой байх; 2. төрөл байх, гарал нэгтэй байх, төстэй байх; ~ **языков** төрөл олон хэл.

РО́ДЫ төрөх, амаржих, нярайлах; **трудные** ~ зовж төрөх; ***преждевременные*** ~ дутуу төрөх.

РОЕ́НИЕ овоорох, бүүрлэх; ~ **пчёл** зөгий овоорох.

РО́Ж||А I 1. нүүр ам, хушуу ам; **строить ~и** нүүр амаа арзайлгах.

РО́Ж||А II ёлом; **заболеть ~ей** ёломтох.

РОЖА́ТЬ төрөх, амаржих, хөнгөрөх; /хоёр/ яс хагацах.
РОЖДА́ЕМОСТ||Ь төрөх, төрөлт; **рост ~и** төрөхийн өсөлт.
РОЖДА́ТЬ төрүүлэх, гаргах, буй болгох.
РОЖДА́ТЬСЯ 1. төрөх, гарах, мэндлэх; 2. төрөх, буй болох, үүсэх.
РОЖДЕ́НИ||Е 1. төрөх; **день ~я** төрсөн өдөр; **год и место ~я** төрсөн газар, он; 2. төрсөн өдөр, төрсөн өдрийн баяр.
РОЖДЕСТВО́ христосын мэндэлсэн өдөр.
РОЖЕ́НИЦА төрөх эх, амаржих эх, нярайлах эх.
РОЖИ́СТ||ЫЙ ёлмын; **~ое воспаление** ёлмын үрэвсэл.
РОЖО́К 1. рожки бяцхан эвэр; 2. **рожки** урам; **пастуший ~** малчны урам; 3. **рожки** /тамхины/ эвэр сав; 4. **рожки** угж; **детский ~** угж.
РОЖО́Н лезть на ~ бүтэлгүй юманд тэмүүлэх.
РО́ЖЬ хөх тариа; **озимая ~** өвөлжих хөх тариа; **яровая ~** хаврын хөх тариа.
РО́ЗА сарнай цэцэг.
РОЗА́РИЙ сарнай цэцгийн хүлэмж.
РО́ЗВАЛЬНИ зайдан чарга.
РО́ЗГА 1. туйван, саваа, чавчрага; 2. **розги** туйвандах, чавчрагадах, саваадах.
РОЗЕ́ТКА 1. */чанамал жимсний/* дийз; 2. унтраалгын суурь.
РО́ЗНИЦ||А жижиглэн худалдах; **торговать в ~у** жижиглэн худалдах, жижиглэн худалдаалах.
РО́ЗНИЧН||ЫЙ жижиглэн худалдах, жижиглэсэн; **~ая торговля** жижиглэн худалдах; **~ые товары** жижиглэн худалдах бараа; **~ая цена** жижиглэн худалдах үнэ.
РО́ЗНЬ 1. хямралдаан, эвдрэл; **сеять ~** хямралдаан гаргах, эвдрүүлэх; 2. адилгүй байх, өөр өөр байх; **человек человеку ~** хүн хүн адилгүй.
РОЗОВА́ТЫЙ ягаавтар.
РОЗОВЕ́ТЬ ягаарах, ягаан болох.
РО́ЗОВ||ЫЙ 1. сарнай цэцгийн; **~ куст** сарнай цэцгийн бут; 2. ягаан; **~ое платье** ягаан хувцас; **видеть всё в ~ом цвете /свете/** юм болгоныг сайн гэх.
РО́ЗЫГРЫШ 1. сугалааны хонжвор гаргах, сугалах; 2. тэнцэх, хайнцах.
РО́ЗЫСК 1. эрэх; 2. мөрдөн байцаах; **уголовный ~** эрүүгийн хэргийг мөрдөн байцаах газар.
РОЙ́ТЬСЯ 1. овоорох, бүүрлэх; 2. бүүрлэн нисэх, хуйлран нисэх, сүрэглэн нисэх; 3. оргилох, даргилах.
РОЙ 1. бүүр, сүрэг; 2. үүр; **пчелиный ~** зөгийн үүр; 3. түмэн юм, олон юм; **~ воспоминаний** түмэн юм дурсах.
РОК үйл, хувь; **по воле ~а** үйлийн үрээр.
РОКИРОВА́ТЬСЯ */шатарт/* ноён тэрэг хоёрыг солбиулах.
РОКИРО́ВКА шатрын ноён тэрэг хоёрыг солбиулж тавих.
РОКОВ||О́Й үйлээр ирсэн, үйлийн үрээр болсон, үйлийн үргүй; **~ая ошибка** үйлийн үргүй алдаа.
РО́КОТ хүнгэнэх чимээ, дүүгэх дуу, нижигнээн, нүжигнээн, нүргээн; **~ моря** тэнгисийн нүжигнээн.
РОКОТА́||ТЬ хүнгэнэх, дүүгэх, нижигнэх, нүжигнэх, нүргэх; **~л отдалённый гром** алс тэнгэрийн дуу нүжигнэж байв.
РО́ЛИК 1. өнхрүүлэг; **кровать на ~ах** өнхрүүлэгтэй ор; 2. домбон үрэл; 3. домбогор, шаазан хөндийрүүл; 4. ролики дугуйтай тэшүүр; **кататься на ~ах** дугуйтай тэшүүрээр тэших.
РО́ЛЬ 1. роль; **главная ~** гол дүр; 2. жүжиглэх үг; **выучить ~** жүжиглэх үгээ цээжлэх; 3. үүрэг, учир холбогдол, нөлөө; **всемирно-историческая ~** дэлхий дахины түүхэн үүрэг; **это обстоятельство играет большую ~** энэ явдал их учир холбогдолтой байна.
РОМ ром /нэг зүйл хатуу архи/.
РОМА́Н 1. роман; **исторический ~** түүхэн роман; **написать ~ может каждый, если дать ему шесть недель времени, ручку, бумагу и убрать телефон и жену. (Ивлин Во)** Зургаан долоо хоног, үзэг цаас өгөөд утас, эхнэр хоёрыг нь холдуулчих юм бол хэн ч роман бичнэ. (Ивлин Во) 2. янагийн холбоо, янаг амрагийн явдал.
РОМАНИ́СТ I романч, роман зохиогч.
РОМАНИ́СТ II романч, роман хэлний мэргэжилтэн.
РОМАНИ́ЧЕСКИЙ 1. романы; 2. янагийн холбооны, янаг амрагийн явдлын.
РОМА́НС уянгал дуу.
РОМА́НСК||ИЙ роман /эртний Ромтой түүхэн баримдлагатай ард түмний хэл, соёлд холбогдолтой/; **~ие языки** роман хэлнүүд /франц, испан, итали, провансаль, португали, румын, молдав хэл/.
РОМАНТИ́ЗМ 1. романтизм XIX зууны эхэнд утга зохиол, урлагт гарсан, өнгөрсөн үеийг магтан сайшаагаад, бодит байдлаас тасарч, ганц нэг хүнийг тахин шүтдэг байсан чиглэл; 2. хүний эрхэм үүргийг хурц тод дүрслэн харуулах зорилготой, утга зохиол, урлагийн чиглэл/; 2. сайхан бодол.
РОМА́НТИК 1. романтизмыг баримтлагч; 2. сайхан бодолтой хүн.
РОМА́НТИКА 1. сайхан бодол; 2. урам, урам зориг, цог; **~ борьбы за свободу** эрх чөлөөний төлөө урам зоригтой тэмцэх.
РОМАНТИ́ЧЕСК||ИЙ 1. романтизмыг баримталсан; **~ая поэма** романтизмыг баримталсан яруу найраг; 2. сайхан бодолтой.
РОМАНТИ́ЧНОСТЬ сайхан бодолтой байх.
РОМАНТИ́ЧНЫЙ сайхан бодолтой.
РОМА́ШКА хамба шарилж, балжингарма, алтан товч.
РОМБ 1. ромбо, адил талт жишүү дөрвөлжин; 2. жишүү дөрвөлжин.
РО́НДО 1. дахилгат шүлэг; 2. түгрэглэсэн үсэг; 3. мохоо үзэг.
РОНЯ́||ТЬ 1. унагаах, алдах; **~ что-либо из рук** юм газар алдах; **~ книги со стола** ширээн дээрээс ном унагах; 2. гулдайлгах, ганзагалах; **~ голову на грудь** толгойгоо гулдайлгах; 3. гуужих, гээх, унагаах, унах; **деревья ~ют листву** мод навчаа гээж байна, модны навч унаж байна; **птицы ~ют оперение** шувууны өд гуужиж байна; **~ волосяной покров** үс гуужих; 4. унагах, цувруулах, цувуулах; **~ слёзы** нулимс цувруулах; **~ капли крови** цусаа дусал дуслаар цувуулах; 5. хугалах, гутаах; **~ себя в чьих-либо глазах** хүний өмнө нэрээ гутаах; **~ своё достоинство** нэр төрөө хугалах.
РО́ПОТ 1. дургүйцэл, дургүйцэн гүнгэнэх; **глухой ~** битүү дургүйцэл; 2. гунигт дуу, шулганаан; **~ ручья** горхийн усны шулганаан.
РОПТА́НИЕ дургүйцэн гүнгэнэх.
РОПТА́ТЬ дургүйцэн гүнгэнэх, дургүйцэх.
РОСА́ шүүдэр; утренняя роса өглөөний шүүдэр.
РОСИ́НК||А шүүдрийн дусал; **маковой ~и во рту не было** хэлэн дээр юм тавиагүй.
РОСИ́СТ||ЫЙ шүүдэртэй, шүүдэр унасан, шүүдэр унах; **~ая трава** шүүдэр унасан өвс, өвсний шүүдэр; **~ое утро** шүүдэр унах өглөө, шүүдэр унасан өглөө.
РОСКО́ШЕСТВО 1. хээнцэрлэх, хээнцэр зан; 2. хэтэрхий хээнцэрлэх, илүүц явдал; **отказаться от всяких роскошеств** аливаа илүүц явдлыг орхих.
РОСКО́ШЕСТВОВАТЬ, хээнцэрлэх, тансаг хээнцэр суух, хэтрүүлэх.
РОСКО́ШНО хээнцэр, тансаг.
РОСКО́ШН||ЫЙ 1. хээнцэр, хээнцэр гоё; **~ое издание** хээнцэр гоё хэвлэл; 2. гайхамшиг сайхан, тансаг; **~ые волосы** гайхамшиг сайхан үс; **~ обед** тансаг зоог.

РО́СКОШ||Ь 1. хээнцэр байдал, хээнцэр тансаг байдал; **жить в ~и** хээнцэр тансаг байдалд суух; 2. элбэг сайхан байх, элбэг үзэсгэлэн; **~ южной природы** дулаан орны байгалийн элбэг үзэсгэлэн; **позволить себе ~ что-либо сделать** тэсэлгүй хэтрүүлэх.

РО́СЛЫЙ чацархаг, биерхэг, өндөр, том биетэй; **~ мальчик** чацархаг хүү.

РОСОМА́Х||А /нохой/ зээх; **детёныш ~и** бөртөн.

РО́СПИСЬ 1. данс; **~ государственных доходов и расходов** улсын орлого зарлагын данс; 2. туурганы зураг.

РОСПУ́СК тархаах, чөлөө тавих; **~ учащихся на каникулы** сурагчдын амралтын чөлөө тавих.

РОССИ́ЙСКИЙ орос.

РО́ССЫП||Ь 1. үйрмэг, бутархай юм, сул асгасан юм; **грузить зерно ~ью** тариа сул ачих; 2. бутархай, уурхай; **золотые ~и** алтны уурхай.

РОСТ 1. өсөх, ургах; **~ растений** ургамал ургах; 2. өсөлт, хөгжилт, дэвжилт, дэгжилт; **~ промышленности** үйлдвэрийн өсөлт; 3. өсөн нэмэгдэх, өсч боловсрох, арвижих; **~ таланта** авъяас билиг арвижих; 4. чац, бие, нуруу; **высокого ~а** өндөр нуруутай; **низкого ~а** чац богинотой.

РОСТОВЩИ́К мөнгө хүүлэгч.

РОСТОВЩИ́ЧЕСКИЙ мөнгө хүүлэгчийн, мөнгө хүүлэх; **~ капитал** мөнгө хүүлэх капитал.

РОСТОВЩИ́ЧЕСТВО мөнгө хүүлэх; **заниматься ~м** мөнгө хүүлэх.

РОСТО́К 1. соёо; **семена пустили ростки** үр соёолж байна; 2. нахиа, нахиалсан мөчир.

РО́СЧЕРК эвхэж зурах, маяглаж зурах; **подпись с ~ом** эвхэж зурсан гарын үсэг.

РОТ ам; полоскать рот ам зайлах; **дышать ртом** амаар амьсгалах; **заткнуть ~** ам бөглөх, ам таглах; **во весь ~ /орать/** амныхаа хирээр хашгирах, хоолой мэдэн хашгирах; **зажать кому-либо ~** ам ангайлгахгүй байх, үг хэлүүлэхгүй байх; **не сметь рта раскрыть** ам нээхээс айх; **в ~ не возьмёшь** хоёр чихнээс хойш явахгүй, амтгүй; **смотреть в ~ кому-либо** бялдуурхан сонсох.

РО́ТА суман; **стрелковая ~** бууч суман.

РОТАЦИО́НН||ЫЙ ~ая машина ротац машин, булт машин /ном, сонин хэвлэх машин/.

РОТА́ЦИЯ ротаци.

РО́ТНЫЙ 1. сумангийн; **~ командир** сумангийн дарга; 2. сумангийн дарга.

РОТОЗЕ́Й алмай хүн, эргүү амьтан.

РОТОЗЕ́ЙНИЧАТЬ алмайрах, эргүүтэх.

РОТОЗЕ́ЙСТВО алмай, эргүү явдал.

РО́ЩА төгөл, шүгуй, зуун мод.

РОЯ́Л||Ь төгөлдөр хуур, рояль; **играть на ~е** төгөлдөр хуур дарах.

РТУ́ТНЫЙ мөнгөн усны, мөнгөн уст, мөнгөн устай; **~ термометр** мөнгөн устай халуун хүйтний хэмжүүр.

РТУТЬ мөнгөн ус; **гремучая ~** тэсрэмтгий мөнгөн ус.

РУБА́НОК харуул.

РУБА́ХА цамц; **~-парень** эгэл шулуун хүн.

РУБА́ШЕЧН||ЫЙ цамцны; **~ая ткань** цамцны бөс.

РУБА́ШК||А 1. цамц; **верхняя ~** гадуур цамц; **нижняя ~** дотуур цамц; 2. хөзрийн ар; 3. бүрхүүл, гэр; 4. гадуур дүгтүй; **родиться в ~е** буянтай төрөх; **остаться в одной ~е** *модоо* барих, дампуурах.

РУБЕ́Ж 1. хил, хязгаар; **за ~ом** хилийн чанад; **зорко охранять ~и нашей Родины** Эх орныхоо хилийг сэргэг хамгаалах; 2. зааг, уулзвар; **оборонительный ~** хамгаалалтын зааг; 3. хязгаар, зааг, уулзвар; **на ~е двух эпох** хоёр үеийн зааг дээр.

РУБЕ́Ц I 1. *сорви*; 2. гувруу; 3. *оёдол*.

РУБЕ́Ц II гүзээ, хужирхай.

РУБИ́Н бадмарага, нал эрдэнэ.

РУБИ́НОВ||ЫЙ 1. бадмарага, нал эрдэнэ, бадмарагын, нал эрдэнийн, бадмарагатай, нал эрдэнэтэй; **~ые серьги** бадмарага эмэг; 2. хүрэн улаан, бадмарагын өнгө, нал эрдэнийн өнгө; **~ цвет** хүрэн улаан өнгө, бадмарагын өнгө.

РУБИ́ТЬ 1. цавчих, хагалах, огтлох, татах, хэрчих; **~ дрова** түлээ хагалах; **~ мясо** мах татах; **~ капусту** байцаа хэрчих; 2. барих, зааж барих; **~ избу** байшин барих, мод зааж байшин барих.

РУ́БИЩЕ *уранхай* хувцас, *ноорхой* хувцас; **в ~** *ноорхой* хувцастай.

РУ́БКА I цавчих, хагалах, огтлох, хэрчих, татах.

РУ́БКА II /хөлөг онгоцны/ давхарлаг.

РУБЛЁВЫЙ нэг рублийн, нэг төгрөгийн, **~ билет** нэг төгрөгийн билет.

РУ́БЛЕН||ЫЙ 1. цавчсан, хэрчсэн, татсан; **~ое мясо** татсан мах; 2. заамал, заамал модон; **~ая изба** заамал модон байшин.

РУ́БЛЬ рубль.

РУ́БРИК||А 1. гарчиг; 2. бүлэг, хүснэгт; **разнести по ~ам** хүснэгүүдийг нөхөх.

РУБЦЕВА́ТЬ арлах.

РУ́БЧИК товгор судал.

РУ́ГАНЬ хараал.

РУГА́ТЕЛЬН||ЫЙ хараалын, хараах; **~ые слова** хараалыг үг.

РУГА́ТЕЛЬСТВО хараал зүхэл; хараал болох.

РУГА́ТЬ хараах, хараал тавих, зүхэх, загнах, зэмлэх.

РУГА́ТЬСЯ 1. хараах, хараал болох; 2. хэрэлдэх, хэрүүл хийх.

РУГНУ́ТЬСЯ хараачихах, хараагаад авах.

РУД||А́ хүдэр; **промывать ~у** хүдрийг зайлах; **железная ~** төмрийн хүдэр, гүр.

РУДИМЕ́НТ 1. илүүц эрхтэн; 2. хуучны үлдэгдэл.

РУДНИ́К уурхай; **медные ~и** зэсийн уурхай.

РУДНИКО́ВЫЙ рудничный уурхайн; **~ газ** уурхайн хий.

РУ́ДН||ЫЙ хүдрийн, хүдэртэй; **~ое месторождение** хүдрийн орд, хүдэртэй газар.

РУДОКО́П хүдэр малтагч.

РУДОНО́СНЫЙ хүдэртэй; **~ пласт** хүдэртэй давхраас.

РУЖЕ́ЙНИК бууны дархан, бууны үйлдвэрийн ажилчин.

РУЖЬ||Ё буу; **двуствольное ~** хоёр амтай буу; **стрелять из ~я** буу буудах, буу тавих; **заряжать ~** буу сумлах; **призвать под ~** цэрэгт дайчлах, цэрэгт татах; **быть под ~ём** дайтахад бэлхэн байх.

РУИ́НЫ эвдэрхий, эвдэрхий балгас.

РУК||А́ 1. гар; **правая ~** 1. баруун гар, зөв гар; 2. баруун гар, дотно найз; **левая ~** зүүн гар, солгой гар; **длинные ~и** урт гар; **поднять ~и** гараа өргөх; **опустить ~и** гараа буулгах, гараа доош болгох; **протянуть кому-либо ~у** *гараа сунгах*, гараа сарвайх; **выронить из рук** газар алдах; **пожать кому-либо ~у, пожать чью-либо ~у** хүний гар барих, атгах; **переписывать от ~и** гараар хуулах, сийрүүлэх; 3. гар, хүний гар, хүн; **у него умелые ~и** тэр /хүн/ гартаа дүйтэй; **дело в опытных ~ах** хэрэг туршлагатай хүний гарт орсон; туршлагатай хүнд очсон; **мало свободных рук** чөлөөтэй хүн цөөн байна; 4. бичгийн хэв, бичиг, гарын үсэг; **разобрать чью-нибудь ~у** хүний бичгийг гаргах; **неразборчивая ~** гаргагдахгүй бичиг; **~у приложить** гарын үсэг тавих; 5. тал, гар, тал, гар зүг; **по правую ~у** зөв талаар нь, баруун гар талд нь; 6. тал, танил, талын хүн; **своя ~** *өөрийн тал, талын хүн*; 7. гэрлэх, гэрлэхийг зөвшөөрөх; **просить чьей-либо ~и** хүнийг гэрлэ

гэх; **отдать кому-либо ~у** хүнтэй гэрлэхийг зөвшөөрөх; 8. гар, хэмжээ, зэрэг; **взять себя в ~и** биеэ барих; **в ~ах /быть, находиться/ у кого-либо** хүний гарт байх, мэдэлд байх; **в ~ах держать, в своих ~ах держать** гартаа барьж байх, гартаа атгах; **в ~и взять, в свои ~и взять** гартаа авах; **идти с кем-либо под ~у** хүнтэй сугадалцан явах; **~ об ~у** гар гараасаа барилцан; **передать из рук в ~и** биеэр шилжүүлэх, гарт нь өгөх; **~ ~у моет** гэмтэн гэмтнээ далдална, муу муудаа түшиг; **~ не дрогнет** буцахгүй, сүрдэхгүй; **~ не поднимается** зүрхлэхгүй; **всё из рук валится** юм хийх тэнхэл алга; **в наших ~ах** бидний эрхэнд; **отдать в хорошие ~и** сайн хүнд өгөх; **быть в чужих ~ах** бусдын гарт байх; **с фактами на ~ах** гартаа баримттай; **в одни ~и отпустить** нэг хүнд олгох; **в две ~и играть, в четыре ~и играть** /төгөлдөр хуур/ ганцаараа дарах, хоёулаа дарах; **в ~и отдать кому-либо** 1. гарт нь өгөх; 2. хүний мэдэлд өгөх; **это дело его рук** энэ түүний хийсэн хэрэг; **держать чью-либо ~у** хүний тал барих; **живой ~ой** шалавхан; **из рук вон /плохо/** тэр гэх тэмдэггүй муу, адгийн муу; **переходить из рук в ~и** хүн хүн дамжих; **прибрать к ~ам что-либо** гартаа оруулах, гартаа авах; **как ~ой сняло** огт мэдэгдэхгүй болох; **быть как без рук** гар мухар байх; **на все ~и мастер** юм болгонд дүйтэй хүн; **он на ~у нечист** юм хумсалдаг хүн; **выдать на ~и** гарт нь өгөх; **умереть на ~ах у кого-либо** хүний гар дээр нас нөгчих; **~и не доходят** зав болохгүй байна; **~и опускаются** урам хугарав; **~и чешутся** гар загатнана, зодолдох дур хүрнэ, гар загатнана, юм оролдох дур хүрнэ; **~и коротки** сачий хүрэхгүй; **~и прочь тонил, бүү гар хүр; сидеть сложа ~и** элгээ тэврээд суух, дэмий суух; **не покладая рук** гар хумхилгүй, борви бохирохгүй; **махнуть ~ой на кого-либо** зөнд нь орхих, зөнд нь тавих; **~ой подать** энүүхэнд, хоёр алхмын газар; **набить ~у на чём-либо** юманд гар нугарах; **протянуть ~у помощи** туслах; **приложить ~у к чему-либо** юманд гар оролцох; **наложить ~у на что-либо** гар хүрэх, булаан авах, эзэмдэн авах; **наложить на себя ~и** амиа хорлох; ломать руки толгойгоо шаах **нагреть ~и** идэж баяжих; **развязать ~и кому-либо** зоргонд нь тавих, дураар нь орхих; **умыть ~и** гэмгүй гарах, өөрийгөө цагаатгах; **ухватиться обеими ~ами** дуртайяа зөвшөөрөх, завшаан гэх, амандаа орсон махыг хэлээрээ түлхэхгүйг бодох; **чужими ~ами жар загребать** хүний гараар могой барих; **выпустить из рук** гараасаа алдах, мэдлээсээ гаргах; **на ~у кому-либо** зохистой байх, сэтгэлд нийлэх; **отбиться от рук** мэдлээс гарах, үг дуулахаа байх; **дать по ~ам** сургамж үзүүлэх, цөг гэх; **ударить по ~ам** олон гар дамжих, олон хүний нүүр үзэх; **под пьяную ~у** согтуугаар, согтуу явахад; **говорить под ~у кому-либо** ярьж саад болох; **попасть под горячую ~у** уурлайд нь тааралдах; **сойти с рук** ял эдлэлгүй гарах; **сбыть с рук** ангижрах, гэтлэх, салах; **вернуться с пустыми ~ами** гар хоосон буцах; **правая ~а чья-либо** хүний баруун гар, гол туслагч; **с ~ами оторвать** юутай хэзээ нь авах; **под ~и вести** сугадан хөтлөх; **не ~ кому-либо** гар нийлэхгүй; **сон в ~у** зүүд биелэх.

РУКА́В 1. ханцуй; **платье с длинными ~ами** урт ханцуйтай хувцас; 2. ташуур, салаа; **~ реки** голын ташуур, голын салаа; 3. хоолой, олгой, цорго; **пожарный ~** усан хөөрөгний олгой; **работать спустя ~а** хааш яаш ажиллах; **приняться за дело, засучив ~а** ханцуй шамлан орох.

РУКАВИ́Ц||А бээлий; **меховые ~ы** хөдсөн бээлий, **держать кого-либо в ежовых ~ах** хатуу гарт барих, хатуу гараар атгах.

РУКОВОДИ́ТЕЛ||Ь 1. удирдагч; **~и партии и правительства** нам, засгийн удирдагчид; 2. эрхлэгч; **~ кружка** дугуйлангийн эрхлэгч.

РУКОВОДИ́ТЬ 1. удирдах; **~ учреждением** албан байгууллага захирах, албан байгууллага удирдах; **Руководить — это значит не мешать хорошим людям работать. (П.Капица)** Удирдах гэдэг бол сайн хүмүүст ажиллахад нь садаа болохгүй байхыг хэлж байгаа юм. (П.Капица)

РУКОВОДИ́ТЬСЯ баримтлах, удирдлага болгох, мөрдлөг болгох.

РУКОВО́ДСТВ||О 1,удирдах, удирдлага; **методы ~а** удирдах арга; **оперативное ~** шаламгай удирдах, шуурхай удирдлага; 2,удирдлага, мөрдлөг; **принять к ~у** удирдлага болгох; 3. удирдагчид, удирдлага; **новое ~** шинэ удирдагчид, шинэ удирдлага; 4,гарын авлага; **~ по химии** хувилахуй ухааны гарын авлага.

РУКОВО́ДСТВОВАТЬСЯ баримтлах, мөрдлөг болгох, удирдлага болгох.

РУКОВОДЯ́Щ||ИЙ 1. удирдах; 2. удирдлага болох, заавар болох; **~ая статья** удирдлага болох өгүүлэл.

РУКОДЕ́ЛИЕ 1,үйл хийх, хатгамлах, сүлжих; **заниматься ~м** үйл хийх; 2,оёсон юм, сүлжсэн эд, хатгамласан зүйл.

РУКОДЕ́ЛЬНИЦА үйлчин эмэгтэй.

РУКОДЕ́ЛЬНИЧАТЬ үйл хийх, хатгамлах, сүлжих.

РУКОКРЫ́ЛЫЕ савар жигүүртэн.

РУКОМО́ЙНИК угаагуур.

РУКОПА́ШНАЯ гардан байлдах, гардан байлдаан.

РУКОПА́ШНЫЙ гардан байлдах; **~ бой** гардан байлдах, гардан байлдаан.

РУКОПИ́СН||ЫЙ 1. бичмэлийн, гар бичгийн; **~ отдел библиотеки** номын сангийн гар бичгийн хэлтэс; 2. бичмэл, гараар бичсэн; **~ые заметки** бичмэл тэмдэглэл.

РУ́КОПИСЬ бичмэл, гар бичиг.

РУКОПЛЕСКА́НИ||Е алга таших; **раздались ~я** алга ташив.

РУКОПЛЕСКА́ТЬ алга таших, баяр хүргэх; **~ оратору** илтгэгчид алга таших; **народ рукоплещет героям** ард түмэн баатруудад баяр хүргэж байна.

РУКОПОЖА́ТИ||Е гар барих, гар барилцах; **дружеское ~** нөхөр ёсоор гар барих; **обменяться ~ями** гар барилцан мэндлэх.

РУКОПРИКЛА́ДСТВО гар хүрэх, зодох.

РУКОЯ́ТКА, РУКОЯ́ТЬ бариул, иш; **~ кинжала** чинжаал хутганы бариул; **~ молотка** алхны иш.

РУЛЕВ||О́Й 1. залуурын; **~ое колесо** залуурын цагариг; 2. залуурчин.

РУЛЕ́Т 1. */татсан махан/* ороомог; 2. ороомог боов; 3. гуяны махан ороомог.

РУЛЕ́ТКА эвхмэл метр, хэмжүүр тууз.

РУЛИ́ТЬ жолоодох, залуурдах, жолоо эргүүлэх, залах.

РУЛО́Н хүй, ороодол, толгой.

РУ́Л||Ь 1. жолоо, залуур; **механизм ~я** залуурын оньс, **править ~ём** жолоо залах, залуур барих, жолоодох; 2. жолоо; **~ государственного управления** төрийн жолоо.

РУМЫ́Н румын.

РУМЫ́НКА румын эмэгтэй, румын эхнэр.

РУМЫ́НСКИЙ румын, румыны; **~ язык** румын хэл.

РУМЯ́НА энгэсэг **покрыть щёки ~ми** хацартаа энгэсэг тавих.

РУМЯ́Н||ЕЦ улаан, **залиться ~цем** нүүр улайх, улаан болох.

РУМЯ́НИ||ТЬ 1. улайлгах, улаан болгох; **мороз ~т лица** хүйтэнд нүүр улайна; 2. энгэсэг тавих, энгэсэг түрхэх; **~ себе щёки** хацартаа энгэсэг түрхэх.

РУМЯ́НИТЬСЯ 1. улайх, улаан болох; 2. хацартаа энгэсэг тавих, нүүртээ энгэсэг түрхэх; 3. шарлах; **пирог начал ~** бялуу шарлаж эхлэв.

РУМЯ́Н||ЫЙ улаан, улаан хацартай; **~ые щёки** улаан хацар.

РУ́ПОР 1. дуу чангаруулагч хоолой; 2. үзэл санаа дэлгэрүүлэгч.
РУСА́К бор туулай.
РУСА́ЛКА лусын охин.
РУСИ́СТ оросч.
РУ́СЛ||О 1. гулдрил, сав; ~ **реки** голын сав, гулдрил, 2. зам, чиглэл; **жизнь пошла по новому** ~**у** амьдрал шинэ замаар явж байна.
РУ́ССКАЯ I орос эмэгтэй, орос эхнэр.
РУ́ССКАЯ II орос /бүжиг/.
РУ́ССКИ||Й орос хүн; **любовь придумали** ~**е, чтобы не платить женщине** эмэгтэй хүнд мөнгө төлөхгүйн тулд оросууд хайр дурлалыг сэтгэж зохиосон.
РУ́ССК||ИЙ орос, оросын; ~ **язык** орос хэл; ~ **народ** оросын ард түмэн, ~**ая литература** оросын утга зохиол; ~**ие долго запрягают, но быстро едут. (О. Бисмарк)** Оросууд хөллөхдөө удаан ч, давхихдаа хурдан. (О. Бисмарк)
РУ́С||ЫЙ шар үстэй; ~**ые волосы** шар үс; ~ **парень** шар үстэй залуу хүү.
РУТИ́НА хэвшсэн заншил дууриах.
РУТИНЁР хэвшсэн заншил дууриагч.
РУ́ХЛЯДЬ новш, новщ ноохой.
РУ́ХНУ||ТЬ 1. нурах, хэмх унах, хамх буух; **старый мост** ~**л** хуучин гүүр хэмх унав; 2. тасрах, нурах; **надежды** ~**ли** горьдлого тасрав; **все планы** ~**ли** бүх төлөвлөгөө нурав.
РУЧА́ТЕЛЬСТВО даалт, баталгаа; **письменное** ~ бичмэл даалт.
РУЧА́ТЬСЯ даах, даалт гаргах, баталгаа өгөх, батлах; ~**головой** толгойгоороо даах; **нельзя** ~**, что завтра будет хорошая погода** маргааш тэнгэр сайхан болно гэж батлах аргагүй.
РУЧЕЁК бяцхан горхи, булаг.
РУЧЕ́Й горхи; **горный** ~ уулын горхи; **течь ручьями** урсах.
РУ́ЧК||А 1. бяцхан гар; 2. бариул, иш, сэнж; **дверная** ~ хаалганы бариул, ~ **ножа** хутганы иш, **чашка без** ~**и** сэнжгүй аяга; 3. үзгийн иш, үзэг иш, үзэг; ~ **с пером** үзэг иш.
РУЧН||О́Й 1. гар, бугуйны, гар нүүрийн, гарын; ~ **труд** гар хөдөлмөр; ~**ые часы** бугуйны цаг; ~**ое полотенце** гарын алчуур; нүүр гарын алчуур; ~ **багаж** гар тээш; 2. тэжээвэр, тэжээмэл; ~**ая торговля** гар худалдаа.
РУ́ШИТЬ I нураах, буулгах; ~ **дом** байшин буулгах.
РУ́ШИТЬ II хальслах, хальсыг нь арилгах; ~ **просо** шар будаа хальслах.
РУ́ШИ||ТЬСЯ 1. эвдрэх, нурах, нүрхийтэл унах, түсхийтэл буух; 2. нурах, эвдрэх, арилах; **наши планы** ~**лись** манай төлөвлөгөө эвдрэв.
РЫ́Б||А загас; **свежая** ~ сая барьсан загас, шинэ загас; **солёная** ~ давсалсан загас; **мороженая** ~ хөлдүү загас; **копчёная** ~ утсан загас; **вяленая** ~ борцолсон загас, хатаасан загас; **удить** ~**у** загас хахуулдах; **ни** ~**, ни мясо** өөх ч биш, булчирхай ч биш; **ловить** ~**у в мутной воде** муу эр чөлөөнд, чоно бороонд; **биться, как** ~ **об лед** аргаа барах.
РЫБА́К загасчин.
РЫБА́ЦКИЙ загасчны, загас барьдаг; ~ **колхоз** загасчны хамтрал, загас барьдаг хамтрал; ~ **посёлок** загасчны суурин.
РЫБА́ЧИЙ загасчны, загасны; **рыбачьи сети** загасны тор, өөш.
РЫБА́ЧИТЬ загасчлах, загас барих, загас агнах.
РЫБА́ЧКА загасчин эмэгтэй, загасчин эхнэр, загасчны эхнэр.
РЫБЁШКА жараахай, муусайн жараахай; **мелкая** ~ жижиг
РЫ́БН||ИЙ загасны; ~ **жир** загасны тос; ~**ья чешуя** загасны хайрс.
РЫ́БН||ЫЙ 1. загасны; ~**ая ловля** загас барих; ~**ая промышленность** загасны үйлдвэр; 2. загасан, загасаар хийсэн, загасны, загастай; ~**ые консервы** загасан консерв, загасан хадгалаас; 3. загастай элбэг загастай; ~**ое озеро** загастай нуур.
РЫБОВО́ДСТВО загас үржүүлэх.
РЫБОЛО́В загасчлагч, загасчин.
РЫБОЛОВЕ́ЦКИЙ загас барих.
РЫБОЛО́ВН||ЫЙ загасчлах, загас барих; ~**ые снасти** загасчлах хэрэгсэл; ~**ый промысел** загас барих ажил.
РЫБОЛО́ВСТВО загас барих, загас агнах ажил.
РЫБОПРОДУ́КТЫ загасан бүтээгдэхүүн.
РЫБОПРОМЫСЛО́ВЫЙ загасны ажлын, загасны ажилтай.
РЫБОПРОМЫ́ШЛЕННОСТЬ загасны үйлдвэр.
РЫВО́К ухасхийх, угз татах, угзрах; ~ **вперед** урагш ухасхийх, **тянуть рывками** угз угз татах.
РЫГА́ТЬ хэхрэх.
РЫГНУ́ТЬ хэхэрчих, хэхрээд орхих.
РЫДА́НИ||Е цурхиран ухилах; **разразиться** ~**ями** цурхиран ухилж эхлэх.
РЫДА́ТЬ цурхиран ухилах, гэгэн уйлах, эгшин уйлах.
РЫЖЕВА́ТЫЙ улаан шаравтар, улаан шаравтар үстэй.
РЫ́Ж||ИЙ улаан, 1. шар улаан шар үстэй; ~**ие волосы** улаан шар үс; ~**ий человек** улаан шар үстэй хүн; 2. зээрд; 3. гандаж шарласан, гандсан; ~**ая шляпа** гандсан бүрх малгай.
РЫ́ЖИК сархиаг.
РЫК хүрхрэх дуу, архираан; **львиный** ~ арсланы хүрхрэх дуу.
РЫ́КАТЬ хүрхрэх, архирах.
РЫ́ЛО 1. хоншоор, хошуу; **свиное** ~ гахайн хоншоор; 2. хоншоор ам.
РЫ́ЛЬЦЕ бяцхан хоншоор.
РЫ́НОК зах, зах зээл, зээл; **внешний** ~ гадаадын зах зээл; **внутренний** ~ дотоодын зах зээл; ~ **сбыта** борлуулах зах зээл.
РЫ́НОЧН||ЫЙ захын, зах зээлийн, зээлийн; ~**ая цена** захын үнэ.
РЫСА́К хатиртай морь, хатирч морь; ~ **перебойный** арилжаа морь.
РЫ́СИЙ 1. шилүүлсний, шилүүсэн; ~ **мех** шилүүсний арьс; 2. гялганасан, хурц; **рысьи глаза** хурц нүд.
РЫСИ́СТ||ЫЙ хатираа, хатирч, хатиртай; ~**ая лошадь** хатиртай морь.
РЫ́СКАТЬ 1. хэсэх, хэрэх, зайх; 2. уудлах, суйлах; ~ **по карманам** халаас уудлах.
РЫСЦА́ шогшоо; **бежать рысцой** шогших.
РЫСЬ I хатир, хатираа; **ехать** ~**ю** хатирах, хатируулах.
РЫСЬ II шилүүс.
РЫ́СЬЮ 1. хатиран, хатируулан; **пустить лошадь** ~ морио хатируулах, 2. хурдаараа; **он пустился бежать** ~ тэр хүн хурдаараа гүйв.
РЫТВИНА замын хонхор, хонхор цонхор.
РЫТЬ малтах, ухах, эрэх; ~ **яму** нүх ухах, нүх малтах; ~ **колодец** худаг малтах.
РЫТЬЁ малтах, малталт; ~ **канав** суваг малтах.
РЫ́ТЬСЯ онгилох, уудлах, эрэх; ~ **в песке** элс онгилох; ~ **в старых журналах** хуучин сэтгүүл онгилж эрэх.
РЫХЛЕ́НИЕ хөвсийлгөх, сэвсийлгэх.
РЫХЛИ́ТЬ хөвсийлгэх, сэвсийлгэх, зөөлрүүлэх; ~ **землю** газар

РЫ́ХЛ||ЫЙ 1. хөвсгөр, хөвхгөр, сэвсгэр, зөөлөн, сул; **~ая почва** сул хөрс, хөвсгөр хөрс; 2. бамбагар, бэлхгэр, бэлцгэр; **~ое тело** бамбагар бие.

РЫ́ЦАРСК||ИЙ 1. баатрын, цэрэг тайжийн; **~ие доспехи** баатарын хуяг дуулга; **~ роман** баатарын роман, цэрэг тайжийн роман; 2. баатарлаг, агуу сэтгэлийн, уудам сэтгэлтний; **~ поступок** агуу сэтгэлийн үйл, уудам сэтгэлийн явдал, баатарлаг явдал.

РЫ́ЦАРСТВО 1. баатрууд, цэрэг тайж нар; 2. баатарлаг явдал, уудам сэтгэлтний үйл, агуу сэтгэл, уужим дотор.

РЫЦАРЬ 1. цэрэг, тайж, баатар; **странствующий ~** хэрмэл цэрэг тайж; **~ печального образа** гуниг дүрт баатар; 2. баатар, чин зоригт эр, агуу сэтгэлт хүн, уудам сэтгэлт эр.

РЫЧА́Г 1. хөшүүрэг, хөшүүр, гөнжүүр, үлүүр; **поднять ~ом** хөшүүргээр өргөх, хөшүүргэдэн өргөх; 2. хөшүүрэг, зэвсэг; **грамотность — ~ культуры** бичиг үсэг мэдэх явдал бол соёлыг хөгжүүлэх зэвсэг мөн.

РЫЧА́НИЕ хүрхрэх, архирах, урхирах, хүрхрээн, архираан, урхираан.

РЫЧА́ТЬ хүрхрэх, архирах, урхирах.

РЬЯ́НО шамдуу, шамдгай.

РЬЯ́НОСТЬ шамдлага, шамдгай байх.

РЬЯ́НЫЙ шамдлагатай, шамдгай, шамдуу, шамдгай тоглоомч.

РЮКЗА́К үүргэвч.

РЮ́МКА хундага, жүнз.

РЯБИ́НА I тэс, сэндэн, хадир.

РЯБИ́НА II нөрөө, цоохор.

РЯБИ́НКА бяцхан нөрөө.

РЯБИ́НОВКА тэс буйлуулсан архи.

РЯБИ́НОВ||ЫЙ тэсийн; **~ая настойка** тэсийн буйлуулмал архи.

РЯБИ́||ТЬ 1. яралзуулах, мяралзуулах, атираа татуулах, атираатуулах; **ветер ~т воду** салхи ус мяралзуулна; 2. эрээлжлэх; **у меня в глазах ~т** миний нүд эрээлжилж байна.

РЯБ||О́Й 1. цоохор, нөрөөтэй; 2. цоохор, алаг, бидэртэй; **~ая корова** алаг үнээ, цоохор үнээ.

РЯ́БЧИК цорхируу, хөх ногтруу, хөтүү.

РЯБЬ 1. ирж, яралж, хунираа, атираа; **озеро подёрнулось ~ю** нуурын ус яралжлав; 2. эрээлжлэх, эрээлж; **~ в глазах** нүд эрээлжлэх.

РЯ́ВКНУТЬ зандрах, хашгирах.

РЯД 1. эгнээ, **стулья в два ~а** хоёр үе сандал; 2. эгнээ, мөр, жагсаал; **построиться в ~ы** эгнээ эгнээгээр жагсах; 3. хэдэн **~ поколений** хэдэн үе; 4. хэд хэдэн, нилээд хэдэн, нилээд олон; **~ известных учёных** нилээд олон нэрт эрдэмтэн; **целый ~ обстоятельств** бүр нилээд хэдэн учир явдал; 5. эгнээ, бүрэлдэхүүн; 6. зэгэл, зах; **овощной ~** ногооны зах; **из ~а вон /выходящий/** бусдаас шал өөр, гойд маягийн; **в ~у** дунд, дотор, хамт; **в ~е** нилээд хэдэн, нилээд олон.

РЯДИ́ТЬ I хувцас өмсгөх, эрээн мяраан хувцас өмсгөх, **~ шутом** алиа салбадайн хувцас өмсгөх.

РЯДИ́ТЬ II 1. шүүж таслах, 2. хөлслөх, хөлс тохирох, **~ извозчика** хөлсний тэрэг хөлслөх.

РЯДИ́ТЬСЯ I 1. гоёж гоодох, гангалах; 2. багт наадмын хувцас өмсөх.

РЯДИ́ТЬСЯ II 1. хөлс тохиролцох; 2. хийхээр тохиролцох.

РЯДКО́М зэрэгцэнхэн, зэрэгцээд.

РЯДОВО́Й 1. энгийн, жирийн, эгэл, ерийн; **~ работник** жирийн ажилтан, 2. жагсаалын; **~ боец** жагсаалын цэрэг; 3. мөрлөн тарьдаг, мөрлөсөн; **~ сев** мөрлөн тарих; 4. жагсаалын цэрэг.

РЯ́ДОМ 1. зэрэгцэн, зэрэгцээд, дэргэд, хажууд; **сесть ~ с кем-либо** хүний дэргэд суух; 2. зэргэлдээ, дэргэд, зэрэгцээ; **сплошь да ~** захаас аваад, хааяагүй.

РЯ́ЖЕНЫЙ 1. багт наадмын хувцастай; 2. багт наадмын хувцастай хүн.

РЯ́СА занч, өмсгөл.

РЯ́СКА (*бот*) лавшига.

С

С (СО) 1. - аас *(- ээс, - оо,өөс),*дээрээс; **спуститься ~ горы** уулнаас буух; 2. аас *(- ээс, - оос, - өөс)* (эхлээд, аваад, хойш); **~ самого детства** хар бага наснаасаа; 3. - аас *(- ээс, - оос, - өөс),* дээрээс; 4. - аас *(- ээс, - оос, - өөс),* - ын *(- ийн),* - ы *(- ий),* - н; **получить ~ кого-либо деньги** хүнээс мөнгө авах; **перевести ~ русского языка** орос хэлнээс орчуулах; 5. - аар *(- ээр, - оор, - өөр),* **~ разрешения начальника** даргын зөвшөөрлөөр; 6. - д, - ж, - ч, - аад *(- ээд, - оод,- өөд),* **сгорать ~ стыда** ичиж улайх; 7. - аар *(- ээр, - оор, - өөр),* - н; **писать ~ большой буквы** том үсгээр бичих; 8. орчим, шахам, хиртэй, дайтай, чинээн; **~ километр** километр орчим, километр хиртэй; 9. - тай *(- тэй, - той) (хамт хэрэглэсэн нэр үгийг нь үйл үг болгоно),* **я иду ~ тобой** би чамтай явна; **читать ~ интересом** сонирхон унших; 10. - аар *(- ээр, - оор, - өөр),* **поспешить ~ отъездом** мордохыг яарах; 11. ахихад, өнгөрөхөд; **остепениться ~ годами** нас ахихад томоожих; 12. тохиолдуулан.

СА́БЛЯ сэлэм; 2. морин цэрэг.

СА́БЕЛЬНИК *бот.* зэдгэлж.

СА́БЕЛЬН||ЫЙ сэлэмний; **~ые ножны** сэлэмний хуй.

САБОТА́Ж ажил санаатай тасалдуулах, боогдуулах, хор саад учруулах.

САБОТА́ЖНИЧАТЬ санаатай тасалдуулах, зориуд саад хийх, хойш татах, боогдуулах.

САБОТИ́РОВАНИЕ ажил санаатай тасалдуулах, хойш татах.

САБОТИ́РОВАТЬ санаатай тасалдуулах, зориуд саатуулах, хойш татах, боогдуулах.

СА́ВАН *(нас эцэслэсэн хүнд өмсгөх)* цагаан өмсгөл.

САВРА́СЫЙ хул; **~ жеребец** хул азарга.

СА́ГА сага, скандинав тууль.

САД цэцэрлэг, хүрээлэн; **ботанический ~** ургамлын цэцэрлэг; **гулять в ~у** цэцэрлэгт зугаалах; **детский ~** хүүхдийн цэцэрлэг.

САДИ́ЗМ 1. садизм; 2. тарчилган зовоох.

СА́ДИК бяцхан цэцэрлэг.

САДИ́СТ садист, тарчилган жаргагч.

САДИ́ТЬ 1. суулгах, тарих; 2. суулгах; 3. хийлгэх, суулгах; 4. хийх, суулгах, хорих; 5. даруулах; 6. хийх, тавих.

САДИ́ТЬСЯ I 1. суух; 2. суух, унах; 3. орох, шингэх; 4. буух, суух; 5. суугаад эхлэх, орох; 6. суух, тулах, тогтох.

САДИ́ТЬСЯ II агших, унах.

САДНИ́||ТЬ загатнах, хорсон загатнах, сэрвэгнэн хорсох; **в горле ~т** хоолой сэрвэгнэн хорсоно.

САДО́ВНИК цэцэрлэгч.

САДОВО́Д цэцэрлэгжүүлэгч, цэцэрлэгийн мэргэжилтэн.

САДОВО́ДСТВО 1. цэцэрлэгжүүлэх, цэцэрлэг тарих; 2. цэцэрлэгийн аж ахуй.

САДОВО́ДЧЕСКИЙ цэцэрлэгжүүлэх, цэцэрлэг тарих.

САДО́В||ЫЙ цэцэрлэгийн, цэцэрлэгт ургадаг; **~ая калитка** цэцэрлэгийн суга хаалга; **голова ~ая** тэнэг толгой.

СА́ЖЕНЬ сажин *(оросын хуучин уртын хэмжүүр; 2. 1. 3. метртэй тэнцэнэ);* **маховая ~** алд; **косая ~ в плечах** өргөн мөртэй, ханхар цээжтэй.

САЗА́Н булуу цагаан, салбарс.

САЗА́Н||ИЙ 1. булуу цагааны, салбарсын; 2. булуу цагааны, салбарсаар хийсэн, булуу цагааны махтай; **~ья уха** салбарсын шөл; **~ пирог** салбарсын махтай бялуу.

САЙГА́ бөхөн *(гөрөөс);* **~-самец** хэрэгчин; **~-самка** гирээ.

САЙГА́К бөхөн.

СА́ЙКА загасан талх.

САКВОЯ́Ж хумбага *(аяны сав),* цүнх.

САКРАМЕНТА́ЛЬНЫЙ ариун нандин.

САКСАУ́Л заг.

САЛА́ЗК||И явган чарга, чарга; **кататься на ~ах** чаргаар гулгах.

САЛА́Т 1. шанцайн ургамал; 2. шанцай, хигдэс; 3. салат, зууш.

САЛА́ТНЫЙ шанцайн, хигдсийн.

СА́ЛО 1. өөх, тарга; 2. өөх, өөхөн тос; **топлёное ~** өөхөн тос.

САЛО́Н 1. үзэсгэлэнгийн танхим; 2. салон, өрөө; **~ красоты** гоо сайхны өрөө 3. зочдын танхим; 4. *(язгуургы)* бүлгэм; **литературный ~** утга зохиолын бүлгэм.

САЛФЕ́ТК||А 1. хооловч, амны алчуур, салфетк; **повязать ~у** хооловч зүүх; 2. бяцхан бүтээлэг.

СА́ЛЬНИК 1. сэмж; 2. жийргэвч.

СА́ЛЬНОСТЬ билэн, завхай үг.

СА́ЛЬН||ЫЙ I 1. тос болсон, тостой; **~ая железа** тосны булчирхай; 2. өөхөн тосон; **~ая свеча** өөхөн тосон лаа.

СА́ЛЬНЫЙ II билэндсэн, завхай; **~ анекдот** завхай үг.

СА́ЛЬТО үсэрч хий эргэх.

САЛЮ́Т ёслох, ёслолын буудлага.

САЛЮТОВА́ТЬ ёслох, ёслол хийх, буудаж ёслох.

САМ өөр, өөрөө, бие эрээ; **сами** өөрсөд, өөрсдөө; **он ~ это сказал** тэр өөрөө үүнийг хэлсэн.

САМА́Н зөн, хөрзөн.

САМЕ́Ц эр *(амьтан),* эрэгчин.

СА́МКА эм *(амьтан),* охин *(амьтан),* өлөгчин, эмэгчин.

САМОАНА́ЛИЗ явдлаа эрэгцүүлэн үзэх, сэтгэлээ шинжлэх.

САМОБИЧЕВА́НИЕ биеэ буруушаах, өөрийгөө зэмлэх.

САМОБРА́НКА скатерть~~ шидэт бүтээлэг.

САМОБЫ́ТНОСТЬ өвөрмөц чанар, өвөрмөц байдал; **национальная ~** үндэсний өвөрмөц байдал.

САМОБЫ́ТН||ЫЙ өвөрмөц, өвөрмөц чанартай, өвөрмөц байдалтай; **~ая культура** өвөрмөц соёл.

САМОВА́Р халуун тогоо, самовар, галт хувин.

САМОВА́РНЫЙ халуун тогооны; **~ кран** халуун тогооны цорго.

САМОВЛА́СТНЫЙ 1. эзэрхий, эзэрхэг, хэмжээгүй эрхт; **~ правитель** эзэрхэг засаг ноён; 2. эзэрхий, эзэрхэг, зоргоороо; **~ человек** эзэрхий хүн.

САМОВЛЮБЛЁННЫЙ өөрийгөө өргөмжилдөг; **~ человек** биеэ өргөмжилдөг хүн.

САМОВНУШЕ́НИЕ өөрөө өөрийгөө үнэмшүүлэх, өөрийгөө итгүүлэх.

САМОВОЗГОРА́НИЕ өөрийн шаталт.

САМОВО́ЛИЕ дур зоргоороо, зоргоороо.

САМОВО́ЛЬНИЧАТЬ дур зоргоороо аашлах, зоргоороо загнах, зоргондоо байх.

САМОВО́ЛЬНЫЙ 1. дур зоргоороо, зоргоороо, дураараа; **~ ребёнок** зоргоороо хүүхэд; 2. зөвшөөрөлгүй, дур мэдэн *(хийсэн),* дураараа.

САМОВОСПИТА́НИЕ өөрийгөө хүмүүжүүлэх.

САМОВОСПЛАМЕНЕ́НИЕ өөрөө асах.

САМОВОСХВАЛЕ́НИЕ биеэ магтах.

САМОГО́Н нэрмэл архи, самогон.

САМОГО́НКА нэрмэл архи.

САМОДВИЖЕ́НИЕ *өөрөө хөдлөх, өөрөө хөгжих.*

САМОДВИ́ЖУЩИЙСЯ өөрөө хөдлөх, өөрөө явах.
САМОДЕ́ЛКА гараар хийсэн юм, гэрийн хийцтэй юм.
САМОДЕ́ЛЬНЫЙ өөрийн хийсэн, гараар хийсэн, гэрийн хийцтэй.
САМОДЕРЖА́ВИЕ хэмжээгүй эрхт *(хаант)* засаг.
САМОДЕРЖА́ВН||ЫЙ хэмжээгүй эрхт; **~ая власть** хэмжээгүй эрхт засаг.
САМОДЕ́РЖЕЦ хэмжээгүй эрхт хаан, эзэн хаан.
САМОДЕ́ЯТЕЛЬНОСТЬ 1. хувийн санаачилга, өөрийн санаачилга; **проявить** ~ хувийн санаачилга гаргах, санаачлах; 2. сайн дурын, уран сайхан.
САМОДЕ́ЯТЕЛЬНЫЙ сайн дурын, сайн дурын уран сайхны, өөрсдийн санаачилсан.
САМОДИСЦИПЛИ́НА хувийн сахилга бат.
САМОДОВЛЕ́ЮЩИЙ төгөлдөр, төгс агуулгатай.
САМОДОВО́ЛЬНО маадайн, хангалуун, сэхүүн; **~ улыбаться** маадайн инээмсэглэх.
САМОДОВО́ЛЬНЫЙ маадгар, хангалуун, хангалуун байдалтай.
САМОДОВО́ЛЬСТВО маадгар зан, хангалуун байдал, биеэ тоох.
САМОДУ́Р сэхүүн заантай хүн, зоргоороо хүн, ёргио хүн.
САМОДУ́РСТВО сэхүүн зан, ёргио явдал. зоргоороо аашлах.
САМОДУ́РСТВОВАТЬ сэхүүн аашлах, зоргоороо загнах, ёргих.
САМОЗАБВЕ́НИ||Е 1. онгирох, ухаан алдах; 2. амь бие хайрлахгүй, нойр хоолгүй, амь тавих; **работать до ~я** амь бие хайрлахгүй ажиллах.
САМОЗАРЯ́ДНЫЙ өөрөө цэнэглэгдэх, өөрөө сумлагддаг.
САМОЗАЩИ́ТА өөрийгөө хамгаалах, амиа хамгаалах.
САМОЗВА́НЕЦ нэр зээлдэгч, хуурамч этгээд.
САМОЗВА́НЫЙ нэр зээлдсэн, хуурамч.
САМОЗВА́НСТВО нэр зээлдэх, хуурамч нэр зүүх.
САМОКА́Т унадаг дугуй.
САМОКОНТРО́ЛЬ өөрийн хяналт.
САМОКРИ́ТИКА өөрийн шүүмжлэл.
САМОКРИТИ́ЧЕСКИЙ өөрийн шүүмжлэлтэй, өөрийгөө шүүмжилсэн.
САМОКРИТИ́ЧНО өөрийгөө шүүмжлэн.
САМОКРИТИ́ЧНЫЙ өөрийн шүүмжлэлтэй, өөрийгөө шүүмжилсэн.
САМОЛЁТ онгоц; **транспортный** ~ тээврийн нисэх онгоц; **~ истребитель** сөнөөгч онгоц.
САМОЛЁТОСТРОЕ́НИЕ нисэх онгоц үйлдвэрлэх.
САМОЛЁТОСТРОИ́ТЕЛЬНЫЙ нисэх онгоц үйлдвэрлэх, нисэх онгоцны.
САМОЛИ́ЧНО өөрийн биеэр, өөрөө биеэрээ.
САМОЛЮБИ́ВЫЙ биеэ тоосон, нэрээ их хичээдэг.
САМОЛЮ́БИЕ биеэ тоох, нэрээ их хичээх.
САМОМНЕ́НИЕ биеэ өргөх, биеэ тоох, би би гэх; **страдать ~м** биеэ хэтэрхий өргөх.
САМОНАДЕ́ЯННОСТЬ өөртөө найдах, биедээ эрэмших, бардам зан.
САМОНАДЕ́ЯННЫЙ өөртөө найддаг, биедээ эрэмшсэн, бардам; **~ ответ** бардам хариу.
САМООБЛАДА́НИЕ тэвчээр, биеэ барьж чадах, самбаа; **терять ~** тэвчээр алдах; **сохранить ~** самбаатай байх.
САМООБМА́Н биеэ мэхлэх, биеэ хуурах.
САМООБОРО́НА өөрийгөө хамгаалах.
САМООБРАЗОВА́НИЕ өөрийгөө боловсруулах, өөрөө сурах.
САМООБРАЗОВА́ТЕЛЬНЫЙ биеэ боловсруулах, өөрөө сурах.
САМООБСЛУ́ЖИВАНИЕ өөрийгөө үйлчлэх, өөртөө үйлчлэх.
САМООКУПА́ЕМОСТЬ зарлагаа нөхөх, зардлаа даах.
САМООКУПА́ТЬСЯ, САМООКУПИ́ТЬСЯ зарлагаа нөхөх, зардлаа даах.
САМООПРЕДЕЛЕ́НИЕ тусгаар тогтнох; **право наций на ~** үндэстний тусгаар тогтнох эрх.
САМООПРЕДЕЛЯ́ТЬСЯ байр суурьиа олох, биеэ даах.
САМООТВЕ́РЖЕННО амь бие хайргүй; **~ трудиться** бие хайргүй хөдөлмөрлөх *(ажиллах)*.
САМООТВЕ́РЖЕННОСТЬ амь биеийг үл хайрлах.
САМООТВЕ́РЖЕННЫЙ амь бие хайрлахгүй, өөрийг бодохгүй, баатарлаг; **~ поступок** баатарлаг үйл.
САМООТВО́Д өөрөө татгалзах.
САМООТРЕЧЕ́НИЕ өөрийн тусыг бодохгүй, бие хайргүй.
САМООЦЕ́НКА өөрийгөө үнэлэх, дүгнэн үзэх.
САМОПОЖЕ́РТВОВАНИЕ амиа өгөх, амь бие хайрлахгүй зүтгэх, юугаа ч хайрлахгүй байх.
САМОПРОИЗВО́ЛЬНО аяндаа, өөрөө.
САМОПРОИЗВО́ЛЬНОСТЬ аяндаа үүсэх, өөрөө гарах.
САМОПРОИЗВО́ЛЬН||ЫЙ аяндаа үүсэх, өөрөө гардаг; **~ые движения** өөрөө үүсэх хөдөлгөөн.
САМОРАЗВИ́ТИЕ 1. өөрийгөө боловсруулах, өөрөө боловсрох; 2. өөрөө хөгжих, дотоод хөгжил.
САМОРЕКЛА́МА биеэ магтах, өөрийгөө магтах.
САМОРО́ДНЫЙ 1. *(байгалийн)* бөөн, тунгаамал, цул, жинд; 2. угийн, төрөлхийн; **~ талант** төрөлхийн авьяас.
САМОРО́ДОК 1. *(байгалийн)* бөөн, цул; **~ металла** *(байгалийн)* цул төмөрлөг; 2. төрөлхийн авьяастай хүн, угийн авьяастай хүн; **писатель-~** төрөлхийн авьяастай зохиолч.
САМОСА́Д өөрийн тарьсан тамхи, гэрийн тамхи.
САМОСА́ДОЧН||ЫЙ 1. тунамал давстай; 2. тунамал; **~ая соль** тунамал давс.
САМОСВА́Л өөрөө буулгагч машин.
САМОСОЗНА́НИЕ ухамсар; **классовое ~** ангийн ухамсар.
САМОСОХРАНЕ́НИ||Е биеэ хамгаалах; **инстинкт ~я** биеэ хамгаалах зөн.
САМОСТОЯ́ТЕЛЬНО 1. тусгаар, толгой дааж, бие даан, тусгаар тогтнон; **жить ~** толгой дааж амьдрах; 2. эршүүд, толгой мэдэн; **~ вести себя** эршүүд загнах; **~ поступать** толгой мэдэн хийх; 3. өөрөө, толгойгоороо; **~ решить задачу** бодлого толгойгоороо бодох.
САМОСТОЯ́ТЕЛЬНОСТЬ 1. биеэ даасан байдал, тусгаар тогтнол; **политическая ~** улс төрийн бие даасан байдал; 2. толгой дааж хийсэн байх, бусдын нөлөөгүй байх, өөрийн байх; **~ работы** толгой дааж хийсэн ажил; **~ суждения** өөрийн бодол.
САМОСТОЯ́ТЕЛЬН||ЫЙ 1. тусгаар, биеэ даасан, тусгаар тогтносон; **~ое государство** тусгаар тогтносон улс; 2. эршүүд, толгой мэдэлтэй; **~ человек** толгой мэдэлтэй хүн; 3. өөрөө хийсэн, биеэ дааж хийсэн, бусдын нөлөөгүй, ажлын чадвар бүхий; **~ое сочинение** бусдын нөлөөгүй зохиол, биеэ даасан зохиол; **~ое население** ажлын чадвар бүхий хүн ам; * **~ое предложение** биеэ даасан өгүүлбэр.
САМОСТРЕ́Л сааль *(зэвсэг)*.
САМОСТРЕ́ЛЬНЫЙ өөрөө буудах.
САМОСУ́Д дур мэдэн шийтгэх.
САМОТЁК 1. өөрөө урсах, аяндаа гүйх; 2. аяндаа бүтэх, зөнд нь тавих.
САМОТЁКОМ 1. аяндаа урсан, өөрөө гүйж; 2. үрсгалаар, аяндаа, зөнд нь.
САМОУБИ́ЙСТВО амиа хорлох; **покончить жизнь ~м** амиа хорлох.

САМОУБИ́ЙЦА амиа хорлосон хүн.
САМОУВАЖЕ́НИЕ өөрийгөө хүндэтгэх.
САМОУВЕ́РЕННО өөртөө найдан, биедээ эрэмшин, биеэ би гэж.
САМОУВЕ́РЕННОСТЬ өөртөө найдах, биедээ эрэмших, биеэ би гэх.
САМОУВЕ́РЕННЫЙ өөртөө найдсан, биедээ эрэмшсэн.
САМОУНИЖЕ́НИЕ биеэ зориуд басах, өөрийгөө дор үзэх.
САМОУПРАВЛЕ́НИЕ 1. өөртөө засах эрх; 2. захиргаа; **местное** ~ нутгийн захиргаа.
САМОУПРА́ВНЫЙ дураар аашилсан, зоргоороо загнах; ~ **поступок** зоргоороо загнах явдал.
САМОУПРА́ВСТВО дураар аашлах, зоргоороо загнах.
САМОУПРА́ВСТВОВАТЬ дураар аашлах, зоргоороо загнах, дур зоргоор шийдэх.
САМОУСПОКОЕ́НИЕ сэтгэлээ тайвшруулах, амарлингуй болох.
САМОУЧИ́ТЕЛЬ өөрөө сурах бичиг.
САМОУ́ЧКА өөрөө сурсан хүн.
САМОХВА́ЛЬСТВО биеэ магтах.
САМОХО́ДНЫЙ өөрөө явагч.
САМОЦВЕ́Т туяат чулуу, гэрэлт чулуу, гялгар чулуу, зэндмэнэ; **уральские ~ы** Уралын туяат чулуу.
САМОЦВЕ́ТНЫЙ туяат, гэрэлт, гялгар; ~ **изумруд** туяат маргад.
САМОЦЕ́ЛЬ гагц зорилго.
САМОЧИ́НСТВО хууль бус явдал, дур зоргоороо аашлах.
САМОЧИ́НСТВОВАТЬ хууль бусаар аашлах, дур зоргоороо загнах.
САМОЧУ́ВСТВИЕ бие, лагшин, бие лагшин; **как ваше ~?** таны бие ямар байна?
САМШИ́Т нягт шар.
СА́М||ЫЙ 1. чухам, яг, мөн, мөнхүү; **в этом ~ом месте** яг энд, эгээ л энд; 2. бүр, яг, ид, жин; **с ~ого утра** бүр өглөөнөөс; 3. л, ч; 4. хамгийн, бүр, нэн; ~ **хороший** хамгийн сайн; **~ая малость** бүр өчүүхэн юм; * **в ~ом деле** үнэхээр, нээрээ; **на ~ом деле** үнэндээ; **в ~ раз** яг тааруулж, яг таарч.
САН хэргэм; **носить высокий** ~ их хэргэмтэй байх.
САНАТО́РИЙ сувиллын газар.
САНАТО́РНО-КУРО́РТНЫЙ аршаан сувиллын.
САНАТО́РНЫЙ сувиллын газрын; ~ **режим** сувиллын газрын дэглэм.
САНГВИ́НИК хурц авирт, түргэн аашгай.
САНДА́Л зандан.
САНДА́ЛИИ сандааль, сэрүүн шаахай.
СА́НИ чарга; **ехать в санях, ехать на санях** чаргаар явах.
САНИТА́Р санитарч, ариутгагч, асрагч.
САНИТАРИ́Я ариун цэвэр.
САНИТА́РКА санитарч эмэгтэй, ариутгагч эмэгтэй, асрагч эмэгтэй.
САНИТА́РНЫЙ ариун цэврийн; ~ **инспектор** ариун цэврийн байцаагч.
СА́НКИ чарга, явган чарга.
САНКЦИОНИ́РОВАТЬ батлах, зөвшөөрөх.
СА́НКЦИЯ 1. батламж, зөвшөөрөл; 2. **санкции** цээрлэл; **экономические** ~ эдийн засгийн цээрлэл.
СА́ННЫЙ чарганы, чарган; ~ **путь** чарган зам.
САНО́ВНИК амбан сайд, түшмэл.
СА́НОЧКИ бяцхан чарга.
САНСКРИ́Т санскрит, самгарди.
САНСКРИ́ТСКИЙ санскрит, самгарди, санскритийн, самгардийн.
САНТИМЕ́ТР 1. сантиметр *(метрийн зууны нэг)*; 2. сантиметртэй шугам, сантиметртэй тууз.
САНЧА́СТЬ *(санитарная часть)* ариун цэврийн анги.
САП сахуу, ям.
САПЁР сапёр, цэргийн барилгачин.
САПЁРНЫЙ сапёрын.
САПО́Г гутал, савхин гутал; **кожаные ~и** савхин гутал; * **два ~а пара** хоёр таарсан амьтан, ижил дугуй, өрөөсөн дугуй.
САПО́ЖНИК гуталчин.
САПО́ЖНИЧАТЬ гутал оёх, гуталчны ажил хийх.
САПО́ЖН||ЫЙ гутлын, гуталчны; **~ая щётка** гутлын сойз.
САПФИ́Р индранил *(эрдэнийн чулуу)*.
САРА́Й саравч, пин; ~ **для дров** түлээний пин.
САРАНЧА́ царцаахай; * **наброситься на что-нибудь, как** ~ хамаг юмыг цөлмөн сүйтгэх.
САРАФА́Н сарафан.
САРДЕ́ЛЬКА бүдүүн зайдас, зайдас.
САРДИ́НА сардин загас.
САРДОНИ́ЧЕСКИЙ ёжтой, зэвүүн; ~ **смех** ёжтой инээх.
САРКА́ЗМ ингүүхэн үг; **говорить с ~ом** ингүүхэн үг хэлэх.
САРКАСТИ́ЧЕСК||ИЙ ингүүхэн; **~ая улыбка** ингүүхэн инээмсэглэх.
САРКО́МА *мед.* холбогч эдийн хорт хавдар.
САРКОФА́Г чулуун авс, бунхан.
САРПИ́НКА сарепт даавуу.
САРЫ́Ч сар *(шувуу)*.
САТАНА́ шулам, шулмас.
САТАНИ́НСКИЙ 1. шулмын, шулмасын; 2. шулмасын, шулмын эрлэг.
САТЕЛЛИ́Т 1. дагуул; 2. хамсаа, хамсаатан.
САТИ́Н сатин *(даавуу)*.
САТИ́НОВЫЙ сатин.
САТИ́РА 1. хошигнол, шоолол, шог; 2. уран элэглэл.
САТИ́РИК уран элэглэгч.
САТИРИ́ЧЕСКИЙ уран элэглэлийн; ~ **роман** уран элэглэлийн роман.
САТРА́П 1. эртний Персийн засаг ноён; 2. эзэрхэг этгээд.
САТУ́РН санчир, бямба.
САФЬЯ́Н 1. торгон илэг; 2. бухаар.
САФЬЯ́НОВ||ЫЙ торгон илгэн; **~ые сапоги** торгон илгэн гутал.
СА́ХАР чихэр; **чай с ~ом** чихэртэй цай; **~рафинад** ёотон; ~ **в крови** цусны чихэр.
САХАРИ́Н сахарин, чихрийн оронцог.
САХАРИ́СТЫЙ чихэрлэг; ~ **вкус** чихэрлэг амт.
СА́ХАРИТЬ чихэрлэх, чихэр хийх, чихэр хийцлэх.
СА́ХАРНИЦА чихрийн сав.
СА́ХАРН||ЫЙ 1. чихрийн; ~ **песок** элсэн чихэр; ~ **завод** чихрийн үйлдвэр; 2. зулгуйч; **~ые речи** зулгуйч үг.
САЧО́К шүүрэн ховоо.
СБА́ВИТЬ 1. бууруулах, буулгах, саах; ~ **цену** үнэ бууруулах, үнэ саах; 2. бууруулах, татуулах, дарах; ~ **спеси** омгийг нь дарах; 3. багасгах, хасах; 4. багасах, хасагдах, шуугдах; ~ **в весе** бие шуугдах.
СБАВЛЯ́ТЬ 1. бууруулах, буулгах, саах; 2. бууруулах, татуулах, дарах; 3. багасгах, хасах; 4. багасах, хасагдах.
СБАЛАНСИ́РОВАТЬ жигдрүүлэх, баланс гаргах.
СБА́ЛТЫВАТЬ хутгах, холих.
СБЕ́ГАТЬ очоод ирэх, яваад ирэх.
СБЕГА́ТЬ 1. гүйн буух; 2. зуггах, оргох, босох, алга болох; 3. болих, байх.
СБЕГА́ТЬСЯ цугларах, гүйлдэн ирэх, хуралдах.

СБЕЖА́||ТЬ 1. гүйн буух; ~ **с лестницы** шатаар гүйж буух; 2. зугтах, оргох, босох, алга болох; 3. болих, байх; **улыбка ~ла с его лица** тэр инээмсэглэхээ болив.

СБЕЖА́ТЬСЯ цугларах, гүйлдэн ирэх, хуралдах; ~ **на крик** хашгирахад гүйлдэн ирэх.

СБЕРЕГА́ТЕЛЬН||ЫЙ хадгаламжийн; **~ая книжка** хадгаламжийн дэвтэр, ~ **сертификат** хадгаламжийн гэрчилгээ.

СБЕРЕГА́ТЬ 1. хадгалах, гамтай байлгах, гамнах; 2. хамгаалах; 3. хуримтлуулах, хэмнэх, гамнаж хадгалах.

СБЕРЕЖЕ́НИЕ 1. хуримтлуулах, хэмнэх, нөөх, гамнах; 2. **сбережения** хуримтлуулсан мөнгө.

СБЕРЕ́ЧЬ 1. хадгалах, гамтай байлгах, гамнах; 2. гамнах, хамгаалах; 3. хуримтлуулах, хэмнэх, гамнан хадгалах; ~ **некоторую сумму денег** жаахан мөнгө хуримтлуулах.

СБЕРКА́ССА *(сберегательная касса)* хадгаламжийн касс.

СБЕРКНИ́ЖКА *(сберегательная книжка)* хадгаламжийн дэвтэр.

СБИВА́ТЬ 1. цохиж унагах, ховх цохих, дайрч унагах; 2. буудаж унагах, сөнөөх; 3. майжийлгах, майжиг болгох; 4. бүлэх; 5. эвлэрүүлэх; 6. самууруулах, самгардуулах, алдуулах, бууруулах, дарах.

СБИВА́ТЬСЯ 1. хэлтийх, ойчих, хөдлөх; 2. майжийх, майжиг болох; 3. өрөмтөх, ялгарах; 4. самуурах, будлих, алдах; 5. овоорох, бөөгнөрөх; 6. төөрөх, зүг алдах.

СБИ́ВЧИВО будилж, самуурч; ~ **говорить** ярихдаа будлих.

СБИ́ВЧИВОСТЬ будлиантай байх, самуурсан байх; ~ **показаний** будлиантай мэдүүлэг, мэдүүлэхдээ будлих.

СБИ́ВЧИВЫЙ будлиантай, будилсан, самуурсан; ~ **ответ** будилсан хариу.

СБИТЬ 1. цохиж унагах, ховх цохих, дайрч унагах; ~ **с ног** дайрч унагах; 2. буудаж унагах, сөнөөх; 3. майжийлгах, майжиг болгох, элээх; ~ **каблуки** гутлынхаа өсгийг майжийлгах; 4. бүлэх; ~ **масло** тос бүлэх; 5. эвлүүлэх; ~ **ящик из досок** банзаар хайрцаг эвлүүлэх; 6. самууруулах, самгардуулах, алдуулах; ~ **с толку** самууруулах; 7. бууруулах, дарах; ~ **цену** үнэ бууруулах.

СБИ́||ТЬСЯ I 1. хэлтийх, ойчих, хөдлөх; **повязка ~лась** боолт нь ойчив, боолт нь хөдлөв; 2. майжийх, майжиг болох, элэх; **каблуки ~лись** гутлын өсгий майжийв; 3. самуурах, будлих, алдах; ~ **в показаниях** мэдүүлэхдээ самуурах; 4..төөрөх, алдах; ~ **с дороги** төөрөх; * ~ **с ног** ядарч ойчиход хүрэх.

СБИ́||ТЬСЯ II 1. өрөмтөх, ялгарах; **масло ~лось** тос өрөмтөв; 2. овоорох, бөөгнөрөх.

СБЛИЖА́ТЬ 1. ойртуулах, ойр болгох; 2. ойр дотно болгох, дотно болгох, нөхөрлөх.

СБЛИЖА́ТЬСЯ 1. ойртох, ойр болох; 2. ойролцоо болох, адилавтар болох; 3. нөхөрлөх, найзлах, дотно болох.

СБЛИЖЕ́НИЕ ойртох, ойр болох, нөхөрлөх, найзлах; **дружеское** ~ ойртож нөхөрлөх.

СБЛИ́ЗИТЬ 1. ойртуулах, ойр болгох; ~ **ножки циркуля** гортигийн хөлийг ойртуулах; 2. ойр дотно болгох, дотно болгох, нөхөрлөх.

СБЛИ́ЗИ||ТЬСЯ 1. ойртох, ойр болох; 2. ойролцоо болох, адилавтар болох; **взгляды ~лись** үзэл ойролцоо болов; 3. нөхөрлөх, найзлах, дотно болох; **дети быстро ~лись** хүүхдүүд түргэн найзлав.

СБОЙ I толгой, шийр, гэдэс дотор.

СБОЙ II хэлтийх.

СБО́КУ 1. хажууд; **стать** ~ хажууд зогсох; 2. хажуугаас, хажуу талаас; **смотреть** ~ хажуу талаас нь харах.

СБОЛТА́ТЬ хутгах, холих, хольж хутгах.

СБОЛТНУ́ТЬ хэлчхэх, үг алдах, чалччихах; ~ **глупость** дэмий юм чалччихах.

СБОР 1. хураах, түүх; ~ **урожая** тариа хураах; 2. татвар, татсан мөнгө; **таможенный** ~ гаалийн татвар; 3. цуглах, цугларах, цуглуулах, цуглаан; ~ **информации** мэдээлэл цуглуулах; 4. түр цэрэг татах; 5. цугларах дохио; **бить** ~ цугларах дохионы хэнгэрэг дэлдэх, цуглах дохио өгөх; 6. **сборы** төхөөрөх; ~ **в дорогу** юманд явахаар төхөөрөх; * **все в ~е** бүгд цуглажээ.

СБО́РИЩЕ овооролдсон цуглаан, сүрэг.

СБО́РКА 1. эвлүүлэх, угсрах, угсралт; ~ **машины** машин угсрах; 2. хуниас.

СБО́РНИК, эмхтгэл; ~ **статей** өгүүллийн эмхтгэл; ~ **цен** үнийн эмхтгэл.

СБО́РН||ЫЙ 1. цуглах, цугларах; ~ **пункт** цуглах газар; 2. угсармал, эвлүүлсэн, түүвэр; ~ **дом** угсармал байшин; 3. шигшээ; **~ая футбольная команда** хөл бөмбөгийн шигшээ баг.

СБО́РОЧНЫЙ угсрах; ~ **цех** угсрах тасаг.

СБО́РЩИК 1. татвар хураагч; 2. угсрагч; ~ **двигателей** хөдөлгүүр угсрагч.

СБРА́СЫВАНИЕ хаях, тайлж хаях, унагаах.

СБРА́СЫВАТЬ 1. хаях, унагаах, буулгах; 2. тайлж хаях, хуу татан хаях, хуулан хаях; 3. түлхэн унагах, устгах; 4. унагах, гээх, гүвэх.

СБРИВА́ТЬ хусах, авах.

СБРИТЬ хусах, авах; ~ **бороду** сахлаа авах.

СБРОД муусайн хүн, новш, шаар; **всякий** ~ элдэв муусайн хүн.

СБРОС хаях, зөрөг, хаягдал.

СБРО́СИ||ТЬ 1. хаях, унагаах, буулгах; 2. тайлж хаях, хуу татан хаях, хуулан хаях; 3. түлхэн унагах, унагах; 4. унагах, гээх, гүвэх; **деревья ~ли летний наряд** мод зуныхаа өмсгөлийг гээв, мод навчсаа гээв; * ~ **со счетов** тоохоо болих; ~ **маску** хоёр нүүр гаргахаа болих, жинхэнэ нүүр царайгаа харуулах.

СБРО́СИТЬСЯ 1. үсэрч буух, харайж буух; 2. мөнгөө нийлүүлэх.

СБРУ́Я тоног.

СБРЫ́ЗГИВАТЬ,

СБРЫ́ЗНУТЬ үсэргэх, шүрших, цацах.

СБЫВА́ТЬ I 1. борлуулах, худалдах; 2. далд оруулах, салах.

СБЫВА́ТЬ II татрах.

СБЫВА́ТЬСЯ бүтэх, биелэх,гүйцэлдэх.

СБЫТ борлуулах, худалдах, борлуулалт, худалдаа; **рынки ~а** борлуулах зах зээл; ~ **товаров** бараа борлуулалт, бараа борлуулах.

СБЫТОВО́Й борлуулах, худалдах, худалдааны.

СБЫТЬ I 1. борлуулах, худалдах; ~ **много товаров** их бараа борлуулах; 2. далд оруулах, салах.

СБЫ||ТЬ II татрах, татах; **вода в реке ~ла** голын ус татрав.

СБЫ||ТЬСЯ бүтэх, биелэх, гүйцэх; **надежды мои ~лись** санасан хэрэг минь бүтэв.

СВА́ДЕБН||ЫЙ хуримын; **~ые обряды** хуримын ёслол; **~ые песни** хуримын дуу.

СВА́ДЬБ||А хурим, төр, хурим төр; **справлять ~у** хурим хийх.

СВА́ЙН||ЫЙ шонт, шон дээр барьсан, тулгат, тулга дээр барьсан; **~ые постройки** шонт барилга, тулгат барилга.

СВА́ЛИВАТЬ 1. унагах, хаях; 2. хаях, овоолох; 3. түлхэх, тохох; 4. багасах, буух.

СВА́ЛИВАТЬСЯ I 1. унах, ойчих; 2. хэвтэх, өвдөх.

СВА́ЛИВАТЬСЯ II ширэлдэх.

СВАЛЙ||ТЬ 1. унагах, хаях; **ветер ~л дерево** салхинд мод унав; 2. хаях, овоолох; ~ **дрова в кучу** түлээ овоолох; 3. түлхэх,

тохох; ~ **ответственность на другого** хариуцлагыг хүн рүү түлхэх; 4. багасах, буурах.

СВАЛИ́||ТЬСЯ 1. унах, ойчих; **дерево ~лось** мод унав; 2. хэвтэх, өвдөх.

СВА́ЛК||А 1. унагах, хаях; 2. хог хаях газар, хог; **выбросить на ~у** хог дээр хаях.

СВАЛЯ́ТЬ бөөрөнхийлөх, дарах, хийх; ~ **войлок** эсгий хийх; * ~ **дурака** тэнэглэх.

СВАЛЯ́||ТЬСЯ ширэлдэх; **у лошади грива ~лась** морины дэл ширэлдчихжээ.

СВА́РИВАТЬ 1. чанах, болгох, хийх; 2. ширээх, гагнах.

СВАРИ́ТЬ 1. чанах, болгох, хийх; ~ **курицу** тахианы мах чанах; ~ **суп** шөл хийх; 2. ширээх, гагнах.

СВАРИ́||ТЬСЯ 1. болох, чанагдах; **суп ~лся** шөл болов; 2. ширээгдэх, гагнагдах.

СВА́РКА ширээх, гагнах, ширээлт, гагналт.

СВАРЛИ́ВОСТЬ гэмэргэн зан, яншаа зан, хэрүүлч зан.

СВАРЛИ́ВЫЙ гэмэргэн, яншаа, хэрүүлч.

СВАРН||О́Й ширээмэл, гагнасан; **~ое соединение** гагнасан залгаас.

СВА́РОЧН||ЫЙ ширээх, гагнах; **~ые работы** ширээх ажил.

СВА́РЩИК гагнуурчин.

СВА́СТИКА хас тэмдэг.

СВАТ 1. зууч; 2. худ.

СВА́ТАТЬ 1. зуучлах, зууч болох, хадамлах; 2. хүүхэн гуйх.

СВА́ТАТЬСЯ хүүхэн гуйх, хадамлах; ~ **за дочь соседа** айлынхаа охиныг гуйх.

СВАТОВСТВО́ хүүхэн гуйх, хадамлах.

СВА́ХА зууч эхнэр, худгай.

СВА́||Я шон, тулга; **забить ~и** шон шаах.

СВЕ́ДА *бот.* бударга.

СВЕ́ДЕНИ||Е 1. мэдэх, мэдэгдэх; **довести до чьего-либо ~я** хүнд мэдэгдэх, сонорт хүргэх; **принять к ~ю** мэдэж авах, анхаарах; 2. мэдээ, сураг; 3. мэдлэг; 4. мэдээ, тайлан.

СВЕ́ДУЩИЙ мэддэг, мэдлэг ихтэй, мэдэх; ~ **человек** мэдлэг ихтэй хүн.

СВЕЖЕВА́ТЬ гэдэс дотрыг нь гаргах.

СВЕЖЕИСПЕЧЁННЫЙ 1. сая болгосон, халуун, шинэ; ~ **хлеб** халуун талх, сая болгосон талх; 2. сая болсон, цэл *ногооноороо* байгаа.

СВЕ́ЖЕСТ||Ь 1. шинэ; **не первой ~и** хуучрах янз орсон.; 2..сэрүү; ***пахнуло ~ью*** сэрүү татав.

СВЕЖЕ́||ТЬ 1. сэрүүн болох, сэрүү орох, жихүүн болох, жихүүрэх; **ветер ~ет** *салхи жихүүн болж байна*; 2. царай орох, өнгө орох.

СВЕ́Ж||ИЙ 1. *шинэ*; **~ее мясо** *шинэ мах*; 2. *давслаагүй*; ~ **огурец** давслаагүй хэмх; 3. цэвэр, эрүүл; ~ **воздух** цэвэр агаар, эрүүл салхи; 4. *сэрүүн, жихүүн, хүйтэн*; ~ **ветер** *жихүүн салхи*; 5. цэвэр, угаагаад өмсөөгүй; **~ее бельё** цэвэр дотуур хувцас; 6. шинэ, саяын, *сая гарсан, сая олсон*; **~ая газета** *шинэ сонин*; 7. хуучраагүй; 8. эрүүл саруул, ануухан; ~ **цвет лица** эрүүл саруул царай; ~ **вид** ануухан харагдах; 9. *шинэ, сүүлийн*; ~ **номер газеты** шинэ сонин, сонины сүүлийн дугаар; 10. шинэ, ядарч зүдрээгүй, тэнхээ орсон; **со ~ими силами** тэнхээ орж.

СВЕЗТИ́ 1. тээж аваачих, хүргэх; ~ **больного в больницу** өвчтөнийг эмнэлэгт хүргэх; 2. буулгах; ~ **с горы** *уулнаас* буулгах; 3. гаргаж аваачих, гаргах.

СВЁКЛА улаан манжин, алаг лууван; **столовая ~** улаан манжин; **сахарная ~** чихрийн манжин; **кормовая ~** малын тэжээлийн манжин.

СВЕКЛОВИ́ЧНЫЙ чихрийн луувангийн.

СВЕКЛОВО́ДСТВО алаг лууван тарих.

СВЕКО́ЛЬН||ЫЙ алаг луувангийн; **~ая ботва** алаг луувангийн иш навч.

СВЁКОР хадам эцэг, хадам аав, *нөхрийн аав*.

СВЕКРО́ВЬ хадам эх, хадам ээж, нөхрийн ээж.

СВЕРГА́ТЬ 1. түлхэн унагах, авч хаях, буулгах; 2. түлхэн унагах, устгах.

СВЕ́РГНУТЬ 1. түлхэн унагах, авч хаях, буулгах; 2. түлхэн унагах, устгах.

СВЕРЖЕ́НИЕ түлхэн унагах, устгах.

СВЕ́РИТЬ тулган үзэх, нийцүүлэн хянах, тулгах, нийлүүлэх; ~ **копию с подлинником** хуулбарыг эхтэй нь тулган үзэх.

СВЕ́РКА 1. нийлүүлэх, тулгах; 2. хянах, даралт хуудас.

СВЕРКА́НИЕ гялалзах, цахилах, гялбах; ~ **молнии** цахилгаан цахилах.

СВЕРКА́||ТЬ 1. гялганах, гялтганах, гялталзах, гялалзах, цахилах, гялбах; **~ют звёзды** од гялалзаж байна; 2. гялганах, гялалзах; **глаза ~ли гневом** уурлаж нүд нь гялалзав, уур нь хүрэв.

СВЕРКНУ́||ТЬ 1. гялсхийх, цахилах, гялбах; **~ла молния** цахилгаан гялсхийв; 2. дотор орох; **~ла мысль** бодол дотор оров.

СВЕРЛЕ́НИЕ өрөмдөх, нүхлэх.

СВЕРЛИ́ЛЬНЫЙ өрөмдөх; ~ **станок** өрөмдөх суурь машин.

СВЕРЛИ́ТЬ өрөмдөх, нүхлэх; ~ **отверстие в доске** банз өрөмдөж нүхлэх.

СВЕРЛО́ВОЧНЫЙ өрөмдөх, өрөмддөг.

СВЕРЛО́ВЩИК өрөмдөгч.

СВЕРНУ́||ТЬ 1. хуйлах, хуйлж эвхэх, ороож эвхэх, ороох; ~ **ковёр** хивс хуйлах; ~ **папиросу** тамхи ороох; 2. хумих, хумхих; **цветы ~ли свои лепестки** цэцэг дэлбээгээ хумив; 3. цомтгох, багасгах; ~ **производство** үйлдвэрлэлийг цомтгох; 4. эргэх, хазайх, гарах, гажих; ~ **с дороги** замаас хазайх, замаас гарах; * ~ **шею** хүзүүгээ булгалах.

СВЕРНУ́||ТЬСЯ 1. хуйрах, хуйлагдах, хуйлран эвхрэх, хумирах, этийх; 2. цагариглан хэвтэх, атирах; **кошка ~лась клубком** муур цагариглан хэвтэв; 3. бүлэгнэх, нөжрөх, бүрэлдэх, ээдэх, язармагтах; **молоко ~лось** сүү ээдэв; **кровь ~лась** цус нөжрөв; 4..цомтох, багасах.

СВЕРСТА́ТЬ үсэг өрсний дараа хуудсуудаар хуваарилах.

СВЕ́РСТНИК үеийн хүн, чацуу хүн, үетэн, чацуутан.

СВЕ́РСТНИЦА үеийн эмэгтэй, чацуу эмэгтэй.

СВЁРСТЫВАТЬ үсэг өрсний дараа хуудсуудаар хуваарилах.

СВЁРТОК боодол, боолттой юм.

СВЁРТЫВАНИЕ 1. хуйлах, хуйлж эвхэх, ороох; 2. цомтгох, багасгах; 3. бүлэгнэх, нөжрөх, бүрэлдэх, ээдэх, язармагтах; ~ **крови** цус бүлэгнэх.

СВЁРТЫВАТЬ 1. хуйлах, хуйлж эвхэх, ороож эвхэх, ороох; 2. хумих, хумхих; 3. цомтгох, багасгах; 4. эргэх, гарах, хазайх, гажих.

СВЁРТЫВАТЬСЯ 1. хуйлрах, хуйлагдах, хуйлран эвхрэх, хумирах, этийх; 2. цагариглан хэвтэх, атирах; 3. бүлэгнэх, нөмрөх, бүрэлдэх, ээдэх, язармагтах; 4. цомтох, багасах.

СВЕРХ 1. дээр, дээгүүр; 2. гадуур, гадна, илүү давуулсан, *хэтэрсэн*; **расходы ~ сметы** төсвөөс хэтэрсэн зардал; 3. гадна; 4. үгүй байтал; ~ **всякого ожидания** огт санаанд үгүй байтал.

СВЕРХМО́ЩНЫЙ хэт хүчтэй, үлэмж хүчтэй; ~ **двигатель** хэт хүчтэй хөдөлгүүр.

СВЕРХНОРМАТИ́ВНЫЙ *нормоос илүү*.

СВЕРХПЛА́НОВЫЙ төлөвлөгөөнөөс гадуур хийсэн, *төлөвлөснөөс илүү гүйцэтгэсэн, төлөвлөгөөнөөс давуу*.

СВЕРХПРИ́БЫЛЬ илүү ашиг, хэт ашиг.

СВЕРХСКОРОСТНО́Й *хэт хурдан*.

СВЕРХСРО́ЧН||ЫЙ 1. улирсан хугацаа, хэтэрсэн хугацаа, дууссан хугацаанаас илүү; **~ая военная служба** хугацаанаас илүү цэргийн алба хаах, цэргийн албанд улирах; 2. маш яаралтай, хэт яаралтай; **~ое задание** маш яаралтай даалгавар.

СВЕ́РХУ 1. дээр, дээгүүр, өнгөнөөсөө, өнгөн талаасаа; **жир плавает ~** дээр нь тос хөвнө; 2. дээрээс; **вторая строка ~** дээрээс хоёрдохь мөр; 3. дээрээс, өндөр дээрээс; **вид ~** өндөр дээрээс харагдах байдал; 4. дээд газраас гаргасан, дээд газрын, дээрээс гаргасан; **директива ~** дээд газрын удирдамж.

СВЕРХУРО́ЧН||ЫЙ 1. илүү цагийн, ажлын цагаас гадуур; **~ая работа** илүү цагийн ажил; 2. **сверхурочные** илүү цагийн ажлын хөлс.

СВЕРХЧЕЛОВЕ́ЧЕСКИЙ хүний хэмээс хэтэрсэн, дааж давшгүй; **~ труд** дааж давшгүй хөдөлмөр.

СВЕРХЪЕСТЕ́СТВЕНН||ЫЙ 1. ид шидэт, ирд хувилгааны; **~ые силы** ирд хувилгааны хүчин; 2. ер бусын, гайхамшигт; **~ая скорость** ер бусын хурд.

СВЕРЧО́К хүрэлзгэнэ.

СВЕРША́ТЬ бүтээх, үйлдэх, гүйцэтгэх.

СВЕРША́ТЬСЯ бүтэх, гүйцэлдэх, дайрах, учрах.

СВЕРШИ́ТЬ бүтээх, үйлдэх, гүйцэтгэх.

СВЕРШИ́ТЬСЯ бүтэх, гүйцэлдэх, дайрах, учрах.

СВЕРЯ́ТЬ тулган үзэх, нийлүүлэн хянах, тулгах нийлүүлэх.

СВЕРЯ́ТЬСЯ тулган үзэх.

СВЕ́СИТЬ унжуулах; **~ ноги** хөлөө унжуулах.

СВЕ́СИ||ТЬСЯ унжих; **через забор ~лись ветви дерева** модны мөчир хашаан дээгүүр унжина.

СВЕСТИ́ 1. буулгах, хөтөлж буулгах; 2. зайлуулах, хөтөлж зайлуулах; 3. хүргэж өгөх, аваачиж өгөх; 4. арилгах; **~ бородавку** үү арилгах; 5. нийлүүлэх, ойртуулах, шахах; 6. нэг дор авчрах, цуглуулах, бөөгнөрүүлэх; 7. уулзуулах, учруулах; **~ друзей** найз нарыг уулзуулах; 8. танилцуулах, ханилуулах, болгох, танилцах, ханилах, болох; **~ знакомство с кем-либо** хүнтэй танилцах, танил болох; 9. хуулах, буулгах; **~ рисунок на кальку** зургийг гэрэлтүүлэх, цаасан дээр буулгах; 10. нэгтгэх, дүгнэх; **~ данные в таблицу** баримтыг нэгтгэн хүснэгтлэх; 11. хязгаарлах, хэмжээлэх, товчлох, болгох; 12. чиглүүлэх, оруулах; **~ разговор на вчерашний случай** яриагаа өчигдрийн явдал руу чиглүүлэх; 13. огтлох, хядах; 14. татах; **судорогой свело ногу** хөлийн шөрмөс татав; *** ~ концы с концами** дөнгөж данган болж байх, чуутай чаатай амьдрах; **~ счёты с кем-либо** хүнээс хариугаа авах; **~ с ума** галзууруулах, солиоруулах, ухаан алдуулах.

СВЕСТИ́СЬ 1. буулгагдах; 2. хязгаарлагдах, хэмжээлэгдэх, болж дуусах; **дело свелось к пустякам** хэрэг шалигүй юм болж дуусав.

СВЕТ I 1. гэрэл, гэгээ; **солнечный ~** нарны гэрэл; **преломление ~а** гэрэл хугарах; 2. дэн, гэрэл; **зажечь ~** гэрэл бариx, дэн бариx; 3. гэрэлтэй газар, гэрэл; **выйти на ~** гэрэлтэй газар гарах; 4. гэгээ, үүр; **чуть ~** хар өглөөгүүр; 5. гэрэл, туяа; **ученье — ~, а неученье — тьма** сурсан нь далай, сураагүй нь балай; *** в ~е чего-либо** үүднээс үзэхэд; **пролить ~ на что-либо** тайлбарлах, ойлгомжтой болгох; **представить что-либо в мрачном ~е** юмыг муу талаас нь харуулах.

СВЕТ II 1. дэлхий, ертөнц, одон орон; **страны ~а** дөрвөн зүг; **части ~а** зургаан тив; **путешествие вокруг ~а** дэлхийг тойрон жуулчлах; 2. хүн, олон нийт; **всему ~у это известно** үүнийг хүн бүхэн мэднэ; 3. дээд нийгэмлэг, язгууртны хүрээ; *** белый ~** алтан дэлхий, нарт ертөнц; **произвести на ~** хүн болгож төрүүлэх; **явиться на ~, увидеть ~** хүн болон төрөх, хүний биеийг олох, төрөх, нийтлэгдэх, буй болох; **сжить со ~а** тонилгох; **более всего на ~е** хамгаас илүү; **ни за что на ~е** яасан ч, яалаа ч гэсэн, юу болсон ч; **тот ~** хойт нас; **отправить на тот ~** талийгаач болгох; **отправиться на тот ~** талийгаач болох; **на край ~а** газрын мухарт.

СВЕТА́ТЬ үүр цайх, гэгээрэх, үүр гийх, үүрийн хяраа шарлах.

СВЕТЕ́ЛКА гэгээн тасалгаа.

СВЕТИ́ЛО 1. од; **движение небесных светил** огторгуйн одны хөдөлгөөн; 2. алдарт зүтгэлтэн, гэгээн эрдэмтэн; **~ науки** шинжлэх ухааны алдарт зүтгэлтэн.

СВЕТИ́ЛЬНИК 1. зул, тосон дэн; 2. гийгүүлэгч.

СВЕТИ́ТЬ 1. гэрэлтэх, гийх; 2. гэрэлтүүлэх, гэрэл барьж өгөх; **~ кому-либо фонарём** хүнд дэнлүү барьж өгөх.

СВЕТИ́||ТЬСЯ 1. гялалзах, гэрэлтэх, гэрэл гаргах; **тускло ~тся луна в сумраке тумана** манан бүрэнхийлээд сар бүдэг гэрэлтэнэ; 2. гялалзах; **в глазах ~лась радость** баярлаж нүд нь гялалзаж байв.

СВЕТЛЕ́||ТЬ 1. гэгээ орох, гэгээн болох, гэгээрэх; **небо над горизонтом ~ет** тэнгэрийн хаяа гэгээрч байна; 2. гэгээрэх, саруул болох, үүр цайх; **на улице ~ет** гадаа саруул болж байна; 3. гялалзаж харагдах; 4. саруул болох; **ум ~ет** ухаан саруул болов.

СВЕТЛЕ́ТЬСЯ гялалзан харагдах, гялалзах.

СВЕТЛИ́ЦА саруул тасалгаа, зочдын өрөө.

СВЕТЛО́ 1. саруул, гэгээн, гэрэлтэй, гэрэл сайтай; 2. саруул байх, гэгээн байх, гэрэлтэй байх; **на дворе ~** гадаа гэрэлтэй байна.

СВЕ́ТЛ||ЫЙ 1. гэгээн, гэрэлтэй; 2. саруул, гэгээн, гэрэлтэй; **~ая комната** саруул тасалгаа; 3. хурц, гялгар, гялалзсан; **~ огонёк** гялалзсан гал; 4. тунгалаг, цэвэр; **~ ручеёк** тунгалаг булаг; 5. цайвар, цэгээн, бүдэг, шингэн; **~ костюм** цайвар хувцас; 6. гэгээн, гэрэлт, саруул; **~ое будущее** гэгээн ирээдүй; 7. саруул; **~ ум** саруул ухаан.

СВЕТЛЯЧО́К галт хорхой.

СВЕТОВ||О́Й 1. гэрлийн; **~ые волны** гэрлийн долгио; **~ раздражитель** гэрлийн цочроогч; 2. гэрэл, цахилгаан гэрлээр хийсэн; **~ сигнал** гэрэл дохио.

СВЕТОЛЕЧЕ́НИЕ гэрлээр эмнэх, гэрэл засал.

СВЕТОЛЮБИ́В||ЫЙ гэрэлд дуртай, наранд ургадаг; **~ые растения** наранд ургадаг ургамал.

СВЕТОМАСКИРО́ВКА гэрэл далдлах, халхлах.

СВЕТОНЕПРОНИЦА́ЕМЫЙ гэрэл нэвтрэхгүй.

СВЕТОПРЕСТАВЛЕ́НИЕ галав юүлэх.

СВЕТОСИ́ЛА гэрлийн хүч.

СВЕТОТЕ́ХНИКА гэрлийн техник.

СВЕТОФИ́ЛЬТР гэрлийн шүүр.

СВЕТОФО́Р *(замын)* гэрэл дохио.

СВЕ́ТОЧ соён гийгүүлэгч, түгээгч.

СВЕТОЧУВСТВИ́ТЕЛЬН||ЫЙ гэрэлд эмзэг, гэрэл мэдрэх; **~ая плёнка** гэрэлд эмзэг хальс.


СЛЫТЬ цууд гарах, цуутай байх, нэртэй байх, хэлцэх; ~ **любителем музыки** хөгжимд дуртай хүн гэж хэлцэх.

СЛЫХА́ТЬ дуулдах; **о нём ничего не** ~ түүний тухай юу ч дуулдахгүй байна.

СЛЫ́ШАТЬ 1. *дуулдах, сонсох*; **плохо** ~ **звуки** авиа муу сонсох; 2. сураг дуулах, сонсох, хэл авах; 3. анзаарах, мэдрэх, мэдэх, үнэртэх.

СЛЫ́ШАТЬСЯ 1. сонсдох, дуулдах; **слышится музыка** хөгжим сонсдож байна; 2. мэдэгдэх, илэрхий байх, ил байх.

СЛЫ́ШИМОСТЬ сонсдох, дуулдах, сонсдоц, дуулдац.

СЛЫ́ШНО 1. сонсдох, дуулдах; **отсюда хорошо** ~ эндээс сайн сонсодно; 2. сонсдох, сураг байх, чимээ байх; **о нём давно ничего не** ~ түүнээс хэдийнээ сураг алга байна; 3. гэлцэх, хэлцэх; **~, что будет обильный урожай** элбэг ургац гарна гэлцэнэ.

СЛЫ́ШНЫЙ 1. сонсдох, дуулдах; **еле** ~ **голос** сонсдох төдий дуу; 2. **слышен** сонсдож байх, сонсдох; **слышны выстрелы** буун дуу сонсдож байна.

СЛЮДА́ гялтгануур.
СЛЮДЯНО́Й гялтгануурын, гялтгануур.
СЛЮН||А́ шүлс; ***глотать ~и** шүлсээ залгих.
СЛЮНИ́ТЬ шүлсдэх, шүлс түрхэх; ~ **пальцы** хуруугаа шүлсдэх.
СЛЮ́НК||А шүлс; **~и текут** шүлс асгармаар.
СЛЮ́НН||ЫЙ шүлсний; **~ые железы** шүлсний булчирхай.
СЛЮНОТЕЧЕ́НИЕ шүлс асгарах, шүлс гоожих.
СЛЮНЯ́ВИТЬ шүлсдэх.
СЛЮНЯ́ВЫЙ шүлсээ савируулсан, шүлсээ гоожуулсан, шүлсдсэн, шүлхий.
СЛЯ́КОТЬ шавар, шавхай, шавар шавхай; **осенняя** ~ намрын шавхай.
СМА́ЗАТЬ 1. түрхэх, - дах *(- дэх, - дох, - дөх);* ~ **йодом** йод түрхэх, йодлох; 2. бүрхэгдүүлэх, балархай болгох; ~ **вопрос** асуудал бүрхэгдүүлэх; 3. хахууль өгөх.
СМА́ЗКА 1. тослох, тосдох, тосолгоо; ~ **замков** цоож тослох; 2. түрхэх тос; ~ **для лыж** цананд түрхэх тос.
СМАЗЛИ́В||ЫЙ хөөрхөн, цэвэрхэн; **~ое личико** хөөрхөн царай.
СМА́ЗОЧН||ЫЙ түрхэх, тослох; **~ое масло** түрхэх тос; ~ **аппарат** тослох аппарат.
СМА́ЗЫВАНИЕ 1. түрхэх, тослох, тосдох; 2. бүрхэгдүүлэх.
СМА́ЗЫВАТЬ 1. түрхэх, тосдох, тослох, - дах *(- дэх, - дох, - дөх);* 2. бүрхэгдүүлэх, балархай болгох.
СМАК 1. амт; **есть что-либо со ~ом** юм амтархан идэх; 2. бах; **рассказывать что-либо со ~ом** юмыг бах болгон ярих; 3. учир, сонин, хошин; **понять весь ~ этого рассказа** өгүүллэгийн бүх учрыг ойлгох.
СМАКОВА́ТЬ 1. амтархах, амтархан идэх, тамшаах; ~ **каждый глоток** балга балгаар амтархан уух; 2. сонирхох, бах болгох, сонирхон унших, бахдан үзэх, бах болгон ярих; ~ **новость** сонин зүйлийг бах болгон ярих.
СМАЛОДУ́ШНИЧАТЬ зүрх алдах, зориг шантрах, зүрх үхэх.
СМА́НИВАТЬ 1. даллаж цуглуулах, юмаар хуурч барих; 2. олзуурхуулан аваачих, хуурч авчрах, олзуурхуулан оруулах.
СМАНИ́ТЬ 1. даллаж цуглуулах, юмаар хуурч барих; 2. олзуурхуулан аваачих, хуурч авчрах, олзуурхуулан оруулах.
СМАСТЕРИ́ТЬ дархлах, урлах.
СМА́ТЫВАТЬ 1. ороох, эвхэх; 2. задлах, цувах.
СМА́ХИВАТЬ 1. арилгах, арчих, гүвэх, сэгсрэх, унагах; 2. үргээх, хөөх; 3. адилархуу байх, төстэй байх.
СМАХНУ́ТЬ 1. *арилгах*, арчих, гүвэх, *сэгсрэх*, унагах; ~ **щёткой пыль** сойзоор тоос арилгах, тоос сойздох; 2. үргээх, хөөх; ~ **мух** ялаа үргээх.
СМА́ХУ 1. далайж далайж, далайн; **ударить** ~ далайж далайж цохих; 2. цочмог, гэнэт, бодолгүй; **решить что-либо** ~ юмыг цочмог шийдэх.
СМА́ЧИВАТЬ норгох, дэвтээх, чийгтүүлэх.
СМА́ЧИВАТЬСЯ норох, дэвтэх, чийгтэх.
СМА́ЧНО 1. амтархан, тамшаалан; ~ **жевать** амтархан зажлах; 2. бахдан, бах болгон; ~ **рассказывать** бах болгон ярих.
СМЕЖА́ТЬ анилдуулах, анилдах; **сон смежил** нойр хүрч нүд анилдав.
СМЕ́ЖНОСТЬ айл зэргэлдээ *(байх),* зэргэлдээ *(байх),* хөрш *(байх),* зэрэгцэх; ~ **понятий** зэрэгцээ ухагдахуун.
СМЕ́ЖН||ЫЙ 1. зэргэлдээ, айл зэргэлдээ, хөрш, хамар, зах нийлсэн, залгаа; **~ые углы** хамар өнцөг; 2. зэрэгцсэн, зэргэлдээ; 3. үйлдвэрлэлийн холбоотой; **~ые предприятия** үйлдвэрлэлийн холбоотой үйлдвэрүүд.
СМЕКА́ЛИСТЫЙ авхаалжтай, самбаатай.
СМЕКА́ЛК||А авхаалж, ухамсар, самбаа, арга самбаачлах; **человек со ~ой** авхаалжтай хүн.
СМЕКНУ́||ТЬ ухах, тухайлах; ***он сразу ~л, в чём дело*** үчрыг нь дор нь ухав.
СМЕЛЕ́ТЬ зүрх орох, зориг орох.
СМЕ́ЛО 1. зүрхтэй, аймшиггүй, зоригтой, зоримог; ~ **выступить** зүрхтэй хэлэх; 2. дажгүй, уужуухан.
СМЕ́ЛОСТ||Ь зүрх, зориг, аймшиггүй; ~ **поступка** зоригтой явдал; **у него не хватило ~и** түүнд зүрх хүрсэнгүй; **взять на себя ~** зүрх гаргах, зүрхлэх.
СМЕ́ЛЫЙ зүрхтэй, зоригтой, зоримог, аймшиггүй, эрэлхэг; ~ **человек** зоригтой хүн.
СМЕЛЬЧА́К зүрхтэй эр.
СМЕ́Н||А 1. халах, халаа; ~ **караула** харуул халах; 2. ээлж; **ночная** ~ шөнийн ээлж; 3. ээлжийнхэн, халаа; **пришла вечерняя** ~ оройн ээлжийнхэн ирлээ; 4. хойчийг залгамжлагч, залгамжлагч, халаа; 5. сэлээ; ~ **белья** сэлээ хувцас; * **на ~у** а)халаанд, оронд; **брат пришёл — ~ мне** ах миний халаанд ирэв; б)халж, халаад.
СМЕНИ́||ТЬ 1. сэлэх, сэлгэх, сольж өмсөх; ~ **бельё** дотуур хувцас солих; 2. халах, халж солих, солих; ~ **часового** манаа халах; 3. байгаад,... болох, байснаа... болох, солих; **прохлада ~ла зной** халуун байснаа сэрүүн болов.
СМЕНИ́||ТЬСЯ 1. халагдах, солигдох; **караул ~лся** харуул солигдов; 2. солигдох, байснаа...болох; **печаль ~лась весельем** уйтгарлаж байснаа наргих болов.
СМЕ́НН||ЫЙ *ээлжийн, ээлжийнхний;* **~ая работа** ээлжийн ажил.
СМЕ́НЩИК ээлжийн ажилчин.
СМЕНЯ́ЕМОСТЬ халагдах, сэлгэгдэх, сэлэгдэх, солигдох.
СМЕНЯ́ЕМ||ЫЙ солигдох, сэлгэгдэх, сэлгэгддэг; **~ые части машины** машины сэлгэгдэх зүйлс.
СМЕНЯ́ТЬ 1. сэлэх, сэлгэх, сольж өмсөх; 2. халах, халж солих, солих; 3. байгаад, болох, байснаа...болох, *солих;* 4. *арилжих,* арилжаа хийх, солих; * ~ **кукушку на ястреба** морь унаж явснаа илжиг унах.
СМЕНЯ́ТЬСЯ 1. халагдах, солигдох; 2. солигдох байснаа...болох.
СМЕРДЕ́ТЬ өмхий үнэртэх, муухай үнэртэх.
СМЕРЗА́НИЕ барилдан хөлдөх.
СМЕ́РИТЬ хэмжих; * ~ **кого-либо взглядом** хөлөөс толгой хүртэл ширтэн харах.
СМЕРКА́ТЬСЯ баруй бүрий болох, харуй бүрий болох, бүрий болох, бор хараа тасрах, цагаан гэгээ тасрах; **уже смеркается** бүрий болж байна.
СМЕРТЕ́ЛЬНО 1. аюултай, үхэхээр, үхмээр, аминд хүрэх; ~ **ранен** аюултай шархаджээ; 2. үхтэл, тэсгэлгүй; ~ **устать** үхтэл ядрах.
СМЕРТЕ́ЛЬНОСТЬ аюултай *(байх),* аминд хүрэх.
СМЕРТЕ́ЛЬН||ЫЙ 1. аюултай, үхэхээр, үхмээр, аминд хүрэх, алах; **~ая рана** аюултай шарх; 2. амь өрссөн, хайр найргүй, шийдвэртэй; **~ая борьба** амь өрссөн тэмцэл; 3. тэсвэрлэшгүй, тэсгэлгүй, өшөөт; **~ая ненависть** тэсгэлгүй үзэн ядалт; 4. хэмжээлшгүй, туйлгүй, маш их; **~ая усталость** туйлгүй ядрах.
СМЕ́РТНИК 1. цаазлагдах ялтан; 2. амиа золиослогч.
СМЕ́РТНОСТЬ үхэл хорогдол, үхэх.
СМЕ́РТН||ЫЙ 1. үхлийн, үхэх; ~ **час** үхлийн цаг; 2. цаазлах, цаазаар аваачих, алах, засаглах; **~ая казнь** цаазаар аваачих; 3. хүн; **простой** ~ энгэл хүн, ард, харц; 4. амь өрссөн, ширүүн; ~ **бой** амь өрссөн тулалдаан; 5. тун их, туйлгүй; **скука ~ая** тун их уйдах, үхтэлээ уйдах.

СМЕРТОНО́СНЫЙ үхлийн аюултай, алах;~ **яд** үхлийн аюултай хор.

СМЕРТ||Ь 1. үхэл, үхэх, нас нөгцөх; **естественная** ~ үхэл, үхлээрээ нас нөгцөх, ер бусын үхэл; **скоропостижная** ~ зуурдын үхэл; **быть при ~и** үхлүүт байх; **спасти от ~и** үхлээс аврах; **вопрос жизни и ~и** үхэх сэхэхийн хэрэг; **между жизнью и ~ью** амь наана, там цаана; **стоять на** ~ амь өрсөн тулалдах; 2. мөхөл, мөхөх, сөнөх; * **до ~и, ~ как** тэсвэрлэшгүй, яах аргагүй; **до ~и спать хочется** тэсвэрлэшгүй нойр хүрч байна; **бороться не на жизнь, а на ~** амь өрсөн тэмцэх; **двум ~ям не бывать, а одной не миновать** айсан ч ойчно, алцайсан ч ойчно.

СМЕРЧ догшин хуй.

СМЕСИ́ТЕЛЬ холигч.

СМЕСТИ́ 1. хамах, шүүрдэх; ~ **сор** хог хамах; 2. шүүрдэн хаях, арчин цэвэрлэх, арилгах, үгүй хийх, устгах; ~ **всё на своём пути** замдаа тохиолдсон бүхнийг устгах; 3. шүүрдэн хамах, хамж овоолох; ~ **листья на кучу** унасан навч шүүрдэж овоолох.

СМЕСТИ́ТЬ 1. огцруулах, халах, татах; 2. зайлуулах, байрнаас нь хөдөлгөх, сэлгэх; ~ **точку наблюдения** ажиглаж байсан газраа сэлгэх.

СМЕСТИ́ТЬСЯ зайлах, байрнаасаа хөдлөх.

СМЕСЬ 1. холимог; **горючая** ~ холимог шатахуун; 2. холио, холион бантан; ~ **разнородных явлений** элдэв үзэгдлийн холио.

СМЕ́Т||А төсөв; **составить ~у** төсөв зохиох; ~ **расходов** зарлагын төсөв; ~ **исполнительная** гүйцэтгэлийн төсөв.

СМЕТА́НА зөөхий.

СМЕТА́ТЬ I 1. хамах, шүүрдэх; 2. шүүрдэн хаях, арчин цэвэрлэх, үгүй хийх, устгах.

СМЕТА́ТЬ II шидэх.

СМЕТА́ТЬ III хураах, нуруулдах; ~ **стог сена** нэг нуруу өвс хураах.

СМЁТКА авхаалж, ухвар сайтай.

СМЕТЛИ́ВОСТЬ авхаалжтай *(байх)*, ухвар сайтай *(байх)*.

СМЕТЛИ́ВЫЙ авхаалжтай, ухвар сайтай, ухамтгай.

СМЕ́ТНЫЙ төсвийн.

СМЕТЬ 1. зүрхлэх, зориглох; *үгчлэн орчуулахгүй утгыг нь гаргаж ч болно;* **не ~ войти** орж зүрхлэхгүй байх; **не смей!** битгий! байг! боль!; 2. эрхтэй байх; **вы не смеете этого делать** танд ингэх эрх байхгүй.

СМЕХ инээдэм, инээд; **меня разбирает** ~ миний инээд хүрч байна; **разразиться ~ом** тачигнатал инээх; **прыснуть со смеху** инээд алдах; **взрыв смеха** ниргэтэл инээх; **сдерживать** ~ инээдээ барих; * **и ~, и грех, и ~, и горе** инээдэм ханиадам; **без ~а** тоглоом биш; **на** ~ инээлгэхийн тул, элэг доог болгож; **не до ~а** цэнгэх цаг биш, инээж баясах юм алга; **поднять кого-либо на** ~ хүнийг инээдэм болгох, элэг доог болгох; **~а ради** тоглоом хийж, тохуу хийж; * **курам на** ~ түмний доог болох.

СМЕХОТВО́РНОСТЬ инээдэмтэй *(байх)*, инээдтэй *(байх)*.

СМЕХОТВО́РНЫЙ инээдэмтэй, инээдтэй, инээд хүрмээр; ~ **случай** инээдэмтэй явдал.

СМЕ́ШАНН||ЫЙ 1. холимог, холимол, хутгамал; 2. хамтарсан, хэдэн этгээдийн, хамтын; **~ая комиссия** хамтарсан комисс, хэдэн этгээдийн комисс.

СМЕША́ТЬ 1. холих, хийх; 2. холих, хутгах, будлиантуулах; ~ **карты** а) хөзөр холих; б) будлиантуулах; 3. самуурах, андуурах, будлих, хутгах; ~ **два понятия** хоёр ухагдахууныг хутгах.

СМЕША́||ТЬСЯ 1. холилдох, хольцолдох, хутгалдах; **краски ~лись** будаг холилджээ; 2. хутгалдах, будлиантах, самуурах; **все понятия ~лись** эдгээр ухагдахуун цөм будлиантжээ; 3. хутгалдах, нийлэх; ~ **с толпой** хүний дунд хутгалдах.

СМЕШЕ́НИЕ хутгах, холих, хутгалдах, холилдох, самуурах, будлих; ~ **понятий** олон ухагдахууныудыг хутгах.

СМЕ́ШИВАНИЕ холилт, холих.

СМЕ́ШИВАТЬ 1. холих, хийх; 2. холих, хийх, будлиантуулах; 3. самуурах, андуурах, будлих, хутгах.

СМЕ́ШИВАТЬСЯ 1. холилдох, хольцолдох, хутгалдах; 2. хутгалдах, будлиантах, самуурах; 3. хутгалдах, нийлэх.

СМЕШИ́ТЬ инээлгэх, инээд хүргэх.

СМЕШЛИ́ВОСТЬ инээд муутай байх, инээд хүргэх.

СМЕШЛИ́ВЫЙ инээд муутай, инээмхий; ~ **человек** инээд муутай хүн.

СМЕШНО́ 1. инээдэмтэй, инээд хүрмээр; ~ **рассказывать** инээдэм хүрмээр ярих; 2. инээдтэй байх, инээд хүрэм; **стало** ~ инээд хүрэв.

СМЕШН||О́Й инээдэмтэй, инээдэс хүрмээр, хөгтэй, наргиантай; ~ **случай** инээдтэй явдал, хөгтэй явдал; ~ **наряд** инээд хүрмээр гоёлын хувцас; ***до ~ого** инээд хүрмээр; **выставлять что-либо в ~ом виде** инээдтэй байдлаар харуулах, амьтны доог болгох.

СМЕШО́К инээдэс, инээчлэх.

СМЕЩА́ТЬ 1. огцруулах, халах, татах; 2. зайлуулах, байрнаас нь хөдөлгөх, сэлгэх.

СМЕЩА́ТЬСЯ зайлах, байрнаасаа хөдлөх.

СМЕЩЕ́НИЕ сэлгэх, байрнаас нь хөдөлгөх, огцруулах, халах, татах; ~ **с должности** тушаалаас нь халах.

СМЕЯ́ТЬСЯ 1. инээх; 2. доог хийх, элэглэх, элэг барих; 3. тоглох, тоглож хэлэх; 4. тоохгүй байх, юманд эс тоох; ~ **над угрозами врага** дайсны заналыг юманд эс бодох.

СМИ́ЛОВАТЬСЯ нигүүлсэх, өршөөх.

СМИРЕ́НИЕ номхрох, хүлцэнгүй байх.

СМИРЕ́ННО номхон, хүлцэнгүй, даруу.

СМИРЕ́ННОСТЬ номхон зан, хүлцэнгүй байх.

СМИРЕ́ННЫЙ номхон, хүлцэнгүй, даруу.

СМИРИ́ТЕЛЬН||ЫЙ номхотгох, номхруулах; **~ая рубашка** номхотгох цамц.

СМИРИ́ТЬ номхотгох, номхруулах, дарах.

СМИРИ́ТЬСЯ номхрох, дарагдах, дагах, хүлцэх, аядах, тогтох.

СМИ́РНО номхон; ~ **сидеть** номхон суух; ~! номхон!

СМИ́РН||ЫЙ номхон; **~ая лошадь** номхон морь.

СМИРЯ́ТЬ номхотгох, номхруулах, дарах.

СМИРЯ́ТЬСЯ номхрох, дарагдах, хүлцэх, аядах, тогтох.

СМОКО́ВНИЦА бибал.

СМОЛА́ давирхай, бах.

СМОЛА́ЧИВАТЬ цохих/тариа/

СМОЛЁВКА *бот.* шээрэнгэ.

СМОЛЕ́НИЕ давирхайдах.

СМОЛЁНЫЙ давирхайдсан, давирхай түрхсэн; ~ **канат** давирхайдсан татлага.

СМОЛИ́СТ||ЫЙ 1. давирхайтай, давирхайлаг; **~ое дерево** давирхайтай мод; 2. давирхайрхуу, давирхай ханхалсан; ~ **запах** давирхайрхуу үнэр.

СМОЛИ́ТЬ давирхайдах, давирхай түрхэх; ~ **лодку** завь давирхайдах.

СМОЛКА́ТЬ намдах, чимээгүй болох, дуугүй болох.

СМО́ЛКНУТЬ намдах, чимээгүй болох, дуугүй болох.

СМО́ЛОДУ залуугаасаа, залуу наснаасаа, идэр наснаасаа; **береги честь** ~ залуугаасаа нэрээ хайрла, нэр хугарахаас яс хугар.

СМОЛОТИ́ТЬ *(тариа)* цохих; ~ **рожь** хөх тариа цохих.

СМОЛО́ТЬ тээрэмдэх, талхлах, нунтаглах; ~ **кофе** кофе нунтаглах.
СМОЛЧА́ТЬ дуугүй өнгөрөх, чимээгүй өнгөрөх.
СМОЛЬ давирхай; **чёрный, как** ~ давирхай шиг хар, хав хар, тас хар.
СМОЛЯН||О́Й давирхайн; **~ая бочка** давирхайн торх.
СМОНТИ́РОВАТЬ, угсрах, эвлүүлэх.
СМОРГНУ́ТЬ нүд чавчих.
СМОРКА́ТЬСЯ нусаа нийх.
СМОРО́ДИНА 1. үхрийн нүдний бут, улаалзганы бут; 2. **чёрная** ~ үхрийн нүд; **красная** ~ улаалзгана.
СМОРЧО́К үрчгэр мөөг.
СМО́РЩИТЬ үрчийлгэх, атируулах; ~ **нос** хамраа атируулах.
СМО́РЩИТЬСЯ үрчийх, атирах, ярвайх.
СМОТА́ТЬ 1. ороох, эвхэх; ~ **нитки** утас ороох; 2. цувах, задлах; * ~ **удочки** алга болох.
СМОТР 1. үзэх, шалган үзэх, үзлэг; ~ **войск** цэргийг шалган үзэх; 2. бүртгэн үзэх.
СМОТРЕ́||ТЬ 1. харах, шагайх; ~ **во двор** гадагш харах; ~ **в окно** цонхоор шагайх; 2. үзэх; ~ **выставку** үзэсгэлэн үзэх; 3. үзэх, шалган үзэх; ~ **больного** өвчтөнийг үзэх; 4. харах, *бөөцийлөх, сахих, сахиулах;* ~ **за порядком** журам сахиулах; 5. үлгэр авах, жишээ авах; ~ **на старших** ахмад хүмүүсээс үлгэр авах; 6. үзэх, үнэлэх, гэх; **как вы на это смотрите?** та үүнийг юу гэж үзэж байна? 7. харагдах, цухуйх; **из-за тучи ~ло солнце** үүлний цаанаас нар цухуйв; 8. байдал гаргах, дүр үзүүлэх, шиг байх; ~ **героем** баатрын байдал гаргах; 9. харах, хандах; **окна смотрят на улицу** цонх нь гудамж руу ханджээ; 10. **смотри, смотрите** сайхан мэдээрэй, - уусай *(- үүзэй);* **смотри, не упади** ойчуусай; * **смотри в оба** сайн харж яв, болгоомжтой; ~ **сквозь пальцы на что-либо** юмыг хараа ч үгүй хүн болох; ~ **в глаза чему- либо** а)ажрахгүй байх, зориг үл *шантрах;* ~ **в глаза опасности** аюул ирэхэд ажрахгүй байх; б)зөв үнэлэх; ~ **в глаза фактам** баримтыг зөв үнэлэх; ~ **чьими-либо глазами** хүний амаар будаа идэх.
СМОТРЕ́ТЬСЯ 1. харах; ~ **в зеркало** толинд өөрийгөө харах; 2. үзэх; **эта пьеса смотрится с большим интересом** энэ жүжгийг ихэд сонирхон үзэж байна.
СМОТРИ́ТЕЛЬ даамал, сахиул; **станционый** ~ өртөөний даамал.
СМОТРЯ́ 1. - аас *(- зэс, - оос, - өөс);* ~ **какой человек** ямар хүн болохоос шалтгаална; 2. ~**по** харгалзан, үзэж байж; ~ **по обстоятельствам** байдлыг үзэж байж; **одеваться, ~ по погоде** *тэнгэрийн байдлыг* харгалзан хувцаслах.
СМОЧИ́ТЬ норгох, дэвтээх, чийгтүүлэх.
СМОЧЬ чадах.
СМОШЁННИЧАТЬ хууран мэхлэх, луйвардах.
СМРАД өмхий үнэр, өмхий самхай, муухай үнэр, үнэр танар, хиншүү хярвас.
СМРА́ДНЫЙ өмхий, өмхий самхай, муухай үнэртэй, хиншүү оргисон, хярвас үнэртсэн; ~ **дым** өмхий утаа.
СМУГЛЕ́ТЬ бор*лох*, бараан болох, хүрэн хар болох.
СМУГЛОЛИ́ЦЫЙ бор царайтай, бараан царайтай, хүрэн хар царайтай.
СМУ́ГЛЫЙ бор, бараан царайтай, хүрэн хар; ~ **юноша** бор залуу.
СМУГЛЯ́НКА бор эхнэр, бор охин.
СМУ́Т||А самуун, үймээн самуун, үймээн; **сеять ~у** самуун тарих.
СМУТИ́ТЬ ичээх, зовоох, аягүйрхүүлэх, бачимдуулах.
СМУТИ́ТЬСЯ ичих, зовох, эмээх, аягүйрхэх, бачимдах.
СМУ́ТНО бүүр, түүр; ~ **помнить** бүүр түүр санах.
СМУ́ТН||ЫЙ 1. бүүр, түүр, тодорхой бус, балар бүдэг; ~ **шум** бүүр түүр чимээ; 2. самуун, түгшүүртэй; **~ое время** самуун цаг.
СМУТЬЯ́Н үймүүлэгч, самуун гаргагч.
СМУ́ШКОВ||ЫЙ хурган, нарийн хурган, нарийн хурганы арьсан; **~ая шапка** хурган малгай.
СМУЩА́ТЬ ичээх, зовоох, аягүйрхүүлэх, бачимдуулах.
СМУЩА́ТЬСЯ ичих, зовох, эмээх, аягүйрхэх, бачимдах.
СМУЩЕ́НИЕ ичих, зовох, аягүйрхэх.
СМЫВ угаах, усанд идэгдэх, нурах, усанд урсах.
СМЫВА́ТЬ 1. угаах; 2. цагаатгах, ариутгах; 3. усанд автах, урсах.
СМЫВА́ТЬСЯ угаагдах, арилах.
СМЫКА́||ТЬ 1. шахах, шахуу жагсаах, үргэлж болгох, *нийлүүлэх;* 2. аних, хамжих; **не ~я глаз** хар нүдээ хамхилгүй.
СМЫКА́ТЬСЯ 1. шахуу жагсах, нийлэх; 2. аних, хамхих.
СМЫСЛ 1. утга, утга санаа, утга учир; **понять ~ чего-либо** юмны утга учрыг ойлгох; **слово в переносном ~е** шилжүүлсэн утгатай үг; учир утга, учир, зорилго; ~ **жизни** амьд явахын зорилго; 3. ухаан, бодол; **здравый** ~ эрүүл ухаан; * **в полном ~е слова** бүр, яах аргагүй.
СМЫ́СЛИТЬ ухах, ойлгох, мэдэх; **ничего не ~ в музыке** хөгжмийн талаар юу ч мэдэхгүй байх.
СМЫСЛОВ||О́Й утгын; **~ые оттенки слова** үгийн утгын нарийн ялгаа.
СМЫТЬ 1. угаах, угааж *арилгах;* ~ **грязь с чего-либо** юмны хир угаах; 2. цагаатгах, ариутгах; ~ **с себя позор** гутамшигт хэргээ цагаатгах; 3. усанд автах, урсаад явчих.
СМЫ||ТЬСЯ угаагдах, арилах; **пятно ~лось** толбо арилав.
СМЫ́ЧКА 1. холбох; 2. холбоо, барилдаа.
СМЫЧКО́ВЫЙ нумт.
СМЫЧО́К нум.
СМЫШЛЁННОСТЬ цовоо *(байх),* сэргэлэн *(байх),* ухаалаг *(байх).*
СМЫШЛЁНЫЙ цовоо, сэргэлэн, ухаалаг.
СМЯГЧА́ТЬ 1. зөөлрүүлэх, намдуулах, зөөлтгөх; 2. зөөлрүүлэх, намдуулах, хөнгөрүүлэх, дарах; 3. зөөлрүүлэх, номхотгох; 4. зөөлрүүлэх.
СМЯГЧА́ТЬСЯ 1. зөөлрөх, зөөлөн болох; 2. зөөлрөх, номхрох; 4. зөөлрөх.
СМЯГЧЕ́НИ||Е 1. зөөлрүүлэх, зөөлтгөх; 2. хөнгөрүүлэх, зөөлрүүлэх; **хлопотать о ~и приговора** шүүхийн тогтоолыг зөөлрүүлэхийг оролдох; 3. зөөлрөх; ~ **согласных** гийгүүлэгч зөөлрөх.
СМЯГЧИ́ТЬ 1. зөөлрүүлэх, зөөлтгөх; ~ **кожу выделкой** арьс элдэж зөөлрүүлэх; 2. зөөлрүүлэх, намдуулах, хөнгөрүүлэх, дарах; ~ **боль** өвчин намдуулах; 3. зөөлрүүлэх, номхотгох; 4. зөөлрүүлэх.
СМЯГЧИ́||ТЬСЯ 1. зөөлрөх, зөөлөн болох; **кожа ~лась** арьс зөөлрөв; 2. зөөлрөх, намдах, хөнгөрөх, дарагдах; **гнев ~лся** хилэн дарагдав; 3. зөөлрөх, номхрох; 4. зөөлрөх.
СМЯТЕ́НИ||Е 1. бачимдах, мэгдэх; **он ушёл в ~и** тэр хүн бачимдан одов; 2. сандрах, үймэх, сандрал, үймээн.
СМЯТЬ 1. үнгэх, үрчийлгэх, хорчийлгох, хонхойлгох; ~ **бумагу** цаас үнгэх; 2. дайран сандаах, сарниулах; ~ **вражеские войска** дайсны цэргийг дайран сандаах.
СМЯ́||ТЬСЯ үнгэгдэх, үрчийх, хорчийх, хонхойх; **платье ~лось** хувцас үрчийв.
СНАБДИ́ТЬ хангах, *нийлүүлэх,* олгох, өгөх
СНАБЖА́ТЬСЯ 1. хангах; 2. хангагдах.
СНАБЖЕ́НЕЦ хангагч, хангах байгууллагын ажилтан.
СНАБЖЕ́НИЕ 1. хангах, нийлүүлэх; 2. хангамж, юм; **продовольственное** ~ хүнсний хангамж.

СНАБЖЁНЧЕСК||ИЙ хангах, нийлүүлэх; **~ие органы** хангах байгууллага.
СНА́ДОБЬЕ эм, эм дом.
СНА́ЙПЕР мэргэн буудагч, мэргэн бууч.
СНА́ЙПЕРСК||ИЙ мэргэн буудагчийн, мэргэн буучийн, мэргэн; **~ая стрельба** мэргэн буудлага.
СНАРУ́ЖИ гаднаас, гадаанаас, гадаа талаас; **запереть дверь ~** хаалгыг гаднаас нь түгжих.
СНАРЯ́Д 1. сум; **артиллерийский ~** их бууны сум; 2. төхөөрөмж, тоног; **~ для бурения** өрөмдөх төхөөрөмж.
СНАРЯДИ́ТЬ бэлтгэх, төхөөрөх, тоноглох, илгээх, явуулах.
СНАРЯ́ДНЫЙ их бууны сумны; **~ ящик** их бууны сумны хайрцаг.
СНАРЯЖА́ТЬ бэлтгэх, төхөөрөх, тоноглох, илгээх, явуулах.
СНАРЯЖА́ТЬСЯ бэлдэх, төхөөрөх.
СНАРЯЖЕ́НИЕ 1. бэлтгэх, төхөөрөх, тоноглох; 2. тоног, төхөөрөмж, тоноглол, төхөөрөг, хэрэгсэл; **воинское ~** цэргийн хэрэгсэл.
СНАСТ||Ь 1. **~и** татлага; **корабельные ~** хөлөг онгоцны татлага; 2. тоног, төхөөрөмж, хэрэгсэл; **рыболовная ~** загасны хэрэгсэл.
СНАЧА́ЛА 1. анхнаас, эхлээд, урьд, түрүүндээ; **~ подумай, потом говори** эхлээд бод, дараа нь хэл; 2. эхнээс, дахиад, дахин; **начать ~** дахин эхлэх; **прочитай ~** эхнээс нь унш.
СНА́ШИВАТЬ элээх, хуучруулах.
СНА́ШИВАТЬСЯ элэх, хуучрах.
СНЕГ цас; **идёт ~** цас орж байна; **выпал ~** цас унав; **мокрый ~** нойтон цаас; **вечный ~** мөнх цас; **первый ~** түрүүчийн цас; *** как ~ на голову** гэв гэнэт.
СНЕГИ́РЬ зана шувуу.
СНЕГОВО́Й цасны, цасан, цаст; **~ покров** цасан хучлага, цасан бүрхүүл.
СНЕГОЗАДЕРЖА́НИЕ цас тогтоох.
СНЕГООЧИСТИ́ТЕЛЬ цас цэвэрлэгч, цас хагалуур.
СНЕГООЧИСТИ́ТЕЛЬНЫЙ цас цэвэрлэх, цас хагалах.
СНЕГОПА́Д цас орох, цас унах.
СНЕГОТА́ЯНИЕ цас хайлах, цас хайлуулах.
СНЕГОУБО́РОЧН||ЫЙ цас арилгах; **~ая машина** цас арилгах машин.
СНЕГУ́РОЧКА цасан охин.
СНЕДА́||ТЬ тарчилгах, шаналгах, тарчлах, шаналах; **~ет зависть** атаархаж шаналгаж байна.
СНЕДЬ идээ, идээ будаа.
СНЕЖИ́НКА цасны ширхэг.
СНЕСТИ́ I 1. аваачих, аваачиж өгөх, хүргэх; 2. цуглуулах, хураах; 3. хуу татах, авч хаях; 4. буулгах, эвдэх; **~ старый дом** хуучин байшин буулгах; 5. тас цавчих, тас огтлох, авах; **~ голову** толгойгий нь тас цавчих; 6. хүлцэх, тэвчих, тэсвэрлэх; **~ оскорбление** доромжлоход хүлцэн өнгөрөх.
СНЕСТИ́ II өндөглөх; **курица снесла яйцо** тахиа өндөглөв.
СНЕСТИ́СЬ I харилцах, харилцаа тогтоох.
СНЕСТИ́СЬ II өндөглөх.
СНИЖА́ТЬ 1. дорогшлуулах, доош болгох; 2. хасах, багасгах, саах, хорогдуулах, хямдруулах, бууруулах; 3. нам болгох, дарах; 4. бууруулах, буулгах.
СНИЖА́ТЬСЯ 1. дорогшлох, доош болох; 2. багасах, хорогдох, хямдрах, буурах, буух; 3. нам болох.
СНИЖЕ́НИЕ 1. хямдрулах, бууруулах, хорогдуулах, багасгах, хямдрах, буурах, хорогдох, багасах; **~ цен** үнэ бууруулах; 2. дорогшлох, доош болох; **~ самолёта** онгоц доошлох.
СНИ́ЗИТЬ 1. дорогшлуулах, доош болгох; **~ самолёт** онгоцоо доошлуулах; 2. хасах, багасгах, саах, хорогдуулах, хямдруулах, бууруулах; 3. нам болгох, дарах; **~ тон** дуугаа нам болгох; 4. бууруулах, буулгах.
СНИ́ЗИ||ТЬСЯ 1. дорогшлох, доош болох; **самолёт ~лся** онгоц доошлов; 2. багасах, хорогдох, хямдрах, буурах, буух; 3. нам болох.
СНИЗОЙТИ́ болгоох, болгоож айлдах, өршөөн үзэх; **~ к чьим-либо нуждам** хүний гачигдлыг болгоох.
СНИ́ЗУ 1. дороос, доод талаас; **~ дует** дороос салхилна; **~ вверх** дороосоо дээш; 2. дороос.
СНИМА́ТЬ 1. авах, хуулах, хамах, буулгах, өвчих; 2. хураах; 3. тайлах; 4. буулгах; 5. халах, огцруулах, гаргах, хасах; 6. хүчингүй болгох, буцааж авах, хасах; 7. хуулах, буулгах, авах; 8. зураг авах; 9. хөлслөх; 10. мэдүүлэг авах, байцаах; 11. хөзөр таслах.
СНИМА́ТЬСЯ 1. автах, тайлагдах, салах; 2. хөдлөх, мордох; 3. зургаа авахуулах.
СНИ́МОК зураг, авдас; **рентгеновский ~** рентген зураг.
СНИСКА́ТЬ олох, - тай *(- тэй, - той)* болох; **~ чьё-либо доверие** хүний итгэлийг олох.
СНИСХОДИ́ТЕЛЬНО 1. зөөлөн, хүлцэнгүй; **отнестись к кому-либо ~** хүнд зөөлөн хандах, хүнтэй зөөлөн харьцах; 2. ивээнгүй байдалтай, өршөөнгүй янзаар; **~ разговаривать с кем-либо** хүнтэй ивээнгүй байдалтай ярих.
СНИСХОДИ́ТЕЛЬНОСТЬ хүлцэнгүй байх, хүлцэнгүй байдал; **проявить ~** хүлцэнгүй байдал гаргах, хүлцэнгүй байх.
СНИСХОДИ́ТЕЛЬНЫЙ 1. зөөлөн, хүлцэнгүй; 2. ивээнгүй байдалтай, өршөөнгүй янзтай.
СНИСХОДИ́ТЬ болгоох, болгоож айлдах, өршөөн үзэх.
СНИСХОЖДЕ́НИЕ хүлцэх, уучлах, өршөөх, хүлцэл, уучлал, өршөөл.
СНИ́||ТЬСЯ зүүдлэх, зүүдэнд орох; **это ему и во сне не ~лось** энэ зүүдэнд нь ч орсонгүй.
СНК *(Совет Народных Комиссаров)* АКЗ *(Ардын Комиссар нарын Зөвлөл).*
СНОБ дээдсийг дууриагч.
СНОБИ́ЗМ дээдсийг дууриах.
СНО́ВА дахин, дахиад, бас шинээр; **~ пошёл дождь** бороо дахиад орлоо; **начать ~** шинээр эхлэх.
СНОВА́ТЬ хөлхөх, өөдөө сөөргөө явах, ийшээ тийшээ явах; **люди снуют по улицам** гудамжаар хүмүүс хөлхөнө.
СНОВИДЕ́НИЕ зүүд, зүүд зүүдлэх.
СНОГСШИБА́ТЕЛЬН||ЫЙ гайхаад баршгүй, аймшигтай сонин, нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй; **~ая новость** гайхаад баршгүй сонин.
СНОП 1. юүж, боолт; **вязать ~** юүж боох; 2. бөөн; **~ лучей** бөөн сацраг.
СНОРОВИ́СТЫЙ дадалтай, дүйтэй, чадмаг;
СНОРО́ВК||А дадал, дүй; **приобрести ~у** дадал олох, дүйтэй болох.
СНОС I буулгах, эвдэх; **дом предназначен к ~у** буулгах ёстой байшин.
СНОС II ~у нет элэгдэж өгдөггүй, урагддаггүй.
СНОСИ́ТЬ I урах, элээх; **~ обувь** гутал урах.
СНОСИ́ТЬ II аваачаад авчрах, хүргэж өгөөд авчрах.
СНОСИ́ТЬ III 1. аваачих, аваачиж өгөх, хүргэх; 2. цуглуулах, хураах; 3. хуу татах, авч хаях; 4. буулгах, эвдэх; 5. тас цавчих, тас огтлох, авах; 6. хүлцэх, тэвчих, тэсвэрлэх
СНОСИ́ТЬСЯ I урагдах, элэх.
СНОСИ́ТЬСЯ II харилцах, харилцаа тогтоох.
СНО́СКА зүүлт.
СНО́СНО зүгээр, боломжтой, гайгүй; **живётся ~** боломжтой амьдарч байна.

СНО́СН||ЫЙ зүгээр, боломжтой, гайгүй, тааруу; **~ые условия** болохтой нөхцөл.
СНОТВО́РН||ЫЙ нойрны, унтуулах; **~ое средство** нойрны эм.
СНОХА́ бэр.
СНОША́ТЬ хурьцах, хурьцалд орох.
СНОШЕ́НИ||Е 1. харилцаа; **дипломатические ~я** дипломат харилцаа; **прервать ~я с кем-либо** хүнтэй харилцаагаа таслах; 2. хурьцал үйлдэх.
СНЮ́ХАТЬСЯ,
СНЮ́ХИВАТЬСЯ хэл амаа ололцох.
СНЯ́ТИЕ авах, татах, хуулах, буулгах, зогсоох; **~ запрета** хориглохыг зогсоох.
СНЯТ||О́Й хамсан; **~ое молоко** цөцгийгий нь хамсан сүү.
СНЯТЬ 1. авах, хуулах, хамах, буулгах, өвчих; **~ сливки с молока** цөцгий хамах; 2. хураах; **~ урожай** ургац хураах; 3. тайлах; **~ пальто** пальтогоо тайлах; 4. буулгах, татах; **~ караул** харуул буулгах; 5. халах, огцруулах, гаргах, хасах; **~ с должности** тушаалаас огцруулах; 6. хүчингүй болгох, буцааж авах, хасах; 7. хуулах, буулгах, авах; **~ копию с документа** баримт бичгийг хуулах; 8. зураг авах; **~ морской вид** тэнгисийн зураг авах; 9. хөлслөх; **~ комнату** өрөө хөлслөх; 10. мэдүүлэг авах, байцаах; **~ показания с кого-либо** хүнээс мэдүүлэг авах; 11. хөзөр таслах; **~ колоду** хөзөр таслах; *** как рукой сняло** зүв зүгээр болчив.
СНЯ́ТЬСЯ 1. автах, тайлагдах, салах; 2. хөдлөх, мордох; 3. зургаа авахуулах; **~ группой** хэсгээрээ зургаа авахуулах.
СОА́ВТОР хамтрагч, хамтран зохиогч, зохиолцогч.
СОА́ВТОРСТВО хамтран зохиох.
СОБА́К||А нохой; **цепная ~** уяаны нохой; *** он на этом ~у съел** үүнд тоть болсон хүн, үүнд мэргэжсэн хүн; **вот где ~ зарыта!** учир нь ийм байж!
СОБАКОВО́ДСТВО 1. нохой үржүүлэх; 2. нохой үржүүлэх газар.
СОБА́ЧИЙ нохойн; **~ корм** нохойн тэжээл; *** ~ холод** үхрийн эвэр хөлдөхөөр хүйтэн.
СОБА́ЧИТЬ *разг.* ямар нэгэн юмыг хурдан хийх.
СОБА́ЧКА 1. бяцхан нохой, нохойхон, хав; 2. тээглүүр.
СОБЕ́С *(социальное обеспечение)* нийгмийн тэтгэвэр, нийгмийн тэтгэврийн газар, нийгэм хангамж.
СОБЕСЕ́ДНИК ярилцагч, үг хэлэлцэгч.
СОБЕСЕ́ДНИЦА ярилцагч эмэгтэй, үг хэлэлцэгч эмэгтэй.
СОБЕСЕ́ДОВАНИЕ ярилцах, ярилцлага, үг хэлэлцэх.
СОБИРА́ТЕЛЬ цуглуулагч; **~ сказок** үлгэр цуглуулагч.
СОБИРА́ТЕЛЬН||ЫЙ хам; **~ые имена существительные** хам шинжит жинхэнэ нэр.
СОБИРА́ТЬ 1. цуглуулах, хуралдуулах, бөөгнөрүүлэх; 2. цуглуулах, хураах, бадарлах; 3. хураах, түүх; 4. цуглуулах, бөөгнүүлэх, хураах, овоолох; 5. угсрах, эвлүүлэх; 6. авах, хураах; 7. бэлтгэх, зэхэх, төхөөрүүлэх; 8. дайчлах, зангидах, цогцлох; 9. хуних, хуниаслах, хуниас гаргах.
СОБИРА́ТЬСЯ 1. цуглах, цугларах, хуралдах, хурах, хүйлэх; 2. хурах, бөөгнөрөх, цуглах; 3. зэхэх, бэлтгэх, төхөөрөх; 4. шийдэх, завдах; 5. дайчлах, зангидах, цогцлох.
СОБЛАГОВО́ЛИТЬ айлдах, хайрлах; **~ ответить** хариулж айлдах.
СОБЛА́ЗН дур татах, дур татагдах, хорхойтуулах, хорхойтох, толгой эргүүлэх, уруу татах, уруу татагдах; **ввести кого-либо в ~** хүний дур татах, хүнийг уруу татах.
СОБЛАЗНИ́ТЕЛЬ уруу татагч, толгой эргүүлэгч, дур татагч, панаалдагч.
СОБЛАЗНИ́ТЕЛЬНИЦА уруу татагч эмэгтэй, толгой эргүүлэгч эхнэр, дур татагч эмэгтэй.
СОБЛАЗНИ́ТЕЛЬНО дур татагдмаар, хорхой хүрмээр, толгой эргүүлэхээр, панаалдмаар.
СОБЛАЗНИ́ТЕЛЬНОСТЬ дур татахаар байх, хорхой хүрмээр юм, толгой эргүүлэхээр байх, панаал.
СОБЛАЗНИ́ТЕЛЬНЫЙ дур татагдмаар, хорхой хүрмээр, толгой эргүүлэхээр, панаалдмаар.
СОБЛАЗНИ́ТЬ 1. дур татах, хорхойтуулах, толгой эргүүлэх; **~ обещанием** юм амлаж толгой эргүүлэх; 2. ятгах, үгэндээ оруулах, уруу татах, панаалдах.
СОБЛАЗНИ́ТЬСЯ дур татагдах, хорхойтох, уруу татагдах, панаалдагдах.
СОБЛАЗНЯ́ТЬ 1. дур татах, хорхойтуулах, толгой эргүүлэх; 2. ятгах, үгэндээ оруулах, уруу татах, панаалдах.
СОБЛАЗНЯ́ТЬСЯ дур татагдах, хорхойтох, уруу татагдах, панаалдагдах.
СОБЛЮДА́ТЬ сахих, биелүүлэх, гүйцэтгэх, баримтлах, дагах; **~ закон** хууль баримтлах; **~ дисциплину** сахилга сахих.
СОБЛЮДА́ТЬСЯ сахигдах, биелэх, баримтлагдах.
СОБЛЮДЕ́НИЕ гүйцэтгэх, баримтлах, сахих, биелүүлэх, дагах; **~ порядка** журам сахих.
СОБЛЮСТИ́ сахих, биелүүлэх, дагаж гүйцэтгэх, ёсчлон дагах.
СОБОЛЕ́ЗНОВАНИЕ гашуудал, эмгэнэл; **выразить ~** эмгэнэл илэрхийлэх.
СОБОЛЕ́ЗНОВАТЬ гашуудах, эмгэнэх.
СОБОЛИ́Н||ЫЙ булган, булганы; **~ мех** булганы арьс; **~ая шапка** булган малгай.
СО́БОЛ||Ь булга; **ходить в ~ях** булган дээл өмсөх.
СОБО́Р 1. чуулган, хурал; 2. цогчин дуган.
СОБО́РН||ЫЙ 1. чуулганы, хурлын; 2. цогчин дуганы; **~ая башня** цогчин дуганын цамхаг.
СОБРА́НИЕ 1. хурал; **общее ~** бүх гишүүдийн хурал, бүх ажилчдын хурал; 2. хурал, газар; **законодательное ~** хууль тогтоох хурал, хууль тогтоох газар; 3. цуглуулга, эмхтгэл, түүвэр; **~ редкостей** нандин зүйлийн цуглуулга; **~ сочинений** зохиолын эмхтгэл, сүмбүм.
СОБРА́Т *(хамт ажиллагч)* нөхөр, анд.
СОБРА́ТЬ 1. цуглуулах, хуралдуулах, бөөгнөрүүлэх; **~ людей** хүмүүс цуглуулах; 2. цуглуулах, хураах, бадарлах; 3. хураах, түүх; **~ хороший урожай** сайн ургац хураах; 4. цуглуулах, бөөгнүүлэх, хураах, овоолох; 5. угсрах, эвлүүлэх; **~ машину** машин угсрах; 6. авах, хураах; **~ большинство голосов** олонхи саналыг авах; 7. бэлтгэх, зэхэх, төхөөрүүлэх; **~ сына в дорогу** хүүгээ юманд явуулахаар бэлтгэх; 8. дайчлах, зангидах, цогцлох; **~ все свои силы** бүх хүчээ дайчлах; 9. хуних, хуниаслах, хуниас гаргах.
СОБРА́ТЬСЯ 1. цугларах, цуглах, хуралдах, хүйлэх, хурах; 2. хурах, бөөгнөх, цуглах; 3. зэхэх, бэлтгэх, төхөөрөх; **~ в гости** айлд зочлохоор бэлдэх; 4. шийдэх, завдах; 5дайчлах, зангидах, цогцлох; **~ с силами** хүчээ зангидах; **~ с духом** зоригоо дайчлах.
СО́БСТВЕННИК 1. өзөн, өмчтөн; **~ права** *юрид.*эрх өмчлөгч; 2. өмчирхөг хүн.
СО́БСТВЕННИЧЕСК||ИЙ өмчийн, өмчирхөг; **~ие замашки** өмчирхөг зан.
СО́БСТВЕННО 1. чухамдаа, чухмыг хэлбэл, үнэндээ, үнэнийг хэлэхэд; **это, ~, не совсем так** чухамдаа энэ арай тийм биш; 2. жинхэнэ, чухам, тухайлан.
СОБСТВЕННОРУ́ЧНО өөрийн гараар, өөрөө.
СОБСТВЕННОРУ́ЧН||ЫЙ өөрийн гарын, өөрийн бичсэн, өөрийн **~ая подпись** өөрийн гарын үсэг.
СО́БСТВЕННОСТЬ өмч, зөөр, хөрөнгө; **государственная ~** улсын хөрөнгө; **частная ~** хувийн өмч.

СО́БСТВЕНН||ЫЙ 1. өмчийн, амины, хувийн, өөрийн; **~ое имущество** өмчийн хөрөнгө; 2. өөрийн, хувийн; **~ыми средствами** өөрийн хөрөнгөөр, өөрийн мөнгөөр; **в ~ые руки** өөрийн нь гарт, гарт нь, өөрт нь; **видеть ~ыми глазами** өөрийн нүдээр харах; 3. өөрийн дураар, сайн дурын; **по ~ому желанию** өөрийн хүслээр; 4. өөрийн, биеийн; **~ вес** өөрийн жин, биеийн жин; 5. жинхэнэ, чухам, шууд; **в ~ом смысле слова** үгийн жинхэнэ утгаар; *** имя ~ое** оноосон нэр; **~ корреспондент** өөрийн сурвалжлагч.

СОБЫТИ||Е хэрэг, явдал, байдал, явц, үйл явдал, учрал; **неожиданное ~** гэнэтийн хэрэг; **международные ~я** олон улсын байдал; **историческое ~** түүхэн үйл явдал; **радостное ~** баярт учрал.

СОВА́ уул.

СОВА́ТЬ 1. гудрах, чихэх, хийх; **~ вещи в чемодан** чемоданд юм хийх; **~ руки в карманы** гараа халаасандаа хийх; 2. өгөх, шургуулах; **~ книгу в руки** ном гарт нь өгөх; *** ~ нос не в свои дела** хөндлөнд хөлөө.

СОВА́ТЬСЯ 1. тэмүүлэх, улалзах, зүтгэх; **не суйся вперёд** урагш битгий тэмүүл; 2. оролцох, оролдох; **~ в чужие дела** бусдын хэрэгт оролцох; **~ со своими советами** зөвлөгөө өгөхийг оролдох.

СОВЕРША́ТЬ 1. хийх, үйлдэх, бүтээх, байгуулах, гаргах; 2. байгуулах.

СОВЕРША́ТЬСЯ 1. болох, тохиолдох, учрах; 2. бүтэх, биелэх.

СОВЕРШЕ́НИЕ хийх, үйлдэх, бүтээх, байгуулах, гаргах.

СОВЕРШЕ́ННО огт, бүр, тун, тас, бүрмөсөн, төгс, туйлын; **~ не знать** огт үл мэдэх; **~ глухой** бүр дүлий; **~ необходимо** тун зайлшгүй, туйлын чухал; **~ темно** хав харанхуй.

СОВЕРШЕННОЛЕ́ТИ||Е насанд хүрэх, нас гүйцэх, эрийн цээнд хүрэх; **достигнуть ~я** насанд хүрэх.

СОВЕРШЕННОЛЕ́ТНИЙ 1. насанд хүрсэн, нас гүйцсэн, эрийн цээнд хүрсэн; 2. насанд хүрсэн хүн, эрийн цээнд хүрсэн хүн.

СОВЕРШЕ́НН||ЫЙ I 1. төгс *(сайн)*, төгөлдөр *(сайн)*, эрхэм *(сайн)*; **~ое произведение искусства** урлагийн төгс сайн бүтээл; 2. туйлын, төгс, бүр, бүрмөсөн, тун; **~ая правда** төгс үнэн, туйлын үнэн.

СОВЕРШЕ́ННЫЙ II төгс, төгссөн; **~ вид** төгс байдалт, төгссөн байдал.

СОВЕРШЕ́НСТВ||О төгс *(сайн)*, чанар төгөлдөр, эрхэм *(чанар)*, сайны туйл; **верх ~а** эрхмийн дээд.

СОВЕРШЕ́НСТВОВАНИЕ нарийн болгох, боловсруулах, сайжруулах.

СОВЕРШЕ́НСТВОВАТЬ сайжруулах, дээшлүүлэх, *(улам)* нарийн болгох, боловсон болгох, боловсруулах.

СОВЕРШЕ́НСТВОВАТЬСЯ *(улам)* нарийн болох, боловсон болгох, боловсрох, сайжрах, дээшлэх.

СОВЕРШИ́ТЬ 1. хийх, үйлдэх, бүтээх, байгуулах, гаргах; **~ ошибку** алдаа гаргах; **~ подвиг** гавьяа байгуулах; **~ сделку** хэлэлцээ хийх.

СОВЕРШИ́||ТЬСЯ 1. болох, тохиолдох, учрах; **~лось важное событие** чухал явдал болов; 2. бүтэх, биелэх.

СО́ВЕСТИТЬ санаагий нь зовоох, ичээх, аягүйрхүүлэх.

СО́ВЕСТИТЬСЯ санаа зовох, ичих, аягүйрхэх.

СО́ВЕСТЛИВОСТЬ санаа зовох, сэтгэл зовомтгой зан.

СО́ВЕСТЛИВЫЙ санаа зовдог, сэтгэл зовдог, сэтгэл зовомтгой, ичих нүүртэй; **~ человек** санаа зовомтгой хүн.

СО́ВЕСТНО санаа зовох, эвгүй байх, ичгэвтэр байх, ичингүйрэх; **как вам не ~!** та яасан санаа зовдоггүй хүн бэ? **мне ~ вас беспокоить** таны тавыг алдагдуулах эвгүй байна.

СО́ВЕСТ||Ь сэтгэл санаа, дотоод сэтгэл, ичих нүүр; **спокойная ~** сэтгэл амгалан байх; **люди с чистой ~ью** ариун сэтгэлт хүмүүс; **не иметь ни стыда, ни ~и** ичгүүр сонжуургүй; **без зазрения ~и** ичих нүүргүй; *** ради очистки ~и** сэтгэлээ засахын тул, хожим гэмшихгүйн тулд, хожим амаа барихгүйн тулд; **свобода ~и** шүтэх, бишрэх эрх чөлөө; **не за страх, а за ~** үнэн сэтгэлээсээ; **по ~и, по чистой ~и** ний нуугүй, илэн далангүй, чин үнэнийг хэлэхэд; **говоря по ~и** чин үнэнийг хэлэхэд; **со спокойной ~ью** сэтгэл амгалан, санаа амар; **делать что-либо на ~** хийе гэж хийх.

СОВЕ́Т I зөвлөл; **государственный ~** төрийн зөвлөл; **~ директоров компании** компаний төлөөлөн удирдах зөвлөл.

СОВЕ́Т II зөвлөгөө; **военный ~** цэргийн зөвлөлгөөн; **семейный ~** гэр бүлийн зөвлөлгөөн; **держать ~** зөвлөлгөөн хийх.

СОВЕ́Т III зөвлөгөө, заавар, сургамж; **обратиться к кому-либо за ~ом** хүнээс зөвлөгөө өгөхийг гуйх; **последовать чьему-нибудь ~у** хүний зааснаар явах.

СОВЕ́ТНИК 1. зөвлөгч; 2. зөвлөх; **~ посольства** элчин сайдын яамны зөвлөх.

СОВЕ́ТОВАТЬ зөвлөгөө өгөх, зөвлөх, сануулах, дурдах, хэрэгтэй гэх, гэж хэлэх; **~ отдохнуть** амрахыг зөвлөх.

СОВЕ́ТОВАТЬСЯ зөвлөгөө авах, зөвлөх, зөвлөн хэлэлцэх; **~ с доктором** эмчтэй зөвлөх; **~ с друзьями** нөхөдтэйгээ зөвлөх.

СОВЕ́ТСКИЙ зөвлөлт, зөвлөлтийн.

СОВЕ́ТЧИК зөвлөгч.

СОВЕ́ТЧИЦА зөвлөгч эмэгтэй.

СОВЕЩА́НИЕ зөвлөлгөөн; **устроить ~** зөвлөлгөөн хийх.

СОВЕЩА́ТЕЛЬНЫЙ зөвлөх; **~ голос** зөвлөх эрх; **~ орган** зөвлөх газар.

СОВЕЩА́ТЬСЯ зөвлөх, зөвлөлдөх; **~ со специалистами** мэргэжилтнүүдтэй зөвлөх.

СОВИ́Н||ЫЙ уулийн; **~ое гнездо** уулийн үүр.

СОВЛАДА́ТЬ барих, давах, дийлэх; **~ с собой** биеэ барих.

СОВЛАДЕ́ЛЕЦ хамт эзэмшигч, эздийн нэг.

СОВЛЕКА́ТЬ хуу татах, гаргах.

СОВЛЕ́ЧЬ хуу татах, гаргах; **~ с правильного пути** зөв замаас нь гаргах.

СОВМЕСТИ́МОСТЬ нийлэмж, нийцэх, таарах; **~ двух понятий** хоёр өөр ухагдахууны нийлэмж; **~ крови** цусны тохироо.

СОВМЕСТИ́МЫЙ нийцэм, таармаар.

СОВМЕСТИ́ТЕЛЬСТВ||О хавсрах; **работать по ~у** хавсран ажиллах.

СОВМЕСТИ́ТЕЛЬСТВОВАТЬ хавсрах, хавсран ажиллах.

СОВМЕСТИ́ТЬ хамруулах, хамтруулах, таруулах, нийцүүлэх; **~ две специальности** хоёр мэргэжил хослуулах.

СОВМЕСТИ́ТЬСЯ 1. тааралдах, онолдох; 2. аль аль нь байх, хослуулах; **в нём совместились теоретические познания и практический опыт** онолын мэдлэг практик дадлага хоёрыг хослуулсан хүн.

СОВМЕ́СТНО хамт, цуг, хамтад, хамтран.

СОВМЕ́СТН||ЫЙ хамтарсан, хамтын; **~ое заседание** хамтарсан хурал; **~ая работа** хамтын ажил.

СОВМЕЩА́ТЬ 1. хавсруулах, хослуулах, хамтруулах, таруулах, нийцүүлэх; 2. хавсрах, хавсран ажиллах.

СОВМЕЩА́ТЬСЯ 1. тааралдах, онолдох; 2. аль аль нь байх, хослуулах.

СОВМЕЩЕ́НИЕ таарах, онолдох, хавсрах, хавсран ажиллах.

СОВНАРКО́М *(Совет Народных Комиссаров)* Ардын Комиссар нарын Зөвлөл.

СОВО́К 1. утгуур; 2. *разг.* зөвлөлт аж төрөх ёсыг баримтлагч, хуучинсаг үзэлтэн.

СОВОКУПЛЕ́НИЕ эвцэлдэх.

СОВОКУ́ПНОСТ||Ь бүгд, нийт, нийцэм, цогц; ~ **условий** бүгд нөхцөл; **в ~и** нийтдээ.

СОВОКУ́ПНЫЙ хамтарсан, хамтын, нийтийн, нийгмийн, цогцолсон.

СОВПАДА́ТЬ 1. давхцах, тааралдах, тохиолдох, тохиох; 2. нийлэх, мөргөх, таарах, адил байх; 3. онолдох, мөргөх.

СОВПАДЕ́НИЕ давхцах, тааралдах, тохиолдох, тохиолдол, тохиол; ~ **обстоятельств** учир байдал давхцах.

СОВПА́||СТЬ 1. давхцах, тааралдах, тохиолдох, тохиох; 2. нийлэх, зохицох, мөргөх, таарах, адил байх; **показания свидетелей ~ли** гэрч нарын мэдүүлэг адил байв; 3. онолдох, мөргөх.

СОВРАТИ́ТЬ замыг нь алдуулах, уруу татах.

СОВРАТИ́ТЬСЯ замаа алдах, буруу замд орох.

СОВРА́ТЬ худал хэлэх.

СОВРАЩА́ТЬ замыг нь алдуулах, уруу татах.

СОВРАЩА́ТЬСЯ замаа алдах, буруу замд орох.

СОВРАЩЕ́НИЕ замыг нь алдуулах, уруу татах, панаалдах.

СОВРЕМЕ́ННИК орчин цагийн хүн, нэг үеийн хүн.

СОВРЕМЕ́ННОСТЬ орчин цаг, эдүгээ үе, одоогийн байдал.

СОВРЕМЕ́НН||ЫЙ 1. орчин цагийн, нэг үеийн; 2. орчин цагийн, эдүгээгийн, одоо үеийн; **~ая литература** орчин үеийн утга зохиол.

СОВСЕ́М 1. бүр, гон, огт; ~ **новое платье** бүр шив шинэ хувцас; ~ **готов** бүр бэлэн; 2. огт, огтхон ч; **он меня ~ не знает** тэр хүн намайг огт танихгүй; 3. бүр, бүрмөсөн; **он уехал ~** тэр хүн бүрмөсөн явсан.

СОВХО́З *(советское хозяйство)* зөвлөлтийн сангийн аж ахуй.

СОВХО́ЗНЫЙ *(зөвлөлтийн)* сангийн аж ахуйн.

СОГЛА́СИ||Е 1. зөвшөөрөл, зөвшөөрөх; **с моего ~я** миний зөвшөөрснөөр; 2. санал нийлэх, нэг саналтай байх, зөвшөөрөх; **прийти к ~ю** нэг саналтай болох, санал нийлэх; 3. эв, найрамдал; **жить в ~и** эвтэй байх.

СОГЛАСИ́ТЬСЯ 1. зөвшөөрөх, зөвшөөх; ~ **на предложение** саналыг зөвшөөрөх; 2. хэлэлцэн тогтох, тохирох, *зөвшөөрөлцөх*.

СОГЛА́СНО I 1. эвтэй, найрамдалтай; **жить ~** эвтэй байх; 2. *хоолой нийлүүлэн, найруу, яруу;* **петь ~** хоолой нийлүүлэн дуулах.

СОГЛА́СНО II ёсоор, зохицуулан, дагуу; ~ **правилу** дүрэмд зохицуулан; *** ~ с, ~ закону** хуулийн ёсоор.

СОГЛА́СН||ЫЙ I 1. *зөвшөөрөх, хүлээх* **согласен на все условия** бүх болзлыг хүлээнэ; 2. санал нийлэх, нэг саналтай байх; 3. эвтэй, *найрамдалтай*; 4. *хоолой нийлүүлсэн, найруу, яруу;* **~ое пение** хоолой нийлүүлэн дуулах.

СОГЛА́СНЫЙ II *гийгүүлэгч;* ~ **звук** *гийгүүлэгч авиа.*

СОГЛАСОВА́НИЕ 1. зөвших, зөвлөх, санаа нэгдэх, зохицуулах; 2. зохицуулах, зохиох.

СОГЛАСО́ВАННОСТЬ зохицуулсан байх, санаа нийлэх; ~ **действий** зохицуулсан ажиллагаа.

СОГЛАСО́ВАННЫЙ зохицуулсан, санаа нэгдсэн.

СОГЛАСОВА́ТЬ 1. зөвших, санаа нэгдэх, *нийцүүлэх,* зохицуулах; 2. зөвлөх, зөвших, зөвшилдөх, хэлэлцэн тогтох; 3. зохицуулах; ~ **прилагательное с существительным** хүртээл нэрийг жинхэнэ нэртэй зохицуулах.

СОГЛАСОВА́ТЬСЯ зохилдох, нийлэх, нийцэх.

СОГЛАСО́ВЫВАТЬ 1. зөвших, санаа нэгдэх, нийцүүлэх, зохицуулах; 2. зөвлөх, зөвших, зөвшилдөх, хэлэлцэн тогтох; 3. зохицуулах.

СОГЛАСО́ВЫВАТЬСЯ 1. зохилдох, нийлэх, нийцэх; 2. зохицох.

СОГЛАША́ТЕЛЬ эвлэрэгч.

СОГЛАША́ТЕЛЬСК||ИЙ эвлэрэх; **~ая политика** эвлэрэх бодлого.

СОГЛАША́ТЬСЯ 1. *зөвшөөрөх, зөвшөөх;* 2. хэлэлцэн тогтох, тохирох, *зөвшөөрөлцөх.*

СОГЛАШЕ́НИ||Е 1. хэлэлцэн тогтох, тохирох, *зөвшөөрөлцөх;* **прийти к ~ю с кем-либо** хүнтэй тохирох; 2. хэлэлцээр; **заключить торговое ~** худалдааны хэлэлцээр байгуулах.

СОГНА́ТЬ 1. хөөх, үлдэх, арилгах; ~ **с места** байрнаас нь хөөх; ~ **веснушки с лица** нүүрний сэвх арилгах; 2. хураах, цуглуулах; ~ **скот** мал хураах.

СОГНУ́ТЬ 1. нугалах, матах, тахийлгах; 2. *бөгтийлгөх, бөгтөр болгох;* 3. зоригийг нь мохоох, шантруулах, шалчийлгах.

СОГНУ́ТЬСЯ 1. нугарах, атийх, тахийх; 2. *бөхийх, бөгтийх.*

СОГРЕВА́НИЕ дулаацах, дулаацуулах, халах, халаах, бүлээсэх, бүлээсгэх; ~ **воздуха** агаар дулаацах.

СОГРЕВА́ТЬ 1. дулаацуулах, халаах, бүлээсгэх, бүлээцүүлэх; 2. сэтгэл амруулах, баясгах, уяруулах.

СОГРЕВА́ТЬСЯ дулаацах, халах, бүлээсэх, бүлээцэх.

СОГРЕ́ТЬ 1. дулаацуулах, халаах, бүлээсгэх, бүлээцүүлэх; 2. сэтгэл амруулах, баясгах, уяруулах; ~ **своей лаской** энхрийлэн баясгах.

СОГРЕ́||ТЬСЯ дулаацах, халах, бүлээсэх, бүлээцэх; **~лись мы чаем** цай ууж дулаацав.

СОГРЕШИ́ТЬ нүгэл хийх, хилэнц үйлдэх, алдаа хийх, эндэх.

СО́ДА соод, хужир; **питьевая ~** уух соод.

СОДЕ́ЙСТВИ||Е дэмжлэг, тусламж; **оказать ~** дэмжлэг үзүүлэх; **при ~и кого-либо** хүний дэмжлэгтэйгээр.

СОДЕ́ЙСТВОВАТЬ дэмжих, туслах, дэмжлэг үзүүлэх; ~ **успеху** амжилт олохыг дэмжих.

СОДЕРЖА́НИЕ 1. хорих, байлгах; ~ **под арестом** баривчлан хорих; 2. агуулга, утга агуулга, утга; 3. гарчиг, товъёог; ~ **книги** номын гарчиг; 4. доторхи зүйл, агуулсан зүйл, агуулга; 5. хэрэглэл, тэтгэмж, цалин, мөнгө; **получить месячное ~** сарын тэтгэмж авах; ~ **и уход** асран тэтгэх.

СОДЕРЖА́НКА тэжээлгэгч эхнэр, тэжээлгэгч эм.

СОДЕРЖА́ТЕЛЬНОСТЬ утга төгөлдөр, гүнзгий агуулга.

СОДЕРЖА́ТЕЛЬН||ЫЙ утга төгөлдөр, гүнзгий агуулгатай; **~ая беседа** гүнзгий агуулгатай яриа.

СОДЕРЖА́ТЬ 1. тэжээх, тэтгэх; ~ **семью** гэр бүлээ тэжээх; 2. хорих, агуулах, байлгах; ~ **в тюрьме** шоронд хорих; 3. байлгах; ~ **вещи в порядке** юмаа эмхтэй байлгах; 4. агуулах, - тай *(- тэй, - той)* байх, бий.

СОДЕРЖА́ТЬСЯ 1. байх, хадгалагдах, хоригдох; **вино содержится в погребе** дарс зооринд хадгалагдана; 2. байлгах; ~ **в тайне** нууц байлгах; 3. байх, бий, багтах; **в метре содержится сто сантиметров** нэг метрт зуун сантиметр байдаг.

СОДЕРЖИ́МОЕ агуулсан зүйл, доторхи юм; ~ **ящика** хайрцагт агуулсан юм.

СО́ДОВ||ЫЙ соодын, соодтой; **~ая вода** соодтой ус.

СОДОКЛА́Д хавсралт илтгэл.

СОДОКЛА́ДЧИК хавсран илтгэгч, хавсралт илтгэл хийгч.

СОДО́М хөл үймээн, үймээн шуугиан; **поднять ~** үймээн шуугиан гаргах.

СОДРА́ТЬ хуулах, ховхлох, өвчих, шулах, шулгалах; ~ **шкуру с убитого зверя** алсан ангийн арьсыг өвчих.

СОДРОГА́НИЕ сэтгэл догдлох, донслох, дотор зарсхийх, чичрэх; **вспоминать с ~м** санахад дотор зарсхийх.

СОДРОГА́ТЬСЯ,

СОДРОГНУ́ТЬСЯ 1. чичирхийлэх, чичрэх; 2. сэтгэл догдлох, донслох, зарсхийх, чичирхийлэх; ~ **от ужаса** айж дотор зарсхийх.

СОДРУ́ЖЕСТВО андлал, нөхөрлөл, нөхөрсөг нэгдэл.
СО́ЕВ||ЫЙ буурцгийн, шар буурцгийн; **~ое масло** буурцгийн тос.
СОЕДИНЕ́НИЕ 1. нийлүүлэх, нийлэх, залгаа холбоо, нэгтгэх, нэгдэх; **~ сил** хүч нэгтгэх; 2. залгаа; 3. нэгдсэн анги; **танковое ~** танкийн нэгдсэн анги; 4. нийлэл; **химическое ~** химийн нэгдэл.
СОЕДИНЁНН||ЫЙ 1. холбосон, залгасан; 2. нэгдсэн, нийлсэн, хамтарсан, нэгдмэл, нийлмэл, хамтын; **~ыми усилиями** нэгдсэн хүчээр.
СОЕДИНИ́ТЕЛЬН||ЫЙ холбох, нийлүүлэх, нэгтгэх; **~ая ткань** холбох нэхдэс, холбогч эд; * **~ое деепричастие** зэрэгцэх нөхцөл.
СОЕДИНИ́ТЬ 1. холбох, залгах; **~ концы верёвки** татлагын үзүүрийг залгах 2. нэгтгэх, хамтатгах, нийлүүлэх, холбох; **~ теорию с практикой** онол практик хоёрыг холбох; 3. холбох, харилцуулах.
СОЕДИНИ́||ТЬСЯ 1. залгагдах, нийлэх; **провода ~лись** утас нийлжээ; 2. нэгдэх, хамтрах, нийлэх; 3. холбоо барих, харилцах; 4. бүрдэх, хослох.
СОЕДИНЯ́ТЬ 1. холбох, залгах; 2. нэгтгэх, хамтатгах, нийлүүлэх, холбох; 3. холбох, харилцуулах.
СОЕДИНЯ́ТЬСЯ 1. залгагдах, нийлэх; 2. нэгдэх, хамтрах, нийлэх; 3. холбоо барих, харилцах; 4. бүрдэх, хослох.
СОЖАЛЕ́НИ||Е 1. харамсах, хайрлах, халаглах, гэмших; **~я о потерянном времени** үрэгдүүлсэн цагандаа харамсах, цаг дэмий өнгөрүүлснээ харамсах; 2. өрөвдөх, хайрлах, хайр; **чувствовать ~ к кому-либо** хүнийг өрөвдөх; **к ~ю** харамсалтай нь, хайрлах нь, харамсалтай байна.
СОЖАЛЕ́ТЬ харамсах, хайрлах, халаглах, гэмших, харамсалтай байх; **~ о допущенных ошибках** алдаа гаргасандаа гэмших.
СОЖЖЕ́НИЕ шатаах, галдах, түлэх.
СОЖИ́ТЕЛЬ хамт суудаг хүн, цуг байдаг хүн, хамтран амьдрагч, нөхцөн амраг.
СОЖИ́ТЕЛЬНИЦА хамтран амьдрагч эмэгтэй, цуг байдаг эмэгтэй, нөхцөн
СОЖИ́ТЕЛЬСТВО хамт суух, хамтын амьдрал.
СОЖИ́ТЕЛЬСТВОВАТЬ хамт суух, цуг амьдрах, хамтран амьдрах.
СОЗВА́НИВАТЬСЯ утсаар ярилцах.
СОЗВА́ТЬ 1. урих, дуудах; **~ гостей** зочдыг урих; 2. зарлах, хуралдуулах.
СОЗВЕ́ЗДИЕ одны орд.
СОЗВОНИ́ТЬСЯ утсаар ярилцах.
СОЗВУ́ЧИЕ эгшиг нийлэх, найруу дуу, найрал авиа.
СОЗВУ́ЧН||ЫЙ 1. эгшиг нийлсэн, найруу дуут, найрал авиат; 2. зохицсон, нийцсэн, зохилдсон; **~ые образы** зохилдсон дүр.
СОЗДАВА́ТЬ 1. буй болгох, бүтээх, зохиох, байгуулах; 2. үүсгэх, төрүүлэх; 3. бэлтгэх, буй болгох.
СОЗДАВА́ТЬСЯ 1. буй болох, гарах, үүсэх; 2. үүсэх, төрөх; 3. байгуулагдах.
СОЗДА́НИ||Е 1. буй болгох, бүтээх, зохиох, байгуулах; **~ книги** ном зохиох; 2. бүтээл, зохиол; **~я художника** зураачийн бүтээл; 3. амьтан, хүн.
СОЗДА́ТЕЛЬ 1. бүтээгч, байгуулагч, үүсгэгч, зохиогч, гаргагч; **~ теории** онол зохиогч, онол гаргагч; 2. хамгийг бүтээгч.
СОЗДА́ТЬ 1. буй болгох, бүтээх, зохиох, байгуулах; **~ государство** төр байгуулах; 2. үүсгэх, төрүүлэх; **~ впечатление** сэтгэгдэл төрүүлэх; 3. бэлтгэх, буй болгох.
СОЗДА́||ТЬСЯ 1. буй болох, гарах, үүсэх; 2. үүсэх, төрөх; **~лось впечатление** сэтгэгдэл төрөв.
СОЗЕРЦА́НИ||Е бясалгах, бясалгал, даяан хийх, даяан; **предаваться внутреннему ~ю** амарлингуйд орох.
СОЗЕРЦА́ТЕЛЬНОСТЬ бясалгах, бясалгах чанар, ажиглан суух.
СОЗЕРЦА́ТЕЛЬНЫЙ бясалгадаг, ажиглан суух.
СОЗЕРЦА́ТЬ бясалгах, ажиглан суух, даяан хийх; **~ природу** байгалийг ажиглан суух.
СОЗИДА́НИЕ үүсгэн байгуулах, бүтээн байгуулах, бүтээх.
СОЗИДА́ТЕЛЬ үүсгэн байгуулагч, бүтээн байгуулагч, бүтээгч.
СОЗИДА́ТЕЛЬНЫЙ бүтээлч, бүтээн байгуулах; **~ труд** бүтээлч хөдөлмөр.
СОЗИДА́ТЬ үүсгэн байгуулах, бүтээн байгуулах, бүтээх.
СОЗИДА́ТЬСЯ буй болох, гарах, үүсэх, бүтэх.
СОЗНАВА́ТЬ 1. ухамсарлах, ухах, ойлгох; 2. ойлгох, мэдэх.
СОЗНАВА́ТЬСЯ *(бурууга)* хүлээх, улайх.
СОЗНА́НИЕ 1. мэдэх, ухамсарлах, бодол; **~ своего долга** үүргээ ухамсарлах; 2. хүлээх, мэдэх; **~ своей вины** гэмээ мэдэх; 3. ухамсар; 4. мэдээ, мэдрэл, ухаан; **потерять ~** мэдээ алдах, ухаан алдах; **прийти в ~** мэдээ орох, ухаан орох.
СОЗНА́ТЕЛЬНО 1. ухамсартай, учраа мэдэж; 2. зориуд, санаатай, мэдсээр байж; **сделать что-либо ~** зориуд хийх.
СОЗНА́ТЕЛЬНОСТЬ 1. ухамсар, учраа мэдэх; 2. зориуд хийх, санаатай үйлдэх, мэдсээр байж хийх.
СОЗНА́ТЕЛЬН||ЫЙ 1. ухамсартай; **человек — существо ~ое** хүн бол ухамсартай амьтан мөн; 2. ухамсартай, учрыг мэдэх; 3. зориуд үйлдсэн, санаатай хийсэн, мэдсээр байж үйлдсэн; **~ поступок** санаатай хийсэн хэрэг.
СОЗНА́ТЬ ухамсарлах, ухах, ойлгох; **~ свой долг** үүргээ ухамсарлах.
СОЗНА́||ТЬСЯ *(бурууга)* хүлээх, улайх; **~ в своей ошибке** алдаагаа хүлээх; **преступник во всём ~лся** ялтан бүх хэргээ улайв.
СОЗРЕВА́НИЕ боловсрох, болох, бойжилт; **половое ~** бэлгийн бойжилт.
СОЗРЕВА́ТЬ 1. боловсрох, болох, идээлэх; 2. боловсорч гүйцэх.
СОЗРЕ́ТЬ 1. боловсрох, болох, идээлэх; 2. боловсорч гүйцэх.
СО́ЗЫВ зарлах, хуралдуулах, удаагийн сонгуулийн.
СОЗЫВА́ТЬ 1. урих, дуудах; 2. зарлах, хуралдуулах.
СОЗЫВА́ТЬСЯ хуралдах.
СОИЗВО́ЛИТЬ соёрхох, хайрлах; **~ прийти** морилж ирэн соёрх.
СОИЗМЕРИ́МОСТЬ адил хэмжүүртэй *байх;* **~ величин** адил хэмжүүртэй хэмжигдэхүүн.
СОИЗМЕРИ́М||ЫЙ 1. адил хэмжүүртэй; 2. зүйрлэж болох, харьцуулж болмоор; **~ые понятия** зүйрлэж болох ухагдахуун.
СОИСКА́НИЕ горилох; **диссертация на ~ учёной степени** эрдмийн зэрэг горилох зохиол.
СОИСКА́ТЕЛЬ эрдмийн зэрэг горилогч.
СО́ЙКА туу, цуйран, ятга шаазгай, хулан жороо.
СОЙТИ́ I 1. буух, зайлах, хөдлөх, шилжих; 2. болох; 3. халих, мултрах, гарах, шилжих; **~ с рельсов** зам төмрөөс халих; 4. зулгарах, гуужих, хуурах, арилах; **кожа сошла** арьс гуужив.
СОЙТИ́ II гэгдэх, тоологдох; **~ за старика** өвгөн гэгдэх; * **сойдёт и так** ингээд ч болчихно; **~ с ума** солиорох.
СОЙТИ́СЬ 1. уулзах, дайралдах, учрах; 2. цуглах, цугларах; 3. ойртох, нөхөрлөх; 4. ханилах, нөхцөх; 5. нийлэх, таарах, тохиролцох; **~ во мнениях** санал нийлэх; **в цене ~** үнэ тохиролцох; 6. хүрэх; **пояс не сошёлся** бүс богинодов.
СОК шүүс, шим, шүүлт; **ягодный ~** жимсний шүүс; **желудочный ~** ходоодны шүүс; * **в полном ~у** ид дундаа, ид дээрээ.

СОКА́МЕРНИК *разг.* хамачлага.
СО́КОЛ начин, шонхор.
СОКО́ЛИК янаг, хонгор хүү.
СОКОЛИ́Н||ЫЙ начны, шонхрын; **~ая охота** шонхроор агнах; **~ взгляд** шонхрын харц.
СОКРАТИ́ТЬ 1. богиносгох, товчлох, хураангуйлах, хураах; **~ статью** өгүүлэл товчлох; **~ срок** хугацаа богиносгох; 2. багасгах, хасах, цөөтгөх, хороох, цомхтгох; **~ расходы** зарлага багасгах; 3. халах, гаргах; 4. хураангуйлах; **~ дробь** бутархай тоо хураангуйлах.
СОКРАТИ́||ТЬСЯ 1. богиносох, хорох, товчлогдох; **дни ~лись** өдөр богиносов; 2. багасах, хасагдах, цөөрөх, хорох, цомтох; **расходы ~лись** зарлага багасав; 3. хураангуйлагдах; 4. агших.
СОКРАЩА́ТЬ 1. богиносгох, товчлох, хураангуйлах, хураах; 2. багасгах, хасах, цөөтгөх, хороох, цомхтгох; 3. халах, гаргах; 4. хураангуйлах.
СОКРАЩА́ТЬСЯ 1. богиносох, хорох, товчлогдох; 2. багасах, хасагдах, цөөрөх, хорох, цомтгох; 3. хураангуйлагдах; 4. агших.
СОКРАЩЕ́НИ||Е 1. богиносгох, багасгах, хасах, товчлох, хураах, цомтгох; **~ штатов** орон тоо цомхтгох; 2. хураангуйлах; 3. хураасан үг, товчилсон үг; **список условных ~й** хураасан үгийн цэс; 4. хураангуйлах, товчлох.
СОКРАЩЁННО хураангуйлан, товчлон, хураангуй, товч; **писать ~** товчлон бичих.
СОКРАЩЁНН||ЫЙ товчилсон, хураангуйлсан, хураасан, товч, хураангуй; **~ое слово** хураасан үг, товчилсон үг.
СОКРОВЕ́НН||ЫЙ нандин, дотроо агуулсан, нууц; **~ые мысли** нандин бодол; **«~ое сказание монголов»** «Монголын нууц товчоо».
СОКРО́ВИЩЕ 1. эрдэнэ; 2. үнэт зүйл, эрдэнэ.
СОКРО́ВИЩНИЦА эрдэнэсийн сан.
СОКРУША́ТЬ *бут ниргэх, бут цохих, устгах.*
СОКРУША́ТЬСЯ энэлэх, шаналах, гашуудах, гуниглах.
СОКРУШЕ́НИЕ I *бут ниргэх, бут цохих, устгах.*
СОКРУШЕ́НИЕ II энэлэл, шаналал, гашуудал, гуниг.
СОКРУШИ́ТЕЛЬНЫЙ *бут ниргэх, устгах, аймшигтай;* **~ удар** аймшигт цохилт.
СОКРУШИ́ТЬ I *бут ниргэх, бут цохих, устгах.*
СОКРУШИ́ТЬ II энэлгэх, шаналгах, гашуудуулах, гуниглуулах.
СОКРЫ́ТИЕ нуух, далдлах; **~ преступления** гэмт хэргийг далдлах.
СОЛГА́ТЬ худал хэлэх.
СОЛДА́Т цэрэг; *** плох тот ~, который не мечтает стать генералом** олныг санасан хүн оргүй хоосон.
СОЛДА́ТСКИЙ цэргийн, цэрэг.
СОЛЕВАРЕ́НИЕ давс чанах.
СОЛЕ́НИ||Е 1. давслах; **~ грибов** мөөг давслах; 2. давсалсан идээ; **запас ~й** давсалсан идээний нөөц.
СОЛЁНОСТЬ давстай байх, давслаг; **~ морской воды** далайн давслаг ус.
СОЛЁН||ЫЙ 1. давстай, давслаг; **~ая вода** давстай ус, шорвог ус; 2. давсархаг, давстай; **слишком ~ суп** их давсархаг шөл, давс нь ихэдсэн шөл; 3. давсалсан, давсанд дарсан; **~ые огурцы** давсалсан өргөст хэмх.
СОЛИДАРИЗА́ЦИЯ эв санаа нэгдэх, эв санааны нэгдэл, санаа нийлэх.
СОЛИДАРИЗИ́РОВАТЬСЯ эв санаа нэгдэх, санаа нийлэх.
СОЛИДА́РНОСТЬ эв санаа нэгдэх, эв санааны нэгдэл, санаа нийлэх.
СОЛИДА́РН||ЫЙ санал нийлсэн, эв санал нэгтэй, хамтын; **~ая ответственность** хамтын хариуцлага; **~ые должники** *(юрид)* хамтран үүрэг гүйцэтгэгчид.
СРЕ́ДСТВ||О 1. арга, арга чарга, арга барил; **пустить в ход все ~а** бүх аргыг хэрэглэх; 2. хэрэгсэл, зэвсэг, хэрэглүүр; **~а производства** үйлдвэрлэлийн хэрэгсэл; ~ **защиты** хамгаалах хэрэгсэл; **~а финансовые** санхүүгийн хэрэгсэл; **язык** — ~ **общения людей** хэл бол хүмүүсийн харилцах хэрэглүүр мөн; 3. эм, хэрэглэгдэхүүн, зүйл, арга; ~ **от кашля** ханиадны эм; ~ **стимулирующее** идэвхжүүлэх бодис, хэрэглүүр; 4. **~а** мөнгө, хөрөнгө, бэл, тэжээл, арга; **оборотные** ~ гүйлгээний мөнгө, гүйлгээний хөрөнгө; **отпустить** ~ мөнгө олгох; ~ **существования** амин тэжээл, амь зуух арга.

СРЕДЬ дунд, хооронд; ~ **бела дня** гэгээн цагаан өдөр; ~ **гор** уулын дунд, уулсын хооронд.

СРЕЗ огтлоос, тайраас, огтолсон газар, тайрсан газар.

СРЕ́ЗАТЬ тайрах, зүсэх, өөлөх, шулах; ~ **угол** шууд явах.

СРИСОВА́ТЬ хуулан зурах, харж зурах, зурж авах; ~ **рисунок из книги** номын зураг харж зурах.

СРОДНИ́ хамаатай *(байх)*, төрөл *(байх)*, садан *(байх)*.

СРОДНИ́||ТЬ ижилсгэх, дасгах, ойртуулах, дөт болгох; **общая борьба нас ~ла** нэг тэмцэл биднийг ойртуулав.

СРОДНИ́||ТЬСЯ 1. ижилсэх, дасах, ойртох, дөт болох; **мы с ним ~лись за три года совместной жизни** тэр бид хоёр гурван жил хамт амьдарч дасав; 2. дасах, идээших; ~ **с работой** ажилдаа идээших.

СРОДСТВО́ нэг төрлийн *(байх)*, адил *(байх)*.

СРО́ДУ хүн болсоор, энэ насандаа, урьд хожид; ~ **не видел** энэ насандаа үзээгүй.

СРОК 1. хугацаа, цаг; **на долгий** ~ удаан хугацаагаар; **по истечении ~а** хугацаа гүйцэхэд; ~ **амортизационный** элэгдэл хорогдлын хугацаа; ~ **гарантии** баталгаат хугацаа; ~ **директивный** заагдсан хугацаа; ~ **испытательный** туршилтын хугацаа; ~ **кредита** зээллэгийн хугацаа; ~ **окупаемости** нөхөн төлөгдөх хугацаа; ~ **платежа** төлөх хугацаа; ~ **службы** эдэлгээний хугацаа; **годичный** ~ жилийн хугацаа; ~ **давности** хөөн хэлэлцэх хугацаа; **продлить** ~ хугацаа сунгах; **~ом до**.....хүртэл хугацаатай; 2. болзоо, болзох, хугацаа; **к ~у приехать** болзоондоо ирэх, хугацаандаа ирэх; **дай** ~ бололцоо олго, бололцоо гарга; **ни отдыху, ни ~у не давать** зогсоо жолоогүй яаруулах.

СРО́ЧНО яаралтай, нэн даруй, үтэр түргэн; ~ **выехать** яаралтай мордох.

СРО́ЧНОСТЬ 1. яаралтай *(байх)*; ~ **заказа** яаралтай захиалга; 2. яарах, тэвдэх; **что за ~?** яарах юу байна?

СРО́ЧН||ЫЙ 1. яаралтай; **~ая телеграмма** яаралтай цахилгаан мэдээ; ~ **пакет** яаралтай захидал; 2. хугацаатай, хугацаа бүхий, болзоотой; **~ая ссуда** хугацаатай зээллэг.

СРУБ 1. огтлох; **лес на** ~ огтлох мод; 2. торх, хашлага; **колодезный** ~ худгийн хашлага.

СРУБИ́ТЬ 1. огтлох, хийх; 2. барих, босгох; ~ **избу** байшин барих.

СРЫВ 1. тасалдуулах, саатуулах, эвдэх, алдагдуулах, таслах; 2. тасалдах, тасрах явдал, саатал; **~ов в работе не было** ажилд тасалдах явдал гараагүй.

СРЫВА́ТЬ I 1. таслах, тас татах, зулгаах, хуулах; хуу татах; 2. *(уурыг)* тайлах, гаргах.

СРЫВА́ТЬ II тасалдуулах, саатуулах, эвдэх, алдагдуулах.

СРЫВА́ТЬ III нураах, нурааж хаях, устгах.

СРЫВА́ТЬСЯ I 1. мултрах, алдуурах; 2. босон харайх; 3. унах; 4. үг алдах, санамсаргүй хэлчих.

СРЫВА́ТЬСЯ II тасалдах, эс бүтэх.

СРЫВА́ТЬСЯ III нураагдах, устгагдах.

СРЫ́ВЩИК тасалдуулагч, саатуулагч, эвдэгч.

СРЫ́ГИВАТЬ гулгих.

ССА́ДИНА шалбархай, шулгархай, зулгархай, дайр.

ССАДИ́ТЬ I буулгах.

ССАДИ́ТЬ II шалбалах, шалба татах, шулгалах, шулга татах, зулгалах, зулга татах; ~ **локоть** тохойгоо шалбалах.

ССА́ЖИВАТЬ I буулгах.

ССА́ЖИВАТЬ II *шалбалах*, шалба татах, шулгалах, шулга татах, зулгалах, зулга татах.

ССО́Р||А хэрүүл, хэрүүл доруул, хэрүүл баруул; **шумная** ~ хэрүүл шуугиан; **быть в ~е** хэрэлдсэн байх, муудсан байх.

ССО́РИТЬ хэрэлдүүлэх, муудуулах, хэрүүл хийлгэх, хэрүүл болгох.

ССО́РИТЬСЯ хэрэлдэх, муудах, хэрүүл хийх, хэрүүл болох.

ССО́Х||НУТЬСЯ хагсах, хатах; **глина ~лась** *шавар* хатжээ.

СССР *(Союз Советских Социалистических Республик)* ЗСБНХУ.

ССУ́ДА зээллэг, зээл; **долгосрочная** ~ удаан хугацааны зээллэг; **беспроцентная** ~ хүүгүй зээллэг; ~ **банковская** банкны зээллэг.

ССУДИ́ТЬ зээлүүлэх, зээлдүүлэх, зээллэг олгох, зээл өгөх; ~ **небольшую сумму** цөөн төгрөг зээлүүлэх.

ССУ́ДН||ЫЙ зээлийн, зээлүүлэх, зээлдэх; **~ая касса** зээлийн касс; ~ **капитал** зээлүүлэх капитал, зээлүүлэх мөнгө.

ССУЖА́ТЬ зээлдүүлэх, зээлүүлэх, зээл өгөх, зээллэг олгох.

ССЫЛА́ТЬ цөлөх.

ССЫЛА́ТЬСЯ шалтаг заах, шалтаглах, иш татах, нэр барих.

ССЫ́ЛК||А I цөллөг; **жить в ~е** цөллөгөнд байх; **сослать в ~у** цөллөгөнд явуулах, цөлөх.

ССЫ́ЛКА II 1. иш татах, шалтаг заах, нэр барих; ~ **на авторитет** *алдар хүндтэй хүний нэр барих*; 2. иш татсан зүйл, заалт; ~ **напечатана внизу текста** иш татсан зүйл эх бичгийн доод талд бий.

ССЫ́ЛЬНЫЙ цөлөгдсөн хүн.

ССЫ́ПАТЬ хийх, (*тарна*) тушаах, хүлээлгэн өгөх; ~ **муку в мешок** гурил шуудайд хийх.

СТАБИЛИЗА́ТОР тогтворжуулагч.

СТАБИЛИЗА́ЦИЯ тогтонгишуулал, тогтонгишуулах, тогтонгишил, тогтонгиших.

СТАБИЛИЗИ́РОВАТЬ тогтонгишуулах.

СТАБИЛИЗИ́РОВАТЬСЯ тогтонгиших.

СТАБИ́ЛЬНОСТЬ тогтонги (*байх*), тогтвортой байх, тогтонги байдал, тогтонги чанар.

СТАБИ́ЛЬН||ЫЙ тогтонги, тогтонгишсон; **~ые цены** тогтонги үнэ.

СТА́ВЕНЬ цонхны самбар.

СТА́ВИТЬ 1. тавих, өрөх, босгох, зоох; ~ **столбы** шон зоох; 2. тавих, хийх, оруулах; ~ **вещи на место** юмыг байранд нь тавих; 3. тавих, гаргах; ~ **часового на пост** харуул гаргах; 4. босгох, байгуулах, тавих; ~ **памятник великим людям** их хүмүүст хөшөө байгуулах; ~ **телефон** утас тавих; 5. тавих, хийх, наах; ~ **термометр** *халууны шил хийх*; ~ **банки** бумба тавих; 6. тавих, зурах; ~ **свою подпись** гарынхаа үсгийг зурах; 7. тавих, зохиох, хийх; ~ **новую пьесу** шинэ жүжиг тавих; ~ **опыты** туршлага хийх; 8. тавих, тогтоох, оруулах; ~ **задачу** зорилт тавих; ~ **твёрдые сроки** хатуу хугацаа тогтоох; 9. оруулах, байлгах; ~ **в трудное положение** бэрх байдалд оруулах; ~ **под контроль рабочих организаций** ажилчны байгууллагын хяналтад байлгах; 10. (*мөнгө*)тавих; ~ **на туза** тамгад тавих; 11. засах; ~ **голос** хоолойгий нь засах; 12. тавих, хийх, тогтоох; ~ **диагноз** оношт тавих; 13. хүлээлгэх, оногдуулах; ~ **в обязанность** үүрэг хүлээлгэх; ~ **в вину** бурууг оногдуулах; 14. болгох, тооцох; ~ **за правило** журам болгох; **его ни во что не ставят** түүнийг хүнд тооцдоггүй; ~ **в известность** мэдэгдэх; ~ **на карту** төөрөг мэдэг гэх, яавал яаг гэх; ~ **крест на чем-либо** дүүрсэн хэрэг гэж үзэх; ~ **часы** цаг тааруулах; ~ **во главу угла** нэн чухалд тооцох.

СТА́ВИТЬСЯ тавигдах.

СТА́ВКА I өргөө; ~ **Верховного главнокомандующего** бүх цэргийн жанжны өргөө.

СТА́ВК||А II 1. мөрий, бооцоо, тавьц; **крупная** ~ том бооцоо; 2. цалин; ~ **льготная** хөнгөлөлттэй цалин; ~ **налоговая** цалингийн татвар; ~ **процентная** хүүний хэмжээ; **повышение ~и** цалин нэмэгдэх; 3. хэмжээ; **~и подоходного налога** ашгийн татварын хэмжээ; 4. найдвар, найдлага; **делать ~у на кого-либо** хүнд найдварлах, найдах; **очная** ~ нүүрэлдүүлэх.

СТА́ВЛЕННИК гарын хүн, төлөөний хүн.

СТА́ВНИ цонхны самбар.

СТАГНА́ЦИЯ стагнаци, зогсонги байдал, үлбэгэр, тогтонги байдал; **экономическая** ~ эдийн засгийн зогсонги байдал.

СТАДИО́Н цэнгэлдэх хүрээлэн.

СТА́ДИЯ шат, үе; ~ **возбуждения** сэрлийн шат.

СТА́ДНОСТЬ *сүрэглэх, сүрэглэн амьдрах.*

СТА́ДН||ЫЙ 1. сүрэглэх, сүрэглэн амьдрах, сүрэг; **~ое животное** сүрэглэх амьтан; 2. сүргийн; **~ое чувство** сүргийн мэдрэхүй.

СТА́ДО сүрэг; ~ **коров** сүрэг үнээ.

СТАЖ 1. *(ажилласан)* хугацаа; **трудовой** ~ хөдөлмөрлөсөн хугацаа; ~ **непрерывный** тасралтгүй ажилласан хугацаа; 2. *дадлагажих хугацаа, дагалдан сургах хугацаа*; **испытательный** ~ дадлагажих хугацаа, турших хугацаа.

СТАЖЁР дадлагажигч, дагалдан сурагч.

СТАЖИРОВА́ТЬ дадлагажих, дагалдан сурах.

СТАЖИРО́ВКА дадлагажих, дадлагажилт, дагалдан сурах.

СТА́ЙЕР хол уралдагч, холч.

СТАКА́Н шилэн аяга, домбон аяга, стакан аяга; **выпить ~ чаю** аяга цай уух.

СТАЛЕБЕТО́Н болд бетон, төмөр бетон.

СТАЛЕВА́Р болд хайлуулагч, ган хайлуулагч.

СТАЛЕЛИТЕ́ЙНЫЙ болд цутгах, ган цутгах; ~ **завод** болд цутгах үйлдвэр.

СТАЛЕПЛАВИ́ЛЬН||ЫЙ болд хайлуулах, ган хайлуулах; **~ая печь** ган хайлуулах зуух.

СТАЛЕПРОКА́ТНЫЙ болд цувих, ган цувих; ~ **цех** ган цувих цех.

СТА́ЛКИВАТЬ 1. түлхэх, түлхэн хөдөлгөх, түлхэн унагах; 2. мөргөлдүүлэх, хавиралдуулах, харшилдуулах.

СТА́ЛКИВАТЬСЯ 1. мөргөлдөх, хавиралдах, харшилдах; 2. мөргөлдөх, дайралдах, тохиолдох; 3. харшилдах, мөргөлдөх, харгалдах.

СТАЛ||Ь болд, ган; **закалка ~и** болд хатаах; **рассорная ~** нумын ган; 2. **~ дамасская** мишил болд.

СТАЛЬН||О́Й 1. ган, болд, гангаар хийсэн; **~ нож** ган хутга; 2. болдын өнгөтэй, гангийн өнгөтэй; 3. ган болд, ган төмөр, ган хатуу; **~ая воля** ган болд зориг.

СТАМЕ́СКА цүүц.

СТАН I их бие, бие.

СТАН II 1. суурь, буудал, хүрээ; **военный ~** цэргийн хүрээ; 2. этгээд, тал, бүлэг, сүрэг; **вражеский ~** дайсны тал.

СТАН III суурь; **прокатный ~** цувих суурь.

СТАНДА́РТ 1. стандарт загвар, үлгэр, нэг хэв, нэг маяг; **изготовить по ~у** нэг загвараар үйлдэх; **~ отраслевой** салбарын стандарт; 2. стандарт, үндсэн хэмжээ; **золотой ~ в денежном обращении** мөнгөний эргэлтийн алтны үндсэн хэмжээ; 3. улиг болсон юм, нэг хэмийн юм, нэг янзын юм.

СТАНДАРТИЗА́ЦИЯ стандартчилах, загварчлах, нэг хэвийн болгох, стандартчилалт, загварчлалт.

СТАНДАРТИЗИ́РОВАТЬ стандартчилах, загварчлах, нэг хэвийн болгох, нэг маяг болгох.

СТАНДА́РТНОСТЬ стандарт *(байх)*, нэг загварын *(байх)*, нэг маяг *(байх)*.

СТАНДА́РТН||ЫЙ 1. стандарт, стандартад тохирсон, нэг загварын, нэг хэвийн, нэг маягийн; **~ые изделия** стандарт эдлэл; 2. улиг болсон, нэг хэмийн, нэг янз; **~ые фразы** улиг болсон үг.

СТАНИ́ЦА хасаг тосгон, том суурин.

СТАНИ́ЧНЫЙ хасаг тосгоны.

СТА́НКОВ||ЫЙ I адууны хоргын; **~ая загородка** адууны хоргын хашаа.

СТА́НКОВ||ЫЙ II 1. суурилуулсан, суурилууртай; 2. тавиурын; **~ая живопись** тавиурын уран зураг.

СТАНКОСТРОЕ́НИЕ суурь машин үйлдвэрлэх.

СТАНКОСТРОИ́ТЕЛЬНЫЙ суурь машин үйлдвэрлэх; **~ завод** суурь машин үйлдвэрлэх үйлдвэр.

СТАНОВИ́ТЬСЯ 1. болох, зогсох, гаран зогсох; 2. буух; 3. хийж эхлэх, ажиллаж эхлэх; 4. болох.

СТАНОВЛЕ́НИЕ үүсэх, үүсэн тогтох, тогтох; **~ нового быта** шинэ ахуй үүсэн тогтох.

СТАНОВО́Й гол, уг; **~ хребет** гол нуруу; **~ берег** уг эрэг.

СТАНО́К 1. суурь машин; **печатный ~** хэвлэлийн суурь машин; 2. суурилуур, суурь.

СТАНО́ЧНИК суурь машинч.

СТАНО́ЧНЫЙ суурь машины; **~ завод** суурь машины үйлдвэр.

СТАНЦИО́НН||ЫЙ өртөөний; **~ое здание** өртөөний байшин.

СТА́НЦИЯ 1. өртөө; **железнодорожная ~** төмөр замын өртөө; 2. өртөө *(газар)*; 3. хороо, өртөө, станци; **телефонная ~** утасны хороо; **~ опытная** туршилтын станц.

СТА́ПТЫВАТЬ майжийлгах, майжгий гишгэх, хазгай гишгэх.

СТАРА́НИ||Е хичээлт, оролдолт, мэрийлт, чармайлт, хичээх, оролдох, мэрийх, чармайх; **приложить все ~я** бүх чармайлтаа тавих; **работать с большим ~ем** их мэрийн ажиллах.

СТАРА́ТЕЛЬ алт хайгч, эрэгч.

СТАРА́ТЕЛЬНО хичээнгүйлэн, хичээн, оролдлоготой, мэрийлттэй, чармайн.

СТАРА́ТЕЛЬНОСТЬ хичээл, оролдлого, оролдоц, мэрийлт.

СТАРА́ТЕЛЬНЫЙ хичээнгүй, хичээлтэй, зүтгэлтэй, оролдлоготой, мэрийлттэй; **~ ученик** хичээлтэй сурагч.

СТАРА́ТЕЛЬСКИЙ алт хайх, алт эрэгчдийн.

СТАРА́ТЕЛЬСТВО алт хайх, алт эрэх.

СТАРА́||ТЬСЯ хичээх, оролдох, мэрийв, улайх, оролдох, мэрийх, улайх, чармайх, зүтгэх; **~ изо всех сил** чадлаараа оролдох, үхэн зүтгэх; **~лся удержаться на ногах** хөл дээрээ тогтох гэж мэрийх.

СТАРЕ́ЙШИНА омгийн тэргүүлэгч, зайсан.

СТАРЕ́НИЕ 1. өтлөх; 2. хуучралт; **~ информации** мэдээллийн хуучралт.

СТАРЕ́ТЬ 1. өтлөх, хөгшрөх, өвгөрөх; 2. хуучрах.

СТА́РЕЦ өтгөс, өвгөн; **мудрый ~** мэргэн өтгөс буурал.

СТАРИ́К өвгөн.

СТАРИКО́ВСКИЙ өвгөн хүний, өвгөдийн.

СТАРИН||А́ I 1. хуучин цаг, эртний үе, хуучин; **в ~у** хуучин цагт; **преданья ~ы** хуучин домог; 2. хуучин юм; **коллекционировать ~у** хуучны юм цуглуулах; **тряхнуть ~ой** хуучнаа сэргээх, залуугийнхийгаа сэргээх.

СТАРИНА́ II өвгөн; **послушай, ~!** өвгөн сонс!

СТАРИ́НК||А по старинке хуучныхаар, хуучин цагийнхаар, хуучны ёсоор; **работать по ~е** хуучин цагийнхаар ажиллах.

СТАРИ́НН||ЫЙ хуучны, хуучин цагийн; **~ обычай** хуучны заншил; **~ая пословица** хуучны зүйр үг.

СТА́РИ||ТЬ 1. өвгөрүүлэх, хөгшрүүлэх, өтлүүлэх; 2. овор оруулах, оворжуулах; **борода его ~т** сахал нь овор оруулна.

СТА́РИТЬСЯ өвгөрөх, хөгшрөх, өтлөх.

СТА́РИЦА татуурга.

СТАРИЧО́К өвгөн, өвөө.

СТАРОВЕ́Р шимээсэг, хуучин номтон.

СТАРОДА́ВНИЙ эрт урьдын; **~ обычай** эрт урьдын заншил.

СТАРОЖИ́Л уул нутгийн хүн, хуучин сууж байсан хүн.

СТАРОМО́ДН||ЫЙ янз нь хуучирсан, хуучирсан маягтай; **~ая шляпа** янз нь хуучирсан малгай.

СТАРООБРА́ЗН||ЫЙ өвөгжөөр, овор ихтэй, хөгшин царайтай; **~ое лицо** өвөгжөөр царай.

СТАРООБРЯ́ДЕЦ шимээсэг, хуучин ёстон.

СТАРООБРЯ́ДЧЕСКИЙ шимээсгийн.

СТАРОРЕЖИ́МН||ЫЙ хуучин засгийн үеийн, эзэрхэг засгийн үеийн; **~ые взгляды** эзэрхэг засгийн үеийн үзэл.

СТАРОСВЕ́ТСК||ИЙ хуучны заншилтай; **~ие помещики** хуучны заншилтай газрын эзэд.

СТАРОСЛАВЯ́НСКИЙ хуучин слав; **~ язык** хуучин слав хэл.

СТА́РОСТА ахлагч; **~ группы** бүлгийн ахлагч.

СТА́РОСТ||Ь нас өвгөрөх, хөгшрөх, өтлөх, өтөл нас; **на ~и лет** нас өвгөрсөн хойно, өтөл насандаа.

СТАРТ 1. гараа, гарааны дохио, тавих дохио; **дать ~** гарааны дохио өгөх; **взять ~** уралдаж эхлэх, тавих; 2. гарааны газар, тавих газар, эхлэх газар.

СТА́РТЕР гарааны дохио өгөгч, эхлэх дохио өгөгч, хөдөлгөгч, дохиологч.

СТАРТОВА́ТЬ уралдаж эхлэх, эхлэн хөдлөх, тавих.

СТАРУ́ХА эмгэн, хөгшин.

СТАРУ́ШЕЧИЙ эмгэдийн, эмгэд хөгшдийн, хөгшин хүний.

СТА́РЧЕСК||ИЙ өтөлсөн, өвгөн хүний, хөгшин; **~ая физиономия** хөгшин царай; **~ кашель** өвгөн хүний ханиах.

СТА́РШ||ИЙ 1. ахмад, ах, эгч, их, эгчмэд, ууган; **~ сын** ууган хүү, их хүү; **~ брат** ах; **~ая дочь** эгчмэд охин, их охин; **~ая сестра** эгч; 2. ахлагч, ахлах; **~ научный сотрудник** эрдэм шинжилгээний ахлах ажилтан; **~ лейтенант** ахлагч дэслэгч; 3. ах хүн, ахмад, эгчмэд хүн, эгч хүн.

СТАРШИНА́ ахлагч.

СТАРШИ́НСТВ||О 1. ахлах, ахмад настан, эгчмэд настан; 2. ахлах, ахмад тушаалтан; **по ~у** ахлахаараа, ахмадаараа.

СТА́Р||ЫЙ 1. өвгөн, настай, хөгшин; **~ человек** өвгөн хүн; **~ конь** хөгшин морь; 2. хуучны, урьдын, эртний; **~ знакомый** урьдын танил; 3. хуучин, хуучирсан; 4. хуучин, хэрэг өнгөрсөн, хугацаа хэтэрсэн; **~ билет** хуучин тасалбар;

5. хуучны, хуучин цагийн; **~ая архитектура** хуучны уран барилга; 6. хуучирсан, хуучин, урьдын; **~ые времена** хуучин цаг, урьдын цаг; 7. хуучин, урьдын, түрүүчийн; **~ая квартира** хуучин байр, түрүүчийн байр; 8. **старое** хуучин юм, хуучин; **по~ому** хуучнаараа; **стар и мал, ~ и малый** хөгшин залуугүй, их багагүй; **по ~ой памяти** хуучнаа сэргээе гэж, хуучнаа санаад.

СТАРЬЁ хуучин юм, новш.

СТАРЬЁВЩИК хуучин юмны наймаачин.

СТАСКА́ТЬ зөөж аваачих, аваачиж тавих; **~ дрова в сарай** түлээ саравчинд зөөж аваачих.

СТА́СКИВАТЬ 1. гулдран аваачих, чирж оруулах; 2. хуу татах, хуулах, суга татах, сугалах, тайлах.

СТА́ТИКА 1. статик, тэнцэллэг; 2. тогтонги байдал, тэнцвэр, тэнцэл.

СТАТИ́СТ дагалдан тоглогч.

СТАТИ́СТИК тоо бүртгэгч, статистикч.

СТАТИ́СТИКА 1. тоо бүртгэлийн ухаан, статистик; 2. тоо бүртгэл.

СТАТИСТИ́ЧЕСК||ИЙ тоо бүртгэлийн; **~ая таблица** тоо бүртгэлийн хүснэгт.

СТАТИ́ЧЕСКИЙ 1. статик, тэнцэллэг; 2. тогтонги, хөдөлдөггүй.

СТАТИ́ЧНЫЙ тогтонги, хөдөлдөггүй.

СТА́ТНЫЙ гуалиг биетэй, бие тэгш, бие бялдар сайтай; **~ юноша** бие бялдар сайтай залуу.

СТА́ТСКИЙ иргэний; **~ советник** тавдугаар зэргийн түшмэл.

СТАТС-СЕКРЕТА́РЬ төрийн нарийн бичгийн дарга.

СТА́ТУС-КВО статус-кво, тухайн байдал; **восстановить ~** тухайн байдлыг сэргээх.

СТАТУЭ́ТКА бяцхан хүн хөшөө.

СТА́ТУЯ хүн хөшөө, хүний дүр.

СТА||ТЬ I 1. *босох*; **ни ~, ни сесть** босох ч, суух ч аргагүй; **~ на цыпочки** өлмий дээрээ босох; 2. зогсох, тогтох, явахаа болих; **часы ~ли** цаг зогсов, явахаа болив; 3. хөлдөх, баринтаглах; **река ~ла** гол хөлдөв; 4. гарч зогсох; **~ на ковёр** хивс дээр гарч зогсох; 5. буух; 6. эхлэх, ажиллаж эхлэх, хийж эхлэх; 7. болох, гарах; **~ известным** нэрд гарах; **~ примером** үлгэр жишээ болох; 8. болох; **на улице ~ло темно** гадаа харанхуй болов 9. *үгүйсгэх не - гийн хамт үгүй болох*; 10. хүрэх, байх; **~нет ли у тебя сил?** хүч чадал чинь хүрэх үү? 11. хүрэх, болох, зарах; **во что бы то ни ~ло** юу ч боллоо гэсэн, яалаа ч гэсэн; **~ло быть** тэгвэл, чингэхүл.

СТАТЬ II *бие бялдар*; **под ~** таарах, зохих, зохицох; **под ~ ему была и жена его** түүнд эхнэр нь ч таарч байлаа.

СТАТ||Ь III шинж, маяг; *** с какой ~и?** ямар учраас, яалаа гэж, яагаад, юунд?

СТА́||ТЬСЯ что с ним ~лось? тэр яав? тэр юу болов? **может ~** магадгүй, болох юм, тийм байж мэднэ.

СТАТЬЯ́ 1. өгүүлэл; **передовая ~** тэргүүний өгүүлэл; **журнальная ~** сэтгүүлийн өгүүлэл; **научная ~** эрдэм шинжилгээний өгүүүлэл; 2. зүйл; **~ закона** хуулийн зүйл; **~ дохода** орлогын зүйл, орлогын анги.

СТАЦИОНА́Р байран байгууллага, суурин байгууллага.

СТАЦИОНА́РН||ЫЙ 1. байнгын, тогтмол; **~ое состояние** байнгын байдал; 2. байран, суурин; 3. байран, хэвтэж эмнүүлдэг; **~ больной** байран өвчтөн; 4. байран эмнэх, хэвтүүлж эмчлэх.

СТАЧА́ТЬ шивж оёх.

СТА́ЧЕЧНИК ажил хаягч.

СТА́ЧЕЧН||ЫЙ ажил хаях, ажил хаягчдын; **~ое движение** ажил хаях хөдөлгөөн; **~ комитет** ажил хаягчдын хороо.

СТА́ЧИВАТЬ билүүдэх, билүүдэж гаргах, гуранздах, хуурайдах, үрэх.

СТА́ЧКА ажил хаях.

СТАЩИ́ТЬ 1. гулдран аваачих, чирж оруулах, чирж гаргах; **~ пароход с мели** газардсан галт онгоцыг чирж гаргах; 2. хуу татах, хуулах, суга татах, сугалах, тайлах; **~ сапог с ноги** өрөөсөн гутал сугалах; 3. сэм авах, хулгайлах, дэлсэх.

СТА́Я сүрэг; **~ волков** сүрэг чоно; **~ рыбы** заарцаг.

СТА́Я||ТЬ хайлах; **снег ~л** цас хайлав.

СТВОЛ 1. их бие, иш; **~ берёзы** хусны их бие; 2. (*буюу*) гол төмөр; 3. гол ам; **~ шахты** уурхайн гол ам; 4. судас, судал, багана; **~ блуждающего нерва** хэрмэл мэдрэлийн багана.

СТВОРА́ЖИВАТЬ эздүүлэх, шалхмагтуулах, ээзгийрүүлэх.

СТВОРА́ЖИВАТЬСЯ эздэх, *шалхмагтах*, ээзгийрэх.

СТВО́РК||А далавч, хавтас; **~и ставней** цонхны далавч.

СТВОРО́ЖИТЬ эздүүлэх, шалхмагтуулах, ээзгийрүүлэх.

СТВОРО́ЖИТЬСЯ эздэх, шалхмагтах, ээзгийрэх.

СТВО́РЧАТ||ЫЙ далавчтай, хавтастай; **~ая дверь** далавчтай хаалга.

СТЕАРИ́Н стеарин, царц.

СТЕАРИ́НОВЫЙ 1. стеарины, царцын; 2. стеарин, царц, царцаар хийсэн.

СТЕ́БЕЛЬ 1. иш, шилбэ; **~ травы** өвсний шилбэ; 2. шилбэ; **~ листа** навчны шилбэ.

СТЕ́БЕЛЬНЫЙ (*ургамлын*) *ишийн, шилбэний*.

СТЕБЕ́ЛЬЧАТЫЙ иштэй, шилбэтэй.

СТЕБЛЕВА́НИЕ ишлэх, шилбэлэх.

СТЕБЛИ́СТЫЙ ишлэг, шилбэлэг, олон иштэй.

СТЁГАНКА хөвөнтэй хүрэм, олондой.

СТЁГАН||ЫЙ хавмал, хаваастай, ширээстэй, ширмэл, хөвөнтэй; **~ое одеяло** хаваастай хөнжил, хөвөнтэй хөнжил.

СТЕГА́ТЬ I гуядах, туйвандах, саваадах, ташуурдах.

СТЕГА́ТЬ II хавах, ширэх; **~ одеяло** хөнжил хавах.

СТЕГНУ́ТЬ гуядаад авах, шавхраад орхих.

СТЁЖКА I 1. хавах, ширэх; 2. хаваас, ширээс, оёдол.

СТЁЖКА II *жим, зөрөг*.

СТЕЖО́К хаваас, ширээс, оёдол.

СТЕЗЯ́ харгуй, зам.

СТЕКА́ТЬ урсан орох, гоожих, савирах.

СТЕКА́ТЬСЯ 1. урсан нийлэх, цутгах, хурах; 2. хурах, цугларах.

СТЕКЛЕНЕ́ТЬ цийлийх, цийлгэр болох.

СТЕКЛО́ шил; **оконное ~** цонхны шил; **зеркальное ~** толины шил; **цветное ~** өнгийн шил; **вставлять ~** шиллэх.

СТЕКЛОВИ́ДНЫЙ шилэрхүү, шил шиг.

СТЕКЛО́ГРАФ шилэн бар.

СТЕКЛОДУ́В *шил үлээгч*.

СТЕКЛОДУ́ВНЫЙ шил үлээх.

СТЕКЛОЗАВО́Д шилний үйлдвэр.

СТЕКЛОРЕ́ЖУЩИЙ шил зүсэх; **~ инструмент** шил зүсүүр.

СТЕКЛОРЕ́З 1. шил зүсэгч; 2. шил зүсүүр.

СТЕКЛЯ́НН||ЫЙ 1. шил, шилний; **~ая масса** шил; 2. шилэн, шилээр хийсэн; **~ая посуда** шилэн сав; 3. шилэн, шилтэй, шил хийсэн; **~ая дверь** шилэн хаалга; 4. цийлгэр, цийлийсэн.

СТЕКЛЯ́РУС өнгийн шил чимэг, жинжүү.

СТЕКЛЯ́РУСНЫЙ өнгийн шил, жинжүү.

СТЕКЛЯ́ШКА шилний хэлтэрхий.

СТЕКО́ЛЬЩИК *шилч*.

СТЕЛИ́ТЬ 1. дэлгэх, дэвсэх, засах; 2. тавих, зүйж хийх.

СТЕЛЛА́Ж 1. давхарлаг тавиур; 2. босоо тавиур.

СТЕ́ЛЬК||А улавч; *** в ~у пьяный** «тас» компаний захирал болох..

СТЕ́ЛЬНАЯ хэлтэй, тугаллах; * ~ **корова** боос.
СТЕ́ЛЬНОСТЬ хэлтэй (*байх*).
СТЕМНЕ́||ТЬ харанхуй болох; **уже ~ло** харанхуй болов.
СТЕН||А́ 1. хана, туурга; **капитальная** ~ зузаан туурга; 2. хэрэм; **крепостная** ~ хэрэм; 3. жагсаал, эгнээ; 4. харанхуй, шигүү; ~ **деревьев** харанхуй мод; ~ **тумана** харанхуй манан; **в четырёх ~ах** гэрийн мухар сахиад; **как об ~у горох** хаданд харвасан сум адил; **как за каменной ~ой** бат цайзанд байгаа адил; **припереть к ~е** амыг таглах, гарцаагүй болгох; **на ~у лезть** мод мөргөөр цухалдах.
СТЕНА́ТЬ гаслах, ёолох.
СТЕНГАЗЕ́ТА ханын сонин.
СТЕНД 1. үзмэрийн самбар, тавиур; 2. турших газар, туршуур.
СТЕ́НК||А хана, туурга; **поставить к ~е** буудан алах.
СТЕНН||О́Й ханын, туурганы; **~ая живопись** туурганы зураг; ~ **календарь** ханын хуанли.
СТЕНОБИ́ТН||ЫЙ хэрэм цөмлөх; **~ое оружие** хэрэм цөмлөх зэвсэг.
СТЕНОГРА́ММА таталгасан тэмдэглэл; ~ **доклада** илтгэлийн таталгасан тэмдэглэл.
СТЕНОГРАФИ́РОВАТЬ таталган бичих, таталган тэмдэглэх; ~ **прения** шүүмжлэл таталган бичих.
СТЕНОГРАФИ́СТ таталган бичигч.
СТЕНОГРАФИ́ЧЕСКИЙ таталган бтчсэн, таталган тэмдэглэсэн; ~ **отчёт** таталган бичсэн тайлан.
СТЕНОГРА́ФИЯ таталгах бичиг.
СТЕНО́З бачуудах.
СТЕНОКАРДИ́Я зүрхний бах өвчин.
СТЕНОПИСЬ туурганы зураг.
СТЕПЕ́ННО намбатай, төлөв, түвшин, томоотой, төв; ~ **здороваться** намбатай мэндлэх.
СТЕПЕ́ННОСТЬ намба, төлөв зан, түвшин байдал, томоо.
СТЕПЕ́ННЫЙ 1. намбатай, намбагар, төлөв, түвшин, төв, томоотой; ~ **человек** намбатай хүн; 2. настай, томоотой, насжуу.
СТЕ́ПЕН||Ь 1. зэрэг, хэмжээ, хир, хир зэрэг, хир хэмжээ; ~ **мастерства** мэргэжлийн хир, уран чадварын хэмжээ; **в высшей ~и** туйлын их, маш их; **в значительной ~и** нилээд их, үлэмжхэн; **в равной ~и** адил хэмжээгээр, нэг адил; **до известной ~и** мэдээж хэмжээгээр, бага зэрэг; **в некоторой ~и** ямар нэг хэмжээгээр, зарим талаар, заримдаа; **до какой ~и** хир зэрэг, хэдий хүртэл; **ни в малейшей ~и** бага зэрэг ч, өчүүхэн ч; **до какой ~и** төдий чинээ, тийм ч; 2. *(эрдмийн)* зэрэг; **возвести в** ~ зэрэг дэвшүүлэх; **показатель ~и** зэрэг илтгэгч; 4. зэрэг; **сравнительная** ~ харьцуулсан зэрэг; **превосходная** ~ давуу зэрэг.
СТЕПН||О́Й талын, хээрийн, тал газрын; **~ая зона** хээрийн бүслүүр; **~ая растительность** хээрийн ургамал, хээрийн өвс ногоо.
СТЕПНЯ́К тал нутгийн хүн.
СТЕПЬ тал, хээр.
СТЕРВЯ́ТНИК дэлт бүргэд.
СТЕРЕОКИНО́ стереокино.
СТЕРЕОМЕ́ТРИЯ стереометри, дүрс хэмжих ухаан.
СТЕРЕОСКО́П стереоскоп.
СТЕРЕОТИ́П төмөрлөг хэв, хэвшсэн бодол, хандлага.
СТЕРЕОТИ́ПН||ЫЙ 1. төмөрлөг хэвийн; **~ое издание** төмөрлөг хэвийн хэвлэл; 2. олон, давтсан, байнга ярьдаг, дөжин болсон; **ответ** ~ олон давтсан хариу.
СТЕРЕ́ТЬ 1. арчих, арилгах; ~ **пыль** тоос арчих, арилгах; ~ **пот с лица** нүүрийн хөлс арчих; 2. баллах, баллуурдах, арчих; ~ **пятно** толбо арилгах; 3. холгох, үрэх, шалбалах; ~ **ногу** нөлөө холгох; 4. нухах; ~ **что- либо в порошок** юм нухаж талхлах; ~ **кого-либо в порошок** үнсэн товрог болгох; ~ **с лица земли** газрын хөрснөөс арилгах.
СТЕРЕ́ТЬСЯ 1. арилгах, балрах; **краска на скамейке стёрлась** бандангийн будаг арилжээ; 2. алга болох, үгүй болох, мартагдах; 3. мөлийх, мөлүү болох; **монета стёрлась** зоос мөлийжээ.
СТЕ́РЕХ цэн, цагаан тогоруу.
СТЕРЕ́ЧЬ 1. харах, сахих, манах, хариулах, адуулах; 2. отох, амдах; ~ **волка** чоно отох.
СТЕ́РЖЕНЬ 1. гол, иш, шилбэ, туйван; ~ **поршня** бүлүүрийн шилбэ; 2. гол, нуруу; ~ **исследования** шинжилгээний гол нь.
СТЕРЖНЕВО́Й 1. голтой, иштэй, шилбэтэй; ~ **трансформатор** голтой хувьсгуур; 2. гол, ноён.
СТЕ́РЛЯДЬ бэхэр.
СТЕРИЛИЗА́ТОР ариутгуур.
СТЕРИЛИЗА́ЦИЯ 1. ариутгах; ~ **хирургических инструментов** мэс заслын багаж ариутгах; 2. засах, хөнгөлөх.
СТЕРИЛИЗОВА́ТЬ 1. ариутгах, ариутгал; 2. засах, хөнгөлөх, үргүй болгох.
СТЕРИЛИЗОВА́ТЬСЯ ариутгагдах.
СТЕРИ́ЛЬНОСТЬ ариун (байх), ариутгасан *(байх)*.
СТЕРИ́ЛЬН||ЫЙ 1. ариун, ариутгасан; **~ая вата** ариутгасан хөвөн; 2. үргүй, хөнгөлсөн.
СТЕ́РЛИНГ стерлинг; **фунт ~ов** стерлингийн паунд.
СТЕ́РЛЯДЬ шүхэрлэг загас.
СТЕРЛЯ́ЖИЙ шүхэрлэг загасны.
СТЕРПЕ́ТЬ хүлцэх, тэсэх, тэвчих; ~ **обиду** гомдоосныг хүлцэх.
СТЕРПЕ́ТЬСЯ дасах.
СТЁРТ||ЫЙ мөлийсөн, мөлгөр; **~ая монета** мөлгөр зоос.
СТЕСА́ТЬ цавчин засах; ~ **брёвна** гуалингийн үзүүрийг цавчин засах.
СТЕСНЕ́НИ||Е 1. хавчигдах, хяхагдах, хязгаарлагдах, хавчих, хяхах, хязгаарлах, хавчигдал, хавчлага; ~ **в правах** эрхийг хязгаарлах; 2. бачимдах, давчдах, амьсгаадах; ~ **в груди** амьсгаа бачимдах; 3. ичих, зовох, аягуйрхэх, эрээлэх, нэрэлхэх; **без всякого ~я** огт зовохгүй, өчүүхэн ч нэрэлхэлгүй.
СТЕСНЁННЫЙ 1. хашигдсан, шахагдсан; 2. бачимдсан, давчидсан, явцуудсан; **~ое дыхание** амьсгаадах.
СТЕСНИ́ТЕЛЬНОСТЬ 1. хавчигдал, хавчлага; ~ **положения** хавчигдалтай байдал; 2. аягуйрхэл, ичимхий байх, эрээ, нэрэлхэх.
СТЕСНИ́ТЕЛЬН||ЫЙ 1. хавчигдалтай, хавчлагатай, хэцүү; **жить в ~ых условиях** хавчигдалтай нөхцөлд амьдрах, хоёр идэхгүй, хоосон хонохгүй; 2. ичимтгий, зовомтгой, эрээлхэг, нэрэлхэг.
СТЕСНИ́ТЬ 1. шахах, хавчих, хаших; 2. хавчих, хязгаарлах, хяхах; 3. саад болох, төвөг болох; 4. бачимдуулах, бачуудуулах.
СТЕСНИ́ТЬСЯ шахалдах, шахцалдах, түлхэлдэх; ~ **у входа** үүдэнд шахцалдах; ~ **в толпе** олон хүнтэй түлхэлдэх.
СТЕСНЯ́ТЬ 1. шахах, хавчих, хаших; 2. хавчих, хязгаарлах, хяхах; 3. саад болох, төвөг болох; 4. бачимдуулах, бачуудуулах.
СТЕСНЯ́ТЬСЯ 1. шахалдах, шахцалдах, түлхэлдэх; 2. аягуйрхэх, ичих, зовох, нүүр халах, эрээлэх, нэрэлхэх; ~ **незнакомых людей** танихгүй хүмүүсээс зовох.
СТЁСЫВАТЬ цавчин засах.
СТЕТОСКО́П чагнуур.
СТЕЧЕ́НИЕ цугларах, бөөгнөрөх, цуглах; ~ **народа** хүн цугларах; * ~ **обстоятельств** нөхцөл бүрэлдэх.

СТЕЧЬ урсан орох, гоожих, савирах.
СТЕ́ЧЬСЯ 1. урсан нийлэх, цутгах, хурах; **ручьи стеклись в реку** горхи нийлж гол болов; 2. хурах, цугларах.
СТИЛЕ́Т матга *(хутга)*.
СТИЛИЗА́ЦИ||Я 1. маягаар найруулах, янзлан найруулах; **заниматься ~ей** маягаар найруулах; 2. найруулсан зохиол, янзлан найруулсан бүтээл.
СТИЛИЗОВА́ТЬ маягаар найруулах, янзлан бүтээх, янзлах.
СТИЛИ́СТ найруулга сайтай хүн.
СТИЛИ́СТИКА найруулга зүй.
СТИЛИСТИ́ЧЕСК||ИЙ найруулгын, найруулах; **~ие особенности** найруулгын онцлог; **~ приём** найруулах арга.
СТИЛ||Ь I 1. маяг, янз; 2. арга маяг; 3. найруулга; **ошибки в ~е** найруулгын алдаа.
СТИЛЬ II улирал, тоолол; **старый ~** хуучин улирал; **новый ~** шинэ тоолол.
СТИ́ЛЬН||ЫЙ тусгай янзтай, тусгай маягтай, янзлан хийсэн, тусгай найруулгатай; **~ая мебель** тусгай янзтай тавил.
СТИ́МУЛ түлхэц, урам, урамшуулга, урамшлага; **~ работы** ажлын урам; **~ы моральные** сэтгэл санааны урамшуулал.
СТИМУЛИ́РОВАНИЕ урамшуулалт.
СТИМУЛИ́РОВАТЬ урамшуулах, урам оруулах, түлхэц өгөх.
СТИМУЛИ́РОВАТЬСЯ урамшуулагдах, түлхэц авах, урамших, түлхэц болох.
СТИПЕНДИА́Т цалинт оюутан.
СТИПЕ́НДИЯ *(оюутны)* цалин, тэтгэлэг.
СТИРА́ЛЬН||ЫЙ угаалгын, юм угаах; **~ая машина** угаалгын машин; **~ порошок** угаалгын нунтаг.
СТИ́РАНЫЙ 1. цэвэр, угаасан; 2. угааж байсан, угаасан, шинэ биш.
СТИРА́ТЬ I 1. арчих, арилгах; 2. баллах, баллуурдах, арчих; 3. холгох, үрэх, шалбалах.
СТИРА́ТЬ II угаах.
СТИРА́ТЬСЯ I 1. арилах, балрах; 2. алга болох, үгүй болох, мартагдах; 3. мөлийх, мөлүү болох; 4. арчигдах.
СТИРА́ТЬСЯ II угаагдах.
СТИ́РК||А угаах, угаалга; **отдать бельё в ~у** дотуур хувцас угаалганд өгөх, дотуур хувцас угаалгах.
СТИ́СКИВАТЬ,
СТИ́СНУТЬ 1. атгах, базах, хавчих, тэврэх; **~ руку** гар базах; 2. зуух, зууруулах; **~ зубы** шүдээ зуух.
СТИ́СНУ||ТЬСЯ зуурах, хавчигдах; **зубы ~лись** шүд зуурав.
СТИХ шүлэг; **размер ~а** шүлгийн хэмжээ; **сочинять ~и** шүлэг зохиох.
СТИХА́ТЬ намдах, номхрох, аядах, буурах.
СТИХИ́ЙНОСТЬ аяндаа гарах, эмхгүй, зохион байгуулалтгүй.
СТИХИ́ЙН||ЫЙ 1. цаг бусын, гал усны, байгалийн; **~ые бедствия** цаг бусын аюул, гал усны аюул; 2. аяндаа гарсан, эмхгүй, зохион байгуулалтгүй.
СТИХИ́||Я 1. байгалийн хүчин, гал ус, ган зуд; **разбушевавшаяся ~** гаарсан байгалийн хүчин; 2. эмхгүй хүч, зохион байгуулалтгүй хүч; 3. дассан орчин, сурсан байдал; **быть в своей ~и** сурсан байдалдаа байх.
СТИ́ХНУТЬ намдах, намжих, номхрох, аядах, буурах; **ветер стих** салхи намжив.
СТИХОПЛЁТ толгой холбогч, шүлэг оронцоглогч.
СТИХОПЛЁТСТВО толгой холбох, шүлэг оронцоглох.
СТИХОСЛОЖЕ́НИЕ шүлэг зохиох.
СТИХОТВОРЕ́НИЕ шүлэг, шүлэглэл.
СТИХОТВО́РЕЦ шүлэгч.
СТИХОТВО́РН||ЫЙ шүлгийн, шүлэглэн бичсэн; **~ое произведение** шүлгийн зохиол.
СТИХОТВО́РСТВО шүлэг бичих; **заниматься ~м** шүлэг бичих.
СТИШО́К 1. бяцхан шүлэг, шүлэгхэн; 2. шүлгийн оронцог, шүлэг шүү юм.
СТЛАТЬ 1. дэлгэх, дэвсэх, бүтээх, засах; **~ постель** ор дэвсэр засах; 2. тавих, зүйж хийх; **~ пол** шал тавих.
СТЛА́ТЬСЯ 1. бүрхэх, тунах, суунаглах; **туман стелется** манан суунаглана; 2. хэвтэж ургах.
СТО зуу.
СТОГ цомог, өвсний цогц, нуруу; **~ сена** цомог өвс, өвсний цогц.
СТОГОВА́ТЬ цомоглох, *(өвс)* нуруулдах.
СТОГРАММО́ВЫЙ зуун граммын.
СТО́ИМОСТЬ 1. өртөг; **меновая ~** арилжааны өртөг; **прибавочная ~** нэмүү өртөг; **~ производства** үйлдвэрлэлийн өртөг; **~ основных фондов** үндсэн фондын өртөг; 2. үнэ; **~ купленной вещи** худалдан авсан юмны үнэ.
СТО́ИТЬ 1. үнэтэй байх; **стоит больших денег** их үнэтэй; **сколько стоит?** ямар үнэтэй вэ? 2. хэрэгтэй байх, - ууштай *(- үүштэй), бэнтэй байх, дайтай байх, таарсан байх;* **стоит внимания** анхаарууштай; **пьесу стоит посмотреть** үзүүштэй жүжиг; **один стоит другого** хоёр таарсан хүн, хоёр таарсан юм; 3. -магц *(- мэгц, - могц, - мөгц);* **стоит сказать одно слово, как он противоречит** үг хэлмэгц, зөрдөг хүн; *** ничего не стоит** юу ч биш, юман төдий санахгүй.
СТО́ЙБИЩЕ бууц, хот.
СТО́ЙКА I тулаас, шон.
СТО́ЙКА II лангуу.
СТО́ЙКА III зогсох, зогсолт; **~ на голове** толгойгоор зогсох.
СТО́ЙКИЙ 1. бөх, бат бөх, эвдэрдэггүй; **~ кирпич** бөх тоосго; 2. тэсвэртэй, хатуужилтай, тогтвортой; **~ человек** тогтвортой хүн.
СТО́ЙКО тэсвэртэй, хатуужилтай, тогтвортой; **~ защищаться** өөрийгөө тогтвортой хамгаалах.
СТО́ЙКОСТЬ 1. бөх *(байх),* эвдэрдэггүй *(байх),* тэсвэр, хатуужил, тогтвор.
СТО́ЙЛО дал, хорго.
СТОЙМЯ́ босоогоор, босгон, зогсоогоор; **поставить полено ~** хэрчмийг босгон тавих.
СТОК 1. урсах, урсац; 2. суваг, ховил, хоолой, гоожуур.
СТОКРА́Т,
СТОКРА́ТНО зуу дахин.
СТОКРА́ТН||ЫЙ зуу *дахин,* зуу *дахин их;* **в ~ом размере** зуу дахин их хэмжээгээр, зуу дахин нугалж.
СТОЛ 1. ширээ; **письменный ~** бичгийн ширээ; **накрывать на ~** ширээ засах; **убрать со ~а** ширээ хураах, ширээн дээрхийг хураах; **обеденный ~** хоолны ширээ; **круглый ~** дугуй ширээ; 2. хоол, идээ, идэш ууш; **мясной ~** махан хоол; 3. тасаг; **справочный ~** лавлах тасаг; **~ заказов** захиалгын тасаг, захиалга авах тасаг.
СТОЛБ 1. багана, мод, шон, овоо; **пограничный ~** хилийн овоо; 2. хуйларсан юм; **~ пыли** хуйларсан тоос; **~ воды** хуйларсан ус; *** позвоночный ~** нуруу; **стоять ~ом** ёрдойн зогсох.
СТОЛБЕНЕ́ТЬ мэлрэн зогсох; **~ от ужаса** айж мэлрэн зогсох.
СТОЛБНЯ́К татран өвчин.
СТОЛБНЯ́ЧНЫЙ татраны; **~ микроб** татраны нян.
СТОЛБОВ||О́Й баганын, шонгийн; *** ~ая дорога** 1. дардан зам, их зам, гол зам; 2. *(хөгжлийн)* жанжин зам, гол зам.
СТОЛЕ́ТИЕ 1. зуун жил; 2. зуун жилийн ой.
СТОЛЕ́ТН||ИЙ зуун жилийн, зуун наст; **~яя война** зуун жилийн дайн; **~яя годовщина** зуун жилийн ой.
СТОЛЕ́ТНИК агар, зуун наст.

СТО́ЛИК бяцхан ширээ.
СТОЛИ́ЦА нийслэл.
СТОЛИ́ЧНЫЙ нийслэлийн, нийслэл; **~ город** нийслэл хот.
СТОЛКНОВЕ́НИ||Е 1. мөргөлдөөн, мөргөлдөх; **~ автомобилей** машин мөргөлдөх; 2. мөргөлдөөн, харшилдаан, харгалдаан; **~ противоположных интересов** харш эрх ашгийн мөргөлдөөн; **прийти в ~** харшилдах; 3. мөргөлдөөн, тулалдаан; **кровавое ~** цуст тулалдаан; 4. хэрүүл, маргалдаан; **избегать ~й** маргалдаанаас зайлсхийх.
СТОЛКНУ́ТЬ 1. түлхэх, түлхэн хөдөлгөх, түлхэн унагах; **~ лодку в воду** завь ус руу түлхэх; 2. мөргөлдүүлэх, хавиралдуулах, харшилдуулах.
СТОЛКНУ́||ТЬСЯ 1. мөргөлдөх, хавиралдах, харшилдах; 2. мөргөлдөх, дайралдах, тохиолдох; 3. харшилдах, мөргөлдөх, харгалдах; **интересы ~лись** эрх ашиг харшилдав.
СТОЛКОВА́ТЬСЯ учраа ололцох, үгээ ойлголцох; **с ним трудно ~** түүнтэй учраа ололцох бэрх.
СТОЛО́ВАТЬСЯ хооллох.
СТОЛО́ВАЯ 1. хооллох тасалгаа, хоолны өрөө; 2. хоолны газар, гуанз; **общественная ~** нийтийн гуанз.
СТОЛО́В||ЫЙ хоолны, ширээний; **~ая ложка** хоолны халбага, том халбага; **~ое вино** ширээний дарс.
СТОЛП 1. багана, мод, шон; 2. түшиг болсон хүн, гарамгай зүтгэлтэн; **~ы науки** шинжлэх ухааны түшиг бологсод.
СТОЛПИ́ТЬСЯ овооролдох, бөөгнөрөлдөх, бөөгнөрөх, цугларах.
СТОЛПОТВОРЕ́НИЕ хөл үймээн, үймээн шуугиан.
СТОЛЬ тийн, төдий; **это не ~ важно** энэ тийн чухал бус.
СТО́ЛЬКО 1. төдий, төдий чинээ, өдий, өдий чинээ, төчнөөн, өчнөөн; 2. төдий *(их)*, тийм *(олон)*, өдий *(олон)*, ийм *(их)*; **где ты был ~ времени?** чи ийм удаан хаа байв?; **среди стольких знакомых ни одного друга** ийм олон танилын дотор нэг ч найз алга.
СТОЛЯ́Р нарийн мужаан, модоч, модны дархан.
СТОЛЯ́РНИЧАТЬ нарийн мужаан хийх, мод дархлах, модны дарх хийх.
СТОЛЯ́РН||ЫЙ 1. нарийн мужааны, модчины, модны дархны; **~ая мастерская** нарийн мужааны газар, модчины газар; 2. модны; **~ клей** модны цавуу.
СТОМАТОЛОГИ́ЧЕСКИЙ амны хөндийн.
СТОМАТОЛО́ГИЯ амны хөндийн судлал.
СТОМИЛЛИО́НН||ЫЙ дүнчүүр; **~ое население** дүнчүүр хүн ам.
СТОНА́ТЬ ёолох, гаслах, гэнгэнэх, гангинах.
СТОП зогс, байз, бай.
СТОП||А́ I 1. тавхай, ул; **плоская ~** хавтгай тавхай; 2. өлмий; **направить куда-либо свои ~ы** өлмийгөө чиглүүлэх, морилох; *** идти по чьим-либо ~ам** хүний мөрөөр замнах.
СТОПА́ II *(шүлгийн)* өлмий.
СТОПА́ III 1. бөөн, багц; **~ книг** бөөн ном; *2.* толгой *(цаас)*.
СТОПИ́ТЬ хайлуулах; **~ воск с салом** лав өөхтэй хольж хайлуулах.
СТО́ПКА I бяцхан шил аяга, хундага; **~ водки** хундага архи.
СТО́ПКА II бөөмхөн, багцхан.
СТО́ПОР тогтоогуур, стопор *(механизмын хөдлөх хэсгийг бэхлэх оньс)*.
СТО́ПОРИТЬ зогсоох, тогтоох; **~ машину** машин зогсоох.
СТО́ПОРИТЬСЯ зогсох, тогтох.
СТО́ПОРНЫЙ тогтоогуурын, стопорын, тогтоох, зогсоох.
СТОПРОЦЕ́НТНЫЙ зуун хувийн, зуун хувь.
СТОПТА́ТЬ майжийлгах, майжгий гишгэх, хазгай гишгэх; **~ каблуки** гутлынхаа өсгийг майжийлгах.
СТОПТА́ТЬСЯ майжийх.
СТОРГОВА́ТЬСЯ наймаа таарах, үнэ тохиролцох.
СТО́РИЦ||А воздать ~ей 1. тусыг тусаар хариулах; 2. өшөө хонзон авах.
СТО́РОЖ манаач, манаа; **ночной ~** шөнийн манаач.
СТОРОЖЕВ||О́Й манааны; **~ая будка** манааны шовгор, манааны бүхээг; **~ая собака** манааны нохой; **~ая вышка** манааны аранга.
СТОРОЖИ́ТЬ манах, сахих, харах; **~ дом** гэр сахих; **~ склад** агуулах манах.
СТОРО́ЖКА манааны шовгор, манааны бүхээг.
СТОРОН||А́ 1. тал, этгээд, бие, зүг; **пойти в разные ~ы** зүг зүг явах; **обе ~ы** хоёр тал, хоёр этгээд; **со всех сторон** тал талаас, зүг бүхнээс; **лицевая ~** нүүр тал; **~ оборотная** ар тал; 2. газар, нутаг, орон; **родная ~** төрсөн нутаг; **жить на чужой ~е** хүний газар суух, хүний нутагт амьдрах; 3. тал, этгээд, хажуу, зах; 4. хажуу этгээд, хажуу тал, хажуу, гадна; **остаться в ~е** а)хажууд үлдэх, харагдахгүй хоцрох; б)ард хоцрох, гадна үлдэх; **отойти в ~у** хажуу тийш болох; 5. хөндлөнгийн этгээд, хажуу; **со ~ы виднее** хөндлөнгийн этгээдэд ил байна, хажуугаас харахад ил байна; 6. тал, өнгө, хажуу; 7. тал; **обсудить вопрос со всех сторон** асуудлыг тал талаас нь шүүмжлэн хэлэлцэх; 8. тал, чанар; **показная ~** өнгөн тал, хуурамч чанар; **у него много хороших сторон** олон сайн чанартай хүн; 9. этгээд, тал; **договаривающиеся ~ы** хэлэлцэгч этгээд; **выслушать обе ~ы** хоёр этгээдийг хоёулыг сонсох; 10. тал, зүг; **родственники со ~ы отца** эцгийн талын хамаатан; 11. тал; **~ квадрата** нэг дөрвөлжний нэг тал; **~ой** өөр талаас, өөр этгээдээс, бусдаас; **услышал ~ой** бусдаас сонссон; **моё дело ~** над хамаагүй; **на все четыре ~ы прогнать, отпустить** *(дөрвөнзүг найман зовхист яв гэж)* хөөх, тавих; **на ~е** өөр газар, ондоо газарт; **на ~у** өөр газар, ондоо газар; **на ~у** хажуу тийш; **с одной ~ы ... с другой ~ы**... нэг талаас... нөгөө талаас, нэгтээгүүр... нөгөөтэйгүүр, нэгтээ талаас, нөгөө талаас; **со ~ы кого- чего-либо**... зүгээс; **со ~ы** *(взять)* өөр газраас *(авах)*; **шутки в ~у** инээдэм наадмаа орхи.
СТОРОНИ́ТЬСЯ 1. зайлах, хажуу тийш болох, хойш болох; 2. зайлсхийх, тойрох, дөлөх, холуур явах; **~ старых друзей** хуучин найз нараасаа зайлсхийх.
СТОРО́ННИК талын хүн, *(талыг)* баримтлагч; **~ новой теории** шинэ онолын *(талыг)* баримтлагч.
СТОСКОВА́ТЬСЯ уйтгарлах, гуниглах.
СТОЧИ́ТЬ билүүдэх, билүүдэж гаргах, гуранздах, хуурайдах, үрэх.
СТОЧИ́||ТЬСЯ *(билүүнд)* элэгдчихэх, элчхэх; **нож совсем ~лся** хутга бүр элчихжээ.
СТО́ЧН||ЫЙ 1. урсгал, урсах; **~ая вода** урсгал ус; 2. урсгах, татах, гоожуулах; **~ая канава** урсгах шуудуу.
СТОШНИ́ТЬ бөөлжис хүрэх, бөөлжих.
СТО́Я зогсон, босоогоороо; **выслушать ~** зогсон сонсох; **читать ~** босоогоороо унших.
СТОЯ́НИ||Е зогсох, босоо зогсох, босоогоороо байх; **ноги устали от долгого ~я** удаан зогссоноос хөл чилэв.
СТОЯ́НКА 1. зогсох газар, зогсоол; **~ автобусов** автобусны зогсоол; 2. бууц; **~ каменного века** чулуун зэвсгийн үеийн бууц.
СТОЯ́||ТЬ 1. зогсох, *(босоо)* байх, гозойх; 2. тогтох, байх; 3. байх, орших; **юрта ~ла у реки** гэр голын дэргэд байв; 4. байх, болж байх; **~ во главе чего-либо** юмны тэргүүн болж байх, тэргүүлэн байх; **стояла жара** халуун байв; 5. байх, тулгарах; **перед нами ~т важные задачи** бидний өмнө чухал

зорилт тулгарч байна; 6. байх, байрлах; 7. хамгаалах, өмгөөлөх, өмөөрөх, баримтлах, талд байх; ~ **грудью за что-то** юмыг биеэрээ хамгаалах; ~ **за друга** найзыгаа өмөөрөх; 8. хөдлөхгүй байх, явахгүй байх, ажиллахгүй байх, сул зогсох, зогсох; **поезд долго стоит** галт тэрэг удаан зогсож байна; **часы ~т** цаг явахгүй байна; **стойте!** хүлээгтүн! зогс!; ~ **на своём** өөрийнхөө зүтгэх; **не ~ за чем-либо** хайрлахгүй байх; ~ **над душой** гуйж гувших, шалаад салахгүй байх; **у двора ~** хаяанд ирэх.

СТОЯ́Ч||ИЙ 1. босоо, зогсоо, зогссон, *(юман дээр)* тавиатай; **в ~ем положении** зогсон, зогсоод, зогсоогоороо; **~ие часы** *(юман дээр)* тавиастай цаг; 2. тогтмол; **~ая вода** тогтмол ус.

СТО́ЯЩ||ИЙ анхаарууштай, сонирхуушгай, бүтэлтэй, дөмөгтэй; **~ее предложение** анхаарууштай санал.

СТРАВИ́ТЬ хэрэлдүүлэх, яс хаях; ~ **собак** ноход хэрэлдүүлэх.

СТРА́ВЛИВАТЬ хэрэлдүүлэх, яс хаях.

СТРА́ГИВАТЬСЯ хөдлөх.

СТРАДА́ 1. *(хадлан, тарианы)* ид ажил; 2. хүчир ажил, бэрх тэмцэл.

СТРАДА́ЛЕЦ зовсон хүн, зовсон хүн.

СТРАДА́ЛИЦА зовсон эмэгтэй, ядарсан эмэгтэй.

СТРАДА́ЛЬЧЕСКИЙ зовсон, зовлонтой, зовлонт, нажидтай.

СТРАДА́НИЕ зовлон, нажид.

СТРАДА́ТЕЛЬНЫЙ үйлдэгдэх; ~ **залог** үйлдэгдэх хэв.

СТРАДА́ТЬ 1. зовох, тарчлах, шаналах; ~ **от боли** өвдөж зовох; 2. өвчинтэй байх, баригдах, нэрвэгдэх; 3. нэрвэгдэх, эрсдэх, өртөх, хохирох; ~ **от наводнений** үерт нэрвэгдэх; 4. зовлон үзэх, зовлонд өртөх, хохирох; ~ **по своей вине** өөрийнхөө буруугаас болж зовлонд өртөх, хохь нь болох; 5. муутай байх, унасан байх; 6. санах, - гүй уйдах, санаж гуниглах, санаж зовох; ~ **по родителям** эцэг эхийгээ санах.

СТРА́ДН||ЫЙ ид ажлын; **~ая пора** ид ажлын үе.

СТРАЖ хамгаалагч, манаа.

СТРА́Ж||А манаа, харуул, сахиул; **пограничная** ~ хилийн харуул; *** быть на ~е чьих-либо интересов** хүний эрх ашгийг хамгаалах; **заключить под ~у** баривчлах, хорих.

СТРАНА́ 1. орон, улс; **родная** ~ төрсөн орон; 2. газар орон, газар нутаг, газар; **далёкая** ~ алс гэзар орон; **горная** ~ уулархаг газар.

СТРАНИ́Ц||А 1. тал, нүүр, *(тал)* хуудас; **~у за ~ей** хуудас хуудсаар, хуудас дараалан; 2. **~ы** ном, сэтгүүл, сонин; **на ~ах газеты** сонинд; 3. үе, хэсэг, хуудас.

СТРА́ННИК бадарчин, бидэгч, Хэсүүл хүн, хэрмэл хүн.

СТРА́ННИЧЕСКИЙ бадарчны, хэсүүл *(хүний)*, хэрмэл *(хүний)*.

СТРА́ННО 1. жигтэй, хачин; ~ **вести себя** хачин загнах; 2. жигтэй байх, хачин байх, гайхмаар байх; **как ни ~** хичнээн гайхмаар байвч.

СТРА́ННОСТ||Ь 1. жигтэй *(байх)*, хачин *(байх)*, гайхалтай *(байх)*; 2. хачин зан, жиг; **человек со ~ями** хачин зантай хүн.

СТРА́НН||ЫЙ жигтэй, гайхмаар, хачин, янзын, сонин; **~ые взгляды** хачин үзэл; ~ **человек** жигтэй хүн.

СТРА́НСТВИЕ бидэх, хэсэх, тэнэх, хэрэх.

СТРА́НСТВОВАТЬ бидэх, хэсэх, тэнэх, хэрэх.

СТРА́НСТВУЮЩИЙ бидэгч, хэсүүл, хэрмэл; ~ **музыкант** хэсүүл хөгжимчин, бидэгч хөгжимчин.

СТРА́СТНО тэсгэлгүй, тэчьяадан, шуналтай, тачаалтай, тачаан.

СТРА́СТНОСТЬ тэсгэлгүй *(байх)*, тэчьяадалтай *(байх)*, шуналтай *(байх)*, сэтгэл оргилуулах, тачаалтай *(байх)*, тачаангуй байх.

СТРА́СТН||ЫЙ 1. тэсгэлгүй, тэчьядалтай, шуналтай, зоригжуулсан, сэтгэл оргилуулсан; **~ое желание** тэсгэлгүй хүсэх; 2. шуналтай, шунал болсон, тэсгэлгүй дуртай, тачаалтай; 3. тачаангуй, тачаалтай, тачаасан; ~ **взгляд** тачаангуй харц; 4. гал амьтан.

СТРАСТ||Ь 1. шунал, тэчьяадал, тачаадал; **~и у спорщиков разгорелись** маргачид тачаадан булаалдав; 2. тачаангуй, тачаал,тачаадал; **воспылать ~ью к кому-либо** тачаах, тачаан дурлах.

СТРАТЕ́Г стратегч, жанжин.

СТРАТЕГИ́ЧЕСКИЙ стратегийн, стратегийн ач холбогдолтой.

СТРАТЕ́ГИЯ стратег 1) дайныг удирдах чадвар, дайтах ухаан; 2)нийгмийн ба улс төрийн тэмцлийг удирдах чадвар.

СТРАТОСТА́Т стратостат, давхраа мандалд тогтогч.

СТРАТОСФЕ́РА давхраа мандал *(далайн түвшнээс 9-11 километрээс дээшхи агаар)*.

СТРАТОСФЕ́РНЫЙ давхраа мандлын.

СТРА́УС тэмээн хяруул, тохь.

СТРА́УСОВ||ЫЙ тэмээн хяруулын, тохийн; **~ое перо** тэмээн хяруулын өд.

СТРАХ 1. айдас, аймшиг, аюумшиг, айх, аюух, эмээх, сүрдэх; **задрожать от ~а** айж чичрэх; **чувство ~а** айдас хүрэх, аймшиг төрөх; **под ~ом чего-либо** юмнаас айн, айж сүрдэн; **держать кого-либо в ~е** хүнийг айлган сүрдүүлэх; **~а ради делать что-то** эмээсэндээ хийх; **не за ~, а за совесть** айснаасаа биш, ариун сананаасаа; 2. **~и** аймшигтай юм, аймшиг; **рассказывать о своих ~ах** элдвийн аймшиг ярих; 3. зөнгөө мэдэг гэх, толгой даах; **сделать на свой ~** толгой даагаад хийчхэх.

СТРАХОВА́НИ||Е даатгах, даатгал; **социальное** ~ нийгмийн даатгал; ~ **вреда** гэм хорын даатгал; **государственное** ~ улсын даатгал; ~ **жизни** амь биеэ даатгах; **предмет ~я** даатгалын зүйл; **вид риска ~я** даатгалын эрсдэлийн төрөл.

СТРАХОВА́ТЕЛЬ даатгуулагч.

СТРАХОВА́ТЬ 1. даатгах; ~ **жизнь** амь бие даатгах; 2. хамгаалах, сэргийлэх.

СТРАХОВА́ТЬСЯ 1. өөрийгөө даатгах, юмаа даатгах; 2. даатгагдах.

СТРАХО́ВКА 1. даатгалын гэрчилгээ, даатгалын үнэмлэх; 2. даатгалын шан; 3. хамгаалах, сэргийлэх.

СТРАХОВ||О́Й даатгалын; ~ **взнос** даатгалын татвар; **~ое свидетельство** даатгалын баталгаа; ~ **агент** даатгалын төлөөлөгч.

СТРАХО́ВЩИК даатгагч.

СТРАШИ́ЛИЩЕ аймшигт юм, Аймшигт амьтан.

СТРАШИ́ТЬ айлгах, сүрдүүлэх.

СТРАШИ́ТЬСЯ айх.

СТРА́ШНО 1. сүрхий *(их)*, айхавтар, аймшигтай; **он ~ обрадовался** тэр *(хүн)* сүрхий барлав; 2. аймшигтай байх, аймаар байх, айх.

СТРА́ШН||ЫЙ 1. аймшигт, аймшигтай, аюумшигтай, аймаар, айдас хүрмээр, аюулт, аюултай, сүрээтэй; ~ **сон** аймшигтай зүүд; ~ **взгляд** аймаар харц; **~ая дорога** аюултай зам.

СТРАЩА́ТЬ айлгах, айдас хүргэх, сүрдүүлэх.

СТРЕ́ЖЕНЬ усны гүн, гүнзгий газар.

СТРЕКА́Ч дать ~а, задать ~а ухаан жолоогүй арилж өгөх, ухасхийн дутаах.

СТРЕКОЗА́ тэмээлзгэнэ.

СТРЕ́КОТ цархих авиа, чар чар гэх, цагчих.

СТРЕКОТА́НИЕ цархийх, цагчих.

СТРЕКОТА́ТЬ 1. цархийх, цар цар хийх, цар цар гэх, чархийх, чар чар гэх, цагчих, чахнах, чахрах; **стрекочут кузнечики** дэвхрэг цар цар хийнэ; 2. дуржганах, дур дур гэх, дужигнах.

СТРЕКОТНЯ́ цар цар хийх, чар чар гэх, цагчих.

СТРЕЛ||А́ 1. сум, годил; **пустить ~у** сум харвах; **ранить ~ой** харваж шархдуулах; 2. *(ногооны)* иш, шилбэ; 3. сум; **подъёмная ~** өргөх сум; **промчаться, как ~** харвасан сум шиг өнгөрөх.

СТРЕЛЕ́Ц бууч *(XVI - XVII зууны Москвагийн Оросын байнгын цэргийн албан хаагч).*

СТРЕЛЕ́ЦК||ИЙ бууч, буучдын; **~ие войска** бууч цэрэг.

СТРЕ́ЛКА I зүү; **часовая ~** цагийн зүү, ахар зүү.

СТРЕЛКА II *(төмөр замын)* сум; **автоматическая ~** автомат сум.

СТРЕ́ЛК||А III *разг.* уулзаа, уулзахаар тохиролцох; **забить ~у** уулзахаар тохиролцох байсан.

СТРЕЛКО́ВЫЙ 1. буудлагын; 2. буучдын, бууч цэргийн, явган цэргийн; **~ полк** буучдын хороо, явган цэргийн хороо.

СТРЕЛО́К 1. бууч, буудагч; **искусный ~** мэргэн бууч; 2. бууч, бууч цэрэг, явган цэрэг.

СТРЕ́ЛОЧНИК сумчин; * **искать ~а** золиосны хүн хайх.

СТРЕЛЬБА́ буудлага, буудах, харвах; **~ из орудий** их буугаар буудах.

СТРЕ́ЛЬБИЩЕ буудлагын газар.

СТРЕЛЬНУ́ТЬ буудаад авах, буудчихах.

СТРЕ́ЛЬЧАТЫЙ 1. сумархуу, сум хэлбэртэй, шовх; **~ свод** сум хэлбэрийн хүнхэр; 2. иштэй, шилбэтэй, ишилсэн, шилбэлсэн; **~ лук** ишилсэн сонгино.

СТРЕ́ЛЯН||ЫЙ 1. буудаж алсан; **~ая дичь** буудаж алсан зэрлэг шувуу; 2. дарь үнэртсэн, дайтаж үзсэн; **~ солдат** дарь үнэртсэн цэрэг; 3. буудсан, хуучин, **~ые гильзы** буудсан бортого, хоосон хонгио; **~ воробей, ~ая птица** хал үзсэн хүн.

СТРЕЛЯ́||ТЬ 1. буудах, тавих, үсэргэх, харвах; **~ из ружья** буу буудах; **~ из лука** нум сумаар харвах; **~ в цель** бай буудах; **~ в птиц** шувуу буудах; 2. хатгах, лугших; **~ет в ухе** чихээр хатгаж байна.

СТРЕЛЯ́ТЬСЯ 1. өөрийгөө буудах; 2. буудалцах.

СТРЕМГЛА́В хар гүйхээрээ, хар хурдаараа, тэнхээ мэдэн, нүүр нүдгүй; **~ броситься бежать** хар хурдаараа гүйчхэх.

СТРЕМИ́ТЕЛЬНОСТЬ хурдан *(байх)*, түргэн *(байх)*, эрчимтэй *(байх).*

СТРЕМИ́ТЕЛЬНЫЙ хурдан, түргэн, эрчимтэй; **~ поток** түргэн горхи.

СТРЕМИ́ТЬСЯ 1. тэмүүлэх, эрмэлзэх, зорих, зүтгэх, мэрийх, улайх; **~ к свободе** эрх чөлөөг эрмэлзэх; **~ понять что-либо** юм ойлгох гэж улайх; 2. тэмүүлэх, зорих, зүглэх.

СТРЕМЛЕ́НИЕ эрмэлзэл, эрмэлзлэг, хүсэл, эрмэлзэх, тэмүүлэх, хүсэх; **~ к славе** алдрын хүслэн, алдрыг эрмэлзэх.

СТРЕМНИ́НА 1. даргиа, харгиа, түргэн урсгал; 2. түргэн, ганга, эгц эрэг.

СТРЕМНИ́СТЫЙ түргэн, эгц, огцом; **~ берег** эгц эрэг.

СТРЕ́М||Я дөрөө; **вдеть ногу в ~** дөрөө дөрөөлөх; **стоя в ~енах** дөрөө жийн давхих.

СТРЕМЯ́НКА хөнгөн шат, олсон шат, өлгөдөг шат.

СТРЕНО́ЖИТЬ чөдөрлөх; **~ коня** морь чөдөрлөх.

СТРЕПТОЦИ́Д стрептоцид *(уух эм).*

СТРЁМ айдас, түгшүүр, санаа зовох, сэрэмж, бэлэн байдал.

СТРИГУНО́К даага.

СТРИГУ́ЩИЙ хяргах, хяргадаг; **~ лишай** хяргадаг үлд.

СТРИЖ тэмээн хараацай, ураацай.

СТРИ́ЖЕН||ЫЙ хяргасан, хайчилсан, үсээ хяргуулсан, үсээ авахуулсан, мухар толгойтой, тоймог; **~ая овца** хайчилсан хонь.

СТРИ́ЖКА 1. үс авах, засах; 2. хайчлах, хяргах; **~ овец** хонь хяргах.

СТРИХНИ́Н хүнж, стрихнин *(хортой эм).*

СТРИЧЬ *(үс)* авах, засах, хайчлах, хяргах; **~ волосы** үс хяргах; **~ овец** хонь хайчлах; **~ ногти** хумс авах; **~ всех под одну гребёнку** хүн болгоныг адилд үзэх, хүн болгон адилгүй.

СТРИ́ЧЬСЯ 1. үсээ авахуулах, засуулах; **~ у парикмахера** үсчинд үсээ засуулах; 2. хайчлагдах, хяргагдах, хайчлах, хяргах.

СТРОГА́ЛЬНЫЙ харуулдах, зорох; **~ станок** харуулдах суурь машин.

СТРОГА́ЛЬЩИК харуулдагч, зорогч.

СТРОГА́ТЬ харуулдах, зорох; **~ доску** банз харуулдах.

СТРО́Г||ИЙ 1. чанга, хатуу, хэцүү, шаардлагатай; 2. нарийн; **~ учёт** нарийн бүртгэл; 3. хатуу, чанга, ширүүн; **~ закон** чанга хууль; **~ выговор** хатуудонгодох; 4. хатуу, чанга, ариун, сайн; **человек ~их правил** ёс ариун хүн; 5. түвшин, төв; **~ие черты лица** түвшин царай.

СТРО́ГО хатуу, чанга; **~ воспитывать** хатуу хүмүүжүүлэх; 2. хатуу, чанга, ширүүн; **~ наказать** чанга шийтгэх; 3. нарийн; **~ рассчитать** нарийн тооцоолох; 4. ёсорхуу; **~ держаться** ёсорхуу байх; 5. ёс баримтлан, төв, түвшин; **~ одеваться** ёс баримтлан хувцаслах.

СТРО́ГОСТ||Ь 1. чанга зан, хатуу *(байх)*, чанга байдал; **~ воспитания** хатуу хүмүүжил; 2. хатуу арга хэмжээ, хатуу журам; **ввести ~и** хатуу журам тогтоох.

СТРОЕВ||О́Й I жагсаалын; **~ая подготовка** жагсаалын бэлтгэл.

СТРОЕВО́Й II барилгын; **~ лес** барилгын мод.

СТРОЕ́НИЕ I барилга.

СТРОЕ́НИЕ II бүтэц, байгууламж; **~ атома** атомын бүтэц; **~ клетки** эсийн бүтэц; **~ земной коры** дэлхийн газрын бүтэц; **~ слова** үгийн бүтэц.

СТРОИ́ТЕЛЬ 1. барилгачин; 2. зохион байгуулагч, байгуулагч, зүтгэлтэн.

СТРОИ́ТЕЛЬН||ЫЙ барилгын; **~ые материалы** барилгын хэрэглэгдэхүүн; **~ые работы** барилгын ажил; **~ая площадка** барилгын талбай.

СТРОИ́ТЕЛЬСТВ||О барих, байгуулах, бүтээх, зохиох, барилга байгуулалт, бүтээлт, зохиолт; **~ высотных зданий** өндөр барилга барих; 2. байгуулах, бүтээх, байгуулалт, бүтээлт; **культурное ~** соёл байгуулал, соёлын байгуулалт; 3. барилгын байгууллага, барилгын газар; 4. барилга; **работать на ~е** барилга дээр ажиллах.

СТРО́ИТЬ I 1. барих, босгох, байгуулах, бүтээх, зохиох, тавих; **~ дом** байшин барих; **~ плотину** далан босгох; **~ железную дорогу** төмөр зам тавих; *2.* байгуулах, бүтээх, зохиох; **~ новую жизнь** шинэ амьдрал зохиох; 3. найруулах, өгүүлэх, илэрхийлэх; **правильно ~ предложение** өгүүлбэр зөв найруулах; 4. зурах; * **~ козни** далдуур хөнөөх; **~ рожу** нүүр амаа муруйлгах; **~ гримасы** ярваганах, ярвалзах; **~ дурака** мангуу юм шиг загнах; **~ глазки** нүдээ ирмэх.

СТРО́ИТЬ II жагсаах; **~ полк** хороо жагсаах.

СТРО́ИТЬСЯ 1. өөртөө барилга барих; 2. баригдах, байгуулагдах, босогдох, барих, байгуулах, босгох; 3. жагсах.

СТРОЙ I 1. байгуулал, журам, төр; **республиканский ~** бүгд найрамдах байгуулал, бүгд найрамдах төр.

СТРОЙ II байгуулал; **грамматический ~** хэл зүйн байгуулал.

СТРО||Й III жагсаал; **боевой ~** байлдааны жагсаал; **машина вышла из ~я** машин жагсаалаас гарав, машин эвдрэв.

СТРО́ЙК||А 1. барих, барилт, барилга; **приступить к ~е дома** байшин барьж эхлэх; 2. барилга; **работать на ~е** барилга дээр ажиллах.

СТРО́ЙНО 1. жигд, тэгш, ярс ярс *(хийн);* 2. хоолой нийлүүлэн, эгшиг нийлүүлэн; **~ петь** хоолой нийлүүлэн дуулах.

СТРО́ЙНОСТЬ 1. гуалиг биетэй *(байх)*, бие тэгш *(байх)*; 2. авцалдаа, эвтэй *(байх)*; **~ доклада** илтгэлийн авцалдаа.

СТРО́ЙН||ЫЙ 1. гуалиг биетэй, голшиг биетэй, бие тэгш, цэвэр; **~ая девушка** гуалиг биетэй хүүхэн; 2. жигд, жирийсэн, жирийтэл жагссан, зурайсан, жиргэр, ярс ярс хийсэн; **~ые ряды** жирийтэл жагссан эгнээ; 3. авцалдаатай, эвтэй; 4. хоолой нийлсэн, эгшиг нийлсэн, жигд.

СТРОКА́ мөр; **красная ~** шинэ мөр, догол мөр, тэтгэсэн мөр; *** читать между строк** далд утгыг тааж унших.

СТРО́НУТЬ хөдөлгөх; **~ с места** байрнаас нь хөдөлгөх.

СТРО́НУТЬСЯ хөдлөх; **~ с места** байрнаасаа хөдлөх.

СТРОП аргамж.

СТРОПИ́ЛО шувуун нуруу.

СТРОПИ́ЛЬН||ЫЙ шувуун нурууны; **~ые брёвна** шувуун нурууны гуалин.

СТРОПТИ́ВОСТЬ зөрүүд, зөрүүд зан, ярдаг зан, хэдэр зан, ардаг зан.

СТРОПТИ́В||ЫЙ зөрүүд, ярдаг, хэвцгий, хэдэр, адар, ардаг; **~ конь** ардаг морь; **укрощение ~ой** адайр бүсгүйг номхотгох.

СТРОФА́ бадаг.

ТРЯПИ́ЧНЫЙ 1. хуучин даавуугаар хийсэн, (*даавууны*) өөдсөөр хийсэн; 2. зориггүй, зүрхгүй, хэтэрхий зөөлөн; **~ характер** хэтэрхий зөөлөн зан.

ТРЯ́ПК||А 1. хуучин даавуу, (*даавууны*) өөдөс; 2. зориггүй хүн, зүрхгүй хүн, хэтэрхий зөөлөн хүн; **быть ~ой** хүний гарын арчуур болж, байх.

ТРЯ́ПОЧКА (*даавууны*) өчүүхэн өөдөс.

ТРЯ́ПОЧНЫЙ даавуун, даавуу шуувуун, бөсөөр хийсэн, өөдсөн.

ТРЯПЬЁ хуучин даавуу шуувуу, (*даавууны*) өөдөс мөөдөс, новш.

ТРЯСИ́НА бамбалзуур, балчиг, намагтай газар.

ТРЯ́СКА донсолгоо, дэнсэлгээ.

ТРЯ́СК~ИЙ||, донсолгоотой, дэнсэлгээтэй; **~ая телега** дэншээ тэрэг; **~ая дорога** донсолгоотой зам.

ТРЯСТИ́ 1. гүвэх, дуртрах, хөдөлгөх, ганхуулах, сэгсрэх; **~ руку** гар барьж сэгсчих; **~ дерево** мод ганхуулах; 2. сэгсрэх, хөдөлгөх; **~ ногой** хөлөө сэгсчих; **лошадь трясёт гривой** морь дэлээ сэгсчинэ; 3. чичрэх, чичрэгнэх, чичигнэх, дагжих, салганах; чичрүүлэх, чичрэгнүүлэх, чичигнүүлэх, дагжуулах, салгануулах; **его трясёт малярия** тэр (*хүн*) хумх тусч чичирнэ (*хумхаа түүнийг чичрүүлнэ*); **его трясёт от страха** тэр (*хүн*) айж чичрэгнэнэ; **~ от холода** хүйтэнд дагжих, дарч чичрэх; **рука трясётся** гар чичигнэнэ; 4. донслох, дэнслэх, дэнших; **телега трясёт** тэрэг донсолно.

ТРЯСТИ́СЬ 1. чичрэх, чичрэглэх, салганах, ганхах, хэлбэлзэх; **деревья трясутся от ветра** мод салхинд ганхана; 2. донслох, дэнслэх, дэнших, донслогдох, дэнслэгдэх, дэншигдэх, донслуулах, дэнслүүлэх, дэншүүлэх; **~ на телеге** тэргэнд дэнслэгдэх, зайлагдах; 3. чичрэх, чичрэглэх, чичирхийлэх, чичигнэх, дагжих, давжигнах; **~ от холода** дарч чичрэх, хүйтэнд дагжих; 4....гэж (*гэхээс*) айн чичрэх.... гэж зовох, харамлан чичрэх; **~ над своим ребёнком** хүүхдээ яачих бол гэхээс айн чичрэх; **~ над каждой копейкой** сохор улаан мөнгө зарахаас айн чичрэх, сохор улаан мөнгө бүрийг харамлан чичрэх.

ТРЯХНУ́ТЬ 1. гүвэх, дуртрах, хөдөлгөх, ганхуулах, сэгсрэх; 2. сэгсрэх, хөдөлгөх; 3. чичрэх, чичрэгнэх, чичигнэх, дагжих, салганах, чичрүүлэх, чичрэглүүлэх, чичигнүүлэх, дагжуулах, салгануулах; **~ стариной** залуугийнхийгаа санах, залуугийнхаараа хийх; **~ мощной** түрийвчээ гүвэх, мөнгө харамгүй зарах.

ТУАЛЕ́Т 1. гоёл, (*эмэгтэй үний*)хувцас; **роскошный ~** гоёмсог хувцас; 2. гоёх, хувцаслах; **заниматься ~ом** гоёх, хувцаслах; 3. бие засах газар, жорлон.

ТУАЛЕ́ТН||ЫЙ гар нүүрийн; туалетное мыло гар нүүрийн саван; **~ые принадлежности** гар нүүрийн хэрэгсэл; **~ая комната** бие засах өрөө.

ТУ́БА их бүрээ

ТУБЕРКУЛЁЗ сүрьеэ (өвчин); **~ лёгких** уушигны сүрьеэ; **костный ~** ясны сүрьеэ.

ТУБЕРКУЛЁЗНЫЙ сүрьеэгийн, сүрьеэ өвчний, сүрьеэтэй, сүрьеэ өвчтэй; **~ больной** сүрьеэ өвчтэй хүн.

ТУВИ́НЕЦ урианхай хүн, туваа хүн.

ТУВИ́НКА урианхай эмэгтэй, туваа эмэгтэй.

ТУВИ́НСКИЙ урианхай, туваа, урианхайн, туваагийн.

ТУ́ГО 1. пиг дүүрэн, дүүрэн, чигжүү; **~ набить мешок** хүүдий пиг дүүрэн чихэх, хүүдий пиг дүүргэх; 2. чанга; **~ натянуть** чанга татах; 3. арай гэж, чуу гэж, арай чамай, арай муруй; **дело подвигается ~** хэрэг урагш муутай байна; 4. бэрх(*тэй*) байх, хэцүү байх, бэрхшээлтэй байх; **ему пришлось ~** тэр (*хүн*) бэрхшээлтэй байв; **~ натуго** 1)чав чанга; 2) пиг дүүрэн, дүв дүүрэн.

ТУГ||О́Й 1. чанга, чанга татсан, хатуу, хатуу, хөшүүн; **~ая пружина** чанга пүрш; 2. пиг дүүрэн, дүүрэн чихсэн, дүүрэн, чигжүү хийсэн; **~ мешок** пиг дүүрэн хүүдий; **~ на ухо** чих хатуу.

ТУГОПЛА́ВКИЙ хайлц муутай; **~ металл** хайлц муутай төмөрлөг.

ТУГОПЛА́ВКОСТЬ муу хайлц, хайлц муу

ТУ́ГРИК төгрөг

ТУДА́ тийш, тэнд, цааш; **идите ~** тийшээ очигтун; **билет ~ и обратно** очиж ирэхийн билет; ни туда, ни сюда цаашаа ч үгүй, наашаа ч үгүй, тийшээ ч үгүй, ийшээ ч үгүй, хаашаа ч үгүй; **~ ему и дорога** болж, болжээ, болж.

ТУДА́-СЮДА́ 1. ийш тийшээ; **посмотреть ~** ийш тийшээ харах; 2. зүгээр, нуруутай, гайгүй; **это ещё ~** энэ ч нуруутай байна.

ТУЖИ́ТЬ гунихрах, гуних, саная зовох, шаналах, энэлэх.

ТУ́ЖИТЬСЯ дүлэх.

ТУЖУ́РКА морин хүрэм.

ТУЗ 1. тамга; червонный туз буймангийн тамга; **ходить с ~а** тамгаар явах; 2. том хүн, нөлөөтэй хүн.

ТУЗЕ́МЕЦ нутгийн хүн, тэндхийн хүн; **туземцы** тэндхийнхэн.

ТУЗЕ́МКА (*уул*) нутгийн эмэгтэй, тэндхийн эмэгтэй.

ТУЗЕ́МН||ЫЙ (*уул*) нутгийн, тэндхийн; **~ое население** уул нутгийн хүмүүс.

ТУЗИ́ТЬ нударгадах, балбах, жанчих.

ТУЗЛУКОВА́ТЬ (*шкуру*) арьс шир ганлах.
ТУК эрдэс бордоо.
ТУКА́Н *(птица)* арвас хошуут.
ТУ́ЛОВИЩЕ их бие, мухар бие, цээжин бие.
ТУЛУ́П хөдсөн дээл, нэхий дээл; **овчинный** ~ хонины нэхий дээл.
ТУ́ЛЬ||Я (*малгайн*) орой; **шляпа с высокой ~ей** өндөр оройтой бүрх.
ТУМА́К нударга шаах; **дать ~а кому-либо** нударгалах.
ТУМА́Н 1. манан, будан, униар; **густой** ~ өтгөн манан; **спустился** ~ манан буув, манан татав; 2. бүртэлтэх, манарах, балартах, мансуурах; ~ **в глаза** нүд бүртэлтэх; **у меня в голове** ~ *миний* толгой мансуурч байна.
ТУМА́НИ||ТЬ 1. манантуулах, хүдэнтүүлэх, будантуулах, униартуулах, манантах, хүдэнтэх, будантах, униартах; **дым ~т даль** алст утаа манантана; 2. манаруулах, балартуулах, мансууруулах, бүргэлтүүлэх, манарах, балартах, мансуурах, бүртэлтэх; **слёзы туманят глаза** нүд нулимсанд бүртэлзэнэ; **вино ~т голову** толгой архинд мансуурна.
ТУМА́НИТЬСЯ 1. манантах, хүдэнтэх, будантах, униартах, манарах; 2. манарах, балартах, мансуурах, бүргэлтэх.
ТУМА́ННОСТЬ 1. хүдэн, мананцар; 2. (одон орны) мананцар; 3. балар байх, бүрэг байх, бүдэг болох.
ТУМА́НН||ЫЙ 1. манантай, хүдэнтэй, будантай, униартай, манарсан, манан татсан, манан хүдэн татуулсан; **~ая погода** манантай тэнгэр; **~ая даль** униар татсан алс, униартсан алс; 2. утга балар, бүрэг, бүрхэг, учир дутмаг; **~ое выражение** бүрхэг утгатай үг, бүрхэг утгатай хэллэг; 3. гөлийсөн, бүдэг; **~ый взгляд** бүдэг харц.
ТУ́МБА 1. шон; 2. тавиур, суурь; 3. лаглагар хүн.
ТУ́МБОЧКА орны шүүгээ, шургуулга.
ТУНГ чулууны туулайн бөөр.
ТУ́НГОВ||ЫЙ чулууны туулайн бөөрний; **~ое масло** чулууны туулайн бөөрний тос.
ТУНГУ́С хамниган
ТУНГУ́СКА хамниган эмэгтэй.
ТУНГУ́ССКИЙ хамниган, хамниганы.
ТУ́НДРА, тундр
ТУ́НДРОВ||ЫЙ тундрын; **~ая полоса** тундрын бүслүүр.
ТУНЕЯ́ДЕЦ бусдын хүчээр амьдрагч, хувалз.
ТУНЕЯ́ДКА бусдын хүчээр амьдрагч эмэгтэй, хувалз
ТУНЕЯ́ДСТВО бусдын хүчээр амьдрах.
ТУННЕ́ЛЬ хонгил, туннель; ~ **метрополитена** метроны хонгил; **горный** ~ уулын хонгил.
ТУННЕ́ЛЬНЫЙ хонгилын, туннелийн.
ТУПЕ́ТЬ 1. мохох, толхигдох; 2. мохох, моҳдог болох, мунхрах, эргүү болох.
ТУПИ́К 1. (*гудамжны*) мухар, мухар гудамж; 2. (*замын*) мухар, мухар зам; 3. мухардал, мухардах, тулгамдах, газардах; **поставить в** ~ мухардуулах, газардуулах.
ТУПИ́ТЬ *мохоох толхих;* ~ **нож** хутга толхих.
ТУПИ́ТЬСЯ мохох, мохоо болох, толхигдох
ТУПИ́ЦА мохоо хүн, моҳдог хүн.
ТУП||ОЙ 1. мохоо, иргүй; **~ая пила** иргүй хөрөө; 2. үзүүргүй, мохоо; **~ая игла** үзүүргүй зүү; 3. мохоо, мондгор, мухар; ~ **конец яйца** өндөгний мондгор тал; ~ **нос лодки** завины мухар хушуу; 4. мохоо, моҳдог, эргүү, мунхаг; ~ **человек** моҳдог хүн; 5. мохоо, балай; ~ **взгляд** *мохоо харц;* 6. үг дуугүй, дугай, хариугүй; **~ая покорность** үг дуугүй дагах, үг дуугүй захирагдах; 7. чинэрэх; **~ая боль** чинэрэх өвчин, чинэрэн өвдөх; ~ **угол** мохоо өнцөг.
ТУПОКОНЕ́ЧНЫЙ мухар үзүүртэй.
ТУПОНО́С||ЫЙ мохоо хамартай, мухар хушуутай, монхгор хоншоортой; **~ые сапоги** монхгор хоншоортой гутал.
ТУ́ПОСТЬ *мохоо, моҳдог;* ~ **ума** *ухаан моҳдог.*
ТУПОУ́МИЕ мунхаг ухаан, мохоо ухаан.
ТУПОУ́МНЫЙ мунхаг, тэнэг, моҳдог, мохоо ухаантай.
ТУР I 1. эргэлт; ~ **вальса** вальсын нэг эргэлт; 2. даваа; 3. шат; **выборы в два ~а** хоёр шаттай сонгууль.
ТУР II бух гөрөөс
ТУР III янгир ямаа
ТУ́РА *разг. (шатрын)*тэрэг
ТУРБИ́НА турбин, хөдөлгүүр (*уур, хий, усны урсгал гурвын аль нэгний хүчээр хөдөлнө*); **паровая** ~ уурын хөдөлгүүр; **газовая** ~ хийн хөдөлгүүр; **гидравлическая** ~ усан хөдөлгүүр.
ТУРБИ́НН||ЫЙ турбины, хөдөлгүүрийн, турбинт, хөдөлгүүрт; **~ое отделение** хөдөлгүүрийн салбар, хөдөлгүүрт тасаг.
ТУРБОБУ́Р өрөмдүүр, газар өрөмдөх машин; **скорость вращения ~а** өрөмдүүрийн эргэлтийн хурд.
ТУРБОГЕНЕРА́ТОР турбогенератор, хөдөлгүүрт үүсгүүр.
ТУРБОГЕНЕРА́ТОРНЫЙ турбогенераторын, хөдөлгүүрт үүсгүүрийн; ~ **завод** хөдөлгүүрт үүсгүүрийн завод.
ТУРБОСТРОЕ́НИЕ турбин үйлдвэрлэх, хөдөлгүүр үйлдвэрлэх.
ТУРЕ́ЦКИЙ түрэг, түрэгийн; ~ **язык** түрэг хэл.
ТУРИ́ЗМ жуулчлал, жуулчлах; **горный** ~ уулын жуулчлал, уулаар жуулчлах.
ТУ́РИЙ I бух гөрөөсний; ~ **рог** бух гөрөөсний эвэр.
ТУ́РИЙ II янгир ямааны, янгирын.
ТУРИ́СТ жуулчин.
ТУРИСТИ́ЧЕСК||ИЙ тойрон явагчдын, жуулчдын; **~ая база** тойрон явагчдын бааз.
ТУРИ́СТКА жуулчин эмэгтэй.
ТУ́РКИ түрэгүүд
ТУРКМЕ́Н туркмен хүн
ТУРКМЕ́НКА туркмен эмэгтэй.
ТУРКМЕ́НСК||ИЙ туркмен, туркмений; **~ие ковры** туркмен хивс.
ТУ́РМАН годройтдог тагтаа; **полететь ~ом** годройтон унах.
ТУРНЕ́ПС тэжээлийн манжин, турнепс
ТУРНИ́К турник, дүүжин
ТУРНИКЕ́Т (*хумуусийг нэг нэгээр нь оруулахад зориулсан*) хүрдэн хаалга.
ТУРНИ́Р 1. тэмцээн, наадам; 2. тэмцээн; **шахматный** ~ шатрын тэмцээн.
ТУРНУ́ТЬ хөөх, хөөн зайлуулах, үлдэн хөөх.
ТУ́РОК түрэг хүн.
ТУРПА́Н ангир, дөрт нугас.
ТУРУ́СЫ хоосон чалчаа яриа, худал хуурмаг үг; **разводить** ~ дэмий чалчих, худал хуурмаг үг ярих.
ТУРЧА́НКА түрк эмэгтэй.
ТУ́СКЛОСТЬ 1. бүдэг *байх,* бүдэх *байх,* бүдэнх *байх,* бүүдгэр *байх,* сүүмгэр *байх;* 2. хурц бус *байх,* золбоогүй *байх,* үхээнц *байх,* сүүмгэр *байх.*
ТУ́СКЛ||ЫЙ 1. бүдэг, бүдэнх; **~ое стекло** бүдэх шил; 2. бүдэг, бүдэх, бүдэнх, бүүдгэр, сүүмгэр; ~ **свет** сүүмгэр гэрэл, бүдэнх гэрэл; ~ **день** бүүдгэр өдөр, 3. хурц бус, золбоогүй, үхээнц, сүүмгэр, ~ **взгляд** сүүмгэр харц.
ТУСКНЕ́ТЬ 1. бүдэгрэх, бүдэхрэх, бүдэнхрэх, бүүдийх, сүүмийх; 2. хурц бус болох, золбоогүй болох, үхээнц болох, сүүмийх, сулрах; 3. буурах, доройтох.

ТУ́СКНУТЬ 1. бүдэгрэх, бүдэхрэх, бүдэнхрэх, бүүдийх, сүүмийх; 2. хурц бус болох, үхээнц болох, золбоогүй болох, сүүмийх, сулрах; 3. буурах, доройтох.

ТУТ I энд; **я пойду, а ты подожди** ~ би явъя, чи энд хүлээ; **и всё** ~ ийм л байна; ондоо юмгүй, ондоо яах ч аргагүй; ~ **как** ~ яг ирээд байх, яг бий болоод байх.

ТУТ II ялам мод.

ТУ́ТОВ||ЫЙ ялам, ялмаа, ялмын; **~ое дерево** ялмын мод; ~ **шелкопряд** ялмын хүр хорхой.

ТУТ-ТО чухам энд, энд л; **не ~ было** тэгээд газардав, гэнэт арга мухардав.

ТУФ бөсөл (*чулуу*); **вулканические ~ы** галт уулын бөсөл.

ТУ́ФЛИ шаахай; **домашние** ~ гэрийн шаахай.

ТУ́ХЛ||ЫЙ өмхийрсөн, өмхий, ялзарсан; **~ое яйцо** өмхийрсөн өндөг, ялзарсан өндөг; **~ое мясо** ялзарсан мах.

ТУХЛЯ́ТИНА өмхийрсөн юм, бээсэн юм, ялзарсан юм.

ТУ́ХН||УТЬ I унтрах, сөнөх, бөхөх; **костёр ~ет** түүдэг унтарна.

ТУ́ХНУТЬ II үнэр орох, өмхий болох, өмхийрөх, бээх, ялзрах, гутах.

ТУ́Ч||А 1. үүл; **грозовая** ~ аадар бороонд үүл, дуутай бороонд үүл; 2. үй түмэн, тоо томшгүй олон; **~и комаров** үй түмэн шумуул; 3. гай, аюул; **~и собрались над ним** түүнд гай тохиолдох нь байна; **~~ей** 1)үй олон, үй түмэн; 2)хөрхгөр, баргар; **смотреть ~ей** баргар царай гаргах; **не из ~и гром** гай газар дороос.

ТУЧЕВО́Й үүлний, үүлэн.

ТУ́ЧКА бяцхан үүл, үүлхэн.

ТУЧНЕ́ТЬ бүдүүрэх, таргалах, мариалах.

ТУ́ЧНОСТЬ 1. бүдүүн байх, тарган байх, мариатай байх; 2. ургац сайтай байх, үржилтэй байх, шимтэй байх; 3. өвс ногоо сайтай байх.

ТУ́ЧН||ЫЙ 1. тарган, бүдүүн, мариатай, лухгар; ~ **мужчина** лухгар эр; 2. ургац сайтай, үржилтэй, шимтэй; ~ **чернозём** шимтэй хар шороо; 3. өвс ногоо сайтай; **~ые луга** өвс ногоо сайтай нуга.

ТУШ туш, ёслох хөгжим, ёслолын хөгжим; **сыграть** ~ туш хөгжимдөх.

ТУ́ША 1. гулууз; **коровья** ~ үхрийн гулууз; 2. лаглагар хүн, лантгар хүн.

ТУШЕ́ 1. хүрцэл; 2. дал газардах, дал шороодох.

ТУШЕВА́ТЬ харандаа буюу будгаар сүүдэр зурах, сүүдэрлэх.

ТУШЁВКА 1. сүүдэр зурах, сүүдэрлэх; 2. зураас, зурсан сүүдэр

ТУШЕ́НИЕ I унтраах, бөхөөх, сөнөөх

ТУШЕ́НИЕ II битүү шарах, битүү болгох, жигнэн хайрах.

ТУШЁН||ЫЙ битүү шарсан, битүү болгосон, жигнэн хайрсан; **~ое мясо** битүү шарсан мах.

ТУШИ́ЛКА унтраагуур, унтраах сав.

ТУШИ́ТЬ I 1. унтраах, сөнөөх, бөхөөх; ~ **лампу** дэн унтраах; ~ **огонь** гал сөнөөх; 2. дарах, номхотгох; ~ **гнев** уур дарах.

ТУШИ́ТЬ II битүү шарах, битүү болгох, жигнэн хайрах; ~ **овощи** ногоо битүү болгох.

ТУШИ́ТЬСЯ I унтрах, сөнөх, бөхөх; **огни тушатся рано** гэрэл эрт унтарна.

ТУШИ́ТЬСЯ II битүү шарагдах, битүү болгогдох, жигнэгдэн хайрагдах, битүү шарах, битүү болгох; **мясо должно ~ два часа** махыг хоёр цаг битүү болгох хэрэгтэй.

ТУШКА́НЧИК алгадаахай.

ТУШЬ өтгөн бэх, түүш; **цветная** ~ өнгийн түүш.

ТУ́Я майлаас; ~ **восточная** дорнодын майлаас; ~ **японская** япон дэлбэн майлаас.

ТЩА́ТЕЛЬНОСТЬ нарийн нягт, нарийн нямбай байх, нарийн байх, нямбай байх, хичээнгүй байх, оролдлоготой байх.

ТЩА́ТЕЛЬН||ЫЙ нарийн, нягт нямбай, нямбай, хичээнгүй, оролдлоготой; **~ое изучение вопроса** асуудлыг нарийн нягт судлах.

ТЩЕДУ́ШИЕ бие үлбэгэр байх, тамир тэнхээгүй байх, бие сул байх, бие дорой байх.

ТЩЕДУ́ШНЫЙ үлбэгэр, тамир тэнхээгүй, сул дорой.

ТЩЕСЛА́ВИЕ нэрэлхүү зан, ихэрхэг зан.

ТЩЕСЛА́ВНЫЙ нэрэлхэг нэрэлхүү, нэр алдарт дуртай, ихэрхүү, ихэрхэг, дээрэлхүү, дээрэлхэг.

ТЩЕ́ТА дэмий байх, хоосон чанар, үргүй явдал, тусгүй хэрэг; ~ **надежд** хоосон горьдлого.

ТЩЕ́ТНО дэмий хоосон, үргүй.

ТЩЕ́ТНОСТЬ дэмий байх, хоосон байх, тусгүй байх, үргүй байх.

ТЩЕ́ТН||ЫЙ дэмий, хоосон, талаар, тусгүй, үргүй; **~ые попытки** дэмий оролдлого; **~ая надежда** хоосон горьдлого.

ТЫ чи; **что ~ тут делаешь?** чи тэнд юу хийж байна? **тебя зовут** чамайг дуудаж байна.

ТЫ́КАТЬ I 1. чичих, хатгах, тонших; ~ **палкой в землю** модоор газар чичлэх; 2. шаах, хатгах; ~ **колья в землю** гадас газар шаах; 3. гудрах, шургуулах, чихэх, нудрах; 4. заах; ~ **пальцем на кого-либо** (*хүн рүү*) хуруугаараа чичлэх; ~ **в нос** сануулан улиг болох. зэмлэн улиг болох; ~ **свой нос** хушуу нэмэх, хүний хэрэгт оролцох.

ТЫ́КАТЬ II чийлэх, чи гэх.

ТЫ́КАТЬСЯ мөргөх, чихэлдэх.

ТЫ́КВА хулуу

ТЫ́КВЕНН||ЫЙ хулуугийн; **~ые семечки** хулууны үр.

ТЫКВООБРА́ЗНЫЙ хулуу мэт, хулуу шиг, хулуу хэлбэртэй.

ТЫЛ 1. ар, ар тал; **глубокий** ~ хол ар тал; **в ~у врага** дайсны ар талд; **работать в ~у** ар талд ажиллах; 2. ар, арын анги; **служба ~а** арын алба; **подтянуть ~ы** арын ангийг ойртуулах; 3. ар, ар тал; **ветер дует с ~а** ар талаас салхи үлээнэ.

ТЫЛОВИ́К арын албаны хүн.

ТЫЛОВО́Й арын, ар талын.

ТЫ́ЛЬН||ЫЙ ар, мөр, арын, ар талын, мөрийн; **~ая часть руки** алганы ар; **~ая сторона ножа** хутганы мөр.

ТЫН хашаа, шивээ

ТЫ́СЯЧ||А 1. мянга(н); **десять тысяч** түм; **сто тысяч** бум; ~ **и одна ночь** мянга нэгэн шөнө; 2. мянга мянган, мянга түмэн, олон мянган; **~и людей** мянга түмэн хүн; **~у раз** мянга түм дахин, зуу дахин; **в ~у раз** хэмжээлшгүй, хязгаарлашгүй, мянга түм дахин.

ТЫСЯЧЕЛИ́СТНИК *бот.* төлөгч өвс

ТЫСЯЧЕЛЕ́ТИЕ 1. мянган жил; 2. мянган жилийн ой.

ТЫСЯЧЕЛЕ́ТНИЙ мянган жилийн, мянган наст.

ТЫ́СЯЧНИК мянгатан

ТЫ́СЯЧН||ЫЙ 1. мянгадугаар, мянгадахь; ~ **по счёту** мянгадугаар; 2. мянган, олон мянган; мянгын, олон мянгын; 3. мянганы; **~ая доля** мянганы нэг хувь; 4. мянганы хувь; **одна ~ая** мянганы нэг хувь.

ТЫЧИ́НКА дохиур

ТЬМА I 1. харанхуй; **ночная** ~ шөнийн харанхуй; 2. мунхаг харанхуй, харанхуй бүдүүлэг, харанхуй.

ТЬМА II үй түм, түм түмэн, тоолшгүй олон; ~ **народу** үй түмэн хүн; **~~тьмущая** тоо томшгүй, үй түмэн.

ТЬФУ түй, пээ, хээ

ТЮБЕТЕ́ЙКА тоорцог, товь (*малгай*).

ТЮБИК олгойнцор.

ТЮК баглаа, боодол; **~и хлопка** баглаа хөвөн.

ТЮКОВА́ТЬ баглах, боох

ТЮ́ЛЕВ||ЫЙ шаа, шааны, шаагаар хийсэн; **~ая занавеска** шаа хөшиг.
ТЮЛЕ́НЕВЫЙ далайн нохойн арьсан, хав загасны арьсан.
ТЮЛЕ́НИЙ далайн нохойн, хав загасны; **~ жир** далайн нохойн өөх.
ТЮЛЕ́НЬ 1. далайн нохой, хав загас; 2. болхи амьтан, болхи хүн.
ТЮЛЬ шаа.
ТЮЛЬПА́Н 1. алтан зул цэцэг; 2. дэнгийн шилэн бүрхүүл.
ТЮЛЬПА́ННЫЙ алтан зул цэцгийн
ТЮРБА́Н алчуур, толгойн ороолт.
ТЮРЕ́МН||ЫЙ шоронгийн, гяндангийн; **~ое здание** шоронгийн байшин; **~ое заключение** шоронд хорих.
ТЮРЕ́МЩИК (*шоронгийн*) хуяг
ТЮРК тюрк, түрэг.
ТЮ́РКИ тюркүүд, түрэгүүд.
ТЮ́РКСК||ИЙ тюрк, түрэг, турк, түрэгийн; **~ие языки** түрэг хэлнүүд.
ТЮРЬМ||А́ шорон, гяндан, хар гэр; **заключить (посадить) в ~у** шоронд хийх, шоронд хорих; **выпустить из ~ы** шоронгоос тавих, суллах.
ТЮ́РЯ талх үрсэн ус (*квас*)
ТЮФЯ́К 1. дэвсгэр, ширдэг; **волосяной ~** хялгасан дэвсгэр; **соломенный ~** сүрэл дэвсгэр; 2. зориггүй хүн, өөдгүй хүн.
ТЮФЯ́ЧНЫЙ дэвсгэрийн.
ТЯ́ВКАНЬЕ, ТЯ́ВКАТЬ,
ТЯ́ВКНУТЬ чор чор хуцах.
ТЯ́ГА 1. зүтгүүр, хөллүүр, чирүүл, татуур; **механическая ~** механик чирүүл; **электрическая ~** цахилгаан зүтгүүр; **паровая ~** уурын зүтгүүр; 2. татац; **~ дымохода** яндангийн татац; 3. зүтгүүр, зүтгэх хүч; 4. тэмүүлэх, эрмэлзэх; **~ к науке** эрдэм рүү тэмүүлэх; **~ к культуре** соёл боловсролтой болохыг эрмэлзэх; 5. шувуу нислэг; **дать тягу** түргэн зугтаах.
ТЯГА́ТЬСЯ 1. өрсөлдөх, үзэлцэх, уралдах; **с ним ~ трудно** түүнтэй үзэлцэх бэрх; 2. заргалдах, заалдах.
ТЯГА́Ч чирдэг трактор, зүтгүүр трактор.
ТЯ́ГОСТН||ЫЙ 1. хүнд, хүчир, хэцүү бэрх; **~ое положение** хэцүү байдал; 2. яршигтай, төвөгтэй, залхуутай, зовуурьтай, зовлонтой; **~ое явление** зовлонтой үзэгдэл.
ТЯ́ГОСТЬ 1. дарамт, төвөг, зовлон, яршиг; **быть кому-либо в ~** хүнд зовлон болох, хүнд төвөг болох; 2. ядарч туйлдах, цуцрах; **чувствовать ~ во всём теле** бүх бие цуцрах, хамаг бие өвдөх.
ТЯГОТА́ дарамт, зовлон, төвөг, яршиг.
ТЯГОТЕ́НИЕ 1. таталт, таталцах хүч, **земное ~** дэлхийн таталт; 2. тэмүүлэх, эрмэлзэх, дурлах; **~ к науке** шинжлэх ухааныг эзэмшихийг эрмэлзэх; **~ к музыке** хөгжим сурахыг эрмэлзэх, хөгжимд дурлах.
ТЯГОТЕ́ТЬ 1. тэмүүлэх, эрмэлзэх, дурлах; **~ к музыке** хөгжимд дурлах; 2. зовоох, дарах.
ТЯГОТИ́ТЬ дарамт болох, тээр болох, яршиг болох, төвөг болох.
ТЯГОТИ́ТЬСЯ бэрхшээх, хүндшээх, төвөгшөөх, яршиглах, хашрах; **~ одиночеством** ганцаараа байж хашрах, ганцаараа байхаас бэрхшээх.
ТЯГУ́ЧЕСТЬ 1. сунац; 2. унжралдсан наалданги (*байх*); 3. урт (*байх*), унжралдсан удаан (*байх*).
ТЯГУ́Ч||ИЙ 1. сунадаг, сунах; **~ металл** сунадаг төмөрлөг; 2. унжралдсан, нялцгай өтгөн; **~ее тесто** нялцгай гурил; 3. урт, уртын, унжралдсан, удаан; **~ая песня** уртын дуу.
ТЯЖ татлага, сур; **~ тормозного вала** торможын голын сур.
ТЯ́ЖБА 1. зарга, зарга заалхай; 2. бооцоо, арцалдаа.
ТЯЖЕЛЕ́||ТЬ хүндрэх, хүнд болох; **веки у меня ~ют** миний нүд анилдаж байна.
ТЯЖЕЛО́ 1. хүнд; **~ натруженный автомобиль** хүнд ачаатай машин; 2. хүнд, нүсэр; **~ ступать** нүсэр алхлах; 3. нахүнд; **он ~ болен** тэр (*хүн*) хүнд.
ТЯ́ЖЕСТ||Ь 1. хүнд; **центр ~и** 1) хүндийн төв; 2) гол зүйл, гол асуудал; **сила ~и** хүндийн хүч; 2. хүнд юм, ачаа; **поднятие ~и** хүнд юм өргөх; 3. бэрх байх, хэцүү байх, хүнд байдал, бэрхшээл; **~ разлуки** хагацлын бэрхшээл; 4. хүнд, хатуу; **смягчить ~ наказания** хатуу шийтгэлийг зөөлрүүлэх.
ТЯ́ЖК||ИЙ хүнд хүчир, хэцүү бэрх, хүнд их; **~ие преступления** хүнд их ял.
ТЯНУ́ТЬ 1. татах, чангах, чирэх; **~ веревку** олс татах; **~ кого-либо за рукав** ханцуй дээрээс нь чангаах; 2. татах; **печка хорошо тянет** пийшин сайн татаж байна; 3. удаашруулах, дарах, удаашрах, дарагдах; **он тянет с ответом** тэр (*хүн*) хариу өгөхийг удаашруулж байна; **~ дело** хэрэг удаашруулах, хэрэг дарагдуулах; 4. дуудаж аваачих (*авчрах*), урьж аваачих (*авчрах*), чирч аваачих (*авчрах*); 5. дур татах, дур хүрэх; **меня тянет попутешествовать** миний жуулчлах дур хүрнэ; 6. үлээх, цоргих, ханхлах, үнэртэх; **от окна тянет холодом** цонхноос хүйт үлээнэ.
ТЯНУ́ТЬСЯ 1. сунах, тэнийх, тэлэгдэх. 2. суниах 3. цэлийх, нэлийх, үргэлжлэх 4. үргэлжлэх, ужих 5. удах, удаан болох, ужих 6. тэмүүлэх, уллах, эрмэлзэх 7. цувах, цуврадах 8. гүйцэх, зэрэгцэхийг эрмэлзэх.
ТЯНУ́ЧКА маатан.
ТЯ́ПАТЬ 1. цохих, цавчих 2. дэлсэх, хулгайлах.
ТЯ́ПНУТЬ 1. цохих, цавчих **~ топором** сүхээр цохих 2. дэлсэх, хулгайлах.
ТЯ́ТЯ ажаа, аав.

У

У I 1. эз, ээдэз; 2. ий; **~, какие страсти!** ий, яасан айхтар юм!

У II 1. дээрх, дэргэд, хажууд, захад; **дом ~ самого берега реки** голын яг эрэг дээрхи байшин; **остановиться ~ двери** үүдний дэргэд зогсох; 2. - д, - тай; **сидеть ~ моря, ждать погоды** далайн хөвөөнд сууж тэнгэр засрахыг хүлээх *(бухын засааг харж үнэг турж үхэх);* **жить ~ своих родителей** аав ижийндээ суух; **шить пальто ~ портного** оёдолчныд хүрэм оёулах; **работать ~ нас хорошо** манайд ажиллах сайхан; **~ певца сильный голос** сайн хоолойтой дуучин, **~ меня нет свободного времени** над зав байхгүй; **~ него три сына** тэр гурван хүүтэй; **~ певца сильный голос** дуучин дорвитой хоолойтой, дуучин хүчтэй хоолойтой юм; 3. - ын, - ны; **ящик ~ стола выдвижной** ширээний шургуулга сугардаг юм; **ворота ~ сарая закрыты** саравчны хаалга хаалттай; 4. - аас *(- ээс, - оос, - өөс);* **спросить ~ учителя** багшаас асуух; **узнать ~ товарища** нөхрөөс олж мэдэх; **купить ~ букиниста книгу** хуучин ном худалдагчаас ном авах; **смотри ты ~ меня!** чи сайхан мэдээрэй!

УБА́ВИТЬ 1. багасгах, богиносгох, хасах, хорогдуулах, танах; **~ расходы** зардлыг багасгах; **~ скорость** хурдыг хасах; **~ цену** үнийг хорогдуулах; **~ длину платья** тэрлэгийн уртаас танах; 2. хөнгөрөх, багасах; **~ в весе** жин нь хөнгөрөх.

УБАВЛЯ́ТЬ 1. багасгах, богиносгох, хасах, хорогдуулах, танах; 2. хөнгөрөх, багасах.

УБАВЛЯ́ТЬСЯ багасах, богиносох, хасагдах, хорох, дундрах, татрах.

УБАЮ́КАТЬ 1. бүүвэйлэх, бүүвэйлж унтуулах; 2. зүүрмэглүүлэх, үүрэглүүлэх, дуурайлуулах; 3. тайтгаруулах, тайвшруулах; **~ надеждой** горьдлогоор тайтгаруулах.

УБАЮ́КИВА||ТЬ 1. бүүвэйлэх, бүүвэйлж унтуулах; 2. зүүрмэглүүлэх, үүрэглүүлэх, дуурайлуулах; **морская качка ~ет** далайн долгио займчсаар зүүрмэглүүлнэ; 3. тайтгаруулах, тайвшруулах.

УБЕГА́ТЬ 1. гүйж очих, гүйж явчхах; 2. оргох, зугтах; 3. дэврэх, халих, асгарах.

УБЕДИ́ТЕЛЬНО 1. итгэмээр, үнэмшим; **~ говорить** итгэмээр хэлэх; 2. учирлаж; **~ просить** учирлаж гуйх.

УБЕДИ́ТЕЛЬНОСТЬ итгүүлэх чадал, үнэмшүүлэх чадал.

УБЕДИ́ТЕЛЬНЫЙ 1. итгүүлэх, үнэмшүүлэх; **~ аргумент** үнэмшүүлэх баримт; **~ пример** итгүүлэх жишээ; 2. учирлах, ихэд; **убедительная просьба** учирлаж гуйх.

УБЕДИ́||ТЬ 1. итгүүлэх, үнэмшүүлэх, сэнхрүүлэх; **~ в своей правоте** өөрийнхөө зөв болохыг итгүүлэх; 2. зөвшөөрүүлэх, ятгах, ойлгуулж өгөх, үгэндээ оруулах; **его ~ли лечиться** биеэ эмнүүлэхийг түүнд ойлгуулж өгөв.

УБЕДИ́||ТЬСЯ үнэмших, итгэх, зөвшөөрөх; **я ~лся в том, что он прав** түүнийхийг би зөв гэдэгт итгэсэн.

УБЕЖА́||ТЬ 1. гүйж очих, гүйгээд явчих; 2. оргох, зугтах; **~ из плена** олзлогдсон хүн, оргох; 3. дэврэх, халих, асгарах; **молоко ~ло** сүү дэврэв.

УБЕЖДА́ТЬ 1. итгүүлэх, үнэмшүүлэх; 2. сэнхрүүлэх, ятгах, ойлгуулж өгөх.

УБЕЖДА́ТЬСЯ үнэмших, итгэх, зөвшөөрөх, ятгагдах.

УБЕЖДЕ́НИ||Е 1. ятгалга, ятгах, сэнхрүүлэх, үнэмшүүлэх, итгүүлэх; **действовать путём ~я** сэнхрүүлэх аргаар ажиллах; **сила ~я** ятгалгын хүч; 2. үзэл, бат үзэл, тогтсон үзэл; **политические ~я** улс төрийн бат үзэл.

УБЕЖДЁННО итгэлтэй, найдлагатай, үнэмшилтэй.

УБЕЖДЁННОСТЬ итгэл, бат итгэх, найдлага, бат найдах; **~ в своей правоте** өөрийнхөө зөвд бат итгэх.

УБЕЖДЁННЫЙ бат, итгэсэн, бат итгэлтэй, туушгай; **~ последователь** бат итгэлтэй мөрдөн дагагч.

УБЕ́ЖИЩ||Е хоргодох газар, хоргодох, орох орон; **право ~а** хоргодох эрх.

УБЕЛЁННЫЙ цайсан, бууралтсан; **~ сединами** үс нь цайсан азай буурал.

УБЕЛИ́ТЬ,

УБЕЛЯ́ТЬ цав цагаан болгох, бүр цайруулах.

УБЕРЕГА́ТЬ хамгаалах, хямгадах, арчлах, хүргэхгүй байх.

УБЕРЕГА́ТЬСЯ хамгаалах, биеэ хамгаалах, арчлах.

УБЕРЕ́ЧЬ хамгаалах, хямгадах, арчлах, хүргэхгүй байх.

УБЕРЕ́ЧЬСЯ хамгаалах, биеэ хамгаалах, арчлах; **~ от простуды** ханиаднаас биеэ хамгаалах.

УБИВА́ТЬ 1. алах, нядлах; 2. үгүй хийх, устгах, таслах; 3. цохрөөх, гутраах, алж хаях; 4. гарздах, барах.

УБИВА́ТЬСЯ гасалж зовох, гинших, гашуудаж зовох, сэтгэл овох,гаслахын ихээр гаслах.

УБИ́ЙСТВЕНН||ЫЙ 1. үхмээр, хортой, хөнөөлтэй; **~ климат** хортой уур амьсгал; 2. айхтар их, тэсэх аргагүй, тэсэшгүй; **~ая жара** айхтар их халуун.

УБИ́ЙСТВО хүнийг алах, алах, амь бусниулах.

УБИ́ЙЦА алагч, хүн алагч, алуурчин, алсан хүн.

УБИРА́ТЬ 1. хураах, татаж авах, авах, хурааж авах; 2. цэвэрлэх, цэгцэлж засах, засах, засаж залах; 3. чимэглэж засах, гоёх; 4. хийх, хадгалах.

УБИРА́||ТЬСЯ 1. цэвэрлэж засах, засаж залах, өөд татах; 2. тонилох, зайлах; **~йся вон!** зайл! тонил!

УБИ́ТЫЙ 1. алагдсан, алуулсан, амь үрэгдсэн, үхсэн; 2. их гутарсан, их цөхөрсөн; **у него ~ вид** тэр их гутарсан царайтай байна.

УБИ́||ТЬ 1. алах, нядлах; **~ волка** чоно алах; 2. үгүй хийх, устгах, таслах; **~ надежду** горьдлогыг таслах; 3. цохрөөх, гутраах, алж хаях; **это известие его ~ло** энэ мэдээ түүнийг цохрөөв. 4. гарздах, барах; **на это дело ~то много времени** энэ хэрэгт их цаг гарзадсан юм; **хоть убей меня — не могу** *(не знаю)* ална ч гэсэн, аварна ч гэсэн чадахгүй *(мэдэхгүй).*

УБИ́ТЬСЯ их гэмтэх, биеэ их гэмтээх, бэртээх, чанга цохих, биеэ чанга цохих.

УБЛАГОТВОРИ́ТЬ,

УБЛАГОТВОРЯ́ТЬ таллыг хангах.

УБЛАЖА́ТЬ,

УБЛАЖИ́ТЬ аргадах, долигонох; **~ старика** өвгөнийг аргадах.

УБЛЮ́ДОК 1. ортоом, бэсрэг мал; 2. хяргуй, хүний оронцог, шаараи амьтан; **фашистские ублюдки** фашистын хяргуйнууд.

УБО́Г||ИЙ 1. ядуу, ягир, ягтаа тулсан, дорой, ядуу дорой; **~ое жилище** ядуу дорой сууц; 2. эрэмдэг, мундсан; **~ая старуха** эрэмдэг эмгэн.

УБО́ЖЕСТВО 1. эрэмдэг, мундал; 2. ядуу ядуу, дорой, дуль, дуль ядуу; **~ воображения** ургуулан бодохдоо дуль ядуу.

УБО́Й нядлах, нядлага, ярга, ярга хийх, идэш хийх; **кормить на ~** 1. шахаж тэжээх; 2. бялуурталд идүүлэх.

УБО́ЙНЫЙ 1. ярганы, нядлах, нядалгааны, идэшний; **~ скот** нядлах мал; **~ вес** нядалгааны жин, гулуузын жин; 2. сөнөөх, сүйтгэх; 3. *разг.* маш гоё, дээд зэргийн.

УБО́Р хувцас, гоёл; **свадебный ~** хуримын гоёл; **головной ~** малгай.

УБО́РИСТЫЙ шигүү; **~ почерк** шигүү бичиг.

УБО́РКА 1. хураах, хурааалга; **~ урожая** ургац хураах; 2. цэвэрлэж засах, хурааж хумих, татаж авах, засаж залах; **~ помещения** гэр байраа цэвэрлэх; **~ инструментов** багаж цэвэрлэх.

УБО́РНАЯ 1. тасалгаа, хувцаслах өрөө; **артистическая ~** жүжигчдийн хувцаслах өрөө; 2. жорлон, бие засах газар.

УБО́РОЧНЫЙ хураах, тариа хураах, тариа хураалгын.

УБО́РЩИК 1. тариа хураагч; 2. цэвэрлэгч.

УБО́РЩИЦА цэвэрлэгч, цэвэрлэгч эмэгтэй.

УБОЯ́ТЬСЯ айх сүрдэх, ширвээтэх; **~ бездны премудрости** гүн бэрх ухаанаас сүрдэх.

УБРА́НСТВО засал, чимэг засал, тохижил; **~ комнаты** өрөөний засал.

УБРА́ТЬ 1. хураах, хурааж авах, татаж авах; 2. цэвэрлэх, цэгцэлж засах, засах, засаж залах; **~ помещение** гэр байраа засаж залах; 3. чимэглэж засах, гоёх; **зал убран цветами** танхим цэцгээр засагджээ; 4. хийх, хадгалах; **~ книги в шкаф** шүүгээнд ном хийх.

УБРА́||ТЬСЯ 1. цэвэрлэж засах, засаж залах, өөд татах; **~лись во всех комнатах** өрөө тасалгаагаа цэвэрлэж засав; 2. тонилох, зайлах; **~ подобру-поздорову** эсэн мэнд дээрээ тонилох; **еле ~лся оттуда** тэндээс арай гэж зайлав.

УБЫВА́ТЬ 1. багасах, цөөрөх, хорох, хорогдох, татрах; 2. хасагдах, бүрэлдэхүүнээс гарах.

У́БЫЛЬ багасал, хорогдол, цөөрөлт, татрал, татралт; **на ~ идти** багасах, цөөрөх, хорогдох, буурах, татрах.

УБЫСТРИ́ТЬ хурдатгах, түргэсгэх; **~ шаг** алхаагаа хурдатгах.

УБЫ́ТОК гарз, гарлага, алдах, алдагдал, хохирол; **терпеть ~** гарз учрах; **продать с убытком** алдагдалтай зарах.

УБЫТО́ЧН||ЫЙ гарзтай, гарлагатай, алдагдалтай, хохиролтой; **~ая торговля** алдагдалтай худалдаа.

УБЫ́||ТЬ 1. багасах, цөөрөх, хорох, хорогдох, татрах; **силы ~ли** хүч багасав; **народу ~ло** хүн цөөрөв; 2. хасагдах, бүрэлдэхүүнээс гарах.

УВАЖА́ЕМЫЙ хүндэт, хүндтэй, эрхэм; **~ товарищ** эрхэм нөхөр; **он всеми ~ человек** тэр олонд хүндтэй хүн.

УВАЖА́ТЬ хүндлэх, хүндэтгэх, эрхэмлэх; **~ старших** ахмад настныг хүндлэх; **заставить себя ~** биеэ хүндлүүлэх.

УВАЖЕ́НИ||Е хүндлэх, хүндэтгэх, хүндэтгэл; **внушать ~** хүндэтгэл төрүүлэх; **из ~я к вам** таныг хүндэтгэж.

УВАЖИ́ТЕЛЬН||ЫЙ хүндтэй, ноцтой, чухал; **~ые причины** хүндтэй шалтгаан.

УВА́ЖИ||ТЬ 1. ёсоор гүйцэтгэх, хүндэтгэж гүйцэтгэх, чухалчилж биелүүлэх; **я ~л вашу просьбу** би таны гуйсан ёсоор гүйцэтгэв; 2. хүндэтгэх, хүндлэх; **~ родителей** эцэг эхээ хүндлэх.

УВА́Л гүвээ, дөрөлж.

У́ВАЛЕНЬ бовь хүн, бойдоо хүн, болхи хүн.

УВА́РИВАТЬСЯ 1. гүйцэд чанагдах, гүйцэд болох, шалзрах; 2. ширгэх, ширгэтэл чанагдах.

УВАРИ||ТЬСЯ 1. гүйцэд чанагдах, гүйцэд болох, шалзрах; **мясо ~лось** мах гүйцэд болжээ; 2. ширгэх, ширгэтэл чанагдах.

УВЕДОМИ́ТЕЛЬН||ЫЙ мэдэгдэх, мэдээ өгөх, дуулгах; **~ое письмо** мэдэгдэх захидал.

УВЕ́ДОМИТЬ мэдэгдэх, мэдээ өгөх; **~ о дне приезда** ирэх өдрөө мэдэгдэх.

УВЕДОМЛЯ́ТЬ мэдэгдэх, мэдээ өгөх; **~ о получении письма** захидал хүлээн авсныг мэдэгдэх.

УВЕДОМЛЕ́НИЕ 1. мэдэгдэх, мэдээ өгөх; 2. мэдэгдэх хуудас, мэдэгдэх бичиг; **получить по почте** шуудангаар мэдэгдэх бичиг авах.

УВЕЗТИ́ аваачих, авч явах; **~ детей в деревню** хүүхдүүдийг тосгонд аваачих; **~ свои книги** номоо авч явах.

УВЕКОВЕ́ЧЕНИЕ мөнхжүүлэх, мөнхлөх.

УВЕКОВЕ́ЧИВАТЬ мөнхжүүлэх, мөнхлөх, мөнх болгох.

УВЕКОВЕ́ЧИВАТЬСЯ мөнхжих, мөнхрөх, мөнх болох.

УВЕКОВЕ́ЧИТЬ мөнхжүүлэх, мөнхлөх, мөнх болгох; **~ память павших героев** амь үрэгдсэн баатруудын дурсгалыг мөнхжүүлэх.

УВЕКОВЕ́ЧИТЬСЯ мөнхжих, мөнхрөх, мөнх болох.

УВЕЛИЧЕ́НИЕ 1. ихсэх, ихэсгэх, томрох, нэмэгдэх; 2. ихэсгэх, томсгох, нэмэгдүүлэх; 3. нэмэгдэл, өсөлт; **~ численности населения** хүн амын тооны өсөлт.

УВЕЛИ́ЧИВАТЬ ихэсгэх, нэмэгдүүлэх, өсгөх, томруулах.

УВЕЛИ́ЧИВАТЬСЯ ихсэх, нэмэгдэх, өсөх, томрох.

УВЕЛИ́ЧИТЬ ихэсгэх, нэмэгдүүлэх, өсгөх, томруулах; **~ портрет** хөргийг томруулах.

УВЕЛИ́ЧИ||ТЬСЯ ихсэх, нэмэгдэх, өсөх, томрох; **территория парка ~лась вдвое** цэнгэлдэх хүрээлэнгийн дэвсгэр газар хоёр дахин нэмэгдэв.

УВЕЛИЧИ́ТЕЛЬН||ЫЙ өсгөх, томруулах, тодотгох, ихэсгэх; **~ое стекло** өсгөх шил; **~ суффикс** ихэсгэх дагавар; **~ая форма** ихэсгэх хэлбэр.

УВЕНЧА́||ТЬ 1. өргөх, чимэглэх, олгох; **~ премией лучшее сочинение** шилдэг зохиолд шагнал олгох; 2. сүндэрлүүлэх, урагштай төгсгөх, амжилттай гүйцэтгэх; **здание ~ли башней** цамхгаар байшинг сүндэрлүүлэв.

УВЕНЧА́||ТЬСЯ амжилттай төгсөх, урагштай дуусах, сайнаар төгсөх; **дело ~лось полным успехом** уг хэрэг бүрэн амжилттай төгсөв.

УВЕ́НЧИВАТЬ 1. өргөх, чимэглэх, олгох; **~ премией лучшее сочинение** шилдэг зохиолд шагнал олгох; 2. сүндэрлүүлэх, урагштай төгсгөх, амжилттай гүйцэтгэх.

УВЕ́НЧИВАТЬСЯ амжилттай төгсөх, урагштай дуусах, сайнаар төгсөх.

УВЕРЕ́НИЕ батлан өгүүлэх, батлан илэрхийлэх, илэрхийлэл; **примите ~ в моём совершенном уважении** миний гүн хүндэтгэлийн илэрхийллийг хүлээн авна уу.

УВЕ́РЕННОСТ||Ь лав итгэх, бат итгэх; **быть в полной ~и** гуйцэд бат итгэж байх.

УВЕ́РЕННЫЙ итгэлтэй, бат итгэлтэй, итгэх, лав итгэсэн; **~ шаг** итгэлтэй алхам; **в нём я вполне уверен** би түүнд нээрээ итгэж байна; **будьте уверены** битгий зовоорой, найдаж болно.

УВЕ́РИТЬ итгүүлэх, үнэмшүүлэх, баталж хэлэх; **~ в своей правоте** өөрийнхөө зөвийг итгүүлэх.

УВЕ́РИТЬСЯ итгэх, үнэмших, сэнхрэх; **~ в чьей-либо преданности** хүний үнэнч шударга байгаад итгэх.

УВЕРНУ́ТЬСЯ 1. мултрах, дальдрах, бултах, холбирох; **~ от удара** цохилтоос дальдрах; 2. зайлсхийх, цаарталах; **~ от прямого ответа** шууд хариулахаас зайлсхийх.

УВЕ́РОВАТЬ итгэх, үнэмших.

УВЁРТКА зайлсхийх, цаарталал, бултах, булзаарал; **говорить без увёрток** цаарталалгүй хэлэх.

УВЁРТЛИВЫЙ, зайламтгай, мултархай, холбирхой, цаарга; **~ парень** холбирхой залуу.

УВЁРТЫВАТЬСЯ 1. мултрах, дальдрах, бултах, холбирох; 2. зайлсхийх, цаарталах, булзах.

УВЕРТЮ́РА удиртгал хөгжим.

УВЕРЯ́||ТЬ итгүүлэх, үнэмшүүлэх, батлан хэлэх; **я ~ю тебя, что я прав** миний зөв гэдгийг чамд батлан хэлье.

УВЕРЯ́ТЬСЯ итгэх, үнэмших, сэнхрэх.
УВЕСЕЛЕ́НИЕ найр цэнгэл, цэнгэл, зугаа.
УВЕСЕЛИ́ТЕЛЬН||ЫЙ цэнгэлийн, цэнгэлт, цэнгэх; **~ая прогулка** цэнгэн зугаацаж явах.
УВЕСЕЛЯ́ТЬ цэнгүүлэх, цэнгэлдүүлэх, зугаацуулах, наргиулах.
УВЕ́СИСТЫЙ 1. жинтэй, нүсэр, лагс; **~ чемода́н** нүсэр чемодан; 2. хүчтэй, жинтэй; **~ уда́р** жинтэй цохилт.
УВЕСТИ́ 1. аваачих, аваад явчих; **~ детей домой** хүүхдүүдийг гэртээ аваачих; 2. хулгайлж аваачих, хулгай хийх; **~ лошадь** морь хулгайлж аваачих.
УВЕ́ЧИТЬ бэртээх, гэмтээх; **~ в драке** зодолдож бэртээх.
УВЕ́ЧИТЬСЯ бэртэх, гэмтэх.
УВЕ́ЧЬЕ бэртэх, бэртэнги, гэмтэл; **получить ~** бэртэнги олох.
УВЕ́ШАТЬ дүүрэн өлгөх, дүүрэн зүүх, дүүртэл зүүх; **~ стены карти́нами** хана дүүрэн зураг өлгөх.
УВЕ́ШИВАТЬ дүүрэн өлгөх, дүүрэн зүүх, дүүртэл зүүх.
УВЕЩА́НИЕ ятгах, сэнхрүүлэх.
УВЕЩА́ТЬ ятгах, сэнхрүүлэх, сургаж хэлэх.
УВЕЩЕВА́НИЕ ятгалга, сэнхрүүлэл, сургамж.
УВЕЩЕВА́ТЬ ятгах, сэнхрүүлэх, сургаж хэлэх.
УВИВА́ТЬ хэрэх, ороох, орооцолдуулах.
УВИВА́ТЬСЯ үлхээцэлдэх, хоргоох.
УВИДА́ТЬСЯ уулзах, учрах.
УВИ́ДЕ||ТЬ 1. харах, үзэх; **он его ~л издалека** тэр түүнийг холоос харав; 2. ойлгох, мэдэх, ойлгож мэдэх; **он ~л, что ошибся** тэр эндүүрснээ ойлгож мэдэв.
УВИ́ДЕТЬСЯ уулзах, учрах; **~ со знако́мыми** танилуудтайгаа уулзах.
УВИ́ЛИВАТЬ 1. дальдарч зайлах, бултах; 2. зайлсхийх, цаарга́лах.
УВИЛЬНУ́ТЬ 1. дальдарч зайлах, бултах; **~ от уда́ра** цохилтоос дальдарч зайлах; 2. зайлсхийх, цаарга́лах; **~ от отве́та** хариулахаас зайлсхийх.
УВИ́||ТЬ хэрэх, ороох, орооцолдуулах; **изгоро́дь ~та плющо́м** бургасан хашаа ороонго өвсөөр хэрэгджээ.
УВЛАЖНЕ́НИЕ чийгтүүлэх, чийг авахуулах, дэвтээх.
УВЛАЖНИ́||ТЬ чийглэх, чийг авахуулах, дэвтээх; **дождь ~л зе́млю** бороо газар дэвтээв.
УВЛАЖНИ́||ТЬСЯ чийгтэх, чийг авах, дэвтэх; **почва ~лась** хөрс чийгтэв.
УВЛАЖНЯ́ТЬСЯ чийгтэх, чийг авах, дэвтэх.
УВЛЕКА́ТЕЛЬНОСТЬ сонирхолтой зүйл, дур татах, ташуурам.
УВЛЕКА́ТЕЛЬНЫЙ сонирхолтой,дур татах, ташуурмаар; **~ расска́з** сонирхолтой яриа.
УВЛЕКА́ТЬ 1. аваачих, аваад явчих, дагуулаад явчих; 2. ташуурах, сониучирхах, сонирхон орох; 3. сонирхлыг татах, дурыг татах, дур булаах; 4. дурлах.
УВЛЕКА́ТЬСЯ 1. ташуурах, сонирхох, сонирхон орох; 2. дур татагдах, дур булаагдах, дурлах.
УВЛЕЧЕ́НИЕ 1. урам, бахдал, баяр бахдал; **с ~м рабо́тать** урамтай ажиллах; 2. их сонирхох; **~ футбо́лом** хөл бөмбөг их сонирхох; 3. сонирхох, дур татагдах, таалагдах; **~ перешло́ в про́чную привя́занность** сонирхож явсаар ижил дасал боллоо.
УВЛЕ́||ЧЬ 1. аваачих, аваад явчих, дагуулаад явчих; 2. ташуурах, сонирхох, сонирхон орох; **рабо́та ~кла его** тэр ажилдаа сонирхон оржээ; 3. сонирхлыг татах, дурыг татах, дур булаах; **~ зри́телей игро́й** тоглолтоороо үзэгчдийн дур татах; 4. дур татах; **~ де́вушку** бүсгүйн дур татах.
УВЛЕ́ЧЬСЯ 1. ташуурах, сонирхох, сонирхон орох; **~ люби́мой рабо́той** дуртай ажилдаа сонирхон орох; 2. дур татагдах, дур булаагдах, дурлах; **~ де́вушкой** бүсгүйд дур татагдах.
УВОДИ́ТЬ 1. аваачих, аваад явчих; 2. хулгайлж авах.
УВОЗИ́ТЬ аваачих, аваад явчих.
УВО́ЛИТЬ халах, огцруулах, чөлөөлөх, чөлөө олгох; **~ с рабо́ты** ажлаас халах; **~ в отпуск** амралтын чөлөө олгох.
УВО́ЛИТЬСЯ халагдах, огцрох, чөлөөлөгдөх, гарах; **~ с рабо́ты** ажлаас халагдах.
УВОЛО́||ЧЬ чирж аваачих, аваачих, аваад явчих; **волк ~к о́вцу в лес** чоно хонийг ой руу чирээд явчихав.
УВОЛЬНЕ́НИЕ халах, огцруулах, чөлөөлөх; **~ со слу́жбы** албанаас чөлөөлөх.
УВОЛЬНИ́ТЕЛЬНЫЙ халагдсан үнэмлэх, чөлөөний үнэмлэх.
УВОЛЬНЯ́ТЬ халах, огцруулах,. чөлөөлөх, чөлөө олгох.
УВОЛЬНЯ́ТЬСЯ халагдах, огцрох, чөлөөлөгдөх, гарах.
УВЫ́ халаг, ээ халаг, ээ тоогүй харин.
УВЯДА́НИЕ 1. хагдрал, гандал, хувхайрал, өлбийх; 2. хөгшрөл, буурал, доройтол, сульдал.
УВЯДА́||ТЬ 1. хагдрах, гандах, гулжийх, хувхайрах, зэвхийрэх; **цветы́ о́сенью ~ют** цэцэг намар гандана; 2. хөгшрөх, буурах, сульдах; **красота́ ~ет** үзэсгэлэн нь буурч байна.
УВЯ́ДШ||ИЙ 1. хагдарсан, гандсан, гулжийсан; **~ цвето́к** гандсан цэцэг; 2. хөгширсөн, буурсан, сульдсан; **~ая красота́** буурсан үзэсгэлэн.
УВЯЗА́ТЬ I 1. боох, баглах, хүлэх, уях; **~ вещи** юмаа баглах; 2. холбох, нийцүүлэх, зохицуулах; **~ теорию с практи́кой** онолыг туршлагатай холбох.
УВЯЗА́ТЬ II шигдэх, шаагдах, шавардах.
УВЯЗА́||ТЬСЯ I 1. хүлэгдэх, баглагдах; 2. юм хумаа боох; **~лись и пое́хали на ста́нцию** юм хумаа боож аваад өртөө рүү явав.
УВЯЗА́||ТЬСЯ II дагаж явах, салахгүй дагах; **за на́ми ~лся щено́к** бидний хойноос гөлөг дагав.
УВЯ́ЗКА 1. хүлэлт, баглалт, боолт; 2. нийцүүлэх, зохицуулах, тохируулах.
УВЯ́З||НУТЬ шигдэх, шавардах, шаагдах; **лошадь ~ла в снегу** морь хөр цасанд шигдэв.
УВЯ́ЗЫВАТЬ 1. боох, баглах, хүлэх; 2. нийцүүлэх, зохицуулах, тохируулах, уялдуулах.
УВЯ́ЗЫВАТЬСЯ 1. хүлэгдэх, баглагдах; 2. юм хумаа боох; 3. дагаж явах, салахгүй дагах.
УВЯ́НУТЬ 1. хагдрах, гандах, гулжийх, хувхайрах, зэвхийрэх; 2. хөгшрөх, буурах, сульдах.
УГАДА́ЙКА *разг.* ойлгомжгүй байдал.
УГАДА́||ТЬ таах, тааж мэдэх, тааварлах, тааварлаж мэдэх, төсөөлөх; **я ~л его́ наме́рения** би түүний саналыг таварлаж мэдэв.
УГА́ДЫВАТЬ таах, тааж мэдэх, тааварлах, тааварлаж мэдэх, төсөөлөх.
УГА́ДЧИК таагч, тааварлагч, тааж мэдэгч; **он плохо́й ~** тэр муу тааварлагч.
УГА́Р 1. хордуулах хий, нүүрсэн хий, бүгтрээх хий, угаар; **смерть от ~а** бүгтрээх хийд хордож үхэх; **в ко́мнате пахне́т ~ом** тасалгаанд угаар үнэртэж байна; 2. манан, ганирал; **любо́вный ~** янагийн манан.
УГА́РНЫЙ 1. хорт хийн, нүүрсэн хийтэй; **~ воздух** нүүрсэн хийтэй агаар; 2. *разг.* дээд зэргийн, маш гоё.
УГАСА́НИЕ 1. унтрах, бөхөх; 2. доройтох.
УГАСА́||ТЬ 1. унтрах, бөхөх; 2. доройтох; **си́лы ~ют** тамир доройтож байна.
УГА́СНУТЬ 1. унтрах, бөхөх; **костёр угас** түүдэг гал унтрав; 2. доройтох.
УГЛЕВО́Д нүүрс ус.
УГЛЕВО́ДНЫЙ ~ обме́н нүүрс усны солилцол.

УГЛЕВОДОРО́Д нүүрс ус төрөгч *(нүүрс төрөгч, ус төрөгч хоёрын нийлмэл).*

УГЛЕВО́З нүүрсний хөсөг, нүүрс зөөх хөсөг.

УГЛЕДОБЫ́Ч||А нүүрс малтлага, нүүрс гаргалт; **повышение ~и** нүүрс гаргалтыг нэмэгдүүлэх.

УГЛЕДРОБИ́ЛЬНЫЙ нүүрс хэмхчих, чулуун нүүрс бутлах.

УГЛЕЖЖЕ́НИЕ модны нүүрс хийх, мод шатааж нүүрс бэлтгэх.

УГЛЕКИСЛОТА́ нүүрс хүчил, нүүрсний хүчил, нүүрс хүчлийн хий.

УГЛЕКИ́СЛ||ЫЙ нүүрс хүчлийн; **~ое соединение** нүүрс хүчлийн нэгдэл; **~ые воды** нүүрс хүчлийн ус; **~ газ** нүүрс хүчлийн хий.

УГЛЕКО́П нүүрс малтагч, нүүрсчин.

УГЛЕПРОМЫ́ШЛЕННОСТЬ нүүрсний үйлдвэр.

УГЛЕПРОМЫ́ШЛЕННЫЙ нүүрсний үйлдвэрийн, нүүрсний уурхайн.

УГЛЕРО́Д нүүрс төрөгч.

УГЛОВА́Т||ЫЙ 1. өнцөглөг, өнцгүүдтэй, өнцөг булантай; **~ое лицо** өнцөглөг нүүр; 2. болхи, дүйгүй; **~ое движение** болхи хөдөлгөөн.

УГЛОВ||О́Й өнцгийн, өнцөгтэй, өнцөг булангийн; **~ дом** өнцгийн байшин; **~ое измерение** өнцөг хэмжих.

УГЛОМЕ́Р өнцөг хэмжүүр, өнцөгт хэмжүүр.

УГЛОМЕ́РН||ЫЙ өнцөг хэмжих, өнцөгт хэмжүүрийн; **~ые инструменты** өнцөгт хэмжүүрийн багаж.

УГЛУБИ́ТЬ 1. гүнзгий болгох, гүнзгийрүүлэх, хонхойлгох; **~ свои знания** мэдлэгээ гүнзгийрүүлэх; 2. гүнзгий хийх, гүнзгий оруулах; **~ сваи ещё на метр** тулцыг бас нэг метр гүнзгий шаах.

УГЛУБЙ||ТЬСЯ 1. гүнзгий болох, гүн болох, гүнзгийрэх, хонхойх; **дно ~лось** ёроол нь гүнзгий болов; **противоречия ~лись** зөрчил гүнзгийрэв; 2. гүнзгий орох, гүн орох; **~ в лес** ойн гүнд орох; 3. бодоод л байх, санаашрах; **~ в воспоминания** дурсамждаа автах; **~ в себя** дотроо санаашрах.

УГЛУБЛЕ́НИЕ 1. гүнзгийрэх, гүнзгий болох; 2. гүнзгийрүүлэх, гүнзгий болгох; **~ дна реки** голын ёроолыг гүнзгийрүүлэх; 3. гүнзгийрэл; 4. хонхор, хотгор; **~ в земле** газрын хонхор.

УГЛУБЛЁНН||ЫЙ 1. гүнзгий, гүн; **~ое изучение литературы** утга зохиолыг гүнзгий судлах; 2. бодлого болсон, санааширсан; **~ в себя** дотроо санааширсан.

УГЛУБЛЯ́ТЬ 1. гүнзгий болгох, гүн болгох, гүнзгийлэх, хонхойлгох; 2. гүнзгий оруулах, гүнзгий хийх.

УГЛУБЛЯ́ТЬСЯ 1. гүнзгий болох, гүн болох, гүнзгийрэх; 2. гүнзгий орох, гүн орох; 3. бодоод л байх, санаашрах.

УГЛЯДЕ́||ТЬ 1. харах, олж харах, ажих; **~л приятную девушку среди студентов мединститута** АУДС-ийн оюутан эмэгтэйчүүдийн дундаас нүдэнд дулаахан охиныг олж харав.

УГНА́ТЬ 1. туух, тууж аваачих, тууж гаргах; **~ стадо в поле** малаа хөдөө тууж гаргах; 2. хөөх, хөөж аваачих, хөөгөөд явчих, хулгайлах; **~ лошадь** морь хулгайлах.

УГНА́ТЬСЯ 1. гүйцэх, хөөж гүйцэх; **за хорошим бегуном не ~** хурдан гүйгчийг хөөж гүйцэхгүй; 2. гүйцэх, зэрэгцэх; **в учёбе за ним не ~** сурлагаар түүнийг гүйцэх бэрх.

УГНЕЗДИ́ТЬСЯ хавчуулж суух, хавчуулж амьдрах, завсарт, үүрлэх, үүрлэж байх.

УГНЕТА́ЕМЫЙ дарлагдагч, дарлагдсан хүн.

УГНЕТА́ТЕЛЬ дарлагч.

УГНЕТА́ТЕЛЬСКИЙ дарлагчдын, дарлалтын, дарлах.

УГНЕТА́||ТЬ 1. дарлах; 2. зовоох, сэтгэл зовоох; **его ~ли мрачные мысли** олхиогүй юм санагдаж сэтгэлийг нь зовоодог байв.

УГНЕТА́ТЬСЯ дарлагдах.

УГНЕТЕ́НИ||Е 1. дарлал, дарлах; 2. сэтгэл зовох, зовиур; **быть в ~и** зовиуртай байх.

УГНЕТЁННОСТЬ дарлагдал, зовиур.

УГНЕТЁНН||ЫЙ 1. дарлагдагч, дарлагдсан; 2. сэтгэл зовсон, зовиуртай, гутарсан; **~ое состояние** гутранги байдал.

УГОВА́РИВАТЬ 1. ятгах, ойлгуулах, панаалдах; 2. *разг.* их хэмжээний архи уух, **уговорить бутылку** шилтэй юмыг дуустал уух.

УГОВО́Р 1. үгэнд орох, үгэндээ оруулах, ятгах; **он не поддаётся никаким ~ам** тэр яагаад ч үгэнд орохгүй байна; 2. хэлэлцээ, хэлэлцэж тохирох,болзоо, болзож тохирох; **~ дороже денег** хэлэлцээ бол мөнгөнөөс эрхэм.

УГОВОРИ́ТЬ үгэндээ оруулах, ятгах, ойлгуулах.

УГОВОРЙ||ТЬСЯ хэлэлцэх, хэлэлцэж тохирох, болзох; **мы ~лись вместе ехать** бид хамт явахаар болзов.

УГО́Д||А **в ~у кому-либо** санаанд нь тааруулж, тааруулж, саймсарч.

УГОДЙ||ТЬ 1. сэтгэлд тааруулах, тааруулах, санаанд нийлүүлэх, аялдуулах; **всем не ~шь** бүгдэд тааруулж чадахгүй; 2. орох, ойчих; **лиса ~ла в капкан** үнэг хавханд оров; 3. тусах, онох, мөргөх; **~ камнем в окно** чулуугаар цонх онох; **пуля ~ла ему в плечо** сум мөрөнд нь тусжээ.

УГО́ДЛИВОСТЬ саймсрал, зусар, зулгуй.

УГО́ДЛИВ||ЫЙ саймсрах, зусарч, зулгуй, долигонуур; **~ая улыбка** саймсарч инээмсэглэх; **~ человек** зусарч хүн.

УГО́ДНИК 1. саймсрагч, долигоногч; **дамский ~** хүүхэнд саймсрагч, панаал эр; 3. ивээлт, хутагт.

УГО́ДНИЧАТЬ саймсрах, зусардах; **~ перед сильным** хүчтэний өмнө зусардах.

УГО́ДНИЧЕСТВО саймсрах, зусардах, бялдуучлах; **низкопоклонство и ~** мэхэлээн бялдуучлах.

УГО́ДНО 1. хэрэгтэй; **что вам ~?** танд юу хэрэгтэй вэ? **если вам ~** танд хэрэгтэй бол; **не ~ ли?** хэрэгтэй биш байгаа? 2. ч гэсэн, боловч, хамаагүй, өөрцгүй, бишгүй; **кто ~** хэн ч гэсэн, хэн боловч; **как ~** яагаад ч гэсэн; **какой ~** ямар ч хамаагүй, ямар боловч; **где ~** хаа ч гэсэн, хаана ч хамаагүй; **куда ~** хаашаа ч гэсэн, хаашаа ч хамаагүй; **откуда ~** хаанаас ч гэсэн, хаанаас боловч; **сколько ~** хэдийг ч гэсэн, хэдийг л бол хэдийг, бишгүй; **сколько душе ~** хэдий дуртай бол тэдий, хэдий ч гэсэн хамаагүй.

УГО́ДНЫЙ нийлэмжтэй, таарамжтай, тааламжтай, тохиромжтой.

УГО́ДЬ||Е 1. эдэлбэр, эдлэн газар; **лесные ~я** ой модны эдэлбэр; **земельные ~я** газар эдэлбэр; 2. ашигтай юм, ашигтай газар; **пьян да умён — два ~я в нём** архины согтуу ухаантай, ашигтай юмыг андахгүй.

УГОЖДА́ТЬ 1. сэтгэлд тааруулах, тааруулах, санаанд нийлүүлэх, аялдуулах; 2. орох, ойчих; 3. тусах, онох, мөргөх.

У́ГОЛ 1. өнцөг; **прямой ~** тэгш өнцөг; **тупой ~** мохоо өнцөг; **острый ~** шовх өнцөг; **вертикальный ~** босоо өнцөг; **горизонтальный ~** хэвтээ өнцөг; **~ наклона** налуугийн өнцөг; **вершина угла** өнцгийн орой; **~ отражения** тусгалын өнцөг; **~ падения** ynалтын өнцөг; 2. өнцөг, булан; **~ зрения** харааны өнцөг; **~ века** зовхины булан; **на углу улицы** гудамжны өнцөгт; **~ преломления** хугарлын өнцөг; **рёберный ~** хавирганы өнцөг; **челюстный ~** эрүүний өнцөг; 3. булан; **снимать ~** хажуу? хөлсөлж суух; **красный ~** улаан булан; 4. орох орон, орон гэр, хоргодох газар; **жить в своём углу**

орон гэртээ суух; **иметь свой** ~ орох оронтой байх; ~ **рта завьж**; **из-за угла сделать что-нибудь** сэмхэн далдуур юм хийх; **ходить из угла в** ~ гэр дотуур сэлгүүцэж явах; **медвежий** ~ бөглүү нутаг.

УГОЛЁК 1. хэсэг нүүрс, нүүрсний хэлтэрхий; 2. *разг.* негр хүн.

УГОЛО́ВНИК эрүүгийн хэрэгтэн, ялтан.

УГОЛО́ВН||ЫЙ эрүүгийн; ~ **кодекс** эрүүгийн хууль; ~**ое преступление** эрүүгийн хэрэг; ~**ые преступники** эрүүгийн хэрэгтэн, ялтан.

УГОЛО́ВЩИН||А эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэг өдүүлэх, ялт хэрэг; **борьба с** ~**ой** эрүүгийн хэрэг өдүүлэх явдалтай тэмцэх.

УГОЛО́К өнцөг, булан, өнцөг булан; **во всех уголках страны** тус орны өнцөг булан бүрт.

У́ГОЛЬ 1. нүүрс; **каменный** ~ чулуун нүүрс; **древесный** ~ модны нүүрс; **бурый** ~ хүрэн нүүрс; 2. нүүрс, цог; **выгрести угли из печи** зуухнаас нүүрс малтаж авах; **горящие угли** цог; * **белый** ~ цагаан нүүрс, усны хүч; **как на** ~**ках сидеть** цог дээр суусан юм шиг байх, байж ядах.

УГО́ЛЬНИК өнцөгт шугам, өнцөг хэмжих шугам, гурвалжин шугам.

У́ГОЛЬН||ЫЙ нүүрсний; ~**ая шахта** нүүрсний уурхай; ~**ая промышленность** нүүрсний үйлдвэр; ~**ая кислота** нүүрсний хүчил.

УГО́ЛЬНЫЙ өнцгийн, булангийн; ~ **дом** өнцгийн байшин.

У́ГОЛЬЩИК нүүрсний ажилчин.

УГОМОНИ́ТЬ шуугихыг болиулах, чимээгүй болгох; ~ **детей** хүүхдийн шуугихыг болиулах.

УГОМОНИ́||ТЬСЯ чимээгүй болох, шуугихаа болих; **дети** ~**лись** хүүхэд шуугихаа болилоо.

УГО́Н 1. аваачих, тууж аваачих, тууж гаргах; ~ **скота в поле** мал тууж бэлчээрт гаргах; 2. гулзайх; ~ **пути** зам шугам төмөр гулзайх; 3. хулгайлах; ~ **машины** машиныг хулгайлах.

УГОНЯ́ТЬ аваачих, тууж аваачих, тууж гаргах, хөөж аваачих.

УГОРА́ЗДИ||ТЬ тулгах, баалах; **и** ~**ло же его уехать** түүнийг тулгаж байгаад явуулсан юм шүү; **чёрт** *(леший)* ~л ад адлажээ, ад шүглэсэн.

УГОРА́ТЬ I нүүрсний хийд бүгтрэх, угаарт хордох.

УГОРА́ТЬ II шатаж хорогдох.

УГОРЕ́ТЬ I нүүрсний хийд бүгтрэх, угаарт хордох.

УГОРЕ́ТЬ II шатаж хорогдох.

УГОРЕ́ЛЫЙ нүүрсний хийд хордсон, нүүрсний угаарт бүгтэрсэн; **он мечется, как** ~ дон шүглэсэн юм шиг сандарч явна; хулжсан адуу аятай.

У́ГОРЬ I могой загас.

У́ГОРЬ II батга; **лицо в угрях** батгатай нүүр.

УГОСТИ́ТЬ дайлах, зочлох, хүндлэх, амсуулах; ~ **обедом** үдийн хоолоор дайлах.

УГОСТИ́ТЬСЯ ханатал ууж идэх, цадтал идэх, зөндөө идэх.

УГОЩА́ТЬ дайлах, зочлох, хүндлэх, амсуулах.

УГОЩА́ТЬСЯ ханатал ууж идэх, цадтал идэх, зөндөө идэх.

УГОЩЕ́НИЕ 1. дайлах, дайллага, зочлох, зочлол, хүндлэх, хүндлэл, зоог барих; 2. идээ, зоог; **обильное** ~ элбэг идээ.

УГРЕВА́Т||ЫЙ батгатай, батга дүүрсэн; ~**ое лицо** батга дүүрсэн нүүр.

УГРО́БИТЬ баллах, бусниулах, нураах, сүйтгэх; ~ **дело** хэрэг нураах.

УГРОЖА́||ТЬ занах, занал учрах, аюул учрах, сүрдүүлэх; ~ **наказанием** шийтгэнэ гэж занах; **ему** ~**ет опасность** түүнд аюул учрах гэж байна.

УГРОЖА́ЮЩ||ИЙ заналтай, аюултай, сүрдүүлэх; ~**ее положение** аюултай байдал.

УГРО́З||А 1. занал; **пустые** ~**ы** хоосон занал; 2. аюул, аюулт занал; **быть под** ~**ой** аюул дор байх.

УГРО́ЗЫСК *(уголовный розыск)* эрүүгийн хэрэг мөрдөх газар, мөрдөн байцаах газар.

УГРЫЗЕ́НИ||Е гэмших, гутрах; ~**я совести** дотроо гэмших.

УГРЮ́МЫЙ дүнсгэр, уруу царайтай, гонсгор, барайсан; ~ **лес** барайсан ой.

УДА́В аварга могой.

УДАВА́ТЬСЯ бүтэх, амжилттай өнгөрөх, чадах.

УДАВИ́ТЬ боож алах, боомилох, багалзуурдаж алах.

УДАВИ́ТЬСЯ боож үхэх.

УДА́ВКА *разг.* зангиа, ороолт, хүзүүний гинж.

УДА́ВЛЕННИК боож үхсэн хүн, боомилогдсон хүн.

УДАЛЕ́НИЕ 1. холдох, холдуулах; ~ **от города** хотоос холдох, хотоос холдуулах; 2. гаргах, зайлуулах; 3. арилгах, цэвэрлэх; ~ **влагалища** үтрээг авах; ~ **дефекта** согог арилгах; ~ **инородных тел из глотки** залгиураас гадны юм авах; ~ **инородных тел из пищевода** улаан хоолойд орсон юм авах; ~ **кисты** бундуу авах; ~ **нерва** мэдрэлийн судас авах; ~ **отрывков тканей** эдийн цэвдэл арилгах; ~ **остеохондромы** мөгөөрс ясны хавдрыг авах; ~ **повреждения** гэмтэл арилгах; ~ **рака** өмөн үү авах; ~ **саркомы** холбогч эдийн хорт хавдар авах; ~ **фиброза** ширхэнгэнцэрт эдийн хавдар авах; ~ **экссудата** шүүрдсийг авах.

УДАЛИ́ТЬ 1. холдуулах, хөндийрүүлэх; ~ **предмет от себя** юмыг өөрөөсөө холдуулах; 2. гаргах, зайлуулах; 3. авах, авахуулах; ~ **зуб** шүд авахуулах; 4. арилгах, цэвэрлэх; ~ **пятна** хир толбо арилгах.

УДАЛИ́ТЬСЯ 1. холдох, хөндийрөх, цаашлах; ~ **от дома** гэрээс холдох; 2. очих, орох, зайлж орох; ~ **к себе в комнату** өөрийнхөө тасалгаанд орох.

УДАЛО́Й эрэмгий, идэрхэг; ~ **молодец** эрэмгий сайн эр.

УДА́ЛЫЙ эрэмгий, идэрхэг.

У́ДАЛЬ эрэмгий, эрэмгий зориг, идэрхэг, идэрхэг явдал.

У́ДАЛЬСТВ||О эрэмгий, эрэмгий зориг, идэрхэг, идэрхэг явдал; **сделать что-нибудь из** ~**а** юмыг эрэмгий зориг гаргаж хийх.

УДАЛЯ́ТЬ 1. холдуулах, хөндийрүүлэх; 2. гаргах, зайлуулах; 3. авах, авахуулах; 4. арилгах, цэвэрлэх.

УДАЛЯ́ТЬСЯ 1. холдох, зайлах, хөндийрөх, цаашлах; 2. очих, орох, зайлж орох.

УДА́Р 1. цохилт, цохих, шаах; **свалить врага** ~**ом** дайсныг цохиж унагах; ~ **кулаком** гараа зангидаж шаах; ~ **боковой** хажуугийн цохилт; ~ **центральный** гол цохилт; 2. цохих, нир хийх; ~ **колокола** хонх цохих; ~ **грома** тэнгэр нир хийх; 3. дайралт, дайрах, цохилт, цохих; **сокрушительный** ~ бут цохих; 4. гай, хохирол; **испытать** ~ **судьбы** төөргийн гайд учрах; 5. цохигдох, тархинд цус харвах, саа өвчин; **солнечный** ~ наранд цохиулах, нарших; **тепловой** ~ халуудах; **он сегодня в** ~**е** тэр өнөөдөр овоо байна, тэр өнөөдөр золбоотой байна; **под** ~**ом** цохигдох аюултай.

УДАРЕ́НИЕ 1. өргөлт; ~ **падает на последний слог** өргөлт нь сүүлийн үе дээр оногдоно; 2. өргөлт, өргөлтийн тэмдэг; **поставить** ~ **над «а»** а үсэг дээр өргөлтийн тэмдэг тавих.

УДА́РИ||ТЬ 1. цохих, шаах; ~ **палкой** саваагаар цохих; ~ **кулаком** нударгаар шаах; 2. цохих, дэлдэх, цохиж мэдээлэх; ~ **в барабан** хэнгэрэг цохих, бөмбөр дэлдэх; ~ **в колокол** хонх цохих; **часы** ~**ли полночь** цаг цохиж шөнө дунд болсныг мэдээлэв; 3. буух, ниргэх; **молния** ~**ла в дерево** аянга мод руу буув; 4. цохих, дайрах, довтлох; ~ **по врагу** дайсныг дарах; 5. тас цохих, устгах; 6. гэнэт болох, болох; ~**ли морозы** гэнэт хүйтэн болов; **не** ~ **в грязь лицом** нэрээ хугалахгүй; **палец о**

палец не ~л хуруугаа ч хөдөлгөсөнгүй, юу ч хийсэнгүй; **~ ногой** өшиглөх; **~ ниже пояса, ниже пейджера** шударга биш цохилт.

УДА́РИ||ТЬСЯ 1. цохих, биеэ цохих, цохигдох, мөргөх; **~ о камень** чулуунд биеэ цохих; **~ головой** толгойгоороо мөргөх; 2. тусах; **мяч ~лся в стену** бөмбөг туурганд тусав; 3. эхлэх, гарах; **~ бежать** зугтааж гарах; **~ в крайность** хэтэрч эхлэх.

УДА́РНИК I гавшгай ажилчин, гавшгайч, ударник.

УДА́РНИК II цохиур, цохилуур.

УДА́РНИЦА гавшгайч эмэгтэй.

УДА́РНИЧЕСТВО гавшгайлал, гавшгайч ажиллах.

УДА́РНО гавшгай; **~ работать** гавшгай ажиллах.

УДА́РН||ЫЙ гавшгай; **у~ая бригада** гавшгай бригад; 2. яаралтай, чухал, яаралтай чухал; **у~ое задание** яаралтай даалгавар; 3. цохивор, цохих, цохилтын; **~ музыкальный инструмент** цохивор хөгжмийн зэмсэг; **~ая волна** цохих долгион.

УДАРЯ́ЕМЫЙ өргөлтөт, өргөлттэй.

ЧА́СТН||ЫЙ 1. заримдаг, салангад, тухайн; **~ случай** заримдаг тохиолдол; **~ вывод** салангад дүгнэлт; 2. тусгай, салангад; **~ая хирургия** тусгай мэс засал; 3. хувийн, амины, өөрийн; **по ~ому делу** амины хэргээр; энгийн; **~ почин** хувийн санаачилга; 4. хувийн, амираа хийх; **~ые уроки** хувийн хичээл; хөлсний хичээл; **~ым образом** хувираа; **~ое лицо** хувийн хүн, энгийн хүн; 5. хувийн, энгийн, өмчийн; **~ капитал** хувийн капитал; **~ая собственность** хувийн өмч, өмчийн хөрөнгө; **~ая торговля** энгийн худалдаа; 6. ангилсан; **~ая патология** ангилсан эмгэг судлал.

ЧА́СТО 1. олонтоо, байн байн, үргэлж; 2. түргэн түргэн, хурдан хурдан; 3. шигүү, ойр ойр; **деревья посажены ~** мод шигүү суулгажээ.

ЧАСТОКО́Л шивээ.

ЧАСТОТА́ үелзэл, давтамж; **~ пульса** судасны лугшилтын давтамж

ЧАСТО́ТНЫЙ үелзлийн.

ЧАСТУ́ШКА явган дуу.

ЧА́СТ||ЫЙ 1. олонтоо болдог, байн байн ирдэг, үргэлж тохиолддог; **~ гость** байн байн ирдэг зочин; **~ые встречи** олонтоо уулзах; 2. түргэн (*болдог*), хурдан хурдан (*болдог);* **~ое дыхание** түргэн түргэн амьсгалах; **~ пульс** судас хурдан хурдан цохилох; 3. шигүү, нягт; **~ лес** шигүү ой.

ЧАСТ||Ь 1. хувь, хэсэг; **большая ~** ихэнх хэсэг, олонхи; **резать на ~и** хэсэг хэсэг болгох; 2. мөч, эрхтэн; **~и тела** биеийн хэсэг; 3. тив; **~и света** дэлхийн тэвүүд; 4. бүрэлдэх хэсэг, анги; **~и машины** машины бүрэлдэх хэсгүүд; **запасные ~и** сэлбэг анги; 5. бүлэг, анги; **роман в трёх ~ях** гурван ангит роман; 6. анги, хэлтэс, салбар; **учебная ~** хичээл анги; **хозяйственная ~** аж ахуйн анги, аж ахуйн хэлтэс; 7. цэргийн анги; **воинская ~** цэргийн анги; **~ речи** үгсийн аймаг; **большей ~ью, по большей ~и** олонхидоо, гол төлөв; **по ~и чего-либо** юмны талаар; **это не по моей ~и** энэ миний эрхлэх хэрэг биш; **рвут на ~и** булаацалдан авна.

ЧА́СТЬЮ зарим хэсэг.

ЧАСЫ́ цаг; **карманные ~** энгэрийн цаг; **стенные ~** ханын цаг; **завести ~** цаг түлхэх.

ЧА́ХЛЫЙ 1. ганданги, наршинги, хатсан, тачир; ~ **куст** тачир бут; 2. хатангир, туранхай, үлбэгэр.

ЧА́ХНУТЬ 1. гандах, нарших, хатах; 2. хатангирах, турах, үлбийх.

ЧАХО́ТКА уушигны өвчин, уушигны сүрьеэ.

ЧАХО́ТОЧНЫЙ 1. уушигны өвчтөн, уушигны сүрьеэтэй хүн.

ЧА́Ш||А цар, хул, тагш; **дом — полная** ~элбэг баян гэр; **испить** ~**у до дна** хал үзэж, халуун чулуу долоох; ~ **терпения переполнилась** тэсэхүйеэ бэрх болов.

ЧА́ШЕЧКА 1. бяцхан аяга; 2. цоморлиг; 3. ~ **коленная** тойг.

ЧА́ШКА 1. аяга, тагш; **фарфоровая** ~ шаазан аяга, шаазан; 2. (*жигнүүрийн*) таваг; 3. тойг.

ЧА́ЩА шугуй, ширэнгэ, шивэр (*мод*).

ЧА́ЩЕ олонтоо, түргэн; **как можно** ~ аль болохуйц олонтоо.

ЧА́ЯНИ||Е хүслэн, хүсэл, горьдлого; **сверх всякого** ~, **паче** ~**я** гэнэт, санамсаргүй байтал, хүсч хүлээгээгүй байтал.

ЧА́ЯТЬ хүсэх, хүсч хүлээх, горьдох; **души не** ~ **в ком-либо** ухаангүй хайртай байх.

ЧВА́НИТЬСЯ бардамлах, бардах, сайрхах, ихэрхэх.

ЧВАНЛИ́ВОСТЬ бардам зан, ихэрхэг зан.

ЧВАНЛИ́ВЫЙ бардам, бардан, сайрхаг, ихэрхэг, хөөргөн; ~ **характер** бардам зан.

ЧВА́НСТВО бардам зан, ихэрхэг зан, сайрхал.

ЧЕГО́ юунд, яагаад, юу гэж; ~ **ты так долго ездил?** яагаад чи ийм удаан явав?

ЧЕГО́-ТО 1. жаахан, нэг л; 2. яагаад ч юм, яасан ч юм (*бүү мэд*).

ЧЕЙ 1. хэний, юуны; **чья это тетрадь?** энэ хэний дэвтэр вэ?; 2. нь (*үгчлэн орчуулахгүй*).

ЧЕК 1. чек; **получить деньги по** ~**у** чекээр мөнгө авах; **выписать** ~ чек бичих; 2. толоон.

ЧЕКА́ чагт, чих.

ЧЕКА́Н 1. хэвээр цохих, цутгах; 2. хэв; 3. цохиур.

ЧЕКА́НИТЬ 1. хэвээр цохих, цутгах; ~ **монету** зоос цутгах; 2. хээ цохих, хээ гаргах, цохих; 3. тэв тэв алхах, тод хэлэх; ~ **шаг** тэв тэв алхах; ~ **слова** үг тод хэлэх.

ЧЕКА́НКА 1. хэвээр цохих, цутгах; 2. хээ цохих, хээ гаргах, цохих.

ЧЕКА́НН||ЫЙ 1. хэвээр цохисон, цутгасан; ~**ая работа** хэвээр цохисон юм; 2. тод сайхан, ягштал боловсруулсан; ~ **стиль** тод сайхан найруулга.

ЧЕКА́НЩИК хэвээр цохигч, цутгагч.

ЧЕКИ́СТ (*Зөвлөлтийн*) онц комиссийн ажилтан, аюулаас хамгаалах газрын ажилтан, чекист.

ЧЕ́КОВ||ЫЙ чекийн; ~**ая книжка** чекийн дэвтэр.

ЧЁЛКА хөхөл, (*хуухдийн*) эвэр.

ЧЁЛН завь, онгоц.

ЧЕЛНО́К I бяцхан завь, онгоц.

ЧЕЛНО́К II (*эвхээс утасны*) онгоц, шорноок.

ЧЕЛО́ магнай; **бить** ~**м кому-либо** мөргөн гуйх, хичээнгүйлэн гуйх.

ЧЕЛОБИ́ТНАЯ өргөдөл бичиг, өргөдөл.

ЧЕЛОБИ́ТЧИК өргөдөл өргөгч.

ЧЕЛОВЕ́К хүн; **честный** ~ шударга хүн; **пять** ~ таван хүн.

ЧЕЛОВЕКОЛЮБИ́ВЫЙ хүнлэг, энэрэнгүй.

ЧЕЛОВЕКОЛЮ́БИЕ хүнлэг ёс, энэрэнгүй сэтгэл, нинжийн сэтгэл.

ЧЕЛОВЕКОНЕНАВИ́СТНИК хүнийг үзэн ядагч.

ЧЕЛОВЕКОНЕНАВИ́СТНИЧЕСКИЙ хүнийг үзэн ядах.

ЧЕЛОВЕКОНЕНАВИ́СТНИЧЕСТВО хүнийг үзэн ядах (*явдал*).

ЧЕЛОВЕКООБРА́ЗН||ЫЙ хүн дүрст, хүн шиг, хүнэрхүү; ~**ая обезьяна** хүн дүрст сармагчин.

ЧЕЛОВЕ́ЧЕСКИ хүний ёсоор, хүн шиг; **по** ~ хүний ёсоор.

ЧЕЛОВЕ́ЧЕСК||ИЙ 1. хүний, хүн; ~ **род** хүн төрөлхтөн; 2. энэрэнгүй, хүнлэг, хүн шиг; ~**ое обращение** энэрэнгүй хандах, хүн шиг байх.

ЧЕЛОВЕ́ЧЕСТВО хүн төрөлхтөн.

ЧЕЛОВЕ́ЧИЙ хүний.

ЧЕЛОВЕ́ЧНОСТ||Ь хүний ёс, энэрэнгүй сэтгэл, хүний үнэр; **в нём нет ни капли** ~**и** хүний үнэр ч үгүй хүн.

ЧЕЛОВЕ́ЧН||ЫЙ хүний ёсны, энэрэнгүй, хүний үнэртэй; ~**ое отношение к людям** хүнтэй хүний ёсоор харьцах.

ЧЕЛЮСТНО́Й эрүүний.

ЧЕ́ЛЮСТЬ эрүү; **верхняя** ~ дээд эрүү; **нижняя** ~ доод эрүү, эрүү.

ЧЕ́ЛЯДЬ зарц нар, барлагууд.

ЧЕМ 1. -аас (*-ээс,-оос,-өөс*), орвол; **лучше поздно,** ~ **никогда** ор үгүй байснаас оройтсон нь дээр; 2. -аас (*-ээс,-оос,-өөс*), -аар (*-ээр,-оор, -өөр*)-ын оронд; ~ **торопиться, выйдем лучше раньше** яарч явахын оронд эртхэн гарсан дээр; 3. л бол, тутмаа; ~ **больше, тем лучше** их тутмаа бүр сайн.

ЧЕМЕРИ́ЦА агширгана.

ЧЕМОДА́Н чемодан, хайрцаг, авдар.

ЧЕМПИО́Н аварга, тэргүүлсэн хүн.

ЧЕМПИОНА́Т аварга шалгаруулах тэмцээн; **шахматный** ~ аварга шатарчин шалгаруулах тэмцээн.

ЧЕПЕ́Ц оройвч.

ЧЕПРА́К гөлөм, хэжим, зоо, духны арьс; **ковровый** ~ хивсэн гөлөм.

ЧЕПУХ||А́ 1. дэмий юм, чалчаа үг, хоосон яриа; **нести** ~**у** дэмий юм өгүүлэх, чалчих, айварлах; 2. дэмий, юу ч биш, дэмий юм, ялихгүй юм.

ЧЕ́ПЧИК бяцхан оройвч.

ЧЕ́РВА зөгийн авгалдай.

ЧЕРВООБРА́ЗНЫЙ хорхой хэлбэрт, өт хэлбэрт, хорхойрхуу.

ЧЕ́РВИ бундан, буймин.

ЧЕРВИ́ВЕ||ТЬ өтөх, хорхойтох, өттэй болох; **яблоки** ~**ют** алим өтнө.

ЧЕРВИ́В||ЫЙ өттэй, хорхойтой, өтсөн, хорхойтсон, өт идсэн; ~**ое мясо** өттэй мах.

ЧЕРВО́НЕЦ 1. (*тавт, аравтын*) алтан зоос; 2. аравт, аравтын дэвсгэр.

ЧЕРВО́НН||ЫЙ I улаан; ~**ое золото** шижир алт.

ЧЕРВО́ННЫЙ II, бундангийн, буймингийн.

ЧЕРВОТО́ЧИНА хорхой идсэн газар, хорхой идсэн нүх.

ЧЕ́РВ||Ы бундан, буймин; **ходить с** ~**ей** бундангаар явах.

ЧЕРВЬ 1. өт, хорхой; **земляной** ~ чийгийн хорхой; 2. санааны зовлон, санаашрах; ~ **сомнения** сэжиглэн санаашрах.

ЧЕРВЯ́К I өт, хорхой.

ЧЕРВЯ́К II хорхой шураг.

ЧЕРВЯ́ЧН||ЫЙ хорхой; ~**ая шестерня** хорхой араа.

ЧЕРВЯЧ||О́К бяцхан хорхой; **заморить** ~**а** хорхой дарах.

ЧЕРДА́К дээврийн хөндий, дээврийн хөндий дэх тасалгаа.

ЧЕРДА́ЧН||ЫЙ дээврийн хөндийн; ~**ое помещение** дээврийн хөндий дэх тасалгаа.

ЧЕРЁД ээлж; **мой** ~ миний ээлж; **идти своим** ~**ом** зохих замаараа явах, хэвийн ёсоор явах.

ЧЕРЕДОВА́НИЕ ээлжлэх, сэлгэх; ~ **звуков** авиа сэлгэх.

ЧЕРЕДОВА́ТЬ сэлгүүлэх, ээлжлүүлэх; ~ **труд с отдыхом** ажиллах, амрах хоёрыг сэлгүүлэх.

ЧЕРЕДОВА́ТЬСЯ ээлжлэх, сэлгэх.

ЧЕ́РЕЗ 1. хөндлөн, дээгүүр; **мост** ~ **реку** гол дээгүүр тавьсан гүүр; 2. дундуур, -аар (*-ээр,-оор-өөр*)нэвт, дайран, дамжин, -аар (*-ээр,-оор,-өөр*); **пройти** ~ **лес** ой дундуур гарах; **влезть**

~ **окно** цонхоор шурган орох; 3. дамжуулан; **сообщить ~ друга** найзаараа дамжуулан мэдэгдэх; 4. тавьж; **писать слово ~ чёрточку** зураас тавьж үг бичих; 5. болоод, дараа; 6. алгасаад, өнгөрөөд; 7. болоод, тутам; **принимать лекарство ~ час** цаг болоод эм ууж байх; 8. алгасаад, алгасаж; **писать ~ две строчки** хоёр мөр алгасаад бичиж байх.

ЧЕРЁМУХА 1. монос; 2. мойл.

ЧЕРЕМША́ халиар.

ЧЕРЕНО́К 1. иш, бариул; ~ **ножа** хутганы иш; 2. шилбэ, иш; ~ **листа** навчны шилбэ.

ЧЕ́РЕП хохимой толгой, толгойн яс, гавал.

ЧЕРЕПА́ХА яст мэлхий; **тащиться как ~** яст мэлхий шиг удаан явах.

ЧЕРЕПА́ХОВЫЙ яст мэлхийн, яст мэлхийн хуягаар хийсэн; ~ **гребень** яст мэлхийн сам, яст мэлхийн хуягаар хийсэн сам.

ЧЕРЕПА́Ш||ИЙ 1. яст мэлхийн; 2. яст мэлхий шиг удаан, маш удаан, хэт удаан; **идти ~ьим шагом** маш удаан явах.

ЧЕРЕПИ́ЦА ваар; ~ **плоская** амцгар ваар.

ЧЕРЕПИ́ЧН||ЫЙ ваарын, ваар; ~ **завод** ваарын үйлдвэр; ~**ая крыша** вааран дээвэр.

ЧЕРЕПН||О́Й хохимой толгойн, толгойн ясны, гавлын; ~**ая коробка** гавлын яс, гавал.

ЧЕРЕПО́К шаазангийн хэлтэрхий, хэлтэрхий ваар.

ЧЕРЕСПОЛО́СИЦА газрыг цоохорлон эдлэх, шаантаг газар.

ЧЕРЕССЕДЕ́ЛЬНИК сойлт.

ЧЕРЕСЧУ́Р дэндүү, хэтэрхий, даан; ~ **много говорил** хэтэрхий их ярилаа.

ЧЕРЕ́ШНЯ 1. чий мод; 2. чий жимс, интоор.

ЧЕРЕШО́К 1. иш, бариул; 2. шилбэ, иш.

ЧЕРКНУ́ТЬ зурвас бичих, татлах.

ЧЕРНЁН||ЫЙ харлуулсан; ~**ая сталь** харлуулсан ган.

ЧЕ́РНЕТЬ шунгадаг нугас.

ЧЕРНЕ́||ТЬ, 1. харлах, хар болох; 2. харлах, бараантах, харлан харагдах; **вдали ~л лес** алсад ой бараантаж байв.

ЧЕРНЕ́ТЬСЯ харлах, бараантах, бараантан харагдах.

ЧЕРНИ́КА нүр, хар нэрс.

ЧЕРНИ́ЛА бэх.

ЧЕРНИ́ЛЬНИЦА нагван, бэхийн сав, янтай.

ЧЕРНИ́ЛЬН||ЫЙ бэхийн; ~**ое пятно** бэхийн толбо, бэх дуссан толбо.

ЧЕРНИ́ТЬ 1. харлуулах, хар болгох, бараалах, бараан болгох; 2. муу хэлэх, гүтгэх.

ЧЕРНИ́ЧНЫЙ нүрийн, хар нэрсний.

ЧЕРНОБРО́ВЫЙ хар хөмсөгт.

ЧЕРНОБРЮ́ШКА *рыб.*хар хайга.

ЧЕРНОБУ́Р||ЫЙ хар халтар, галт хар; ~**ая лиса** галт хар үнэг.

ЧЕРНОВИ́К ноорог.

ЧЕРНОВО́Й ноорог.

ЧЕРНОВОЛО́СЫЙ хар үстэй.

ЧЕРНОГЛА́ЗЫЙ хар нүдтэй.

ЧЕРНОГОЛО́ВНИК сөд.

ЧЕРНОЗЁМ хар шороо, хар хөрс.

ЧЕРНОЗЁМН||ЫЙ хар шороот, хар хөрст; ~**ая степь** хар хөрст тал.

ЧЕРНОКНИ́ЖНИК домч, тарнич.

ЧЕРНОКО́ЖИЙ 1. хар арьст; 2. хар арьстан.

ЧЕРНОКО́РЕНЬ *бот.*чонын хэл.

ЧЕРНОЛЕ́СЬЕ хар модон ой, шинэсэн ой.

ЧЕРНОМО́РСК||ИЙ хар тэнгисийн; ~**ое побережье** хар тэнгисийн эрэг.

ЧЕРНООКИЙ хар нүдэн, хар мэлмийт.

ЧЕРНОПЛО́ДНИК *бот.*хохимой өвс.

ЧЕРНОРАБО́ЧИЙ хар ажилчин.

ЧЕРНОСЛИ́В хар чавга.

ЧЕРНОСО́ТЕНЕЦ хар үзэлтэн, харгис үзэлтэн.

ЧЕРНОТА́ хар (*өнгө*).

ЧЁРН||ЫЙ 1. хар, бараан; ~**ая краска** хар будаг; ~**ое платье** хар даашинз; ~ **хлеб** хар талх, бараан талх; 2. хар, уйтгартай, хүнд, бэрх; ~**ые дни** уйтгартай өдрүүд, бэрх өдрүүд; 3. хар, хорт, ялт; ~**ая измена** ялт урвалт; 4. өрхгүй, утаатай; 5. арын ~ **ход** арын хаалга; 6. хар; ~**ая работа** хар ажил; 7. хар хувцас, хар; **ходить в ~ом** хар хувцас өмсөх, хар өмсөх; ~ **амур** *рыб.*хар загас; ~**ые металлы** хар төмөрлөг; ~ **лес** хар модон ой, шинэсэн ой; ~**ая болезнь** хар мөөгөнцрийн өвчин; ~ **окунь** даравгар хар алгана; **держать кого-либо в ~ом теле** шоовдорлох, хавчих; **на ~ день** ядрахдаа хэрэглэнэ гэж; ~**ый рынок** дамын наймаа, панз; ~**ым по белому** тов тодорхой; **чёрным-черно** 1) хав хар, пад хар; 2) хар үүл шиг олон.

ЧЕРНЬ I харц.

ЧЕРНЬ II харлуулсан мөнгө.

ЧЕРПА́К 1. шанага; 2. утгуур

ЧЕРПА́ЛКА 1. шанага; 2. утгуур.

ЧЕРПА́ЛЬН||ЫЙ утгах; ~**ая машина** утгах машин.

ЧЕ́РПАТЬ 1. утгах; ~ **воду из колодца** худгаас ус утгах; 2. олох, олж авах; ~ **сведения** мэдээ олж авах.

ЧЕРПНУ́ТЬ утгаад авах; ~ **воды** ус утгаад авах.

ЧЕРСТВЕ́||ТЬ 1. хатуу болох, хатах, хуучрах; **хлеб быстро ~ет** талх амархан хуучирдаг; 2. ширүүн зантай болох; сэтгэл хатуурах, хатуу болох, өр зузаан болох.

ЧЁРСТВОСТЬ 1. хатуу байх, хатсан юм; 2. ширүүн зан, энэрэлгүй сэтгэл, өр зузаан.

ЧЁРСТВЫЙ 1. хатуу, хатсан, хуучирсан; ~ **хлеб** хатсан талх; 2. ширүүн, хатуу, өр зузаан, энэрэлгүй; ~ **человек** өр зузаан хүн.

ЧЁРТ ~ **возьми!** ~ **побери!** чөтгөр алгад!; **до ~а** үхтлээ, аймшигтай их; **к ~у, ко всем чертям** (*послать, бросить*) арилаг, тонилог, юу ч биш, золигийн нь; **послать к ~у, ко всем чертям** арил гэж хөөх; **всё дело пошло к ~у** хэрэг юу ч биш болов; **какой, к ~у, он инженер!** ямар золигийн нь инженер юм тэр!; **иди к ~у!** арил, тонил!; **жить у ~а на куличках** газрын мухарт суух; **на кой ~, на ~а** золигийн нь, золигоо; **ни к ~у не годится** огт зохихгүй; **чем ~ не шутит** яаж ч магадгүй; ~ **знает** бүү мэд; **что за ~!** ай, золиг! юу гээчийн чөтгөр вэ? **ни богу свечка, ни ~у кочерга** хэнд ч хэрэггүй; **не так страшен ~, как его малюют** хоосон сүрээс цаашгүй, үхсэн буурын толгойноос амьд ат айв.

ЧЕРТ||А́ 1. зураас, шугам; **провести ~у** шугам татах, шугамдах; 2. тэг, гороо, шугам; **пограничная** ~ хилийн шугам; **в ~е города** хотын тэг дотор, хотын гороо дотор; 3. онцлог шинж; ~ **характера** зан авирын онцлог; 4. байдал, төрх; ~**ы лица** нүүрийн төрх, нүүр царай.

ЧЕРТЁЖ зураглал, шугам зураг.

ЧЕРТЁЖНИК шугам зурагчин.

ЧЕРТЁЖНИЦА шугам зурагчин эмэгтэй.

ЧЕРТЁЖН||ЫЙ шугам зургийн; ~**ая доска** шугам зургийн самбар.

ЧЕРТИ́ТЬ 1. зурах, шугам татах; ~ **линию** зураас зурах; 2. зурах, хийх; ~ **план** дэвсгэр зураг зурах.

ЧЕРТО́ВСКИ золиг шиг, айхавтар, сүрхий; ~ **устал** золиг шиг ядарлаа, үхтлээ ядарлаа.

ЧЕРТО́ВСКИЙ золигийн, айхавтар, сүрхий; муухай; ~ **холод** золигийн хүйтэн.

ЧЕРТОВЩИ́НА золигийн юм; **что за ~?** ямар золигийн юм бэ?

ЧЕРТО́Г орд, харш.

ЧЕРТОПОЛО́Х зараа уул, чоныи өргөс.
ЧЕ́РТОЧКА 1. бяцхан зураас, богинохон шугам; 2. онцлог, шинж; 3. богино зураас.
ЧЕРТЫХА́ТЬСЯ золиг гэж хараах, чөтгөр гэж хараах.
ЧЕРЧЕ́НИ||Е шугам зураг; **урок ~я** шугам зургийн хичээл.
ЧЕСА́ТЬ 1. маажих; **~ себе затылок** шилээ маажих; 2. самнах, үс самнах; **~ волосы** үс самнах; 3. самнах, самнаж цэвэрлэх; **~ лён** маалинга самнах; **~ язык** хэлээ билүүдэх.
ЧЕСА́ТЬСЯ 1. биеэ маажих; 2. үсээ самнах; 3. загатнах; **у него спина чешется** түүний нуруу загатнаж байна; **язык чешется** хэлэх гээд болохгүй, хэлмээр санагдаад болохгүй.
ЧЕСНО́К сармис.
ЧЕСО́ТКА хамуу, маажуур.
ЧЕСО́ТОЧН||ЫЙ хамууны, маажуурын, хамуутай, маажууртай; **~ больной** хамуутай хүн; **~ые клещи** хамууны хачиг.
ЧЕ́СТВОВАНИЕ 1. хүндэтгэн ёслох; 2. баяр ёслол.
ЧЕ́СТВОВАТЬ шударга, үнэнч, цэх, шулуун.
ЧЕСТНО́Й ах дээд, ах зах; **~ народ** ах дээд хүмүүс.
ЧЕ́СТНОСТЬ шударга (*байх*), үнэнч зан, үнэнч шударга, цэх шулуун.
ЧЕ́СТН||ЫЙ шударга, голч, үнэнч, цэх, шулуун; **~ человек** шударга хүн, шударга шулуун хүн; **~ труд** шударга хөдөлмөр; **дать ~ое слово** тангараглах; **держаться на ~ом слове** архи даахгүй.
ЧЕСТОЛЮ́БЕЦ нэр алдар хүсэгч, нэр хүндэд дуртай хүн, эрх тушаалд шунагч.
ЧЕСТОЛЮБИ́ВЫЙ нэр алдар хүссэн, нэр хүндэд дуртай, эрх тушаалд шунасан; **~ человек** эрх тушаалд шунасан хүн.
ЧЕСТОЛЮ́БИЕ нэр алдар хүсэх, нэр хүндэд дурлах, эрх тушаалд шунах.
ЧЕСТ||Ь 1. нэр төр, нэр хүнд, *нэр*; **береги ~ смолоду** хүн болох багаасаа; 2. хүндлэх, хүндэтгэл; **это большая ~ для меня** энэ бол намайг их хүндэлсэн хэрэг; **в ~ кого-либо** хүн юмыг хүндэтгэн, зориулан; **выйти с ~ью** нэр төртэй гарах; **к чести** нэр төрөө бодож, нэрд нь сайн болох; **к его ~и, он сразу *исправил свою ошибку*** нэр төрөө бодож алдаагаа дор нь зассан; **отдать ~** ёслох; **пора и ~ знать** дуусгах цаг боллоо; **по ~и сказать** үнэнийг хэлэхэд, ний нуугүй хэлэхэд; **с ~ью выполнить** нэр төртэй биелүүлэх; **~ю просить** журам ёсоор гуйх, гүнээ хүсэх.
ЧЕСУЧА́ чисчүү.
ЧЁТ тэгш тоо; **~ и нечёт** тэгш сондгой тоо.
ЧЕТА́ (*ижил*) хоёр, эр эм хоёр; **супружеская ~** эр эм хоёр; **счастливая ~** жаргалтай хос; **не ~** ижил биш, ижил болохгүй, тэнцэхгүй.
ЧЕТВЕ́РГ пүрэв гариг, дөрөвдэх өдөр.
ЧЕТВЕРЕ́НЬК||И на ~ах дөрвөн хөллөн; **стать на ~** дөрвөн хөллөх.
ЧЕТВЁРКА 1. дөрвөн, дөрвөн тоот; 2. дөрвийн дүн, дөрөв (*сургуулийн дүн*); 3. (*хөзрийн*) дөрөвт, *дөрөв*; **бубновая ~** дөрвөлжингийн дөрөв; 4. дөрвөн хүн; 5. хөллөсөн дөрвөн; **~ лошадей** хөллөсөн дөрвөн морь.
ЧЕ́ТВЕРО дөрвөн; **~ человек** дөрвөн хүн.
ЧЕТВЕРОНО́ГИЕ дөрвөн хөлтөн.
ЧЕТВЕРОНО́Г||ИЙ *дөрвөн* хөлт, дөрвөн хөлтэй; **~ое животное** дөрвөн хөлт амьтан.
ЧЕТВЕРОСТИ́ШИЕ дөрвөн мөрт шүлэг.
ЧЕТВЕРТИ́ЧН||ЫЙ дөрөвдөгч; **~ый период** дөрөвдөгч галав.
ЧЕТВЕРТОВА́НИЕ (*дөрвөн мөч,толгойг*)цаазлах.
ЧЕТВЕРТОВА́ТЬ цаазаар(*дөрвөн мөч,толгойг*)авах.
ЧЕТВЕРТУ́ШКА дөрөвний нэг.
ЧЕТВЁРТ||ЫЙ 1. дөрөвдүгээр, дөрөвдэх, дөрөв, дөрвөн; **~ этаж** дөрөвдүгээр давхар; **~ая страница** дөрөвдүгээр тал, дөрөвдэх нүүр; **в ~ых** дөрөвт; **~ое августа** наймдугаар; сарын дөрвөн; 2. дөрөвний нэг, дөрөвний; **одна ~ая** дөрөвний нэг.
ЧЕ́ТВЕРТЬ 1. дөрөвний нэг, мөч, мөчлөг; **~ часа** дөрөвний нэг цаг, мөч; **~ года** жилийн дөрөвний нэг, гурван сар; **вторая ~ двадцатого века** хорьдугаар зууны хоёрдугаар мөчлөг; 2. аливаа хэмжүүрийн дөрөвний нэг, дөрөвний нэгэн хувин; **~ вина** дөрөвний нэгэн хувин дарс.
ЧЁТКИ эрих.
ЧЁТК||ИЙ 1. тод, тодорхой, хурц тод, ялгацтай; **~ шрифт** ялгацтай үсэг, тод үсэг; 2. тодорхой, товтой нарийн; **~ая речь** тодорхой үг; **~ая организация труда** хөдөлмөрийг *нарийн зохион* байгуулах.
ЧЁТКО тодорхой, тод, нарийн.
ЧЁТКОСТЬ 1. тод байх, тодорхой байх, хурц тод байх, ялгац; **~ рисунка** хурц тод зураг, ялгац сайтай зураг; 2. тодорхой байх, товтой байх, нарийн байх.
ЧЁТН||ЫЙ тэгш; **~ые числа** тэгш тоо.
ЧЕТЫ́РЕ дөрөв, дөрөвний тоо.
ЧЕТЫ́РЕЖДЫ дөрвөнтөө, *дөрөв дахин*, *дөрвөн*; **~ четыре — шестнадцать** дөрвөн дөрвийн-арван зургаа.
ЧЕТЫ́РЕСТА дөрвөн зуун.
ЧЕТЫРЁХГОДИ́ЧНЫЙ дөрвөн жилийн; **~ срок** дөрвөн жилийн хугацаа.
ЧЕТЫРЁХГРА́ННИК дөрвөн талт.
ЧЕТЫРЁХДНЕ́ВНЫЙ дөрвөн өдрийн, дөрвөн өдөрчийн, дөрвөн хоногийн; **~ переход** дөрвөн өдөрчийн газар.
ЧЕТЫРЁХЛЕ́ТИЕ 1. дөрвөн жил, дөрвөн жилийн хугацаа; 2. дөрвөн жилийн ой.
ЧЕТЫРЁХЛЕ́ТНИЙ дөрвөн жилийн, дөрвөн настай, дөрөвтэй; **~ юбилей** дөрвөн жилийн ой; **~ ребёнок** дөрвөн настай хүүхэд.
ЧЕТЫРЁХМЕ́СТНЫЙ дөрвөн хүний суудалтай, дөрвөн байртай, дөрвөн хүний.
ЧЕТЫРЁХМЕ́СЯЧНЫЙ дөрвөн сарын, дөрвөн сартай.
ЧЕТЫРЁХПО́ЛЬЕ дөрвөн талбайт тариалан.
ЧЕТЫРЁХПО́ЛЬНЫЙ дөрвөн талбайт.
ЧЕТЫРЁХСЛО́ЖН||ЫЙ дөрвөн үет, дөрвөн үетэй; **~ое слово** дөрвөн үетэй үг.
ЧЕТЫРЁХСОТЛЕ́ТИЕ 1. дөрвөн зуун жил, дөрвөн зуун жилийн хугацаа; 2. дөрвөн зуун жилийн ой.
ЧЕТЫРЁХСОТЛЕ́ТНИЙ дөрвөн зуун жилийн.
ЧЕТЫРЁХСО́ТЫЙ дөрвөн зуудугаар, дөрвөн зуудахь.
ЧЕТЫРЁХУГО́ЛЬНИК дөрвөлжин, дөрвөн өнцөгт.
ЧЕТЫРЁХУГО́ЛЬНЫЙ дөрвөлжин; **~ стол** дөрвөлжин ширээ.
ЧЕТЫРЁХЧАСОВО́Й дөрвөн цагийн; **~ поезд** дөрвөн цагийн галт тэрэг.
ЧЕТЫРЁХЭТА́ЖНЫЙ дөрвөн давхар; **~ дом** дөрвөн давхар байшин.
ЧЕТЫРНАДЦАТИЛЕ́ТНИЙ арван дөрвөн настай, арван дөрвөтэй.
ЧЕТЫ́РНАДЦАТ||ЫЙ арван дөрөвдүгээр, арван дөрөвдэх, арван дөрөв, арван дөрвөн; **~ая страница** арван дөрөвдүгээр тал; **~ое января** нэгдүгээр сарын арван дөрвөн.
ЧЕТЫ́РНАДЦАТЬ арван дөрөв.
ЧЕХ чех хүн.
ЧЕХАРД||А́ бие биеэ харайх наадам; **играть в ~у** биеэ биеэ харайж наадах.
ЧЕХО́Л гэр, дугтуй, бүрээс.
ЧЕХОСЛОВА́ЦКИЙ чехословак, чехословакийн.

ЧЕЧЕВИ́ЦА I сэвэг, зарам, алагар.
ЧЕЧЕВИ́ЦА II мэшил, галт шил.
ЧЕЧЕВИ́ЧНЫЙ сэвэг зармын, сэвэг зарман; ~ **суп** сэвэг зарман шөл.
ЧЕЧЁТКА I улаан залаат (*шувуу*).
ЧЕЧЁТКА II товших бүжиг.
ЧЕ́ШКА чех эмэгтэй, чех эхнэр.
ЧЕ́ШСКИЙ чех, чехийн; ~ **язык** чех хэл.
ЧЕШУ́ЙКА хайрс.
ЧЕШУ́ЙЧАТЫЙ хайрстай, хайрст, хайрслаг.
ЧЕШУЯ́ хайрс, **рыбья** ~ загасны хайрс.
ЧИ́БИС хавтгаалж, зааpаг шувуу.
ЧИ́ЖИК алтан жигүүр, ногоолзой.
ЧИЙ дэрс.
ЧИЛИ́ГА *бот.* хатгуур.
ЧИН 1. хэргэм зэрэг, цол; **повышение в ~е** зэрэг нэмэх, зэрэг дэвшүүлэх; **офицерский** ~ цэргийн даргын цол; 2. түшмэл **~ы дипломатического корпуса** дипломат корпусын түшмэд; **без ~ов** хэргэм зэрэг харалгүй, эрээлзлгүй.
ЧИНА́РА чинар мод.
ЧИНИ́ТЬ I засах, сэлбэх, нөхөх, хадах; ~ **замки** цоож засах, ~ **бельё** хувцас сэлбэх.
ЧИНИ́ТЬ II үзүүрлэх; ~ **карандаш** харандаа үзүүрлэх.
ЧИНИ́ТЬ III учруулах, хийх, болох; ~ **препятствия** саад учруулах.
ЧИ́ННО ёсыг баримтлан, ёсорхон, томоотой; **сели ~ в ряд** ёсорхон зэрэглэж суув, томоотой зэрэгцэн суув.
ЧИ́ННЫЙ ёсыг баримталсан, ёсорхсон, ёсорхуу, томоотой.
ЧИНО́ВНИК 1. түшмэл; **С плохими законами и хорошими ~ами вполне можно править страной. Но если ~и плохи, не помогут и самые лучшие законы. (О.Бисмарк)** Муу хуультай ч сайн түшмэлтэй бол улс орныг удирдаж болно. Харин түшмэд нь муу бол ямар ч сайн хууль байгаад нэмэргүй. (О.Бисмарк); 2. түшмэл, албархаг хүн, хүнд сурталтан.
ЧИНО́ВНИЧЕСКИЙ түшмэлийн, албархаг, хүнд сурталтай; ~ **подход к делу** түшмэлийн ажлын арга, хоосон албархах.
ЧИНО́ВНИЧЕСТВО түшмэд.
ЧИНО́ВНИЧИЙ түшмэлийн.
ЧИНО́ВН||ЫЙ дээгүүр зэрэгтэй, хэргэм зэрэгтэй; **~ое лицо** дээгүүр зэрэгтэн.
ЧИНОПОЧИТА́НИЕ дээгүүр зэрэгтнийг хүндлэх, ахмад зэрэгтнийг хүндлэх.
ЧИНОПРОИЗВО́ДСТВО зэрэг дэвшүүлэх.
ЧИ́РЕЙ хатиг.
ЧИРИ́КАНЬЕ жиргэх дуу.
ЧИРИ́КАТЬ жиргэх.
ЧИРИ́КНУТЬ жиргээд орхих, жиргэсгэх.
ЧИ́РКАТЬ зурах; ~ **спичками** чүдэнз зурах.
ЧИ́РКНУТЬ зураад орхих, зурчих.
ЧИРО́К голын нугас, шурхий, шүрэг нугас, шивээ нугас, алаг нугас.
ЧИ́СЛЕННОСТЬ ~ **населения** хүн амын тоо.
ЧИ́СЛЕНН||ЫЙ тооны, тооны талын; **~ое превосходство** тоогоор давуу байх.
ЧИСЛИ́ТЕЛЬ хүртвэр.
ЧИСЛИ́ТЕЛЬН||ЫЙ имя ~ое тооны нэр.
ЧИ́СЛИТЬСЯ тоологдох, тооцогдох, тоонд орох, ~ **в командировке** томилолтоор явсанд тооцогдох.
ЧИСЛ||О́ 1. тоо; **целое** ~ бүхэл тоо; **дробное** ~ бутархай тоо; 2. өдөр, өдөр сар; **какое сегодня ~?** өнөө хэдний өдөр вэ? **в последних ~ах сентября** есдүгээр сарын сүүлээр; **пометить задним ~ом** өнгөрсөн өдрөөр тэмдэглэгдэх, өнгөрсөн өдөр сар тавих; 3. тоо, тоо хэмжээ, олон цөөн; **~ом в двадцать человек** хорин (*тооны*) хүн; **большое ~ людей** олон (*тооны*) хүн; ~ **книг в библиотеке сильно возросло** номын сангийн номын тоо хэмжээ их нэмэгдэв; 4. тоо; **единственное** ~ ганц тоо; **множественное** ~ олон тоо; **в том ~е** оролцуулан.
ЧИСЛОВ||О́Й тооны; **~ое соотношение** тооны харьцалдаа.
ЧИСТЕ́Ц улбар аргуй.
ЧИ́СТИЛЬЩИК цэвэрлэгч; ~ **сапог** гутал цэвэрлэгч.
ЧИ́СТИТЬ цэвэрлэх, арилгах, арчих; ~ **зубы** шүдээ цэвэрлэх; ~ **платье** хувцас цэвэрлэх; ~ **картошку** төмс арилгах; ~ **обувь** гутал арчих; ~ **дно реки** голын ёроол арилгах.
ЧИ́СТИТЬСЯ 1. биеэ цэвэрлэх, юмаа цэвэрлэх; 2. цэвэрлэгдэх, арилгагдах.
ЧИ́СТК||А цэвэрлэх, арилгах, арчих; **отдать костюм в ~у** костюм цэвэрлүүлэхээр өгөх.
ЧИ́СТО I цэвэр, цэвэр болтол, цэвэрхэн; ~ **вымыть руки** гараа цэвэрхэн угаах.
ЧИ́СТО II яг л... шиг, эгээ л... шиг, шиг л.
ЧИСТОВ||О́Й сийрүүлэн бичсэн, сийрүүлэн бичих, найруулсан, ~ **экземпляр** сийрүүлэн бичсэн хувь; **~ая тетрадь** сийрүүлэн бичих дэвтэр.
ЧИСТОГА́Н бэлэн мөнгө; **получить ~ом** бэлэн мөнгөөр авах.
ЧИСТОКРО́ВНЫЙ цэвэр үүлдрийн; ~ **жеребец** цэвэр үүлдрийн азарга.
ЧИСТОПИСА́НИ||Е цэвэр бичиг; **урок ~я** цэвэр бичгийн хичээл.
ЧИСТОПЛО́ТНОСТ||Ь 1. цэвэрч цэврийг эрхэмлэх; **привычка к ~и** цэвэрч заншил; 2. ариун явдал, ариун суртахуунтай байх.
ЧИСТОПЛО́ТНЫЙ 1. цэвэрч, цэврийг эрхэмлэгч; ~ **человек**, цэвэрч хүн; 2. ариун явдал, ариун сурталтай.
ЧИСТОПОРО́ДНЫЙ цэвэр үүлдрийн; ~ **скот** цэвэр үүлдрийн мал.
ЧИСТОСЕРДЕ́ЧНО үнэн сэтгэлээс, чин үнэнээс, ний нуугүй; ~ **признаться** үнэн сэтгэлээс хүлээх, ний нуугүй хэлэх.
ЧИСТОСЕРДЕ́ЧНОСТЬ үнэн сэтгэл, чин үнэн, цагаан санаа.
ЧИСТОСЕРДЕ́ЧНЫЙ үнэн сэтгэлийн, чин үнэнээс хэлсэн, чин үнэнч, цагаан сэтгэлтэй, үнэн санаатай; ~ **человек** цагаан сэтгэлтэй хүн.
ЧИСТОСО́РТНЫЙ цэвэр сортын, холиогүй, нэг сортын.
ЧИСТОТ||А́ 1. цэвэр байдал, ариун цэвэр, цэвэр байх; **соблюдать ~у** ариун цэврийг сахих; **содержать в ~е** цэвэр байлгах; 2. цэвэр (*байх*), хольцоогүй (*байр*), дан (*байх*); ~ **воды** усны цэвэр байх; 3. тунгалаг (*байх*), хиргүй (*байх*), ариун (*байх*); ~ **души** хиргүй сэтгэл.
ЧИСТОШЕРСТЯН||О́Й цэвэр ноосон; **~ая ткань** цэвэр ноосон даавуу.
ЧИ́СТ||ЫЙ 1. цэвэр, хиргүй, ариун, тунгалаг; **~ое полотенце** цэвэр алчуур; ~ **воротничок** хиргүй зах; ~ **воздух** цэвэр агаар, ариун агаар; 2. цэвэр, хольцоогүй, ёстой; ~ **спирт** цэвэр спирт; **~ое золото** ёстой алт; 3. цэвэр, цэвэр сайхан; зөв; **~ое произношение** цэвэр дуудлага; 4. тунгалаг, хиргүй, ариун, шудрага, үнэн; **~ая совесть** ариун сэтгэл; 5. цэлмэг, тунгалаг; **~ое небо** цэлмэг тэнгэр; 6. ёстой, жинхэнэ, лав, яриагүй; **~ая правда** ёстой үнэн; 7. цэвэр, нарийн, цэмцгэр; **~ая работа** нарийн ажил, нарийн хийсэн юм; ~ **вес** цэвэр жин; **~ая прибыль** цэвэр орлого.
ЧИТА́ЛЬНЫЙ уншлагын, ном үзэх; ~ **зал** уншлагын танхим; ном үзэх танхим.
ЧИТА́ЛЬНЯ уншлагын газар, ном үзэх газар; **университетская** ~ их сургуулийн уншлагын танхим.

ЧИТА́ТЕЛ||Ь уншигч; **встреча писателя со своими ~ями** зохиолч уншигчидтайгаа уулзах.
ЧИТА́ТЕЛЬНИЦА уншигч эмэгтэй.
ЧИТА́ТЬ 1. унших, үзэх; ~ **книгу** ном унших, ном үзэх; 2. унших, заах; ~ **лекции** лекц унших; ~ **русскую историю** Оросын түүх унших; 3. сургах, донгодох, хэлэх; ~ **нотации** сургаж донгодох, сургамж үг хэлэх; ~ **чьи-либо мысли** хүний санааг таах.
ЧИТА́||ТЬСЯ уншигдах; **эта книга ~ется легко** энэ уншихад хялбар ном.
ЧИ́ТКА 1. унших, уншлага; **коллективная ~ газет** хамтран сонин унших; 2. уншин жүжиглэх.
ЧИХА́НЬЕ найтаалгах, найтаалга.
ЧИХА́ТЕЛЬНЫЙ найтаалгах, найтаалганы; ~ **газ** найтаалгах хий; ~ **табак** найтаалганы тамхи.
ЧИХА́ТЬ найтаах.
ЧИХНУ́ТЬ найтаалгаад авах, найтаалгаад орхих.
ЧИ́ЩЕ илүү цэвэр, улам цэвэр.
ЧЛЕН 1. гишүүн; **~-корреспондент Академии Наук** Шинжлэх Ухааны Академийн сурвалжлагч гишүүн; 2. эрхтэн, мөч, үе гишүүн, үе мөч; 3. (*хэлзүйн*) гишүүн; ~ **предложения** өгүүлбэрийн гишүүн.
ЧЛЕ́НИК биеийн үе.
ЧЛЕНИСТОНО́ГИЕ үе биетэн, үе хөлтөн.
ЧЛЕНИ́ТЬ хуваах, хэсэг хэсэг болох, үелэх, гишүүн гишүүнээр нь болгох.
ЧЛЕНОВРЕДИ́ТЕЛЬСТВО эрхтэн гэмтээх, эрэмдэг зэрэмдэг болгох.
ЧЛЕНОРАЗДЕ́ЛЬНО тод, авиагий нь тодорхой, ойлгогдохоор; **говорить ~** авиагийн нь тодорхой өгүүлэх, тод өгүүлэх.
ЧЛЕНОРАЗДЕ́ЛЬН||ЫЙ тод, авиа тодорхой, ойлгогдох; **~ая речь** авиа тодорхой үг хэлэх.
ЧЛЕ́НСКИЙ гишүүний; ~ **билет** (*гишүүний*) батлах; ~ **взнос** гишүүний татвар.
ЧЛЕ́НСТВО гишүүн байх.
ЧМО́КА||ТЬ 1. тамшаах, шов шов хийх; 2. шал шал хийх, чал чал гэх; **грязь ~ла под ногами** явахад шавар шал шал гэж байв; 3. шов гэтэл озох.
ЧМО́КНУТЬ шов хийтэл озоод авах.
ЧО́КАТЬСЯ, ЧОКНУТЬСЯ тулгах; ~ **рюмками** хундага тулгах.
ЧО́ПОРНО хэтэрхий ёсорхуу; ~ **держаться** хэтэрхий ёсорхуу байх; хэт ёсорхох.
ЧО́ПОРНОСТЬ хэтэрхий ёсорхог зан, хэт ёсорхуу байх.
ЧО́ПОРНЫЙ хэтэрхий ёсорхог, хэт ёсорхуу; ~ **человек** хэт ёсорхуу хүн.
ЧО́ХОМ 1. бөөнөөр; **опустить товар ~** бараа бөөнөөр олгох; 2. багцаагаар, багцаалан, барагцаалан; ~ **отмерить** барагцаалан хэмжих.
ЧРЕВА́Т||ЫЙ удмаар, татаж болох, гаргаж болмоор; **события, ~ые последствиями** урших удаж болох явдал.
ЧРЕВНО́Й гэдэсний.
ЧРЕ́В||О хэвэл; (*ещё*) **во ~е матери** эхийн хэвэлд байхдаа.
ЧРЕВОЩА́НИЕ уруулаа хөдөлгөлгүй дугарах.
ЧРЕВОВЕЩА́ТЕЛЬ уруулаа хөдөлгөлгүй яригч.
ЧРЕВОУГО́ДИЕ ховдоглох, их идэх.
ЧРЕВОУГО́ДНИК ховдог хүн, идэмхий хүн.
ЧРЕВОУГО́ДНИЧАТЬ ховдоглох, их идэх.
ЧРЕДА́ ээлж.
ЧРЕЗ 1. хөндлөн, дээгүүр; 2. дундуур; 3. дамжуулан; 4. тавьж; 5. болоод; дараа; 6. алгасаад, өнгөрөөд; 7. болоод, тутам; 8. алгасаад, алгасаж.
ЧРЕЗВЫЧА́ЙНО тун, сүрхий, онц, үлэмжхэн, гаргуу; **всё это ~ ново** энэ бүгд тун шинэ зүйл байна; ~ **важный вопрос** онц чухал асуудал.
ЧРЕЗВЫЧА́ЙН||ЫЙ 1. гаргуу, гарамгай, үлэмжхэн, сүрхий, онцгой; ~ **успех** үлэмжхэн амжилт; 2. онц, онцгой; ~ **и полномочный посол** онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд; **~ые меры** онцгой арга хэмжээ; **~ое положение** онц байдал.
ЧРЕЗМЕ́РНО хэт, хэтэрхий, дэндүү, дээнч; **он ~ скромен** тэр дэндүү даруу зантай.
ЧРЕЗМЕ́РН||ЫЙ хэтэрхий, хэтрүү, дэндүү их, хэмээс хэтэрсэн; **~ое внимание** хэтэрхий анхаарал; **~ые требования** дэндүү их шаардлага.
ЧТЕ́НИ||Е унших, үзэх, уншлага; ~ **вслух** унших, дугарч унших; **книга для ~я** унших бичиг.
ЧТЕЦ уншигч.
ЧТИТЬ хүндлэх, хүндэтгэх; ~ **память погибших бойцов** амь үрэгдсэн дайчдын дурсгалыг хүндэтгэх.
ЧТИ́ЦА уншигч эмэгтэй.
ЧТО I 1. юу, юм; ~ **случилось** юу болов? ~ **это такое?** энэ юу вэ? **сделайте вот ~** ийм юм хийгтүн; 2. ямар, яаж; ~ **больной?** өвчтөн ямар байна? 3. юу юунд, яагаад; ~ **ты задумался?** чи юунд бодлого болов? 4. хэдий, аль, ямар; ~ **было сил** аль байдаг чадлаараа; 5. *хамт хэрэглэгдсэн үйл үгийг нь үйлт нэр болгоно;-ын(ийн), -ы(ий),-н, тай(тэй, той)*; **дом, ~ стоит на лугу** буланд байгаа байшин, булангийн байшин; **вода, ~ в чашке** аягатай ус; 6. ямар нэг юм, нэг юм,юм; **в случае чего** ямар нэгэн юм тохиолдвол; **чуть ~— сразу сообщи** ямар нэгэн юм болбол дор нь дуулгаарай; **не забыл ли ты чего?** чи юм мартаагүй биз? **а что?** тэгээд юу гэж? **на ~ (*уж*)** 1)хичнээн их; хэдий их; 2)үүнээс сайн юу байх вэ? **ни при чём остаться** юу ч үгүй хоцрох; **ни за ~** юу боловч; **ни за ~, ни про ~** шал дэмий,ямар ч шалтгаангүй; **ни к чему** 1)ямар ч хэрэггүй; 2)анзаарсангүй; **уйти ни с чем** юу ч үгүй зайлах; **с чего** яагаад юунд; ~ **делать!** яая гэх вэ!; ~ **за** юу гэгчийн; **чего доброго** магад ч үгүй, яаж мэдэх вэ; ~ **и говорить** хэлээд яах вэ; что ли 1)юм билүү; 2)юм болов уу; ~ **ты!** яав чи! ~ **вы!** яагаа вэ та!
ЧТО II 1. *хамт хэрэглэгдсэн үйл үгийг нь үйлт нэр болгоно*; **знаю, ~ ты скажешь** чиний хэлэхийг би мэднэ; **такой тяжёлый, ~ не поднять** даахгүй хүнд; 2. гэж; ~ **волки жадны, всякий знает** чоныг хомхой гэж хүн бүхэн мэднэ; **я надеюсь, ~ ты напишешь письмо** чамайг захидал бичнэ гэж би найдаж байна; 3. бүхэн, бүр, тутам; ~ **ни день, растёт движение за мир** өдөр ирэх тутам энх тайвны хөдөлгөөн өсч байна; 4. ч...ч, ч тэр,...ч тэр; **мне безразлично — что у тебя, ~ у меня собраться** танайд ч цугласан, манайд ч цугласан над өөрцгүй.
ЧТОБ и ЧТО́БЫ 1. гэж, тул, тулд; **тороплюсь, ~ не опоздать на поезд** галт тэрэгнээс хоццохгүйн тул яарч байна; *2. хамт хэрэглэгдсэн үйл үгийг нь захирах хүсэх хэлбэртэй болгоно*; **~ этого больше не было!** ийм явдал дахин бүү гарга!
ЧТО-ЛИ́БО, ЧТО-НИБУ́ДЬ юм, нэг юм, ямар нэг юм; **взять ~ почитать** унших юм авах; **купи !** нэг юм худалдаж аваач.
ЧТО-ТО I нэг юм; ~ **приятное** нэг аятайхан юм; **чего-то хватает** нэг юм дутаад байна.
ЧТО́-ТО II 1. жаахан, нэг л **мне ~ нездоровится** бие нэг л эвгүй байна; 2. яагаад ч юм, яасан ч юм, нэг л; ~ **руки трясутся** гар нэг л салганаад байна.
ЧУ хүш, сонсооч; **~! по лестнице идут** хүш! шатаар хүн явж байна.
ЧУБ тав үс, самбай.
ЧУБА́РЫЙ цоохор.

ЧУБУ́К I гансны соруул.
ЧУБУ́К II (усан үзмийн) шилбэ.
ЧУВА́Ш чуваш хүн.
ЧУВА́ШКА чуваш эмэгтэй, чуваш эхнэр.
ЧУВА́ШСК||ИЙ чуваш, чувашийн; ~ **язык** чуваш хэл; ~**ая литература** чувашийн уран зохиол.
ЧУ́ВСТВЕНН||ЫЙ 1. мэдрэлийн, мэдрэхүйн, мэдрэх; ~**ое восприятие** мэдрэн хүртэх; 2. тачаангуй, биеэр амсах, бие махбодын; ~ **взгляд** тачаангуй харц.
ЧУВСТВИ́ТЕЛЬНОСТЬ 1. мэдрэц, эмзэг дотор, уян сэтгэл, уриалаг байх; 2. эмзэг байх, мэдээ, хөндүүр байх; 3. эмзэг байх, мэдрэц ихтэй байх; 4. мэдэгдэхүйн байх, чанга байх, хүчтэй байх; 5. сэтгэл уяруулах, сэтгэл хөдөлгөх.
ЧУВСТВИ́ТЕЛЬН||ЫЙ 1. сайн мэдрэх, эмзэг дотортой, уян сэтгэлтэй, уриалаг; ~ **ребёнок** эмзэг хүүхэд; 2. эмзэг, мэдээтэй, хөндүүр; ~**ые нервы** эмзэг мэдрэл; ~**ая зона** мэдрэх бүс; эмзэг нерв; ~**ое место тела** хөндүүр газар; ~ **порог** мэдрэх зааг; 3. эмзэг, мэдрэц ихтэй; ~ **прибор** эмзэг багаж; 4. мэдэгдэхүйц, дориун, чанга, хүчтэй; ~**ая разница** мэдэгдэхүйц ялгаа; ~ **мороз** дориун хүйтэн; 5. сэтгэл уярам, сэтгэл хөдөлмөр; ~ **романс** сэтгэл уярам уянгал дуу.
ЧУ́ВСТВО 1. мэдрэхүй, мэдрэл, мэдрэх; **органы чувств** мэдрэхүйн эрхтэн; 2. мэдээ, мэдрэл; **прийти в** ~ мэдрэл орох; **лишиться чувств** мэдээ алдах; 3. сэтгэл, мэдрэл; ~ **гордости за свою Родину** эх орноо бахдах сэтгэл; 4. сэтгэл, дурлах, хайр.
ЧУ́ВСТВОВАТЬ мэдэх, мэдрэх, ойлгох; ~ **свою вину** гэмээ мэдэх; ~ **голод** өлсөөнөө мэдрэх; ~ **музыку** хөгжим ойлгох.
ЧУ́ВСТВОВАТЬСЯ мэдэгдэх, харагдах, үзэгдэх.
ЧУГУ́Н I ширэм.
ЧУГУ́Н II ширмэн тогоо.
ЧУГУ́ННЫЙ ширмэн, ширмийн; ~ **горшок** ширмэн тогоо; ~**ое производство** ширмийн үйлдвэрлэл.
ЧУГУНОЛИТЕ́ЙНЫЙ ширэм цутгах; ~ **завод** ширэм цутгах үйлдвэр.
ЧУГУНОПЛАВИ́ЛЬНЫЙ ширэм хайлуулах.
ЧУДА́К хачин хүн, жигтэй хүн.
ЧУДАКОВА́ТЫЙ хачивтар, жигтэйвтэр.
ЧУДА́ЧЕСТВ||О хачин зан, жигтэй ааш; **брось свои** ~**а** хачин загнахаа боль.
ЧУДА́ЧКА хачин эмэгтэй жигтэй зантай эхнэр.
ЧУДЕСА́ гайхамшиг, гайхалтай юм.
ЧУДЕ́СНО гайхамшиг сайхан, гайхалтай сайхан.
ЧУДЕ́СН||ЫЙ 1. гайхамшигтай, гайхамшигт, гайхалтай сайхан; ~**ое спасение** гайхамшигтай аврагдах; 2. гайхамшиг сайхан, гайхалтай сайхан; ~ **день** гайхамшигтай сайхан өдөр.
ЧУДИ́ТЬ жигтэй загнах, дүрсгүйтэх.
ЧУ́ДИТЬСЯ үзэгдэх санагдах, сэтгэлд орох шиг болох.
ЧУ́ДИЩЕ хачин амьтан, мангас.
ЧУ́ДНО гайхамшигтай, гайхалтай; сонин.
ЧУДНО́ хачин жигтэй, гайхалтай; ~, **что такие вещи могут случаться** ийм юм тохиолддог нь хачин юм; **он** ~ **ведет себя** тэр(хүн) жигтэй аашилна.
ЧУДНО́Й хачин, жигтэй, гайхалтай, этгээд; ~ **человек** хачин хүн; этгээд хүн.
ЧУ́ДНЫЙ гайхамшигтай, гайхалтай, сайхан, хачин сайхан.
ЧУ́ДО 1. гайхамшиг, ирд, хувилгаан; **совершить** ~ гайхамшиг үзүүлэх; ~**м спастись от смерти** үхлээс гайхамшигтай аврагдах; 2. гайхамшиг, гайхамшигт үйл; ~ **искусства** урлагийн гайхамшиг; 3. гайхамшиг амьтан; ~ **морское** далайн гайхамшиг амьтан; 4. гайхалтай, гайхамшигтай; ~, **как было весело** хөгжөөнтэй байсан гэдэг нь гайхамшигтай; ~**-богатырь** гайхамшиг баатар.
ЧУДО́ВИЩЕ 1. гайхамшиг том амьтан, мангас; 2. ширүүн хэрцгий хүн, догшин харгис хүн, мангас.
ЧУДО́ВИЩНОСТЬ айхавтар байх, айхавтар сүрхий байх, аюултай хэрцгий байх; ~ **преступления** айхавтар гэмт хэрэг.
ЧУДО́ВИЩН||ЫЙ 1. айхавтар том, гайхамшиг том; ~ **зверь** айхавтар том амьтан; 2. айхавтар, айхавтар муухай, айхавтар сүрхий, аюултай хэрцгий; ~**ое преступление** айхавтар муухай гэмт хэрэг; 3. асар их, айхавтар том; ~**ые размеры** айхавтар том хэмжээ.
ЧУДОДЕ́ЙСТВЕНН||ЫЙ идтэй, ид шидтэй; ~**ое средство** ид шидтэй арга.
ЧУДОТВО́РНЫЙ гайхамшигтай ид шидтэй.
ЧУЖА́К 1. харийн хүн; 2. харш этгээд.
ЧУЖБИ́НА харь газар, хүний нутаг.
ЧУЖДА́ТЬСЯ зайлсхийх, дөлөх, бишүүрхэх; ~ **людей** хүнээс зайлсхийх; хүнээс бишүүрхэх.
ЧУ́ЖД||ЫЙ 1. харш, элэг бууруу, харийн; ~**ая идеология** харш үзэл суртал; ~ **элемент** элэг бууруу этгээд; 2. гэгчийг мэдэхгүй, гэгчээс хол; **человек,** ~ **зависти** атаархахыг мэдэхгүй хүн, атаархана гэгчээс хол хүн.
ЧУЖЕЗЕ́МЕЦ харь хүн, харийн хүн, хүний газрын хүн.
ЧУЖЕЗЕ́МКА харь эмэгтэй, харийн эмэгтэй, хүний нутгийн эмэгтэй.
ЧУЖЕЗЕ́МНЫЙ харь, харийн, хүний газрын; ~ **товар** хүний газрын бараа.
ЧУЖЕСТРА́НЕЦ харь газрын хүн.
ЧУЖЕСТРА́НКА харь нутгийн эмэгтэй.
ЧУЖ||О́Й 1. хүний, бусдын, харь, харийн, бус хүний; ~**ая сторона** харь нутаг; ~**ие вещи** хүний юм; **назваться** ~**им именем** хүний нэрээр өөрийгөө нэрлэх; 2. гаднын, хөндлөнгийн, харь бус хүний; ~**ие люди** гадны хүмүүс; хөндлөнгийн хүмүүс; 3. харш, элэг бууруу, хөндий хол; **они** ~**ие друг другу** тэд нэг нэгнээс хөндий байдаг; тэд бие биетэйгээ таардаггүй; 4. хүний юм; **взять** ~**ое** хүний юм авах; **с** ~**их слов** хүний амаар.
ЧУКО́ТСКИЙ чукчид, чукчдын.
ЧУ́КЧИ чукчид.
ЧУЛА́Н пин.
ЧУЛО́К оймс; **шерстяные чулки** ноосон оймс; **синий** ~ эрмэг эхнэр; номчирхог эм.
ЧУЛО́ЧН||ЫЙ оймсны; ~**ая фабрика** оймсны үйлдвэр.
ЧУМ урц.
ЧУМА́ тарваган тахал; ~ **бубонная** моомт тарваган тахал; ~ **верблюдов** гувруу; ~ **коз** годрон; ~ **крупного рогатого скота и свиней** мялзан; ~ **лошадей** сөдрөг; ~ **овец** хорхироо; ~ **птиц** шувууны тахал.
ЧУМА́ЗЫЙ хирэнд баригдсан, хар халтар; ~ **мальчик** хирэнд баригдсан хүү.
ЧУМНО́Й, ЧУ́МНЫЙ 1. (тарваган) тахлын; 2. (тарваган) тахалтай.
ЧУР 1. байз, биттий хүр, боль; ~ **меня** над биттий хүр! намайг боль! 2. болзол, хэлцээ; ~ **пополам!** болзоо ёсоор хагасы нь (өг!).
ЧУРА́ТЬСЯ цэрвэх, зайлсхийх, гирвэших.
ЧУРБА́Н 1. тайрдас; 2. тэнэг годил.
ЧУ́РКА тайранхай, тайрдас.
ЧУ́ТК||ИЙ 1. соргог, сонор, сэргэг; ~ **зверь** сэргэг амьтан, сонор амьтан; ~ **слух** соргог сонор; ~**ое ухо** сонор чих; ~ **сон** сэргэг нойр; 2. сортог, анддаггүй, сонор сэрэмжтэй, сонор, эмзэг; 3. өрөвч, зөөлөн сэтгэлтэй, анхааралтай, соргог; ~**ое сердце** өрөвч сэтгэл; ~ **человек** соргог хүн; өрөвч хүн.

ЧУ́ТКО 1. соргог, сонор, сэргэг, анхааралтай; ~ **спать** сэргэг унтах; 2. соргог, сонор сэрэмжтэй, сонор, анхааралтай; ~ **прислушиваться к событиям** байдлыг соргог чагнаж байх. 3. анхааралтай, соргог; ~ **относиться к кому-либо** хүнд анхааралтай хандах; соргог хандах.

ЧУ́ТКОСТЬ 1. соргог байх, сонор байх, сэргэг байх; ~ **слуха** соргог сонортой байх; 2. өрөвч байх, зөөлөн сэтгэлтэй байх, анхааралтай байх.

ЧУ́ТОЧКУ жаахан, өчүүхэн төдий, ялигүй; **подвинься** ~ жаахан цааш бол.

ЧУТЬ 1. арай, төдий, дөнгөж, арай мурий; ~ **больше** арай их; ~ **живой** амьдын төдий; 2. *магц(-мэгц,-мөгц,-иогц)*, дөнгөж, зэрэг; ~ **кто войдёт, услышу** хүн ормогц сонсоно; ~ **ли не** байж магадгүй, *шиг* байх; ~ (***было***) не арай л; ~ **что** шалихгүй юм болбол; ялихгүй ч юм гарсан; ~~ арай мурий; арай арай; өчүүхэн төдий.

ЧУТЬЁ 1. мэдэх чадвар, үнэр мэдэх; **собака с тонким ~м** үнэр мэдэхдээ сайн нохой, сайн үнэрч нохой; 2. зөн, төрөлх авьяас, зөгнөл, мэдрэл; ~ **языка** хэлний төрөлх авьяас.

ЧУ́ЧЕЛО 1. сатга, чихмэл; 2. мануухай.

ЧУШЬ тэнэг үг, дэмий юм; **нести** ~ дэмий юм чалчих.

ЧУ́ЯТЬ 1. үнэр авах, мэдэх; **собака чует дичь** нохой ангийн үнэр авчээ; 2. зөгнөх, зөгнөн мэдэх, таах, мэдэх; ~ **правду** үнэнийг тааж мэдэх.

Ш

ШАБЛО́Н 1. хэв, загвар, үлгэр; 2. нэг загвар, нэг хэв, дууриах; **работать по ~у** нэг загвараар ажиллах, бусдын загвараар ажиллах.

ШАБЛО́ННЫЙ 1. хэвээр цохисон, загвараар хийсэн, нэг хэвийн, нэг загварын; 2. нэг хэвийн, нэг загварын, дууриамал, дөжин болсон үг.

ША́ВКА гудамжны хав.

ШАГ 1. алхам, алхах; **сделать ~** (*нэг*) алхах; **отмерить ~ами** алхмаар хэмжих; 2. алхаа; **прибавить ~** алхаагаа нэмэх, түргэтгэх; 3. алхам, явдал; **правильный ~** зөв алхам, зөв явдал; **необдуманный ~** бодолгүй явдал; **на каждом ~у** алхам бүрд; **в нескольких ~ах, в двух ~ах** хэдхэн алхмын газар, ганц хоёр алхмын газар; **ни на ~ не отходить** алхам ч зайлахгүй; **ни ~у назад!** нэг ч алхам бүү ухар!; **первые ~и** анхны алхам; **сделать первый ~** анхны алхам хийх, эхлэх; **~ за ~ом** алхам алхмаар, хэлбэрэлтгүй; **ни ~у не сделать для кого- чего-либо** юу ч хийхгүй.

ШАГА́ТЬ 1. алхлах; **~ по дороге** замаар алхлах; 2. алхах, алхан гарах; **~ через порог** босго алхах.

ШАГА́ЮЩИЙ алхлагч; **~ экскаватор** алхлагч ухуур машин.

ШАГНУ́ТЬ алхах; **далеко ~ вперёд** их амжилт олох.

ША́ГОМ алхлан, алхалж, алхаад; **идти ~** алхлан явах; **~ марш!** алхаад марш!

ШАГРЕ́НЕВ||ЫЙ зогой ширэн; **~ая кожа** зогойн шир.

ШАГРЕ́НЬ зогой шир.

ШАЖО́К жижигхэн алхам; **идти мелкими шажками** жижигхэн алхмаар явах, шожиг шожиг алхлах.

ША́ЙБА I жийрэг даравч.

ША́ЙБА II хоккейн бөмбөг.

ША́ЙБА III (*разг.*) нүүр.

ША́ЙКА I бүлэг; **разбойничья ~** бүлэг дээрэмчин.

ША́ЙКА II хөнөг.

ШАЙТА́Н чөтгөр.

ШАКА́Л 1. цөөвөр чоно; 2. өөдгүй амьтан.

ШАКА́ЛИТЬ (*разг.*) тагнах, юм гуйх.

ШАЛА́ВА айхтар хүүхэн.

ШАЛА́Ш овоохой, хүрмэл гэр, гэр.

ШАЛИ́ТЬ томоогүй аашлах, дүрсгүйтэх, аалигүйтэх.

ШАЛМА́Н (*разг.*) архины газар

ШАЛОВЛИ́ВЫЙ томоогүй, дүрсгүй, аальгүй; **~ ребёнок** томоогүй хүүхэд.

ША́ЛОСТЬ томоогүй зан, дүрсгүй явдал, аалигүйтэх.

ШАЛУ́Н томоогүй хүү, дүрсгүй хүү, аалигүй хүү.

ШАЛУ́НЬЯ томоогүй охин, дүрсгүй охин, аалигүй охин.

ШАЛФЕ́Й шар дэр, мөгөв.

ШАЛЬ их алчуур.

ШАЛЬН||О́Й галзуу, хийтэй, сагсуу; **~ые ребята** хийтэй залуус, сагсуу залуус; **~ая пуля** зэрлэг сум, тэнэсэн сум.

ШАМА́Н бөө, зайран.

ШАМА́НИТЬ бөөлөх, бөө буух, удгалах.

ШАМА́НКА удган.

ШАМА́НСКИЙ бөөгийн.

ШАМА́НСТВО бөөгийн мөргөл, бөөгийн шашин.

ША́МКАТЬ аман дотроо бувтнах.

ШАМПА́НСКОЕ шампан дарс.

ШАМПИНЬО́Н өндгөн мөөг.

ШАНС боломж, магадын хувь; **иметь все ~ы на успех** амжилт олох боломж бүрэн байх.

ШАНТА́Ж илчлэхээр айлгах.

ШАНТАЖИ́РОВАТЬ илчлэхээр айлгах.

ШАНТАЖИ́СТ илчлэхээр айлгагч.

ШАНХА́Й борчуудын амьдардаг газар, овоохой.

ША́НЦЕВЫЙ малтах; **~ инструмент** малтах зэвсэг.

ША́ПК||А малгай; **меховая ~** үстэй малгай; **на воре ~ горит** гэмт хүн гилбэлзэнэ; **~ волос, волосы ~ой** өтгөн үс.

ША́ПОЧКА бяцхан малгай.

ША́ПОЧНИК малгайчин.

ША́ПОЧН||ЫЙ малгайн; **приходить к ~ому разбору** сүүл дарж ирэх.

ШАР бөмбөрцөг, бөмбөг, **воздушный ~** агаарын бөмбөрцөг; **земной ~** дэлхийн бөмбөрцөг; **хоть ~ом покати** мэлгэн, юу ч үгүй хоосон; **~ загнать** хүүхэн цохих.

ШАРАБА́Н хөндлөн суудалтай тэрэг, хоёр дугуйтай тэрэг.

ШАРА́ДА үгийн оньсого.

ШАРА́ХАТЬ архи уух.

ШАРА́ХАТЬСЯ ухасхийн зайлах, бусгах; **~ в сторону** хажуу тийш ухасхийн зайлах.

ШАРЖ шог зураг; **дружеский ~** нөхөр ёсны шог зураг.

ШАРЖИ́РОВАТЬ шоолон зурах, элэглэн наадах, элэглэх.

ША́РИК 1. мөхлөг, үрэл, жинс; **~и для подшипников** эргэвчийн мөхлөг; 2. бөөм; **кровяные ~и** цусны бөөм.

ША́РИКОВЫЙ мөхлөгт; **~ подшипник** мөхлөгт эргэвч; 2. (*разг.*) ойлгох, гадарлах.

ШАРИКОПОДШИ́ПНИК мөхлөгт эргэвч, холхивч.

ША́РИТЬ тэмтрэн эрэх, уудлах; **~ в карманах** халаасаа уудлах

ША́РКАТЬ шир шир хийлгэх, шар шур хийлгэх **~ ногами** гутлаа шар шур хийлгэх, хөлөө чирэх.

ШАРЛАТА́Н мэхч, хуурагч, луйварчин.

ШАРЛАТА́НСКИЙ мэхлэх, хуурах.

ШАРМА́НКА 1. баян хуур; 2. (*разг.*) хөгжмийн хэрэгслэл

ШАРМА́НЩИК баян хуурч.

ШАРНИ́Р нугас, **на ~ах** нугастай.

ШАРОВА́РЫ шалбуур өмд, шарваар өмд.

ШАРОВИ́ДН||ЫЙ бөмбөрцөг хэлбэртэй, бөмбөгөн хэлбэртэй, бөөрөнхий (*хэлбэртэй*), бөндгөр; **~ая опухоль** бөндгөр хавдар уран хавдар.

ШАРОВ||О́Й бөмбөрцгийн, бөмбөгийн, бөмбөлгөн, бөөрөнхий, бөмбөгөр, бөмбөгөн; **~ая молния** бөмбөгөн цахилгаан.

ШАРООБРА́ЗНЫЙ бөмбөрцөг дүрстэй, бөмбөгөн хэлбэртэй, бөөрөнцөг маягтай, бөөрөнхий.

ШАРФ хүзүүний ороолт.

ШАРЫ́ төмсөг; **~ гонять** гар хангалга хийх; **~ залить** үхтлээ архи уух.

ШАССИ́ 1. (*машины*) арал анги; 2. (*нисэх онгоцны*) дугуй, цана, хөвүүр.

ШАТА́НИ||Е 1. холхих, хөдлөх, найгах, гуйвах; 2. сэлгүүцэх, тэнэх, хэсүүчлэх; **бесцельное ~ по улицам** гудамжаар дэмий сэлгүүцэх; 3. гуйвах; **идейные ~я** үзэл суртлын талаар гуйвах.

ШАТА́||ТЬ 1. холхиулах, хөдөлгөх, ганхуулах, найгуулах, гуйвуулах; **~ столб** шон холхиулах, хөдөлгөх; 2. найгах, гуйвах, ганхах; **его ~ет из стороны в сторону** тэр (*хүн*) ийш тийшээ найгана.

ШАТА́||ТЬСЯ 1. холхих, хөдлөх, ганхах, найгах, гуйвах; **зуб ~ется** шүд хөдөлж байна; 2. сэлгүүцэх, тэнүүчлэх, хэсүүчлэх; ~ **по городу** хотоор тэнүүчлэх; 3. гуйвах, зарчимгүй байх.
ШАТЁН элгэн хүрэн үстэй хүн.
ШАТЁНКА элгэн хүрэн үстэй эмэгтэй.
ША́ТК||ИЙ 1. холхисон, хөдөлдөг, ганхдаг, найгасан, гуйвганасан, суурь муутай, ~ **стол** ганхдаг ширээ, суурь муутай ширээ; **~ая походка** гуйвганасан явдал; 2. итгэлгүй, батгүй, тогтворгүй; **~ое положение** тогтворгүй байдал; **~ие принципы** тогтворгүй зарчим.
ШАТУ́Н I сэжлүүр.
ШАТУ́Н II сэлгүүцэгч, хэсүүчлэгч.
ШАФРА́Н гүргэм, шафран алим.
ШАФРА́ННЫЙ алтлаг.
ШАХ I шаг (*хаан*).
ШАХ II шаг; **объявить ~ королю** ноёныг шалах, шаглах.
ШАХМАТИ́СТ шатарч
ШАХМАТИ́СТКА шатарч эмэгтэй.
ША́ХМАТН||ЫЙ шатрын, **~ая доска** шатрын хөлөг; **в ~ом порядке** шатарчлан.
ША́ХМАТЫ шатар; **играть в ~** шатар тавих, тоглох.
ША́ХТА уурхай; **каменноугольная ~** чулуун нүүрсний уурхай.
ШАХТЁР уурхайч.
ШАХТЁРСК||ИЙ уурхайчны, уурхайчдын; **~ая лампа** уурхайчны дэн; **~ посёлок** уурхайчдын тосгон.
ША́ШЕЧН||ЫЙ даамын; **~ая доска** даамын хөлөг.
ШАШИ́СТ даамч.
ША́ШКА I сэлэм.
ША́ШКА II даам, мягман.
ША́ШКА III дэр мод.
ША́ШКИ даам; **играть в ~** даам тоглох, тавих.
ШАШЛЫ́К шорлог, шарсан мах.
ШВА́БРА шүүр.
ШВАРТОВА́ТЬ эрэгт тулах, аргамжих.
ШВЕД швед хүн.
ШВЕ́ДКА швед эмэгтэй.
ШВЕ́ДСК||ИЙ швед, шведийн; **~ язык** швед хэл; **~ая литература** шведийн утга зохиол.
ШВЕ́ЙН||ЫЙ, оёдлын; **~ая машина** оёдлын машин.
ШВЕЙЦА́Р хаалгач, үүдэч, үүдний хүн.
ШВЕЙЦА́РЕЦ швейцар хүн.
ШВЕЙЦА́РКА швейцар эмэгтэй, швейцар эхнэр.
ШВЕЙЦА́РСКИЙ I швейцарын, швейцар.
ШВЕЙЦА́РСКИЙ II хаалгачийн, үүдчийн үүдний хүний.
ШВЕЯ́ үйлчин эхнэр, оёдолчин эмэгтэй.
ШВО́НДЕР *(разг.)* еврей.
ШВО́РЕНЬ нугас төмөр, гацаа төмөр.
ШВЫРКО́В||ЫЙ хөрөөдсөн, хэрчсэн; **~ые дрова** хэрчсэн түлээ, хэрчим.
ШВЫРНУ́ТЬ шидэх, чулуудах, хаях.
ШВЫРО́К 1. шидэх, чулуудах; 2. хэрчсэн түлээ, хэрчим, хөрөөдсөн түлээ.
ШВЫРЯ́ТЬ 1. шидэх, шидлэх, чулуудах, хаях, хаялах ~ **камни (камнями)** чулуу (чулуугаар) шидэх, чулуудах; 2. үрэх, үрэн таран хийх; ~ **деньгами** мөнгө үрэх.
ШВЫРЯ́ТЬСЯ 1. шидэлдэх, чулуудалдах, шидэлцэх, чулуудалцах, бие биеэ чулуудах, бие биерүүгээ шидэлдэх; 2. үрэх, үрэн таран хийх.
ШЕВЕЛИ́ТЬ хөдөлгөх; ~ **губами** уруулаа хөдөлгөх; ~ **мозгами** бодох, эрэгцүүлэн бодох.
ШЕВЕЛИ́ТЬСЯ хөдлөх **листья шевелятся** навчис хөдөлнө.
ШЕВЕЛЬНУ́ТЬ хөдөлгөөн хийх **пальцем не ~** жишим хийхгүй байх.
ШЕВЕЛЬНУ́ТЬСЯ хөдлөхийх.
ШЕВЕЛЮ́РА толгойн үс; **пышная ~** сагсайсан үс.
ШЕВИО́Т шевиот даавуу.
ШЕВИО́ТОВЫЙ шевиот, шевиотоор хийсэн ~ **костюм** шевиот хувцас.
ШЕВРО́ торгон савхи, шевро.
ШЕВРО́В||ЫЙ торгон савхин, шевро торгон савхиар хийсэн, шеврогоор хийсэн; **~ые сапоги** торгон савхин гутал, шевро гутал.
ШЕДЕ́ВР эрхэм дээж.
ШЕ́ЙКА 1. бяцхан хүзүү, хүзүүхэн; 2. хоолой, хүзүү, нарийн хэсэг, шувтан тал, онги.
ШЕ́ЙН||ЫЙ хүзүүний; **~ые позвонки** хүзүүний үе, хүзүүний яс.
ШЕ́ЛЕСТ сэржигнэх чимээ, сэрчигнээн, шарчигнах авиа, ~ **листьев** навчсын сэрчигнээн.
ШЕЛЕСТЕ́ТЬ сэржигнэх, шарчигнах, сарчигнах, шаржигнах, шар шүр гэх.
ШЁЛК1. торгон утас; торго; **платье из ~а** торгоор хийсэн хувцас; торгон хувцас; 3. торго, торгон хувцас; **ходить в шелках** торго өмсөх; **в долгах, как в шелках** *толгойтой үснээсээ их өртэй.*
ШЕЛКОВИ́НА мяндас
ШЕЛКОВИ́СТЫЙ торгомсог, торголог, мяндаслаг.
ШЕЛКОВИ́ЦА ялам мод.
ШЕЛКОВИ́ЧНЫЙ торгоны; ~ **червь** торгоны хорхой, хүр хорхой.
ШЕЛКОВО́ДСТВО 1. хүр хорхой үржүүлэх, хүр хорхойн аж ахуйн; 2. торго үйлдвэрлэх, торгоны үйлдвэр.
ШЁЛКОВ||ЫЙ 1. торгоны, торгон; **~ая ткань** торгон нэхмэл; 2. номхон, дуулгавартай; **он стал ~ым, он стал, как ~** тэр хүн *номхроод өгөв,* дуулгавартай болов; ~ **путь** торгон зам.
ШЁЛКОПРЯ́Д хүр хорхой.
ШЁЛКОПРЯ́ДИЕ торго ээрэх.
ШЁЛКОПРЯДИ́ЛЬН||ЫЙ торго ээрдэг; **~ая машина** торго ээрдэг машин.
ШЁЛКОТКА́ЦК||ИЙ торго нэхэх, **~ая фабрика** торго нэхэх үйлдвэр.
ШЕЛОХНУ́ТЬ хэлбэгэсхийлгэх, хөдлөсхийлгэх.
ШЕЛУДИ́ВЕТЬ түүхийрэх.
ШЕЛУДИ́ВЫЙ түүхийтэй, хамуутай; ~ **пёс** хамуутай нохой.
ШЕЛУХА́ 1. хальс; **картофельная ~** төмсний хальс; 2. бүрхэвч; **словесная ~** бүрхэвч үг, хэрэггүй үг.
ШЕЛУШЕ́НИЕ хогжрох, хоцрох, хуурах; ~ **кожи** арьс хогжрох.
ШЕЛУШИ́ТЬ хальслах, хальс арилгах.
ШЕЛУШИ́||ТЬСЯ хогжрох, холцрох, холцруутах, хураах; **кожа на лице ~тся** нүүр холцруутав.
ШЁЛЬМА мэхч, луйварчин
ШЕЛЬМЕ́Ц мэхч, луйварчин.
ШЕЛЬМОВА́ТЬ гутаах, нэр бузарлах.
ШЕПЕЛЯ́ВИТЬ тальтраа хэлэх, тальтрах.
ШЕПЕЛЯ́ВО тальтран.
ШЕПЕЛЯ́ВЫЙ тальтраа хэлтэй, ~ **старик** тальтраа хэлтэй өвгөн.
ШЕПНУ́ТЬ шивнэх, шивэн хэлэх; ~ **на ухо** чихэнд шивнэх.
ШЁПОТ 1. шивнээн, шивнэх, шивгэнэх; 2. шоржигноон, шоржигнох; ~ **ручья** горхины шоржигнох.
ШЕПТА́ЛО *(разг)* хамт цагийн орчуулагч, киноны орчуулагч.
ШЕПТА́ТЬ шивгэнэх, шивнэх, шивэр авир гэх, шивэр шавир гэх.

ШЕПТА́ТЬСЯ шивгэнэлдэх, шивнэлдэх, шивэр авир гэлдэх, шивэр шовор гэлдэх.
ШЕПТУ́Н шивнүүр, шивнээч.
ШЕРЕ́НГ||А эгнээ; **идти ~ами** эгнээ эгнээгээр явах.
ШЕРОХОВА́Т||ЫЙ 1. арзгар, барзгар, биржгэр, барчгар, адруу, будруу, өөтэй, овон товонтой; **~ая бумага** барзгар цаас; **~ пол** овон товонтой шал; 2. адраатай; өөтэй; цөвтэй; **~ая речь** адраатай үг; өөтэй үг.
ШЕРСТЕОБРАБА́ТЫВАЮЩ||ИЙ ноос боловсруулах; унгас боловсруулах; **~ие предприятия** ноос боловсруулах үйлдвэр.
ШЕРСТИ́НКА ширхэг үс; ноосны ширхэг; унгасны ширхэг.
ШЕРСТИ́ТЬ загнах, лүндэн буулгах.
ШЁРСТНОСТЬ ноосны чанар; ноослог.
ШЁРСТНЫЙ ноосон; унгасан.
ШЕРСТОБИ́Т унгас савагч.
ШЕРСТОБИ́ТН||ЫЙ унгас савах; ноос савах; **~ая работа** ноос савах ажил.
ШЕРСТОБО́Й унгас савагч.
ШЕРСТОБО́ЙНЫЙ унгас савах; ноос савах.
ШЕРСТОБО́ЙНЯ унгас савах газар; ноос савуурь.
ШЕРСТОМО́ЙКА 1. ноос угаагуур машин; унгас угаах машин; 2. ноос угаагуур; унгас угаах газар.
ШЕРСТОНО́СНЫЙ ноосны; унгасны; ноослог.
ШЕРСТОПРЯДЕ́НИЕ ноос ээрэх унгас томох.
ШЕРСТОПРЯДИ́ЛЬН||ЫЙ ноос ээрэх; унгас томох; **~ая фабрика** унгас ээрэх үйлдвэр.
ШЕРСТОПРЯДИ́ЛЬНЯ ноос ээрэх газар; унгас томуурь.
ШЕРСТОТКА́ЦК||ИЙ ноос нэхэх; унгас нэхэх; **~ая фабрика** ноос нэхэх үйлдвэр.
ШЕРСТОТКА́ЧЕСТВО ноос нэхэх; унгас нэхэх.
ШЕРСТ||Ь 1. унгас ноос; үс; **густая ~** өтгөн ноос, өтгөн унгас; **~ стриженная** хяргасан үс; 2. ээрсэн унгас; ээрсэн ноос; ээрсэн утас; **вязать чулки из ~и** ээрсэн унгасаар оймс сүлжих; 3. ноосон нэхмэл; унгасан даавуу; **против ~и** 1) үсгийг нь сөргөн; 2) зөрөн.
ШЕРСТЯ́НКА ноос шиг бөс.
ШЕРСТЯН||О́Й ноосны; унгасны; ноослог; ноосон; унгасан; **~ая промышленность** ноосны үйлдвэр; **~ая овца** ноосны хонь; **~ые чулки** ноосон оймс.
ШЕРША́ВЕ||ТЬ ширүүн болох; иржийх; баржийх; аржийх; хөрзийх; **руки ~ют от холода** даарахад гар ширүүн болдог.
ШЕРША́ВЫЙ 1. ширүүн, иржгэр, баржгар, аржгар, хөрзгөр; 2. *(разг)* эрэгтэй хүний бэлэг эрхтэн.
ШЕ́РШЕНЬ бөхгөнө; зөгий.
ШЕСТ урт мод; уурга.
ШЕ́СТВИЕ жагсаал; **первомайское ~** майн нэгний жагсаал.
ШЕ́СТВОВАТЬ зорчих; зорчин явах; залрах.
ШЕСТЕРЁНКА бяцхан араа.
ШЕСТЁРКА 1. зургаа, зургаан тоо; 2. зургаат, зургаа; **~ червей** бундангийн зургаа.
ШЕСТЕРНЯ́ араа, араат дугуй; **ведущая ~** хөтөч араа; **ведомая ~** хөтөлгөө араа.
ШЕ́СТЕРО зургаан, зургаан хос; **~ человек** зургаан хүн.
ШЕСТИГРА́ННЫЙ зургаан талтай, зургаан цамцаалтай, зургаадай.
ШЕСТИДЕСЯТИЛЕ́ТИЕ 1. жаран жил; 2. жаран жилийн ой, жаран насны ой.
ШЕСТИДЕСЯТИЛЕ́ТНИЙ жаран жилийн, жаран насны, жаран настай, жартай; **~ человек** жаран настай хүн; **~ юбилей** жаран жилийн ой; жаран насны ой.
ШЕСТИДЕСЯ́ТЫЙ жардугаар, жардахь.
ШЕСТИДНЕ́ВНЫЙ зургаан хоногийн, зургаан өдрийн.
ШЕСТИКРА́ТН||ЫЙ зургаа нугалсан, зургаан давхар, зургаа дахин үржүүлсэн; **в ~ом размере** зургаа нугалсан хэмжээгээр.
ШЕСТИЛЕ́ТИЕ 1. зургаан жил; 2. зургаан жилийн ой.
ШЕСТИЛЕ́ТНИЙ зургаан жилийн, зургаан насны, зургаан настай, зургаатай; **~ ребёнок** зургаатай хүүхэд.
ШЕСТИМЕ́СЯЧНЫЙ зургаан сарын, зургаан сартай.
ШЕСТИПА́ЛЫЙ зургаан хуруутай.
ШЕСТИСОТЛЕ́ТИЕ 1. зургаан зуун жил; 2. зургаан зуун жилийн ой.
ШЕСТИСОТЛЕ́ТНИЙ зургаан зуун жилийн.
ШЕСТИСО́ТЫЙ зургаан зуудугаар, зургаан зуудахь; **~ мерседес** бух бенц.
ШЕСТИУГО́ЛЬНЫЙ зургаан өнцөгтэй.
ШЕСТИЭТА́ЖНЫЙ зургаан давхар; **~ дом** зургаан давхар байшин.
ШЕСТНАДЦАТИЛЕ́ТН||ИЙ арван зургаан настай, арван зургаатай; **~ая девушка** арван зургаатай охин.
ШЕСТНА́ДЦАТ||ЫЙ арван зургадугаар, арван зургаадахь, арван зургааны, арван зургаан; **~ год** арван зургадугаар он, арван зургаан он; **~ая часть** арван зургааны нэг хувь.
ШЕСТНА́ДЦАТЬ арван зургаан.
ШЕСТО́Й зургадугаар, зургаадахь, зургааны, зургаан; **шестая страница** зургадугаар хуудас; **шестое января** нэгдүгээр сарын зургаан.
АЗ счастье, удача, ~ **жаргал** *парн.* счастье, ~ **хийморь** фортуна, ~ **болох/дайрах** посчастливиться, удаться, ~ **нь гозойх** быть везучим, быть любимчиком фортуны, ~ **дутах** нет удачи, не везёт, **~аа үзэх/~ сорих** пытать счастья, ~ **туршилт** риск, **~ны юм** *присказка:* «слава-те господи», **~ эз хоёроо үзэх** пытать счастья

АЗАЙ: ~ **буурал** серебристая седина, седой, старый, ~ **буурал ээж минь** моя седовласая мать, ~ **буурлууд** старики, старцы

АЗГҮЙ несчастливый, неудачливый, несчастный, незадачливый, ~ **явдал/хэрэг** неудача

АЗГҮЙДЭХ быть неудачливым, не иметь счастья, быть несчастливым

АЗГҮЙТЭХ становиться несчастливым, оказаться неудачливым

АЗИ Азия, **Дундад ~** Средняя Азия, **~ийн хөгжлийн банк** Азиатский банк развития

АЗНАХ ждать, поджидать, повременить, **явахаа жаахан ~ая** подождём с поездкой, *отложим поездку на время*, **түр ~ая** подождём немного, отложим на время

АЗРАГА 1) жеребец, 2) в сочетании с названиями животных означает самец, ~ **үрээ** трёхгодовалый жеребец, **агталсан/хөнгөлсөн ~** кастрированный жеребец, **~нд гишгүүлэх** а) быть покрытым жеребцом, покрываться жеребцом, б) случная кампания, **~н бороо** ливень, сильный дождь, **хүрэн (бор) ~** *шутл.* половой член, **хүрэн ~аа услуулах** окунуть, напоить жеребца, *букв.* «трахнуть кого-либо»

АЗРАГАЛАХ 1) собирать кобылиц, покрывать кобылу, 2) *перен.* командовать, распоряжаться, петушиться, властвовать

АЗРАГАСАХ проситься к жеребцу, **гүү ~на** кобыла просится к жеребцу

АЗТАЙ счастливый, удачливый, ~ **хүн** счастливец, удачник, ~ **явдал/тохиолдол** счастливый случай

АЗТАН счастливец, победитель в лотерее

АЙ 1. *междометие, выражающее различные модальные оттенки огорчения, сожаления, досады, чувства облегчения, удивления и т.п.* **~, халаг** ах горе, **~, яанаа** ой, что делать, **~, мөн гоё** ах, как прекрасно, **~, хөөрхий** ой, бедняга

АЙ 2. категория, **хэлзүйн ~** грамматическая категория

АЙ 3. бесчисленное множество, ~ **түмэн адуутай** имеющий очень много лошадей/неисчислимое множество лошадей

АЙВАН: ~ **тайван** спокойно, мирно, в спокойной обстановке, ~ **тайван ярьж суух** сидеть и беседовать в мирной/спокойной обстановке

АЙВУУ: ~ **тайвуу** *парн.* спокойный, спокойно, ~ **тайвуу явах** идти спокойно/тихо

АЙДАС страх, боязнь, ужас, ~ **хүрэх** становиться страшно, бояться, страшиться, ~ **төрүүлэх** рождать ужас, страх, ~ **хүрснээс чичрэх** дрожать от страха, ~ **хүрмээр** ужасающий, вызывающий страх, **~ын кино** фильм ужаса, **~аа авдартаа хийх** забывать о своих страхах

АЙЗАМ такт, ритм, темп, **~аас гажих/зөрөх, ~ алдагдах** сбиться с такта, **монгол шүлгийн ~** ритм монгольского стиха

АЙЛ семейство, семья, группа юрт, дом, ~ **өрх/~ гэр** семья, дом, двор, **~ын эзэн** хозяин дома, глава семьи/семейства, **~ын ганц** единственный ребёнок в семье, ~ **гэр болох** обзаводиться семьей, жениться, ~ **зэргэлдээ /~ хөрш суух** жить по соседству, **~аас эрхээр авдраа уудал** *чем искать у соседей, поищи лучше в своём сундуке*, ~ **саахалт** соседи (в сельской местности), **~ын хажууд амьдрах, ~ын кармааны өрөөнд суух** жить с подселением, снимая комнату/угол

АЙЛГАХ наводить страх, устрашать, пугать, **~н сүрдүүлэх** терроризировать, угрожать, устрашать, **~аад авах** припугнуть

АЙЛДАХ изволить говорить, изрекать, соизволить

АЙЛТГАЛ назидательное поучение/указание, почтительная просьба, доклад, рапорт, ходатайство

АЙЛТГАХ доводить до сведения, уведомлять, докладывать, рапортовать («наверх», уважаемому лицу), **амрыг ~** посылать приветствие, почтительно приветствовать, **~н заалдагч** аппелянт

АЙЛТГҮЙ нечего бояться/беспокоиться, не к чему бояться/тревожиться, не стоит бояться, не бойся, **чи энэ талаар ~** ты не беспокойся об этом

АЙЛЧИН гость, гости, гостья, ~ **гийчин** *парн.* гости

АЙЛЧЛАЛ визит, **засгийн төлөөлөгчдийн ~** визит правительственной делегации, **албан ёсны нөхөрсөг ~** официальный дружественный визит, **ажлын түр ~** кратковременный рабочий визит

АЙЛЧЛАХ гостить, ходить/ездить в гости, быть в гостях, **ноён Токаев тэргүүтэй төлөөлөгчид манай оронд ~в** делегация во главе с господином Токаевым находилась в нашей стране с визитом, **~н тоглох** *гастроли*

АЙМАГ 1) аймак (административная единица), 2) раздел, вид, мир, 3) части речи *лингв.* **амьтны ~** животный мир, фауна, **нарны ~** солнечная система, **ургамлын ~** растительный мир, флора, **Халхын дөрвөн ~** четыре аймака Халхи

АЙМАГЛАХ группировать, разделять, собирать (по родам, признакам и др.), районировать, **газар орныг муж болгон ~** разделить территорию на области, **~н хядах/~н устгах бодлого** геноцид

АЙМААР страшный, опасный, внушающий чувства страха, страшно, опасно, ~ **санагдах/харагдах** казаться/оказаться страшным, **бодохоос ч ~** страшно даже подумать, **яасан ~ юм бэ!** как страшно, как ужасно!

АЙМТГАЙ трусливый, боязливый, пугливый, робкий

АЙМХАЙ боязливый, пугливый, трусливый, неуверенный, робкий, **чи ямар ~ юм бэ!** какой ты трусливый! ~ **хүн арав үхнэ** *погов.* трус умирает десять раз, ~ **мөөрс** мечевидный отросток

АЙМШИГ страх, ужас, боязнь, опасность

АЙМШИГТҮЙ бесстрашный, неустрашимый, смелый, отважный, храбрый

АЙМШИГТ (ай) страшный, странный, ужасный, жуткий, грозный, ~ **үзэгдэл** ужасающее зрелище, страшное явление

АЙРАГ айрак, кумыс, ~ **цагаа/~ тараг/тараг** ~ *парн.* айрак и тому *подобные, молочные продукты*, ~ **бүлэх/хийх** *производить/делать* айраг/кумыс, заквасить молоко/айрак, ~ **бүлэх** пахтать/взбивать айрак/кумыс, **~ийн эмнэлэг/эмчилгээ** кумысолечебница, кумысолечение, **~ны архи** водка из айрака, водка из

заквашеного кислого молока, ~ **сацаж мялаах** окропить айраком, кумысом

АЙСУЙ идёт, идут, едет, еду (по направлению к говорящему), приближаются, приближается, **галт тэрэг** ~ поезд приближается

АЙХ бояться, пугаться, страшиться, опасаться, робеть, **~/~ж ичих** бояться, робеть, стесняться, **~ж мэгдэх/~н сандрах** паниковать, **~н чичрэх** дрожать от страха, **~сан янзтай/байдалтай** испуганный вид, с испуганным видом, **~хыг мэдэхгүй** не знающий страха, храбрый, **үхэхээс ~ хэрэгтүй, үгнээс ~ хэрэгтэй** *посл.* не страшись смерти, а бойся слов!, **биттий ай л даа** не бойся, не бойтесь, **та ~ явдалгүй** вам нечего бояться, **эмэгтэй хүн насандаа ганцхан л удаа** ~ женщина боится лишь раз в жизни

АЙХТАР страшный, ужасный, страшно, ужасно, очень, чрезвычайно, ~ **зовлон** ужасная мука, ~ **өвчин** страшная/серьёзная болезнь, **Та яасан ~ хүн бэ!** Какой Вы страшный человек! ~ **баяжих** сильно разбогатеть

АЙХГҮЙ не знающий страха, смелый, храбрый, безбоязненный, **~гээ авдрандаа хийх** опасность позади, теперь нечего бояться, дело в шляпе

АКАДЕМИ академия, академический, **Шинжлэх ухааны** ~ Академия наук, **Нийгмийн ухааны** ~ Академия общественных наук, **~ийн жинхэнэ/сурвалжлагч гишүүн** действительный член/член-корреспондент академии наук

АКАДЕМИЧ академик

АККУМЛЯТОР (хумлятор), аккумулятор, ~ **цэнэглэх** зарядить аккумулятор

АКТ акт, **эмнэлгийн** ~ больничный лист, листок нетрудоспособности, бюллетень, ~ **гаргах/тогтоох** составлять акт

АКТЛАХ составлять акт (о негодности чего-либо), списывать

АЛ 1. *усилительная частица к слову улаан:* ~ **улаан** красный, алый, ярко-красный

АЛ 2. ляжка (с внутренней стороны), половой орган женщины, срамная часть тела, срам, **ам бардан, ~ шалдан** *погов.* уста важные, а ляжка голая, много амбиции, да мало амуниции

АЛААН: ~ **хядаан** бойня, побоище, резня

АЛАГ 1. пёстрый, полосатый, разноцветный, пегий, ~ **морь** пегий конь, ~ **цоохор хувцас** разноцветная одежда, ~ **үр минь** дитя моё, дети мои, ~ **хорвоо** белый свет, ~ **үзэх** покровительствовать кому-либо, выделять кого-либо (в ущерб другим), быть односторонним/предвзятым, быть тенденциозным, протежировать комунибудь, ~ **бөөрний сүлбээтэй/холбоотой** связанный кровными узами, ~ **мэлхий** – название игры

АЛАГ 2.: ~ **цоохор үнээ** рябая корова, ~ **өнгөт хурдас** пестроцветы

АЛАГДААХАЙ тушканчик

АЛАГДАХ *страд. от* **алах**, быть убитым/мёртвым, погибнуть, **~сан цэрэг** убитый солдат

АЛАГЛАХ 1) испещрять, делать что-либо пёстрым/полосатым, 2) пестреть, пестреться, виднеться (о чем-нибудь пестром или о предметах разного цвета), **хээр талд цэцэгс ~на** степь пестреет цветами

АЛАГТАХ покрываться пестротой/пестринами, становиться более пестрыми, пестреться, делаться пестрыми/полосатыми

АЛАГЧ пёстрая, пеструха, пегая (о масти самок животных), ~ **үүр/үнээ** пегая кобыла/корова

АЛАГЧЛАХ пристрастно относиться, быть пристрастным/предвзятым/тенденциозным, несправедливо покровительствовать, протежировать, ~ **бодлого** протекционистская политика, ~ **үзэл/явдал** покровительство, тенденциозность, протекционизм

АЛАЛДААН кровопролитие, взаимное истребление, резня, бойня, побоище, грызня, убийство (в бою, схватке, драке)

АЛАЛДАХ 1) сражаться, убивать друг друга, биться, драться, 2) очень кропотливо заниматься чем-нибудь, возиться, сильно желать/хотеть достичь чего-либо, **эрдэм сурахын төлөө** ~ изо всех сил стараться познавать, **зорьсондоо/зорилгодоо хүрэхийн төлөө** ~ во что бы то ни было достичь своей цели

АЛАХ убивать, резать, забивать(скот), **~ж талах** убивать, грабить, ~ **ял** смертный приговор, **~н хядагч** террорист

АЛБА (н) 1) служба, обязанность, миссия, 2) налог, повинность, 3) официальный, **улсын** ~ государственная/общественная служба, **цэргийн** ~ военная служба, **цэргийн** ~ **хаах** быть на военной службе, ~ **хаах/хаших** выполнять/нести службу, служить, **~н байгууллага** учреждение, **~н хэргээр** по делам службы, **харуулын** ~ караульная служба, **~н бичиг** официальная бумага, **~н мэдээ** официальное сообщение, коммюнике, **~н паспорт** служебный паспорт, **~н үүрэг** служебная обязанность, **~н тушаал** должность, **~н хариуцлага** ответственность, **~н татвараас чөлөөлөх** освобождать от налогов, **~наас/~н тушаалаас чөлөөлөх/огцруулах** освобождать/увольнять от службы/от занимаемой должности, **~н хэрэгцээнд** для служебного пользования, **~аар/~н ёсоор** официально, **~н дайчилгаа** повинность, **~н ёсны бус журмаар** в неофициальном порядке, **~н ёсны жагсаалт** регистр, официальный список, **~н ёсны мэдээлэл** официальное сообщение, **~н ёсны няцаалт** официальное опровержение, **~н ёсны тайлан** официальный отчёт, **~н ёсны тайлбар** официальное разъяснение, толкование, **~н ёсны төлөөлөгч** официальный представитель, **~н ёсны харилцаа** официальные отношения, **~н ёсны эсэргүүцэл** официальный протест, ~ **өнгөрөөх** выполнять что-либо формально, для отвода глаз

АЛБААР нарочно, нарочито, умышленно, неслучайно, специально, **тэр намайг ~ тийш нь явуулсан юм** он нарочно отправил меня туда, ~ **саатуулах/саад хийх** нарочно помешать, умышленно задерживать

АЛБАДАХ принуждать, заставлять, вынуждать, **хүчээр ~/~н шахах** силой заставить, силою побудить к чему-нибудь, **яв гэж/явахыг** ~ заставить/принудить кого-либо уйти/уехать, **~н** *юрид.* принудительно, **~н саатуулах** *юрид.* задержание, **~н авах** *юрид.* принудительное отчуждение, **~н биелүүлэх** *юрид.* принудительное исполнение, **~н нүүлгэх** принудительное выселение, переселение, **~н оногдол** принудительная повинность, **~н саатуулах захирамж** распоряжение о задержании, **~н татан буулгах** принудительная ликвидация, **~н хөдөлмөр** принудительный труд, **~н худалдаалах** принудительная продажа, **~н хураах** экспроприация, **~н эмчлэх** принудительное лечение

АЛБАДЛАГА принуждение, принудительность, **~аар хийх** делать по принуждению, **~ын арга хэмжээ** принудительные меры

АЛБАРХАГ проникнутый служебным формализмом, педантичный, формалистический, формальный

АЛБАРХУУ чрезмерно официальный

АЛБАТ подданные, подвластные, крепостной, данник, **«амьгүй ~»** «мёртвые души»

АЛГА 1. ладонь, длань, **~аа дээш нь харуулах** вверх ладонью, **~н дээр байгаа мэт харагдах** быть видным как на ладони, **~а дарам** с ладонь, клочок, ~ **таших** а) аплодировать, рукоплескать, бить в ладоши, б) аплодисменты, рукоплескания, **~ын чинээ** а) размером с ладонь, б) *перен.* мизерный, слишком маленький, **~ны амт үзэх** получить пощечину, **~ны амт үзүүлэх** давать пощечину, **~н боов идүүлэх** дать затрещину, дать леща, **~ны хонхорхой хазахтай адил** невозможное, неосуществимое на деле, *приблизительно:* укусить локоть, **танилтай бол талын чинээ, танилгүй бол ~н чинээ** *букв.* со знакомством, связями ты широк как степь, без них ты узок как ладонь

АЛГА 2. нет, отсутствует, ~ **болох** исчезать, исчезнуть, потеряться, **эргэлзэх юм** ~ *нет сомнения*, **өөрчлөлт** ~ нет изменений, **энд юу ч** ~ здесь ничего нет

АЛГАДАХ ударять/бить ладонью, ударять лапой (о медведе), хлопать, шлёпать, давать пощёчину, **мөр** ~ хлопать по плечу, **~аад авах** хлопнуть шлепнуть, **хацар** ~ дать пощёчину

АЛГАДУУЛАХ *побуд. от* **алгадах**, получать пощечину, **аавдаа** ~ получать пощечину от отца

АЛГАНА окунь, **бага** ~ *малый жёлтый горбыль*

АЛГАСАХ миновать, пропускать, **мөр** ~ пропустить строчку

АЛГЕБР алгебра

АЛГУУР постепенно, медленно, тихо, спокойно, ~ **хөдлөх** двигаться постепенно/медленно

АЛГУУРЛАХ медлить, затягивать, задерживать, **~н хойш тавьж үл болно** нельзя медлить/задерживать, не следует откладывать

АЛД 1. послелог, примерно, около, **10 цагийн ~(ад)** *примерно* в 10 часов

АЛД 2. маховая сажень, ~ **дэлэм** полторы сажени, алд бие тело, фигура

АЛДАА ошибка, погрешность, недостаток, упущение, вина, промах, опечатка, ~ **дутагдал гаргах** делать/допускать ошибку, ~ **онооны дэнс** попадание и промахи, ~ **хийх** совершить ошибку, **~гаа хүлээх** признать ошибку, **номын ~ны жагсаалт/залруулга** список опечаток в книге

АЛДАА: ~ **онооны дэнс** *приблизительно:* чаша фемиды

АЛДААТАЙ ошибочный, неправильный, неверный, ошибочно, с ошибками, убыточный, ~ **наймаа/гүйлгээ /худалдаа** убыточная торговля, **монголоор** ~ **ярих** говорить по-монгольски с ошибками

АЛДАГ: ~ **оног** изредка, кое-где, как попало

АЛДАГДАЛ 1) потеря, утрата, убыток, убыточность, 2) *упущение, ошибка, недостаток, дефект,* **худалдааны** ~ убыточность/дефицит торговли, ~ **гаргах/учруулах** причинять ущерб/убытки, привести к потере, ~ **нөхөн төлөх** возмещение убытков, **~д орох** терпеть убытки, **~ыг нөхөх мөнгөний дүн** сумма возмещения убытков, ~ **гаргуулах нэхэмжлэл** иск о взыскании убытков, **~ыг зохицуулах** решить вопрос компенсации за убытки

АЛДАГДАЛГҮЙ безубыточный, без потерь, без утраты, беззатратный, безубыточно, безошибочно, ~ **ажиллах** работать без потерь/без убытков, ~ **зарах/худалдах** продать без убытка

АЛДАГДАЛТАЙ убыточный, приносящий убыток, доставляющий ущерб, убыточно, ~ **ажил** убыточная работа, убыточное дело

АЛДАД примерно, около, **үдийн** ~ примерно в полдень

АЛДАЛ 1) промах (при выстреле), проигрыш, 2) лишение, упущение, **байг ~гүй онох/буудах** попадать в мишень без промаха, *выстрелить без промаха*

АЛДАМ: **нүд** ~ необозримый, просторный, бескрайный, **нүд** ~ **тал** бескрайная/просторная степь

АЛДАНГИ убыток, пени

АЛДАР 1) слава, известность, популярность, знаменитость, 2) *почтит.* имя, фамилия, ~ **нэр** *парн.* имя, авторитет, известность, популярность, **таны** ~ **хэн бэ?** как вас величают? ~ **хүнд** *парн.* честь, авторитет, репутация, престиж, ~ **цол** почётное звание, слава, ~ **гавьяа** заслуга, ~ **суу/суу** ~ известность, знаменитость, ~ **цуутай хүмүүс** знаменитые/известные люди, знаменитости, ~ **нэрийг/хүндийг гутаах** компрометировать, дискредитировать, ~ **нэрийг олох** завоевать авторитет, ~ **цолоо дуудуулах** величать участника соренований по борьбе, вызывать на сражение, восславить

АЛДАРТ известный, знаменитый, славный, прославленный, пользующийся очень большой известностью, ~ **жүжигчин** знаменитый артист, **үнэн ~ны шашин** православная религия

АЛДАРТАН знаменитость, известный/знаменитый человек, **урлагийн ~уудын тоглолт** концерт мастеров искусств

АЛДАРШИХ стать известным, прославиться, быть прославленным, сделаться *знаменитым, прослыть, пользоваться большой* популярностью, **олонд** ~ пользоваться большой популярностью у народа

АЛДАС 1) нарушение табу религиознонравственных предписаний у верующих, 2) грех, заблуждение, нарушение, оскорбление, преступление, 3) проигрыш, ошибка, **болъё, над** ~ **болно** нет, не надо, это будет грех с моей стороны, **үнэний эсрэг явбал/тэмцвэл** ~ **болох биз** восстанишь *против истины, греха* наберешься

АЛДАХ 1) *лишаться,* утрачивать, терять, упускать, ронять, **хэн нэгэн хүний барааг** ~ терять кого-либо из виду, **нэр хүнд** ~ терять авторитет, **тэвчээр** ~ терять терпение, **би найдвар ~гүй байна** я не теряю надежды, **ухаан** ~ терять сознание, **хүч тамир** ~ терять силы, **боломж** ~ упустить случай, **ажлын чадвар** ~ терять трудоспособность, **баримжаа** ~ потерять ориентацию, **амь** ~ лишиться жизни, **цаг** ~ терять время, **мөнгө хулгайд** ~ потерять *деньги при краже,* **нойр ~х** *лишаться сна,* **ам** ~ промолвиться, **дуу ~х** вскрикнуть, **гал/түймэр** ~ вызывать пожар, устраивать пожар, **санаа** ~ вздыхать, **царай** ~ худеть, плохо выглядеть, бледнеть, 2) едва не было...чуть не..., чуть-чуть..., почти, чуть ли не..., **охин уйлан ~в** девочка чуть не расплакалась, **би унан ~в** я чуть не упал, **Монголоо** ~ утратить черты монгола

АЛДЛАХ мерить саженью, измерять размахом обеих рук, **үүд бүү ~аарай/үүд ~ж болдоггүй юм** нельзя/не следует загораживать дверь распростёртыми руками, не принято стоять в двери с распростёртыми руками

АЛДЛУУЛАХ *побуд. от* **алдлах, гарыг нь ~ж зогсоох** заставлять/ принуждать стоять с распростёртыми руками

АЛДРАЙ миленький, миленькая моя, милочка моя, славная, ~ **бага нас** счастливые годы детства

АЛДРАЙХАН: **миний** ~ **үр** моё милое/славное дитя

АЛДРАХ 1) развязываться, расстёгиваться, 2) ослабевать (физически), 3) *перен.* ускользать, высвобождаться, **уяа/зангилаа ~в** узел развязался, **товч ~лаа** пуговица расстегнулась, **тамир тэнхээ** ~ чувствовать слабость, **зориг** ~ робеть, чувствовать робость, **~ч гарах** вырваться на волю

АЛДТАЙ (д) приблизительно в такое-то время

АЛДУУЛ потерявшийся, заблудившийся (о скоте), пригульный скот, ~ **тэмээ** потерявшийся верблюд

АЛДУУРАХ 1) развязываться, распутываться, ослабевать (об узле), расстёгиваться (о пуговицах), 2) освобождаться, избавляться, срываться, отвязываться, **нохой уяанаасаа ~чээ** собака сорвалась с цепи

АЛЖААЛ слабость, усталость, томление, истома, изнеможение, **~аа гаргах/тайлах** снимать усталость, восстановить силы, отдохнуть

АЛЖААХ уставать, утомляться, быть томным, ослабевать, **~ж ядрах/ядарч** ~ чувствовать усталость, испытывать усталость, обессиливать, изнемогать, изнуряться

АЛЗАХ уставать, претерпевать

АЛЗАХГҮЙ быть самостоятельным/выносливым/уверенным, чувствовать себя надёжным/уверенным, ничему не поддаваться, **тэр хаа ч явсан** ~ куды бы он не пошёл нигде не пропадёт

АЛИА шутливый, весёлый, жизнерадостный, клоунский, баловной, озорной, ~ **хошин/~а шог** смешной, комический, комич-

ный, скомороший, ~ **хүн** весёлый человек, шутник, шалун, баловник, весельчак, ~ **яриа** шутка

АЛИАЛАХ шутить, смешить, **манай аав ~ дуртай** наш отец любит пошутить

АЛИАЛАГЧ клоун, шутник, скоморох, **циркийн ~** цирковой комик/клоун

АЛИВ дай, дайте, ~ **нааш нь** дай сюда, ~ **наад номоо** дай эту книгу, ~ **явья** давай (те) пойдём

АЛИВАА всякий, каждый, любой, какой бы ни был, ~ **хүн** любой человек, ~ **тохиолдолд** во всяком случае, ~ **зүйл** всякое, разное

АЛИМ яблоко, яблочный, **болсон ~** спелое яблоко, **~ны амт/шүүс** яблочный вкус/сок, **~ны мод** яблоня

АЛЛАГА убийство

АЛМААС алмаз, алмазный; ~ **эрдэнэ** алмаз, ~ **эрдэнийн сан** алмазный фонд

АЛМАЙРАХ ротозейничать, быть рассеянным/невнимательным

АЛМАН: ~ **сар** полумесяц, лунный серп

АЛМАС 1) снежный человек, дикий человек, 2) ведьма

АЛС даль, вдали, далёкий, дальний, **Алс Дорнод** Дальний Восток, ~ **ирээдүй** далёкое будущее, **~сыг харагч** колесо обозрения, **~сыг харах** быть дальновидным, **~сыг ширтэх** глядеть вдаль, **~сын мөрийд дөрөөлөх** отправиться в дальние края, **~ын зам/аян** далёкий/дальний путь, **~аас гүйдэлтэй морь** конь, прискакавший из далека, **~ын хамаатан** дальний родственник, ~ **бөглүү газар** захолустье, ~ **дорнодын бэгбаатар** неясыть длинноухая дальневосточная, ~ **хэтийн** перспективный

АЛСААС издали, издалека, ~ **ирэх** приехать издалека

АЛСЛАГДАХ *страд. от* **алслах**, быть отдалённым, отдаляться, находиться вдали от чего-либо, **~сан хязгаар** отдалённые края

АЛСЛАХ удаляться, отдаляться, находиться вдали

АЛТ (ан) золото, золотой, **шижир/цэвэр ~т** червонное чистое золото, **~н зоос** золотая монета, **~ан бөгж** золотое кольцо, **~ан гар** золотые руки, **~н дунд/дундаж** золотая середина, **~н баталгаа** золотое содержание, **~н хүхэр** реальгар, **~ны уурхай** золотые прииски, **~ны нөөц** золотые запасы, **~ны чулуу** золотая руда, **~н биндэрьяа** *геол.* гелиодор, ~ **гагнуур** четырёхлистник золотистый, **~ны дэргэдэх гууль шарлана** *погов.* рядом с золотом и латунь желтеет, ~ **хайлуулах** выплавка, отлив золота, **валютын ~ны агуулдац** золотое содержание валюты, **~ны сорьц** проба золота, **Алтан од** *астр.* Венера, **Алтан мэлхийн орд** созвездие Жертвенник, **Алтан мөнгөн шаргуудын орд** созвездие Малая Медведица, **Алтан гадас одон** орден Полярной звезды, **~н зул** тюльпан, **~н гургалдай** соловей, **~н хараацай** ласточка, **~н хайрцаг** шкатулка с предсказаниями судьбы (в смысле книга судеб), **~н хайрцаг нээх** открыть «золотой ларец» покойного, т.е. справиться у ламы-астролога о благоприятной дате похорон, выяснить судьбу умершего человека – обряд-консультация у ламы, **~н жад загас** тунцеобразные рыбы, **~н загас наадуулах** заниматься любовью, **~н ёл** ягнятник среднеазиатский, **~н мэлхий үзүүлэх** предсказать что-либо, гадая на жертвенной черепахе, **~н хошуу өргөх** распространять сплетни, доносить, ябедничать

АЛТАДМАЛ позолоченный, покрытый позолотой

АЛТАЙ Алтай, **Алтайн нуруу** Алтайский хребет, **Алтайн цагшаан шонхор** кречеты алтайски

АЛТДАХ золотить, покрывать позолотой, **~сан** золочённый, **бөгж** ~ золотить кольцо

АЛТЛАГ золотистый, цвета золота, ~ **өнгө/өнгийн** золотистый цвет

АЛТТАЙ золотоносный, имеющий золото, ~ **элс** золотоносный песок

АЛУУЛАХ *побуд. от* **алах**, велеть/заставлять убить, велеть заколоть, заставлять зарезать (напр. овцу), быть убитым

АЛХ молоток, молот, ~ **дөш хоёр** молот и наковальня, **~н хээвид** орнамента, ~ **загас** рыба-молот

АЛХАА шаг, походка, поступь, **жигд ~** ровный шаг, **бардам ~а** гордая поступь, **түргэн ~гаар явах** идти быстрыми шагами

АЛХАМ шаг, походка, **анхны ~ хийх** сделать первый шаг, **~ ~аар** шаг за шагом, ~ **бүрд** на каждом шагу, ~ **ч ухрахгүй** не отступать ни на шаг

АЛХАН: ~ **хээ** вид монгольского национального орнамента

АЛХАХ шагать, ступать, идти, переступать, **удаан/зөөлөн ~** шагать медленно, идти тихим шагом, **замаар ~** идти по дороге, **юман дээгүүр ~** перешагнуть через что-либо, **хөл нийлүүлэн ~** шагать в ногу, **~аад марш!** шагом марш!

АЛХДАГ шагающий, ~ **экскаватор** шагающий экскаватор, ~ **нэвтэрхий толь** ходячая энциклопедия

АЛХЛАХ шагать быстро, ступать, идти быстрыми шагами

АЛХУУЛАХ *побуд. от* **алхах, танайхыг хүртэл ч бас нэлээн ~на шүү** *разг.* до вашего дома ещё довольно долго шагать

АЛЦАЙХ расставлять/раздвигать ноги, расставлять ноги в небрежной позе, **~н суух** сидеть растопырившись, **хөлөө ~ж/~лгаад зогсох** стоять, широко расставив ноги, **~ж хэвтэх** а) лежать с раздвинутыми ногами, б) лениться, бездельничать, сидеть без дела

АЛЦГАНАХ 1) расстопыриваться, ковылять, идти утиной походкой, 2) вести себя непристойно/легкомысленно (о женщине)

АЛЦГАР 1) кривоногий, расстопыренный, 2) низкий, низкорослый, коренастый, **тэр ~ хөлтэй** он кривоногий

АЛЧУУР платок, тряпка, салфетка, полотенце, **нусны ~** носовой платок, **нүүр гарын ~** полотенце, **гурвалжин ~** косынка

АЛЬ 1. какой, который, любой, ~ **хир/зэрэг** насколько, сколько, в какой степени, ~ **нэг** какой-либо, ~ **нь ч адил** всё равно, безразлично, ~ **болох түргэн** как можно скорее, ~ **болох аргаар** любым возможным способом, ~ **эрт/дивангарт** давным давно, ~ **ч улсын харьялалгүй иргэн** апатрид, человек, не имеющий гражданства

АЛЬ 2. дай, дайка, **дэвтэр ~** дай тетрадь

АЛЬБИН *геол.* кобальт

АЛЬБОМ альбом

АЛЬХАН где же, на какой же сторонке, **уулын ~ талд нь байна** на какой же сторонке горы находится

АМ 1. 1) рот, уста, пасть, 2) слово, язык, 3) едок, иждивенец, ~ **авах** взять слово, ~ **алдах/өгөх/гарах** клясться, дать слово, ~ **алдуулах** ловить на словах, **~аар амьсгалах** дышать ртом, ~ **ангайх** а) раскрывать рот/пасть, б) заговорить, сказать, молвить слово, **~наас ~ дамжих** передаваться из уста в уст, ~ **асуух** спрашивать о чём-либо с иронией, язвить, **~аа барих** сожалеть о сказанном, досадовать, ~ **бардам** хвастливый, ~ **бузарлах** не сдерживать слова, обнадёжить кого-либо зазря, ~ **бүл семья**, ~ **гэрээ** устный договор, ~ **дагах** поддакивать, **~н дээрээ** на словах, ~ **зайлах** полоскать рот, **~н зохиол** фольклор, ~ **мэдүүлэг** устные показания, ~ **нотолгоо** устные доказательства, **~н секс, ~аараа секс хийх** оральный секс, **~аа тат/хамхи!** закрой рот! замолчи! **~ны тамхи** табак для курения, ~ **шалгалт** устный экзамен, ~ **мөлтөс** в последний миг, **~ны ус** питьевая вода, ~ **халах** находиться в возбуждённом состоянии, быть «под мухой», ~ **хамарт орох (хүн)** чересчур бойкий, «без мыла влезет», **~ны хишиг** успех, фортуна, **~ны хөндий** полость рта, ~ **хуурай буцах** возвращаться ни с чем, не солоно хлебавши, ~ **хэлээр доромжлох** оскорблять словесно, ~ **цангах** испытывать жажду, **бууны ~** дуло ружья, **задгай ~тай** болтливый, **үхэр бууны ~** жерло пушки, **хүн ~** население, ~ **алдвал барьж болдоггүй агт**

алдвал барьж болно коня можешь воротить, а слово нет, **~аараа шороо үмхэх** приходить к плохому концу, **~нд ч үгүй, хамарт ч үгүй** *приблизительно:* ни нос, ни в рот (в смысле мало), **хөхүүрийн ~ цаашилж, хүйтний ~ наашилж байна** трескучие морозы, холода

АМ 2. падь, **уулын ~нд** в пади горы, **Их Тэнгэрийн ~** Падь Великого неба, *истор.* другое название «Маршальская падь» – правительственная резиденция рядом с Улан-Батором

АМ 3. мера измерения, **зуун ~ метр** газар земля в сто квадратных метров

АМААР 1) устно, 2) устный, **~ хэлэх** сказать/говорить устно, **~ харцу өгөх** ответить устно

АМАНЦАР говорун, краснобай

АМАР спокойный, благополучный, спокойно, благополучно, лёгкий, нетрудный, легко, нетрудно, **~ тайван байх/суух** быть спокойным, сидеть спокойно, **~ хялбар** *парн.* лёгкий, простой, **~ ажил** лёгкая работа, **хэлэ-хэд ~** лёгко сказать/говорить, **бид мэнд ~/~ мэнд сууж байна** мы живём благополучно, **~ заяа өгөхгүй/үзүүлэхгүй байх** не давать покоя, **хэн нэгний ~ тайвныг эвдэх** нарушать чей-либо покой, **бид ~ заяа үзэхгүй байна** мы не знаем покоя, **~ тайван байлгах** оставить кого-либо в покое, **саная ~ суух** *жить спокойно/беззаботно,* **~ сайн уу? ~ байна уу?** здравствуйте! **~ заяа үзүүлэхгүй** лишать покоя, «затрахать»

АМАРЖИХ 1) успокаиваться, 2) рожать, **~ газар** родильный дом, роддом, **~сны тэтгэмж** пособие по беременности и родам

АМАРЖУУЛАХ *побуд. от* **амаржих**, 1) давать покой, успокаивать, 2) дать возможность рожать, принять роды

АМАРЛИНГУЙ беспечный, беззаботный, благодушный, спокойный, беспечно, беззаботно, благодушно, спокойно, беспечность, беззаботность, благодушие, спокойствие, **~ амьдрал** беспечная/беззаботная жизнь, **юманд ~ хандах** относиться к чему-либо *слишком* беспечно/беззаботно

АМАРХАН простой, лёгкий, просто, легко, **үүнийг сурахад ~** легко научиться этому, **энэ бол туйлын ~** это очень легко

АМБААР 1) амбар, складское помещение, кладовая, 2) *разг.* домик

АМБАН большой, крупный, **~ шар** большой/крупный вол

АМБУЛАТОРИ амбулатория, амбулаторный

АМГАЛАН мир, спокойствие, благополучие, благоденствие, мирный, спокойный, мирно, спокойно, **~ тайван байдал** мир, спокойствие, **~ айлтгах** приветствовать, **~ байдлыг үймүүлэх/алдагдуулах** нарушить покой, лишить покоя

АМДАХ 1) *поджидать на пути,* пересекать кому-либо путь, 2) идти навстречу, **~н уулзах** встретить, идти кому-либо навстречу, **~н саатуулагч** перехватчик

АМЕРИК Америка, американский, **Америкийн Нэгдсэн Улс** Соединённые Штаты Америки

АМЖИЛТ успех, достижение, рекорд, прогресс, **ололт ~** достижение, успех, **дэлхийн дээд ~ тогтоох** установить мировой рекорд, **~ эвдэх** побить рекорд, **таны ажилд ~ хүсье** желаю успехов в вашей работе, **~ гаргах** делать успехи, добиться успеха

АМЖИЛТГҮЙ безуспешный, напрасный, безуспешно, напрасно

АМЖИЛТТАЙ успешный

АМЬЖИРГАА жизнь, существование, **~ны нөхцөл** условия существования, **~ны өртөг** стоимость жизни

АМЖИХ успевать, делать вовремя, суметь, **гэрлэж ~гүй явна** ещё не женат, успел пожениться

АМЖУУЛАХ *побуд. от* **амжих**, выполнить в срок, исполнять в нужный срок, осуществлять

АМИАРАА лично, сам, отдельно, **~ явсан нь дээр** лучше идти самому, **~ ярилцах** поговорить отдельно/наедине/с глазу на глаз

АМИЛАХ оживать, воскрешать, приходить в себя/в чувство

АМИЛУУЛАХ *побуд. от* **амилах**, оживлять, воскрешать, приводить в чувство, возвратить к жизни

АМИН 1. жизненный, **~ дэм** витамин, **~ гол** аорта, **~ сүнс** душа

АМИН (даа) 2. отдельно, только для себя, для личного пользования, **хэдэн мал ~ үлдээх** оставить для себя несколько голов скота, **~ хэрэглэх** использовать для себя/для личных нужд

АМИНДЭМ витамин, витаминный, витаминозный

АМИНДАЙ однофамилец, тёзка

АМИНЧ эгоист, себялюбец, эгоистичный, эгоистический, **~ үзэл** себялюбие, эгоизм, **~ хүн** эгоист

АМИНЧЛАХ 1) секретничать, шептаться, 2) вести себя эгоистично

АМИНЧХАН *эгоист, эгоистический*

АМЛАХ 1. 1) обещать, дать слово, 2) бросать вызов, вызвать противника (о борцах), **~сныа биелүүлэх** выполнить обещание, **~сандаа хүрэх** сдержать слово

АМЛАХ 2. впервые брать грудь (о новорождённом)

АМЛАХ 3. измерить на квадраты

АМЛАХ 4. подниматься вверх по пади

АМРААХ *побуд. от* **амрах**, давать отдых, предоставлять отдых, давать возможность отдохнуть, давать покой, успокаивать, **Нүхт амралтанд ~/амруулах** отправить в дом отдыха Нухт

АМРАГ любимый, милый, дорогой, любящий, **~/~ийн сэтгэл** любовь, **нууц ~** *любовник, любовница,* **аргагүй ~** *данный судьбой* любовник, любовница

АМРАГЛАХ любить, испытывать любовь, влюбляться

АМРАЛГҮЙ 1) без отдыха, бе передышки, 2) неустанно, беспрестанно, **~ хийх/ажиллах** делать/работать без отдыха

АМРАЛТ отдых, отпуск, каникулы, **~ын газар** дом отдыха, **~ын өдөр** выходной день, день отдыха, **~аар явах** ехать в отпуск, уйти в отпуск, **ээлжийн ~** очередной отпуск, **жирэмсний ~** декретный отпуск, **~ын мөнгө** отпускные деньги, **сургуулийн зуны ~** школьные летние каникулы

АМРАЛТТАЙ находиться в отпуске, иметь отпуск

АМРАХ *отдыхать,* быть/находиться в отпуске, **~ цаг** время отдыха, **бие ~** чувствовать себя отдохнувшим, **саная/сэтгэл ~** успокаиваться, утешаться, **энэ жил Бээжин явж ~сан** в этом году съездил (и) отдохнул(и) в Пекине

АМСАР горлышко, отверстие (сосуда, посуды), край сосуда, край отверстия, **аяганы ~** верхний край чашки/пиалы, **~ дүүрэн** полный до краёв, **хавцалын/ангалын ~ дээр** на краю пропасти

АМСАХ 1) пробовать, отведывать, 2) испытывать, переживать, **~** отведать пищу, **зовлон ~** испытывать горе/трудности, **жаргал ~** вкушать счастье, наслаждение

АМСУУЛАХ *побуд. от* **амсах**, давать пробовать, отведывать, угощать, *дать полакомиться*

АМСХИЙХ чуточку/немножко отдохнуть, перевести дыхание, перевести дух, сделать передышку

АМТ вкус, вкусовое свойство, привкус, **эвгүй ~** неприятный привкус, **~ оруулах** приправлять, делать вкусным

АМТАГДАХ 1) ощущать вкус, 2) чувствовать гордость, **муухай ~** ощущать неприятный вкус, **цус ~** ощущать вкус крови, **бяр ~** чувствовать прилив силы

АМТАЙ 1) языкастый, острый на язык, 2) *перен.* говорливый, болтливый, несдержанный на язык, 3) имеющий отверстие, **хоёр ~ буу** двуствольное ружьё

АМТАРХАГ сладенький, сладковатый, вкусненький

АМТАРХАХ 1) проявлять аппетит, лакомиться, 2) *прям. и перен.* пристраститься к чему-либо, смаковать, **ихэд ~н идэх/уух** есть/пить со смаком, лакомиться, смаковать

АМТАТ сладкий, вкусный, приятный, ~ **жүрж** апельсин, ~ **гуа** дыня, ~ **идээ** вкусная пища, ~ **сархиаг мөөг** гриб рыжик
АМТГҮЙ 1) невкусный, безвкусный, 2) неинтересный, невыразительный, ~ **хоол** безвусное кушанье
АМТЛААЧ дегустатор
АМТЛАГ вкусный, сладкий
АМТЛАГЧ приправа, добавки
АМТЛАХ 1) вкушать, пробовать, 2) делать вкусным, придавать вкус, приправлять, **~ж үзэх** пробовать на вкус, **хоол ~ зүйл** приправа
АМТЛУУЛАХ *побуд. от* **амтлах**, давать пробовать, заставлять отведать
АМТТАЙ 1) вкусный, лакомый, сладкий, 2) имеющий привкус/какое-то вкусовое свойство, **шорвог ~** имеющий солёный вкус, **муухай/сайхан ~** неприятный/приятный на вкус, **~ хоол** вкусное кушанье, вкусная еда
АМТТАЙХАН вкусненький, сладенький, лакомый
АМТТАН сладости, деликатес, **дорно зүгийн ~** восточные сладости
АМТШИХ 1) вкушать, входить во вкус, привыкать, 2) приучиться, **~сан хэрээ арван гурав дахин** *посл.* повадившаяся ворона тринадцать раз прилетит *приблизительно:* повадился волк в овчарню
АМУУ злаки, зёрна, общее название злаковых растений, **~ будаа/~ тариа тарих** сеять зерна/злаки
АМЬ жизнь, дыхание, **~на аваад явах** идти своей дорогой, преследовать личные интересы, **~ аврах** спасать жизнь, **~на аргалах** перебиваться, жить чем бог послал, **~ гарах** остаться в живых, выжить, **~ давирах** слишком печься о себе, **~ дүйх** рисковать своей жизнью, **~ зуух** жить, существовать, **~ мэрийх** страстно желать, хотеть больше жизни, **~ нас** жизнь, **~ насаа даатгах** страховать свою жизнь, **~ орох** оживать, приходить в себя, возвращаться к жизни, **~иа солих** убить друг друга, **~ тавих** умирать, **~ таєрах** умирать, дохнуть, **~иа хамгаалах** защищать свою жизнь, **~ хайргүй** не щадя жизни, беззаветно, **~на хорлох** лишать себя жизни, покончить жизнь самоубийством, **~ хэлтрэх** избежать смерти, быть помилованным
АМЬД живой, одушевлённый, **~ юмс** всё живое, **~ын жин** живой вес, **~ мэнд байх** быть живым и здоровым, **~ байгаль** живая природа, **~ явах** быть живым, жить, **~ явах эрх** право на жизнь, **~ гарах** выйти/остаться живым, **~ хүн аргатай, аргалын гал цогттой** живой человек всегда найдёт выход (из положения), в теплящемся очаге всегда есть искра
АМЬДААР живьём, заживо, **дуучин Сарантуяаг ~ харах** видеть живьём певицу Сарантуяа
АМЬДРАЛ жизнь, жизненный, **аж ~** жизнь, существование, **чинээлэг ~** зажиточная жизнь, **~ын түвшин** уровень жизни, **~ын хэрэгцээ/шаардлага** жизненные потребности, **~ын төлөө тэмцэл** борьба за жизнь, **~ын өртөг** стоимость жизни, **~аа холбох** соединить свою жизнь/судьбу
АМЬДАЙ тёзка
АМЬДРАХ жить, существовать, **~ арга** способ существования, **ядуу ~** жить в нищете, **ганцаараа ~** жить одиноко, **жаргалтай ~** жить счастливой жизнью, **~ хэрэгсэл** средства к существованию
АМЬДРУУЛАГЧ оживляющий, животворный, воскрещающий, **сэхээн ~** *мед.* реаниматор
АМЬДРУУЛАХ *побуд. от* **амьдрах**, возвращать к жизни, воскрешать, оживлять, **сэхээн ~ тасаг** *мед.* отделение реанимации, реанимационное отделение, **сэхээн ~ ухаан** реаниматология
АМЬЖИРГААжизнь, существование, условия существования/жизни, **~ны өртөг өссөөр байна** всё ещё растёт/увеличивается стоимость жизни
АМЬНЫ личный, собственный, **~ ажил** личные дела
АМЬСГАА дыхание, вздох, старик, старуха, **~ авах** вздыхать, **~гаа татах** затаить дыхание, задерживать дыхание, **~ хураах** умереть, **дөнгөж ~тай байх** еле дышать, **~ны тоо гүйцэх** умереть, преставиться
АМЬСГААДАХ запыхаться, почувствовать одышку, задыхаться, одышка, **хурдан явснаас/гүйснээс болж ~** запыхаться/начать дышать с трудом от быстрой ходьбы/бега, **их ~даг болох, их ~даг хуучтай/өвчтэй болох** страдать одышкой
АМЬСГАЛ дыхание, дыхательный, **~ын эрхтэн** дыхательный орган, **уур ~** климат, **~ хураах** испускать последний вздох, умереть, **~ давхцах** страдать от отдышки, **~ боогдуулах хий** удушающмий газ, **~ын дээд зам** верхние дыхательные пути, **~ын цочмог халтгай хам шинж** атипичная пневмония
АМЬСГАЛАХ дышать, **чөлөөтэй ~** вздохнуть/дышать свободно, **гадагш ~** выдыхать, производить выдох
АМЬТАЙ живой, одушевлённый, **нэг ч ~ юм үзэгдэх биш/үл үзэгдэнэ** не видно ни одной живой души, **~ юмс** одушевлённые предметы, **нэг ~, амь нэгтэй** единодушный, единогласный
АМЬТАН живое существо, животное, **улс ~/хүн ~** люди, **адгуусан ~** животные, **~ы аймаг** фауна, животный мир, **~ судлал** зоология, **~и сургагч** дрессировщик, **өөдгүй ~** сволочь, ублюдок, **ямар сонин ~ бэ** какое странное существо, *разг.* кого я вижу!
АН 1. трещина, щель, расщелина, расселина, **газрын ~** расщелина в земле, **~ цав** трещина, щель, **хадны ~ цав** трещина/расщелина в скалах, **~ гарах** дать трещину, треснуть, трескаться
АН 2. зверь, **~ гөрөөс/~ амьтан** *собир.* звери, зверьё, дичь, дикие животные, **~ агнах/хийх, ~ гөрөө хийх** охотиться на зверей, заниматься охотой, **~ амьтнаар элбэг нутаг/газар** местность, богатая зверем, **~ агнуурын хууль** закон о правилах охоты, **~гийн мах** дичь, мясо диких животных, **~гийн арьс** звериная шкура, пушнина, **~ агнах эрхийн бичиг**, разрешение на охоту
АНА: ~ **мана** а) равный, одинаковый, б) равно, одинаково, **~ мана ноцолдох** не уступать друг другу в силе и ловкости, схватиться из-за чего-то, имея равные силы
АНААШ *зоол.* жираф
АНАГААХ лечить, **~ ухаан** медицина, **~ ухааны дээд сургууль** медицинский институт, **~ ухааны дунд сургууль** медицинское училище, **эмээр ~** лечить лекарствами, **өвчтөнийг ~** лечить больного
АНАР *бот.* гранат, *геол.* гранат
АНАРХИ анархия, анархический, **~ зан /байдал, ~ үзэл** анархизм
АНАТОМИ анатомия, анатомический, **хүний биеийн ~** анатомия человека, **ургамлын ~** анатомия растений
АНАТОМИЧ анатом, специалист по анатомии
АНАХ 1. 1) подкарауливать, подкрасться, подстеречь, 2) опасаться, остерегаться, настораживаться, избегать, **~ж байгаад барих/барьж авах** поймать/схватить кого-либо, подкараулив, **муур хулганыг ~аж байгаад барив** кошка подстерегла мышку и схватила её
АНАХ 2. заживать, заживляться (о ране)
АНГААХАЙ птенец, птенчик
АНГАГАР 1) открытый, раскрытый, 2) широкий, разинутый, 3) зевака, бездельник
АНГАЙЛГАХ *побуд. от* **ангайх**, раскрывать/открывать что-либо, **амаа ~** раскрывать/открывать рот/пасть
АНГАЙХ 1) раскрываться, открываться, зиять, 2) *перен.* зря проводить время, бездельничать, ротозейничать, **~ж харагдах** зиять, выглядеть зияющим, **~ амтай ч залгих хоолойгүй** *загадка* с раскрывающимся ртом, но без горла, чтобы глотать (**хайч** — ножницы), **мэдэлгүй ~аад зогсож байв** *разг.* стоял, разинув рот, ничего не ведая

АНГАЛ пропасть, ущелье, расселина, бездна, **хадны ~** ущелье в скале
АНГАЛЗАХ 1) открывать, раскрывать, 2) потерять способность говорить, 3) *перен.* бездельничать, ротозейничать, **биттий худлаа ~аад бай** *разг.* не болтай языком, **толгой ~ж/~аад байна** голова трещит
АНГАЛЗУУР постоянно открываю-щийся, **~ хайч** крупные/большие ножницы для стрижки овец, **~ амьтан/хүн** *простореч. пренебреж.* болван, болтун, пустослов, ротозей
АНГАМ: **~ халуун** палящий зной
АНГАРАГ вторник, **Ангараг гараг** планета Марс
АНГАРХАЙ щель, разрез, трещина, щелистый, открытый, растворённый, разинутый, **шалны ~** щель в полу, **хаалганы ~гаар харах** смотреть в щель двери
АНГАА жажда, **~г тайлах/гаргах** утолить жажду
АНГАХ 1. 1) испытывать жажду, жаждать, 2) испытывать сильное желание, сильно хотеть чего-либо, **миний ам ихэд ~ж байна** меня мучит жажда, мне очень хочется пить
АНГАХ 2. выцветать, выгорать, высыхать (из-за отсутствия дождя, влаги), **~сан газар** высохшая земля
АНГИ класс, курс, **ажилчин ~** рабочий класс, **ноёлогч ~** господствующий класс, **~ийн тэмцэл** классовая борьба, **дөрөвдүгээр ~ийн оюутан** студент четвёртого курса, **наймдугаар ~ийн сурагч** ученик/ученица восьмого класса, **~т нийгэм** классовое общество, **бэлтгэл ~д орох** поступить на подготовительный курс, **олон ~т кино** многосерийный фильм
АНГИД 1) кроме, за исключением, отдельно, 2) другой, **үүнээс ~ ном алга** кроме этой другой книги нет
АНГИЖРАЛ избавление, освобождение
АНГИЖРАХ избавляться, освобождаться, спасаться, отделяться, **аюулаас ~** избавляться от опасности, **зовлонгоос ~** избавиться от мучений
АНГИЖРУУЛАХ *побуд. от* **ангижрах**, избавлять, спасать, освобождать
АНГИЛАГДАХ *страд. от* **ангилах**, разделяться, классифицироваться, группироваться, дифференцироваться, расчленяться, распадаться, отделяться
АНГИЛАЛ разделение, классификация, группировка, дифференциация, расчление, **баримт материалын ~** дифференциация/группировка материалов, **хэлний ~** классификация языков
АНГИЛАХ классифицировать, разделять, дифференцировать, группировать, расчленять, **ургамлыг ~** классифицировать растения, **хэдэн хэсэг(т) ~** разделить на несколько частей/групп, **~сан мах** расфасованное мясо
АНГИНА *мед.* ангина, **~аар өвдөх** болеть ангиной
АНГИНТАХ заболеть ангиной, **хоолой ~** а) болеть ангиной, б) воспаление горла
АНГИР *зоол.* турпан, **~ шар** красно-жёлтый, **~ үр** дитя кровный
АНГЛИ английский, **~ хэл** английский язык, **~и хүн** англичанин/англичанка
АНГУУЧ (ин) охотник, зверобой
АНГУУЧЛАХ охотиться, заниматься охотой
АНД друг, приятель, товарищ, дружище, **~ нөхөр** хороший/близкий друг, **бид ~ бололцов** мы стали друзьями, **~ барих/болох** стать побратимами, друзьями
АНДАХ ошибаться, допускать неточность, заблуждаться, **халзан Ганболдыг хэн эс ~ вэ?** кто не знает лысого Ганболда?
АНДАХГҮЙ не ошибаться, знать безошибочно/хорошо, не путать, не заблуждаться, **тэр замаа ~** он не заблудится по дороге, он хорошо знает дорогу
АНДГАЙ клятва, присяга, зарок, честное слово, **~ тангарага өгөх/тавих** дать клятву, дать честное слово, присягать
АНДГАЙЛАХ клясться, присягать, **үнэнээ/үнэнчээ ~** клясться в верности, **~н хэлэх/өчих** клятвенно заверить, **~ж гаргасан (бичмэл) мэдүүлэг** (письменное) показание под *присягой*, аффидевит
АНДУУ 1. деревянный бак/бачок (для жидкости)
АНДУУ 2. ошибочный, неверный, неправильный, ошибочно, неверно, неправильно, **~ ташаа/эндүү ташаа** ошибочное, неверное, **~ ярих/хэлэх** говорить неправильно, говорить неправду
АНДУУРАЛ ошибка, неправильность в чём-либо, погрешность, неточность
АНДУУРАХ *ошибаться, путать*, обознаваться, **та намайг хүнтэй ~ч байх шиг байна** пожалуй, вы меня с кем-то путаете/вы меня принимаете за другого, **би ~аад өөр ном авчихжээ** я по ошибке, оказывается, взял другую книгу
АНЗ неустойка
АНЗААРАХ замечать, примечать, обращать внимание, **би таны хэлснийг ~сангүй** я не обратил внимание, что вы сказали, **түүний ~сны хэрэггүй** *не обращай на него внимания*
АНЗААРАХГҮЙ не обращать внимания, не замечать, не примечать
АНИА табуированное обращение к старшей сестре, тёте
АНИАТАЙ закрытый, зажмуренный, **~ нүд** закрытые глаза
АНИВ: **~ ~ хийх/гэх** а) мигать, моргать (глазами), б) мерцать (о звёздах)
АНИВАЛЗАХ часто мигать/моргать, часто мерцать
АНИВАСХИЙХ моргнуть, мигнуть, **тэр над руу нүдээ ~в** он *подмигнул мне*
АНИВХИЙХ моргнуть, мигнуть
АНИВЧИХ мигать, моргать, щуриться, жмуриться, **хурц наранд ~** щуриться от яркого солнца
АНИЛДАХ закрываться, смыкаться, **өөрийн эрхгүй нүд минь ~на** глаза мои сами/невольно слипаются
АНИР отголосок, отзвук, **~ чимээ/чимээ ~** а) звук, шорох, б) весть, слух, **~ гарах** издаваться(ся) какие-то звуки, шуметь, **~ чимээ алга/~ чимээгүй** а) тихо, ни звука, б) мёртвая тишина, в) нет вестей
АНИРЛАХ издавать какие-то звуки
АНИРТ шумный, **~ гийгүүлэгч** *лингв.* шумный согласный
АНИС 1. брусника, **~ түүх** собирать бруснику, **~нд явах** ходить по бруснику/за брусникой
АНИС 2. суть, сущность, **~ыг нь олох** *добиваться сути, постигать суть*
АНИСГА веко, веки
АНИХ 1) зажмуривать, закрывать, смыкать (глаза), 2) заживать, зарубцеваться (о ране), 3) *перен.* умереть, скончаться, **нүдэ ань** закрой глаза, **шарх нь ~жээ** рана зажила/закрылась
АНИУЛАХ *побуд. от* **аних**, заставить закрыть глаза, *тюрем.* убить, отправить на тот свет кого-либо
АНКЕТ анкета, анкетный, **~ бөглөх** заполнить анкету, **~ын арга** анкетный метод, метод анкетирования, **~ын судалгаа явуулах** анкетирование
АНСАМБЛЬ ансамбль, **Ардын дуу бүжгийн ~** ансамбль народных песни и танца
АНТЕН антенна, **зурагтын ~** телевизионная антенна, **гадаах/гадуур ~** наружная антенна
АНУУХАН полный сил, крепкий, бодрый, здравствующий, находящийся в добром здравии (о старых пожилых людях), **~ өвгөн** бодрый старик
АНХ 1) первый, первоначальный, 2) сперва, вначале, впервые, **~ удаа** первый раз, впервые, **~ан шатны сургууль** начальная школа, **~ан шатны боловсрол** начальное образование, **~ан шатны шүүх** суд первой инстанции

АНХААРАГДАХ *страд. от* **анхаарах**, привлекать внимание, быть в центре/фокусе внимания

АНХААРАЛ внимание, ~ **муутай** невнимательный, **~аа хандуулах** обращать внимание, **~аа төвлөрүүлэх** сосредоточивать/акцентировать внимание на чём-либо, ~ **татах** привлекать внимание, **~ын төвд байх** быть в центре внимания, **их ~ тавих** уделять большое внимание, **~даа авах** принимать во внимание

АНХААРАХ обращать внимание, внимательно относиться, вникать, вслушиваться, **биттий анхаар!** не обращайте внимание! **~маар асуудал** вопрос заслуживающий внимания

АНХДАГЧ первый, первичный, ~ **төрөл** стратотип, ~ **нотлох баримт** первичное доказательство, ~ **үе** первый период, первичный период, ~ **эрх** первичное право, ~ **өргөлт** *муз.* хорей

АНХДУГААР первый, ~ **дэвтэр** первый том, первая тетрадь, **намын ~ их хурал** первый съезд партии

АНХАНДАА первоначально, сначала, когда-то

АНХЛААД *разг.* сначала, сперва, **чи ~ тэгж хэлээ биз дээ** *разг.* сперва ты ведь так сказал

АНХИЛАМ благоуханный, ароматный, душистый, ~ **үнэртэй цэцэг** благоухающие цветы, ~ **үнэрт саван** душистое мыло

АНХИЛАХ благоухать, распространять аромат

АНХИЛУУН/АНХИЛУУР ароматный, благоуханный

АНХНААСАА сначала, с самого начала, сперва, прежде всего

АНЧ 1) охотничий, звероловческий, занимающийся охотой, 2) охотник, ~ **нохой** охотничья собака, ~ **хүн** охотник

АНЧИН охотник, зверолов, **сайн/тэргүүний** ~ хороший/передовой охотник, **хулгайн** ~ браконьер, **~ы овоохой** охотничий шалаш

АНЧЛАХ охотиться, заниматься охотой

АНЬСАГА глазная щель

АППАРАТ аппарат, **зургийн** ~ фотографический аппарат, фотоаппарат, **утасны** ~ телефонный аппарат

АПТЕК аптека, **төв** ~ центральная аптека, **аяны** ~ дорожная аптечка

АР 1) задняя, теневая сторона, северная сторона, 2) зад, спина, север, 3) задний, тыльный, северный, ~ **биеэ/~ нуруу** спина, ~ **нуруугаар нь хаях** *спорт.* бросать на обе лопатки, **гэрийн ~ тал** задняя/тыловая сторона юрты, **уулын ~ бэл** северный склон горы, ~ **өвөргүй** и сзади и спереди, **цаасны/хуудасны ~ өвөргүй бичих** исписать обе стороны листа бумаги, ~ **тал** а) тыл, б) задняя/оборотная сторона, ~ **талын алба** интендантская служба, **~ын хаалга** задний, «чёрный ход», блат, по блату, **~ын хаалгадах** делать что-либо по блату, ~ **талын эмнэлэг** тыловой госпиталь, **гарын** ~ тыльная сторона руки/ладони, **~д/~ талд** а) в тылу, б) за спиной, за сценой, **~д үлдэх** оставаться в тылу/за спиной, ~ **Монгол/~ Газар** Внешняя Монголия, ~ **Солонгос** Северная Корея, **салхи ~аас үлээнэ** ветер дует с тыла, ~ **гэр** дом, семья, **~ын хаалга** чёрный ход *букв.* тыловая/задняя дверь, **залуу насанд охидууд ~ өвөрөөр минь гүйж байлаа,** когда был молодым, девушки бегали вокруг да около меня, **~аар тавих** гулять на стороне, наставлять рога

АРАА 1. коренной зуб, ~ **шүд** *парн.* зубы, **агт ~/захын** ~ зубы мудрости, **~ндаа зуух** иметь зуб против кого-либо, точить зубы против кого-либо

АРАА 2. *тех.* шестерня, передача, **дамжуулах ~, залгах** ~ передача управления, **нэгдүгээр ~нд залгах** перевести /переключать на первую скорость, **шүдэт** ~ зубчатая передача, **унадаг дугуны гишгэх/гишгүүр** ~ педальная передача в велосипеде, ~ **залгах бариул** рычаг переключения передачи

АРАА 3.: ~ **тоть** попугай

АРААЖИО *устар.* радио

АРААР 1) сзади, позади, 2) отсутствие кого-либо, **сүүлдэж ирсэн нь ~ суув** те, которые пришли с опозданием/опоздали, сели сзади, **тэр байшингийн ~ орсон** он скрылся за домом, **бидний ~р нийм хэрэг болжээ** это случилось в наше отсутствие, ~ **тавих** обмануть, одурачить, оставлять в дураках, обвести вокруг пальца, «наставить рога», **~раа тавиулах** быть обманутым/одураченным

АРААТАН хищник, хищный зверь, ~ **амьтан** звери, дикие животные, **зэрлэг** ~ хищные животные

АРААЛАХ (араа ургах) прорезаться (о коренных зубах)

АРАВ/АРВАН 1) десять, десяток, десяти-, 2) *для обозначения неопределённого множества* много раз, неоднократно, 3) *для выражения малого количества* несколько, всего, лишь, 4) десятое (в названиях чисел месяца), **арван арваар зуу** десятью десять сто, ~ **дахих** а) повторять десять раз, б) удесятерять, ~ **дахин их** в десять раз больше, ~ **арваар** по десять, по десяти, **~н жилийн дунд сургууль** десятилетка, десятилетняя/средняя школа, **~н хоёр жилийн орчил** двенадцатилетний цикл (по лунному календарю), **~н хуруу шигээ мэдэх** знать как свои пять *букв.* десять пальцев, **~н хуруу тэгш** мастер на все руки, **~н долоон настай** семнадцать летний, ~ **хэлүүлэх** заставлять повторять несколько/много раз, **олон ~/олон ~аараа бий/байна** имеется много десятков чего-либо, **хэд ~н/тав ~н/~ таван төгрөг олох санаатай** намерен/хочется заработать всего лишь несколько (*букв.* кое какие деньги **~н цагаан буян** десять благодеяний, **~н хар нүгэл** десять смертных грехов, **өнөөдөр ~и сарын арван** сегодня десятое октября, **~ны өдөр** десятое число, **~ны хоёр** две десятых, **~ын/~аас хоёр нь** две/двое из десяти, ~ **дахь жил** десятый год, **~тай хүү** десятилетний мальчик

АРАВГАР: ~ **царай гаргах** строить кислую мину, корчить рожу

АРАВДУГААР десятый, ~ **сар** октябрь

АРАВТ: ~ *разг.* десятитугровка, **~ын дэвсгэр** десятитугриковая купюра, **~ын бутархай** десятичная дробь

ЗОГСОЛГҮЙ беспрерывно, безостановочно, беспрерывный, безостановочный, **тэр хоёр «үүлэн бороony ажил» хэдэн цаг ~ хийж байсан** те двое занимались любовью несколько часов беспрерывно

ЗОГСОЛТ остановка, стойка *спорт.* стояние, пауза

ЗОГСОЛТГҮЙ безостановочный, беспрерывный, безостановочно, беспрерывно, ~ **явах** ехать/идти без остановки

ЗОГСОЛТТОЙ с остановкой, с перерывом, имеющий остановку/перерыв, с пересадкой, с паузой

ЗОГСОНГИ застойный, ~ **байдал** застой, упадок, ~ **байх** находиться в застое, ~ **үе** застойный период, ~ **хөрөнгө** замороженные средства, **үнэ** ~ **болох (болгох)** замораживание цен

ЗОГСОО стоймя, ~ **зайгүй** беспрестанно, беспрерывно, ~ **зайгүй ярих** беспрерывно говорить

ЗОГСООГООР (оо) стоймя, в стоячем положении

ЗОГСООЛ стоянка, место стоянки, **автобусны** ~ стоянка автобуса

ЗОГСООЛГОХ *побуд. от* **зогсох**, заставлять стоять, остановить

ЗОГСООХ останавливать, приостанавливать, прекрещать, прерывать, **ажлаа** ~ прекращать работу, **машинаа** ~ остановить машину, **гал** ~ прекратить огонь, **элсэлтийг** ~ прекратить набор, **цөмийн зэвсгийн туршилтыг** ~ запретить/прекратить испытание ядерного оружия

ЗОГСОХ 1) стоять, торчать, 2) останавливаться, приостанавливаться, прекращаться, перестать, **гэнэт** ~ внезапно остановиться, **ажил ~в** работа стоит, **харуул манаанд** ~ стоять на страже/на часах, **«зогс! буудлаа»** «стой! стреляю!», **бороо ~в** дождь перестал идти, **хөл дээрээ** ~ стоять на ногах, **өлмий дээрээ** ~ стоять на цыпочках

ЗОГСОХГҮЙ не только… но и…, **ийм бодлого эдийн засгийн хүрээнд муугаар нөлөөлөөд зогсохгүй нийгмийн амьдралд ч алдагдалтай юм** такая политика не только отрицательно скажется в экономической сфере, но и принесёт проблемы в общественную жизнь

ЗОГТУСАХ встрепенуться

ЗОГЪСОХ икать

ЗОДОГ борцовская одежда, ~ **тайлах** отменить поединок борцов, уйти из большого спорта (о борце)

ЗОДОЛДООН драка

ЗОДОЛДОХ *взаим. от* **зодох**, бить друг друга, драться, **хүнтэй** ~ драться с кем-либо

ЗОДОЛДУУЛАХ *побуд. от* **зодолдох**, доводить дело до драки, провоцировать драку

ЗОДООН драка, дебош, ~ **гаргах** затевать драку, устроить дебош, ~ **цохиондоо хүрэх** доходить до драки

ЗОДООНЧ драчун, драчливый

ЗОДОХ бить, избивать, колотить, ударять, ~**ж нүдэх/жанчих** ударять, избивать

ЗОДУУЛАХ *побуд. от* **зодох**, быть побитым, быть избитым, **хүнд** ~ быть побитым кем-нибудь

ЗОДУУР кнут, бич (как средство наказания)

ЗОЖИГ упрямый, необщительный, нелюдимый, ~ **хүн** необщительный человек, бирюк

ЗОЖИГЛОХ вести себя упрямо, упрямствовать, держаться упрямо

ЗОЛ счастье, удача, фортуна, **зол заяа** счастье, ~ **завшаан** удачный случай, ~**оор** к счастью, **мань хүнд** ~ **болсон** ему повезло, ~**оор хүний амь эрсдээгүй** к счастью, обошлось без жертв

ЗОЛБИН бродячий, ~ **нохой** бродячая собака

ЗОЛБОО великолепие, сияние, красота, бодрость, удачливость, задор, **цог** ~, ~ **хийморь** великолепие, величие, бодрость

ЗОЛБООГҮЙ не блестящий, лишённый великолепия, не величественный, унылый

ЗОЛБООТОЙ бодрый, блестящий, великолепный, удачливый, блестяще, великолепно, ~ **харагдах** выглядеть великолепно/блестяще

ЗОЛГОЛТ встреча нового года по Восточному календарю

ЗОЛГОХ 1) приветствовать, встречаться, приветствовать обеими руками за обе руки, 2) *перен.* схватываться

ЗОЛГҮЙ несчастный, неудачливый, несчастливый, злополучный, ~ **явдал** невзгода, несчастный случай, несчастье, ~ **өдөр** злополучный день, несчастливый день

ЗОЛИГ чёрт, фигурка из теста, которой откупались от духов, козёл отпущения, ~**т гаргах** сделать козлом отпущения, предать анафеме

ЗОЛИОС жертва, козёл отпущения, ~**гүй хувьцаа** невыкупаемая акция

ЗОЛТОЙ 1) счастливый, удачливый, 2) *разг.* к счастью, чуть ли, ~ **хүн** счастливый человек

ЗОМГОЛ щепка, стружка, ~ **болгох** *перен.* разбить в щепки, разбить вдребезги

ЗОН: ~ **ард** люди, народ

ЗОНХИ большинство, большая часть, преобладающая часть, **олонхи** ~, **ихэнх** ~ *парн.* подавляющее/преобладающее большинство

ЗОНХИЛОЛ доминанта

ЗОНХИЛОХ преобладать, доминировать, господствовать, ~ **нь,** ~ **олонх нь** подавляющее/преобладающее большинство, доминирующая часть, ~ **өрөг** доминант, ~ **ургамал** доминирующее растение

ЗОО поясничная часть спины, ~ **нуруу** спина, ~ **мах** филе, ~ **авах, ~ хөдлөх, ~нд юм орох, ~нд юм хавчуулах** прострел (ревматический)

ЗООГ еда, кушанье, яства, трапеза, **~ийн газар** ресторан, ~ **барих** дать обед, подавать кушать

ЗООГДОХ *страд. от* **зоох**, 1) быть вкопанным, быть вбитым/врытым, быть всаженным, 2) застрять, **дугуй шаварт ~в** колесо застряло в грязи

ЗООГЛОХ кушать, вкушать, отведывать

ЗООЛОГИ зоология

ЗООЛОГИЧ зоолог

ЗООЛТ вкапывание, установка, **шон** ~ вкапывание/установка столбов

ЗООЛТТОЙ 1) вкопанный, вставленный, 2) застрявший

ЗООМОЛ закопанный, вкопанный, врытый

ЗООН зона, в основном в исправительно-трудовом учреждении

ЗООПАРК зоопарк

ЗООРИЛОХ хранить что-либо в подвале

ЗООРЬ погреб, подвал, **ногооны** ~ овощехранилище

ЗООС монета, **алтан** ~ золотая монета, **хуурамч** ~ фальшивая монета, **зэс** ~ медная монета, ~ **татах** гадать на монетах, **сохор ~ны үнэгүй** не стоит медного гроша, гроша ломаного не стоит, **~ны нүхээр харах** все мерить деньгами, **Тэнгэрийн ~ны орд** созвездие Южных Рыб

ЗООТЕХНИК зоотехника, зоотехнический, **~ий лаборатори** зоотехническая лаборатория

ЗООТЕХНИКЧ зоотехник

ЗООХ вкалывать, закапывать, врывать, вбивать, всаживать, посадить, **утасны шон** ~ вкопать телеграфный столб

ЗОРГО своеволие, произвол, **дур ~ооров аашлах/загнах** самовольничать, своевольничать, самодурствовать

ЗОРГОДОС стружка, **модны** ~ древесная стружка, **төмрийн** ~ металлическая стружка

ЗОРГОЛ годовалый олень, лосёнок

ЗОРИГ смелость, храбрость, сила воли, **шийдвэр** ~ решимость, решительность, **шийдвэр ~ төгс байх** быть полным решимости, **эрэлхэг ~ гаргах** проявить мужество, ~ **орох** набираться храбрости, собираться с духом, **~мохох/шантрах/алдрах** не хватать смелости, не осмеливаться, терять присутствие духа, ~ **бадрангуй** воодушевлённый, полный энтузиазма, ~ **эрмэлзэл** намерение, стремление, ~ **шулуудах** принимать (окончательное) решение, **Монголын Иргэний Зориг Нам** Партия Гражданской Воли (Мужества)

ЗОРИГТЙ несмелый, трусливый, нерешительный, безвольный

ЗОРИГГҮЙДЭХ недоставать смелости, не хватать решительности, не находить в себе смелости/силы для чего-либо

ЗОРИГЖИХ воодушевляться, вдохновляться, мужаться

ЗОРИГЖУУЛАГЧ вдохновитель

ЗОРИГЖУУЛАХ *побуд. от* **зоригжих**, вдохновлять, воодушевлять, стимулировать, **буєдыг** ~ вдохновлять других

ЗОРИГЛОХ сметь, осмеливаться, отваживаться, ставить целью, намереваться, **тэр нөхөртөө хэлж ~гүй** она не посмеет сказать мужу

ЗОРИГТ смелый, отважный, храбрый, решительный, волевой, **чин ~ Сүхбаатар** неустрашимый Сухэ-Батор

ЗОРИГТОЙ смелый, отважный, храбрый, решительный, смело, отважно, храбро, решительно, ~ **өөрчлөлт хийх** сделать смелые изменения, ~ **шинэчлэлт хийх** производить решительные реформы

ЗОРИЛГО цель, намерение, задача, **тодорхой** ~ ясная цель, **~д тохирох** целесообразный, **гол/үндсэн** ~ главная цель, основная задача, **дайвар** ~ привходящая цель, **ээлжит** ~ очередная задача, ~ **тавих** ставить задачу, поставить цель, **~доо хүрэх** достичь цели, **~д таарах/тохирох** отвечать цели, **ямар ~оор** с какой целью, **~той байх** иметь целью, **~оор** с целью, в целях

ЗОРИЛГОГҮЙ бесцельный, бесцельно, без цели, ~ **явах** идти/ехать бесцельно/так просто

ЗОРИЛГОТОЙ имеющий цель, **ямар ~ вэ?** с какой целью? какая цель? **тодорхой ~ хүн** человек, имеющий определенную цель

ЗОРИЛТ задача, цель, **шинэ** ~ новые задачи, **хойшлуулшгүй чухал** ~ важнейшие неотложные задачи, **амин чухал** ~ жизненно важная задача

ЗОРИМОГ смелый, отважный, решительный

ЗОРИУД намеренно, нарочно, с целью, умышленно, специально, ~ **хийх** делать нарочно, ~ **хэлэх** сказать преднамеренно, ~ **худал мэдээлэх** заведомо ложный донос

ЗОРИУЛАГДАХ *страд. от* **зориулах**, посвящать, предназначать, 2) направлять, устремлять, **биеэ зориулах** посвящать себя, **ойд зориулах** посвящать юбилею, **хүчээ зориулах** отдать силы, направлять силы

ЗОРИХ 1) стремиться, намереваться, 2) направляться, **~сондоо хүрэх** достичь своей цели

ЗОРОХ строгать, обстругивать, **мод** ~ резать по дереву

ЗОРЧИГЧ пассажир, пассажирский, временно пребывающий, **билеттүй** ~ бесбилетный пассажир, **~дын хөдөлгөөн** пассажирское движение, **дамжин нэвтрэх** ~ транзитный пассажир

ЗОРЧИХ шествовать, идти, ехать, **~н явагч** пассажир, путешественник, **замаар** ~ идти по дороге

ЗОХИЛДОХ *взаим. от* **зохих**, соответствовать друг другу, сочетаться, гармонировать, подходить, годиться, **нэг нь нөгөөтэйгээ ~гүй байна** одно не соответствует другому, одно не сочетается с другим, **бүрэн** ~ целиком, полностью совпадать, **ингэж ~гүй** так не годится, так нельзя поступать

ЗОХИЛДУУЛАХ *побуд. от* **зохилдох**, сочетать, гармонировать, согласовывать, приводить в соответствие

ЗОХИМЖ соответствие, сочетание, гармония, годность, пригодность, ~ **алга** не годится, не подходит, **~оор сайн** годный, хороший

ЗОХИМЖГҮЙ 1) несоответствующий, неподходящий, негодный, 2) неприличный, непристойный, ~ **эд/зүйл** неподходящая вещь, негодный предмет, ~ **юм ярих** говорить что-то неприличное, **над ~ санагдана** мне кажется неприличным/ неподходящим

ЗОХИМЖТОЙ 1) подходящий, размерный, гармоничный, 2) приличный, пристойный

ЗОХИОГДОХ организовываться, проводиться

ЗОХИОГЧ создатель, творец, автор, **~ийн эрх** авторское право, **~ийн гэрчилгээ** авторское свидетельство

ЗОХИОЛ 1. сочинение, произведение, создание, творение, труд, **ардын аман** ~ устное народное творчество, фольклор, **сонгодог утга** ~ классическая литература, **түүвэр** ~ избранные произведения, **үргэлжилсэн үгийн** ~ прозаическое произведение, **хөгжмийн** ~ музыкальное произведение, **хүүхдийн** ~ детская литература, **орчуулгын** ~ переводная литература, **шог** ~ сатира, **ном** ~ книги, ~ **бүтээл** труды, ~ **бичих** писать произведение /сочинение, **~ын хулгай** плагиат

ЗОХИОЛ 2. судьба, **хувь** ~ *парн.* судьба, участь, доля

ЗОХИОЛГОХ *побуд. от* **зохиох**, поручать сочинять, давать составлять, заставлять создавать

ЗОХИОЛЧ писатель, автор, составитель, сочинитель, **залуу ~** *молодой писатель*, **жүжгийн ~** драматург, **хөгжмийн ~** композитор, **хүүхдийн ~** детский писатель, **~дын холбоо** союз писателей, **~ болох** *стать писателем*

ЗОХИОМЖ композиция, структура, построение, **туужийн ~** *композиция повести*

ЗОХИОМОЛ 1) искусственный, неестественный, 2) *придуманный, задуманный, изобретенный, сфабрикованный*, **~ амжилт** бум, **~ шалтаг** придуманная отговорка, **~ хээлтүүлэг** *искусственное осеменение*, **~ хэрэг** *сфабрикованное дело*

ЗОХИОХ сочинять, создавать, творить, конструировать, **ая ~** написать *музыку, сочинять мелодию*, **шүлэг ~** сочинять стихи, **~н бүтээх** конструировать, создавать, **~н байгуулах** организовывать, **~и бүтээгч** создатель, конструктор, **~н байгуулагч** организатор, **~н байгуулах хороо** оргкомитет, **~н байгуулалт** организация, структура, **~н байгуулалтай гэмт хэрэг** *организованная преступность*, **~н бичлэг** сочинение, **~н орчуулах** адаптированный перевод

ЗОХИРОЛ гармония, **~ын их хөг** *муз.* гармонический мажор

ЗОХИС подходящий случай, уместность, *приспособляемость*, **зүй ~оор нь** соответствующим образом

ЗОХИСГҮЙ неподходящий, несоответствующий, *неподобающий*, недопустимый, неприличный, нетактичный, неблагоприятный, неприемлемый, неприлично, нетактично, неприятно, **~ явдал** нетактичный поступок, **~ асуудал** неподходящий/нетактичный вопрос, **~ зан гаргах, ~ авирлах** вести себя нетактично/неприлично, **~ байдалд орох** попадать в неловкое положение

ЗОХИСТ годный, подходящий, благоприятный, удобный, **байдал ~ намар цаг** благодатная осенняя пора, **~ аялгуу** поэзия

ЗОХИСТОЙ соответствующий, целесообразный, подходящий, годный, удобный, приятный, **~ үе** подходящий/удобный, момент, **~ хариу өгөх** дать соответствующий ответ, **ажлын ~ хэлбэр** подходящая форма работы

ЗОХИХ 1) соответствовать, подходить, годиться, 2) соответствующий, целесообразный, подходящий, удобный, **~ арга хэмжээ авах** принимать соответствующие меры, **~ хугацаа** соответствующий срок, подходящее время, **~ хэмжээгээр** в соответствующей мере, **тэгвэл ~но** следует сделать так, так надо, **~ ёсны** надлежащий, **~ ёсоор бүрдүүлсэн** надлежаще оформленный

ЗОХИХГҮЙ 1) быть неподходящим, 2) несоответствующий, неподходящий, нецелесообразный, недопустимый

ЗОХИЦОЛ соответствие, гармония, комбинация, сочетание, совпадение, **өнгөний ~** сочетание цветов, колорит

ЗОХИЦОЛДОО гармония, сочетание, увязка, связь, согласование, **ажлын ~** согласованность работы/в работе

ЗОХИЦОХ соответствовать, сочетаться, совпадать, согласовываться, быть в согласии, **хоорондоо ~** согласоваться между собой, найти общий язык

ЗОХИЦУУЛАГЧ 1) регулировщик, регулятор, координатор, 2) регулирующий, координирующий, **гудамжны хөдөлгөөнийг ~** регулировщик /регулятор уличного движения, **автомат ~** автоматический регулятор, **найдвартай ~** надёжный регулятор

ЗОХИЦУУЛАЛТ согласование, координация, регулирование, регулировка, **~ хийх** провести координацию, делать регулирование, **~ бүхий валютын ханш** регулируемая валюта

ЗОХИЦУУЛАХ *побуд. от* **зохицох** регулировать, координировать, согласовывать, **хоёр талын эрх ашгийг ~** согласовать, интересы обеих сторон, **~дагүй уулзвар** нерегулируемый перекрёсток

ЗОЧИД гости, **~ буудал** гостиница, отель

ЗОЧИН гость, **~ гийчин** *парн.* гости, **хүндэт ~** почётный гость, **~ хүлээн авах** принимать гостей, **~оор очих** идти в гости, **~дын өрөө** гостиная, горница

ЗОЧИР неожиданно, внезапно, вдруг, **~ уур** вспыльчивость, **~ хүн** вспыльчивый горячий человек

ЗОЧИРДОЛ внезапность, неожиданность, **~д орох** быть застигнутым врасплох

ЗОЧИРДОХ 1) быть вспыльчивым, возбуждённым, горячиться, 2) оказываться очень неожиданным, быть слишком внезапным, **битгий зочирд, тайван бай!** не горячись, будь спокойным!

ЗОЧИРХОГ 1) гостеприимный, 2) церемонный, стеснительный

ЗОЧИРХОХ церемониться, стесняться, **та битгий ~оод байгаарай** вы не церемоньтесь!

ЗОЧЛОМТГОЙ гостеприимный, **~ зан/байдал** гостеприимство

ЗОЧЛОХ 1) гостить, быть в гостях, 2) принимать гостей, угощать гостей

ЗОЧЛУУЛАХ *побуд. от* **зочлох** угощаться, быть угощаемым, *принимать угощение*

ЗОЧМОГ внезапно, вдруг, **~ уур** горячность, вспыльчивость

ЗОЧМОГДОХ оказываться слишком внезапным

ЗӨВ правильный, верный, справедливый, точный, правильно, верно, точно, правый, **~ шийдвэр** правильное решение, **~ шаардлага** справедливые требования, **~ зам** верный путь, **~ ярих** *говорить правильно*, **~ бичих дүрэм** орфография, правописание, **маш/тун ~** совершенно верно, **~ үйл** правильный, **~ тал** а) *правая сторона*, б) левая сторона (у верховых животных), **чиний ~** ты прав/права, **нар ~ эргэх** поворачиваться по часовой стрелке, **~ эс болох** *умирать*

ЗӨВДӨХ быть правильным, оказываться верным, оправдываться

ЗӨВЛӨГЧ советник, консультант, инструктор, **техникийн ~** технический советник

ЗӨВЛӨЛ *совет*, **Сайд нарын ~** *Совет министров*, **Аюулгүйн ~** Совет безопасности, **~ийн гишүүн** член совета, **Зөвлөлт Холбоот Улс** *Советский Союз*

ЗӨВЛӨГӨӨ совет, консультация, **эмчийн ~** врачебная консультация, **эмэгтэйчүүдэд ~ өгөх газар** женская консультация, **хуулийн ~ өгөх газар** юридическая консультация, **~ өгөх** дать совет

ЗӨВЛӨГӨӨН совещание, **~д оролцогч** участник конференции, **~ хийх** организовать устроить совещание

ЗӨВЛӨЛДӨХ 1) совещаться, консультироваться, 2) совещательный, консультативный, **~ уулзалт** консультативная встреча, **хоорондоо ~** советоваться, консультироваться друг с другом, **янз бүрийн асуудлаар ~** проконсультироваться по разным вопросам, **~ байгууллага** совещательный орган

ЗӨВЛӨЛТ советский, **~ засаг** советская власть

ЗӨВЛӨМЖ рекомендация, **~ гаргах/батлах** принять/утвердить рекомендацию, **~илсөн шинжтэй** имеющий характер рекомендации

ЗӨВЛӨМЖЛӨХ рекомендовать

ЗӨВЛӨХ 1) советовать, рекомендовать, советоваться, 2) консультант, советник, **~ эрх** право совещательного голоса, **элчин сайдын яамны ~** советник посольства, **~ эмч** врач-консультант,

ЗӨВТГӨХ делать правильным, исправлять, оправдывать, **өөрийгөө/биеэ ~** оправдывать себя

ЗӨВТӨХ оказываться правильным/верным, оправдываться

ЗӨВХӨН только, лишь, один, **би ~ мэдэх гэсэн юм** я только хотел узнать, **~ нэг талд ашигтай хэлцэл** сделка, выгодная только одной стороне, **~ охид иржээ** пришли одни девочки

ЗӨВШИЛДӨӨ согласованность, консенсус

ЗӨВШИЛДӨХ *взаим.от* **зөвших** совещаться, сговариваться, обсуждать, **цаг үеийн асуудлаар** ~ совещаться по текущим вопросам, обсуждать текущие дела, ~ **гэрээ** консенсуальный договор

ЗӨВШИЛЦӨЛ согласование, согласие, ~**ийн үнэ** контрактная (согласованная) цена

ЗӨВШИХ советоваться, обсуждать, совещаться

ЗӨВШӨӨРӨГДӨХ *страд. от* **зөвшөөрөх** разрешаться, быть разрешаемым разрешённым, ~**сөн хэмжээ** разрешённая норма, ~**гүй асуудал** неразрешимый вопрос, ~**сөн зээл** акцетный кредит

ЗӨВШӨӨРӨЛ разрешение, согласие, санкция, позволение, **таны ~өөр** с вашего позволения, ~ **олгох** давать разрешение, ~ **авах/гуйх** взять/просить разрешение, **гаалийн** ~ разрешение таможни, **ачаа олгох** ~ разрешение на выдачу груза

ЗӨВШӨӨРӨЛГҮЙ без разрешения, ~ **орох** войти без разрешения

ЗӨВШӨӨРӨЛТЭЙ с разрешением, **даргын** ~ **хийх** делать с разрешения начальника

ЗӨВШӨӨРӨХ разрешать, позволять, санкционировать, ~**сөн санал** голос «за»

ЗӨВШӨӨХ разрешать, позволять, одобрять, соглашаться

ЗӨГИЙ пчела, пчелиный, **эр** ~ трутень, **хатан** ~ пчёлиная матка, ~**ийн үүр** пчёлиный улей, ~**ийн бал** мёд, ~**ийн аж ахуй** пчеловодство, ~**ий үржүүлэгч** пчеловод, ~**ий тэжээх газар** пасека, пчельник, ~**ийн өвөлжөө** зимовник, омшаник, ~**ийн үрвэлдэй** пчелиный расплод, **шар** ~**ий** оса, ~**ийн уут** пчелиные соты, бїл ~ пчелинная семья.

ЗӨГИЙЧИН пчеловод, пасечник

ЗӨГНӨГДӨХ *страд. от* **зөгнөх** предчувствоваться, заранее ощущаться, предвидеться

ЗӨГНӨГЧ 1) ясновидец, пророк, 2) мечтатель, романтик, фантаст, фантазёр

ЗӨГНӨЛ 1) предчувствие, предвидение, пророчество, 2) мечта, фантазия, **шинжлэх ухааны уран** ~ научная фантастика

ЗӨГНӨЛТ пророческий, утопический, фантастический, ~ **роман** фантастический роман

ЗӨГНӨХ предчувствовать, предвидеть, мечтать, фантазировать, **бороо** ~ предчувствовать дождь, ~**ж хэлэх** предсказать, предугадать, **ирээдүйгээ** ~ мечтать о будущем

ЗӨН 1. предчувствие, предвидение, предзнаменование, чутьё, интуиция, ~ **билэг** *парн.* инстинкт, предвидение, **муу** ~ дурное предчувствие, ~ **билэгт итгэх** верить предчувствиям, ~ **татах** предчувствовать, обладать интуицией/чутьём

ЗӨН 2. воля, произвол

ЗӨНГӨӨР 1) по своей воле, по предчувствию, по интуиции, 2) самотёком, стихиино, само собой, свободно, непроизвольно, ~ **нь байлгах** не трогать, оставлять в покое, ~**өө мэдрэх** предчувствовать, интуитивно предсказывать

ЗӨНД: ~ **нь орхих/тавих** пускать на самотёк, оставлять на произвол судьбы, ~ **нь уух** много пить

ЗӨНДӨӨ очень много, большое количество, уйма, без ограничения, ~ **их ажил** очень много работы, ~ **юм мэдэх** знать очень многое

ЗӨНӨГ 1) старческий маразм, слабоумие, 2) выживший из ума, маразматик, одряхлевший

ЗӨНӨГЛӨХ дряхлеть, впадать в детство, выживать из ума, **биттий ~өөд бай**! не дури!

ЗӨНӨХ дряхлеть, впадать в детство, выживать из ума

ЗӨНЧ предсказатель, пророк, оракул, ~ **Моисей** пророк Моисей

ЗӨӨВӨР кладь, груз

ЗӨӨВӨРЛӨЛТ перевоз, перевозка, возка, **ачаа** ~ перевозка грузов

ЗӨӨВӨРЛӨХ перевозить, транспортировать, **хотоос хөдөөд** ~ перевозить из города в село

ЗӨӨГ остывший, ~ **цай** остывший чай

ЗӨӨГДӨХ 1. быть остывшим, слегка остывать

ЗӨӨГДӨХ 2. *страд. от* **зөөх** перевозиться

ЗӨӨГДҮҮ слегка остывший

ЗӨӨГЧ 1. носильщик, возчик, **ачаа** ~ грузчик, **шуудан** ~ почтальон, **хоол** ~ официант, официантка, **ус** ~ водовоз, **хов** ~ сплетник, сплетница

ЗӨӨГЧ 2. носитель, ~ **пуужин** ракета – носитель, **халдвар** ~ носитель инфекции

ЗӨӨЛДӨХ становиться слишком мягким, быть более мягким, смягчаться

ЗӨӨЛӨВЧ подушка, мягкая подкладка, мягкая обивка, упругая прокладка

ЗӨӨЛӨН мягкий, нежный, тихий, мягко, нежно, тихо, **зөлдэг** ~ **харьцаа** вежливое отношение, ~ **дуу** мягкий голос, приятный голос, ~ **сэтгэл** мягкое сердце, мягкий характер, ~ **харц** нежный взгляд, ~ **уур амьсгал/салхи** мягкий климат, легкий ветерок, ~ **сандал** мягкое кресло, ~ **вагон** мягкий вагон, ~**ий тэмдэг** мягкий знак, ~ **явах** ехать тихо, идти медленно, ~ **гийгүүлэгч** *линг.* мягкий согласный, ~ **бөх** *юм.* сон, ~ **яр** мягкий шанкр

ЗӨӨЛРӨЛТ смягчение, размягчение

ЗӨӨЛРӨХ смягчаться, размягчаться, становиться мягким, становиться тихим/слабым

ЗӨӨЛРҮҮЛЭХ *побуд. от* **зөөлрөх**, смягчать, размягчать, ослаблять

ЗӨӨЛТГӨХ размягчать, смягчать, ослаблять

ЗӨӨЛХӨН мягкий, нежный, тихий, мягче, тихо, ~ **дэр** мягкая подушка

ЗӨӨХ таскать, возить, транспортировать, **машинаар ачаа** ~ перевозить грузы на машине, **ус** ~ таскать воду, **гэртээ ~ж аваачих** приносить домой, **хов** ~ сплетничать, заниматься сплетнями

ЗӨӨХИЙ сметана

ЗӨРЛӨГ перекрёсток, разъезд, узел, **замын** ~ перекрёсток дороги, **төмөр замын** ~ железнодорожный разъезд, узел

ЗӨРӨГ тропа, тропинка, ~**өөр явах** идти тропинкой/по тропинке

ЗӨРӨЛДӨӨН противоречие, разногласие, **үзэл санааны** ~ разногласие во взглядах, ~**ийг арилгах** устранить разногласие, ~**ийг эвлүүлэх** уладить разногласия

ЗӨРӨЛДӨХ 1) перемещаться друг около друга, передвигаться мимо друг друга, 2) противоречить, иметь разногласия

ЗӨРӨМТГИЙ упрямый, непослушный

ЗӨРӨӨ разница, различие, разногласие, **их** ~ большая разница, **насны** ~ разница в годах, **үнийн** ~ разница в цене

ЗӨРӨӨГҮЙ не имеющий разницу/разногласие, без разницы, без разногласия

ЗӨРӨӨТЭЙ имеющий разницу/разногласия, различный, отличительный, разный, ~ **санал** разные мнения/предложения

ЗӨРӨХ 1) разъехаться, разминуться, 2) не соответствовать, противоречить, возражать, не подчиняться, **ам ажил хоёр нь ~ж байна** слова его противоречат его делам, **хажуугаар** ~ проходить мимо, **үгнээс** ~ возражать советам, не послушаться слов, **гар** ~ драться

ЗӨРҮҮ 1. косой, косо расположенный

ЗӨРҮҮ 2. разница

ЗӨРҮҮ 3. упрямый

ЗӨРҮҮД упрямый, упрямо, ~ **зан** упрямство, ~ **хүн** упрямец, упрямица, ~ **загнах** упрямиться

ЗӨРҮҮДЛЭХ упрямствовать, вести себя упрямо, быть непослушным, упрямиться

ЗӨРҮҮЛДЭХ переставлять/перемещать друг около друга

ЗӨРҮҮЛЭХ *побуд. от* **зөрөх**, перемещать/передвигать друг около друга, **~ж хэлэх үг** слово в ответ, возражение, **энгэр ~** *букв.* распахнуть полы одежды друг друга, заниматься любовью, прелюбодействовать

ЗӨРЧИГДӨХ *страд. от* **зөрчих**, нарушаться, не соблюдаться, быть нарушенным/нарушаемым

ЗӨРЧИГЧ нарушитель, **хил ~** нарушитель границы, **хууль ~** правонарушитель, нарушитель закона

ЗӨРЧИЛ противоречие, конфликт, **эвлэршгүй ~** непримиримые противоречия, **ангийн ~** классовые противоречия, **~д орох** впасть в противоречие, **~ арилгах** устранить противоречия

ЗӨРЧИЛГҮЙ не противоречивый, без противоречия, без конфликта

ЗӨРЧИЛДӨӨН противоречие, противоположность, вражда, конфликты, **тэмцэл ~** *парн.* противоборство, вражда

ЗӨРЧИЛДӨХ противоречить друг другу, находиться в противоречии, конфликтовать, **бодит байдалтай ~** противоречить действительности, **бие биедээ ~** противоречить друг другу

ЗӨРЧИЛТ нарушение, несоблюдение, **хил ~** нарушение границы, **дүрэм ~** несоблюдение/нарушение правила, **~ хөгжим** соната

ЗӨРЧИЛТЭЙ противоречивый, конфликтный, противоречиво, **~ асуудал** спорный вопрос, **~ мэдүүлэг** противоречивые показания, **~ баталгаа** противоречивое доказательство, **~ ярих** говорить/рассказывать противоречиво, **~ үзүүлэлт** противоречивые показатели

ЗӨРЧИМТГИЙ часто нарушающий, то и дело нарушающий

ЗӨРЧИХ нарушать, не соблюдать, беспокоить, **хуулыдүрэм ~** нарушать закон/правила, **тангараг ~** нарушать клятву, **нийгмийн хэв журам ~** нарушать общественный порядок, **гэрээний болзлыг ~** нарушить условия договора, **хугацаа ~** нарушение сроков

ЗУГАА развлечение, веселье, забава, **~ гаргах** развлекаться, **хүүхдийн ~** детская забава, **~ цэнгээний гудамж** улица красных фонарей

ЗУГААЛАХ гулять, развлекаться, забавляться, веселиться

ЗУГААЛГА прогулка, гулянье, пикник, **~аа хийх, ~аар явах** ездить на прогулку, организовать прогулку

ЗУГААТАЙ развлекательный, забавный, весёлый, интересный, увлекательный, **~ яриа** увлекательный рассказ

ЗУГААЦАХ веселиться, развлекаться, гулять

ЗУГТААЛГАХ *побуд. от* **зугтаах**, обращать в бегство

ЗУГТААХ бежать, обращаться в бегство, удирать, спасаться бегством, **~ж гарах** а) выбежать, б) спасаться бегством, **тал тал тийшээ ~** разбежаться в разные стороны

ЗУГТАЛТ бегство

ЗУГТАХ бежать, удирать, спасаться бегством

ЗУГУУ не спеша, постепенно, со временем, **уужуу ~** *парн.* постепенно

ЗУГУУХАН довольно степенно, ни чуть не спеша, не торопясь, **~ явах** идти совсем не спеша

ЗУД дзут, бескормица, гололедица, недостаток корма для скота, **~ гачиг, ~ турхан** *парн.* стихийные бедствия, **ган ~** засуха, **~ болох** наступление стихийных бедствий, наступление бескормицы, **~тай тэмцэх** бороться с бескормицей, **цагаан ~** дзут при обилии снега, **хүнд суртлын ~** сплошной бюрократизм, **хариуцлагагүйн ~** сплошное/полное отсутствие ответственности

ЗУЗААВТАР довольно толстый, толстоватый, **~ хувцаслах** одеваться потеплее

ЗУЗААДАХ оказываться толще, чем нужно, быть чрезмерно толстым

ЗУЗААДУУЛАХ *побуд. от* **зузаадах**, делать толще, чем нужно, делать слишком толстым

ЗУЗААЛАХ 1) утолщать, делать толстым, 2) умножать, укреплять, усиливать, **хөрөнгөө ~** умножать/сколотить состояние, **усны даланг ~** укреплять дамбу/насыпь, **хүчээ ~** укреплять силу

ЗУЗААЛГА утолщение, укрепление

ЗУЗААН 1. 1) толстый, 2) толщина, **~ нимгэн** *парн.* толщина, **~ цай** *кирпичный* чай, **~ыг нь хэмжих** измерять толщину чего-нибудь

ЗУЗААН 2. прочный, крепкий, верный, близкий, **~ найрамдал** крепкая дружба, **~ нөхөр/найз** верный, близкий друг, **~ амраг** возлюбленный/возлюбленная, **~ холбоо тогтоох** установить прочную связь

ЗУЗААН 3. *геол.* мощность, **харагдах ~** мощность видимая, **судлын ~** мощность жилы

ЗУЗААНДУУ толстоватый

ЗУЗААРАХ 1) становиться толстым, толстеть, утолщаться, стать толще, 2) усиливаться, укрепляться, умножаться, **бие ~** толстеть, **үүл ~в** облака сгустились

ЗУЗААСАХ 1) делаться толстым, стать потолще, 2) ещё более укрепляться

ЗУЗААТАХ 1) утолщаться, 2) укрепляться, усиливаться

ЗУЗААТГАЛ 1) утолщение, 2) укрепление, усиление

ЗУЗААТГАХ 1) утолщать, 2) укреплять, усиливать

ЗУЗААХАН толстенький

ЗУЛ лампадка, жировая лампа, **~ барих/өргөх** зажигать лампадку, **сэтгэлийн ~ өргөе** душевно помянем, **~ бөхөх/жаргах/унтрах** гаснуть (о лампадке), **~ын цөгц** чашечка для лампадки, **~ сар** первый зимний месяц по лунному календарю, **алтан ~ цэцэг** тюльпан, **~ сарын баяр** рождество

ЗУЛАЙ темя, макушка, родничок, **нялх хүүхдийн ~** родничок младенца, **~ ~гаа гишгэн гарах** рождаться один за другим (от одной матери)

ЗУЛАХ раскладывать слоем, чесать, **ноос ~** раскладывать слоем шерсть для валяния, **дээлэнд хөвөн ~** раскладывать вату для подкладки дэли

ЗУЛБАА выкидыш

ЗУДБАДАГ каракульча, шерсть на вырост

ЗУЛБАЛТ выкидыш, аборт, **тулгарсан ~** *мед.* угрожающий аборт

ЗУЛБАХ 1. выкидыш, недоносок

ЗУЛБАХ 2. линять, менять кожу

ЗУЛБАХ 3. *перен.* убегать, спасаться бегством

ЗУЛГА *частица усиления при глаголах, часто соответствующая приставкам:* вы-, на-, **~ татах** выдернуть, вырвать, снимать кожу, **~ маажих** выцарапывать, **~ угаах** вымыть

ЗУЛГААГДАХ *страд. от* **зулгаах**, выдёргиваться, выщипываться, вырываться, **үндсээрээ/үндэстэйгээ ~** вырываться/выдернуться с корнем

ЗУЛГААХ теребить, выдёргивать, рвать, выдирать, полоть, **өвс ~** полоть траву, **үсээ ~** теребить волосы, рвать волосы, **гараараа ~** рвать руками

ЗУЛГАЛАХ 1) сдирать покров, снимать покров, отделить с поверхности, 2) сдирочный, **~ багаж** сдирочный инструмент

ЗУЛГАРАХ вылезать, выпадать (о шерсти, волосах), линять

ЗУЛГУЙ 1) льстивость, вкрадчивость, хитрость, 2) льстивый, вкрадчивый, хитрый, **~ зан** льстивое поведение, вкрадчивый характер, **зусар ~** *парн.* заискивание, подхалимство, льстивость

ЗУЛГУЙДАХ заискивать, подлизывать, льстить, подхалимничать, **зусардан ~** подхалимничать

ЗУЛЗАГА (н) 1) детёныш животных, *передаётся также суффиксом* -ёнок, -онок, 2) молодая поросль, **барын ~** тигрёнок, **арслангийн ~** львёнок, **~н мод** молодое дерево

ЗУЛЗГАЛАХ 1) приносить детёнышей, давать приплод (о диких животных), щениться, котиться, 2) распускаться, **мод ~в** деревья распустились
ЗУМЛАХ облив кипятком, выдёргивать шерсть, перья, ошпаривать, очищать от шерсти, обваривать
ЗУМРАХ ошпариваться, обвариваться, лезть (о шерсти), линять
ЗУН лето, **~ цаг** летнее время, **~ы амралт** летние каникулы
ЗУНГАГ 1) первородный кал новорождённого, 2) кал молодняка животных, 3) ленолин, жиропот
ЗУНЖИН всё лето, целое лето, в течение всего лета, **~ амрах** отдыхать всё лето
ЗУНШИХ становиться по-летнему, устанавливаться (о лете)
ЗУНШЛАГА установление летней погоды, природные условия в летний период, **~ сайтай газар/нутаг** местность с хорошими летними условиями
ЗУРАА бедренный канал у скота, **гуяны ~** *анат.* бедренный канал, **уулын ~** ровный горный овраг
ЗУРААДАС штрих
ЗУРААС черта, линия, тире, дефис, чёрточка, **цэг ~** точка и тире, **~ гаргах** проводить черту, штриховать
ЗУРААЧ художник, чертёжник, **уран ~** живописец, художник, **~ болох** стать художником
ЗУРАГ 1. рисунок, картина, снимок, карта, фотография, портрет, чертёж, **монгол ~** стиль монгольского изобразительного искусства, **шог ~** карикатура, шарж, **шугам ~** черчение, **~ зурах** рисовать, писать картину, **зураасан ~** графика, **~ийн хуар шиг** прелестная, красивая, **~ авах** снимать, фотографировать, **~ийн багш** учитель рисования, **~ийн дарга** директор картины, **ашигт малтмалын ~** карта полезных ископаемых
ЗУРАГ 2. судьба, участь, **~ тавилан** *парн.* фортуна, участь, предначертание
ЗУРАГДАХ *страд. от* **зурах**, рисоваться, быть рисованным, зургадсан пянз заезженная пластинка
ЗУРАГЗҮЙ картография
ЗУРАГЛАЛ зарисовка, рисунок, **өвлийн ~** зимний пейзаж
ЗУРАГЛАХ зарисовать, делать рисунок, изображать/запечатлеть рисунком, **~н хэрээлах** обрисовывать, изображать кистью
ЗУРАГТ с рисунком, иллюстрированный, **~ сэтгүүл** иллюстрированный журнал, **~ хуудас** плакат, **~ үзэх** смотреть телевизор, **~ын хөтөлбөр** телевизионная программа, программа телепередачи, **~ын нэвтрүүлэг** телепередача, **~ын цамхаг** телевышка
ЗУРАГТАЙ с рисунками, с иллюстрациями
ЗУРАГЧ рисующий, рисовальщик
ЗУРАГЧИН фотограф
ЗУРАГЧЛАЛ начертание, графическое изображение, рисунок
ЗУРАЙХ рисоваться, вырисовываться, виднеться, ясно обозначаться, **алсад зам ~на** вдали ясно виднеется дорога
ЗУРАМ суслик, **~ны арьс** сусличья шкурка
ЗУРАХ 1. рисовать, чертить, **гарын үсэг ~** расписаться, подписать
ЗУРАХ 2. чиркать, **чүдэнз ~** чиркать спичками
ЗУРВАС 1) полоса, 2) записка, **~ газар** полоса земли, **~ явуулах/илгээх** отправить записку
ЗУРВАСЛАХ разделывать/разрезать на полосы
ЗУРВАСХАН полоска, **~ газар** полоска земли, ограниченный участок
ЗУРГАА (н) шесть, шестой, **~ дахин** шесть раз, шестикратно, **~н талт** шестигранный, **~н (яам)** министерство во времена Автономной Монголии
ЗУРГААДАЙ: **~ таяг** трость, посох
ЗУРГАА ДАХЬ шестой, **~ орц** шестой подъезд
ЗУРГААТАЙ 1) шестилетний (о возрасте), 2) имеется шесть штучек/экземпляров кого-, чего-либо, **~ хүү** шестилетний мальчик
ЗУРГАДУГААР шестой, **~ сар** июнь
ЗУРГУУЛ (аа) вшестером, все шесть, *муз.* секстет
ЗУРЛАГА рисование, черчение
ЗУРМАЛ нарисованный, **~ хөрөг** нарисованный портрет
ЗУРУУЛ: **чүдэнзний ~** тёрка спичечная
ЗУРХАЙ астрология, математика, **~н ном** книга перемен
ЗУРХАЙЧ астролог
ЗУРШИЛ привычка, уклад, **муу ~** дурная/плохая привычка, **тамхи татах ~** привычка курить
ЗУРШИХ привыкать, усваивать привычку
ЗУРШМАЛ привычный, вошедший в обыкновение, ставший привычкой, **~ үзэгдэл** привычное явление
ЗУСААЛ: **~ морь** заезженная в летнее время лошадь
ЗУСАГ впервые суягная, **~ ямаа** впервые суягная коза
ЗУСАР лесть, заискивание, подхалимство, **~ бялдууч** подхалим
ЗУСАРДАГЧ подхалим, льстец
ЗУСАРДАЛ подхалимство, лесть
ЗУСАРДАХ подхалимствовать, льстить, заискивать
ЗУСАРЧ подхалим, льстец
ЗУСАРЧЛАХ подхалимствовать, льстить, заискивать
ЗУСАХ проводить лето, летовать, **зусланд ~** проводить лето на даче/на летнем стойбище
ЗУСЛАН 1) дача, 2) летнее местожительство, летнее стойбище, **~д гарах** выехать на дачу, жить на даче
ЗУТАН 1. кашица, болтушка, **~тай цай** чай-болтушка
ЗУТАН 2. *геол.* клинкер
ЗУУ (н) 1. 1) сто, 2) век, столетие, **~н мянга** сто тысяч, **~ жил** сто лет, **~н наст** *бот.* агава алоэ, **~н хурга** *зоол.* травник красноножка, **дундад ~н** средний век, **хорин нэгдүгээр ~н** двадцать первый век, **«~н хорин мянгат»** «сто двадцатитысячник» – название района в Улан-Баторе площадью в 120 тыс. м^2
ЗУУ 2.: **~ ~ —** возглас, которым подзывают коз
ЗУУ 3. одно из имён Будды
ЗУУВАН эллипс, овальный, продолговатый, **~ толь** овальное зеркало
ЗУУВАНДАХ делаться овальным, стать слегка овальным
ЗУУВАНДУУ слегка овальный, **~ царайтай/нүүртэй** со слегка овальным лицом
ЗУУГААД 1) по сто, 2) около ста
ЗУУ ДАХЬ сотый, **~ удаагаа** сотый раз
ЗУУДУГААР сотый, **~ хуудас** сотая страница
ЗУУЗАЙ 1. кольца удил, **~ холбох** *перен.* прибежать, прибыть к финишу одновременно (о беговых лошадях)
ЗУУЗАЙ 2. задник обуви
ЗУУЛГАХ *побуд. от* **зуух**, быть искусанным, быть укусанным, **нохойд ~** быть искусанным собакой, **аяганы амсар ~** давать чашку чая
ЗУУЛГА: **амь ~** существование, жизнь
ЗУУЛТ укус, кусание, зажим зубами
ЗУУНТАА сто раз
ЗУУР 1) дорогой, по пути, 2) во время, когда, между тем как, при, **гэр ~ байх** находиться дома, никуда не идти, **зам ~** по пути, по дороге, **түр ~** кратковременно, временно, **нүд ирмэх ~** моментально, вмиг, **хоромхон ~** мгновенно, моментально, **агшин ~** мгновение, мгновенно
ЗУУРАЛДАХ *взаим. от* **зуурах 1 и 2**, становиться вязким, густым, держаться друг за друга, возиться, бороться, **гэрийн ажилтай ~** возиться домашним хозяйством
ЗУУРАЛТ схватка, клейкость, липкость

ЗУУРАХ 1. месить, мешать, **гурил ~** месить тесто, **шавар ~** месить глину

ЗУУРАХ 2. цепляться, сжимать, держаться зацепившись, непроизвольно стискивать, **шүд ~** непроизвольно стискивать зубы, **гараас ~** цепляться за руку

ЗУУРД промежуточный, средний, преждевременный, **~ын ганцхан шөнө чинь Зуун алтан зоосны үнэтэй (Рубоко Шо)** Мимолётная ночь с тобой дороже сотен золотых монет, **~аар нас барах** преждевременно скончаться, **~ын нас** 49 дней *после смерти*

ЗУУРМАГ 1. недоведённый до конца, недоделанный, незаконченный

ЗУУРМАГ 2. 1) тесто, раствор, 2) замешанный, **цементийн ~** цементное тесто, **шохойн ~** известковый раствор, **~ийн машин** цементомешалка

ЗУУРМАГЛАХ 1. оставлять недоделанным, недоделать, не закончить, не доводить до конца

ЗУУРМАГЛАХ 2. вымешивать, месить, мешать

ЗУУРМАЛ 1) замешенный (напр. о тесте), паста, 2) растёртый (напр. о краске), **~ шавар** вымешенная глина

ЗУУТ 1) сотня, войсковое подразделение, 2) денежный знак в сто тугриков, сотня

ЗУУХ 1. печь, печка, **төмөр ~** железная печка, **гал ~** кухня

ЗУУХ 2. 1) держать в зубах, схватывать зубами, 2) кусать, **шүд ~** а) стиснуть зубы, б) злиться, таить злобу

ЗУУХ 3.: **амь ~** жить, существовать

ЗУУХЧ печник

ЗУУЧ посредник, брокер, сват, сводник, **~ шүүгч** третейский судья

ЗУУЧЛАГЧ посредник, брокер, маклер

ЗУУЧЛАЛ посредничество

ЗУУЧЛАХ посредничать, быть посредником, сводить

ЗУУШ закуска, **хүйтэн ~** холодная закуска, **~ны газар** закусочная

ЗҮВ *усилительная частица к слову:* **зүгээр: ~ зүгээр** а) абсолютно *ничего*, б) никакой цели, б) совершенно здорово, в) совсем бездейственно, **би ~ зүгээр ирлээ** я прищёл просто так

ЗҮГ 1. сторона, направление, **~ чиг** направление, **~ бүрт** во всех направлениях, **~ бүрээс** со всех сторон, **~ чигээ олох** ориентироваться, **~ чигээ алдах** потерять ориентировку, **урд ~ээс** с южной стороны

ЗҮГ 2. просто, просто так, без причины, без определённой цели, **би ~ явна** я иду просто так, без особого намерения, **буян хишгийн ~** наилучшее направление при возвращении, **~ даргах** обычай направляться утром первого *дня нового года* по восточному календарю в ту сторону, где загадано найти счастье

ЗҮГҮЙ 1) шаловливый, проказливый, 2) чрезвычайно, очень много, **~ жаал** проказливый ребёнок, **~ их ажил** очень много работы

ЗҮГҮЙРХЭЛ шалость, шаловливость, проказа, проделка

ЗҮГҮЙРХЭХ шалить, проказничать, дурачиться

ЗҮГҮЙТЭХ вести себя шаловливо, шалить, проказничать, **биттий ~ээд бай!** не шали, не валяй дурака!

ЗҮГЛҮҮЛЭХ *побуд. от* **зүглэх**, направлять куда-либо, устремлять

ЗҮГЛЭХ держать направление, направляться, идти по направлению к кому, чему-нибудь, **баруун тийш ~** идти на запад, держать направление на запад

ЗҮГШРҮҮЛЭХ *побуд. от* **зүгшрэх**, приучать, научить, наладить, заставлять привыкнуть, **хэл ~ хэллэг** скороговорка

ЗҮГШРЭЛ привычка, усвоение привычки, приобретение навыка

ЗҮГШРЭХ 1) приучаться, привыкать к чему-нибудь, 2) находить правильное направление, находить свой путь, **ажилд ~** привыкать к работе, научиться работе, научиться работать, 3) привыкать к седлу, упряжи (о лошади и вьючных животных)

ЗҮГЭЭР 1) обыкновенный, простой, обычный, сносный, 2) ничего, так себе, просто так, 3) бесплатно, даром, безвозмездно, **~ зантай хүн** человек со сносным характером, **~ залуу** хороший парень, хороший парень, простой парень, **~ бай!** оставь! не балуйся! **~,** ~ ничего, ничего, **~, яахав** ну, так себе, **~ суух** сидеть без дела, сидеть просто так, ничем не занимаясь, **~ өгөх** дать даром, бесплатно, **~ болох** стать обычным, становиться нормальным

ЗҮГЭЭРГҮЙ 1) необыкновенный, необычный, 2) шаловливый, проказливый, 3) таинственный, подозрительный, **~ хүүхэд** *шаловливый/непростой ребёнок*, **тэр хоёр лав ~ байх** *разг.* пожалуй, в их отношениях есть что-то интимное/подозрительное

ЗҮДРҮҮ слабый, усталый, истощённый, изнеможённый, **царай чинь ~ байна** ты выглядишь утомлённо

ЗҮДРЭЛ усталость, истощённость, изнурение, *изнеможение*, **зовлон ~** *парн.* мука, изнурение, **~ үзэх** испытывать усталость/изнурение

ЗҮДРЭХ изнуряться, изматываться, изнемогать, утомляться, **өвдөж ~** быть изнурённым болезнью, **замд их ~лээ** дорога сильно утомила

ЗҮДРЭЭ усталость, утомление, **~ гараагүй байна** усталость ещё не прошла

ЗҮДРЭЭХ изнурять, изматывать, утомлять, **биеэ ~ хэрэггүй** не надо утомлять себя

ЗҮДҮҮ 1) бедный, бедственный, 2) слабый, хворый, **ядуу ~ амьдрал** бедность, нищая жизнь, **ядуу ~ аж төрөх** жить в нищете

ЗҮДҮҮР истощение, усталость, истощённость, изнурение, **зовлон ~ амсах** испытывать муки, страдать, мучиться, терпеть страдания

ЗҮДҮҮРТЭЙ трудный, тягостный, тяжкий, изнурительный

ЗҮДЭРГЭХ изматывать, изнурить, доводить до изнеможения

ЗҮДЭРГЭЭ истощение, утомление, ослабление сил, **ядаргаа ~** *парн.* усталость, слабость

ЗҮДЭРГЭЭГҮЙ лёгкий, простой, несложный, неутомительный

ЗҮДЭРГЭЭТЭЙ утомительный, утомляющий, изнурительный, **~ ажил** изнурительный труд, утомительная работа, **явахад ~** утомительный для езды

ЗҮДЭХ истощаться, ослабевать, обессиливаться, изнуряться

ЗҮЙ сущность, принцип, приличие, пристойность, **~ бус** *непристойный, незаконный*, **~ ёс** правномерность, **~ ёсны** законный, **~ зохис** должный порядок, **~ тогтоол** закономерность, **учир ~** суть, сущность, причина, **хэргийн учир ~** суть дела, **~ зохисгүй авирлах** вести себя неприлично, **арга ~** методология, метод, **~ нийцэх** быть правым

ЗҮЙГҮЙ непристойный, неприличный, **~ үг** неприличные слова, **~ аяш авир** непристойное поведение, **~ явдал** неприличный поступок

ЗҮЙДЭЛ 1) шов, 2) надставка, приставка, надставленный кусок, **ханцуйны ~** надставка рукавов, *приставка материи к рукавам*, **Тэнгэрийн ~** *астр.* Млечный путь

ЗҮЙДЭЛГҮЙ не имеющий надставки/приставки, без шва, безшовный

ЗҮЙДЭЛТЭЙ надставленный, имеющий приставку, состоящий из кусков

ЗҮЙЛ 1) сорт, род, разряд, категория, вид, разновидность, 2) статья, пункт, параграф, вопрос, 3) вещь, предмет, 4) явление, случай, **анги ~** часть, **элдэв ~ийн бараа** всякого рода товары, **архины ~** алкогольные напитки, **эмийн ~** медикаменты, **хүнсний ~** продовольственные товары, **~ бүрийн** всякого рода,

всякие, различные, **хэрэгцээний ~с** предметы потребления, **хуулийн ~** статья закона, **хэлэлцэх ~** повестка дня, вопросы, подлежащие обсуждению, **аар саар ~** мелочь, **жижиг ~** обычное явление, **хачин ~** странное явление, **сонирхолтой ~** интересный случай, примечательный факт, **тэсрэх дэлбэрэх ~** взрывчатые вещества, взрывчатки, **шинэ ~** новшество, нововведение, **судалгааны шинэлэг ~** новизна исследования

ЗҮЙЛГҮЙ: **өөр ~** а) всё, всё исчерпано, б) больше нечего сказать, **гайхах ~** нечему удивляться

ЗҮЙМЭЛ составленный из отдельных кусков, составной, надставной, **~ шал** паркет

ЗҮЙР сравнение, сопоставление, **~ үг** поговорка

ЗҮЙРГҮЙ несравнимый, несравненный, несопоставимый, непохожий, несравнимо, несравненно, несовопоставимо, **~ шударга хүн** несравнимо честный человек, **~ дээр** несравнимо лучше, куда лучше

ЗҮЙРЛЭЛ сравнение, **ухаалаг ~** остроумное сравнение, **аман зохиол ~ээр элбэг** фольклор изобилует сравнениями

ЗҮЙРЛЭХ сравнивать, сопоставлять, **чамтай ~гүй** не сравним с тобой, не сравнить с тобой, **юмыг хооронд нь ~** сравнить вещи между собой

ЗҮЙРЛЭШГҮЙ несравненный, несравнимый, несравненно, несравнимо, **~ авьяас** несравненный талант, **~ сайн** несравненно лучше, **~ хурдан хийх** несравненно быстро сделать, **~ хайр** несравненная любовь, любовь, которую трудно представить

ЗҮЙТЭЙ верный, правильный, целесообразный, справедливый, **~ шийдвэр** правильное решение, **~ арга хэмжээ** справедливые меры, **туйлын ~** совершенно справедливо, **~ гэж үзэх** считать целесообразным/правильным

ЗҮЙХ составлять из отдельных частей, надставлять, приставлять, **дээлийн хормойг уртасган өөдөс ~жээ** чтобы удлинить полы дэли приставили кусок материи

ЗҮЙЧ: **хэл~** грамматист, **агнуур ~** охотовед

ЗҮЛГҮҮР 1) наждак, наждачная бумага, песочная бумага, полировальник, 2) щётка

ЗҮЛГҮҮРДЭХ чистить наждаком, тереть стеклянной бумагой, **мод ~** шлифовать дерево наждачной бумагой

ЗҮЛГЭЛТ полировка, шлифовка

ЗҮЛГЭГЧ шлифовальщик, шлифовщик, полировщик

ЗҮЛГЭГДЭХ *страд. от* **зүлгэх**, полироваться, шлифоваться, тереться

ЗҮЛГЭХ полировать, шлифовать, тереть, обтирать, чистить, прочищать, **арчиж ~** чистить, прочищать, **үрж ~** тереть, обтирать, **шил ~** шлифовать стекло, **ширээ ~** полировать стол

ЗҮЛД часть туши, как правило голова, сердце, которые вручаются охотнику, убившему дичь

ЗҮЛЭГ луг, мурава, луговина, дёрн, газон, **~ ногоо, ширэг ~** *парн.* зелёный луг, газон, дёрн, **ногоон ~** зелёная трава, зелёный газон, **~ суулгах** облагать дёрном, покрывать дёрном, **~ дээгүүр явж болохгүй!** не ходить по газонам! по газонам ходить воспрещается! **~ мөрөн** река Лена

ЗҮЛЭГЖИХ покрываться зелёной травой/газоном

ЗҮЛЭГЖҮҮЛЭХ озеленять

ЗҮРЖ апельсин

ЗҮРХ 1) сердце, 2) храбрость, смелость, **~ сэтгэл/сэтгэл ~** *парн.* сердце, душа, **~ний цохилт** сердцебиение, **~ний гэм/гажиг** порок сердца, **~ний шигдээс** инфаркт, **~ний амраг** любимый человек, возлюбленный, **чин ~ний үгээс** от всего сердца, от чистого сердца, **~ аман дээр гарах** быть в отчаянии, испуге, **чин ~ний баяр** чистосердечный привет, **~ээ барих** подавлять свои чувства, не терять присутствия духа, **~ дэлбэрэх** разрыв сердца, **~ алдах/шантрах/үхэх/мохох** робеть, трусить, не осмеливаться, бояться, **~ маажих** волновать сердце, душу, **~ орох** набраться храбрости, **~ гаргах** осмеливаться, отважиться, рисковать, **~ хүрэхгүй, ~ муутай** не осмеливаться, бояться, **~нд шар ус хуруулах** заставить испытывать щемящее чувство боли, тревоги, **~ний хийтэй** стервозный

ЗҮРХГҮЙ несмелый, робкий, трусливый, боязливый, нерешительный, **~ эр** трусливый мужчина, **хэлэх ~ байх** не набраться/не хватать смелости сказать, не осмеливаться говорить

ЗҮРХЛЭХ сметь, смелеть, отваживаться, решаться, набираться храбрости, храбриться, рисковать, **чи наашаа яаж ирж ~в?** как ты посмел приехать сюда? **би хэлж ~сэнгүй** я не посмел сказать, у меня не хватило смелости сказать, **хийхээр ~** решиться сделать, рисковать сделать, **~ээд алдах уу/үзэх үү?** рискнём что ли?

ЗҮРХТЭЙ 1) смелый, храбрый, отважный, решительный, 2) *перен.* рискованный, жестокий, глупый, **~ явдал** смелый поступок, рискованный поступок, **их ~** очень смелый, бесстрашный, **том/бөх ~** бесстрашный, неустрашимый, **туулай ~** робкий, трусливый, **чулуун ~, хатуу ~** жестокий, бессердечный

ЗҮРХТЭН смельчак, не робкого десятка

ЗҮРХШИХ робеть, не набираться смелости, не осмеливаться, трусить

ЗҮРХШЭЭХ бояться, не отваживаться, не решаться, чувствовать робость

ЗҮС 1.: **~ бороо** умеренный, продолжительный дождь, обложные дожди

ЗҮС 2. внешность, внешний вид, цвет кожи, лицо, масть, **~ царай** лицо, внешний вид, **өнгө ~** цвет и внешность, **~ үзэсн хүн** знакомое лицо, **~ буруу** необычной масти, совсем другого цвета, неоднородной масти, **малын ~** масть животных, **хар ~мийн морь** вороной конь, лошадь вороной масти

ЗҮСГҮЙ плохого цвета, неважной внешности, **царай ~** некрасивый, не смотрящийся

ЗҮСЛҮҮЛЭХ *побуд. от* **зүслэх**, давать запоминать, заставлять запоминать по цвету, по масти

ЗҮСЛЭГДЭХ *страд. от* **зүслэх**, запоминаться по внешности/по масти, быть узнаваемым по внешности

ЗҮСЛЭГ разрез, **хөндлөн ~** поперечный разрез, **дагуу/уртаашаа ~** продольный разрез

ЗҮСЛЭХ 1) различать по масти, по цвету, определять по внешности, узнавать по предметам, запоминать цвет кожи/масть, 2) конкретно показывать кому-либо что-нибудь в качестве дара или для передачи, **мал ~** а) определить, узнать скот по масти, б) обещать показать кому-либо скот в качестве дара

ЗҮСМЭЛ разрезанный полосками/кусками, нарезанный кусками, распилённый, **~ банз** распилённая доска, пиловочник

ЗҮСРЭХ идти умеренно и продолжительно (о дожде), **бороо ~ч байна** дождь затянулся, зачастил

ЗҮСТЭЙ хорошей внешности, имеющий какой-либо цвет

ЗҮСҮҮР режущий инструмент, резак

ЗҮСЭГДЭХ *страд. от* **зүсэх**, разрезаться, вырезаться, быть разрезанным

ЗҮСЭГЧ режущий, распиловщик, **~ хутга** режущее лезвие, **атомын мөс ~ хөлөг онгоц** атомный ледокол

ЗҮСЭЛТ резка, резание, разрез, **босоо ~** *спец.* вертикальный разрез чего-либо, **металл ~** резание металлов, **хажуугийн ~** разрез боковой, **хөндлөн ~** разрез поперечный

ЗҮСЭМ 1. масть животных

ЗҮСЭМ 2. кусок, ломоть, **~ талх** кусок/ломоть хлеба, **~ ~ээр хуваах** разбить на куски

ЗҮСЭХ 1) резать ломтями, разрезать в длину, нарезать, 2) разрезать, рассекать, разделять, **урташ нь ~** разрезать вдоль, **талх ~** нарезать хлеб, **хуруугаа ~** порезать/рассечь палец, **агаар**

~ рассекать воздух, **төмөр** ~ резать железо, **олны дундуур ~ж гарах** прорываться сквозь толпу

ЗҮТГҮҮР 1) упрямый, неуступчивый, упорный, настойчивый, 2) вызывающий усилия, требующий большого труда, 3) тяга, **цахилгаан** ~ электрическая тяга, **галт тэрэгний** ~ локомотив поезда, **~ийн депо** локомотивное депо

ЗҮТГЭГЧ: хамтран ~ соратник, соратница, сподвижники

ЗҮТГЭЛ усилие, усердие, старание, **гавьяа зүтгэл** заслуга, **хичээл** ~ усердие, ~ **гаргах** прилагать усилие

ЗҮТГЭЛТЭЙ усердный, старательный, с усердием, ~ **ажиллах** работать с усердием, усердно работать

ЗҮТГЭЛТЭН деятель, **төрийн** ~ государственный деятель, **урлагийн гавьяат** ~ заслуженный деятель искусства

ЗҮТГЭМТГИЙ усердный, упорный, настойчивый

ЗҮТГЭХ тянуть, тащить, напрягаться, стараться, усердствовать, стремиться, ~ **мал** тягловый скот, рабочий скот, **чармайн** ~ усердствовать, сильно стараться, **хүчин** ~ напрягать силы, прилагать усилия

ЗҮҮ 1. игла, иголка, стрела, ~ **хуруувч** набор для шитья, **нэхмэлийн** ~ вязальная игла, **тарианы** ~ игла для укола, **сүлбээр** ~ булавка английская, **энгэрийн** ~ брошка, **~ний сүвэгч** ушко *для иглы, игольное ушко,* **~гээр хатгах** *проколоть* иголкой, ~ **ороох** заниматься рукоделием, ~ **эмчилгээ** иглотерапия, ~ **тавих** ставить иголки, ~ **орох зайгүй** водой не разольёшь, душа в душу

ЗҮҮ 2.: **заа** ~ **болох** *разг.* конкретно договариваться, точно уславливаться

ЗҮҮ 3. стрелка (часов)

ЗҮҮВЧ игольник, коробка/подушка для хранения игл

ЗҮҮГДЭХ *страд. от* **зүүх**, подвешиваться, привешиваться, цепляться, повиснуться

ЗҮҮГЧ: нэр ~ самозванец

ЗҮҮД сон, сновидение, ~ **нойр** *парн.* сон, ~ **зүүдлэх** видеть во сне, **~ндээ үзэх** *видеть во сне, видеть сон,* **энэ миний ~нд ч орсонгүй** это мне даже не снилось, **«Зүүдэнд оромгүй явдал»** «Вам и не снилось»

ЗҮҮДЛЭГДЭХ *страд. от* **зүүдлэх**, быть увиденным во сне

ЗҮҮДЛЭХ сниться, видеть сон, видеть во сне

ЗҮҮЛГЭХ *побуд. от* **зүүх**, привешивать, навешивать, прикреплять что-либо кому-нибудь

ЗҮҮЛТ 1) привесок, подвесок, украшение, 2) сноска, **хүзүүний** ~ ожерелье, **алтан гинжин** ~ золотая цепочка, **өгүүллийн** ~ сноски к статье

ЗҮҮН 1) восток, 2) восточный, 3) левый, **хотын** ~ **хэсэг** восточная часть города, ~ **хил хязгаар** восточная граница, ~ **зүг** восток, восточный, ~ **гар** левая рука, ~ **тал** левая сторона, **~ий нугалаа** левый уклон, левизна, ~ **гарын улс** Джунгария, ~ **хиурын орд** Созвездие Стрела, ~ **оргилогийн орд** Созвездие хамелеон

ЗҮҮНТЭЭ налево, на левой стороне, ~ **явах** идти налево, ~ **бий** находится на левой стороне

ЗҮҮРМЭГЛЭХ дремать, вздремнуть, **би ~ээд авав** я вздремнул

ЗҮҮХ привешивать, пристёгивать, нацеплять, носить, надевать, **одон** ~ носить орден, **шил** ~ надевать очки, **цаг** ~ носить часы, **бөгж** ~ надевать/носить кольцо, **буу зэвсэг** ~ носить оружие

ЗҮХЭЛ проклятие, брань

ЗҮХЭХ *проклинать,* бранить, ругать, **харааж ~, занаж** ~ бранить, проклинать, поносить по чём свет стоит

ЗҮЧЭЭ конюшня

ЗЭВ 1. остриё, наконечник, **сумны** ~ остриё стрелы

ЗЭВ 2. ржавчина, **~д идэгдсэн** изъеденный ржавчиной, ~ **идэх** покрываться ржавчиной, **~тэй хадаас** ржавый гвоздь

ЗЭВРҮҮН прохладный, прохладно, **өнөөдөр нэлээд ~ байна** сегодня довольно прохладно

ЗЭВРҮҮХЭН холодноватый, прохладноватый, довольно прохладный, прохладновато, довольно прохладно, ~ **шөнө** прохладная ночь

ЗЭВРЭХ 1. ржаветь, **~дэггүй ган** нержавеющая сталь

ЗЭВРЭХ 2. быть прохладным, делаться холодноватым

ЗЭВСЭГ 1) оружие, 2) орудие, инструмент, приспособление, инвентарь, **зэр ~, буу** ~ оружие, вооружение, **галт** ~ огнестрельное оружие, **хүйтэн** ~ холодное оружие, **атомын/цөмийн** ~ атомное/ядерное оружие, **стратегийн** ~ стратегическое оружие, ~ **хураах** а) разоружать, б) разоружение, **хүнийг олноор устгах** ~ оружие массового уничтожения, ~ **барих** браться за оружие, **~ээ хураалгах/хаях** сложить оружие, положить оружие, **~ийн агуулах** арсенал, **хөдөлмөрийн багаж** ~ орудие труда, **үйлдвэрлэлийн багаж** ~ *орудие производства,* **чулуун ~ийн үе** каменный век, **хөгжмийн** ~ музыкальные инструменты

ЗЭВСЭГГҮЙ безоружный, невооружённый, ~ **хүн** а) безоружный человек, б) человек без орудия труда

ЗЭВСЭГЖИХ вооружаться, стать вооружённым, приобретать оружие

ЗЭВСЭГЖҮҮЛЭХ *побуд. от* **зэвсэгжих**, вооружать, снабжать вооружением

ЗЭВСЭГЛЭГДЭХ *страд. от* **зэвсэглэх**, вооружаться, быть вооружённым, оснащаться, **орчин үеийн техникээр** ~ оснащаться/вооружаться современной техникой

ЗЭВСЭГЛЭЛ *вооружение,* **~ээр хөөцөлдөх** *гонка вооружений,* **~ийг хорогдуулах** сокращение вооружений, **~ийг бүх нийтээр бүрэн хураах** всеобщее и полное разоружение

ЗЭВСЭГЛЭЛТ вооружение, вооружённость

ЗЭВСЭГЛЭХ вооружаться, вооружать, снабжаться вооружением, оснащаться, **орчин үеийн техникээр ~сэн** вооружённый современной техникой, **мэдлэгээр** ~ вооружаться знаниями, **~сэн гэмт хэрэгтэн** вооружённый преступник, **шүдээ хүртэл ~сэн** вооружённый до зубов

ЗЭВСЭГТ вооружённый, ~ **хүчин** вооружённые силы, ~ **босогч** вооружённое восстание, ~ **мөргөлдөөн** вооружённый конфликт, *вооружённое столкновение,* ~ **довтолгоо** вооружённый налёт, ~ **дээрэм** вооружённое ограбление

ЗЭВТЭЙ ржавый, заржавленный

ЗЭВТЭХ ржаветь, покрываться ржавчиной

ЗЭВҮҮ возмущение, негодование, отвращение, омерзение, ~ **хүрэх** прийти в негодование, испытывать отвращение

ЗЭВҮҮН возмутительный, отвратительный, отталкивающий, омерзительный, гадкий, странный, ~ **үнэр** отвратительный запах, ~ **харц** возмутительный/странный взгляд, ~ **санагдах** казаться отвратительным/возмутительным

ЗЭВҮҮРХҮҮ страшноватый, довольно отвратительный, омерзительный/*странный*

ЗЭВҮҮРХЭЛ отвращение, омерзение, возмущение, негодование, крайнее недовольство, **хүний** ~ **төрүүлэх** вызывать у кого-либо крайнее недовольство

ЗЭВҮҮРХЭЛТЭЙ с отвращением, отвратительно, гнусно, мерзко, гадко, ужасно, ~ **харах** смотреть на кого-либо с отвращением

ЗЭВҮҮРХЭХ негодовать, возмущаться, быть крайне недовольным, испытывать отвращение

ЗЭВҮҮХЭН страшноватый, довольно отвратительный, омерзительный/странный

ЗЭВҮҮЦҮҮЛЭХ *побуд. от* **зэвүүцэх**, вызывать отвращение, доводить до негодования, вызывать сильное недовольство

ЗЭВҮҮЦЭЛ негодование, возмущение, сильное недовольство, брезгливость, гадливость, ~ **төрүүлэх** вызывать возмущение, возмущать, раздражать

ЗЭВҮҮЦЭХ испытывать отвращение, негодовать, возмущаться, бояться, страшиться, **идэх гэхээс ~** брезговать есть, **нүүрий нь харахаас ~** испытывать отвращение при виде кого-либо
ЗЭВХИЙ бледный, бескровный, **~ царайтай** с бледным лицом
ЗЭВЭР: **ховор ~** скудный, редкий
ЗЭВЭРГЭН прохладный, прохладно, **~ орой** прохладный вечер, **гадаа нэлээд ~ байна** на улице довольно прохладно
ЗЭГЗГЭР рослый, длинный, тонкий, **~ нарийхан** стройный, длинный, **~ нуруутай охин** рослая (обычно о девочках-подростках), вытянувшаяся девочка
ЗЭГС (эн) камыш, заросли, тростник, камышовый, **~н шугуй** камышовые заросли, **~ий болжмор** камышовый воробей
ЗЭГСЭН хороший, порядочный, изрядный, порядочно, изрядно, вполне, довольно, **~ морь** довольно хороший конь, **~ хүйтэн** порядочный мороз
ЗЭДГЭНЭ клубника
ЗЭЛ 1) протянутая волосяная верёвка для привязывания телят и жеребят, 2) вереница, **~ татах** а) протягивать волосяную верёвку, б) двигаться вереницей, растянуться вереницей, в одну линию, **~тэй гартай** золотые руки, имеющий золотые руки
ЗЭЛГЭЭДЭХ чуть остывать, становиться тёпленьким (напр. о горячем чае), **цай ~жээ** чай чуть остыл, чай стал тёпленький
ЗЭЛЛЭХ 1) привязывать к протянутой верёвке, 2) вытягиваться вереницей, вытягиваться в одну линию, **~н нисэх** лететь, вытягиваясь вереницей
ЗЭЛМҮҮР: **өлөн ~** голодный, голодно
ЗЭЛМЭХ чуть утолить голод, слегка утолить жажду
ЗЭЛҮҮД глухой, безлюдный, **~ газар** пустырь, безлюдное место
ЗЭЛҮҮДХЭН довольно глухой, безлюдный, довольно свободный
ЗЭЛХЭН: **бэлэн** ~ *парн.* готовый, готово
ЗЭЛЭН: **бэлэн ~** *парн.* готовый, приготовленный, **бэлэн ~ хоол** готовая еда, заранее приготовленная пища, **бэлэн ~ амлах** обещать золотые горы
ЗЭМ 1) вина, проступок, прегрешение, 2) замечание, выговор, порицание, **гэм ~, ~ буруу** проступок, провинность, **ял ~** наказание, взыскание
ЗЭМГҮЙ невинный, безвинный, безнаказанный, невинно, безнаказанно, **гэм ~ хүн** невинный человек, **гэм ~ орхих** оставить безнаказанно, **тэр ямар ч ~ гарав** он вышел без всякого взыскания/наказания
ЗЭМЛҮҮЛЭХ *побуд. от* **зэмлэх**, быть обвиняемым, порицаться, осуждаться, **аавдаа ~** услышать упрёк от отца за что-либо
ЗЭМЛЭГДЭХ *страд. от* **зэмлэх**, обвиняться, порицаться, осуждаться
ЗЭМЛЭЛ порицание, обвинение, наказание, замечание, взыскание, **ял ~** *парн.* наказание, обвинение, **~ хүлээх** получить замечание, **~ хүлээлгэх** сделать замечание, порицать, упрекать
ЗЭМЛЭХ порицать, винить, осуждать, **биеэ ~** обвинять самого себя, **бусдыг ~** винить/обвинять других
ЗЭМСЭГ инструмент, орудие, оружие, **хөгжмийн ~** музыкальные инструменты, **агнуурын ~** охотничьи принадлежности
ЗЭНДМЭНЭ *миф.* драгоценный камень, удовлетворящий все желания
ЗЭМТЭЙ виновный, виноватый, провинившийся
ЗЭР: **~ зэвсэг** *собир.* оружие, боевые доспехи, вооружение, **~ зэвсэг агсах** надевать доспехи
ЗЭРВЭС мельком, мимоходом, бегло, случайно, между прочим, **~ харах** взглянуть мимоходом, смотреть мельком, **Вуанги над руу ~ харсан ч гэсэн миний хувьд мартагдашгүй мөч байлаа** хотя Вуанги взглянула на меня лишь мельком, мгновение это
ЗЭРВЭСХЭН мельком, мимоходом, бегло, случайно, между прочим, **~ дурдах** упомянуть мимоходом
ЗЭРГЭД параллель, параллельный, симметричный, **~ шугам** параллельная линия, **~ сэлгээ эгшиглэгээ** *муз.* параллельно-переменный лад
ЗЭРГЭЛДЭХ быть параллельным, оказываться симметричным, находиться рядом, стоять рядом, быть по соседству
ЗЭРГЭЛДЭЭ соседний, по соседству, параллельный, симметричный, **хөрш ~ байшин** соседний дом, **~ хоёр шугам** параллельные линии, **~ байрлал** симметричное расположение
ЗЭРГЭЛЭЭ мираж
ЗЭРГЭЭР 1) одновременно, синхронно, в одно и то же время, разом, 2) и так далее, и тому подобное, **нэгэн ~ цугларах** собраться в одно их то же время, **нэгэн ~ хашгиралдах** кричать разом, **гэх ~ бичих** написать и тому подобное, писать в таком же духе
ЗЭРЛЭГ 1) дикий, 2) зверский, варварский, жестокий, 3) дикорастущий, **~ араатан** хищные звери, **~ амьтан** дикое животное, **~ гахай** кабан, **~ явдал** дикость, зверство, **~ сонгино** *бот.* лук алтайский, **~ олс** *бот.* каннабис, анаша, **~ өвс** сорняк, **~ загнах/~ээр авирлах** зверствовать, поступать варварски, вести себя жестоко, **~ сум** шальная пуля, **~ балмад** варвар, **~ муур** дикая кошка манул
ЗЭРЛЭГДЭХ вести себя слишком варварски/жестоко, проявлять жестокость, зверствовать, поступать зверски, грубеть
ЗЭРЛЭГШИХ дичать, становиться диким, **~сэн нохой** одичавшая собака
ЗЭРМЭГХЭН бегло, мельком, мимоходом, **~ харахад** при мимолётном взгляде, при взгляде мельком
ЗЭРТГЭР 1) кокетливый, шаловливый (преимущественно о девочке), 2) с острыми ушами, **~ чихтэй морь** конь с острыми ушами
ЗЭРЭГ 1) звание, степень, чин, титул, 2) уровень, степень, сорт, категория, 3) одновременно, как только, сразу, в тот же момент, 4) и так далее, и прочие, и тому подобное, **~ цол, хэргэм ~** звание, титул, **эрдмийн ~ олгох** присуждать учёную степень, **докторын ~ хамгаалах** защитить докторскую степень, **~ нэмэх** повышаться в чине, повышение в чине, дээд **~** высшая степень, высший класс, высший сорт, **хоёрдугаар ~** второй сорт, **бага ~** немного, **хэр/аль ~** в какой степени, как, какой, **дунд ~ мэдэх** знать посредственно, **нар гарахтай ~** как только взойдёт солнце, **гэх ~** и так далее, и тому подобное, **хонь ямаа ~ мал** овцы, козы и другие виды скота, **~ дуурьсал** *муз.* созвучие, **хир ~?** как? насколько?
ЗЭРЭГЛЭЛ категория, **нөөцийн ~** категория запасов, **~ээр ялгах** распределять по категориям
ЗЭРЭГЛЭХ 1. составлять ряд, сортировать, распределять по сортам
ЗЭРЭГЛЭХ 2. ярко блестеть, сверкать
ЗЭРЭГЛЭЭ мираж, марево, **говийн ~** мираж в пустыне, **~ татах** появляться (о мираже), **бид хоёрын учрал зүүд ~ шиг** наша встреча словно сон
ЗЭРЭГЛЭЭТЭХ представляться, образовываться (о мираже)
ЗЭРЭГЦҮҮЛЭЛ сравнение, сопоставление, **~ хийх** проводить сопоставление
ЗЭРЭГЦҮҮЛЭЛТ сравнение, сопоставление
ЗЭРЭГЦҮҮЛЭХ *побуд. от* **зэрэгцэх**, сравнивать, сопоставлять, ставить рядом, **~н тавих** ставить рядом, **~ арга** параллелизм
ЗЭРЭГЦЭХ идти рядом, выстраиваться в ряд, равняться, приравниваться, **~н суух** сидеть рядом, сесть рядом, **~н зогсох** стоять рядом, **эн ~** равняться, соперничать

ЗЭРЭГЦЭЭ 1) стоящий рядом, соседний, по соседству, параллельный, 2) одновременно, вместе с тем, наряду, **үүний** ~ вместе с этим, наряду с этим, одновременно с этим

ЗЭРЭГЦЭЭГЭЭР наряду, одновременно, параллельно, **суралцахын** ~ наряду с учёбой

ЗЭРЭМГЭР имеющий узкие глаза, с узким разрезом (о глазах), ~ **нүдтэй хүн** узкоглазый человек, человек с узкими глазами

ЗЭРЭМДЭГ физически неполноценный, изуродованный, искалеченный, абрахия (болезнь скота), **эрэмдэг** ~ *парн.* искалеченный, ~ **бие** изуродованное тело

ЗЭРЭМДЭГЛЭХ 1) изуродовать, искалечить, 2) *перен.* делать что-либо кое-как, выполнять неполностью, относиться к работе спустя рукава

ЗЭС 1. медь, медный, ~ **зоос** медная монета, **аранжин** ~ самородная медь, ~**ээр бүрэх** покрывать медью, ~**ийн хүдэр** медная руда, ~**ийн үйлдвэр** меднорудная промышленность, ~**ээ цухуйлгах** проявлять свой норов

ЗЭС 2. *бот.* баклажан

ЗЭТГЭР помеха, препятствие

ЗЭХЭХ приготовить, подготовить, ~**ж бэлтгэх** приготовить заранее, **замд гарахаар** ~ снаряжаться в дорогу, **биеэ** ~ готовиться, быть наготове

ЗЭХЭЭ приготовление, подготовка

ЗЭХЭЭСТЭЙ готовый, приготовленный, приготовившийся, подготовленный, **морь** ~ **байгаа** конь уже осёдлан

ЗЭХЭЭТЭЙ готовый, приготовленный, приготовившийся, подготовленный

ЗЭЭ 1. внук, внучка (по дочери), племянник, племянница (по материнской линии), ~ **охин** внучка (от дочери)

ЗЭЭ 2. *междометие выражает согласие:* ладно, хорошо, ~, **мэдлээ** хорошо, понял

ЗЭЭГТ: ~ **наамал** художественная аппликация

ЗЭЭЛ 1. кредит, заём, ссуда, долг, **хүүгүй** ~ беспроцентный заём, **богино хугацааны** ~ краткосрочный заём, **удаан хугацааны** ~ долгосрочный заём, ~**ийн карт** кредитная карта, ~ **олгох нөхцөл бүрдүүлэх** обеспечение кредита, **нээлттэй** ~ открытый кредит, **хөнгөлөлттэй** ~ льготный кредит, **сэргээгдэх** ~ возобновляемый кредит, ~**ийн эрсдэл** кредитный риск, ~**ийн хүү** ссудный процент, ~ **олгох** предоставить кредит, ~ **авах** брать в долг, ~**ээр худалдах** торговать в кредит, **зах** ~**ийн эдийн засаг** рыночная экономика

ЗЭЭЛ 2. рынок, базар, **зах** ~ рынок, **нийтийн зах** ~ общий рынок, **гадаадын/дотоодын зах** ~ внешний/внутренний рынок

ЗЭЭЛДҮҮЛЭГЧ кредитор, ссудодатель

ЗЭЭЛДҮҮЛЭХ *побуд. от* **зээлдэх**, давать в долг, кредитовать, ссужать, **бусдад их мөнгө** ~ кредитовать/дать в кредит кому-нибудь большую сумму

ЗЭЭЛДЭГЧ получающий в долг/в кредит, ссудополучатель, заёмщик, **иэр** ~ самозванец

ЗЭЭЛДЭХ брать взаймы, брать в долг, занимать, **мөнгө** ~ занимать деньги, брать деньги взаймы, **нэр** ~ выдавать себя за кого-либо, ~**н авагч** заёмщик

ЗЭЭЛЛЭГ заём, ~**ийн батлан даалт** кредитное (долговое) поручительство, **үл хөдлөх хөрөнгийн барьцааны** ~ ипотечная ссуда

ЗЭЭЛҮҮЛЭХ давать в долг, ~ **капитал** ссудный капитал

ЗЭЭЛЭХ брать в долг, ~**сэн өр** кредиторская задолженность

ЗЭЭР антилопа, джейран

ЗЭЭРГЭНЭ *бот.* эфедра, хвойник односемянный, эфедрин

ЗЭЭРД гнедой, ~ **морь** гнедая лошадь

ЗЭЭРЭНЦ дискета

ЗЭЭТҮҮ мотыга

И

ИВ *частица усиления* 1) совершенно, совсем, весьма *только перед словами,начинающимися с* «и», 2) напролом, насквозь, ~ **ижил** совершенно одинаковый, ~ **ил** совершенно ясно, весьма ясно, ~ **цохих** пробивать, ~ **дайрах** прорваться, ворваться

ИВЛЭХ давать молоко, доиться (напр. о корове после подпуска телёнка)

ИВҮҮР подпорка, подставка, подкладка

ИВЭЛГЭХ вызывать появление молока в вымени

ИВЭР: ~ **зэвэр** шушуканье

ИВЭРХИЙ 1) провал, прорыв, оседание, прокол, 2) *мед.* грыжа, **цавины** ~ паховая грыжа

ИВЭХ подкладывать, подложить, **нуруунд нь өндөрлөх юм ~ж өгөх** подкладывать (подушку) под спину

ИВЭЭГДЭХ *страд.от* **ивээх**, быть под покровительством

ИВЭЭГЧ покровитель, защитник, заступник, протектор, филантроп

ИВЭЭЛ эгида, покровительство, забота, филантропия, протекция, **хайр** ~ *парн.* забота, покровительство, **хуулийн** ~д под покровительством закона, ~ **үзүүлэх** оказывать протекцию, ~**дээ авах** взять под свою защиту/под свое покровительство, ~ **жил** благоприятный год

ИВЭЭЛГҮЙ противоположный, беспощадный, недоброжелательный

ИВЭЭЛТЭЙ доброжелательный, покровительственный, благосклонный, благодетельный, доброжелательно, благосклонно, покровительственно, **буєдад ~ байх** быть доброжелатель-ным к кому-либо, относиться к кому-нибудь благосклонно

ИВЭЭС подпорка, подкладка, **авдрын** ~ подкладка под сундуком, **орны** ~ подпорка под кроватью, подпорка для кровати

ИВЭЭХ протежировать, покровительствовать, оказывать протекцию/ поддержку, заботиться, **~н тэтгэх/дэмжих** оказывать протекцию/спонсорскую помощь, **өршөөж ~/~ж хайрлах** оказывать покровительство, **~н тэтгэгч** спонсор, **~н тэтгэлэг** спонсорская помощь

ИД 1. 1) превосходство, сила, мощь, энергия, 2) разгар, полное развитие чего-либо, ~ **бахтай** активный, с энергией, ~ **хав** *парн.* сила, величие, отвага, ~ **дундаа** в самом разгаре, **ажил ~ дундаа байна** работа идёт в полном разгаре, **маргааны ~ дундуур** в разгаре спора, ~ **насандаа** во цвете лет, **залуу насны ~ийг үзүүлэх** показать энергию молодости

ИД 2.: ~ **шид** магия, волшебство, **үгийн ~ шид** магия/сила слова

ИДЕАЛИЗМ идеализм

ИДЕАЛИСТ идеалист, идеалистический

ИДТЭЙ 1. энергичный, сильный, мощный, величественный, удалой

ИДТЭЙ 2. волшебный, чудесный, чарующий, ~ **эм** чудесное лекарство

ИДТЭЙ 3. удалой, ~ **эр** удалец

ИДҮҮЛЭХ *побуд. от* **идэх**, быть съеденным, **мал чоноид ~в** *букв.* скот был съеден волком/волк загрыз скот, **морио өвс** ~ *букв.* дать лошади есть траву

ИДҮҮР кормушка, корыто (для кормления собак и свиней)

ИДЭВХ активность, ~ **санаачлага** инициатива, ~ **чармайлт/зүтгэл** активность, старательность, ~ **гаргах** проявлять активность, быть активным, **~ний дөл** активные протуберанцы, ~ **харалдаа зохиомж** *муз.* подвижный контрапункт

ИДЭВХГҮЙ пассивный, бездеятельный, вялый, пассивно, вяло, ~ **байдал** пассивность, ~ **хүн** пассивный человек, ~ **үүрэг гүйцэтгэх** играть пассивную роль

ИДЭВХЖИЛ активизация, активирование, активация, **тектоник** ~ тектоническая активизация, **молекулын** ~ активация молекул, **ферментийн** ~ активация ферментов, **нарны** ~ солнечная активность

ИДЭВХЖИЛТ активность, активизация

ИДЭВХЖИХ активизироваться, становиться активнее, активироваться

ИДЭВХЖҮҮЛЭХ *побуд. от* **идэвхжих**, активизировать, стимулировать, оживлять, **ажлыг** ~ активизировать работу, **~сэн нүүрс** активированный уголь

ИДЭВХИЙЛЭЛ активность, старание, старательность, прилежание, усердие, стремление, **ихээхэн ~ гаргах** проявлять большую старательность

ИДЭВХИЙЛЭХ стараться, проявлять усердие, быть усердным/ активным, проявлять активность, **~н ажиллах** работать с усердием

ИДЭВХЛЭХ быть усердным, быть инициативным, **~н санаачлах** проявлять инициативу

ИДЭВХТЭЙ активный, деятельный, энергичный, инициативный, активно, энергично, деятельно, ~ **амралт** активный отдых, **химийн ~ урвал** активная химическая реакция, ~ **дэмжих** активно поддержать

ИДЭВХТЭН активист, актив, ~ **бичигч** активно пишущий в газету, внештатный корреспондент

ИДЭГДЭЛ абразия, **~ийн гадаргуу** абразионная поверхность

ИДЭГДЭХ *страд. от* **идэх**, изъедаться, разъедаться, **төмөр зэвэнд ~жээ** ржавчина разъела железо

ИДЭГДЭЛ съедение, съедание, абразия

ИДЭГЧ *геол.* абразивы

ИДЭМХИЙ 1) прожорливый, ненасытный, жадный к еде, 2) *перен.* взяточник, 3) разъедающий, едкий, ~ **хүн** обжора, прожора, прожорливый человек, ~ **ямаа** прожорливая коза, ~ **түшмэл** чиновник-взяточник, мздоимец

ИДЭР молодой, возмужалый, ~ **залуу** *парн.* юный, молодой, ~ **нас** юность, молодость, ~ **гоо** планета Адонис

ИДЭРМЭГ удалой, молодецкий, лихой, бойкий, ~ **эр** лихач, удалец, храбрый/удалой мужчина

ИДЭРХЭН *уменьш. от* **идэр**, молоденький, совсем юный, ~ **залуудаа хайртай болжээ** совсем молоденькой влюбилась

ИДЭХ 1) есть, кушать, жрать, 2) разъедать, подтачивать, кариоз, 3) присваивать, похищать, растрачивать, **~ж уух** есть и пить, **хоол** ~ кушать, обедать, ~ **юм** пища, еда, кушанье, **амтархан** ~ есть с аппетитом, **зэв** ~ ржаветь, **хорхой ~сэн шүд** кариозный зуб, **улсын мөнгө** ~ присваивать казённые деньги, **дутуу** ~ недоедать, **цаттал** ~ есть досыта, **~дэггүй, ~ж болдоггүй юм** несъедобное, **цаг** ~ тратить много времени, **хараал** ~ быть осыпаемым проклятьями/ругательством, **~сэн эрүү хувхайрч идүүлсэн дов ургана** *приблизительно:* за одного битого двух небитых дают, **үрээ ~ээр үнээнд** лучше съесть корову, чем плод

ИДЭШ 1) пища, продовольствие, продукты питания, провиант, 2) скот, скотина (для зимнего забоя на мясо), ~ **ууш** пища, еда, **өвлийн** ~ мясо на зиму, зимний запас мяса, **~нд үхэр гаргах** колоть корову на мясо

ИДЭШЛЭХ пастись, есть (о скоте)

ИДЭЭ 1. 1) еда, кушанье, ~ **цагаа,** ~ **будаа** *собир.* пища, кушанье, **цагаан** ~ молочные продукты, **~ний зүйл** продукты питания, пищевые продукты, съестные припасы, **цайны** ~ чай для заварки, ~ **цагаагаа бэлтгэх** приготовить *пищу/пищевые продукты,* ~ **амсах** отведать, попробовать, «~ **зэнээ танихгүй**» *букв.* «кушанье хозяина не знает» так говорят, когда ставят перед гостем принесённое им же угощение

ИДЭЭ 2. гной, **~т шарх** гнойная рана, ~ **татах** вызвать нагноение

ИДЭЭ 3. дубильное вещество, дубитель

ИДЭЭ 4.: **самрын** ~ ядро ореха

ИДЭЭЛЭХ 1. кушать, есть, принимать пищу, **~ж будаалах** угощаться, принимать пищу

ИДЭЭЛЭХ 2. нагнаиваться, гноиться, **шарх ~сээр л байна** рана всё еще гноится

ИДЭЭЛЭХ 3. дубить, подвергать дублению, **нэхий/арьс** ~ дубить кожу, обрабатывать кожу путем дубления

ИДЭЭШИЛ привыкание, осваивание, акклиматизация, ~ **сайтай нутаг** местность, где акклиматизация проходит успешно

ИДЭЭШИХ 1. приучаться, приспособляться, привыкать, акклиматизироваться, **шинэ газар** ~ привыкать к новому месту, приспособляться/акклиматизироваться к новой местности

ИДЭЭШИХ 2. настаиваться, густеть, **цай ~в** чай заварился

ИДЭЭШМЭЛ настойка, **бамбайн** ~ валериановая настойка

ИЖ: ~ **бүрэн** комплект, набор, комплекс, полное собрание, комплексный, ~ **бүрэн зохиолын эмхтгэл** полное собрание сочинений, ~ **бүрдүүлэн нийлүүлэх** комплектные поставки

ИЖИЙ мама, мать, матушка

ИЖИЛ 1. одинаковый, равный, сходный, подобный, парный, **ив ~, эгээ** ~ совершенно одинаковый, точь-в-точь, как две капли воды, ~ **зүсмийн мал** одномастный скот, домашнее животное одинаковой масти, ~ **эгшиглэн** унисон, ~ **мөрөн** река Волга

ИЖИЛ 2. привыкшие друг к другу, близкие друг другу, ~ **дасал болох** привыкать друг к другу, становиться близкими друзьями, ~ **хань** подруга, суженая

ИЖИЛГҮЙ 1) бесподобный, беспримерный, несравненный, 2) единственный, одинокий, ~ **сайн** несравненно лучше

ИЖИЛДЭХ привыкать друг к дуруг, стать близкими друзьями, **~н дасах** сродниться, дружить, привыкать друг к другу

ИЖИЛСГЭХ *побуд. от* **ижилсэх,** делать похожим, заставлять привыкать, делать одинаковым, сближать

ИЖИЛСҮҮЛЭХ *побуд. от* **ижилсэх,** делать одинаковым, делать похожим, заставлять привыкать, делать одинаковым, **мал** ~ приучать животных к стаду

ИЖИЛСЭГ склонный привыкать, быстро привыкающий, ~ **мал** быстро привыкающий скот

ИЖИЛСЭЛТ идентификация

ИЖИЛСЭХ быть похожим друг на друга, походить друг на друга, иметь сходство с кем- чем-нибудь

ИЙ *междометие выражающее испуг:* ой, **~, тэгж болохгүй** ой, так нельзя

ИЙЖ: яаж ~ байгаад, яаж ~гээд как-нибудь, каким-нибудь образом, **яаж ~ байгаад өрнөөс салах хэрэгтэй** надо каким-нибудь образом развязаться с долгом, **яаж** ~ едва, еле, еле-еле, с трудом

ИЙЛДЭС *мед.* сыворотка, **сахуугийн** ~ противодифтерийная сыворотка, **үүрийн** ~ семя, зародыш

ИЙМ такой, подобный, этакий, ~ **олон** так много, ~ **янзаар** таким образом, таким путем, подобным образом, ~ **учраас** поэтому, **учир явдал ~ байна** так обстоит дело, ~ **юм болно гэж санасангүй** не подумал, что такое может случиться

ИЙМХЭН *уменьш. от* **ийм,** всего лишь, всего столько, лишь столько, даже такое, ~ **юм мэдэхгүй** *не знает такого* элементарного/таких мелочей

ИЙМЭРХҮ вот такой, такой же, вот так, такой вот, вроде этого, **ажил ~ явж байна** работа идёт вот таким образом

ИЙН так, таким образом, ~ **тийн ярилцах** беседовать о том, о сём

ИЙНХҮҮ таким образом, таким путем, вот так

ИЙШ сюда, в эту сторону, ~ **тийш** туда-сюда

ИЙШЭЭ сюда, в эту сторону, ~ **суугаарай** сядьте сюда

ИЛ 1. явный, ясный, открытый, легальный, явно, ясно, открыто, *легально,* ~ **захидал** открытка, ~ **санал хураалт** открытое голосование, ~ **уурхай** карьер, разрез, ~ **хэлэх** говорить в глаза, ~ **болох/гарах** выявляться, быть открытым, стать очевидным/ясным, ~ **гаргах** обнаруживать, сделать ясным, ~ **тод байдал** гласность, ~ **тод байх зарчим** принцип гласности, ~ **уурхай** карьер, разрез

ИЛ 2. детёныш оленя

ИЛААРШИХ выздоравливать, чувствовать себя лучше

ИЛБЭ фокус, колдовство, проделка, **хөзрөөр** ~ **үзүүлэх** карточный фокус, ~ **үзүүлэх** показывать фокусы

ИЛБЭДЭХ показывать фокусы, манипулировать, колдовать

ИЛБЭХ гладить, ласкать, ласково проводить по чему-либо ладонью, **хацрыг** ~ гладить по щеке

ИЛБЭЧИН фокусник, иллюзионист, колдун

ИЛГЭН замшевый, ~ **дээл** *замшевое пальто,* ~ **цамц** замшевая куртка

ИЛГЭЭГДЭХ *страд. от* **илгээх,** быть отправленным, оказываться направленным, отправляться, направляться

ИЛГЭЭГЧ посылающий, отправляющий, отправитель

ИЛГЭЭЛТ 1) посылка, отправка, 2) послание, 3) путёвка, **шуудангийн** ~ почтовая посылка, **Шинэ жилийн баярын** ~ Новогоднее приветственное послание, **~ийн эзэд** обладатели ревсомольских путёвок, ~ **явуулах** отправлять посылку

ИЛГЭЭХ *посылать, отправлять, направлять,* **шуудангаар** ~ посылать по почте, **хүн** ~ отправлять человека, **захидал** ~ отправить письмо, **цахилгаан утас** ~ направлять телеграмму

ИЛГЭЭМЖ посылка, бандероль, посылочный, **шуудангийн ~ийн тасаг** посылочное отделение на почте, отдел посылок на почте, **~ийн худалдаа** выписка, заказ товаров по почте, **~ийн гэрээ** договор экспедиции

ИЛД 1. меч, сабля, ~ **бамбай** *щит и* меч

ИЛД 2. *мед.* лишай

ИЛЖИГ осёл, ослиный, **~ний чих** ослиные уши, ~ **унах** ехать на осле, садиться верхом на осле

ИЛЖИРХИЙ гнилой, тухлый, разложившийся, разлагающийся

ИЛЖЛЭХ доводить до гниения/гнилости, делать тухлым

ИЛЖРЭХ гнить, тухнуть, разлагаться, разрушаться из-за гниения, подвергаться гниению

ИЛЛЭГ массаж, ~ **хийх** делать массаж, **цэгэн** ~ точечный массаж

ИЛРҮҮЛЭХ разоблачать, обличать, выявлять, обнаружить, раскрывать разоблачать, **олж ~, ~ж гаргах** выявлять, раскрывать, **гэмт хэрэг** ~ раскрыть преступление, **~д төвөгтэй гэмт хэрэг** трудно раскрываемое преступление, **нууцыг** ~ раскрыть тайну, **буруутныг олж** ~ разоблачать виновных

ИЛРЭЛ выражение, проявление, **тод** ~ чёткое выражение

ИЛТ ясно, явно, заметно, ~ **харагдах** ясно видеться, ~ **өгүүлэх** *нэр синоним*

ИЛРЭХ выявляться, обнаруживаться, раскрываться, стать очевидным

ИЛТГЭГЧ докладчик, **уран** ~ оратор

ИЛТГЭЛ доклад, речь, **тайлан ~** отчётный доклад, **~ хэлэлцэх** обсуждение воспользоваться этим (напр. взять себе или отдавать кому-нибудь), отдавать лишнее

ИЛТГЭЛЦҮҮР коэффициент, **идэвхжилийн ~** коэффициет активности, **хөрс хуулалтын ~** коэффициент вскрыши, **батшлын ~** коэффициент прочности, **зууралдлын ~** коэффициент сцепления

ИЛТГЭХ докладывать, делать доклад, доложить, **~ хуудас** докладная записка

ИЛТЭД ясно, явно

ИЛҮҮ 1) лишний, излишний, ненужный, 2) свыше, более, больше, **~ зардал** излишний расход, **~ үг** лишние слова, **~ үгтэй илгэн хоншоортой** быть чересчур болтливым, **~ юм ярих** говорить лишнее, сказать не то, что надо было, **~ дутуу** то-сё, **~ орои тоо** сверхштатный, лишний, дополнительный, **хамаагүй/хавьгүй ~** куда лучше, намного лучше, **~ төлөх** переплачивать, заплатить больше денег, **~ авах** брать больше, **~ харах** желать большего/ лишнего, смотреть жадными глазами, **~гийн дотор дутуу буй, ихийн дотор бага буй** *приблизительно:* от сумы (и тюрьмы) не зарекайся

ИЛҮҮДЭЛ излишек, остаток, остаточный, излишний, **~ийг тушаах** сдача излишков, сдавать излишки, **~ бараа** остаточный товар, **~ мөнгө** остаточные деньги, **~ жин** избыточный вес, **~ санхүүжилт** избыточное финансирование

ИЛҮҮДЭХ быть лишним, оказываться излишним, превышать, **тогтоосон хэмжээнээс ~** превышать установленную норму

ИЛҮҮР 1. утюжок

ИЛҮҮР 2. штукатурная лопатка, мастерок

ИЛҮҮРДЭХ гладить, утюжить

ИЛҮҮЦ излишний, лишний, излишне, **~ үг** лишние слова, **~ хэрэг** лишний поступок

ИЛҮҮЧЛЭХ делать излишними

ИЛХЭН чётко, ясно, **~ харагдана** чётко видно

ИЛЧ теплота, жар, **халуу ~** жар, **биеийн ~** температура тела, **нарны ~** солнечная температура

ИЛЧИТ тепловой, **~ тэрэг** тепловоз

ИЛЧЛЭХ разоблачать, выявлять, выяснять, обнаруживать, делать известным

ИЛЭГ замша, **~н бээлий** замшевые перчатки

ИЛЭН: **~ далангүй** откровенно, искренне, чистосердечно, откровенный, открытый, искренний, **~ далангүй байдал** искренность, откровенность, **~ далангүй яриа** откровенный разговор, **~ далангүй хүн** открытый, искренний человек, **~ далангүй ярих** говорить откровенно, высказаться чистосердечно

ИЛЭРХИЙ ясный, явный, понятный, известный, очевидный, ясно, явно, понятно, очевидно, **~ асуудал** явный вопрос, **~ давуу байдал** явное преимущество, **~ болгох** делать известным

ИЛЭРХИЙГЭЭР явно, очевидно, открыто

ИЛЭРХИЙЛЭЛ заверение, обещание, рапорт

ИЛЭРХИЙЛЭЛТ заверение, рапорт, **баярын ~** приветственное заверение, **~ гаргах** дать заверение, делать рапорт, представить рапорт

ИЛЭРХИЙЛЭХ высказываться, объявлять, заявлять, обещать, заверять, **талархал ~** выразить благодарность, объявить благодарность, **санал ~** выразить мнение, **эсэргүүцэл ~** заявить протест, **эмгэнэл ~** выразить соболезнование, **батлан ~** заверять

ИЛЭРЦ (рудные) проявления

ИЛЭХ 1) гладить, ласкать, 2) массировать, делать массаж, **үсээ ~** поглаживать свои волосы

ИМЖ кенгуру

ИМНЭХ 1. ставить на ушах скота метку, делать метку подрезом ушей у скота, **мал ~** ставить метку на ушах скота

ИМНЭХ 2. холостить, кастрировать

ИМПЕРАТИВ императив, **~ хэм хэмжээ** императивная норма

ИМПЕРИАЛИСТ империалист, империалистический, **~ бодлого** империалистическая политика

ИМПЕРИ империя, **Ромын ~** Римская империя

ИМПОРТ импорт, импортный, **~ын бараа** импортные товары, **~ын хориг** запрет на импорт, **~ын хадгаламж** импортный депозит, **татвар төлөгдөөгүй ~ын бараа** импортные товары с не оплаченной пошлиной, **~ын хураамж** импортные пошлины

ИМПОРТЛОХ импортировать, ввезти из-за границы

ИМРЭХ сучить, скручивать, свивать, крутить между пальцами, **утас ~н нийттэх** сучить нитки, крутить нитки, **сахлаа ~** подкручивать усы

ИМХЭРДЭХ подрубать, подшивать край чего-нибудь, загибать края чего-нибудь, складывать в складку (напр. края ткани)

ИНГЭ верблюдица

ИНГЭХ делать так, делать таким образом, **тэр ~ж хэлэв** он сказал так, **би ~ээд явна** я скоро уйду, **чамайг ~нэ гэж санасангүй** я не подумал, что ты поступишь так, **би бас ~нэ** я сделаю/поступлю тоже так, **~ж хий** сделай так

ИНГЭЭД так, итак, таким образом, затем, а теперь, скоро, **~ яах вэ?** и так что теперь будем делать? **~ бүх юм тодорхой боллоо** и так, всё стало ясно

ИНДРААНИЛ сапфир

ИНДЕКС индекс, указатель, **аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ~** индекс промышленной продукции

ИНДЕКСЖҮҮЛЭХ индексация

ИНДҮҮ утюг, **цахилгаан ~** электрический утюг, **цогийн ~** жаровой утюг

ИНДҮҮДЛЭГ 1) утюжка, 2) сгиб, складка (напр. на брюках после утюжки), **~ муу авах** плохо утюжиться

ИНДҮҮДЭХ утюжить, гладить, **хувцас ~** гладить одежду, **өмд ~** утюжить брюки

ИНДЭР трибуна, **~т гарах** подняться на трибуну, **~ийн хурал** митинг, **зочны ~** гостевая трибуна, трибуна для гостей

ИНДЭХ: **тариа ~** молотить зерно

ИНЖ 1. приданое

ИНЖ 2.: **~ буурал** *бот.* синяк обыкновенный

ИНЖЕНЕР инженер, инженерный, **барилгын ~** инженер-строитель, **~ техникийн ажилтнууд** инженерно-технические работники

ИНТЕГРАЦ интеграция, **эдийн засгийн ~** экономическая интеграция

ИНТЕРНАЦИОНАЛ интернационал, интернациональный

ИНТЕРНАЦИОНАЛИЗМ интернационализм

ИНТЕРНАЦИОНАЛЧ интернационалист, **~ үзэл** интернационализм

ИНТООР вишня

ИНЭЭД смех, хохот, **~ алдах** рассмеяться, **~ хүргэх** вызывать смех, смешить, **~ хүрмээр** смешной, смехотворный, забавный, **чамд ~, над ханиад** *погов. приблизительно:* кошке — игрушка, а мышке — слезки, **~ ханиад болох** балагурить, смеяться до слёз

ИНЭЭДТЭЙ смешной, комичный, потешный, забавный, смешно, комично, забавно, **~ юм болов** вышло смешно, **танд ~ байна уу?** вам смешно?

ИНЭЭЛДЭХ *взаимн. от* **инээх** смеяться (мн. число)

ИНЭЭДЭМ смех, смешок, **~ наадам** шутка, насмешка, **~ тоглоом болгох** делать посмешищем, поднимать на смех, делать/сказать на смех, **~ биш** не до смеху, не время веселиться

ИНЭЭДЭМТ смешной, смехотворный, комический, **~ жүжиг** комедия

ИНЭЭДЭМТЭЙ смешной, комический
ИНЭЭЛГЭХ смешить, вызывать смех
ИНЭЭСЭМГЛЭЛ улыбка, **үл мэдэг ~** чуть заметная улыбка, **хөгжүүн ~** веселая улыбка
ИНЭЭМСЭГЛЭХ улыбаться, **гунигтайяа ~** грустно улыбаться **доогтой ~** саркастический улыбаться
ИНЭЭМХИЙ смешливый, **~ бүсгүй** смешливая девушка, хохотунья
ИНЭЭМТГИЙ смешливый, **~ хүн** весельчак, смешливый человек, человек, который смеется
ИНЭЭХ смеяться, хохотать, **элгээ хөштөл/муурч унаталаа ~** хохотать до упаду, помирать со смеху, **тачигнатал ~** громко смеяться, хохотать во все горло, разразиться смехом, **~сэн хүнээс асуу, уйлсан хүнээс бүү асуу** *погов.* у смеющегося человека спроси причину, а у плачущего не спрашивай , **инээхэд ихдэх, уйлахад багадах хэрэг** и плакать и смеяться.
ИОД иод
ИОДЖУУЛАХ иодифицировать
ИР лезвие, остриё, **хутганы ~** остриё ножа, лезвие ножа, **хадуурын ~** лезвие косы, **сэлэмний ~** лезвие меча, **хутганы ~н дээр байх** находиться в безвыходном положении, держаться на волоске
ИРВЭГНЭХ ощущать прикосновение к телу насекомых, меха, волос, покрываться мурашками
ИРВЭС леопард, снежный барс
ИРГҮЙ тупой, **~ хутга** тупой нож
ИРГҮҮЛ ободок, край посуды
ИРГЭД граждане, люди, **~ийн амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдрын эсрэг гэмт хэрэг** преступление против жизни, здоровья, свободы и достоинства граждан
ИРГЭН 1. гражданин, народ, люди; гражданский, **~ий эрх** гражданские нрава, **~ий хууль** гражданский кодекс, **~ээс хасах** лишение гражданства, **~ий үүрэг** гражданский долг, **~ий гэр бүл** гражданский брак, **~ий хамгаалалт** гражданская оборона, **~ий дайн** гражданская война, **~ий байцаан шийтгэх ажиллагаа** гражданский процесс, **~ий байцаан шийтгэх эрх зүй** гражданское процессуальное право, **~ий үнэмлэх** удостоверение личности
ИРГЭН 2. китаец, **дундад ~** улс Китай
ИРГЭНШИЛ: **соёл ~** цивилизация, **эртний соёл ~** цивилизация древности, **нүүдэлчдийн соёл ~** цивилизация номадов/кочевников
ИРГЭНШИХ цивилизоваться, стать цивилизованным
ИРГЭНШҮҮЛЭХ *побуд. от* **иргэнших,** цивилизовать, приобщать к цивилизации
ИРЖГЭР неровный, шершавый, тряский
ИРЖИЙЛГЭХ *побуд. от* **иржийх** делать шершавым, делать неровным
ИРЖИЙХ делаться неровным, становиться шершавым/шероховатым
ИРЛЭГДЭХ *страд. от* **ирлэх** точиться, быть заточенным
ИРЛЭХ точить, делать острым, заострять, **хутга ~** точить нож, **сүх ~** заострять топор
ИРМҮҮН энергичный, ударный, сильный, быстрый, энергично, ударно, быстро, хорошо, **~ ажиллах** работать энергично, трудиться ударным темпом, **~ хурдан хөлөг** быстроногий скакун, быстрый конь
ИРМЭГ острый край, ребро грани, грань, **ширээний ~** ребро стола, острый край стола, **үхлийн ~ дээр** на грани смерти
ИРМЭХ мигать, моргать, подмигивать, **нүд ~** моргать глазами, **нүд ~ зуур** мгновенно, моментально
ИРТЭЙ острый, **~ хутга** острый нож
ИРҮҮЛЭХ *побуд. от* **ирэх,** заставлять приходить, велеть прийти, присылать, **дуудаж ~** вызвать, **урьж ~** приглашать прийти, **хариу ~** присылать ответ
ИРЦ посещаемость, присутствие, приход людей
ИРЭХ приходить, приезжать, прибывать, являться, идти, **чи хаанаас ~в?** откуда ты пришёл? **түрүүлж ~** приходить первым, **буцаж/эргэж ~** возвращаться, вернуться, **гарч ~** выходить, **орж ~** входить, **бууж ~** сходить, спускаться, **хамт ~** приходить вместе, **~ цаг** время прибытия, **~ жил** будущий/следующий год, **биеийн юм ~** наступление менструации
ИРЭЭДҮЙ будущий, будущее, **алс ~** будущность, **~д** в будущем, **~ цаг** будущее время, **ойрын ~** ближайшее будущее, **~нхээ төлөө саная тавих** заботиться о своем будущем, **~ судлал** футурология
ИРЭЭДҮЙГҮЙ бесперспективный, лишённый будущности, без будущего, **~ бодлого** бесперспективная политика
ИРЭЭДҮЙТЭЙ перспективный, имеющий хорошее будущее, **~ ажил** перспективная работа
ИСГЭЛЭН кислый, квашеный, **~ тараг** кислый кефир, кислая простокваша, **~ ус** кислые воды
ИСГЭРЭЛТ свист, свистеть
ИСГЭРЭХ свистеть, издавать свист, **битгий исгэр!** не свисти!
ИСГЭРЭЭН свист, **~ шуугиан** *парн.* свист и шум
ИСГЭХ *побуд. от* **исэх,** квасить, заквашивать, окислять, **гурил ~** квасить тесто, **айраг ~** квасить кобылье молоко, готовить кумыс
ИСЛҮҮД окислы
ИСПАН Испания, испанский, испанец, испанка, **~ хэл** испанский язык, **~иар ярих** говорить по-испански, **Даниэль хүүхдүүдтэйгээ монголоор ба ~ хэлээр ярьдаг** Даниэль говорит со своими детьми по-монгольски и по-испански
ИСЭЛ окись, **нүүрс төрөгчийн ~** окись кислорода
ИСЭЛДҮҮЛЭГЧ окислитель
ИСЭЛДҮҮЛЭХ *побуд. от* **исэлдэх,** окислять
ИСЭЛДЭЛ (т) окисление
ИСЭЛДЭХ 1) окисляться, 2) окисление, **~ урвал** реакция окисления
ИСЭЛТ кислое брожение, заквашивание, закваска, окисление
ИСЭХ заквашиваться, делаться кислым, подвергаться брожению, закисать, бродить, окисляться, **айраг ~жээ** кумыс заквашен, кумыс приготовлен, **~ явц** процесс брожения/заквашивания
ИТАЛИ Италия, итальянский, итальянец, итальянка, **~д үйлдвэрлэв** изготовлено в Италии, **~ийн сэргэн мандалт** итальянское возрождение
ИТГҮҮЛЭХ *побуд. от* **иттэх,** убеждать, уверять, вызывать доверие, **үнэнийг ~** убедить в истинности чего-нибудь, **өөрийн зөвд ~** уверить в своей правоте
ИТГЭГДЭХ *страд. от* **иттэх,** вериться, пользоваться доверием, войти в доверие, придавать уверенность, заслуживать доверие, **над нэг л ~гүй байна** мне почему-то не вериться
ИТГЭЛ доверие, вера, надежда, уверенность, **~ үнэмшил** *парн.* уверенность, **~ найдвар** *парн.* надежда, доверие, **~ төгс байх** быть уверенным, **~ олох/хүлээх** пользоваться доверием, **~ хүлээлгэх тухай асуудал** вопрос о доверии, **~ алдах** потерять доверие, **~ зөвдэх** совершать вероломство, **хатуу ~** твёрдая вера/твёрдая уверенность, **~ үнэмшилтэй байх эрх чөлөө** свобода убеждений и их выражений, **сохор ~** слепая вера, **өөртөө иттэх ~** вера в самого себя, **~ хөсөрдүүлэх** злоупотреблять доверием
ИТГЭЛГҮЙ ненадежный, не пользующийся доверием, не заслуживающий доверия, подозрительный, недоверчиво, подозрительно, с подозрением, **ИТГЭХ** 1) верить, доверять, оказывать доверие, 2) надеяться, полагаться, расчитывать на кого-то либо, **хүчиндээ ~** верить своим силам, **ялалтад ~** верить в по-

беду, **нүдэндээ эс ~** не верить своим глазам, **над ~ж болно** можете полагаться на меня, можно рассчитывать на меня, **би ~гүй байна** я не верю, мне не вериться

ИТГЭЛТЭЙ надежный, внушающий доверие, вызывающий доверие, уверенный, уверенно, убеждённо, надёжно, **~ нөхөр** надёжный товарищ, **~ өмчтөн** доверительный собственник, опекун, **~ хариу** уверенный ответ

ИТГЭЛЦЭЛ доверие, взаимное доверие, **~ийг бий болгох** установить взаимное доверие, **~ийн арга хэмжээ** меры взаимного доверия

ИТГЭЛЦЭХ *совм. взаим. от* **итгэх**, верить друг другу, заслуживать доверие друг у друга, **бие биедээ ~** доверять друг другу

ИТГЭМЖ доверие, вера, надежда, уверенность, **~ найдлага** *парн.* вера, уверенность, **~ төрөх** вызывать/внушать доверие, **~ алдах** потерять доверие, лишаться доверия

ИТГЭМЖГҮЙ не заслуживающий доверия, безнадёжный

ИТГЭМЖИЛСЭН доверительный, **~ нярав** инкассатор

ИТГЭМЖИТ дипломатический ранг

ИТГЭМЖЛЭГ доверенность, аккредитив, **~ олгох** выдать доверенность, **~ээр мөнгө авах** получить деньги по доверенности

ИТГЭМЖЛЭГДЭХ *страд. от* **итгэмжлэх**, быть доверенным, доверяться, **~сэн хүн** доверенное лицо

ИТГЭМЖЛЭГЧ доверитель

ИТГЭМЖЛЭЛ доверенность, доверие, **хувьцаа авах ~** доверенность на получение дивидентов

ИТГЭМЖЛЭХ 1) оказывать доверие, вверять, доверять, верить, 2) верительный, **~ жуух бичиг барих** вручать верительные грамоты

ИТГЭМТГИЙ доверчивый, легковерный, **~ зан** доверчивость, легковерие, **~ хүүхэд** доверчивый ребёнок

ИТГЭМХИЙ доверчивый, легковерный

ИХ 1) большой, великий, грандиозный, огромный, 2) очень, весьма, сильно, 3) старший, **~ гүрэн** великая держава, **~ хурал** съезд, **~ сургууль** университет, **~ дэлгүүр** универмаг, **~ буу** артиллерийское орудие, **~ эмч** врач, **Их Хүрээ** — название столицы Монголии в начале XX века, **~ замын дээрэм** разбой на большой дороге, **~ алаг бялзуухай** соловей, **~ зэрэг сувилах** переболеть оспой, **~ цааз** основной закон, **~ амт** волк (в Завханском аймаке), **~ зан** высокомерие, надменность, **~ хөг** мажор, **агуу ~** величественный, гигантский, **~ гарын, ~ гартай** сильные, высокопоставленные, **~ гарын баячууд** олигархи, **~ийг шийр барих** быть степенным, рассудительным, **~ том** очень большой, **~ сайн** очень хорошо, **~ баярлалаа** большое спасибо, **~ хүү** старший сын, **~ ах** старший брат, **~ хөг** *муз.* мажор, **~ уян налархай** пластичный, **~ хиур од** звезда Бета в созвездии Персея, **~ хаан од** звезда Бета в созвездии Малой Медведицы

ИХДҮҮЛЭХ *побуд. от* **ихдэх**, делать слишком большим, делать большим, чем надо

ИХДЭХ оказываться больше чем надо, быть большим, чем нужно, делаться слишком большим, быть великим (об одежде), превзойти меру

ИХСЭЛТ возрастание, увеличение, усиление

ИХСЭХ становиться еще больше, возрастать, увеличиваться, усиливаться, **шуугиан чимээ ~в** звуки и шум возрастали, **салхи ~в** ветер усилился, **цусны даралт ~в** кровяное давление поднялось

ИХЭВЧЛЭН в большей части, в основном, главным образом

ИХЭД много, весьма, очень, сильно, **~ хүсэх** сильно желать, гореть желанием, **~ зовох** сильно мучиться, сильно страдать

ИХЭМСЭГ высокомерный, горделивый, важный, **~ хүн** высокомерный человек, **~ дүр** высокомерный вид, **~ зан** высокомерие, важность, **~ оршихуй** экзистенциализм.

ИХЭМСЭГЛЭХ вести себя высокомерно, важничать

ИХЭНХ большая часть, большинство, **~ нөхөд нь** большинство его друзей, **~ хувь** большая часть, значительная часть, **~ нь болох** быть большинством, **~ийн саналаар** большинством голосов

ИХЭНХДЭЭ в большинстве случаев, главным образом, большей частью, преимущественно, обычно, **~ гэртээ байх** обычно бывать дома

ИХЭР близнецы, двойня, **гурван ~** трое близнецов, тройня

ИХЭРЛЭЛТ рождение близнецов

ИХЭРЛЭХ родить близнецов, рождать двух и более детёнышей (о животных)

ИХЭРХҮҮ высокомерный, кичливый, надменный, важный, **~ зан** высокомерие, надменность, чванство

ИХЭРХЭГ высокомерный, кичливый, надменный, важный

ИХЭРХЭХ важничать, чваниться, высокомерничать

ИХЭС 1. высокопоставленное лицо, элита, **~ дээдэс** *парн.* вельможи, сановники, элита

ИХЭС 2. *анат.* плацента, послед, **төрсний дараа ~ нь гарах** выход последа после родов, **~ цөглөх** отделение последа, **~ийн үлдэгдэл** *мед.* остатки плаценты, **~ийн төвийн түрүүлэлт** центральное предлежание плаценты, **~ийн цэлмэн** хориод

ИХЭСГҮҮР усилитель, увеличитель

ИХЭСГЭХ *побуд. от* **ихсэх**, усиливать, увеличивать, расширять, **бүтээгдэхүүний гаргалтыг ~** увеличить выпуск продукций

ИХЭЭХЭН 1) значительный, довольно большой, 2) довольно много, сильно, **~ ажил хийх** проделать большую работу

ИЧГҮҮР стыд, позор, срам, **~ сонжуур** *парн.* позор, срам, **~ сонжуургүй** бесстыдный, **~ээ алдах** наглеть, терять стыд, делаться нахальным

ИЧГҮҮРГҮЙ бесстыдный, не чувствующий стыда, непристойный, бесстыжий, наглый, **~ загнах/аашлах** нахальничать, грубить

ИЧГҮҮРТЭЙ постыдный, позорный, позорящий, **~ явдал/хэрэг** позорный поступок, постыдный поступок

ИЧГЭВТЭР стыдно, позорно, постыдный, позорный, **~ явдал** постыдный поступок

ИЧИГ стыдно, как не стыдно!

ИЧИМТГИЙ стыдливый, застенчивый, чрезвычайно скромный, **~ охин** стыдливая девочка, **~ зан** стыдливость, скромность

ИЧИМХИЙ стыдливый, застенчивый

ИЧИХ 1. стыдиться, стесняться, **би ~ж байна** мне стыдно, **~ээд яах вэ, хонгор минь** не стесняйся, милая моя, **~ нүүрэндээ илэг наах** терять стыд

ИЧИХ 2. погружаться в зимнюю спячку

ИЧМЭЭР постыдный, позорный

ИЧЭЭ зимняя спячка, зимние норы (у некоторых животных), **баавгайн ~** берлога, **~ нээс гарах** выходить весной из зимних нор

ИЧЭЭХ *побуд. от* **ичих**, стыдить, конфузить, **амьтны нүүрэн дээр ~** пристыдить перед людьми

ИШ 1) ручка, рукоятка, черенок, 2) ствол, стебель, **хутганы ~** рукоятка ножа, **сүхний ~** топорище, **хүрзний ~** черенок лопаты, **модны ~** ствол дерева

ИШ 2. источник, основа, начало, **~ үндэс** основа, основание, **ямар ~ үндэс дээр** на каком основании, **ямар ч ~ үндэсгүй, ямар ч ~ үндэс алга** лишено всякого основания, **~ баримт** факт, доказательство, **~ татах** цитировать, приводить цитату, ссылаться на источник, **~ үзүүлэх** пророчить, предвещать

ИШ 3. *междометие:* увы! **~, чаавааc!** увы!, **тамхины ~** окурок

ИШИГ козлёнок
ИШИГЛЭХ давать козлёнка, котиться (о козе)
ИШЛЭЛ цитата, цитирование, ссылка
ИШЛЭХ приделать рукоятку, прикреплять рукоятку
ИШЧООШИГ счётчик (электро)

Й

ЙЕМЕН Йемен, йеменский
ЙОГ йог, йога
ЙОГЧ йог

К

КАБЕЛЬ кабель, кабельный, ~ **телевиз** кабельное телевидение, ~ **шугам** кабельная линия
КАБИН кабина
КАБИНЕТ кабинет
КАЗАК казаки, казачий
КАЗАХ казахский, ~ **уран зохиол** казакская литература
КАКАО какао, **лааз тай** ~ банка какао, **аяга** ~ уух выпить стакан какао
КАЛЕНДАРЬ календарь, **ширээний** ~ настольный календарь
КАЛИБР ~**буу** мелкокалиберная винтовка
КАМЕР камера, **хийтэй/хийлсэн** ~ камера, наполненная воздухом
КАМПАНИ кампания, **тариалалтын** ~ посевная кампания, **сонгуулийн** ~ избирательная кампания, **ургац хураалтын** ~ уборочная кампания, ~**т ажил эхлэх** начать кампанию
КАПИТАЛ капитал, **санхүүгийн** ~ финансовый капитал, **үндсэн** ~ основной капитал
КАПИТАЛИЗМ капитализм, ~**ыг алгасан** минуя капитализм
КАПИТАЛИСТ капиталистический, ~ **байгуулал** капиталистический строй, ~ **нийгэм** капиталистическое общество, ~ **бус хөгжлийн зам** некапиталистический путь развития
КАПРОН капрон, капроновый, ~ **оймс** капроновые чулки
КАРАКУЛЬ каракуль, каракулевый, **хар** ~ чёрый каракуль, ~ **зах** каракулевый воротник, ~ **хонь** каракулевая овца
КАРАНТИН карантин
КАРМАН карман, ~**д хийх** положить в карман, ~**ы хулгайч** карманный вор, карманник
КАРТ карточка, карточный, ~**ын бараа** товары по карточкам, **зээлийн** ~ кредитная карта
КАРТОН картон, картонный, ~ **хайрцаг** картонная коробка
КАСС касса, **хадгаламжийн** ~ сберегательная касса, **билетийн** ~ билетная касса, **тооцооны** ~ расчётная касса, ~**ын тайлан** кассовый отчёт, ~**ын бэлэн мөнгө** кассовая налычность
КАССЧИН кассир, кассирша
КАТАЛОГ каталог, **үсэг дараалсан** ~ алфавитный каталог
КАУЧУК каучук, каучуковый, ~ **мод** каучуковое дерево
КАФЕ кафе
КВАДРАТ квадрат, квадратный, ~ **тэгшитгэл** квадратное уравнение
КВАС квас, **талхны** ~ хлебный квас
КЕРОСИН керосин, керосиновый, керосинный, ~**ы үнэр** керосинный запах, ~ **дэнлүү** керосиновая лампа
КИЛО *разг.* килограмм
КИЛОВАТТ киловатт, ~ **цаг** киловатт /час
КИЛОГРАММ килограмм, килограммовый, ~**ын туухай** килограммовая гиря
КИЛОМЕТР километр, километровый, ~**ийн зай** расстояние в километр
КИНО кино, фильм, ~ **үйлдвэр** киностудия, ~ **найруулагч** кинорежиссёр, ~ **жүжигчин** киноактёр, **уран сайхны** ~ художественный фильм, **баримтат** ~ документальный фильм, хүүхдийн ~ детский фильм, **өнгөт** ~ цветной фильм, хүүхэлдэйн ~ мультипликационный фильм, ~**ны хөгжим** музыка к кинофильм, **дуутай/дуугүй** ~ звуковой/немой фильм, **нүүдлийн** ~ кинопередвижка, ~ **зураг авах** снимать фильм
КИНОТЕАТР кинотеатр
КЛИНИК клиника, клинический, ~**ийн байшин** клинический корпус
КЛИРИНГ клиринг, **хоёр талын** ~ двусторонний клиринг, ~**ийн хэлбэрээр тооцоо хийх** расчёты в форме клиринга
КЛУБ клуб
КНОП кнопка, ~ **дарах** нажимать на кнопку
КОКО: **«коко» авах** набрать очки
КОКС кокс
КОКСЖИХ 1) коксоваться, 2) коксующийся, ~**сон нүүрс** коксующиеся угли
КОКСЛОХ коксовать, **нүүрс** ~ коксовать уголь, превратить уголь в кокс
КОЛЛЕГИ коллегия, **яамны** ~ коллегия министерства, ~**ийн шийдвэр** решение коллегии
КОЛОНИ колония, колониальный, ~**ийн бодлого** колониальная политика, **хөдөлмөр хүмүүжлийн** ~ воспитательно-трудовая колония
КОЛОНЧЛОЛ колонизация, **шинэ** ~ неоколонизация
КОЛОНК колонка, **бензин** ~ бензоколонка, автозаправка
КОМАНД команда, **гал** ~ пожарная команда, ~ **өгөх** подать команду, ~**аар ажиллах** работать по команде
КОМАНДЛАГЧ командующий, **арми** ~ командующий армией, командарм
КОМАНДЛАЛ командование, дээд ~ верховное/высшее командование, **армийн** ~ армейское командование
КОМАНДЛАХ командовать, произносить слова команды, **хороо** ~ командовать полком
КОМБАЙН комбайн, комбайновый, **хөдөө аж ахуйн** ~ сельскохозяйственный комбайн, **нүүрсний** ~ угольный комбайн
КОМБАЙНЧ комбайнер
КОМБИНАТ комбинат, **хүнсний** ~ пищевой комбинат, **гурилын** ~ мукомольный комбинат, **мах** ~ мясокомбинат, **уулын баяжуулах** ~ горнообогатительный комбинат
КОМЕНДАНТ комендант, комендантский, **хотын** ~ комендант города, ~**ын тушаал** комендатский приказ
КОМЕНДАТУР комендатура
КОМЕНТЕРН коммунистический интернационал, коминтерн
КОМИСС комиссия, комиссионный, **сонгуулийн** ~ избирательная комиссия, **мөрдөн байцаах** ~ следственная комиссия, **шалгалтын** ~ экзаменационная комиссия, **мэргэжлийн** ~ специализированная комиссия, ~**ийн худалдаа** комиссионный продажа
КОМИССАР комиссар, начальник охраны высокопоставленного лица
КОММУНИЗМ коммунизм, ~ **байгуулах** строить коммунизм
КОММУНИСТ коммунист, коммунистический, ~ **нам** коммунистическая партия, ~ **нийгэм** коммунистическое общество
КОМПАНИ компания, **хязгаарлагдмал бус хариуцлагатай** ~ компания с неограниченной ответсвенностью, **хязгаарлагдмал хариуцлагатай** ~ компания с ограниченной ответсвенностью, **охин** ~ дочерняя компания, **хувь нийлүүлсэн** ~ акционерная компания, ~ **үүсгэн байгуулагч** учредитель компании
КОМПАС компас, компасный
КОМПОТ компот
КОМПЬЮТЕР компьютер, **хувийн** ~ персональный компьютер
КОНДУКТОР кондуктор, **автобусны** ~ кондуктор автобуса
КОНСЕРВ консервы, консервный, **махан** ~ мясные консервы, **загасан** ~ рыбные консервы, ~**ын үйлдвэр** консервная фабрика, ~**ын лааз** консервная банка

КОНСЕРВЛОГДОХ *страд. от* **консервлох**, консервироваться, быть консервированным
КОНСЕРВЛОХ 1) консервировать, 2) консервирование, **ногоо ~** консервировать овощи, **~сон загас** консервированная рыба
КОНЦЕРН концерн
КОНСПЕКТ конспект, **~ хийх** составлять/писать конспект
КОНСУЛ консул, консульский, **ерөнхий ~** генеральный консул, **~ын газар** консульство, **~ын хэлтэс** консульский отдел, **~ын дэнж** историческое название района в Улаанбаатаре, ныне XV микрорайон, **~ын эрх зүй** консульское право, **өргөмжит ~** почётный консул
КОНТОР контора, **тээврийн ~** транспортная контора, **~ын ажилтан** конторский служащий
КОНТОРЛОХ работать в конторе
КОНТРАБАНД контрабанда
КОНЦЕРТ концерт, концертный, **~ тоглох** дать концерт, **~ын танхим** концертный зал
КОНЬЯК коньяк, коньячный
КОРИДОР коридор, коридорный
КОСТЮМ костюм, **~ны хэмжээ** размер костюма
КОСЧООМ костюм
КОТЛЕТ котлета, **махан ~** котлета с мясом
КОФЕ кофе, **хар ~** чёрный кофе, **сүүтэй ~** кофе с молоком, **~ уух** пить кофе, **~ чанах** варить кофе
КОШМААР кошмар, **паах, ямар ~ юм бэ** какой кошмар
КООПЭЭ *разг.* кофе
КОЭФФИЦИЕНТ коэффициент, **ашигт үйлийн ~** коэффициент полезного действия
КРАН кран, **өргөгч ~** подъёмный кран, **усны ~** водопроводный кран
КРАНТ крановый, **~ын ус** вода из-под крана
КРИМИНОЛОГИ криминология
КУБ куб, **~ мод/түлээ** куб дров, **~ зурах** начертить куб
КУРААН коран
КУРС курс, курсы, курсовой, **эмчилгээний ~** курс лечения, **бүрэн ~** полный курс, **мэргэжил дээшлүүлэх ~** курсы повышения квалификации, **гадаад хэлний ~** курсы иностранных языков, **тэр жолооны ~д суралцдаг** он учится на водительских курсах
КҮНЗ Конфуций, конфуцианский

Л

НАС (ан) возраст, годы, лета, жизнь, **амь ~** жизнь, **бага ~** детство, **залуу ~** молодость, **дундаж ~** средний возраст, **үр буяны ~** время зачатия, **эхийн ~** время от начала беременности до рождения, внутриутробная жизнь, **хүргачин ~** возраст от 4 до 5 лет, **тугалчин ~** возраст от 5 до 6 лет, **ботточин ~** 6-8 лет, **хоньчин ~** 8-16 лет, **адуучин ~** возраст с 17 лет, **эрэлчин ~** время поиска любимого (ой), **залуу ~** 25-35 лет, **идэр ~** 35-45 лет, **хижээл ~** старше 50 лет, **сургуулийн ~наас хэтрэх** выйти из школьного возраста, **тэд ~ чацуу** они одних лет, **~ ах** старше по возрасту, **~аар дүү** моложе по возрасту, **~ хөгшрөх** стареть, **~нд хүрэх** достигать совершеннолетия, **~нд хүрсэн** совершеннолетний, **~ барах/нөгчих** скончаться, умереть, **таны ~ сүүдэр ямар байна вэ?** каковы ваши лета? **~н хутаг болох** почить непробудным (вечным) сном, **хижээл ~ны** пожилого возраста, **~ болох** достигнуть преклонного возраста, **~аа идэх** выглядеть моложе своих лет, **~ барсанд тооцох** объявление умершим, объявление о признании умершим, **~ сүүдэр дээр гарах** быть в преклонном возрасте, **~н турш** пожизненный, **~н турш эзэмших эрх** право на пожизненное владение, **~н туршийн түрээслэгч** пожизненный арендатор, **~нд хүрээгүй хүн** несовершеннолетний, **~нд хүрээгүй гэмт хэрэгтэн** несовершеннолетний преступник, **~ны тэтгэвэр** пенсия по возрасту, **~ны хязгаарал** возрастные ограничения, возрастной ценз, **~ юулэх** почить, преставиться, **~ны мөчлөг** жизненный цикл, **~ бага цус шингэн** молоко на губах не обсохло, молодозелено

НАСГҮЙ: ~ болох готовиться к смерти из-за ухудшения здоровья (дословно не иметь возраста)

НАСЖИХ стариться, становиться пожилым, стареть

НАСЛАЛТ продолжительность жизни, **дундаж ~** средняя продолжительность жизни

НАСЛАХ достигать какого-либо возраста, проживать жизнь, **урт удаан ~ыг ерөөх** желать долгих лет жизни

НАСОС насос, насосный, **шахах ~** компрессор-насос, **бүлэх ~** поршневый насос, **хийн ~** воздушный насос, **усыг ~оор соруулах** выкачать воду насосом

НАСТ имеющий какой-либо возраст, **зуун ~** а) столетний (человек) б) столетник

НАСТАЙ 1) имеющий какой-либо возраст, 2) старый, пожилой, **та хэдэн ~ вэ?** сколько вам лет? **би дөчин хоёр ~** мне сорок два года, **~ хүн** старый/пожилой человек

НАСТАЙВТАР пожилой, немолодой, преклонных лет, **~ эмэгтэй** женщина преклонных лет

НАСТАЙДУУ довольно пожилой/старый

НАСТАЙХАН престарелый, преклонных лет, довольно пожилой

НАСТАН имеющий какой-либо возраст, **өндөр ~, урт ~** долгожитель, **хорин ~гууд** двадцатилетние (юноши и девушки)

НАХИА росток, почки, **навч ~** *парн.* листья

НАХИАЛАХ распускаться, начинать расти, **модод ~в** деревья распустились

НАХИГАР искривлённый, чуть кривой, гнутый, **~ саваа** искривлённая палочка

НАХИЙЛГАХ *побуд. от* **нахийх**, нагибать, наклонять, сгибать

НАХИЙХ сгибаться, изгибаться, наклоняться, нагибаться

НАХИЛЗАХ 1) сгибаться, гнуться (об длинном предмете), 2) кивать головой, кланяться, **~ бөхөлзөх** *парн.* кланяться

НАХИУ 1) седловина (между гор), 2) согнутый, дугообразный

НАЧИН 1) сокол, 2) первое низшее звание, присваиваемое борцам-победителям на надаме, **~ шонхор** пустельга обыкновенная

НАЯ(н) восемьдесят, **~н нэг** восемьдесят один

НАЯАД около восьмидесяти, **~ он** восьмидесятые годы, **~ оны эхээр/эцсээр** в начале/конце восьмидесятых годов, **~ километр** около восьмидесяти километров

НАЯДУГААР восьмидесятый, **~ хуудас** восьмидесятая страница

НАЯХАН *уменьш. от* **ная**, только восемьдесят, всего восемьдесят, **над ~ доллар байна** у меня имеется всего лишь восемьдесят долларов

НЕЙТРОН нейтрон, нейтронный, **~ы бөмбөг** нейтронная бомба

НЕФТЬ нефть, нефтяной, **~ олборлох** добывать нефть, **~ийн үйлдвэр** нефтяная промышленность, **~ боловсруулах үйлдвэр** нефтеперегонный завод, **~ийн цооног** нефтяная скважина

НИГҮҮСЭЛ милосердие, милость, сожаление, сострадание

НИГҮҮЛСЭЛ милосердие, милость

НИГҮҮЛСЭНГҮЙ милосердный, сострадательный, гуманный

НИДРЭХ 1) стирать на стиральной доске, 2) тереть, ударяться (о что-либо), 3) *разг.* ударить, убивать, наносить скользящий удар

НИЖГЭНЭХ греметь, грохотать

НИЖГЭР 1) грандиозный, шумный, пышный, обильный, 2) шумно, пышно, обильно, **~ хурим/найр** пышная свадьба, богатый, большой пир, **~ амжилт** грандиозный/шумный успех, **~ тэмдэглэх** шумно справлять/отмечать

НИЖГЭЭД по одному

НИЖИГНЭХ греметь, грохотать, звучать громко, **тэнгэр ~нэ** гром гремит, **~сэн алга ташилт** бурные аплодисменты

НИЖИГНЭЭН грохот, сильный шум с раскатами

НИЙ: **~ нуугүй** откровенно, **~ нуугүй ярилцах** беседовать откровенно, **~ нуугүй ярихад** откровенно говоря

НИЙВИЙ мастерок, лопаточка каменщика, кельня

НИЙГЭМ общество, общественный, **хүй нэгдлийн ~** первобытное общество, **ангигүй ~** бесклассовое общество, **ангит ~** классовое общество, **~ийн бүтэц** социальная структура, **~ийн өмч** общественная собственность, **~ийн хөдөлмөр** общественный труд, **~ийн амьдрал** общественная жизнь, **~ийн үйл ажиллагаа** общественная деятельность, **~ийн ухамсар/үзэгдэл** общественное сознание /явление, **~ийн үүрэг** общественный долг, **~ийн эрх ашиг** общественные интересы, **~ийн дэвшил** социальный прогресс, **~ийн байдал/гарал** социальное положение/происхождение, **~ийн хэв журам** общественный порядок, **~ийн аюулгүй байдал** общественная безопасность, **~ийн үйлдвэрлэл/хэрэглээ** общественное производство/потребление, **~ийн даатгал** социальное страхование, **~ийн хангамж** социальное обеспечение, социальное благосостояние, **~ийн ухаан** гуманитарные науки, **~ийн шударга ёс** социальная справедливость, **~ийн амгалан тайван байдал** общественное спокойствие, **~ийн байгуулал** общественный строй, **~ийн байгууламж**

общественное устройство, **~-эдийн засгийн байгууламж** социально-экономическое устройство, **~д аюултай этгээд** социально-опасный элемент, **~д харш зан үйл** антисоциальное поведение

НИЙГЭМЛЭГ *общество, ассоциация, объединение*, **найрамдлын ~** общество дружбы, **улаан загалмайн ~** общество Красного креста, **хувь нийлүүлсэн ~** акционерное общество, **хувьцаат ~** акционерное общество, **хааттай хувьцаат ~** закрытое акционерное общество

НИЙГЭМЧЛЭГДЭХ *страд. от* **нийгэмчлэх**, обобществляться, быть обобществлённым, **~сэн хөдөө аж ахуй** обобществлённое сельское хозяйство

НИЙГЭМЧЛЭЛ обобществление, **мал ~** обобществление скота

НИЙГЭМЧЛЭХ обобществлять, превратить в общественную собственность, объединять/обратить в общественную собственность, **үйлдвэрлэлийн хэрэгслэлийг ~** обобществлять средства производства

НИЙЛБЭР 1) сумма, 2) устье реки, **~ дүн** общий итог, **~ дүнгээр** в совокупности

НИЙЛМЭЛ сложный, составной, соединенный, **~ өгүүлбэр** *сложное предложение*, **~ үг** составное слово, **~ айзам** сложные такты, **~ төрөл** синтетический жанр

НИЙЛЛЭГ соединение, согласие

НИЙЛҮҮЛЭГ 1) случка, 2) слияние, присоединение, 3) поставка, доставка, **мал ~ийн кампани** случная кампания, **мал ~ийн газар/цэг** случной пункт, **мал ~ийн үе** случной сезон, **түүхий эд ~** поставка сырья

НИЙЛҮҮЛЭГЧ *поставщик, снабженец*, **бараа ~** *поставщик* товаров, **хувь ~** акционер, пайщик

НИЙЛҮҮЛЭЛТ поставки, **~ийн үнэ** цена поставки

НИЙЛҮҮЛЭХ 1) соединять, присоединять, объединять, 2) смешивать, перемешивать, перепутывать, 3) случить, 4) поставлять, снабжать, **бараа ~** снабжать товарами, поставлять товары, **хувь ~** вносить пай, **хонь малаа ~** смешивать скот/отары овец из разных стад, **улсад мах сүү ~** *поставлять* государству мясо и молоко, **~ хугацаа** сроки поставок (товара), **хөлөө ~н алхах** шагать в ногу

НИЙЛЭГ синтез, синтетический, **~ эдлэл** синтетическое изделие

НИЙЛЭЛ: **~ зохирол** *муз.* полигармония, **~ хэм** полиметрия, **~ эгшиглэн** полифония

НИЙЛЭМЖ пристойность, комбинация

НИЙЛЭХ 1. соединяться, объединяться, сливаться, собираться вместе, жениться, **ам ~** договориться, сходиться в мнениях, **гар ~** *действовать дружно, работать рука об руку*, **санаа ~** быть в согласии, соглашаться, **санал ~** разделять мнение, быть одного мнения, присоединяться к чьему-либо мнению, **~ хэлбэрээр** путём слияния

НИЙЛЭХ 2. точить (нож)

НИЙСЛЭЛ столица, столичный, **манай орны ~** столица нашей страны, **~ийн иргэн** столичный житель, житель столицы, **~ Хүрээ** название Улан-Батора в *начале XX века*

НИЙТ 1) весь, все, всего, 2) общий, общественный, валовой **~ дүн** общая сумма, общий итог, всего, **~ бүтээгдэхүүн** валовая продукция, **~ орлого** валовой доход, **хөрөнгө оруулалтын ~ дүн** общая сумма капиталовложений, **~ даруул** клавиатура, **олон ~ийн байгууллагууд** общественные организации, **~ийн эрх ашиг** общие интересы, **~ийн үйл хэрэг** общее дело, **~ийн хүчээр** общими усилиями, **~ийн хоолны газар** предприятия общественного питания, **~ийн үйлчилгээ** коммунальное обслуживание, **~ийн байр** общежитие; **~ээр хүлээн зөвшөөрсөн** общепринятый, **олон ~ийн ажил** общественная работа, **~ийн тээврийн хэрэгсэл** общественный транспорт, **~ийн эзэмшлийн газар** земля общего пользования, **~ээрээ сонгох эрх** всеобщее избирательное право, **~ хамарсан жин** вес брутто, **зээлийн ~ шугам** общая кредитная линия

НИЙТГҮҮЛЭХ *побуд. от* **нийтгэх**, давать сучить, заставлять скручивать

НИЙТГЭМЭЛ сучёный, скручённый, **~ утас** сучёная нить

НИЙТГЭХ скручивать, сучить, свивать, **утас ~** сучить/скрутить нитку, сучить пряжу

НИЙТЛҮҮЛЭХ *побуд. от* **нийтлэх**, публиковать, печатать, издавать, **өгүүлэл сонинд ~** опубликовать статью в газете, **зохиолчийн хэвлэгдээгүй шүлгүүдийг ~** публиковать неизданные стихотворения писателя

НИЙТЛЭГДЭХ *страд. от* **нийтлэх**, публиковаться, издаваться, печататься, **сэтүлд ~** публиковаться в журнале

НИЙТЛЭГ типичный, общий, **~ дүр** типичный образ, **~ шинж** типичная черта, **бэлтгэн нийлүүлэх ~ нөхцөл** общие условия поставки, **~ журам** общее правило, **~ үүрэг** общее обязательство, **~ эрсдэл** общий риск

НИЙТЛЭГЧ *публицист, автор, издатель*

НИЙТЛЭЛ 1) публицистика, 2) публикация, **сонины ~** газетная публикация

НИЙТЛЭХ 1) публиковать, печатать, издавать, 2) публикация, **хэвлэн ~** издавать, **хэвлэлд ~** публиковать в печати, **түүхэн баримтуудыг ~** а) публиковать исторические документы, б) публикация исторических документов

НИЙХ сморкаться, сморкать нос, **алчууртаа ~** *сморкаться в платок*

НИЙЦ 1) согласие, единомыслие, гармония, 2) общительность, обходительность, **хоорондоо ~ муутай хүмүүс** люди, не имеющие согласия между собой

НИЙЦГҮЙ 1) несогласованный, несогласный, 2) необщительный, необходительный, **бусадтай ~ хүн** необщительный

НИЙЦТЭЙ 1) согласованный, сочетающийся, гармоничный, 2) *общительный, обходительный*, **бусадтай ~ хүн** общительный человек

НИЙЦҮҮЛЭХ *побуд. от* **нийцэх**, согласовывать, привести к согласию, установить связь/соответствие между чем-нибудь

НИЙЦЭХ соответствовать, быть в соответствии, согласовываться, соглашаться, **үнэн байдалд ~** соответствовать действительности, **байдалд ~** соответствовать обстановке, **зорилгод ~** *соответствовать цели*, **шаардлагад ~** *соответствовать требованиям*, **дүрэмд ~** соответствовать положению, быть в соответствии с правилом, **авсан үүрэгтэйгээ ~** согласовываться с принятыми на себя обязательствами

НИЙЦЭХ *юр.* согласие

НИЛ фиолетовый, **~ цэцэг** фиалка, **~ болор** аметист, **~ эрдэнэ** сапфир

НИЛЭЭД значительно, достаточно

НИМБЭГ лимон, лимонный, **~ний үндаа** лимонад, лимонадный сок, **~ний хүчил** лимонная кислота, **~ний мод** лимонное дерево

НИМГЭДЭХ быть слишком тонким, оказываться тоньше положенного

НИМГЭЛЭХ 1) утончать, делать более тонким, 2) уменьшать, **хувцас ~** снимать лишнюю одежду

НИМГЭН 1) тонкий (о плоских предметах), 2) ничтожный, незначительный, поверхностный, **~ зузаан** *парн.* толщина, **~ ном** тонкая *книга*, **ханын ~ зузаан** толщина стены, **~ мэдлэг** поверхностные знания, **малын тарга хүч ~ байна** упитанность скота небольшая

НИМГЭРҮҮЛЭХ *побуд. от* **нимгэрэх**, делать слишком тонким

НИМГЭРЭХ 1) делаться тонким, становиться тоньше, стать тонким, утончаться, 2) рассеиваться (об облаках), 3) уменьшаться, сокращаться, пустеть (об имуществе, о кармане), **үүл ~ч байна** облака рассеиваются, **хөрөнгө чинээ ~ч байна** состояние/имущество идёт на убыль

НИНГЭДЭХ быть слишком тонким

НИНГЭЛЭХ утончать, уменьшать

НИНЖА *разг.* ниндзя, старатель-нелегал

НИНЖ (ин): **~ сэтгэл, ~н сэтгэл** милосердие, сострадание, **~н сэтгэл гаргах** проявлять милосердие, **~н сэтгэлтэй хүн** милосердный человек

НИРВААН *рел.* нирвана, **~ болох** переселиться в нирвану, умереть, **~ы дүр үзүүлэх** отходить в мир иной, успокоиться, **~ы хутгийг олох** преставиться

НИРГҮҮЛЭХ *побуд. от* **ниргэх**, быть поражённым молнией

НИРГЭГДЭХ *страд. от* **ниргэх**, быть разгромленным, **дайсан бут ~в** враг был разгромлен

НИРГЭЛТ разгром, гром

НИРГЭХ громить, ударять, **дайсныг бут ~** разгромить врага, **~сэн хойно хашгирах** махать кулаками после драки

НИРХИЙХ издавать сильный шум грохот, сильно зашуметь, галдеть, **шувууд ~н нисэв** птицы с шумом взлетели, **цугларагсад суудлаасаа ~н босов** собравшийся с шумом встали с места

НИСВАНИС *рел.* чистилище, место между раем и адом осквернение

НИСГЭГЧ лётчик, пилот, авиатор, **сансрын ~** лётчик-космонавт, **туршин ~** лётчик-испытатель

НИСЛЭГ полёт, **~ийн хуваарь** расписание полётов, **~ хойшлох/хойш-луулах** отложить полёт, **удаан ~** продолжительный полёт, **шууд ~** полёт без промежуточных посадок, прямой рейс, **~ийн өндөр** высота полёта

НИСЭГЧ летающий, летательный, лётчик, пилот, **~ аппарат** летательный аппарат

НИСЭЛТ полёт, **~ийн хурд** скорость полёта

НИСЭХ лететь, летать, **~дэг тэрэг** вертолёт, **~ онгоц** самолёт, **~ онгоцны буудал** аэропорт, **~ онгоцны үйлдвэр** авиационная промышленность, **~ онгоц зөөгч** авианосец, **~ хүч** авиация, **~ийн сургууль** авиашкола, нисдэг загас летучка (рыба), **~ж ирэх** прилетать, **~ж одох/явах** улететь

НОВ *частица усиления к словам с начальным но:* **~ ногоон** совсем зелёный, совершенно зелёный, ярко-зелёный

НОВШ ветошь, хлам, рухлядь, сор, **~ оо!** ругательство: мудак, **муусайн ~нууд** мудаки

НОВШИРХОГ захламленный, засоренный

НОВШИРХУУ захламленный

НОВШРОХ заваливаться ветошью, захламиться, быть разбросанным в беспорядке

НОГДОЛ квота, доля, пай, **~ ашиг** дивиденд, **онцгой ~ ашиг** экстренный дивиденд, **~ ашгийн хязгаарлалт** дивидендное ограничение, **~ ашгийн татвар** дивидендный налог

НОГДОХ причитаться, **~сон хувь** квота, **татварын ~сон хувь** налоговая квота, **экспортын ~сон хувь** экспортные квоты

НОГДУУЛАХ налагать, облагать, **~сан орлого** облагаемый доход, **~сан үнэ өртөг** облагаемая стоимость

НОГОО 1) зелень, 2) овощи, **өвс ~** трава, **хүнсний/идэшний ~** овощи, **~ны талбай** овощная площадь, **~ны дэлгүүр** овощной магазин, **~ны зоорь/агуулах** овощехранилище, **~ны аж ахуй** овощеводство, **~той хоол** овощное блюдо, **~ хураах** собирать/убирать овощи, **~н хувьсгал** «зелёная революция»

НОГООВТОР зеленоватый, зеленовато

НОГООЛИН малахит, медная зелень

НОГООН зелёный, **~ будаг** зелёная краска, **~, ~ цаас** доллар, **~ зүлэг** зелёная трава, **~ы бөөс** тля, **~ы мэлхий** лягушка травяная, **~ цай** зелёный кирпичный чай, **~ лаг** зелёный ил, **~ мана** гелиотроп, **~ хаш** нефрит, **~ хошууны арлууд** острова Зелёного мыса, **~ морь** зелёная лошадь (чучело) используемая в ритуале «Майдар», **~ морь цагаан болтол, нохойн толгой гурав болтол наргих** напиться до чёртиков, *букв.* пока зелёная лошадь не станет белой, а у собаки не появиться три головы, **~ малгайтан** энкэвэдэшник

НОГООНТОН «зелёные» экологи, **~ы нам** партия зелёных

НОГООРОХ зеленеть, покрываться зеленью/зелёной травой, **хээр тал ~в** степь покрылась зелёной травой, опухать от сна или пьянства

НОГООРУУЛАХ *побуд. от* **ногоорох**, озеленять, делать зелёным, **хот ~** озеленить город

НОГООЧИН огородник, овощевод

НОГТ недоуздок

НОГТЛОХ надеть недоуздок

НОДНИН прошлый, **~ жил** прошлый год, **~ зун** прошлое лето

НОЁД господа, князья, **~ын үхэл чуулганд, нохойн үхэл ганд** князья умирают на сейме, собака — во время засухи

НОЁЛОГ господствующий, главенствующий, главный, центральный, **~ оргил** главная/центральная вершина

НОЁЛОГЧ господствующий, доминирующий

НОЁЛОХ 1) господствовать, властвовать, командовать, начальствовать, распоряжаться, 2) преобладать, быть большинством

НОЁН 1. нойон, феодальный князь, господин, **~ дарга аа!** господин председатель! **~ оргил пик, гл** дамы и господа!

НОЁН 2. король (в шахматах и картах)

НОЁН 3. вершина, пик, поперечина, стержень, **байшингийн ~ нуруу** главная верхняя поперечина здания, **~ нуруутай** имеющий стержень (о человеке)

НОЁНТОН господин, сэр

НОЁРХОЛ господство, власть, доминирование, **хөрөнгөтний ~ыг устгах** ликвидировать/уничтожать господство буржуазии

НОЁРХОГЧ господствующий, **~ анги** господствующий класс

НОЁРХОХ 1) господствовать, властвовать, 2) преобладать, иметь преимущество, доминировать, **далайд/агаарт ~** господствовать на море/в воздухе

НОЁРХУУ властолюбивый, любящий командовать, властный, **~ зан** властный характер, властолюбивое поведение, **~ хүн** властный человек

НОЗООРОХ отяжелеть, чувствовать усталость/лень (от зноя), чувствовать вялость

НОЗООРУУЛАХ *побуд. от* **нозоорох**, доводить до усталости/вялости

НОЙЛ: **~ өрөө** туалет, туалетная комната

НОЙР сон, **~н дундаа** во сне, **бөх ~** крепкий сон, **~ ихтэй** сонный, сонливый, любящий много спать, **~ хүрэх** хотеться спать, клонить в сон/ко сну, **~ авах** поспать, вздремнуть, **~оос сэрэх** просыпаться, **~ муутай болох, ~ хүрэхээ болих, ~ хүрэхгүй болох** страдать бессонницей, **~ны эм** снотворное, **~ ханах** выспаться, **миний ~ хулжив** мне не спится, **~ны тулам** сонная тетеря, **~ булчирхай** *анат.* поджелудочная железа

НОЙРГҮЙ бессонный, **~ хоносон шөнө** бессонная ночь, **~ хонох** проводить бессонную ночь

НОЙРГҮЙДЭЛ бессоница, отсутствие сна, лишаться сна, страдать бессонницей

НОЙРМОГ сонный, заспанный, сонливый

НОЙРМОГЛОХ быть сонным, дремать

НОЙРСОХ спать, почивать, **сайхан ~оорой!** спокойной ночи!

НОЙРСУУЛАХ *побуд. от* **нойрсох**, доводить до сна, усыплять, **заставлять уснуть, хүүхэд ~** усыпить ребёнка, **~ эм** усыпляющее/снотворное средство

НОЙРТОЙ сонливый, **~ хүн** сонливый человек

НОЙТДОХ оказываться слишком мокрым, быть слишком мокрым/влажным

НОЙТОН мокрый, влажный, сырой, пропитанный влагой, **~ алчуур** мокрое полотенце, мокрый платок, **~ хувцас** мокрая одежда, **~ газар** *мокрая/сырая земля*, **~ хамуу** а) *мед.* проказа, б) назойливый, навязчивый, **~ хамуу оргих** не оставлять кого-либо в покое, быть назойливым, докучливым, приставать, как банный лист **~ шөнийн тэвэрт** в мокрых ночных объятиях

НОЛ: ~ магнаг один из видов златотканного шёлка

НОЛГО украшения, побрякушки шамана

НОМ 1. книга, книжный, **эрдэм ~** *парн.* образование, учёба, **~ унших** читать книгу, **~ унших ~** *книга для чтения*, **~ хэвлүүлэх** выпустить книгу в свет, **~ын сан** библиотека, **~ын дэлгүүр** книжный магазин, **~ын тавиур** книжная полка, **~ын хавтас** книжный переплёт, **~ сурах, ~ заалгах, ~ үзэх** учиться, **~ хаялцах** вести учёный спор, дискутировать

НОМ 2. учение, канон, **буруу ~тон** еретик, **~ын их хурим хийх** диспут, обсуждение книг (как правило, перед защитой богословских степеней), **~ уншуулах** заказывать чтение молитвы в храме, **~ хүн авах** получать духовное напутствие, **~ хэлэлцэх** *вести религиозный диспут*

НОМГОН: ~ хараацай стриж белопоясничный

НОМЕР номер, номерок, **өрөөний ~** номер комнаты

НОМЕРЛОХ нумеровать, **суудал ~** нумеровать места, **хуудас ~** нумеровать страницы

НОМИН 1. 1) *мин.* лазурит, 2) лазурный, лазоревый, **~ цэнхэр/хөх** синий с зеленоватым отливом(о цвете), **~ хөх тэнгэр** *лазурное небо*, **~ цэнхэр далай** *лазурное море*, **~ эрэг** лазурный берег, **~ аврага** голубая акула

НОМИН 2.: **сохор ~** *зоол.* а) крот, кротовый, цокоры, **сохор ~гийн арьс** кротовая шкура, **сохор ~гийн арьсан дээл** кротовая шуба

НОМЛОГДОХ *страд. от* **номлох**, проповедоваться, выслушиваться проповедь

НОМЛОГЧ проповедник, *миссионер*

НОМЛОЛ учение, проповедь, доктрина, **шашны ~** религиозные учения, религиозная проповедь

НОМЛОХ 1) учить, утверждать, 2) проповедывать, агитировать, пропагандировать

НОМОЙ тихий, смирный, вялый, апатичный, флегматичный, **~ хүүхэд** вялый/апатичный ребёнок

НОМОЙДОХ оказываться слишком тихим/вялым, смирным

НОМТОЙ 1) имеющий книги, 2) грамотный, образованный, **~ хүн** *образованный человек*

НОМТОН: образованный человек, книгочей, **буруу ~** еретик, диссидент

НОМХДОХ быть слишком тихим, оказываться слишком смирным

НОМХОН смирный, спокойный, тихий, покорный, **~ хүн** смирный/спокойный человек, **~ Далай** Тихий океан, **~ морь** смирный конь, **~ дорой** *покорность*, **~!** *команда:* смирно!

НОМХОТГОГЧ: ~ цамц смирительная рубашка

НОМХОТГОЛ усмирение, успокоение

НОМХОТГОХ усмирять, укрощать, привести в покорность, делать смирным, **агсам соогтуг ~** усмирить буяна

НОМХРОХ усмиряться, становиться смирным, успокаиваться, укрощаться

НОМХРУУЛАХ *побуд. от* **номхрох**, усмирять, успокаивать, укрощать, делать смирным/покорным, **эмнэг ~** укротить строптивую лошадь, **араатан ~** усмирить зверя

НОМХОЧЛОХ пользоваться чьей-либо покорностью/смиренностью, выбирать более покорного/смирного, **чи намайг хэтэрхий ~ж байна** ты слишком пользуешься моей покорностью

НОМЧ 1) книжник, любитель и знаток книг, 2) образованный человек, учёный

НОМЧИРХОХ кичиться знаниями, хвастаться учёностью/знанием

НОМЧИРХУУ любящий хвастаться своей учёностью, кичащийся своими знаниями

НООГДВОР доля, пай

НООГДОЛ доля, принадлежащая комулибо при распределении чего-либо, часть, пай, норма выдачи, распределение

НООГДОХ распределяться, доставаться, облагаться, **татвар ~** облагаться налогом

НООГДУУЛАХ *побуд. от* **ноогдох**, распределять, облагать, **татвар ~** облагать налогом, **торгууль ~** облагать штрафом

НООЛОХ трепать, теребить, раздёргивать, тормошить

НООЛУУЛАХ: хүнд ~ж байх быть «страхнутым» кем-либо

НООЛУУР *пух, пуховый*, **ямааны ~** козий пух, **~н цамц** пуховый свитер, **~н алчуур** пуховый платок, **~н өд** перья пуховые, **бөмбөгөн ~** топс, **самнасан ~** чёс, чёсанный пух, **~ бол дайлуур** *разг.* кашемир — это деньги

НООРОГ черновик, набросок, черновой, **хэлэх үгийн ~** набросок речи, **шүлгийн ~** черновой текст стихотворения

НООРОГЛОХ делать набросок, составлять черновик, **захиа ~** составить черновик письма

НООРОГЛУУЛАХ *побуд. от* **ноороглох**, поручать делать набросок, давать составлять черновик

НООРОНХОЙ истрёпанный, измятый, изорванный, изодранный, **~ хувцас** изорванная, измятая одежда, лохмотья

НООРОХ изнашиваться, истрёпываться, быть изодранным

НООРХОЙ изорванный, истрёпанный, изношенный, **~ хувцастай хүн** оборвыш, человек, *одетый в лохмотья*

НООС (он) шерсть, шерстяной, **цэвэр ~** чистая шерсть, **~ ээрэх үйлдвэр** шерстопрядильная фабрика, **~ угаах үйлдвэр** шерстомоечная фабрика, **~н бүтээлэг** шерстяное одеяло, **~н даавуу** шерстяная материя, **ахар ~** шерсть осенней стрижки, **уртын ~** шерсть весенней стрижки, **бохир ~** немытая шерсть

НООСЛОХ снимать шерсть, стричь шерсть, **хонь ~** стричь, снимать шерсть с овец

НООСОРХОГ шерстистый, **~ хонь** шерстистая овца

НООСТ *имеющий шерсть, покрытый шерстью*, **нарийн ~ хонь** тонкорунные овцы

НООСТОЙ покрытый шерстью

НОРВЕГ норвежец, норвежский

НОРГОХ *побуд. от* **норох**, мочить, смачивать, промачивать, делать мокрым /влажным, **үсээ ~** мочить волосы, **усанд ~** смачивать в воде

НОРМ норма, **өдрийн ~** *дневная норма*, **үйлдвэрийн ~** производственные нормы

НОРОХ мокнуть, промокать, намокнуть, **бороонд ~** мокнуть под дождём

НООТ нота, **~ бичиг солилцох** обмениваться нотами, **дууны ~** нота для песни

НОТАРИАТ нотариат, **~аар батлуулах** заверить нотариально, **~аар гэрчлүүлсэн гэрээсэл** *нотариально оформленное завещание*

НОТЛОГДОХ подтверждаться, устанавливаться, быть доказанным, подтверждённым, **~оогүй бол тэр буруугүйд тооцох** презумция невиновности, **~сон гэмт хэрэг** доказанное преступление

НОТ нота

НОТЛОХ доказывать, подтверждать, **үгээ ~ын тулд** для подтверждения своих слов, чтобы подтвердить свои слова, **шинжлэх ухааны үндэстэй ~** научно доказать, **~ баримт** доказательство, **~ баримтын эрх зүй** доказательственное право

НОТОЛГОО доказательство, подтверждение, гарантия, **баталгаа ~** *парн.* гарантия, доказательство, **~ хэрэгтэй** нужно доказательство, **~ны учир холбогдолтой** доказательный

НОХОЙ 1) собака, пес, собачий, 2) хитрый, лукавый, плутовской, **анч ~** охотничья собака, **золбин ~** бездомная собака, **зуудаг ~** злая собака, **~н хоол** собачий корм, **уяаны ~** цепная собака, **~ тухирах/тавих** пускать собаку, травить собакой, **~ хүн** хитрый человек, **~ загас** рыба-ящерица, **~ зээх** рос сомаха, **~ мич** павиан, **~н цагаан хорхой** солитер собачий, **мөрч ~, эрэлч ~** розыскная собака, собака идущая по следу, **хоточ ~** сторожевая собака, **хоньч ~** собака-пастух, **~ гаслам халуун** знойная жара, **~н хошуу** шиповник, **~ явган, гахай нүцгэн** беден как церковная мышь, **~ хэрэг/явдал** неприятный/сложный поступок, **бууны ~**«легавый», провокатор, сексот, **~ жилтэй** рождённый в год собаки, **~ хорь!** «уберите собаку!» (возглас, с которым обращаются к хозяевам при приближении к их юрте), **~ гурав харагдах** «двоиться в глазах» так говорят о степени опьянения, *букв.* «когда собака будет троиться в глазах», **~ долоо!** *букв.* собака оближи! чёрт подери! **~ долоож үх!** пропади всё пропадом! чёрт бы побрал! **~ долоомор** бестолковый, беспутный, **~ зан гаргах** плутовать, мошенничать, **~ морины хүч гаргах** усердствовать, стараться изо всех сил, **~ гахайдаа хүрэх** браниться, ругаться, собачиться, **~н дуу сонсдох (ойртох)** приближаться к концу, завершаться (о чём-либо, о каком-нибудь деле), **явсан ~ яс зууна** получается у того, кто для этого что-то предпринимает, **даахгүй ~ булуу хураана** *букв.* собака, если не сможет грызть кости, то собирает их в кучку, плохому танцору яйца мешают, **~ гаслам халуун** нестерпимая жара

НОХОЙТОХ проявлять плутовство, поступать подло/плутовски, обманывать хитрить

НОЦОЛДООН схватка, драка

НОЦОЛДОХ 1) схватываться, бороть-ся, драться, 2) заниматься с кем-чем-либо, возиться с кем чем-нибудь

НОЦООХ зажигать, разжигать, **гал ~** разводить огонь, **чүдэнз ~** зажигать спичку

НОЦОХ 1. гореть, зажигаться, загораться

НОЦОХ 2. схватывать, набрасываться

НОЦТОЙ важный, особенный, особый, серьёзный, **~ хэрэг** серьёзное дело, **~ алдаа** серьёзная ошибка, **~ дутагдлыг арилгах** устранять серьёзные недостатки

НӨГӨӨ 1) другой, иной, второй, 2) тот, самый, **~ талд** на той стороне, на том берегу, **~ талаас** с другой стороны, **энэ ~ харандаа юу?** это тот карандаш? **~ юм** то самое, **~ хүн хаана байна?** где же тот самый человек?

НӨГӨӨДӨР послезавтра, **~ ирээрэй** приходите послезавтра

НӨГӨӨДҮҮЛ другие, иные, остальные, те самые, **~ ирлээ** приехали те самые

НӨГӨӨТӨХ тот, тот самый, другой, второй, **~өө аль!** дай ту самую вещь/тот самый предмет

НӨГӨӨТЭЙГҮҮР с другой стороны, кроме того, наряду с тем/этим

НӨГӨӨХ: **~ ном** та самая книга, **~ үгээ мартуузай** не забудьте те самые слова

НӨГЧИХ 1) проходить, протекать, миновать (о времени), 2) скончаться, умереть, **цаг ~ тутам** по мере протекания времени, **нас ~** умереть

НӨГЧӨӨХ проводить, **цаг дэмий ~** зря проводить время, бесполезно провести время

НӨЖ сгусток крови, запекшаяся кровь, **хөх ~** синяк, **ай, ~!** чёрт побери!

НӨЖРӨХ свёртываться, сгущаться (о крови)

НӨЛӨӨ влияние, воздействие, **~нд байх** находиться под влиянием, **~ үзүүлэх** оказывать влияние, **~нд орох** поддаваться чьему-либо влиянию, подпасть под влияние, **~нд оруулах** подчинять своему влиянию, **бусдын ~гөөр** под влиянием других, **сайн/муу ~** хорошее/плохое влияние, **~ саа** *мед.* паралич, **~тэй толь** кривое зеркало

НӨЛӨӨЛӨЛ оказание воздействия/влияния, влияние, воздействие

НӨЛӨӨЛӨХ влиять, воздействовать, оказывать влияние, **муугаар ~** оказать дурное/плохое влияние

НӨЛӨӨТЭЙ 1) влиятельный, 2) кривой, **~ хүн** влиятельный человек; авторитетный персонал, **~ толь** кривое зеркало

НӨМӨР 1) прикрытие, укрытие, 2) защита, протекция, **~ газар** укрытое от ветра и холода место, **бусдын ~т байх/явах** оказываться под чьей-нибудь защитой, быть под протекцией кого-либо

НӨМӨРДӨХ прикрываться, укрываться, находиться в укрытии

НӨМӨРЛӨХ 1) прикрывать, укрывать, 2) спрятаться, найти себе защиту

НӨМРӨГ покров, накидка, попона, **~ бүргэд** орлан долгохвост, **~т аврага загас** плащеносная акула

НӨМРӨХ накидывать на себя, накрываться, покрываться, **дээл ~** накинуть на себя халат/дэли, **хөнжил ~** накрываться одеялом

НӨӨХ запасаться, экономить, сберегать, копить, хранить, **хүчээ ~** экономить свои силы, **~ зээл** компенсационный заем

НӨӨЦ запасы, резерв, **алтны баялаг ~** богатые запасы золота, **үгийн ~** запас слов, **ажиллах хүчний ~** людские ресурсы, **усны ~** водные ресурсы, **тэжээлийн ~** кормовые ресурсы, запасы кормов, **баталгаат ~** запасы доказанные, **балансын бус ~** забалансовые запасы, **үнэмшилт ~** вероятные запасы, **хуримтлагдсан ~** накопившиеся (накопленные) запасы, **хөндөшгүй ~** неприкосновенный запас, **~өө барах/шавхах** истощить запас, **татвар ногдуулалтаид зорилсан ~** резерв для налогообложения, **~ийн эргэх чадвар** оборачиваемость запасов, **~ийн сан** резервный фонд, **барааны ~ийн худалдааны нийлбэр дэхь харьцаа** отношение товарных запасов к сумме продаж

НӨӨЦЛӨЛ заготовка, накопление, сбережения

НӨӨЦЛӨХ запасаться, делать запасы, держать в запасе, накапливать, **~н бэлтгэх** заготавливать про запас, **өвөлд ~** запасать на зиму, заготовка зимних нужд, **түлш ~** запасаться дровами, топливом

НӨӨЦТЭЙ с запасами, запасной, имеющий запасы/резервы, **манай орон ашигт малтмалын их ~** наша страна имеет большие запасы полезных ископаемых

НӨР большой, огромный, **~ их хөдөлмөр** огромный труд

НӨХВӨР *юр.* компенсация

НӨХӨД товарищи, друзья, **найз ~** друзья, **эрхэм ~ өө!** дорогие товарищи! **зэвсэгт нэгт ~** товарищи по оружию, **над олон ~ бий** у меня много друзей

НӨХӨДТЭЙ 1) имеющий много друзей, 2) дружелюбный

НӨХӨЖ: **~ баршгүй гарз** невосполнимая утрата

НӨХӨӨС 1) латка, заплата, заплатка, 2) *перен.* затычка, замена кого-чего-нибудь недостающего, **~ тавих** за платать, наложить заплатку, **~нд явах** замещать кого-нибудь недостающего, слу-

жить/работать затычкой, быть затычкой, быть козлом отпущения

НӨХӨӨСТЭЙ латанный, ~ **пальто** латанное пальто, пальто в заплатках

НӨХӨР 1) товарищ, друг, 2) муж, **дотно сайн** ~ близкий хороший друг, **иттэлт** ~ верный друг, **эр** ~ муж, **~т очих/гарах** выйти замуж, ~ **ёсны тусламж** дружеская помощь/услуга, **Арван хуруу тэгш ~ гэж авгайгаа арван хуруу тэгш гэж боддог эрийг хэлнэ. Оскар Уайлд.** Идеальный муж — это мужчина, считающий, что у него идеальная жена. Оскар Уайлд.

НӨХӨРЛӨЛ 1) товарищество, *дружба, содружество,* 2) кооперация, 3) кооперативный, **орон сууц хоршооллын** ~ жилищно-кооперативное товарищество, **~ийн дэлгүүр** кооперативный магазин

НӨХӨРЛӨХ дружить, стать друзьями, быть товарищами, находиться в дружеских, приятельских отношениях, **бид хоёр хар багаасаа ~сөн я** с ним дружу с малых/детских лет, **хүний ясыг/чанарыг ~ж мэддэг** качество человека узнаётся в дружбе

НӨХӨРСӨГ дружественный, дружеский, товарищеский, ~ **уулзалт** дружеская встреча, ~ **харьцаа** товарищеские/дружеские отношения, **албан ёсны ~ айлчлал** дружеский официальный визит

НӨХӨРТЭЙ 1) замужняя, 2) дружелюбный, ~ **эмэгтэй** замужняя женщина

НӨХӨХ 1) латать, заплатать, наложить заплатку, 2) компенсировать, навёрстывать, возмещать, **өмд** ~ заплатать штаны, **цоорхой** ~ ставить/делать заплатку на дырявое место, **алдагдлыг** ~ возмещать убыток, компенсировать ущерб/потерю, **~н олгох** компенсировать, **~н сонгууль** дополнительные выборы, **~н төлбөр** денежное возмещение, **~н олгох хувь хэмжээ** кумулятивные паи, **ашиг ~н олгох давуу эрхтэй хувьцаа** кумулятивная привилегированная акция

НӨХЦӨЛ 1. условие, *обстоятельство,* возможность, среда, ~ **байдал** обстоятельство, ситуация, **амьдралын** ~ условия жизни, бытовые условия, **орон сууцны** ~ жилищные условия, **ажлын /хөдөлмөрийн** ~ условия труда, **цаг агаарын** ~ климатические условия, **байгалийн** ~ природные условия, **ямар ч** ~д при любых обстоятельствах, **байршлын** ~ условия залегания (полезных ископаемых), **ямар ч** ~ **алга** нет никакой возможности, ~ **хангах** обеспечивать условия

НӨХЦӨЛ 2. *грам.* суффикс, **нэрийн** ~ именные суффиксы, ~ **үйл үг** деепричастие

НӨХЦӨЛГҮЙ невозможный, невозможно, **хийх** ~ невозможно сделать/выполнить, **ямар ч** ~ никак нельзя, нет никакой возможности, ~ **халуун** нестерпимая жара

НӨХЦӨЛДӨӨН: **харилцан** ~ взаимообусловленность, взаимосвязь

НӨХЦӨЛДӨХ взаимообуславливаться, взаимосвязываться

НӨХЦӨӨХ проводить, **цаг** ~ а) зря проводить время, б) времяпрепровождение

НӨХЦӨХ 1. подружиться, быть в интимных отношениях, приставать

НӨХЦӨХ 2. миновать, проходить, **нас** ~ умереть, скончаться

НУГА 1. луга, **~ын хадлан** луговой покос, **~ын бор эрвээхэй** мотылёк луговой

НУГА 2. *усил. частица:* ~ **дарах** перегнуть

НУГАЛАА сгиб, складка, загиб, **хувцасанд** ~ **гаргах** делать складки на платье

НУГАЛАХ 1) сгибать, перегибать, складывать, 2) *перен.* увеличивать в несколько раз, **өвдгөө** ~ сгибать колени, **хоёр** ~ складывать вдвое, увеличивать вдвое, **тохойгоо** ~ согнуть локоть

НУГАН *книжн.* сын, мальчик

НУГАРАХ сгибаться, перегибаться

НУГАС 1. утка, утиный, **нударга** ~ утка чирок, **~н хушуут** утконос, **~ны өндөг** утиное яйцо, **~гүй байх** быть *без ума от* чего-либо

НУГАС 2. *анат.* спинной мозг

НУГАС 3. петля, шарнир, **хаалганы** ~ дверные петли

НУГАСГҮЙ без ума от чего-либо

НУГАСЛАХ 1. убивать животное (вонзая нож в затылочную часть головы и прокалывая спинной мозг)

НУГАСЛАХ 2. приделывать, устанавливать петли

НУГДАЙХ быть короткошеим

НУГДАГАНАХ двигаться (о короткошеем)

НУГДГАР короткий, короткошеий

НУД: ~ **хийх** хрустеть, издавать хруст, **хуруугаа ~ хийлгэх** хрустеть пальцами

НУДАРГА 1) кулак, 2) умение, навык, опыт, 3) обшлаг, ~ **зангидах** сжимать кулак, ~ **далайх** замахнуться кулаком, **~аар сүрдүүлэх** грозить кулаком, ~ **суух** приобретать умение/навык, **~тай дээл** дэли/шуба с обшлагами

НУДАРГАДАХ бить кулаком, ударять кулаком, демонстрировать свою силу

НУДАРГАЛАХ преодолевать что-либо силой/умением

НУДАРГАН 1) кулак, 2) кулачный, ~ **баян** кулак, кулачество, ~ **зодоо** кулачный бой, бокс

НУДРАЛТ удар, толчок, тыканье

НУДРАХ тыкать, толкать, ударять, **тохойгоор** ~ толкать локтём, **хуруугаараа** ~ тыкать пальцем, **хажуу бөөр уруу** ~ тыкать в бок, **нуруу руу** ~ толкать/тыкать в спину

НУЖИГНАХ хрустеть, издавать хруст

НУЛИМАХ плевать, плюнуть, **цэр** ~ сплюнуть мокроту, отхаркнуть

НУЛИМАС слеза, ~ **гоожуулах/асгаруулах** проливать слёзы, разразиться слезами, ~ **гүйлгэнэх/цийлэгнэх** слезиться, наполняться слезами, ~ **асгаруулагч хий** слезоточивый газ

НУМ 1) лук, 2) дуга, 3) рессора, ~ **сум харвах** стрелять из лука, **~ны хөвч** тетива лука, ~ **хэлбэрт** дугообразный, **тэрэгний** ~ рессора экипажа, **гадаад** ~ внешняя дуга, **дотоод** ~ внутренняя дуга, **цахилгаан** ~ электрическая дуга, **~н хэсэг** сегмент, сегментация, **~ын орд** созвездие Стрельца

НУМДАХ бить шерсть при помощи специального лука

НУНТАГ порошок, ~ **оо** зубной порошок, **угаалгын** ~ стиральный порошок, моющие порошки, ~ **эм уух** принимать порошки

НУНТАГЛАХ смолоть в порошок, толочь, измельчать, дробить, **эм** ~ приготовить лекарство в порошках

НУНТАГШИХ становиться порошкообразным; иметь вид порошка

НУРААХ обваливать, *обрушивать, разрушать,* разваливать, **байшин** ~ разрушить дом

НУРАЛТ обвал, оползень, обрушение, крушение, разрушение

НУРАХ 1) разрушаться, обрушиваться, обваливаться, оползать, 2) проваливаться (напр. о плане), **бидний төлөвлөгөө ~лаа** наш план провалился

НУРУУ 1. спина, спинной хребет, позвоночник, **~гаа үүрэх** заложить руки за спину, быть важным, гордым, **өндөр ~тай** высокого роста, **~ны гол судас** аорта спинная

НУРУУ 2. 1) хребет, 2) общее состояние, **уул ~д** горные хребты, **гол ~, дүн** ~ общее состояние, **ноён** ~ стержень, состояние *какого-либо дела*

НУРУУ 3. скирда, **~тай өвс** скирды сена

НУРУУГҮЙ 1) беспозвоночный, 2) со стёртой спиной, 3) непоследовательный, изменчивый, неверный, **сээр** ~ **амьтад** беспозвоночные животные, ~ **морь** лошадь со стёртой спиной,

тэр ч ~ хүн шүү он же ведь человек изменчивый/ненадёжный, без стержня

НУРУУЛАХ завершать какое-либо дело

НУРУУЛДАХ скирдовать, складывать в скирды, собирать в одну кучу, **өвс ~** складывать сено в скирды, **~сан өвс** скирдованное сено

НУРМАГ лагуна

НУРМАЙХ клонить в сон, быть сонливым

НУРШАА надоедающий своими словами, докучливый многословием, излишне многоречивый/многословный, **~ яриа/үг** докучливый, нудный разговор, **~ хүн** назойливо многословный человек

НУРШИМТГАЙ надоедающий однообразной речью

НУРШИХ надоедать своей однообразной речью, докучать излишним многословием, «толочь воду в ступе»

НУРШУУ надоедливый

НУС сопли, **~ нийх** сморкать нос, высморкаться, **~аа татах** шмыгать носом, **~аа гоожуулах** распустить сопли, **~ны алчуур** носовой платок, **хүүхдийн ~ыг арчих** утереть ребёнку сопли, **~аа хацартаа наах, ~аа хацартаа нааж явах** попасть в переделку, быть затраханым, быть, как выжатый лимон

НУСГАЙ 1) сопливый, сопляк, 2) насморк, **~ жаал** а) сопляк, сопливый ребёнок, б) *пренеб.* молокосос, сопляк, **~ хүрэх** схватить насморк

НУТАГ родное место, родина, родное кочевье, родной край, местность, **~ дэвсгэр, газар ~** территория, **төрсөн ~** родина, **хөдөө ~** сельская местность, **орон ~** регион, зона, область, **орон ~ийн цаг** местное время, **~ бэлчээр** пастбище, **сайхан ~** живописная местность, **~ийн хүн** местный уроженец, **~ийн аялгуу** местный диалект/говор, **~ дэвсгэрийн бүрэн бүтэн байдал** территориальная целостность, **~ дэвсгэрийн халдашгүй дархан байдал** территориальная неприкосновенность, **~ дэвсгэрийн нэгж** территориальная единица, **~ заах** ссылать, отправлять в ссылку, на поселение, **~ийн орос** местный русский, постоянно проживающие в Монголии русские, **~ийн нүдгийг олох** найти хорошее место для кемпинга (стоянки)

НУТАГЛАХ обитать где-нибудь, жить в какой-либо местности, поселяться, населять что-нибудь, водиться где-нибудь, **Монгол орны баруун хязгаарт хасагууд ~даг** казахи живут на западной окраине Монголии

НУТАГЛУУЛАХ *побуд. от* **нутаглах**, 1) разрешать жить в какой-либо местности, поселять, 2) *перен.* хоронить, предать земле

НУТАГТАН: *зоол.* **хоёр ~** земноводное животное, амфибия

НУТАГШИЛ акклиматизация, приспособление к новому климату, привыкание к новому местожительству

НУТАГШИХ акклиматизироваться, приспособляться к новой местности, привыкать к новому местожительству, осваиваться, привыкать жить в одной местности, **говьд ~** приспособляться к гобийским условиям/гобийскому климату, **энд манай мал сайхан ~ж байна** наш скот хорошо акклиматизируется здесь, **бид өндөр уулаад бүр ~чихжээ** мы совсем привыкли жить на высокогорье

НУТАГШУУЛАХ *побуд. от* **нутагших**, 1) акклиматизировать, приучать к новым условиям, 2) поселять, расселять населять, **шинэ газарт тахь ~** акклиматизировать лошадей Пржевальского к новому местожительству

НУУВЧ 1) окоп, 2) тайник, **~нд суух** сидеть в окопах, **~наас буудах** стрелять из окопов, **~нд хийх** положить в тайник

НУУГДАХ прятаться, скрываться, таиться, **~ж тоглох** играть в прятки, **хэрэгтэн хаа нэгтэй ~ж байна** преступник скрывается где-то, **чи надаас ~ хэрэгтүй** тебе не надо прятаться (скрываться) от меня

НУУГДМАЛ скрытый, таинственный, латентный, **~ гэмт хэрэг** латентное преступление, **үгийн ~ утга** скрытый смысл слов

НУУДГАЙ секретный, тайный, **~ хүүхэд** внебрачный, незаконнорождённый ребёнок, срамное место

НУУР озеро, **давст ~** соленое озеро, **гүн ~** глубокое озеро, **уулын ~** горное озеро, **цэнгэг ~** пресное озеро, **том хиймэл ~** пруд, искусственное озеро, **~ын эрэг** берег озера, **~ын ургамал** озерные растения, **~ судлаач** лимнолог

НУРАГ лавина, обвал осыпь, **вулканы ~** вулканическая лавина, **эргийн ~** осыпь береговая

НУУХ 1. прятать, скрывать, секретничать, таить, **бусдаас юм ~** скрывать что-либо от кого-либо, **нэрээ ~** скрывать свое имя, **гэмт хэрэгтнийг ~** скрывать преступника, **~н далдлах** укрывать, **~и дарах** умолчание, сокрытие фактов, **юу ч ~лгүй ярих** говорить ничего не скрывая, **~гаад яах вэ?** да чего тут скрывать? *погов.* **сумаа харваад нумаа ~** выпустив стрелу, спрятать свой лук, умыть руки

НУУХ 2. гной (на глазах), **нүд нуухтай байна, нүднээс ~ гарч байна** глаза гноятся, из глаз идет гной, **~ыг авах гээд нүдийг сохлох** *погов. букв.* хотят очистить гной на глазах, да глаз лишают, оказать медвежью услугу

НУУХ 3. коронка табакерки

НУУХТАХ гноиться (о глазах)

НУУЦ тайна, секрет, тайный, секретный, конспиративный, подпольный, засекреченный, **~ амраг** любовник, любовница, **улсын ~** государственная тайна, **цэргийн/албаны ~** военная/служебная тайна, **~ хадгалах** сохранять тайну, **~ыг мэдэх** узнать тайну, **~ байлгах** держать в тайне, **~ задлах, задраах** выдать тайну, разболтать секрет, рассекречивать, **~ цоож** секретный замок, **~ хуйвалдаан** тайный сговор, **~ байгууллага/ажил** подпольная организация/работа, **~ байр** конспиративная квартира, **~ яриа** секретный разговор, **~ санал/сонгууль** тайное голосование, **~ нэр** псевдоним, **~ болзоо/уулзалт** тайное свидание, тайная встреча, **~ мөрөөдөл/хүсэл** тайная мечта, тайное желание, **~ явуулга** интрига, **~ хуйвалдаан** тайный заговор, **маш ~** совершенно секретно, весьма секретно, **~аар уулзах** тайком встречаться, **~ түлхүүр** секретный код, кодирование

НУУЦГАЙ секретный, тайный, секретно, тайно, тайком, **~ газар** тайное /секретное место, тайник, **~ амраг** любовник, любовница, **~ уулзах** а) встречаться тайком, б) тайная встреча

НУУЦЛАГДАХ *страд. от* **нуулах**, засекречиваться, делаться тайным, быть секретным, **~сан баримтууд** засекреченные документы

НУУЦЛАХ засекречивать, делать тайным/секретным, **зааврыг ~** засекречивать инструкцию

НУХАМШ пюре, **төмсөн ~** картофельное пюре

НУХАМШЛАХ приготовлять пюре, делать пюре из чего-либо

НУХАХ 1) мять, разминать, размягчать, массировать, тереть, размешивать, протирать, 2) *перен. разг.* убивать, колоть, резать, доконать, **нүдээ ~** протирать глаза, **гурил ~** замешивать тесто, **гараар ~** мять рукой, **шавар ~** мять/размешивать глину, **арьс ~** мять разминать кожу, **хүүхэд нойрмоглон нүдээ ~ж байна** ребёнок трёт глаза спросонья, **хонь ~ж идэх** *разг.* резать барана, колоть барана

НУХАЦ серьёзность, вдумчивость, важность

НУХАЦГҮЙ несерьёзный, необдуманный, **~ явдал/хэрэг** несерьёзное дело, необдуманный поступок

НУХАЦТАЙ серьёзный, обдуманный, серьёзно, обдуманно, ~ **ажил** серьёзная работа, ~ **судалгаа** серьёзное исследование, ~ **судлах** изучать серьёзно

НУХАШ пюре, паштет, **элэгний** ~ паштет из печени, ливерный паштет

НУХАШЛАХ приготовлять паштет из чего-либо

НУХЛАГДАХ *страд. от* **нухлах**, 1) мяться, быть размятым, быть тёртым, 2) *перен.* перегружаться, **ажилд** ~ иметь много работы

НУХЛАХ мять/протирать время от времени, **арьс** ~ разминать кожу время от времени, **нүдээ** ~ то и дело протирать глаза

НУХМАЛ мятый, тёртый, растёртый

НУХУУР пест

НҮБ (Нэгдсэн Үндэстний Байгууллага) ООН (Организация Объединённых Наций)

НҮГЭЛ грех, прегрешение, ~ **хилэнц** *парн.* ~ **хийх/үйлдэх** совершить грех, **~ээ наминчлах** искупить свой грех, **ингэж ярих нь/яривал танд ~ болно** грешно вам так говорить, **хамаг ~ийг өөртөө хураах/үүрэх** принять на себя все грехи, оказаться во всех грехах, ~ **хураах** напрасно подозревать кого-либо; ~ **нь нүдээр гарах** выйти боком; **~ийн нүдийг гурилаар таглах** втирать очки, *«вешать лапшу на уши»*, **гэмшихэд хэзээ ч хожимдохгүй, гэтэл ~ үйлдэхэд хожимдож болно** раскаяться никогда не поздно, а согрешить можно и опоздать.

НҮГЭЛГҮЙ безгрешный, **би ямар ч ~** я не грешен ни в чём

НҮГЭЛТ исполненный греха, согрешивший, грешный, ~ **хорвоо** грешный мир, ~ **хүн** грешник, ~ **эм** грешница

НҮГЭЛТЭЙ 1) грешный, греховный, 2) *разг.* удивительно, поразительно, ~ **хэрэг** грешное дело, ~ **сайхан охин** удивительно красивая девушка, ~ **хурдан морь** поразительно быстроногий скакун

НҮГЭЛТЭН грешник

НҮД(эн) глаз, глаза, **хурц** ~ острый глаз, **~ний цэцгий** зрачок, хрусталик, **~ний цэцгий мэт хайрлах** беречь как зеницу ока, **~ний ухархай** глазница, **~ний бор бие** хрусталик, **~ний шил** очки, **~ний эмч** глазной врач, окулист, **хоёр ~ний дуран** бинокль, **~ний хараа** зрение, **~ээ харах/нээх** открывать глаза, **~ээ аних** закрывать глаза, **~ээ онийлгох** щурить глаза, **~ээ цавчих/ирмэх** мигать глазами, моргнуть глазом, **~ээ бүлтийлгэх/том болгох** таращить глаза, выпучивать глаза, ~ **сохрох** ослепнуть, ~ **гялбах** слепить, ~ **булаах** пленять, очаровывать, **~нд тусах** бросаться в глаза, ~ **тайлах** видеть много, познавать многое, обогащаться жизненным опытом, ~ **хужирлах** любоваться кем-, чем-либо, наслаждаться каким-либо зрелищем, ~ **хуурах** заниматься очковтирательством, втирать очки, ~ **үзүүрлэх** не любить, стеснять, **~нд дулаан** миловидный, симпатичный, **~нд дулаахан охин** приятная, миловидная девочка, **~нд хүйтэн** отвратительный, несимпатичный, холодный, **ширээний** ~ выдвижной ящик стола, ~ **аних** умереть, ~ **анчулах** отправить на тот свет, ~ **алдах** прельщаться, приходить в восторг от увиденного, ~ **алдам** необозримый, бескрайний, ~ **алдам тал** степь да степь кругом, **~ний булай болох** пользоваться дурной славой, ~ **ирмэх зуур** в мгновение ока, ~ **далдлах** создавать ложное впечатление, пускать пыль в глаза, ~ **сэргээх** обрадовать кого-либо радостной вестью, ~ **хорхойтох** тайно завидовать, смотреть с тайной завистью, ~ **хорсох** испытывать жгучую ненависть к кому-либо, **~ний хор гаргах** вздремнуть, отоспаться, ~ **унах** влюбиться, быть очарованным кем-либо, **~нээс далд болгох** убрать кого-либо, пустить в расход, **~нээс гарах** быстро худеть, **~ээ олох** быть ко времени, **шагнал ~ээ олсон** *приблизительно:* награда нашла героя, **~н бенц** мерседес бенз класса Е

НҮДГҮЙ 1) безглазый, слепой, незрячий, 2) ненаблюдательный, **нүүр** ~ очень сильно, очень много

НҮДЛҮҮЛЭХ *побуд. от* **нүдлэх**, давать запоминать, **үсэг** ~ давать запоминать буквы

НҮДЛЭГДЭХ *страд. от* **нүдлэх**, быть замеченным, быть увиденным

НҮДЛЭХ 1) запоминать, замечать, сохранять в зрительной памяти, 2) начинать появляться, цвести (о молодой траве), **мал** ~ запоминать скот, **үсэг** ~ запоминать буквы, **агъ ~ж байна** полынь начинает появляться, **усан** ~ быть плаксивым, плакать, **нүд улаан, мөнгө цагаан** глаза завидующие, руки загребущие, деньги не пахнут

НҮДТЭЙ 1) имеющий глаза/зрение, зрячий, 2) наблюдательный, обладающий хорошей зрительной памятью, **хар** ~ черноглазый, с чёрными глазами, **бүлтгэр** ~ пучеглазый, лупоглазый, **сөлөр** ~ кривоглазый, **өрөөсөн** ~ одноглазый, **малд ~ охин** хорошо запоминающая масть скота девочка, способная к уходу за скотом девочка

НҮДҮҮЛЭХ *побуд. от* **нүдэх**, 1) быть толчённым, 2) быть избитым, побитым

НҮДҮҮР чугунный пестик, колотушка (для толчения чего-либо, напр. кирпичного чая)

НҮДЭХ 1) толочь, 2) избивать, колотить, **хаалга** ~ колотить в дверь, **цай** ~ толочь чай кирпичный, **зодож** ~ избивать, бить

НҮНЖИГ 1) жирность, содержание обильного жира, 2) *перен.* хорошее качество, качественность, добротность, 3) щедрость

НҮНЖИГГҮЙ 1) нежирный, постный, 2) некачественный, плохого качества, 3) скупой, эгоистичный, ~ **хоол** постная, не жирная пища, ~ **эд** плохая вещь, ~ **амьтан** скупой, эгоистичный человек

НҮНЖИГТЭЙ 1) жирный, 2) хороший, качественный, добротный, 3) щедрый, добрый, отзывчивый

НҮР черника

НҮРГЭЛЭХ то и дело грохотать, часто издавать громкий шум, **тэнгэр ~ сонсдоно** *слышен грохот в небе*

НҮРГЭХ греметь, грохотать, громыхать

НҮРГЭЭН 1) грохот, рёв, 2) громкий шум, сенсация

НҮРГЭЭНТЭЙ громкий, шумный, оживлённый, сенсационный, громко, шумно, сенсационно, ~ **их ажил** оживлённая, шумная работа, ~ **хэрэг явдал** громкое дело, громкий процесс, сенсационный поступок, ~ **хэлэлцэх** шумно обсуждать

НҮСЭР громоздкий, тяжёлый, грузный, грандиозный, гигантский, ~ **хүнд ажил** очень тяжёлая работа, **захиргааны ~ аппарат** громоздкий административный аппарат, **гэрийн ~ тавилга** громоздкая домашняя мебель, ~ **биетэй** с грузной фигурой, ~ **алхлах** тяжело ступать/шагать

НҮСЭРДЭХ оказываться слишком громоздким, быть грандиозным, делаться чрезвычайно тяжёлым, быть очень грузным

НҮҮДЭЛ 1) кочёвка, перекочёвка, кочевание, 2) ход, **~ийн** кочевой, передвижной, **~ийн аж байдал** кочевой образ жизни, **~ийн мал аж ахуй** кочевое скотоводство, **~ийн ба хагас нүүдлийн аж ахуй** кочевое и полукочевое хозяйство, **~ийн шувуу** перелётная птица, **~ийн худалдаа** передвижная торговля, ~ **хийх** а) перекочевать, переехать с одного места на другое, б) делать ход (о шахматах), **морины** ~ ход конём

НҮҮДЭЛЛЭХ кочевать, перекочёвывать

НҮҮДЭЛЧИН кочевник, кочевой, кочующий, **~дийн соёл иргэншил** *цивилизация кочевников, кочевая цивилизация*

НҮҮЛГЭХ 1) *побуд. от* **нүүх**, переселять, эвакуировать, 2) кидать, бросать, **шинэ сууцанд ~н оруулах** переселять на новую квартиру, **чулуу** ~ бросать камнями, **албадан** ~ выселение (принудительное)

ОНОВЧ конкретность, определённость, чёткость, рациональность, корректность, **~ муутай** не совсем удачный, не очень подходящий

ОНОВЧГҮЙ неудачный, неподходящий, несоответствующий чему-либо, **~ ажил** бесполезная работа

ОНОВЧТОЙ конкретный, определённый, точный, правильный, удачный, **~ арга хэмжээ** конкретные меры, **~ хариулт өгөх** дать точный ответ, **~ санал** конкретное предложение, **~ (санал) санаачлага** рационализаторское предложение, **~ орчуулга** удачный перевод, **~ хэллэг** удачное выражение, **~ сонголт** удачный выбор, **~ ашиглах** наиболее рационально использовать

ОНОГДОЛ чья-либо доля при разделе, причитающееся

ОНОГДОХ *страд. от* **онох,** причитаться, попадаться, доставаться

ОНОГДУУЛАХ *побуд. от* **онох,** распределять, облагать, возлагать

ОНДОО другой, иной, отличный, разобложить налогом, **торгууль ~** облагать штрафом, **хариуцлага ~** возлагать ответственность, **~ хэмжээ** сумма обложения, **ял ~** присудить наказание, приговорить к какому-нибудь наказанию

ОНОЛ теория, теоритический, **~ дадлага хоёр** теория и практика, **~ын физик** теоретическая физика, **танин мэдэхүйн ~** теория познания, **харьцангуйн ~** теория относительности, **магадлалын ~** теория вероятности, **мэдээллийн ~** теория информации, **~ын мэдлэг** теоретическое знание, **~ын үндэс** теоретическая основа, **~ын бага хурал** теоретическая конференция, **~ын дүгнэлт** теоретический вывод

ОНОЛДОХ 1. теоретизировать, умничать

ОНОЛДОХ 2. встречаться, сходиться

ОНОЛЧ теоретик, **хэл шинжлэлийн ~** теоретик лингвистики

ОНОО 1. очко, балл, **олон ~ авах** набрать много очков, **~гоор ялах** победить по очкам, **~ны давуу** преимущество по очкам/в очках

ОНОО 2. партнёр в борьбе, распределение партнёров в соревнованиях по жребию/по жеребьёвке

ОНОО 3. попадание в цель (при стрельбе)

ОНОО 4. разрез, прорезь, **хүрэмний ~** разрез куртки, **~ гаргах** делать разрез

ОНОО 5.: **~т аяг** лейтмотив, **~т зохирол** лейтгармония

ОНООЛОХ распределять партнёров в борьбе

ОНООХ *побуд. от* **онох,** распределять, развёрстывать

ОНОХ 1) попадать в цель, 2) *перен.* предвидеть, угадывать, **бай ~** попадать в мишень

ОНОШ диагноз, **~ зүй** диагностика, **~ тогтоох/тавих** ставить диагноз, **өвчний ~** диагноз болезни, **зөв ~** правильный диагноз

ОНОШЛОЛ диагностирование, диагностический, **~лзүй** диагностика, **~ын арга** диагностический метод

ОНОШЛОХ диагностировать, определять диагнозом, **өвчнийг зөв ~** правильно диагностировать болезнь

ОНХГОР 1) высокий, возвышающийся среди других, 2) глубокий, **~ хад** высокая скала, **~ аяга** глубокая чашка

ОНХОЛДОХ перевёртываться, опрокидываться, **машин ~жээ** машина перевернулась

ОНХОЛДУУЛАХ *побуд. от* **онхолдох,** перевёртывать, опрокидывать

ОНЦ особый, особенный, отличный, лучший, чрезвычайный, исключительный, особо, особенно, отлично, исключительно, **~ арга хэмжээ** чрезвычайные меры, **сургуулиа ~ төгсөх** окончить школу на отлично/с отличием, **~ сонин/~ гойд юмгүй** ничего особенного, **~ эрх** полномочие, монополия, чрезвычайные права, **~ бөгөөд бүрэн эрхт элчин сайд** чрезвычайный и полномочный посол, **~ ялгаа алга, ~ын ялгаагүй юм байна** нет ничего специфичного/особого, **~ хүнд гэмт хэрэг** особо тяжкое преступление

ОНЦГОЙ особенный, специфический, особый, исключительный, чрезвычайный, обособлённый, уединённый, особенно, особо, исключительно, **~ байдал** особое положение, **~ нөхцөл байдал** чрезвычайные обстоятельства, **~ ял** исключительная мера наказания, **~ эрх** исключительное право, **~ анхаарал тавих** уделять особое внимание, **бусдаас ~ хүн** своеобразный, оригинальный человек, **~ гавьяа** выдающие заслуги

ОНЦГОЙДОХ оказываться весьма своеобразным, быть более специфическим, становиться слишком чрезвычайным

ОНЦГОЙДУУ несколько своеобразный/специфический, довольно важный

ОНЦГОЙЛОХ выделять, обособлять, подчёркивать, особо рассматривать, **~н анхаарах** уделять особое внимание

ОНЦГОЙРОХ выделяться, обособляться, подчёркиваться, уединяться, бусдаас онцгойрох обособиться от других, отличаться среди других

ОНЦЛОГ особенность, специфика, соеобразие, **үндэсний ~** национальная особенность, **орон нуттийн ~** местные особенности, **өвөрмөц ~** специфическое своеобразие, специфическая особенность, **~ болох, ~ зүйл мөн болох** являться особенностью/спецификой

ОНЦЛОХ выделять, обособлять, подчёркивать, считать важным/особым, **~н тэмдэглэх хэрэгтэй** надо особо отметить, **~ж үзэх** особо выделить, ставить в особое положение, особо подчёркнуть

ОНЧ 1. главное, суть сущность, смысл, ядро, зерно, конкретность, **~ийг нь олох** а) вникнуть в сущность чего-либо, постигнуть смысл чего-либо, б) найти подход к чему-либо

ОНЧ 2. инерция

ОНЬ 1) выемка, вырез, проём, 2) седловина, 3) *геол.* седло, **уулын ~ иор давах** переехать через седловину горы, **юманд ~ гаргах** сделать выемку над чем-либо

ОНЬС 1. 1) задвижка, засов, затвор, запор, 2) внутренний механизм, **хаалганы ~** дверная задвижка, **модон ~** деревянный засов, **~н техник** техника с внутренними механизмами, сложная техника, **хаалга ~оор түгжих** задвинуть дверь засовов

ОНЬС 2. суть, сущность

ОНЬСОГО загадка, **~ хэлэх/таалгах** загадывать загадку, **~ таах/тайлах** отгадывать загадку

ОНЬСЛОХ запирать на задвижку, засов, защёлкивать, замыкать

ОНЬСТОЙ 1) имеющий засов/запор, 2) заводной, **~ тоглоом** заводная игрушка

ОО порошок, пудра, паста, **шүдний нунтаг ~** зубной порошок, **шүдний нойтон ~** зубная паста

ООДГОР короткий

ООДОЙХ быть коротким (об одежде, хвосте), **~сон дээл** короткая шуба, короткополое дэли

ООДОН короткий, куцый, ~ **сүүл** куцый хвост, ~ дээл короткополая шуба, *полушубок*

ООДОНДОХ быть слишком коротким, оказываться очень коротким/куцым

ООДРОХ 1) зазнаваться, загордиться, 2) восторгаться, прыгать от радости (о детях), **чи их ~ч байна** ты *сильно зазнаёшься*

ООДРУУЛАХ *побуд. от* **оодрох**, подталкивать к зазнайству, давать загордиться

ООНО самец антилопы/дзерена, **салаа эвэртэй ~ыг шархтуулалгүй намнана** *фольк.* самца *антилопы с ветвистыми* рогами отстрелим, не причинив ран, **~ын эвэр** рога самца антилопы

ООРЦОГ одинокий, отделённый от других, отдельный, раздельный, единичный, ~ **цохио/хад** одинокая скала, *отдельная скала*

ООСОР шнур, верёвка, тесьма, жгут, перевязка, **цагны ~** цепочка для часов, **гэрийн ~** перевязь для покрытия юрты, **өрхний ~** перевязь для покрывала дымника/дымового отверстия, ~ **бүчгүй орд цагаан өргөө** *фольк.* белая юрта-дворец без верёвки-крепления, **түлхүүрийн ~** брелок для ключей, связка ключей, ~ **бүчгүй зэрэглээ** мираж, иллюзия

ООСОРЛОГДОХ *страд. от* **оосорлох**, быть перевязанным, быть привязанным (за шею)

ООСОРЛОХ подвязывать, привязывать верёвкой, перевязывать/завязывать шнурком/шпагатом

ООЧИР очередь, ~ **авах** занимать очередь, ~ **баримтлах** соблюдать очередь, **урт ~** длинная очередь

ООЧИРЛОХ стать в очереди, занимать очередь, **зураач Төгс-Оюуны үзэсгэлэнгийн тасалбарт ~** стоять в очереди за билетами на выставку художницыТугс-Оюун

ООЧИХ вбирать в рот, делать глоток, **халуун цай ~** пить горячий чай

ООЧЛОХ пить мелкими глотками, пить быстрыми глотками

ОПЕРАТОР оператор, **дууны ~** звукооператор

ОПЕРАЦ операция, **хэвлийн хөндийн ~** операция в брюшной полости

ОППОЗИЦ оппозиция, оппозиционный

ОР 1. кровать, койка, постель, ~ **дэр/дэвсгэр** постель, **~ны хэрэглэл** постельные принадлежности, **~ны даавуу** простыня, **~ны бүтээлэг** покрывало для постели, **хүүхдийн ~** детская кровать, **дүүжин ~** гамак, **хоёр хүний ~** двуспальная кровать, **эвхдэг ~** складная кровать, раскладушка, **аяны ~** походная кровать, **зуун ~той эмнэлэг** больница на сто коек, ~ **засах** стлать/стелить постель, ~ **хураах** убирать постель, **~ндоо орох** слечь в постель, **~ноос босох** встать с постели, **~н дээр хэвтэх** лежать на кровати, **Бүсгүй хүний хамгийн нарийхан ~н дээр ч гэсэн хоёр хүн хэзээд багтана** даже на самой узкой девичьей кровати всегда поместятся два человека (И.Тургенев)

ОР 2. след, отпечаток, ~ **мөр** следы, **хурууны ~** отпечаток пальца, ~ **сураггүй болох** исчезать бесследно, пропадать без вести, ~ **нэр** одно название, одна видимость, формальность, ~ **нэр болгох** относить к чему-либо совершенно формально

ОР 3. *частица усиления* совсем, совершенно, ~ **тас мартах** совсем забыть, ~ **тас очихгүй байх** совсем/вообще не приходить, ~ **мэдэхгүй** совершенно не знать, ~ **ганцаар хоцрох** остаться совсем один, ~ **ганц** единственный, одинокий

ОР 4. вакансия, место, замена, замещение, заменитель, **~н тоо** штаты, **~н тоо хорогдуулах** сокращение штатов, **миний ~ны хүн** моя замена, **Чингис хааны ~ залган суусан Өгөөдэй хаан** хан Угэдэй, *сменивший* на престоле Чингисхана

ОР 5.: ~ **буга** олени северные

ОРВОН корневище, корень, **модны ~** корневище дерева, **үсний ~** корень волос, **мод ~гоор нь унагах** свалить дерево, выворачивая его с корнем

ОРГАНИЗМ организм, **амьд ~** живые организмы, **~ын хөгжил** развитие организма

ОРГАНИК органика, органический, ~ **бодис** органические вещества

ОРГИЛ вершина, пик, зенит, апогей, кульминация, **уулын ~** вершина горы, **уран бүтээлийн ~** вершина творчества, **эрдмийн ~** вершина знания/науки, **түүний авьяас билэг ~доо хүрэв** его талант достиг апогея, **алдрын ~д хүрэх** в зените славы, ~ **цаг** час пик

ОРГИЛОЛТ извержение, **галт уулын ~** извержение вулкана, **усан дорхи ~** подводное извержение

ОРГИЛОХ *многократ. от* **оргих**, 1) бить ключом, фонтанировать, 2) клубиться, 3) извергаться, **газар дороос ус ~н гарав** вода била фонтаном из-под земли, **галт уул ~в** вулкан извергался

ОРГИЛУУН горячий, возбуждающийся, страстный, темпераментный, ~ **хүсэл** страстное желание, ~ **дарс** шампанское

ОРГИЛУУР фонтан, *геол.* грифон, **цэцэрлэгийн усан ~** фонтан в саду, **нефтийн ~** нефтяной фонтан, ~ **ус** фонтанная вода

ОРГИХ 1) фонтанировать, *бить фонтаном/ключом*, клубиться, 2) кипеть, клокотать, 3) извергать, извергаться, выбрасывать из себя, 4) чувствовать что-нибудь, **булгийн ус ~ж байна** вода источника бьёт ключом, **газраас нефть ~ж гарав** нефть фонтанирует из-под земли, **гал дээр цай ~ж байна** чай *кипит на огне*, **утаа ~ж байна** дым клубится/идёт клубами, **гэнэт хүйт ~** вдруг повеяло холодом, **халуу ~** обдавать жаром, **сэрүү ~** веять прохладой, обдавать прохладой, **эвгүй ~** почувствовать неприятность/неудобство

ОРГОДОЛ беглец, беглый, дезертир

ОРГОХ сбежать, убежать, удрать, дезертировать, **~н зүгтах/зайлах** убежать, избавиться, **шоронгоос ~** бежать из тюрьмы, **цэргээс ~** дезертировать из армии

ОРГУУЛАХ *побуд. от* **оргох**, давать убежать, позволять удрать, заставлять сбежать, допускать дезертирство, организовать бегство, **шоронгоос ~** организовать бегство из тюрьмы

ОРГҮЙ 1) необоснованный, беспочвенный, ложный, 2) необоснованно, беспочвенно, 3) бесследно, без вести, ~ **гүтгэлэг** необоснованная клевета, ~ **цуурхал** ложная молва, *необоснованный/нелепый слух*, ~ **юм ярих** говорить неправду/нелепости, врать, лгать, ~ **алга болох** бесследно исчезать, ~ **хоцрох** остаться ни с чем, остаться с пустыми руками, **~д орвол охинтой нь дээр** лучше поздно, чем никогда

ОРД 1. созвездие, **Долоон бурханы ~** Созвездие Большая Медведица, **Гурван Маралын ~** созвездие доход, **мөнгөн ~** денежный доход, **бодит ~** реальный доход, ~ **зарлага** приход и расход, **ашиг ~ын татвар** подоходный налог, **хөдөлмөрийн бус ~** нетрудовой доход, ~ **зарлагын төсөв** бюджет, ~ **олох** получить прибыль, ~ **орох** давать доход, приносить прибыль, **~ын эх сурвалж** источники дохода

ОРД 2. месторождение, **ашигт малтмалын ~** месторождение полезных ископаемых, **алтны ~** месторождение золота, **шилтгээлэг ~** месторождение вкраплённое, **өгөршлийн ~** месторождение выветривания, **судлын ~** жильное месторождение, **шавхагдсан ~** месторождение истощённое, **сарнимал ~** рассеянное месторождение, **шижирмэг ~** россыпное месторождение

ОРД 3.: **хулганын ~** мышиная нора с зимними припасами

ОРД 4. дворец, **соёлын ~н** дворец культуры

ОРДОН дворец, дом, дворцовый, **засгийн газрын ~** дом правительства, **соёлын ~** дворец культуры, дом культуры, **Саарал ~**

разг. Серый Дом, здание Монгольского Правительства, **Цагаан ~**Белый Дом

ОРДЕР ордер, **байрны ~** ордер на квартиру

ОРИЛОО крикливый, сварливый, плаксивый, **~ хүүхэд** плаксивый ребёнок, плакса, **~ эхнэр** сварливая жена/супруга, **~ зан** крикливый характер, **~ тэмээ** крикливый верблюд

ОРИЛООН крики, плач, вопли, **~ чарлаан** *парн.* крики, рыдания

ОРИЛОХ кричать, орать, плакать, реветь, **биттий ~оод бай!** ~**оо боль!** не кричи! не ори! **байдгаараа ~** орать во всё горло, ~**ж чарлах** кричать, плакать, **уйлж ~** рыдать, плакать

ОРКЕСТР оркестр, **хөгжмийн ~** музыкальный оркестр, **үлээвэр хөгжмийн ~** духовой оркестр

ОРЛОГО доход, приход, прибыль, **цэвэр ~** чистый доход, **дундаж ~** средняя прибыль, **нийт ~** валовая прибыль, валовый доход, **жилийн ~** годовой доход, **жилийн дундаж ~** среднегодовой доход, **үндэсний ~** национальный

ОРЛОГОГҮЙ бездоходный, бесприбыльный, бесполезный, невыгодный, **~ ажил** бесприбыльная работа, бесполезная работа

ОРЛОГОТОЙ 1) доходный, прибыльный, выгодный, 2) доходно, прибыльно, **~ ажил** прибыльное занятие, доходная работа, **~ аж ахуй** прибыльное хозяйство

ОРЛОГЧ заместитель, **~ сайд** заместитель министра, **~ дарга** заместитель председателя

ОРЛОХ замещать, заменять, **даргыг ~** замещать начальника, **бусдыг ~** замещать других, **нөхрийг түр ~** временно замещать мужа, **эгч маань наддаа ээжийг ~дог билээ** сестра моя заменяет мне мать, ~**и тоглогч** дублёр, каскадёр

ОРЛУУЛГА замещение

ОРОГНОХ 1) проживать где-нибудь, ютиться, приютиться, сожительствовать, 2) тайно проживать где-либо, убежище, **зусланд ~** проживать/прятаться на даче, **~ эрх** право убежища

ОРОГНУУЛАХ *побуд. от* **орогнох**, приютить, дать приют

ОРОЙ 1. 1) вечер, вечером, 2) поздно, **өнөө/өчигдөр ~** сегодня/вчера вечером, ~**н курс** вечерние курсы, ~**н ээлж** вечерняя смена, ~**н хоол** ужин, **шөнө ~** поздно ночью, **бүр ~** поздно вечером, **~ болж байна** вечереет, **~ ирэх** приходить вечером, прийти поздно, **~ болтол** до вечера, допоздна

ОРОЙ 2. вершина, верх, зенит, **байшингийн ~** крыша дома, **уулын ~** вершина горы, **сүмийн ~** купол церкви, **нар чанх ~ дээр байна** солнце находится в зените, **~ руугаа ус хийх** *букв.* на свою макушку воду лить, т.е. делать что-либо во вред, ~**оо авах** жаловать, любить, почитать кого-либо

ОРОЙ 3. четверть отреза материи

ОРОЙВТОР поздновато, довольно поздно, попозже, попозднее, **~ босох** встать поздновато, **~ ирэх** приходить попозже

ОРОЙГУУР вечером, вечерней порой

ОРОЙД (оо) по вечерам, вечером, **Гэрлээ ~оо голдуу гэртээ байдаг** по вечерам Гэрлээ обычно бывает дома

ОРОЙЖИН (гоо) весь вечер, целый вечер, в течение всего вечера, **~ Агиймаатай зугаалах** весь вечер гулять с Агиймой

ОРОЙЛОХ 1) возглавлять, быть во главе, 2) делать кровлю, **байшинг төмрөөр ~** крыть дом железом

ОРОЙТОЛ (т) опоздание, запоздание

ОРОЙТОХ запаздывать, опаздывать, явиться позже, задерживаться, **одоо бид явахгүй бол ~но** если сейчас мы не пойдём, то будет поздно, ~**ж сэрэх** поздно просыпаться, ~**сон туслamж** запоздалая помощь

ОРОЙТУУЛАХ *побуд. от* **оройтох**, задерживать, затягивать, **дурдсан цагаас ~** не успеть к назначенному сроку, не закончить в назначенный срок

ОРОЙХОН *уменьш. от* **орой**, поздновато, попозже

ОРОЛДЛОГО старание, стремление, усилие, попытка, **идэвх ~** активность, старательность, **~ хийх** предпринимать попытку, **~ гаргах** прилагать старания/усилия

ОРОЛДЛОГОГҮЙ нестарательный, неусердный, неприлежный

ОРОЛДЛОГОТОЙ старательный, усердный, прилежный, **~ сурагч** старательный ученик

ОРОЛДОХ 1) стараться, стремиться, пытаться, пробовать, 2) заниматься, 3) трогать, приставать (к женщине), **цаг хожихыг ~** стараться выиграть время, **юм хийх гэж ~** пытаться сделать что-либо, **гараар ~** трогать руками, ~**оод үзэх** попробовать, **биттий оролд!** не торгай!

ОРОЛДОЦ старательность, прилежность, усердность, **алив юмand ~той хандах** отнестись к любому делу со старательностью

ОРОЛТ вхождение, вступление, введение, включение, вход

ОРОЛЦОГЧ участник, участница, соучастник, **тэмцээнд ~** участник соревнования/состязания, **аялалд ~** участник похода/экскурсии, **хэлэлцээрт ~сод** участники соглашения

ОРОЛЦОО 1) участие, вмешательство, 2) поддержка, помощь, **бусдын/хөндлөнгийн ~** постороннее вмешательство, **та нарын ~ хэрэгтэй байна** нужна ваша поддержка

ОРОЛЦООГҮЙ без участия, **хэний ч ~гээр хийж дуусгах** закончить что-либо без чьего-либо участия

ОРОЛЦООТОЙ с участием, при участии, при вмешательстве, **та нарын ~гоор гүйцэтгэх** выполнить с вашим участием/при вашем участии

ОРОЛЦОХ 1) участвовать, принимать участие, включаться, 2) вмешиваться, **биеэр ~** принимать личное участие, **хуралд ~** участвовать в собрании, **сонгуульд ~** участвовать в голосовании/в выборах, **тэгш эрхтэй ~** участвовать на равных правах, **бусдын хэрэгт ~** вмешиваться в чужие дела, **бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс ~** вмешиваться во внутренние дела других стран, **ярианд хажуугаас ~** включаться в разговор, **хүний хэрэгт биттий оролц!** не вмешивайся (не лезь) в чужие дела!

ОРОЛЦУУЛАХ *побуд. от* **оролцох**, приглашать участвовать, включать, привлекать к участию, вовлекать, заставлять вмешиваться, **бүгдийг ~ хэрэгтэй** всех надо пригласить участвовать, надо включать всех

ОРОМ след, отпечаток, *геол.* включения, **~ гаргах/үлдээх** оставить следы чего-либо, **хурууны ~** отпечаток пальцев, **шархны ~** следы шрама, рубец, **эрдэс үүсгэгч уусмалын ~** включения минералообразующих растворов

ОРОМДОХ 1. делать кое-как, выполнять что-либо совершенно формально, относиться к чему-нибудь совершенно формально/поверхностно

ОРОМДОХ 2. оставлять отпечаток, след, оттиск

ОРОМЖ приют, прибежище, хижина, домик, избушка, лачуга

ОРОН 1. страна, государство, край, **эх ~** родина, **улс ~** страна, **ардчилсан ~** демократическая страна, **~ нуттийн засаг захиргаа** местная администрация, **аж үйлдвэрхөдөө аж ахуйн ~** индустриально-аграрная страна, **~ нуттийн заншил** местные традиции, **~ нутаг** периферия, местность, **~ нуттийн татвар** местные налоги, **~ тооны бус албан тушаал** внештатная должность, **~ тооны цомхоттолоор халах** увольнение по сокращению штатов

ОРОН 2. жилище, кров, **~ сууц/байр** жилище, квартира, жилой дом, **~ сууцны талбай** жилая площадь, **~ сууцны хороолол** жилые кварталы, **~ сууцны нөхцөл** жилищные условия, **~ сууцны хөлс** квартирная плата/плата за квартиру, **шинэ ~ сууцанд орох** переселяться на новую квартиру, **~ байр эвдэж шөнийн цагаар хулгай хийх** ночная кража со взломом

ОРОН 3. место, вакансия, ~ **тоо** штат, вакансия, ~ **тооны бус**, ~ **тооноос гадуур** внештатный, сверхштатный, вне штата/вакансии, ~ **гарсан** свободная вакансия, ~ **тооны ажилтан** штатный работник, ~ **тоонд оруулах/бүртгэх** зачислять/включать в штат, ~ **тооны цомхотгол** сокращение штатов/кадров

ОРОН поле, пространство, ~ **зай** пространство, **геосоронзон** ~ геомагнитное поле

ОРОНД вместо, взамен, **таны** ~ вместо вас, **үүний** ~ взамен этого, вместо этого

ОРОНЦОГ *с унизительным оттенком:* подобие кого-, чего-либо, одно название, одна видимость, *гэрийн оронцог* подобие юрты, избёнка, **зуухны** ~ печурка, одно название печи

ОРОНЧ: **эх** ~ патриот, **эх** ~ **үзэл** патриотизм, любовь к отечеству, **эх** ~ **сэтгэл** патриотические чувства

ОРОО 1. убегающий, уклоняющийся, неуловимый, ~ **морь** неуловимая лошадь, **өрөнд** ~ **хүн** человек, уклоняющийся от уплаты долгов

ОРОО 2. течка, гон, ~ **нь орсон буур** вердлюдпроизводитель в течке, **~ны үе** период течки, случной период, ~ **хөөцөнд орох** быть в гоне

ОРООГДОХ *страд. от* **ороох**, 1) завёртываться, обёртываться, быть завёрнутым/обёрнутым, 2) запутываться, **хэрэгт** ~ запутываться в делах, проблемах

ОРООЛГОХ бить, ударять, хлестать, стегать (чем-нибудь эластичным), **морийг ташуураар** ~ хлестать лошадь кнутом, **шилбүүрээр** ~ ударять бичом

ОРООЛДОХ сплетаться, запутываться, обвиваться

ОРООЛОН: **босоо** ~ чертёнок, вампир, упырь

ОРООЛОХ убегать, уклоняться, избегать, **өрнөөс/өр өгөхгүй** ~ не отдавать долг, уклоняться от уплаты долгов, **морь ~в** конь убежал, конь никого не подпускал к себе

ОРООЛТ шарф, упаковка, **хүзүүний** ~ шарф, **хөлийн** ~ портянка, ~ **цаас** обёрточная бумага

ОРООМОГ 1. угощение из внутренностей мелкого скота, фаршированных в тонкие кишки

ОРООМОГ 2. катушка с нитками

ОРООХ 1. завёртывать, обвёртывать, окутывать, обвивать, наматывать, **хүзүүгээ ороолтоор** ~ обмотать шею шарфом, повязать шею шарфом, **хүүхдийг өлгийд** ~ укутать ребёнка одеялом

ОРООХ 2. *перен.* придираться, искать предлог к ссоре

ОРООЦОЛДОО сплетение, запутывание, запутанность, спутанность, осложнение, **хэргийн** ~ запутанность дела, **утасны** ~ **гаргах** распутать нитки

ОРООЦОЛДОХ 1) сплетаться, запутываться, спутываться, обвиваться, 2) связываться с кем-, чем-нибудь, возиться, перепутываться, **дээс ~жээ** верёвка запуталась, **хэрэгт** ~ запутываться в плохих делах, **өөдгүй хүнтэй** ~ связываться с негодяем, **хүүхэдтэй** ~ возиться с ребёнком

ОРОС русский, **Оросын Холбооны Улс** Российская Федерация, ~ **хэл үзэх** изучать русский язык, **~оор ярих** говорить по-русски, ~ **хүн** русский, ~ **эмэгтэй** русская, **шинэ** ~ новый русский

ОРОСЖИХ обрусеть, стать русским по языку и обычаям, русифицироваться

ОРОСЖУУЛАХ *побуд. от* **оросжих**, руссифицировать, подвергать руссификации

ОРОХ 1) входить, въезжать, заходить, заезжать, направляться, идти, ехать, 2) вступать, поступать, входить, 3) проникать, попадать, залезать во вкус чего-либо, пристратиться, 4) заходить, скрываться, забираться, 5) подчиняться, повиноваться, слушаться, подвергаться, попадаться, начинать, **гэрт** ~ входить в дом, **шинэ байранд** ~ переселяться на новую квартиру, **~ж болох уу?** можно войти? **бүрэлдэхүүнд орох** входить в состав, **намд** ~ вступать в партию, **тоонд** ~ *входить в число*, **тооцоонд** ~ входить в счёт, **өрөнд** ~ входить в долги, влезать/залезать в долги, **амтанд** ~ входить во вкус чего-либо, **түүхэнд** ~ войти в историю, **тулалдаанд** ~ вступать в бой, **хот** ~ ехать в город, **ажилд** ~ поступать на работу, **сургуульд** ~ поступать в школу, **цэрэгт** ~ поступать на военную службу, **аюулд** ~ подвергаться опасности, **гарт** ~ попадать кому-либо в руки, **эрхэнд/нөлөөнд** ~ подвергаться влиянию, попадать под влияние, **засгийн эрхэнд** ~ прийти к власти, **үгэнд** ~ послушаться, **нар үүлний цаагуур ~в** *солнце* скрылось за тучами, **зүүдэнд** ~ сниться, видеть во сне, **санаанд** ~ вспоминать, вспоминаться, **үнэд** ~ дорожать, становиться дороже, **ухаан** ~ очнуться, прийти в сознание, **зориг** ~ набраться храбрости/смелости, **гэгээ** ~ светать, проясняться, **дулаан** ~ становиться тёплым, **сэрүүн** ~ стать прохладным, **хэлд** ~ начинать говорить, **хөлд** ~ начинать ходить, **цас ~ж байна** снег идёт, **бороо ~ж байна** дождь идёт

ОРСГОЙ торчащий, кривой, неровный (о зубах)

ОРСГОР торчащий, неровный

ОРСОЙХ торчать, быть кривым/неровным (о зубах)

ОРТОЙ имеющий основание, имеющий долю правды, правдоподобный, вероятный, ~ **юм ярих** говорить что-то правдоподобное, **түүний ярьсан болгон нэлээд ~ дог шүү** всё, что он рассказал, довольно (серьёзно) основательно, ~ **үг** правдоподобные слова

ОРУУЛАЛТ введение, вложение, включение, **хөрөнгө** ~ капиталовложды, защищать окружающую среду, **хотын** ~ **тойронд** в окрестностях города, **~доо дасах** привыкать к своей среде, ~ **үе** современность, ~ **цагийн монгол хэл** современный монгольский язык, ~ **тойрондоо аюултай зүйлс** источник опасности для окружающих

ОРУУЛАХ 1) вводить, вносить, впускать, пропускать, вкладывать, 2) вносить, попадать, включать, **гэрт** ~ впускать в дом, **өөрчлөлт** ~ *вносить изменения*, **засвар** ~ вносить поправки, **хуульд өөрчлөлт/нэмэлт** ~ вносить изменения/дополнения в закон, **төөрөгдөлд** ~ вводить в заблуждение, **маягт/моодонд** ~ вводить в моду, **ашиглалтад** ~ вводить в эксплуатацию, **нэрсийн жагсаалтад** ~ вносить в список, **санал** ~ вносить предложение, **хувь нэмэр** ~ вносить вклад

ОРУУЛГА вставка, внесение, **гар бичмэлийн** ~ вставка в рукопись

ОРХИГДОХ *страд.от* **орхих**, оставляться, быть оставленным/брошенным, забываться, быть забываемым, оказываться забытым

ОРХИХ 1) оставлять, покидать, 2) *употребляется в роли вспомогательного глагола:* **гэртээ юм** ~ оставлять что-либо дома, **хаалга онгорхой** ~ оставить дверь открытой, **ардаа хол** ~ оставлять далеко позади, **анхааралгүй** ~ оставлять без внимания, **мартаж** ~ совсем забыть, **энэ тухай би тэгж хэлээд ~сон** об этом я прямо так сказал

ОРХООДОЙ: **хүн** ~ женьшень

ОРЦ 1. 1) доля, количество чего-либо, порция (напр. о пище), 2) доход

ОРЦ 2. подъезд, вход в здание, **~ны үүд** дверь в подъезд здания, **~ны дэргэд үнсэлцэх** целоваться у подъезда

ОРЧИЛ цикл, круговорот, **үйлдвэрлэлийн** ~ производственный цикл

ОРЧИМ около, возле, поблизости, приблизительно, **гуч ~ хонь** около тридцати овец

ОРЧИН 1) окрестность, окружение, среда, 2) возле, поблизости, ~ **тойрон** окрестность, вокруг, **газарзүйн** ~ географическая среда, **хүрээлэн буй** ~ окружающая среда

ОРЧИНЗҮЙ экология

ОРЧЛОН мир, вселенная

ОРЧУУЛАГДАХ *страд. от* **орчуулах**, переводиться, быть переведённым, **тэр ном монголоор ~сан** та книга переведена на монгольский язык, **~аагүй зохиол** непереведённое произведение

ОРЧУУЛАГЧ переводчик, **хамт цагийн** ~ синхронный переводчик, **мэргэжлийн** ~ квалифицированный переводчик, **орос хэлний** ~ переводчик русского языка, **~ийн мэргэжил** специальность переводчика

ОРЧУУЛАХ переводить, **орос хэлнээс монголоор** ~ переводить с русского на монгольский, **үгчлэн/махчилан** ~ дословно переводить

ОРЧУУЛГА 1. перевод, переводной, **~ын уран зохиол** переводная литература, **~ын онол** теория перевода, **махчилсан** ~ механический или дословный перевод, переводкалька, **чөлөөтэй** ~ вольный перевод, **зөв сайн** ~ правильный хороший перевод, **хамт цагийн** ~ синхронный перевод

ОРЧУУЛГА 2. вращение

ОРЧУУЛУУЛАХ *побуд. от* **орчуулах**, давать переводить, заставлять переводить, поручать переводить

ОРШИЛ 1. предисловие, пролог, вступительные слова, **хоёр дахь хэвлэлийн** ~ предисловие ко второму изданию, **судалгааны** ~ предисловие к исследованию, **номын** ~ **бичих** написать предисловие к книге

ОРШИЛ 2.могила, кладбище

ОРШИХ 1. 1) находиться, существовать, располагаться, 2) заключаться в чём-либо, состоять в чём-либо, **~н суух** жить, проживать, **~н суух газар** местожительство, ~ **газар** местоположение, **~н суугчид** жители, **учир нь юунд ~но вэ?** в чём заключается суть? **энэ ажлын ач холбогдол чухам үүнд ~ж байгаа юм** значение настоящей работы состоит/заключается именно в этом, ~ **уу? эс** ~ **уу?** быть или не быть

ОРШИХ 2. неметь, терять чувствительность, **хөл ~чихлоо** ноги онемели

ОРШУУЛАХ хоронить, **талийгаачийг** ~ хоронить покойного, ~ **ёслол** похоронная церемония

ОРШУУЛГА похороны, **~ын газар** кладбище

ОРЬ 1. юный, молодой, ~ **залуу нас** светлая молодость, юность

ОРЬ 2.: ~ **дуу тавих/алдах** вопить, кричать, стонать от сильной боли

ОСГООХ *побуд. от* **осгох**, доводить до замерзания/окоченения

ОСГОХ мёрзнуть, сильно зябнуть, коченеть от холода (о живых существах), **~ж үхэх** замёрзнуть

ОСОЛ 1) авария, несчастный случай, 2) небрежность, неосторожность, оплошность, ~ **эндэгдэл** ошибка, авария, **авто замын** ~ автодорожное происшествие, авария на автодороге, **гэр ахуйн** ~ бытовая авария, **~ын дохио** аварийный сигнал

ОСОЛГҮЙ 1. без аварии, без происшествия, безаварийный, безопасный, ~ **техник** безаварийная техника, ~ **газар** безопасное место

ОСОЛГҮЙ 2. 1) наверняка, точно, конкретно, 2) точный, конкретный, ~ **үнэн** сущая правда, конкретная истина, **би** ~ **харсан** я точно видел

ОСОЛДОХ 1) ошибаться, поступать неосторожно, совершать оплошность, допускать небрежность, 2) случиться, совершаться, происходить (о несчастном случае, аварии), **дайнд** ~ погибать на войне, **усанд/үерт** ~ потонуть в воде, погибать от наводнения

ОСОЛТОЙ опасный, грозящий какой-либо бедой, рискованный, вредный, опасно, рискованно, ~ **газар** опасное место, ~ **зам** опасный путь, ~ **явдал** рискованный поступок, ~ **алхам** рискованный шаг

ОТГОЛОХ кончать, заканчивать, завершать

ОТГОН 1) самый младший, 2) последний, завершающий, заключительный, ~ **охин** самая младшая дочь в семье

ОТОГ 1. 1) отог (административная единица в дореволюционной Монголии), 2) род, клан, ~ **омог** клан

ОТОГ 2. бивуак

ОТОГЛОХ организовывать артель охотников

ОТОР отгон, выпас скота на отгонных пастбищах/дальних пастбищах, ~ **хийх** перекочёвывать/переезжать от одного пастбища на другое, выгонять на дальние пастбища, **~ын мал** скот на отгонных пастбищах

ОТОРЛОХ 1) пасти скот на дальних пастбищах, выгонять скот на отгонные пастбища, 2) уклоняться от работы, лодырничать, **биеэ** ~ сидеть без дела, бить баклуши

ОТОРЧИН скотовод на отгонном пастбище

ОТОХ подкарауливать, подстерегать, **ан** ~ подкарауливать дичь на охоте, **би тэр Солонгоог оройжингоо ~ж байгаад уулзлаа** я эту Солонгоо подкарауливал целый вечер и наконец встретил (застал)

ОТОЧ лекарь

ОТРЯД отряд, **тэргүүний** ~ передовой отряд, **томоохон** ~ крупный отряд, **шинжилгээний** ~ экспедиционный отряд, исследовательский отряд, **~ын дарга** начальник/командир отряда

ОТУУЛАХ *побуд. от* **отох**, заставлять подкарауливать

ОФИЦЕР офицер, офицерский, ~ **цол авах** получить офицерский чин/звание, **~уудын ордон** дом офицеров

ОХИН 1) дочь, 2) девочка, 3) самка, **төрсөн** ~ родная дочь, ~ **дүү** младшая сестра, ~ **хурга** ягнёнок-самка, **~ы орд** созвездие Девы, ~ **компани** дочерняя компания

ОХИР: ~ **далавчит царцаахай** саранча итальянская

ОХОР 1) короткий, непродолжительный, недалёкий, ~ **дээл** короткое дэли, ~ **сүүл** а) короткий хвост, б) копчик, ~ **бодол** недальновидность, ~ **бодолтой хүн** недальновидный/несообразительный человек, ~ **болгох** укорачивать, делать коротким, ~ **болох** укорачиваться, делаться коротким

ОХОРДОХ оказываться слишком коротким, сильно укорачиваться, **энэ цув танд арай ~ж байна** этот плащ оказывается несколько коротким для вас

ОХОРХОН *уменьш. от* **охор**, коротковатый, краткий, ~ **хугацаа** кратчайший срок, самое короткое время

ОХТОР: ~ **загас** короткохвостый верхогляд

ОХЬ 1. самое лучшее, экстра

ОХЬ 2. спирт, самогон

ОЦГОНОХ качаться, трепыхаться, **биттий ~оод бай!** не дёргайся!

ОЦГОР выступающий верхней частью вперёд

ОЦОН выступающий вперёд, ~ **шувуу** пингвин

ОЧ искра, искры, ~ **үсрэх** блестеть искрами, сверкать блёстками, искриться, **нүдээс** ~ **үсрэх шиг/мэт болов** как будто искры из глаз посыпались

ОЧИР символ могущества, ~ **алмаас** алмаз, бриллиант, ~ **там** ад, чистилище

ОЧИХ 1) идти, ехать, отправляться, 2) *употребляется в роли вспомогательного глагола* **ажилд** ~ идти на работу, **сургууль/дэлгүүрт** ~ идти в школу/в магазин, **хадамд** ~ выходить замуж, **хаа** ~ **вэ?** куда идти? **авч** ~ принести, привезти, **гарч** ~ выходить, уходить, **~оод ирэх** сходить, буцаж очих вернуться

ОЮУ бирюза, бирюзовый, **~ ээмэг** бирюзовые серьги, **~ шигтгээ** украшения из бирюзы, бирюзовые украшения, вставляемые в рамки на чём-либо

ОЮУН 1) ум, разум, интелект, 2) умственный, **~ы хөдөлмөр** умственный труд, **~ы өмч** интеллектуальная собственность, **~ санаани амьдрал** духовная жизнь, **~ билэг** талант, **~ санааны баялаг** духовные богатства, **~ цэц** мудрость, **~ы чадвар** умственные способности, **~ ухааны коэффициент** коэффициент умственного развития, **~ ухааны хомсдол** умственная неполноценность

ОЮУТАН студент, студентка, студенческий, **~ы байр** студенческое общежитие, **Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийн ~ охид «Гоёл» уралдаанд амжилттай оролцож ирсэн ч Анагаах Ухааны Их Сургуулийн ~ охид тэд нараас илүү гоё байсан ч шалгарч чадаагүй** хотя студентки Института международных отношений успешно участвуют в конкурсе «Красота», студентки Медицинского Университета куда приятнее и нежнее их, **~ы амьдрал мэдэх** знать студенческую жизнь

Ө

ӨВ наследство, наследие, ~ **залгамж-лагч** наследник, ~ **залгамжлал** наследование, ~ **залгамжлах эрх** право наследования, ~ **хөрөнгө** наследие, наследство, ~ **залгамжлах/~ залгамжилж авах** наследовать, получать в наследство, ~ **залгамжлагчийн эрхийн байдал** статус наследника, **соёлын ~** культурное наследство, ~ **уламжлал** исконные традиции, **соёлын ~ийг хамгаалах** сохранять культурное наследие, ~ **залгамжлалаас хүртэх хууль ёсны хувь хэмжээ** законная доля в наследстве, ~ **залгамжлалын журам** нормы, регулирующие порядок наследования, ~ **залгамжлах эрхийн гэрчилгээ** свидетельство о праве наследства, ~ **залгамжлуулсан эд хөрөнгө, газар** наследуемое имущество, земля, ~ **залгамжлалын эрх зүй** наследственное право

ӨВГӨД 1) старики, старцы, 2) предки, **эцэг ~**, ~ **дээдэс** предки, **эцэг ~ийн сургаал** поучение предков, назидание старцев, **нуттийн ~ хөгшид** местные старожилы/старики

ӨВГӨЖӨӨР пожилой, старый, престарелый, **нэлээд ~ хүн** престарелый человек

ӨВГӨН 1) старик, старец, 2) *простореч.* муж, *разг.* друг, ~ **аав** дедушка, ~ **хүн** старый человек, ~ **болох** стареть, **Долоон ~** *астр.* Большая медведица, **хөх ~** волк

ӨВГӨРӨХ постареть, стариться

ӨВДӨГ 1. колено, ~ **таттал** по колено, ~ **сөгдөх** стать на колени

ӨВДӨГ 2.: **нүдний ~** ячмень

ӨВДӨГЛӨХ надавливать коленями

ӨВДӨХ болеть, хворать, **таны юу ~ж байна** что у вас болит? на что вы жалуетесь?

ӨВЛӨГДӨХ: ~ хөрөнгө наследуемое имущество

ӨВЛӨГЧ наследник

ӨВЛӨХ наследовать, получить в наследство, **тэр энэ сэлмийг буурал ааваасаа ~сөн юм** он наследовал эту саблю от деда

ӨВЛҮҮЛЭГЧ наследодатель

ӨВӨГ 1. предок, ~ **дээдэс** предки, ~ **эцэг/аав** дед, дедушка

ӨВӨГ 2. хохолок у птиц, **~т тогоруу** журавль красавка, **~т хөх бух** синица хохлатая

ӨВӨГЖӨӨР пожилой, старый

ӨВӨГРӨХ стареть

ӨВӨГЧЛӨХ почитать, относиться с благоговением к пожилым людям

ӨВӨЛ зима, **цастай хатуу ~** снежная суровая зима, **өнгөй ~ болж байна** наступает благополучная зима, **~ийн өдөр** зимний день, **~ийн хувцас** зимняя одежда, **~ийн улирал** зимний сезон

ӨВӨЛЖИН в течение всей зимы

ӨВӨЛЖИХ зимовать, проводить зиму где-нибудь, **хотод ~зимовать в городе, би энд ~ байх/биз** я, наверно, перезимую/проведу зиму здесь

ӨВӨЛЖӨӨ зимовка, зимнее местожительство, зимняя стоянка

ӨВӨӨ *разг.* дед, дедушка

ӨВӨӨЛЖӨӨЛӨХ располагаться на зимовку, жить на зимнике

ӨВӨР 1. южный склон, южная сторона, внутренняя сторона, **уулын ~** южный склон гор, **Өвөр Монгол** Внутренняя Монголия, **~ монголчууд** жители Внутренней Монголии

ӨВӨР 2. пазуха, колени, **хүүхэд эхийнхээ ~ дээр сууж байна** ребёнок сидит у матери на коленях, **~өөсөө гаргах** вытащить из-за пазухи, ~ **түрий** карманы, **~т унтах** спать под одним одеялом, ~ **сул хүүхэн** слабая на «передок» женщина, **~ийн дэвтэр** блокнот, **~ийн шар шувуу** филин южный, ~ **түрийдээ орох** а) спать под одним одеялом, б) стать закадычными друзьями

ӨВӨРЛӨГЧ уроженец Внутренней Монголии

ӨВӨРЛӨХ 1. идти по южному склону горы

ӨВӨРЛӨХ 2. 1) класть за пазуху, держать за пазухой, 2) мстить, 3) спать вместе, **өшөө ~** проявлять месть по отношению к кому-либо, затаивать ненависть

ӨВӨРМӨЦ своеобразный, особенный, самобытный, специфический, ~ **чанар** специфика, своеобразие, ~ **байдал** особенность, ~ **онцлог** специфические особенности, ~ **үзэл бодол** своеобразная точка зрения, ~ **арга** своеобразный приём, особый метод, ~ **үнэр** специфический запах, ~ **заншил** своеобразный обычай, специфические нравы

ӨВӨРТЛӨХ 1) класть за пазуху, держать за пазухой, 2) спать вместе, **хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдмийг ~н ирэх** (Д.Нацагдорж) *приблизительно:* со знаниями вернётся сын оттуда, куда не долетают стаи диких птиц

ӨВС трава, сено, ~ **хадлан** сенокос, ~ **хадах** косить, ~ **бухалдах/хураах** копить сено, стоговать сено, ~ **нуруулдах** скирдовать сено, **~н бухал** копна сена, **~ний хадуур** коса, **~ний үнэр** травяной запах, **~ний тармуур** грабли, **~ний хашаа** сеновал, **~н овоохой** шалаш, **~нд хаясан зүү эрэхтэй адил** искать иголку в стоге сена

ӨВСЛӨХ скармливать сено животным

ӨВСӨРХӨГ обильный травой, травянистый, ~ **газар** местность, обильно растущей травой

ӨВХӨС: ~ ~ **хийх** подпрыгивать, пружинить в седле

ӨВЧ цельный, комплексный, ~ **хуяг** бронированный, полностью бронированный, ~ **бүрэн хэрэглэлтэй гэр** юрта с полным комплектом

ӨВЧИГНӨХ дурить, прикидываться дурачком, валять дурака

ӨВЧИЛТ свежевание туши, снятие шкуры с животного, **задгай ~** ковровое свежевание, **оймслох ~** свежевание чулком, **тулам ~** свежевание с задних ног

ӨВЧИН болезнь, заболевание, боль, **халдварт ~** заразная болезнь, **архаг ~** хроническая болезнь, **хүнд ~** тяжёлая болезнь, **толгойн/сэтгэлийн ~** головная/душевная боль, **арьсны ~** кожная болезнь, **~ий цэг** болевые точки, **нийгмийн ~** социальные болезни, **~ий түүх** история болезни, ~ **хүрэх/тусах** заболеть, ~ **тарих/халдаах** распространять болезнь, заражать болезнью, ~ **үгдрэх** осложняться (о болезни), **~д баригдах/нэрвэгдэх** постоянно болеть, часто хворать, ~ **намдаах** эм болеутоляющее/обезболевающее средство, ~ **илаарших** выздоравливать, **~ий улмаас авах даатгалын тэтгэмж** страховое пособие по болезни

ӨВЧИНГҮЙ 1) здоровый, 2) безболезненный, ~ **бол жаргал** *погов. дословн.* счастье это здоровье

ӨВЧИХ снимать/сдирать кожу, свежевать, **хонь ~** свежевать барана, **арьсыг битүү ~** снимать кожу чулком

ӨВЧЛӨЛ (т) заболевание, заболеваемость, **хөдөлмөрийн чадвар түр алдуулах ~** заболевание, вызвавшее временную потерю трудоспособности

ӨВЧЛӨМТГИЙ болезненный

ӨВЧЛӨХ болеть, заболевать, **хижгээр ~** болеть тифом

ӨВЧТӨН больной, ~ **эргэх** навестить больного/больную, **~ий биеийн байдал** состояние здоровья больного, ~ **эмчлэх** лечить больного/больную

ӨВЧТЭЙ больной, нездоровый, болезненный, ~ **хүн** больной человек, ~ **шүд** больной зуб, **мэдрэлийн ~** психически больной

ӨВЧҮҮ грудинка, грудная кость, **хонины ~** баранья грудинка, **~ний цаад руу юм хаях** есть, кушать

ӨВШ: ~ эрвээхэй медведица (насекомое)

ӨГЗӨГ ягодица

ӨГЛӨГ 1) *подаяние, милостыня*, 2) *долг, задолженность*

ӨГЛӨГЧ охотно раздающий, нескупой, щедрый

ӨГЛӨӨ утро, утром, **~ бүр** каждое утро, **~ эрт** рано утром, **нэг ~** однажды утром, **~гүүр** утром, по утрам, **~гүүр их унтах** долго спать утром, **~ний цай/хоол** завтрак, **~ний дасгал** утренняя зарядка, **~ний мэнд хүргэе** доброе утро!

ӨГӨӨ: ~ авах долг, взаимная дача чего-либо, **~ аваатай байх** а) взаимно выручать друг друга, оказывать взаимную помощь, б) оказываться равным, быть равносильным

ӨГӨӨЖ отдача, выгода, прибыль, польза, **ямар ч ~ алга** нет никакой отдачи/выгоды

ӨГӨӨЖГҮЙ *не прибыльный, не выгодный*, бесполезный

ӨГӨӨЖТЭЙ прибыльный, выгодный, полезный, **~ аж ахуй** прибыльное хозяйство

ӨГӨӨМӨР 1) щедрый, 2) обильный, богатый, **~ хүн** щедрый человек, **~ нутаг** богатый край, **~ авьяас билэг** богатый талантами, **~ гараа сунгах** протянуть щедрую руку помощи, **~үйлстэн** филактрон

ӨГӨР выгоревший, выцветший, обветшалый

ӨГӨРШИХ выцветать, выгорать, выветриваться, ветшать, **наранд ~** выцветать на солнце

ӨГӨХ 1) давать, отдавать, поддавать, 2) *употребляется в роли вспомогательного глагола* **даалгавар ~** давать задание, **бэлэг ~** поднести подарок, **цахилгаан ~** давать телеграмму, **тушаал ~** отдавать приказ, **замы нь зааж ~** показать дорогу, **зөвлөгөө ~** давать совет, **хэл ~** сообщать, извещать, **зөвшөөрөл ~** давать разрешение, **харму ~** дать ответ, **эрх ~** давать право, **өргөдөл ~** подавать заявление, **хэлж ~** объяснять, говорить, подсказать, **зааж ~** показать, **авчирч ~** принести, **гардуулж ~** вручать, **бууж ~** сдаваться, капитулировать

ӨГСӨХ идти вверх, ехать вверх, подниматься, **уул өөд ~** подниматься в гору, **гудамж ~** идти вверх по улице, **гол ~** идти/плыть вверх по течению реки, **~ уруудах** подниматься и спускаться, **~ Давхцал** *муз. обертоны*, **~ хөдөлгөөн** *муз.* восходящее движение

ӨГСҮҮЛЭХ двигаться вверх, двигать вверх, **~ээд** от... и до..., начиная с..., **засгийн газрын гишүүдээс ~ээд хүүхэд багачууд хүртэл...** от членов правительства до детворы...

ӨГСҮҮР 1) подъём, 2) поднимающийся, идущий на подъём, **эгц ~ газар** крутой подъём, **налуу ~** пологий подъём

ӨГҮҮЛБЭР предложение, **гол ~** главное предложение, **захирах ~** императивное предложение, **гишүүн ~** придаточное предложение, **энгийн/нийлмэл ~** простое/сложное предложение, **~ийн ялгал** разбор предложения, **урт ~** длинное предложение, **~ зохиох** *составлять предложение*

ӨГҮҮЛБЭРЗҮЙ синтаксис, **~н** хэсгүүд разделы синтаксиса

ӨГҮҮЛЛЭГ рассказ, **зохиолчийн ~үүд** рассказы писателя, **тууж ~ийн эмхэтгэл** сборник повестей и рассказов

ӨГҮҮЛШГҮЙ невыразимо, неописуемо, **~ сайхан** невыразимо красивый, несравнимо прекрасный, **~ муухай** невыразимо дурной, **~ сэтгэгдэл төрүүлэх** произвести неизгладимое впечатление, **~ зовлон учруулах** причинять неисчислимые/невыразимые страдания

ӨГҮҮЛЭГДЭХҮҮН подлежащее, субъект, **гишүүн өгүүлбэрийн ~** подлежащее придаточного предложения, **хэлзүйн ~** грамматическое подлежащее, **логик ~** логический субъект

ӨГҮҮЛЭГЧ рассказчик

ӨГҮҮЛЭЛ статья, **тэргүүн ~** передовая статья, **эрдэм шинжилгээний ~** научная статья, **сонины ~** газетная статья, **өмнөх ~** предисловие, **үг ~ гаргах/тавих** выражать недовольство

ӨГҮҮЛЭХ 1. говорить, повествовать, произносить, изрекать

ӨГҮҮЛЭХ 2. *побуд. от* **өгөх**, посылать, отправлять, **Сэлэнгэ охиндоо тоглоом ~жээ** Сэлэнгэ послала дочери игрушку, **гэртээ захиа ~** отправить *письмо домой*

ӨГҮҮЛЭХҮҮН сказуемое, предикат, **нэр ~** именное сказуемое, **үйл ~** глагольное сказуемое, **энгийн/нийлмэл ~** простое/сложное сказуемое

ӨГҮҮЛЭШГҮЙ невыразимо, **~ сайхан бүсгүй** невыразимо прекрасная девушка

ӨД 1) перо, перья, пух, 2) сделанный из перьев, пуховой, **~ сөд** перья, оперение, **~ сөд нь гуужих** линять (о птице), **дэрэнд ~ чихэх** набить подушку перьями, **~н хөнжил** пуховое одеяло, **~н куртк** пуховик, пуховая куртка

ӨДГӨӨ сейчас, ныне

ӨДИЙ 1. *не скоро, ещё не, столько*, **~ болтол** *до сих пор*

ӨДИЙ 2.: **~ чинээ** столько, вот столько, **~ төдий** много, большое количество

ӨДИЙ 3.: **~д, ~й үед** в это время, ~д к этому времени, в это время

ӨДИЙХӨН *уменьш. от* **өдий**, всего лишь, всего/навсего, всего столько

ӨДИЙЧИНЭЭ столько, вот столько, **~ урт** столько в длину/по длине

ӨДЛӨХ оперяться, покрываться оперением, **сум ~** оперить стрелу

ӨДӨӨГЧ подстрекатель, **хаттан ~** провокатор, **дайн ~д** поджигатели войны

ӨДӨӨГДӨЛ индукция, **~ийн соронзшил** индукционная магнитность

ӨДӨӨЛТ провокация, подстрекательство, вызов, побуждение к чему-либо

ӨДӨӨХ побуждать, затевать, начинать, провоцировать, подстрекать, **хэрүүл ~** начинать ссору, затеять спор, **зодоон ~** затеять драку, **~н түлхэх** подталкивать, подстрекать, **~н хаттах, хаттан ~** подстрекать, провоцировать, **~н хаттагч** провокатор

ӨДӨР день, **~ бүр, ~ болгон/тутам** каждый день, ежедневно, **~ дунд** полдень, **~өөс ~т** изо дня в день, **~ ирэх тутам** с каждым днём, **ажлын ~** рабочий день, **амралтын/баярын ~** выходной/праздничный день, **төрсөн ~** день рождения, **бүтэн сайн ~** воскресенье, **час ~** трудный день, день, когда всё наладится, **олон улсын эмэгтэйчүүдийн ~** международный женский день, **дөрвөн сарын нэгний ~** первое апреля, **бүтэн ~** целый день, **анхны ~өөс** с первых дней, **анхны ~үүдэд** в первые дни, **~ шөнөгүй** и днём и ночью, **ойрын ~үүдэд** на днях, в ближайшие дни, **сүүлийн ~үүдэд** в последние дни, **гэгээн цагаан ~өөр** среди бела дня, **~ийн гэрэл** дневной свет, **~ийн ээлж** дневная смена, **~ийн цагаар** *в дневное время*, **~ийн хоол** обед, ланч, **~өө хүлээх** ждать смертного часа, **~ийн од шиг** очень редко

ӨДӨРЖИН целый день, весь день, в течение дня, за день, **бүхэл ~** целый день, за весь день, **нэг ~ газар** место, до которого надо добираться целый час

ӨДӨРЛӨГ дневник, дневное мероприятие

ӨДӨРЛӨХ датировать, **захиаг өнөөдрөөр ~** датировать письмо сегодняшним числом/днём

ӨДӨРТӨӨ днём, в течение дня, в один день, в тот же день, **~ түр зуурын бороотой** днём ожидаются кратковременные дожди

ӨДӨХ 1. затевать, побуждать, заставлять сделать что-либо, начинать что-либо, **ярил ~** затевать разговор
ӨДӨХ 2. подстрекать, провоцировать, **хатган ~** провоцировать
ӨДҮҮЛЭХ *побуд. от* **өдөх**, совершать, затевать, натворить что-либо, **гэмт хэрэг ~** совершить преступление
ӨЕГ 1) питательный, сытный 2) сытый, 3) нежадный, неалчный, **~ хоол** сытная пища, питательное блюдо, **~ байх/явах** быть сытым, **~ тарган** полный, толстый, **~ хүн** а) сытый человек, б) нежадный человек
ӨЕГДӨХ быть чрезмерно питательным, сытным
ӨЕГШИХ быть удовлетворённым, **сэтгэл ~** испытывать душевное удовлетворение
ӨЛ 1. 1) питательность, сытность, калорийность, 2) пища, питание, **~ шимгүй** непитательный, несытный, **~ хоолгүй явах/байх** ходить/быть без пищи, голодать, чувствовать голод, **~ даах** выдерживать голод, **~ даахдаа сайн** хорошо переносящий голод, **~ залгах** подкрепляться, утолять голод, закусывать
ӨЛ 2.: **~ буурал** сизый, сивый, **~ буурал морь** сивый конь, **~ халзан** белолобый, с белой полосой на лбу (о лошади)
ӨЛ 3. холм, возвышенность,
ӨЛБӨЛЗӨХ высматривать, искать вытягивая шею
ӨЛБӨРӨЛ голодание, голод, истощение от голода
ӨЛБӨРӨХ сильно голодать, истощаться от голода, **~ч үхэх** умереть от голода, умереть голодной смертью
ӨЛГИЙ колыбель, люлька, **~ нутаг** родина, родные места, **~тэй хүүхэд** младенец в колыбели, **~и дуу** вать голод, проголодаться
ӨЛГИЙДӨХ пеленать, **хүүхэд ~** пеленать младенца/ребёнка
ӨЛГӨГДӨХ *страд. от* **өлгөх**, висеть, быть повешенным/привешенным, цепляться
ӨЛГӨӨС крючок, петля, вешалка
ӨЛГӨР: **~ загас** речная горбушка, ханка, верхоглядка
ӨЛГӨХ 1) вешать, подвешивать, привешивать, 2) *перен.* придираться, **ханаад ~** вешать на стену, **хүний үг ~/~ж авах** придираться к чьим-либо словам
ӨЛГӨЦ рубрика, раздел, **олон улсын ~** международная рубрика, **сонины ~** газетные рубрики
ӨЛГҮЙ непитательный, несытный, **~ хоол** непитательная пища
ӨЛГҮҮЛЭХ *побуд. от* **өлгөх**, давать повесить, поручать повесить, **гадуур хувцасаа ~** сдать верхнюю одежду на вешалку
ӨЛДӨХ 1. голодать, быть голодным, проголодаться
ӨЛДӨХ 2. быть свободной, оказываться слишком просторной (об одежде)
ӨЛЗИЙ 1. мир и счастье, **~ хутаг** счастье и благоденствие
ӨЛЗИЙ 2. символический орнамент благополучия, **~ утас** символ мира и счастья
ӨЛЗИЙГҮЙ неудачливый, несчастливый, не обещающий счастья и удачи
ӨЛЗИЙГҮЙДӨХ быть/оказаться несчастным, неудачливым
ӨЛЗИЙТЭЙ счастливый, удачливый, приносящий счастье и благополучие, **~ өдөр** счастливый/благополучный день
ӨЛЗИЙХҮҮ табуированное название пугала
ӨЛИЙХ вытягивать шею, задирать голову
ӨЛЛӨХ перекусить, покормить, **морио ~** немного накормить свою лошадь
ӨЛМИЙ 1) передняя часть ноги, стопа, подъём ноги, **~ дээрээ зогсох** стоять на цыпочках, 2) *поэт.* нога, шаг, стопа, 3) носок обуви, 4) *поэтическ.* **дэвхцмэл ~** ямб, **тонгорол ~** анапест, **хуруун ~** дактиль, **~и лянхуа батад орших** *приблизительно:* наслаждаться долгой жизнью, **~д нь мөргөх** *фольк.* склоняться к чьим-либо ногам
ӨЛМИЙЛДӨХ вставать на носки, идти на цыпочках
ӨЛМӨН: **~ зэлмэн (өлмүүн зэлмүүн)** тощий, скудный, **өлмүүр зэлмхүүрхэн амьдрах** жить, перебиваясь с воды на хлеб
ӨЛӨГ 1.: **~ эд** физическое тело, вещество
ӨЛӨГ 2.: **~ өвчин** сухотка
ӨЛӨГ 3. сырьё
ӨЛӨГЧИН самка плотоядных животных, сука, **~ бар** тигрица
ӨЛӨЛЗӨХ часто вытягивать шею, то и дело задирать голову
ӨЛӨМИЙ: ~ шилэмгүй непитательный
ӨЛӨН 1. голодный, несытный, неевший, голодающий, **~ элгээр, ~ элгэн дээр** натощак, **~ байх/явах** голодать, быть голодным, **~ гэдэс** тонкие кишки, **~ үс** пушок, **~ ус** моча
ӨЛӨН 2.: **~ өвс** *бот.* осока, **~ сахал** *бот.* луговой хвощ
ӨЛСГӨЛӨН голод, голодание, голодовка, голодный, голодающий, **~ зуд** бескормица, голод, **~гөөр үхэх** умирать от голода/с голоду, **~ зарлах** объявлять голодовку, **~ байх/болох** испытывать голод, голодать
ӨЛСГӨХ заставлять голодать, морить голодом
ӨЛСӨӨХ *побуд. от* **өлсөх**, доводить до голода, заставлять голодать, **~ж зовоох** морить голодом
ӨЛСӨХ голодать, быть голодным, проголодаться, **би ~ж байна** я голоден/проголодался, **~ж үхэх** умирать от голода/с голоду
ӨЛХӨН 1. свободно, вольно, достаточно, более чем достаточно, довольно легко, достаточно быстро, **энэ ажлыг бид хугацаанд нь ~ дуусгана** мы закончим эту работу довольно быстро/легко в срок
ӨЛХӨН 2. *уменьш. от* **өлөн**, 1) голодноватый, немного голодный, 2) *перен.* недо-, недостаточно, неполностью, **~ унтах** недоспать, не выспаться
ӨЛЧИР выносливый к морозу, морозостойкий, холодостойкий, не боящийся холода, **~ хүн** человек, который не боится холодов/хорошо переносит мороз
ӨМ *усилительная частица, обозначающая что-либо оторванное от целого или процесс отделения части от целого* **~ цөм** оторванный кусками, что-либо оторванное, **~ татах** отрывать кусками, **~ хазах** откусывать зубами, **~ цохих** выбивать, отламывать
ӨМБҮҮ «му!» мычание коровы
ӨМГӨӨЛӨГЧ 1) защитник, заступник, адвокат, 2) защита, **хэрэгтний ~** защитник подсудимого, **~ийн коллеги** коллегия адвокатов, **~ болох** а) стать адвокатом, б) заступиться за кого-либо, быть защитником кого-либо, **~дийн пүүс** адвокатская фирма, **~өөс татгалзах** отказываться от адвоката, дать отвод адвокату
ӨМГӨӨЛӨЛ адвокатская защита, защита, заступничество, адвокатура, **~дөө авах** взять под свою защиту
ӨМГӨӨЛӨХ защищать, заступиться, адвокатствовать, **~ коллеги** коллегия адвокатов
ӨМГӨӨЛҮҮЛЭХ: **~ эрх** право на защиту
ӨМГӨР очень маленький, ничтожно малый, **~ гэр** слишком маленькая юрта, **~ сав** слишком маленькая посуда, **~ загал** малоротые, микростомовые (вид рыбы)
СЭЖИГТЭЙ 1) сомнительный, подозрительный, 2) сомнительно, подозрительно, с подозрением, с сомнением, **~ хүн** подозрительный человек, сомнительная личность, **~ харах** смотреть с подозрением, **~ болгох** ставить под сомнение
СЭЖИГТЭН подозреваемый, **~ийг саатуулах** задержание подозреваемого
СЭЖИГЧ мнительный, брезгливый
СЭЖИХ поддеть рогами, боднуть одним рогом, мотать головой
СЭЖҮҮР конец, край, кромка
СЭЛБҮҮР весло, **~ хөлтөн** ластоногие
СЭЛБЭГ 1) запас, резерв, замена, 2) запасной, запасный, **~ хэрэгсэл** запасные части
СЭЛБЭЛЗЭХ смотреть большими (круглыми) глазами
СЭЛБЭХ 1) чинить, ремонтировать, исправлять, **~н засах** восстанавливать, 2) прибавлять жидкость в посуде, 3) **цус ~** улучшать кровь, породу
СЭЛГҮҮЦЭХ бродить, прогуливаться, странствовать, бездельничать, **гудамжаар ~** бродить по улицам, **гадуур ~** бездельничать
СЭЛГЭХ менять, сменять, переменять, чередоваться, **хувцас ~** менять одежду, переодеваться
СЭЛГЭЦ замена, смена
СЭЛГЭЭ запас, ротация, **~ үйлдэл** *муз.* переменные функции, **~ эгшиглэгээ** переменные лады
СЭЛДИЙ половой член жеребца
СЭЛҮҮН свободный, безлюдный, **хүнгүй ~ газар** безлюдная местность, **~ гудамж** безлюдная улица, **өнөөдөр ажил ~ байна** сегодня мало работы
СЭЛҮҮР весло, вёсла, **~ээр сэлүүрдэх** грести вёслами
СЭЛҮҮРДЭХ грести (веслом)
СЭЛҮҮРЧ гребец
СЭЛЭМ меч, шашка, сабля, **хатан болд ~** *фольк.* булатный меч, **~ далайх** размахивать саблей/мечом, **хурц ~** острый меч, **~ээр цавчих** разрубить мечом, **~ гаргах** обнажить меч
СЭЛЭМДЭХ рубить шашкой, рубить мечом
СЭЛЭХ 1. плавать, плыть, **урсгал сөрөн ~** плыть против течения, **урсгал даган ~** плыть по течению, **тэр сайн ~дэг** он хорошо плавает
СЭЛЭХ 2. сменять, переменять, чередовать, делать что-либо попеременно, **хувцас ~** менять одежду, переодеваться, **нутаг ~** перекочевать на другое место/пастбище
СЭМ тихо, крадучись, осторожно, тайком, незаметно, втихомолку, **~ чагнах** подслушивать, **~ харах** подсматривать, **~ гарах** выйти тихонько, **~ отох** тайком подкарауливать, подстерегать, **~ хуйвалдах** а) тайный заговор, б) тайно договариваться, тайком соглашаться, **~ томилох** кооптировать
СЭМБЭГЭР 1) мягкий, пушистый, рассыпчатый, рыхлый, 2) чистоплотный, опрятный, 3) жеманный, манерный
СЭМБЭЛЗЭХ двигаться жеманно, манерно
СЭМГЭР тонкий, прозрачный, ажурный, **~ үүл** перистые облака, **~ даавуу** прозрачная ткань
СЭМЖ (ин) 1) *анат.* сальник, жировой покров брюшины, 2) перистый, **~ үүл** перистые облака
СЭМЖЛЭХ жиреть, толстеть, **шар ~** седина в бороду, а бес в ребро
СЭМЛЭХ распускать, вытаскивать нитки, делать более редким (ткань), прореживать ткань
СЭМРЭХ распускаться, изнашиваться, обиваться, рваться (о материи при ношении), **олон жил өмссөн торго ~ч байна** шёлк от долгой носки сечётся
СЭМХЭН *уменьш. от* **сэм**, тихонько, потихоньку, тайно, по секрету, **эндээс ~ яваад өгье** уедем отсюда потихоньку, **~ шивнэлдэх** тайком шептаться
СЭМЭРХИЙ секущийся по нитке, расползавшийся, разорвавшийся, **~ даавуу** секущаяся по нитке ткань/материя
СЭМЭЭР тихо, тайком, украдкой, исподтишка, незаметно, **~ хийх** действовать исподтишка, делать украдкой, **сэм ~ хэлж өгөх** незаметно подсказывать
СЭМЭЭРХЭН тихо, незаметно, украдкой, тайком, **~ дөхөж очих** незаметно подойти, незаметно подкраться сзади, **~ авах** взять тайком
СЭНГЭНЭХ 1) обдавать дуновением, прохладой, 2) издавать приятный запах, **зөөлөн салхи ~ж байв** веял лёгкий ветер, **цонхоор ~нэ** дует от окна, **хүдрийн заар түүнд ~н үнэртэв** сильный запах мускуса обдал его, **~сэн үнэр** аромат, душистый запах
СЭНДИЙЛЭГЧ разрыхлитель
СЭНДИЙЛЭЛТ разрыхление, **хөрс ~** разрыхление почвы
СЭНДИЙЛЭХ разрыхлять, делать рыхлым, подрывать, **хөрс ~** разрыхлить землю, **доогуур нь ~** подрывать землю под чем-либо

СЭНДЛЭХ копать, разрывать, разрыхлять, рыхлить
СЭНДЧИХ вскапывать, делать рыхлым, **гахай газар ~нэ** свинья роет землю
СЭНЖ дужка, ручка, ушко, **хувингийн ~** ведерная дужка, **дөрөөний ~** ушко у стремени, **~тэй аяга** кружка, **~гүй аяга** чашка без ручки, **~ барнул** *парн.* ручка, рукоятка, крючок
СЭНЖЛЭХ приделать ушко/петлю, продырявить
СЭНС 1. винт, вентилятор, пропеллер, **усан онгоцны ~** пароходный винт, **~ээр салхи оруулах, ~ээр салхилуулах** вентилировать, **цахилгаан ~** электрический вентилятор
СЭНС 2. крупная мерлушка
СЭНСЛЭХ коробиться, кривиться, делать «восьмёрку», **дугуй ~ж байна** колесо делает восьмёрку
СЭНХРҮҮЛЭХ *побуд. от* **сэнхрэх**, убеждать, уговаривать, уверять в чём-нибудь
СЭНХРҮҮЛЭЛ убеждение, уверение
СЭНХРЭЛТ осознание, понимание, разумение
СЭНХРЭХ убеждаться, уверяться, осознавать, понимать, разуметь
СЭР 1.: **~ ~ салхи** лёгкий ветерок, **~ ~ салхилна** слегка веет ветерок, слегка дует
СЭР 2.: **мэр ~** иногда, изредка, кое-где, *см.* **мэр**
СЭРВИЙХ 1) торчать, топорщиться, подыматься вверх, вздыматься торчком, 2) *перен.* выздоравливаться, **~сэн хадан хясаа** торчащие скалы, **үс нь ~нэ** волосы у него торчат, **сэхэх ~** *парн.* поправляться, выздороветь
СЭРВЭГНҮҮЛЭХ *побуд. от* **сэрвэгнэх**, 1) качать, колыхать, колебать, 2) заставлять перхать, вызывать перхоту, 3) раздражать, вызывать раздражение
СЭРВЭГНЭХ 1) слегка качаться, чуть колыхаться, 2) слегка дуть, веять, 3) першить, перхать, ощущать щекотание в горле, 4) быть раздражительным, оказываться вспыльчивым, **модны навч салхинд ~нэ** ветер колышет листья дерева, **салхи ~ж байна** у меня в горле першит, **~сэн хачин хүн** странный, раздражительный человек
СЭРВЭГЭР торчащий, гребневидный, **уулсын ~ орой** гребень гор, гребневидные вершины гор
СЭРВЭСХИЙХ 1) неожиданно показаться, вдруг появиться (о торчащем предмете), 2) вздрогнуть, вздрагивать
СЭРГИЙЛЭГЧ милиционер, полицейский
СЭРГИЙЛЭЛТ предупреждение, предостережение, **урьдчилан ~** профилактика
СЭРГИЙЛЭХ оберегаться, остерегаться, предостерегаться, **урьдчилан ~** предостерегать, предупреждать, **урьдчилан ~ арга хэмжээ** предупредительные, профилактические меры, **аюулаас ~** остерегаться опасности, **~ дуудах** вызвать милицию/полицию, **цагдан ~** милиция, полиция
СЭРГЭГ 1) бдительный, осторожный, осмотрительный, 2) бодрствующий, чуткий, 2) сообразительный, находчивый, 4) бдительно, осторожно, осмотрительно, находчиво, чутко, **~ хүн** осмотрительный человек, находчивый человек, **нойронд ~ байх, ~ унтах** спать чутким/лёгким сном
СЭРГЭЛТ 1) возрождение, возобновление, воскресение, 2) *геол.* регенерация
СЭРГЭЛЭН бодрый, живой, весёлый, 2) сообразительный, умный, находчивый, проницательный, ловкий
СЭРГЭЛЭНДЭХ быть слишком весёлым и умным
СЭРГЭМЖ бдительность, осторожность, **сонор ~** *парн.* осторожность, предусмотрительность, **~ бүхий байх хэрэгтэй** надо быть бдительным, надо соблюдать осторожность
СЭРГЭМЖГҮЙ неосторожный, небдительный, невнимательный
СЭРГЭМЖЛЭЛ предостережение, бдительность, предосторожность
СЭРГЭМЖЛЭХ предостерегаться, остерегаться, быть бдительным, проявлять осторожность, соблюдать бдительность, **аюулаас ~** предостерегаться от опасности
СЭРГЭМЖТЭЙ 1) осмотрительный, бдительный, внимательный, 2) осмотрительно, бдительно, внимательно, **ямагт ~ байх** сохранять постоянную бдительность, **гудамж замаар гарахдаа ~ яваарай** будьте осторожны при переходе через улицу
СЭРГЭХ пробуждаться, оживляться, бодрствовать, воспрянуть духом, возрождаться, возобновляться, **нойр ~** очнуться от сна, пробуждаться, проснуться, **ардчилал ил тодын нөхцөлд хүмүүсийн улс төрийн идэвхи ихээхэн ~ж байна** в условиях демократии и гласности значительно оживляется политическая активность людей, **хавар болохоор газар дэлхий ~дэг** весной вся земля пробуждается, **ажил дахиад ~в** работа снова возобновилась, **ухаан алдаад ~** приходить в чувство после обморока, **~н талсжилт** рекристализация, **~н мандалтын үеийн уран зохиол** литература Эпохи Возрождения, ренессансная литература
СЭРГЭЭЛТ возобновление, восстановление, реставрация
СЭРГЭЭГДЭХ: ~ эрчим хүч возобновляемые источники энергии
СЭРГЭЭХ 1) пробуждать, будить, возбуждать, 2) восстанавливать, возобновлять, реставрировать, **нойроо ~** прогонять сон, разгонять дремоту, **уйтгараа ~** прогнать скуку, развлекаться, **аж ахуйгаа ~** восстанавливать хозяйство, **хэлэлцээрийг/дипломат харилцааг ~** возобновлять переговоры/дипломатические отношения, **хичээлээ ~** возобновлять занятия, **толгойгоо ~** освежить голову, **мартсаныг ~** возобновлять забытое, вспомнить забытое, **шударга ёсыг ~** восстановить/возродить справедливость, **зураг ~н шинэтгэх** реставрировать картину
СЭРГЭЭШ допинг, возбудитель
СЭРДЛЭГ подозрение, сомнение, недоверие, **хардлага ~** *парн.* опасение, подозрение, недоверие
СЭРДХИЙХ вздрогнуть, замереть, вызвать подозрение
СЭРДЭГДЭХ *страд. от* **сэрдэх**, быть подозреваемым, подозреваться, **хулгайд ~** подозреваться в краже
СЭРДЭХ подозревать, недоверять, предполагать, думать, **хардах ~** *парн.* иметь на кого-либо подозрение, **гэмгүй хүнийг хардаж ~** подозревать невинного человека, **хулгайд хардаж ~** подозревать в краже
СЭРЖИГНЭХ 1) веять, слегка дуть, 2) шелестеть, дрожать, трепетать
СЭРСХИЙХ вздрогнуть, вздрагивать
СЭРТВЭЛЗЭХ кокетничать, кривляться, ломаться
СЭРТГЭР торчащий, оттопыренный, торчком, **~ чихтэй адуу** лошадь с оттопыренными ушами, **~ эвэр** торчащие рога
СЭРТИЙЛГЭХ *побуд. от* **сэртийх**, делать торчащим, ставить торчком, **чихээ ~** навострить уши, настораживать уши (напр. о лошади, собаке)
СЭРТИЙХ оттопыриваться, торчать (об ушах), стать торчащим
СЭРТЭГНҮҮЛЭХ *побуд. от* **сэртэгнэх**, напрягать уши, настораживать, **морь тургин чихээ ~нэ** конь фыркает и настороженно прядет ушами
СЭРТЭГНЭХ 1) шевелить/водить настороженными ушами, настороженно прясть ушами, оттопыриваться (об ушах), 2) кокетничать
СЭРТЭЛЗЭХ 1) шевелить, двигать чем-либо торчащим, 2) *перен.* жеманничать, кривляться, быть легкомысленным
СЭРҮҮ прохлада, свежесть, **оройн ~ оров** наступила вечерняя прохлада, **намрын ~ орох** наступать (об осенних холодах), **~**

оруулах а) ждать наступление прохлады, б) ждать наступление зимы, **нуурын зүгээс ~ татаж байна** с озера веет прохлада

СЭРҮҮВТЭР 1) холодноватый, довольно прохладный, 2) холодновато, довольно прохладно, **~ өглөө** довольно прохладное утро

СЭРҮҮДҮҮЛЭХ *побуд. от* **сэрүүдэх**, делать более прохладным, слишком прохлаждать, сильно проветривать

СЭРҮҮДЭХ оказываться более прохладным, свежеть, прохлаждаться

СЭРҮҮЛЭГ звон, **цагийн ~** звон часов, часы со звоном, **~тэй цаг** будильник, **~ тавих** завести будильник, установить стрелку будильника на определённый час

СЭРҮҮН 1. 1) прохладный, свежий, 2) прохладно, свежо, **~ салхи** свежий ветер, **орой тийшээ ~ болов** к вечеру стало прохладно, **~ ундаа** прохладительные напитки

СЭРҮҮН 2. неспящий, бодрствующий, **чи ~ байна уу?** ты не спишь? **би зөндөө удаан ~ хэвтэв** я долго не мог заснуть, **~ байх** бдеть, бодрствовать

СЭРҮҮХЭН *уменьш. от* **сэрүүн**, 1) свеженький, прохладненький, довольно прохладный, 2) довольно прохладно, **~ орой** прохладный вечер, **гадаа ~ байна** на улице свежо/прохладно

СЭРҮҮЦҮҮЛЭХ *побуд. от* **сэрүүцэх**, освежать, охлаждать, проветривать

СЭРҮҮЦЭХ освежаться, охлаждаться, проветриваться, **бөгчим өрөөнөөс ~зэр гарт дээр гарах** выйти из душной комнаты прохладиться на балкон, **гадаа ~** проветриваться на улице

СЭРШГҮЙ непробудный, **~гээр унтах** погрузиться в непробудный сон, спать непробудным сном

СЭРЭВГЭР раскидистый, торчащий

СЭРЭЛ: **~ (өгөх)** возбуждение

СЭРЭМЖ бдительность, осторожность, **сонор ~ээ дээшлүүлэх** повысить бдительность

СЭРЭМЖГҮЙ неосторожный, невнимательный, небдительный, **~ байснаас ийм хэрэг боллоо** это случилось из-за неосторожности

СЭРЭМЖЛЭЛ предостережение, бдительность

СЭРЭМЖЛЭХ быть бдительным, оказываться осмотрительным, быть начеку, проявлять бдительность

СЭРЭМЖТЭЙ бдительный, осмотрительный, внимательный, чуткий, **юмыг яаж мэдэх вэ! ~ байгаарай!** мало ли, будьте осторожны!

СЭРЭХ просыпаться, пробуждаться, бодрствовать, **нойрноос ~** очнуться от сна, **~гүй унтах** спать без просыпу, уснуть крепко, **хөөе! ~ээрэй! ~ээрэй!** проснись! вставай!

СЭРЭХҮЙ ощущение, чувство

СЭРЭЭ вилка, **~гээр хоол идэх** есть вилкой

СЭРЭЭДЭХ брать вилкой, поддеть вилкой, бить острогою

СЭРЭЭХ будить, разбудить, пробудить, **хүүхэд ~** будить ребёнка, **нойр ~** разгонять сон, **намайг эрт ~гээрэй** разбудите меня рано, **хүүхэд саяхан унтсан, биттий ~чихээрэй** ребёнок только уснул, смотри, не разбуди

СЭТ *усилительная частица* насквозь, напролёт, пере-, про-, вы-, **~ цохих** выбить, отбить, пробить, **~ татах** выдернуть, **~ малтах** вырыть, **~ огтлох** прорезать, вырезать

СЭТГҮҮЛ 1) журнал, 2) журнальный, **~ийн дугаар** номер журнала, **~ийн өгүүлэл** журнальная статья, **зураг ~** иллюстрированный журнал, **сар тутмын ~** ежемесячный журнал, **~зүй** журналистика, **~ийн тойм** журнальный обзор, обзор журнала, **~ийн ерөнхий эрхлэгч** главный редактор журнала

СЭТГҮҮЛЧ журналист, **нэртэй ~** известный журналист, **олон улсын ~** журналист-международник

СЭТГЭГДЭЛ впечатление, **~ төрүүлэх** произвести впечатление, **хүүхэд насны ~** впечатление детства, **аятай ~** приятные впечатления, **Монгол орны тухай ~** впечатления о Монголии

СЭТГЭГДЭХ *страд. от* **сэтгэх**, мыслиться, думаться, представляться

СЭТГЭГЧ мыслитель, ум, **эртний Энэтхэгийн их ~** великий древнеиндийский мыслитель

СЭТГЭЛ мысль, дума, сердце, душа, психика, **энэрэнгүй, нинжин ~** гуманность, человеколюбие, **сайхан ~** добродушие, **хатуу ~** строгий нрав, **зөөлөн ~** мягкое сердце, **~ хөдлөх/догдлох** взволноваться, **~ хөдөлгөх/догдлуулах** волновать, возбуждать, **~ баясах** радоваться, **~ булаах/татах** чаровать, привлекать к себе сердце, покорить сердце, **~ зовох** беспокоиться, заботиться, **~ ханах** удовлетворяться, удовольствоваться, быть довольным, **~ уярах** быть тронутым, растрогаться, **~ уймрах/үймэх** расстариваться, беспокоиться, быть рассеянным, **~ мэдрэл нь сарнисан** психическое расстройство, **~ саная цочрон балмагдах** душевное волнение, состояние аффекта, **~ гутрах** разочаровываться, огорчаться, **~д таарах/зохих** нравиться, **энэ таны ~д таарч байна уу?** нравится ли это вам? **~ тайтгаруулах** успокаивать, **~ түгших** тревожиться, беспокоиться, **~ татмаар/булаамаар** очаровательный, привлекательный, пленительный, **~ийн хөдөлгөөн** эмоция, **~ийн зовлон** душевное страдание, беспокойство, **~ийн амраг** возлюбленный, возлюбленная, **~ харамгүй тусламж** бескорыстная помощь, **чин ~ийн угаас** от всей души, от чистого сердца, **~тэй болох** влюбляться, **~ийн хоймрыг эзлэх** быть любимым, **~ийн хөдөлгөөн ихтэй** душевнопорывистый, **~ судлал** психология, **~ дүрслэх арга (дэг)** *муз.* импрессионизм

СЭТГЭЛГЭЭ рассуждение, мышление, размышление, мысль, **шинэ ~** новое мышление

СЭТГЭЛЧЛЭН по желанию, согласно желанию

СЭТГЭМЖ мысль, идея, воображение, фантазия, **уран ~** фантастика, **уран ~ийн зохиол** фантастическая литература

СЭТГЭХ мыслить, рассуждать, разуметь, думать, размышлять, представлять в мысли/мысленно, **~ чадвар** способность рассуждать/мыслить, **зөв ~** правильно мыслить, **хурдан ~** бегло рассуждать, быстро мыслить, **та муугүй ~ж байна** вы неплохо рассуждаете

СЭТГЭХҮЙ мышление, **хэл ~ хоёрын харилцаа** взаимодействие языка и мышления, **ухамсар ~ хоёр** сознание и мышление

СЭТГЭЦ психика, психология, **эрүүл ~** здоровая психика, **хүүхдийн ~** детская психология, **уран чадварын ~** психология творческой способности, **~ийн байдал** психическое состояние

СЭТГЭШГҮЙ 1) немыслимый, невозможный, невероятный, невообразимый, 2) немыслимо, невообразимо, невозможно, невероятно

СЭТГЭЛТ прорыв, пролом, прорез, разрыв

СЭТЛЭХ отбивать, отламывать (о крае посуды), прорывать, проламывать, надрезать, **дайсны хамгаалалтын шугамыг ~** прорвать линию обороны противника, **ус далангаа ~в** вода прорвала плотину, **аяганы амсар ~** отбить/отломить край чашки

СЭТРЭХ отбиваться, отламываться, прорываться, разрываться

СЭТЭР ленты, повязываемые скоту, предназначенному для заклания, **~ зүүлгэх** *ирон.* присваивать пустое звание, **~тэй мал** скот для заклания, в угоду духам

СЭТЭРХИЙ 1) надрыв, надрез, прорез, вырез, выемка, 2) разрезанный, разорванный, **~ гаргах** сделать надрез/выемку, **~ аяга** чашка с отбитыми краями, **~ уруул** заячья губа, **~ имтэй чих** разрезанное ухо (как метка у овец и коз)

СЭХЛҮҮН довольный собой, самодовольный, горделивый, **~ зан** самодурство, самодовольство, самодовольный характер

СЭХҮҮН самодовольный, горделивый, ~ **зантай** хїн гордец

СЭХЭЛ 1) улучшение, возрождение, 2) выздоровление, 3) приход в сознание, ~ **авах** а) улучшаться, б) выздороветь, 3) приходить в себя

СЭХЭХ 1) улучшаться, возрождаться, возобновляться, 2) выздоравливать, реанимироваться, 3) приходить в сознание, **муужирч унаад** ~ приходить в себя после обморока

СЭХЭЭ 1) ум, разум, сознание, 2) сообразительность, находчивость, догадливость, ~ **авах** осознавать, догадываться, сообразить, ~ **орох** вспомниться, начинать осознавать, ~ **сайтай** сообразительный, находчивый, ~ **муутай** несообразительный, недогадливый

СЭХЭЭВЧ беседка, **цэцэрлэг доторх** ~ беседка в саду, **~нд суугаад ярилцах** сидеть в беседке и разговаривать

СЭХЭЭГҮЙ несообразительный, ненаходчивый, недогадливый

СЭХЭЭРЭЛ осознание, понимание

СЭХЭЭРЭХ осознавать, понимать, разуметь, опомниться, **бурууга** ~ осознавать свою вину

СЭХЭЭТЭЙ сообразительный, находчивый, догадливый

СЭХЭЭТЭН *интеллигент, интеллигенция*

СЭХЭЭХ *побуд. от* **сэхэх**, *оживить, оживлять*, воскрещать, воскресать, возрождать, возобновлять, реанимировать, **~н амьдруулах** а) реанимация, б) реанимировать, **~н амьдруулах тасаг** реанимационное отделение

СЭЦЭН мудрый, проникнутый мудростью

СЭЦЭРХҮҮ привыкший мудрствовать, любящий мудрствовать

СЭЦЭРХЭХ мудрствовать, умничать, философствовать

СЭЭР *анат.* грудная часть позвоночника, ~ **нуруугүйтэн** беспозвоночные

СЭЭТГЭР 1) легкомысленный, кокетливый, манерный, 2) высокомерный

СЭЭТЭГ *сетка в волейболе, настольном теннисе*

СЭЭТЭГНҮҮР жеманный, манерный, ветреный, легкомысленный, ~ **зан** манерность, жеманство, ~ **ам** жеманница, кокетка

СЭЭТЭГНЭХ кокетничать, манерничать, вести себя легкомысленно

СЭЭТЭН флирт, ~ **хаях** кокетничать, стрелять глазами

СЭЭХЭЛЗҮҮР хвастливый, ветреный, легкомысленный

СЭЭХЭЛЗЭХ быть легкомысленным, оказываться ветреным, манерничать

Т

ТА вы, **~ нар** вы, **~ бүгд, ~ бүхэн** вы все, **~ хоёр** вы оба, **~ бид хоёр** мы с вами, **би ~ныг танина** я вас знаю, мы с вами знакомы, **~нтай уулзмаар байна** хочется с вами встретиться/увидеться

ТААВААР (аа) спокойно, не торопясь, по желанию, **~ ажиллах** работать не торопясь, работать по своему усмотрению/желанию, **~ явах** идти/ехать не торопясь

ТААВАР догадка, предположение, загадка, отгадка, разгадка, **энэ бол ~ төдий юм** это всего лишь догадка, **~ гаргах** строить предположение, **~ таах** отгадать загадку

ТААВАРЛАХ предполагать, загадывать, отгадывать, разгадывать

ТААВЧИК *разг.* тапочки

ТААГДАХ *побуд. от* **таах**, быть разгаданным, отгадываться, загадываться

ТААГДАШГҮЙ загадочный, необъяснимый, таинственный, не поддающийся разгадке, **~ үзэгдэл** загадочное явление, **~ оньсого** не поддающаяся разгадке загадка, необъяснимая загадка

ТААГҮЙ 1. неудобный, неприятный, неподходящий, неудобно, неприятно, **энд над тун ~ байна** здесь мне очень неудобно, **тун ~ юм боллоо** случилось что-то очень неприятное

ТААГҮЙ 2. не нравиться, недолюбливать, чувствовать неприязнь к кому-либо, **тэр чамд ~ байдаг** он тебе не нравится

ТААДАЙХ быть низкорослым, быть коротким

ТААДГАР короткий, низкорослый, низкого роста, **~ цув** короткий плащ, **~ хүн** коротыш, приземистый человек

ТААЗ кровля, потолок, **өндөр ~тай** с высоким потолком, **суудлын ~** *геол.* кровля жилы

ТААЛАГДАХ *страд. от* **таалах**, нравиться, быть ласкаемым, соответствовать чьему-нибудь вкусу, **хүүхэнд ~** нравиться девушке

ТААЛАЛ благоволение, воля, желание, **~д нийцэх/нийлэх** удовлетворять чьему-либо благоволению/желанию, **таны ~аар болтугай** пусть будет по вашей воле/по вашему желанию, **~ барах, ~ төгсөх** скончаться

ТААЛАМЖ удовольствие, удовлетворение, (о высших духовных и светских лицах), благоприятность, ласка

ТААЛАМЖГҮЙ неприятный, неблагоприятный, непристойный, противный, неприятно, непристойно, противно, **тааламжгүй үнэр** неприятный запах, **цаг агаарын ~ нөхцөл** неблагоприятные погодные условия

ТААЛАМЖТАЙ удобный, приятный, удовлетворённый, довольный, симпатичный, **инээхэн ~таар** с большим удовольствием, **~ инээмсэглэл** приятная улыбка, **~ санагдах** казаться приятным

ТААЛАХ ласкать, нежить, любить, **үнсэж ~** целовать, **илж ~** гладить и ласкать, **хүүхдээ энхрийлж ~** ласкать ребёнка

ТААЛГАХ *побуд. от* **таах**, давать отгадать, заставлять загадывать, **би чамд нэг оньсого ~ая** я тебе загадаю одну загадку

ТААЛЦАХ *совм. от* **таах**, загадывать друг другу, взаимно отгадывать, **бодсоноо ~** угадывать мысли друг друга, **таавар ~** загадывать друг другу загадки

ТААМАГ 1) загадочный, предположительный, таинственный, априорный, 2) предположение, прогноз, догадка, **~аар** наугад, на авось, **~аар ярих** говорить наугад, **~.төдий мэдэх** представлять лишь априорно

ТААМАГЛАЛ предположение, домысел, догадка, допущение, гипотеза, версия, **~ гаргах** строить гипотезу, сделать допущение, **шинжлэх ухааны ~д хүрэх** прийти к научному предположению, **~аа илэрхийлэх** высказать предположение, **хоосон ~** пустые домыслы

ТААМАГЛАХ предполагать, догадываться, смутно представлять себе, действовать наугад, **ойролцоогоор ~** приблизительно догадываться, **~н зурах** нарисовать приблизительно

ТААМНАЛ гипотеза, предположение, домысел, допущение, **лугшилтын ~** гипотеза пульсационная, **дэлхийн тэлэлтийн ~** гипотеза расширяющейся земли

ТААМНАХ предполагать, догадываться, строить гипотезы

ТААР дерюга, волосяная дерюга, изделие из дерюги, **~ шуудай** дерюжный мешок, мешок из дерюги

ТААРАЛДАХ встречаться, попадаться, видеться, случаться, натыкаться, **хадаас ~** натыкаться на гвоздь, **бэрхшээлтэй ~** встречаться с трудностями, **гадаа танилтайгаа ~** встречаться со знакомыми на улице

ТААРАМЖ согласие, соответствие, согласованность, годность, пригодность, совместимость, гармония, **гэрийн дотор ~аар муу болох/байх** иметь проблемы в семье, не ладить в семье

ТААРАМЖГҮЙ неблагоприятный, невыгодный, неподходящий, непригодный, несоответствующий, неприемлемый

ТААРАМЖТАЙ годный, приемлемый, подходящий, соответствующий, удобный, приятный

ТААРАХ 1) соответствовать, годиться, подходить, 2) совпадать, 3) встречаться, 4) нравиться, **байдалд ~** соответствовать обстановке, **ингэж ~гүй** так поступать не следует, так не годится, **санаанд ~** приходиться по душе, **тэдний аяш зан ~сангүй** они не сошлись характерами, **гэрч нарын мэдүүлэг ~ч байна** показания свидетелей совпали, **энэ түлхүүр цоожинд яг ~ч байна** этот ключ как раз подходит к замку

ТААРУУ 1) вполне соответствующий, вполне годный, подходящий, 2) посредственный, заурядный, неважный, **бие ~ байх** неважно себя чувствовать

ТААРУУЛАХ приводить в соответствие с чем-либо, приспосабливать, прилаживать, подгонять, настраивать

ТААТАЙ приятный, благоприятный, годный, подходящий, **~ нөхцөл** благоприятные условия, **харахад ~** приятный на вид, **~ хэтийн төлөв** благоприятные перспективы

ТААХ 1) отгадывать, разгадывать, предполагать, 2) предсказывать, предугадывать, **оньсого ~** отгадывать загадку, **хүний санааг ~ж мэдэх** предугадывать чьи-либо намерения, **ирээдүйгээ ~ж мэдэх** предсказывать будущее, загадывать вперёд, **худлаа ~ж ярих** говорить наугад

ТААШААГДАХ *побуд. от* **таашаах**, нравиться, получать одобрение, поощряться, **энэ ном бидэнд ~в** эта книга нам понравилась

ТААШААЛ удовольствие, лепота, приятное впечатление

ТААШААХ 1) нравиться, производить хорошее впечатление, 2) одобрять, поощрять, отзываться с похвалой, испытывать удовольствие, **бүгд хурлын шийдвэрийг ~** одобрять решение пленума, **бид чамайг ~ж байна** мы по-хорошему отзываемся о тебе

ТАВ 1. спокойствие, покой, удовольствие, уют, **~ тух** покой, **~ тухыг алдуулах** нарушать покой, **~ алдах** не знать покой, не иметь покоя, чувствовать себя неудобно, становиться неуютным, **~аа ханах** злорадствовать, тешить самолюбие

ТАВ 2.: **хадаасны ~** шляпка гвоздя, головка, бляха

ТАВ 3.: **~ гэзэг** чуб, хохол

ТАВ (ан) пять, **~н удаа** пять раз, пятикратно, **~н жилийн төлөвлөгөө** пятилетний план, **~н давхар байшин** пятиэтажный

дом, **~н хошуу** пятиконечная звезда, **~н хошуу мал** пять видов скота, **~н цул** пять паренхиматозных органов, **~н засал** пять основных методов традиционной монгольской медицины, **~н/~тын мөнгө** пятак, **~н өрөг** *муз.* пентахорд, **~н өдрийн дотор** в пятидневный срок, за пять дней, **~ны өдөр** пятое *число*, **~ны нэг** одна пятая, **~н хувьт хэмжээ** пятидольный размер, **~н эгшигт/таван хөгт** *муз.* пентатоника, **шалгалтанд ~ авах** получить пять на экзамене, **оюутанд ~ тавих** поставить студенту пять/отлично, **~н салаа боов өгөх** дать оплеуху, дать «леща», **~н тэрэгний орд** созвездие возничий

ТАВААД по пять, около пяти, приблизительно пять

ТАВААР товар, **бараа ~** товары, **~ын эргэлт** товарооборот, **~ мөнгөний харилцаа** товарно-денежные отношения, **жижиг ~ын үйлдвэрлэл** *производство мелких товаров*

ТАВАГ 1. блюдо, тарелка, чашка, **аяга ~** посуда, **шөлний ~** глубокая тарелка, **жижиг ~** хлебница, маленькая тарелка, **нисдэг ~** летающая тарелка, **хоолны ~** большая тарелка, **жигнүүрийн ~** чаша/чашка весов, **пял ~** мелкая тарелка, плоская тарелка, **зуушны ~** десертная тарелка, **шаазан ~** фарфоровая тарелка, **модон ~** деревянная миска, **~тай шөл** тарелка супа, **~ийн ёроол** дно блюда, **~ тавих** *предпонести тарелку с угощениями*

ТАВАГ 2. стопа, ступня, лапа, **хөлийн ~** ступня ноги

ТАВАГЛАХ 1. класть в тарелки, наливать в тарелки, **шөл ~** наливать суп в тарелку

ТАВАГЛАХ 2. привязывать за ногу, **тэмээ ~** привязывать верблюда за ногу

ТАВАНТАА пять раз

ТАВАРГАХ скакать верхом на верблюде

ТАВГҮЙ 1) неудобный, неподходящий, неуютный, 2) плохо, неважно, **~ цагаар/үеэр ирэх** приходить в неподходящее время, выбрать неудобное время, **бие ~ байх** чувствовать себя неважно

ТАВГҮЙДЭХ оказываться слишком неудобным, стать не очень уютным, быть неподходящим

ТАВГҮЙРХЭХ вести себя не очень вежливо, быть недовольным, проявлять нежелание, чувствовать себя плохо

ТАВГҮЙТЭЛ дискомфорт

ТАВ ДАХЬ *пятый по счёту*, **~ өдөр** *пятница*

ТАВДУГААР пятый, **~ сар** май, **~ эгнээ** пятый ряд

ТАВИАД 1) около пятидесяти, приблизительно пятьдесят, 2) по пятьдесят, **~ оны эхээр** в начале пятидесятых годов

ТАВИГДАХ *страд. от* **тавих**, ставиться, быть поставленным перед кем-, чем-либо, стоять перед кем-, чем-нибудь, освобождаться, выпускаться, быть выпущенным, освобождённым, **шоронгоос ~** освобождаться *из тюрьмы*

ТАВИГЧ ставящий, кладущий, **үндсийг ~** основатель, **эх суурийг ~** начинатель, зачинатель, зачинщик, **үндэс суурийг ~** основоположник

ТАВИЛ 1) партия, 2) обстановка, мебелировка, **шатрын ~** партия в шахматы, **бид хэдэн ~ тоглов** мы сыграли несколько партий в шахматы

ТАВИЛАН 1. судьба, участь, фортуна, преодоление, **хувь ~** *парн.* жизненный путь, судьбина, **хувь ~даа захирагдах** подчиняться своей судьбе

ТАВИЛАН 2. брод, переправа

ТАВИЛГА: гэрийн ~ мебель, **~ын дэлгүүр** мебельный магазин

ТАВИН: барин ~ а) в свободное время, на досуге, б) явно, открыто, точно, **би энэ дээлийг барин ~ оёсоор дуусгав** я сшил эту шубу на досуге, **барин ~ худал хэлэх** а) явная ложь, б) явно говорить ложь, **барин ~ мэдэх** точно знать

ТАВИНТАА *пятьдесят раз*

ТАВИРАХ чувствовать облегчение

ТАВИУ широкий, обширный, свободный, благополучный, мягкий, спокойный, тихий, умеренный, **~ хувцас** широкая, свободная одежда, **уужим ~ нутаг** раздолье, раздольный край, **өн ~ өвөл** благополучная зимовка, мягкая зима, **~н хүн** спокойный человек, **~н өдөр** *тихий день*

ТАВИУР подставка, подпорка, крышка, **номын ~** этажерка, книжная полка, **лааны ~** подставка для свечи, канделябр, **тогооны ~** крышка для котла

ТАВИХ 1. класть, ставить, выставлять, выдвигать, **ширээн дээр ~** положить на стол, **байран дээр нь/байранд нь ~** класть на место, **суурь ~** класть/заложить фундамент, основание, **эгнүүлж ~** *ставить в ряд*, **утас ~** *ставить телефон*, **жин ~** ставить компресс, **бумба ~** ставить банки, **шаардлага ~** предъявлять требования, **зорилго ~** ставить цель, **болзол ~** ставить условия, **зам ~ж өгөх** освобождать дорогу, пропускать, **асуулт ~** ставить, задавать вопрос, **асуудал ~** поднимать проблему, **онош ~** ставить диагноз, **анхаарал ~** обращать внимание, **хараал ~** осыпать ругательствами, **ерөөл ~** желать блага, **сахал ~** отпускать бороду, **жүжиг ~** ставить пьесу, **шатар ~** играть в шахматы, **хөзөр ~** играть в карты

ТАВИХ 2. 1) выпускать, освобождать, отпускать, **суллаж ~** освобождать, 2) кончать, спускать, извергать семя, достигать оргазма, **чи тавьсан уу?** ты кончила?

ТАВЛАГ удобный, комфортабельный

ТАВЛАХ 1. злорадствовать, испытывать злорадство, **~н инээх** злорадно улыбаться, **биттий тавла!** не злорадствуй!

ТАВЛАХ 2. устраиваться поудобнее, чувствовать себя уютно, **гэртээ ~н суух** *спокойно сидеть дома*

ТАВРАХ 1) топтать передней ногой (о верблюде), 2) скакать, бежать

ТАВТАЙ удобный, уютный, благоприятный, спокойный, спокойно, благополучно, на досуге, **~ цагтаа** в свободное время, **~ сууж ярилцах** спокойно сидеть и разговаривать, поудобнее располагаться и разговаривать, **~ амрав уу?** хорошо отдохнули? **~ морилно уу!** *добро пожаловать!* **~ өвөлжих** благополучно перезимовать, благополучно проводить зиму

ТАВТИР серьёзность, характер, нрав, поведение, **~ муутай хүн** человек со вздорным характером

ТАВТИРГҮЙ непостоянный, несерьёзный, ветреный, легкомысленный, **~ мал** норовистое животное, **~ хүн** ветреный человек

ТАВУУЛ 1) впятером, всего пятеро, 2) *муз.* квинтет

ТАВХАЙ ступня, лапа, **тэмээний ~** верблюжья нога

ТАВЦАН 1) платформа, 2) арена, 3) пьедестал, 4) палуба, **олон улсын ~** международная арена, **дэлхийн ~ дээр** на мировой арене, **хүндэтгэлийн ~** пьедестал почёта, **онгоцны ~** палуба корабля

ТАВЬ (тавин) пятьдесят, **~н нас** пятьдесят лет, пятидесятилетие, **~н жилийн ой** пятидесятилетие, **тэр ~ шахаж байгаа** ему под пятьдесят

ТАВЬДАХЬ пятидесятый по счёту, **~ шон** пятидесятый по счёту столб

ТАВЬТ: ~ын дэгээр банковский билет стоимостью в пятьдесят денежных единиц

ТАВЬДУГААР пятидесятый, **сайд ~ харшинд суудаг** министр живёт в особняке N 50

ТАГ 1. крышка, **авдрын ~** крышка сундука, **данхны ~** крышка чайника, **авсны ~** крышка гроба

ТАГ 2. совсем, совершенно, абсолютно, **~ сохор** *совершенно слепой*, **~ мартах** совсем забыть, **~ дуугүй/чимээгүй болох** совсем молчать, совершенно ничего не говорить, **~ чиг болох** так и исчезать бесследно, пропадать без вести

ТАГ 3. плоская вершина горы, **~ийн бүслүүр** альпийская зона

ТАГ 4. полка, **номын ~** книжная полка
ТАГАЛЦАГ путы, бабка (лошади)
ТАГДАЙХ быть коротким (об одежде), быть низкорослым, быть низкого роста, низким
ТАГДГАР короткий, низкорослый, низенький, невысокого роста, **~ дээл** короткое дэли, короткая шуба, **~ хүн** низкорослый человек
ТАГЖГАНАХ ходить, двигаться (о человеке невысокого роста)
ТАГЖГАР короткий, низкий
ТАГЖИЙХ быть коротким, низким
ТАГЛАА затычка, пробка, втулка, закупорка для бутылок, крышка, **хувингийн ~** крышка для ведра
ТАГЛАРАХ закупориваться, засоряться, затыкаться
ТАГЛАХ закупоривать, затыкать, закрывать, засорять, **шилийг боглоо-гөөр нь ~** заткнуть бутылку пробкой, **чихээ ~** заткнуть уши, **гараараа нүдээ ~** закрывать глаза рукой, **гал тогооны усны тосгуурыг ~** засорить раковину в кухне
ТАГНАЙ нёбо, **хатуу ~** твёрдое нёбо, **зөөлөн ~** мягкое нёбо
ТАГНАЙШИХ *лингв.* палатализироваться, палатализоваться, **~сан гийгүүлэгч** палатализованные согласные
ТАГНАХ разведывать, шпионить, заниматься разведкой/шпионажем, **~н турших** вести разведовательную деятельность, **~ замаар цуглуулсан мэдээлэл** информация, полученная (получаемая) разведовательным путём
ТАГНУУЛ разведка, шпионаж, разведчик, шпион, агент, шпик, **~ явуулах** высылать разведчика, **~д явах** идти в разведку, **~ үйлдэх** заниматься шпионажем/разведкой, **гадаадын ~** иностранный шпион/агент, **үйлдвэрийн ~** промышленный шпионаж, **~ын алба** разведывательная служба, спецслужба, **~ын ерөнхий газар** главное разведывательное управление, **~ын мэдээ сэлт** разведывательные данные
ТАГНУУЛЧ разведчик, шпион, шпик, **нэртэй ~** известный разведчик, **~ийг баривчлах** арестовать разведчика/шпиона
ТАГТ 1. балкон, веранда, **~тай байшин** дом с балконом
ТАГТ 2. плато
ТАГТАА голубь, **энх тайвны ~** голубь мира
ТАЙВАН 1. 1) мир, спокойствие, покой, тишина, 2) мирный, спокойный, мирно, спокойно, **энх ~ цаг** мирное время, **~ хүн** спокойный человек, **энх ~** мир, **нам ~** тишина, **энх ~ы төлөө тэмцэл** борьба за мир, **энх ~ы бага хурал** мирная конференция, **энх ~аар зохицуулах** мирное урегулирование, **энх ~ч бодлого** мирная политика, **~ байх** быть спокойным, **~ явах** спокойно ходить
ТАЙВАН 2. Тайвань, тайванцы
ТАЙВУУ спокойный, мирный, тихий, **~ зан** спокойный нрав, мирный характер
ТАЙВШРАЛТ успокоение, утихомиривание
ТАЙВШРАХ успокаиваться, униматься, утихомириваться, угомониться, **та тайвшир!** успокойтесь, **олсон амжилтандаа ~** успокаиваться на достигнутом, **хүүхэд ~аад унтлаа** ребёнок унялся и уснул
ТАЙВШРУУЛАХ *побуд. от* **тайвшрах**, успокаивать, унимать, утихомиривать, угомонять, **өвчтөнийг ~** успокоить больного, **бид тэднийг ~ж чадахгүй нь ээ** мы не можем утихомирить их, **хүүхэд ~** унимать ребёнка, **~ эм** успокоительное лекарство
ТАЙГА 1. 1) тайга, горный лес, 2) таёжный, **уул ~, ой ~, хөвч ~** *парн.* дремучая тайга, **~ын ан амьтад** таёжные звери, **~ын ургамал** таёжные растения, **~ын анчин** таёжный охотник
ТАЙГА 2. борзой кобель
ТАЙГАН: ~ хүн евнух, скопец, кастрат
ТАЙЗ сцена, эстрада, **театрын ~** сцена театра, **~ны засал** декорация, **эргэдэг ~** вращающаяся сцена
ТАЙЛАГДАХ открываться, раскрываться, развязываться, распутываться, **уяа/ зангилаа ~лаа** узел распутался
ТАЙЛАГНАХ давать отчёт, подотчётный
ТАЙЛАЛ развязка, развязывание, разгадка, решение, расшифровка, **туужийн үйл явдлын ~** развязка сюжета повести, **үгийн сүлжээний ~** решение кроссворда, **зөв ~** правильная разгадка, **хадны бичээсийн ~** расшифровка наскальных надписей
ТАЙЛАЛТ дешифрование, **зэмсэгт ~** дешифрование инструментальное
ТАЙЛАН отчёт, отчётный, **~ илтгэл** отчётный доклад, **эрдэм шинжилгээний ажлын ~** отчёт о научной работе, **жилийн ~** годовой отчёт, **депутатаас сонгогчдод тавих ~** отчёт депутата перед избирателями, **~ тавих** выступить с отчётом, **~ сонгуулийн хурал** отчётно-выборное собрание, **~гийн хугацаа** отчётный период, **~ шаардсан нэхэмжлэл** иск с требованием отчётности
ТАЙЛАХ 1) развязывать, отвязывать, расстёгивать, расшнуровывать, 2) снимать, раздеваться, 3) разгадывать, разбирать, отгадывать, расшифровывать, 4) открывать, отворять, **зангилаа ~** развязывать узел, **товч ~** расстёгивать пуговицу, **гутлын үдээс ~** расшнуровывать ботинки, **гутал ~** снимать сапоги, **хувцас ~** снимать одежду, раздеваться, **нууц ~** разгадывать тайну, разбирать секрет, **оньсого ~** разгадывать загадку, **хаалга ~** открывать дверь, **нууц түлхүүр ~** расшифровать коды/написанное шифром, **гашуу (н) ~** помянуть
ТАЙЛБАР объяснение, разъяснение, комментарий, толкование, примечание, оговорка, интерпретация, **~ толь** толковый словарь, **үгийн ~** толкование слов, интерпретация слов, **хуулийн ~** толкование законов, **утгын ~** толкование значений, **бодлогын ~** разъяснение задачи, **~ хэрэггүй** не надо объяснения, комментарии излишни, **~ хийх** делать примечание, **~ хийх журам** правила толкования, **тогтворгүй үнийн тухай ~** оговорка о скользящих ценах
ТАЙЛБАРЛАГЧ комментатор, экскурсовод, интерпретатор, гид, **музейн ~** экскурсовод музея
ТАЙЛБАРЛАГДАШГҮЙ необъяснимый, непонятный, непостижимый, **~ оньсого** необъяснимая загадка, **огт ~ явдал** совсем непонятное явление, совершенно необъяснимый случай
ТАЙЛБАРЛАЛ объяснение, комментарий, интерпретация, объяснительное примечание
ТАЙЛБАРЛАЛТГҮЙ не стоит объяснять, не к чему объяснять, **~ аяндаа тодорхой байна** нечего объяснять и так понятно
ТАЙЛБАРЛАХ объяснять, разъяснять, толковать, комментировать, **үгийн утга ~ж өгөх** разъяснять кому-либо значение слова, **хэргийн учрыг ~** разъяснять суть/сущность дела, **сурагчдад бодлого ~** объяснить учащимся задачу, **олон улсын байдлыг ~** комментировать международные события
ТАЙЛБАРЛАШГҮЙ необъяснимый, непонятный
ТАЙЛБАРЛУУЛАХ *побуд. от* **тайлбарлах**, заставлять, объяснить, поручать комментировать, давать возможность разъяснять, **сурагчид мэдэхгүй үгээ багшаар ~в** ученики попросили учителя объяснить незнакомые слова
ТАЙЛБАРЧ (ин) комментатор, толкователь, экскурсовод
ТАЙЛУУЛАХ *побуд. от* **тайлах**, раздевать кого-либо, снимать с кого-либо одежду, разувать кого-либо
ТАЙРАЛТ отсечение, ампутация
ТАЙРАНХАЙ отрезанный, отрубленный, обрезанный, отсечённый, ампутированный
ТАЙРАХ обрезать, отрезать, отрубать, отсекать, ампутировать, **гээг ~** отрезать косу, **олс ~** обрезать верёвку, **сандлын хөл ~** обрезать ножки стула, **сургааг ~** обрубать жердь, **хөл ~** ампутировать ногу

ТАЙРДАС чурка, обрезок, обрубок, отрезок
ТАЙРМАЛ *отрезанный, обрезанный,* **~ гээг** отрезанная коса
ТАЙТГАРАЛ утешение, успокоение
ТАЙТГАРАХ утешаться, успокаиваться, утихомириваться, **битгий уйл! ~ч үз!** не плачь! успокойся!
ТАЙТГАРУУЛАХ *побуд. от* **тайтгарах**, успокаивать, утешать, утихомиривать
ТАЙТГАРШГҮЙ безутешный, **~ уйтгар** безутешная печаль, **~ гуниг зовлон** безутешное горе
ТАЙЧИХ снимать, раздеваться, **~ урлаг** стриптиз
ТАКТИК тактика, **~ийн цөмийн зэвсэг** тактическое ядерное вооружение
ТАКСИ такси, **~ны зогсоол** стоянка такси, **~ийн жолооч** *шофёр* такси, таксист, **~ дуудах/захиалах** вызвать/заказать такси
ТАЛ 1. поле, степь, открытое пространство, **цагаан ~**, хээр ~ степь, равнина, **уудам ~** открытая, *широкая степь*
ТАЛ 2. сторона, место, часть, направление, аспект, грань, **ар/өвөр ~** задняя/передняя сторона, **нүүрэн ~** фасад, **хойд/умард ~** северная сторона, **дээд/доод ~** *верхняя/нижняя* сторона, **гадна/дотно ~** внешняя/внутренняя сторона, **баруун/зүүн ~** правая/левая сторона, **гудамжны нөгөө ~д** по ту сторону улицы, на той стороне *улицы,* **олон ~ын** многосторонний, всесторонний, **нэг ~аар** с одной стороны, **нөгөө ~аар** с другой стороны, **~ бүрээс** с разных сторон, со всех сторон, **~ хувь** дубликат, **асуудлыг олон ~аас нь авч үзэх** рассматривать вопрос со всех сторон, **миний ~аас** с моей стороны, **хэн нэгний ~д орох/байх** становиться на чью-либо сторону, **тэр миний эцгийн ~ын хамаатан** он мой родственник со стороны моего отца, **гурван ~т гэрээ** трёхсторонний договор, **~ тохой татсан гэрч** пристрастный свидетель
ТАЛ 3. половина, **~ сар** полумесяц, **~ хувь** половина, пятьдесят процентов, **замын ~д зогсох** остановиться на полдороге/полпути, **~ хошуутын загас** рыбы-полурылые
ТАЛ 4. друг, приятель, симпатия, **~ харах, ~ тохой татах** быть пристрастным, **~ засах/өгөх** выказывать к кому-либо симпатию, угодничать, **~ өгөх** проявлять учтивость
ТАЛ 5.: **~ тул** *звукоподр.* неясная нечёткая речь, **монголоор ~ тул ярих** плохо говорить по-монгольски
ТАЛААР 1. в отношении, по отношению, относительно, в области, **энэ ~** в этом отношении, **бүх ~** во всех отношениях, **энэ төлөвлөгөөний ~** относительно этого плана
ТАЛААР 2. зря, напрасно, *впустую, бесполезно,* **тэр тийшээ ~ яваад иржээ** он напрасно съездил туда, **~ болох** быть напрасным, быть бесполезным
ТАЛАРХАЛ благодарность, признательность, благодарение, симпатия, расположение, **~ илэрхийлэх** выражать благодарность, **~ дэвшүүлэх/хүргэх** объявить благодарность, **~ын үг** слова благодарности
ТАЛАРХАХ благодарить, проявлять дружелюбие, быть приветливым, оказываться признательным, симпатизировать, **чин сэтгэлээсээ ~** благодарить от всей души, **~н сайшаах** симпатизировать, относиться с симпатией, **~сан харц** признательный взгляд
ТАЛАРХУУ дружески расположенный, дружелюбный, признательный, благодарственный
ТАЛАХ грабить, отнимать силой, разорять, **~ж дээрэмдэх** разбойничать, **гэгээн цагаан өдрөөр ~ж дээрэмдэх** грабить среди бела дня
ТАЛБАЙ 1) площадь, площадка, участок, 2) поле, **төв ~** центральная площадь, **хүүхдийн ~** детская площадка, **биеийн тамирын ~** спортивная площадка, **тариалангийн ~** площадь, поле, пашня, **хүдэржилтийн ~** *площадь* рудоносная, **геосоронзон ~** поле геомагнитное
ТАЛБАР поле, площадь, **байлдааны ~** поле битвы, **барилгын ~** строительная площадь
ТАЛИМААРАХ становиться мягким и нежным (о взгляде)
ТАЛИЙГААЧ 1) покойник, покойница, 2) покойный, умерший
ТАЛИЙХ 1) *исчезать,* удаляться, затеряться, 2) умереть, скончаться
ТАЛЛАХ 1) делить пополам, разделять, **хэд хэд ~** разделить на несколько частей, 2) познакомиться, подружиться
ТАЛОН талон, **хоолны ~** талон на обед, **бензины ~** талон на бензин, **~оор өгөх/олгох** давать/отпускать по талонам
ТАЛСЖИЛТ кристаллизация, **~ын занаршил** кристаллизационная слацеватость
ТАЛСТ 1) кристалл, 2) кристаллический, кристальный, ихэрлэсэн ~ кристалл двойниковый, **~ хэлбэрзүй** кристалломорфология, **~зүй** кристаллография
ТАЛСТАХ кристаллизоваться, делаться кристаллическим
ТАЛХ хлеб, **цагаан/хар ~** белый/чёрный хлеб, **хөх тарианы ~** ржаной хлеб, **гэрийн ~** домашний хлеб, **шинэ /хатсан ~** свежий/чёрствый хлеб, **~ны дэлгүүр** хлебный магазин, **~ны үйлдвэр** хлебозавод, **~ тариа** зерно, **~ны мөнгө олох** зарабатывать себе на хлеб, **зүсэм ~наас нь салгах** лишить кого-либо куска хлеба, **~ барих** печь хлеб, **~ зүсэх** резать хлеб, **загасан ~** продолговатая булка хлеба
ТАМ ад, **~ын орон** ад, **~аа цайх** мучиться, хождение по мукам, адские страдания, **~ын амьтан ~даа жаргалтай арван найман ~** круги ада, **авсан хүн нэг ~тай, алдсан хүн арван ~тай** у взявшего — один круг, у потерявшего — десять кругов ада
ТАМГА 1) печать, штемпель, штамп, 2) туз (в картах), 3) тавро, клеймо, **төрийн ~** государственная печать, **~ дарах** ставить печать, накладывать печать, **~тай байх** носить печать, **бүдэнгийн, гилийн ~** червовый, пиковый туз, **~гаар явах/нүүх** пойти с туза, **гарын үсгийг ~ дарж батлах** удостоверить подпись печатью, **Ерөнхийлөгчийн Тамгын Газар** Канцелярия Администрации Президента, **есөн ~гат тогоо** котёл водоизмещения в) печатей = 45 литров
ТАМГАГҮЙ не имеющий печати, без печати, без штампа, **~ үнэмлэх** удостоверение без печати, **~ бол үнэмлэх хүчингүй** без печати удостоверение недействительно
ТАМГАЛАХ штамповать, ставить печать, наложить печать, метить, клеймить, **тушаал ~** ставить печать на приказ, **цаас ~** штамповать бумагу, **мал ~** клеймить скот
ТАМГАТАЙ имеющий печать, с печатью, за печатью, со штампом, с тавром, с клеймом, **~ цаас** бумага с печатью, гербовая бумага, **~ мал** клеймённый скот
ТАМИР сила, энергия, **~ тэнхээ** здоровье, физическая сила/крепость, **~ тэнхээ орох** набираться сил, **~ алдах** терять силы, **~ тэнхээгээ барах** выбиться из сил, **~ тэнхээтэй байх** быть ещё в силах, **~ муутай байх** чувствовать себя слабым, **биеийн ~** физическая культура, **дотуур ~** коварство, зло, злой умысел
ТАМИРГҮЙ бессильный, слабый, немощный, **~ хөгшин** бессильный старик, **~ болох** стать бессильным, обессилить
ТАМИРДАЛ (т) бессилие, слабость, упадок сил, изнурение
ТАМИРГҮЙДЭХ быть бессильным, оказываться слабым, обессилеть
ТАМИРДАХ ослабевать, изнемогать, астения, **эцэж ~** изнемогать от усталости, **~ж доройтох** изнуряться, чувствовать полное бессилие
ТАМИРТАЙ сильный, здоровый, **их хүч ~, тэнхээ ~** могучий, сильный, **дотуур ~** злонамеренный, злой, коварный

ТАМИРЧ (ин) физкультурник, спортсмен, **дэлхийд нэртэй ~н** всемирноизвестный спортсмен, **~ны амжилт** успехи спортсмена, **монголын ~д** монгольские физкультурники, спортсмены

ТАМЛАГЧ мучитель, истязатель

ТАМЛАГДАХ *страд. от* **тамлах**, мучиться, истерзаться, подвергаться пыткам, испытывать муки

ТАМЛАЛТ мучение, терзание, страдание, истязание, пытка

ТАМЛАХ мучить, истязать, терзать, пытать, **зэрлэгээр ~** зверски пытать

ТАМТАГ отрепье, лохмотья, что-либо ветхое, потрёпанное, **дээлийн ~ өмсөж явах** ходить в отрепье

ТАМТАГГҮЙ 1) что-либо сильно потрёпанное, искромсанное, 2) невозможный, невыносимый, очень сильный, 3) недисциплинированный, негодный, плохой, **гадаа ~ халуун байна** на улице невыносимая жара, **~ худалч** невозможный лгун, презренный лгун, **~ худал хэлэх** бессовестно лгать

ТАМХИ 1) табак, 2) табачный, **амны ~** табак, **хамрын ~** нюхательный табак, **хар ~** опиум, наркотик, **дүнсэн ~** трубочный табак, **навчин ~** листовой табак, **янжуур ~** сигарета, **~ны соруул** мундштук, **~ны уут/хавтага** табачный кисет, **~нд орох** привыкать к табаку, становиться курильщиком, **~ ороох** делать самокрутку, **~наас гарах** бросать курить, **~ битгий тат!** не курить! **~ны хавтага** кисет, **~ны цох** жук табачный

ТАМХИЛАХ угощать друг друга табаком, закуривать вместе

ТАМХИЧИН курильщик, курильщица, **архаг ~** заядлый курильщик

ТАМШААХ чавкать, смаковать, щёлкать языком, пробовать на вкус, **амталж ~** смаковать, лакомиться

ТАН порошок из лекарственных трав, **эм ~** *парн.* лекарства

ТАНА 1) перламутр, 2) перламутровый, **~н товч** перламутровая пуговица, **~н давхарга** перламутровый слой

ТАНАГГҮЙ негодный, ветхий, потрёпанный, **~ амьтан** никуда негодный человек, **авах ~ хувцас** совсем ветхая/никуда негодная одежда

ТАНАГТАЙ 1) ещё пригодный, вполне приемлемый, не совсем потрёпанный, 2) пока ещё здоровый, пока в силах, **насныхаа/биеийнхээ ~д** пока возраст позволяет, пока здоровье позволяет

ТАНАЙ ваш, **~ гэр хаана вэ?** где ваш дом? **бид ~ руу очлоо** мы пошли к вам

ТАНАЙХ ваше, ваш дом, ваша семья, **~ аль вэ?** который ваш дом? которая ваша юрта?

ТАНАЙХАН ваши, **~ ирлээ** ваши пришли

ТАНГАД тангуты, монгольская народность на севере Тибета

ТАНГАРАГ клятва, присяга, честное слово, **~ өргөх** присягать, клясться, **~ тавих** дать клятву, **~ эвдэх** нарушать клятву, **ам ~ийг нь авах** взять клятву с кого-либо, **~тны төлөөлөгч** присяжный заседатель, **~тны шүүх** суд присяжных

ТАНГАРАГЛАХ клясться, давать клятву, присягать, давать честное слово, **үнэнч байхаа ~** клясться в верности

ТАНГАЧ Калмыкия, калмыки

ТАНДАЛТ зондирование, **зайн ~** дистанционное зондирование, **гүний чичирхийллийн ~** сейсмическое глубинное зондирование

ТАНДАХ разведывать, обследовать, заниматься разведкой

ТАНЗУУР булочка-колобок, сваренная на жиру

ТАНИГДАХ *страд. от* **таних**, быть опознанным, узнаваться, быть опознаваемым, тэр над ~сангiй я его не узнал

ТАНИГДАШГҮЙ неузнаваемый, неузнаваемо, неузнаваемость, **~ болтлоо эцэж турах** похудеть до неузнаваемости, ~ болтлоо **өөрчлөгдөх** преобразоваться/измениться до неузнаваемости

ТАНИЛ 1) знакомый, приятель, 2) знакомство, **~ охин** знакомая девочка, **~ газар** знакомая местность, **~ болох** завязать/заводить знакомство, **~ тал харах** проявлять семейственность

ТАНИЛТАЙ имеющий знакомых, **~ байх** иметь знакомства, поддерживать большие связи, **~ хүн талын чинээ, танилгүй хүн алгын чинээ** *погов. букв.* у кого много знакомых — тот широк, как степь, у кого нет знакомых — тот узок, как ладонь, *приблизительно:* не имей сто рублей, а имей сто друзей

ТАНИЛЦАХ знакомиться, представляться, ознакомляться, **бид ~лаа** мы познакомились, **хоттой ~, хот үзэж ~** знакомиться с городом, **тантай ~сандаа баяртай байна** я очень рад(а) с вами познакомиться

ТАНИЛЦУУЛГА представление, буклет, проспект, **заавар ~** инструкция

ТАНИЛЦУУЛАХ знакомить, представлять, ознакомлять, **бусадтай ~** познакомить с кем-либо, **шинэ ажил-тантай ~** знакомить с новым сотрудником, **хотын дурсгалт зүйлтэй ~** знакомить с достопримечательностями города

ТАНИМГАЙРАХ притворяться знакомцем, фамильярничать

ТАНИУЛАХ *побуд. от* **таних**, объяснять, разъяснять, устанавливать тождество, знакомить, **ухуулан ~** пропагандировать, разъяснять, **учрыг ~** разъяснить причины

ТАНИУЛГА разъяснение, объяснение, ознакомление

ТАНИХ 1) узнавать, распознавать, опознавать, 2) опознавательный, **зүс ~** знать в лицо, **ялгаж ~** различать, **өвчин ~** распознавать болезнь, **~даг хүн** знакомый человек, **~ тэмдэг** опознавательные знаки, знаки различия, *геол.* легенда, условные обозначения

ТАНК танк, **~ эсэргүүцэх залуурт тийрэлтэт сум** противотанковый управляемый реактивный снаряд

ТАНСАГ 1) приятный, прекрасный, чудный, 2) удовольствие, **~ идээ** деликатесы, изысканное кушанье, лакомство, **~ үнэртэй** благовонный, ароматный, душистый, **~ амт** приятный вкус

ТАНСАГЛАХ роскошествовать, шиковать

ТАНСАР: **~ хилэн** вельвет, рубчатый плис

ТАНТАН плевальница, **хогийн ~** мусорный ящик

ТАНТГАР пухлый, округлый, **~ хүн** «колобок»

ТАНХАЙ распоясавшийся, распущенный, безалаберный, авантюрный, беспорядочный, **~ балмад эгтгээдүүд** хулиганы, молодчики, **~ явдал** бесчинство, беспорядок, хулиганство

ТАНХАЙРАГЧ хулиган

ТАНХАЙРАЛ хулиганство, бесчинство, **~тай тэмцэх** а) бороться с хулиганством, б) борьба с хулиганством

ТАНХАЙРАХ распоясываться, распускаться, хулиганить, **гудамжинд ~** хулиганить на улице

ТАНХИ изнеженный, избалованный, **эрх ~ хүүхэд** избалованный ребёнок, **эрх ~ өсөх** расти изнеженным

ТАНХИЛ нежный, изнеженный, избалованный, **~ бие** изнеженное тело, **~ зөөлөн арьс** нежная кожа, **~ өссөн охид** томные барышни

ТАНХИМ палата, зал, **хурлын ~** аудитория, лекционный зал

ТАР 1. качество, совесть, человечность, **~аа таниулах** показать себя, показать свое нутро, **~ муутай хүн** бессовестный человек

ТАР 2. *звукоподражание, выражающее дребезжание:* **~ ~ гэх** дребезжать, издавать звяканье, **~ няр хийх** издавать треск, греметь, **~ түр гэх/хийх** перебраниться, вздорить, устраивать перебранку

ТАРААГДАХ *страд. от* **тараах**, распускаться, разбрасываться, быть распущенным

ТАРААГУУР: **~ судас** артерия

ҮЛ не, **~ барам** не только ... но и, даже, **~ болно** воспрещается, нельзя, **тамхи татаж ~ болно!** курить воспрещается! **~ таних хүн** незнакомец, незнакомый человек, **~ хөдлөх хөрөнгө** недвижимое имущество, **~ мэдэг, ~ ялих** незаметно, слегка, **~ тоох, ~ ойшоох** пренебрегать, игнорировать, **~ ойлголцох** непонимание, **~ ташшаагдах этгээд** персона, эрхээ **~ ашиглах** неиспользование права, **~ хөдлөх эд хөрөнгө** недвижимость, **~ хөдлөх эд хөрөнгийг насан туршдаа эзэмшигч** пожизненный владелец недвижимости, **~ төлөх** неплатёж, **~ хөдлөх эд хөрөнгийг түрээслэх эрх** арендные права на недвижимость, **~ хөдлөх эд хөрөнгийн эрх шилжүүлэх тухай баримт бичиг** документ о передаче прав на недвижимость, **~ хамаарах** независимо от ..., **~ хөрвөх валют** неконвертируемая валюта
ҮЛБИЙХ быть дряблым, стать вялым
ҮЛБЭГЭР *дряблый, вялый, хилый, слабый, болезненный*
ҮЛГЭН: ~ салган очень слабо, еле еле, едва, **~ салган хөдлөх** еле еле двигаться
ҮЛГЭР 1. пример, образец, модель, форма, **~ дууриал/жишээ авах** брать пример/образец, **~ жишээ болох** подавать пример, стать образцом, служить примером, **~ жишээ үзүүлэх** показать пример, **~ жишээ сургууль** образцовая школа
ҮЛГЭР 2. сказка, сказание, **ардын ~** народная сказка, **ёгт ~** басня, **шог ~** юмористическая сказка, **домог ~** легенда, миф, **~ийн орон** сказочная страна, **~ хэлэх/ярих** рассказывать сказки
ҮЛГЭРЛЭХ приводить пример, показывать пример, делать образцом, сравнивать, уподоблять, **~вээс, ~н хэлвээс** например, если сравнить, **~ жишээгүй хэрэг** дело, по которому не имеется прецендентов
ҮЛГЭРЧИЛСЭН (дӣрэм) типовой, примерный (об уставе)
ҮЛДМЭЛ реликтовый, **~ ургамал** реликтовые растения
ҮЛДЭГДЭЛ 1) остаток, излишек, 2) пережиток, **хуучин нийгмийн ~** пережитки старого общества, **мөнгөний ~** остатки денег
ҮЛДЭХ 1. оставаться, быть излишним, **гэртээ ~** оставаться дома, **юу ч ~сэнгүй** ничего не осталось, **амьд ~** остаться в живых, **өнчин ~** остаться сиротой
ҮЛДЭХ 2. гнать, выгонять, прогонять
ҮЛДЭЭХ *побуд. от* **үлдэх,** оставлять, покидать, сохранять, **ардаа хол ~** оставлять далеко позади, **өөртөө ~** оставлять за собой
ҮЛЭГ: ~ гүрвэл динозавр, **~ гүрвэлийн өндөг** яйцо динозавра, **~ харцага** тетервятник, большой ястреб
ҮЛЭМЖ значительный, большой, значительно, очень, весьма, довольно, **~ тооны** в огромном количестве, **~ сайн** довольно/весьма хороший, **~ их мөнгө** весьма крупная сумма денег, **~ хэмжээний мөнгөн хөрөнгө** значительные денежные средства, **~ хохирол** значительный ущерб
ҮЛЭМЖҲЭН *уменьш. от* **үлэмж,** значительный, большой, значительно, очень, весьма, довольно, **~ амжилт олох** достичь значительных успехов
ҮЛЭЭВЭР духовой, **~ хөгжим** духовой инструмент, **~ хөгжмийн чуулга** духовой оркестр, **~ хөгжмийн зэмсэг** духовые музыкальные инструменты
ҮЛЭЭХ дуть, веять, раздувать, **салхи ~нэ** ветер дует, **лимбэ ~** играть на лимбэ/флейте
ҮМХ кусочек, **~ мах** кусочек мяса
ҮМХЭХ хватать зубами, класть в рот, рень, обоснованный, основательный
ҮНГЭХ мять, разминать, **ном ~** истрепать книгу, **цаас ~** мять бумагу
ҮНГЭГДЭХ *страд. от* **үнгэх,** быть мятым, мяться, **~сэн хувцас** мятая одежда
ҮНДСЭН коренной, основной, корень, основа, основание, базис, источник, начало, происхождение
ҮНДСЭРХЭГ националистический, **~ үзэл** национализм
ҮНДСЭРХЭХ вести себя националистически, быть националистом
ҮНДЭС (эн) 1. 1) корень, 2) основа, основание, базис, источник, начало, происхождение, **~ суурь** основа, фундамент, **эх ~** начало, основа, **онолын ~** теоретическая основа, **эдийн засгийн ~** экономическая основа, **үгийн ~** основа слова, **~ болгох** брать за основу, **~ийг тавих** заложить основу, **сайн дурын ~н дээр** на добровольных началах, **~ээр нь өөрчлөх** изменить в корне/коренным образом, **~ээр нь устгах/таслах** уничтожать в корне, вырывать с корнем, **~н хөрөнгө** основной капитал, **~н хууль** конституция, основной закон, **~н хуулийн цэц** конституционный суд, **~н хуулийн баталгаа** конституционные гарантии, **~н салбар** основные отрасли, **~н хэлбэр** основная форма, **~н шалтгаан** основная причина, **~н зарчим** основной принцип, **~н өөрчлөлт** коренное изменение, **~н утга** основное значение, **~н мэргэжил** основные профессии, **~н хам эгшиг** основной аккорд, **~н шинж** основные признаки, **~н чулуулаг** коренные породы
ҮНДЭС 2. национальность, национальный, **~ний шинж** национальный характер, **~ний эрх ашиг** национальные интересы, **~ний бодлого** национальная политика, **~ний эдийн засаг** национальная экономика, **~ний тусгаар тогтнол** национальная независимость, **~ний баялаг** национальное богатство, **~ний орлого** национальный доход, **~ний аюулгүй байдал** национальная безопасность, **~ний цөөнхи** национальное меньшинство, **~ний эвлэрэл** национальное примирение, **~ний эв нэгдэл** национальное единство, **~ний эрх зүй** национальное право, **~тний хамаарал** национальная принадлежность
ҮНДЭСГҮЙ необоснованный, неосновательный, без основания, лишённый основания, необоснованно, неосновательно, **~ зэмлэх** необоснованно осуждать

ҮНДЭСЖИХ укореняться, пускать корни
ҮНДЭСЛЭГЧ основатель, основоположник, **сургалтыг ~** основоположник учения
ҮНДЭСЛЭГДЭХ *страд. от* **үндэслэх**, основываться, обосновываться, быть основанным
ҮНДЭСЛЭГЭЭ довод, **~ гаргах** представлять доводы, **~тэй** обоснованный
ҮНДЭСЛЭЛ обоснование, обоснованность, основа, аргументация, **онолын ~** теоретическое обоснование, **~ муутай нэхэмжлэл** необоснованный иск
ҮНДЭСЛЭЛГҮЙ необоснованный, неаргументированный, необоснованно, неаргументированно, **~ дүгнэлт** необоснованные выводы, **~ баривчилгаа** необоснованный арест, **~гээр ял тулгах** ложное, необоснованное обвинение
ҮНДЭСЛЭЛТЭЙ имеющий обоснование/аргументацию, обоснованный, аргументированный, обоснованно, аргументированно
ҮНДЭСЛЭХ 1) основывать, обосновывать, вести начало, происходить от чего-либо, основываться, обосновываться, 2) пускать корни, **хотыг ~** основать город, **туршлагаас ~** опираться на опыт, исходить из опыта, **зээлийн төлбөрийн чадварыг ~** обоснование кредитоспособности
ҮНДЭСТЭН нация, национальность, **Нэгдсэн ~ий Байгууллага (НҮБ)** Организация Объединённых Наций (ООН), **~ий цөөнх, олонх** национальное меньшинство, большинство, **та ямар ~ бэ?** какой вы национальности? **~ дамнасан корпораци** межнациональная корпорация
ҮНС (эн) пепел, зола, пепельный, **~ий сав** пепельница, **~н саарал** пепельно-серый, **зуухны ~ авах/гаргах** выгребать золу из печки, **тамхины ~ унагах** стряхнуть пепел с папиросы, **~н товрог болгох** разбить в пух и прах, **~ хуттах** сжечь дотла, стереть с лица земли, **~зэр хийсгэх** истребить поголовно
ҮНСГЭЛЖИН: ~ охин золушка
ҮНСЭЛДЭХ *взаимн. от* **үнсэх**, целоваться, целовать друг друга, **тэврэлдэн ~** обниматься и целоваться
ҮНСЭЛТ поцелуй, целование, **хий ~** воздушный поцелуй, **~ — энэ бол хүүхэд үнэгүй, залуу хүн нууцаар, өвгөн хүн худалдаж авдаг зүйл** поцелуй — это то, что ребёнок получает бесплатно, юноша скрывает тайком, а старик покупает; **Профессор лекц уншиж байна. — Ганцхан удаа үнсэхэд л 5 сая нян дамждаг. — Гэхдээ нөгөө талаас, профессор оо, тэдий чинээн нянгаас ангижирч байгаа шүү дээ!** Профессор на лекции: — Только при одном поцелуе передаётся 5 миллионов микробов. — Но ведь, с другой стороны, от стольких же и избавляешься!
ҮНСЭХ целовать, **хацрыг нь ~** целовать кого-либо в щёку, **уруул дээр ~** целовать в губы, **хоёр хацар дээр нь ~** целовать в обе щёки
ҮНХЭЛЦЭГ *анат.* околосердечная сумка, **~ хагарах** а) разрыв сердца, разрыв околосердечной сумки, б) *перен.* сильно бояться
ҮНЭ цена, **~ өртөг** стоимость, **~ төлбөргүй сургалт** бесплатное обучение, **~ бүхий зүйл** ценная вещь, **бөөний худалдааны ~** оптовая цена, **жижиглэн худалдах ~** розничная цена, **зах зээлийн ~** рыночная цена, **тогтсон ~** твёрдая, стабильная цена, **хямд/өндөр ~** дешёвая/высокая цена, **хямд/өндөр ~тэй** дешёвый/дорогой, **өндөр ~ээр авах** купить по высокой цене, **~ асуух** спрашивать цену, **~ хаялцуулах** продавать с аукциона, **~ хаялцуулагч** аукционист, маклер, **~ийн** хэлбэлзэл, **~ хэлбэлзэх** колебание цен, **~ нэмэгдэх** подниматься в цене, **~ нэмэх** повышать цену, **~ алдах обесцениваться, ~ буулгах** скидка, делать скидку, **~ зохиолт** калькуляция, **~ зохицуулалт** регулирование цен, **тохиролцсон ~** договорная цена, **ямар ~тэй вэ?** какова цена? сколько стоит? почём? **~ төлөөлөх** либерализировать цены, либерализация цены, **~ийн ханшны бууралт** инфляция, **~гүй зорчих** бесплатный проезд, **~ийн дүн** сумма
ҮНЭГ лиса, лисица, **~ний арьс** лисья шкура, лисий мех, **~ний нүх** лисья нора, **~н зах** лисий воротник, **~н заль** лисья хитрость, **~н малгай өмсгүүлэх** расточать лесть, **~н сүүлээрээ хуурах** лицемерить, плутовать, **~ний орд** созвездие Тукань
ҮНЭЛГЭЭ оценка, расценка, **өндөр ~ авах** получить высокую оценку, **барааны ~** расценка товаров
ҮНЭЛШГҮЙ неоценимый, бесценный, **~ хувь нэмэр** неоценимый вклад
ҮНЭЛЭГДЭХ *страд. от* **үнэлэх**, цениться, оцениваться, быть оценённым, **гадаадад өндөр ~** высоко цениться за рубежом, за границей
ҮНЭЛЭГЧ ценящий, оценивающий, ценитель, оценщик
ҮНЭЛЭЛТ оценка, **сайн ~ өгөх** дать хорошую оценку
ҮНЭЛЭХ оценивать, ценить, дорожить, **~ж дүгнэх** оценивать, **~ж барашгүй тусламж** неоценимая помощь
ҮНЭМЛЭХ удостоверение, свидетельство, пропуск, грамота, сертификат, **сайшаалын ~** похвальная грамота, **жолоочийн ~** водительские права, **боловсролын ~** аттестат зрелости, **~ олгох** выдавать удостоверение, **орохдоо ~ээ үзүүлэх** предъявить пропуск при входе, **~ээ цоолуулах** получить штрафной прокол в права (водительские)
ҮНЭМЛЭХҮЙ абсолютный, **~ эрх** абсолютное право, **~ олонх** абсолютное болшинство, **~ өндөр** абсолютная высота
ҮНЭМШИЛ 1) убеждённость, уверенность, 2) вероятность
ҮНЭМШИХ убеждаться, верить, **үгэнд ~** верить словам
ҮНЭН 1) правда, истина, 2) правдивый, истинный, настоящий, подлинный, **бодит ~** объективная истина, **туйлын/харьцангуй ~** абсолютная/относительная истина, **~ зөв** правда, правдивый, **~д нийцэх** отвечать истине, **~ сэтгэлээсээ** от всего сердца, **~ийг эрэх/хайх** искать правды, **~ээ хэлэх** говорить правду, **~ийг хэлэхэд** говоря правду, по правде говоря, **энд ~ий хувь байна** здесь есть доля правды, **~ээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ** *приблизительно:* честность лучшая политика, *букв.* будешь действовать правдиво и на колымаге догонешь зайца, **~ алдартны** шашин Православная религия
ҮНЭНЧ честный, верный, преданный, правдивый, **~ нөхөр** верный друг, **~ дурлал/нөхөрлөл** верная любовь/дружба, **~ээр зүтгэх** верно служить, **~ чанар** преданность
ҮНЭР запах, **анхилам сайхан ~** ароматный, приятный запах, **муухай ~** дурной запах, **хурц ~** острый запах, **ёмхий ~** вонь, вонючий запах, **~тэй ус** одеколон, духи, **~ авах** чуять/чувствовать запах, **~ гарах** пахнуть, **~ гаргах** издавать запах, **хүний ~** совесть
ҮНЭРГҮЙ не имеющий запаха, без запаха, **~ шингэн** жидкость без запаха, **хүний ~ амьтан** бессовестное существо, бездушный человек
ҮНЭРЛЭХ нюхать, обнюхивать, **цэцэг ~** нюхать цветы, **~ эрхтэн** органы обоняния
ҮНЭРТЭН парфюмерия, парфюмерный, **~ий үйлдвэрлэл** производство парфюмерии
ҮНЭРТЭХ 1) пахнуть, пропахнуть, 2) нюхать, **хиншүү ~** пахнуть гарью
ҮНЭРХЭХ 1) дорого запрашивать, набивать своему товару цену, поднимать цену, 2) заставлять упрашивать себя
ҮНЭРЧ чуткий к запаху, имеющий чуткое обоняние, **~ нохой** собака-ищейка
ҮНЭТ ценный, ценностный, **~ зүйлс** ценности, **~ чулуу** драгоценные камни, **~ эдлэл** ценные изделия, **дарагдмал ~ зүйл** клад, **~ цаас** ценные бумаги, **~ цаасны орлого** доход от ценных бумаг, **алт, мөнгөөр үнэлэгдсэн ~ цаас** ценные бумаги, обеспе-

ченные золотом и серебром, **эргэлтийн ~ цаас** оборотные ценные бумаги, **~ цаас гаргагч** эмитент

ҮНЭТЭЙДЭХ оказываться очень дорогим, быть слишком дорогим

ҮНЭХЭЭР действительно, поистине, в самом деле, **~ агуу их** поистине великий

ҮНЭЭ корова, **саалийн ~** дойная корова, **~ саах** доить корову

ҮР 1. 1) плод, семя, зерно, 2) результат, следствие, плоды, **~ тариа** зерно, **~ тарианы аж ахуй** зерновое хозяйство, **~ дүн** результат, **~ төл** плоды, **~ ашиг** эффект, эффективность, отдача, **үйлдвэрлэлийн ~ ашиг** эффективность производства, **~ дүнтэй /ашигтай арга** эффективный метод, **~ дүн/ашиг өгөх** давать результаты, **~ дагавар** последствия, **~ тариx/суулгах/цацах** сеять семена, сажать семена, **~ шим** плоды труда и т.п., **сайхан ~ дүнд хүрэх** добиться хороших результатов, **~ дүн үзүүлэх** показать результаты, **~ээр** благодаря, в результате, **~ дүнд** в результате, **~гүй зардал** лишние затраты, непроизводительные расходы, **~ийн дусал** сперма

ҮР 2. ребёнок, дитя, **~ хүүхэд** дети, **~ийн ~д** из поколения в поколение, **~гүй** бездетный, бесплодный, **~ үнэрлэх** обзавестись ребёнком, *букв.* нюхать дитя, **~ зулбах** выкидыш, аборт, **~ үнэрлүүлэх** сделать кого-то дедушкой или бабушкой, **~ хөврөл** эмбрион

ҮРГҮЙДЭЛ стерильность, бесплодность

ҮРГҮЙДЭХ быть бесплодным

ҮРГЭЛЖ 1. всегда, постоянно, всё время, **~ дэмжих** постоянно поддерживать, **дэмий юманд ~ маргадаг** постоянно спорит из-за пустяков

ҮРГЭЛЖ 2. вместе, слитно, целиком, всецело, сплошь, слитный, единый, сплошной, соединённый в одно, **~ бичих** написать слитно

ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ *побуд. от* **үргэлжлэх**, продолжать, **уламжлалыг ~** продолжать традицию, **яриагаа ~** продолжать свой рассказ

ҮРГЭЛЖЛЭЛ продолжение, **~ бий** продолжение следует

ҮРГЭЛЖЛЭХ продолжаться, длиться, **хэлэлцээр ~сээр байна** *переговоры ещё продолжаются*, **дараа жил хүртэл ~** продолжаться до следующего года

ҮРГЭХ пугаться, шарахаться (о лошади)

ҮРГЭЭХ *побуд. от* **үргэх**, пугать, отпугивать

ҮРЖИГДЭХҮҮН множимое, множитель

ҮРЖИЛ размножение, рост, плодородие, селекция, **бэлгийн ~** сексуальное размножение, **вегетатив ~** вегетативное размножение, **~ийн мал** племенной скот, **~ сайтай хөрс** *плодородная земля*, **~ийн ажил** селекционные работы

ҮРЖИХ умножаться, размножаться, плодиться

ҮРЖҮҮЛЭХ *побуд. от* **үржих**, множить, размножать, плодить, разводить, **арван нэгийг долоогоор ~д далан долоо болно** одиннадцать умножить на семь будет семдесят семь, **мал ~** разводить скот

ҮРЛЭГ трата, непроизводительные издержки/расходы, расточительство, **~н зан** расточительность, расточительство, **~н хүн** расточительный человек

ҮРТЭС опилки, осколки, обрезки, **төмрийн ~** металлические опилки, **модны ~** опилки, **шилний ~** осколки стекла

ҮРЧГЭР морщинистый, мятый, помятый, **~ нүүр** лицо, покрытое морщинами, **~ хувцас** мятая одежда

ҮРЧИЙХ морщиться, мяться (об одежде)

ҮРЧЛЭГЧ усыновитель

ҮРЧЛЭЛТ усыновление, удочерение

ҮРЧЛЭХ усыновлять, удочерять, **~сэн** усыновлённый, удочерённая

ҮРЧЛЭЭ (с) морщина, складка, **гүн ~с** глубокие морщины/складки

ҮРЭВСЭЛ воспаление, **уушгины ~** воспаление лёгких, пневмония, **бөөрний ~** воспаление почек

ҮРЭВСЭХ 1) воспаляться, 2) усиливаться, увеличиваться, распространяться

ҮРЭГДҮҮЛЭХ *побуд. от* **үрэгдэх**, расхищать, расточать, мотать, зря тратить, разбазаривать, **ард олны хөрөнгийг ~** расточать народное достояние

ҮРЭГДЭЛ затраты

ҮРЭЛГЭН: ~ мөнгө лёгкие деньги

ҮРЭЛТ трение, **~ийн хүч** сила трения

ҮРЭМТГИЙ расточительный, **~ эзэд** расточительный человек

ҮРЭХ 1. тратить, растрачивать, **мөнгөө ~** растрачивать деньги, **цагаа ~** тратить своё время

ҮРЭХ 2. 1) тереть, растирать, 2) рассыпать, просыпать

ҮС 1) волосы, шерсть, 2) мех, **~ авах** стричь, **~ засах** подстричь волосы, причёсываться, поправлять причёску, **~ самнах** причёсываться, **~ээ буржийлгах** завивать волосы, **хиймэл ~** парик, **ангийн ~** *пушнина*, **~ хатаагч** *фен для волос*, **гээг ~ээ сүлжих** заплести косу, **~ээ хагалах** выходить замуж, **~ийг нь хагалах** брать в жёны

ҮСДЭХ схватывать за волосы, таскать за волосы

ҮСЛЭГ волосатый, пушной, пушистый, **~ ан** пушной зверь, **~ муур** пушистый кот, **~ ангийн аж ахуй** пушное хозяйство

ҮСРЭЛТ прыжок, скачок, прыгание, **~ хийх** сделать скачок, **«их ~»** «большой скачок»

ҮСРЭХ 1) прыгать, 2) брызгать, лететь (о каплях жидкости и т.д.), **усанд ~** прыгнуть в воду, **~тлээ алгадуулах** получить оплеуху, затрещину

ҮСТЭЙ покрытый шерстью, волосатый, меховой, **~ дээл** дэли/шуба на меху

ҮСЧИН парикмахер, **~ий газар** парикмахерская

ҮСЭГ буква, **бичиг ~** письменность, **шинэ ~, кирилл ~** кириллица, **дүрс ~** иероглифы, **том ~** большая, прописная/заглавная буква, **жижиг ~** маленькая, строчная буква, **дармал/бичмэл ~** печатный/рукописный шрифт, **гарын ~** подпись, **гарын ~ үүсэглэх** ставить подпись, «ставить крестик», **~ өрөгч** наборщик, **~ийн дүрэм** орфография, **~ийн хэв, ~ийн хэлбэр** почерк

ҮТРЭЭ *мед.* влагалище, **~н амсар** влагалище, **~ний үүдэвч** преддверие влагалища, **~ний үзлэг** влагалищные исследования, **~ний уйланхай** киста влагалища, **~н өвөр хана унжилт** выпадение передней стенки влагалища, **~н үрэвсэл** кольпит, вагинит, **~н хатингаршсан үрэвсэл** атрофический кольпит, **~н сахуун үрэвсэл** дифтерия вульвы, **~н хүйтэн** гонорейный кольпит, **~н мөөгөнцрийн үрэвсэл** микотический вульво, вагинит, **~ дурандах** кольпомикроскопия, **~н хананы урагдал** разрыв стенок влагалища

ҮҮ 1. *вопросительная частица, употребляемая после слов с гласными переднего ряда:* ли, ль, **чи шалгалтаа өгсөн ~?** сдал ли ты экзамен?

ҮҮ 2. бородавка, **өмөн ~** рак, канцер

ҮҮГЭЭР здесь, по этой стороне, в этой местности

ҮҮД дверь, ворота, вход, **~ нээх/онгойлгох** открывать дверь, **~ хаах** закрывать дверь, **~нээс** от двери, **~н шүд** передние зубы, резцы

ҮҮДНЭЭС в целях, из-за, того что, **шинжлэх ухааны ~** с научной точки зрения, **чин сэтгэлийн ~** от всей души

ҮҮЛ 1) облако, туча, 2) бельмо, **борооны ~** дождевые облака, **сэмжин ~** перистые облака, **~ бүрхэх** покрываться тучами/облаками, **нүдний ~** бельмо, **~н хурын орд** созвездие золотая рыба

ҮҮЛДЭР порода, **малын ~ угсаа** порода скота, **малын ~ угсааг сайжруулах** улучшать породу скота, **шилжэл ~ийн адуу** лошадь отборной породы, породистая лошадь

ҮҮЛТ: **~ молор** *геол.* пирофизалит

ҮҮЛТЭЙ облачный, покрытый тучами/облаками, **~ тэнгэр** облачное небо, **нүдэндээ ~** с бельмом на глазах

ҮҮЛТЭХ покрываться, заволакиваться облаками

ҮҮЛШИХ покрываться облаками/тучами, заволакиваться (о небе)

ҮҮЛЭРХЭГ облачный, покрытый тучами/облаками, пасмурный, **~ өдөр** облачный, пасмурный день

ҮҮНИЙ: ~ өмнө до этого, **~ гадна** кроме этого, **~ зэрэгцээ** наряду с этим, **~ талаар/тухай юу мэдэх вэ?** что вы знаете об **ҮҮРэй?** рассвет, утренняя заря, **~ээр ирэх** приехать на рассвете/с зарёй, **~ цүүрээр** очень рано, ни свет ни заря, **~ хаяарах/цайх, ~ гэгээрэх** рассветать, **эрх чөлөөний ~ гийх үед** на заре свободы

ҮҮР 2. гнездо, **шувууны ~** птичье гнездо, **зөгийн ~** пчелиный улей, **~ засах/барих** гнездиться, вить гнездо

ҮҮР 3. ячейка, притон, **намын ~** партийная ячейка, **хулгайчийн ~** воровской притон

ҮҮРГЭВЧ рюкзак, походная сумка, **~тэй, ~ үүрсэн хүн** человек с рюкзаком за спиной

ҮҮРД навеки, навсегда, вечно, **~ дурсах** вечно помнить, **~ийн гавьяа** вечный подвиг, вечная слава

ҮҮРЛЭХ 1) гнездиться, делать гнездо, вить гнездо, 2) ютиться, **хараацай дээвэр дор ~жээ** ласточки гнездились под крышей

ҮҮРМЭГ крошки, **талхны ~** крошки хлеба

ҮҮРТЭХ быть не в состоянии делать/поднимать что-либо, не успевать справляться с работой, быть не в состоянии одолеть что-либо

ҮҮРЭГ 1) долг, обязанность, обязательство, 2) функция, роль, 3) ноша, **~ даалгавар** поручение, **~ хариуцлага** ответственность, **~ хүлээх** нести ответственность, принимать на себя обязательство, **~ээ биелүүлэх** исполнять, выполнять обязанность, **~ болгох** обязывать, **~ээ гэж үзэх** считать своим долгом, **чухал ~ гүйцэтгэх** играть большую роль, **~ гүйцэтгэгч** и.о.: исполняющий обязанности, **~ийн биелэлтийг хангах** обеспечить выполнение обязательств, **барьцааны ~** залоговые обязательства, **~ гүйцэтгүүлэгч** кредитор, **хамтран ~ гүйцэтгүүлэгч** солидарный кредитор

ҮҮРЭГЛЭХ дремать, клонить ко сну

ҮҮРЭХ 1. размельчаться, разбиваться, дробиться, крошиться, **талх ~ч байна** хлеб крошится

ҮҮРЭХ 2. нести на себе, носить на спине, **буу ~** нести ружьё на плече, **нуруугаа ~** заложить руки за спину

ҮҮСВЭР начало, зачаток, происхождение, эх **~ийг тавих** положить начало чему-нибудь

ҮҮСГҮҮР *тех.* генератор, производитель, **тогтмол гүйдлийн ~** генератор постоянного тока, **~ийн хий** генераторный газ

ҮҮСГЭВЭР толчок, побуждение, импульс, начало, **~ санаачлага** инициатива, почин

ҮҮСГЭГЧ зачинщик, зачинатель, инициатор, возбудитель, **хэрүүл ~** зачинщик ссоры, **өвчин ~** возбудитель болезни, болезнетворные микробы

ҮҮСГЭЛ инициатива, почин, возникновение, начало, **олон нийтийн ~ санаачилгаар** по инициативе общественности/масс

ҮҮСГЭХ начинать, делать почин, положить начало, затевать, порождать, образовывать, **~н байгуулах** основать, **~н байгуулагч** основатель

ҮҮСЭЛ возникновение, происхождение, начало, **нийгмийн гарал ~** социальное происхождение

ҮҮСЭХ начинаться, образовываться, возникать, создаваться, **~н тогтох** становление, **ертөнцөд амьдрал хэдийд ~сэн бэ?** когда возникла жизнь на земле?

ҮХЛҮҮД 1) смертельный, обречённый на смерть, смертельно, 2) крепко, плотно, крепко-накрепко, **~ өвчтэй** смертельно больной, **тэр ~ шархаджээ** он смертельно ранен, **юмыг ~ уях/зангидах** крепко-накрепко завязать что-нибудь, **~ хадах** крепко-накрепко забить

ҮХМЭЛ мёртвый, **~ хөрөнгө** мёртвый капитал

ҮХҮҮЛЭХ *побуд. от* **үхэх**, доводить до смерти/гибели, губить, умерщвлять, лишаться, терять кого-либо, хоронить

ҮХЭЛ смерть, кончина, **гэнэтийн ~** скоропостижнаясмерть, неожиданная смерть, **~ээс аврах** спасать от смерти, **~ийн аюул** угроза смерти, **~ийн амсар дээр гарах** быть на краю гибели

ҮХЭР 1) крупный рогатый скот, 2) большой, крупный, **~ мал** скот, **~ хариулах** пасти крупный рогатый скот, **~ийн мах** говядина, **~ийн чанасан мах** говядина отварная, **~ийн жигнэсэн мах** говядина тушёная, **~ тэрэг** бычья телега, арба, **~ чулуу** валун, большая каменная глыба, **~ хэдгэнэ, ~ зөгий** шмель, **~ийн нүд** чёрная смородина, **~ийн орд** созвездие Тельца

ҮХЭРЧИН пастух крупного рогатого скота

ҮХЭХ умирать, скончаться, гибнуть, лишаться жизни, **зуурдаар ~** скончаться скоропостижно, **~тэл айх** бояться до смерти, **~тэл ядрах** смертельно устать, **~тэлээ уйдах** очень/смертельно скучать, **~лийн даваан дээр байх** быть одной ногой в могиле, **~н хатан** изо всех сил, **~ сэхэхээ мэдэлгүй** презирая опасность, **~ээ мэдэхгүй** ничего не боясь (часть о маленьких детях, не подозревающих об опасностях), **~сэн хойно** после смерти, **~ төрөхийн үнэн** есть две правды: рождение и смерть, **~сэнээ хийж** *разг.* какого чёрта

ҮХЭШГҮЙ бессмертный, **~ мөнхийн гавьяа** бессмертная слава, бессмертный подвиг

ҮХЭЭНЦ слабый, бессильный, бездарный, тупой

Ф

ФА: ~ **эгшиг** нота фа

ФАБРИКА фабрика, фабричный, **чү-дэнзний** ~ спичечная фабрика, **~ийн тэмдэг** фабричная марка

ФАКУЛЬТЕТ факультет, факультетский

ФАКТЛАХ допускать ошибку, сплоховать

ФАШИСТ *фашист, фашистский,* ~ **дэглэм** фашистский режим

ФЕОДАЛ феодал, феодальный, **хар шар** ~ светские и духовные феодалы, **~ын нийгэм** феодальное общество

ФЕОДАЛИЗМ феодализм, **~аас капитализмыг алгасан социализмд шилжих** переходить/переход от феодализма к социализму, минуя капитализм

ФЕРМ ферма, **мал аж ахуйн** ~ животноводческая ферма

ФЕРМЕНТ фермент

ФЕРМЕР фермер

ФЕСТИВАЛЬ фестиваль, **дэлхийн оюутан залуучуудын** ~ фестиваль молодёжи и студентов мира

ФИЗИК *физика, физический,* **онолын** ~ теоретическая физика, **~ийн туршлага** физические опыты

ФИЗИКЧ физик, ~ **эрдэмтэн** учёный-физик

ФИЗИОЛОГИ физиология, физиологический, **ургамлын/хүний** ~ физиология растений/человека, **~ийн шаардлага** физиологические потребности

ФИЛАРМОНИ филармония, **улсын** ~ государственная филармония

ФИЛИППИН Филиппины, филиппинский

ФИЛОСОФИ философия, философский, **эртний** ~ античная философия, **~ийн судалгаа** философское исследование

ФИЛЬМ фильм

ФИН Финляндия, финны

ФИРМ фирма, **~ийн нэр** фирменное название

ФЛОТ флот

ФОКУС *фокус (в оптике)*

ФОН фон

ФОНД фонд, **аж үйлдвэрийн үндсэн** ~ основные фонды промышленности, **~ын биржс** фондовая биржа, **~д зэвсэглэмж** фондовооружённость

ФОСФОР фосфор, фосфорный

ФОТО фото, фотографический, ~ **зураг** фотокарточка, фотоснимок, ~ **зурагчин** фотограф

ФОТОАППАРАТ фотоаппарат

ФРАНЦ Франция, французский, ~ **хэл** французский язык, **~ын соёлын төв** французский культурный центр

ФРОНТ *фронт, фронтовой,* **өргөн/нэгдсэн** ~ широкий/единый фронт, **~ын шугам** фронтовая линия, **~ын 100 грамм** фронтовые 100 грамм

Х

ХАА 1. где, куда, **~ газарт, ~ л бол ~** везде, повсюду, **~ нэгтэй, ~ нэг газар** где-то, где-нибудь, **~ ~гүй, ~ сайгүй** везде, всюду, **хаа хамаагүй** где бы то ни было

ХАА 2. передняя нога туши с рёбрами, **~ гуя хоёр** передняя и задняя ноги туши, **шулдан ~** передняя нога туши без рёбер

ХАА 3.: ха! возглас, которым понукают волов и верблюдов

ХААГДАХ *страд. от* **хаах**, закрываться, захлопнуться, быть закрытым, запертым, **хаалга ~в** дверь закрылась, ворота закрылись, **зам ~лаа** дорога была закрыта

ХААГУУР где, в каких местах, **нөхөр минь! та ~ тэнээд ирэв?** где шлялся, муж? **чи ~ ирэв?** ты откуда пришёл? какой дорогой пришёл?

ХААГЧ закрывающий, запирающий, **албан ~** служащий

ХААДАЙХ оказываться коротким и плотным, быть коренастым, толстым

ХААДГАНАХ двигаться, ходить (о приземистом, плотном человеке)

ХААДГАР короткий и плотный, приземистый

ХААЗ *разг.* педаль газа в автомобиле

ХААЗЛАХ давить на газ

ХААЛГА 1) дверь, ворота, 2) вход, выход, 3) дверной, **орох, гарах ~** вход и выход, **гол ~** главный вход, **арын ~** а) задняя дверь, б) чёрный ход, **арын ~аар авах** получить что-нибудь по блату, незаконным способом, **~ны цоож** дверной замок, **~ны түлхүүр** дверной ключ, ключ от двери, **~ тайлах** открыть, отворить дверь, **~ цоожолох** запереть дверь на замок, **~нд бөмбөг оруулах** *спорт.* забить гол в ворота

ХААЛГАЧ 1) швейцар, портье, привратник, 2) вратарь, голкипер, **хааная ~** *приблизительно:* жалует царь, да не жалует псарь, привратник важнее хана

ХААЛТ преграда, барьер, заграждение, заслонка, крышка, скобка, закрытие, **замын ~** преграда на дороге, **үгийг ~д хийх** взять слово в скобках, **~ын хуралдаан** заключительное заседание, **~ын ёслол** церемония закрытия, **шаврын ~** *жарг.* помеха

ХААЛТТАЙ закрытый, **~ цонх** закрытое окно, **~ хурал** закрытое заседание, **~ бүс** запретная/закрытая зона, **~ эдийн засаг** закрытая экономика

ХААН хан, царь, монарх, **~ хатан хоёр** хан и ханша, **эзэн ~** император, **цагаан ~** царь (так монголы называли российских царей), **~ ширээнд залах ёслол** коронация, **~ы алба халаатай эзний алба ээлжтэй** *приблизительно:* всё когда-нибудь заканчивается, имеет свой срок и царская служба, **хар гэртээ ~, бор гэртээ богд** *приблизительно:* дома и стены помогают, **~ ширээг залгамжлах ханхүү** наследный принц

ХААНА где, куда, **~ ч алга/байхгүй** нигде нет, **би ~ төрөв?** где я родился? (из стиха)

ХААНААС откуда, **та хаанаас мэдэв?** откуда вы узнали?

ХААНАХ откуда, из каких мест, **~ын хэн гэгч вэ?** кто и откуда?

ХААНТ ханский, царский, **~ засаг** царская власть, царизм, **~ улс** ханство, царство, **~ ёс** монархия

ХААНЧЛАЛ царствование, ханство, **Чингисийн ~ын үед** в эпоху царствования Чингисхана

ХААНЧЛАХ царствовать, быть царём, ханствовать

ХААХ 1) закрывать, захлопнуть, запирать, затворять, 2) преграждать, заграждать, 3) прекращать, закрывать, роспускать, 4) нести, **үүд ~** закрывать дверь, **зам ~** преграждать путь, **хурал ~** закрывать заседание, **хил ~** закрывать границу, **цэргийн алба ~** нести воинскую службу, **ам ~** выполнить что-либо на скорую руку, кое-как, халтурить, сделать что-либо лишь бы отделаться, **өр ~** вернуть/отдать долги, **~ж хорьсон данс** блокированные счета

ХААХАЛЗАХ 1) двигаться, ходить (о широкоплечем человеке), 2) гордиться, вести себя высокомерно

ХААЦАЙЛАХ 1) защищать, покровительствовать, служить ширмой, 2) скрывать, 3) заслонять, загораживать собой, **дутагдлаа ~** скрывать свои недостатки, **гэрэл ~** заслонить свет/лучи

ХААЧИХ *разг.* идти куда-нибудь, **бид одоо ~ вэ?** куда теперь нам идти? **чи ~ нь вэ?** ты куда собрался?

ХААШ: ~ ~аа в ту и другую сторону, по ширине и по длине, во все стороны, **~ яаш хүн** небрежный, неаккуратный человек, **~ яаш хандах** небрежно относиться, **~ болович** во всяком случае, на всякий случай, **~ явдал/хэрэг** случайность, что-то неладное

ХААШАА 1) куда, в каком направлении, 2) какой, что за, **чи ~ явах вэ?** куда будешь идти, **та нар ямар ~ улс вэ?** ну что вы за люди!

ХААЯА иногда, изредка, местами, **~ тааралдах/уулзалдах** изредка встречаться

ХААЯАГҮЙ везде, всюду, повсюду, повсеместно

ХААЯАХАН *уменьш. от* **хааяа**, изредка, порой, не часто

ХАВ 1. *частица усиления к словам с начальным:* **ха-, ~ хар** совсем чёрный, чёрный-пречёрный, **~ харанхуй** темным-темно, полная темнота, темень, **~ халуун** очень горячий

ХАВ 2.: **ид ~** волшебная, чудесная сила, редкие способности

ХАВ 3. болонка, маленькая комнатная собачка, моська, **Бээжин ~** пекинес, **~ гумбираа** аллигатор

ХАВ 4.: **~ ханах** злорадствовать, наслаждаться несчастьем других

ХАВАГНАХ отекать, опухать (о лице)

ХАВАН 1. *мед.* отёк, опухоль, водянка, **хөлийн ~** отёк ног, опухоль на ноге, **усан ~** водянка

ХАВАН 2. чиновничий чин во время Маньчжурской администрации

ХАВАНТАЙ опухший, распухший, отёклый, **~ нүүр** отёклое лицо

ХАВАР весна, весной, **~ын улирал** весеннее время, **~ын урь** весенняя оттепель, **~ын тариалан** весенний сев

ХАВАРЖАА весеннее стойбище, **~нд буух** перекочевать/переселиться на весеннее стойбище

ХАВАРЖИН всю весну, в течение всей весны, **~ салхилав** всю весну дул ветер/было ветрено

ХАВАРЖИХ проводить весну, **тавтай ~** благополучно провести всену

ХАВГҮЙ неудобный, неуютный, неприятный, неуклюжий, примитивный, некрасивый, **эв ~** неуклюжий, неповоротливый, **~ өдөр** тяжёлый/неважный день, **~ явдал** неприятный случай

ХАВДАР опухоль, отёк, **хорт ~** злокачественная опухоль, **хорт ~ үүсгэгч** канцероген, **хоргүй ~** доброкачественная опухоль, **элэгний ~** опухоль печени, **~ судлал** онкология, **~ хагалах** вскрыть опухоль

ХАВДААХ *побуд. от* **хавдах**, допускать отёк, доводить до опухания

ХАВИРАХ тереть одно об другое, производить трение, скрипеть, скрежетать, **чүдэнз ~** чиркнуть спичкой, **шүд амаа/араа шүдээ ~** скрежетать зубами

ХАВИРГА ребро, **богино ~** короткие рёбра, **~ны нум** рёберная дуга, **~н сар** лунный серп, серп луны, **~аар хатгах** колики в боку, **~н товцогийн орд** созвездие Октант

ХАВСАРГА 1. 1) побочный, прикладной, 2) присовокупление, прибавление, добавление, приложение, 3) совмещение, сочетание, ~ **урлаг** прикладное искусство, ~ **шинжлэх ухаан** прикладные науки, ~ **бүтээгдэхүүн** побочные продукты

ХАВСАРГА 2. холодный, пронизывающий ветер, **хаврын** ~ весенний холодный ветер

ХАВСАРГАХ прилагать, приложить, присоединять

ХАВСРАЛТ приложение, вкладыш, добавление, присоединение, ~ **илтгэл** содоклад, **номын** ~ приложение к книге

ХАВСРАХ присоединять, прилагать, совмещать, **хүч** ~ действовать совместно, **~сан нийлмэл өгүүлбэр** сложноподчинённое предложение, **~ч ажиллах** работать по совместительству

ХАВТАГА небольшая сумка, кисет, **тамхины** ~ кисет с табаком

ХАВТАЙХ 1) быть плоским, расплющиваться, 2) становиться ниже, принижаться

ХАВТАН плита, панель, **барилгын** ~ строительные панели, **боржин чулуун** ~ мраморная плита, **булшны** ~ могильная плита

ХАВТАНЦАР плиточка, плита, плиточный, ~ **шал** плиточный пол

ХАВТАС 1) папка, 2) переплёт, **бичгийн** ~ папка для бумаг, папка для рукописи, **хатуу** ~ твёрдая, жёсткая папка, **гялгар** ~ коленкоровый переплёт, **нимгэн ~тай ном** книга в тонком переплёте, **~т хэрэг** досье материалов по делу

ХАВТАСЛАГЧ переплётчик

ХАВТАСЛАХ переплетать, **ном** ~ переплести книгу

ХАВТГА кошелёк, **тамхины** ~ кисет для табака

ХАВТГАЙ 1. 1) плоский, квадратный, плоскость, 2) всюду, везде, ~ **гадаргуу** плоская поверхность, плоскость поверхности, ~ **газар** плоская местность, ~ **дөрвөлжин километр** квадратный километр, **налуу/хэвтээ** ~ наклонная/горизонтальная поверхность, **хагарцын** ~ плоскость излома

ХАВТГАЙ 2. дикий верблюд, хавтагай

ХАВТГАЙЛАХ делать плоским, **гурил** ~ катать тесто

ХАВТГАЙРАХ 1) делаться плоским, становиться плоским, сплющиваться, 2) распространяться, делаться повсеместным

ХАВТГАЙРУУЛАХ *побуд. от* **хавтгайрах**, делать повсеместным, всеохватывающим

ХАВХ капкан, ~ **тавих/зүүх** ставить капкан, **~нд орох** попасть в капкан

ХАВЦАЛ ущелье, каньон, **уулын** ~ горное ущелье, **~ын ёроолд** на дне ущелья, **гүн** ~ глубокое ущелье

ХАВЧ рак, ~ **хэлбэртэн** ракообразные

ХАВЧААР 1) скрепка для бумаг, 2) заколка, зажим для волос, 3) прокладка, 4) лампасы, окантовка

ХАВЧГАР притиснутый, придавленный, сплюснутый с боков, сжатый с двух сторон, ~ **цээжтэй** плоскогрудый

ХАВЧИГ 1. узкий, тесный, ~ **өрөө** тесная комната, ~ **толгой** сплющенная с боков голова, **уулын** ~ горная теснина

ХАВЧИГ 2.: ~ **соёолон морь** шестигодовалый конь

ХАВЧИГДАХ *страд. от* **хавчих**, быть зажатым, оказываться прижатым, быть притесняемым, притесняться, **бусдад** ~ притесняться другими, находиться в притеснении, **аргагүйн эрхэнд** ~ оказываться в безвыходном положении

ХАВЧИЙХ делаться плоским, оказываться приплюснутым, быть узким/тесным

ХАВЧИХ 1) ущемлять, жать, зажимать, 2) притеснять, зажимать, прищемлять, **мөрөө** ~ пожать плечами, **сүүлээ** ~ поджать хвост, **амаа** ~ зажимать себе рот, молчать, **сонирхолыг ~н хяхах** ущемлять чьи-либо интересы

ХАВЧЛАГА нажим, притеснение, принуждение, гонение, травля, ~ **шахалтаар хийх** делать по принуждению, **бусдын ~аар** по принуждению других, **~гагүйгээр** без нажима/принуждения, **~д өртөх** подвергаться гонениям

ХАВЧУУЛАХ *побуд. от* **хавчих**, сдавливать, зажимать, прижимать, прищемлять, вкладывать, втискивать, всовывать, затыкать, **сугандаа** ~ брать под мышку, **бүсэндээ** ~ засовывать/затыкать за пояс

ХАВЬ 1) окрестность, 2) поблизости, вокруг, около, неподалёку, **~ийн хүн** люди, находящиеся поблизости, здешние, **энэ ~д, ойр ~д** в окрестности, вокруг, поблизости, **Тэрэлж энэ ~д байх ёстой** Тэрэлж должен быть где-то здесь поблизости, **~гүй дээр, ~гүй илүү/давуу** куда лучше, намного лучше

ХАВЬТАЛ интимный контакт, связь, **анхны ~аар жирэмслэж болох уу?** можно ли забеременеть при первом половом сношении?

ХАВЬТАХ 1) приближаться, подходить поближе, 2) *перен.* быть в интимных отношениях, **~ж ойртох** быть в интимных отношениях, **тэр хэн дайралдсан хүнтэй ~гүй** с первым попавшимся она не пойдёт, она ещё по рукам не пошла

ХАВЬТУУЛАХ *побуд. от* **хавьтах**, приближать, позволять подходить/приближаться, допускать близости, согласиться быть с кем-либо в интимных отношениях, **~гүй байх** не допускать к себе, совсем не соглашаться, отказываться наотрез

ХАВЬЦАА окрестность, поблизости, приблизительно, **энэ** ~ здесь, в окрестности, **тэр л ~ байх** там, очевидно

ХАВЬЧИХ 1) быть болтливым, оказываться словоохотливым, 2) быть беспокойным, суетливым, быть вертлявым

ХАГ 1. налёт, накипь, нагар, **үсний** ~ перхоть, **шүдний** ~ налет на зубах, зубные камни, **хадны** ~ лишайники на камне

ХАГ 2. послед у животных

ХАГА *частица усиления при глаголах, часто соответствующая приставке* раз, рас, ~ **цохих** разбить, разломать, ~ **зүсэх** разрезать, рассекать

ХАГАЛАЛТ 1) колка, разрезание, 2) вспашка, пахота, **газар** ~ вспашка земли

ХАГАЛАХ 1) раскалывать, разламывать, 2) разрезать, оперировать, 3) пахать, вспахать, **түлээ мод** ~ колоть дрова, **аяга** ~ разбить чашку, **газар** ~ пахать землю, **олгой** ~ удалить аппендецит, **өвчтөн** ~ оперировать больного

ХАГАЛБАР разделяющая линия, **усны** ~ водораздел, **үсний** ~ пробор на голове

ХАГАЛГАА *мед.* операция, разрез, **хэвлийн хөндийн** ~ операция в брюшной подости, ~ **хийх** сделать операцию, **~ны ширээ** операционный стол

ХАГАРАЛ раскол, разногласие, раздор, трещина, разлом, ~ **гаргагч** раскольник, фракционер, ~ **гаргах** внести разногласия в среду кого-чего-нибудь, привести к расколу, расколоть, **~ыг гүнзгийрүүлэх** углубить раскол, **гүний** ~ глубинный разлом, **түгээмэл** ~ глобальный разлом

ХАГАРАЛТ трещина, раскол, разлом, **мөсний** ~ разлом льда, ~ **үүсэх** дать трещину, образовываться (о трещине)

ХАГАРАХ разбиваться, раскалываться, разрываться, трескаться, ломаться, распадаться, иметь разногласия, ссориться, **уруул ~в** губа растрескалась, **цонх ~в** окно разбилось, **түнжин ~, эв** ~ ссориться, находиться в плохих отношениях

ХАГАРХАЙ 1) трещина, 2) осколок, 3) разбитый, расколотый, **шилний** ~ осколки стекла, ~ **аяга** разбитая чашка, ~ **хэнгэрэг шиг, хамар доорх ~ ам** *приблизительно:* язык без костей, человек, который говорит лишнее, (*досл.* разбитый барабан, рваный рот под носом)

ХАГАС половина, пол-, полу-, ~ **зуун** полвека, ~ **жил** полгода, ~ **сар** пол-месяца, ~ **цаг** полчас, ~ **сайн өдөр** суббота, **арван цаг ~** половина одиннадцатого, **тэргүүн/эхний** ~ первая половина,

сүүлийн ~ вторая половина, **~ дамжуулагч** полупроводник, **~ боловсруулсан бүтээгдэхүүн** полуфабрикаты, **бүтэн ~** полтора, **~ шат** *муз.* полутон, **~ эгшиг** *муз.* половинная нота

ХАГАСЛАХ делить пополам, разделять надвое, разрывать на две половины, недоделывать, **шөнө ~аад мордох** выехать в полночь

ХАГАЦААХ *побуд. от* **хагацах**, разделять, отделять, разлучать, избавлять

ХАГАЦАЛ разлука, расставание, **~ үзэх** испытывать разлуку

ХАГАЦАХ расставаться, разлучаться, лишаться, избавляться, **сайн нөхрөөс ~** разлучиться с любимым другом, **амь наснаас ~** лишаться жизни, **~ цаг боллоо** наступил день разлуки, **үхлээс ~** избавиться от смерти

ХАГАЦАШГҮЙ неразлучный, неотделимый, **~ сайн нөхөд** неразлучные друзья

ХАГТАХ покрываться налётом, перхотью

ХАД (ан) скала, утёс, каменная гора, **~ чулуу** *парн.* камни, скалы, **~ны ёроол** подошва скалы, **~ны хонгил/агуй** пещера в скале, **~н хөрс** скальный грунт, **~ны дорго** мангуст, **~ны суусар** куница каменная, **~н гэртээ очих** сойти в могилу, **~ны сээтэн** полевка серебристая

ХАДААС гвоздь, **эрэгтэй ~** шуруп, **дардаг ~** кнопка, **~аар хадах** прибить гвоздями, **~ шаах** забить гвоздь, **~ны тав** шляпка гвоздя

ХАДАГ хадак (сложенный вдвое шёлковый платок, которое преподносится в знак уважения почётным гостям), **~ барих** преподнести хадак, **Аюуш ~** хадак, преподносимый изображению Будды

ХАДАЛТ жатва, косьба, **тариа ~** жатва хлебов, **өвс ~** сенокос

ХАДАМ родня по мужу/жене, **~ эцэг** свёкор, тесть, **~ эх** свекровь, тёща, **~д гарах, ~д очих** выходить замуж, **~ эцгийн орд** созвездие Голубя

ХАДАМЛАХ сватать, выдавать замуж

ХАДАМСАГ любитель ходить в гости к родне жены/мужа

ХАДАРХАГ каменистый, скалистый, **~ эрэг** каменистый берег

ХАДАРХУУ 1) скалистый, каменистый, 2)скалообразный, похожий на скалу

ХАДАХ 1. косить, жать, убирать, **өвс/хадлан ~** косить траву/сено, **тариа ~** жать хлеб

ХАДАХ 2. 1) прибивать, вбивать, 2) пришивать, **хадаас ~** забивать гвоздь, **хадаасаар ~** прибивать гвоздями, **хананд зураг ~** прибить картину к стене, **гутал ~** чинить сапоги, **гутлын ул ~** подбивать подмётку, **моринд тах ~** прибивать к копытам лошади подковы

ХАДАХ 3. подниматься, устремляться ввысь

ХАДАХ 4.: **хавирга ~** отделять рёбра от позвоночника при разделке туши

ХАДГАЛАГДАХ *страд. от* **хадгалах**, храниться, сохраняться, быть хранимым, **хүнсний зүйлс сэрүүн газар ~ж байна** продукты хранятся в холодном месте, **энергийн ~ хууль** закон сохранения энергии

ХАДГАЛАГЧ хранитель, держатель, владелец, **хуучны ном судар ~** хранитель старинных книг

ХАДГАЛАЛТ хранение, владение, держание, сохранение, **бараа ~** хранение товаров

ХАДГАЛАМЖ вклад, **~ийн банк** сберегательный банк, **~ийн дэвтэр** сберегательная книжка

ХАДГАЛАХ хранить, сохранять, беречь, **кассанд мөнгө ~** хранить/держать деньги в сберкассе, **нууц ~** хранить тайну, хранить секреты, **сэтгэлдээ ~** хранить в памяти, **ачаа тээш ~ газар** камера хранения багажа

ХАДГАЛУУЛАГЧ поклажедатель

ХАДГАЛУУЛАХ *побуд. от* **хадгалах**, давать на хранение, **~аар өгөх** отдавать на хранение, депонировать

ХАДЛАН покос, сенокос, **~гийн үе** сенокосная пора

ХАДЛАНЧИН косарь, косец

ХАДМАЛ подстрочный, **~ орчуулга** подстрочный перевод

ХАДУУР коса, **гар ~** серп, **~ ирлэх** точить косу, **~ давтах** отбивать косу, **~аар хадах** косить косой, жать серпом

ХАДУУРАХ 1. сходить/сбиться с дороги, отклоняться от прямой линии, кидаться в сторону (о лошади)

ХАДУУРАХ 2. привирать, завираться, слишком увлекаться своим рассказом

ХАЖИГ бирюк, неуживчивый, замкнутый, скрытный, необщительный, придирчивый

ХАЖИГЛАХ быть бирюком, быть замкнутым, вести себя неуживчиво, придираться

ХАЖУУ 1) бок, сторона, склон, край, 2) боковой, **~ тийш болох** отойти в сторону, **~ тийшээ харах** смотреть в сторону, **замын ~д** у дороги, **хоёр ~гаар** по бокам, по обеим сторонам, **~д суух** сидеть рядом, **~гаас, ~ талаас харах** смотреть сбоку, **~гаар өнгөрөх** проходить мимо, **миний ~д** рядом со мной, **~гийн үндэс** побочный корень (корешок)

ХАЖУУД рядом

ХАЖУУЛАХ прилечь, лечь отдохнуть, вздремнуть

ХАЖУУЛДАХ 1) наклоняться набок, накреняться набок, 2) прилечь, **~ж унах** упасть на бок

ХАЖУУЛДУУЛАХ *побуд. от* **хажуулдах**, ставить что-либо боком, накренять/нагибать набок, наклонять набок

ХАЗААР узда, уздечка, **~ ногт** узда и неуздок, **~ын амгай** удила узды, **моринд ~аас барьж байх** держать лошадь под уздцы, **~ дарах** проявлять нетерпение, **мөнгөн ~ын чимээ** звон серебряной уздечки (стих Б.Явуухулана), **~ гүйлгэгч** конокрад

ХАЗААРГҮЙ без узды, необузданный, невзнузданный

ХАЗААРГҮЙДЭХ 1) не иметь узды, нуждаться в узде, 2) *перен.* не сдерживать себя

ХАЗААРЛАГДАХ *страд. от* **хазаарлах**, 1) взнуздываться, 2) обуздываться

ХАЗААРЛАЛТ обуздывание, взнуздывание, укрощение

ХАЗААРЛАХ 1) надевать узду, взнуздывать, обуздывать, 2) *перен.* обуздывать, укрощать, сдерживать, **морь ~** взнуздать лошадь, надевать узду на лошадь

ХАЗААРТАЙ с надетой уздой, взнузданный, обузданный, **~ морь** лошадь с неснятой уздой, взнузданный конь

ХАЗАГДАХ *страд. от* **хазах**, откусываться, быть откусанным

ХАЗАЙЛГАХ *побуд. от* **хазайх**, наклонять набок, накренять набок

ХАЗАЙЛТ наклонение, отклонение, искривление, **~гүй** неуклонный, неуклонно

ХАЗАЙХ клониться, наклоняться, накреняться, податься в сторону, **сэдвээс ~** отклоняться от темы, **замаас ~** отклоняться от дороги, **~ өнцөг** угол наклона, угол виража

ХАЗАХ кусать, откусать, кусаться, **тас ~** откусать, разгрызть, **хорсохдоо уруулаа ~** кусать губы от злости

ХАЗГАЙ кривой, косой, наклонный, искривлённый, косо, криво, неправильно, **муруй ~, ~ муруй** кривой, неправильный, **~ газар** наклонная местность, **~ гишгэх** а) ступать криво, стантывать обувь, б) ошибаться, совершить проступок, **үгийн ~ дуудлага** неправильное произношение слова, **~ дуудах/хэлэх** произносить неправильно, **монголоор ~ ярих** говорить на ломаном монгольском языке, **~ барих** держать что-либо криво, боком, косо

ХАЗГАЙВТАР несколько кривой, довольно косой, косоватый

ХАЗГАЙДАХ оказываться слишком кривым/косым, быть слиш-

ХАЗГАЙДУУ наклонённый набок
ХАЗГАЙРАХ 1) становиться кривым, делаться косым, искривляться, 2) *перен.* искажаться, извращаться
ХАЗГАЙРУУЛАХ *побуд. от* **хазгайрах**, 1) делать кривым, искривлять, 2) *перен.* искажать, извращать
ХАЗГАНАХ хромать, ковылять, **~ж явах** идти прихрамывая
ХАЗГАР хромой, хромающий, **~ хүн** хромой человек, хромоногий человек, **~ сандал** хромой/хромоногий стул, **~ болох** стать хромым
ХАЗГАРДАХ сильно хромать, становиться слишком хромым
ХАЙГУУЛ разведка, разведывание, поиск, **ашигт малтмалын ~** разведка полезных ископаемых, **геологи ~** геологическая разведка, **~ хийх/явуулах** произвести разведку, заниматься разведкой
ХАЙГУУЛЧ разведчик, поисковик, **геологи ~д** геологоразведчики
ХАЙЛААС ильм приземистый, вяз
ХАЙЛАЛТ 1) плавка, плавление, 2) таяние, 3) растворение, **ширэм ~** плавка чугуна
ХАЙЛАХ 1. 1) плавиться, расплавляться, растапливаться, 2) таять, 3) растворяться, 4) плавильный, 5) плавка, плавление, **цас ~ж байна** снег тает, **хар тулалга хурдан ~даг** свинец быстро плавится, **~ зуух/тасаг** плавильная печь/плавильный цех, **~ цэг** точка плавления
ХАЙЛАХ 2. терять в весе осенью (о скоте)
ХАЙЛАХ 3. лить слёзы, **уйлан ~** плакать
ХАЙЛАМТГАЙ плавкий, способный быстро плавиться, **~ төмөрлөг** плавкий металл, **~ чанар** плавкость
ХАЙЛГАН: намрын ~ цаг период осени, когда скот быстро теряет в весе при неразумном ухаживании за ним/при неумелом использовании его
ХАЙЛМАГ 1) плавка, плавленный, расплавленный, растоплённый, 2) растаявший, 3) кушанье из растоплённой пенки, **~ цас** талый/растаявший снег, **ширмийн түрүүчийн ~** первая плавка чугуна, **тэжээгч ~** расплав питающий
ХАЙЛМАГТАХ подтаивать, слегка таять, **цас ~на** снег подтаивает
ХАЙЛТ поиски, разыскивание, розыск
ХАЙЛУУЛАГЧ плавильщик, растворитель, **ган ~** сталевар
ХАЙЛУУЛАХ *побуд. от* **хайлах**, 1) плавить, расплавлять, растапливать, 2) растаивать, 3) растворять, **шил ~** плавить стекло, **тос ~** растапливать масло, **~сан өөх** топлёный жир, топлёное сало, **төмөрлөг ~** плавить металл
ХАЙЛУУР плавильщик, **~ жонш** флюорит, плавиковый шпат
ХАЙМАР резина, камера (в мяче)
ХАЙНАГ хайнак, помесь монгольской коровы с яком
ХАЙНГА 1) небрежный, неаккуратный, невнимательный, 2) небрежно, неаккуратно, невнимательно, **~ хүн** небрежный человек, **~ хандах** небрежно относиться
ХАЙНГАДАХ оказываться небрежным, быть невнимательным, вести себя неаккуратно/небрежно
ХАЙНГАДУУ довольно небрежный, отчасти неаккуратный, достаточно невнимательный
ХАЙР 1. любовь, **эхийн ~** материнская любовь, **~ хүрэх** любить, испытывать любовь, **~ хүргэх** вызывать любовь, завоевать любовь, **~ булаах** завоёвывать любовь, **~ сэтгэлээрээ суух/гэр бүл болох** жениться по любви, **~ хүндэтгэл** любовь и уважение, **~ талархал** любовь и благодарность, **~ найргүй** беспощадный, беспощадно, **~ гамгүй** небрежный, беззаботный, безжалостный, **амь ~гүй** беззаветно, самоотверженно, изо всех сил (что-либо делать), **~ энэрэл** благотворительность, любезность, чуткость, **Хорвоогоос уйдсан хүн байхгүй, ~аасаа уйдсан хэн ч байхгүй...** Нет уставших от этого мира и разве кто-то устал от любви? (из песни группы «Камертон»), **Их ~ их эрдэлийг дагуулж явдгийг сана (Далай лам)** Помни, великую любовь сопровождают большие горести (Далай лама)
ХАЙР 2. галька
ХАЙР 3.: **~ чулуурхаг** каменистая местность
ХАЙРАН 1) бедный, жалкий, ценный, 2) жаль, жалко, **~ нөхөр минь** бедный мой друг, **~ ч бие минь** бедный я, бедный, **~ ч юм** такая ценная вещь! **~ цаг!** сколько времени зря ушло!
ХАЙРАХ 1) жарить, 2) прижигать, 3) обжигать (о морозе), **хүйтэн жавар нүүр ~на** сильный мороз обжигает лицо
ХАЙРГА гравий, галька, щебень, грубый точильный камень, **~тай хөрс** грунт, содержащий мелкие камешки
ХАЙРГҮЙ 1) нелюбящий, 2) безжалостно, беспощадно, неаккуратно, **~ болох** разлюбить, **~ усттах** беспощадно уничтожать, **юманд ~ хандах** небрежно относиться к чему-либо, **амь ~** не щадя жизни, не щадя живота своего
ХАЙРЛАГДАХ *страд. от* **хайрлах**, быть любимым, завоёвывать любовь, пользоваться чьей-нибудь любовью, завоевать чью-либо симпатию
ХАЙРЛАНГҮЙ с любовью, **~ харах** смотреть с любовью
ХАЙРЛАХ любить, жалеть, испытывать любовь, 2) беречь, щадить, **эх орноо ~** любить родину, **юмыг ~ж хамгаалах** бережно относиться к чему-либо, **~н дурлах** любить, **нэр ~** дать имя кому-либо, **тэнгэр ~сан** ниспосланный небом, **«~н ~н суухад минь Салаад явчихсан хонгор минь...»** Уж как любил я тебя, Уж как ты ушла от меня...
ХАЙРС чешуя, **загасны ~** рыбья чешуя
ХАЙРТ любимый, дорогой, **~ нөхөр** дорогой друг, любимый товарищ, **«~ минь чамтайгаа хүн болон дүүлэхсэн...»** Любимая моя, с тобой хотел бы лебедем я стать... (из песни группы «Камертон»)
ХАЙРТАЙ 1) любимый, пользующийся любовью, дорогой, 2) любить, **~ хүн** любимый человек, **би чамд ~ я** тебя люблю
ХАЙРУУЛ сковорода, сковородка, **~ дээр мах хайрах** поджарить мясо на сковородке
ХАЙРХАН милостивый, священный (почтительное название гор), змея — почтительное название змеи в Завханском аймаке
ХАЙРЦАГ ящик, коробка, сундучок, шкатулка, пачка, **чүдэнзний ~** спичечная коробка, **шуудангийн ~** почтовый ящик, **тамхины ~** портсигар, папиросница, **эгшиг ~** музыкальная шкатулка
ХАЙРЦАГЛАХ класть в коробку, укладывать в ящик
ХАЙС 1. частокол, забор, ограда, *уст.* крепость с бойницами, **цэцэрлэгийн ~** ограда садового участка, садовый заборчик
ХАЙС 2. котелок
ХАЙС 3. дикий верблюдсамец
ХАЙХ искать, разыскивать, стараться найти, заниматься розысками, **ажил ~** искать работу, **мөр ~** искать следы/по следам
ХАЙХРАМЖ внимание, внимательность, забота, предупредительность, осмотрительность, **~ муутай хандах** относиться невнимательно/небрежно
ХАЙХРАМЖГҮЙ по небрежности, невнимательный, небрежный, неосторожный
